



"АЙМШГИЙН ХААН" - НЫ ШИНЭ БҮТЭЭЛИЙН ДЭЭЖ

**БҮРХҮҮЛД
ОРСОН ХОТ-2**

**БҮРЭН
СҮЙРЭЛ**

ДЭЛХИЙН БЕСТСЕЛЛЕР

Бүрхүүлд орсон хот
Зохиолч: Стивен Кинг
Орчуулсан: Т.Амардаваа
Редактор: С.Нарангэрэл, А.Гэрэл

ISBN: 978-99962-1-705-0

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Стивен Кинг бол дэлхийн аймшигийн зохиолын Хаан билээ Унш. Яагаад гэвэл Тууний бараг бүх номоор дэлхийн шилдэг аймшигийн кинонууд бүтээгдсэн байдаг

Унш. Яагаад гэвэл Хумуус дотроо мунхаг харанхуйг тээж, аймшигтай санаа бодол өвөрлөж, хамгийн хар муу сэтгэлийг агуулж явдаг боловч туунийгээ таг нууж хэнд ч ул хэлнэ. Гэвч хуний дотоод сэтгэлрүү нэвтрэх давтагдашгүй мастер Стивен Кинг энэ бүхнийг номондоо нээн харуулдаг. Бусад хумуусийн хар санаа таньд бас байнау?

Унш. Яагаад гэвэл Энэ ном таныг айлгах боловч та нүдээ салгаж чадахгүй уншина. Энэ ном таны жигшил зэвүүцлийг төрүүлэх боловч та энэ номонд хайртай болно. Яагаад гэвэл Стивен Кинг уншигч таны дотоод сэтгэлийн харанхуйг хайр найргуй, дээрэнгүй, улайран ухдаг юм.

Унш. Яагаад гэвэл Бидний хэн нь ч сэтгэл дотор байх айдсынхаа аймшигт хар ангалын ирмэг дээр зогсож байдаг өрөвдөлтэй хун билээ. Сэтгэлрүүгээ чин сэтгэлээсээ хэзээ ч өнгийж харж чадахгүй. Яагаад гэвэл та өөрөө өөрөөсөө айдаг. Харин Агуу Стивен Кинг л таныг тийш харахад туслах болно.

"Аймшигийн хаан" Стивен Кингийн шинэ роман. АСАР ТОМ ГАЙ гэнэт дайрсан жижигхотын шинэ туух. Нэгэн удаа энэ жижиг хотыг бүх оршин суугчдынх нь хамт нүдэнд ул үзэгдэх нууцлаг Бурхуул хөмрөн дарав. Хэн ч Бурхуул дороос гарах юмуу орох аргагүй боллоо. Одоо энэ хотод юу болох вэ? Тууний оршин суугчид яах бол? Хэрэв хууль цааз ба шийтгэлийн айдас угуй болох цагт хун харгис араатан болон хувирахад хамгийн нимгэн хаалт улддэг ажээ. Энэ хаалтыг хэн цөмлөн гарч, харин хэнхун хэвээрээ үлдэх вэ? Та энэ хотод байсан бол Хунхэвээрээ үлдэх уу, Араатан болох байсануу?

Шоронд

1

Эдлэн рүү нь орж яваа Брендаг хэн ч хараагүй гэж хотын захиргааны хоёрдугаар гишүүн Реннигийн бодсон нь зөв байсан юм. Гэвч өглөөгүүр тэр эмэгтэйн нааш цааш холхихыг гурван ч хүн харсан бөгөөд тэр бүү хэл тэдний нэг нь Үйлдвэрийн гудамжинд амьдардаг байлаа. Хэрэв Том Жим үүнийг мэдсэн бол гэмт үйлдэл хийхээ зогсоох байсан болов уу? Бараг л үгүй байх. Тэр сонгосон замдаа аль хэдийн хөл тавьсан бөгөөд эргэж буцаж чадахгүй болсон. Гэвч хүмүүс харсаныг мэдсэн бол Ренни багахан ч гэсэн бодолд автаж, (тэр өөрийнхөөрөө их бодлогоширдог хүн байсан) тэгээд хүн алах нь яг "Лейс" шарсан төмс идэхтэй адил бөгөөд нэг удаа амтлах л юм бол зогсч чадахаа болино гэсэн дүгнэлтэнд хүрэх байсан.

2

Том Жим Төв гудамж руу дөхөхдөө тэдгээр ажиглагчдыг хараагүй юм. Толгойн энгэр даган хотын төв талбай руу өгссөн Бренда ч бас тэднийг хараагүй. Яагаад гэвэл ажиглагчид өөрсдөө хэнд ч харагдахыг хүсээгүй болоод тэр. Тэд аль хэдийн ослын байдалд орсон Энхтайвны гүүрэн дээр нуугдсан байлаа. Гэхдээ яг энэ үед тэд долоон дор юм үйлдэж суув. Хэрэв Клер Макклетчи тэдний тамхи татаж байгааг харсан бол арын сүвээр нь баасны оронд тоосго шахаж гаргах байсан байх. Тэр бүү хэл хоёр тоосго гаргаж мэдэх байсан. Мэдээж Жо-г цаашид Норри Кэлвертэй харьцахыг хориглох байсан. Тэдний нөхөрлөлөөс хотын хувь заяа хамаарах байлаа ч хориглох л байсан. Яагаад гэвэл тамхийг энэ охин авчирсан бөгөөд тэр нь гараашийн тавиур дээрээс олсон ихэд хорчийж бас тахийсан хайрцагтай "Винстон" тамхи байлаа. Түүний эцэг жилийн өмнө тамхинаас гарсан бөгөөд энэ хайрцаг тоос шороонд дарагджээ. Гэхдээ Норригийн бодлоор зориулалтаар нь хэрэглэх боломжтой харагдав. Хайрцагт гурван ширхэг тамхи байсан нь хүн бүхэнд нэг оногдох учир хамгийн тохиромжтой санагдана.

-Энэ бол аз завшаан авчрах ёслол гэж тооцоорой. Бид бурхнаас ангийн олз гуйж байгаа индианууд шиг тамхилах болно. Тэгээд ажилдаа орцгооё гэж Норри хэлэв.

-Муугүй сонсогдож байна гээд Жо толгой дохилоо. Тэр аль хэдийнээс тамхи татахыг сонирхож байсан. Юугаараа дур татаад байгааг ойлгохгүй байв. Гэвч маш олон хүн татдаг болохоор ямар нэг шалтгаан байж таарна.

-Ямар бурхнаас? гэж Бенни асуулаа.

-Ямрыг сонгохоо өөрөө мэд гэж хэлээд Норри түүн рүү урд нь энэ хорвоогийн бүх тэнэгээс хамгийн тэнэг нь зогсч байгаа юм шиг харав. Тэгснээ:

-Чи тэгтлээ хүсээд байгаа юм бол бурханлаг бурханаас гуй гэлээ.

Үрчгэр богино жинсэн өмд ба ягаан цамц өмсч, үргэлж үсээ ардаа боогоод тэр нь хоёр тийш

санжиганаж байдгаа энэ өдөр орхин задгай тавьсан бөгөөд жижиг үнэгэн нүүрийг нь үс эмжээрлэх энэ охин өнөөдөр хоёр хүүгийн аль алины хувьд тун дур булаам харагдаж байсан юм. Ер нь тэгж хэлэх юм бол нүд сохлом харагдсан гэж ч болно.

-Би хувьдаа Гайхамшигт эмэгтэйд мөргөх болно гэж охин хэллээ.

-Гайхамшигт эмэгтэй бол бурхан биш гэж Жо хэлээд удаан хадгалагдсан тамхинаас нэгийг авч тэгшлэв. Тэгснээ жаахан бодож байгаад:

-Гайхамшигт эмэгтэй бол супер баатар. Супер баатар эмэгтэй гэж болно.

-Миний хувьд тэр бурхан гэж Норри хэлэх үед түүний нүд яг энэ үед сэтгэлээсээ ярьж байгааг илтгэн гэрэлтэв. Охин ч бас өөрийн тамхийг болгоомжтой тэгшилнэ. Харин Бенни тэднийг дуурайсангүй. Тахийсан тамхи илүү мундаг харагдана гэж тэр бодлоо.

-Би 9 нас хүртлээ Гайхамшигт эмэгтэйн хүчний бугуйвч зүүдэг байсан. Дараа нь алдчихсан л даа. Бугуйвчийг тэр муу Ивонн гичий туучихсан гэж боддог юм гэж хэлээд Норри шүдэнз зурж мануухай Жо-гийн тамхийг асааж өгөөд дараа нь Беннид барив. Тэгснээ өөрийнхийгөө асаах гэтэл Бенни үлээж унтраалаа.

-Чи яаж байна аа?

-Галыг гуравлах нь гай авчирдаг юм. -Чи үүнд итгэдэг хэрэг үү?

-Нэг их ч итгээд байдаггүй. Гэхдээ өнөөдөр бидэнд аз завшаан бүхэн хэрэг болно гэснээ Бенни унадаг дугуйн сагсанд байгаа хүнсний уут руу хяламхийн хараад тамхиа сорлоо. Тэгээд хахаж цацан утааг гадапнлуулахад нүдэнд нь нулимс цийлэгнэв.

-Амт гэж хархны баас юм даа.

-Чи тэр хархны бааснаасаа зөндөө татсан уу аан? гэж Жо тамхинаас соронгоо хэлэв. Тэр сул дорой харагдахыг хүссэнгүй. Бас ханиах юмуу магадгүй бөөлжихийг ч хүссэнгүй. Утаа дотрыг нь харлуулж, тааламжтай юм нэг ч байсангүй. Эцсийн эцэст яг энд л ямар нэг нууц байдаг байх. Гэхдээ толгой нь бага зэрэг эргэв.

"Тамхийг болгоомжтой уушиглах хэрэгтэй. Тасрах юм бол бөөлжсөнтэй адил шившигтэй" гэж дотроо өөртөө хэлэв. Гэхдээ Норригийн өвөр дээр унавал ч дэндүү сайхан байх.

Норри хармаа руугаа гараа шургуулаад "Верифайн" жүүсний лонхны таг гаргаж ирлээ.

-Үнсний савны оронд хэрэглэх гэсэн юм. Тамхи татах индиан ёслол мэдээж гоё л доо. Гэвч би Энхтайваны гүүрээ шатаахыг хүсэхгүй гэж хэлээд Норри нүдээ анив. Уруул нь татвалзана. Тамхи хурууны завсар байх ба үнсний хэмжээ уртассаар байлаа.

Бенни Жо руу харж мөрөө хавчсанаа мөн л нүдээ анив.

-Тэнгэрийн явган цэрэг Жо та номхорсон шинэ цэрэг Беннигийн залбирлыг сонс...

Норри нүдээ нээлгүй түүнийг тийрэв. Жо босч зогслоо. (Толгой нь тийм их хүчтэй биш боловч эргэнэ. Тиймээс зогсч байгаад тамхиа татахыг хүссэн аж.) Жо унадаг дугуйн хажуугаар гарч, гүүрний хотын талбай руу гардаг үзүүрт очлоо.

-Чи хаачихна вэ? гэж Норри нүдээ аньсан чигээр асуув. -Байгаль дэлхийгээ харж байгаад зальбирвал илүү сайн байдаг юм.

Үнэн хэрэгтээ Жо цэвэр агаар залгилахыг хүсчээ. Ингэх шалтгаан нь тамхины утаа биш бөгөөд тамхины үнэр түүнд тэр бүү хэл таалагдсан гэхэд болно. Гэвч битүү гүүрэнд бусад үнэр хангалттай байлаа. Муудсан хүнс, асгарсан шар айраг, бас нэг юу ч юм исгэлэн химийн үнэр ханхлах нь тэр доогуур урсах Престил-Стрим голоос гарч байх бололтой.

Гэвч гаднах агаар ч тийм цэнгэг байсангүй. Агаарыг аль хэдийн хэрэглэчихсэн юм шиг сэтгэгдэл төрнө. Тэгээд өнгөрсөн жил Нью-Йорк руу аялсан тухайгаа Жо саналаа. Тэндхийн метронд яг ийм агаар үнэртэж байсан. Ялангуяа орой хүмүүс вагонуудыг дүүргэн гэртээ буцах үед.

Тэр үнсээ гар дээрээ цохиж унагаав. Тэгээд үлээх үед толгой руу өгсч яваа Брендаг олж харжээ. Яг энэ үед түүний мөрөнд гар хүрлээ. Беннигийнх гэхэд дэндүү жижигхэн бас хөнгөн байв.

-Тэр хэн бэ? гэж Норри асуув.

-Би түүнийг таньж байна. Гэхдээ нэрийг нь мэдэхгүй. Бенни тэдэн дээр ирлээ.

-Тэр бол хатагтай Перкинс. Шерифийн бэлэвсэн эхнэр.

Норри түүнийг тохойгоор нудрав.

-Тэнэг минь цагдаагийн даргын гээч.

Бенни мөрөө хавчаад

-Ямар ялгаа байгаа юм бэ? гэлээ.

Өөр харах хүнгүй болохоор тэд түүнийг ажиглав. Хотын бусад иргэд хүнсний төлөөх дэлхийн хамгийн том тулалдаанд оролцохоор их дэлгүүр рүү явсан бололтой. Гурван жаал тагнуулдаж эхэлсэн ч тулалдааны талбарт ойртсонгүй. Тэдэнд гардуулсан багажны үнэ цэнийг тооцох юм бол тулалдаанаас хол байх ёстойг ятгаж сануулах хэрэг ч гарсангүй.

Бренда Төв гудамжаар өнгөрч Престил-Стрит рүү эргэлээ. Тэгээд Маккейнуудын байшингийн дэргэд түр зогссоноо цаашаа өнгөрч, Андреа Гриннелийн байшин руу очив.

-Явцгаая гэж Бенни уриаллаа.

-Тэр эмэгтэй яваагүй цагт бид явж болохгүй гэж Норри эсэргүүцэв.

Бенни мөрөө хавчив.

-Сүртэй юм. Тэр биднийг харлаа ч гэсэн хотын талбайгаар тэнэж яваа гурван жаал л гэж бодно. Яагаад гэдгийг мэдэх үү? Тэр эмэгтэй бидэнд тулж харсан ч биднийг анзаарахгүй. Томчууд хүүхдүүдийг хэзээ ч олж хардаггүй юм. Мэдээж хэрэв скейтборд хөлөглөөгүй бол шүү дээ гэж хэлэхдээ тэр сүүлчийн өгүүлбэрээ ихэд бодож байж хэлэв.

-Эсвэл тамхи татаагүй бол олж харахгүй гэж Норри нэмж хэллээ. Тэгээд гурвуулаа утаа манарах тамхиа харав.

Жо Беннигийн унадаг дугуйн жолоонд бэхэлсэн сагс руу заагаад:

-Бас тэд хотын мэдлийн үнэтэй багажаар ямар нэг юм хийж байгаа хүүхдүүдийг олж хардаг онцлогтой гэв.

Норри тамхиа амныхаа буланд шилжүүлж зуух тэр агшинд шууд л аймаар мундаг, аймаар хөөрхөн, бас аймаар том хүүхэн харагдав.

Жаалууд ажиглалтаа үргэлжлүүллээ. Одоо цагдаагийн даргын эхнэр хатагтай Андреатай ярилцаж байна. Хэдхэн хормын дараа цаадах нь зочныхоо яг хамарны өмнө хаалгаа тасхийтэл хаав.

-Пөөх ямар бүдүүлэг юм бэ? Хэрэв бид ингэсэн бол долоо хоногийн турш хичээлийн дараа ангидаа үлдэж шийтгүүлэх байсан даа гэж Бенни толгой сэгсрэн хэлэхэд Жо Норри хоёр инээлдэв.

Хатагтай Перкинс хаагдсан хаалганы өмнө яахаа мэдэхгүй мэт хэсэг зогсов. Дараа нь довжоогоор уруудаж эхлэхэд гурван жаал зөн совингоороо хойш ухарч битүү гүүрний сүүдэрт шургалаа. Ингэснээр тэд хатагтай Перкинсийг харж чадахгүй болов. Гэвч Жо тэр дороо хажуугийн хананд тохирох нүх оллоо.

-Төв гудамж руу буцаж явна. Тийм ээ, толгой руу өгсөөд, дахиад Төв гудамжийг огтоллоо гэж тэр илтгэнэ.

Бенни микрофон дүрслэн гараа зангидаад түүний хамар дор аваачив.

-Зураг авалт эхэллээ.

Жо түүнийг огт тоосонгүй.

-Одоо манай гудамж руу эргэж байна гэснээ тэр Бенни Норри хоёр руу харж: -Тэр арай манай ээж дээр очиж яваа юм биш биз? гэв.

-Тэнэг ээ, Үйлдвэрийн гудамж гэдэг чинь дөрвөн хорооллыг дайрдаг юм. Танайд очих магадлал ямархуу байна даа? гэж Бенни хэлэв.

Хатагтай Перкинс тэднийд очлоо ч гэсэн юугаараа муу болохыг тэр төсөөлөхгүй байсан ч

Жо-гийн дотор хөнгөрөөд явчихав. Гэхдээ эцэг нь Бүрхүүлийн гадна үлдсэнээс хойш ээж нь сэтгэл санаа ихэд хямарсан ба одоо ямар ч хамаагүй шалтгаанаар дүрсхийдэг болсон. Ээж нь түүнийг энэ аялалд оролцохыг бараг шууд хориглосон. Гэвч хатагтай Шамуэй ээжийг нь ятгаж чадсан болохоор түүнд баярлах хэрэгтэй. Барбарагийн бодлоор Жо-гоос өөр энэ даалгаврыг илүү сайн гүйцэтгэх хүнгүй гэж хэлсээр ятгаж чадсан. (Жо Бенни Норри гурав ч тэдэнд даалгасан ажлыг үүрэг даалгавар гэж нэрлэхийг илүүд үзнэ.)

-Хатагтай Макклэтчи, хэрэв хэн нэгэн хүн энэ багажийг ажиллуулж чадна гэх юм бол тэр ганцхан таны хүү л юм.

Барби Жо-д итгэж байгаа. Энэ маш чухал гэж Жулия хэлсэн. Мэдээж ингэж тодорхойлсны дараа Жо-гийн сэтгэл санаа өргөгдөөд ирэв. Гэвч түгшиж цонхийсон ээжийнхээ царайг ганц хараад л дахин сэтгэлээр уналаа. Бүрхүүл бий болсноос хойш гурван өдөр ч өнгөрөөгүй байхад ээж нь аль хэдийн туржээ. Тэр аавынх нь гэрэл зургийг гартаа барьж ширтэхийг хараад Жо-гийн зүрх шимширнэ. Эцэг нь тохилог буурчийн газарт сууж шар айраг уунгаа Эйч-Би-Оу суваг үзэж байгаа биш харин үхчихсэн гэж бодоод байгаа ч юм шиг. Гэвч ээж нь Жулиатай санаа нийлэв.

-Тэр техник ойлгодог нь үнэн. Үргэлж ойлгодог байсан гэснээ тэр хүүгээ хөлөөс толгой хүртэл харж санаа алдаад: -Хүү минь чи хэзээдээ ийм болж амждаг байна вэ? гэв.

-Мэдэхгүй гэж Жо шударгаар хариуллаа.

-Хэрэв би чамайг явахыг зөвшөөрөх юм бол чи болгоомжтой байж чадах уу?

-Бас найз нараа дагуулаарай гэж үг хавчууллаа.

-Бенни Норри хоёрыг уу? Мэдээж шүү дээ.

-Бас болгоомжтой байгаарай. Миний юу хэлж байгааг чи ойлгож байна уу? гэж Жулия хэллээ.

-Тийм ээ, ойлгож байна.

Өөрөөр хэлбэл битгий баригдчихаарай гэсэн үг.

3

Бренда үйлдвэрийн гудамж дагуу ургасан моддын дунд алга болов.

-За явцгаая гээд Бенни толгой сэжлээ.

Тэр үнсний хуурамч саванд тамхиа унтраагаад сагснаас хүнсний уут татан гаргав. Дотор нь Барбигаас Растид очоод тэндээс Жулиягаар дамжин Жо ба түүний багт ирсэн Гейгерийн шар тоолуур хэвтэнэ.

Жо лонхны тагийг авч өөрийнхөө тамхийг бас унтраах үедээ, мэдрэмжид хамаг анхаарлаа төвлөрүүлэх боломжтой цаг гарах юм бол дахиад татаж үзнэ гэж бодов. Гэхдээ хэрэггүй ч

байж мэдэх юм. Тэр компьютер, Брайан Воэний (америкийн зураач зохиолч) зурагт ном ба скейтбордоор хичээллэж байгаа. Нэг нуруу үүнээс ихийг даах болов уу?

-Хүмүүс хажуугаар өнгөрөх болно. Магадгүй маш олон хүмүүс өнгөрнө. Их дэлгүүрийн наргианд залхсан хүмүүс буцах байх. Тэд биднийг бүү анзаараасай гэж найдах л үлдэж байна хэмээн тэр Бенни Норри хоёрт сануулав.

Ээжид нь энэ ажил хстод хичнээн чухал болох тухай хэлэх хатагтай Шамуйэн яриа толгойд нь дүнгэнэнэ. Тэр Жо-д бол энэ тухай хэлэхгүй байсан ч болох байсан. Учир нь Жо бусдыгаа бодвол илүү сайн ойлгож байлаа.

-Хэрэв цагдаа нар гараад ирвэл яах вэ? гэж Норри ярьж эхлэв.

Жо шууд толгой дохин яриаг нь таслаад: -Тоолуур хүүдийнд буцан орж, оронд нь гоймонтой хоол гарч ирнэ.

-Ингэхэд хотын Төв талбай дор ямар нэг харь гаригийн үүсгүүр булаастай байгаа гэж чи үнэхээр бодоод байгаа юмуу? гэж Бенни асуув.

-Ийм байх боломжтой гэж би хэлсэн шүү дээ. Ийм юм байх боломжтой гэж Жо огцом хариуллаа.

Үнэнийг хэлэхэд Жо ийм юм байх нь боломжтойгоор зогсохгүй харин ч бүр магадлалтай гэж бодож байна. Хэрэв Бүрхүүл өөрөө ер бусын байгалийн зүйл биш юм бол энэ нь хүчний орон зай байж таарна. Хүчний орон зайг ямар нэг юм үүсгэдэг. Тиймээс Жо-д ямар ч эргэлзээ байсангүй. Тэр бусдынхаа найдварыг үлээж бадраахыг хүссэнгүй. Өөрийнхийгөө ч бас.

-За тэгвэл эрлээ эхлэе. Та хоёр сайн залбирсан биз дээ? гээд Норри цагдаагийн шар туузан доогуур шурган гарлаа.

Жо залбирлын хүчинд иттэдэггүй. Хүн өөрөө л бүхнийг хийх ёстой гэдэгт иттэдэг. Гэхдээ тэр залбирсан нь өөр шалтгаантай. Яагаад гэвэл хэрэв үүсгүүрийг олох юм Норри түүнд бас нэгэн үнсэлт бэлэглэж жаргал хайрлана гэж бодсон. Амттай удаан үнсэлт.

4

Өглөө тэд Макклэтчигийн гэрийн зочны өрөөнд шуурхай зөвлөгөөн хийх үеэр мануухай Жо баруун хөлийн пүүзээ дараа нь спорт оймсоо тайлав.

-Амттан эсвэл новш. Чи миний хөлийг үнэрлэсэн тул надад шарсан төмс өг гэж Бенни хөгжилтэй хашгирлаа.

-Амаа тат тэнэг минь.

-Найзыгаа тэнэг гэж нэрлэх сайхан биш шүү гэж хатагтай Макклэтчи хэлэнгээ Бенниг зэмлэнгүй харав. Жо хэрхэн оймсоо зочдын өрөөний хивсэн дээр тавиад илж тэнийлгэхийг

Норри сонирхон ажиглангаа дуугүй байхыг эрхэмлэв.

-Энэ бол Честерс-Милл хот. Хэлбэр нь яг адилхан байгаа биз? гэж Жо тайлбарлав.

-Чиний түмэн зөв. Бидний хувь тавилан ийм байж дээ. Жо-гийн спорт оймстой төстэй хотод амьдрах хувьтай гэж Бенни зөвшөөрлөө.

-Эсвэл хөгшин эмгэний шаахайтай адилхан гэж Норри үг хавчуулав.

-**"Шаахай дотор нэгэн эмгэн ганцаараа амьдардаг байжээ"** гэж хатагтай Макклэтчи ишлэв. Тэр буйдан дээр суух бөгөөд өчигдөр орой хатагтай Шамуэй Гейгерийн тоолуур авчрах үед сууж байсан шигээ өвдөг дээрээ нөхрийнхөө гэрэл зургийг тавьсан чигээр сууна.

-**"Тэгээд хүүхдүүд төрүүлжээ. Маш олон хүүхэд төрүүлжээ. Тэднийг яахаа ч мэдэхээ больжээ"**. (ихэд түгээмэл "Галуу эхийн үлгэр" хэмээх хүүхдийн шүлэг.)

-Ээж ээ сайн байна гэж хэлэхдээ Жо инээхгүй байхыг байдгаараа хичээв. Яагаад гэвэл сургуульд энэ шүлгийг өөрөөр уншдаг. **"Тэгээд хүүхдүүд төрүүлжээ. Маш олон хүүхэд төрүүлжээ. Тэр бүү хэл өнөөх нь салж унатар төрүүлжээ"** гэдэг.

Жо оймсоо ширтэнгээ:

-Ингэхэд оймсны гол хэсэг нь аль юм бэ? гэв.

Бенни Норри хоёр бодлогоширов. Жо тэднийг шахаж яаруулсангүй. Тэд олон зүйлээр түүнд таалагддагийн дотор иймэрхүү асуултыг сонирхдог нь бас таалагдана.

-Дөрвөлжин юмуу дугуйн төв хэсэг шиг бол биш. Энэ бол геометр дүрс биш гэж Норри дуугүй байж байснаа арай гэж хэлэв.

-Харин би оймсыг геометрийн дүрс гэж бодож байна. Гэхдээ юу гэж нэрлэхээ мэдэхгүй юм. Оймс өнцөгт гэлтэй биш гэж Бенни хариуллаа.

Норри инээд алдав. Тэр бүү хэл Клер бараг инээв.

-Газрын зураг дээр бол Честерс-Милл хот 6 өнцөгттэй илүү төстэй. Гэхдээ энэ чухал биш. Эрүүл ухаандаа захирагдах хэрэгтэй гэж Жо хэллээ.

Норри өсгий хэсэгнээс түрий рүү шилжиж байгаа тэр хэсгийг заав.

-Төв хэсэг нь энэ байна.

Жо түүний заасан газрыг тосон балаар зурж тэмдэглэлээ.

-Энэ толбо арилна гэж би бодохгүй байна ноёнтоон. Гэвч чамд ямар ч гэсэн шинэ оймс хэрэгтэй байх. Хэрэв газрын зураг дээр харах юм бол чиний тэмдэглэсэн газарт хотын Төв талбай бий. Та нар түүнийг тэнд л хайх хэрэгтэй гэж Клер санааширан хэллээ.

-Яг тэндээс хайж эхлэх болно гэж Жо бувтнав. Түүний хэлэх гэж байсан үгийг ээж нь шүүрээд хэлчихсэн болохоор сэтгэл ханамжгүй байгаа нь тэр.

-Яагаад гэвэл хэрэв үүсгүүр байгаа л юм бол түүнийг хотын нутаг дэвсгэрийн яг голд нь тавьж таарна. Эсвэл аль болох ойр гэж Клер бодлоо үргэлжлүүлэн хэллээ.

Жо толгой дохив.

-Хатагтай Макклэтчи ёстой мундаг. Түүнд онц тавь. Миний үзэл бодол нэгт ахын ээж гэж Бенни гараа өргөн хэлэв.

Клер нөхрийнхөө гэрэл зургийг барьсан чигээр инээхчээ аядаад Беннигийн алган дээр алгадав.

-Ядахдаа хотын төв талбай аюулгүй газар. Ямар ч гэсэн би тийм гэж найдаж байна. Гэхдээ хэн мэдэх билээ дээ гэж Клер бодлогоширон хөмсөг зангидав.

-Та битгий санаа зов. Би түүнээс хараа салгахгүй гэж Норри түүнийг тайвшруулна.

-Та нар зүгээр л надад нэг юм амал. Хэрэв ямар нэг юм олох юм бол юу болохыг нь мэргэжилтнүүд тогтоох ёстой шүү.

"Ээж минь дээ тэр мэргэжилтнүүд чинь бид нар байна" гэж Жо бодлоо. Гэвч мэдээж гадагш хэлсэнгүй. Хэлэх юм бол ээжийнхээ сэтгэлийг улам илүү зовооно гэдгээ мэдэж байв.

-Амлая. Миний үзэл санаа нэгт ахын ээж дахиад гараа алгадая гэж хэлээд Бенни хуруунуудаа сарвайлган гараа өргөлөө.

Энэ удаад тэдний гар гэрэл зургийн хальсанд үлдэв. -Бенни би чамд хайртай. Гэвч чи заримдаа намайг ядраах

юм.

Жаалхүү гунигтай инээмсэглэв. -Манай ээж ч бас тэгж хэлдэг.

Жо найзуудын хамт хотын талбайн төв хэсэг рүү зүглэв. Бүрхүүл хотын баруун хойд хэсгийг огтолсоноос болж үүссэн далангийн гайгаар усгүй болж эхэлсэн Престил-Стрим гол тэдний ард ямар нэг юм аяархан бувтнах шиг болно. Хэрэв Бүрхүүл дахиад хэд хонох юм бол Жо-гийн бодлоор Престил-Стрим гол ёроолын шавар дундуур гүйсэн бяцхан горхи болох байлаа.

-За за. Дэмий юм хийж боллоо. Скейтчид Честерс-Миллийг аврах цаг нь болжээ. Нөгөөхөө ажиллуул.

Жо хүнсний уутнаас Гейгерийн тоолуурыг болгоомжтой "үнэн таашаалтай гаргаж ирлээ". Тоолуурыг цахилгаан эрчим хүчээр хангах ёстой өөрийнх нь цэнэг хураагуур аль хэдийн нам

суужээ. Хүрэлцэх шонгууд нь зузаан зэвэн давхаргаар хучигдсан байв. Гэвч давхар нүүрсхүчлийн содоор арчаад зэвийг арилгаж дөнгөжээ. Харин Норри эцгийнхээ урлангаас нэг биш бүр гурван ширхэг 6 вольтын цэнэг хураагуур олсон юм. "Цэнэг хураагуурын тухай ярих юм бол цаадах чинь солиорно. Тэр хэзээ нэгэн цагт скейт дээр гулгаж сурах гэж байгаад үхэх байх. Гэхдээ би түүнд хайртай" гэж Норри найзууддаа үнэнийг өчсөн юм.

Жо асаагуур дээр хуруугаа тавиад найз нар руугаа царай барайн ширтэв.

-Энэ нөхөр бидэн рүү туяа илгээж байгаа бүхнийг илрүүлэх чадвартай. Үүсгүүр ч байж мэднэ. Үүсгүүр байлаа гэхэд зөвхөн альфа юмуу бета туяа...

-Бурхан минь больж үз. Зүгээр л залга. Хүлээсээр үхэх нь гэж Бенни дуу алдав.

-Түүний зөв. Алив эхэл гэж хэлээд Норри толгой дохилоо.

Гэвч энд нэг сонирхолтой юм бий. Юу гэвэл Жо Гейгерийн тоолуурыг гэртээ аль хэдийн ажиллуулж үзсэн. Нүүрэндээ радийтай хуучны цагийг түүнд дөхүүлэхэд зүү нь заналтай чичирч байсан. Тоолуур онц сайн ажиллаж байна. Гэвч энд, тулалдааны талбарт гэж хэлдэг дээ, Жо гэнэт хүйт даагаад явчихав. Духан дээр нь хөлс чийхрахыг мэдэрлээ. Хөлс том дуслууд болон бөөгнөрөхийг мэдэрсэн ба удахгүй нүүрээр нь цугтах болно.

Хэрэв Норри түүний гар дээр гараа тавиагүй бол мань хүн өшөө хичнээн удаан шон шиг зогсох байсныг бүү мэд. Дараа нь Бенни бас гараа тавьлаа. Ингээд гурвуулаа асаагуурыг хөдөлгөв. "Нэг секунд дэх импульсын тоо" гэсэн заалтын зүү нүд ирмэх зуур нэмэх тав гэсэн заалт дээр давхиж очиход Норри Жо-гийн мөрнөөс базаад авав. Гэвч зүү эргээд нэмэх хоёр дээр ирэхэд охин гараа сулрууллаа. Тэд радио идэвхит туяаны тоолууртай ажиллах туршлагагүй. Гэвч энэ бол зүгээр л дэвсгэр гэдгийг таацгааж байв.

Жо талбайн төв хэсгээр аажуухан тойрно. Гейгер-Мюллерийн хоолой телефон утасныхтай төстэй мушгиа утасны дотроос цухуйна. Цахилгаан гүйдэл ирж байгааг харуулдаг индикатор гэрэл хув шиг гялалзана. Зүү үе үе чичрэх боловч тэг гэсэн заалтын орчимд байсаар байв. Жо гайхсан ч үгүй. Шууд болчихно гэж огт бодоогүй. Гэхдээ үүний хажуугаар гашуун урам хугаралтыг мэдрэв. Урам хугаралт ба гайхал төрөхгүй байх хоёр бие биенээ ямар сайхан дэмжиж өгдөг нь гайхалтай. Яг л Олсений ихрүүд шиг. (Мэри ба Эшли Олсен нар нь ихрүүд бөгөөд нэртэй жүжигчид, бас дуучид юм)

-Алив надад өг. Би азтай байх ч юмуу билүү? гэж Норри гуйв.

Жо огт эсэргүүцэлгүй тоолуурыг өглөө. Дараа нь бараг цаг илүүтэй тэд Гейгерийн тоолуурыг бие биедээ дамжуулан хотын талбайг тойров. Үйлдвэрийн гудамж руу эргэсэн машиныг харсан ч жолооны ард сууж яваа бага Реннийг анзаарсангүй. Хэн ч тэднийг анзаараагүй. Анивчуур ба дуут дохиогоо залгасан түргэний тэрэг толгойн бэл рүү уруудаж "Хүнсний ертөнц" рүү чиглэв. Жаалууд түргэний тэрэгийг хяламхийн харчихаад ажлаа үргэлжлүүлээ. Энэ ажилдаа хэт их татагдсан учир эцгийнхээ "хаммер" машиныг жолоодон дахин гарч ирсэн Жижгээг анзаарсангүй.

Тэд хэн нэгний анхаарлыг сарниулах зорилгоор авч гарсан гоймонтой хоолоо ашиглаж чадсангүй. Учир нь туяа цацруулагчийн эх сурвалжийг хайх ажилд хамаг анхаарлаа төвлөрүүлжээ. Тэгээд ч хэн нэгний анхаарлыг сарниулах хэрэгцээ гараагүй.

Гэр гэрээ зүглэх цөөхөн оршин суугчид хотын Төв талбай руу харсан ч үгүй. Зарим нь авсан шархандаа анхаарал хандуулна. Олонхи нь дээрэмдсэн хүнсээ зөөх ба хэн нэгэн тэрэг дүүрэн юм түрнэ. Бүгд ичиж зовсон харагдана.

Үд дунд гэхэд Жо ба түүний нөхөд цагаан тугаа өргөхөд бэлэн болоод байв.

-Манайх руу буцъя. Ээж бидэнд хоол өгөх байх гэж Жо санал болголоо.

-Гайхалтай сайхан санаа. Ногоотой жигнэсэн мах өгнө гэж найдъя. Танай ээжийн тэр хоол дээд зэрэг гэж Бенни толгой

Стивен Кинг дохилоо.

-Бид Энхтайваны гүүрээр гараад нөгөө талыг нь шалгавал яасан юм бэ? гэж Норри санал тавив. Жо духаа үрчийлгэлээ.

-Тэнд ой модноос өөр юу ч байхгүй. Тэгээд ч төвөөс холдчихно.

-Тийм л дээ. Гэхдээ... гэснээ охин дуугаа хураав. -Юу гэж?

-Юу ч биш л дээ. Гэхдээ нэг санаа байна. Тэнэг санаа ч байж мэднэ.

Жо Бенни рүү харлаа. Цаадах нь мөрөө хавчаад тоолуурыг Норри руу сунгав.

Тэд Энхтайваны гүүр рүү буцаж очоод өлгөөстэй шар туузан доогуур шургав. Гүүрэн дээр бүрэнхий байсан ч гэрэл хангалттай учир гүүрний талаас цааш өнгөрөх үед зүү чичирч эхлэхийг Жо Норригийн мөрөн дээгүүр харав. Тэд өмхөрсөн банзанд ачаалал өгөхгүйн тулд өлмийдөн болгоомжтой алхана. Хүүхдүүд гүүрний нөгөө талд гарах үед заагч самбар дээрх бичиг "Та бүхэн 1808 онд барьсан Миллийн хотын талбайг орхиж байна" гэж мэдээлэв. Баларсан жим уулын бэлээр дээш өгсөх ба энд хус, царс мод битүү ургажээ. Намрын навчис мөчир дээрээ санжиганах бөгөөд хөгжилтэй биш харин гунигтай харагдана.

Жим рүү орох үед "Секунд дэх импульсын тоо" гэсэн хуваарийн зүү нэмэх тав ба арвын хооронд байсан юм. Нэмэх арав гэсэн хуваарийн дараа нэмэх 500 хүртэл тун бага зай харагдах бөгөөд дараа нь нэмэх 1000 байв. Хувиарийн төгсгөлийн заалтуудыг улаанаар буджээ. Зүү улаанаас тун хол байгаа хэдий ч одоогийн үзүүлэлтүүд ерөнхий дэвсгэр биш гэдэгт Жо огт эргэлзсэнгүй.

Жо Норри руу харах үед Бенни чичирхийлэх зүүг ширтэнэ.

-Ингэхэд чи юу бодсон юм бэ? Айгаад байлгүй дэлгэн хэл. Чиний санаа лав л тэнэг санаа биш гэж тэр асуув.

-Яавч тэнэг санаа биш гэж Бенни зөвшөөрлөө. Тэр "Секунд дэх импульсын тоо" гэсэн хуваарийн шилийг хуруугаар тогшино. Зүү огцом үсэрсэнээ нэмэх долоо ба наймын хооронд ирэв.

-Үүсгүүр ба дамжуулагч хоёр зарчмын хувьд адил гэж би бодсон юм. Дамжуулагчийг заавал гол хэсэгт тавьдаггүй. Түүнийг өндөрт суулгахад хангалттай гэж Норри хэлэв.

-ХБЭ-ийн дамжуулагч уулан дээр байдаггүй юм. Нугад байрлах ба есүсийн алдарыг магтдаг. Би харсан гэж Бенни санууллаа.

-Тийм л дээ. Гэхдээ тэр чинь маш хүчтэй дамжуулагч. 1100 ватт гэж аав надад хэлсэн. Бидний хайж байгаа зүйл дохиогоо богино зайд дамжуулдаг байж болно. Тэгээд л би хотын хамгийн өндөр цэг хаана байдаг билээ гэж бодсон.

-Блэк-Ридж гэж Жо хариулав.

-Блэк-Ридж гэж Норри давтаад бяцхан нударгаа өргөлөө. Жо түүнтэй нударгаа мөргөлдүүлээд дараа нь гараа сунган заав.

-Тийшээ очиход хоёр юмуу гурван милл зайтай. Ингэж хэлэнгүүтээ Жо тоолуурын хоолойг заасан зүг рүү чиглүүлэхэд тоо нэмэх арав дээр очихыг харлаа.

-Намайг эзэмдээсэй билээ гэж Бенни дуу алдав.

-Эзэмдэх л байх. 40 орчим насанд гэж Норри ёжлон инээлээ. Тэр үргэлж байдаг шигээ дайчин харагдах боловч улайгаад ирэв. Гэхдээ жаахан.

-Блэк-Ридж-Роудад алимны хуучин цэцэрлэг бий. Тэндээс Милл тэр чигээрээ харагдана. Ти-Эр-90 бас харагддаг. Ямартаа ч аав тэгж ярьдаг байсан. Бидний хайж байгаа юм тэнд ч байж мэднэ. Норри чи суут ухаантан гэж Жо хэлэв.

Охин түүнийг үнсэхийг хүлээх хэрэг ч гарсангүй. Мань хүн ч боломжийг ашиглан охиныг үнсэв. Гэхдээ уруулыг нь биш амных нь булан дээр үнслээ.

Норри сэтгэл ханамжтай харагдана. Гэвч цохон дээр нь тээнэгэлзэлийн босоо үрчлээ үлдэв.

-Гэхдээ энэ бүхэн юу ч биш байж ч болно. Ямар зүү улаан шугам дээр очсон биш дээ. Ингэхэд бид тийшээ унадаг дугуйгаар очиж болох уу?

-Мэдээж гэж Жо дуу алдав.

Тэхдээ хоолны дараа гэж Бенни нэмж хэллээ. Тэр өөрийгөө нөгөө хоёроосоо хамгийн илүү амьдрах ухаантайд тооцно.

Жо Бенни Норри гурав Макклэтчигийн гэрт хооллож байх зуур (яг ногоотой жигнэсэн мах),

харин Расти Барби ба хоёр бүсгүйн тусламжтай хүнсний үймээнд хохирч эмнэлэгт хүргэгдэн ирсэн хүмүүстэй зууралдаж байх тэр үед Том Жим

Ренни өрөөндөө суугаад жагсаалтаа шагайж хийсэн ажлаа зурж байв.

Орцны зам руу орж ирэх "хаммер" машиныг хараад жагсаалтын бас нэг мөрийг дарж зурлаа. Яагаад гэвэл Бренда одоо бусад хүүрнүүдтэй хамт хэвтэж байгаа. Одоо Ренни бэлэн болсон гэж бодно. Ямартаа ч үүний төлөө чадах бүхнийг хийсэн. Бүрхүүл өнөөдөр алга боллоо ч гэсэн ар тал найдвартай хамгаалагдсан гэж Том Жим бодно.

Жижгээ орж ирээд "хаммер"-ийн түлхүүрийг эцгийнхээ ширээн дээр чулуудав. Хацар дээгүүр нь сахал нь ургаж, царай нь цонхийсон тэрбээр яг л үхэл шиг харагдана. Зүүн нүд нь улаан хэвээр байвч шатсангүй.

-Хүү минь бүгд бэлэн үү?

Жижгээ толгой дохилоо.

-Биднийг шоронд суулгах болов уу? Ингэж асуух үед Жижгээгийн хоолойд зөвхөн сониуч аяс тодорно.

Үгүй. Түүнийг шоронд хийж болох тухай санаа Бренда Перкинс шулам энд хүрч ирээд ял тулгаж эхлэх үед ч Том Жимийн толгойд ч төрөөгүй билээ. Тэр инээмсэглэв.

-Гэхдээ Дейл Барбараг бол шоронд хийнэ.

-Түүнийг Бренда Перкинсийг алсан гэхэд хэн ч итгэхгүй

дээ.

Том Жим инээсээр байв.

-Итгэнэ ээ, хүмүүс их айсан болохоор итгэнэ. Амьдрал ийм л байдаг юм.

-Чи яаж мэдэж байгаа юм бэ?

-Яагаад гэвэл би түүх судалдаг. Чи ч бас судлахад илүүдэхгүй дээ.

Ингэхэд хүү нь яагаад Боудиныг орхисон тухай асуулт хэлнийх нь үзүүр дээр гарч ирэв. (Энэ нь Мэн муж улсын Брансуик хотын дээд шатны хувийн коллеж.) Хүүг нь хөөсөн юмуу, өөрөө хаясан юмуу эсвэл сургуулиас гарахыг хүссэн юмуу? Тэгснээ яг одоо бол ийм юм ярих газар биш гэж шийдлээ. Түүний оронд Жижгээ ахиад нэг даалгавар гүйцэтгэж чадах эсэхийг асуув.

Цаадах нь чамархайгаа үрнэ.

-Чадах байх аа.

-Чамд туслалцаа хэрэг болно. Чи Фрэнкийг дагуулж болох юм. Гэхдээ би Картер нь дээр гэж бодож байна. Өнөөдөр болсон явдлын дараа тэр хөдөлж чадаж байвал шүү дээ. Харин

Мэлийг бол дагуулж болохгүй шүү. Сайн залуу. Гэхдээ тэнэг.

Жижгээ ам нээсэнгүй. Том Жим дахиад л дотор бодолдоо автав. Гэвч түүний хүү яагаад нэг л биш байна вэ? Гэхдээ тэр өөрөө үүнийг мэдэхийг үнэхээр хүснэ гэж үү? Амралт төгссөн хойно магадгүй л юм. Харин одоохондоо цахилгаан зуухан дээр дэндүү олон тогоо шанага овоорчээ. Гэтэл үдийн хоол хүртэл юу ч байдаггүй.

-Би юу хийх хэрэгтэй юм бэ? гэж Жижгээ ямар ч гэсэн асуув.

-Эхлээд би зарим нэг юм тодруулах хэрэгтэй байна гээд Том Жим гар утсаа авлаа. Тэр гар утсаар ярих үедээ гар утаснаас гарах ашиг тус нь ямаанаас сүү саахтай адил гэж боддог. Гэвч гар утас ажиллаж байв. Ямартаа ч хот дотор ярьж болоод байх бөгөөд түүнд өөр юу ч хэрэггүй. Тэр цагдаагийн газар руу утасджээ. Гурван удаа дуудсаны дараа Стейси Моггиний ердийн ажил хэрэгч дуу биш харин амьсгаадах дууг сонслоо. Өглөөний бантанг тооцох юм бол Том Жим үүнд гайхсангүй. Харин одоо тэр хэн нэгний орилохыг сонсов.

-Цагдаагийн газар байна. Хэрэв танд ямар нэг онцгой асуудал байхгүй бол утсаа тавиад дараа залгана уу? Бид одоо маш их ачаа...

-Хонгор минь, би Жим Ренни байна. Намайг даргатайгаа холбо. Түргэл гэв. Стейси хэн нэгэн түүнд хонгор минь гэж хандах үед тэвчиж чаддаггүйг тэр мэддэг учир албаар ингэжээ.

-Дарга жижүүрийн ширээний урд болж байгаа зодооныг салгах гэж оролдож байна. Та хожуу залгавал ямар вэ?

-Үгүй би хожуу залгаж чадахгүй. Намайг ямар нэг дэмий асуудлаар залгана гэж бодоод байна уу? Өөрөө тийшээ очоод хамгийн их дайраад байгаа руу нь "Мейсом" цац хонгор минь. Дараа нь Питийг өрөөндөө оч гээрэй.

Бүсгүй түүний яриаг гүйцэд сонссонгүй. Бас хожуу залгахыг ч хүссэнгүй. Утас нь ширээн дээр тасхийн уналаа. Том Жим сэтгэл ханамжтай толгой дохив. Хэрэв хэн нэгнийг эвгүй байдалд орууллаа гэхэд тэр тухайгаа мэдэх нь түүнд таалагддаг. Холоос бөглүү дуу сонсогдоно. Хэн нэгэн нөгөөгөө хулгайч гэж зүхнэ. Том Жим инээд алдав.

Хормын дараа түүнийг өөр утастай холбож өгчээ. Стейси ингэсэн тухайгаа мэдээлэхийг хүссэн ч үгүй. Хэсэг хугацаанд хэн нэгний хараал зүхлийг сонсов. Дараа нь хэн нэгэн утсыг авлаа. Энэ бол амьсгаадсан Рэндолф байв.

-Жим хурдхан яриарай. Манай энд яг л галзуугийн эмнэлэг. Хавирга нь хугарч эмнэлэгт очоогүй юмуу ер нь ямар нэг шарх аваагүй нэг нь яг л чөтгөр шиг догшин байна. Бүгд л бусдыгаа буруутгах юм. Би тэр доор байдаг хорих өрөөг дүүргэмээргүй байна. Гэвч энд байгаа хүмүүсийн тэн хагас нь тийшээ ормоор байх шиг байна.

-Цагдаагийн тоог нэмэгдүүлэх санаа өнөөдөр үнэхээр сэтгэлд нийцтэй байгаа биз дарга аа?

-Яг тийм. Бурхан минь. Бид өнөөдөр ёстой хэцүүдсэн. Манай нэг цагдаа Ру эмнэлэгт байгаа. Нүүрний доод хэсэг нь хэмхэрсэн. Яг л Франкенштейний сүйт бүсгүй шиг харагдаж байсан шүү.

Том Жимийн царай тэр чигээрээ инээмсэглэлд автав. Сэм Вердро түүний даалгаврыг хөсөрдүүлсэнгүй. Мэдээж энэ бол зургаа дахь мэдрэхүйн нэг онцлог юм. Хэрэв чи өөрөө хийж болохгүй тэр цөөхөн тохиолдолд хэн нэгэнд хандаж гуйх хэрэг гарлаа гэхэд яг хэрэгтэй хүндээ хандаж үргэлж чаддаг.

-Хэн нэгэн түүн рүү чулуу шидсэн. Мэл рүү бас. Мэл хэсэг хугацаанд тасарч босоод одоо хэвийн байх шиг байна. Гэхдээ дух нь тэр чигээрээ шархтай. Би түүнийг боолт хийлгэхээр эмнэлэг рүү явуулчихлаа.

-Энэ байж болшгүй явдал.

-Хэн нэгэн миний цагдаа нар руу онилж байна. Ганц хүн ч биш байх. Ингэхэд бид туслагчууд нэмж болох уу? Том Жим ээ?

-Энэ хотын шударга залуусын дундаас олныг олж болно гэж би бодох юм. Би ч бас Ариун гэм цайруулагчийн сүмийн сүсэгтнүүдээс хэд хэдийг санал болгож чадна. Жишээ нь ах дүү Кильян байна.

-Жим ээ, тэр Кильянууд чинь түлээнээс тэнэг хүмүүс.

-Мэдэж байна. Гэхдээ тэд бөх бат биетэй, бас гүйцэтгэл сайтай залуус. Бас буудаж чадна.

-Бид шинэ цагдаа нарыг зэвсэглэх гэж байгаа хэрэг үү? гэх Рэндолфын дуунд эргэлзээ ба найдвар зэрэг сонсдов.

-Өнөөдөр болсон явдлын дараа юу? Мэдээж шүү дээ. Миний бодлоор эхлээд 10 юмуу 12 хүнийг татаж оруулах хэрэгтэй байна. Шинэ хүний сонголт дээр Френк Жижгээ хоёр чамд туслана. Хэрэв дараа долоо хоног гэхэд бүх юм хэвэндээ орохгүй юм бол өшөө ч хүмүүс хэрэг болно. Тэдэнд цалин өгөх тухай баталгаа гаргаарай. Тэгээд хэрэв хувиарлалт эхлэх юм бол хамгийн эхний ээлжинд тэднийг бараагаар хангаарай. Өөрсдийг нь, бас гэр бүлийг нь.

-За ойлголоо. Жижгээг нааш нь явуул. Френк энд байгаа. Картер ч бас. Их дэлгүүрийн дэргэд тэр овоо юм амссан шүү. Мөрнийх нь боолтыг солиод одоо хэвэндээ орсон. Боолтыг Барбара хийж өгсөн гэж тэр хэлсэн. Тун муугүй боосон гэнэ билээ гэж Рэндолф дуугаа намсган хэллээ.

-Энэ сайн хэрэг. Гэвч манай ноён Барбарад боолт сольж явах хугацаа нэг их үлдээгүй л болов уу? Жижгээд даалгах өөр ажил надад байна. Цагдаа Картерт ч бас даалгах ажил бий. Тэгэхээр түүнийг нааш нь явуулчих.

-Яах гэж?

-Хэрэв чамайг мэдэх шаардлагатай гэж бодсон бол би аль хэдийн чамд хэлэх л байсан. Зүгээр л нааш нь явуул. Жижгээ Френк хоёр шинэ цагдаа нарын нэрсийн жагсаалтыг дараа гаргана биз.

-За за... Нэгэнт чи тэгж хэлж байгаа бол... Энэ үед ямар нэг юм ямар нирхийх дуу Рэндолфын яриаг таслав. Хэн нэгэн унасан юмуу эсвэл хэн нэгнийг унагаасан бололтой. Дахиад л нирхийв. Энэ удаад ямар нэг юм хагарчээ.

-Больцгоо гэж Рэндолф бахирна. Том Жим малийтал инээмсэглэн гар утсаа чихнээс холдууллаа. Ийм зайнаас ч бүх юм сонсогдоно.

-Наад хоёроо бариад ав. Тэнэг ээ, энэ биш ээ, тэр хоёрыг... Үгүй ээ, тэднийг баривчлах хэрэггүй. Зүгээр л эндээс гаргаж чулууд. Хэрэв тэд өөрсдөө гарахыг хүсэхгүй байгаа бол амбаардаад гарга.

Хэсэг хугацааны дараа Рэндолф дахиад Том Жимтэй ярив.

-Би яагаад энэ ажлыг авахыг хүссэнийг сануулаад өг. Эс тэгвэл би мартаж эхлээд байна.

-Бүх юм хэвийн болно доо. Тун удахгүй бат чийрэг биетэй таван залуу шинэхэн цагдаа чам дээр очно. Дараа нь дахиад таван цагдаа очно. Доод тал нь тав. Харин одоо Картерыг нааш нь явуул. Бас хамгийн цаад булангийн хорих өрөөг шинэ зочин хүлээн авахад бэлд. Ноён Барбара өнөөдөртөө багтан тэнд морилох болно гэж Ренни хэллээ.

-Ямар ялаар?

-Дөрвөн хүн амины хэрэг ба их дэлгүүрийн дэргэдэх үймээн зохион байгуулсан хэргийн талаар чи юу хэлэх вэ? Ийм байвал болох уу?

Рэндолфыг хариулж амжаагүй байхад тэр утсаа таслав.

-Чи Картер бид хоёроор юу хийлгэх гээд байгаа юм бэ? гэж Жижгээ асуулаа.

-Өдрийн цагаар уу? Нэгдүгээрт тагнуулдах ба төлөвлөх ажил хийнэ. Төлөвлөх тал дээр би чамд туслана. Дараа нь чи Барбараг баривчлах ажиллагаанд оролцоно. Энэ чамд таашаал авчирна гэж бодож байна.

-Гарцаагүй таашаал авчирна.

-Барбараг шоронд хийсний дараа цагдаа Картер та хоёр сайтар хооллох хэрэгтэй. Яагаад гэвэл жинхэнэ ажил нь бүх шөнийн турш үргэлжилнэ.

-Ямар ажил?

-"Ардчилал"-ын редакцийг шатаана. Энэ чамд ямар санагдаж байна даа?

Жижгээгийн нүд томроод ирэв. -Яах гэж?

Хүүгийнх нь асуулт түүний урмыг хугалав.

-Яагаад гэвэл ойрын хугацаанд хотод сонин хэрэггүй. Эсэргүүцэж байгаа зүйл байна уу?

-Аав аа та өөрийгөө хэзээ нэгэн цагт гажигтай гэж бодож үзсэн үү?

-Буруу тодорхойлолт байна.

7

-Би энэ өрөөнд хичнээн удаа орж гарсан билээ дээ. Гэтэл өөрөө энэ ширээн дээр хэвтэх юм гэж хэзээ ч бодож байсангүй гэж Жинни Томлинсон өөртөө ч танигдахгүй хачин дуугаар ярив.

-Хэрэв тэгж төсөөлсөн байлаа ч гэсэн өглөө чамд жигнэсэн мах, шарсан өндөг бэлдэж өгсөн залуу чамд мэс засал хийх юм гэж лав бодохгүй байсан даа.

Барби ийнхүү наргихыг хичээнэ. Гэвч тэр түргэний тэрэгний анхны давхилтаар "Кэтрин Рассел" эмнэлэгт ирснээс хойш оёос хийж, боолт тавьж байгаа учраас одоо маш их ядарчээ. Ядрах гол шалтгаан нь стресс гэж тэр сэжиглэнэ. Хэн нэгэнд туслахын оронд хор хүргэх вий гэж Барби үхтэлээ айж байв. Бас Гарриет ба Жина нарын царайд ч ийм түгшүүрийг олж харна. Гэхдээ Барбигаас ялгаатай нь тэдний чихэн дээр Жим Реннигийн хугацаа тавьсан цаг цохилохгүй байсан бөгөөд энэ нь Барбигийн байдлыг улам дордуулна.

-Би дахиад жигнэсэн мах идэж чадахаар болох хүртэл багагүй хугацаа өнгөрнө гэж бодогдоод байна хэмээн Жинни санаа алдав.

Расти бусад өвчтөнүүдтэй ноцолдохоосоо өмнө түүний хамрыг тэгшилж өгчээ. Барби түүнд тусалж байлаа. Тэр бүсгүйн толгойг аль болох зөөлнөөр хөдөлгөөнгүй барьж өгөнгөө сэтгэл заслын үг бувтнана. Расти эхлээд анагаахын кокаинтай уусмал шингээсэн хөвөн бөглөөсийг түүний хамарт чихэв. Мэдээ алдуулахын тулд 10 минут хүлээлээ. Энэ хооронд тэр өөр нэг бүдүүн эмэгтэйн хавдсан хөлөнд уян боолт тавьж, бас няцарсан бугуйг нь эмчлэв. Дараа нь бөглөөсөө сугалж аваад мэс заслын хутга барьлаа. Бага эмч маань бахдам хурдан хөдөлж байлаа. Барби Жиннид дүлээрэй гэж хэлж амжихаас өмнө Расти мэс заслын хутганы бариулыг хамрын нэг нүх рүү шургуулаад хоёр хамрыг тусгаарлах хана руу наангуугаа хөшүүрэг болгон хэрэглэв.

Чихэнд мөгөөрс хирдхийх сулхан дуу сонсогдохын зэрэгцээ Жиннигийн хамар урьдын байсан хэлбэртээ (эсвэл түүнтэй төстэй) орохыг харангаа Барби "Яг машины дугуйны хавхагтай ноцолдож байгаа хүн шиг" гэж бодож амжлаа. Бүсгүй хашгирсангүй. Гэвч ширээ хучсан даавуун бүтээлгийг хумс нь тас татаж нүднээс нь нулимс урсав.

Харин одоо Жинни тайвширчээ. Расти түүнд өвчин намдаах хоёр эм өгөв. Гэхдээ арай бага хавдсан нүднээс нь нулимс урссаар байлаа. Яргуйн өнгөтэй болсон хацар нь мөн хавджээ. Энэ эмэгтэй Аполло Кридтэй тулалдсаны дараах Рокки Бальбоатай адилхан болчихсон байна гэж Барби бодов.

-Амьдралын гэгээтэй талыг нь хар гэж тэр Жиннид хэллээ.

-Тийм тал байдаг юм уу?

-Мэдээж шүү дээ. Жишээ нь Ру бүтэн сар сүү ба шөлнөөс өөр юм идэж ууж чадахгүй болчихлоо.

-Жоржия юу? Түүнийг чулуунд оногдсон гэж сонссон. Их хүчтэй юу?

-Тэр үхчихгүй л дээ. Гэхдээ сайхан бүсгүй болох хүртэл их хугацаа өнгөрнө.

-Жоржия "Алимны өнгөт Мисс" цолонд хэзээ ч өрсөлдөж чадахгүй л дээ. Гэхдээ сая хашгирсан хүн тэр үү? гэж Жинни дуугаа намсган асуув.

Барби толгой дохилоо. Ру-гийн орилж чарлах дуу эмнэлгээр нэг хадна.

-Расти түүнд морфин өгсөн. Гэвч тэр тайвшрах хүртлээ удсан шүү. Тэр яг л морь шиг эрүүл чийрэг биетэй байх.

-Харин ухамсар нь яг матрынх. Хэн нэгэн хүнтэй ийм юм тохиолдоосой гэж би хүсэхгүй. Гэвч энэ тохиолдолд бол бурхны цээрлэл гарцаагүй гэдгийг харуулсан тун сайн нотолгоо гэж би бодоод байна. Ингэхэд би энд ирээд удаж байна уу? Миний цаг эвдэрчихжээ гэж Жинни урьдын адил тод биш дуугаар ярина.

Барби цагаа харлаа.

-Одоо хоёр хагас болж байна. Өөрөөр хэлбэл та эдгэрэх замд гараад таван цаг хагас болчихжээ.

Барби биеэ эргүүлж хөдөлгөхөд бэлхүүс хавиар нь нужигнах дуу дуулдсан ба ууц нуруу нь бага зэрэг сулав. "Том Петтигийн түмэн зөв юм байна, хүлээх гэдэг хамгийн хэцүү зүйл юм" гэж тэр бодлоо. Шоронд орсон хойно бүх юм арай хялбар болох мэт санагдана. Гэхдээ хэрэв түүнийг алчихгүй бол шүү дээ. Баривчлах үед эсэргүүцэл үзүүлсэн шалтгаанаар түүнийг алах нь хамгийн сайн гарц гэж хэн нэгэн бодож болох тухай санаа түүнд төрнө.

-Чи юундаа инээгээд байгаа юм бэ? гэж Жинни асуулаа.

-Онц юм биш ээ. Харин одоо тайван хэвт. Надад битгий саад болоорой. Эрт эхэлбэл эрт дуусна гэж хэлээд тэр чимхүүр авлаа.

-Би босч ажилдаа орох ёстой.

-Хэрэв чи бослоо гэхэд ганцхан үр дүнд хүрнэ. Шалан дээр л тэрийх байх.

Бүсгүй чимхүүр рүү харав.

-Түүнийг яаж ашиглахыг чи мэддэг юм уу?

-Эргэлзэх хэрэггүй. Шилний хэлтэрхий түүх олимпийн тэмцээнд алтан медаль авсан хүн шүү.

-Худлаа буудах тал дээр чи миний хуучин нөхрөөс ч илүү гарах юм байна гэж Жинни сулхан инээмсэглэв. Хэдийгээр бүсгүй өвчин намдаах эм уусан хэдий ч инээмсэглэх нь түүнд асар их өвдөлт авчирч байгааг Барби тааж байлаа. Энэ эмэгтэйн хагуу чанга зан араншин түүнд таалагдав.

-Чи өөрсдөө эмчлүүлэх болохоор мангас болон хувирдаг тэр ядаргаатай эмч нараас ондоо юм байна тийм үү?

-Хаскель эмч яг тийм хүн байсан даа. Нэг удаа тэр хумсандаа өргөс оруулчихсан. Расти сугалаад өгье гэхэд мэргэжилтэн хэрэгтэй гэж хариулж байж билээ гээд бүсгүй инээснээ ярвайж ёолов.

-Чиний сэтгэл амрах эсэхийг мэдэхгүй байна. Гэхдээ чамайг цохисон цагдаа толгойдоо чулуугаар цохиулсан.

-Бас л бурхны цээрлэл. Гэхдээ тэр ухаан орсон биз дээ?

-Тийм ээ.

Мэл толгойдоо боолт хийлгээд хоёр цагийн өмнө эмнэлгийг орхисон.

Барби чимхүүр барин тонгойход бүсгүй совингоороо толгойгоо цааш эргүүлэв. Барби гараар болгоомжтой даран толгойг нааш эргүүлээд арай бага хавдсан хацрыг нь дэрлүүллээ.

-Чи үүнийг хийх ёстой гэдгийг би мэдэж байна. Зүгээр л нүднээсээ болоод их айж байна гэж бүсгүй хэлэв.

-Чамайг ямар хүчтэй цохисоныг тооцох юм бол чи азтай байна шүү. Яагаад гэвэл үйрмэгүүд нүдний эргэн тойронд байхаас биш нүдэнд ороогүй.

-Мэдэж байна. Гэхдээ намайг битгий өвтгөөрэй, за юу?

-Мэдээж шүү дээ. Жинни чи удахгүй хөл дээрээ босно. Би маш түргэн амжуулна.

Тэр гараа хуурай эсэхийг шалган сайтар арчаад тонгойв. Хөдөлгөөн оновчгүй болохоос айсандаа бээлий өмссөнгүй. Хагарсан линзний хэдэн арван жижиг үйрмэгүүд хөмсөг болоод нүдний эргэн тойронд зоогджээ. Гэхдээ зүүн нүдний булангийн доохон талд байгаа нэг үйрмэг Барбигийн сэтгэлийг ихэд түгшээнэ. Хэрэв Расти анзаарсан бол түүнийг өөрөө суга татах байсан. Гэвч хамаг анхаарлаа Жиннигийн хамарт хандуулсан тул анзаараагүй гэдэгт Барби үл эргэлзэнэ.

Аль болох хурдан хийх хэрэгтэй. Эргэлзэж байгаа хүн бүтэлгүйтдэг гэж Барби дотроо хэлэв.

Тэр чимхүүрийн үзүүрээр шилний үйрмэгийг хавчиж татаад ширээн дээр тавьсан гялгар уут

руу хаялаа. Шархнаас бичил цусан дусал гарч ирэхийг хараад Барби санаа алдав.

-Пөөх. Бусад нь юу ч биш. Ямар ч асуудал байхгүй.

-Чиний амнаас гарсан бүхэн бурхны чихэнд сонсогдож байгаа.

Барби сүүлчийн хэлтэрхийг дөнгөж сугалж амжаад байтал Расти үзлэгийн өрөөний хаалгыг нээн орж ирээд Барби түүнд тусалж чадах эсэхийг асуув. Бага эмч гартаа "Сукритс"-ын лааз барьжээ.

-Юунд туслах гэж?

-Яг хүн шиг явдаг шамбарамтай тэмцэхэд туслах хэрэгтэй байна. Энэ арын сүвний шарх хулгайлсан бараатайгаа явах гээд байна. Ердийн тохиолдолд байсансан бол энэ новшийн бөгс хаалгаар гарахыг хараад би үнэхээр баярлах байсан. Харин энэ тохиолдолд бол ашиг авчирахгүй л дээ.

-Жинни чи зүгээр үү? гэж Барби асуулаа.

Бүсгүй хаалганы зүг гараа савав. Барби Растиг даган алхахад Жинни түүнийг дуудлаа.

-Хүүе сайхан залуу минь.

Барбиг эргэж харахад бүсгүй түүнд агаараар үнсэлт илгээв. Барби түүнийг нь барьж авлаа.

8

Честерс-Милл хотод ганцхан шүдний эмч байдаг нь Жо Боксер юм. Түүний эмнэлэг Страут-лейний төгсгөлд байх бөгөөд өрөөнийх нь цонхоор Престил-Стрим гол ба Энхтайваны гүүр маш сайхнаар харагддаг. Гэхдээ суугаад харах юм бол харагдана. Гэтэл зочдын ихэнхи нь хэвтээ байдалд байдаг учраас таазаар нэг өлгөсөн боксер нэртэй чихуахуа үүлдрийн нохойны хэдэн арван гэрэл зургийг л харах болдог.

"Нэг зураг дээр нь тэр чөттөрийн нохой яг баах гэж байгаа юм шиг гарсан байдаг. Энэ үүлдрийн нохой угаасаа тэгж суудаг юмуу бүү мэд. Гэхдээ би эргэлзэж байна. Би л лав хэрэгцээгээ хангаж байгаа тэр муу том нүдтэй самбайг харж хагас цаг хэвтсэн юмдаг. Тэгэхэд Бокс миний хоёр ч агт арааг сугалсан даа. Цүүцээр аваад байгаа юм шиг тэгж мэдрэгдсэн" гэж Дуги Твитчел нэг удаа тэр эмнэлэг рүү явж ирээд Растид ярьж байсан удаатай.

Боксерийн эмнэлгийн орох хаалганы дээр өлгөсөн танилцуулга нь үлгэрт гардаг аварга биет хүнээс тайлж авсан сагсан бөмбөгийн богино өмд шиг л харагдана.

"Зэрлэг муурнууд"-ын өнгө болох шаргал ногоон өнгөтэй бөгөөд дээд талаар нь "ЖОЗЕФ БОКСЕР ШҮДНИЙ ЭМЧ" гэсэн бичиг хөвөрнө. Доод талд нь "ТҮРГЭН БОКСЕР" гэж бичжээ. Энэ тал дээр хүмүүс түүнтэй санал нийлдэг. Тэр үнэхээр хурдан ажилладаг. Гэхдээ ямар ч даатгалыг үл тоомсорлох бөгөөд төлбөрийг бэлнээр авна. Хэрэв түүн дээр шүд нь

янгинаж, тагнай нь шатаж, хацар нь самар чихсэн хэрэм шиг болсон хэн нэгэн ирсэн байлаа ч даатгалын тухай ярих л юм бол Боксёр түүнд "Антем" юмуу "Цэнхэр загалмай" руу очих эсвэл хаа нэгтээгээс мөнгө олсныхоо дараа эргэж ир л гэж хэлнэ.

Хэрэв энд бага зэрэг өрсөлдөөн байсан бол энэ мангасын гэмээр хатуу бодлого зөөлрөх л байсан. Гэвч 90-өөд оноос хойш Честерс-Миллд ажиллах гэж оролдсон хэд хэдэн эмч зорилгоосоо няцжээ. Боксёрын сайн найз Жим Ренни өрсөлдөгчдөө зайлуулахад нь түүнд тусалдаг гэсэн цуурхал явдаг ч хэн ч баталж чадаагүй. Одоохондоо Боксёр өдөр бүр хотоор "порше" машинаа унан давхих ба арын бампер дээр нь "миний хоёр дахь машин бас л порше" гэсэн наалт тодорно.

Расти Барбигийн хамт хонгилд гарч ирэхэд Боксёр гарах хаалгыг чиглэж явж байв. Эсвэл чиглэх гэж оролдож байсан. Учир нь Дуги хаалганы өмнөх зайнд түүний гарнаас зуурчээ. Боксёр нөгөө гартаа "Эгго" өрмөнцөр дүүргэсэн сагс барьжээ. Зөвхөн олон тооны боодолтой өрмөнцөрөөс өөр юу ч үгүй. Энэ үед Барбигийн толгойд урьд нь нэг бус удаа төрсөн бодол дахин харвалаа. Ингэхэд би "Дипперс" авто зогсоолын цаагуур өнгөрдөг сувагт ухаан алдатлаа зодуулаад хэвтэж байгаа юм биш биз. Тэгээд энэ харж байгаа бүхэн бодит бус бөгөөд гэмтсэн тархины солиорол байж мэдэх юм.

-Би энд яасан ч үлдэхгүй. Би энэ бүхнийг гэртээ аваачиж хөргөгчиндөө хийх ёстой. Та нарын ярьж байгаа бүтэхгүй. Тийм учир надаас холд гэж Боксёр хашгирна. Боксёрын баруун гарын тохойны дээгүүрх боолт ба хөмсөг дээрх шархны туузан наалтыг Барби анзаарав. Шүдний эмч маань хөлдөөсөн өрмөнцөрийг ширүүн тулалдааны дүнд олж авсан бололтой.

-Энэ аварга биетэндээ намайг тавьж явуул гэж хэл. Надад нэгэнт тусламж үзүүлчихсэн болохоор би гэртээ харимаар байна гэж тэр Растиг харангуугаа хэллээ.

-Одоохондоо үгүй шүү. Танд тусламж үзүүлсэн болохоор та төлбөрөө хийхийг би хүлээж байна.

Өндөр биш нуруутай Боксёр таван фут дөрвөн дюйм нуруугаа байдгаараа эгцлээд мөрөө сэгсэрч цээжээ түрэв.

-Хүлээж л байхгүй юу. Хараал ид. Миний бодлоор эрүү нүүрний мэс засал бол хоёр ширхэг тууз наасантай харьцуулах аргагүй ар&д. рго цию юм. (францаар төлөөс гэсэн үг). Дашрамд хэлэхэд Мэн муж улсаас ийм мэс засал хийх зөвшөөрөл надад олгоогүй. Расти минь би амьдрахын тулд ажилладаг хүн. Тэгээд миний ажлын төлөө бас төлбөр байх ёстой гэдэг үүднээс ханддаг.

-Танд тэнгэрт очихоор чинь бүрэн төлбөр хийх болно. Танай найз Ренни ингэж хэлдэг биш бил үү? гэж Барби ярианд оролцлоо.

-Гэхдээ тэр ямар ч хамаагүй...

Энэ үед Барби Боксёрын гартаа чанга атгасан худалдан авагчийн ногоон өнгөтэй сагс руу шагайхаар ойртов. Сагсны бариул дээр "Хүнсний ертөнцийн өмч" гэсэн бичээс тод

харагдана. Боксёр тэр дороо сагсаа хаацайлах гэж оролдсон ч онц амжилт олсонгүй.

-Нэгэнт төлбөрийн тухай яриа болсон хойно би танаас асууя. Ингэхэд та энэ өрмөнцөрийн төлбөрөө хийсэн юм уу?

-Та юу ярина вэ? Бүгд л бүхнийг шүүрч байсан. Гэтэл би ганцхан үүнийг авсан. Манай гэрт маш том хөргөгч бий. Би өрмөнцөрт нугасгүй гэж хэлээд мань хүн Барби руу дайсагнан ширтэв.

-Бүгд бүхнийг шүүрч байсан гэдэг чинь дээрэм хийсэн хүний хувьд тийм ч жинтэй зөвтгөх шалтгаан биш юм байна даа гэж Барби зөөлөн хэллээ.

Уг нь Боксёр одоо байгаагаасаа илүү сунаж чадахааргүй харагдсан ч ямар нэг байдлаар бүр эгцрээд ирэв. Түүний нүүр улаан биш, бүр хүрэн улаан болж ирлээ.

-Тэгээд чи намайг тэр шүүх рүүгээ аваад очооч. Тэр шүүх чинь хаана байгаа юм бэ? Хэрэг хаагдсан. Ха-ха-ха гээд тэр хаалга руу эргэв.

Барби гараа сунган сагснаас зуурлаа.

-Тэгвэл би энэ өрмөнцөрийг зүгээр л хурааж авна.

-Та ингэж болохгүй шүү дээ.

-Үгүй гэж үү? Тэгээд намайг шүүх рүүгээ аваачаач дээ. Өө нээрээ би мартчихаж. Тэр шүүх чинь хаана байгаа юм бэ? гээд Барби инээмсэглэв.

Боксёр эмч заналтай харцаар түүнийг өрөмдлөө. Ам нь шазайхад гайхалтай тэгшхэн боловч жижигхэн шүднүүд нь ярайна.

-Бид цайны газарт ийм өрмөнцөр хийдэг. Амттай шүү гэж Расти Барбиг дэмжив.

-Тийм ээ. Одоохондоо өрмөнцөр шарах цахилгаан байж байна. Эсвэл өрмөнцөрийг сэрээнд өлгөж байгаад хог шатаах зуухан дээр шарж болох юм гэж Дуги бувгналаа.

-Та нар ингэж болохгүй.

-Алив бүхнийг тодорхой болгоё. Хэрэв та Растигийн хүсээд байгаа зүйлийг хийхгүй юм бол би таныг эндээс өрмөнцөр авч гарахыг зөвшөөрөхгүй гэж Барби зүтгэлээ.

Цохон дээрээ нэг, бас хүзүүн дээрээ нэг тууз наалгасан түүхийн багш Чээ Бендер инээд алдав. Гэхдээ дэмжсэн инээд биш байлаа.

-Төлбөрөө хийгээч дээ. Чи өөрөө дандаа л үүнийг нэхдэг биз дээ эмч ээ?

Боксёр эхлээд Бендер рүү, дараа нь Расти руу хорсолтой ширтлээ.

-Бүтнэ гэсэн найдлага бараг тэгтэй тэнцэнэ дээ. Та үүнийг ойлгох ёстой.

Расти барьж явсан лаазаа нээв. Дотор нь 6 ширхэг шүд байлаа.

-Тори Макдональд тэднийг их дэлгүүрийн орчмоос түүсэн юм. Жоржия Ругийн цусан дотроос олохын тулд тэр өвдөг сөхрөн мөлхсөн. Хэрэв та ойрын үед "Эгго" өрмөнцөр идмээр байвал эдгээр шүдийг эргүүлээд Жоржиягийн эрүүнд суулгах хэрэгтэй байна.

-Би зүгээр л яваад өгвөл та нар яах юм бэ?

Чэз Бендер нударга зангидан урагш нэг алхлаа.

-Хэрэв тэгэх юм бол худалдагддаг найз минь чамайг би машины зогсоол дээр цус гартал зодно доо.

-Би ч бас туслана гэж Дуги нэмж хэлэв.

-Би туслахгүй. Гэхдээ харах болно гэж Барби ч үг нэмлээ.

Энэ үед бүгд инээлдэж алга ташицгаав.

Барбид наргиантай санагдавч яагаад ч юм аюулхай нь татаж өвдөнө.

Боксёрын мөр унжаад ирэв. Тэр гэнэт л том асуудалтай учирсан жижигхэн хүн болон хувирлаа.

-Тун сайн нөхцөл байдалд л эрүү нүүрний мэс засалч эмч тэдгээр шүдийг буцааж суулгаж чадах байх. Магадгүй шүд тэндээ барьцалдаж мэднэ. Гэвч ямар ч эмч баталгаа өгч чадахгүй. Миний хувьд бол эдгээр шүднээс нэг юмуу хоёр нь барьцалдаж чадах юм бол хамгийн азтай хэрэг болно. Түүний оронд шүд улаан хоолой руу ороод тэр эмэгтэй хахаж үхэх магадлал нь хавьгүй илүү.

Энэ үед шатаж байгаа юм шиг улаан үстэй тарган эмэгтэй Бендерийг хажуу тийш нь түлхэж орхиод:

-Тийм юм болгохгүйн тулд би хажууд нь сууж байя. Би ээж нь байна гэв.

Боксёр эмч санаа алдлаа. -Бүсгүй ухаантай байгаа юу?

Түүнийг хариулт сонсож амжаагүй байтал цагдаагийн хоёр ч машин эмнэлэг дээр ирсний нэг нь даргын ногоон машин байв. Нэг машинаас нь Фредди, Жижгээ, Фрэнк ба Картер нар бууж ирлээ. Даргын ногоон тэрэгний урд хаалгаар Рэндолф дарга ба Жекки хоёр буусан бол арын хаалгаар нь Растигийн эхнэр гарч ирэв. Эмнэлгийн хаалганд дөхөж ирэнгүүт тэд бүгд буугаа гаргалаа.

Жо Боксёртой болсон сөргөлдөөнийг харж зогссон жижигхэн бөөгнөрөл шуугилдаад ухарлаа. Дээрмийн хэргээр баривчлах гэж байна гэж тэдний олонхи нь эргэлзээгүй бодсон байх.

Барби Расти руу эргэв. -Намайг хар. -Чи юу...

-Намайг сайн хар гээд Барби гараа өргөж хоёр талыг нь эргүүлж харуулав. Дараа нь цамцаа тайлж эхлээд хавтгай гэдсээ дараа нь нуруугаа харууллаа.

-Миний биен дээр ямар нэг хөхрөлт няцралт байна уу?

-Үгүй.

-Тэдэнд ч бас үүнийг мэдүүлэх хэрэгтэй шүү. Тэр өөр юм хийж амжсангүй. Рэндолф дайчдаа дагуулан хаалгаар орж ирэв.

-Дейл Барбара урагшаа нэг алх.

Рэндолф түүн рүү гар буугаа шагайхаас урьтан Барби бушуухан урагш алхлаа. Яагаад гэвэл ийм үед золгүй явдал тохиолдох нь олон байдаг. Заримдаа тохиолддын бус хэлбэрээр ч учирч болно.

Барби Растигийн гайхаж алмайрахыг олж хараад энэ гэнэн бага эмчид улам сэтгэл татагдав. Жинна ба Гарриет нар нүдээ бүлтийлгэн ширтэхийг бас харлаа. Гэхдээ Рэндолф дарга ба түүний цагдаа нарт анхаарал хандуулав. Тэд бүгд чулуун хөшөө шиг царайлах бөгөөд гагцхүү Картер ба Френк нарын нүдэнд таашаал илэрнэ. Тэдний хувьд энэ нь авто зогсоол дээр өнгөрсөн тэр нэг шөнийн төлбөрөөс цаашгүй. Харваас төлбөрийг ханатал хийх хэрэг гарах нь илт.

Расти Барбигийн өмнүүр орж хаан зогслоо.

-Ингэх хэрэггүй гэж Барби шивнэв. -Расти боль гэж Линда хашгирлаа.

-Рэндолф дарга аа, юу болсон юм бэ? Барби надад тусалж байна. Бүр гайхалтай сайн ажиллаж байна гэж Расти хэлэв.

Барби бахим чийрэг биетэй бага эмчийг холдуулахаас айна. Түүнд гар хүрэхээс ч айж байв. Тэр зөвхөн алгаа дэлгээд гараа маш аажуухан дээш өргөлөө.

Барби гараа өргөхийг хараад Жижгээ Фредди хоёр түүнийг чиглэв. Маш хурдан. Жижгээ Рэндолфын гарыг мөргөж орхисонд даргын гарт аттаастай байсан "беретта" маркийн гар буу буудаж орхилоо. Чих дөжрөм панхийв. Сум Рэндолфын баруун хөлнөөс гуравхан дюймын зайд модон шалыг нэвтрэхдээ гайхалтай том нүхэлжээ. Агаарт шатсан дарь хүхрийн үнэр ханхлав.

Жинна Гарриет хоёр муухай чарлаад гол хонгил руу харайлгасан ба энэ үед тэд шалаар мөлхөж явсан Жо Боксёр дээгүүр гишгэлэн гарав. Мань эмч толгойгоо мөрөндөө наахад үргэлж нямбай самнаж явдаг үс нь нүүрийг нь бүрхжээ. Эрүү нь мултарсан Брендэн Эллерби шүдний эмчийг хажуугаараа мөлхөх үед нь мөр рүү өшиглөв. Боксёрын гартаа барьж явсан лааз мулт үсэрч, хүлээн авахын ширээг цохиод таг нь задрав. Хөөрхий Торигийн асар чармайлт гарган цуглуулсан шүднүүд тал тал тийш цацагдлаа.

Жижгээ Фредди хоёр Растиг барьж авахад тэр эсэргүүцэл үзүүлсэнгүй. Царайд нь мэл гайхсан төрх илэрнэ. Цагдаа нар бага эмчийг хажуу тийш түлхэж орхилоо. Бага эмчийн хөл солбиход Линда тулах гэж оролдсон ч тэд хамтдаа шалан дээр тэрийн хадав.

-Юу гээч чөтгөр болоод байна вэ? гэж Дуги бахирав.

Картер бага зэрэг хазганан Барби руу чиглэхэд өнөөх нь түүнийг юу хүлээж байгааг мэдэх боловч гараа буулгасангүй. Яагаад гэвэл гараа буулгах л юм бол түүнийг алж мэдэхээр байлаа. Ганцхан түүнийг ч биш. Буун дуу нэгэнт хадсан болохоор бусад буу ч хадааж эхлэхэд гайхах зүйлгүй.

-За сайн уу? Найз минь. Чи цагийг зүгээр өнгөрөөдөггүй хүн байж дээ гэж хэлээд Барбиг элэгдлээ.

Уг нь Барби цохилт ирэхийг угтан гэдэсний булчингаа чангалсан ч эвхэрч унав. Картер хангалттай хүчтэй ажээ.

-Больцгоо гэж Расти хашгирна. Түүний царайд гайхал тодорсон хэвээр боловч одоо хорсол занал нэмэгджээ.

-Одоохон больцгоо. Чөтгөр авмар.

Тэр босох гэж оролдсон ч Линда түүнийг хоёр гараар зуурчихаад тавьсангүй.

-Үгүй. Хэрэггүй. Тэр маш аюултай хүн.

-Юу гэнэ ээ? Чи галзуурав уу? гэж Расти эхнэр рүүгээ гайхан хараад асуув.

Барби урьдын адил гараа өргөсөөр байсан бөгөөд цагдаа нарт гар хоосон гэдгээ харуулна. Тэр эвхэрсэн байх тул хөндлөнгөөс харахад цагдаа нартай мэндлэн бөхөлзөх мэт харагдана.

-Картер холд. Одоо хангалттай гэж Рэндолф тушаав.

-Тэнэг минь, буугаа далд хий. Хэн нэгнийг алах гээ юу? гэж Расти дарга руу хашгирлаа.

Рэндолф түүн рүү жигшил зэвүүцэл дүүрэн харц чулуудаад Барби руу эргэв.

-Алив тэгширч үз, хүү минь.

Барби өндийлөө. Тэр өвдөлтийг байдаг хүчээрээ даван эгцрэв. Хэрэв тэр Картерын цохилтонд урьдчилан бэлдээгүй бол одоо агаар залгих гэж ангалзан шалан дээгүүр өнхөрч байх байсан. Хэрэв тэгсэн бол Рэндолф түүнийг бос гээд өшиглөх байсан болов уу? Юу болж байгааг сайтар харахаар ойртож ирсэн олон тооны үзэгчдийг тоолгүй бусад цагдаа нар ч түүнтэй хөл нийлэх байсан уу? Тэгэх байсан. Яагаад гэвэл цагдаа нарын цус одоо буцалж яваа. Иймэрхүү нөхцөл байдалд үйл явдал яг л тэгж өрнөдөг.

-Би чамайг Бренда Перкинс, Лестер Коггинс, Дорин Сандерс, Анжела Маккейн нарыг алсан

хэрэгт буруутган баривчилж байна.

Барби нэр хэлэх бүрт давхийн цочиж байсан ба ялангуяа Брендагийн нэр түүний зүрх рүү зоогдох шиг болов. Тэр сайхан эмэгтэй болгоомжтой байхаа мартаж дээ. Барби түүнийг буруутгасангүй. Тэр эмэгтэй нөхрийнхөө араас дэндүү гашуудаж байсан учир аргагүй биз. Харин түүнийг Ренни рүү явуулсныхаа төлөө өөрийгөө буруутгана. Тэр бүү хэл түлхэж явуулсан учир.

-Юу болсон юм бэ? Бурхны нэрийг барьж асууя. Та нар юу хийсэн юм бэ? гэж тэр Рэндолфоос асуулаа.

-Чи одоо мэдэхгүй байгаа юмуу? гэж Фредди тургив.

-Чи ямар гээч гаж донтон бэ? гэж хашгирах үед Жеккигийн царай жигшин зэвүүцсэндээ үрчийж ирсэн ба нүд нь хорсол заналдаа болоод жижигрэв.

Барби тэднийг тоосонгүй. Тэр урьдын адил гараа өргөсөн чигээр Рэндолф руу ширтэнэ. Цагдаа нар түүн рүү ухасхийхэд өчүүхэн шалтаг хэрэгтэй байлаа. Тэр бүү хэл ерөнхийдөө хонгор зөөлөн ааштай эмэгтэй болох Жекки хүртэл тэдэнтэй нийлэхэд бэлэн байсан ба үүний тулд шалтаг биш ноцтой шалтгаан хэрэгтэй байлаа ч гэсэн тоолгүй дайрахад бэлэн болжээ. Магадгүй ер нь ямар нэг шалтгаан хэрэггүй болжээ. Заримдаа сайн хүмүүс ч ондоо болдог шүү дээ.

-Тэгвэл надад арай дээр асуулт байна. Та нар яагаад Ренниг ийм юм хийх боломж олгоо вэ? Энэ бол түүний ажил гэдгийг та нар сайн мэдэж байгаа. Бүх ул мөр түүн рүү хөтөлж байна гэж Барби үргэлжлүүлэн хэлэв.

-Дуугаа тат гэж Рэндолф хашгираад Жижгээ рүү хандан: -Түүнийг гавла гэв.

Жижгээ Барби руу дөхөхөд цаадах нь түүний ойртохыг хүлээлгүй гараа нуруундаа аваад цааш харж зогслоо. Расти Линда хоёр шалан дээр хэвтсэн хэвээр. Линда нөхрөө тэврэн зуурсаар байлаа.

-Сануулаарай гэж Барби хуванцар гав бугуйг нь ороон арьсанд зоогдох үед хэлэв.

Расти босч ирлээ. Линда түүнийг барих гэхэд эхнэрээ түлхэж орхиод түүн рүү урьд хожид хэзээ ч хараагүй тийм харц чулуудав. Түүний харцанд хатуу ширүүн байдал дуугүй зэмлэл болоод өрөвдөж энхрийлсэн санаа уншигдана. Тэгээд тэр цагдаагийн дарга руу хандан: - Питер гэж дуудав. Цаадах нь түүнийг тоолгүй цааш эргэхэд дуугаа өндөрсгөн байдгаараа ориллоо.

-Би чамтай ярьж байна. Намайг ярьж байхад чи над руу харах ёстой гэж хашгирав. Рэндолф түүн рүү эргэж харлаа. Царай нь яг л чулуун баг шиг болжээ.

-Та нар түүний араас ирэхийг Барби мэдэж байсан.

-Мэдээж мэдэж л таарна. Тэр гаж донтон байж болно. Гэхдээ тэнэг биш гэж Жижгээ хэллээ.

Расти түүн рүү харсан ч үгүй.

-Тэр сая надад гар ба нүүрээ шалгуулсан. Бас цамцаа өргөж нуруу ба гэдсээ үзүүлсэн. Сая Картерын цохилтын дараа бий болсон хөхрөлтөөс өөр юу ч байхгүй, цэв цэвэрхэн.

-Гурван эмэгтэй. Гурван эмэгтэй ба ламыг алсан. Тэр ингүүлэх хэрэг хийсэн хүн гэж Картер хэллээ.

Расти урьдын адил Рэндолф руу харна. -Энэ бол чихээс.

-Би чамайг хэдий хүндэлдэг боловч энэ чиний мэдэх салбар биш гэж хэлээд Рэндолф гар буугаа гэрэнд нь шургуулахад бүх хүний санаа амрав.

-Яг зөв. Би эмч болохоос цагдаа юмуу өмгөөлөгч биш. Тиймээс би чамд хэлж байна. Хэрэв чиний хараа хяналтанд орсоноос хойш би түүнтэй уулзах цаг ирж, тэр үед биенд нь хөхрөлт няцралт илрэх юм бол бурхан ч чамд тусалж чадахгүй шүү.

-Чи тэгээд юу хийх юм бэ? Иргэний эрх чөлөөний холбоо руу утасдах юмуу? Чиний найз дөрвөн хүн алсан байна. Бренда Перкинсийн хүзүүг хугалсан байна. Тэр үхсэн бүсгүйчүүдийн нэг нь миний сүйт хүүхэн байсан. Түүнийг хүчиндсэн байна. Үхэхээс нь өмнө, бас үхсэнийх нь дараа хүчиндсэн юм шиг байна билээ. Тэгээд чи ийм залууг хамгаалах хэрэг үү? Үүний төлөө чамайг өөрийг чинь шоронд хийх хэрэгтэй гэж Френк хэлэх үед уур хорсолоос уруул нь цайрав. Буун дуу нирхийх үед тарж зугтсан хүмүүс бүгд цугласан байсан ба энэ яриаг сонсоод бүгд дуу алдлаа.

-Френк дуугаа тат гэж Линда хашгирав.

Расти салхин цэцэг ба гахайн хавдар тусах үед нь эмчилж байсан бөгөөд толгойтой үснээс нь бөөсийг нь түүдэг байсан тэр жаалхүү Френк рүү харав. Френк зуны зусланд яваад бөөстөж, бас өвчин тусч эргэж ирсэн. Мөн бейсбол тоглохдоо зүүн гар нь хугарах үед гипс тавьж өгч байсан. 12 настайдаа хортой өвсөнд хатгуулаад аймаар загатнах өвчин тусахад нь эдгээж байсан. Одоо тэр жаалхүү ба энд зогсч байгаа эр хүн хоёрын хооронд ижил юм үгүй болжээ.

-Намайг шоронд хийчихвэл яах юм бэ? Дараа нь юу болох вэ Френк? Өнгөрсөн жилийнх шиг танай ээжийн цөсний чулуу дахиад хөдөлбөл хэн туслах вэ? Ээжийг чинь шоронд хүргэж ирэх хүртэл би хүлээх үү?

Френк түүнийг алгадах юмуу нударгалах санаатай гараа өргөн урагш алхав. Жижгээ түүнийг барьж авлаа.

-Тэр хариугаа авах цаг ирнэ. Бүү санаа зов. Барбигийн талд байгаа бүх хүн хариугаа авна. Цаг нь ирнэ.

-Талд гэнэ үү? Ямар талын тухай чи яриад байгаа юм бэ? Энд ямар хөл бөмбөгийн тэмцээн болж байгаа юм уу? гэх Растигийн дуу цөхөрч гайхсан өнгө аястай байв. Жижгээ ямар нэг нууцыг мэдэж байгаа хүн шиг инээд алдлаа. Расти Линда руу эргээд: -Чиний хамтран

зүтгэгчид ийм юм ярих ч гэж дээ. Энэ бүхэн чамд таалагдаж байна уу?

Эхнэр нь түүн рүү харцаа өргөж чадалгүй хэсэг зогсов. Дараа нь нөхөр рүүгээ хараад:

-Тэд уурлаж хорссон байна. Энэ бол үнэн. Гэвч би тэднийг буруугтахгүй. Би ч бас хорсож байна. Дөрвөн хүн шүү дээ. Чи сонсоогүй юм уу? Тэр бүгдийг нь алаад хоёр бүсгүйг хүчиндсэн юм шиг байна. Би Боуигийн шарилын машинаас тэдний цогцосыг гаргахад тусалсан. Би толбонуудыг олж харсан.

Расти толгой сэгсрэв.

-Би өглөөний турш түүнтэй хамт байсан. Тэр хүмүүсийг өвгөх биш харин туслахыг харж байсан.

-Явцгаая гэж Барби хэлэв.

-Алив холд. Одоо ингэх цаг биш...

Энэ үед Жижгээ түүний хавирга руу хүчтэй нударав.

-За жингэрийн гөлөг минь чамд дуугүй байх эрх бий.

-Энэ хэргийг тэр үйлдсэн гээд Линда Расти руу гараа сунгав. Гэвч нөхөр нь атгахыг хүсэхгүй байхыг хараад гар нь ташуур шиг шулдайн унжлаа.

-Түүний цэргийн энгэрийн тэмдэгийг Энжи Маккейний атгасан гар дотроос олсон.

Расти үг хэлэх ч чадваргүй болов. Барбиг даргын машины арын сандал дээр суулгаад түгжихийг л харж зогслоо. Гарын гавыг хэн ч авсангүй. Гэвч Барби ганцхан хормын хугацаанд Раститай харц тулгарав. Тэгээд толгой сэгсэрлээ. Ганцхан удаа. Гэхдээ үл анзаарагдам боловч ян тан ойлгогдохоор сэгсрэв.

Дараа нь түүнийг авч одсон.

Эмнэлгийн танхимд нам гүм ноёрхов. Жижгээ Френк хоёр Рэндолфын машинд суулаа. Картер Жекки ба Фредди нар хоёр дахь машиныг чиглэв. Линда зогссон чигээр байх ба нөхрөө хорсож занасан ба гуйж мөргөсөн харцаар ширтэнэ. Гэвч хорсол занал нь тэр дороо алга боллоо. Тэр гараа өргөөд нөхөр рүүгээ дөхөв. Ганц хором ч болтугай тэврэх байх гэж хүлээв.

-Үгүй гэж нөхөр нь тас цохилоо.

Бүсгүй дороо хөшив.

-Чи яачихаад байгаа юм бэ?

-Чи өөрөө яачихаад байгаа юм бэ? Эсвэл чи дөнгөж сая энд юу болсныг ойлгоогүй юм уу?

-Расти минь дээ. Энжигийн гарт Барбигийн цэргийн энгэрийн тэмдэг атгаастай байсан.

Нөхөр нь аажим толгой сэгсрэв.

-Тэгээд л бүх юм тодорхой болсон гэж чи хэлэх гээд байна

уу?

Царайд нь шаналал ба найдвар тодорч байсан бүсгүйн царай хөшлөө. Линда урьдын адил гараа сунгасан зогсч байгаагаа сая анзаарч гараа буулгав.

-Дөрвөн цогцос. Гурвыг нь таних аргагүй болтол нь зодож цохисон байна. Одоо талууд гэж бий болсон. Тэгэхээр чи аль талд нь орохоо бодох хэрэгтэй.

-Чи ч бас бодох хэрэгтэй хонгор минь.

-Линда нааш ир гэж Жекки гаднаас дуудав.

Расти энд хоёулхнаа биш байгаа гэдгээ гэнэт ухаарав. Тэр хоёрын эргэн тойронд Жим Реннигийн төлөө байнга саналаа өгдөг олон хүн зогсч байлаа.

-Линда минь болсон явдлын талаар сайн бод. Тэгээд Рэндолф хэний талд ажиллаад байгааг ч бодоорой.

-Линда гэж Жекки дахиад дуудлаа.

Линда толгой унжуулан явж одов. Эргэж харсангүй. Расти эхнэрээ цагдаагийн машинд суух хүртэл биеэ барьж чадлаа. Дараа нь хамаг бие нь салгалан чичрэв. Яг одоо суухгүй бол унах нь байна гэж тэр бодов.

Түүний мөрөн дээр хэн нэгэн гараа тавьлаа. Дуги байжээ.

-Босс оо, чи зүтээр үү?

-Тийм ээ.

Энэ үгийг хэлэхээр бүх юм хэвэндээ орчих юм шиг санан бушуухан хэллээ. Барбиг шорон руу авч одсон. Расти өөрөө эхнэртэйгээ анх удаа маргалдсан. Дөрөв билүү эсвэл зургаан жилийн хугацаанд. Үгүй ээ, бүх юм хэвийн биш байна.

-Надад нэг асуулт байна. Хэрэв хүмүүсийг алсан юм бол яагаад задлан шинжилгээ хийхээр нааш нь авчралгүй цогцосыг нь "Боуигийн оршуулгын товчоо" руу хүргэсэн байна вэ? Энэ хэний санаа вэ?

Растиг хариулж амжаагүй байтал гэрэл унтарлаа. Эмнэлгийн цахилгаан үүсгүүрийг тэжээж байсан хийтэй чингэлэг хоосорчээ.

Тэд гурвуул ногоотой жигнэсэн махыг гялалзтал идэж дуусахад (үүгээр энэ айлын махны нөөц дуусав) Клер тэднийг өмнөө зогсохыг хүслээ. Тэгээд тэдэн рүү нухацтай ширтэнэ. Харин тэд цэл залуу айдас төрөм шийдэмгий залуус түүн рүү ширтэх ажээ. Дараа нь Клер санаа алдаад Жо-д үүргэвч өглөө.

Бенни үүргэвч рүү шагайвал дотор нь самрын тос ба жимсний чанамал түрхсэн гурван хэрчим талх, гурван өндөг, гурван лонх "снэпл" (энэ нь жимсний жүүс ба цай хольсон сэрүүцүүлэх ундаа) ба зургаан ширхэг үзэмтэй овъёсны жигнэмэг байв. Хоолны дараа ходоод дүүрсэн хүмүүс хүртэл үүнийг хараад царай нь гэрэлтэв.

-Хатагтай Макклэтчи үнэхээр гайхамшигтай. Та жинхэнэ...

Эмэгтэй түүн рүү эргэж харсангүй. Тэр зөвхөн Жо-г нүд салгалгүй ширтэнэ.

-Энэ маш чухал ажил гэдгийг би ойлгож байна. Тиймээс та нартай хамт явна. Тэр бүү хэл хүргэж өгч чадна. Хэрэв...

-Тэгэх ямар ч шаарддага байхгүй ээж ээ. Тийшээ хүрч очих чинь алга урвуулахтай адилхан.

-Бас ямар ч аюулгүй. Зам хоосон байгаа гэж Норри нэмж хэлэв.

Клер эх хүний хатуу чанга харцаа хүүгээс салгасангүй.

-Гэвч би хоёр амлалт авах ёстой. Нэгдүгээрт та нар харанхуй болохоос өмнө эргэж ирэх ёстой. Би шөнө болохын өмнөх бүрэнхийг хэлж байгаа юм биш шүү. Нар жаргаж амжаагүй байхад та нар ирсэн байх болно. Хоёрдугаарт хэрэв та нар ямар нэг юм оллоо гэхэд тэр ямар нэг зүйлийн байрлалыг тэмдэглэж аваад оролдолгүй орхих ёстой. Тэр ямар нэг зүйлийг хайж олох ажилд та гурваас илүү тохирох хүн үгүй гэдэгтэй би санал нэг байна. Гэвч хайж олсон зүйлийн учрыг тайлах нь томчуудын ажил. Та нар надад ам өчиг өгөх үү? Хэрэв өгөхгүй бол би хүмүүжүүлэгчийн журмаар та нартай хамт явахаас өөр аргагүй.

Беннигийн царайд эргэлзээ тодорлоо.

-Хатагтай Макклэтчи би Блэк-Ридж-Роуд зам дээр хэзээ ч очиж байгаагүй. Гэхдээ дэргэдүүр нь гарч байсан. Таны "сивик" тэр замаар явахад тохиромжтой гэж би бодохгүй байна.

-Тэгвэл та нар эсвэл ам өчиг өг. Эсвэл эндээ үлд. За юу гэх

Жо ам өчиг өглөө. Нөгөө хоёр нь ч бас. Норри тэр байтугай загалмайлав.

Жо үүргэвчээ бараг үүрэх гэж байтал Клер гар утас шургуулав.

-Ноёнтон, түүнийг бүү гээчихээрэй.

-Алдахгүй ээ, ээж ээ гэж хэлэхдээ Жо хөлөө солбин зогсоно. Тэр явахын түүс болж байв.

-Норри хэрэв энэ хоёрын тоормос ажиллахаа больчихвол чи ямартаа ч ухаанаа гээхгүй гэж би найдаж болох уу?

-Тийм ээ, хатагтай гэж Норри түгдрэлгүй хариулав. Өнгөрсөн жил скейтээр гулгаж явахдаа ясаа хугалах нь бүү хэл хүзүүгээ хугалах мянга мянган тохиолдолтой учирч яваагүй хүн шиг л шууд хариулав.

-Та итгэлтэй байж болно.

-Би үүнд их найдаж байна. Маш их найдаж байна гэж хэлэхдээ Клер толгой нь өвдсөн хүн шиг чамархайгаа үрэв.

-Сэтгэл хөдлөм гайхалтай сайхан хоол байлаа, хатагтай Макклэтчи гэж Клер дуу алдаад гараа дээш өргөж -Алив савраа гэв.

-Бурхан минь би юу л хийж байна даа гэж Клер ёжтой асуусанаа жаалхүүгийн гар руу тасхийтэл алгадав.

10

Хүмүүсийн хулгай, танхайн хэргийн тухай мэдээлэх юмуу хөршийн нохой чанга хуцаж байгаа талаар гомдол гаргах гэж ирдэг цагдаагийн газрын цэлгэр үүдний өрөөнд байх цээжээр татам өндөр хаалтын ард "кофе ба чихэртэй боов төлбөртэй" гэсэн үглээ бичээс бүхий кофе чанагч ба жижиг шүүгээнүүд бас ширээнүүд эгнэсэн жижүүрийн хэсэг байрлана. Баривчлагдаж ирсэн хүмүүсийг энд бүртгэдэг. Фредди энд Барбигийн зургийг авч харин Генри хурууны хээг нь авлаа. Энэ ажиллагаа явуулах үед Рэндолф ба Фредди нар гар буугаа бэлэн барин дэргэд нь зогсоно.

-Хуруугаа сулла, суллаач гэж Генри хашгирав. Энэ хүн "Эглантери"-д хооллох үеэр "Ред Сокс" ба "Янки" багуудын өрсөлдөөний тухай Барбитай чалчиж суух дуртай тэр хүн биш болжээ. Мань хүн үргэлж л гахайн утсан махтай талх ба салат мөн улаан лооль, давсалсан өргөст хэмх авдагсан. Харин одоо тэр Дейл Барбарагийн хамар дундуур дуртайяа татаад авах шинжтэй харагдана.

-Хуруугаа битгий өнхрүүлээд бай. Би дарж өнхрүүлнэ. Зүгээр л сулла.

Дэргэд гар буу бэлэн барьсан хүмүүс зогсч байх үед, тэр тусмаа зэвсгээ дуртайяа хэрэглэж мэдэх хүмүүс байхад гараа суллах нь тун хэцүү тухай Барби Генрид хэлмээр санагдана. Гэвч тэр ам нээгээгүй бөгөөд Генри хурууны хээ авахаар өнхрүүлэх боломж олгохын тулд хуруунуудаа сулруулахад хамаг анхаарлаа төвлөрүүлнэ. Муугүй болчих шиг боллоо. Хэрэв өөр нөхцөлд байсан бол тэр Генригээс яах гэж ингэж дүр үзүүлээд байгааг асуух байсан. Гэвч энэ тохиолдолд тэр ам нээсэнгүй.

-За боллоо. Түүнийг доош нь аваач. Би гараа угаамаар байна. Түүнд хүрнэ гэдэг чинь шавхайнд өнхөрсөнтэй адил гэж хурууны хээ одоо л нэг авагдсан гэж итгэсэн Генри арай гэж тушаав.

Жекки Линда хоёр нэг талд зогсоно. Рэндолф Фредди хоёр буугаа далд хийхэд хоёр бүсгүй буугаа сугалав. Тэд Барби руу чиглүүлээгүй ч хэзээ ч ингэхэд бэлэн байлаа.

-Хэрэв би чаддагсан бол чиний надад өгч байсан бүх хоолыг бөөлжмөөр байна. Чамайг харахаас ч дургүй хүрч байна гэж Генри хэлэв.

-Би юу ч хийгээгүй. Генри чи энэ талаар сайн бодоорой гэхэд Генри зүгээр л цааш харлаа.

"Яг одоо энд бодох тал дээр хэцүү л байна даа" гэж Барби өөртөө хэлэв. Ренни яг ийм үр дүнд тэмүүлсэн гэдэгт тэр эргэлзсэнгүй.

-Линда, хатагтай Эверетт...

-Над руу битгий яриад бай гэх үед түүний царай нүдэн доогуурх улаан хагас дугуйг эс тооцвол цаас шиг цагаан болсон байв. Тэр толбо нь яг хөхөрсөн мэт харагдана.

-За алт минь алхаж үз. Чиний өргөө хүлээж байна гэж Фредди тургиад бөөрнийх нь дээхэн талд ар нуруу руу нь нударгалав.

11

Жо Бенни Норри гурав унадаг дугуйгаар Блек-Ридж-роудын зүг хурдлана. Зуны халуун өдөр байх ба бүгчим агаарт утаа хөшинө. Салхи сэвхийх ч үгүй. Замын хоёр талаар өндөр өвсөн дотор голио цархийнэ. Тэнгэрийн хаяа шарласан байх ба Жо эхэндээ үүл харагдаж байна гэж бодов. Гэвч энэ нь

Бүрхүүл дээр наалдсан бохир ба тоос шорооны хольц болохыг ойлголоо. Энд Престил-Стрим гол замын хажуухан талаар урсах бөгөөд зүүн өмнө зүгт Касл-Рокийг чиглэн хүчирхэг Аидроскоггин мөрөнд цутгахаар яарна. Голын дагуу модон дээгүүр тарж суусан хэрээ гуагалах ба голио цархийх дуу хүүхдүүдийн чихийг дэлсэнэ.

Тэд хаа сайгүй том том хонхорхойтой хөдөөгийн жижиг Блэк-Ридж-роуд замд тулж ирлээ. Салаан дээр хоёр зам заагч самбар хазайсан харагдана. Зүүн талын самбар дээр "Дөрвөн дугуйгаар мааждаг машинаар явбал зохино" гэсэн байх бол баруун самбар дээр "Зөвшөөрөгдсөн дээд жин дөрвөн тонн. Гүүрээр хүнд тэрэг явахыг хориглоно" гэсэн байв. Хоёр самбарыг бууны сумаар шүүр болгожээ.

-Манай хотын оршин суугчид байнга буудах дасгал хийдэг нь надад таалагддаг. Эль Клайдер манай энд бол амжилт олохгүй шүү гэж Бенни онцлов.

-Тэнэг минь, Аль Кайда гэдэг юм гэж Жо засч хэллээ.

Бенни биеэ тоонгуй инээмсэглэж толгой сэгсрэв.

-Би Мексикийн алдарт дээрэмчин Эль Клайдерын тухай ярьж байна. Тэр хүн оргож зайлахын тулд баруун Мэнд ирсэн юм...

-Алив Гейгерийн тоолуураа гаргаад ир гэж Норри яарлаа.

Беннигийн унадаг дугуйн арын хаалт дээрх сагсанд тоолуурыг хийсэн байв. Тэд гэрийнхээ даавууны сагснаас хэд хэдэн алчуур түр зээлдэж тоолуураа боожээ. Бенни тоолуураа гаргаж ирээд Жо-д сунгалаа. Бүүдгэр орчинд шар багаж тод толбо мэт онцгойрно. Беннигийн инээмсэглэл аль хэдийн алга болжээ.

-Алив чи үүнийг хий. Би арай хэтэрхий сэтгэл догдлоод байдаг юм.

Жо Гейгерийн тоолуурыг хэсэг ширтсэнээ Норрид өглөө.

-Сүүлээ хавчсан хулчгарууд гэж охин бодох санах юмгүй тайлбар хийгээд багажийг залгав. Зүү тэр дороо нэмэх 50 хүртэл үсрэв. Үүнийг харсан Жо-гийн зүрх нь цээжин дотроо биш хоолой дээр нь ирэхийг тэр мэдэрлээ.

-Пөөх, мөрөөр нь орчихлоо гэж Бенни дуу алдав.

Норри улаан бүсээс хангалттай хол зайтай байгаа (хуваарийн гол орчимд) зүүнээс хараа салгаад Жо руу ширтэв.

-Цаашаа явах юм уу?

-Мэдээж шүү дээ, чөтгөр ав.

Цагдаагийн газарт одоогийн байдлаар цахилгаан хангамжийн тал дээр асуудал үүсээгүй байлаа. Хонгилын шал ногоон өнгийн плитагаар бүрэн хучигджээ. Таазан дор нь ёлтойх хөхөвтөр гэрэл хоногийн турш хонгилыг сэтгэл гутаах өнгөөр гэрэлтүүлнэ. Шөнө дунд байсан ч, үүр хаяарч байсан ч, энд бол яг л үд дунд шиг гэрэлтэй байдаг. Дарга Рэндолф ба Фредди нар Барбиг шатаар доош туув. (туух гэж хэлж болохгүй нь. Яагаад гэвэл тэд булчингаас нь базжээ). Эмэгтэй цагдаа нар гар буугаа бэлэн барин араас нь алхав.

Хонгилын зүүн талд архив байрлана. Харин баруун талд таван хорих өрөө байх бөгөөд хонгилын хоёр талд хос хосоор байрлаж харин нэг өрөө нь хамгийн цаад буланд байх ажээ. Энэ өрөө бусдаасаа хэмжээ бага ба ханз нь нарийн мөн суултуургүй төмөр жорлонтой бөгөөд Барбиг яг тийш нь туулаа.

Том Жимээс авсан чиглэлийн дагуу Рэндолфын тушаалаар "Их дэлгүүрийг цөлмөх" жүжигт оролцсон хамгийн харгис жүжигчдийг хүртэл тавьж явуулжээ. Тэдний хааш явахыг ч асуулгүй гаргаж хаяцгаав. Тиймээс одоо хорих өрөөнүүд хоосон мэт байв. Тийм ч учир дөрвөн номерын өрөөнд нуугдаж байгаад гэнэт гарч ирсэн Мэлийн үйлдэл бүгдийн хувьд гэнэтийн бэлэг байлаа. Тэр гартаа ямар нэг юмаар дүүргэсэн спорт оймс болох гар хийцийн бороохой барьсан байв. Толгойн боолт нь дух руу нь доошилж, хар шил зүүн хөхөрсөн нүдээ хаажээ. Үл үзэгдэгч хүн түүн рүү шууд дайрна гэж Барби бодов.

-Муу новш гэж Мэл орилоод оймсоороо савлаа. Барби тонгойв. Оймс толгой дээгүүр нь сүнгэнэн гараад Фреддигийн мөр рүү онолоо. Өнөөх нь ёлон дуу алдаад Барбигийн гарыг

алдав. Хойно эмэгтэйчүүд хашгиралдана.

-Хараал идсэн алуурчин. Миний толгойг хагалахын тулд чи хэнд мөнгө төлсөн бэ аан? гэж Мэл орилоод дахин савахад энэ удаа Барбигийн шуун дээр онолоо. Гар нь хөшөөд явчихав. Мэл оймсонд элс биш ямар нэг хатуу юм хийжээ. Төмөр юмуу шилэн зүйл хийсэн байх ба ямартаа ч бөмбөлөгүүд аж. Хэрэв хурц үзүүртэй зүйл хийсэн бол цус урсах байсан.

-Муу газарт булуулмар. Өмхий бэлгивч гэж Мэл дахин орилоод дахиад л оймсон бороохойгоо савлаа.

Рэндолф дарга мөн Барбигийн гарыг тавиад хойшоо үсрэв. Өнөөх нь бороохой бугуйн дээр буух үед нэг ярвайгаад оймсны дээд хэсгээс атгаж өөр рүүгээ хүчтэй татан Мэлийн оймсон бороохойг гараас нь мултлав. Энэ үед Мэлийн толгойн боолт доошоо унаж хар шилийг нь хаав.

-Зогс. Боль. Одоохон боль. Хэрэгтэн танд ганцхан удаа сануулна шүү гэж Жекки бахирлаа.

Хүйтэн төмөр цагираг нурууны дал хооронд наалдахыг Барби мэдрэв. Хэдийгээр тэр харж чадахгүй ч гэсэн Жекки түүний нуруунд гар буугаа тулгасаныг мэдэж байв. "Хэрэв тэр буудах юм бол сум яг тийшээ зоогдоно. Тэр буудаж мэднэ. Яагаад гэвэл хамгийн том гайн шалтгаан нь гадны хүн болчихдог жижигхэн хот болохоор тэр. Энд мэргэжлийн хүмүүс ч юу ч биш" гэж тэр бодлоо.

Барби оймсыг доош нь хаяхад дотор нь байгаа зүйл шальгг түнхийн цохив. Тэгээд тэр гараа өргөлөө.

-Би түүнийг хаясан. Би зэвсэггүй байна. Буугаа авна уу?

Мел нүдийг нь тагласан боолтыг сөхөв. Боолт нь тайлагдаж дорны хүмүүсийн толгойн боолт аятай хөвөрлөө. Тэр Барбигийн аюулхай ба гэдэс рүү хоёр удаа дэлсэв. Энэ удаад Барби цохилтонд бэлдэж амжаагүй учир уушиг дахь агаар нь гадагш нэг дор хүчтэй дуу гарган урсав. Тэр эвхрээд дараа нь өвдөг сөхрөн уналаа. Мел түүний хүзүүн дундуур татав. Магадгүй Фредди ч байж мэднэ. Гэхдээ аймшиггүй толгойлогч дарга өөрөө ч цохиж чадахыг Барби мэдэж байлаа. Тэр ногоон шалан дээр тэрийн унахад хорвоо ертөнц улам холдож улам нам гүм болов. Түүний тод томруун харсан ганц зүйл нь нэг плитан дээр байх цөмөрсөн нүх ажээ. Яагаад үгүй гэж? Учир нь плита түүний нүднээс ганц дюймээс ч ойр зайтай байсан.

-Боль. Болиоч, түүнийг зодохоо боль гэх дуу алсыгн алсаас дуулдав. Гэвч энэ дуу Растигийн эхнэрийн дуу гэдэгт Барби эргэлзсэнгүй.

-Тэр хэвтэж байна. Түүний хэвтэж байгааг харахгүй байна

уу?

Эргэн тойронд яг нарийн хөдөлгөөнтэй бүжиг шиг хөлнүүд хөдөлцгөөнө. Хэн нэгэн түүний бөгсөн дээр гишгэж бүдрээд "Чөтгөр" гэж хараав. Барбигийн хавирга руу өшиглөнө. Энэ

бүхэн холын холд болох мэт санагдана. Хожим хавирга өвдөж мэднэ. Гэвч одоохондоо бүх юм тийм ч муу биш байна.

Хэн нэгний гар түүнийг шүүрээд босоо байдалд авчирлаа. Барби толгойгоо өргөх гэснээ унжуулсан нь дээр болохыг ойлгов. Түүнийг хонгилын төгсгөл дэх хорих өрөө рүү чирлээ. Хөлөн доогуур ногоон плитанууд урсан. Фредци тэр дээр юу гэж хэллээ дээ. "Чиний өргөө чамайг хүлээж байгаа".

"Гэвч үйлчлэгч эмэгтэй дэрэн дээр гаатай чихэр тавьж орхисон гэдэгт би эргэлзэж байна" гэж Барби бодов. Гэхдээ үүнд огт санаа зовсонгүй. Тэр шархаа долоохын тулд ганцаар үлдэхийг хүснэ.

Хорих өрөөний хаалган дээр хэн нэгэн түүнд нэмэлт хурд өгөхийн тулд өгзөг рүү нь хөлөөр жийлээ. Барби урагш чулуудагдахад ногоон өнгийн үнсэн ханыг мөргөхгүйн тулд баруун гараа урдаа сунгав. Зүүн гараа ч бас өргөх гэж оролдсон ч тохойноос доош мэдээ алджээ. Гэхдээ л тэр толгойгоо хамгаалж дөнгөсөн бөгөөд үүндээ баярлав. Тэр баруун гараар ханыг мөргөж найган ганхаад энэ удаад ханзны дэргэд унтлагын өмнөх залбирал үйлдэх гэж байгаа хүн аятай өвдөг сөхөрлөө. Ард нь гүйдэг торон хаалга нижигнэн хаагдав.

Барби ханзыг хоёр гараар тулаад өндийв. Зүүн гар нь одоо мэдээ орж эхэлжээ. Эргэж харахад хоёр гараа зангидаж толгойгоо унжуулсан Рэндолф цааш алхаж явахыг олж харлаа. Түүний ард Фредди явах ба Мелийн толгойн боолтыг засна. Харин Мел Барби руу ширтэх ажээ. (Түүний харцан дахь хорсол занал хамар дээр нь арай ядан тогтох шилийг харагдахгүй болгоно). Эрчүүдийн хойно бараг шатны дэргэд хоёр эмэгтэй зогсох ба тэдний царайд яах ухаанаа олохоо байсан байдал ба айдас уншигдана. Линда бүр хувхай цайсан байх ба түүний нүдэнд нулимс гялтаганаж байна гэж Барби бодов.

Барби сэтгэлийн бүх хүч тэнхээгээ хуримтлуулаад түүнд хандлаа.

-Цагдаа Эверетт гэж тэр дуудав. Бүсгүй ийм юм хүлээгээгүй тул давхийн цочлоо. Ингэхэд урьд нь хэн нэгэн түүнийг "Цагдаа Эверетт" гэж дуудаж байл уу? Замын хөдөлгөөн зохицуулж байхад сургуулийн сурагчид л тэгж дуудсан байх. Энэ нь орон тооны бус цагдаад хүлээлгэдэг хамгийн хүнд даалгавар юм. Ямартаа ч энэ долоо хоногийг хүртэл хэн ч түүнийг ингэж дуудаагүй.

-Цагдаа Эверетт. Хатагтай. Хатагтай гуйя.

-Дуугаа тат гэж Фредди шүдээ хавирлаа.

Барби түүн рүү өчүүхэн ч анхаарал хандуулсангүй. Юу юугүй ухаан алдах гэж байна гэж Барби бодов. Ямартаа ч одоохон тэрийн унах бөгөөд гэхдээ одоохондоо хөл дээрээ зогссон хэвээр байлаа.

-Та нөхрөө цогцоснуудыг үз гэж гуйгаарай. Ялангуяа хатагтай Перкинсийн цогцосыг. Тэр цогцоснуудыг үзэх ёстой. Цогцосыг эмнэлэгт аваачихгүй. Ренни үүнийг зөвшөөрөхгүй...

Рэндолф буцаж ирэв. Тэр Фреддигийн бүсэнд зүүлттэй зүйлийг авахыг Барби харлаа. Тэгээд нүүрээ гараар дарах гэж оролдсон ч гар нь даагдсангүй.

-Хүү минь хангалттай гээд Рэндолф торон завсар "Мейсом" савтай хийг шургуулж товчийг дарав.

13

Зэвэнд идэгдсэн Блэк-Ридж гүүрний голд Норри унадаг дугуйгаа зогсоогоод урагшаа хаашаа ч юм ширтэв.

-Бид зогсох учиргүй. Өдрийн үлдсэн цагийг ашиглах хэрэгтэй гэж Жо онцоллоо.

-Би мэдэж байна. Гэхдээ хараач дээ гэж Норри хаашаа харах ёстойг гараар заав.

Голын нөгөө эрэгт Бүрхүүл үүсэхээс өмнө Престил-Стрим гол урсаж байсан тэр газарт одоо хуурай шавар бий болсон байх ба тэнд дөрвөн ширхэг үхсэн бугын сэг байв. Нэг эр, хоёр эм ба нэг янзага. Бүгд их тарган том биетэй байв. Миллд энэ зун сайхан зун болсон бөгөөд буганууд тарга тэвээр авгалаа иджээ. Сэгэн дээр эргэлдэх ялаан үүлийг Жо олж харсан бөгөөд тэр бүү хэл залхуутай дүнгэлдэхийг ч сонсов. Жирийн өдөр байсан бол голын урсах чимээ энэ дууг дарах байсан.

-Тэд яачихсан юм болоо? Бидний эрж байгаа зүйл үүний шалтгаан гэж чи бодоод байна уу? гэж Бенни асуув.

-Хэрэв чи цацраг идэвхит хордлогын талаар асууж байгаа бол түүнээс болж ийм хурдан үхдэггүй юм гэж Жо хариуллаа.

-Хэрэв маш хүчтэй цацраг идэвхижилт биш бол шүү дээ гэх Норригийн дуунд түгшүүр тодорлоо.

Жо энэ үед Гейгерийн тоолуурьш зүү рүү заав.

-Чиний зөв. Гэвч цацраг идэвхижилт тийм ч хүчтэй биш байна. Тэр бүү хэл зүү улаан бүсийг өнгөрлөө ч гэсэн энэ нь буга шиг том амьтныг гуравхан хоногийн дотор үхүүлэхэд хангалттай биш гэж бодож байна.

-Эр буга хөлөө хугалсан нь эндээс ч харагдаж байна гэж Бенни ажиглалтынхаа дүнг хуваалцлаа.

-Нэг эм нь хоёр хөлөө хугалжээ. Урд хөлөө хугалсан байна. Эргэж мушгирсаныг хараач гэж Норри хэлэв.

Буга ямар нэг акробатын хэцүү үзүүлбэр хийхийг оролдон үхсэн байна гэж Жо бодлоо.

-Тэд үсэрсэн бололтой. Эрэг дээрээс үсэрчээ. Өнөөх хархтай төстэй жижигхэн амьтад үсэрдэг шиг гэж Норри санаагаа хэлэв.

-Лемон гэдэг юм гэж Бенни хэлж өглөө.

-Леммингүүд гэдэг юм шүү дээ тахиа тархитууд минь гэж Жо засч хэлэв.

-Тэд ямар нэг юмнаас зугтах гэж оролджээ. Тэгээд үсэрсэн болов уу гэж Норри асуулаа.

Хоёр жаалын хэн нь ч хариулсангүй. Тэд хоёулаа долоон хоногийн өмнөхөөс илүү балчир харагдах бөгөөд яг л аяны түүдгийн дэргэд аймшигт түүх сонсоход хүрсэн жаахан хүүхдүүд шиг харагдах ажээ. Тэд гурвуулаа үхсэн бугануудыг ширтэж ялаа нэгэн хэмээр дүнгэнэхийг сонсон унадаг дугуйнхаа дэргэд зогсоцгооно.

-Явцгаая гэж Жо санал тавьлаа.

-Энэ бол бидний үүрэг гэж бодож байна гээд Норри дугуйн хүрээ төмөр дээгүүр хөлөө давуулсан ч газарт тавьчихав.

-Яг тийм гээд Жо дугуйндаа мордлоо.

-Чи намайг дахиад л нэг балиар юманд татан орууллаа гэж Бенни хэлэв.

-Юу гэнэ ээ?

-Чухал юм биш ээ, үзэл санааны ах минь ээ, явцгаая.

Гүүрний нөгөө төгсгөлд очих үедээ тэд бүх бугын хөл хугарсан байхыг олж харав. Үр төл нь толгойгоо бяцалжээ. Ердийн цагт усанд далдлагдаад харагддаггүй үхэр чулууг мөргөсөн бололтой.

-Алив тоолуураа асаа гэж Жо хэллээ.

Норри асаахад энэ удаад зүү нэмэх 75 дээр заав.

14

Рэндолф Герцог Перкинсийн ширээний нэг шургуулганаас хуучин дуу хураагуур гаргаж шалгаад цэнэг хураагуур хэвийн байгаад иттэв. Бага Ренниг орж ирэхэд Рэндолф "бичлэг" гэсэн товч дээр дараад "сони"-гийн жижиг төхөөрөмжөө залууд харагдахуйц газарт ширээний өнцөг дээр тавьлаа.

Жижгээгийн сүүлийн толгой хатгалт тун хөнгөн өнгөрчээ. Толгойн зөвхөн зүүн талаар бага зэрэг дүнгэнээд л өнгөрсөн болохоор одоо тэр тун тайван байв. Тэр эцэгтэйгээ хамт мэдүүлэг хэрхэн өгөх сургуулилт хийсэн болохоор Жижгээ одоо юу ярихаа ян тан мэдэж байлаа.

"Энэ бол зүгээр л дүр эсгэж үзүүлэх ажил. Цэвэр жүжиг" гэж Том Жим түүнд тайлбарласан.

Бүх юм яг түүний хэлснээр болж өнгөрлөө.

-Хүү минь чи цогцоснуудыг яаж олсон юм бэ? гэж Рэндолф асуугаад эргэдэг сандалынхаа арыг налан хэвтэв. Тэр Перкинсийн бүх хувийн эд зүйлсийг хажуугийн хананд байх шүүгээ рүү далд хийжээ. Одоо нэгэнт Бренда үхсэн болохоор бүгдийг нь хогийн сав руу илгээх санаатай. Хувийн эд зүйлс зөвхөн хамаатан садны хувьд л ямар нэг хэмжээгээр үнэ цэнэтэй байдаг.

-Тэгэхээр... Би эргүүл хийгээд 117-р гудамжнаас буцаж явсан... Их дэлгүүрийн хажууд болсон бантанд оролцоогүй... гэж Жижгээ ярьж эхлэв.

-Чамд аз таарсан гэж тооцож болно. Тэнд ёстой нэг холион бантан болсон доо. Кофе уух уу? гэж Рэндолф асуулаа.

-Үгүй баярлалаа. Миний толгой хатгаж өвддөг юм. Кофе толгойн өвдөлтийг нэмээд байх шиг санагддаг.

-Муу зуршил гэдэг нь үнэн шүү. Хэдийгээр тамхи татах шиг тийм муу биш боловч ямартаа ч муу зуршил. Би Аврагдах хүртэлээ тамхи татдаг байсныг чи мэдэх үү?

-Үгүй ноёнтон мэдэхгүй.

Энэ тэнэг дэмий юм донгосохоо больж зохиосон түүхээ яриад эндээс бушуухан зайлах боломж олгоно гэж Жижгээ найдна.

-Тийм ээ, Лестер лам гэж хэлэх үедээ Рэндолф гараа цээжиндээ наав.

-Толгойг минь Престил-Стримд булхуулсан. Зүрхээ шууд л Есүст өгч дээ. Би бусад зарим нэг хүн шиг тийм сүсэгтэй хүн биш л дээ. Энэ тал дээр танай эцэгтэй харьцуулах юмгүй. Гэвч гэгээн лам Лестер бол сайн хүн байсан. Дейл Барбарагийн ухамсарт маш их толбо бий дээ. Хэрэв түүнд ухамсар гэж байдаг бол гээд Рэндолф толгой сэгсэрлээ.

-Тийм ээ, ноёнтон.

-Тэр олон зүйлд хариу өгөх хэрэг болно. Би түүнийг "Мейсом"-оор дайлсан. Энэ бол түүний хүлээж байгаа зүйлсийн өчүүхэн хэсэг. За за. Чи эргүүлээс буцаж явсан. Тэгээд...

-Энэ үед би хэн нэгэн надад Энжигийн машиныгт гараашт харсан гэж хэлснийг санасан юм. Маккейнуудын байшингуудын гараашт.

-Чамд хэн тэгэж хэлсэн юм бэ?

-Френки бил үү дээ. Френки гэж бодож байна гээд Жижгээ чамархайгаа үрэв. -Цааш нь ярь.

-Нэг үгээр хэлэхэд би гараашийн цонхоор шагайсан юм. Түүний машин үнэхээр байсан. Гол хаалган дээр очоод хонхыг нь дарахад хэн ч нээсэнгүй. Би арын хаалгаар очсон. Яагаад гэвэл сэтгэл түгшсэн юм л даа. Тэнд муухай үнэр гараад байсан.

Рэндолф санаа нийлэх маягтай толгой дохилоо.

-Зарчимын хувьд чи үнэрлэх чадвартаа хөтлөгдсөн юм байна. Энэ бол цагдаагийн сайн ажил хүү минь.

Жижгээ Рэндолф руу нухацтай ширтэнэ. Энэ наргиан юмуу далд өргөс үү гэж дотроо тааж ядна. Гэвч даргын нүдэнд үнэн сэтгэлээс бахадсан байх нь уншигдав. Жижгээгийн толгойд эцэг нь Энди Сандерсаас ч илүү тэнэг хүнийг туслагчаар сонгосон юм байна гэсэн бодол төрөв. (эхэндээ хамтрагчаар гэсэн үг толгойд харвасан) Гэвч Жижгээ ийм юм байх боломжтой гэдгийг төсөөлж чадахгүй байлаа.

-Цааш нь ярь ярь. Энэ чамд сэтгэлийн шарх авчирч байгааг би ойлгож байна. Бид бүгдийн сэтгэлийг өвгөлөө.

-Тийм ээ та зөв хэллээ. Арын хаалга онгорхой байсан. Үнэр намайг зоорийн өрөө рүү хөтөлсөн. Би тэнд харсан зүйлдээ арай ядан итгэсэн.

-Чи тэнд түүний цэргийн энгэрийн тэмдэгийг олж харсан.

-Тийм. Үгүй. Ямар нэг утгаар бол тийм. Би Энжи гартаа ямар нэг юм аттасныг олж харсан... Гинжтэй юм харагдсан... Яг юу болохыг нь мэдэж чадаагүй. Юугд ч гар хүрмээргүй байсан юм. Би зүгээр л нэг шинэ сурагч гэдгээ мэдэж байна гээд Жижгээ даруу загнан нүдээ буруулав.

-Зөв шийдвэр. Ухаалаг шийдвэр. Ердийн тохиолдолд бол бид Барбараг жинхэнээр нь хананд наахын тулд муж улсын прокурорын газраас шинжээчдийн бүхэл бүтэн баг дуудах хэрэгтэй болох байсан. Гэвч манай энд ер бусын нөхцөл байдалтай байна. Гэхдээ эд мөрийн баримт хангалттай. Хэрэв тэр хүн гэмт хэргийн газарт цэргийн энгэрийн таних тэмдгээ үлдээж байгаа юм бол бүр усан тэнэг болж таарна.

-Би гар утсаа аваад аав руу ярьсан. Радио холбооноос сонсоход та нар энд маш их ачаалалтай байх шиг санагдсан юм...

-Ачаалалтай гэнэ шүү. Хүү минь чи тун бага юм мэдэж байна даа. Гэвч эцэг рүүгээ утасдсан нь зөв болсон. Тэр хүн үнэндээ бол цагдаагийн ажилтан шүү дээ гэж Рэндолф нүдээ эргэлдүүлэн ярина.

-Аав хоёр цагдаа олсон нь Фредди ба Жекки нар байсан. Тэд Маккейний гэрт ирсэн юм. Фредди гэмт хэргийн газарт гэрэл зураг авч байхад Линда бас ирсэн. Дараа нь Стюарт Боуи ахтайгаа хамт шарилын тэргээр ирсэн. Үймээний дараа эмнэлэг шархадсан хүнээр дүүрсэн байсан учраас энэ зөв зам гэж аав боджээ.

Рэндолф толгой дохив.

-Зөв шийдвэр. Үхэгсэдийг оршуулж үлдэгсдэд туслах хэрэгтэй. Цэргийн тэмдгийг хэн олсон юм бэ?

-Жекки. Тэр Энжигийн гарыг харандаагаар хөшиж тавиулахад тэмдэг газарт унасан. Фредди

зургийг нь дарсан.

-Шүүх хурал дээр энэ бидэнд туслана. Хэрэв Бүрхүүл байрандаа үлдэх юм бол бид эндээ шүүх хурал хийх болно. Бид хийх л болно. Библи сударт юу гэж бичсэнийг мэдэх үү? Бид итгэл үнэмшилээр уулыг хөдөлгөнө гэдэг юм. Хүү минь. чи хүүрнүүдийг хэдэн цагт олсон юм бэ?

-Үд дундын үед гэж хариулах үед түүний толгойд "Охидтойгоо салах ёс хийсний дараа" гэх бодол харвана.

-Чи тэгээд шууд аав руугаа утасдсан уу?

-Шууд биш л дээ гэж хэлэх үедээ Жижгээ Рэндолф руу үнэнч шударга нүдээр харав.

-Эхлээд би гэрээс гараад бөөлжсөн. Тэднийг аймшигтай нүдсэн байна лээ. Би хэзээ ч тийм юм харж байгаагүй гэх үедээ тэр хүчтэй амьсгаадаж давхийн цочив. Дуу хураагуур үүнийг бичиж чадахгүй ч Рэндолф харж санаж авчээ.

-Бөөлжихөө больсны дараа эцэг рүүгээ утасдсан.

-За яахав болсон. Надад хэрэгтэй юм ингээд болсон гэж би бодож байна.

Дахиад нэг ч асуулт тавьсангүй. Тэр бүү хэл илтгэл бичихийг шаардсангүй. (Энэ нь сайн хэрэг гэж Жижгээ бодов. Яагаад гэвэл одоо гартаа үзэг авангуут толгой нь өвддөг болжээ) Рэндолф дуу хураагуураа унтраах санаатай урагш тонгойлоо.

-Жижгээ чамд баярлалаа. Өнөөдөртөө яагаад ингээд дуусгаж болохгүй гэж. Гэртээ харьж амар. Чи их ядарсан харагдаж байна.

-Би Барбараг байцаах үед энд баймаар байна.

-Өнөөдөр ямар нэг юм өнгөрөөчихнө гэж санаа зовох хэрэггүй. Тэр өөрийнхөө шүүсэнд чанагдахын тулд бид түүнд 24 цаг өгч байгаа юм. Чиний эцгийн гаргасан санаа. Маш сайн санаа. Бид түүнийг маргааш үдээс хойш юмуу орой байцаах болно. Чи энд хамт байна. Чамд амлаж байна. Бид түүнийг жаахан тамлаж байцаах болно.

-Тийм ээ, ноёнтон. Сайн хэрэг.

-Дуугүй байх эрх энэ тэрийн талаар үг ч байж болохгүй. -Ойлгож байна ноёнтон.

-Бид Барбараг тойргийн цагдаагийн газарт шилжүүлэх хэрэггүй болсондоо Бүрхүүлд талархая. Вегаст болсон зүйл бүхэн Вегастаа үлдэх ёстой гэдэг тохиолдол нь энэ дээ гэж хэлэх үедээ Жижгээ рүү нухацтай ширтлээ.

Жижгээ түүнд тийм юмуу үгүй гэж хариулахын алийг ч мэдсэнгүй. Яагаад гэвэл цагдаагийн даргын ширээний ард налайсан энэ тэнэг ямар утгаар яриад байгааг ойлгосонгүй.

Рэндолф дахиад хэдэн хором түүн рүү нүд салгалгүй ширтсэн ба тэд бие биенээ ойлгож байгаа гэдэгт итгэх гэж хичээх мэт. Дараа нь алгаа ташаад босч зогслоо.

-Жижгээ харьж үз. Өнөөдөр чи хангалттай ажилласныг харж байна.

-Тийм ээ, ноёнтон. Би ч бас явья гэж бодож байна. Жаахан амарья.

-Лестер лам намайг, миний толгойг усанд булхуулах үед хармаанд минь хайрцаг тамхи байсан юм гэж Рэндолф сэтгэлд тун ойрхон ямар нэг зүйлийг гэнэт санасан хүний өнгөөр ярьлаа. Хаалга руу алхах үед тэр Жижгээгийн мөрөөр тэврэв. Жижгээ царайндаа хүндэтгэн ойлгож байгаа дүр илэрхийлсэн ч дотроо бол энэ хүнд гарнаас болж хашгирмаар санагдана. Түүний хүзүүнд махан буулга зүүчихсэн мэт санагдах ажээ.

-Мэдээж тамхи маань нурууд хэнд ч хэрэггүй болсон. Би дахиж тамхи худалдаж аваагүй. Бурхны хүүгийн ачаар чөтгөрийн өвснөөс аврагдсан юм. Чамд энэ бүхэн ямар санагдаж байна даа?

-Сэтгэл хөдөлгөж байна гэж Жижгээ арай гэж хэллээ.

-Хэн анхаарал татаж байна гэвэл Бренда ба Энжи нар юм. Тэгэх нь зүйн хэрэг. Нэг нь хүндэт эмэгтэй, нөгөө нь бүх амьдрал өмнө нь байсан залуухан бүсгүй. Лестер ламын хувьд ч өөрийн шүтэн бишрэгчидтэй байсан. Түүнийг хайрладаг олон мөргөлчидийн тухай хэлэх ч үт алга.

Жижгээ зүүн нүднийхээ булангаар Рэндолфын мухар өргөн хуруунуудыг хялайв. Хэрэв толгойгоо тонгойгоод энэ хуруунуудыг зуучихвал тэр ер нь яах бол гэж бодлоо. Нэгийг нь тас хазаад шалан дээр нулимаж юмсан.

-Додиг ч бас бүү мартаарай гэж Жижгээ хэлэхдээ яагаад ингэсэнээ ойлгосонгүй. Гэвч үр дүнтэй байв. Рэндолфын гар түүний мөрнөөс саллаа. Цагдаагийн дарга аянганд ниргүүлсэн хүн шиг хөшив. Рэндолф Додигийн тухай таг мартсан болохыг Жижгээ ойлголоо.

-Бурхан минь, Доди. Ингэхэд Эндид хэн нэг нь хэлсэн болов уу? гэж Рэндолф гаслав.

-Мэдэхгүй ноёнтон.

-Танай аав утсаар ярьсан байх тийм үү? -Тэр тун завгүй байгаа.

Жижгээ үнэнийг хэлсэн юм. Том Жим гэр дэх ажлыгнхаа өрөөнд суугаад пүрэв гаригийн хотыг хураад хэлэх үгээ бэдцэж байлаа. Тэрбээр хямралын энэ үед хотын захиргааны гингүүдэд огцгой эрх олгох талаар санал хураалт явуулах хурлын өмнө хэлэх үгээ бэлдэж байв.

-Би Энди рүү утасдах ёстой юм байна. Гэвч эхлээд залбирах хэрэгтэй. Хүү минь надтай хамт өвдөг сөхрөхгүй юм уу?

Түүний оронд асаагуурьш шингэнийг өмдөн дотроо асгаад өөрийнхөө төмсөгийг шатаасан

дээр гэж Жижгээ боддог боловч мэдээж Жижгээ гадагш хэлсэгтгүй.

-Бурхантай ганцаараа нүүр тулан ярилцвал түүний хариултыг тод сонсоно гэж эцэг маань хэддэг юм.

-Тийм дээ хүү минь, энэ их ажил хэрэгч зөвлөгөө байна.

Рэндолфыг дахиад юм хэлэхээс урьтан Жижгээ өрөөнөөс гарч дараа нь цагдаагийн газрыг орхив. Тэр эгнэгт аддсан найз охидыгнхоо араас гашуудаж бас шинэ найз олж чадах эсэхээ тааж ядан гүн бодолд автсаар гэрээ зүглэв. Нэг бус найз охинтой болбол зүгээр юмсан.

Бүрхүүл дор юм юм л болно доо.

15

Рэндолф залбирахыг оролдсон ч тэс ондоо бодлууд түүнийг эзэмдэх ажээ. Түүнээс гадна өөрөө өөртөө тусалдаг тэр хүнд л бурхан тусалдаг билээ. Библи сударт ингэж бичсэн эсэхэд тэр итгэлтэй биш байсан ч энэ бол үнэн гэдгийг ян тан мэднэ. Тэр хананд байрлуулсан мэдээллийн самбар дээр хадсан жагсаалтаас Сандерсын гар утасны дугаарыг аваад залгалаа. Хариу ирэхгүй байх гэж найдсан ч дөнгөж ганц дуудангуут Эндигийн дуу хадав... Хульхи хууль гэдэг энэ нгүү дээ. Ойлгомжтой хэрэг.

-Энди сайн уу? Надад чамд дуулгах эмгэнэлтэй мэдээ байна. Чи эхлээд суучих.

Их хэцүү яриа болж өнгөрөв. Хэрэв шударга хэлэх юм бол бүр аймшигтай яриа. Ярьж дуусаад Рэндолф ширээн дээр хуруугаар бөмбөрдөв. Яг энэ тохиолдолд Герцог Перкинс ширээндээ сууж байсан бол би гомдохгүй байсан даа гэж тэр дахин бодлоо. Огтхон ч гомдохгүй байсан. Энэ бүхэн түүний төсөөлж байснаас хавьгүй хүнд хэцүү бохир ажил байлаа. Тусдаа өрөөтэй байлаа гээд одоо түүний үүрч байгаа ачаатай харьцуулах юм биш. Тэр бүү хэл даргын ногоон тэрэг ч энэ ачаатай дүйцэхгүй. Тэр жолооны ард сууж түүний өгзөг герцогийн илүү хүнд жинтэй өгзөгнөөс үлдсэн хонхорхой руу шигдэх тоолонд толгойд нь "Чи энэ суудалд тохирохгүй" гэсэн бодол харвана.

Сандерс аль хэдийн наашаа гарчээ. Тэр Барбаратай нүүр тулж уулзахыг хүсэв. Уг нь Рэндолф түүнийг ятгах гэж оролдсон. Одоо бурхан тэнгэрээс энэ хүнд ачааг дааж гарах хүч чадал хайрлах ба бас эхнэр охин хоёрынхоо сүнсийг тайтгаруулахын тулд өвдөг сөхөрч суух ёстой цаг гэж ятгасан ч Энди утсаа шууд тасалчихсан.

Рэндолф санаа аддаад өөр дугаар руу залгав. Хоёр дуудсаны дараа Том Жимийн цухалдангуй дуу түүний чих рүү хатгалаа.

-Юу вэ? Юу гээд байгаа юм бэ?

-Би байна аа, Жим. Чиний ажиллаж байгааг би мэднэ. Чамайг ажлаас чинь салгахыг хүсэхгүй байна. Гэвч чи наашаа ирж чадах уу? Надад тусламж хэрэгтэй байна.

Өсвөр насны гурван хүү үд дундаас хойшхи хурц нарны гэрэлд шаргалтах тэнгэрийн дор

зогсоод утасны шонгийн дэргэд гулдайх үхсэн баавгайг харцгаана. Шон хазайжээ. Шон дээр газраас дөрвөн фут өндөрт зомгол сэрдийх ба цусанд будагджээ. Бас өөр ямар нэг юм байв. Цагаан өнгөтэй. Ясны хэлтэрхийтэй төстэй. Бас нэг саарал хөвсгөр зүйл байв. Тархи бололтой...

Жо нүд буруулаад бөөлжих рефлексээ хянах гэж оролдов. Тэр бараг ингэж чадаад байтал Бенни чанга хахаж цацан бөөлжсөн ба Норри ч түүний жишээг дагав. Мэдээж Жо тэдэнтэй нийлэхээс аргагүй болжээ.

Тэд жаахан дотор онгоймогц Жо үүргэвчээ мулталж нээгээд уяаг тайлж дотроос нь гурван лонхтой ундаагаа гаргаж тараалаа. Эхлээд нэг балгаж амаа зайлаад тургив. Бенни Норри хоёр ч түүнийг давтлаа. Дараа нь бүгд ууж гарав. Амтаг цай мэдэгдэхүйц халсан байсан ч хатсан хоолойнд бол шидэт ундаа гэсэн үг.

Норри шонгийн ёроолд хэвтэх ялаа шавсан хар гулууз мах руу болгоомжтой алхав.

-Бухтай тохиолдсонтой адилхан түүх. Хөөрхий амьтан дээрээс нь үсрэх эргээ олсонгүй. Тэгээд утасны шон мөргөж тархиа хагалжээ.

-Эсвэл тэр галзуурсан юм болов уу? Буганууд ч бас галзуурсан байж болно гэж Бенни сөөнгө дуугаар санаагаа хэлэв.

Ийм юм байх боломжтой ч магадлал тун бага гэдгийг Жо дотроо бодлоо.

-Энэ амиа хорлолтуудын тухайд гэвэл миний бодол ийм байна гэж тэр яриагаа эхэллээ. Тэр хоолойгоо чичрэхийг үзэн яддаг боловч өөрөөр ярьж чадсангүй.

-Халим ба далайн гахайнууд ийм юм хийдэг. Тэд эрэг дээр үсэрч гардаг юм. Би зурагтаар үзсэн. Найман хөлт ч бас тэгдэг гэж аав хэлсэн.

-Наймаалж гэж Норри түүний үгийг заслаа.

-Юу гэж нэрлэх нь хамаагүй. Ямартаа ч амьдрах орчин нь бохирдох юм бол тэд тэмтрүүлээ тас хаздаг гэж аав хэлсэн.

-Хүн гуай та намайг дахиад бөөлжүүлмээр байна уу? гэх Беннигийн дуу ядарсан бас цухалтай сонсдов.

-Энд яг ийм юм болж байна гэх гээд байна уу? Хүрээлэн буй орчин бохирдсон гэж үү? гэж Норри асуулаа.

Жо шарласан тэнгэр үү гараа сунгав. Дараа нь пуужингийн цохилтоос үүдсэн галын тортог суусан Бүрхүүл рүү, баруун өмнө зүг рүү заав. Толбоны өндөр хоёроос гурван зуун фут, өргөн нь миль орчим байлаа. Түүнээс ч том байж мэднэ.

Тэхдээ энэ чинь өөр шүү дээ. Тийм биш гэж үү? гэж Норри тайлбарлав.

Жо мөрөө хавчив.

-Тэгвэл бидэнд ч бас гэнэт амиа хорлох хүчтэй хүсэл төрж мэдэх юм байна. Ингэхэд буцвал яасан юм бэ? Яагаад гэвэл би амьдармаар байна. Би "Вархаммер"-ыг ялж чадаагүй байгаа шүү гэж Бенни гунигтай хэллээ.

-Гейгерийн тоолуурыг баавгай дээр туршвал яасан юм бэ? гэж Норри санал гаргав.

Жо хоолойг гулууз мах руу чиглүүлэв. Зүү тэг рүү хөдлөөгүй ч дээшээ бас хөдөлсөнгүй.

Норри дорно зүг рүү заалаа. Тэдний өмнөх зам хар царс модон төгөлөөс сугаран гарчээ. Эндхийн нэрийг үүнээс үүдэн өгсөн бололтой. Модон доороос гарах юм бол Блэк-Риджийн оройд байдаг алимны цэцэрлэгийг харж болно гэж Жо бодов.

-Алив модон доороос гарцгаая. Тоолуур юу заахыг тэнд үзье. Хэрэв зүү дээшлэх юм бол бид хот руу эргэж очоод Расти эмч юмуу эсвэл тэр Барбарад, эсвэл хоёуланд нь хэлье. Тэд өөрсдөө учрыг нь олог гэж Норри Жо-гийн бодлыг тааж унших мэт хэллээ.

Беннигийн царайд эргэлзээ тодров.

-Ёстой мэдэхгүй юм даа.

-Хэрэв бид ямар нэг хачин мэдрэмж төрөх юм бол шууд буцах болно гэж Жо дундуур нь шийдвэр олов.

-Хэрэв энэ зүйл тус болно гэж үзэх юм бол бид хийх ёстой. Бүх юм дуусахаас өмнө би Миллээс салмаар байна гэж Норри зүтгэв.

Тэр энэ нь наргиан гэж харуулах санаатай инээмсэглэсэн ч наргиантай огт төстэй сонсогдсонгүй. Жо хүртэл наргиан гэж хүлээж авсангүй. Милл хот хичнээн жижигхэн хот болох талаар олон хүн ярьдаг. Энд Жеймс Макмертригийн дуу тийм нэрд гарсан болохоор тэгсэн ч байж мэднэ. Бас өөр хүчин зүйл ч бий. Хотод ази гаралтай ганцхан хүн байдгийг тэр санав. Заримдаа номын санд Лиссад тусалдаг Памела Чен гэж бүсгүй бий. Лаверти Обурн руу явснаас хойш энэ хотод

хар арьстан нэг ч үлдээгүй. Макдональдс ч байхгүй. Тэр бүү хэл "Старбакс" ч байхгүй. Кино театр аль хэдийн хаагдсан. Гэвч урьд нь энэ хот түүнд их том санагддаг байжээ. Хорвоог таньж мэдэх газар энд хангалттай байв. Жо ээж аавынхаа хамт машиндаа суугаад Льюистон орж шарсан нялхан хорхой болоод мөхөөлдөс идэж чадахгүй гэдэг нь тодорхой болсоноос хойш Милл хот Жо-гийн тархинд гайхалтай агшиж жижгэрсэн билээ. Мэдээж хотод багагүй нөөц байгаа ч хэзээ нэгэн цагт дуусч таарна.

-Чиний зөв. Энэ их чухал. Аз турших л хэрэгтэй. Ямартаа ч би тэгж бодож байна. Хэрэв Бенни чи хүсэх юм бол эндээ үлдэж болно. Учир нь бидний ажлын энэ хэсэг жинхэнэ сайн дурын үндсэн дээр явагдах ёстой.

-Үгүй. Би та нартай хамт. Хэрэв та нараас хоцрох юм бол та нар намайг нохойтой жиших

болно.

-Аль хэдийн жишчихсэн юмсан гэж Жо Норри хоёр зэрэг хэлээд бие бие рүүгээ харж инээлдэв.

17

-Чиний уйлах чинь зөв. Уйл уйл.

Энэ дуу их холоос сонсдов. Барби дуу гарсан зүг рүү хандсан ч шатах мэт хорсох нүдээ нээж чадсангүй. -Чамд уйлах шалтгаан олон бий.

Энэ үгийг хэлж байгаа хүн өөрөө уйлж байгаа бололтой. Хоолой нь их танил сонсдов. Барби түүн рүү харах гэж оролдсон ч зовхи нь хавдаж даагдахгүй болжээ. Нүд нь зүрхний цохилтын хэмнэлээр лугшина. Хамрын хөндий битүүрч, шүлсээ залгих тоолонгоор чих нь дүнгэнэнэ.

-Чи яагаад түүнийг алсан юм бэ? Чи яагаад миний охиныг алав?

"Хэн нэгэн жингэрийн хүү над руу "Мейсом цацаж ухаан алдуулсан. Фредди бил үү? Үгүй. Рэндолф юм байна".

Барби хөмсөг дээрээ алгаар дарж зовхио дээш нь татаад сая нэг нүдээ харахтай болов. Хорих өрөөний үүдэнд Энди Сандерс зогсч байхыг олж харлаа. Хацрыг нь даган нулимс урсана. Сандерсын нүдэнд юу харагдсан бэ? Мэдээж хорих өрөөнд сууж байгаа хүн. Тэгвэл хорих өрөөнд сууж байгаа хүн бусдын нүдэнд дандаа л буруутай харагддаг хойно доо.

-Миний охин бол надад байсан ганц эрдэнэ байсан гэж Сандерс хашгирав.

Рэндолф түүний цаахан талд зогсох бөгөөд бие засах газар руу явуулахыг гуйж зүрхлэхгүй 20-иод минут болж байгаа жаалхүүгийн адил хөлөө ээлжлэн сойх бөгөөд царай нь ихэд тааламжгүй харагдана. Хэдийгээр нүд нь хорсож, хамар нь битүүрч байсан ч, Рэндолф Сандерст хонгил руу буухыг зөвшөөрсөнд нь Барби гайхсангүй. Энди Сандерс бол хотын захиргааны нэгдүгээр гишүүн. Тэгэхээр цагдаагийн дарга түүнд үгүй гэж хэлэх боломж бараг байхгүй.

-За болно доо Энди. Хангалттай. Чи түүнийг харахыг хүссэн. Хэдийгээр энэ дүрэм журмын дагуу биш боловч би зөвшөөрсөн. Тэр байх ёстой газраа, торны цаана байна. Тэр хийсэн бүхнийхээ төлөө хариуцах болно. Одоо дээшээ гарцгаая. Би чамд цай аягалъя гэж Рэндолф ам нээлээ.

Энди Рэндолфыг заамдаж авав. Хэдийгээр цагдаагийн дарга түүнээс 4 дюйм өндөр байсан ч айсан харагдана. Барби өтгөн улаан манангийн цаанаас хорвоог харж байгаа хэдий ч Эндигийн дотор дүрэлзэн асах хорсол заналыг үзэж байв.

-Алив, гар буугаа надад өг. Түүнийг гтгүүнэ гэдэг их хүндэтгэл үзүүлсэн хэрэг. Тэр яаж ийгээд л мултарчихна. Тэр чинь дээгүүр найз нөхөдтэй хүн. Жим тэгж хэлсэн. Би түүнтэй тооцоо бодох ёстой. Би түүнтэй тооцоо бодох эрхтэй. Тэгэхээр гар буугаа өгөөд аль.

Хотын удирдлагын таалалд нийцүүлэх Рэндолфын хүсэл тиймдээ тулгал өссөн гэж Барби бодохгүй байв. Барбиг борооны торхонд орсон харх бууддаг шиг буудах боломж олгож гар буугаа Эндид өгчихнө гэдэгт эргэлзэж байсан ч бүрэн итгэлтэй биш байлаа. Хэрэв Рэндолф Сандерсыг ганцааранг нь энэ доошоо дагуулж ирсэн юм бол зөвхөн түүний таашаалд нийцүүлэхээс ондоо өөр ямар нэг шалтгаан байж таарна.

Барби арай гэж хөл дээрээ босов.

-Ноён Сандерс хэмээн ярьж эхэллээ. "Мейсом" ам руу ч бас оржээ. Хэл ба хоолой нь хавдсан байв. Тэр ярих биш хяхатнаж байлаа.

-Би танай охиныг алаагүй ноёнтон. Би хэнийг ч алаагүй. Хэрэв та энэ тухай бодож үзэх юм бол танай найз Реннид золиосонд гаргах хүн хэрэгтэй байгааг ойлгоно. Би хамгийн тохиромжтой нь...

Харин Энди энэ тохиолдолд юу ч бодох сөхөөгүй байв. Тэр шууд л Рэндолфын гар бууны хуйнаас зуурч бууг сугалах гэж оролдлоо. Айж сандарсан цагдаагийн дарга буугаа байх ёстой газарт нь үлдээх гэж хамаг хүчээрээ тэмцэв.

Яг энэ үед аварга том гэдэстэй эр хүн шатаар бууж ирлээ. Хэдийгээр лагс биетэй боловч хөнгөн шингэн тэр бүү хэл уран гоёмсог хөдлөх ажээ.

-Энди. Энди найз минь над дээр ир гэж Том Жим хонгилоор нэг хадаав.

Тэр хоёр гараа дэлгэжээ. Энди гар буутай тэмцэлдэхээ болиод уйлсан хүүхэд эцэг рүүгээ гүйдэг шиг Ренни рүү ухасхийв. Том Жим түүнийг тэврэн авлаа.

-Надад гар буу хэрэгтэй. Надад гар буу өг. Жим ээ, одоо өг. Яг одоо өг. Түүнийг хийсэн хэргийнх нь төлөө би буудаж ална. Эцэг хүний хувьд би ийм эрхтэй. Тэр миний бяцхан охиныг алчихжээ гэж Энди нус нулимсаа цувуулан Том Жимийн нүд рүү харангаа зогсолтгүй бувгнана.

-Ганцхан түүнийг биш шүү дээ. Магадгүй тэр Энжи, Лестер ба хөөрхий Брендаг ч алсан.

Үүнийг сонсоод Энди хэл нь татах шиг боловч. Тэр Том Жимийн махлаг нүүр рүү юу ч ойлгоогүй шинжтэй гөлөрлөө. Яг л элэгдүүлсэн хүн шиг.

-Чиний эхнэрийг ч бас. Герцогийг. Майра Эвансыг. Ер нь бүгдийг нь.

-Юу...

-Бүрхүүл хэн нэгний хичээл зүтгэлээр бий болсон шүү дээ. Эсвэл би буруу яриад байна уу?

-Тийм байх... гэхээс өөр Эндид хэлэх үг олсонгүй. Гэвч Том Жим хариултыг хүлээж авсан маягтай толгой дохилоо.

-Үүнийг хийсэн хүмүүс энд өөрийн гэсэн хүнтэй байгаа гэж надад бодогдоод байна. Үймээн

самуун зохион байгуулах хүн. Тэгвэл түргэн хоолны тогоочоос өөр хэн энэ дүрд хамгийн сайн тохирох вэ? гээд Эндиг мөрөөр нь тэвэрч Рэндолф дарга руу очлоо. Том Жим Барбигийн улайж хавдсан царай руу өмнөө ямар нэг үл таних шавьж байгааг харах аятай ширтэв.

-Бид баталгаа нстолгоог олно. Би үүнд эргэлзэхгүй байна. Ямартаа ч тэр ул мөрөө арилгах ухаангүй болох нь харагдсан. Барби Рэндолф руу ширтэнэ.

-Энэ бол зохион байгуулсан занга. Энэ бүхэн Ренни өгзөгөө хаацайлах хэрэгцээ гарсанаас эхэлсэн байх. Харин одоо бол эрх мэдлийн төлөө тэмцэл явагдаж байна. Цагдаагийн дарга та одоохондоо түүний хувьд хэнээр ч солынгүй хүн. Гэвч солих хүн олдмогц тэр танаас салах л болно гэж Барби хэллээ. -Дуугаа тат гэж Рэндолф хашгирав.

Ренни Эндигийн үсийг илнэ. Тэдний кокер-спаниэль үүлдрийн Мисси нохой хөгширч зөнөөд шээсээ барьж чадахаа больсон үед ээж нь дандаа ингэж илдэг байсныг Барби гэнэт санав.

-Энди тэр хийсэн бүхнийхээ төлөө хариуцах болно. Гэвч эхлээд бид тодруулах хэрэгтэй байна. Хэзээ, хаана, юу, яагаад, бас энэ бүхэнд хэн оролцож байгааг. Яагаад гэвэл тэр ганцаараа биш. Би ингэж мөрий тавиад сүүлчийн шүдээ өгөхөд ч бэлэн байна. Түүнд хамсаатнууд бий. Тэр төлбөрөө хийх болно. Гэвч бид эхлээд түүнээс бүх мэдээллийг шахаж гаргах хэрэгтэй.

-Ямар үнээр? Тэр ямар үнээр төлбөр хийх юм бэ? гээд Энди хэлэх үт бүрийг нь шунамхай сонсон Том Жим рүү харна.

-Яахав дээ. Хэрэв тэр Бүрхүүлийг яаж зайлуулахыг мэдэж байвал, тийм байж болзошгүй гэж би бодож байна, хэрэв тийм бол бид түүнийг Шоушенк шорон руу илгээнэ. Цагаас өмнө суллагдах эрхгүйгээр бүх насаар нь хорих болно.

-Энэ хангалтгүй гэж Энди шивнэв.

Ренни түүний толгойг илсээр байлаа.

-Хэрэв Бүрхүүл алга болохгүй бол яах вэ? Тэгвэл бид түүнийг өөрсдөө шүүх хэрэг гарна. Буруутайг нь нотлоод бид түүнийг цаазлана. Энэ чамд илүү таалагдаж байна уу? гээд инээлээ.

-Хавьгүй илүү гэж Энди шивнэв.

-Найз минь надад ч бас. Надад ч бас гээд Том Жим түүний толгойг илсээр байв.

Тэд Блэк-Риджийн оройд байх алимны цэцэрлэг рүү дээш өлийн харсаар ойгоос зэрэгцэн гарч ирээд зогтуслаа.

-Тэнд ямар нэг юм байна. Би харж байна гэж Бенни дуу алдав. Түүний дуунд сэтгэл хөдлөл илэрч байсан ч харин Жо-д бол нэг л хүйтэн хөндий дуугарах шиг санагдав.

-Би бас харж байна. Энэ нэг юмтай төстэй, нөгөө... нөгөө... гэж Норри дэмжив. Уг нь тэр "радио цамхаг" гэж хэлэхийг хүссэн боловч хэлж чадсангүй. Тэр зөвхөн элсэн дээр тэрэг түрэн тоглож байгаа жаалхүү шиг "rrr-rrr" гэж дуугарч амжлаа. Дараа нь унадаг дугуйн дээрээсээ тэрийн унав. Зам дээр тэрийгээд гар хөл нь салгалж гарлаа.

-Норри гэж Жо хашгираад тэр айж түгшсэн гэхээсээ илүү гайхсан харцаар эхлээд охиныг, дараа нь Бенниг харав. Тэр хоёрын харц нэг уулзалдаад дараа нь Бенни ч бас газарт унасан бөгөөд унадаг дугуй нь дагаж ойчлоо. Хөл нь мөн л татваганаж эхлэхдээ сагсыг хажуу тийш өшиглөж орхив. Гейгерийн тоолуур сагснаас суга үсэрч нүүрээрээ доош харан уналаа.

Жо тийшээ алхаж гараа сунгалаа. Гар нь резин шиг сунаад байх мэт санагдав. Шар өнгийн багажийг эргүүлэв. Зүү нэмэх 200 хүртэл зааж, улаан бүсийн хязгаар дээр иржээ. Тэр дөнгөж үүнийг харж амжаад дараа нь дөлийн ягаан хэл дүүрсэн хар нүх рүү ойчих шиг болов. Дөлийн хэл оршуулгын цац суварга хэлбэртэй өрсөн тоо томшгүй олон овоолоостой хулуунаас бүрдэх ажээ. Айж алдарсан дуу хоолойнууд хаа нэгтээгээс сонсдов. Дараа нь Жо-г харанхуй нөмрөн авлаа.

19

Жулия их дэлгүүрээс "Ардчилал"-ын редакци руу ирэхэд урьд нь спортын сурвалжлагч байгаад одоо мэдээний хэлтэсийг тэр чигээр нь хариуцах болсон Тони Гуэй нөүтбук дээрээ ямар нэг юм шивж суув. Жулия түүнд аппаратаа өглөө.

-Наад хийж байгаа юмаа орхиод энэ гэрэл зурагнуудыг хэвлээдэх.

Ингэж хэлээд өөрөө нийтлэл бичихээр компьютерийн ард суулаа. Төв гудамжаар явж байхдаа нийтлэлээ юу гэж эхлэхийг толгойдоо бясалгаж байсан юм. "Хүнсний ертөнцийн захирал асан Эрни Кэлверт хүмүүсийг албаны хаалгаар орохыг уриалсан. Хаалгыг нээчихсэн гэж хэлэв. Гэвч хожимджээ. Үймээн самуун хүчээ авсан байлаа". Энэ эхлэл түүнд таалагдаж байв. Гол асуудал нь тэр бодсоноо шивж чадахгүйд оршино. Хуруунууд нь яагаад ч юм өөр товчийг очиж дараад байв.

-Дээшээ гарч жаахан хэвтээч дээ гэж Тони хэллээ. -Үгүй. Би бичих ёстой...

-Чи ийм байдалтайгаар юу ч бичиж чадахгүй. Чи яг л салхинд өртсөн навч шиг салгалж байна. Энэ бол айдсаас үүдсэн саатал. Ганц цаг хэвт. Би гэрэл зурагнуудыг гаргаад чиний компьютер руу хийчихнэ. Чиний тэмдэглэлүүдийг тайлаад уншчихна. Дээшээ гар.

Хэдийгээр энэ үгс Жулияд таалагдахгүй байсан ч тэр үнэнийг хэлж байна. Тэгээд явж хэвтсэн бөгөөд харин ганц бус цаг өнгөрчээ. Тэр баасан гаригаас хойш нойр авч чадаагүй. Түүнээс хойш эрин зуун өнгөрсөн мэт санагдана. Тэгээд Жулия толгой дэрэнд хүрмэгц гүн нойронд автлаа.

Сэрээд унтлагын өрөөнд аль хэдийн сүүдэр татсаныг харж ихэд сандрав. Орой болсон бололтой. Горасыг салхинд гаргаагүй. Аль нэг буланд очоод шээчихсэн байх даа. Тэгээд одоо өөрөө хэдийгээр буруугүй боловч эзэн рүүгээ буруутай нүдээр харах болно. Энэ бол

бүхлээрээ миний л буруу.

Пүүзээ өмсч гал тогоо руу яаран очвол нохой нь хаалганы дэргэд гийнах биш харин зуух хөргөгч хоёрын хоорондох хэвтэр дээрээ тайван унтаж байх юм. Ширээн дээр үнсний саваар дарж орхисон зурвас байв.

15.00. Жулия

Пит бид хоёр их дэлгүүрийн тухай нийтлэлийг хамтдаа бичлээ. Шилмэл бүтээл биш нь ойлгомжтой. Гэвч чиний мастерын гар илээд өнгөрөхөд тийм болно. Чи бас өмнөх үг бичих ёстой гэж тэр хэлсэн. Чиний дарсан гэрэл зургууд муугүй шүү. Ромми Берпи ороод гарсан. Түүнд цаас хангалттай тул энэ тал дээр санаа зовох хэрэггүй гэж тэр хэлсэн. Болсон явдлын тухай титэм үг бичихийг тэр бас хүссэн. Тэр их дэлгүүрийг хаасан талаар "Ямар ч шаардлагагүй шийдвэр. Бас ямар ч цагаа олоогүй алхам. Тэд хэрэв бүх юм яг ийм болоосой гэж хүссэн тохиолдолд ингэх байсан. Би ийм байж болохыг үгүйсгэхгүй. Би Рэндолфын талаар ярьж байгаа юм биш " гэж тэр хэлсэн. Пит бид хоёр ч титэм үг байх ёстой гэдгийг зөвшөөрч байна. Гэвч нотолгоо цуглахыг хүлээх хэрэгтэй. Бас чи титэм үгсийг байх ёстой хэмжээнд нь бичихийн тулд нойр авах ёстой гэдэг дээр бид санал нийллээ. Дарга аа, таны нүдэн доор зовхи биш чөмөдөн байсан шүү. Би эхнэр хүүхэдтэйгээ багахан хамт байхаар гэр рүүгээ явлаа. Пит цагдаагийн газар руу явчихсан. Тэнд нэг их чухал юм болсон гэх юм. Яг юу болохыг тодруулахаар явчихсан.

Тони.Г

Нээрээ би Горасыг салхийд гаргачихсан. Тэр ажлаа амжуулсан шүү.

Горас нохой нь түүнийг амьдралынхаа нэг хэсэг гэдгийг бүү мартаасай гэсэндээ Жулия нохойгоо сэрээж тал хиамаар хооллов. Дараа нь доошоо бууж ирлээ. Тэр Тони Пит хоёрын санал болгосон титэм үгс бичих ба нийтлэлийг нь засахаар явж байна. Дөнгөж компьютерийн ард суухад гар утас нь дуугарав.

- "Ардчилал" сонин. Шамуэй байна.

- Жулия чи ийшээ ирвэл дээр байх. Марти Арсено жижүүрт байна. Тэр намайг нэвтрүүлэхгүй байна. Тонил гэж хөөсөн. Тэр чинь цагдаа биш биз дээ? Уг нь зун цагт тээврийн хөдөлгөөн зохицуулж цагдаагаас хэдэн төгрөг тоншдог тэнэг бүдүүн энэ амьтан одоо хамгийн мундаг цагдаа шиг л аяглаж байна.

- Пит би маш их ажилтай байна. Тиймээс... - Бренда Пэркинс үхсэн байна. Бас Энжи Маккейн, Доди Сандерс...

- Юу гэнэ ээ? гээд бүсгүй үсрэн босоход сандал нь хойшоо уналаа.

- Бас Лестер лам. Бүгдийг нь алчихжээ. Чи анхааралтай сонс. Эдгээр аллагад Дейл Барбараг буруутган баривчилсан юм байна. Тэр хорих өрөөнд, хонгилд байгаа.

-Би очлоо.

-Чөтгөр ав. Энди Сандерс ирж явна. Чөтгөрийн нүднээс нь нулимс тасралтгүй бөмбөрч байна. Түүнд асуулт тавиад үзэх үү, яах вэ?

-Хэрэггүй. Энэ хүн гурав хоногийн өмнө эхнэрээ алдсан. Одоо охиноо алдчихлаа. Бид "Нью-Йорк пост" биш шүү. Би одоо очлоо.

Тэр Питийн хариуг сонсолгүй утсаа таслав. Эхэндээ сэтгэл нэг их догдлохыг мэдэрсэнгүй. Тэр бүү хэл редакцийн хаалгыг цоожлох ёстойгоо ч санав. Гэвч тамхины өнгөтэй тэнгэр дор халуун агаарт явган хүний зам дээр гарч ирсэн хойноо тайвширал нь хийсэн одоод гүйж гарлаа.

20

Жо, Норри, Бенни нар нэг л хачин сийрэг шингэн болсон нарны туяан дор Блэк-Ридж зам дээр хөл гар нь таталдан хэвтэцгээнэ. Халуун бүгчим агаар тэднийг бүрхэн жигнэнэ.

Амиа хорлох тал дээр ямар нэг оролдлого огт үл хийх хэрээ харин цахилгааны утсан дээр суугаад гялалзсан ухаалаг нүдээр тэднийг ширтэх ажээ. Тэгснээ чанга гуагалаад далавчаа дэвэн үдээс хойшхи цагийн нэг л хачин агаар руу нэвт нисэн одов.

-Хэллоуин гэж Жо бувгнана.

-Тэднийг хашгирахыг болиулаад өгөөч гэж Бенни гасална.

-Нар алга. Нар байхгүй болсон. Бурхан минь нар байхгүй болчихлоо гэж Норри агаар залгилаан уйлах ажээ.

Харин тэртээ дээр, Честерс-Милл хот тэр чигээрээ алган дээр тавьсан мэт харагддаг алимны цэцэрлэгт улбар ягаан хурц гэрэл анивчих ажээ.

15 секунд тутамд гялсхийн анивчина.

21

Удтал унтсанаас болж нүүр нь хавдаж, үс нь ардаа арзайсан Жулия цагдаагийн хэсгийн шатаар гүйн гарав. Пит түүн рүү дөхөж ирэхэд бүсгүй толгой сэгсрээд:

-Чи эндээ үлдсэн нь дээр. Би ярилцлага авах хэрэг гарвал чамайг дуудна гэлээ.

-Би өөдрөг сэтгэлгээнд дуртай. Гэвч тийм юм болно гэж бодохгүй байна. Эндигийн араас хэн ирсэн гэж бодож байна даа гэснээ Пит гал сөнөөх хоолойн урд тавьсан "хаммер" машин руу заав. Машины дэргэд Линда ба Жекки хоёр яриандаа бүрэн татагдсан шинжтэй зогсоцгооно. Тэр хоёр эмэгтэй маш их сэтгэл хөдөлсөн нь эндээс ч мэдрэгдэж байлаа.

Цагдаагийн хэсэгт орж ирээд Жулияг хамгийн түрүүнд гайхахад хүргэсэн зүйл нь бүгчим

халуун байв. Цахилгаан хэмнэх үүднээс агаар хөргүүрийг салгасан бололтой. Түүний дараа энд хуран цугларсан залуус гайхал төрүүллээ. Тэнд ах дүү Кильян нар ч байна. Түнжин толгой ба дэгээ хамраар нь тэднийг хэн ч алдалгүй таньдаг. Залуучууд ямар нэг хүснэгт бөглөх ажээ.

-Хэрэв хамгийн сүүлд ажиллаж байсан газар гэж огт байхгүй бол яах вэ? хэмээн нэг нь нөгөөгөөсөө асууна.

Харин тэртээ дороос Энди Сандерсын цурхиран уйлах ба хэн нэгний хашгирах дуу сүлэлдэн сонсогдоно.

Жулия цэлгэр хонгилын дундуур гарч доод давхар руу хөтлөх шатыг чиглэв. Тэр энд олонтаа ирж байсан. Тэр бүү хэл кофе ба нарийн боовны санд мөнгө хуримтлуулж явсан.

Түүнийг урьд нь хэн ч зогсоож байсангүй. Харин энэ удаад Марти Арсено түүнийг зогсоов.

-Хатагтай Шамуэй, та тийшээ явж болохгүй. Ийм тушаалтай.

Түүний дууны өнгөнд буулт хийсэн, уучлал гуйсан өнгө аяс тодрох нь Питийг эндээс хөөх үед байсантай огт адилгүй.

Яг энэ үед том Жим Ренни ба Энди Сандерс хоёр "тахяны саравч"-наас гарч ирэв. Миллийн цагдаагийн хэсгийн ажилтнууд хонгилоо ингэж нэрлэдэг. Энди уйлж байлаа. Том Жим түүнийг тэврээд тайтгаруулах өнгөөр ямар нэг юм ярина. Питер Рэндолф тэдний араас гарч ирэв. Цагдаагийн даргын өмсгөл яг л ёслолын жагсаалд оролцох гэж байгаа мэт харагдах боловч царай нь бөмбөг дэлбэрэлтээс золоор амьд гарсан хүнийг санагдуулна.

-Жим. Питер. Би "Ардчилал" сониндоо зориулан та нартай ярилцмаар байна гэж Жулия тэдэнд хандлаа.

-Том Жим түүн рүү эргэж хоромхон хугацаанд хяламхийв. Түүний харцанд халуун тамд орсон нүгэлтнүүд мөстэй ус уусанд гайхсан мэт тийм харц илэрлээ. Дараа нь тэр Эндиг дагуулан даргын өрөөг чиглэсэн ба замдаа одоо залбирах хэрэгтэй хэмээн ярих ажээ.

Жулия жижүүрийн ширээний хажуугаар шурдхийх гэж оролдов. Марти буруутай царайлан түүний гараас шүүрлээ.

-Марти чи өнгөрсөн жил эхнэрийнхээ хэрүүл маргааны тухай юу ч бичихгүй байхыг надаас гуйсан. Би ч бичээгүй. Яагаад гэвэл чи ажилгүй болох байсан. Тэгэхээр хэрэв чи хүний ач тусыг санадаг л юм бол намайг тавь гэж Жулия түүнд санууллаа.

Марти түүний гарыг тавив.

-Би чамайг зогсоох гэж оролдсон боловч чи үгэнд ороогүй шүү. Ингэж санаж ав гэж Марти шивнэлээ. Жулия Ренни нарын араас дагав.

-Уучлаарай. Рэндолф дарга та хоёр хотын түшмэд учраас надтай ярилцах ёстой гэж тэр Том

Жимд хандав.

Энэ удаад Том Жимийн харцанд уур хилэн ба зэвүүцэл тодорлоо.

-Үгүй. Бид чамтай ярилцахгүй. Чи энд байх эрхгүй. -Тэгвэл тэр эрхтэй юм уу? Хэрэв миний Додигийн тухай сонссон үнэн бол тэр хонгил руу буух ямар ч эрхгүй гэж хэлээд Жулия Энди Сандерс руу заав.

-Энэ муу жингэрийн хүү миний хайртай охиныг алчихлаа гэж Сандерс чарлав.

Том Жим Жулия руу хуруугаар чичин:

-Чамд дэлгэрэнгүй танилцуулахад бэлэн болох үед чи бүгдийг мэдэх болно. Үүнээс эрт бол яасан ч үгүй.

-Би Барбаратай уулзмаар байна.

-Тэр дөрвөн хүний амины хэргээр баривчлагдсан. Чи арай солиороогүй биз дээ?

-Түүний хэрэг гэж таамаглаад буй хохирогчдын нэгний эцэг түүнтэй уулзсан бол би яагаад болохгүй гэж?

-Яагаад гэвэл чи хохирогч юмуу хохирогчийн хамаатан биш гэж хэлэх үед Том Жимийн дээд уруул сөхөгдөж шүд нь ярзайв.

-Түүнд өмгөөлөгч байгаа юу?

-Үүгээр бидний яриа дууслаа. Эмэг...

-Түүнд ямар ч өмгөөлөгч хэрэггүй. Түүнийг дүүжлэх хэрэгтэй. Тэр миний хайртай охиныг алсан.

-Найз минь явъя. Бид залбирахдаа энэ тухай бурханд хэлнэ.

-Та нарт ямар нотолгоо байгаа юм бэ? Тэр хэргээ хүлээсэн юм уу? Хэрэв үгүй бол өөрөө энэ тухай юу гэж тайлбарлаж байна вэ? Түүний тайлбар үхэл болсон цаг хугацаатай ямар нийцэлтэй байна вэ? Ингэхэд та нар хүн бүрийн үхсэн цагийг тогтоосон уу? Хэрэв цогцосыг дөнгөж сая олсон юм бол яаж түүнийг ийм итгэлтэй буруутгаж чадна вэ? Тэднийг буудсан юм уу? Эсвэл хутгалсан юм уу? Эсвэл...

-Пит энэ чалчаа шулмасыг зайлуулаад өгөөч. Хэрэв тэр өөрөө явахгүй бол гаргаж хая. Бас жижүүрийн ширээний ард суугаа хүнийг ажлаас нь хал гэж Том Жим эргэж харалгүй хэлэв.

Марти царай нь хачин ярвайгаад нүдээ арчлаа. Том Жим Эндиг дагуулан арын өрөө рүү орж хаалгаа хаав.

-Түүнд ял тулгасан юм уу? Өмгөөлөгчгүйгээр ял тулгаж болохгүй гэдгийг чи мэднэ. Энэ хууль

бус явдал гэж Жулия Рэндолфоос асуув.

Хэдийгээр цагдаагийн дарга аюултай хүн биш ердөө л барьц алдсан хүн мэт харагдах боловч түүний хэлсэн үгнээс Жулиягийн зүрх зогсох шиг боллоо.

-Бүрхүүл байгаа цагт юу хуулийн дагуу ба юу хууль бус болохыг бид шийднэ.

-Тэднийг хэзээ алсан юм бэ? Ядаж үүнийг чи надад хэлж болно биз дээ?

-Хоёр бүсгүйг лав...

Өрөөний хаалга гэнэт нээгдэв. Том Жим хаалганы цаана үг бүрийг сонсч байсан гэдэгт Жулия эргэлзсэнгүй. Энди нүүрээ гараар таглан Рэндолфын ширээний ард сууна.

-Түүнийг эндээс зайлуул. Дахиж давтахыг хүсэхгүй байна гэж Том Жим бархирав.

-Та нар Барбараг бүрэн тусгаарлах ёсгүй. Бас энэ хотын оршин суугчдыг мэдээллээр хангахгүй байх эрхгүй гэж Жулия хашгирлаа.

-Чи аль аль тал дээр алдаж байна. Ингэхэд "хэрэв чи шийдлийн нэг хэсэг биш бол чи асуудлын нэг хэсэг" гэсэн хэлц үгийг сонсож байсан уу? Чи энд байснаараа юу ч шийдэхгүй. Чи хүн залхаасан самуун амьтан. Чи үргэлж тийм л байсан. Хэрэв чамайг явахгүй бол бид баривчлах болно. Энэ сүүлчийн анхааруулга.

-Сайн байна. Намайг баривчил. Хонгилд хорих өрөөнд суулгаад өг гээд тэр гав зүүхэд бэлэн байгаа аятай хоёр гараа бугуйгаар нийлүүлэн урагш сунгав.

Жим Ренни яг одоо түүнийг цохино гэж хоромхон зуур бодогдов. Ямар ч гэсэн түүний царайд ийм хүсэл тод байлаа. Гэвч тэр Рэндолфд хандаж:

-Би чамд сүүлчийн удаа хэлж байна. Энэ самуун дэгдээгчийг эндээс зайлуул. Эсэргүүцвэл чирч гарга гээд хаалгаа хаалаа.

Дөнгөж сая улайсгасан тоосго шиг өнгөтэй хацартай болсон Рэндолф түүнээс харц буруулан байж гарнаас нь барьж авав. Энэ удаад Жулия түүнийг эсэргүүцсэнгүй. Жижүүрийн ширээний хажуугаар гарах үед Марти уурласан гэхээс илүү гунигтай дуугаар түүнд хандав.

-Юу болсныг харав уу? Одоо миний суудлыг бөгс тохойгоо ялгахгүй энэ дээрэмчдийн нэг нь эзлэх болно.

-Марти чамайг халагдахгүй. Би түүнтэй ярилцана гэж Рэндолф түүнийг тайвшруулав.

Ганц хормын дараа Жулия нарны хурц гэрлээс нүд займчуулан гадаа зогсч байв.

-За юу болов? гэж Пит асуулаа.

Хамгийн эхлээд Бенни ухаан орлоо. Жаахан халууцахаас биш бүх юм хэвийн байв. Түүний ханхар бус бөгөөд хөлстэй нойтон цээжинд цамц нь наалджээ. Тэр Норри руу мөлхөж очоод мөрнөөс нь сэгсрэв. Охин нүдээ нээж түүн рүү харсан ч юу ч сэтгэхгүй байгаа нь илт. Хөлсөнд норсон хацарт нь үс нь наалджээ.

-Юу болсон бэ? Би унтсан бололтой. Ямар нэг юм зүүдэлсэн. Яг юуг санахгүй байна. Гэхдээ муу зүүд. Үүнийг яг мэдэж байна гэж тэр асуув.

Жо хөрвөөж доош хараад өвдөглөн өндийв.

-Жожо гэж Бенни дуудлаа. Тэр дөрөвдүгээр ангиас хойш найзаа ингэж дуудах болсон.

-Чи ямархуу байна даа?

-Хэвийн байна. Хулуу шатаад л байсан.

-Юун хулуу?

Жо толгой сэгсрэв. Санасангүй. Нэг л зүйлийг санана. Сүүдэрт сууж ундаа уумаар байна. Дараа нь тэр Гейгерийн тоолуурын талаар бодлоо. Сувагт унасан тоолуурыг гаргаж аваад урьдын адил хэвийн ажиллаж байгааг хараад сэтгэл хөнгөрөв. Хорьдугаар зуунд бүхнийг чанартай хийдэг байсан бололтой.

Тэр Беннид заалтыг харууллаа. Өнөөх нь нэмэх 200 хэвээр байв. Норрид бас харуулахыг хүссэн ч цаадах нь дээшээ Блэк-Риджийн оройд байгаа алимны цэцэрлэгийг ширтэнэ.

-Энэ одоо юу вэ? гээд тэр гараар заав.

Жо эхэндээ юу ч олж харсангүй. Дараа нь хурц улаан гэрэл гялсхийлээ. Маш хурц тул нүд нь гялбана. Хэсэг хугацааны дараа дахиад л гялсхийв. Гялсхийх хооронд ямар хугацаа өнгөрч байгааг мэдэхээр цагаа харлаа. Гэтэл цаг нь 16.02 дээр зогсчээ.

-Энэ бидний хайж байсан зүйл мөн гэж бодож байна. Эндээс зайлцгаая. Энэ новш биднийг ариутгах ч юмуу ямар нэг юм хийж мэднэ гээд Жо босов. Хөл нь мэдээгүй болж биеэ тулж дийлэхгүй гэж бодсон ч үгүй байжээ. Жаахан халууцахыг эс тооцвол бие нь сайн байв.

-Хүн гуай, хүүхдүүд хэнд хэрэгтэй юм бэ? Тэд яг бидэн шиг болж өсч мэднэ нгүү дээ гэсэн мөртлөө Бенни аль хэдийн унадаг дугуйгаа зайддав.

Тэд ирсэн замаараа буцлаа. Амрах юмуу хооллох гэж зогссонгүй. Гүүрээр гарч 119-р замд хүрэв.

Давс

1

Том Жимийн "хаммер" машины дэргэд зогсох хоёр эмэгтэй цагдаа урьдын адил ярилцсаар байв. Жекки цухалдан тамхи татах бөгөөд Жулияг хажуугаар нь гарах үед дуугаа хураав.

-Жулия хүүе... гэж Линда шийдэмгий бус дуудлаа.

Жулия тэдэн рүү эргэсэнгүй. Тэр уурандаа шатах бөгөөд одоо Честерс-Миллд тогтоод байгаа хууль цаазын нэг төлөөлөгчтэй ярилцахыг огт хүссэнгүй. Тэр "Ардчилал" хүрэх замын хагасыг туулаад байсан ч гэнэт нэг зүйлийг ойлгов. Хэдийгээр уур хилэн түүнийг эзэмдээд байсан ч шал өөр мэдрэмж дийлэн гарч ирлээ. Тэр номын дэлгүүрийн доошоо буусан төмөр хаалганы өмнө зогсчээ. (Шилэн хоргонд гараар бичсэн "дараагийн удирдамж ирэх хүртэл хаалттай" гэсэн зарлал өлгөжээ.) Тэр зүрхний цохилтоо намсгах гэхээс илүү өөрийнхөө дотор руу өнгийхийн тулд энд зогсов. Тийм ч их цаг шаардагдсангүй.

-Би юуны өмнө маш их айсан байна гэж хэлэх үедээ тэр өөрийн дуунаас давхийн цочив. Энэ үтийг тэр чанга хэлэхийг хүсээгүй юм.

Түүнийг Пит гүйцэж ирлээ.

-Чи зүгээр үү?

-Бүх юм сайн байна гэж Жулия худлаа хэллээ. Гэхдээ түүний хоолой үнэмшилтэй мэт байв. Гэхдээ царай төрх нь юу хэлж байгааг тэр мэдсэнгүй. Жулия үсээ хойш илэхийг хичээнэ. Үс нь тогтож өгөхгүй байв. Дахиад л арзайлаа. Үс хүртэл дөнгөж сая орноос боссон хүн шиг гэж тэр бодов.

-Ренни цагдаагийн шинэ даргад тушааж чамайг баривчлуулна гэж би бодсон гэж хэлэх үед Питийн нүд нь бүлтийж, гучаад наснаасаа хавьгүй залуу харагдав.

-Би ч бас тэгнэ гэж найдсан юм гээд Жулия үл үзэгдэх гарчигийг гараар тойруулан зурлаа. "Ардчилал" сонины хорих өрөөнд чихэгдсэн сурвалжлагч, хүн амины хэргийн яллагдагчаас ярилцлага авав"

-Жулия юу болоод байна вэ? Би Бүрхүүлийн тухай яриагүй байна. Тэр хүснэгт бөглөж байгаа залуусыг харсан уу? Нэг л аймаар.

-Би харсан. Тэгээд энэ талаар бичих санаатай байна.

Бүхний талаар бичих санаатай. Пүрэв гаригт болох хурал дээр зөвхөн би ч биш олон хүн Жим Реннид ноцтой асуулт тавих болно. Би тэдгээр аллагын тухай чадах бүхнийг тодруулаад энэ тухай бичнэ. Бас сонины оршил нь шийдэмгий бөгөөд хурц байх болно. Дураар аашлахыг уриалахгүй. Хэрэв хүмүүс дур мэдэн өөрсдөө шүүж эхлэх юм бол Жим Ренни энэ тал дээр давуу болно гэж тэр гунигтай инээмсэглээд Питийн гарнаас атгав.

-Би чиний юу яриад байгааг ойлгохгүй байна.

-Зүгээр дээ. Ажилдаа орцгооё. Надад биеэ хянахад ердөө хоёр минут хэрэгтэй. Дараа нь хэнтэй хамгийн түрүүнд ярилцах хэрэгтэйг тодорхойлно. Хэрэв бид өнөөдөр сониноо хэвлэнэ гэвэл цаг тун бага байна.

-Хувилагчаар хувилах уу?

-Юу гэнэ ээ?

-Өнөөдөр хувилагчаар сониноо хувилахыг хүсч байна.

Жулия түүн рүү цухалдан инээмсэглээд гараа даллан цааш нь явуулав. Редакцийн хаалган дээр ирээд Пит түүн рүү дахин эргэж харав. Жулия дахин гараа савж бүх юм сайн гэж харуулав. Тэгээд номын дэлгүүрийн тоостой хоргыг ширтсээр байлаа. Хотын төвийн кино театр хаалгаа бариад таван жил болж байна. Хотын гаднах авто кино театр түүнээс ч өмнө хаагдсан. (нэгэн цагт 119-р зам дээр том дэлгэц сүндэрлэж байсан тэр газарт одоо Реннигийн салоны нэмэлт зогсоол байрладаг) Гэтэл Рей Таул гэгч хүн жижиг дэлгүүрийг өнөө хүртэл амьдруулсаар байгаа. Хоргоны талыг нь төрөл бүрийн өөрөө сурах бичгүүд эзэлнэ. Харин хоргоны тэн хагаст хармаанд багтах хэмжээтэй номнууд байна. Тэдгээр номны хавгас дээр манан буданд хучигдсан эртний орд харшийн зураг, зовлонд автсан төрхтэй сайхан бүсгүйчүүд ба ханхар цээжээ нүцгэлж газарт бат тулан зогсох юмуу эсвэл морь унан давхиж байгаа сайхан залуусын зураг харагдана. Дээр дурьдсан залуусын зарим нь сэлэм далайсан байх ажээ. Хоргонд эдгээр номнуудыг дээр "Нууц хуйвалдаанд шимтээрэй" гэсэн бичиг өлгөсөн байв.

Жинхэнэ нууц хуйвалдаан болж байна даа.

Бидэнд Бүрхүүл багадсан юм шиг тамаас илгээгдсэн хотыгн захиргааны гишүүн бас гараад ирлээ.

Тэр юунаас хамгийн их түгшиж байгаагаа ухаарав. Юунаас хамгийн их айж түтшиж байна гэвэл эдгээр өөрчлөлтийн явагдаж байгаа хурд юм. Ренни урьд нь ч шувууны хашаан дахь хамгийн том ба хамгийн хэрцгий азарган тахиа байсаар ирсэн. Тэр хотод тогтоосон эрх мэдлээ бэхжүүлэхийг заавал оролдоно гэдгийг Жулия мэдэж байсан. Ертөнцөөс тусгаарлагдсанаас долоо хоногийн дараа юмуу сарын дараа. Гэтэл ердөө гуравхан хоног өнгөрөхөд ийм өөрчлөлт гарчихжээ. Кокс ба түүний эрдэмтэд энэ орой Бүрхүүлийг цооллоо гэж бодъё. Эсвэл Бүрхүүл алга болно гэж бодъё. Тэгвэл яах вэ? Том Жим тэр дороо л өмнөх хэмжээндээ хүртэл агшина. Гэхдээ тэр хариугаа өгч таарна.

-Хариулт нь ямар вэ? гэж Жулия "Нууц хуйвалдаан" гэсэн бичгийг харангаа өөрөөсөө асуув.

-Тэр зүгээр л хотын тусын тулд, тухайн үеийн нөхцөл байдлыг тооцон хөдөлсөн гэж хариулна. Бүгд түүнд итгэх болно.

Ренни ч бас яг ингэж бодож байгаа байх. Гэвч энэ бүхэн тэр яагаад ингэж яарч сандарсаны

тайлбар болохгүй.

Ямар нэг юм болохоо больж дээ. Тэгээд тэр хурдан хөдлөхөөс өөр аргагүй болсон. Тэгээд ч...

-Тэгээд ч түүний толгой хэвийн бус гэж би боддог гэж Жулия номнууд руу харан хэлэв.

-Энэ сая дөнгөж үүссэн юм биш.

Гэвч хэрэв энэ тал дээр ч Жулия алдаагүй юм бол гэрийнхэн нь харанхуй өрөөнд хоол хүнс дүүрэн овоолгоостой байгаа хүмүүс хотын их дэлгүүрийг дээрэмдсэнийг юу гэж тайлбарлах вэ? Энэ ямар ч утгагүй хэрэг. Гэхдээ хэрэв...

-Гэхдээ хэрэв Ренни энэ бүхнийг найруулаагүй бол шүүдээ.

"Сэрдэх дон" кафед цэнхэр тавганд аягалсан тухайн өдрийн хоол идэх нь тэнэг хэрэг үү? Эсвэл үгүй юу? (тухайн өдрийн хоол гэдэг нь рестораны үнээс хавьгүй хямд үнэтэй хоолыг хэлнэ). Хүнсний ертөнцийг түйвээхэд оролцсон хүмүүсээс сайтар асуух ёстой гэдгийг Жулия ойлгов. Тэд юу харсаныг тодруулах хэрэгтэй. Гэхдээ хүн амины хэрэг илүү чухал санагдана. Одоо тэр өөртөө сонинтой цорын ганц жинхэнэ сурвалжлагч болж үлджээ. Тэгэхээр...

-Жулия? Хатагтай Шамуэй?

Жулия бодолдоо бүрэн автсан байсан тул гэнэт ингэж дуудахыг сонсоод давхийн цочив. Тэгээд огцом эргэсэн бөгөөд хэрэв Жекки түүнийг түшээгүй бол унах байлаа. Цаана нь

Линда зогсож байв. Жулияг тэр хашгирч дуудсан байжээ. Хоёулаа ихэд айж тэвдсэн царайтай харагдана.

-Бид чамтай ярилцаж болох уу? гэж Жекки асуув.

-Мэдээж шүү дээ. Би ийм л ажил хийдэг. Хүмүүсийн ярихыг сонсдог. Бас тэдний ярьсан бүхнийг нийтэлдэг нь сөрөг үр дагавар гэх үү дээ. Та нар энэ тухай мэднэ биз дээ?

-Хэрэв тэглээ гэхэд та бидний нэрийг дурьдах ёсгүй. Хэрэв үүнийг зөвшөөрөхгүй бол бидэнтэй ярилцсанаа март гэж Линда хэлэв.

-Та нар мөрдөн байцаалтанд туйлын ойр байгаа эх сурвалж гэдэг чинь миний хувьд хангалттай. Ингэвэл болох уу? гэж асуугаад Жулия инээмсэглэв.

-Хэрэв та бидний асуултанд хариулна гэж амлах юм бол болно. Хариулна биз дээ? гэж Жекки тодруулав.

-Тэгье ээ.

-Та Их дэлгүүрт байсан тийм үү гэж Линда асуув.

"Алиса гайхамшгийн оронд" хэмээх үлгэрт гардаг шиг бүх юм улам аамаар ба аамаар болж

байна.

-Тийм ээ, яг та хоёр шиг. Алив ярилцацгаая. Санал сэтгэгдлээ сольцгооё.

-Гэхдээ энд биш шүү гээд Линда толгой сэгсрэв.

-Гудамжинд биш. Дэндүү ил тод байна. Бас сонины редакцид ч биш.

-Линда минь тайвшир гээд Жекки түүний мөрөн дээр гараа тавив.

-Чи л тайван байж чадах байх. Чамд ямар гэм буруугүй хүнийг торонд суулгахад тусалсан гэж бодох нөхөр байгаа биш.

-Тийм ээ, надад нөхөр байхгүй гээд Жекки толгой дохив.

"Тэр нь ч зөв дөө. Нөхрүүдийн тэр саруул ухаан ихэнхидээ амьдралыг хүндрүүлж байдаг" гэж Жулия дотроо бодов.

-Би хаашаа очиж болох газрыг мэднэ. Хаалгандаа цоожгүй боловч хүнгүй газар. Ямартаа ч Бүрхүүл үүсэх хүртэл цоожгүй байсан юмдаг гэж тэр түтдчин ярив.

Дөнгөж саяхан хэнээс асууж эхлэх билээ хэмээн бодож зогссон Жулия энэ хосыг алдах хүсэлгүй байлаа.

-Явцгаая. Гэхдээ цагдаагийн газрыг өнгөрөх хүртэл гудамжны хоёр талаар явцгаая тэгэх үү?

Линда инээмсэглэв.

-Тун ажил хэрэгч санаа байна.

2

Пайпер Либби хурлын нэгдүгээр сүмийн гол тахилгын өмнө болгоомжтой сөхрөн суулаа. Өвдсөндөө ярвайв. Хэдийгээр сандал дээрээс дэр авч өвдөг дороо ивсэн ч урагдаж хавдсан өвдөг нь өвджээ. Тэр баруун гараар тулж байв. Зүүн гар нь дөнгөж саяхан мултарсан болохоор одоо их биед наалдсан чигээр байлаа. Өвдөгнөөс ялгаатай нь энэ гар нь түүнийг өвдөж зовоосонгүй. Гэвч Пайпер онцын шаардлага гарахгүй бол энэ гарандаа ачаалал өгөхийг үл хүснэ. Мөрөө дахиад мултлахад онцгой хүчлэл шаардлагагүй. Хамгийн анх хөл бөмбөгийн талбай дээр гэмтэл авсны дараа түүнд яг ингэж хэлж байсан. (тун хатуу хэлсэн). Пайпер гараа урдаа бариад нүдээ анив. Тэр дороо түүний хэл дөнгөж өчигдөр шүд ярайж байсан боловч одоо нүх болсон газраар бултайна. Гэхдээ одоо түүний амьдралд энэ нүхнээс хавьгүй аймаар нүх бий болжээ.

-Байхгүй минь сайн байна уу? Чамайг хайр энхрийлэл ба зөөлөн сэтгэлээр дахиад туслаач гэсэндээ би дахин Чам дээр ирлээ гэх үед түүний хавдсан аньсага дороос нулимс гарч мөн л хавдсан хацрыг нь даган урсав.

-Миний нохой Чиний ойр хавьд байна уу? Би түүнийг маш их санаж байгаа болохоороо асууж байгаа юм шүү. Хэрэв ойр хавьд чинь байвал Чи түүнд чихэртэй ястай эн тэнцэх сэтгэлийн дэм өгнө гэдэгт би найдаж байна. Тэр ингэж шагнуулах гавьяатай. Гэхдээ гол шашнуудын олонхи нь нохой тэнгэрт хальдаггүй гэдэг дээр санал нийлдэг. Гэвч зарим нэг урсгал тухайлбал хэрэв би буруу санаагүй бол "Ридерс дайжест" үүнийг зөвшөөрдөггүй.

Мэдээж Тэнгэр гэж байдаггүй бол энэ тухай ярих нь ямар ч утгагүй болно. Тэгвэл Тэнгэр бурхангүй амьдралын тухай энэ санаа урьд нь түүний итгэл байсан тэр газарт яг гэртээ байгаа хүн шиг л тухлах байсан. Магадгүй бүх хүнийг мартагдах юмуу түүнээс дор зүйл ч хүлээж байж мэднэ. Жишээ нь цайвар тэнгэрийн доор нэг ч мөргүй, зах хязгааргүй тал үргэлжлэх ба тэнд цаг хугацаа хэзээ ч биш, очих газар нь хаашаа ч биш, дагалдагсад нь хэн ч биш байхсан. Нэг үгээр хэлбэл эртний ганцхан том Хаа ч биш гэсэн үг. Муу цагдаа, эмэгтэй санваартан болоод санамсаргүй өөрийгөө буудсан өсвөр насны хүүхдүүд юмуу эзнээ хамгаалах гэж байгаад үхсэн нохдын очих газар. Үр тариаг хальснаас нь салгах Дээд төрөлтөн нэг ч байхгүй. Үүнтэй төстэй санаа өвөрлөн залбирал үйлдэх нь бурхан тэнгэрийг доромжилсон хэрэг мөн боловч заримдаа ийм мөргөл тус болох нь бий.

-Гэвч одоо Тэнгэр байх эсэх нь гол юм биш. Одоо хамгийн гол нь миний нохойтой учирсан тэр аймшигт төгсгөлийн ямархан хэсэг нь миний буруу вэ гэдэг л гол юм. Би буруутай гэдгээ мэдэж байна. Дүрсхийдэг зан маань саруул ухааны дээр гарсан. Дахиад л ийм юм болчихлоо. Чи надад их богинохон нондог утас суулгаж өгчээ. Гэвч дарь дүрсхийн асахад хүргэхгүй байх нь хүний өөрийн хэрэг гэж шашин маань сургадаг. Гэвч би ийм байдлыг үзэн ядаж байна. Би үүнийг бүрэн үгүйсгэж байгаа юм биш. Гэхдээ л үзэн ядаж байна. Энэ бүхэн авто засварын газарт үүсдэг нөхцөл байдлыг надад санагдуулдаг. Тийш нь машинаа авчрах л юм бол машин эвдэрсэн явдалд зөвхөн чамайг л буруутана. Эсвэл чи машинаараа их явдаг, эсвэл хэт бага явдаг, эсвэл гар тоормосоо тавихаа мартсан, эсвэл шилээ өргөхөө мартсанаас болж борооны ус цахилгааны утсыг гэмтээсэн гээд л. Гэхдээ хамгийн муу нь юу гэдгийг мэдэх үү? Байхгүй минь, Чамд би өөрийн бурууны өчүүхэн хэсгийг ч тохож чадахгүй. Тэгэхээр юу үлдэж байна вэ? Өнөөх гайтай удамшил уу? Би муу үгс хэлж байгаадаа харамсч байна. Ингэхэд Чи миний хэлсэн бүхнийг сонсоогүй юм шиг царайлж яагаад болдоггүй юм бэ? Ээж маань дандаа тэгдэгсэн. Гэхдээ надад өөр асуулт байна. Би одоо яах вэ? Туслахын тулд юу хийхээ шийдэж чадахгүй байна. Би өөрийгөө тэнэг, сул дорой, замаасаа хазайсан гэдгээ мэдэрч байна. Хэрэв би Хуучин гэрээний тэнүүлч байсан бол надад ямар нэг тэмдэг хэрэгтэй гэж хэлэх байсан. Энэ тохиолдолд "зам тавь" юмуу "сургуулийн дэргэд хурд сааруулах бүс" гэсэн бичиг байсан ч болж байна.

Түүнийг дөнгөж ингэж хэлж дуусахад гадна хаалга нээгдээд дараа нь тасхийн хаагдав. Гялалзсан цагаан хувцастай, далавчтай сахиусан тэнгэрийг хүлээсэн харцаар Пайпер эргэн харлаа. Хэрэв тэр надтай үзэлцэх гэж байгаа бол эхлээд миний гарыг эмчлэх хэрэг гарна даа гэж дотроо бодов.

Гэвч сүмд сахиусан тэнгэр биш харин Ромми Берпи орж ирсэн зогсч байв. Цамцны хормой нь өмднөөсөө сугарч, гуяны орчимд санжиганана. Ромми яг л гэлэнмаа шиг сэтгэлээр унасан харагдана. Тэр сүмийн гол гудмаар алхаж явснаа гэлэнмааг хараад зогтусч, түүнээс ч илүү гайхсан харцаар ширтэв.

-Энэ чинь одоо юу вэ? Таныг энд байгаа чинээ санасангүй. Уучлаарай. Би дараа ирье гэж хэлэх үед түүний дуунд льюистон аялга тод сонсогдоно.

-Үгүй дээ, би залбиралаа дуусгаад байсан гээд гэлэнмаа босохдоо зөвхөн баруун гараар тулав.

-Үнэндээ бол би католик шашинтан. Гэвч Миллд католик сүм байхгүй. Та санваартан болохоор үүнийг мэдэж байгаа. Бас далайн шуурганы үед номхон дөлгөөн боомтонд хорогдох тухай та мэднэ. Би Брендагийн араас залбирахаар ийшээ ирсэн юм. Би тэр эмэгтэйг үргэлж хайрладаг байсан гээд Ромми хацраа арчив. Сахлаа алгаар үрэх үед гарах дуу сүмийн нам гүм орчинд их чанга сонсогдлоо.

-Би түүнд хайртай байсан. Гэхдээ хэзээ ч өөрт нь хэлж байгаагүй. Гэвч тэр мэддэг байсан гэж боддог.

Пайпер түүн рүү айдаст автан ширтэнэ. Тэр өнөөдөр гэрээсээ гараагүй. Хэд хэдэн сүсэгтэн түүн рүү утасдсан болохоор "Хүнсний ертөнц"-д юу болсныг мэдэж байв. Харин Бренда үхсэнийг анх удаа сонсч байна.

-Бренда юу? Тэр яасан юм бэ?

-Түүнийг алчихжээ. Бусдыг нь бас. Барби гэдэг тэр залуу ингэсэн гэх юм. Түүнийг баривчилсан.

Пайпер гараар амаа дараад найган ганхав. Ромми түүн рүү үсэрч очоод бэлхүүсээр нь тэвэрлээ. Тэд ийм байдалтайгаар яг гэрлэх гэж байгаа эрэгтэй эмэгтэй хоёр шиг гол тахилын өмнө зогсоно. Энэ үед хаалга дахин нээгдээд Жекки, Линда, Жулия гурав орж ирэв.

-Магадгүй энэ тийм ч сайн газар биш байх гэж Жекки гаргасан шийдвэртээ эргэлзэв.

Сүмийн доторхи дуу тархалт онц сайн байдаг болохоор хэдийгээр бүсгүй тун аяархан ярьсан ч Пайпер Ромми хоёр түүнийг сонсжээ.

-Битгий яваарай. Хэрэв юу болж байгаа талаар ярилцах гэж ирсэн бол битгий яваарай. Би л лав ноён Барбара гэдэгт итгэж чадахгүй нь. Тэр хүн ийм юм хийж чадахгүй. Миний мөр мултарихад тэр оруулж өгсөн. Тэр тухайн нөхцөл байдалд байж болох хэмжээгээр маш болгоомжтой зөөлөн байсан. Наашаа ойрт. Наашаа ойрт, гуйя гэж Пайпер бодлогоширон хэлэв.

-Ямар ч хүн мултарсан мөр оруулахын хажуугаар алуурчин байж болно гэж Линда хэлэхдээ уруулаа хазаж, бас хуруун дахь хуримын бөгжөө эргүүлэв. Жекки түүний бугуйгаар атгажээ.

-Линда бид илүү дутуу юм ярихыг хүсээгүй тийм биз дээ?

-Одоо дэндүү оройтсон. Хэрэв Жулия нийтлэл бичээд бас энэ хоёр биднийг түүнтэй байхыг харсан гэх юм бол бид бүх юмны буруутан болно гэж Линда хэллээ.

Тэд юу яриад байгааг Пайпер сайн ойлгоогүй ч зөв чиг барив. Баруун гараа дээш өргөөд

танхимыг тойруулан заалаа.

-Та нар миний сүмд байна. Та нарын хэлсэн бүхэн зөвхөн энд үлдэнэ.

-Та амлаж байна уу?

-Тийм ээ. Тэгэхээр яагаад бид чин сэтгэлээсээ ярьж болохгүй гэж? Би дөнгөж саяхан бурханаас тэмдэг хайрлахыг гуйж залбирсан. Гэтэл та нар ороод ирлээ.

-Би ийм юманд итгэдэггүй гээд Жекки толгой сэгсрэв.

-Түүндээ хүрэх юм бол би ч бас итгэдэггүй гээд Пайпер инээлээ.

-Надад энэ бүхэн таалагдахгүй байна. Тэр юу гэж хэллээ ч гэсэн энд олон хүн байна. Марти шиг ажилгүй болох нь нэг хэрэг. Би үүнийг тэсээд гарна. Тэртэй тэргүй цалин гэх юмгүй. Харин Жим Ренниг хилэгнүүлэх нь сайн санаа биш гээд тэр толгой сэгсрэв.

-Бид тийм ч олуулаа биш байна. Хэд хэрэгтэй тэр тоогоор л байна. Ноён Берпи та нууцыг хадгалж чадах уу? гэж Пайпер асуув.

Амьдралдаа эргэлзээтэй хуйвалдаан чамгүй хийж явсан Ромми толгой дохиод хуруугаа уруул дээрээ тавьсан нь "загас шиг чимээгүй" гэсэн үг.

Жекки урьдын адил эргэлзэж байгааг анзаарсан Пайпер түүнд зүүн гараа сунгаад:

-Алив явцгаая. Бүгдээрээ хамтдаа ярилцъя. Виски уунгаа гэлээ.

Сүүлийн өгүүлбэр Жеккийг эргүүлж чадав.

3

31-НД ГАЛААР АРИУСГАНА ГАЛААР АРИУСГАНА АРААТАНГ ШАТАЖ БАЙГАА НУУР ХУУ ХАЯНА

(НЭЭЛТ 19:20)

ТЭНДЭЭ ЗУУН ЗУУНЫ ТУРШ ӨДӨР ШӨНӨГҮЙ

ЗОВНО (20:10)

БУЗРЫГ ШАТААНА

ЗӨВ НОМТОНГ ЦЭВЭРШҮҮЛНЭ

ГАЛААР АРИУСГАНА, ГАЛААР АРИУСГАНА 31 -НД

31 ГАЛЫН ЕСҮС ИРНЭ 31

Хотын захиргааны олон нийтийн ажилд зориулсан тачигнасан ямбий ачааны машины кабинд шахалдан суусан гурван эр энэ таавар мэт зарлалыг гайхан харцгаав. ХБЭ студийн хойд талд барьсан зоорины барилгын ханан дээр улаан дэвсгэр дээр хар будгаар бичсэн байх ба аварга том үсгүүдээр бичсэн нь бараг бүх ханыгг эзэлжээ.

Тахиа үржүүлдэг фермер эр бөөрөнхий толгойт Рожер Кильян жолоо барьсан Стюарт Боуид хандав.

-Энэ одоо юу гэсэн үг вэ?

Харин түүнд Ферн Боуи хариуллаа.

-Энэ бол чөтгөр авмар Фил Буши бүр ухаангүй болсон гэсэн үг гээд тэр урд хайрцагаа нээж, тос бээлий ба гучин найман калибрийн гар буугаа авлаа. Нүх бүрт сум байгаа эсэхийг шалгасны дараа хүрдийг гарын хөнгөн хөдөлгөөнөөр буцааж байранд оруулаад гар буугаа бүсэндээ хавчуулав.

-Ферн минь энэ бол бэлиг эрхтэн буудах хамгийн тохиромжтой арга гэдгийг мэдэх үү? гэж Стюарт хэлэв.

-Чи надад санаа зовох хэрэггүй. Түүнд л санаа зов гээд Ферн студи рүү заав. Тэндээс сүмийн хөгжим хангинана.

-Фил жилийн ихэнхи цагийг өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс кайф авч өнгөрөөдөг хүн. Одоо тэр найдвартай эсэх тал дээр бол цэвэр хор болсон шүү.

-Одоо Филд өөрийг нь Шеф гэж дуудвал таалагддаг болсон гэж Рожер хэллээ.

Эхлээд тэд студийн дэргэд зогсоод Стюарт хэд хэдэн удаа чагнаалдав. Фил харагдсангүй. Тэр студи дотроо нуугдсан юмуу эсвэл радио станцыг барьж байгуулсан ой дотор тэнүүчилж яваа. Фил лаборатори дотор ч байж мэднэ гэж Стюарт бодов. Сэтгэцийн өвчтөн. Маш аюултай. Гэсэн хэдий ч зэвсэггүй явсан нь дээр. Тэр тонгойж Фернийн бүснээс гар бууг суга татаад жолоочийн сандал доор хийв.

-Хөөш гэж Ферн дургүйцэн хашгирлаа.

-Энд буудаж болохгүй. Чи биднийг бүгдийг нь саранд нисгэмээр байна уу? гэснээ Стюарт Рожерт хандан:

-Чи тэр туранхай ухныг хамгийн сүүлд хэзээ харсан бэ?

Рожер бодлоо.

-Багаар бодоход дөрвөн долоо хоногийн өмнө. Тэгэхэд хотоос сүүлчийн хэсгийг илгээсэн. "Чинук" нисдэг тэрэг ирэх үеэр гэв. Тэр аялгатай ярих бөгөөд "Шинуук" гэж хэлсэн бөгөөд хэрэв энд Ромми байсан бол түүнийг шууд ойлгоно.

Стюарт бодлогоширов. Хэрэв Фил ойгоор тэнэж яваа бол сайн хэрэг. Гэтэл хэрэв тэр чөтгөрийн сэтгэцийн өвчтөн өөрсдийг нь цагдаа нар гэж бодоод студид нуугдсан бол яах вэ? Магадгүй бас ч муугүй байж мэднэ. Гэхдээ хэрэв буудаад эхлэхгүй бол шүү дээ.

Харин Фил зооринд нуугдсан бол асуудал үүснэ дээ.

Стюари ахдаа хандан:

-Ачаан дээр модон саваанууд байгаа. Хэрэв Фил гарч ирээд элдэв ааш гаргах юм бол түүнийг номхруул гэв.

-Хэрэв тэр буугтай байвал яах юм бэ? гэж Рожер зөв асуулт тавьлаа.

-Тийм байх ёсгүй гэж Стюарт хариулсан ч яаж мэдэх билээ дээ. Ямартаа ч эндээс хоёр ширхэг хийтэй чингэлэг авч яаралтай эмнэлэгт хүргэх тушаал авсан. "Бусдыг нь ч бас аль болох хурдан эндээс гаргана. Бид одоо дахиж мет үйлдвэрлэхгүй" гэж Том Жим хэлсэн.

Үүнд тэр баярлаж байв. Хот Бүрхүүлээс салах юм бол Стюарт ч бас оршуулгын бизнесээ орхино. Ямар нэг дулаан газарт очно. Ямайка юмуу Барбадос. Тэр дахиад нэг ч хүүр хармааргүй байна. Бас Шеф Бушид мухлагаа хаасан тухай хэлэхийг үл хүсч байгаагаа Том Жимд шууд хэлсэн.

"Шефэд би өөрөө хэлнэ" гэж Том Жим түүнд хариулсан

юм.

Стюарт том ягаан ачааны тэргээр зоорийг тойроод хаалга руу ухран ойртов. Гэхдээ өргүүр болон татагчийг ашиглах хэрэгтэй байсан тул хөдөлгүүрийг унтраасангүй. Бүгд кабинаас гарлаа.

-Үгүй ер. Та нар хараач гэх Рожерийн дуунд бахдал тодорно. Тэр баруун тийш харж зогсох бөгөөд нар тэнгэрийн хаяа руу уруудахдаа улаан нялга өнгөтэй болж түгшүүр төрүүлэх ажээ. Удахгүй нар ойн түймрийн дараа үлдсэн хар толбо руу шургаж өнгө ба хэлбэрээ өөрчлөх болно.

-Та нар ийм новшийн юм хэзээ нэгэн цагт үзсэн үү?

-Одоо больж үз. Би ажлаа дуусгаад явмаар байна. Ферн мод аваарай. Жинтэйхнийг аваарай гэж Стюарт яриаг тасаллаа.

Ферн татагчийн дээгүүр алхан гараад бейсболын цохиурын хэртэй урт бороохой авав. Хоёр гараар барьж тал тал тийш савж үзлээ.

-Болох юм байна.

-Яг "Баскини Роббинс" гэж Рожер мөрөөдөнгүй хэлээд нүдээ онийлгон саравчилж баруун тийш ширтэнэ. Онийх нь түүнд огт үл зохино. Тэр одоо яг үлгэрт гардаг үсэрдэг чөттөрийг

санагдуулах ажээ.

Стюарт хийж байснаа орхиод хоёр цоож нээж бас төмөр хөндлөвчийг буулган зоорины хаалгыг онгойлгов.

-Чи юу яриад байна вэ?

-Гучин нэгэн амт гэж хэлээд Рожер инээхэд Жо Боксер юмуу өөр ямар нэг шүдний эмч хэзээ ч үзлэг хийгээгүй нь илт үжирсэн шүднүүд нь ил гарав.

Рожер юу яриад байгааг Стюарт огт ойлгосонгүй. Харин дүү нь ойлгожээ.

-Ханан дээр зайрмагны сурталчилгаа бичсэн гэж бодохгүй байна. Мэдээж хэрэв Нүгэл наминчлах номонд "Баскини Роббинс"-ын тухай дурсаагүй бол шүү гэж Ферн хэлэв.

-Хоёулаа амаа хамхи. Ферн бэлэн байгаарай гэж Стюарт тушаагаад хаалгыг нээж дотогш шагайгаад: -Фил гэж хашгирав.

-Түүнийг Шеф гэж дуудсан нь дээр шүү. "Саут-Парк"-ийн негр тогооч шиг. Түүнд энэ нэр таалагддаг юм гэж Рожер зөвлөв.

-Шеф. Чи энд байна уу Шефээ? гэж Стюарт дахин дуудав.

Хариу алга. Түүнийг яг одоо гарнаас нь шүүрэн барих байх гэж бодон Стюарт харанхуй зоорь руу орж унтраалгыг эргүүлэв. Гэрэл асч зоорины барилгын гуравны хоёрыг гэрэлтүүллээ. Ханын доторлогоог хийж дуусгаагүй байх ба хөндлөн моднуудын хооронд ягаан өнгийн тусгаарлагч навсайна. Янз бүрийн хэмжээ хэлбэртэй дотроо хий агуулсан сав чингэлгүүд дүүрэн байх ажээ. Энд хичнээн ийм сав байгааг Стюарт мэдэхгүй. Гэвч хэрэв түүнээс хичнээн байсныг асуух юм бол тэр 400-600 гэж хариулах байсан.

Тэр чингэлэг дээрх бичээсүүдийг уншингаа голын гудмаар аажуухан алхана. Том Жим түүнд тодорхой захирамж өгсөн бөгөөд авах ёстой чингэлгүүд гүгд байгаа гэж хэлсэн. Бурхныг авралаар тэд тэндээ л байв. Стюарт "Хотын захиргааны хэмжээний" таван чингэлгийн дэргэд зогсоход бөөрөнд нь "КР эмнэлэг" гэсэн бичээс харагдана. Цаагуур наагуур нь Милл хотын дунд сургууль болоод шуудангийн салбарын гэсэн бичээстэй бусад чингэлгүүд хөглөрнө.

-Хоёрыг нь аваарай гэсэн. Гинж аваад ир. Эхэлцгээе. Ферн чи цаад хана руу очоод лабораторийн хаалгыг шалга. Хэрэв онгорхой байвал түгжээрэй гэж хэлээд Ферн рүү цагирагт хэлхсэн түлхүүр шидэв.

Ферн энэ даалгаврыг дуртайяа биелүүлэхгүй байх байсан хэдий ч тэр үргэлж ахынхаа үгэнд ордог. Хаалга руу дөхөв. Сав чингэлэгүүд гол замын хоёр талаар хөглөрнө. Хаалганы наадах арваадхан фут газар л хоосон байлаа. Хаалга онгорхой байхыг хараад Ферн зүрх үхэв. Ард нь гинж хажигнаж, дараа нь татагч чихран дуугараад бас ямар нэг юм шажигнана. Эхний чингэлэгийг ачааны машин руу татаж байгаа нь тэр. Гэвч энэ бүх дуу чимээ алсын алсад мэт

санагдана. Ялангуяа хаалганы нөгөө талд "ТЕК-9" шүршдэг гар буугаар зэвсэглэж хар тамхиа татан мансуурсан улаан нүдтэй солиотой Шеф зогсч байгаа гэж бодохоор.

-Шеф, найз минь, чи энд байна уу? гэж тэр дуудлаа. Хариу алга. Хэдийгээр тийшээ шагайх хэрэггүй байсан ч сониуч зан нь дийлж тэр бороохойгоор хаалгыг түлхэн том нээв. Ёстой ухаангүй хүн л ийм юм хийх байсан.

Лаборатори дотор өдрийн гэрлүүд асна. Гэвч "Христ бидний эзэн" радио станцын зоорины барилгын энэ хэсэг ч бас хүнгүй байлаа. Тус бүр өөртөө хийтэй баллонтай ба соруултай хорин ширхэг том галлуурууд ажиллахгүй байв. Тавиур дээгүүр үнэтэй шилэн савнууд, хэмжих аяганууд ба тогоо савнууд хөглөрнө. Лабораториос үмхий ханхлана. "Үргэлж үмхий ханхалдаг. Цаашид ч ханхлах болно" гэж Ферн бодов. Гэхдээ шалыг шүүрдсэн байх бөгөөд эмх цэгц ноёрхоно. Хананд 8 дугаар сард нээлтээ хийсэн "Жим Реннигийн хуучин авто машины салон"-ы хуанли өлгөөстэй байв. Энэ ухна яг тэр сард бодит амьдралаас тасарсан байх гэж Ферн бодлоо. Зүгээр л өөрийнхөө ертөнц рүү хөвчихсөн. Тэр дахиад жаахан цаашлав. Хэдийгээр мет тэднийг бүгдийг нь алтжуулсан ч түүнд энэ ажил хэзээ ч таалагдаж байсангүй. Тэгээд ч эндхийн үнэр цогцосыг сүүлчийн замд нь үдэхээр бэлтгэдэг оршуулгын товчооны хонгилын өрөөнийхтэй тун адилхан байв.

Ханын нэг талын буланд голдоо хаалгатай зузаан төмөр хавтан харагдана. Тэнд Шефийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн хадгалдаг гэдгийг Ферн мэднэ. Галлон хэрийн эзлэхүүнтэй хүүдийнүүдэд биш харин "Хефти"-гийн том том хогийн ууганд хийсэн метийн тунгалаг талстууд байдаг. Жижиг юм энд байхгүй. Нью-Йорк юмуу Лос-Анжелесын гудамжаар метийн тун хайн мансуурагчид бол дүүрэн хангалттай тийм үйрмэг огт байхгүй. Зоорь дүүрэх үеэр энд бүх АНУ-ын хэрэглээг хэдэн сараар, магадгүй бүтэн жилээр хангах мет хуримтлагддаг.

Том Жим яагаад түүнд тийм их мет бэлдэхийг зөвшөөрдөг юм бол гэж Ферн өөрөөсөө асуув. Бид яагаад түүнд тусалдаг юм бэ? Бид юу бодсон хэрэг вэ? Түүнд ердийн хариултаас өөр ямар ч хариулт олдсонгүй. Яагаад гэвэл тийм боломжтой байсан болоод л тэр. Хятад гаралтай орц бодисуудын хямд үнэ болоод Бушигийн чадвар хослон тэднийг бүтдийг нь худалдан авчээ. Бас энэ мөнгөөр бүх зүүн эргийн дагуу бурхны ариун үйлсийг түгээх "ХБЭ корпораци" санхүүжинэ. Хэрэв хэн нэгэн хүн асуух юм бол Том Жим үргэлж бурхны нэр барина. Бас Сургаалиас ишлэл татах бөгөөд "Ямар ч хөдөлмөрчин хөдөлмөрийнхөө төлөө шагнал авах ёстой" гэх юмуу "Нунтаглаж байгаа шарын амыг бүү тагла" гэх ажээ.

Шарын тухай энэ ишлэлийг хэрхэн тайлбарлахаа Ферн хэзээ ч ойлгож байсангүй.

-Шеф найз минь? гэж хашгираад тэр лаборатори руу оров.

Хариу алга. Толгойгоо өргөөд хоёр хананы дагуу хөвөрсөн модон тавиуруудыг гүйлгэн харлаа. Орц найрлагыг хадгалахад тавиур зориулагдана. Тэнд өрсөн хайрцагнуудын доторхи зүйлс Холбооны Мөрдөх Товчооны сонирхолыг тун их татах байсан. Эсвэл Хүнсний бүтээгдэхүүн ба Эмийн хяналтын захиргаа юмуу Согтууруулах ундаа тамхи болоод Галт зэвсгийн худалдааны хяналтын товчооны сонирхолыг татах байсан. Дээгүүр бас хэн ч алга. Гэвч энэ удаад бас нэг шинэ юм бий болжээ. Хоёр эгнээ тавиурын хашлага дээгүүр цагаан утас хөврөх

ба модонд төмөр үдээсээр бэхлэгдсэн байв. Цахилгааны утас юм болов уу? Хааш нь татсан юм бол? Энэ галзуу дээд давхарт бас шатаагуур тавьсан хэрэг үү? Телевиз юмуу радио шиг жирийн төхөөрөмжид зориулан татсан гэхэд үнэмшмээргүй их бүдүүн утас байлаа.

-Ферн хэрэв Буши тэнд байхгүй бол наашаа ирж бидэнд тусал. Би эндээс хурдан явмаар байна. Зургаан цагт зурагтаар мэдээ гарна. Одоо тэд юу бодож байгааг мэдмээр байна гэж

Стюарт хашгирахад тэр давхийн цочив.

Одоо Честерс-Миллд хотын гадна байгаа бүх хүнийг тэд гэж дуудах болсон.

Ферн хаалганы дээрх хана руу харалгүй, цахилгааны шинэ утас хаашаа хөвөрсөнийг анзааралгүй буцаж гарлаа. Энэ утас жижиг тавиур дээр тавьсан харахад шавар шиг цагаан бодисын том шаваас руу хүрчээ. Энэ бол тэсрэх бодис байв.

Шеф түүнийг өөрийн жороор бэлдсэн юм.

4

Зоориноос холдох үед Рожер:

-Хэллоуин. Энэ чинь бас 31-нд шүү дээ гэлээ.

-Чи ч ёстой мэдээллийн зоорь юм даа гэж Стюарт бувгнав.

Рожер зулай руугаа тогшоод:

-Би бүгдийг нь энд хадгалдаг юм. Албаар биш. Өөрсдөө л хадгалагддаг.

"Ямайка эсвэл Барбадос. Заавал дулаан газарт очно. Бүрхүүл алга болонгуут явна. Ямар ч Рожерийг дахиж хармааргүй байна. Ер нь энэ хотоос хэнийг ч хармааргүй" гэж Стюарт бодов.

-Бас хөзөр 31 ширхэгтэй байдаг гэж Рожер үргэлжлүүлэв.

Ферн түүн рүү огцом эргээд:

-Чи юу донгосоод байгаа юм бэ? Хараал идмэр.

-Тоглосон юм. Зүгээр л тоглосон юм гээд Рожер тачигнатал инээв. Түүний энэ жихүүдэс төрөм цангинасан инээднээс болоод Стюартын толгой өвдлөө.

Тэд эмнэлэг рүү бараг иржээ. "Кэтрин Рассел"-аас гарч яваа саарал өнгийн "форд таурус"-ыг Стюарт олж харлаа.

-Хүүе энэ чинь Расти эмч байна. Хими эргэж ирсэнд тэр баярлана гэж би мөрий тавихад бэлэн байна. Чагнаалд гэж Ферн хэллээ.

Бурхангүйчүүд явсны дараа Шеф Буши тэднийг явах хүртэл гартаа барьж байсан гараажийн хаалганы алсын удирдлагыг сая тавив. Тэр өнөөх гурван эрийг радио станцын эрэгтэй нойлын цонхоор ажиглаж байсан юм. Тэд зооринд орж ямар нэг юм хийх үед эрхий хуруу нь товчин дээр бэлэн байв. Хэрэв тэд бүтээгдэхүүн авч гарах юм бол тэр товчийг дарж зоорийг тэнгэрт илгээх байсан.

-Миний есүс. Бүх юм чиний гарт. Яг л бид хүүхэд байхдаа ярьдаг байсан шиг. Би хүсэхгүй байна. Гэхдээ хийх болно гэж тэр бувтнана.

Гэвч есүс бүхнийг хамгийн сайнаар зохицуулжээ. Энэ үед Жорж Дау ба "Госпел-Тоунс" нар "Бурхан минь чи бидний төлөө хичнээн их анхаарал тавина вэ?" дууг дуулах үед бүх юм ийм л байх болно гэдгийг Шеф мэдрэв. Бас энэ бүхэн зүгээр нэг хальсан дээр бичсэн дуу биш харин дээрээс илгээсэн тэмдэг гэдгийг Шеф мэдэрчээ. Тэр гурав мет авах гэж биш харин хийтэй хоёр чингэлэг авах гэж ирсэн байж.

Тэр тэднийг явтал нь ажиглаад дараа нь студи ба зоорины барилгыг холбосон лаборатори байрлах тэр хэсэгт орж ирэв. Одоо энэ барилга түүний эзэмшил. Бас энд байгаа бүх мет түүнийх. Есүс өөрөө ирж бүхнийг өөртөө авах хүртэл түүний мэдлийнх.

Хэллоуин болоход ирэх юмуу болов уу?

Магадгүй арай эрт байх.

Түүнд бодох юм байлаа. Ойрын өдрүүдэд хар тамхи татсаны дараа бодоход бүр ч амар хялбар болж байв. Хавьгүй амар.

Жулия таашаал авангаа вискийг бага багаар балгав. Харин эмэгтэй цагдаа нар яг л морин цэрэг шиг хийж өгснийг ганц хөнтөрч орхив. Тэд согтоогүй боловч архи хэдийнээ чалчаа болгожээ.

Жекки газар ширтэн шилэн аягаа гартаа эргэлдүүлэх бөгөөд Пайпер нэмж хийх гэтэл толгой сэгсрэв.

-Хамгийн гол нь би их айж байна. Хэрэв Герцог амьд байсан бол ийм юм хэзээ ч болохгүй байсан. Энэ бодол миний санаанаас гарахгүй байна. Тэр бүү хэл Барбара түүний эхнэрийг алсан гэж сэжиглэх үндэс байлаа ч тэр тогтоосон ном журмын дагуу явах байсан. Өөр юу ч хийхгүй. Хохирогчийн эцгийг "тахяны байр" руу оруулж сэжигтэнтэй нүүр тулах боломж олгох байсан уу? Хэзээ ч үгүй. Тэр залуу яах бол гэхээс би айж байна хэмээн түүний ярихад Линда зөвшөөрөн толгой дохив.

-Хэрэв Барбитай ийм явдал тохиолдож байгаа гэдэг чинь хэнтэй ч тохиолдож болно гэсэн үг

үү? гэж Жулия асуув.

Жекки толгой дохилоо. Хөмхий зуужээ. Гарт нь шилэн аяга эргэлдэнэ.

-Хэрэв түүнтэй муу юм тохиолдвол... Би Линчийн шүүхийн тухай яриагүй байна. Зүгээр л камерт нь золгүй тохиолдол боллоо гэхэд... би мэдэхгүй байна. Би ер нь дахиад цагдаагийн дүрэмт хувцас өмсч чадах эсэхээ мэдэхгүй байна.

Линдагийн түгшүүр туйлын энгийн шалтгаантай. Яагаад гэвэл түүний нөхөр Барбараг буруугүй гэдэгт итгэж байсан. Линда уурандаа (Бас Маккейний зоорины өрөөнд харсан зүйлд ой гутсанаас) нөхрийнхөө санааг шууд үгүйсгэсэн. Тэгээд ч Барбигийн цэргийн таних тэмдгийг Энжигийн хөхөрч яс болсон гарнаас олсон шүү дээ. Гэвч энэ тухай бодох тусам түгшүүр улам нэмэгдэнэ. Яагаад гэвэл тэр Растигийн саруул ухааныг үргэлж хүндэлдэг. Түүнээс гадна Рэндолф "Мейсом" цацаж таслахаас өмнө Барбигийн хашгирсан үгс ч бий. "Та нөхрөө цогцост үзлэг хий гэж гуйгаач. Танай нөхөр цогцост үзлэг хийх ёстой" гэсэн.

Жекки гартаа шилэн аяга эргэлдүүлсээр байв.

-Бас нэмж хэлэхэд хоригдлыг хашгирсаных нь төлөө "Мейсом" цацдаггүй юм. Заримдаа бямба гаригт, ялангуяа тэмцээний дараа амьтны хүрээлэнд хоол түгээхийн өмнө хашгиралддаг шиг хорих өрөөнд хүмүүс бахирдаг. Гэлээ гээд тэдний бахирахад саад болдоггүй. Аяндаа ядраад унтраад өгдөг.

Жулия энэ хооронд Линдаг сонжин харсаар байв. Жеккиг яриагаа дуусгамагц түүнд хандлаа.

-Барби юу гэж хэлснийг ахиад хэлээч.

-Тэр Расти цогцоснуудыг үзэх ёстой. Ялангуяа Брендагийн цогцосыг гэсэн. Цогцосыг эмнэлэгт аваачихгүй гэж хэлсэн. Тэр үүнийг мэдэж байсан. Цогцоснууд Боуигийн товчоонд байгаа бөгөөд энэ буруу гэсэн.

-Тэдний алагдсан нь чөттөр шиг хачин юм. Ийм бүдүүлэг үг хэлсэнд уучлаарай ламтан гэж Ромми хэлэв.

Пайпер гараа савлаа.

-Хэрэв Барби тэднийг алсан юм бол цогцост үзлэг хийх нь түүний хувьд яагаад ийм чухал болохыг ойлгохгүй юм. Харин тэр алаагүй бол үзлэг хийх нь түүнийг цагаатгана гэж тэр боджээ.

-Бренда хамгийн сүүлийн хохирогч уу? гэж Жулия асуув. -Тийм ээ. Түүний цогцос хөшиж эхэлсэн ч дуусаагүй байсан. Ямар ч гэсэн Бренда бүрэн хөшөөгүй байсан гэж Жекки баталлаа.

-Үнэхээр хөшөөгүй байсан. Хүний цогцос үхсэнээс хойш ойролцоогоор гурван цагийн дараа хөшиж эхэлдэг. Тэгэхээр миний тооцоолж байгаагаар Брендаг өглөөний 8-9 цагийн орчимд бүрэлгэсэн байна. Гэхдээ би эмч биш л дээ гэж хэлээд Линда санаа алдаж толгойгоо илэв.

-Расти ч бас эмч биш. Гэхдээ хэрэв түүнийг дуудсан бол тэр үхлийн цагийг хавьгүй тодорхой гаргаж чадах байсан. Гэвч хэн ч дуудсангүй. Би ч дуудаагүй. Би их айж цочирдсон болохоор... Сүүлийн үед хичнээн их юм дайрав даа.

Жекки шилэн аягаа тавиад цааш түлхэж орхив.

-Жулия чи өглөө их дэлгүүр дээр Барбаратай хамт байсан биз дээ?

-Тийм.

-9 цагаас арай хойшоо, үймээн эхэлсний дараа юу? -Тийм.

-Та хоёрын хэн нь түрүүлж ирсэн юм бэ? Би мэдэхгүй болоод асууж байна л даа.

Жулия түрүүлж ирсэн бөгөөд харин Барби бол дараа нь, Роуз ба Энсон нараас ч хойно ирсэн гэж тайлбарлав.

-Хүмүүсийг хэрхэн тайвшруулахыг Барби бидэнд харуулсан юм. Магадгүй тэр олон хүнийг ноцтой гэмтэлээс аварсан. Энэ бүхэн зоорины өрөөнөөс олдсон цогцоснуудтай нэг л уялдаж өгөхгүй байна. Та нарт тэдгээр цогцосны үхлийн дарааллын талаар ямар нэг ямар нэг таамаг байна уу? Хамгийн сүүлд үхсэн Брендагаас бусдынх нь тухайд.

-Энжи Доди хоёр хамгийн эхний хохирогчид. Тэдний цогцос Лестер ламын цогцосноос хамаагүй их муудсан байна билээ. Тэгэхээр ламыг сүүлд алсан гэж Жекки хариулав.

-Цогцосыг хэн олсон юм бэ?

-Бага Ренни. Тэр ямар нэг юм сэжиглэсэн байна. Яагаад гэвэл Энжигийн машин гараашт байхыг харсан гэсэн. Гэхдээ энэ бүхэн чухал биш. Хамгийн чухал нь Барбара байна. Ингэхэд тэр Роуз ба Энсон нараас хойно ирсэн гэдэгт чи итгэлтэй байна уу? Яагаад гэвэл энэ тийм ч сайн зүйл биш.

-Би итгэлтэй байна. Тэгэхээр хэрэв Барби хүмүүсийг алаагүй юм бол юу хийж байсан хэрэг вэ? Пайпер гуай би танай утсаар ярьж болох уу?

-Мэдээж.

Жулия жижиг утасны лавлах руу шагайснаа Пайперын гар утсаар "Эглантери" руу залгалаа. Хэн нэгэн шууд л хариулав.

-Бид дараагийн заавар иртэл хаалттай байгаа. Энэ новшнууд манай тогоочийг баривчилсан.

-Роуз уу? Би Жулия Шамуэй байна.

-Өө, Жулия. Чи юу хүсээ вэ? гэх Роузын дуу чадах чинээгээрээ зөөлрөв.

-Барбарагийн юу хийж байсныг тогтоох санаатай. Чи тусалж чадах уу?

-Чи надад итгэж болно. Барби хүн алсан гэх санаа нь өөрөө тэнэг хэрэг. Чи надаас юу мэдмээр байна вэ?

-"Хүнсний ертөнц"-д үймээн эхлэх үед тэр "Эглентери"-д байсан эсэхийг би мэдэх гэсэн юм.

-Өөр хаачих юм бэ? Өглөөний цайны дараа тэр хаачих ёстой гэж? Энсон бид хоёрыг явахад тэр шарах пгүүгээ цэвэрлээд үлдсэн гэх Роузын дуунд гайхшрал тодров.

7

Нар доошилж сүүдэр уртсахын хэрээр Клер Макклэтчи бүр илүү тэвдэж эхлэв. Тэгээд хойш тавьсаар байсан зүйлээ одоо хийхээр шийдэн гал тогоо руу орлоо. Өөрийнхөө гар утас руу нөхрийнхөө гар утсаар ярих гэсэн хэрэг. (нөхөр нь бямба гаригийн өглөө утсаа мартаад явчихсан. Тэр ер нь дандаа утсаа мартдаг) Залгахын өмнө тэр дөрвөн удаа дуудсаны дараа өөрийнхөө хөгжилтэй цангинасан дууг сонсоно гэж айв. Бүх хот нүдэнд үл үзэгдэх шоронд орохын өмнө тэр энэ дууг бичүүлсэн билээ. "Сайн байна уу? Клерийн дуут шуудан байна. Дохио өгсний дараа хэлэх зүйлээ үлдээнэ үү" гэх байх.

Тэгэх юм бол би яах билээ. "Жо хэрэв чи үхээгүй бол залгаарай" гэх үү?

Эмэгтэй товчон дээр хуруугаа аваачаад хөшив. Хэрэв Жо эхний удаад хариулахгүй байлаа гэхэд тэр унадаг дугуйтай яваа бөгөөд дуут гпуудан залгагдахаас өмнө дугуйнаасаа бууж үүргэвчнээс гар утсаа гаргаж амжаагүй гэсэн үг. Тэгэхээр хоёр дахь удаа залгахад ээж нь залгаж байгааг мэдэж байгаа болохоор шууд утсаа авна.

Хэрэв утас хоёр дахь удаагаа дуут шууданд холбогдвол яах вэ? Гурав дахь удаа залгахад мөн тэгвэл яах вэ? Ингэхэд би яагаад түүнийг тавьж явуулав даа? Би самуурсан байж таарна.

Клер нүдээ анихад оюун санаанд нь заримдаа хар дарсан зүүдэнд үзэгддэг зүйлсээс илүү тод дүрслэл гарч ирэв. Төв гудамжны шилэн хоргууд ба утасны шонгууд дээр Жо Бенни ба Норри нарын гэрэл зургийг наасан байв. Авто замын дагуу амрах газруудын мэдээллийн самбар дээр хүүхдүүдийн зураг наасан байдаг шиг яг тэгж харагдана. Дээр нь үргэлж "Сүүлчийн удаа түүнийг тэнд энд харсан" гэж бичсэн байдаг.

Клер дахиад хулчийхгүйн тулд нүдээ нээгээд шууд залгав. Тэгээд дуут шууданд "Би арван секундын дараа дахин залгах тул ноён Жо та утсаа авсан нь дээр шүү" гэх мэдээлэл үлдээхэд бэлдэв. Гэвч утас эхний удаа дуугарч дуусаагүй байхад Жо-гийн тод цэвэр хоолой цангинасанд тэр ихэд гайхав.

-Ээж ээ, сайн уу ээж ээ? гэх түүний дуу амьдаар барахгүй бүр амьдаас илүү баяртай байв. Дуу хоолойгоор нь бол тэр баяр хөөр оргилж яваа бололтой.

"Чи хаана байна вэ?" гэж Клер асуухыг хүссэн ч эхэндээ нэг ч үг дуугарч чадсангүй. Хөл нь туяхан зөөлөн болж ирэв. Тэгээд шалан дээр сөхрөхгүйн тулд хана налж зогслоо.

-Ээж ээ, та утсан дээрээ байна уу?

Клер ойртон ирж байгаа машины чимээ ба Беннигийн бөглүү боловч тод хашгирах дууг давхар сонслоо. -Расти эмч ээ, хөөе хүн гуай зогс. Арай гэж ярихтайгаа болов.

-Тийм ээ, утсан дээрээ байна. Та нар хаана явна вэ?

-Толгойн орой дээр. Хотын төв талбайн хажууд байна. Бүрэнхий болж эхэлсэн тул таныг битгий санаа зовоорой гэж хэлэх гээд яг залгах гэж гартаа утсаа бариад байсан юм. Гэнэт утас дуугарсан чинь цочоод алдах шахлаа.

Тийм ээ, ээж аав нар дандаа л дэмий сэтгэл зовох юм даа. Толгойн оройд төв талбайн хажууд. Тэд 10 минутын дараа ирэх юм байна. Бенни дахиад гурван фунт хоол идэх байх даа. Бурхан минь чамд талархая.

Норри Жо-д ямар нэг юм хэлэв. "Түүнд хэл, түүнд хэл" гээд байх шиг. Дараа нь утсанд дахиад хүүгийнх нь дэндүү чанга ба баяр хөөртэй дуу хадсан тул ээж нь утсаа чихнээс холдуулахад хүрэв.

-Ээж ээ, бид түүнийг олсон гэж бодож байна. Би бараг итгэлтэй байна. Блэк-Ридж оргил дээр алимны цэцэрлэгт байна.

-Юу олсон гэж?

-Би яг хэлж мэдэхгүй байна. Яаран дүгнэлт гаргамааргүй байна. Гэхдээ энэ Бүрхүүлийг үүсгэж байгаа зүйл байх. Бараг л тийм байх. Нисгэгчид анхааруулга өгөхийн тулд цамхаг дээр тавьдаг анивчуур шиг зүйлийг бид олж харсан. Гэхдээ газарт байх бөгөөд улаан биш хүрэн улаан өнгөөр анивчиж байсан. Бид яг юуг нь олж үзэхээр тийм ойрхон очиж чадаагүй. Бид бүгд тасарчихсан юм. Сэргээд бүх юм хэвийн болохыг ойлгосон. Гэхдээ...

-Тасарсан гэнэ үү? Тасарсан гэсэн чинь юу гэсэн үг вэ? Түргэн гэртээ ир. Одоохон ир. Би чамайг хармаар байна гэж Клер хашгирав.

-Ээж ээ, би зүгээр. Миний бодлоор... Хүмүүс Бүрхүүлд анх хүрэхэд тогоор хөнгөн цохиулах шиг мэдрэмж төрөөд дараа нь энэ мэдрэмж алга болж байсан. Түүн шиг нэг удаа тасраад дараа нь дархлаатай болдог гэж би бодоод байна. Урьдчилан сэргийлэх тарилга хийлгэхэд аюулгүй болдог шиг. Норри ч бас тэгж бодож байна.

-Тэр охин юмуу ноёнтон та юу гэж бодох нь надад хамаагүй. Одоохон гэртээ ир. Чамайг хэвийн байгаа гэдэгт би итгэх ёстой. Эсвэл би чиний бөгсөнд урьдчилан сэргийлэх тарилга хийнэ шүү.

-Тэгье ээж ээ, гэхдээ би ноён Барбаратай ярих ёстой. Тэр Гейгерийн тоолуурын тухай анх сэтгэсэн нь зөв боллоо. Бас Расти эмчид дуулгах хэрэгтэй. Тэр дөнгөж сая бидний хажуугаар өнгөрсөн. Бенни түүнийг зогсоох гээд чадсангүй. Бид Расти эмч ноён Барбара хоёрыг олоод гэртээ аваад ирье. Цааш юу хийхээ бодох хэрэгтэй.

-Жо минь дээ... Ноён Барбара...

Клер дуугаа хураав. Юу хэлэх юм бэ? Зарим хүмүүс хурандаа Барбара гэж нэрлэх болсон тэр хүн хэд хэдэн хүн алсан хэргээр баривчлагдсан гэх үү?

-Юу гэнэ ээ? Тэр яасан бэ? гэж Жо асуух үед баяр хөөрийн дуу нь санаа зовсон аястай болов.

Ээж нь хүүгээ мэдэрдэг шиг хүү нь ээжийнхээ сэтгэл санааны байддыг яг мэдэрдэг юм байна гэж Клер бодов. Мэдээж Жо Бенни ба Норри нарт итгэдэг шигээ Барбарад эргэлзээгүй найдаж байсан. Клер тэгэхийг хүслээ ч гэсэн юу болсон талаар мэдүүлэхгүй байж чадахгүй шүү дээ. Гэхдээ Барбарагийн баривчлагдсан болоод түүнд тулгасан ялын тухай утсаар хэлэх бодолгүй байв.

-Гэртээ хүрээд ир. Энд ярилцъя. Тэгээд Жо... Би та нараар бахархаж байна гэх ээжийнхээ дууг Жо сонслоо.

8

Жимми Сируа үдээс хойш нас баржээ. Жо найз нарынхаа хамт унадаг дугуйгаар хот руу орж ирж байх тэр үеэр.

Расти хонгилд Жина Буффалиног тэврэн суух бөгөөд энгэрт нь наалдан уйлахад нь саад болсонгүй. Хэрэв өөр цагт байсан бол дөнгөж 17 настай бүсгүйг тэврэн ийнхүү сууж байгаадаа тэр их эвгүйцэх байсан. Гэвч цаг өөрчлөгджээ. Одоо өдрийн гэрлээр биш харин Коулманы чийдэнгээр гэрэлтүүлэгдсэн хонгил руу ганц хяламхийхэд л цаг өөрчлөгдсөн болохыг хангалттай ойлгож болно. Эмнэлэг сүүдрээр дүүрсэн агуй болон хувирчээ.

-Чиний буруу гэж байхгүй. Чиний ч биш, миний ч биш, тэр бүү хэл түүний буруу ч энд байхгүй. Тэр өөрөө гуйж чихрийн шижинтэй болоогүй гэж Расти бүсгүйг тайвшируулна.

Гэвч олон олон хүмүүс чихрийн шижинтэй ч он удаан жил амьдардаг гэдгийг бурхан гэрчилнэ. Гэхдээ тэр хүмүүс өөрийнхөө төлөө санаа тавьдаг байсан. Гэтэл Год-Крик-Роуд гудамжинд тэнүүлчин маягаар амьдрах Жимми бол тийм хүн биш. Тэр өнгөрсөн пүрэв гаригт арай гэж эмнэлэгт залрахдаа өөрөө машинаасаа буух чадваргүй байсан ба юу болоод байгааг харахаар Жинни гадагш гарах хүртэл чагнаалдсан билээ. Расти өвгөний өмдийг суга татах үед баруун хөл нь хатингаршиж хөхөрсөнийг харсан. Жимми амьд үлдлээ ч гэсэн үзүүр хэсгийн мэдрэлийн судсууд сэргэхгүй байсан.

"Эмч ээ, огт өвдөхгүй байна" гэж Жимми ухаан алдахынхаа өмнө Хаскель эмчид хэлж байв. Тэр цагаас хойш мань хүн нэг ухаан орж, нэг ухаан алдаж байсан ч хөл нь бол улам дордсоор байв. Хэдийгээр тайрахаас өөр аргагүй гэдгийг мэдэж байсан ч Расти энэ мэс заслыг хойшлуулсаар байлаа. Хэрэв Жиммид амьдрах боломж олгоё гэвэл тайрахаас аргагүй.

Цахилгаан тасарсаны дараа Жимми болоод өөр хоёр өвчтөнд судсаар нь антибиотик тариа хийсэн. Тариа дуслаар орж байсан ч хэмжих багаж тасарсан учраас сувилагч нар хэр их тун орсныг мэдэх боломжгүй. Түүнээс гадна Жиммигийн зүрхний хэмжилтийн дэлгэц болоод уушигт нь агаар өгч байсан амьсгалуурын багаж бас унтарсан. Расти амьсгалуурын багажийг салгаж аваад өвгөний нүүрэн дээр баг тавьж хүчилтөрөгчийн дэрийг хэрхэн ашиглахыг

Жинад зааж өгсөн юм. Бүсгүй хийж чадахгүй байсан ч тун их хичээсэн. Гэвч оройн 6 цаг гэхэд Жимми тэртэй тэргүй үхжээ.

Тэгээд одоо Жина цурхиран уйлж байна.

Тэр асуулт тавихын тулд нулимасанд норсон нүүрээ Растигийн цээжнээс салгав.

-Би түүнд хэт их хүчилтөрөгч өгчихсөн юм болов уу? Эсвэл хэт бага өгсөн үү? Би түүнийг бүтээгээд алчихсан уу?

-Үгүй дээ, Жимми тэртэй тэргүй үхэх байсан. Харин ч мэс заслын хутганд өртсөнгүй. Хөлийг нь тайрахгүй байх аргагүй байсан.

-Би дахиад ийм ажил хийж чадна гэж бодохгүй байна. Аймаар байна. Миний бие муу байна гэж хэлээд Жинна дахин цурхив.

Расти яахаа мэдэхээ больжээ. Яг энэ үед санаанд ороогүй тусламж ирэв.

-Чи өөрийгөө зүхээд байгаа юм уу? Чи ингэх ёстой. Яагаад гэвэл чамгүйгээр бид дийлэхгүй гэх сөөнгө дорой дуу сонсдоод Жинни Томлинсон хонгилоор алгуурхан ойртов.

-Чи босох хэрэггүй байсан юм даа гээд Расти толгой сэгсэрлээ.

-Тэр ч тийм байх гэж Жинни зөвшөөрөөд сэтгэл хөнгөрөх мэт урт амьсгаа авангаа Жинагийн дэргэд суулаа. Хамар дээр наасан тууз ба нүдэн доорх шархны тууз нь түүнийг хүнд хэцүү тэмцээний дараах хоккейчинтай тун адил харагдуулна.

-Гэсэн хэдий ч би ажилдаа эргэж орлоо.

-Маргааш дээргүй юу?... гэж Расти ярьж эхэлтэл

-Үгүй. Яг одоо. Чи ч бас ажилдаа ор. Намайг сувилагчийн сургуульд сурч байхад нэг настай сувилагч "хонгор минь цус хатах үед л чи ажлаа орхиж чадна" гэж надад хэлж билээ гээд тэр Жинагийн гараас атгав.

-Би алдаа гаргачихвал яах юм бэ? гэж Жина шивнэлээ.

-Бүгд алдаа гаргадаг. Гол нь аль болох бага алдах хэрэгтэй. Би чамд тусална. Гарриет та хоёрт тусална. Чи юу гэмээр байна даа?

Жина Жиннигийн хавдсан нүүр рүү эргэлзэн харна. Түүний хаа нэгтгээгээс олж зүүсэн хуучин шил нь огт чимэглэхгүй байлаа.

-Ийм санаачлагыг дэмжихээс өөр аргагүй. Гэвч хөл чинь салгалж эхлэх юм бол хоосон ор олоод хэвтээрэй. Энэ бол Расти эмч миний тушаал шүү.

Жинни инээх үед уруул нь дээш хамар руу татагдаж ярвайв.

-Хэрэв би хүссэн цагтаа Хаскель эмчийн амралтын өрөөн дэх хуучин буйданг ашиглаж болохоор байхад ямар ор хэрэгтэй юм бэ?

Растигийн утас хангинав. Тэр ажлаа хий гэх мэт бүсгүйчүүд рүү гараар дохилоо. Тэд ярилцан явж одов. Жина Жиннигийн бэлхүүсээр тэвэрчээ.

-Байна уу? Эрик Расти байна.

-Харин би Эрикийн эхнэр байна. Эрикээс уучлалт гуйхаар ярьж байна гэх бөглүү дуу хадлаа.

Расти одоо хоосорсон хүлээн авах өрөө рүү ороод хаалгаа хаав.

-Ямар ч уучлалт гуйх хэрэггүй дээ. Цаг хугацааны нөлөө шүү дээ. Ингэхэд түүнийг сулласан уу? гэж асуух үедээ тэр өөрийнхөө үгэнд эргэлзэж байв. Түүний мэдэх Барби хүн алж чадахгүй учраас энэ асуулт байж болох хамгийн зөв асуулт мэт өөрт нь санагдана.

-Би энэ талаар утсаар яримааргүй байна. Чи гэртээ ирж чадах уу? Гуйя. Бидэнд ярих юм байна.

Расти чадна гэж бодов. Амь насанд аюултай байдалтай ганцхан өвчтөн байсан нь дөнгөж саяхан нас барж түүний мэргэжлийн амьдралыг хавьгүй хөнгөвчилж өгсөн. Хэдийгээр хайртай эхнэртэйгээ хийсэн маргаанд цэг тавигдсанд сэтгэл нь хөнгөрсөн ч эхнэрийнх нь дуу ийм болгоомжтой байгаа нь түүнд таалагдсангүй.

-Чадна. Гэхдээ удаан байж чадахгүй. Жинни хөл дээрээ боссон. Гэхдээ би хянахгүй бол тэр дахиад унана. Хамт хооллох уу?

-Тэгье гэж хэлэх үед эхнэрийн мөрнөөс уул унах шиг хөнгөрч үүнийг мэдэрсэн Расти ч бас их баярлав.

-Би тахианы шөл халаая. Хий дуусахаас өмнө амжиж хөлдөөсөн хоол аль болох их идэх хэрэгтэй.

-Бас нэг юм байна. Чи урьдын адил Барбиг буруутай гэж бодсоор байна уу? Бусад хүмүүс юу гэж бодох хамаагүй юу?

Эхнэр нь удтал дуугүй байлаа.

-Энэ тухай гэртээ ярилцъя гээд холбоо тасрав.

Расти өвчтөнд үзлэг хийдэг ширээн дээр лагхийн суув. Тэр гар утас руугаа хэсэг ширтсэнээ улаан товчийг дарлаа. Түүнд олон юм ойлгомжгүй санагдана. Яг л асуултын тэнгист хөвж яваа хүнийг санагдуулна. Гэвч тэр ганцхан зүйлд эргэлзсэнгүй. Тэдний яриаг хэн нэгэн чагнаж байгаа гэж эхнэр нь боджээ. Хэн чагнасан байх вэ? Арми уу? Аюулгүй байдлын яам уу? Том Жим Ренни юу?

-Шал тэнэг юм гэж Расти хоосон өрөөнд өөртөө хэлэв. Тэгээд Твитчийг олж хэсэгхэн

хугацаанд гарахаар болсоноо хэлэхээр хонгил руу алхлаа.

9

Твитч Жиннид анхаарал тавихыг зөвшөөрөв. Түүнийг хэт их ажиллуулахгүй байх талаар хянахаар болов. Гэхдээ нэг болзол тавьлаа. Расти явахаасаа өмнө хүнсний үймээний үеэр гэмтсэн Генриетта Клаварыг үзэх ёстой.

-Тэр яачихсан юм бэ? гэж асуухдаа Расти муу зүйл сонсохоос айна. Хэдийгээр Генриетта өвчин тоочоод байдаггүй ч 84 настай хөгшин.

-Би түүний хэлсэн үгийг яг тэр чигээр нь чамд дамжуулъя. "Тэр новшийн эгч дүү Мерсье нарын нэг нь миний ахар сүүлийг хугалчихлаа" гэсэн. Тэр одоо Вензиано овогтой болсон Карлаг хэлээд байх шиг.

-За за манай хот жижиг болохоор бид бүгд нэг л багийн хөгжөөн дэмжигчид. Тийм биз дээ?

-Яг тийм, багш аа.

-Ахар сүүл хугарсан хэрэг үү?

-Мэдэхгүй. Тэр надад үзүүлэхгүй байгаа юм. Тэр "Би өмдөн доторхоо зөвхөн мэргэжлийн нүдэнд харуулна". Яг ингэж хэлсэн.

Тэд инээлдэв. Гэхдээ аль болох дуугаа дарахыг хичээв. Хаалттай хаалганы цаанаас эмгэний сөөнгө дурамжхан дуу хадлаа.

-Миний ахар сүүл хугарсан болохоос биш чих хугараагүй шүү. Би бүгдийг сонсож байна.

Расти Твитч хоёр бүр чанга инээлдлээ. Твитчийн царай хүрэнгээд ирэв.

-Хэрэв та нарын ахар сүүл гэмтсэн бол ингэж инээхгүй л байсан даа гэж Генриетта хэллээ.

-Хатагтай уучлаарай гэж хэлээд Расти инээсэн чигээр үзлэгийн өрөө рүү оров.

Эмгэн зогсох биш сууж байсан ба бас инээж байсан нь Растигийн сэтгэлийг хязгааргүй хөнгөрүүлэв.

-Зүгээр дээ. Манай энэ эмх замбараагүй үймээнд ямар нэг инээдтэй юм байх ёстой шүү дээ. Тэр нь би болог. Түүнээс гадна би бусадтай хамт хулгай хийсэн. Ахар сүүл хугарах нүгэл үйлдсэн байх.

10

Гэвч эмгэний ахар сүүл хугараагүй ба бага зэрэг хөхрөлт өгсөн нь тодорхой болов. Хэрэв ахар сүүл хугарсан бол инээдтэй зүйл огт үгүй болохоор ийм төгсгөлд баярлахаас өөр аргагүй. Расти эмгэнд өвчин намдаах түрхлэг өгч, бас гэрт нь адвил эм байгаа эсэхийг асуугаад,

хазганах боловч сэтгэл ханамжтай түүнийг гэр рүү нь явууллаа. Түүний хэрийн насны хатагтай хэр сэтгэл ханамжтай байж чадах тэр хэмжээнд байв.

Линда утасдсанаас хойш 15 минут орчмын дараа Расти хоёр дахь удаагаа эмнэлгийг орхих ородлого хийх үеэр Гарриет Бигелоу түүнийг авто зогсоол руу гарах хаалганы дэргэд зогсоов.

-Сэмми Буши явчихсан гэдгийг танд хэлээрэй гэж Жинни дамжуулсан.

-Хаашаа явчихсан юм бэ? гэж Расти асуув. Тэр дунд сургуульд байх үеэс хамгийн тэнэг асуулт бол тавиагүй асуулт гэсэн үзэлтэй болжээ.

-Хэн ч мэдэхгүй байна. Зүгээр л яваад өгсөн.

-Тэр хоол байгаа эсэхийг асуухаар "Эглентэри" рүү явчихсан юм болов уу? Би ийм байгаасай гэж найдаж байна. Яагаад гэвэл хэрэв тэр чиргүүл тэрэг рүүгээ явган алхсан бол бүх оёос нь задарч мэднэ.

Гарриетийн царайд түгшүүр тодров.

-Тэр цус алдаж үхэж мэдэх үү? Хэрэв түүний ву-ву-гаас цус алдвал тун муу биз дээ?

Хүмүүс умайг янз бүрийн үгээр нэрлэхийг Расти олон сонссон. Гэвч ингэж нэрлэхийг анх удаа сонсов.

-Үхэх нь хаашаа юм. Гэхдээ энд илүү удаан хэвтэхээр эргэж ирнэ. Хүүхэд нь яасан бэ?

Гарриетийн царайд айдас тодорлоо. Энэ хонгорхон бүсгүй догдлохоороо зузаан шилнийхээ цаана ойр ойрхон нүдээ цавчдаг ажээ. Ийм хүүхнүүд Смит юмуу Вассарын коллеж төгссөнөөс хойш 15 жил болоход өөрийгөө мэдрэлийн ядаргаанд хүргэдэг гэж Расти бодов.

-Хүүхэд, бурхан минь Литл-Уолтер гэж хашгираад Растиг зогсоож амжихаас өмнө гүйн одов. Тэр дороо царай нь хөнгөрсөн буцаж ирээд: -Энд байна. Нэг их хөдөлгөөнтэй хүүхэд биш. Угаас тийм араншинтай гэв.

-Тэгвэл Сэмми эргэж ирнэ. Түүнд ямар ч асуудал байлаа гэсэн тэр хүүдээ хайртай. Өөрийнхөөрөө хайрладаг.

-Юу гэсэн үг вэ гээд Гарриет дахиад л цавчиж гарав.

-Чухал юм биш ээ. Би аль болох хурдан буцаж ирнэ. Далиа битгий хумиарай.

-Далиа битгий хумиарай гэсэн үү?

-Өвчтөнүүдээ асар гэж би хэлэх гэсэн юм.

Гарриетын царай тавирав.

-Үүнийг бол би чадна шүү. Расти эмч ээ. Асуудал байхгүй.

Ямартаа ч эндээс явах санаатай Расти эргэв. Гэтэл энэ удаад түүний өмнө дэгээ хамрыг нь эс тооцвол нүдэнд дулаан царайтай, туранхай, өтгөн буурал үсээ ардаа боосон эр зогсч байлаа. Саяхан түүнийг залуу бүсгүй ба хоёр хүүхдийн хамт харсанаа Расти санав. Тэгээд дотроо "Эмч минь дээ, чи энэ эмнэлгээс ер нь гарч чадах нь уу?" гэж бодлоо.

-Ноёнтон би танд юугаар туслах вэ?

-Үнэнийг хэлэхэд би та нарт тусалж чадна гэж бодох юм. Намайг Терстон Маршалл гэдэг. Би хамтрагч бүсгүйтэйгээ Честер цөөрмийн дэргэд аялж яваад энэ байдалд орчихлоо гээд тэр ясархаг гараа сунгав.

-Би маш их харамсч байна.

-Юу гэвэл би анагаахын зарим нэг туршлагатай. Вьетнамын дайны үед би дүйцүүлэх албанд явсан юм. Уг нь Канад руу цагаачлах гэснээ... За тэр ч яахав нэг үгээр хэлэхэд дүйцүүлэх алба хааж Массачусетсийн ахмадуудын эмнэлэгт хоёр жил ажилласан.

Энэ хүн Растигийн сонирхолыг татлаа.

-"Эдит Ноурс Рожерс" эмнэлэг үү?

-Яг тийм. Мэдээж би амьдралаас их хоцорсон хүн. Гэвч... -Ноён Маршалл танд даалгах ажил надад байна.

11

117-р зам дээр гарсан хойноо Расти машин чагнаалдахыг сонсов. Толиндоо харвал хотын захиргааны олон нийтийн ажлын ачааны тэрэг эмнэлэг рүү орох зам руу эргэж байгааг олж харлаа. Хэдийгээр жаргаж байгаа нарны улаан туяа юм тод харахад нэмэр болохгүй байсан ч ачааны тэрэгний жолооны ард Стюарт Боуи сууж байх шиг санагдсан. Дахин нэг хараад Расти баярлав. Ачаан дээр хийтэй хоёр чингэлэг байх шиг. Хаанаасаа гарч ирсэнийг тэр хожим мэдэж болно. Тэр бүү хэл хэдэн асуулт ч тавьж мэднэ. Гэвч яг одоо бол сэтгэл нь хөнгөрөв. Удахгүй эмнэлэгт гэрэл асч дэлгэц ба амьсгалын төхөөрөмжүүд ажиллах юм байна. Нэг их удаан биш байж мэднэ. Гэвч тэр өнөөдрөөрөө амьдарч дасчээ.

Хотын төв талбайн дэргэдэх толгой орой дээр Расти өөрийн байнгын үйлчлүүлэгч болох алдарт скэйтч Бенни ба түүний хоёр найзыг олж харав. Пуужингийн цохилтын дүрс бичлэгийн шууд дамжуулалтыг зохион байгуулсан Жо нэг нь байлаа. Бенни гараар даллаж ямар нэг юм хашгирна. Растиг зогсож ярилцахыг хүсч байгаа нь эргэлзээгүй. Расти хариу дохисон ч хурдаа саасангүй. Тэр Линдатай уулзахаар тэсч ядна. Мэдээж тэр эхнэр нь юу ярихыг сонсох хүсэлд автаж байв. Гэхдээ хамгийн гол нь түүнийг харж, тэвэрч, бүрэн эвлэрэх нь чухал байлаа.

12

Барби бараг өмдөндөө шээх шахавч тэссээр байв. Тэр Иракт байцаалт явуулдаг байсан болохоор юу яахыг сайн мэднэ. Энд тэндэх шиг байна гэж баталж чадахгүй ч юу ч болж мэднэ. Нөхцөл байдал маш түргэн өөрчлөгдөж байна. Том Жим үйл явдлын өрнөлөөс үл хоггдох аймшигт чадвартайгаа харуулж байв. Тэр олонхи авьяаслаг хуурамчуудын нэгэн адил санаанд үл багтах ямар ч худлыг олон нийт хүлээн авахад бэлэн байдгийг тэр дор нь үнэлж чадаж байв.

Барбигийн ам нь цангаж зовно. Тэгээд цагдаа нарыгн нэг нь нэг гартаа устай шилэн аяга, нөгөө гартаа үзэг цаас барьсаар хорих өрөөний үүдэнд ирэхэд тэр огт гайхсангүй. Багдад, Мосул, Хилл, Такрит, Фаллуж гээд газар сайгүй яг л ийм байсан. Одоо Честерс-Миллд бас ингэх бололтой.

Гартаа устай шилэн аяга, үзэг цаас барьсан хүн нь бага Ренни байжээ.

-Хүүе энэ хүнийг хараад байгаарай. Чи одоо цэргийн зальжин арга мэхээрээ залуусыг дээрэлхэхэд тийм ч бэлэн биш байх шиг гэж тэр хэлээд үзэг цаас барьсан гараа өргөж хурууны үзүүрээр зүүн чамархайгаа үрлээ.

-Чи ч бас тийм сайн харагдахгүй л байна даа.

Жижгээ гараа буулгав.

-Би яг өргөст хэмх шиг эрүүл байна.

"Хачин юм даа. Хүмүүс бух шиг эрүүл юмуу эсвэл өргөст хэмх шиг сэргэг байна гэж хэлдэг. Харин өргөст хэмх шиг эрүүл гэж хэзээ ч сонсож байсангүй" гэж Барби бодов. Энэ хэллэг юу ч өгүүлэхгүй байж болно. Гэхдээ...

-Чи иттэлтэй байна уу? Нүд чинь улайжээ.

-Миний бүх юм чөтгөр шиг сайн байгаа. Тэгээд ч би энд өөрийнхөө тухай ярилцах гэж ирээгүй.

Жижгээ яах гэж энд ирсэнийг Барби мэдэж байсан ч асуув.

-Энэ ус уу.

Жижгээ аль хэдийн мартсан хүн аятай шилэн аяга руугаа харлаа.

-Тийм ээ, дарга чамайг цангаж зовж байгаа байх гэж хэлсэн. Мягмар гаригт пүрэв гариг, ойлгож байна уу? гээд тэр чанга инээв. Түүний уруул дээрээс энэ ойлгомжгүй хэллэгээс өөр хурц үг хэллэг хэзээ ч нисч байгаагүй аятай.

-Хүсч байна уу?

-Тийм ээ гуйя.

Жижгээ шилэн аягаа сунгав. Барби мөн гараа сунгалаа. Жижгээ гараа татаж авав. Мэдээж. Үргэлж ингэдэг.

-Чи яагаад тэднийг алсан юм бэ? Надад сонин байна Барби гуай. Энжи чамд биеэ тушаахгүй байсан уу? Дараа нь Додиг амталж үзсэн чинь тэр хөхөхөөс илүүтэй долоох дуртай байсан уу? Магадгүй Лестер лам харах ёсгүй тийм зүйлээ харсан уу? Брендад сэжиг төрсөн байх. Яагаад үгүй гэж? Тэр өөрөө цагдаа байсан. Эхнэр нөхөр хоёр гэдэг чинь ойлгомжтой шүү дээ гээд Жижгээ дахин инээлээ. Гэхдээ инээднийхээ цаана туйлын анхааралтай байгаа нь нуугдана. Бас өвчин. Барби энэ тал дээр маргахад бэлэн байв.

-За яасан бэ? Хэлэх юм алга уу?

-Би хэлсэн шүү дээ. Ус уумаар байна. Би цангаж зовж байна.

-Мэдээж тэгж таарна. Тэр "Мейс" ёстой новш шүү дээ. Тийм үү? Чи Иракт алба хаасныг би мэднэ. Тэнд тэгээд ямар байв даа?

-Халуун.

Жижгээ дахин инээхэд ус цалгиж бугуйн дээр нь асгарлаа. Гар нь чичрээд байна уу даа. Бас улайж хавдсан нүдний булангаас нулимс цийлэгнэв. Жижгээ минь чи яасан юм бэ? Толгой хатгуулж өвддөг юм уу? Эсвэл өөр өвчин үү?

-Чи тэнд хүн алсан уу?

-Тийм ээ. Хоолоороо.

Жижгээ инээд алдав. "Оновчтой наргиан" гэж хэлэх аятай.

-Барби чи тэнд ямар ч хоол хийгээгүй. Чи холбооны офицер байсан. Ямар ч гэсэн чиний хаасан албаны тухай ингэж бичсэн байна. Аав интернетээс чамайг хайж олсон. Чиний тухай тийм ч их юм алга. Гэхдээ бас байна. Чи сэжигтнүүдийг байцаадаг байсан гэж тэр үзэж байгаа. Магадгүй нууц ажиллагаанд оролцож байсан. Нэг тийм армийн Жейсон Борн. Тийм үү?

Барби дуугарсангүй.

-Чи тэнд хэн нэгнийг алсан эсэхээ хэл. Эсвэл би чамаас хэдэн хүн алсан гэж асуух ёстой юу? Энд алсан хүмүүсээс гадна пгүү дээ.

Барби дуугарсангүй.

-Залуу минь, энэ тун сайн ус гэдэгтэй маргахад бэлэн байна. Дээр усны савнаас авсан. Сайхан хүйтэн ус. Барби дуугарсангүй.

-Чам шиг залуус бөөн асуудалтай болоод эргэж ирдэг юм байна. Ямар ч гэсэн зурагтаар тэгж гарсан. Энэ үнэн үү худлаа юу? Үнэн үү эсвэл буруу юу?

"Үгүй юм байна. Шалтгаан нь толгойгоор хатгах өвчин биш. Толгойгоор хатгах үед хүн хольж хутгаад байдаггүй".

-Жижгээ чиний толгой хэдийнээс өвдсөн юм бэ?

-Огт өвддөггүй юм.

-Чиний толгой эртнээс өвдсөн үү?

Жижгээ шилэн аягаа шалан дээр болгоомжтой тавьлаа. Энэ орой түүний бүсэнд гар буу зүүлттэй байв. Тэр буугаа гаргаад торны завсар Барби руу чиглүүллээ. Бууны ам бага зэрэг чичирнэ.

-Цаашдаа ч эмч болж тогломоор байна уу?

Барби гар буу руу ширтэнэ. Жүжгийн найруулгад гар буу байгаагүй гэдэгт тэр эргэлзсэнгүй. Том Жим түүнд зориулж тодорхой төлөвлөгөө гаргасан. Магадгүй Барбигийн хувьд баярлах төлөвлөгөө биш боловч энэ төлөвлөгөөнд хорих өрөөндөө буудуулсан Дейл Барбара лав ороогүй. Учир нь хэн нэгэн шатаар доош гүйж буугаад хорих өрөөний хаалга урьдын адил цоожтой ба хохирогч зэвсэггүй байгааг олж харна. Гэвч Жижгээ найруулгыг ян тан дагана гэж тэр найдахгүй байв. Учир нь энэ залуу ямар нэг өвчтэй юм байна.

-Үгүй. Анагаахаар хийх аялал дууслаа. Маш их харамсч байна.

-Тийм ээ, чи маргаангүй харамсч байгаа. Чи харамсалтай бөөн баас гэж Жижгээ хэлсэн боловч Барбарагийн уучлал гуйх нь түүний сэтгэлийг хангасан бололтой. Тэр гар буугаа буцааж хуйнд шургуулаад шалнаас устай аягаа авлаа.

-Миний таамаглаж байгаагаар чи өөрийн биш ухаантай амьтан эргэж ирсэн. Тэнд үзсэн харсан ба хийснээсээ болоод. Чи ойлгож байна уу? ПТСР, ПМС, ВГ гээд чи ойлгож байна уу? (эдгээр нь гэмтлийн гаралтай цухалдах өвчин, сарын тэмдгийн өмнөх өвчин, бэлгийн замын өвчний товчилсон нэрнүүд) Миний таамгаар бол чи ердөө л солиотой амьтан. Зөв үү?

Барби дуугарсангүй.

Гэвч Жижгээд хариулт нь сонин биш бололтой. Тэр аягатай гараа торон завсар сунгав. -Ав ав.

Жижгээ гараа татна гэдэгт итгэлтэйгээр Барби шилэн аяга руу гар сунгасан ч тэр тэгсэнгүй. Барби усыг амслаа. Бүлээн бөгөөд уух нөхцөлгүй.

-Алив алив, би аяганд давсны хагасыг л хийсэн. Чамд яг тохирно. Чи талх давсалж идцэг тийм үү? гэж Жижгээ хэлэв.

Барби Жижгээ рүү харна.

-Чи талх давсалдаг биз дээ? Талх давсалж иддэг тийм үү? Муу бэлгивч.

Барби шилэн аягыг торон завсар буцааж сунгав.

-Өөртөө үлдээ. Үүнийг бас ав гэж Жижгээ их юм өгч байгаа хүн шиг гараа саваад үзэг цаасаа хорих өрөө рүү сунгав.

Барби бичгийг уншлаа. Яг түүний бодож байснаар бүгд байв. Түүний гарын үсэг зурах газрыг ч заажээ.

Барби цаасыг Жижгээ рүү буцааж сунгахад өнөөх нь инээд алдаж толгойгоо саван бүжиглэнгээ хорих өрөөнөөс аль хэдийн холдов.

-Үүнийг ч өөртөө үлдээ. Чамайг шууд гарын үсэг зурахгүй боловч энэ тухай бодох болно гэж аав хэлсэн. Давсгүй аяга ус авах талаар бодох болно. Бас хоол. Жишээ нь том чизбургер. Магадгүй кока кола. Дээр хөргөгчинд хэдэн лааз байна билээ. Чи хүйтэн кола уумаар байна уу? Барби дуугарсангүй.

-Чи талхаа давсалдаг уу? Ичих хэрэггүй, хэл. Давс цацдаг уу? Муу баас.

Барби дуугарсангүй.

-Чи зохих ёсоор өлсч цангаад ирэхээрээ гарын үсэг зурна аа. Аав тэгж хэлсэн. Ийм ажилд тэр алдаггүй юм. Баяртай Барби. Чи над руу гар далайх хэрэггүй л байсан юм. Энэ чиний асар том алдаа гэж хэлээд тэр шат руу хөдлөв.

Жижгээ шатаар өгсөхдөө бага зэрэг хазганах юмуу эсвэл хөлөө чирч байгааг Барби анзаарав. Тийм ээ, зүүн хөлөө чирч байна. Бас тэнцвэрээ хадгалахын тулд баруун гараар шатны бариулаас зуурч байна. Энэ бүх шинж тэмдэгийг хараад Расти Жижгээд ямар онош тавих бол гэж Барби өөрөөсөө асуув. Ингэхэд Растигаас ямар нэг юм асуух боломж ер нь гарах эсэхийг ч өөрөөсөө асуув.

Барби гарын үсэг зураагүй мэдүүлэгээ дахин харлаа. Хэдэн хэсэг тасдаад хонгил руу чулуудмаар санагдана. Гэвч энэ нь хэнд ч хэрэггүй өдөөн хатгалт болно гэж тэр бодов. Барби муурны саварт оржээ. Ийм тохиолдолд хамгийн зөв нь чимээгүй хярах явдал. Тэр хуудас цаасыг ханзан дээр тавиад үзгийг цаасан дээр шидэв. Дараа нь шилэн аягыг шалнаас авлаа. Давсыг ханатал нь нэмжээ. Ямар үмхий ханхалж байгааг Барби мэдрэв. Честерс-Милл яг ийм үнэртэй гэж тэр бодлоо. Гэхдээ аль түрүүнд ийм болсон юм биш биз? Бүрхүүлээс өмнө. Том Жим ба түүний нөхдийн тусламжтай. Барби тийм гэж бодов. Бас энэ хорих өрөөнөөс гайхамшигаар л гарч чадна гэж бодлоо.

Гэсэн хэдий ч энэ тал дээр түүний эсрэг талынхан шинэхэн амьтад байжээ. Тэд жорлонг мартсан байна. Мэдээж тэдний хэн нь ч бохирын сувгаар урсч байгаа ус хүртэл дур булаам харагддаг тийм улсад байж үзээгүй л дээ. Ялангуяа 90 фунт зэвсэг хэрэгсэл үүрч 46 хэмийн халуунд явах үед.

Барби давстай усыг хорих өрөөний булан руу цацав. Дараа нь шилэн аяга руу шээгээд орон дороо тавьлаа. Тэгээд суултуур руу яг мөргөл үйлдэж байгаа хүн шиг тонгойж гэдсээ

Растиг хүрч ирэхэд Линда довжооны гишгүүр сандайлан сууж байв. Хашаанд Жекки бяцхан охидыг савлуур дээр тоглуулах бөгөөд цаадуул нь улам хүчтэй түлхэж дээш хөөргөхийг гуйна.

Линда гараа сунгасаар нөхөр рүүгээ хүрч ирэв. Уруул дээр нь үнсэж хойш ухран нөхрөө нэг харсанаа хоёр алгаар хацрыг нь шахаж ангайсан амыг нь дахин үнсэв. Расти эхнэрийнх нь хэл шүргэхийг мэдрээд өнөөх нь шууд босов. Мэдээж энэ нь Линдагийн анхаарлаас мултраагүй тул тэр биенд нь наалддаа.

-Пөөх. Ингэхэд бид нар хүмүүсийн нүдэн дээр аль болох олон муудалцах хэрэгтэй юм байна шүү. Хэрэв чи наадахаа одоо зогсоохгүй бол бид хүмүүсийн нүдэн дээр өөр нэг юм хийж мэдэхээр байна гэж Расти өөрийн эрхгүй хэллээ.

-Бид хийх болно. Гэхдээ хүмүүсийн нүдэн дээр биш. Юуны өмнө би чамаас дахин уучлал гуйх ёстой.

-Үгүй дээ.

Бүсгүй түүний гараас атгаж довжоо руу алхлаа. -За яахав. Бид ажил ярих хэрэгтэй байна. Тун ноцтой ажил.

Бүсгүй нөгөө гараа нөхрийнхөө гар дээр давхарлаж тавьлаа.

-Би сонсч байна.

Бүсгүй цагдаагийн газарт болсон бүхний тухай түүнд ярив. Энди Сандерсыг доош бууж баривчлагдсан хүнтэй нүүр тулан уулзахыг зөвшөөрсөний дараа Жулияг тэндээс хөөж гаргасан. Мөн Жекки тэр хоёр Жулиятэй ярилцахаар сүмд очсон тухайгаа ярив. Тэнд Пайпер ба Ромми нар нэмэгдсэнийг хэлэв. Тэгээд Жекки тэр хоёр Брендагийн цогцос дөнгөж хөшиж байгааг анзаарсан тухайгаа ярьж эхлэх үед Расти чихээ хурцаллаа.

-Хүүе Жекки, цогцос дөнгөж хөшиж эхэлж байсан тал дээр чи итгэлтэй байна уу? -Дэндүү итгэлтэй.

-Сайн уу аав аа? Жанни бид хоёр "Нар" эргэлдүүлж тоглох гэж байна гэж Жүди хашгирлаа.

-Үгүй одоо болсон гэж Расти хэлэнгээ охид руугаа агаараар үнсэлт илгээн довжоогоор өгсөв. Охид агаарын үнсэлтийг барьж авлаа. Энэ тал дээр тэдэнтэй эн зэрэгцэх хүн үгүй.

-Линда та нар цогцоснуудыг хэдэн цагт үзсэн юм бэ?

-Үд дундаас хойш. Их дэлгүүрийн замбараагүйтэл аль хэдийн дууссан байсан.

-Хэрэв Жекки цогцос дөнгөж хөшиж эхэлсэн тал дээр алдаа гаргаагүй бол... Гэхдээ бид үүнд

бүрэн итгэлтэй байж болно тийм үү?

-Үгүй чи сонсож бай. Би Роузтай ярьсан. Барбара 5 цаг 50 минутанд "Эглантери"-д ирсэн гэсэн. Энэ цагаас эхлээд цогцос илрүүлэх хүртэл хугацаанд хаана байсан тал дээр төмөр баталгаатай гэсэн үг. Тэгэхээр тэр хэзээ Брендаг алсан байх вэ? Өглөөний 5 цагт уу? 5.30-д уу? Дөнгөж хөшиж эхэлж байсан болохоор ингэх магадлал хэр байна вэ?

-Магадлал бага хэдий ч байж болно. Хүүр хөших нь олон хүчин зүйлээс хамаардаг. Жишээ нь цогцос байгаа газрын агаарын хэмээс. Ингэхэд тэр зооринд халуун байсан уу?

-Дулаан байсан. Дулаан бөгөөд үмхий гэж хэлээд бүсгүй хоёр гараа энгэр дээр зөрүүлж мөрөө атгав.

-Миний юу хэлэх гээд байгааг ойлгож байна уу? Ийм нөхцөлд тэр хохирогчийг өглөөний 4 цагт алаад энэ байшин руу чирч авчраад хаях...

-Би чамайг Барбигийн талд гэж бодсон юмсан.

-Тэр ч тийм л дээ. Тэгээд ч миний таамаг үнэн хэрэгтээ магадлал тун бага. Яагаад гэвэл өглөөний дөрвөн цагт зоорины өрөөнд хавьгүй сэрүүн байсан байж таарна. Тэгээд ч өглөөний 4 цагт тэр яаж Брендатай хамт байх юм бэ? Цагдаа нар энэ тал дээр юу хэлэх бол? Тэр өнөөх эмэгтэйтэй хурьцаж байсан хэрэг үү? Тэр бүү хэл түүнд ахимаг насны эмэгтэй таалагддаг байлаа ч... Бүр хөгшин эмэгтэй... 40 жил хамт амьдарсан нөхрөө үхээд гуравхан хонож байхад ийм юм болох уу?

-Цагдаа нар бол харилцан зөвшилцөл байгаагүй гэж хэлнэ. Тэд үүнийг хүчиндсэн гэж хэлэх болно. Өнөөх үхсэн хүүхнүүдийн талаар хэлснээ л хэлэх болно гэж Линда хуурай хариуллаа.

-Тэгвэл Лестер лам?

-Хэрэв Барбараг золионд гаргаж байгаа юм бол тэд ямар нэг юм бодож олох л байх.

-Тэгээд Жулия энэ бүхнийг бичиж хэвлэх гэж байгаа юмуу?

-Тэр нийтлэл бичиж бас зарим нэг асуулт тавих гэж

байна. Тэр цогцос хөшиж эхэлж байсан тухай мэдээллийг өлгөж авах гэж байна. Хэн энэ тухай ярьсаныг таамаглах тал дээр Рэндолф дэндүү тэнэг байж болно. Харин Ренни бол шууд ойлгоно.

-Энэ мэдээж аюултай. Хэрэв тэд бүсгүйн амыг таглах юм бол тэр Эй-Си-Эл-Ю руу хандаж чадахгүй болно доо. (энэ нь Америкийн хүний эрхийг хамгаалах холбоо)

-Түүнд хамаагүй гэж би бодож байна. Тэр маш ууртай байна билээ. Тэр бүү хэл хүнсний самууныг хэн нэгэн зохион байгуулсан гэж бодож байсан.

Үнэхээр тийм байх гэж Расти бодсон ч өөр юм ярьлаа.

-Чөтгөр гэж би цогцоснуудыг үзэхийг маш их хүсч байна.

-Магадгүй чи ингэж чадна.

-Хонгор минь, чиний юу бодож байгааг би мэдэж байна. Ингэлээ гэхэд Жекки та нар ажилгүй болно. Хэрэв Том Жим одоо саад болж байгаа хүн бүрийг зайлуулж байгаа тохиолдолд ажлаар ч зогсохгүй байх.

-Бид холоос хараад зогсч чадахгүй.

-Ингэж азаа үзлээ гээд ашиг гарах эсэхийг дахин бодох хэрэгтэй. Магадгүй үгүй ч байж болно. Хэрэв одоо хүүр хөшиж эхэлсэн бол би гаднах үзлэг хийлээ гээд хэлэх юм тун бага. Касл тойргийн шүүх эмнэлгийн шинжээчид бол тусгай төхөөрөмж байгаа байх. Гэвч бид Эй-Си-Эл-Ю-д хүрч чадахгүй шигээ тийшээ ч хүрч чадахгүй л дээ.

-Чи өөр ямар нэг юм анзаарч мэднэ. Түүний хүүрнээс юмуу бусдынх нь хүүрнээс. Зарим нэг анатомийн театрын хаалган дээр "Энд үхсэн хүмүүс амьд хүнтэй ярилцдаг" гэсэн бичээс байдгийг чи мэднэ.

-Боломж тун бага. Яасан нь дээр вэ гэдгийг мэдэх үү? Барби 5.50 гэхэд ажилдаа ирснээс хойш Брендагийн амьд байхыг харсан хэн нэгэн олдох юм бол сайн. Хөлгийн бүхээгт ийм нүх үүсвэл таглах аргагүй.

Унтлагын хувцасаа өмссөн Жүди Жани хоёр тэврүүлэхээр гүйж ирэв. Расти тэдний хүслийг зохих ёсоор бүрэн хангалаа. Араас нь дагаж явсан Жекки Растигийн сүүлчийн яриаг сонссон байжээ.

-Би асууж сураглах болно.

-Гэхдээ илүү дутуу шуугиан бүү тариарай.

-Итгэлтэй байж болно. Гэхдээ... Түүний цэргийн таних тэмдгийг Энжигийн гарнаас олсон...

-Тэгэхээр Барби хамгийн эхний хүнийг алаад хожим энэ олон цогцосыг илрүүлэх хүртэлх тэр урт хугацаанд тэмдгээ үгүйлээгүй хэрэг үү?

-Аав аа, юун цогцос вэ? гэж Жанни асуув.

Расти уртаар санаа алдлаа.

-Охин минь, энэ бүхэн ойлгоход их хэцүү. Тэгээд ч жаахан охидын хэрэг биш.

Энэ тайлбар сэтгэлд нийцсэн болохыг Жаннигийн нүд харуулав. Харин охин дүү нь цэцэг тасдах санаатай холдсон бөгөөд гар хоосон буцаж ирлээ.

-Цэцэгс үхэж байна. Бүгд хар хүрэн өнгөтэй болоод захаараа хатчихжээ гэж охин илтгэв.

-Цэцгэнд хэт халуун байх шиг байна гэж Линда хэллээ. Эхнэр нь яг одоо уйлах гэж байгаа мэт Растид санагдав. Шагайвар руу түргэхэн очив.

-Охидоо, шүдээ угаагаад унт. Ширээн дээрх домбоноос бага зэрэг ус аваарай. Жанни чи ус хийж өг. Одоо явцгаа гэж хэлээд тэр бүсгүйчүүд рүү эргэв. Үнэндээ бол Линда руу эргэлээ. - Чи ямархуу байна даа.

-Хэвийн. Зүгээр л... Энэ бүхэн миний тал талаас шахаж байна. "Цэцэгс үхэх ёсгүй" гэж нэг бодно. Тэгснээ тэр дороо "Ер нь ийм юм болох ёсгүй байсан" гэж бодох юм.

Тэд дуугаа хураав. Дараа нь Расти ам нээлээ.

-Бид хүлээж харах хэрэгтэй. Рэндолф цогцос үзэх санал надад тавих эсэхийг хүлээе. Хэрэв ийм санал тавих юм бол би та нарыг золиослох аюулгүйгээр ажлаа хийчихнэ. Хэрэв санал тавихгүй бол энэ нь бидэнд зарим нэг юмыг тодорхой болгож өгнө.

-Одоохондоо Барби шоронд байгаа пгүү. Магадгүй яг одоо түүнээс хүчээр мэдүүлэг авч байж ч мэднэ гэж Линда сануулав.

-За яахав та нар цагдаагийн тэмдгээ харуулаад намайг оршуулгын товчоо руу авч орлоо гэж бодъё. Би Барбиг зөвтгөх ямар нэг юм олсон гэж бодъё. Тэд нар "Өө чөтгөр гэж, бид алдаа гаргажээ" гэж хэлээд түүнийг суллана гэж та нар бодоод байна уу? Дараа нь түүнд хотын эрх мэдлийг гартаа авахыг зөвшөөрөх үү? Засгийн газар ингэ гээд байгаа болохоор тэгэх хэрэг үү? Ренни энэ бүхнийг зөвшөөрнө гэж бодож байгаа хэрэг үү?... Энэ үед Растигийн утас хангиналаа. -Бүх цаг үеийн туршид бүтээсэн хамгийн муу бүтээл гэж тайлбарлав. Ямартаа ч эмнэлгээс залгаагүй байлаа.

-Та ноён Расти юу? гэх эмэгтэй хүний дуу гарав. Дууны өнгийг санаж байсан ч яг хэн болохыг танисангүй.

-Тийм ээ, гэхдээ онцгой зүйл биш бол би одоо ажилтай байна...

-Онцгой эсэхийг би мэдэхгүй. Гэхдээ маш чухал болохыг мэднэ. Ноён Барбара, нарийн хэлэх юм бол хурандаа Барбара баривчлагдсан болохоор та л энэ ажлыг гартаа авах ёстой.

-Хатагтай Макклэтчи юу?

-Тийм ээ. Гэхдээ та Жо-той ярих ёстой. Тэр энд байна. -Расти эмч үү? гэх догдолж хөөрсөн дуу хадлаа. -Сайн уу? Жо. Юу болоо вэ?

-Бид үүсгүүрийг олсон гэж бодож байна. Одоо бид яах

вэ?

Энэ үед гэрэл огцом бүдгэрэхэд тэд гурвуулаа дуу алдаж, Линда Растигийн гараас зуурч авав. Гэвч нар Бүрхүүлийн баруун хэсэгт үүссэн хөө тортогон толбоны цаагуур орсон байжээ.

-Хаана?

-Блэк-Ридж.

-Цацраг идэвхит туяагаар олсон юмуу? гэж Расти асуухдаа хариултыг мэдэж байв. Тэд өөр юугаар олох билээ дээ.

-Хамгийн сүүлд бидний тэмдэглэсэн үзүүлэлт нь нэмэх 200. Гэхдээ улаан бүс биш. Тэгэхээр бид яах вэ?

Расти сул гараар үсээ илэв. Эргэн тойрон дэндүү олон үйл явдал болоод байна. Дэндүү олон үйл явдал, бас дэндүү хурдан болж байна. Ялангуяа шийдвэр гаргах, тэр тусмаа манлайлах нь түүний даах зүйл биш гэж боддог жижигхэн хотын бяцхан бариачийн хувьд.

-Өнөө орой юу ч хийхгүй. Бараг харанхуй болчихлоо. Харин одоохондоо Жо чи надад зарим нэг зүйлийг амлах хэрэгтэй. Олзынхоо тухай хэнд ч бүү хэлээрэй. Бенни, Норри, ээж та дөрөв л мэднэ. Энэ чигээрээ үлдэг.

-Ойлголоо. Бид танд зөндөө юм яримаар байна. Гэхдээ маргааш хүртэл хүлээж чадна. Бага зэрэг аймаар байна гэж хэлэх үед Жо-гийн хөөрүү сэтгэл дарагдаж, уртаар санаа алдлаа.

-Тийм ээ, бага зэрэг айлгаж байна.

14

Милл хотын хувь заяаг гартаа атгаж байгаа эр ажлын өрөөнд ширээний ард суугаад хатсан хар талх дээр тавьсан жигнэсэн махыг том том хазан иднэ. Энэ үед Жижгээ хаалгаар орж ирэв. Том Жим дөнгөж сая 45 минут унтсан болохоор хамаг бие нь сэргэж цаашдын ажилдаа бэлэн болжээ. Тэмдэглэлийн дэвтэрээс урж авсан хуудаснууд ширээн дээр хөглөрөх бөгөөд өнөө орой тэдгээрийг хог шатаах зууханд хийж үнс болгоно. Хэт болгоомжтой байх нь хэнд ч хор хүргэхгүй.

Ажлын өрөөнд Коулманы чийдэн шажигнан асах бөгөөд хурц цагаан гэрэл түгээнэ. Шатдаг хийн багагүй нөөц хаана байгааг Ренни мэднэ гэдгийг бурхан гэрчилнэ. Тэр нөөцөөр гэрээ 50 жил гэрэлтүүлэхийн зэрэгцээ бүх цахилгаан төхөөрөмжийг ажиллуулахад хангалттай. Гэвч тэр Коулманы чийдэнг илүүд тооцно. Учир нь байшингийн хажуугаар өнгөрөх хүмүүс энэ хурц цагаан гэрлийг хараад хотын захиргааны гишүүн Ренни ямар ч эрх дарх эдлэхгүй байгаа ба тэдэнтэй л адил хүн бөгөөд бүрэн итгэж болох хүн гэсэн сэтгэгдэл төрүүлэхийг хичээнэ.

Жижгээ бага зэрэг хазганана. Түүний царай бүр цонхийжээ.

-Тэр хэргээ хүлээгээгүй.

Том Жим Барбараг тийм хурдан хэргээ хүлээнэ гэж тооцоолоо ч үгүй учраас ху^лгийнхээ хэлснийг тоосонгүй.

-Чи яачихаа вэ? Аймаар харагдаж байна.

-Дахиад л толгой өвдөөд. Гэхдээ одоо сайн байна.

Тэр үнэнийг хэлсэн юм. Түрүүн Барбитай ярилцах үед харин бүр дордсон. Түүний цэнхэр саарал нүд эсвэл их юм олж үздэг, эсвэл үзсэн мэт царайлдаг аж.

Түүний нүд "Чи зоорины өрөөнд тэдэнтэй юу хийснийг би мэдэж байна. Би бүгдийг мэдэж байна" гэж хэлж байсан.

Гар буугаа суга татсаны дараа гохийг нь дарахгүйн тулд сэтгэлийн бүх тэнхээгээ дайчлахад хүрсэн юм. Энэ нүд үүрд хаагдаасай гэж тэр маш их хүссэн.

-Чи бас хазганаад байна.

-Честерсийн цөөрөмд олсон хүүхдүүдээс болсон юм. Би нэгийг нь тэвэрч яваад булчингаа сунгачих шиг боллоо.

-Шалтгаан нь зөвхөн энэ гэдэгт чи итгэлтэй байна уу? Картер та хоёр нэг жижиг ажил хийх ёстой. Гурван цаг хагасын дараа. Бас энэ ажлыг баллаж огт болохгүй. Бүх юм санаанд хүртэл байх учиртай гээд Том Жим цагаа харав.

-Тэр ажлыг чинь харанхуй болохоос өмнө хийж яагаад бодцоггүй юм бэ?

-Яагаад гэвэл шулмас өөрийн хоёр чөтгөрийн хамт сонин бэлдэж байгаа. Пит тэр хоёртойгоо. Өнөөх үргэлж "Зэрлэг муурнууд" руу дайрч давшилдаг спортын сурвалжлагчтай хамт.

-Тони Гуэй гэдэг юм.

-Яг тэр мөн. Тэд, ялангуяа шулмас хохирлоо гэхэд би огт санаа зовохгүй. Гэтэл ямар нэг юм харсан гэрч огт байх ёсгүй. Харин сонсохын тухайд бол... Энэ шал өөр хэрэг гэж хэлэх үед Том Жимийн дээд уруул нохойн инээдээр цорвойв.

-Аав аа, хүмүүс юу сонсох ёстой гэж?

-Чиний хүч хүрнэ гэдэгт итгэлтэй байна уу? Яагаад гэвэл би чиний оронд Френкийг Картертай явуулж болох юм.

-Үгүй дээ. Би Лестер ламыг янзлахад чамд тусалсан. Өнөө өглөө бас чавганцын хэрэг дээр тусалсан. Тэгэхээр тийшээ явах гавьяатай хүн.

Том Жим шинжих мэт түүнийг ширтэв. Дараа нь толгой дохиод:

-За за. Гэхдээ чамайг хэн нэгэн анзаарах юмуу барьж авч огт болохгүй гэдгийг сана.

-Бүү санаа зов. Чи юу хүсээ вэ?... Гэрч нар юу сонсох ёстой гэж?

Том Жим хэлж өглөө. Том Жим түүнд бүгдийг хэлэв. Гайхалтай санаа гэж Жижгээ бодов. Үүнийг хүлээн зөвшөөрөхгүй байж чадсангүй. Түүний хайртай эцэг нэг ч боломжийг

Жижгээ хөлөө амраах санаатай дээшээ гарах хооронд Том Жим хавчуургатай талхаа идэж дуусаад эрүүний тосоо арчиж Стюартын гар утас руу залгав. Тэр хэн нэгний гар утас руу залгах юм бол үргэлж тавьдаг асуултаа тавьсанаар яриагаа эхэллээ.

-Чи хаана байна?

Стюарт жаахан уух санаатай оршуулгын товчоо руу явж байгаагаа хэлэв. Том Жим согтууруулах ундааны талаар ямар ханддагатайг мэдэх болохоор ажилчин хүний дайчин байдалтайгаар ярилаа.

-Би ажлаа хийсэн. Тэгэхээр миний таашаал авахад бүү садаа бол.

-За за. Гэхдээ ганц аягыг л уу. Энэ өдөр чиний хувьд дуусаагүй шүү. Ферн ба Рожерын хувьд ч мөн адил гэж хэлмэгц нь Стюарт хүчтэй эсэргүүцэв. Түүнийг ярьж дуусангуут Том Жим яриагаа үргэлжлүүлээ.

-Та гурав ес хагас гэхэд дунд сургууль дээр ирэх ёстой. Тэнд хэд хэдэн шинэ цагдаа нар байх болно. Рожерын хүүхдүүд ч бий. Та гурав тэнд хэрэг болно. Би чамайг Честерс-Милл хотын аюулгүйн албаны ахлагчаар томилохыг хүсч байна.

Ферн тэр хоёрын товчоон дээр дөрвөн ч цогцос байгаа тухай Стюарт Том Жимд санууллаа.

-Маккейний зоориноос олдсон цогцоснууд хүлээж чадна. Тэртэй тэргүй үхдэл юм чинь. Хэрэв чи анзаараагүй байгаа бол манай хотод онцгой нөхцөл байдал үүссэн. Хямрал дуусах хүртэл бид бүгд махийх хэрэгтэй. Чи ч бас хувь нэмрээ оруул. Багаа дэмж. 9 хагас гэхэд сургууль дээр ир. Гэхдээ эхлээд та нар бас нэг юм хийх хэрэгтэй. Нэг их цаг авахгүй. Алив утсаа Фернд өг.

Стюарт дүү Фернийгээ адгийн тэнэг гэж үндэслэлгүй биш боддог болохоор яагаад түүнтэй ярих гээд байгааг Том Жимээс асуув.

-Чиний ухаан хүрэх ажил биш. Зүгээр л гар утсаа түүнд өг. Ферн мэнд мэдэв. Том Жим үүнийг тоолгүй шууд ажилдаа орлоо.

-Чи гал сөнөөх сайн дурын нөхөрлөлд багтаж байсан тийм үү? Нөхөрлөлийг тараах хүртэл.

Честерс-Миллийн гал сөнөөх багт албан бусаар багтаж байсан нь үнэн гэдгээ Ферн хэллээ. Гэхдээ нөхөрлөлийг тараахаас нэг жилийн өмнө орхисноо хэлсэнгүй. (2008 оны төсөвт хотыгн захиргааны гишүүд нөхөрлөлд зориулах мөнгө тусгаагүй юм) Тэр бас өөр зүйлсийг ч хэлсэнгүй. Нөхөрлөлд зориулан хандив цуглуулах үйлсэд архи уух хамаг үнэт цагаа ашиггүй үрж байснаа ч хэлсэнгүй.

-Чи цагдаагийн газарт очоод гал сөнөөх хэсгийн түлхүүрийг ав. Дараа нь өчигдөр Берпигийн

хэрэглэж байсан галыг гар насосууд байгаа эсэхийг шалга. Талийгаач Бренда тэр хоёр тийш нь хийсэн гэж надад хүн хэлсэн. Гэхдээ шалгах хэрэгтэй.

Гар насосыг "Берпигийн их дэлгүүр"-ээс авсан бөгөөд түүний өмч болохыг Ферн сануулав. Уг нь нөхөрлөлд өөрийн насос байсан боловч тараасны дараа интернетээр үнэ хаялцуулан зарсан.

-Насосууд урьд нь түүнийх байсан байж болно. Одоо бол үгүй. Хямралын үед эдгээр насос хотын өмч юм. Бидэнд хэрэг болох бүхнийг ингэж тооцох болно. Яагаад гэвэл үүнийг бүх нийтийн тусын тулд хийж байна. Хэрэв Ромми дахиад галын нөхөрлөл байгуулж чадна гэж бодож яваа бол дэмий хэрэг.

Хүмүүсийн ярьж байгаагаар пуужингийн цохилтын дараа үүссэн галыг Берпи маш түргэн унтрааж чадсан гэж Ферн болгоомжтой хэллээ.

-Тэр тэнд үнсний саванд цогшсон тамхины үлдэгдэл унтраасан байх гэж Том Жим тургив. Чамархайн судас лугшиж, зүрх нь дэндүү хүчтэй дэлсэнэ. Тэр дахиад л маш хурдан идсэнээ мэдэж байв. Гэвч үүнийг яаж ч чадахгүй. Өлссөн үедээ өмнөө байгаа бүхнийг шууд л залгадаг. Тэр ийм л хүн.

-Түүнийг хэн ч унтрааж чадах байсан. Чи ч чадна. Ярианы гол нь өнгөрсөн сонгуулиар хэн миний төлөө санал өгсөн, хэн үгүй гэдгийг би мэддэгт байгаа юм. Миний төлөө саналаа өгөөгүй хэн боловч шалчгар чихэр ч олж идэхгүй.

Насосуудыг яах тухай Ферн Том Жимээс асуулаа.

-Галын хэсэгт байгаа гэдгийг эхлээд шалгана. Дараа нь сургууль руу хүрээд ир. Бид спорт танхимд байж байя.

Рожер түүнтэй ярихыг хүсч байгаа тухай Ферн уламжиллаа.

Том Жим залхах мэт тэнгэр рүү харсан ч угсаа бариад хүлээв.

Түүний хүүхдүүдийн хэн нь цагдаа болж байгааг Рожер мэдэхийг хүсчээ.

Ренни санаа алдаад ширээн дээр тараасан цааснуудыг ухаж ухаж шинэ цагдаа нарын нэрсийн жагсаалтай хуудсыг олов. Ихэнхи нь ахлах ангийн эрэгтэй сурагчид хамгийн бага нь болох Микки дөнгөж 15 настай боловч аль хэдийн хулигаан хэмээн нэрд гарчээ. Хөл бөмбөгийн багийн баруун гарын хамгаалагч байсан ч архи уусан хэргээр тэндээс хөөгдсөн.

-Рики ба Рэндолл хоёр.

Рожер эсэргүүцэв. Тэд айлын том хүүхдүүд ба түүний ажлаа үүрүүлэх ёстой хүүхдүүд учир тахиагаа маллахад хэн туслахыг Рожер асуув.

Том Жим нүдээ аниад бурхан тэнгэрээс хүч тэнхээ гуйлаа.

Сэмми сарын тэмдэг ирэх үеийнх шиг гэдэсний доогуур үе үе өвдөхийг мэдэрч байв. Бас түүнээс доошоо хурц хатган өвдөнө. Өвдөлтийг тоохгүй байх ямар ч арга алга. Учир нь алхах болгонд шинээр хатгана. Гэсэн хэдий ч тэр Моттон-Роудыг чиглэн 119-р замаар гүрийн алхана. Өвдсөн ч явахаар шийджээ. Тэр энэ аялалын эцсийн зорилгыг ян тан мэдэж байгаа ба чиргүүл гэрийн тухай энд яригдахгүй. Түүнд шаардагдаж байгаа зүйл чиргүүл тэргэнд байхгүй. Гэхдээ хаанаас авахыг тэр сайн мэднэ. Бүх шөнөжин алхах хэрэг гарсан ч тэр явах л байсан. Хэрэв өвчин тэсэхийн аргагүй болж ирвэл түүний жинсний хармаанд байгаа таван ширхэг перкосет эмийг зажилж болно. Эмийг захлахаар хурдан үйлчилдэг. Фил түүнд ингэж хэлдэг байсан.

Түүнийг эзэмд.

Чамтай жинхэнээсээ энэ ажлыг хийхийн тулд бид дахиад эргэж ирнэ.

Наад гичийгээ эзэмд.

Чи зөвхөн сөхөрч суусан үедээ л амаа ангайж сурах хэрэгтэй.

Түүнийг эзэмд. Энэ гичийг эзэмд. Тэртээ тэргүй чамд хэн ч итгэхгүй.

Гэхдээ Пайпер гэлэнмаа түүнд итгэсэн л дээ. Тэглээ гээд өөрөө яасныг хар. Нохой нь алагдаж мөр нь мултарсан. Энэ гичийг эзэмд.

Тэр араатны тачаал өдөөгдсөн цангинасан дуу бүх насаар толгойд нь дуурсах байх гэж Сэмми бодлоо.

Тийм болоод л энд алхаж явна. Толгой дээр эхний ягаан одод асав. Энэ нь бохир шилний цаанаас ёлтойх оч юм.

Араас нь гэрэл туслаа. Түүний сүүдэр зам дээр уртсав. Фермерийн хуучин ямбий пикап машин давхиж ирээд зогслоо.

-Хүүе наашаа суу гэх эрэгтэй хүний дуу гарав. Гэхдээ энэ үгсийг согтуу орооцолдсон дуугаар хэлсэн тул "Хүү-хүү-е-е-с-уу-уу" гэх мэт сунжирав. Жолооны ард талийгаач Роригийн аав согтуу Динсмор сууж явав.

Гэсэн хэдий ч Сэмми тахир дутуу хүн шиг болгоомжтойгоор машинд орж суулаа.

Динсмор үүнийг анзаарсангүй. Түүний хөлний завсар "Бад" шар айрагны лааз хөглөрнө. Харин хажуугийн сандал дээр тал нь хоосорсон хайрцагтай шар айраг байв. Хоосон лаазнууд Сэммигийн хөл доогуур өнхөрч ирээд мөргөх ажээ.

-Хаашаа явж байна вэ? Моттон уу? гээд Динсмор согтуу байхдаа ч наргих чадвартайгаа харуулах гэж инээлээ.

-Моттон-Роуд ноёнтон. Таны зам нийлэх үү?

-Би хаашаа ч зам нийлнэ. Би зүгээр л явж байна. Би хүүгийнхээ тухай бодоод л явж байна. Тэр бямба гаригт үхсэн.

-Танд тохиолдсон гарзанд би маш их харамсч байна.

Тэр толгой дохиод шар айргаа залгив.

Миний эцэг өнгөрсөн өвөл нас барсан юм. Хөөрхий амьтан амьсгалж чадахгүй байсан. Сүүлийн нэг жилийг хүчилтөрөгч сорж өнгөрөөсөн. Рори маань хүчилтөрөгчтэй баллон сольж өгдөг байж билээ. Өвөөдөө хайртай байсан даа.

-Би маш их харамсч байна.

Тэр энэ үгийг түрүүнд хэлсэн. Гэхдээ одоо өөр юу хэлэх юм бэ?

Динсморын хацар даган нулимс урсав. -Хатагтай Лу таны хэлсэн газар руу би явна. Би шар айргаа дуустал давхимаар байна. Шар айраг уух уу? -Тийм ээ, гуйя.

Хэдийгээр шар айраг бүлээн байсан ч Сэмми шунамхайран уув. Тэр их цангаж байлаа. Тэр хармаанаас нэг эм авч ам руугаа шидээд шар айрагнаас уртаар сорж даруулав. Толгой нь дүнгэнэхийг мэдэрлээ. Энэ сайн хэрэг. Хармаанаас дахин нэг эм гаргаад Динсморт санал болгов.

-Уух уу? Сэтгэл санаа өргөгдөнө.

Тэр юу өгч байгааг ч асуулгүй шууд авч залгиад шар айргаар даруулав. Тэд Моттон-Роуд руу дөхөж ирлээ. Динсмор уулзварыг хожимдон анзаарсан тул холуур тойрон эргэв. Энэ үед Крамлийн шуудангийн хайрцагийг мөргөж унагав. Сэмми дургүйцсэнгүй.

-Хатагтай Лу дахиад авах уу?

-Баярлалаа ноёнтон.

Тэр дахин нэг лааз шар айраг аваад тээглүүрийг татан нээв.

-Миний хүүг хармаар байна уу?

Хянах самбарын туяанд Динсморын нүд нойтон, шар харагдана. Яг л нүхэнд унаж савраа хугалсан нохойн нүд шиг.

-Чи миний хүү Рориг хармаар байна уу?

-Тийм ээ, ноёнтон. Мэдээж хармаар байна. Би тэнд байсан л даа.

-Бүгд байсан. Би талбайг түрээсээр өгсөн юм. Хүүгээ алахад тусалсан хүн. Ингэнэ гэж

мэдсэнгүй. Хэн ч мэдээгүй тийм үү?

-Хэн ч мэдээгүй.

Динсмор комбинзоны энгэрийн хармаа руу гараа шургуулж хуучин түрийвч гаргаж ирлээ. Түрийвчээ нээхийн тулд жолоогоо хаяад нүдээ онийлгон гялгар ханаар тусгаарлагдсан тасалгаануудыг ухаж гарав.

-Хүүхдүүд маань надад энэ түрийвчийг бэлэглэсэн юм. Рори Орри хоёр. Орри амьд байгаа.

-Гоё түрийвч байна гэж хэлэнгээ Сэмми Динсмор руу хазайж жолоог барьлаа. Тэр Филтэй амьдарч байхдаа үүнийг хийдэг байсан. Олон удаа. Ноён Динсморын пикап зам дээр тахир зам тагуулаад дахин нэг шуудангийн хайрцаг мөргөх шахлаа. Гэхдээ энэ одоо хэнд ч хамаагүй. Машины хурд 20 мл-ээс үл хэтрэх бөгөөд Моттон-Роуд зам дээр өөр машин алга. Радио ХБЭ суваг дээр бөглүү ажиллана. "Алабамагийн сохор хүүхдүүд" хамтлаг "Тэнгэрийн найдвар" дууг дуулна.

Динсмор түүнд түрийвчээ сарвайв.

-Энэ байна. Энэ миний хүү өвөөтэйгээ байгаа юм.

-Намайг харах хооронд та машинаа жолоодох уу?

-Мэдээж гээд Динсмор дахин жолоогоо атгалаа. Пикап хурдаа нэмж чиглэл нь тэгшрэв. Гэхдээ заримдаа урсгал сөрнө.

Шарласан өнгөт гэрэл зураг дээр Сэмми бие биенээ тэвэрсэн жаалхүү ба өвгөн хоёрыг харж байна. "Ред Сокс" бейсболын малгай өмссөн өвгөн хүчилтөрөгчийн баг зүүжээ. Жаалхүү инээсэн байв.

-Хөөрхөн хүү байна ноёнтон гэж Сэмми хэллээ.

-Тийм ээ, хөөрхөн хүү. Хөөрхөн бас ухаалаг хүү гэж хэлэх үед Динсмор илжиг орилох мэт дуу гарган цурхирав. Уруул дээрээс нь шүлс үсчинэ. Пикап хажуу тийш огцом даялсанаа зөв замдаа дахин орлоо.

-Надад ч бас хөөрхөн хүү бий гээд Сэмми уйлав. Хэзээ нэгэн цагт хүүхэлдэй тамлах дуртай байснаа тэр саналаа. Харин одоо шарах шүүгээнд байх нь ямар болохыг Сэмми мэддэг болжээ. Шарах шүүгээнд шатах.

-Би хүүтэйгээ уулзангуугаа үнсэх болно. Ахиад үнсэнэ.

-Тийм ээ, түүнийг үнсээрэй.

-Заавал.

-Үнсээд тэвэр. Биендээ наа.

-Заавал тэгнэ ноёнтон.

-Хэрэв болдогсон бол би хүүгээ үнсэх байсан. Түүний цэв хүйтэн хацрыг үнсэх байсан.

-Таны үнсэх байсан гэдгийг би мэдэж байна. -Гэвч бид түүнийг оршуулсан. Өнөө өглөө. Булшилсан. -Би танд тохиолдсон хагацалд маш их харамсч байна. -Дахиад шар айраг ав.

-Баярлалаа гээд Сэмми дахин нэг лааз авав. Тэр чамгүй уужээ. Согтох сайхан болохыг мэдэрч эхлэв.

Тэд ийнхүү явсаар байлаа. Ягаан одод улам тодорно. Одод анивчих боловч харавсангүй. Энэ шөнө солирын бороо орсонгүй. Тэд Сэммигийн чиргүүл тэрэгний хажуугаар гарав. Бүсгүй энд хэзээ ч эргэж ирэхгүй. Тэд хурдаа хасалгүй дэргэдүүр нь өнгөрлөө.

17

8 цагт 15 минут дутуу байх орчимд Роуз "Ардчилал"-ын редакцийн шилэн хаалгыг тогшлоо. Жулия, Пит, Тони нар урт ширээний дэргэд зогсон дөрвөн хуудастай сүүлчийн дугаараа бэлдэж байв. Пит Тони хоёр хуудаснуудыг нэгтгэж, Жулия үдээд хураана.

Роузыг олж харсан Жулия гараа эрчтэй даллав. Роуз хаалгыг нээснээ хойшоо найгалаа.

-Пөөх танай энд ямар халуун юм бэ?

-Хийгээ хэмнэх гээд агааржуулагчаа унтраачихсан гэж Пит хариулав.

-Тэгээд ч хувилагч удаан ажиллахаараа хүчтэй халдаг юм. Өнөө оройнх шиг гэж хэлэхдээ тэр тун бардам харагддаа. Тэд бүгд бардам байв.

-Танай рестораны ажил толгойтой үснээс их болсон байх гэж би бодсон юм? гэж Тони хэллээ.

-Харин ч бүр эсрэгээр. Үйлчлүүлэгч хуруу дарам цөөн байна. Миний тогоочийг хүн амины хэргээр баривчилсан болохоор хүмүүс надаас дөлж байна гэж би бодох юм. Нөгөөтэйгүүр хүмүүс өглөө "Хүнсний ертөнц"-д болсон явдлаас хойш бие биенийхээ урдаас харж суух хүсэлгүй болсон.

-Нааш ир, сонин ав. Роуз чи манай нүүрний чимэг гэж Жулия дуудав.

Хамгийн дээд мөрийг Жулия улаан өнгөөр тодотгожээ.

"ҮНЭГҮЙ БҮРХҮҮЛ ХЯМРАЛЫН ДУГААР ҮНЭГҮЙ" гэжээ. Дараа нь "Ардчилал" сонины сүүлийн хоёр дугаар хүртэл Жулия хэзээ ч хэрэглэж байгаагүй 16-гийн үсгээр гарчиг тавьжээ.

"ХЯМРАЛ ГҮНЗГИЙРЭХИЙН ХЭРЭЭР ҮЙМЭЭН САМУУН БА АЛЛАГА"

Түүний доор Роузын гэрэл зураг байв. Хажуугаас нь авчээ. Амандаа чанга яригч барьсан байна. Духан дээр молцог үс унаж, Роуз гайхалтай хөөрхөн харагдана. Цаад талд шалан дээгүүр хэд хэдэн лонх гоймонтой хуурганы амтлагч сүмс хагарч нялайсан, гоймон ба амтлагчийн тасаг дэвсгэр болж өгчээ. Доогуур бичсэн нь "Үймээнийг дарсан нь: "Эглантери"-гийн эзэгтэй Роуз хүн амины хэргээр баривчлагдсан Дейл Барбарагийн тусламжтай үймээнийг номхотгов. (доорх нийтлэл ба дөрөвдүгээр хуудасны тэргүүн өгүүлэл уншина УУ)"

-Есүс бурхан минь. Үгүй яахав... Ядахдаа чи миний сайн талыг тэмдэглэжээ. Гэхдээ хэрэв надад ийм тал байгаа бол шүү дээ гээд Роуз санаа алдав.

-Роуз чи яг л Мишель Пфайффер шиг харагдаж байна гэж Тони үнэнээсээ хэллээ.

Роуз тургин инээгээд гараа савав. Тэр тэргүүн өгүүллэгийг уншиж эхэлжээ.

ӨНӨӨДРИЙН ҮЙМЭЭН МАРГААШИЙН ШИВШИГ

Жулия Шамуэй.

Дейл Барбара манай хотод харьцангуй шинэ хүн гэдгийг Честерс-Миллийн бүх хүн мэднэ. Гэхдээ хотын олонхи иргэд "Эглантери"-д түүний бэлдсэн хоолыг амталсан. Өнөөдрийг хүртэл түүнийг мэдэх бүх хүн энэ залуу манай хотод яг тохирно гэх байсан. 7 ба 8 дугаар сард софт бөмбөгийн тэмцээнд түүний оролцсон, 9 дүгээр сард дунд сургуулийн сурах бичиг худалдан авсан компанит ажил ба хоёр долоо хоногийн өмнө болсон ариун цэврийн өдрөөр хог цуглуулахад оролцсон зэргийг нь дурсах юм бол бүтд ингэж хэлнэ.

Харин өнөөдөр Барби (түүнийг таньж мэдэх хүмүүс ингэж дууддаг) цочролд оруулам дөрвөн аллагын хэргээр баривчлагдлаа. Энэ хотын хүмүүсийн сайн мэддэг болоод хүндэлдэг хүмүүсийг алсан хэргээр. Дейл Барбарагаас ялгаатай нь тэд энэ хотод бүх насаа өнгөрөөсөн.

Ердийн нөхцөлд байсан бол Барбиг Касл тойргийн шоронд аваачаад хэрэв тэр төлбөр хийх чадваргүй бол ганц утасдаад өмгөөлөгчөөр хангах байсан. Түүнд ял тулгаж ажлаа мэдэх шинжээчид нотлох баримт цуглуулж эхлэх байсан.

Гэвч ийм юм юу ч болсонгүй. Яагаад гэдгийг та бид мэднэ. Бүрхүүл биднийг хүрээлэн байгаа ертөнцөөс тусгаарласан. Ийм нөхцөлд бид зохих журмын дагуу мөрдөн шалгахаас татгалзах ёстой юу? Эрүүл ухаанаас өөр зүйлээр удирдуулах ёстой юу? Гэмт хэрэг хичнээн зүрх зүсэм байлаа гээд буруутай нь батлагдаагүй тохиолдолд Дейл Барбарад үзүүлж буй харгислалыг уучлахад хангалтгүй. Эсвэл цагдаагийн шинэ даргын асуултанд хариулахаас татгалзсаныг тайлбарлахад хангалтгүй. Тэр бүү хэл Дейл Барбара амьд эсэхийг мэдэх гэсэн манай сурвалжлагчид ийм боломж олгоогүйг тайлбарлахад ч хангалтгүй. Гэтэл хотын захиргааны нэгдүгээр гишүүн Энди Сандерст болохоор ял тулгаж эхлээгүй байгаа хоригдогч дээр орохыг зөвшөөрөөд зогсохгүй түүнийг үг хэлээр буруутгахыг ч зөвшөөрсөн байна.

-Яана аа чи энэ бүхнийг үнэхээр хэвлэх юм уу? гээд Роуз толгой өргөв.

Жулия бэлэн болсон боодолтой сонин руу заалаа.

-Аль хэдийн хэвлэчихсэн. Юу гэж? Чи дургүйцэж байгаа юм уу?

-Үгүй л дээ. Гэхдээ... гэснээ Роуз маш урт бөгөөд Барбиг сурталчилсан тэргүүн өгүүллийг хурдан уншиж дуусгав. Энэ өгүүлэл хүн амины хэргүүдийн талаар их бага ямар нэг хэмжээний мэдээлэлтэй хүмүүс байвал сонинтой холбогдохыг хүссэнээр дуусчээ. Мөн хямрал дууссаны дараа эдгээр хүн амины хэрэг дээр ажиллаж байгаа бүх хүний үйл ажиллагааг Мэн муж улсын засаг захиргаа юмуу эсвэл холбооны зохих байгууллагууд сайтар мөрдөж шалгах болно гэсэн таамаг дэвшүүлжээ.

-Таагүй явдалтай учрахаас айхгүй байна уу?

-Роуз минь, хэвлэлийн эрх чөлөө гэж хэлэх Питийн дуунд итгэл үнэхээр дутагдаж байна.

-Горас Грили яг ингэх байсан гэж Жулия хатуу хэллээ. Буланд дэвсгэр дээр унтаж байсан нохой нь нэрээ сонсоод толгой өргөв. Роузыг харангуутаа толгойгоо илүүлэх санаатай дөхөж ирэхэд бүсгүй дуртайяа хийж өгөв.

-Чи энд бичсэнээс илүү юм мэдэж байгаа юу? гэж Жулия асуугаад тэргүүн өгүүллийг хуруугаар тогшив.

-Жаахан, жаахан. Би дотроо хадгалсан юм. Өөр юм мэдэх санаатай.

-Барби ийм юм хэзээ ч хийхгүй байсан. Хийхгүй. Гэхдээ л би түүний төлөө айж байна.

Ширээн дээр байсан гар утаснуудын нэг нь дуугарлаа. Тони утсыг шүүрээд:

-"Ардчилал" сонин Тони байна гэж хэлээд чагаснаа Жулияд утсаа сунгаж: -Хурандаа Кокс байна. Чамтай ярьж гэнэ. Дуу нь өөдрөг биш байна гэлээ.

Кокс. Жулия түүнийг таг мартжээ. Бүсгүй гар утсаа авав.

-Хатагтай Шамуэй, би Барбитай ярьж хотод хяналт тогтоох ажлын амжилтын талаар мэдмээр байна.

-Тэр ойрын хугацаанд амжилт олно гэж би бодохгүй байна. Тэр шоронд байгаа.

-Шоронд оо? Ямар хэргээр?

-Хүн амины хэргээр. Тодруулбал дөрвөн хүний.

-Та тоглоод байна уу?

-Миний дуугаар тоглож байгаа юм шиг мэдрэгдээд байгаа юмуу хурандаа?

Түр чимээгүй болов. Хэн нэгний дууг бүсгүй сонслоо. Кокс дуугаа намсгаад дахин ярьж

ЭХЛЭВ.

-Тайлбарлаад өг, гуйя.

-Үгүй дээ хурандаа. Би энэ тухай дөнгөж сая хоёр цаг бичлээ. Намайг жаахан байхад ээжийн маань хэлдэг байсанчлан нэг байцааны голыг хоёр дахин зажилдаггүй юм. Ингэхэд та Мэнд байгаа юу?

-Касл-Рокт байгаа. Энд манай тэргүүн бааз байрласан.

-Тийм бол түрүүнд уулзсан газраа уулзах санал байна. Моттон-Роуд. Хэдийгээр үнэ төлбөргүй тараагдах боловч би маргаашийн "Ардчилал" сонины дугаараас нэг хувийг танд өгч чадахгүй. Гэхдээ Бүрхүүлд навал та бүгдийг нь өөрөө уншина.

-Цахим шуудангаар нааш нь илгээ.

-Илгээхгүй. Сонин ингэж илгээх нь ёс зүйгүй гэж би боддог. Энэ тал дээр би их хуучинсаг хүн.

-Хонгор хатагтай, та хүний уурьт ноцоож чадах юм.

-Уур ноцоож чадна. Гэхдээ би таны хонгор хатагтай биш. -Надад хэлээд өгөөч. Энэ чихээс үү? Сандерс ба Ренни нартай холбоотой юу?

-Хурандаа минь таны туршлагаас үзвэл баавгай ойд баадаг

уу?

Хэсэг дуугүй болов. -Би тантай нэг цагийн дараа уулзъя. -Би ганцаараа ирэхгүй. Барбигийн ажил олгогчтой ирнэ. Түүний юу хэлэхийг сонсох нь танд сонирхолтой байх болно. -Маш сайн. Жулия утсаа салгав.

-Роуз чи надтай хамт Бүрхүүл рүү очих уу?

-Хэрэв энэ нь Барбид тустай юм бол мэдээж.

-Тэгэж найдъя. Гэвч энд бид өөрөө өөртөө л найдах хэрэгтэй гэж айх юм гэснээ Жулия Пит Тони хоёр руу хандаж: -Та хоёр үлдсэн сониныг үдээрэй. Хаалганы дэргэд хураагаад гарахдаа хаалгаа түгж. Харьж сайн унт. Яагаад гэвэл маргааш бид сонин тараагчид болно. Энэ дугаарын хувь тавилан ийм юм. Бид хотын айл болгонд сонин хүргэнэ. Ойр орчмын фермүүдэд аваачна. Мэдээж Истчестерт хүргэнэ. Тэнд хотод ирээд удаагүй хүмүүс олон бий. Тэд Том Жимийн хууралтанд орохгүй.

Пит хөмсөгөө өргөв.

-Гэхдээ манай ноён Ренни одоо талбайн эзэн шүү дээ. Пүрэв гаригт хотын онц хурал дээр мань хүн хожуул дээр гарч зогсоод хотыг тэр чигээр нь цагийн баадуу шиг мушгих гэж байгаа.

Гэхдээ зочин баг түрүүлж бөмбөгөнд хүрэх эрхтэй. Бидний цохилт энэ байна. Хэрэв сониныг хангалттай олон хүн унших юм бол тэр ярьж эхлэхээсээ өмнө зарим нэг таагүй асуултанд хариулах хэрэг гарна.

- "Хүнсний ертөнц"-ийн дэргэд хэн эхлээд чулуу шидсэнийг олчих юм бол түүнийг бүр цохиж унагааж болох юм. Би чамд хэлмээр байна. Бид тэр хүнийг олж мэднэ. Бид ер нь бүхний учрыг тайлна. Ямар ч зангилаанд сул үзүүр байх л ёстой гэж Пит хэллээ.

- Сул үзүүрээс татах үед Барби амьд байгаасай гэж л найдах юм гээд Жулия цагаа харсанаа: - Роуз явцгаая. Машинаар давхия. Горас чи явмаар байна уу?

Горас явахыг хүсэв.

18

- Намайг энд буулгаач ноёнтон гэж Сэмми Истчестерийн чамин байшингуудын нэгэнд дөхөж ирээд гуйлаа. Хэдийгээр байшингийн цонхоор гэрэл харагдаагүй ч өмнөх нуга нь гэгээтэй байв. Яагаад гэвэл эдлэн газар Бүрхүүлд тулж байрлах бөгөөд харин хилийн нөгөө талаар Честерс-Милл ба Харлоу тусгаарласан заагийн цаана тольдуурын хурц гэрлүүд асна.

- Хатагтай Лу замдаа уух шар айраг авах уу?

- Үгүй дээ ноёнтон, би бараг очих ёстой газраа оччихлоо.

Тийм биш байсан юм. Тэр эргээд хотод очих ёстой. Тольдуурын шар гэрэлд Динсмор 45 настай эр биш 85 настай өвгөн харагдана. Энэ аялалд гарахын өмнө Сэмми эмнэлгийн тасгийн толинд өөрийнхөө царайг харсан бөгөөд өөрийнхөө энэ царайг эс тооцвол Динсморынх шиг гунигтай царайг тэр хэзээ ч харж байсангүй. Сэмми тонгойж түүний хацар дээр үнслээ. Сахал нь уруул хатгав. Динсмор үнссэн газарт гараа хүргээд үл мэдэг инээмсэглэв.

- Ноёнтон, та одоо гэртээ харих хэрэгтэй. Танд дэмжиж тулах ёстой эхнэр чинь бий. Бас санаа тавих учиртай өөр нэг хүү чинь бий.

- Магадгүй таны зөв.

- Миний зөв.

- Тантай ямар нэг юм болохгүй биз?

- Үгүй дээ ноёнтон. Та явж чадах уу? гэж тэр машинаас бууж Динсмор руу эргэн харангаа асуув. - Оролдоод үзье.

Сэмми хаалгыг хаагаад орцны замын үзүүрт зогсонгоо тэр хэрхэн буцаж эргэхийг ажиглана. Машины нэг дугуй замын хажуугийн суваг руу орсон ч суваг хуурай байсан болохоор Динсмор эргээд зам дээр гарч чадав. Эхлээд дугуй татуулсанаа 119-р гудамж руу давхиж одлоо. Арын гэрэл нь бага зэрэг хазайх боловч шулуун одов. Динсмор Филийн хэлдгээр

замын тусгаарлах шугмыг дайран явах ажээ. Гэхдээ Сэмми энэ нь дээр гэж бодов. Цаг 8 хагас болж байна. Харанхуй болжээ. Динсмор замдаа хэн нэгэнтэй таарна гэж тэр бодохгүй байлаа.

Пикап машины арын гэрэл хараанаас мултрах үед Сэмми харанхуй байшин руу алхав. Мэдээж энэ байшин хотын талбайн дэргэдэх толгойн орой дээр байдаг хуучны шилтгээнүүдтэй харьцуулах юмгүй ч бүсгүйн амьдарч байсан байшингуудаас хавьгүй дээр. Дотор нь бүх юм нь гоё. Тэр нэг удаа Филтэй хамт энд ирж байсан. Нөхөр нь өөрийн хэрэгцээнд зориулан бага зэрэг мет чиргүүл тэрэгнийхээ ард чанаж, бас бага зэрэг өвс зардаг байсан тэр алсын өдрүүдэд. Түүнд хачирхалтай санаанууд төрж эхлээд, тэднээс бусад бүх хүмүүс тамд очдог хэмээн итгэдэг сүсэгтнүүдтэй тэр муу баастай сүм рүү явдаг болох хүртэл. Филийн бүх гай шашнаас үүдэлтэй. Шашин түүнийг Лестер лам дээр аваачсан. Лестер юмуу өөр хэн нэгэн түүнийг Шеф болгож хувиргасан.

Энэ байшинд амьдарч байсан хүмүүс мет хэрэглэдэггүй байсан. Мет хэрэглэх болсон мансуурагчид ийм байшинд удаан амьдарч чадахгүй л дээ. Яагаад гэвэл цувуулж төлөх ёстой бүх мөнгө нь мансуурах бодист одох байсан. Гэвч Жек ба Майра Эванс нар үе үе өвс татах дуртай байсан бөгөөд Фил Буши дуртайяа тэднийг хангадаг байв. Тэд их сайн хүмүүс байсан бөгөөд Фил ч бас тэдэнд тэгж хандана. Тэгэхэд тэр хүмүүстэй хүний ёсоор хандаж чаддаг байсан.

Майра тэднийг мөстэй кофегоор дайлсан. Сэмми гэдсэндээ Литл-Уолтерийг тээгээд 7 сар гаруй болж байсан учраас гэдэс нь хамарт нь тулжээ. Майра түүнээс охин хүү хоёрын алийг нь хүсч байгааг асуусан. Тэр түүн рүү өндрөөс хараагүй. Жек Филийг дагуулан төлбөрөө хийхээр жижиг өрөө рүү орсон. Фил тэндээс хашгирсан юмдаг.

"Хонгор минь чи үүнийг харах ёстой".

Энэ бүхэн аль эрт өнгөрч дээ.

Сэмми гол хаалгыг нээх гэж оролдов. Цоожтой байна. Бүсгүй Майрагийн цэлгэр цонхны өмнөх цэцгийн мандалыг тойруулан хашсан гоёлын чулуунаас нэгийг аваад чулууг гартаа барьсаар хэвээр цонх руу очив. Тэгснээ чулуу шидэхээ больж байшинг араар нь тойрлоо. Яагаад гэвэл одоо байгаа байдлаар бол тэр байшин руу цонхоор ггурган орж чадахгүй. Орж чадлаа ч гэсэн шилний хагархайнд зүсэгдэж мэднэ. Ингэж зүсэгдвэл өнөө оройн төлөвлөгөөнд саад болно.

Тэгээд ч гоё байшин болохоор онцгой шаардлага гарахгүй бол зэрэмдэглэх хүсэл төрсөггүй.

Сэмми түүнгүйгээр болчихов. Жеккигийн цогцосыг авч одсон. Тэндхийн хотын амьдралд ямар ч өөрчлөлт орсонгүй. Арын хаалгыг цоожлох санаа хэнд ч төрсөнгүй. Сэмми дотогшоо орлоо. Эвансынхан цахилгаан үүсгүүр хэрэглэдэггүй байсан болохоор гэр дотор сохор номины бөгсөн доторхоос ч илүү харанхуй. Гэхдээ гал тогооныг зуухан дээр хайрцагтай

шүдэнз байлаа. Сэммигийн зурсан анхны шүдэнзний гэрэлд гал тогооны ширээн дээр байгаа гар чийдэн тусав. Чийдэн онц сайн ажиллана. Гэрэлд цусных бололтой шалан дээрх толбо

харагдав. Сэмми гар чийдэнг яаран өөр тийш чиглүүлээд Жеккигийн ажлын өрөөг чиглэв. Энэ нь дотор нь шилтэй шүүгээ ба бичгийн ширээ арай гэж багтах бяцхан өрөө бөгөөд зочдын өрөөний хажууд байрлана.

Сэмми ширээн дээгүүр гэрлээр тэмтчээд, дараа нь дээш өргөхөд Жекийн ихэд бахархдаг байсан ангийн олзны шилэн нүдэн дээр гэрэл ойв. Энэ нь гурван жилийн өмнө Ти-Эр-90-д түүний буудсан хандгайн толгой юм. Тэгэхэд Фил үүнийг харуулах гэж л Сэммиг дуудсан билээ.

"Тэр жил би сугалаанаас сүүлчийн эрхийг хожсон юм. Тэгээд энэ буугаар хандгайг унагасан" гэж Жек ярьж байсан. Тэгээд шүүгээнд байгаа карабин бууг заасан. Дуран хараатай сүртэй эд байсан.

Хөөрхөн, чамин, бас инээмсэглэсэн Майра бүсгүй гартаа мөс хажигнах шилэн аягатай кофе барьсаар орж ирэв. Сэмми хэзээ ч ийм эмэгтэй болж чадахгүй.

"Ирэх 12-р сард Бермуд руу долоо хоног аялна гэж Жек амалсан болохоор би нөхөртөө энэ бууг авахыг зөвшөөрсөн юм. Арай дэндүү үнэтэй".

-Бермуд. Гэвч тэр тийшээ явж чадсангүй дээ. Тун харамсалтай гэж одоо Сэмми хэлэв.

Тэгэхэд Фил мөнгөтэй дугтуйг арын хармаандаа чихсэн.

"Карабин үнэхээр сэтгэл догдлом эд байна. Гэхдээ гэрээ хамгаалахад тохиромжгүй".

"Би энэ талаар ч бас бодсон" гээд Жек Филд яг юу болохыг харуулаагүй боловч ойлгодохуйцаар ширээгээ алгадаад: -Хос гайхалтай сайхан гар буу бас авсан".

Фил мөн ойлголоо гэх маягтай толгой дохин хариулсан. Сэмми Майра хоёр бие бие рүүгээ харсан бөгөөд харц нь "Жаалхүүхдүүд, тэд үргэлж жаалхүүхдүүд чигээрээ үлдэнэ" гэж уншигдсан.

Энэ харилцан харц түүнд хичнээн их таашаал авчирсаныг Сэмми одоо хүртэл санадаг. Энд өөрийн хүн гэдгээ мэдрэхэд хүргэсэн харц. Магадгүй тэр яг энэ шалтгаанаар ийшээ ирсэн байх. Хотод илүү ойр өөр ямар нэг байшинд буу эрж хайж болох л байсан.

Сэмми дахин нэг шахмал эм залгиад ширээний нүднүүдийг татаж гарав. Нэгийг нь ч түгжээгүй байв. Гурав дахь шургуулганаас олсон модон хайрцагийг ч түгжээгүй байлаа. Хайрцаг дотор Жекийн амиа хорлосон хоёр бууны нөгөө нь болох 45 калибрын "спрингфилд-эйч-ди" автомат гар буу хэвтэж байв. Сэмми гар бууг гаргаж аваад бага зэрэг ноцолдон сумны дайзыг сугалав. Буу дүүрэн сумтайг шалгалаа. Нөөцийн дайз хайрцагт бас байв. Сэмми түүнийг ч бас авлаа. Олзоо хийх уут хайн гал тогоонд буцаж ирэв. Бас гараашт байх машины түлхүүрийг эндээс хайв. Тэр хот руу явган буцахыг хүссэнгүй.

Энэ амьдрал нь дуусах шахсаны дараа Жулия Роуз хоёр Честерс-Милл хотыг ирээдүйд юуг

хүлээж болох талаар ярилцав. Хэрэв тэрэг нь эргэлт дээр фермерийн хуучин пикап машинтай мөргөлдсөн бол энэ амьдрал дуусах байсан. Моттон-Роуд ба Бүрхүүл хоёр огтлолцсон тэр газраас бүтэн хагас милийн зайд байх Исти эргэлт дээр энэ явдал болсон. Гэвч Жулия урсгал сөрөн өмнөөс ирж яваа пикапыг цаг алдалгүй олж харсанаар эмэгтэйчүүд мөргөлдөхөөс мултарч чаджээ.

Бүсгүй ямар ч бодож санах завдалгүй автоматаар "прус" машиныхаа жолоог зүүн тийш дарж эсрэг урсгалд орсон бөгөөд хоёр машин хэдхэн хуруу зайтай зөрөв. Хоншоор дээр нь "автомашины зугаалга ямар сайхан юм бэ?" гэх үгс илт бичээстэй Горас нохой арын суудал дээрээс газарт шидэгдээд гайхсандаа гаслав. Энэ дуу л нам гүмийг цочоов. Хоёр эмэгтэйн хэн нь ч хашгираагүй юм. Хашгирч ч амжсангүй. Бүх юм нүд ирмэх зуур болсон. Үхэл юмуу ноцтой гэмтэл бэртэл хоромхон зуур тэдний толгой дээр хүрч ирсэнээ зам салсан.

Жулия "прус" машинаа өөрийн явах урсгалд оруулаад замын хажуу руу гарч хурд шилжүүлэгчээ зогсох дээр тавив. Тэгээд Роуз руу эргэлээ. Өнөөх нь түүн рүү харах бөгөөд нүүр нь бүлтийсэн хоёр нүд ба ангайсан амнаас л бүтнэ. Горас эргээд арын суудал үсрэн гарч, яагаад саатсаныг асуух мэт богинохон хуцав. Үүнийг сонсоод эмэгтэйчүүд инээд алдсан ба Роуз том хагас бөмбөлөгийнхөө дээгүүр цээжээ үрж гарлаа.

-Зүрх минь, хөөрхий зүрх минь гэж тэр гаслав.

-Тийм ээ, минийх ч бас. Бид арай гэж хоёр тийш салахыг харав уу?

Роуз дахиад цухалдан инээлээ.

-Чи тоглоод байна уу? Хэрэв би гараа цонхоор цухуйлгаж явсан бол тэр чөтгөр миний гарыг тохойгоор нь тайрах байлаа. Жулия толгой сэгсрэв. -Согтуу амьтан байх. -Яг согтуу гэж Роуз тургив. -Цаашаа явахад бэлэн үү? -Харин чи.

-Тийм ээ. Горас яах бол?

Нохой төрсөн цагаасаа хойш бэлэн гэх мэт хуцав.

-Үхэл хажуугаар өнгөрөх юм бол бүх азгүйдлийг хамж оддог гэдэг. Өвөө маань ингэж ярьдаг байсан гэж Роуз хэлэв.

-Түүний зөв гэж найдацгаая гээд Жулия машинаа зам руу эргүүлэв. Одоо тэр ойртон ирж байгаа машины гэрлийг цаг тухайд нь анзаарахын тулд харанхуй руу сайтар ширтэнэ. Гэвч өмнөөс дахиад хэн ч ирсэнгүй. Замын төгсгөлийг Бүрхүүлийн нөгөө талд Харлоуд асах тольдуурын хурц гэрэл гэрэлтүүлэх ажээ.

Жулия Роуз хоёрын хэн нь ч Сэмми Бушиг анзаарсангүй. Сэмми ч тэднийг хараагүй. Тэр Майрагийн "малибу" машины түлхүүрийг гартаа бариад гараашийн өмнө зогсч байв. Эмэгтэйчүүд дэргэдүүр давхин өнгөрөх үед Сэмми гараашийн хаалгыг өргөөд (тэр үүнийг гараар хийсэн тул давсаг хавиар хүчтэй өвдөв) жолооны ард суулаа.

"Берпигийн их дэлгүүр" ба "Бензин ба зууш" их дэлгүүрийн дундуур нарийн гудамж өнгөрч Төв болон Баруун гудамжуудыг холбодог. Энэ гудмаар голдуу бараа хүргэж ирэх ачааны тэргүүд л явдаг юм. Харин энэ орой бага Ренни ба Картер хоёр энэхүү нарийн гудамжаар бараг тас харанхуйд, 8 цаг 25 минутын орчимд орж ирэв. Картер гартаа бөөрөнд нь ташуу шар зураастай таван галлоны улаан өнгийн төмөр сав барьжээ. Бөөрөн дээрх бичээс "бензин" гэсэн байв. Тэр нөгөө гартаа зайгаар ажилладаг чанга яригч барьжээ. Чанга яригч цагаан өнгөтэй боловч Картер хүмүүсийн анхаарал татахгүйн тулд хар өнгийн туузаар битүү ороосон байв. Нарийн гудамж руу буцаж шургаж амжихаас өмнө хэн нэгэн харахаас сэргэйлсэн хэрэг.

Жижгээ нуруундаа үүргэвч үүрчээ. Толгой нь үл өвдөх бөгөөд доголохоо бараг больжээ. Бие махбодь шаналгаж байсан өвчнөө давсан гэдэгт тэр хатуу итгэж байв. Магадгүй тэр ямар нэг вирусын халдвар авсан байх. Коллежид энэ баас бол таазанд тулахаар дүүрэн бий. Тэгэхээр тэр нэг залууг зодсон хэргээр сургуулиас ниссэндээ баярлах хэрэгтэй.

Тэд Төв гудамж руу гарч ирлээ. Редакцийн цонх алган дээр мэт харагдана. Цонхоор гэрэл гарч хүнгүй явган зам дээр тусна. Пит Тони хоёр боодолтой сонинуудаа зөөж хаалганы дэргэд хурааж байв. Сонины редакци болоод Жулиягийн гэр байдаг хуучин модон байшин нь "Сандерсын хотын эмийн сан дэлгүүр" ба номын дэлгүүрийн дунд байх боловч яг тулаагүй жаахан зайтай. Номын дэлгүүр болон модон байшингийн дундуур Дип-Кат гудамж байх ба харин эмийн сан байшин хоёрын дундуур саяхан тэр хоёрын явж өнгөрсөн шиг нарийн гудамж оршино. Энэ шөнө салхигүй учир хэрэв эцэг нь дайчдаа түргэн шилжүүлж чадвал нэг их хохирол гарахгүй гэж Жижгээ бодов. Гэхдээ энэ бүхэн түүний санааг тийм ч их зовоосонгүй. Төв гудамжны бүх дорнод жигүүр шатах юм бол Жижгээгийн сэтгэлд тун нийнтэй байхсан. Барбарад л муу болно. Түүний сонжсон хүйтэн харцыг тэр одоо хүртэл бие дээрээ мэдэрсээр байв. Түүн рүү хэн ч ингэж харах ёсгүй. Тэр тусмаа торны цаана байгаа хүн. Булшлуулмар Барби.

-Түүнийг буудсан бол дээр байсан юм гэж Жижгээ бувтнав.

-Юу гэнэ ээ? гэж Картер асуулаа.

-Юу ч биш ээ, халуун байна гээд Жижгээ духаа арчив.

-Тийм ээ, хэрэв цаашдаа ингэж үргэлжлэх юм бол бид жигнүүлж гүйцээд чавга шиг хүрэн улаан болно гэж Френки хэлсэн. Ингэхэд бид ажлаа хэзээ хийх вэ?

Жижгээ мөрөө хавчив. Уг нь эцэг нь цаг заасан боловч тэр санасангүй. 9 цаг гэл үү? За ямар хамаатай юм. Энэ хоёр шатна л биз. Хэрэв сониныг гичий дээд давхарт хайртай банхартайгаа хэцүү өдрийн дараа амарч байгаа бол? Тэр ч бас шатаг. Барбид л илүү асуудал үүснэ биз.

-Алив үүнийг одоо хийцгээе.

-Дүү минь чи итгэлтэй байна уу?

-Гудамжаар хүн харагдана уу?

Картер эргэн тойрноо харав. Төв гудамж ерөнхийдөө харанхуй байх ба нэг ч хүн алга. Хоёрхон үүсгүүр ажиллаж байгаагийн нэг нь редакцийн ард, нөгөө нь эмийн сангийн ард дуугарна. Тэр мөрөө хавчив.

-Тэгье. Яагаад үгүй гэж.

Жижгээ үүргэвчээ нуруунаас авч нээв. Хамгийн дээд талд хоёр хос бээлий байна. Нэгийг нь Картерт өгч нөгөөг нь өөрөө өмслөө. Бээлийн дор алчууранд ороосон дөрвөн ширхэг дарсны хоосон лонх байлаа. Жижгээ алчуурыг болгоомжтой задалж лонхнуудаа цардмал зам дээр тавив. Үүргэвчний ёроолоос төмөр юүлүүр гаргаж ирлээ. Нэг лонхных нь амаар шургуулаад бензинээ авав.

-Би хийвэл дээр юм байна. Чиний гараа салгалаад байна гэж Картер түүнийг хориглов.

Жижгээ гараа гайхан харлаа. Тэр өөрөө чичирч байгаагаа мэдрэхгүй атал гар нь салгалж байна.

-Хэрэв чи намайг айсан гэж бодож байгаа бол би айгаагүй шүү.

-Чамайг айсан гэж хэн ч хэлээгүй. Энэ чиний толгойтой холбоотой. Хэнд ч ойлгомжтой. Чиймар нэг өвчтэй тул Расти дээр очих ёстой. Одоо тэр манай хотын эмч.

-Миний бие маш сайн...

-Хүн сонсоогүй байгаа дээр амаа хамхи. Алчуурыг цуул. Би бензин юүлнэ.

Жижгээ хуйнаас гар бугаа суга татаад Картерын нүд РҮҮ буудав. Түүний толгой зад үсэрч, цус ба тархи зүг зүгт цацагддаа. Дараа нь Жижгээ цогцос дээр зогсоод дахин дахин буудав...

-Жижгээ?

Тэр энэ хоосон бодлоос салахын тулд толгойгоо хүчтэй сэгсэрлээ. Хий төсөөлөл маш тод дүрслэгдэх ажээ. Гар нь үнэхээр гар бууны бариулыг атгасан байв. Вирусаас бүрэн салж чадаагүй юм болов уу?

Магадгүй энэ ерөөсөө вирус биш байх.

Тэгвэл юу юм бэ? Юу вэ?

Бензиний хурц үнэр хамрын самсааг асар хүчтэй цохиход нүд хорсож эхлэв. Картер эхний лонх руу бензин юүллээ. "Бүл-бүл-бүл" гэх дуу төмөр савнаас гарав. Жижгээ үүргэвчний хажуу хармааны цахилгааныг задалж ээжээс нь үлдсэн хайчийг гаргаж ирэв. Тэгээд алчуурыг дөрвөн урт тууз болгон хуваалаа. Нэгийг нь эрчлээд эхний лонхны ам руу шургуулав. Дараа нь суга татаж гаргаад нөгөө үзүүрийг нь лонхны ам руу чихэж бензин нэвчсэн үзүүрийг унжуулж орхив. Бусад бүх лонхийг ингэж бэлдлээ.

Энэ ажилд гар салгалах нь саад болсонгүй.

Хамгийн сүүлд уулзсанаас хойш хурандаа Кокс өөрчлөгджээ. Тэр Бүрхүүл рүү ирэхийн урд сахлаа хусч үсээ самнажээ. Гэхдээ өмд нь индүүдээгүй байх бөгөөд сүүлийн хугацаанд хурандаа хэт их турсан бололтой хүрэм нь сул санжиганана. Тэр хүчлээр хийсэн бүтэлгүй туршилтын дараа Бүрхүүл дээр үлдсэн хэд хэдэн будгийн толбоны дэргэд зогсч байв. Тэгээд Бүрхүүл дээр зурсан хаалганы хүрээний дүрс рүү хөмсөг зангидан ширтэх бөгөөд анхаарлаа дээд зэргээр төвлөрүүлж чадвал тийшээ орж чадах гээд байгаа мэт.

Нүдээ аниад өсгийгөөрөө гурван удаа товш. Яагаад гэвэл Бүрхүүл шиг өөр ийм юм дэлхий дээр байхгүй гэж Жулия бодов.

Тэр Роуз Кокс хоёрыг танилцууллаа. Танилцах хооронд нь эргэн тойрноо харав. Түүний харсан нь Жулияд огт таалагдсангүй. Хаа нэгтээ цахилгаан үүсгүүрүүд дүнгэнэж цахилгаан гүйдэл гарах бөгөөд тольдуурууд асч урьдын адил хязгаарыг гэрэлтүүлэх боловч ачааны тэрэгнүүд үгүй болжээ. Бас урьд нь бүрхүүлээс дөч тавин ярдын зайтай зам дээр бариастай байсан штабын том ногоон асар ч алга болсон байна. Тэр газарт шилний хагархай үйрмэгүүд гялтганана. Коксыг хоёр цэрэг дагалдах боловч тэд телевизийн дурангийн өмнө хэзээ ч зогсоход бэлэн чамбай туслахуудтай адилгүй харагдана. Эргүүлийн цэргүүд байгаа байх. Гэхдээ тэднийг Бүрхүүлээс холдуулсан болохоор Миллийн талаас ирсэн хэн нэг хөөрхийлөлтэй амьтан орчлон ертөнцөд юу болж байгааг асууж хандах боломжгүй болжээ.

Эхлээд асуу, дараа нь залбир гэж Жулия дотроо бодов. -Хатагтай Шамуэй. Надад юу болоод байгааг тайлбарлаж өгөөч? гэж Кокс асуув.

-Эхлээд миний асуултанд хариул.

Тэр залхсан маягтай тэнгэр рүү харлаа. (Жулия нааш ирэх замд тохиолдсон явдлын дараа тайтгарч амжаагүй байсан тул хэрэв түүнд хүрч болохоор байсан бол дуртайяа алгадах байв) Гэвч хурандаа асуултаа тавь гэлээ.

-Биднийг орхисон юм уу?

-Үгүй. Огтхон ч үгүй гэж тэр түгдрэлгүй хариулсан ч харц тулгарахаас зайлсхийв.

Энэ муу тэмдэг бөгөөд Бүрхүүлийн цаана харагдаж байгаа хоосноос ч дор гэж Жулия боддоо. Урьд нь тэнд цирк байрлаж байгаад одоо яваад өгчихсөн юм шиг.

-Үүнийг унш гээд тэр маргаашийн дугаарын эхний нүүрийг үл үзэгдэх Бүрхүүлийн гадаргууд наав. Яг л маргааш хямдрал болох тухай мэдээллийг их дэлгүүрийнхээ шилэн хоргонд нааж байгаа эмэгтэйг санагдуулна. Хурууны үзүүрээр ямар нэг цахилгаан цохилтын сул доргилтыг мэдрэв. Өвлийн хүйтэн өглөө эрт гадаа ямар нэг төмөр зүйлд хүрвэл гүйдэл үүсдэг шиг. Дараа нь зүв зүгээр болчихлоо.

Кокс сониныг тэр чигээр нь уншив. Ам үл нээх бөгөөд зөвхөн хуудас эргүүлж өгөхийг гуйна. Үүнд тэр 10 минут зарцууллаа.

Түүнийг уншиж дуусмагц Жулия ам нээв.

-Сурталчилгааны талбай багассан гэдгийг та анзаарсан байх. Гэхдээ бичлэгийн чанар дээшилсэн гэж би найдаад байгаа. Хэцүү нөхцөлд би дандаа илүү сайн бичдэг юм л даа.

-Хатагтай Шамуэй.

-Та яагаад намайг Жулия гэж дуудаж болохгүй гэж. Бид эртний андууд.

-Сайн байна. Та Жулия би Жей-Си.

-Би чамайг өнөөх усан дээгүүр явдагтай хольж хутгахгүйг хичээе. (Жеймс Коксын товчилсон "18" тэмдэглэгээ нь есүс христтэй адил)

-Энэ Ренни гэгч дарангуйлал

итгэлтэй байна уу? Мэн дэх Мануэль Ортега болох гэж үү? -Тэр бүр Пол Пот болох гэж зүтгэж байгаа гэж би айх юм. -Энэ боломжтой гэж үү?

-Хэрэв хоёр хоногийн өмнө ийм санаа хэлсэн бол би инээх байлаа. Хотын захиргааны хурал хөглөөгүй үедээ тэр хуучин машин зардаг. Гэвч хоёр хоногийн өмнө бол манайд хүнсний самуун болоогүй байсан. Энэ аллагын тухай хэн ч, юу ч мэдээгүй байсан.

-Барби яавч биш. Тэр хэзээ ч ингэхгүй гэж Роуз шийдэмгий толгой сэгсэрнэ.

Кокс хариу хэлсэнгүй. Гэхдээ тэр Роузыг тоолгүй өнгөрөөгүй болохыг Жулия мэдрэв. Ердөө л Жулиягаас анхаарлаа салгахад хүргэхээргүй тэнэг санаа гэж боджээ.

-Аллагыг Ренни үйлдсэн гэж та бодож байна уу?

-Танд юу гэж хэлмээр юм дээ... Бүрхүүл үүссэн цагаас

хойш согтууруулах ундаа худалдахыг хориглохоос эхлээд цагдаагийн даргаар усан тэнэгийг тавих хүртэл түүний хийсэн бүхэн өөрийн эрх мэдлийг бэхжүүлэхэд чиглэсэн улс төрийн шийдэл байсан.

-Тэр аллага хийж чадах хүн үү?

-Эхнэрийг нь үхсэний дараа тэр эхнэрээ алсан гэсэн цуу тарсан. Би энэ цуу яриаг үнэн гэж хэлэхгүй. Гэхдээ хүмүүс тухайн хүнийг ингэж чадах хүн гэж бодсон үед л цуу яриа төрдөг.

Кокс зөвшөөрөн толгой дохив.

-Гэхдээ хоёр залуу эмэгтэйг алж бэлгийн доромжлол үйлдсэн нь улс төрийн ямар ашиг

хонжоо авчрах нь надад ойлгомжгүй байна.

-Барби үүнд хамаагүй гэж Роуз өөрийнхөөрөө зүтгэв.

-Лестер лам ч ойлгомжгүй. Хэдийгээр түүний сүм ялангуяа радио станц нь сэжигтэй их мөнгөтэй байсан боловч Бренда Перкинсийн тухайд бол энэ магадгүй улс төрийн аллага.

-Тэгээд та нар энэ бүхнийг зогсоохын тулд тэнгисийн явган цэрэг илгээж чадахгүй юу? Та нар зүгээр л ажиглаж чадна. Том загас бүх хоолыг хамж идээд дараа нь жижгүүдээ барьж идэхийг хүүхдүүд хардаг шиг та нар шилэн хорго хараад зогсч байгаа гэж Роуз хэллээ.

-Би үүрэн холбоог таслаж чадна. Интернетийг бас таслаж чадна. Энэ бол хүч хүрэх зүйл гэж Кокс хариулав.

-Цагдаагийн газарт богино долгионы холбоо бий. Ренни түүнийг ашиглах байх. Тэгээд ггүрэв гаригт хүмүүс гадаад ертөнцтэй холбоо тасарсан тухай гомдоллох үед тэр бүх юманд та нарыг буруутгах болно гэж Жулия тодотголоо.

-Бид баасан гаригт хэвлэлийн бага хурал хийх гэж байсан юм. Түүнийг хойшлуулж болно.

Үүнийг сонсоод Жулиягийн бие зарайв.

-Тэгэж бодох ч хэрэггүй. Тэгвэл тэр өөрийн үйлдлийг гадаад ертөнцөд тайлбарлах хэрэггүй болно.

-Дээр нь нэмж хэлэхэд хэрэв та нар үүрэн утас болоод интернетийг салгах юм бол энд юу болж байгааг та нарт юмуу өөр хэн нэгэнд хэн ч хэлж чадахгүй болно гэж Роуз нэмлээ.

Кокс хэсэг хугацаанд хөл доорхоо харан зогсов.

-Бүрхүүлийг үүсгэж байгаа болзошгүй үүсгүүрийн талаар юу хэлэх вэ? Үр дүн байна уу?

Түүнийг хайхаар дунд сургуулийн сурагчид явсан талаар

Кокст хэлэх эсэхээ Жулия мэдсэнгүй. Гэвч тэр түүнд юу ч хэлж чадахгүй байсан нь тодорхой болсон юм. Яагаад гэвэл яг энэ үед хотын галын дуут дохио орилов.

Пит хаалганы дэргэд хамгийн сүүлчийн боодол сонинг аваачиж тавьлаа. Тэгээд нуруу тэнийж ташаагаа тулаад суниав. Өрөөн дотор яс нужиганах дуу хадахыг Тони олж сонсжээ.

-Ингэтлээ дуугаргана гэдэг чинь нуруу нь өвдмөөр юм даа.

-Харин ч эсрэгээр бие сайн байна.

-Эхнэр маань унтаж байгаа. Харин гараашт ганц шил юм нуусан бий. Гэртээ харих замдаа

аяга тагш юм уух уу? гээд Тони нүд ирмэв.

-Үгүй дээ. Би зүгээр л... хэмээн Пит ярьж эхэлтэл яг энэ үед эхний лонх цонхоор нисэн орж ирэв. Шатаж байгаа ноцоогуурыг тэр нүдний булангаар олж хараад хойш ухарлаа. Зөвхөн ганцхан алхам ухарсан юм. Гэхдээ энэ алхам Питийг ноцтой түлэгдэх юмуу зовж үхэхээс аварсан билээ.

Цонхны шил болоод лонх бут үсрэв. Бензин галан хучаас болж дүрэлзлээ. Пит газарт унаад өнхөрч холдов. Галан хучаас түүний дээгүүр цоролзон өнгөрөхдөө цамцных нь нэг ханцуйг шатаагаад Жулиягийн ширээний урдах хивс дээр буув.

-Ямар чөтгөр... гэж Тони дөнгөж хэлж амжтал нүхээр хоёр дахь лонх нисэн орж ирлээ. Энэ лонх Жулиягийн ширээний тавцан дээр бууж дээгүүр нь өнхрөхдөө галаар тургин цааснуудыг шатаав. Шатаж байгаа бензиний халуун үнэр агаарт нэвчлээ. Пит шатаж байгаа ханцуйгаа унтраах гэж оролдохын зэрэгцээ буланд байгаа усны сав руу гүйв. Морин шилний голоос нь барьж хазайлгаад хоолойноос асгарах усан дор шатаж байгаа ханцуйгаа тавьж өглөө. Ханцуйн дор гар нь хүчтэй халсныг мэдрэв.

Харанхуйгаас нисэн орж ирсэн Молотовын коктейлийн гурав дахь лонх байсныг оносонгүй. Явган хүний зам дээр унаж хагараад бетон дээр түүдэг гал үүсгэв. Бензинэн тэмтрүүл замын хажуугийн усны суваг руу суналаа.

-Хивсэн дээр ус асга. Хивсэн дээр ус асга. Тэгэхгүй бол эндэх бүх юм шатах нь гэж Тони хашгирав.

Пит хүндээр амьсгалж юм сэтгэх сөхөөгүй болсон амьтан түүн рүү гөлрөх ажээ. Морин шилний ус хивсэн дээр асгарсан ч норгох хэрэггүй байсан тэр хэсэгт нялайв.

Тони зөвхөн залуусын спортын тухай бичдэг нэгэн биш бөгөөд өөрөө ч ахлах сургуульд спорттой нөхөрлөж ирсэн. Түүнээс хойш арван жил өнгөрсөн ч үйлдлийн хөдөлгөөний хурд нь бараг өөрчлөгдсөнгүй. Тэр Питийн гараас морин шилийг суга татан авч, эхлээд ширээн дээрх цаас дараа нь шатаж байгаа хивс рүү ус цацав. Гал тэртэй тэргүй тархаж эхэлсэн ч Тони цагийг дэмий үрээгүй гэж найдах бөгөөд хонгилд байгаа пингээс дахиад хоёр ч морин лонхтой ус олдоно гэдгийг мэдэж байв.

-Дахиад ус аваад ир. Хонгилын хаалга нээгээд пинд байгаа гэж тэр одоо хүртэл шатсан ханцуйгаа гөлрөн зогсох Пит рүү хашгирлаа.

Пит эхэндээ ойлгохгүй байх мэт. Гэвч дараа нь ойлгоод хонгил руу ухасхийв. Тони ширээг тойрон гүйж шилэнд үлдсэн нэгээс хоёр пинт усыг галын дөл рүү цацлаа.

Харанхуйгаас нисч ирсэн сүүлчийн Молотовын коктейлийн лонх хамгийн их хохирол дагуулав. Лонх залуусын хаалганы дэргэд хураасан боодолтой сонинг онолоо. Шатсан бензин шалны хөвөө даган урсаж галын дөл улалзана. Дөлийн цаана Төв гудамж яг зэрэглээ шиг униартах ажээ. Энэ зэрэглээний цаад талд хоёр бараан дүрсийг Тони олж харав. Дээш дэгдсэн халуун агаарын нөлөөгөөр тэдгээр залуус яг л бүжиглэж байх мэт харагдана.

-Барбараг чөлөөл. Тэгэхгүй бол энэ зөвхөн эхлэл шүү. Бид олуулаа. Бид энэ чөтгөрийн хотыг шатаана. Барбараг чөлөөл. Эсвэл өөртөө гомдоорой гэж чанга яригчаар хүч оруулсан дуу хадав.

Тони доош харахад хоёр хөлнийх нь завсар галын нарийн горхи урсаж явах аж. Цацах ус ч байсангүй. Жаахан удвал гал хивсийг идэж дуусаад доорх мод руу нь орох ажээ. Энэ хооронд хаалга цонх бүхий редакцийн урд талын хана авалцаж эхэллээ.

Тони хоосон шилээ чулуудаад хонгил руу ухрав. Өрөөн доторхи халуун аль хэдийн мэдэгдэхүйц өсчээ. Тэр галын халууныг мэдэрч байв. Хэрэв энэ чөтгөрийн сонин байгаагүй бол би магадгүй амжих байсан...

Гэвч түүний хазайх цаг дуусчээ. Тэр эргэж хараад Пит хонгилын хаалган дээр гартаа "Поланд Спринг" дүүрэн устай шил барьсан зогсч байхыг харав. Түүний цамцны ханцуйнаас шатсан салбархай үлджээ. Гарын арьс нь улайсан байв.

-Одоо оройтсон. Дэндүү оройтчихлоо. Арын хаалгаар гарцгаая гэж Тони хашгираад аль хэдийн галан багана болж хувирсан Жулиягийн ширээг нэг гараар халуунаас нүүрээ халхлан байж холуур тойрон гүйв.

Питийг дахин ятгах хэрэг гарсангүй. Тэр хүчээ авч буй гал руу устай лонхоо шидээд хурдан гүйлээ.

23

Хэдийгээр "Бензин ба зууш" дэлгүүр олон жилийн турш нөхөр тэр хоёрыг хангалуун амьдрахад тусалж байсан боловч Кэрри одоо энэ дэлгүүртэй ямар нэг холбоотой байхыг огт үл хүснэ. Тэр өөрийгөө үүнээс дээгүүрт тооцно. Гэвч нөхөр Жонни нь дэлгүүр рүү очиж, үлдсэн лааз савтай хүнснүүдийг гэртээ авчрах санал тавихад шууд зөвшөөрөв. Нөхөр нь өөрийнхөө санааг "Бүтэн байг л дээ" гэж тайлбарласан. Хэдийгээр Кэрри биеийн хөдөлмөрийг огт хүндэлдэггүй боловч энэ удаад өөрөө дуртайяа тусалж байв. Тэр зурагтаар савангийн дуурь үзэхийг илүүд тооцдог. Энэ эмэгтэй "Хүнсний ертөнц"-ийг сүйтгэхэд оролцоогүй ч хожуу найз бүсгүй Лиятай хамт очсон юм. Хагархай цонх, цардмал зам дээрх цус гээд харсан зүйлс нь түүнийг айдаст автуулав. Тэр ирээдүйнхээ төлөө ч айж эхэлжээ.

Жонни хуурай шөл, жигнэсэн мах, шош ба сүмстэй цаасан хайрцагуудыг зөөнө. Кэрри тэднийг дож машиныхаа ачаан дээр хураана. Ачаа талдаа орж байх үед замын нөгөө талд түймэр дүрсхийхийг олж харлаа. Бас чанга яригчаар хүч оруулсан дууг сонсов. "Берпигийн их дэлгүүр" ба шатахуун түгээх станцын дундуурх нарийн гудамжаар 2-3 хүний дүрс гүйхийг Кэрри харах шиг болов. Гэхдээ бүрэн итгэлтэй биш байлаа. Гэвч хожим энэ итгэл дахин бий болох бөгөөд гүйсэн хүний тоо дөрөв болж өснө. Магадгүй тав болно.

-Энэ юу болж байна вэ? Хонгор минь энэ юу болоод байна вэ? гэж тэр асуув.

-Тэр чөтгөр шиг алуурчин ганцаар биш юм байна. Бүхэл бүтэн дээрмийн бүлэг гэж Жонни хариуллаа.

Кэрри нөхрийнхөө гараас атгаж байснаа одоо бүр хумсаа зоов. Жонни гараа суга татаад цагдаагийн газрыг чиглэн гүйж, хамаг хүчээрээ "түймэр түймэр" гэж орилов. Харин Кэрри түүнийг дагаагүй бөгөөд ачаагаа үргэлжлүүлнэ. Одоо тэр ирээдүйнхээ төлөө улам их айх болов.

24

Дунд сургуулийн спорт танхимын сандал дээр Рожер ба ах дүү Боуи нараас гадна Честерс-Милл хотын аюулгүйн албаны арван шинэ дайчин суух ажээ. Том Жим тэдний мөрөн дээр ирж байгаа хариуцлагын тухай яриагаа дөнгөж эхэлж байтал түймрийн дуут дохио муухай орилов. "Жаалхүү яарчихжээ. Би сүнсээ амраах тал дээр түүнд итгэж болохгүй юм байна. Хэзээ ч итгэж болохооргүй байсан. Харин одоо бүр дорджээ" гэж Ренни бодов. Тэгээд залуу Микки Уэрдлоу руу харж дотроо "бурхан минь ямар гээч булиа эр вэ?" гэж бодонгоо ярьж гарав.

-За залуус аа, уг нь би та нарт зөндөө юм ярихыг хүссэн боловч үгээ орхиж ажил хэрэгт орох цаг ирэх шиг боллоо. Ферн чи галын газарт гар насосууд байгаа эсэхийг мэдэхгүй биз?

Ферн хотод галын ямар тоног төхөөрөмж үлдсэнийг зүгээр л сонирхон очиж үзэхэд арваад гар насос байсан тухай хариулав. Бүгд дүүрэн устай савгай.

Том Жим элдэв наргианаа ухаан хүрэх хүмүүст хадгалж байх нь дээр гэж шударгаар шийдээд бурхан тэнгэр ивээл нигүүлсэлээр тэдний дээрээс харж байгаа гэж хэлэв. Тэгээд хэрэв түгшүүр хуурамч биш байх юм бол гал сөнөөх ажлын удирдлагыг өөртөө авч харин Стюартыг туслахаар томилов.

Нүд нь ассан шинэхэн дайчид сандалаас босохыг харах үедээ тэр "Май чи, май чи, муу салдаггүй шулам" гэж дотроо бодлоо. Чи цаашдаа миний ажилд хошуу дүрэх эсэхийг бид харах болно.

25

Картер машинаа Баруун гудамж ба 117-р гудамжны Т хэлбэртэй уулзвар дээр аваачиж зогсоод: -Одоо хаачих вэ? гэж асуув. Бүр 2007 онд хаалгаа барьсан "Тексако" шатахуун түгээх станц энд байдаг. Жижгээ тэр хоёр хотын ажил хэргийн төвийн бараг дэргэд байх боловч энэ станц тэднийг сониуч нүднээс далдлана. Тэдний ирсэн зүгээс галын дуут дохио чарласан хэвээр байх ба тэнгэрт түймрийн эхний хэлүүд цоролзож эхэлсэн нь улбар ягаан гэхээс илүү яв ягаан өнгөтэй байв.

-Юу гэнэ ээ? гээд Жижгээ хүчээ авч байгаа гал руу харна. Түймэр түүнийг өдөөжээ. Одоо тэр найз охингүй болсондоо харамсахад хүрэв.

-Чамайг хаачих вэ гэж би асууж байна. Танай аав баталгаатай газар байх хэрэгтэй гэсэн шүү дээ.

-Би хоёр дугаартай эргүүлийн машиныг шуудангийн цаана үлдээсэн. Өнөөдөр би Фреддитэй

жижүүрлэж байгаа. Өнөө оройжин хамт байсан гэж тэр хэлэх болно. Тиймээс би тийшээ явлаа. Баруун гудамжаар ч явах байх. Яаж дүрээлээж байгааг нь харъя гэж Жижгээ галаас харцаа дуртай дургүй салган хэлэв. Тэгснээ охин хүүхэд шиг часхийтэл инээхэд Картер түүн рүү ойлгож ядан харахад хүрэв.

-Удаан битгий хараарай. Галдан шатаагчид өөрийнхөө тавьсан галыг харах гэж эргэж ирээд баригддаг гэсэн. Би "Америкийн хамгийн их эрэн сурвалжлагдсан гэмт хэргүүд" гэдэг хөтөлбөрөөр үзсэн юм.

-Булшинд ормор Барбигаас өөр хэнийг ч галын хэрэгт буруутгахгүй. Харин чи хаачих юм бэ?

-Гэртээ харьялаа. Манай ээж намайг оройжин гэртээ байсан гэж батлах болно. Мөрний боолтоо ээжээрээ солиулна. Тэр чөтгөрийн нохойн хазалт их өвдөж байна. Аспирин ууна. Дараа нь хот орж гал унтраахад тусална.

-Эрүүл мэндийн төвд аспиринаас хавьгүй хүчтэй эм байгаа даа. Эмнэлэгт ч байгаа. Эмийн санд ч байгаа. Бид тэндээс зарим нэг юмыг зээлдэж авах хэрэгтэй.

-Тэр ч тийм шүү.

-Эсвэл... Мет хэрэглэдэг үү? Би олж чадна.

-Мет ээ? Хэзээ ч холбогдож байсангүй. Харин окси бол би дургүйцэхгүй.

-Окси гэж Жижгээ дуу алдав. Яагаад энэ тухай хэзээ ч бодоогүй юм бэ? Окси чинь зомиг юмуу имитрексээс илүү толгойн өвчин намдаах байх.

-Дүү минь чи зөв ярьлаа.

Жижгээ нударгаа өргөхөд Картер өөрийн нударгыг мөргүүлэв. Гэхдээ тэр Жижгээтэй хамт кайф авахыг үл хүснэ. Тэр ер нь нэг л хачин болчихсон.

-Жижгээ чи явсан нь дээр.

-Аль хэдийн явж байна гээд хаалга онгойлгон бууж Баруун гудамжаар бага зэрэг хазганан явж одов.

Жижгээг бууж явахад сэтгэл нь хөнгөрсөнд Картер ихэд гайхав.

Галын дуут дохио орилох дуунаар Барби сэрээд хорих өрөөний дэргэд зогсч байгаа Мелийг олж харав. Тэр залуу өмднийхөө дэлгүүрийг аль хэдийн нээгээд сүрдэм том эрхтэнээ гартаа барьжээ. Барби харж байгааг анзаарангуутаа шээсээ годгодуулав. Түүний ханзанд хүргэх гэж хичээсэн ч бүтсэнгүй. Гэхдээ бетон дээр шээсээрээ 8 үсэг зураад сэтгэл ханалаа.

-Алив Барби уугаач дээ. Чи цангаж байгаа байх. Бага зэрэг давстай ус шүү дээ. Тэглээ гээд

юу гэж? -Юу шатаад байгаа юм бэ?

-Чи л болж мэдэхгүй байна уу? гээд Мел инээв. Тэр цус их алдсан тул одоо хүртэл цонхигор байх бөгөөд харин боолт нь нэг ч толбогүй цав цагаан.

-Мэдэхгүй гэж тооцё.

-Чиний найз нар сонины редакцийг шатаажээ гэх үед Мел шүдээ ярзайлган инээлээ. Энэ залуу уур хилэнд автсаныг Барби ойлгов. Бас их айжээ.

-Биднийг айлгах гэж оролдоо юу? Чамайг суллах гэж үү? Гэхдээ бид... Айхгүй.

-Би яахаараа редакцийг шатаадаг юм бэ? Яагаад хотын захиргаа биш гэж? Миний найзууд гэдэг чинь хэн юм бэ?

Мел эрхтэнээ өмд рүүгээ буцааж чихэв.

-Барби чи маргааш цангахаа болино. Энэ тал дээр бүү санаа зов. Бид онгоц дүүрэн ус тавиад түүн дээр чиний нэрийг бичнэ. Бас бие угаах хөөсөнцөр нэмж өгнө.

Барби дуугарсангүй.

-Чи Айракийн усны тамлалтыг үзсэн үү? гэснээ Мел Барби үзсэн гэж хэлсэн юм шиг толгой дохиод:

-Одоо чи энэ юу болохыг өөр дээрээ сорино гэснээ тэр хуруугаа түүн рүү чиглүүлэв. Тэгээд - Чиний хамсаатнууд хэн болохыг бид тодруулах гэж байна. Бас хотыг тусгаарлахын тулд юу хийснийг чинь тодруулах болно. Энэ бол усан там. Үүнийг хэн ч тэсдэггүй юм гээд холдож явснаа буцаж ирээд: -Цэвэр ус биш шүү. Давстай ус. Үүнд итгээрэй. Сайн бод гээд Мел явж одов. Тэр боолттой толгойгоо унжуулан шатаар өгслөө. Барби Мелийн шээсээр зурагдсан могой хатахыг харж, бас түймрийн дуут дохиог сонсон ханзан дээрээ суув. Пикап машинд сууж явсан бүсгүйг бодлоо. Түүнийг авах шахсанаа дараа нь больсон цайвар үст бүсгүй. Тэр нүдээ анив.

Чандар

1

Расти эмнэлгийн өмнөх тойрч эргэдэг дугуйрсан зам дээр зогсоод Төв гудамжны хаа нэгтгээгээс цоролзох түймрийн хэлийг ажиглаж байтал бүсэндээ зүүсэн гар утас нь дуугарлаа. Дуги Жина хоёр дэргэд нь байв. Бүсгүй хамгаалалт эрэх мэт Дугигийн гараас зуурчээ. Харин Жинни Гарриет хоёр сувилагч нарын амралтын өрөөнд унтаж байв. Тэдэнд туслахаар сайн дураар ирсэн Маршалл өвчтөнүүдийг тойрно. Тэр гайхалтай сайн мэргэжилтэн байжээ. Гэрэл асч, амьсгалын төхөөрөмж ажиллаж, хэсэг хугацаанд бүх юм хэвэндээ оров. Гал түймрийн дуут дохио орилох хүртэл Расти сэтгэл санаа нь өргөгдөхөд хүрсэн билээ.

Тэр дэлгэц дээр нь "Линда" гэж гарахыг хараад ярив.

-Хонгор минь бүх юм зүгээр үү?

-Энд бол зүгээр. Хүүхдүүд унтаж байна.

-Юу шатаад байгааг чи мэдэх үү?

-Сонины редакци. Энэ ярианы дараа ганц хоёр минутын дотор би утсаа салгаж, хэн нэгэн утасдан түймэр унтраахад туслах тушаал өгөхөөс зайлсхийх учир дуугүй сонсоорой. Жекки энд байгаа. Тэр хүүхдүүдийг харж байх болно. Чи орпгуулгын товчооны дэргэд ирж надтай уулз. Стейси Моггин тэнд бас байх болно. Тэр түрүүнд ирсэн. Тэр бидэнтэй.

Нэрийг нь санах боловч царай нь санагдахгүй байв. Гэхдээ тэр бидэнтэй гэсэн үг тархинд шууд зоогдов. Тэгэхээр үнэхээр талууд болон хуваагдаж эхэлжээ. Зарим нь бидэнтэй, зарим нь тэдэнтэй.

-Линда.

-Түр баяртай. 10 минутын дараа. Түймэр унтраах хооронд ямар ч аюул байхгүй. Яагаад гэвэл ах дүү Боуи нар гал унтраах багт байгаа. Стейси тэгж хэлсэн.

-Тэд яаж баг цуглуулж амжсан юм бэ?

-Мэдэхгүй. Надад хамаагүй. Чи ирнэ биз дээ.

-За.

-Сайн байна. Оршуулгын товчооны дэргэдэх зогсоолд машинаа битгий тавиарай. Байшингийн цаана байдаг жижиг зогсоолд ороорой гээд холбоо тасрав.

-Юу шатаад байгаа юм бэ? гэж Жина асуув.

-Мэдэхгүй. Яагаад гэвэл надтай хэн ч яриагүй гээд Расти тэдэн рүү ширүүн харав.

Жина юу ч ойлгосонгүй. Харин Дуги тэр дороо ойлгов. -Тийм ээ, хэн ч утасдаагүй.

-Би зүгээр л яваад өгсөн. Магадгүй дуудлагаар. Хаашаа гэдгийг та нар мэдэхгүй. Би ч хэлээгүй. Ойлгосон уу?

Жинагийн царайд үл ойлгосон төрх ил байсан ч толгой дохив. Яагаад гэвэл тэр эдний талд. Тэр энэ асуудлыг аль хэдийн шийдсэн. Жина ердөө 17 настай. Тэд ба бид гэж Расти бодов. Ямар ч гэсэн хэцүү юм болох нь дээ. Тэр тусмаа 17 настангуудад.

-Магадгүй дуудлагаар явсан. Хаашаа гэдгийг нь бид мэдэхгүй гэж Жина давтлаа.

-Тийм ээ, бид мэдэхгүй. Чи бол дэвхрэг. Харин бид өрөвдөлтэй шоргоолжнууд гэж Дуги батлав.

-Гэхдээ та хоёр намайг ноцтой ажлаар явж байгаа гэж бодох хэрэггүй хэмээн Расти санууллаа.

Үнэндээ бүх юм тун ноцтой байв. Тэр үүнийг мэднэ. Гай айсуй. Тэгээд Жина энэ түүхэнд татагдан орсон ганц хүүхэд нь биш ч байж мэднэ. Линда тэр хоёрын хоёр хүүхэд одоо унтаж байгаа бөгөөд ээж аав хоёр нь магадгүй тэдний бяцхан завийг сүйрүүлэх хар шуурганы өмнөөс хөвж яваа талаар ойлголт байхгүй байгаа.

Тэглээ ч гэсэн...

-Би удахгүй ирнэ гэж хэлэхдээ Расти ингэх байх гэж найдав.

2

Расти "Боуигийн оршуулгын товчоо" руу яваад тун удаагүй байхад Сэмми Буши Эвансуудын "малибу" машинаар эмнэлэг дээр ирлээ. Тэд хотын талбайн хажуугийн толгой дээр зөржээ. Дуги Жинна хоёр эмнэлэг рүүгээ орсон тул хажуугийн оролтын эргэх тойрог хоосон байв. Гэхдээ Сэмми тэнд зогссонгүй. Зорчигчийн сандал дээр хэвтэх гар буу түүнд болгоомж нэмнэ. (хэрэв Фил байсан бол түүнийг сэрдэх донтон гэх байсан) Бүсгүй цаашаа өнгөрч ажилтнуудад зориулсан зогсоол дээр зогслоо. 45 калибрийн гар буугаа авч жинсэндээ шургуулаад цамцны хормойгоор хаав. Зогсоолыг хөндлөн гарахдаа угаалгын газрын үүдэн дээр зогтусч тэнд өлгөсөн зарлалыг уншлаа. "Нэгдүгээр сарын 1-нээс эхлээд энд тамхи татахыг хориглоно. Эвгүй байдалд орохгүйн

тулд тамхиа одоохон хая" гэжээ. Сэмми хаалганы бариулыг ширтэнэ. Хэрэв энэ бариул эргэхгүй бол тэр төлөвлөгөөнөөс татгалзана гэдгээ мэдэж байв. Энэ бурхны тэмдэг байж болно. Гэвч хаалга түгжээгүй бол...

Яг тэгж таарлаа. Цонхигор цагаан, хазгар, хий үзэгдэл шиг тэр бүсгүй эмнэлэг рүү шурган оров.

Маршалл ядарчээ. Хамаг хүчээ шавхсан гэхэд болно. Гэхдээ тэр ийм аз жаргалыг мэдрэхгүйгээр олон жил өнгөрсөн байна. Мэдээж энэ нь гажиг мэт санагдана. Тэр бол орон тооны профессор, найраг нь байнга хэвлэгддэг яруу найрагч, нэр хүндтэй угта зохиолын сэтгүүлийн редактор, бас түүний өврийг түүнээс илүү эр хүн байхгүй гэдэгт итгэлтэй ухаалаг, хөөрхөн эмэгтэй бүлээцүүлдэг. Гэтэл хэрэв эм тараах, тос түрхэх, нугасныг дэгдээхэйн баас цэвэрлэх (Бушигийн хүүхдийн бохир бөгсийг цагийн өмнө цэвэрлэсэн) зэрэг нь дээр дурьдсан амжилтуудаас илүү түүнийг аз жаргалтай болгож байгаа юм бол тэр жинхэнэ гаж донтон байж таарна. Гэвч яг ийм л мэдрэмж төрөөд байлаа. Шал өнгөлөгчийн үнэр ба ариутгах бодисын үнэр нэвчсэн эмнэлгийн хонгил түүнийг аль хэдийн өнгөрч одсон залуу насанд нь хүргэх ажээ. Хурц дурсамж оргилон гарч ирэв. Дэвид Пернийн (Америкийн кино жүжигчин) өрөөн дэх тосны хурц үнэр "пейсли" хээтэй толгойн боолт юмуу Бобби Кеннедигийн сүнсийг тайтгаруулах дурсгалын ёслол дээрх лааны гэрэлд түүний өмсч байсан "турк өргөст хэмх". Тэр эмнэлгийн тасгуудаар явж "Том хөлтэй эмэгтэй" дууг аяархан дуулдаг байсан.

Маршалл амралтын өрөө рүү шагайвал хамраа зад цохиулсан сувилагч ба түүний залуухан хөөрхөн туслагч Гарриет хоёр наашаа чирч авчирсан модон орон дээрээ унтаж байв. Буйдан хоосон байх ба Маршалл энд хэдэн цаг угтах юмуу эсвэл одоо түр зуур суурьшаад байгаа Хайленд-Авенью дэх байшиндаа эргэж очих хэрэгтэй. Тэр энд үлдсэн нь дээр гэж шийдэв.

-Нөхцөл байдал ямар хачин өрнөнө вэ?

Хачин ертөнц.

Гэхдээ эхлээд өвчтнүүдээ дахин нэг шалгах хэрэгтэй. Тэр тэднийг одоо өөрийн өвчтөнүүд гэж хүлээж авах болсон. Үүнд нэг их цаг зарцуулагдахгүй. Олонхи тасаг хоосон байв. "Хүнсний ертөнц"-ийн дэргэд авсан гэмтлийн улмаас 9 цаг хүртэл унтаж чадаагүй Билл Олдман одоо бөх бат унтах бөгөөд дагзан дээрх шархаа дэрэнд хүргэхгүйн тулд хажуулдан хэвтээд хурхирах ажээ.

Түүнээс хоёр тасгийн наана Ванда Крамли байрлана. Зүрх хэмжигч шаржигнаж даралт нь хэвийн болсон боловч тэр эмэгтэй одоо ч хүчилтөрөгчийн аппаратаар амьсгалах бөгөөд Маршалл түүнийг амьд гарахгүй гэж айж байв. Хэт тарган, хэт их тамхи татдаг. Түүний нөхөр ба бага охин нь дэргэд нь сууна. Маршалл Уэнделлад хоёр хуруугаа гозойлгон V тэмдэг харуулсан нь одоо бол ялалтын тэмдэг бөгөөд харин түүний залууд энх тайвны бэлгэ тэмдэг байсан. Охин инээмсэглээд түүнд бас тэгж хариулав.

Мухар олгойгоо авхуулж одоо бие нь дээрдсэн Тенси Фринен сэтгүүл уншиж байлаа.

-Яагаад галын дуут дохио залгасан юм бэ? гэж тэр асуув.

-Хонгор минь би мэдэхгүй. Гэдэс яаж байна?

-Өвдөж л байна. Заримдаа их хүчтэй. Би маргааш гэртээ гарч болох уу? гэж тэр ажил

хэрэгчээр асуув.

-Үүнийг Расти эмч л шийднэ. Гэхдээ миний болор бөмбөлөг тийм гэж заагаад байна. Түүнийг ингэж хэлэхэд бүсгүй гэрэлтээд ирэхийг хараад Маршалл яагаад гэдгийг хэлж мэдэхгүй ч уйлмаар болов.

-Хүүхдийн эх буцаад ирсэн. Хонгилоор өнгөрөхийг нь би харсан гэж Тенси хэллээ.

-Сайн байна гээд Маршалл толгой дохив. Гэхдээ жаалхүү ямар ч асуудал тариагүй. Ганц хоёр удаа уйлагнаад, ихэнхидээ унтсан бөгөөд хоолоо идээд адар ширтэн орондоо хэвтэж байсан. Түүнийг Уолтер гэдэг юм билээ. (хаалган дээрх хүснэгтэд бичсэн Литл гэсэн үг нэрний нэг хэсэг гэж Маршаллын толгойд орсонгүй). Тэгээд ч Маршалл түүнд дотроо "Торазиний хүүхэд" гэсэн нэр өгсөн юм. (Торазин гэдэг нь мэдээгүйжүүлэлтэд хүч нэмдэг, шизофрени өвчний эмчилгээнд хэрэглэдэг эм бөгөөд олон муу үр дагавартай тул хориглосон)

Тэр одоо "Энд хүүхэд байна" гэсэн шар хүснэгтийг цавуутай туузаар дарж наасан 23-р тасгийн хаалгыг түлхэв. Жинагийн түүнд хэлснээр хүчингийн хэргийн хохирогч болсон залуу бүсгүй орны дэргэд сандал дээр сууж байхыг харлаа. Тэр хүүхдээ өвөр дээрээ суулгаад лонхтой сүүгээр

Стивен Кинг хооллож байв.

-Таны бүх юм зүгээр үү? Хатагтай Буши гэж Маршалл хаалганы хүснэгтийг хяламхийнгээ асуулаа.

Хэдийгээр тэр овгийг нь "Бушес" гэж буруу дуудсан ч Сэмми засч хэлсэнгүй. Залуучууд түүнийг Буша-Туша гэж дууддаг.

-Тийм ээ эмч ээ.

Маршалл ч түүний хэлснийг зассангүй. Дотор нь нуугдсан нулимсны хамт оргилох тайлбарлахын аргагүй баяр хөөр нь улам нэмэгдэв. Хэрэв Каро түүнийг идэвхитэй дэмжээгүй бол тэр эмнэлэгт ирж чадахгүй байсан ба энэ бүхнийг амсахгүй байсан гэж тэр бодлоо.

-Расти эмч таны эргэж ирсэнд баярлах болно. Уолтер бол аль хэдийн баярлаж байна. Танд өвчин намдаах эм хэрэгтэй юу?

-Үгүй. Тэр ингэж хэлэхдээ үнэнийг хэлсэн. Нууц газрынх нь өвчин түүнийг орхиогүй ч яагаад ч юм их холдсон байв. Газартай нарийхан утсаар холбоостой өөрийнхөө биен дээгүүр нисээд байгаа юм шиг Сэммид санагдах ажээ.

-Сайн байна. Энэ чинь та эдгэрч байгаа гэсэн үг.

-Тийм ээ, удахгүй бүх юм дуусна.

-Та хүүхдээ хооллож дуусаад хэвтвэл ямар вэ? Расти эмч өглөө үзлэг хийг. -За тэгье.

-Сайхан амраарай хатагтай Бушес. -Сайхан амраарай эмч ээ.

Маршалл хаалгыг зөөлөн хаагаад цааш одов. Хонгилын төгсгөлд Жоржия Ру-гийн тасаг бий. Тэр тийшээ шагайгаад ажлаа дуусгахыг хүслээ.

Бүсгүй унтаагүй бөгөөд адар ширтэн хэвтэнэ. Харин түүнийг эргэхээр ирсэн залуу тасагт байгаа буланд тавьсан ганц сандал дээр суугаагаараа хурхирна. Өвөр дээр нь спортын сэтгүүл хэвтэх ба тэр урт хөлөө жийжээ.

Жоржия Маршаллыг гараар дуудаад орон дээр нь ирж тонгойход ямар нэг юм шивнэв. Нэг ч пгүд үлдээгүйн зэрэгцээ арай ядан ярих тул тэр ганц хоёр үг л ойлголоо. Тэгээд улам тонгойв.

-Түийг бити сее. Тие намайг эгэх гэж есэн ганц хүн гэж түүний хэлэх нь сонсдов.

Маршалл толгой дохилоо. Мэдээж ийм орой болсон хойно

эргэлтийн хүмүүс тасагт байх ёсгүй боловч түүний цэнхэр хувцас ба зэвсгийг харвал энэ залуу гал түймэр дээр очоогүйн төлөө донго авах байх. Гэвч тэглээ гээд хэнд муу болох юм бэ? Ганц гал сөнөөгч илүү байлаа гээд цаг агаарыг өөрчлөхгүй. Хэрэв энэ залуу галын дуут дохионд сэрэхгүй байгаа юм бол тэнд очлоо гээд ямар ашиг гарах вэ? Маршалл түүнтэй ижил бодолтой байгаагаа бүсгүйд харуулахын тулд уруул дээрээ хуруугаа тавиад чишш гэж шивнэв. Бүсгүй инээх гэж оролдсон ч өвдсөндөө ярвайлаа.

Маршалл орны хөлөнд өлгөсөн хүснэгт дээр шөнийн хоёр цаг хүртэл түүнд үйлчлэх эмийг дээд зэргийн тунгаар хийсэн болохыг уншаад өвчин дарах эм санал болгосонгүй. Тэр өрөөнөөс гарч хаалгыг зөөлөн хаагаад нойронд дарагдсан хонгилоор алхав. "Энд хүүхэд байна" гэсэн шар хүснэгтийг цавуутай туузаар хаалганд наасан тэр хаалга бага зэрэг онгорхой байгааг анзаарсангүй. Амралтын өрөөний буйдан түүнийг даллан дуудах боловч тэр хүүхдүүдтэй хамт байхын тулд гэр рүүгээ буцахаар шийдэв.

4

Сэмми шинэ эмчийг явах хүртэл Литл-Уолтерийг өвөртөө тэвэрсэн чигээр орны хажууд суулаа. Дараа нь хүүгийнхээ хоёр хацар ба уруул дээр үнсэв.

-Хүү минь сайн хүн болоорой. Хэрэв намайг хүлээж авдаг юм бол би Тэнгэрт чамтай уулзана. Авна гэж бодож байна. Яагаад гэвэл би тамд орж үзсэн хүн.

Бүсгүй хүүгээ орон дээр тавиад дараа нь шүүгээний хаалгыг нээв. Гар буу дээд тавиур дээр хэвтэнэ. Сэмми хүүгээ тэвэрч сүүлчийн удаа хооллох үед бууны бариул хүүг нь нухахыг хүсээгүй юм. Одоо Сэмми гар бууг гаргаж авлаа.

5

Төв гудамжийг Моттон-Роудын талаас анивчуураа асаасан хоёр эргүүлийн машин хөндөлсүүлэн хаажээ. Чив чимээгүй, баргар бөөн хүмүүс машины цаана зогсоод болж байгаа

бүхнийг ажиглана.

Горас тайван нохой бөгөөд эзнээ гэртээ эргэж ирэх үед баяртай хуцах юмуу эсвэл өөрийн байгааг сануулахын тулд тасалдан хуцдаг энэ нохой Жулия "прүс" машинаа "Ma180п (1e8 P1eигз"-ийн дэргэд зогсоох үед арын суудал дээр оцойгоод ульж гарав. Жулия түүн рүү гараа сунгаж толгойг иллээ. Нохой тайвширав.

-Жулия бурхан минь гэж Роуз дуу алдлаа.

Тэд машинаас гарцгаав. Жулия эхлээд Горасыг машиндаа орхихыг хүссэн ч тэр мэдэж байгаа юм шиг, үнэхээр мэдэж байгаа юм шиг дахин ульж гарлаа. Тэгэхээр нь Жулия зорчигчийн суудал дороос нохойн хүзүүвчийг гаргаад арын хаалгыг нээж түүнийг үсрэн буунгуут хүзүүнд нь хүзүүвчийг зүүв. Хаалгыг хаахаас өмнө арын сандалын хармаанаас "касио" бэсрэг гэрэл зургийн аппаратаа авлаа. Тэр эвшээн зогсох хүмүүсийг түлхэн урагшилаа. Нохой нь түүний өмнө гарч хүзүүвчээ чангаана.

Урьд нь цагдаагийн газарт хагас дутуу ажиллаж байсан ба таван жилийн өмнө Миллд ирсэн Пайперийн үеэл дуу Руп бүсгүйг зогсоох гэж оролдов.

-Хатагтай цаашаа хэнийг ч оруулахгүй.

-Энэ миний гэр. Энэ хорвоод миний гэсэн бүхэн дээд давхарт байгаа. Хувцас, ном, хувийн эд зүйлс. Доод давхарт өвөг эцгийн минь үндэслэсэн сонин бий. 120 жил өнгөрөхөд ердөө дөрөвхөн удаа хугацаандаа гарч чадаагүй юм. Харин одоо бүгд утаа болон хувирч байна. Хэрэв чи намайг энэ бүхнийг ойроос харахад саад болно гэх юм бол намайг буудах л хэрэг болно доо гэж Жулия дургүйцэв.

Рупийн царайд эргэлзээ тодорсон ч бүсгүй цаашаа алхахад цагдаа холдож өгөв. Гэхдээ хоромхон төдийд. (харин Горас эзнийхээ өвдөгт наалдаад энэ халзан эр рүү иттэлгүй ширтэнэ)

-Чи харин болохгүй гэж цагдаа Роузыг зогсоох гэж оролдов.

-Би болно. Хэрэв чи надад захиалах шоколадны бялууны дараагийн хэрчим дээрээ тайвшируулах юм цацуулахыг хүсэхгүй бол.

-Хатагтай... Роуз... Би тушаалтай.

-Чиний тушаалыг чөтгөр аваасай. Жулиягийн дуунд дайчин гэхээс илүү ядарсан өнгө тодров. Тэр Роузын гараас хөтлөөд явган хүний замаар алхсан ба түймрээс төөнөх халуун тэвчих аргагүй болох үед зогсоцгоов.

Түүний гэр ба "Ардчилал"-ын редакци байрлаж байсан байшин аварга түүдэг болон хувирчээ. Хэдэн арван цагдаа нар хэдийгээр хангалттай олон гар насостой байсан ч галыг унтраах гэж үл оролдоно. (гар насосууд дээр "Берпигийн их дэлгүүрт хямдралтай өдрүүдэд тусгай үнэ" гэсэн бичиг харагдана). Цагдаа нар номын дэлгүүр болоод эмийн дэлгүүр рүү ус

цацах ажээ. Салхи огт байхгүй болохоор тэд энэ хоёр байшинг аварч чадах ба өөрөөр хэлбэл Төв гудамжны зүүн хэсгийн офисын бүх барилгыг авч үлдэнэ гэдэгт Жулия итгэв.

-Тэд энд ямар хурдан ирсэн нь үнэхээр гайхалтай гэж Роуз тайлбарлалаа.

Харанхуйд хөөрч ягаан оддыг бүдгэрүүлэх дөлийн улаан хэлийг Жулия ширтэн юу ч хэлсэнгүй. Тэр уйлах ч сөхөөгүй дэндүү цохилтонд оржээ.

Бүх юм сүйрчээ. Бүгд гэж тэр бодов. Тэгээд Кокстой уулзахын өмнө багажиндаа хийсэн боодол сониныг саналаа. Тэгснээ "бараг бүгд" гэж засч бодов.

Пит "Сандерсийн эмийн дэлгүүр"-ийн хойд хана ба хашаа руу ус шүрших олон цагдаагийн дундуур зүтгэнэ. Түүний тортог болсон царайн дээр нулимсны зам татагджээ.

-Жулия би маш их харамсч байна. Бид бараг унтраасан... Унтраах байсан... Гэвч энэ новшнуудын шидсэн сүүлчийн лонх шалан дээр хураасан сониныг оносон. Тэгээд... би маш их харамсч байна гэж Пит бараг цурхирах бөгөөд ханцуйн үлдэгдлээр нүүрээ шударч, хөө тортогийг улам нялав.

Хэдийгээр Пит түүнээс 6 дюйм өндөр ба 100 фут илүү жинтэй ч бүсгүй түүнийг яг жаахан хүүхэд шиг тэвэрлээ.

-Юу болсон юм бэ? гэж Жулия асуув.

-Шатаах бөмбөг. Тэр муу булшинд ормор Барбара.

-Тэр шоронд байгаа шүү дээ.

-Түүний найзууд, чөтгөр шиг найзууд нь. Тэд үүнийг хийсэн.

-Юу гэнэ ээ? Чи харсан юм уу?

-Би сонссон юм. Сонсохгүй байх аргагүй байсан. Тэд чанга яригчаар хашгирсан. Хэрэв Барбараг суллахгүй бол бүх хотыг шатаана гэсэн. Түүнийг суллана гэнэ үү? Бид түүнийг дүүжлэх ёстой. Надад олс өг. Би өөрийн гараар хийнэ гэж Пит бүсгүйг түлхэн өөрөөсөө холдуулан харж байгаад хэлсэн ба гашуунаар инээв.

Том Жим хол хол алхлан тэдэн дээр ирлээ. Гал түүний хацрыг улбар өнгөөр буджээ. Тэр дарвайтал инээх бөгөөд уруул нь чихэндээ хүрэх шахна.

-Жулия, одоо чиний найз Барби чамд таалагдаж байна уу?

Жулия түүн рүү ойртоход Жим царайд нь ямар нэг юм олж харсан бололтой цохиулахаас айх мэт алхам ухрав.

-Энэ утгагүй юм. Ямар ч утгагүй. Чи үүнийг мэдэж байгаа.

-Би утгатай гэдгийг мэднэ. Хэрэв Барбара болоод түүний нөхөд Бүрхүүл үүсгэснийг чи зөвшөөрөх юм бол утга нь шууд нээгдэнэ. Энэ бол алан хядах үйл ажиллагааны цэвэр үйлдэл.

-Нохойн баас. Би түүний талд байсан. Тэгвэл энэ нь сонин түүний талд гэсэн үг. Тэр үүнийг мэдэж байсан.

-Гэхдээ тэд хашгирсан шүү дээ... гэж Пит эхлэв.

-Тийм ээ, гэж Жулия эргэж харалгүй түүний яриаг тас дайрав. Тэр Реннигийн түймэрт гэрэлтсэн царайнаас нүд үл салгана. -Тэд хэлсэн. Тэд хашгирсан. Гэхдээ тэд гэдэг чинь хэн юм бэ? Чөтгөр ав. Өөртөө энгийн асуулт тавь. Барбид ингэх шалтгаан байгаагүй. Тэгвэл хэнд ийм шалтгаан байв? Амгалан байддыг нь алдагдуулж байгаа Жулиягийн амыг хааснаар хэн хожих вэ?

Том Жим цааш эргэж хоёр шинэ цагдааг дуудлаа. Баруун булчиндаа зүүсэн цэнхэр даавуу л тэднийг хууль сахиулагчид болохыг зааж өгөх ажээ. Өндөр чийрэг нэг залуугийн царай нь хэдийгээр тэр галбир томтой ч жаахан хүүхэд болохыг заагаад өгөв. Хоёр дахь нь Кильяний хүүхдүүдийн нэг болох нь илт. Түнжин толгой, дэгээ хамар нь тэдний таних тэмдэг.

-Микки, Ричи. Энэ хоёр эмэгтэйг эндээс холдуул. Горас хүзүүвчээ тасдах шахан Том Жим рүү архирав. Өнөөх нь жижигхэн нохой руу үзэн ядсан байдалтай ширтэнэ. -Хэрэв тэд сайн дураар холдохгүй бол гарьтг нь мушгиж аль ойр байгаа эргүүлийн машины хамар дээр дарахыг би зөвшөөрч байна.

-Бид дуусаагүй шүү гээд Жулия Жим рүү хуруугаар буу болгон шагайв. Одоо тэр уйлж эхэллээ. Гэхдээ халуун бөгөөд шаналгаат ийм нулимс уй гашууны нулимс яавч биш.

-Муу жингэрийн хүү. Бид ингээд дуусахгүй.

Том Жимийн царайд "хаммер" машины өнгөлгөө шиг инээд гялсхийв. Яг тийм тас хар инээд.

-Харин ч эсрэгээр. Бүх юм дууссан. Хэргийг хаасан гэж тэр хариуллаа.

6

Том Жим гал руу алхлаа. Энэ муу самуун дэгдээгч эмэгтэйн сонинцороос овоолгоостой үнснээс өөр юу ч үлдэхгүй болтол нь түймрийг харахыг тэр хүснэ. Тэр утаа залгилж байв. Цээжинд зүрх гэнэт зогсож, ямар нэг тусгай нөлөөгөөр дэлхий нүднийх нь өмнө хөвөв. Дараа нь зүрх нь хэмнэл алдагдсан байдалтай тарчлангуйгээр дахин ажиллаж гарав. Тэр цээжнийхээ зүүн тал руу зангидсан гараар нүдэж, хүчтэй ханиалаа. Хэмнэл алдагдах өвчнөөс сэргийлэх энэ түргэн аргыг Хаскел эмч түүнд зааж өгсөн юм.

Эхэндээ зүрх нь хямсганаж байв. (цохилт...түр зогсолт... салгалалт...түр зогсолт). Шар өнгийн бортогонд хоригдсон зүрхээ тэр хоромхон зуур нүдэндээ харах шиг болов. Амьдаараа булшлагдсан эрхтэн нь агаар дуусахаас өмнө чөлөөлөгдөх гэж оролдоно. Дараа нь энэ дүрийг толгойноосоо туун гаргав.

Би эрүүл. Зүгээр л ачаалал ихэдчихлээ. Долоон цаг унтахад бүх юм хэвийн болно.

Өргөн нуруундаа гар насос бэхэлсэн Рэндолф дарга дөхөж ирэв. Нүүрээр нь хөлс урсана.

-Жимээ, чи зүгээр үү?

-Бүх юм онц сайн. -Том Жим үнэнийг хэлсэн юм. Үнэн. Энэ нь Реннигийн хүрэх гавьяатай гэдгээ мэдэж байгаа агуу ихэд хүрэх боломж бөгөөд амьдралынх нь оргил байв. Тэгэхээр ямар ч өвчтэй зүрх түүнд ойрхон байгаа энэ ялгуусан ялалтыг булааж чадахгүй. -Жаахан ядарсан байна. Зогсолтгүй гүйгээд удаж байна даа.

-Гэртээ харь. Би Бүрхүүлд хэзээ ч талархана гэж бодож байгаагүй. Одоо ч талархахгүй. Гэхдээ тэр ядахдаа биднийг салхинаас хамгаалж байна. Бүх юм сайн болно гэж би бодоод байна. Эмийн сан болоод номын дэлгүүрийн дээвэр дээр манай хүмүүс байгаа бөгөөд тийшээ оч үсрэхээс сэргийлж байгаа. Тиймээс чи гэртээ харь...

-Ямар хүмүүс?- Зүрхний цохилт хэвэндээ оржээ. Хэвэндээ орж. Сайн байна.

-Генри Моррисон ба Тоби Уилен нар номын дэлгүүрийн дээвэр дээр байгаа. Жорж Фредерик манай шинэ залуусын нэгтэй хамт эмийн сангийн дээвэр дээр бий. Кильянуудын нэг нь гэж бодож байна. Ромми Берпи тэдэнтэй хамт явахыг хүссэн.

-Чамд богино холбоо байна уу? -Мэдээж.

-Фредерикт бас байгаа юу?

-Орон тооны бүх цагдаа нарт байгаа.

-Берпиг сайн харж бай гэж Фредерикт хэл. -Роммиг уу? Бурхан минь, яагаад?

-Би түүнд итгэхгүй байна. Тэр Барбарагийн найз байж мэднэ. -Берпигийн тухайд Том Жим Барбарагаас болж санаа зовоогүй юм. Энэ хүн Брендатай нөхөрлөдөг байсан. Бас ухаалаг хүн.

Рэндолфын хөлстэй царайд үрчлээсүүд тодров.

-Чинийхээр тэд хэдүүлээ юм бэ? Тэр гичийн хүүгийн талд хичнээн хүн байгаа юм?

Том Жим толгой сэгсрэв.

-Пит минь, хэлэхэд хэцүү. Гэхдээ энэ их том хэрэг шүү. Магадгүй урт хугацаанд төлөвлөж бэлдсэн. Хотод орж ирээд удаагүй хүмүүсийг зааж, тэд гэж хэлж болохгүй. Зарим нь манай хотод олон жил, эсвэл олон арван жил амьдарсан байж ч болно. Ийм хүмүүсийг сохор номин гэж нэрлэдэг.

-Бурхан минь. Гэхдээ яагаад? Жимээ? Яагаад?

-Би мэдэхгүй. Энэ туршилт бөгөөд бид туршилтын туулайнууд байж мэднэ. Эсвэл эрх

мэдлийн төлөөх тэмцэл ч байж болно. Хэрэв энэ хэрэгт одоо Цагаан ордонд сууж байгаа дээрэмчин орооцолдсон байлаа гэхэд би гайхахгүй. Хамгийн гол нь бид сонор сэрэмжээ дээшлүүлж, эмх журам тогтоох гэсэн бидний оролдлого руу пуужин харвахыг оролдож байгаа хуурамч амьтасыг хянах хэрэгтэй.

Дэргэд нь Горас нохой нь суугаад халууцсанаас болж хүндээр амьсгалах Жулия орон гэр болоод амьдралын бүх ажил хэрэг нь утаа болж байгааг харан зогсох тэр зүт рүү дарга толгой сэжээд: -Чи түүнийг гэж бодоод байна уу?

-Яг мэдэхгүй Питээ. Гэхдээ тэр өдөр ямаршуухан авирлаж байлаа даа? Цагдаагийн газар руу дайран орж Барбаратай уулзуулахыг шаардсан. Энэ тал дээр чи юу хэлэх вэ?

-Тиймээ гэж хэлээд Рэндолф Жулия Шамуэй рүү нухацтай ширтэнэ. -Өөрөө өөрийнхөө гэрийг шатаасан байх. Хамгийн сайн өнгөлөн далдлалт болно.

"Чи яг байгаа онолоо" гэж хэлэх мэт Том Жим түүн рүү хуруугаа чиглүүлэв.

-Би жаахан хэвтэх хэрэгтэй байна. Жорж Фредериктэй холбоо барь. Тэр льюистоны шувуухайгаас хараа бүү салга гэж хэл.

-За гээд Рэндолф богино долгионоо авлаа. Тэдний ард Фернолд Боуи хашгирав.

-Дээвэр нурлаа. Гудамжинд байгаа бүх хүмүүс ухраарай. Дээвэр дээр байгаа хүмүүс бэлдээрэй. Бэлдээрэй.

Том Жим "хаммер"-ынхаа бариул дээр гараа тавиад "Ардчилал"-ын дээвэр нурж, хар тэнгэр рүү оч гал үсчихийг ажиглана. Зэргэлдээх байшингийн дээвэр дээр зогсож байгаа эрчүүд хамтран зүтгэгчдийнхээ насосны хошуу нь бай руугаа чиглэсэн эсэхийг шалгаад дээвэр дээр бууж ирэх ямар ч очийг усаар шүршиж унтраахад бэлттэн хөшлөө.

"Ардчилал"-ын дээвэр нурах үеийн Жулиягийн царайн хувирал энэ дэлхийн бүх зүрх дэмжигч болоод шалчгар эмнүүдээс хавьгүй илүү ашиг тусыг Жимийн зүрхэнд авчрав. Тэр олон жилийн турш түүний долоо хоног тутмын айлтгах үгстэй эвлэрэхэд хүрч ирсэн бөгөөд хэдийгээр тэр Шамуэйгээс айдаг гэж хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй боловч энэ эмэгтэй түүнийг хангалттай цухалдуулсан билээ.

Одоо түүнийг хар л даа. Гэртээ ирээд ээж нь үхсэн байхыг олж үзсэн хүүхэд шиг л болжээ.

-Одоо чи дажгүй харагдаж байна. Цонхигор чинь арилчихлаа гэж Рэндолф хэллээ.

-Миний бие ч дээрдээд ирлээ. Гэхдээ гэртээ харинаа. Жаахан амрах хэрэгтэй.

-Сайн санаа. Найз минь, чи бидэнд хэрэгтэй. Хэзээ ч байгаагүйгээрээ хэрэгтэй. Хэрэв энэ Бүрхүүл алга болохгүй бол...-Рэндолф толгой сэгсрэх ба түүний нүд Том Жим рүү нохойн үнэнч харцаар ширтэнэ. -Чамгүйгээр яаж тэсч гарахаа мэдэхгүй гэж би хэлэх гэсэн юм. Би Энди Сандерсыг ах шигээ хүндэлдэг хэдий ч түүний толгой хоосон доо. Андреа Гринелийн тухайд унаж нуруугаа гэмтээснээс хойш шалчийсан лааз шиг ямар ч ашиггүй болсон. Харин

чи бол Честерс-Миллийг нэг бүтэн цул болгож байгаа тэр цавуу нь юм.

Эдгээр үгс Том Жимийн сэтгэлийг хөдөлгөв. Тэр Рэндолфын гарыг пгүүрч аваад атгалаа.

-Би энэ хотын төлөө амь насаа өгнө. Би түүнд дэндүү хайртай.

-Мэдэж байна. Би ч бас хайртай. Тэгээд хэн ч түүнийг биднээс хулгайлж чадахгүй.

-Чи бүхнийг зөв ойлгож байна.

Ренни ажил хэргийн төв рүү орох гарцыг хотын талбай талаас хааж зогссон цагдаагийн хоёр машиныг тойрохын тулд явган хүний зам дээгүүр туучихад хүрэв. Зүрх нь дахиад жигд цохилно. (бараг л). Гэвч түпиүүр түүнийг бас орхиогүй байв. Тэр Эвереттэй уулзах ёстойгоо ойлгож байлаа. Энэ санаа түүнд үл таалагдана. Эверетт мөн л самуун дэгдээгчдийн тоонд багтдаг. Хотод нэг цул болж нэгдэх хамгийн хэрэгтэй байхад үймээн дэгдээгч. Тэгээд ч тэр эмч биш. Том Жим зүрхний асуудлаараа малын эмчид хандахыг дээрд үзэх байсан. Даанч хотод нэг ч малын эмч байхгүй. Тэгээд зүрхний цохилтоо хэвийн болгоход шаарддагатай үр дүнтэй эмийг Эверетт хэлж өгнө гэж найдах л үлдэв.

За яахав. Түүний заасан ямар ч эмийг би Эндигээр дамжуулаад шалгачихна гэж тэр бодлоо.

Ренниг өөр нэг юм илүү түгшээж байсан нь Питийн хэлсэн "Хэрэв Бүрхүүл алга болохгүй бол..." гэсэн үгс юм.

Үнэнийг хэлэхэд Том Жим яг энэ тал дээр бол санаа огт зовохгүй байсан бөгөөд харин ч эсрэгээр байв. Гэвч харин Бүрхүүл хэт түргэн алга болох юм бол Ренни тун эвгүй байдалд орох байлаа. Мет үйлдвэрлэх лабораторийг илрүүлээгүй байсан ч гэсэн эвгүй байдалд орно. Түүний шийдвэрүүдэд эргэлзэх шалчгар юмнууд заавал гарч ирж таарна. Түүний аль хэдийн өөрийн болгосон улс төрийн амьдралын дүрэмд бол "хийж чадах хүмүүс юмаа хийдэг. Харин хийж чадахгүй хүмүүс хийж чадах хүмүүсийн шийдвэрийн талаар асуулт тавьдаг" гэдэг юм. Яг энэ хүмүүс түүнийг хэзээ ч ойлгохгүй. Түүний хийсэн бүхэн, эсвэл хийхийг тушаасан бүхэн, тэр бүү хэл өнөө өглөө их дэлгүүрийн урд чулуу шидүүлсэн нь хүртэл түмэн олны тусын тулд гэдгийг тэд ойлгохгүй. Хамгийн түрүүнд Барбарагийн нөлөө бүхий найз нар. Яагаад гэвэл тэд ойлгохыг ч хүсэхгүй. Барбарад найзууд байгаа гэдэгт, хүчирхэг найзууд байгаа гэдэгт Том Жим ерөнхийлөгчийн захидлыг харсан тэр цагаас хойш эргэлзэхээ больсон. Гэхдээ одоо бол тэд нар нь юу ч хийж чадахгүй. Том Жим энэ нөхцөл байдал дахиад хоёр долоо хоног энэ чигээрээ үлдэхийг хүснэ. Эсвэл сар ч юмуу.

Яг үнэнийг хэлэх юм бол Бүрхүүл түүнд үнэндээ таалагдаж байв.

Радиостанц дээр төвлөрүүлсэн хийг хот даяар дахин хувиарлах хүртэл Бүрхүүлд хандах Том Жимийн энэ хандлага өөрчлөгдөхгүй. Лабораторийг салгаж, лаборатори байгаа зоорины хэсгийг үнс болгон хувиргах хүртэл. (Барбарагийн хамсаатнуудад тохих дараагийн гэмт хэрэг). Бас Барбараг шүүхэд өгч, цагдаагийн буудлагын баг ялыг гүйцэлдүүлэх хүртэл. Хямралын үед хийсэн буруу бүхэн бусад олон хүн дээр тохогдож, харин алдар нэр бүхэн түүнд харьяалагдах хүртэл.

Тийм болохоор Бүрхүүл байж байсандаа ч яадаг юм. Том Жим унтахаар хэвтэхийнхээ өмнө өвдөг сөхөрч энэ тухай зальбирахаар шийдлээ.

7

Сэмми тасгуудын хаалган дээр байгаа нэрсийг уншин хонгилоор хазганах бөгөөд нэр усгүй тасаг руу бол юмыг яаж мэдэх вэ гээд шагайн харна. Тэр энэ жингэр эндээс гарчихсан юм болов уу гэж санаа зовж эхлээд байхдаа сүүлчийн хаалган дээр ирсэн ба хаалганд хадаасаар зоосон ил захидлыг олж харав. Ил захидал дээр хүүхэлдэйн баатар нохой "чиний бие муу байгаа гэж би сонслоо, үнэн үү?" хэмээн асууж байгааг дүрсэлжээ.

Сэмми жинсэн өмднийхөө бүсэлхийнээс Жек Эвансын гар бууг гаргаж ирэв. (өмдний бүсэлхий одоо биенд шигдэхээ больсон нь тэр арай гэж бага зэрэг турсаныг илттэнэ. Хэзээ хийхгүй байснаас оройтож байгаад ч болов хийсэн нь дээр гэдэг дээ). Тэр бууны амаар ил захидлыг нээв. Дотор нь хүүхэлдэйн баатар нохой төмсөгөө долоох ба "чиний бөгсийг долоож өгөх үү?" хэмээн асуух аж. Доор нь Мел, бага Ренни, Картер ба Френк нар гарын үсгээ зуржээ. Сэмми бодлоо. Тэднээс ийм л хошигнол хүлээх хэрэгтэй.

Тэр бууны гол төмрөөр хаалгыг түлхэн нээв. Жоржия ганцаараа биш болохыг харлаа. Гэхдээ өөр хүн байлаа гээд Сэммигийн өөртөө мэдэрч байгаа бүрэн тайтгарал ба тайвшралыг ганхуулсангүй. Хэрэв сандал дээр энэ гичийний эцэг юмуу авга ах гээд гэм буруугүй хүн байсан бол эргэлзэхэд хүргэх л байсан байх. Гэтэл сандал дээр хөх самардах нэн дуртай Френки унтаж байв. Түүнийг хамгийн эхлээд хүчиндсэн хүн. Түүнд зөвхөн сөхөрч суусан үедээ л амаа ангай гэж хэлсэн хүн. Түүний унтаж байгаа нь юу ч өөрчлөхгүй. Яагаад гэвэл ийм залуучууд сэрэнгүүтээ л өнөөхөө хийж эхэлдэг.

Жоржия унтаагүй байв. Өвчин үл намдана. Түүнийг эргэж ирсэн урт үст өвчин намдаах ямар нэг юм өгсөнгүй. Тэр

Сэммиг харангуутаа нүд нь бүлтийн томров. -Ши яах нь вэ? Эдээш тонил. Сэмми инээв.

-Чи яг Гомер Симпсон шиг ярьж байх шив.

Жоржия гар бууг харангуутаа нүд нь бүлтрэх шахав. Жоржиягийн хашгирах нь Сэммигийн чихэнд хөгжим мэт эгшиглэж, шарханд нь бал мэт асгарав.

-Энэ гичийг эзэмд гэлүү Жоржия? Зүрх сэтгэлгүй жингэр чи ингэж хэллүү?

Френк сэрээд хаана юу болоод байгааг ойлгохгүй эргэн тойрноо харав. Түүний өгзөг сандалын ирмэг рүү гулссанаа Жоржияг хашгирахад давхийн цочоод шалан дээр унав. Тэр одоо бусад бүх шинэхэн цагдаа нарын нэг адил зэвсэгтэй явж байсан бөгөөд түүнийгээ шүүрэнгээ: -Сэмми буугаа тавь. Зүгээр л тавь. Бид чинь энд бүгд найз нар шүү дээ. Алив найз хэвээр үлдэцгээе гэнэ.

-Зөвхөн сөхөрч суугаад чиний найз Жижгээгийн эрхтэнийг хөхөх үед л амаа нээх ёстой гэж чи хэллүү? гээд Сэмми "спрингфилд"-ийн гохон дээр дарлаа.

Буун дуу нирхийхэд чихнийх нь хэнгэрэг золтой хагарсангүй. Сум Френкийн толгой дээгүүр сүнгэнэн гараад цонхыг хагалав. Жоржия дахиад ориллоо. Тэр дуслын хоолой ба дэлгэцийн утаснуудаас мултарч орноос сугарах гэж оролдоно. Сэмми түүнийг түлхэхэд өнөөх нь дээш харан унав.

Френки гар буугаа сугалж чадахгүй л байв. Тэр айж сандарсандаа бууны бариулаас шүүрэхийн оронд хуйнаас нь зуураад бүсээ хөдөлгөж зогсоно.

Сэмми түүн рүү хоёр алхам ойртоод телевизээр гардаг шиг бууг хоёр гараар атгаад дахин буудав. Френкийн толгойн зүүн тал нь зад үсрэв. Үстэй хуйхны тасархай хананд очиж наалдлаа. Френк гараар шархан дээр дарав. Хурууных нь завсар цус олгойдно. Дараа нь түүний хуруунууд ясны оронд бий болсон цус гоожих зунгаг бөөгнөрөлд живэн харагдахаа болив.

-Болно. Болно, дахиад хэрэггүй. Өвдөж байна гэж тэр хашгираад томорч бүлтийсэн нүднээс нь нулимс урсав. Дараа нь: -ээжээ, ээж минь гэлээ.

-Ээжийгээ дурсах хэрэггүй дээ. Тэр чамайг их муу хүмүүжүүлсэн гэж Сэмми тургиад дахин буудав.

Энэ удаад сум цээжинд зоогдов. Френкийг хана руу чулуудлаа. Гар нь толгой дахь шархнаасаа салаад шал цохив. Тэнд бий болсон цусан шалбааг тал тал тийш цацагдлаа. Сэмми өөрт нь өвдөлт авчирсан түүний тэр эрхтэн рүү гуравдахь сумаа зоов. Тэгээд ор руу эргэлээ.

Жоржия хамаг биеэ хумин атирчээ. Тэр бүх дамжуулагчийг биенээсээ салгаад хаячихсан учир дэлгэц галзуу юм шиг шажигнан дуугарна. Үс нь нүд рүүгээ унасан байв. Тэр орилсоор, орилсоор л байлаа.

-Энэ жингэрийг эзэмд гэж чи хэлсэн байхаа?

-Би халамсаж байна.

-Юу гэнэ ээ?

Жоржия дахиад хэлэх гэж оролдоно.

-Би халамсаж байна. Би халамсаж байна. Шэмми гэснээ тэр бүр тэнэг юм ярьж эхэлсэн нь: - Би бөх өгөө бушааж авлаа гэв.

-Үг гэдэг ямар шувуу биш дээ гээд Сэмми Жоржиягийн нүүр рүү, дараа нь хүзүү рүү нь буудлаа. Жоржия түрүүний Френк шиг оволзоод чимээгүй болов.

Хонгилоос хүмүүсийн хөлийн чимээ ба хашгиралдах дууг Сэмми сонсов. Айж түгшин орилох дуу тасгуудад ч хадав. Тэр хүмүүсийн амгалан байдлыг алдагдуулсандаа харамсав. Гэхдээ заримдаа өөр ямар ч гарцгүй үе байх юм. Заримдаа хийх ёстой юмаа хийхээс өөр аргагүй болдог. Харин бүх юмаа хийсэн хойно бол тайван яваад өгч болно.

Тэр гар бууг чамархайндаа наав.

-Литл Уолтер би чамд хайртай шүү. Ээж нь бяцхан хүүдээ хайртай.

Тэгээд гохыг дарав.

8

Түймрийг тойрохын тулд Расти Баруун гудамжийг ашиглав. Дараа нь Доод Төв гудамжаар орлоо. Энэ гудамж цаашаа 117 ба 119-р зам болж салдаг. "Боуигийн оршуулгын товчоо" харанхуй байх бөгөөд зөвхөн нүүрэн талын ганц нэг цонхонд жижиг цахилгаан чийдэнгүүд асна. Тэр эхнэрийн хэлсний дагуу барилгыг тойрч, машинаа жижиг зогсоолд оршуулгын урт саарал "кадиллак" машины хажууд тавив. Ойрхон, дэргэд шахуу цахилгаан үүсгүүр уухилна.

Расти хаалганы бариулаас татах гэтэл гар утас нь дуугарав. Тэр хэн залгаж байгааг ч харалгүй шууд унтраагаад толгойгоо өргөтөл машины дэргэд цагдаа зогсч байв. Гартаа буу барьжээ.

Эмэгтэй цагдаа байв. Түүнийг цонх руу тонгойход Расти задгай цайвар үсийг харсан ба арай гэж үсээр хүрээлэгдсэн энэ царайг эхнэрийнхээ хэлсэн нэртэй холбож чадлаа. Өдрийн ээлжийн жижүүр ба цагдаагийн газрын диспетчер. Бүрхүүл үүссэн өдрөөс хойш энэ эмэгтэйн үүрэг ихэд өргөжсөн болохыг Расти тааварлав. Гэхдээ энэ орой "Боуигийн оршуулгын товчоон" дахь хүүрнүүдийг хамгаалах ажлыг тэр сайн дураар авчээ.

Эмэгтэй гар буугаа далд хийв.

-Сайн уу доктор Расти? Би Стейси Моггин байна. Хоёр жилийн өмнө та намайг хорт царснаас эмчилсэн дээ. Миний энд... гэж хэлээд эмэгтэй өгзөгөө алгадав.

-Тийм ээ, санаж байна. Хатагтай Моггин таныг дахиад өмд өмссөнийг хараад баяртай байна.

Тэр инээснээ асуув.

-Би таныг айлгаагүй биз дээ?

-Бага зэрэг. Би гар утсаа унтрааж байтал та хүрээд ирсэн.

-Уучлаарай. Байшин руу ор. Линда хүлээж байгаа. Та нарт цаг бага байгаа. Би байшингийн өмнө зогсох болно. Хэрэв хэн нэгэн ирэх юм бол Линдагийн богино холбоо руу дохио өгнө. Хэрэв ах дүү Боуи ирвэл тэд оршуулгын товчооны дэргэдэх зогсоол дээр тэргээ тавьдаг болохоор бид тэдэнд харагдалгүй Дорнод гудамжаар явж чадна гээд эмэгтэй толгойгоо гэлжийлгэн инээлээ.

-Би дэндүү өөдрөг байж мэдэх ч бид танигдалгүй явж чадна гэж найдах юм. Мэдээж бидэнд аз дайрвал.

Расти цайвар үсийг нь баримжаалан түүний араас алхав.

-Стейси чи хаалгыг нь эвдсэн юм уу?

-Бурхан минь яалаа гэж дээ. Цагдаагийн газарт түлхүүр байдаг. Төв гудамжинд байрлах бараг бүх хувийн аж ахуйн нэгжүүд түлхүүрээ үлдээдэг юм.

-Та яагаад энэ хэрэгт оролцож байгаа юм бэ?

-Дэндүү их айдас хуримтлагдаж байгаа болохоор тэр. Герцог Перкинс байсан бол үүнийг аль хэдийн зогсоох байсан. Явцгаая. Ажлаа түргэн амжуулаарай.

-Би үүнийг амлаж чадахгүй. Би ер нь юу ч амлаж чадахгүй. Би чинь задлан шинжээч эмч биш шүү дээ.

-Тэгвэл аль болох хурдан.

Расти түүний араас дагана. Хормын дараа Линда түүнийг тэврэн авлаа.

9

Гарриет Бигелоу хоёр удаа муухай орилоод ухаан алдан унав. Жина айж цочирдоод нүд нь бүлтийжээ.

-Жинаг эндээс холдуул гэж Маршалл хэллээ. Тэр зогсоол дээр очсон хойноо буун дууг сонсоод энэ аймшигийг үзэхээр эргэн гүйжээ. Энэ нядалгааг.

Жинни Жинагийн мөрөөр тэврээд хонгилд гаргахад тэнд Билл ба Тенси зэрэг бусад өвчтнүүд чихэлдэж байв. Тэд айж сандарсан байдалтай нүдээ бүлтийлгэн зогсоцгооно.

-Түүнийг эндээс аваад яв. Хормойг нь буулга. Хөөрхий охин соёлтой харагдах ёстой гээд Маршалл Гарриет руу зааж Дугид хэллээ.

Дуги даалгаврыг гүйцэтгэв. Жинни тэр хоёрыг буцаад тасагт орж ирэхэд Жоржиягийн найз залуугийн оронд эргэлтээр ирээд энд оройтсоноос болж үхсэн Френкийн цогцосын дэргэд Маршалл сөхрөн суусан байв. Маршалл Жоржиягийн цогцосыг аль хэдийн дэвсгэр даавуугаар хучсан ба даавуун дээр цусан цэцэгнүүд цэцэглэжээ.

-Эмч ээ бид ямар нэг юм хийж чадах уу? гэж Жинни асуув. Тэр Маршаллыг эмч биш гэдгийг мэдэж байсан ч айж цочирдсондоо энэ үг өөрөө нисээд гарчихаж. Тэр шалан дээр тэрийсэн Френкийн цогцосыг хараад амаа дарлаа.

-Тийм ээ, цагдаагийн газар руу утасд. Энэ бол гэмт хэрэг болсон газар гэж Маршалл босонгоо хэлэхэд ясархаг өвдөг нь гар бууны дуу шиг л тачигнав.

-Үүргээ гүйцэтгэж байгаа бүх цагдаа нар хотын төвд гал унтрааж байгаа. Үлдсэн нь тийшээ явж байгаа юм уу гар утсаа унтраасан байгаа гэж Дуги хэллээ.

-Бурхан минь, тэгвэл хэн нэгэнд утасдаач. Энд ямар нэг юм хийж болох эсэхийг бид мэдэх

эстой. Энэ бүхний гэрэл зургийг авах юмуу эсвэл өөр юу ч юм? Гэхдээ энд юу болсон талаар хоёр санаа байх аргагүй. Намайг уучлаарай. Би бөөлжих нь ээ.

Жинни холдож өгөхөд Маршалл тасгийн буланд байх бяцхан усны өрөө рүү оров. Тэр хаалгаа хаасан ч шаварт суусан машины хөдөлгүүр орилох шиг л хангалттай чанга дуу тэндээс хаддаа.

Гэнэт бие нь сул оргиж өд шиг хөнгөн болоод өргөгдөж ирэхийг Жинни мэдрэв. Үүнийг давж, ухаан алдаж унахгүйг байдгаараа хичээнэ. Тэр Дуги руу эргэлээ. Өнөөх нь яг утсаа хааж таарав.

-Расти хариу өгөхгүй юм. Би дуут шууданд мэдээ үлдээсэн. Өөр хэнд хэлэх вэ? Реннид хэлэх үү?

-Үгүй. Түүнд яасан ч болохгүй гээд бүсгүй давхийв. -Миний эгчид хэлэх үү? Андреад гэж хэлэх гэсэн юм л даа. Жинни түүн рүү дуугүй ширтлээ.

Дуги энэ харцыг хэсэг тэсвэрлэсэнээ дараа нь нүд буруулав.

-Хэрэггүй юм шиг байна гэж амандаа бувгнав.

Түүний гар гарт нь хүрэхэд айж цочирдсоноос цэв хүйтэн болсон нь мэдрэгдэв. Бүсгүй, миний гар ч бас ийм байгаа гэж таамаглав.

-Хэрэв миний хэлэх нь чамайг их бага хэмжээгээр тайтгаруулна гэж бодвол Андреа түүнд наалдсан новшноос салах гэж оролдож байгаа. Тэр Раститай ирж уулзсан. Энэ шалтгаанаар гэдэгт би итгэлтэй байна.

Дуги нүүрээ илж, дуурийн уйтгар гунигийн баг шиг болов.

-Энэ чинь хар дарсан зүүд байна даа.

-Тийм ээ гээд Жинни гар утсаа гаргалаа.

-Чи хэн рүү залгах нь вэ? Хий үзэгдлийн ангуучдыг дуудах гэж үү? хэмээн Дуги гашуун инээв.

-Үгүй. Хэрэв Андреа ба Том Жим хоёр хэрэггүй юм бол хэн үлдэж байна вэ?

-Сандерс. Гэхдээ түүнээс гарах тус нь нохойн жогорхойтой адил гэдгийг чи мэднэ. Ингэхэд бид яагаад энд өөрсдөө учрыг нь олж болохгүй юм бэ? Болсон явдал нүдэнд илт гэж Маршаллын хэлсэн үнэн.

Маршалл амаа цаасаар арчсаар усны өрөөнөөс гарч ирэв.

-Яагаад гэвэл залуу минь, дүрэм журам гэж байдаг юм. Үүссэн нөхцөл байдалд бид түүнийг дагасан нь дээр. Ядахдаа дагах гэж оролдох хэрэгтэй.

Дуги толгойгоо өргөхөд ханан дээр, таазны доохон талд хатаж байгаа Сэмми Бушигийн тархийг олж харав. Энэ эмэгтэйн боддыг эрхэлж байсан эрхтэн одоо атга овъёосны каша шиг харагдана. Тэр гэнэт цурхиран уйллаа.

10

Энди Сандерс Дейл Барбарагийн өрөөнд орж, Дейл Барбарагийн орон дээр суув. "Ардчилал" сонины редакци байрлах байшин шатсанаас цонхоор улбар ягаан туяа татна. Толгой дээгүүр нь хүмүүс алхах ба ярилцах бөглүү дуу гарна. Дээвэр дээр хүмүүс гарсан байна гэж тэр таамаглав.

Энди дотуур шатаар эмийн сангаас энэ өрөө рүү орж ирсэн. Тэр гартаа хүрэн өнгийн цаасан уут барьсан ба одоо дотор нь байгаа зүйлсийг өмнөө дэлгэв. Шилэн аяга, "дасани" устай лонх, шахмал эмтэй жижиг сав. Энэ нь оксиконтин. Савны бөөрөн дээр "А.Гриннелд зориулан хадгалах" гэж бичсэн цаас наажээ. 20 мг-ийн ягаан эмнүүд. Тэр хэдийг сэгсэрч гарган тоолсноо дахиад сэгсрэв. Хорь. Дөрвөн зуун миллиграммаар. Аль хэдийн дасал болсон Андреаг бол ийм эм алж хүчрэхгүй. Харин Эндиг бол ийм тун гарцаагүй дуусгана гэдэгт тэр эргэлзсэнгүй.

Хана нэвт халуу дүүгнэ. Сандерс хөлөрч эхэллээ. Өрөөний доторхи дулаан тавин хэмээс дээш болжээ. Энди орны бүтээлгээр нүүрээ арчлаа.

Энэ халууныг тэвчих цаг бага үлдсэн. Тэнгэрт хүйтэн салхи үлээдэг. Бид бүгдээрээ Есүсийн ширээнд хамт хооллохоор суух болно.

Мансуурах бодис түргэн үйлчлэх үүднээс тэр эмнүүдийг шилэн аяганы ёроолоор дарж нунтаглаж эхлэв. Яг бухны дух руу лантуу буулгадаг шиг. Зүгээр л оронд хэвтээд нүдээ анина. Дараа нь хонгорхон эмийн санч минь, чамд сайхан нойрсохыг ерөөе. Сахиусан тэнгэрүүдийн дуун дор мөнх амгалан байгаарай.

Би... Бас Клоди... Бас Доди. Үргэлж хамт.

Дүү минь битгий ингэж бод. Лестер ламын дуу дээд зэргийн хагуу чанга бөгөөд сүрлэг байв. Энди эм нухахаа болилоо. "Найз минь амиа хорлогсод ойр дотны хүмүүстэйгээ хамт хооллодоггүй юм. Тэд тамд оддог. Түүнийг улайссан нүүрсээр хооллох бөгөөд дотроос нь зуу зуун жил түлж байдаг. Үүнийг баталж надад аллилуйя гэж хэлэх үү? Аминь гэж хэлж чадах уу?"

-Донгос гэж Энди шивнээд орхисон ажилдаа орлоо. -Чиний чандарлуулах хоншоор бидэнтэй яг адил. Би яагаад чамд итгэх ёстой юм бэ?

"Яагаад гэвэл би үнэнийг ярьж байна. Танай эхнэр хүүхэд хоёр чамайг бүү ингээсэй гэж залбиран дээрээс харж байгаа. Эсвэл чи тэднийг сонсохгүй байгаа юм уу?"

-Үгүй ээ, энэ ч бас чи биш. Энэ бол миний оюун ухааны хулчгар хэсгээс цаашгүй. Тэр бүх насаар минь намайг удирдсан. Түүнээс болоод л Том Жим намайг гартаа эргэлдүүлсэн.

Түүнээс болоод би меттэй холбоотой энэ түүхтэй орооцолдсон. Би мөнгөөр дугааж байгаагүй. Би энэ их мөнгийг ойлгодог ч үгүй. Би зүгээр л "үгүй" гэж хэлэхийг мэддэггүй юм. Үгүй дээ ноёнтон. Одоо надад амьдрах хэрэг байхгүй. Би явлаа. Эсэргүүцэх юм байна уу?

Хараад байхад Лестер лам эсэргүүцэж чадсангүй. Энди эмээ нухаж дуусаад шилэн аягыг усаар дүүргэв. Ягаан нунтагыг алгаараа түрж шилэн аяга руу хийгээд хуруугаараа хутгалаа. Гаднаас гудамж болоод дээвэр дээр галтай тэмцэж байгаа хүмүүсийн хашгиралдах бөглүү дуутай хамт гал тачигнах дуу сонсдох ба бас толгой дээгүүр нь холхих дуу гарна.

-Дуустал нь гэж өөртөө хэллээ... Гэвч уусангүй. Гар нь шилэн аягаа атгасан хэвээр. Гэвч түүний оюун ухааны хулчгар хэсэг, хэдийгээр амьдрал утга учраа алдсан ч үхэхийг хүсэхгүй байгаа тэр хэсэг нь аягыг ам руу аваачихыг зөвшөөрсөнгүй. -Үгүй шүү. Энэ удаад чи намайг ялахгүй. -Гэвч тэр шилэн аягаа дахиад л буулгав. Нүүрээр нь урсах хөлсийг бүтээлгээр арчлаа.

-Хэзээ ч үгүй. Энэ удаад ч үгүй.

Тэр шилэн аягыг дахиад л амандаа аваачлаа. Дотор нь ягаан өнгийн төгсгөл цалгилна. Аягаа дахиад л ширээн дээр тавив.

Хулчгар хэсэг урьдын адил түүнийг жолоодно. Энэ хулчгар хэсгийг бурхан авч одоосой.

-Бурхан минь надад тэмдэг хайрла. Энэ аягатайг уух нь зөв гэсэн тэмдэг хайрла. Хэрэв өөр шалтгаанаар биш бол, би энэ хотыг зөвхөн ингэж л орхиж чадах учраас.

Яг дэргэд нь "Ардчилал" сонины редакцийн байшингийн дээвэр нурлаа. Толгой дээр нь Берпи бололтой хэн нэгэн хашгирав.

-Залуус аа бэлдээрэй. Одоо бэлэн байгаарай.

Бэлэн байгаарай. Мэдээж энэ бол тэмдэг. Сандерс үхлийн аягаа өргөлөө. Энэ удаад хулчгар хэсэг ч түүний гарыг хориглосонгүй. Хулчгар хэсэг бууж өгсөн бололтой.

Түүний хармаанд гар утас дуугарч Клодид ихэд таалагддаг байсан утга уянгын "Чи үнэхээр хөөрхөн" дууны ая дуурсав. Тэр аягатайгаа тэртэй тэргүй уухаар шийдлээ. Гэтэл энэ үед хэн нэгний дуу, энэ арай тэмдэг биш юм биз гэж шивнэв. Хэний дуу болохыг тэр хэлж мэдэхгүй. Хулчгар хэсэг, эсвэл Лестер лам юмуу өөрийнх нь сэтгэл зүрх. Нэгэнт хэлж чадахгүй болохоор утсаа авлаа.

-Ноён Сандерс уу? гэх эмэгтэй хүний айж түгшсэн аз жаргалгүй, ядарсан дуу гарав. Түүнтэй адил шаналсан сэтгэл болохыг Энди мэдэрлээ. -Би эмнэлгээс ярьж байна. Виржиния Томлинсон байна.

-Жинни юу? Мэдээж чи пгүү дээ. Хачин юм даа. Түүний хоолой урьдын адил хөгжилтэй байна.

-Манай энд их хэцүү нөхцөл байдал үүсчихлээ. Та хүрч ирж чадах уу?

Эндигийн доторхи харанхуйг гэрлийн туяа зүсэв. Зүрх нь гайхал бахдал ба талархлаар дүүрлээ. Түүнд "Та хүрч ирж чадах уу?" гэж хэллээ. Эдгээр үгс ямар дулаан мэдрэмж дагуулдагийг тэр мартсан гэж үү? Хэдийгээр яг ийм үгсийн төлөө тэр хотын захиргааны нэгдүгээр гишүүний албан тушаалд өрсөлдсөн ч мартсан бололтой. Тэр эрх мэдэл авах гэж зүтгээгүй. Том Жим л түүнийг сонирхдог. Тэр зөвхөн тусламжийн гар л сунгахыг хүссэн. Үүнээр бүхнийг эхэлсэн болохоор үүгээр дуусгаж болох юм.

-Ноён Сандерс та намайг сонсож байна уу?

-Тийм ээ, Жинни чи итгэлтэй байж болно. Би одоохон очлоо гэж хэлээд тэр дуугаа хураав. Энди минь ямар ч ноён Сандерс хэрэггүй. Бид бүгдээрээ нэг завинд хөвж яваа гэдгээ ойлгож байна уу?

Тэр утсаа салгаж шилэн аягаа барин усны өрөө рүү ороод доторхийг нь жорлон руу асгав. Баяр хөөрийн мэдрэмж, сэтгэл хөнгөрөл ба бахдалын мэдрэмж жорлонгийн ус татах хүртэл түүнд оргилов. Дараа нь сэтгэл гутрал яг л хуучин өмхий хувцас шиг дараад авлаа. Тэр хэн нэгэнд хэрэгтэй гэж үү? Инээд хүрэхээс өөр юм алга. Тэр бол Том Жимийн өвөр дээр суусан салбадай, хөгшин тэнэг Энди Сандерс шүү дээ. Түүний цагаан хоолой. Том Жимийн санаа бодлыг өөрийнхөө юм шиг дуу оруулагч хүн. Хоёр жил тутамд нэг удаа сонгогчдын хайрыг татах цаг ирэхэд тун хэрэгтэй болдог хүн. Том Жим өөрөө үүнийг хийж чадахгүй юмуу эсвэл хийхийг хүсдэггүй.

Саванд дахиад эм үлдсэн. Доор хөргөгчинд ус байгаа. Гэвч Энди энэ талаар нухацтай бодсонгүй. Тэр Жиннид очно гэж амалсан. Тэр хэлсэн үгэндээ хүрдэг хүн. Амиа хорлох санааг тэр үгүйсгээгүй бөгөөд зөвхөн хойшлуулав. Жижиг хотын улс төрчдийн цуглаан дээр ярьдаг шиг даавуун доогуур шургуулсан. Түүний хувьд үхлийн өрөө болох шахсан энэ унтлагын өрөөнөөс гарах ямар сайхан юм бэ?

Тэгээд ч өрөө утаагаар дүүрчээ.

"Боуигийн оршуулгын товчоо"-ны ажлын танхим хонгилд байх ажээ. Тиймээс Линда гэрэл асааж болно гэж үзэв. Гэрэлгүй бол Расти яаж хүүрэнд үзлэг хийх вэ?

-Чи энэ эмх замбараагүй байддыг хараач дээ гээд Расти гутлын мөр дүүрсэн дөрвөлжин хулдаастай бохир шал руу, бас хажуугийн ширээнд хөглөрөх шар айраг ба хийжүүлсэн усны лааз, мөн буланд байх онгорхой хогийн сав болоод дээр нь багшрах ялааг заав. -Хэрэв муж улсын Оршуулгын зөвлөл үүнийг үзвэл... Эсвэл эрүүл мэндийн яам... Энэ товчоог нүд ирмэх зуур хаах байсан.

-Хаана байгаагаа бүү мартаарай гэж Линда түүнд санууллаа. Тэр өрөөний голыг эзэлсэн үл зэврэх ган ширээг харна. Гадаргуу дээр байх олон арван толбо ямар шингэнээс үүдэлтэйг хэлээд дэмий дээ. Шингэн урсахад зориулсан хажуугийн сувагт "сникерс"-ийн үрчийсэн боолт цаас хэвтэнэ. -Бид тэр бүү хэл Мэнд ч байгаа биш шүү. Эрик минь яарч үз. Энд өмхий үнэртээд байна.

-Өмхийгээр барах уу гээд Расти энэ бохир заваан замбараагүй байдалд ихэд уур хүрэв. Хэрэв түүний хүслээр болдог бол үхэгсэдийн цусыг юүлдэг ширээн дээр үлдээсэн чихрийн цаасных нь төлөө Стюартын хоншоор дундуур татах байсан.

Танхимын цаад төгсгөлд цогцос хадгалахад зориулсан 6 ширхэг ган хайрцаг харагдана. Тэндээс хөргөх төхөөрөмжийн дуу дүнгэнэх нь сонсогдоно.

-Энд хийний тал дээр асуудал алга. Ах дүү Боуи ч далайцтай хөдөлж байна даа гэж Расти бувгнав.

Хайрцагнуудын бариулд нэр бүхий хүснэгт үтүй нь ажилдаа хайнга ханддагийн бас нэг баталгаа. Тиймээс Расти зургаан шургуулгыг бүтдийг нь татахад хүрэв. Эхний хоёр нь хоосон байсанд тэр гайхсангүй. Бүрхүүл дор үхсэн бүх хүмүүсийг түүний дотор Хаскел ба Эвансыг ч маш хурдан оршуулсан. Ойр дотны хүнгүй Жимми Сируагийн цогцос эмнэлгийн бяцхан моорогт байгаа.

Дараагийн дөрвөн шургуулганд түүний ийшээ ирэх зорилго болсон цогцоснууд хэвтэнэ. Шургуулгыг дөнгөж татахад ялзарсан үнэр хамар цоргив. Энэ үнэр тааламжтай биш боловч арай түүн шиг тийм муухай биш зандалшуулах түрхлэг ба нөөшлөгчийн үнэрийг дарж байлаа. Линда амаа дараад ухрав.

-Линда бөөлжиж болохгүй шүү гээд Расти хананы дэргэд байх шүүгээнүүдийг чиглэв. Эхний шургуулгыг татахад "Филд-энд-Стрим" сэтгүүл гарч ирэхэд тэр харааж зүхлээ. Доод талын шургуулгаас хайсан зүйлээ олов. Боодолтой хос ногоон амны хаалт гаргаж ирээд нэгийг нь Линдад өгч, нөгөөг нь өөрөө зүүв. Дараагийн шургуулгыг татаж хос хаймар бээлий гаргалаа. Чөтгөр авмар, хөгжилтэй, хурц шар өнгөтэй ажээ. -Хэрэв чи хаалт зүүсэн ч бөөлжих гээд байвал дээшээ Линда дээр оч.

-Бүх юм сайн болно. Би гэрчээр үлдье.

-Чиний мэдүүлгийг хэн нэгэн тооцно гэж бодохгүй байна. Чи чинь миний эхнэр шүү дээ.

-Би гэрчээр үлдэнэ. Хурдан хийж үз.

Цогцос хадгалах хайрцагт ч бохир заваан хангалттай. Энд харсан бүхний дараа энэ нь Растигийн гайхлыг төрүүлээгүй ч урьдын адил дургүйцсээр байв. Линда гараашнаас олсон хуучны хуурцагтай дуу хураагчийг түүнд өглөө. Расти "бичлэг" гэсэн товчийг дарж үр дүнг нь шалгаж үзээд тун муугүй болсонд гайхав. Тэгээд хуучин "Панасоник" дуу хураагчийг хоосон хайрцаг дээр тавьлаа. Бээлийгээ өмсөв. Түүний бодсоноос илүү цаг өнгөрчээ. Гар нь хөлөрнө. Хаа нэгтээ "Жонсонс беби"-гийн нунтаг түрхлэг байгаа л байх. Гэвч тэр дахиад ямар нэг юм хайж цаг алдахийг хүссэнгүй. Тэгээд ч өөрийгөө эвдэн хулгайлагчаар мэдэрч эхэлжээ. Чөтгөр гэж, нээрээ эвдэн хулгайлагч юм чинь.

-За яахав. Бид эхлэе. 10 дугаар сарын 24-ний 22 цаг 45 минут. Үзлэгийг талийгаачдыг сүүлчийн замд нь үдэхэд бэлтгэдэг "Буоигийн оршуулгын товчоо"-ны танхимд явуулж байна. Энд их бохир заваан байна. Хэлэх үггүй. Би дөрвөн цогцос харж байна. Гурав нь эмэгтэй, нэг

нь эрэгтэй хүнийх. Хоёр эмэгтэй нь залуухан. Хорь гаруй насных. Энэ бол Анжела Маккейн ба Доди Сандерс нар.

-Дороти гэж Линда ширээний цаад талаас түүнийг засч хэлэв. -Түүний нэр нь... үгүй ээ байсан юм... Дороти.

-Засвар оруулья. Дороти Сандерс. Гурав дахь эмэгтэй нь ахимаг насны эмэгтэй. Энэ бол Бренда Перкинс. Эрэгтэй хүний хувьд 40 орчим настай. Энэ бол гэгээн лам Лестер Коггинс. Би энэ бүх хүмүүсийг таньж мэднэ гэдгээ гэрчилж байна.

Тэр эхнэрээ дуудаад цогцос руу заав. Линда ирж харах үед нүдэнд нь нулимс цийлэгнэж үг хэлэхийн тулд амны хаалтаа сөхлөө.

-Би Линда Эверетт байна. Би Честерс-Милл хотын цагдаагийн газарт алба хаадаг. Цагдаагийн хувийн тэмдгийн бүртгэлийн дугаар 7-7-5. Би дөрвөн цогцосыг таньж мэдэж байгаагаа гэрчилж байна.

Тэр амны хаалтаа буцааж зүүлээ. Хаалтан дээгүүр эхнэрийнх нь гуйсан харц Расти руу ширтэнэ.

Тэр гараар даллан эхнэрээ байсан газар руу нь буцаав. Энэ ч яахав жүжиг юм чинь. Тэр үүнийг ойлгож байв. Линда ч мэдээж ойлгож байгаа. Гэвч Расти ямар нэг сэтгэл гутралыг огт мэдэрсэнгүй. Тэр бага байхаасаа анагаахын салбарт очихыг хүсдэг байсан. Эцэг эхээ асрахын тулд сургуулиа хаяагүй бол эмч болох л байсан. Одоо тэр ахлах сургуульд биологийн хичээл дээр мэлхий задлахад татагддаг байсан шигээ цэвэр сониуч занд хөтлөгдөв. Мэдэх тэмүүлэл. Тэр бүгдийг нь биш юмаа гэхэд ямар нэг юм мэдэж авах зорилготой байлаа.

Энд үхэгсэд үлдэгсэдэд тусалдаг. Линда ингэж хэлсэн бил

үү?

Ямар байлаа ч гэсэн тэд чадах бүхнээрээ туслана.

-Миний харж байгаагаар гоо сайхны засал хийгээгүй байгаа ч дөрвөн цогцост бүгдэд нь бальзам түрхжээ. Энэ ажиллагаа дууссан эсэхийг мэдэхгүй байна. Гэхдээ үгүй гэж бодож байна. Яагаад гэвэл гуяны бүдүүн судсанд шингэн зайлуулах хоолойнууд залгаастай байна. Анжела ба Доди нар... Уучлаарай Дороти нарыг маш их зодсон байна. Ялзрах үйл явц гүнзгийрчээ. Миний харж байгаагаар Лестер ламыг араатан шиг зодсон байна. Ялзрах үйл явц эхэлсэн ч эхний шатандаа байна. Нүүр ба гарын булчин унжиж эхэлжээ.

Бренда... Би Бренда Перкинс гэх гэсэн юм гээд тэр... дуугаа хурааж тонгойв.

-Расти хонгор минь гэж Линда цухалдан дуу алдлаа.

Тэр бээлийтэй гараа хүүр рүү сунгаснаа бодлоо өөрчилж бээлийгээ тайлаад хүзүүг нь хуруугаар тэмтрэв. Дараа нь Брендагийн толгойг өргөж дагзан доор нь үүссэн том зангилаасыг тэмтэрлээ. Толгойг тавиад нуруу ба өгзөгийг үзэхийн тулд цогцосыг хажуу тийш

нь харуулав.

-Бурхан минь гэж тэр өөрийн эрхгүй дуу алдав.

-Расти яасан бэ?

Нэгдүгээрт энэ эмэгтэйн баасыг цэвэрлээгүй байна гэж тэр дотроо бодсон ч чанга хэлэхгүй нь ойлгомжтой. Тэр бүү хэл Рэндолф Ренни нар энэ хальсны эхний 60 секундыг сонсоод дэвсэлж хаян шатаах байсан ч тэр үүнийг хэлэхгүй. Брендагийн цогцосыг үзэх үедээ харсан энэ зүйлийн талаар дуугүй өнгөрөх нь дээр гэж тооцов.

Гэхдээ хэзээ ч мартажгүй гэдгээ мэдэж байлаа.

-Яасан бэ? гэж Линда дахин шамдуулав.

Расти уруулаа хэлээр норгов.

-Брендагийн цогцосны гуя ба өгзөг хөшиж эхэлсэн нь үхсэнээс хойш 12-14 цаг өнгөрсөнийг зааж байна. Хоёр хацар дээр нь хөхрөлт үүсчээ. Гарын алганы хэлбэртэй. Энэ тал дээр надад эргэлзэх зүйл алга. Хэн нэгэн түүний нүүрнээс бариад толгойг зүүн тийш огцом эргүүлсэн байна. Хүзүүний нэгдүгээр болоод сээрний тэнхлэгийг хугалжээ. ШЦ ба Ц2 сээрийг нь хугалсан байж ч мэднэ.

-Расти минь гэж Линда гаслав.

Тэр эрхий хуруугаар Брендагийн хоёр аньсагыг ээлжлэн сөхөөд айж байсан зүйлээ олж харлаа.

-Хацар дээр үүссэн хөхрөлт ба нүдний цагаанд үүссэн цусан толбо буюу цус хуралт нь үхэл хоромхон зуурынх биш байсныг илтгэнэ. Эмэгтэй амьсгалж чадахгүйн улмаас бүтэж үхсэн байна. Тэр үхэх хүртлээ ухаантай байсан байж мэднэ. Гэвч үгүй гэж найдъя. Харамсалтай нь энэ нь миний хэлэх бүх зүйл. Анжела ба Дороти нар хамгийн түрүүнд үхжээ. Ялзарсан цогцосын байдал нь дулаан газар хадгалагдаж байсныг илтгэнэ гээд тэр дуу хураагуураа унтраав. -Өөрөөр хэлбэл би Барбараг цагаатгах юу ч олж харсангүй. Бас бидний мэдэхгүй ямар нэг зүйлийг үзсэнгүй.

-Хэрэв түүний гар Брендагийн нүүрэн дээрх хөхрөлттэй таарахгүй бол яах вэ?

-Хөхрөлтийн хэлбэр дэндүү тархсан учраас ямар нэг юм батлах аргагүй. Линда минь би өөрийгөө энэ дэлхийн хамгийн агуу тэнэг гэж мэдрээд байна гээд одоо Обурн хотын худалдааны төвөөр тэнэж, ээмэг шинжиж, хувцас худалдан авч, найз залуусынхаа тухай ярилцаж байх ёстой тэдгээр бүсгүйчүүдийг байсан газарт нь буцааж, цогцос хадгалах шургуулгыг харанхуй руу түлхлээ. Дараа нь Бренда дээр эргэж очив.

-Алив надад даавуу өг. Угаалтуурын хажууд хэдэн ширхэг байхыг би харсан. Тэр бүү хэл цэвэр харагдсан нь энэ гахайн хороонд бол гайхалтай явдал.

-Чи юу...

-Зүгээр л надад алчуур өгөөд аль. Бүр хоёрыг өг. Норгоод

өг.

-Бидэнд цаг алга...

-Гаргах л хэрэгтэй болж дээ.

Нөхөр нь Брендагийн өгзөг ба гуяыг хэрхэн сайтар арчихыг Линда дуугүй харж зогсоно. Үүнийг хийж дуусаад тэр бохир алчуурыг булан руу чулуудахдаа нэгийг нь Старт, нөгөөг нь Ферний ам руу дуртайяа чихэх байсан гэж бодов.

Тэр Брендагийн хүйтэн духан дээр үнсээд цогцостой хайрцагийг хөргөөх нүх рүү нь түлхэв. Лестер ламын хайрцагийг ч түлхэх санаатай очсоноо зогтуслаа. Ламын нүүрийг зохих ёсоор угааж цэвэрлээгүй байв. Чих ба хамрын нүхэнд хатсан цус байх бөгөөд духан дээр нь ч бурзайжээ.

-Линда надад дахиад нэг алчуур норгоод өг.

-Хонгор минь бид энд 10 минут болчихлоо. Үхэгсдэд хүндэтгэл үзүүлж байгаагийн чинь төлөө би чамайг хайрлаж байна. Гэхдээ үлдэгсэд бас бий...

-Энд харин ямар нэг юм байх шиг байна. Ламыг өөрөөр зоджээ. Би үүнийг харж байна... Алив алчуур норгоод аль.

Линда маргахаа болиод алчуур норгож мушгиад нөхөртөө сунгав. Расти Брендаг арчих үедээ гаргасан шиг энхрийлэл үл үзүүлэх боловч зөөлөн хөдөлгөөнөөр талийгаачийн нүүрний цусыг арчихыг харав.

Линда Лестер ламд дургүй байсан. (Тэр нэг удаа Америкийн жүжигчин ба поп дуучин Майли Сайрусын уулзалтанд очсон хүүхэд бүр тамд очно гэж 7 хоног бүрийн радио нэвтрүүлгээрээ зарлаж байсан юм.) Гэсэн хэдий ч Растигийн зүтгэлээр түүний нүдний өмнө гарч ирсэн дүр төрх зүрх шимшрүүлэв.

-Бурхан минь жаалууд мануухайг байны оронд ашиглан чулуу нүүлгэсний дараа ийм болсон байдаг.

-Би түүнийг чинь хэлээд байна. Ламыг өөрөөр зоджээ. Нударга юмуу хөлөөр биш.

-Тэр чамархайн дээр нь юу байна вэ? гээд Линда заав.

Расти хариу хэлсэнгүй. Зөвхөн амны хаалт дээгүүр гялалзах нүдэнд нь гайхшрал тодров. Бас өөр юмс. Тэр юу ямар учиртай болохыг ойлгож эхэллээ.

-Эрик энэ юу вэ? Харагдах нь... Ёстой мэдэхгүй... Хавж ширчихсэн юм шиг.

-Бүгдийг ойлголоо гэх үед Растигийн амны хаалт хөдөлсөн нь цаана нь байгаа ам инээмсэглэснийг илтгэнэ. Гэхдээ баярын инээд биш харин сэтгэл ханамжийн инээд юм. Баргар инээд. -Духан дээр нь бас байна. Харж байна. Эрүүн дээр нь ч байна. Энэ цохилт эрүүг нь хугалжээ.

-Тэгээд ямар зэвсэг ийм мөр үлдээдэг юм бэ?

-Бейсболын бөмбөг гээд Расти хайрцгийг түлхэв. -Гэхдээ ердийн биш, алтадсан бөмбөг. Тийм ээ, хэрэв алтадсан бөмбөгөөр далайж байгаад цохих юм бол ийм ул мөр үлдээх болно гэж бодож байна. Тэгээд ч үлдээсэн байна гээд Расти эхнэр рүүгээ тонгойв. Тэдний амны хаалт шүргэлцлээ. Расти эхнэрийнхээ нүд рүү харж байгаад:

-Жим Реннид тийм бөмбөг бий. Би алдагдсан хийн тухай ярихаар тэднийд орох үед ажлын өрөөний ширээн дээр нь тэр бөмбөгийг харсан. Бусдынх нь талаар би юу ч хэлж чадахгүй. Харин Лестер Коггинс хаана үхсэнийг бид мэдэж авлаа. Бас хэн алсаныг.

12

Дээвэр нурж унаснаас хойш Жулия түймрийг дахин хараад зогсож чадсангүй.

-Манайд очъё. Зочдын өрөө чиний бүрэн мэдэлд. Ямар ч хугацаагаар байж болно гэж Роуз санал тавив.

-Баярлалаа. Гэвч үгүй. Роуз, би одоо ганцаараа баймаар байна. Чи ойлгож байгаа шүү дээ. Горастай. Би бодох хэрэгтэй.

-Чи хаана очих юм бэ? Чамтай ямар нэг юм болохгүй биз дээ?

-Зүгээр ээ гэхдээ Жулия тийм байх эсэхийг мэдэхгүй байв. Түүний толгой ажилласаар байлаа. Сэтгэх үйл явцад өөрчлөлт гарсангүй. Харин сэтгэл хөдлөл рүү хэн нэгэн нойрсуулах тун шахсан бололтой. -Би оройхон очиж мэднэ.

Роузыг явсны дараа Жулия приус машиндаа буцаж ирээд Горасыг урд суудалд суулгаж, өөрөө жолооны ард суув. (Роуз гудамжны нөгөө талаар явж одсон ба гараа даллахаар нэг эргэж харав). Жулия Пит ба Тони нарыг харцаараа хайсан ч хэнийг ч харсангүй. Магадгүй Тони Питийг эмнэлэгт хүргэж түлэгдэлт дээр нь ямар нэг түрхлэг тавиулж байгаа байх. Тэдний хэн нь ч ноцтой хохирол амсаагүй нь гайхамшиг гэлтэй. Хэрэв тэр Горасыг Кокстой уулзах үедээ авч яваагүй бол нохой өдийд шатсан байж мэднэ.

Энэ санаа төрөх үед Жулия сэтгэл хөддөл нь мэдээ алдсан биш бөгөөд зүгээр л нуугдсан болохыг ойлгов. Улихтай төстэй ямар нэг дуу түүний цээжнээс хадав. Горас том чихээ хурцлаад эзэн рүүгээ санаа зовох мэт харлаа. Жулия биеэ барих гэж оролдсон ч чадсангүй.

Түүний эцгийн сонин.

Түүний өвөөгийн сонин.

Түүний өвөг эцгийн сонин.

Үнс нурам.

Жулия Баруун гудамжаар явж "Глобус" кино театрын цаана орхигдсон авто зогсоол руу очлоо. Хөдөлгүүрийг унтрааж Горасыг өөр рүүгээ татаад түүний үстэй булчинлаг мөрөнд наалдан 5 минут хэртэй уйлав. Горас үүнийг тэвчээртэй даван гарлаа.

Уйлсны дараа Жулия дээрдээд ирэв. Тайвширчээ. Магадгүй энэ тайтгарал айж цочирдсоноос үүдэлтэй ч ямартаа ч тэр одоо бодож чадахтайгаа болов. Машины багажанд ганц боодол сонин байгааг Жулия саналаа. Горасын дээгүүр тонгойж сунах үед тэр хүзүүг нь нөхөрсөгөөр долоох бөгөөд Жулия элдэв новш агуулсан урд хайрцгийг нээв. Жулия бодохдоо тэнд... Магадгүй...

Гэтэл бурхны бэлэг гэлтэй эрсэн зүйлээ олов. Хавчаар, зургийн хадаас, эмийн сангийн резин ба бичиг хэргийн хадааснуудтай хуванцар хайрцгийг оллоо. Резин ба хавчаар түүнд хэрэггүй. Харин бичиг хэргийн хадаас ба дардаг хадааснууд түүнд тун хэрэгтэй.

-Горас, чи надтай зугаалмаар байна уу?

Тэр тун их хүсч байгаагаа илэрхийлэн хуцав.

-Сайн байна. Яагаад гэвэл би ч бас зугаалмаар байна.

Тэр багаажнаас сониноо гаргаж Төв гудамжинд буцаж ирлээ. "Ардчилал" сонины барилга аль хэдийн улалзах овоолгоостой самбар ба моднууд болж хувирсан байх бөгөөд цагдаа нар ус цацна. (Гэнэт гарын дор орж ирсэн, гэхдээ бүр дүүрэн устай бөгөөд хэрэглэхэд эвтэй насосоор). Мэдээж энэ түүдгийг харах үед зөвхөн шимширсэн ч тийм хүчтэй биш. Яагаад гэвэл тэр хийх ажлаа олжээ.

Жулия гудмаар алхана. (Горас дэргэд нь явна) Тэгээд утасны шон болгонд "Ардчилал"-ын сүүлийн дугаараас нэг хувийг тогтоож гарлаа. "Хямрал гүнзгийрэхийн хэрээр үймээн самуун ба аллага" гэсэн гарчиг түймрийн гэрэлд нүдэнд шууд тусна. Гэвч Жулия "Болгоомжлогтун" гэсэн ганц үтээр хязгаарлагдаагүйдээ харамсав.

Тэр үлдсэн бүх сониноо дуустал нь шонгийн модонд хадлаа.

Түймэр гарсан гудамжны эсрэг талд зогсох Рэндолфын богино холбоо гурван удаа тачигнав. Яаралтай. Юу сонсох бол гэхээс айнгаа тэр хүлээн авах товчийг дарлаа.

-Рэндолф дарга сонсож байна.

Шөнийн ээлжийн ахлагчийн хувьд үнэн хэрэгтээ цагдаагийн даргын орлогч болсон Фредди Дентон байв.

-Дөнгөж сая эмнэлгээс утасдлаа. Тэнд давхар аллага болжээ.

-Юу? гэж Рэндолф чарлав. Шинэ цагдаа нарын нэг болох Микки тойргийн яармагт анх удаа ирсэн тэнэг шиг түүн рүү нүдээ бүлтийлгэн харна.

Дентон цааш ярьлаа. Түүний дуунд биеэ тоосон байдал юмуу эсвэл тайвширал мэдрэгдэнэ. Хэрэв тэр биеэ тоож байгаа бол Рэндолф түүнд сануулаад өгнө.

-Бас амиа хорлосон. Өнөөх манай залуусыг хүчиндсэн хэмээн буруутгаад байсан тэр бүсгүй бууджээ. Хохирогчид нь бас манайхан. Ру ба Френки.

-Чи миний тархийг эргүүлээд байна.

-Би Руп ба Мел нарыг тийш нь илгээсэн. Сайн тал нь юу гэвэл бүх юм дууссан тул тэр эмэгтэйг бид Тахианы саравчинд Барбаратай суулгах хэрэггүй болсон.

-Чи өөрөө явах ёстой байсан юм. Чи чинь ээлжийн ахлагч биз дээ?

-Тэгвэл цагдаагийн газарт хэн үлдэх юм бэ?

Рэндолфод хариулт олдсонгүй. Ямар ч хариулт хэт ухаалаг юмуу эсвэл дэндүү тэнэг болохоор байв. Тэгээд "Кэтрин Рассел" эмнэлэг рүү өөрөө явах ёстойгоо ойлголоо.

Би энэ ажлыг хиймээргүй байна. Үгүй огт хүсэхгүй байна.

Гэвч дарга одоо татгалзаж чадахгүй болжээ. Том Жимийн тусламжтай үүнийг давна гэж найдах л үлдлээ. Том Жим түүнийг чиглүүлж, бас дэмжих болно.

Марти Арсено түүний мөрөн дээр алгадав. Рэндолф огцом эргээд дэлсэх шахлаа. Гэвч Арсено үүнийг анзаарсангүй. Жулия нохойн хамт салхилж яваа гудамжны нөгөө тал руу харна. Салхилахын зэрэгцээ... Юу хийгээд байна вэ?

Хараач, сонин өлгөж байна. Чөтгөр авсан утасны шонгуудад хадаж байна.

-Энэ жингэр яагаад ч номхрохгүй юм байна гэж Рэндолф санаа алдав.

-Би очоод номхруулаад өгөх үү? гэж Арсено асуулаа.

Марти энэ даалгаврыг биелүүлэхийг тун их хүсэв. Цагдаагийн дарга ч бас ийм тушаал бараг өгөх шахлаа. Гэвч хамгийн сүүлчийн мөчид толгой сэгсрэв.

-Тэр чөтгөр авсан иргэний эрхийнхээ талаар орилоон дэгдээх болно. Ялаа бүрийг заан болгон томруулах нь хотын ашиг сонирхолд нийцэхгүй гэдгийг огт ойлгохгүй мэт гэж хэлээд дарга толгой сэгсэрсэнээ: -Тэр ер нь ойлгож байгаа байх. Тэр санаанд багтамгүй... Жулия Шамуэйг бүрэн тодорхойлох үг байсан л юм даа. Нэг тийм франц үг. Ахлах ангид байхдаа цээжилсэн. Рэндолф энэ үгийг санана гэж огт бодоогүй. Гэвч шууд санав. -Тэр санаанд багтамгүй гэнэн.

-Дарга аа би түүнийг зогсооё. Асуудал байхгүй. Тэр яах юм бэ? Өмгөөлөгч рүүгээ утасдах уу?

-Дуртай юмаа хийж л байг. Гол нь тэр бидэнд саад бүү болог. Би эмнэлэг рүү явлаа. Өнөөх Буши Френк ба Жоржия нарыг алсан гэж Дентон хэлсэн. Дараа нь өөрийгөө буудчихжээ.

-Бурхан минь гэж Марти шивнээд хувхай цайв.

-Энэ бүхэн Барбарагийн явуулга гэж бодож байна уу?

Рэндолф үгүй гэж бараг хэлэх шахсанаа бодлоо өөрчиллөө. Буши түүний залуусыг хүчингийн хэрэгт буруутгасан. Амиа хорлосон нь энэ буруутгал үндэсгүй биш болохыг харуулж байна. Гэтэл Миллийн цагдаа нар ийм юм хийж чадах тухай цуу дэгдвэл түүний дааж хариуцаж байгаа албаны нэрийг харлуулах бөгөөд энэ нь хотын ашиг тусад огтхон ч нийцэхгүй. Тэр үүнийг Том Жимгүйгээр ойлгож байв.

-Мэдэхгүй. Гэхдээ бүх юм боломжтой гэж Рэндолф хэлээд мөрөө хавчлаа.

Мартигийн нүдэнд уй гашууны ч юмуу эсвэл утааны улмаас нулимас цийлэлзэв. Магадгүй хоёр шалтгаан давхацсан байх.

-Дарга аа, энэ тухай Том Жимд мэдэгдэх хэрэгтэй.

-Би мэдэгдэнэ. Харин одоохондоо... Рэндолф Жулиягийн тийш толгой сэжээд -Түүний араас харж байгаарай. Ядраад яваад өгөхөөр нь энэ бүх баасыг хуу татаж байх ёстой газар руу нь хая гээд тэр урьд нь сонины редакци байсан ба одоо дүрзэлзэх түүдэг болсон тэр зүтт заав.

-Хотыг хогноос салга.

Марти ход ход инээлээ.

-Босс оо, гүйцэтгэе.

Цагдаа Арсено яг ингэж хийжээ. Гэвч тэр хооронд хотын зарим иргэд хэд хэдэн сониныг гэрэлтэй газар уншихаар авсны дараа. Магадгүй арваадыг авсан байх. Дараагийн хоёр гурван өдөр хотынхон тэднийг гараас гарт дамжуулан навсайж урагдах хүртэл нь уншсан юм.

Энди эмнэлэг дээр ирээд Пайпер ламыг олж харав. Гэлэнмаа танхимын сандал дээр суугаад цагаан нейлон өмд цамцтай хоёр сувилагч бүсгүйтэй ярилцах ажээ. Гэхдээ сувилагч гэхэд нас дэндүү залуу мэт Эндид санагдав. Тэд дөнгөж саяхан уйлсан нь илт бөгөөд одоо ч уйлахад бэлэн мэт харагдана. Гэхдээ Пайпер лам тэдэнд яг л тайвпгруулах эм мэт үйлчилж байгааг Энди харлаа. Хүмүүсийн сэтгэл хөдлөлийг ойлгох нь түүний ганц хийж чадцаг зүйл. Заримдаа Энди хүмүүсийн бодол санааг яг үүн шигээ ойлгож чаддаггүйдээ харамсдаг билээ.

Жинни холгүй зогсоод нэг ахимаг насны эртэй ярилцана. Хоёулаа цочирдож барьц алдсан шинжтэй харагдана. Жинни Эндиг харангуутаа түүн дээр ирэв. Эрэгтэй нь араас нь дагана.

Бүсгүй түүнийг Терстон Маршалл гэж танилцуулаад, бидэнд тусалж байгаа гэж нэмлээ.

Энди үл таних эр рүү нүд дүүрэн инээмсэглээд гарыг нь чанга атгав.

-Ноён Маршалл тантай танилцахдаа би баяртай байна. Би хотын захиргааны нэгдүгээр гишүүн Энди Сандерс.

Пайпер сандал дээр суунгаа тэднийг ажиглана. Тэгснээ:

-Энди чи үнэхээр нэгдүгээр гипгүүн юм бол хоёрдугаар гипгүүнийхээ жолоог атгамаар юм даа.

-Сүүлийн өдрүүдэд чамд хэнүү байгааг би ойлгож байна. Бид бүгд л тийм байгаа гэж Энди инээсэн чигээр хэлэв.

Пайпер түүн рүү мөс шиг хүйтэн харц чулуудаад дараа нь бүсгүйчүүдээс цай уухаар тэднийд очих эсэхийг асуув.

-Би өөрөө ч аяга цай уумаар байна гэж тэр хэллээ.

-Би тантай ярьсны дараа гэлэнмаа руу бас ярьсан юм гэж гэлэнмаа ба залуу сувилагч нар явсны дараа Жинни тайлбарлав. Түүний дуу уучлал гуйх өнгө аястай байлаа.

-Би бас цагдаагийн газар руу утасдсан. Дентонтой ярьсан гэж хэлээд тэр хамрыг нь эвгүй үнэр цохих мэт үрчийлгэв.

-Тийм ээ, Фредди сайн залуу гэж Энди чанга дуу алдлаа. Энэ бүхэн түүний сэтгэлийг үл эзэмдэнэ. Тэр дахиад Дейл Барбарагийн орон дээр суугаад хортой ягаан ус уухад бэлдэх хүсэл төрнө. Гэвч дасч дадсан дүрээ бүтээхэд онцын хөдөлмөр шаардагдахгүй. Хар шуурга дэгдсэн сэтгэл хөдлөлүүдийг номхруулж бүгдийг хэвийн байдалд оруулахыг тэр хэнээс ч илүү сайн чадна.

-Энд юу болоод байгааг надад яриач.

Бүсгүй ярьлаа. Энди хэдийгээр Френкийн гэр бүлийг бүх насаараа таньж мэдэх боловч гайхалтай тайван сонсов. Ахлах сургуульд байхдаа нэгэн удаа Жоржия Ругийн ээжийг болзоонд урьж байсан юмдаг. (Элен Ру амаа том ангайж ирээд л үнсэлцэх нь түүнд их сайхан байсан. Гэхдээ амьсгал нь үмхий байсан) Сэтгэл хөдлөл байхгүй байгаа нь ганц энгийн шалтгаантай гэж Энди бодов. Хэрэв гар утас нь дугараагүй бол тэр яг одоо ухаангүй хэвтэж байх байсан. Үхсэн байж ч мэднэ. Ийм байдал хорвоо ертөнцийг үнэний нүдээр харахад тусалдаг.

-Манай шинэ цагдаа нараас хоёр нь үхжээ гэж тэр хэлэхдээ дуу хоолой нь киноны цаг асуух гэж театр руу утасдахад урдаас хариулах автомат хариулагчтай адилхан мэт санагдав.

-Бас нэг нь их дэлгүүрийг хамгаалж байгаад хүнд бэртэл авсан ёо ёо ёо.

-Яг одоо бол ийм юм ярих цаг биш байх л даа. Гэвч би танай цагдаа нараар бахархахгүй байгаа. Гэхдээ намайг цохисон цагдаа одоо үхчихсэн болохоор гомдол гаргах утгагүй л дээ гэж Маршалл үг хавчуулав.

-Ямар цагдаа? Френки юу эсвэл Ру юу?

-Залуу эр. Би түүнийг таньсан. Хэдийгээр үхлийн шарх гадаад төрхийг өөрчилсөн ч...

-Френк таныг цохисон гэж үү? Энди үүнд итгэж чадсангүй. Френк түүнд дөрвөн жилийн турш нэг ч өдөр алгасалгүй "Льюистон сан" сонин зөөдөг байсан. Сайн санах юм бол хүчтэй шуургатай өдөр нэг хоёр удаа алгассан байх. Бас нэг удаа улаан бурханаар өвчилсөн. Гахайн хавдар ч билүү.

-Түүний нэр тэр юм бол мөн.

-Та мэдэж байна уу? Энэ...

"Энэ юу юм бэ? Ямар хамаатай юм бэ?" гэж асуумаар санагдсан ч дадал зуршил нь дийлэв.

-Энэ үнэхээр гунигтай хэрэг байна. Честерс-Милл хотод бид хариуцлагын тухай байнга санаж байдаг. Бүхнийг зөв хийхийг хичээдэг. Гэвч өнөөдөр бид гар бууны аман дор амьдарч байна. Нөхцөл байдал биднийг давсан. Та үүнийг мэдэж байгаа.

-Би мэднэ. Хэрэв та асуух юм бол ус даланг давсан гэж хэлэх байна. Гэвч ноёнтон танд гэж хэлэхэд энэ цагдаа нар дэндүү залуу байна. Тэгээд ч дээд зэргийн увайгүй. Надтай байсан эмэгтэй бас довтолгоонд өртсөн.

Энэ хүн үнэнийг хэлж байгаа гэдэгт Энди итгэж чадахгүй байв. Хэрэв өдөөн турхирахгүй л юм бол Честерс-Миллийн цагдаа нар хүмүүст хор хүргэдэггүй. Ийм юм хүмүүс нь биеэ хэрхэн авч явахыг мэддэггүй том хотод л болдог. Мэдээж тэр эмнэлэгт болсон явдал Милл хотын тухайд байж болшгүй зүйл гэдгийг ойлгож байв. Энэ хотод эмэгтэй хүн хоёр цагдааг алаад дараа нь амиа хорлосон удаагүй.

Гэвч энэ бүхэн чухал биш. Энэ хүн зүгээр явуулын хүн биш дээр нь бүр өөр муж улсын хүн гэж Энди бодов.

-Энди чи энд байгаа хойно чиний юу хийж чадахыг би мэдэхгүй байна. Дуги цогцоснуудтай зууралдаж байгаа гэж Жинни хэллээ.

Түүнийг үгээ дуусгаагүй байхад хаалга нээгдэж хоёр ч нойрмог хүүхэд хөтөлсөн залуу бүсгүй эмнэлгийн үүдний танхим руу орж ирэв. Өвгөн Маршалл түүнийг тэврэн авахад хүү охин хоёр харц солилцоно. Хоёулаа хөл нүцгэн бөгөөд богино ханцуйтай цамц өмссөн нь унтлагын хувцасны үүрэг гүйцэтгэх ажээ. Жаалхүүгийн цамц бараг шагайнд хүрэх бөгөөд дээр нь "9091 дугаарын хоригдол" ба "Муж улсын Шоушенк шоронгийн өмч" гэсэн бичиг байна. Энэ лав Маршаллын охин ба хоёр ач нь байх гэж Энди тааварлаад Клодет болоод Доди нарыг алдсандаа дахиад хүчтэй гашуудав. Тэгээд тэдний тухай бодлыг хүчээр түлхэн гаргалаа.

Жинни түүнийг туслуулахаар дуудав. Гэхдээ өөрт нь ч тусламж хэрэгтэй байгаа нь эргэлзээ үл төрүүлнэ. Туслалцаа гэдэг нь түүний ярих бүх түүхийг дахиад сонсох гэсэн үг гэдэг нь эргэлзээгүй. Жинни зөвхөн түүнд зориулж ярьсангүй. Жинни ингэж ярингаа өөрийн сэтгэлийг хөнгөлж байгаа юм. Энди үүнд дургүйцэхгүй. Тэр сонсож чаддаг. Тэгээд ч энэ нь гурван хүүр харж зогссоноос хавьгүй дээр. Тэдний нэг нь түүнд саяхан сонин зөөж байсан. Хэрэв сайн бодох юм бол сонсох нь хамгийн амар ажил. Хамгийн тэнэг хүн ч сонсож чадна. Гэтэл Том Жимийн хувьд ингэж яагаад ч чаддаггүй. Харин Том Жим ярьж чадна. Бас төлөвлөж чадна. Ийм гай гамшгийн үед тийм хүн хамт байгаа нь азтай хэрэг.

Жинни болсон явдлыг хоёр дахь удаагаа дуржигнуулж байх үед Эндигийн тархинд нэгэн санаа төрөв. Магадгүй маш чухал.

-Хэн нэг нь...

Яг энэ үед Маршалл өнөөх бүсгүй ба хүүхдүүдийг дагуулан ирлээ.

-Хотын захиргааны гипгүүн Сандерс... Энди... Энэ бол манай ажлын хүн. Каролин Стержес. Харин эд нар бол бидний харж асарч байгаа хүүхдүүд. Элис ба Эйден нар.

-Надад миний угж хэрэгтэй байна гэж Эйден уйлагнана.

-Чи угж хөхнө гэхэд дэндүү том болсон гээд Элис түүнийг тохойгоор ёвров.

Хүүгийн царай ярвайсан ч уйлсангүй.

-Элис чи их муухай юм хийлээ. Бид муу хүмүүсийн тухай юу мэдэх билээ? гэж Каролин түүнийг чангаав.

Элисийн царай гэрэлтээд ирлээ.

-Муу хүмүүсийг харахаар бөөлжис цутгадаг гэж дуу алдаад инээв. Тэр дороо Эйден тэдэнтэй нэгдлээ.

-Уучлаарай. Би тэднийг захиж үлдээх хүн байсангүй. Харин Маршалл над руу ярихдаа дуу нь их түгшүүртэй байсан гээд Каролин Энди рүү хандав.

Итгэхэд хэцүү байсан ч энэ өвгөн залуу эмэгтэйн эцэг биш бололтой. Гэхдээ энэ бодол Эндигийн сонирхолыг огт татсангүй. Өөр нөхцөлд байсан бол тэр энэ талаар нухацтай бодож, тэд ямар байрлалд өнөөх ажлаа хийдэг бол гэдгийг төсөөлж, бүсгүй гялалзсан нойтон уруулаараа түүнийг энхрийлдэг эсэх гээд цаашаа зөндөө юм бодох байсан. Харин одоо бол түүнд бусад асуудал дүүрэн.

-Хэн нэг нь Сэмми үхсэн гэдгийг нөхөрт нь хэлсэн үү? гэж асуув.

-Фил Бушид уу? Тэр жингэрийн хүүхэд эхнэрээ хаяад хотоос явчихсан. Аль эрт гэж яг энэ үед хонгилоос танхим руу орж ирсэн Дуги хэллээ. Тэр гудайж царай нь сааралтжээ. Тэгээд хүүхдүүд рүү харсанаа -Хүүхдүүд ээ уучлаарай гэв.

-Зүгээр дээ. Манай гэрт бол чөлөөтэй илэрхийлдэг. Энэ зөв гэж Каролин хариуллаа.

-Яг тийм. Бид гэртээ "Баас" юмуу "Хичий" гэдэг үгсийг дуртай үедээ хэлдэг. Ээж биднийг орхиогүй тохиолдолд.

-Гичий гэж хэлдэггүй. Гичий гэдэг хориотой хэмээн Эйден хэлэв.

Каролин тэднийг үл сонсох мэт. -Маршалл аа, юу болсон юм бэ?

-Хүүхдүүдийн хажууд ярих юм биш. Хараалыг тэд тоодоггүй байж болно.

-Френкигийн эцэг эх хотод эзгүй байгаа. Гэхдээ би Элен Ру-тай холбоо барьсан. Тэр эмэгтэй их тайван хүлээж авсан шүү гэж Дуги хэлэв.

-Согтуу байна уу? гэж Энди асуулаа.

-Шал согтуу.

Энди хонгилоор алхав. Эмнэлгийн халат ба углааш өмссөн хэдэн өвчтөн цааш харан зогсоно. Нядалгааны газрыг харж байх бололтой. Энди харахыг үл хүсэх бөгөөд Дуги энэ тал дээр анхаарал тавьсанд баярлав. Энди бол эм зүйч бөгөөд улс төрч хүн. Түүний ажил нь амьд хүнд туслах болохоос биш үхсэн хүнтэй зууралдах биш. Тэгээд ч тэр энэ хүмүүсийн мэдэхгүй зүйлийг мэднэ. Гэхдээ Фил Буши одоо хүртэл хотод байгаа бөгөөд радио станцад даяанчилж байгааг эдэнд хэлж чадахгүй. Харин түүний хаяж одсон эхнэр үхсэн тухай Филд хэлж чадна. Тэгээд хэлэхээр шийдэв. Мэдээж Фил ямар хариу барихыг төсөөлж чадсангүй. Ойрын өдрүүдэд Фил шал ондоо болсон. Тэр түүн рүү дайрч мэднэ. Муу мэдээ авчирсаны төлөө алж ч мэднэ. Гэвч энэ бүхэн тийм аймшигтай гэж үү? Амиа хорлогсод шууд тамд очих бөгөөд эрин зуун дуустал улайссан нүүрсээр хооллодог. Харин аллагын хохирогчид тэнгэрт халих бөгөөд тэднийг энд эрин зууны турш жигнэсэн мах ба интоортой бялууг Аврагч бурхантай нэг ширээнд хамт суун идэх заяа хүлээж байгаа гэдэгт Энди эргэлздэггүй.

Мэдээж түүний ойр дотныг хүмүүс ч энэ ширээнд хооллож байгаа.

15

Хэдийгээр өдөр хэдэн цаг угтсан боловч Жулия амьдралдаа хэзээ ч ингэтлээ ядарч үзсэнгүй. Нэгэнт Роузын хамт явах санаанаас татгалзсан болохоор одоо очих газаргүй болжээ. Машинаа очихоос өөр хаачих билээ.

Тэгээд машин дээрээ очиж Горасын уяаг хүзүүвчнээс мултлан зорчигчийн сандал дээр үсэрч гарах боломж олгоод өөрөө нөхцөл байдлыг бодохыг тулд жолооныг ард суув.

Тэр Роузад тун сайнаар ханддаг ч цаадах нь үйл явдал чигжсэн энэ урт өдрийн дараа мөн л амрахыг хүсч байж таарна. Түүнээс гадна Роуз Дейл Барбараг аврахын тулд юу хийж болохыг мэдэх гэж оролдоно. Өөрөөр хэлбэл түүнээс санаа хайх бөгөөд харин Жулияд ямар ч санаа байсангүй.

Горас эзэн рүүгээ чихээ унжуулж нүдээ гялалзуулан ширтэх нь "Одоо яах вэ?" гэж асуух мэт. Нохойгоо хараад тэр дөнгөж саяхан нохойгоо алдсан эмэгтэй буюу Пайперийн тухай бодлоо. Тэр түүнийг хүлээн авч унтах ор өгөх л байх. Гэвч ярьж залхаад нэг шөнө бөх бат нойрсох юм бол Жулия бодох чадвартай болно. Тэр бүү хэл ямар нэг төлөвлөгөө зохиож мэднэ.

Жулия "приус" машинаа асаагаад Конго сүм рүү явлаа. Гэтэл гэлэнмаагийн гэр харанхуй байх ба хаалган дээр нь бичиг тогтоосон байв. Жулия хадаасьгг сугалж гэрэлд уншихын тулд бичгийг аваад мапшн дээр ирлээ.

"Би эмнэлэг явлаа. Тэнд буудсан байна".

Жулия гаслан гангинасан бөгөөд Горас түүний хэмнэлд орон ульж эхлэхэд сая дуугүй болов. Тэр байшин руу эргэж очоод одоо хотод үлдэд байгаа ганц лам дээр нуруундаа түмэн асуудал үүрсэн нь хэн нэгэн сүсэгтэн ирлээ гэхэд уншуулахаар бичгийг буцаан хадав.

Одоо хаачих вэ? Роуз дээр очих уу? Гэвч Роуз унтаж байгаа байх. Эмнэлэг орох уу? Жулия хэдийгээр ядарч цочролд орсон ч хэрэв энэ явдал ямар нэг зорилготой байсан бол хүчээр эмнэлэг рүү явах л байсан. Даанч тэнд болсон явдлын талаар бичих сонин одоо түүнд байхгүй. Харин сонингүй бол Жулияд шинэ аймшгуудыг үзэх нь утгагүй санагдана.

Тэр машинаа ухраан Төв гудамж руу гараад ямар ч зорилгогүй явсаар Престил-Стрит гудамжны уулзварт ирэв. Гурван минутын дараа түүний машин Андреа Гриннелийн орцны зам дээр зогсож байв. Гэвч энэ байшин ч харанхуй байлаа. Үүдийг аяархан цохиход хэн ч хариулсангүй. Андреа маш бөх нойрсдогийг мэдэхгүй болохоор Жулия түүнийг хэн нэг найзындаа юмуу дүүгийн дээ хонохоор явсан гэж бодов.

Харин Горас хаалганы дэргэдэх хивсэнцэр дээр суугаад эзэгтэйн үргэлж тэгдэг шигээ ямар нэг алхам хийхийг хүлээнэ. Гэтэл Жулия одоо юу хийх талаар ямар ч ойлголтгүй. Хаа нэг тийшээ явъя гэхэд хэт ядарчээ. Төв зам дээр эргээд гарлаа гэхэд замаас тэр дороо хазайх бөгөөд ямар нэг юм мөргөж хоёулаа үхнэ гэдэгтээ бараг эргэлзэхгүй байлаа.

Жулия бүх амьдрал нь үлдсэн шатсан байшингийн талаар бодсонгүй. Харин Честерс-Миллийн оршин суугчдыг хаясан эсэх талаар түүнийг асуухад хурандаа Кокс ямархуу байсныг л бодно.

"Үгүй, яасан ч үгүй" гэж тэр түгдрэлгүй хариулсан. Гэвч ингэж хэлэхдээ харц буруулж байсан.

Довжоон дээр савлуур сандал байлаа. Шаардлагатай бол түүн дээр хэвтэж болно. Гэвч магадгүй...

Жулия хаалгыг түлхэж үзтэл онгорхой байв. Жулия эргэлзсэн боловч харин Горас тэгсэнгүй. Түүнийг хаа сайгүй тэврэн угтана гэдэгт бүрэн итгэлтэйгээр мань нохой гэр рүү саадгүй оров. Жулия уяаны нөгөө үзүүрээс зуурсаар араас нь дагахдаа "одоо шийдвэрийг нохой маань гаргадаг болжээ. Юунд хүрэв дээ" гэж бодов.

-Андреа чи байна уу? Би Жулия байна гэж дуудна.

Харин Андреа дээд давхарт дөрвөн хоног амралтгүй давхисан алсын тээврийн жолооч шиг дээш харан хэвтээд хурхирна. Түүний ганцхан эрхтэн хөдөлж байсан нь зүүн хөлийн тавхай татвалзах ажээ.

Зочдын өрөөнд бүрэнхий боловч тас харанхуй биш байлаа. Гал тогоонд зайгаар ажилладаг чийдэн асааж орхижээ. Содон үнэр ханхлана. Хэдийгээр цонхнууд нээлттэй боловч ямар ч салхигүй учраас бөөлжисний үнэр энд хөшжээ. Андреа өвчтэй гэж хэн нэгэн ярьсан. Томуу гэл үү дээ?

Томуу ч байж мэднэ. Эсвэл уудаг эм нь дууссан бол тэр шартсан байж болно.

Ямар ч тохиолдолд өвчний тухай яриа болж байна. Харин өвчтэй хүмүүс ганцаар үлдэхийг хүсдэггүй. Тэгэхээр энэ байр эзгүй гэсэн үг. Жулия маш их ядарчээ. Эсрэг талын хананд байгаа урт тохилог буйдан түүнийг даллан дуудна. Хэрэв Андреа маргааш ирээд Жулияг энд оллоо гэхэд ойлгоно.

-Магадгүй аяга цайгаар дайлж мэднэ. Тэгээд бид энэ бүхнийг шоолж инээлдэнэ гэж Жулия өөртөө хэлэв. Гэхдээ яг энэ үед бол тэр хэзээ ч юунд ч инээхээ больсон мэт санагдаж байлаа.

-Горас явцгаая.

Жулия хүзүүвчийг тайлаад өрөөг хөндлөн алхав. Эзэн нь диван дээр хэвтэж дэр толгой дороо ивэх хүртэл ажиглав. Тэгээд нохой өөрөө хэвтэж хоншоороо савар дээрээ тохов.

-Сайн жаал гэж Жулия түүнийг магтаад нүдээ аньлаа. Тэгээд түүнтэй харц буруулахаас зайлсхийх Коксын нүдийг олж үзэв. Кокс тэднийг Бүрхүүл дор тун удна гэж бодож байна даа.

Гэвч бие махбодь тархины үл хүрч чадах тийм зовлон шаналалыг мэдэрдэг. Жулия унтаж байхад түүний толгой энэ өглөө Брендагийн түүнд дамжуулахыг оролдсон хүрэн өнгийн зузаан цаасан дугтуйнаас ердөө 4 фут зайтай байв. Горас удалгүй диван дээр гараад эзнийхээ хөлний дэргэд цагираглав.

Аравдугаар сарын 25-ны өглөө сүүлийн олон жилийн турш анх удаа жинхэнэ Андреа гэж хэн болохоо мэдэрсэн Андреа шатаар бууж ирээд тэднийг яг ийм байдалтай байхыг олж үзэв.

16

Эвереттийн зочдын өрөөнд Линда Жекки Стейси ба Расти нар цуглажээ. Тэр бүтдэд нь мөстэй цай тарааж өгөөд дараа нь "Боуигийн оршуулгын товчоо"-ны хонгилд юу олж үзсэн тухайгаа ярив.

Эхний асуултыг Стейси тавьлаа.

-Та нар хаалга түгжихээ мартаагүй биз?

-Мартаагүй гэж Линда хариулав.

-Түлхүүрээ нааш аль. Буцааж аваачна.

"Бид ба тэд. Одоо яриа ингэж явна. Тэр ингэж явагдаж байна. Бидний нууц. Тэдний хүч. Бидний төлөвлөгөө. Тэдний санаа" гэж Расти бодлоо.

Линда түлхүүрээ өгөөд хүүхдүүд нь зовоосон эсэхийг Жеккигээс асуув.

-Хэрэв чи тэгж бодож айж байгаа бол ямар ч уналт өгөөгүй шүү. Та нарын эзгүйд яг л хурга шиг унтацгаасан.

-Одоо бид юу хийх билээ? гэж жижиг биетэй зорьсондоо хүрдэг Стейси асуув. -Хэрэв та нар Ренниг баривчлахыг хүсч байгаа бол бид дөрвүүлээ нийлж Рэндолфыг итгүүлэх хэрэгтэй болно. Гурван эмэгтэй нь цагдаагийн хувьд, харин Расти задлан шинжээчийн хувиар.

-Үгүй гэж Жекки Линда хоёр зэрэг дуу алдав. Жекки шийдэмгий, харин Линда айсан дуутай байлаа.

-Бидэнд зөвхөн таамаг бий. Эд мөрийн баримт байхгүй. Бидэнд Том Жимийн Брендагийн хүзүүг хугалж байгаа гэрэл зураг байсан ч Рэндолф итгэнэ гэдэгт би эргэлзэж байна. Ренни тэр хоёр одоо хүлээстэй. Живбэл хамт живнэ, хөвбөл хамт хөвнө. Тэгээд ч цагдаа нарын ихэнхи нь Питийн талд орно.

-Ялангуяа шинэ цагдаа нар гээд Стейси өтгөн үсээ иллээ. -Тэд бүгдээрээ шахуу ухаан муутай боловч ямар ч тушаалыг биелүүлэхэд бэлэн. Тэдэнд зэвсэгтэй явах их таалагдаж байгаа. Дээр нь гэснээ бүсгүй ширээ рүү тонгойж: -Өнөөдөр тэд 6 юмуу 8-аар нэмэгдсэн. Ахлах сургуулийн сурагчид. Эрүүл чийрэг, тэнэг, эрч хүчтэй. Тэд чөтгөр шиг айлгаж байна. Бас юу гээч? Картер ба бага Ренни нар шинэ залуусыг өөр хүмүүс дагуулж авчрахыг хүссэн. Хоёр хоногийн дараа манайд цагдаа биш харин арми бий болно.

-Биднийг хэн ч сонсохгүй юу? гэж Расти асуулаа. Эмэгтэйчүүдэд итгээгүйдээ тэр биш. Зүгээр л тодорхойгүй зүйл үлдээхийг хүссэнгүй. -Нэг ч цагдаа итгэхгүй юу?

-Генри Моррисон магадгүй. Тэр юу болоод байгааг харж байгаа. Энэ бүхэн түүнд таалагдахгүй байгаа. Бусад нь уу, тэд Ренни Рэндолф нарыг дагана. Зарим нь айсандаа, зарим нь эрх мэдэлд дуртайдаа. Тоби ба Жорж нарт хэзээ ч эрх мэдэл байгаагүй. Харин Дентон бол ердөө л хорон санаатан.

-Энэ тэгээд юу гэсэн үг вэ? гэж Линда асуув.

-Энэ нь болсон мэдээлэл зөвхөн бидэнд үлдэх ёстой гэсэн үг. Хэрэв Ренни дөрвөн хүн алж байгаа юм бол тэр маш аюултай хүн.

-Хүлээх нь түүнийг илүү аюултай болгоно гэж Расти дургүйцэв.

-Бид Жүди ба Жанни нарын талаар түгших хэрэгтэй гэж Линда хэлэв. Тэр хумсаа хэмлэж

байх ба Расти олон жил хамт явахдаа үүнийг хараагүй юм. -Бид хүүхдийнхээ сайн сайхнаар дэнчин тавьж болохгүй. Би энэ талаар бодохыг ч хүсэхгүй ба чамд бас зөвшөөрөхгүй.

-Би ч бас хүүхэдтэй. Кэлвин хүү маань таван настай. Би өнөөдөр та хоёрыг оршуулгын товчооны урд хамгаалахын тулд бүх зоригоо дайчлахад хүрсэн. Энэ тэнэг Рэндолфод хандах санаа нь өөрөө... гэснээ тэр дуугүй болсон ч хацар нь цайраад ирсэн нь дутуу хэлсэн үгийг нь сайхан орлож өгөв.

-Чамайг түүн дээр оч гэж хэн ч гуйгаагүй гэж Жекки хэллээ.

-Яг энэ мөчид бол Лестерийг бейсболын бөмбөгөөр алсан гэдгийг л би баталж чадна. Гэхдээ бөмбөгийг хэн ч ашиглаж болно. Реннигийн хүү ч бас гэж Расти тэмдэглэв.

-Тэгсэн байлаа гэхэд би гайхахгүй. Жижгээ сүүлийн үед их хачин байгаа. Түүнийг зодоон хийсний төлөө Боудинаас хөөсөн. Эцэг нь энэ тухай мэдэх эсэхийг би мэдэхгүй. Цагдаагийнхныг зодоон болсон спорт танхимд дуудсан байна лээ. Бидэнд бас илтгэх бичиг илгээсэн. Харин тэр хоёр бүсгүй... Хэрэв энэ бэлгийн гэмт хэрэг бол...

-Яг тийм. Үнэхээр ой гутам. Та нар дэлгэрэнгүй мэдэхгүй байсан нь дээр гээд Расти толгой дохив.

-Гэхдээ Брендад бэлгийн хүчирхийлэл хийгээгүй. Миний хувьд бол Лестер лам ба Брендагийн аллага нэг хэрэг. Харин хоёр бүсгүйг алсан нь шал ондоо хэрэг гэж Жекки дурдлаа.

-Магадгүй хоёр бүсгүйг Жижгээ. Харин Бренда ба лам хоёрыг эцэг нь алсан байх гэж Расти хэлээд бүтд шоолон инээлдэх байх гэж дуугүй чагнав. Гэтэл хэн ч инээсэнгүй. -Хэрэв тийм бол яагаад?

Бүгд нэгэн зэрэг толгой сэгсрэв.

-Шалтгаан байх ёстой. Гэхдээ би энэ нь секс гэдэгт эргэлзэж байна гэж Расти үргэлжлүүлэв.

-Том Жимд ямар нэг нуух юм байгаа гэж чи бодоод байна уу? гэж Жекки асуух үед асуух өнгө дуунд нь огт байсангүй.

-Тийм ээ, тэгж бодож байна. Бас юу нуугаад байгааг нь мэдэх хүн байгаа гэж сэжиглээд байна. Тэр хүн нь цагдаагийн газрын хонгилд түтжээтэй байгаа.

-Барбара юу? Яагаад чи тэгж бодов? гэж Жекки асуулаа.

-Яагаад гэвэл тэр Брендатай ярилцсан. Хашаанд нь их удаан ярилцсан. Бүрхүүл үүссэний маргааш.

-Чи үүнийг хаанаас мэдсэн юм бэ? гэж Стейси гайхлаа.

-Жина Перкинстэй хөрш. Жинагийн унтлагын өрөөний цонх Перкинсийн хашаа руу харсан

байдаг. Тэр хараад надад хэлсэн юм гэж Расти хэлэхдээ Линда түүн рүү асуух мэт ширтэхийг анзаарч мөрөө хавчсанаа: -Яагаад үгүй гэж манай хот жижигхэн. Бид бүгд нэг л хүний хөгжөөн дэмжигчид.

-Чи түүнийг амаа хамхихыг зөвлөсөн гэж найдаж байна гэж Линда асуув.

-Үгүй. Яагаад гэвэл түүнийг энэ талаар ярих үед надад Том Жимийг Брендaгийн үхэлд сэжиглэх шалтгаан байсангүй. Бас бейсболын дурсгалын бөмбөгөөр Лестер ламын толгойг хага цохисон гэсэн сэжиг ч байгаагүй. Тэр бүү хэл тэдний үхсэн гэдгийг ч би мэдээгүй.

-Барбарагийн юу мэдэж байгааг бид мөн мэдэхгүй. Түүний бяслаг ба мөөгтэй гайхам сайхан өндөг шардагаас өөр юуг ч би мэдэхгүй гээд Стейси толгой сэгсрэв.

-Хэн нэгэн түүнээс энэ талаар асуух хэрэгтэй гэж Жекки хэлээд ширээнд суусан хүмүүсийг тойруулан харсанаа би өөрийгөө сонголоо гэв.

-Бид түүний мэдэж байгааг мэдлээ ч гэсэн ингэлээ гээд ямар ашиг гарах юм бэ? Манайд бараг л дарангуйлал тогтчихлоо. Би дөнгөж сая үүнийг ухаарсан. Урьд нь огт ойлгоогүй. Би их муу сэтгэдэг байх гэж Линда ярив.

-Чи мохоо гэхээсээ илүү итгэмтгий гэж Жекки дургүйцээд: -Зарчмын хувьд хүмүүст итгэх нь зөв пгүү дээ. Хурандаа Барбарагийн тухайд бол түүнээс асуухаас нааш хариулт нь ямар ашиг авчрахыг бид мэдэхгүй гэснээ дуугаа хураав. Тэгээд дахиад: -Гэхдээ энэ гол юм биш. Та нар ойлгож байгаа. Тэр буруугүй. Энэ л гол.

-Хэрэв түүнийг алчихвал яах вэ? Зугтах оролдлого хийхээр нь буудчихвал яах вэ? гэж Расти огцом асуув.

-Ийм юм болохгүй гэдэгт би бараг итгэлтэй байна гэж Жекки хариулав. -Том Жимд пгүүх үзүүлбэр хэрэгтэй. Энэ тухай цагдаагийн газарт ярьж байна билээ гэхэд Стейси толгой дохилоо. -Тэр болоод түүний дагалдагсад Барбара бол өргөн хүрээтэй хуйвалдааны тор нэхсэн аалз гэдэгт хүмүүсийг итгүүлэхийг хүсч байгаа. Дараа нь итгэсэн хүмүүс түүнийг цаазлана. Гэвч хэрэв тэд дээд зэрэг хурдалсан ч үүнд хэдэн өдөр шаардагдана. Бидэнд аз таарвал долоо хоног.

-Бидэнд тэглээ аз дайрахгүй. Ренни бүхнийг маш хурдан дуусгах байх гэж Линда үл зөвшөөрөв.

-Магадгүй чиний зөв. Гэхдээ тэр пүрэв гаригт хотын шуурхай хурал зарласан. Мэдээж Барбараг байцаахыг хүснэ. Барби Брендатай харьцдагийг Расти мэдэж байгаа юм чинь Ренни ч бас мэдэж таарна.

-Мэдээж мэдэж байгаа гэх Стейсигийн дуунд тэвчээргүй зан тодорлоо. -Барби Жимд ерөнхийлөгчийн захидлыг үзүүлэхэд Бренда хамт байсан биз дээ.

Бүгд энэ талаар бодов.

-Хэрэв Ренни ямар нэг юм нууж байгаа бол түүнд материалаас салах хугацаа шаардагдана гэж Линда нам гүмийг таслав.

Жекки инээлээ. Жижиг өрөөний түтшүүртэй байдалд ийнхүү инээсэнд бүгд цочив.

-Түүнд аясын салхи хүсье. Ямартаа ч тэр өөрийг нь илчлэх эд мөрийн баримтыг машинд ачаад хотоос гаргаж чадахгүй.

-Энэ чинь хийтэй ямар нэг холбоотой юу? гэж Линда асуув.

-Магадгүй. Жекки чи армид алба хаасан уу? гэж Расти асуулаа.

-Тийм. Хоёр ээлжээр. Цэргийн цагдаад. Байлдааны ажиллагаанд оролцоогүй ч шархадсан хүн олныг үзсэн. Ялангуяа хоёрдугаар ээлжээр. Германы Вюрцвурт. Тэнд явган цэргийн нэгдүгээр дивиз байрладаг. Том улаан нэгийн тоог та нар мэдэх үү? (явган цэргийн нэгдүгээр дивизийн цэрэг офицерууд улаан өнгийн нэгийн тоо зурсан тэмдэгийг гартаа зүүдэг). Бид ихэнхидээ цэргийн эмнэлгийн үүдэнд харуулд зогсох юмуу зодоон цохионыг намжаадаг. Би Барби шиг залуусыг зөндөө үзсэн. Тэр хонгилоос гарч манай талд орохын тулд би юу ч өгөхөд бэлэн. Ерөнхийлөгч түүнийг гол хүнээр томилох шалтгаан байж л таарна. Эсвэл томилох гэж оролдсон гэх үү? Түүнийг тэндээс сугалах хэрэгтэй. Энэ талаар л бодох хэрэгтэй гээд тэр дуугаа хураав.

Цагдаагийн ажилтнуудын зэрэгцээ ээжүүд болох нөгөө хоёр эмэгтэй нь юу ч хэлсэнгүй. Линда хумсаа хэмлэж Стейси үсээ үгтээсээр байв.

-Би та нарыг ойлгож байна гээд Жекки санаа алдлаа.

Линда толгой сэгсрэв.

-Хэрэв өглөө зөвхөн чи л цай өгөх ёстой хүүхдүүд дээд давхарт унтаж байгаа биш бол чи ойлгохгүй.

-Магадгүй. Гэхдээ та өөртөө асуулт тавиарай. Хэрэв бид бүх дэлхийгээс тусгаарлагдсан бол, бид тусгаарлагдчихсан байгаа, хэрэв бидний дээр байгаа хүн ухаангүй алуурчин бол, бараг л тийм байх, бид зүгээр суугаад юу ч хийхгүй байлаа гээд дээрдэх үү?

-Хэрэв бид Барбиг сулаллаа гэхэд яах вэ? Гэрчийг хамгаалах хөтөлбөр энд үйлчлэхгүй шүү дээ гэж Расти асуув.

-Мэдэхгүй гээд Жекки дахин санаа алдлаа.

-Би ганцхан юм мэдэж байна. Ерөнхийлөгч хотын эрх мэдэл авахыг түүнд тушаасан. Харин Том Жим, булшлуулмар Ренни түүнд энэ эрх мэдлийг өгөхгүйн тулд түүний эсрэг хүн амины хуурамч хэрэг зохион байгуулсан.

-Яг одоо бол чи юу ч хийж болохгүй шүү гэж Раст Жекки рүү харан хэллээ. -Тэр бүү хэл түүнтэй ярих оролдлого ч хийж болохгүй. Яагаад гэвэл бүхнийг өөрчилж мэдэх бас нэг чухал

юм байна.

Тэр Гейгерийн тоолуурын тухай ярив. Түүнд хэрхэн дамжиж ирсэн, хэнд дамжуулсан, түүний тусламжтай Жо-г олсон.

-Ёстой мэдэхгүй юм даа гэх Стейсигийн дуунд эргэлзээ тодорно. -Итгэмээргүй бүх юм сайхан сонсогдож байна. Энэ Жо... хэдэн настай юм бэ? Арван дөрөв үү?

-Арван гурав. Гэхдээ тун ухаалаг хүүхэд. Хэрэв тэр Блэк-Ридж-Роуд дээр цацраг идэвхижлийн эх сурвалжийг тогтоож чадсан гэж байгаа бол би түүнд итгэж байна. Хэрэв Бүрхүүлийг үүсгэж байгаа тэр зүйлийг үнэхээр олсон юм бол бид салгаж хаяж чадна...

-Тэгвэл бүх юм дуусна гэж Линда дуу алдлаа. Түүний нүд гялалзаад ирэв. -Жим Ренни яг л талархлын баярын өдөр цоолуулсан "мейси" агаарын бөмбөлөг шиг шалчийна.

-Тэгвэл сайн л байна гээд Жекки мушийн инээв. -Хэрэв зурагтаар үзүүлбэл би бараг итгэх байх.

17

-Фил, Фил гэж Энди дуудна.

Сонсоосой гэсэндээ дуугаа өндөрсгөв. Бонни Нанделла ба "Ридемпшн" нар "Миний сүнс гэрч" дууг хамаг хүчээрээ дуулна. Энэ их нүргэлсэн чимээ баримжаа алдуулна. Тэр бүү хэл ХБЭ радио студи доторхи хурц гэрэл ч баримжаа алдуулна. Энди энэ хурц чийдэнгүүдийн дор ирээд л Милл хот хичнээн их барайсныг ухаарав. Тэр яаж энэ бүүдгэр гэрэлд дассанаа ойлгож ядна. -Шеф

Хариу алга. Энди зурагтын дэлгэц рүү харлаа. (Си-эн-н суваг дуугүй гарч байна) Дараа нь том цонхоор студи рүү шагайв. Тэнд ч бас гэрэлтэй байх бөгөөд тоног төхөөрөмжүүд ажиллана. (хэдийгээр Лестер лам энд бүхнийг компьютер удирддаг гэж түүнд бардамнан тайлбарлаж байсныг санавч арьсан дээгүүр нь шоргоолж гүйх шиг зарайв) Гэвч энд ямар ч Фил алга.

Гэнэт үмхийдүү исгэлэн хөлсний үнэрийг мэдэрлээ. Эргэтэл Фил урд нь зогсч байв. Тэр яг л шалан доороос үсрээд гараад ирсэн юм шиг. Нэг гартаа гар буу нөгөө гартаа гараашийн хаалгын алсын удирдлага шиг зүйл барьжээ. Бууны ам Эндигийн цээж рүү чиглэсэн байв. Гохон дээр байх хурууны яс цайран харагдах мэт бөгөөд бууны ам бага зэрэг чичирхийлнэ.

-Сайн уу Фил? Өөрөөр хэлбэл Шеф.

-Чи энд юу хийж байгаа юм бэ? гэх Шефийн хөлсний үнэрт муужирч унамаар болов. Энгэр дээрээ "ХБЭ" гэсэн бичээстэй богино ханцуйтай цамц ба жинс нь хиртэж өнгө нь өөрчлөгджээ. Хөлд нь (тэр хөл нүцгэн байсан бөгөөд тийм ч учир Энди түүний хөлийн чимээг сонсоогүй) шавар шороо наалджээ. Тэр толгойгоо хамгийн сүүлд лав жилийн өмнө угаасан байх. Угаагаагүй ч байж мэднэ. Гэвч бүхнээс илүү түүний солиотой бас цус дүүрэн

нүд айдас төрүүлнэ.

-Хөгшин минь түргэн хэл. Эс тэгвэл чи хэнд ч, юу ч хэлж чадахгүй болно шүү.

Дөнгөж саяхан ягаан усыг угаалтуур руу асгаж сүүлчийн удаа үхлийг хуурсан Энди Шефийн сүрдүүлгийг тоосонгүй. Тэр бүү хэл инээмсэглэн угтсан гэж болно.

-Зөв гэж бодсоноороо хий Фил, бишээ Шеф.

Шеф түүн рүү хөмсөгөө өргөн гайхан харав.

-Үнэн үү?

-Үнэн.

-Чи яах гэж ирсэн юм бэ?

-Би чамд муу мэдээ авчирлаа. Уучлаарай.

Шеф хариуг нь бодсоноо үлдсэн хэдэн шүдээ гарган инээв.

-Муу мэдээ гэж байдаггүй юм. Христ ирж яваа. Энэ сайн мэдээнд бүх муу мэдээ уусах болно. Энэ их сайн мэдээ. Чи санал нэг байна уу?

-Тийм ээ, би ч бас аллилуйя гэж хэлдэг. Харамсалтай нь эсвэл чиний бодлоор бол азтай нь чиний эхнэр аль хэдийн Түүнтэй хамт байгаа.

-Юу гэнэ ээ?

Энди гараа сунгаж бууг шал руу дарлаа. Шеф түүнийг зогсоох гэж оролдсонгүй.

-Саманта үхсэн Шеф ээ. Өнөө орой тэр амиа хорлосон гэдгийг чамд хэлэх ёстой.

-Сэмми юу? Үхсэн гэж үү? гээд Шеф ойрхон ширээн дээр байсан илгээх бичиг баримтны сагс руу гар буугаа чулуудав. Удирдлага барьсан гараа ч бас буулгалаа. Сүүлийн хэдэн өдөр тэр хааяа нэг унтахдаа ч удирдлагыг гараасаа салгаагүй.

-Би их харамсаж байна Фил Шеф.

Энди өөрийн ойлгосноор Сэммигийн үхсэн түүхийг дамжуулж хэлэв. Хамгийн сүүлд арай баяртай мэдээ хэлсэн нь жаалхүү сайн байгаа. (Энди Сандерс цөхөрсөн үедээ ч хэзээ юу ярихаа мэддэг)

Литл-Уолтерийн сайн байгаа тухай мэдээг сонсох үедээ Шеф удирдлага барьсан гараа савав.

-Тэр хоёр ч гахайг унагасан юм шив?

Энди биеэ чангаллаа.

-Фил гахай биш цагдааг. Сайн хүмүүсийг. Тэр лав галзуурсан. Ийм хэрэг хийж байна гэдэг чинь, би итгэлтэй байна. Чи сая хэлсэн үтээ буцааж авах ёстой.

-Ямар үг?

-Чи манай цагдаа нарыг гахай гэж дуудахыг би хүсэхгүй байна.

Шеф боддоо.

-За яахав буцааж авлаа.

-Чамд баярлалаа.

Шеф тонгойж (тэр чамгүй өндөр нуруутай боловч одоо бол араг яс тонгойсон мэт харагдана) Эндигийн нүүр рүү ширтэв.

-Чи жижигхэн зоримог зулбасага уу?

-Үгүй шүү. Зүгээр л надад яасан ч ялгаа алга гэж Энди шударга хариуллаа.

Энди өөрөө ч гунигт автсан болохыг Шеф ойлгох шиг

болов. Мөрнөөс нь зуураад: -Дүү минь чи зүгээр үү?

Энди гэнэт цурхиран уйлаад "Христ бүх сувгийг үздэг, христ бүх долгионыг сонсдог" гэсэн бичгийн доор байх сандал дээр унаад өгөв. Энэ заналтай хачин үгсийн доор дагзаараа хана налан унаад чихрийн чанамал хулгайлсныхаа төлөө шийтгүүлсэн хүүхэд шиг уйлж гарлаа. Уйлах шалтгаан нь түүний сонссон "дүү" гэсэн үг ажээ. Түүний хувьд тун гэнэтийн үг юм.

Шеф радио станцын удирдлагын ширээн дороос сандал татан гаргаад ямар нэг ховор амьтныг амьдрах орчинд нь харж байгаа байгаль судлаач шиг Энди рүү ширтэнэ. Хэсэг хугацааны дараа асуув.

-Сандерс чи надад алуулах гэж наашаа ирсэн юм уу?

-Үгүй гэж Сандерс цурхирах хоорондоо хэллээ.

-Магадгүй. Тийм. Хэлж мэдэхгүй юм. Гэвч миний амьдрал тэр чигээрээ өөр болчихлоо. Эхнэр охин хоёр маань үхсэн. Энэ баасыг зарсны төлөө бурхан намайг шийтгэж байна гэж би бодох юм.

Шеф толгой дохив.

-Тийм ч байж мэднэ.

-...Би хариултыг хайж байна. Эсвэл үхлийг. Эсвэл өөр нэг юмыг. Түүнээс гадна би чиний

эхнэрийн тухай чамд хэлэх гэж мэдээж ирсэн. Зөв алхам хийх чинь чухал шүү дээ...

Шеф түүний мөрөн дээр алгадав.

-Чи яг тэгсэн дүү минь. Би үүнийг үнэлж байна. Тэр гал тогоонд юу ч хийж чаддаггүй байсан. Гэр орноо цэвэрлэж чаддаггүй байлаа. Гэвч заримдаа хар тамхи татсан үедээ солиотой хурьцдаг байсан. Ингэхэд тэр яагаад цэнхэр хувцастай тэдгээр залууст тэгтлээ уурласан юм бэ?

Энди гашуудаж байсан ч хүчиндсэн тухай ярих бодолгүй байв.

-Тэр Бүрхүүлээс болоод их хямарсан гэж би бодож байна. Ингэхэд чи Бүрхүүлийн тухай мэдэж байгаа юу? Фил, Шеф.

Тэр эерэг хариу өгч байгаа бололтой гараа савлаа.

-Метийн тухайд чи зөв ярьлаа. Үүнийг зарах муу. Чөтгөрт үйлчилж байгаа хэрэг. Харин үйлдвэрлэх нь ондоо. Энэ бол бурхны таалал.

Энди гараа унжуулаад хавдсан нүдээр Шефийг гайхан харав.

-Чи тэгж боддог гэж үү? Яагаад гэвэл би үүнийг зөв гэдэгт итгэхгүй байна.

-Чи хэзээ нэгэн цагт амсч үзсэн үү?

-Шеф түүнээс нохойтой хурьцаж үзсэн үү гэж асуусан юм шиг Энди дуу алдан "Үгүй" гэлээ.

-Эмч чамд эм бичиж өгвөл чи уудаг уу? -Тэр... мэдээж тийм... гэхдээ...

-Мет бол эм гэж Шеф хэлэхдээ түүн рүү тун нухацтай харав. Дараа нь итгүүлэх үүднээс Эндигийн цээж рүү хуруугаар тогшив. Шефийн бүх хумс унажээ.

-Мет бол эм. Давгаж хэл.

-Мет бол эм гэх Эндигийн дуунд зөвшөөрсөн өнгө ДУУДДав.

-Яг зөв. Мет бол хойлог байдлаас аврах эм. Би Рэй Брэдберигээс уншсан юм. Ингэхэд чи хэзээ нэг цагт түүнийг уншсан уу? гээд Шеф бослоо. (нэрт зохиолч хойлог байдлаас аврах эм бол метамфетанин гэж огт бичээгүй)

-Үгүй.

-Брэдбери чинь ёстой гавал пгүү дээ. Тэр мэднэ. Өнөөх далайн номыг бичсэн хүн. Аллилуйя гэж хэл. Тэгээд намайг дага. Би чиний амьдралыг өөрчлөөд өгье. (Шеф "хойлогоос аврах эм" нэртэй өгүүллэгүүдийн түүврийн тухай ярьжээ)

Честерс-Миллийн захиргааны нэгдүгээр гишүүнд мет татах нь мэлхийнд шумуул таалагддаг шиг л таалагдав.

Эгнүүлж тавьсан халаагууруудын голд чихарсан хуучин буйдан байх ба Энди Шеф хоёр энд мотоцикль унасан Христийн зураг дор тухалжээ. (энэ зураг "чамд харагдахгүй замын хань" гэсэн нэртэй) Тэд бие биедээ гаанс дамжуулна. Шатаж байгаа мет таглаастай хөтөвчинд гурав хоног байлгасан шээс шиг үнэртэнэ. Гэвч эхний болгоомжтой соролтын дараа л Энди Шефийн зөв болохыг мэдэрчээ. Метийг зарах аваас чи чөттөрт үйлчилнэ. Харин бүтээгдэхүүн өөрөө бол бурханд нийцнэ. Хорвоо ертөнц гэнэт Эндигийн урьд хожид хэзээ ч хараагүй тод хурц өнгөтэй болов. Зүрхний цохилт нэмэгдэж, хүзүүний цусны судаснууд хөөж, буйлаар хатгах мэдрэмж төрөх бөгөөд төмсөг нь яг л залуу цагийнх шиг чимчигнэнэ. Гэхдээ хамгийн гол нь түүний мөрөн дээр хүнд ачаа болоод байсан ядаргаа ба сүлэлдсэн бодлууд алга боллоо. Тэр тэрэг дээрээ уулыг ачаад зөөж ч чадах мэт мэдрэгдэв.

-Диваажингийн цэцэрлэгт Мод байдаг юм. Сайн ба муугийн Мод. Ойлгож байна уу? гэж Шеф түүнд гаансаа дамжуулахад хоёр үзүүрээс нь ногоон утаа суунаглана.

-Тийм ээ, Библид тэгэж гардаг.

-Шүдээ өгөхөд бэлэн байна. Энэ Модон дээр алим ургасан.

-Яг яг гэж хэлэнгээ Энди ямар нэг юм амсч үзэж байгаа мэт багахан соров. Их сормоор, бүгдийг нь сормоор. Гэвч гүнзгий сорох юм бол толгой нь хүзүүнээсээ салаад хойноосоо тархи ба цусан утаа татуулж лаборатори дотуур пуужин шиг нисч эхлэх мэт санагдана.

-Энэ алимны зөөлөн эд нь Үнэн юм. Алимны хальс нь мет юм гэж Шеф санаагаа дуусгав.

Энди түүн рүү харлаа.

-Гайхалтай.

Шеф толгой дохив.

-Тийм ээ, Сандерс яг тийм юм. Ингэхэд энэ сайн баас уу? гэж гаансыг авангаа асуув. -Сэтгэл донслоом баас.

-Христ хэллоуины баяраар буцаж ирнэ. Хэдэн өдрийн өмнө ч байж магадгүй. Ян тан хэлж чадахгүй нь. Хэллоуины улирал эхэлчихсэн пгүү дээ. Хорон санаат шулмын улирал гээд тэр Эндид гаансаа өгч удирдлага барьсан гараар заан: -Харж байна уу? Тэр төгсгөлд байгаа юмыг. Зоорины талын хаалган дээр.

Энди харав.

-Юу вэ? Тэр цагаан шаваас уу? Шавар шиг л юм. -Энэ шавар биш. Энэ Христийн бие. -Түүнээс юун утас гараа вэ?

-Судаснууд бөгөөд дотуур нь Христийн цус гүйж байгаа.

Энди энэ санааг бодож үзээд гайхалтай гэж шийдэв.

-Мэдлээ. Фил би чамд хайртай. Үгүй Шеф гэж хэлэх гэсэн юм. Би наашаа ирсэндээ баярлаж байна.

-Би ч бас. Чи давхимаар байна уу? Надад ойрхон машин байгаа. Гэхдээ гар салгалаад байна.

-Мэдээж гээд Энди бослоо. Дэлхий эхлээд ганхсанаа дараа нь тогтворжив.

-Хаашаа явмаар байна?

Шеф хаашаа явахыг хэлэв.

19

Жинни "Пиплз" сэтгүүлийг толгой дээрээ тавьчихсан хүлээн авахын ширээний ард унтана. Зүүдэнд нь Брэд Пит ба Анжелина Жоли нар бэлгийн хүсэл төрүүлэм нэгэн жижиг арал дээр гүйлдэх бөгөөд үйлчлэгч тэдэнд шилэн аяган дээр жижиг цаасан шүхэр зоосон ундаа авчирна. Түүнийг ямар нэг юм сэрээх үед аль хэдийн лхагва гариг болсон ба 1 цаг 35 минут болж байлаа. Нүдээ нээвэл урд нь хачин хүн зогсч байхыг харав. "ХБЭ" гэсэн бичигтэй богино ханцуйтай цамц, туранхай таазнаас нь шувтрах шахсан жийнс өмссөн, бүх үс нь тал тал тийш арзайсан, манантсан нүдтэй, өндөр туранхай эр байв. Эхлээд тэр явдаг үхдэлийн тухай хар дарж зүүдэллээ гэж бодов. Гэвч түүнээс гарах үнэрийг мэдэрлээ. Ямар ч зүүдэнд ийм дур гутам үнэр байх боломжгүй.

-Би бол Фил Буши. Би эхнэрийнхээ цогцосыг авах гэж ирлээ. Оршуулах санаатай. Хаана байгааг нь заагаад өг.

Жинни түүнтэй маргасангүй. Салахын түүс болсон тул энд байгаа бүх цогцосыг түүнд өгөх л байсан. Түрдэг тэрэгний дэргэд зогсоод Шефийг сэжигтэй харах Жиннагийн хажуугаар түүнийг дагуулан өнгөрөв. Шеф эргэж харахад бүсгүй агшиж бас хойш ухарлаа.

-Охин минь, чамд хэллоуины өмсгөл бий юу? гэж Шеф асуув.

-Тийм ээ...

-Чи хэн болж хувирах вэ?

-Глинда гэж бүсгүй шивнэв. (энэ нь Америкийн зохиолч Лаймен Баумын "Оз улсын шидтэн" номонд гардаг шидэт эмэгтэй)

-Гэхдээ би үдэшлэгт очихгүй байх. Үдэшлэг Моттонд болно.

-Би Есүс болж хувцаслана гэж Шеф хэлээд хуучин кет өмссөн бохир хий үзэгдэл Жиннийг даган алхлаа. Дараа нь инээмсэглэн эргэж хоосон нүдээр харсанаа: -Би их ууртай байх болно гэв.

Арван минутын дараа Сэммигийн цогцосыг даавуунд ороож гартаа тэвэрсэн Шеф Буши эмнэлгээс гарч ирэв. Будаг нь ховхорсон хумстай нэг нүцгэн хөл даавуунаас цухуйж савчина. Жинни хаалга нээж өглөө. Эмнэлгийн өмнө байх тойрог дээр хөдөлгүүр нь асаалттай зогсох машины жолооны ард хэн байгааг тэр анзаараагүй бөгөөд үүнд Энди баярлав. Тэр Жинни хаалга хаахыг хүлээж байгаад машинаасаа бууж Шефэд машины арын хаалгыг нээж өглөө. Хэдийгээр тэр арьс яс харагдах боловч энэ ачааг хөнгөхөн даах ажээ. Мет бас хүч тэнхээ өгдөг юм байна гэж Энди бодлоо. Харин түүний тэнхээ буурсаар байв. Гутрал эргэн ирлээ. Ядаргаа ч бас.

-Бэлэн. Явцгаая. Гэхдээ эхлээд өнөөхөө надад өг гэж Шеф дүгнэн хэлэв.

Тэр буухдаа удирдлагыг Эндид хариуцлагатай хадгалуулахаар өгсөн юм. Энди удирдлагыг буцааж өгөв.

-Оршуулгын товчоо руу юу? гэж асуув.

Шеф солиотой хүн рүү харах мэт түүн рүү харлаа.

-Эргээд радио станц руу яв. Христ ирэхдээ тийшээ ирэх юм шүү дээ.

-Хэллоуинаар уу?

-Яг зөв. Эсвэл арай эрт. Харин одоохондоо чи энэ бурхны хүүхдийг оршуулахад надад туслах болно.

-Мэдээж. Гэхдээ эхлээд дахиад жаахан татаж болох уу?

Шеф инээд алдаад Эндигийн мөрөн дээр алгадав.

-Чамд таалагдсан тийм үү? Таалагдана гэдгийг би мэдсэн

юм.

-Хойлогоос аврах эм гэж Энди санууллаа. -Яг тийм дүү минь.

Барби үүр цайхыг хүлээж бас ирж болох бүхнийг хүлээн ханзан дээр сууна. Иракт алба хаахдаа тэр үр дагаврын талаар санаа үл зовоход өөрийгөө сургасан. Хэдийгээр төгс амжилтанд хүрээгүй ч тодорхой зуршилтай болжээ. Эцсийн эцэст айдастай холбоотой хоёрхон дүрэм амьдралд байдаг. (тэр айдсыг бүрэн ялна гэдэг бол төөрөгдөлж гэсэн дүгнэлтэд хүрчээ) Тэр хүлээлтийн байдалд хэвгэхдээ өөртөө сануулав. "Би өөрийн хянаж чадахгүй зүйлийг болох ёстой мэт хүлээн авах ёстой. Би өөрийн гай тотгор бүхнийг давуу тал болгох ёстой".

Хоёр дахь дүрмээр бол тэр бүх нөөц бололцоогоо дайчлан хэрхэн ашиглаж болохоо төлөвлөнө гэсэн үг.

Барби ямартаа ч нэг нөөц бололцоог дэвсгэрт шургуулав. Тэр нь швейцарийн цэргийн хутга. Хоёрхон иртэй жижигхэн

хутга боловч хүний хоолойг хэрчихэд хангалттай. Хутга биед үлдсэн нь санаанд оромгүй аз бөгөөд тэр үүнийг мэдэж байв.

Говард Перкинс үхэж Питер Рэндолф дарга болсоноос хойш энд хуучин даргын тогтоосон бүх дотоод дүрэм журам оёдоллоороо зад татжээ. Сүүлийн дөрвөн өдөр хотыг ниргэсэн донсолгоо ямар ч цагдаагийн газрыг барьц алдуулах байсан гэж Барби бодов. Гэхдээ хэрэг үүгээр дуусахгүй. Рэндолф зөвхөн тэнэгээр зогсохгүй бас алмай амьтан болох нь тодорхой болжээ. Ямар ч хүнд сурталт нэгжид доорх хүмүүс нь удирдагчаасаа үргэлж жишээ авдаг.

Барбигийн хурууны хээ авч зургийг нь дарсан боловч царайд нь ядаргаа ба жигшил тодорсон Генри Моррисон доошоо бууж ирээд Барбигийн хорих өрөөнөөс 6 фут зайд хүрэхээргүй газар зогсох хүртэл таван цаг өнгөрчээ.

-Ямар нэг юм мартчихаа юу? гэж Барби асуув.

-Хармаагаа эргүүлж бүгдийг нь хонгил руу шид. Дараа нь өмдөө тайлж торон завсар хая гэж Генри тушаав.

-Хэрэв би үүнийг хийвэл уух юм өгөх үү? Жорлонгоос ус шүүмээргүй байна.

-Чи юу ярьж байгаа юм бэ? Жижгээ чамд ус өгсөн. Би өөрөө харсан.

-Тэр дотор нь давс хийжээ.

-Яг зөв шүү дээ гэж Генри хэлэхдээ тийм ч итгэлтэй харагдсангүй. Түүний тархины аль нэг хэсэг бодох чадвараа хадгалж байх бололтой.

-Барби миний хэлснийг хий. Биш ээ Барбара.

Тэр хармаанаасаа байгаа бүхнийг гаргав. Түрийвч, түлхүүр, зооснууд, хэдэн ширхэг нугалаастай цаасан мөнгө, азын сахиус маягаар биедээ авч явдаг ариун Христофорын тэмдэг.

-Намайг дүүжлэхээр хүзүүнд олс углах үедээ хүсвэл Барби гэж дуудаарай. Ренни тэгэх санаатай байгаа юу? Дүүжилж цаазлах уу? Эсвэл буудах баг бэлдсэн үү?

-Амаа татаад торон завсар өмдөө өг. Цамцаа бас гэж цагдаа жижиг хотын ердийн тэнэг ажилтан шиг хэлэв. Гэхдээ Моррисон тун итгэлгүй байгааг Барби анзаарав. Сайн байна. Ядахдаа эхлэл.

Хоёр шинэхэн цагдаа жаал хонгил руу бууж ирлээ. Нэг нь гартаа лаазтай "Мейс" нөгөө нь "Тазер" цахилгаан бороохой барьжээ.

-Цагдаа Моррисон тусламж хэрэгтэй юу? гэж нэг нь асуув.

-Үгүй. Гэхдээ та нар шатны дэргэд зогсоод намайг ажлаа хийж дуусах хүртэл түүнийг ажигла.

-Би хэнийг ч алаагүй гэж Барби тайван, гэхдээ гаргаж чадах дээд зэргийн шударга өнгөөр хэллээ. -Чи үүнийг мэдэж байгаа гэж би бодож байна.

Генри хувцасыг нь тэмтчих ба гэхдээ Барбиг шалдалж өгзгөө татаж харуулахыг тушаасангүй. Ийм оройтсон нэгжлэг үр дүн өгөх боломжгүй. Гэвч Моррисон ямар ч гэсэн бусад нь сэтгээгүй байхад нэгжлэг хийх шаардлагатайг санасан болохоор Барби түүнд дотроо хэдэн оноо өглөө.

Генри төнхөж дуусаад эргүүлсэн хоосон хармаатай жинсийг тор руу өшиглөв.

-Би тэмдгээ авч болох уу?

-Үгүй.

-Генри чи бодоод үз. Би яалаа гэж... -Амаа тат.

Моррисон Барбигийн хувийн эд зүйлсийг гартаа барьсаар шатны дэргэд зогсох цагдаа залуусын дэргэдүүр өнгөрөв. Залуу цагдаа нар түүнийг дагасан ч нэг нь түр саатаж Барби руу харан мушийгаад хуруугаар хоолойгоо хэрчиж үзүүлэв.

Тэр цагаас хойш ганцаараа болжээ. Ханзан дээр хэвтээд өнгөгүй шилтэй нарийн жижиг цонх руу ширтэнэ. Үүр цайхыг хүлээх ба түүнийг үнэхээр усан тамд оруулах гэж байгаа эсэхийг тааж ядна. Эсвэл Мел зүгээр л түүнийг айлгасан байж болно. Хэрэв эдгээр залуус тамлахыг оролдоод зогсохгүй баривчлах үеийнх шигээ чадмаг хөдлөх юм бол түүнийг живүүлэх нь энүүхэнд. Үүр цайтал хэн нэгэн орж ирэх болов уу гэж тэр өөрөөсөө асуув. Түлхүүр барьсан хэн нэгэн. Хэн нэгэн торонд хэтэрхий ойртож мэднэ. Түүнд хутга байгаа. Тэгэхээр зугтах боломж арай тэг биш. Эсвэл тэр Жижгээтэй азаа үзэх ёстой байсан уу? Устай аяга торон завсар сунгахад нь... Тийм ээ зөвхөн Жижгээ л зэвсгээ хэрэглэх гэж тэвчиж ядаж байгаа. Мэдээж Барби онцын амжилт хүлээх юмуу мэдэрсэнгүй. Цөхөрсөн алхам хийхэд бэлэн биш байв. Гэхдээ тэр үед бэлэн бишээ мэдэрч байсан.

Түүнээс гадна би хайчих юм бэ?

Тэр зугтаж чадаад баригдахгүй байлаа ч найз нараа аюулд оруулна. Мел ба Жижгээ нар шиг цагдаа нар тамалж байцаасны дараа тэд Бүрхүүлийг өөрт тохиолдсон асуудлуудаас хамгийн өчүүхэнд тооцох болно. Том Жим одоо мориндоо морджээ. Түүн шиг хүмүүсийг дураар тавих юм бол дөрөөн дээрээ босч зогсоод л давхина. Заримдаа морь нь багтарч унаад үхэх хүртэл давхина.

Барби бөх баг биш түгшүүртэй зүүдэнд автав. Фордын хуучин пикапын жолооны ард суух цайвар үст бүсгүй зүүдэнд орно. Бүсгүй зогсоод тэд Бүрхүүл үүсэхээс өмнө Честерс-

Миллээс хамтдаа гарч байна гэж зүүддэнэ. Бүсгүй цэцгийн хэлбэртэй хөхний даруулгаа үзүүлэхээр цамцаа тайлж байтал хэн нэгний:

-Хүүе далайн хавны эрхтэн минь сэрээрэй гэх дуу хадав.

22

Жекки энэ шөнө Эвереттийн гэрт хоносон ба хэдийгээр хүүхдүүд нам унтаж, зочдол зориулсан унтлагын ор тун тохитой байсан ч нүд хамхисангүй. Өглөөний дөрвөн цагт тэрбээр хөдөлж эхлэх хэрэгтэй гэж шийдэв. Ямар их аз үзэлт болохыг ойлгож байсан ч бас өөр нэг зүйлийг илүүтэй ойлгож байсан нь Барби цагдаагийн газрын хонгилд суугаа цагт тайван байж чадахгүй гэдгээ мэдэв. Хэрэв тэр урагшаа дөвийн гарч ямар нэгэн эсэргүүцэл зохион байгуулж чадах юмуу эсвэл хүн амины хэргийн талаар ул суурьтай мөрдлөг явуулж чадах байсан бол Жекки энэ замаар явах л байсан. Гэвч тэр өөрийгөө дэндүү сайн мэдэх болохоор ийм юм мөрөөдөөд ч хэрэггүй. Жекки Гуам ба Германд өөрийн сайн талыг харуулж согтуу цэргүүдийг баарнаас суга татаж, оргосон цэргүүдийг хайн олж, автын аваар ослын үеэр эмх журам тогтоох зэрэгт хамаг цагаа зарцуулдаг байв. Гэвч ахлагчийн цалин авдаг хүн Честерс-Миллд болж байгаа байгаа бүхнийг дийлэхгүй нь тодорхой. Цагдаагийн жинхэнэ орон тооныг ажилтан ганц эмэгтэй цагдаа хэдий ч үүнийг дийлэхгүй. Тус хотыгн эрчүүд араас нь Том Хөхт цагдаа гэж дууддаг тэр эмэгтэй. Эрчүүд Жеккийг хоч нэрээ мэдэхгүй гэж боддог ч тэр мэддэг байв. Харин одоо энэ сексизм түүний санааг огтхон ч зовоохгүй байлаа. Хотод болж байгаа дураар авирласан бүхнийг дуусгах шаардлагатай бөгөөд үүнийг дуусгах хүнээр нь ерөнхийлөгч Дейл Барбараг сонгосон. Гэхдээ дээд ерөнхий командлагчийг баярлуулах хүсэл нь Жеккиг түлхсэн юм биш. Хамгийн гол нь дайны цагийн нэгдүгээр дүрэм үйлчилсэн хэрэг. Цэрэг хүн найз нөхдөө гай зовлонд орхих ёсгүй. Ариун дүрэм.

Тиймээс хамгийн түрүүнд тэр ганцаар биш гэдгийг нь Барбид мэдүүлэх ёстой байлаа. Дараа нь үүнээс үүдээд тэр өөрөө үйлдлээ төлөвлөж чадна.

Шөнийн халагтай Линда өглөөний таван цагт доошоо бууж ирэхэд цонхны цаана үүрийн гэгээ дөнгөж хаяарч эхлээд хөшсөн мод бутасыг нүдний өмнө гэрэлтүүлэв. Салхи өчүүхэн төдий ч үлээж үл мэдрэгдэнэ.

-Надад хуванцар сав хэрэгтэй. Аяга хэлбэртэй байвал зүгээр. Нэг их том биш, гэхдээ тунгалаг биш. Чамд иймэрхүү юм байна уу? гэж Жекки түүнд хандлаа.

-Мэдээж байгаа. Гэхдээ чи яах нь вэ?

Яагаад гэвэл бид Дейл Барбарад өглөөний цай хүргэж өгөх болно. Эрдэнэ шишийн нэвс. Харин ёроолд нь зурвас хийе.

-Жекки чи юу яриад байна вэ? Би ийм юм хийж чадахгүй. Надад хүүхдүүд бий.

-Мэдэж байна. Гэвч би чамгүйгээр үүнийг хийж чадахгүй. Яагаад гэвэл намайг ганцаараа доош буухыг зөвшөөрөхгүй. Хэрэв би эрэгтэй байсан бол зөвшөөрөх байсан байх. Гэвч надад эрчүүдийн өнөөх нь байхгүй. Ийм юмтай намайг зөвшөөрөхгүй шүү дээ гээд хөх рүүгээ заав.

-Чи надад хэрэгтэй.

-Юун зурвас?

-Би маргааш орой түүнийг тэндээс гаргах санаатай байна. Хотын хурал болох үеэр. Тэр үед чи хэрэггүй... гэж Жекки тайван ярих боловч тайван бус байгаа нь илт мэдрэгдэнэ.

-Чи намайг ийм юманд оролцохыг ятгаж чадахгүй гэж Линда хэлэв.

-Биттий сүржигнээд бай. Би Ромео Берпигийн тухай бодож байна... Хэрэв Барби Брендаг алаагүй гэдэгт түүнийг итгүүлж чадах юм бол. Бид цанын малгайн дээр нүдний нүх гаргаж нүүрээ битүүлэн өмсөх болохоор биднийг хэн ч танихгүй. Хэн ч бас гайхахгүй. Энэ хотын бүх хүмүүс Барбид хамтрагчид байгаа гэж боддог учир.

-Чи солиорчээ.

-Үгүй шүү. Хурлын үеэр цагдаагийн газарт гурав дөрөвхөн хүн үлдэнэ. Хоёр ч байж мэднэ. Би үүнд итгэлтэй байна. -Харин би итгэлгүй байна.

-Гэвч маргааш орой болтол хол байна. Тэр хүртэл мань хүн тэднийг хуурах хэрэгтэй. Харин одоо надад саваа өг. -Жекки би үүнийг хийж чадахгүй.

-Үгүй чадна гэх дуу гарахад "Шинэ Английн эх орончид" гэсэн бичээстэй цамц ба гэрийн дотуур өмд өмссөн Расти хаалга дээр зогсч байв. -Хүүхэд байсан эсэх хамаагүйгээр азаа үзэх цаг болсон. Бид өөрөө өөртөө найдах л үлддээ. Реннийг зогсоох хэрэгтэй.

Линда доод уруулаа хазлан хэсэг хугацаанд түүн рүү ширтэв. Дараа нь нэг шүүгээ рүү тонгойлоо.

-Хуванцар савнууд энд байдаг юм.

Тэднийг цагдаагийн газарт орж ирэхэд жижүүрийн ширээн дээр хүнгүй байв. Фредди Дентон бага зэрэг унтахаар гэр рүүгээ явжээ. Гэвч жижүүрийн хэсэгт олон залуучууд байх ба кофе ууж чалчицгаана. Тэдний олонхи нь өглөө эрт сэргэг байгаадаа аз жаргалтай байх бөгөөд уг нь бол энэ үед унтацгааж байдаг билээ. Тэдний дунд Кильян овогт олон тооны ах дүүсээс хоёр нь байхыг Жекки олж харлаа. Бас "Дипперс"-т байнга төвөг тарьж явдаг мотоцикл унаж давхих хоббитой бүсгүй Конри болоод Картер нар байв. Бусдынх нь нэрийг тэр мэдэхгүй боловч жижиг сажиг танхайн хэргээр цагдаагийн газарт нэг бус удаа ирж байсан ахлах сургуулийн архаг хоёр хичээл таслагчийг танив. Энэ хамгийн шинэхэн "цагдаа нар"-т дүрэмт хувцас ч үгүй ажээ. Цагдаагийн газарт харъяалагдаж байгааг нь гартаа зүүсэн цэнхэр өнгийн даавуу л батлана.

Тэгсэн мөртлөө бүгд зэвсэглэжээ.

-Та хоёр яагаад ийм эрт ирдэг билээ? Надад бол шалтгаан байна. Өвчин намдаах эм маань

дуучихсан гэж Картер Тибодо тэдэн дээр ирэнгээ асуув.

Үлдсэн хэд нь чөтгөр шиг орилолдоно.

-Барбарад өглөөний цай авчирсан юм гэж Жекки Линдагийн нүүр рүү харахаас айн хэлэв. Түүний царайд хамаг юм тодрох вий хэмээн айна.

Картер гялгар сав руу шагайв.

-Сүү байхгүй юу?

-Түүнд сүү хэрэг болохгүй. Би өөрөө норгоод өгнө гэж Жекки хэлээд эрдэнэ шишийн нэвс рүү нулимлаа.

Дахиад бүгд баяртайгаар орилолдов. Зарим нь алгаа ташина.

Жекки Линда хоёр шатан дээр хүрч явгал Картерийн дуу тэднийг зогсоов.

-Алив нааш нь өг.

Жекки тэр дороо хөшлөө. Гялгар саваа Картер руу чулуудаад ухасхийн гүйж байгаа дүр нүдэнд нь үзэгдэв. Гэхдээ түүнийг ганцхан юм зогсоосон нь хаашаа ч зугтах газаргүй болсон явдал юм. Тэр хоёр цагдаагийн газраас мултарч гарлаа ч гэсэн сайндаа цэргийн дурсгалын хажууд гүйцэгдэх байсан.

Линда Жеккигийн гараас савыг авч Картерт сунгав. Өнөөх нь гялгар сав руу тонгойв. Гэтэл нэвс дотор гараа оруулж ямар нэг хориотой зүйл эрж хайхын оронд нулимлаа.

-Миний хувь нэмэр.

-Алив байзаарай гэж улаан үстэй, хацар нь батгаар дүүрсэн, загвар өмсөгч шиг бие хаатай Конри хашгирав. Тэр охин хамартаа хуруугаа чихсэн тул гуншиж ярина. -Надад ч бас түүнд дамжуулах юм байна гээд том, нус наалдсан хуруугаа үзүүлэв. Дараа нь Конри нусыг нэвс рүү нясаллаа.

Дахиад бүгд алга ташицгааж хэн нэг нь хашгирав.

-Лори ногоон алт нэмж хийлээ.

-Нэвсний хайрцаг болгонд гэнэтийн бэлэг байх ёстой гэж Лори инээгээд бүснээс нь унжсан 45 калибрийн гар бууны бариул дээр гараа тохов. Энэ шумуул шиг хөнгөхөн охин буудлаа гэхэд бууныхаа тийрэлтэнд тэрийн унах байх даа гэж Жекки бодов.

-Сайн байна. Би ч бас та хоёртой хамт явна аа гэж Картер толгой дохилоо.

-Тэгээч гэж Линда хариулсан ч дотор нь хүйтрээд явчихав. Тэр сүүлчийн мөчид зурвасыг Барбид өөрөө өгөх санаатай хармаалах шахсан билээ. Ухаангүй азаа үзэж байна даа гэж дахин

бодов. Гэвч одоо ухрах аргагүй болжээ.

-Гэхдээ чи шатны дэргэд үлдээрэй. Харин Линда чи холхон бай. Аз туршихгүй байсан нь дээр.

Картер дургүйцэх вий гэж тэр айсан ч ийм юм болсонгүй.

24

Барби сууж байлаа. Торны нөгөө талд гартаа цагаан өнгийн хуванцар сав барьсан Жекки Уэттингтон зогсоно. Түүний ард Линда Эверетт хоёр гараар буугаа атган зогсох бөгөөд гэхдээ бууны амыг шал руу чиглүүлжээ. Унтаж босоод арзайсан үстэй, цэнхэр өнгийн дүрэмт цамцных нь энгэр задарсан Картер Тибодо шатны хажууд зогсож байв. Тэр тэнд зогсож байгаа болохоор Барбид нохойд хазуулсан газарт тавьсан боолтын нэг хэсэг л харагдана. - Цагдаа Жекки сайн уу?

Нарийн цонхоор өглөөний бүдэг гэрэл гэтнэ. Ийм гэрэлд амьдрал гэдэг байж болох бүх наргианаас хамгийн оновчтой нь мэт санагддаг.

-Би ямар ч буруугүй. Гэхдээ намайг ямар нэг хэрэгт буруутгасан гэж хэлж ч болохгүй байна. Яагаад гэвэл намайг...

-Амаа тат. Чиний яриаг сонирхох хүн алга гэж Линда яриаг нь таслав.

-Цайвар үст залуу минь ярь ярь. Харин бүсгүй чи оч гэж Картер эвшээн хэлээд боолт орчмын арьсаа маажина.

-Суусан газраа суу. Хуруугаа ч бүү хөдөлгө гэж Жекки санууллаа.

Барби байрандаа хөшив. Жекки торны завсар саваа шургууллаа. Жижигхэн сав торон завсар яг тааран оров.

Барби урагш тонгойгоод савыг авлаа. "Спешл К" нэвсээр дүүргэсэн байх шиг. Гэвч дээр нь шүлс гялалзана. Бас нэг том юм байна. Цусны хольцтой нойтон том нус. Гэвч ходоод нь хоржигнож байлаа. Идэхийг маш их хүснэ.

Гэвч Барби үүний хажуугаар зүрх нь шимшрэхийг мэдрэв. Жекки бусдаас өөр гэж тэр бодож байсан юмсан. (энэ эмэгтэйн биеэ авч явах байдал ба үс засалтаар нь цэрэгт алба хаасныг Барби анх хараад л мэдсэн). Генри Моррисоны ой гутахыг тэр тэвчиж чадна. Харин энэ удаад маш их урам хугарав. Нөгөө нэг эмэгтэй цагдаа болох Растигийн эхнэр хортон шавьжийн ховор төрөл зүйлийг шинжих мэт түүн рүү харна. Цагдаагийн хуучин албан хаагчдаас ядаж хэн нэг нь гэж тэр найдсан юмсан...

-Ид гэж шатны хажууд зогсох Картер хашгирав. -Бид чамд тун сайхан цай бэлдсэн. Тийм биш гэж үү охид оо?

-Тийм ээ, гэж Линда толгой дохив. Түүний амны хоёр булан доошоо унжжээ.

Энэ нэг л биш. Барбигийн сэтгэл хөнгөрөөд ирэв. Линда дайсагнаж байгаа дүр исгэж байсан бололтой. Гэхдээ тэр өөрөө хэт их юманд найдаж байгаа биш биз? Гэвч...

Линда Картерт Жеккиг харах боломжгүй болгох санаатай хажуу тийш бага зэрэг хөдөллөө. Уг нь ингэж хөдлөх шаардлага байгаагүй. Учир нь Картер боолтон дороосоо ямар нэг юм сугалах гэж оролдож байв.

Жекки эргэж хараад Картер түүнийг харахгүй байгааг мэдмэгцээ сав руу заав. Гараа жаахан өргөөд хөмсөгөө хөдөлгөн заав. Уучлаарай гэх мэт. Дараа нь хоёр хуруугаа Барби руу чиглүүлсэн нь анхааралтай байгаарай гэсэн үг.

Барби толгой дохилоо.

-Далайн хавны эрхтэн минь. Өглөөний цайнаасаа таашаал аваарай. Үдийн хоолонд чинь арай дээр юм авчирна. Шээсбургер гэж бодож байна.

Картер боолттойгоо зууралдангаа янцгаах мэт инээв.

-Хэрэв тэр үед чамд хоол идэх шүд үлдвэл гэж Линда нэмлээ.

Тэр дуугүй байсан нь дээр юм гэж Барби бодов. Түүний хоолойнд хорсол занал юмуу тамлах хүслийн өнгө огт илэрсэнгүй. Зөвхөн айдас. Энэ эмэгтэй энд л биш бол хаана ч хамаагүй очихыг хүсч байна. Гэхдээ Картер юу ч анзаарсангүй. Тэр өөрийнхөө мөртэй ноцолдоод завгүй байлаа.

-Явцгаая. Түүний идэхийг харах хүсэл алга гээд Жекки эргэлээ.

-Хангалттай норгосон байна уу? гэж Картер асуув. Эмэгтэйчүүд түүн дээр ирлээ. Линда буугаа хуйнд шургуулав. -Яагаад гэвэл хэрэв үгүй бол би чадна шүү... гэж Картер үглэв.

-Хангалттай гэж Барби хариуллаа.

-За тэгвэл сайн. Удахгүй уулзъя.

Тэд шатаар өгслөө. Картер хамгийн ард явах бөгөөд Жеккигийн бөгс рүү алгадахгүй байж чадсангүй. Өнөөх нь инээгээд гар руу нь тоглоом шоглоомоор цохив. Их сайн жүжиглэж байлаа. Тэр ер нь Линдагаас хавьгүй илүү байна. Гэвч тэд хоёулаа жинхэнэ эрэлхэг зориг гаргасан юм. Хүндэтгэх гавьяатай эрэлхэг зориг.

Барби нусыг авч урд нь шээс асгасан булан руу шидлээ. Гараа цамцандаа арчив. Дараа нь нэвсийг ухлаа. Ёроолд нь зурвас байхыг олов.

"Маргааш орой болтол тэсч тэвчихийг хичээ. Хэрэв бид чамайг гаргаж чадлаа гэхэд очих аюулгүй газраа бодоорой. Энэ зурвасыг яах ёстойг чи мэднэ"

Барби мэднэ.

Барби эхлээд зурвасыг дараа нь нэвсийг идсэнээс нэг цагийн дараа шатан дээр хүнд алхаа сонсогдов. Бүрхүүл доорх захиргаадалтын ээлжит өдөртөө бэлдсэн Том Жим Ренни костюм өмсч зангиа зүүчихсэн ирэв. Түүний араас Картер ба толгойн хэлбэрээс нь харвал Кильянуудын нэг бололтой шинэ цагдаа алхана. Шинэ цагдаа сандал барьж явах ба үүнийг ч тун муу хийж байна. Тэр усан тэнэг болох нь илт.

Доор ирээд Кильян сандалаа Картерт дамжуулахад өнөөх нь хонгилын төгсгөлийн хорих өрөөний урд аваачиж тавив. Ренни өмдөндөө өвдөг гаргахгүйн тулд шууж татаад сандалд залрав.

-Өглөөний мэнд ноён Барбара гэх түүний ёс гүйцэтгэсэн мэндчилгээнд сэтгэл ханамжтай байдал илэрнэ. Барби асуултаар хариу барив.

-Хотын захиргааны гишүүн Ренни таны төлөө би нэр ус цол ба армийн адилтгасан дугаараа хэлэхээс өөр юу хийж чадах билээ. Гэхдээ би дугаараа санахгүй байна л даа.

-Хэрэгээ хүлээ. Биднийг дараанаас салгаж өөрийнхөө сэтгэлийг ч амраа.

-Өчигдөр Мел Сирлс усан тамлалтын тухай үг унагана билээ. Иракт ийм юм үзсэн үү гэж асууж байсан.

Реннигийн ам хөнгөн инээмсэглэл тодруулан мурийв. "Надад дахиад өөр юм хэл. Ярьдаг амьтан тун сонин байна" гэх мэт.

-Хэрэв түүндээ хүрэх юм бол би үзсэн л дээ. Тэнд хэр ойр ойрхон хэрэглэдэгийг би мэдэхгүй. Янз бүрийн л тоо байдаг. Гэхдээ би хоёр ч удаа үзсэн. Нэг эрэгтэй хүн хэргээ хүлээсэн юмдаг. Гэхдээ түүний мэдүүлэг ямар ч ашиггүй байсан. Түүний заасан хүн нь "Аль-Каида"-гийн бөмбөг бэлдээгүй юм билээ. 14 сарын өмнө Иракаас Кувейт рүү явчигсан сургуулийн багш байсан. Харин хоёр дахь хүн нь таталт өгөөд тархинд эргэлт буцалтгүй гэмтэл учирсан болохоор ямар ч мэдүүлэг өгч чадаагүй. Гэхдээ тэр хүнд бол хүлээх хэрэг байсан бөгөөд хүлээх л байсан гэдэгт би итгэлтэй байна. Усан там амссан бүх хүн хэргээ хүлээдэг. Ялангуяа хэдэн минутын турш оруулбал. Би ч бас мэдүүлэг өгнө гэдэгтээ эргэлзэхгүй байна.

-Тэгээд өөрийгөө илүү тамлалтаас ангижруулаач дээ гэж Том Жим санал тавив.

-Ноён та их ядарсан харагдаж байна. Эрүүл биш юм уу?

Хөнгөн инээмсэглэл арилж Том Жим хөмсөг зангидлаа. Хоёр хөмсөг нь нийлэхэд дундуур нь гүнзгий үрчлээс үүсэв.

-Миний эрүүл мэндийн байдал чамд хамаагүй. Ноён Барбара танд би зөвлөгөө өгөх байна. Намайг битгий оролд. Тэгвэл би чамайг оролдохгүй. Чи яагаад өөрийнхөө эрүүл мэндэд санаа тавьж болохгүй гэж. Одоо тэр тун сайн байж мэднэ. Гэвч бүх юм өөрчлөгдөж болно.

Хэдхэн минутын дотор. Тэгэхээр би үнэхээр усан тамлалын тухай бодож байсныг чи харж байна. Түүгээр зогсохгүй хэрэглэх боломжийг нухацтай авч үзсэн. Тийм болохоор хүн амины хэргүүдээ хүлээ. Чамд ингэж их өвдөх ямар хэрэг байгаа юм бэ?

-Надад хүлээх хэрэг байхгүй. Хэрэв та намайг усан тамд оруулах юм бол би олон юм ярьж мэднэ. Тэгэхээр та үүнийг шийдэх үедээ дэргэд хэн байж миний үгийг сонсож болох тал дээр бодоорой.

Ренни бодолд автав. Хэдийгээр тэр ийм өглөө эрт гэхэд тун цовоо байсан ч нүүрний өнгө газар шиг болж, нүдний эргэн тойронд хөх ягаан туяа татсан нь эрүүл мэнд муу байгааг илтгэнэ. Хэрэв Том Жим яг одоо үхлээ гэхэд Барби үйл явдал өрнөх хоёр таамгийг харж байна. Нэгдүгээрт Миллийн улс төрийн шуурга намжиж шинэ хар шуурга дэгдэлгүй өнгөрнө. Хоёрдугаарт цуст нядалгаа эхэлнэ. Хамгийн түрүүнд Барбиг буудахгүйгээр цаазлаад дараа нь болзошгүй хамсаатнуудыг барьж авна. Жагсаалтыг Жулия тэргүүлнэ. Хоёрдугаарт Роуз бичигдэнэ. Гол хорон санаатантай харьцсан бүх хүмүүс буруутай гэдэгт айсан хүмүүс итгэнэ.

Ренни Картер руу эргэв.

-Картер холд. Шатан дээр оч.

-Гэвч тэр таныг барьж авах гэж оролдвол...

-Тэгвэл чи түүнийг ална. Энэ өөрөө мэдэж байгаа. Тийм биз дээ, ноён Барбара?

Барби толгой дохив.

-Түүнээс гадна би ойрхон очих бодолгүй байна. Тийм ч учир чамайг холдохыг хүссэн юм. Бидэнд хувийн яриа байна. Картер холдлоо.

-Харин одоо ноён Барбара... Чи юуны тухай ярьж чадах юм бэ?

-Би мет үйлдвэрлэх лабораторийн тухай бүхнийг мэднэ гэж Барби дуугаа намсган хэлэв. - Перкинс дарга мэдэж

байсан бөгөөд таныг баривчлах гэж байсан. Бренда түүний компьютерт энэ тухай файлийг олсон. Тэгээд та түүнийг алсан. Ренни инээмсэглэв.

-Энэ бүхэн их санааны хоосон мөрөөдөл.

-Муж улсын ерөнхий прокурор таны сэдлийг тооцож үзээд ингэж бодохгүй байгаа. Бид өөрийн хэрэгцээнд зориулж ямар нэгэн дугуйтай байшинд бэлддэг өчүүхэн юмны тухай яриагүй. Бид аж үйлдвэрийн хэмжээний үйлдвэрлэлийн талаар ярьж байна.

-Өнөө орой гэхэд Перкинсийн компьютер устсан байх болно гэж Ренни хэлэв. -Брендагийн компьютер бас. Ямар нэг бичиг баримтын хуулбар Перкинсын гэрт төмөр хайрцагт байгаа гэж би таамаглаж байна. Мэдээж ямар нэг утгагүй хуулбар. Хуурамч, улс төрийн зорилготой гүжирдлэг, намайг үзэн яддаг хүний зохиосон... За яахав, төмөр хайрцагийг нээнэ.

Цааснуудыг шатаана. Миний төлөө биш, хотын сайн сайхны төлөө. Манай хотод хямралын нөхцөл байдал үүссэн. Бид бүгд нягтрах ёстой.

-Бренда үхэхээсээ өмнө энэ файлыг хэвлэж өгсөн.

Том Жим хоёр эгнээ жижиг пгүднүүдээ харуулан инээлээ.

-Нэг уран сэтгэмж, нөгөөгөө төрүүлэх юм даа ноён Барбара. Би ч бас уран сэтгэмжлээд үзэх үү?

Барби тэгээ ч дээ гэх шиг гараа дэлгэв.

-Миний уран сэтгэмжээр бол Бренда энэ тухай хэлэхээр над дээр ирж байна. Тэр чиний яриад байгаа хуулбарыг Жулия Шамуэйд өгсөн гэж хэлнэ. Гэвч энэ худлаа гэдгийг би мэдэж байна. Тэр тэгэх санаатай байсан ч өгч чадаагүй. Хэрэв өгсөн байлаа ч... Ренни мөрөө хавчив. -Чиний хамтран зүтгэгчид өчигдөр шөнө Шамуэйгийн сонины редакцийг шатаачихсан. Тэдний зүгээс энэ их муу шийдвэр. Эсвэл санааг нь чи гаргасан юм уу?

Барби давган хэлэв.

-Бас нэг хуулбар бий. Хаана байгааг нь би мэднэ. Хэрэв та намайг усан тамд оруулах юм бол би бичиг баримт байгаа газрыг зааж өгнө. Чангаар.

Ренни инээлээ.

-Тун пгударга хэллээ пгүү ноён Барбара. Гэвч би улс төр ба худалдаанд бүх насаа зориулсан болохоор худдаа ярьж байгааг сонсоод л мэддэг. Бодоод байхад чамайг зүгээр буудчихсан нь дээр юм байна. Хот баярлах болно.

-Хэрэв та миний хамсаатнуудын нэрийг тодруулалгүй үүнийг хийчихвэл хот хэр чанга баярлах бол. Тэр бүү хэл Питер Рэндолф ч энэ шийдвэрт эргэлзэж мэднэ. Гэтэл тэр ердийн нэг тэнэг хулчгар бөгс долоогч шүү дээ.

Том Жим бослоо. Унжсан хацар нь хуучин тоосгоны өнгөтэй болов.

-Чи хэнтэй зууралдсанаа мэдэхгүй байна.

-Мэдээж мэднэ. Тан шиг юмнуудыг Иракт үзэж л байлаа. Тэд зангианы оронд тоорцог өмсдөг юм. Бусад талаар танаас ямар ч ялгаагүй. Цаг үргэлж бурхны нэр дурьдах нь хүртэл адилхан.

-За яахав чи намайг усан там явуулахаас ятгаж болиулж чадлаа гээд Том Жим толгой сэгсрэв. -Мэдээж харамсалтай байна. Амьдаар нь үзэх гэж их хүссэн юмсан.

-Дуртайяа иттэж байна.

-Одоохондоо бид чамайг энэ тохилог өрөөнд орхиж байна тийм үү? Чамайг ойрхон хооллоно гэж би бодохгүй байна. Яагаад гэвэл цатгалан хүн муу боддог. Хэн мэдэх билээ. Тархиа

төнхөж үзээд чи намайг өөрийгөө амьд үлдээхэд хүргэх хүндтэй шалтгаан олох ч юм билүү. Жишээ нь миний найз биш харин дайсан болох хүмүүсийг нэрлэх гэх мэт. Бүрэн жагсаалт шүү. Би чамд 48 цагийн хугацаа өгье. Энэ хугацаа дуусахад чамгүйгээр би яаж ч чадахгүй гэдэгт намайг итгүүлж чадахгүй бол бид чамайг цэргийн дурсгалын талбай дээр бүх хотын нүдэн дээр буудна. Чиний үхэл үзүүлэх хичээл болог.

-Хотын захиргааны гишүүн та үнэхээр сайнгүй харагдаж байна.

Ренни түүн рүү нүд үл салган ширтлээ.

-Яг чам шиг юмнуудаас болж энэ хорвоод асуудал үүсдэг юм. Хэрэв чамайг олны нүдэн дээр цаазлах нь хотыг нэгтгэх ба муу бүхнээс цэвэрлэхэд сургамж болно гэж би бодоогүй бол ноён Картерт чамайг яг одоо буудах тушаал өгөх байсан.

-Тушаагаач дээ. Бүх юм ил гарна. Хотын бүх хүмүүс мет үйлдвэрлэлийн тухай мэдэж авна. Дараа нь та новшийн жижигхэн хотонцорынхоо хурал дээр зөвшилцөлд хүрэх гэж оролдоод үзээрэй. Өөртөө дурласан муу мангас.

Том Жимийн хүзүү болоод духан дээр бүдүүн судас гүрийв. Тэр яг одоо дэлбэрэх мэт санагдсан ч инээмсэглэлээр дуусгалаа.

-Хичээсний чинь төлөө онц тавья ноён Барбара. Гэвч чи

худлаа ярьж байна.

Тэр яваад өглөө. Тэд бүгд явцгаав. Бүх биеэр нь хөлс цутгасан Барбара ханзан дээр суулаа. Тэр ангалын ирмэгт хичнээн ойрхон очсоноо мэдэж байв. Реннид түүнийг амьд байлгах шалтгаан байсан ч тэр нь тийм ч их жинтэй биш. Түүнээс гадна Барби Жекки ба Линда нарын өгсөн зурвасыг санаж байлаа. Линдагийн царай төрхөнд тэр эмэгтэйд айх үндэслэл, зөвхөн өөрийнхөө төлөө ч биш, айх үндэслэл хангалттай гэдгийг мэдэж байгаа нь илт. Тэгэхээр хутгаа ашиглан зугатах оролдлого хийх нь түүний хувьд аюул багатай ажээ. Честерс-Милл хотын цагдаагийн газрын одоогийн мэргэшлийн түвшинг тооцох юм бол энэ нь тийм найдваргүй зам биш гэдгийг Барби мэдэж байв. Тийм ээ, түүнд аз хэрэгтэй. Гэхдээ бүх юм болчихож мэднэ. Гэвч тэр шоронгоос бие даан гарах оролдлого хийх гэж байгаа тухайгаа Жекки Линда нарт мэдээлж чадахгүй.

Барби гараа дэрлэн хэвтлээ. Бусдаас илүүтэй нэг л асуулт түүнийг зовооно. Жулияд зориулсан "Вейдер" хавгасны хэвлэсэн файл яасан юм бол? Яагаад гэвэл энэ баримт Жулияд хүрсэнгүй. Энэ тал дээр Ренни үнэнийг хэлсэн гэдэгт Барби үл эргэлзэнэ.

Нэгэнт мэдэж яагаад ч чадахгүй хойно хүлээх л үлджээ. Дээш харан тааз ширтэн хэвтэнгээ Барби хүлээж байлаа.

"Сүйрсэн хамтлагийн энэ дууг тоглооч"

1

Линда Жекки хоёрыг цагдаагийн газраас буцаж ирэхэд Расти тэднийг хүлээн довжоон дээр охидтойгоо сууж байв. Эгч дүүс унтлагын цамцаа тайлаагүй байх бөгөөд уг нь жилийн энэ улиралд үслэг бөс цамц өмсдөг байтал тэд хөвөн даавуун цамцтайгаа байна. Хэдийгээр долоон цаг ч болоогүй атал гал тогооны цонхонд өлгөсөн халуун хэмжигч 30 хэмийг заана.

Ээжийгээ угтаж гүйхдээ уг нь охид Растиг хол хаядаг билээ. Харин энэ удаад тэр охидоос хэдэн ярд түрүүлэн гүйв. Линдаг бүсэлхийгээр нь тэврэхэд тэр нөхрийнхөө хүзүүнээс мэндлэх биш харин живж байгаа хүн шиг л зүүгдэв.

-Чи зүгээр үү? гэж эхнэрийнхээ чихэнд шивнэн асуулаа.

Бүсгүйн үс түүний хацрыг эхлээд доош нь, дараа нь дээш илсэн нь толгой дохисоны шинж. Тэгээд толгой холдов. Түүний нүд гялалзаж байлаа.

-Картер нэвсийг ухаж эхэлнэ гэдэгт би эргэлзээгүй. Гэтэл Жекки нэвс рүү нулимаж санааг бодож олсон. Суут санаа. Тэгэхдээ би бас л...

-Ээж яагаад уйлаад байна вэ? гэж Жүди өөрөө уйлах шахан асуув.

-Би уйлаагүй. Үгүй бага зэрэг. Би та нарыг бас аавыг чинь харж байгаадаа баярлаад л гэж хэлээд Линда нүдээ арчлаа.

-Бид бүгд түүнийг харахдаа баяртай байдаг. Яагаад гэвэл миний аав гол хүн нь гэж Жани Жеккид хэлэв.

-Энэ чинь шинэ мэдээ байна гээд Расти Линдагийн уруул дээр чанга үнслээ.

-Уруулын үнсэлт гэж Жанни дуу алдав. Жүди нүдээ дараад инээлээ.

-Алив охидоо савлуур руу явцгаая. Дараа нь сургуулийнхаа хувцасыг өмсөнө гэж Жекки санал болгов.

-Би савлуурдахыг хүсч байна гээд Жанни түрүүлж гүйлээ.

-Сургууль гэсэн үү? үнэн үү? гэж Расти асуув. Линда түүнд:

-Үнэн. Гэхдээ бага сургуулийн хичээл багачуудад зориулан Дорнод гудамжинд болох юм. Үдээс өмнө. Уэнди Голдстоун ба Эллен Вейндестин нар хичээл явуулахаар болсон. Нэг нь нэгээс гуравдугаар ангийг, нөгөө нь 4-6 дугаар ангийг даана.

Жинхэнэ хичээл гэж бодохгүй байна. Гэхдээ л хүүхдүүд хааяа нэг тийш явж амьдралын дассан хэв маягтаа эргэж очих болно гээд тэр шар туяатай үүлгүй тэнгэрийг харав. "Яг цэгээ

унасан цэнхэр нүд шиг" гэж Линда бодов. -Би ч бас дассан юмаа хийвэл сайн юмсан. Энэ тэнгэрийг хар даа.

Расти тэнгэр рүү хяламхийн харсанаа эхнэрээсээ сунгасан гарын зайтай холдож сайтар ажиглав.

-Та хоёр мултарчихсан уу? Чи итгэлтэй байна уу?

-Тийм ээ, гэхдээ галзуурахад ганц хуруу дутуу байсан. Тагнуултай кинон дээр ийм юм наргиантай харагддаг. Гэтэл бодит амьдралд үнэхээр хэцүү юм билээ. Би түүнийг тэндээс гаргаж чадахгүй хонгор минь. Охидоо бодож байна.

-Дарангуйлагчид дандаа хүүхдээр барьцаалдаг юм. Гэвч хүмүүс ийм арга үйлчлэхгүй гэдгийг хэзээ нэгэн цагт ойлгох ёстой.

-Гэвч би үүнийг одоо энд шалгахыг хүсэхгүй байна. Санааг Жекки гаргасан болохоор өөрөө хэрэгжүүлэг. Би үүнд оролцохгүй. Чамайг ч оролцохыг зөвшөөрөхгүй.

Харин Расти эхнэр нь бүгдийг түүний хэлснээр хийнэ гэдгийг мэдэж байлаа. Царайн дээр нь бичээстэй байв. Тийм болоод л хүүхдүүд түүнийг гол хүн гэж тооцдог. Гэвч яг одоо бол тэр гол хүн байхыг үл хүснэ.

-Чи ажилдаа явах уу?

-Мэдээж. Хүүхдүүд Марта дээр очно. Марта тэднийг сургуульд хүргэнэ. Линда Жекки хоёр Бүрхүүл дор дахин нэг өдрийг ажиллаж өнгөрөөхөөр цагдаагийн хэсэгт очно. Тэгэхгүй бол бидэн рүү хялайх болно. Энэ бүхэн надад огт таалагдахгүй байна гээд Линда дуу шуутай санаа алдав. -Тэгээд ч би ядарч байна гээд хүүхдүүд нь сонсоогүй гэдэгт итгэхээр эргэн тойрноо харлаа.

-Чөтгөр авмаар багтарч ядарлаа. Шөнө бараг нүд хамхисангүй. Харин чи эмнэлэг рүүгээ явах уу?

Расти толгой сэгсрэв.

-Жинни Дуги хоёр үд хүртэл надгүй ажиллах хэрэг болжээ... Ядахдаа бидэнд тусалж байгаа шинэ эртэй хамтдаа дийлнэ гэж бодож байна. Маршалл бол Шинэ эринд татагддаг хүмүүсийн нэг боловч ажлаа мэддэг юм билээ. Би Клер Макклэтчи руу явлаа. Би хүүхдүүдтэй ярилцаж Гейгерийн тоолуурын бүртгэсэн радио идэвхижлийн эх сурвалж хаана байгааг тодруулах болно.

-Хүмүүс чиний хаана байгааг асуувал би юу хэлэх юм бэ? Расти бодлогоширов.

-Үнэнийг хэлсэн нь дээр байх. Ядахдаа хэсэгчилэн. Намайг Бүрхүүл үүсгэж байж болзошгүй үүсгүүрийн эрэлд гарсан гэж хэл. Энэ нь зорьсон дараагийн алхамаа хийхийн өмнө Ренниг хоёр дахин бодоход хүргэнэ.

-Яг хаашаа явсныг асуувал яах вэ? Асууж л таарна пгүү

дээ.

-Мэдэхгүй гэж хэлээрэй. Гэхдээ хотын баруун зүгт байх аа гээрэй.

-Блэк-Ридж хойд зүгт байдаг.

-Тийм л дээ. Гэхдээ Ренни Рэндолфод хэлж цагдаа нарын нэгийг миний араас явуулах юм бол тэд миний байгаа газраас өөр тийшээ яваасай гэж би хүсч байна. Хэрэв дараа нь хэн нэгэн чамд энэ тухай хэлэх юм бол их ядарсан болохоор хольж хутгасан гээрэй. Хонгорхон минь, чи цагдаагийн газар руу явахаасаа өмнө Барбиг хүн амины хэрэгт буруугүй гэдэгт итгэх хүмүүсийн нэрсийн жагсаалт гаргаарай. Бид маргаашийн хотын хурлаас өмнө тэдэнтэй ярилцах хэрэгтэй. Анхаарал таталгүйгээр гэж хэлээд дотроо "Бид ба тэд" гэж дахин бодов.

-Расти чи үүндээ итгэлтэй байна уу? Яагаад гэвэл өчигдөр шөнийн түймрээс хойш хот тэр чигээрээ Дейл Барбарагийн найз нөхдийг эрж хайх өнгө аястай болчихсон.

-Би итгэлтэй байна уу гэж үү? Тийм. Надад энэ бүхэн таалагдаж байна уу? Огт үгүй.

Линда шар туяатай тэнгэр рүү дахин нэг хараад дараа нь байшингийн өмнөх нугад ургасан хоёр царс модыг харав. Навчис нь унжиж огт үл хөдлөх бөгөөд ногоон биш хүрэн өнгөтэй болжээ. Тэр санаа алдав.

-Хэрэв Ренни Барбарагийн эсрэг эд мөрийн баримт хуурамчаар бүрдүүлсэн бол тэр л сонины редакцийг шатаасан байж таарна. Чи үүнийг мэдэж байгаа тийм үү?

-Мэднэ.

-Хэрэв Жекки Барбараг шоронгоос сугаллаа гэхэд хаана нуух юм бэ? Хотод аюулгүй газар байгаа юу? -Энэ тухай бодох хэрэгтэй.

-Хэрэв чи үүсгүүрийг олоод салгаж чадах юм бол энэ бүх тагнуулын ажиллагаа хэрэггүй болно доо. -Бүх юм ийм болоосой гэж залбирцгаая.

-Тэгнэ ээ. Харин радио идэвхижил яах вэ? Чи цус багадах өвчин юмуу өөр ямар нэг өвчтэй болчихсон эргэж ирээсэй гэж би хүсэхгүй байна.

-Энэ тал дээр надад санаа бий.

-Би асууж болох уу?

Расти инээмсэглэв.

-За хэрэггүй дээ. Дэндүү солиотой санаа.

Линда түүний хуруунуудын завсар өөрийн хурууг хийлээ.

-Болгоомжтой байгаарай.

Тэр эхнэрээ хөнгөн үнсэв.

-Чи ч бас.

Тэд савлуур дээр охидыг савлах Жеккийг харлаа. Тэдэнд болгоомжтой байх шалтгаан хангалттай ажээ. Гэсэн хэдий ч Расти одоо аз туршилт нь түүний амьдралын гол эх сурвалж болж ирсэн гэдгийг ойлгож байв. Өөр бусад зүйлийг ч ойлгож байлаа. Хэрэв тэр өглөө сахлаа хусахдаа цаашдаа ч толинд өөрийнхөө царайг харахыг хүсвэл аз турших л ёстой болжээ.

2

Горас нохой хүмүүсийн иддэг хоолонд дуртай.

Хэрэв ян тан хэлэх юм бол корги үүлдрийн ноход хүний иддэг хоолонд дуртай. Илүүдэл жинтэй бяцхан нохой (сүүлийн үед амных нь эргэн тойронд бий болсон буурал үсийг тооцохгүй бол) ингэтлээ их идэх ёсгүй юм. Тэгээд ч Жулия малын эмчийн зөвлөгөөг дагах болжээ. Эзэн нь ширээний ард өгөөмөр байлаа гээд нохойн насыг л хоргодуулж байна гэж шууд хэлсэн. Энэ яриа 16 сарын өмнө болсон бөгөөд тэр цагаас хойш Гораст "Бил-Жек" өгөхийг хязгаарлаж, хаа нэгтээ нохойн хоолны дэглэм барих амттан өгдөг болжээ. Энэ амттан харахад хуванцараар хийсэн хөөсөнцөр савыг санагдуулах бөгөөд Горас түүнийг идэж байх үедээ эзэн рүүгээ хаядаг харцнаас нь дүгнэвэл амт нь бас л хөөсөнцөртэй адилхан бололтой. Гэвч Жулия өөрийн байр сууринд хатуу зогсоно. Цаашдаа нэг ширхэг ч тахианы арьс, шарсан төмс ба өглөөний амтат боов өгөхгүй.

Энэ хязгаарлалт хориотой амттаны тоог багасгаж байгаа ч бүрэн дүүрэн тас цохиж бас чадаагүй. Хоолны дэглэм тулгах болсоноор Горасыг өөрөө өөртөө амттан олоход өдөөжээ. Тэр бүү хэл энэ нь түүнд таалагдах болов. Одоо тэр эртний өвөг дээдэс шигээ анчин болон хувирч байлаа. Өглөө ба оройн зугаалга хоол хүнсний тал дээр илүү ургац өгч баярлуулна. Түүний голдуу зугаалдаг Төв ба Баруун гудамжны замын хажуугийн сувагт хүмүүс хичнээн их юм хаяж үлдээдэг нь гайхалтай. Шарсан төмс, самрын тостой жигнэмэг, заримдаа шоколад наалдсан зайрмагны боодол. Нэг удаа тэр бүтэн "тейбл ток" бялуу олж байж билээ. Мэдээж хэн нэгэн холестерин гэж хэлэхээс хавьгүй түрүүнд тэр Горасын ходоодонд орсон.

Замд таарсан амттан бүрийг идэж чаддаггүй нь үнэн. Заримдаа Жулия түүний юу руу зүтгэж байгааг олж харвал олзоо амтлахаас нь өмнө уяаг татдаг. Гэвч эзэн нь дандаа л гартаа "Нью-Йорк таймс"-ын шинэхэн дугаар юмуу ном барин зугаалдаг учир түүнд их юм олдоно. "Таймс" сэтгүүлийг өөрөөс нь дээрд үзэх нь түүнийг нэг их баярлуулдаггүй. Ялангуяа гэдсээ маажуулахыг хүссэн үед. Гэхдээ Горас салхинд зугаалах үедээ бол өөрийг нь аль болох бага анзаараасай гэж бодно. Бяцхан нохойн хувьд эзнийх нь ийм хайхрамжгүй байдал амттай хоол гэсэн үг.

Энэ өглөө ч бас эзэн нь түүнийг тоосонгүй. Жулия нэг эмэгтэйн хамт байв. Тэр нь энэ гэрийн эзэн бололтой. Яагаад гэвэл түүний үнэр газар сайгүй мэдрэгдэх бөгөөд ялангуяа хүмүүс баасаа үлдээж эзэмшил нутгийнхаа тэмдгийг тавих гэж ордог тэр өрөөнд бүр хурц

мэдрэгдэнэ. Нөгөө эмэгтэй нь уйлахад Жулия тэврэх ажээ.

-Би арай дээрдсэн. Гэхдээ тийм ч сайн биш байна гэж Андреа хэллээ. Тэр гал тогоонд сууж байв. Гораст кофены үнэр үнэртэнэ. Халуун биш хүйтэн кофе. Бас жижиг жигнэмэг. Шанцайтай.

-Ямар ч гэсэн би мансууруулагчид татагдаад л байна.

Хэрэв эзэн нь шанцайтай жигнэмэгийн тухай ярьж байгаа бол Горас ч бас нэг хоёрыг идэхээс татгалзахгүй.

-Татагдах нь их удаан хугацаанд үлдэх байх. Гэхдээ энэ гол нь биш. Би чиний зориг зүрхийг бахдаж байна. Гэвч Растигийн зөв. Түүнээс бүрэн татгалзах нь тэнэг бөгөөд аюултай. Чи ухаан алдаагүй давсан чинь үнэхээр азтай хэрэг.

-Миний мэдэж байгаагаар тэгж даваагүй гээд Андреа кофегоо уув. Шуугиулан сорохыг нь Горас сонслоо.

-Би тод зүүд зүүдэлсэн. Нэг нь түймрийн тухай. Маш том түймэр. Хэллоуины өдөр.

-Одоо чи дээрдсэн үү?

-Бага зэрэг. Тэгээд би үүнээс салж чадна гэж бодож эхэллээ. Жулия хэрэв чи энд үлдвэл би баярлах болно. Гэхдээ чи илүү дээр газар ч олж болох юм даа. Энэ үнэр...

-Бид үнэрийг аргалах гэж оролдоё. Берпигээс зайгаар ажилладаг сэнс авна. Хэрэв чи Горас бид хоёрт орох орон, идэх хоол санал болгож байгаа бол би чиний саналыг хүлээж авлаа. Мансууруулагчийн хамаарлаас салах гэж оролдохдоо ганцаараа байж огт болохгүй.

-Хонгор минь өөр ямар нэг арга байгаа гэж огт бодохгүй байна.

-Чи миний юу ярьж байгааг мэднэ. Чи яагаад үүнийг хийж байгаа юм бэ?

-Яагаад гэвэл миний сонгогдсон цагаас хойш анх удаа энэ хотод миний хэрэг боллоо. Бас яагаад гэвэл хэрэв би түүний төлөвлөгөөг эсэргүүцэх гэж оролдох юм бол эм өгөхгүй гэж Жим Ренни сүрдүүлсэн.

Горас цааш нь сонссонгүй. Хана ба буйдангийн завсараас гарч байгаа үнэрийн эх сурвалж түүний сонирхолыг илүүтэй татав. Бие нь хавьгүй дээр байх үед (эмэнд талархая) Андреа энэ буйдан дээр суугаад "Туугдагсад" цуврал киног үзэх дуртай байжээ. Бас "Ододтой бүжиглэх нь" юмуу Эйч-Би-Оугаар ямар нэг кино үздэг байсан. Кино үзэх үед Андреа богино долгионы зууханд бэлдсэн поп-корн иддэг. Тавгаа буйдангийн дэргэдэх жижиг ширээн дээр тавина. Заримдаа хөөмөл эрдэнэ шишийн үр түүний гараас мултарч ширээн доор унана. Горас үүнийг мэдэрчээ.

Нохой эмэгтэйчүүдийг чалчаа яриатай нь орхиод ширээн доогуур шургаж амттанд хүрэх санаатай ширээ буйдан хоёрын завсар руу зүтгэв. Мэдээж нарийн зайд урагш зүтгэх нь

амаргүй байлаа. Гэвч Горас жижиг биетэйн зэрэгцээ хоолны дэглэм сахиулснаас хойш мэдэгдэхүйц туржээ. Эхний поп-корн "Вейдер" хавгаснаас хэвлэсэн бичиг баримтыг дотроо агуулах зузаан хүрэн цаасан дугтуйн цаадхан талд хэвтэнэ. Горас Брендагийн нямбай татлан бичсэн эзнийхээ нэрэн дээр шууд утгаараа зогсож байв. Тэгээд Андреа Жулия хоёр зочдын өрөөнд орж ирэх үед өөрийн олсон санаанд багтамгүй баян зоорины эхний бөмбөлөгүүдийг залгиж эхэлжээ.

Ямар нэг эмэгтэй "Үүнийг түүнд өг" гэж хэлэв.

Горас толгойгоо өргөн чагналаа. Жулия ч биш, нөгөө эмэгтэй ч биш. Тэр үхсэн хүний дууг сонсжээ. Горас бүх нохойн адил үхсэн хүмүүсийн дуу хоолойг үе үе сонсох ба заримдаа сүнсийг нь ч хардаг. Үхсэн хүмүүс эргэн тойронд хангалттай байх атал амьд хүмүүс тэднийг олж үздэггүй. Хүмүүс өөрсдийг нь өдрөөс өдөрт минут тутамд хүрээлж байдаг арван мянган үнэрийн ихэнхийг үнэрлэж чаддаггүйтэй яг адил.

"Үүнийг Жулияд аваачиж өг. Энэ түүнд хэрэгтэй. Энэ түүнийх".

Түүнээс юу хүсээд байгааг Горас ойлгосонгүй. Түүний аманд орсон зүйлийг Жулия хэзээ ч идэхгүй нь ойлгомжтой. Горас өөрийн олон жилийн туршлагаар үүнийг мэднэ. Тэр бүү хэл поп-корныг хамраараа түлхээд өгсөн ч эзэн нь идэхгүй. Тэр хүний хоол олсон нь үнэн боловч энэ хоол шалан дээр байсан.

"Поп-корн биш ээ..."

-Горас гэх Жулиягийн огцом дуу түүний муу авирлаж байгааг заана. Та нар ойлгож байна уу?:
-Өө муу амьтан. Ийм юм хийж болохгүйг чи мэднэ. Тэгээд ля-ля-ля. -Чи яах гэж тийшээ ороо вэ? Одоохон гар.

Горас ухрах араандаа залгалаа. Жулияд хамгийн дур булаам инээмсэглэлээ бэлэглэж "Жулия би чамд хайртай" гэж хэлэхдээ поп-корны хог хоншоорт нь наалдаагүй гэж найдав. Хэдийгээр тэр хэдхэн ширхэг хөөмөл эрдэнэ шиш идсэн ч алтан судасны гол руу нь хүрч амжаагүй гэдгээ мэдэрч байлаа.

-Чи юу идээ вэ?

Горас эзэн рүүгээ бурханчлан ширтэж оцойн суув. Тэр дүр исгээгүй юм. Тэр Жулияд үнэхээр хайртай.

-Асуултаа өөрчилъе. Чи тэнд юу идсэн бэ? гээд бүсгүй буйдан хана хоёрын зай руу шагайхаар тонгойв.

Гэвч тэр үүнийг хийж амжаагүй байтал нөгөө эмэгтэйн хоолой хачин болоод явчихав. Тэр чичрэхээ зогсоох санаатай гараараа өөрийгөө тэвэрсэн ч амжилт олсонгүй. Эмэгтэйн үнэр өөрчлөгдсөн тул одоо тэр бөөлжинө гэдгийг Горас мэдэж байлаа. Тиймээс түүнийг сайтар ширтэнэ. Заримдаа хүмүүсийн бөөлжист амттай хүнс байдаг.

-Андреа чи зүгээр үү?

"Шал тэнэг асуулт. Эсвэл тэр үнэрийг нь мэдрэхгүй байгаа юмуу?" гэж Горас бодов. Гэхдээ түүнийх ч бас тэнэг асуулт. Яагаад гэвэл Жулия өөрийнхөө хөлсний үнэрийг ч мэдэрдэггүй.

-Тийм ээ. Үгүй ээ. Би үзэмтэй талх идэх хэрэггүй байж. Би одоо... Андреа шээс баасны өрөөнөөс гарах үнэр дээр шинэ үнэр нэмэхээр өрөөнөөсөө үсрэн гарлаа гэж Горас бодов. Жулия араас нь яарлаа. Горас дахиад ширээн доогуур орох уу гэж бодсоноо эзнийхээ хоолойд түгшүүр мэдэрсэн тул араас нь харайлгав.

Үхсэн эмэгтэйн дууг тэр таг мартжээ.

3

Расти машин дотроосоо Клер Макклэтчи руу утасдлаа. Хэдийгээр эрт байсан ч тэр эмэгтэй эхний дуудлагаар утсаа авсанд Расти гайхсангүй. Ойрын өдрүүдэд Честерс-Милдд хэн ч орой болтол унтахаа больсон. Ямар ч гэсэн нойрны эм уугаагүй бол.

Оройтлоо гэхэд 8 хагас гэхэд Жо ба түүний нөхөд гэртээ байх болно гэж эмэгтэй түүнд хэлэв. Тэр бүү хэл өөрөө араас нь явж байгаад ч хамаагүй авчирна гэлээ. Дараа нь эмэгтэй дуугаа намсгаад:

-Жо Норригоос салахгүй шинжтэй.

-Тэнэг хүн л салахгүй байх.

-Та тэднийг дагуулж явах нь уу?

-Тийм ээ, гэхдээ өндөр цацраг идэвхжилттэй бүс рүү биш шүү. Үүнийг би танд ампаж байна хатагтай Макклэтчи.

-Клер гэж дууд. Хэрэв миний сонссоноор адгуус амьтад амиа хорлож байгаа тэр газар руу хүүгээ явуулахыг би зөвшөөрөх гэж байгаа бол бид биенээ нэрээр нь дуудах ёстой гэж бодох юм.

-Чи Бенни ба Норри нарыг гэртээ аваад ир. Харин би аялалын үеэр тэднийг харж хандана гэдгээ амлая. Ингэвэл болох уу?

Клер "тийм" гэж хариуллаа. Ийнхүү ярилцсанаас хойш 5 минутын дараа Расти ер бусын хоосон Моттон-Роуд гудамжнаас хоёр талаар нь Истчестерийн хамгийн гоёмсог байшингууд боссон Дранмонд-Лейн богино гудамж руу орлоо. Гоёмсог шууцангайн хайрцагууд дундаас хамгийн гоёмсог хайрцаг дээр "Берпи" гэсэн нэрийг олж уншив. Түүний дараахан тэр Ромео ба түүний эхнэр Мишель нартай гал тогоонд нь цай ууж суув. (Берпишн цахилгаан үүсгүүр ажиллаж байсан учраас халуун кофе уув). Эхнэр нөхөр хоёр баргар цонхигор харагдана. Ромео аль хэдийн костюм өмсчээ. Харин Мишель гэрийн халаттайгаа байв.

-Тэр Барби үүхээр Брендэг алчихсан гэж чи бодож байна уу? Яагаад гэвэл хэрэв тэр үүнийг

хийсэн бол би түүнийг өөрийн гараар ална найз минь гэж Ромми асуулаа.

Мишель түүнд гараа хүргээд:

-Чи арай тийм тэнэг хүн биш биз дээ хонгор минь?

-Би тэгж бодохгүй байна. Миний боддоор түүнийг энэ хэрэгт чихсэн. Гэхдээ чи миний эдгээр үгсийг хэн нэгэнд дамжуулах юм бол бидэнд тун таагүй асуудал үүсч мэднэ гэж Расти хариулав.

-Ромми тэр эмэгтэйд үргэлж хайртай байсан. Заримдаа надаас илүү хайртай байсан гэж би боддог хэмээн Мишель мөс шиг хүйтэн ярингаа инээмсэглэх ажээ.

Ромми түүний яриаг батлаагүй ч бас үгүйсгэсэнгүй. Тэгэхээр сонсоогүй гэсэн сэтгэгдэл төрөв. Тэр Расти руу бөхийхөд хүрэн нүд нь зочны нүүрнээс салсангүй.

-Чи чинь юу яриад байна вэ? Яаж чихээс болгосон гэж?

-Би яг одоо бол дэлгэрэнгүй яримааргүй байна. Өөр хэргээр ирсэн юм. Гэхдээ энэ ч бас нууц гэж айж байна.

-Тэгвэл би сонсмооргүй байна гээд Мишель кофетай аягаа барьж гал тогооноос гарав.

-Өнөө орой энэ эмэгтэйгээс хайр амсахааргүй боллоо гээд Ромми санаа алдав.

-Уучлаарай.

Ромми мөрөө хавчлаа.

-Надад бас нэг бий. Хотын нөгөө буланд. Миша мэдю. Гэхдээ ил гаргадагүй юм. Тэгэхээр эмч гуай хоёр дахь юмаа ярь.

-Хэдэн жаалууд Бүрхүүлийг үүсгэж байгаа үүсгүүрийг олсон гэж бодож байна. Тэд нас бага ч ухаалаг. Би тэдэнд итгэдэг. Тэд Гейгерийн тоолуур авч гараад Блек-Ридж-Роуд дээр цацраг идэвхижлийн эх сурвалжийг илрүүлсэн. Амь насанд аюултай бүс рүү ороогүй ч их ойртсон.

-Юунд ойртсон гэж? Тэд юу харсан юм бэ?

-Гялсхийх хүрэн улаан гэрэл. Чи алимны хуучин цэцэрлэгийг мэдэх үү?

-Чөтгөр гэж, мэдэлгүй яахав. Фермер Маккойгийн уу? Охидтой очиж л явлаа. Бүх хот алган дээр мэт харагддаг. Надад хуучин "Виллис" машин байсан юм гээд тэр дурсамжиндаа автан хэсэг чимээгүй болов.

-Энэ бүхэн чухал биш. Тэгээд зөвхөн гялтганах гэрэл харсан юмуу?

-Тэд бас олон тооны үхсэн амьтан олсон. Баавгай, бугын сүрэг гээд. Жаалуудын бодлоор бол

адгуус амьтад амиа хорлосон мэт харагдаж байсан.

Ромми Расти руу нүд үл салган ширтэнэ.

-Би чамтай хамт явъя.

-Энэ сайн хэрэг. Гэвч ажилдаа орьё. Бидний хэн нэг нь үүсгүүр рүү хүрэх ёстой. Тэр хүн нь би. Гэвч надад цанраг идэвхижлээс хамгаалах өмсгөл хэрэгтэй.

-Эмч гуай та ямар санаа агуулаад байна вэ?

Расти ярьж өгөв. Түүнийг ярьж дуусахад Ромми хайрцаг "Винстон" тамхи гаргаад түүнд санал болголоо.

-Миний хайртай хорт савхнууд.

Расти нэгийг авав.

-Чи юу гэж бодож байна даа?

-Би чамд туслаж чадна гээд Ромми асаагуур чадхийлгэж зочныхоо тамхийг асааж өгөөд өөрийнхийгөө ч асаав.

-Миний дэлгүүрт бүх юм байдаг гэдгийг хот мэднэ дээ гээд тэр утаа суунаглах тамхиараа Расти руу зааж:

-Гэвч чи дараа нь сонин дээр гэрэл зургаа харах хүсэлгүй болох байх даа. Яагаад гэвэл чи чөттөр шиг хачин болох байх.

-Үүнд би огт санаа зовохгүй байна. Тэгээд ч сонин өнгөрсөн шөнө шатчихсан.

-Би сонссон. Бас л өнөөх Барбара. Түүний найзууд.

-Чи үүнд итгээд байгаа юм уу?

-Бурхан минь би тун итгэмтгий хүн гэж хэлэх үед дуунд нь франц аялга сонсогдоно. -Иракт атомын бөмбөг байгаа гэж Буш хэлэхэд би итгэсэн. Хүмүүст "тэр мэддэг хүн" гэж зарлаж явлаа. Бас Ли Харви Освальд ганцаараа ажилласан гэдэгт ч итгэдэг.

Хажуугийн өрөөнөөс Мишель хашгирав. -Чи наад новшийн франц аялгаар хэлээ эргэлдүүлэхээ боль.

"Би юуг тэвчихэд хүрч байгааг харж байна уу?" гэж хэлэх мэт Ромми Расти руу мушийв.

-За, хайрт минь гэж хашгирах үед азтай Пьерийн аялга ор үндэсгүй алга болжээ. Тэр дахин Расти руу хандав.

-Машинаа энд үлдээ. Миний фургоноор явъя. Зай ихтэй. Эхлээд намайг дэлгүүрт хүргээд дараа нь хүүхдүүд дээрээ оч. Би цацрагаас хамгаалах хувцас цуглуулъя. Гэхдээ бээлий... Би мэдэхгүй байна.

-Эмнэлгийн рентгений өрөөнөөс хар тугалгаар бүрсэн бээлийг авцгаая. Тохойнд хүрдэг юм. Би бас хамгаалалтын хормогч авна.

-Тун сайн санаа. Чиний үрийн шингэнд өнөөх бага болохыг би хүсэхгүй байна...

-Далаад онд рентгенчид болоод техникчид хэрэглэж байсан хар тугалган бүрээстэй хамгаалалтын шил ганц хоёр байгаа байх. Хаячихсан ч байж мэднэ. Гэхдээ би цацраг идэвхжилийн түвшин тийм ч их биш гэж найдаж байна. Жаалууд хэлэхдээ сүүлчийн хэмжилтийн үед зүү ногоон бүсээс гараагүй гэсэн.

-Гэхдээ чи тэднийг ойртоогүй гэсэн биз дээ?

Расти санаа алдав.

-Хэрэв Гейгерийн тоолуур дээрх зүү 800 юмуу 1000-д хүрэх юм бол үр удмаа үлдээх чадвараа хадгалах нь надад тулгарах асуудлуудаас хамгийн хөнгөн нь болох байх.

Тэр хоёрыг гарахаас өмнө богино банзал ба бариу цамц өмссөн Мишель гал тогоонд эргэж ирээд нөхөртөө сургаал айлдаж гарав. Энэ бүхэн түүнээс болсон гэнэ. Ийм юм урьд нь болж байсан бөгөөд давтагдаж байгаа аж. Гэхдээ энэ удаад улам дордоно гэлээ.

Ромми түүнийг тэврээд францаар хурдан ярив. Бүсгүй ч үгсээр нулимах аятай өнөөх хэлээр нь хариулав. Нөхөр нь өөрийнхөөрөө зүтгэнэ. Бүсгүй түүний мөр рүү хоёр ч удаа нударгалаад дараа нь уйлж үнсэв.

Тэднийг гэрээс гарах үед Ромми Расти руу эргэж буруутай юм шиг хараад мөрөө хавчлаа.

-Мишель өөрийгөө яаж ч чаддаггүй хүн. Уг нь тэр уяхан сэтгэлтэй ч өөрийн мэдрэмжийг хогийн нохой шиг илэрхийлдэг.

4

Расти Ромео хоёрыг дэлгүүрт ирэхэд тэнд Тоби Мэннинг байсан бөгөөд хэрэв эзэн нь хүсэх юм бол дэлгүүрээ нээж, хүмүүст үйлчлэхэд бэлэн байлаа. Эсрэг талын эмийн санд ажилладаг Петра Сирлс түүний дэргэд сууна. Тэд "Зуны хямдрал дууслаа" гэсэн бичигтэй өлгөх цаасан дээр тохойлдон суужээ.

-Чи 10 цаг хүртэл энэ цацрагийн хувцасын тухай надад юу ч ярихгүй гэдэгтээ итгэлтэй байна уу? гэж Расти асуув.

-Хэлэхгүй байсан нь дээр. Чи намайг сэтгэцийн өвчтөн гэж нэрлэж мэднэ. Эмч гуай явж үз. Тэр бээлий, хамгаалалтын шил ба хормогчоо аваад ир. Хүүхдүүдтэйгээ ярилц. Надад хугацаа өг.

Роммиг машинаас гарч ирэхэд Тоби: -Босс оо, дэлгүүрээ нээх үү? гэв.

-Үгүй. Үдээс хойш магадгүй. Өнөө өглөө надад ажил гарчихлаа.

Расти явж одов. Хотын талбайн дэргэдэх толгой руу өгсч явах үедээ гэнэт Тоби ба Петра нар гартаа цэнхэр тууз зүүсэн байсныг ухаарлаа.

5

Тэр бээлий, хормогч ба хамгаалалтын шилийг ренттений өрөөний зооринд хийсэн эрлээ зогсоохоос ердөө хоёрхон секундн өмнө олов. Нүдний шилний уян тууз тасарсан байсан ч Берпи ямар нэг бэхэлгээ олж өгнө гэж Расти бодлоо. Хэнд ч юуг яах гэж байгаа тухай тайлбарлах хэрэг гарсангүй. Эмнэлэг тэр чигээрээ унтаж байв.

Расти гадаа гараад агаар үнэрлэв. Утааны таагүй амттай, хөшсөн агаар. Дараа нь пуужинг онох үед Бүрхүүл дээр үүссэн толбо харлах баруун зүгт харав. Яг арьсны хорт хавдар шиг. Тэгээд Барби ба Том Жим болоод хүн амины хэргүүд дээр анхаарлаа төвлөрүүлэх ёстой гэж Расти ойлгов. Яагаад гэвэл Расти хүмүүсийг болоод тэдний биеэ авч явах байддыг бас ч муугүй ойлгодог. Гэвч Бүрхүүлийг үл тоох нь алдаа болох бөгөөд бүр аймшигт алдаа болж мэднэ. Түүнийг зайлуулах, аль болох хурдан үгүй хийх хэрэгтэй. Эс тэгвэл багтраа өвчтэй болоод уушигны архаг өвчтэй хүмүүст асуудал эхэлж мэдрэгдэхээр болжээ. Энэ өвчтөнүүд үнэн хэрэгтэй бол уурхайн шувуухайн үүрэг гүйцэтгэж байгаа.

Тэнгэр никотиноор хучигдсан мэт.

-Сайн юм нэг ч алга. Огт алга гэж тэр бувтнаад олсон олзоо фургоны ар руу чулуудав.

6

Растиг ирэхэд гурван жаал Макклэтчигийн гэрт цуглажээ. Хэрэв аз тохиовол үндэсний баатар болж мэдэхээр байсан ч тэд бүгд уруу дорой харагдана.

-Бүгд бэлэн үү? гэж Расти үл мэдрэгдэх өөдрөг байдлаар асуув. -Бид явахаасаа өмнө Берпигээр дайрна. Гэхдээ тэнд...

-Эхлээд тэд чамд ямар нэг юм хэлэхийг хүсч байна гэж Клер яриаг нь тасаллаа. -Хэлэхгүй бол дээр юмсан. Бүх юм дордоод байна. Жүржийн жүүс уух уу? Бид муудахаас нь өмнө ууж дуусгах гэж хичээж байгаа юм.

Расти эрхий ба долоовор хуруугаа нийлүүлж өчүүхэн бага ууна гэсэн тэмдэг харуулав. Тэр хэзээ ч жүржийн шүүсний талархагч байгаагүй бөгөөд ердөө л Клер өрөөнөөс хурдан гараасай гэж хүссэндээ тэр юм. Тэр ч бас гарахыг хүсч байгаа нь мэдрэгдэнэ. Эмэгтэй хувхай цайж дуу нь айдаст автжээ. Жаалуудын Блек Ридж дээр олсон зүйлээс болоод айсан гэж тэр бодов. Гэтэл өөр яриа байжээ.

"Энэ л дутаж дээ" гэж Расти дотроо бодлоо. Тэгээд Клерийг дөнгөж хаалгаа хаангуут: - Дэлгээрэй гэж тэр гуравт хандав.

Бенни Норри хоёр Жо руу эргэлээ. Өнөөх нь санаа алдаад духан дээрх үсээ хойшлуулж, дахин санаа алдав. Энэ ухаалаг, буурь суурьтай хүү гуравхан өдрийн өмнө алчуураар даллаж Олден Динсморын талбайд хүмүүсийг дуудаж байсан хүүгээс шал ондоо болжээ. Царай нь ээжээсээ дутахгүй хувхай цайж, анхны хэдэн тууралт духан дээр нь гарсан байв. Расти иймэрхүү тууралттай таарч явсан. Шалтгаан нь стресс байдаг.

-Өөр юу вэ? Жо.

-Хүмүүс намайг ухаантай л гэдэг хэмэн Жо ярьж эхлэхэд жаалхүү уйлахад бэлэн байгааг хараад Расти түгшив. -Тийм ч байж магадгүй. Гэвч би заримдаа тэнэг баймаар байна.

-Бүү санаа зов. Чи олон чухал зүйл дээр тэнэг хүүхэд гэж Бенни үг хавчууллаа.

-Бенни амаа хамхи гэж Норри хорсолгүй дуугаар сануулав.

Жо тэдний хоорондоо үг хаяхыг анзаарсан ч үгүй.

-Би 6 настайдаа аавыгаа, 8-тайдаа ээжийгээ шатраар хождог болсон. Сургуульд зөвхөн онц сурдаг. Эрдэм шинжилгээний уралдаануудад үргэлж түрүүлдэг. Өөрийн компьютер дээр программ бичдэг болоод хоёр жил өнгөрч байна. Би онгирч байгаа юм биш. Би... гэхэд нь Норри хи-хи инээгээд гаран дээр нь өөрийг гарыг тавив. Жо түүний гарыг атгалаа. -Гэвч би ердөө л шалтгаан ба үр дагаврын холбоог тогтоосон, ойлгож байна уу? Хэрэв А байгаа бол Б байж таарна. А байхгүй бол Б хаанаасаа гарч ирэх вэ? Тэгээд бүх цагаан толгой байхгүй болно.

-Бид юу яриад байна вэ?

-Эдгээр аллагыг тогооч хийсэн гэж бодохгүй байна. Яг хэлэх юм бол бид бодохгүй байна.

Норри Бенни хоёр толгой дохиход түүний царайд хөнгөрөл тодров. Гэвч Растигийн хэлснийг сонсоод царайд нь баяр хөөр, дараа нь гайхал төрлөө.

-Би ч бас тэгэж бодохгүй байгаа.

-Түүний тогоо юм чанах чадвартай гэж би чамд хэлсэн пгүү дээ. Тэгээд ч тэр гайхалтай оёос тавьдаг гэж Бенни Жо-д хэллээ.

Клер шүүстэй жижиг аяга барьсаар орж ирэв. Расти амсч үзэв. Бүлээн боловч тэвчиж болохоор. Цахилгаан үүсгүүр үгүй тул маргааш гэхэд гарцаагүй муудаж эхэлнэ.

-Тэр хүн алаагүй гэж чи яагаад бодож байгаа юм бэ? гэж Норри асуув.

-Та нар эхлээд ярь.

Блек Ридж дээрх үүсгүүрийн тухай Расти бараг мартаж шахжээ.

-Бид өчигдөр өглөө хатагтай Перкинсийг харсан юм. Бид Гейгерийн тоолуурыг турших

санаатай Энхтайваны гүүрэн дээр байсан. Тэрэмэгтэй хотын талбайн дэргэдэх толгой руу өгсч явсан.

Расти шилэн аягаа буйдангийн дэргэдэх ширээн дээр тавьлаа. Урагш бөхийж хоёр гараа өвдөгөндөө хавчуулаад -Хэдэн цагт?

-Миний цаг ням гаригт Бүрхүүлийн тэнд очиход зогсчихсон. Тиймээс яг хэлж чадахгүй. Гэхдээ түүнийг харах үед их дэлгүүрийн том тулаан аль хэдийн болж байсан. Өөрөөр хэлбэл 9 цаг 25 минут орчимд. Түүнээс орой бол биш.

-Бас эрт ч биш. Яагаад гэвэл их дэлгүүрийн дэргэд тулаан эхэлчихсэн байсан. Бид сонсож байсан юм.

-Тийм ээ. Шуугиан хангалттай байсан гээд Норри толгой дохилоо.

-Та нар өөр хэн нэгнийг биш Бренда Перкинсийг харсан гэдэгтээ итгэлтэй байна уу? Растигийн зүрх дэлсэж байв. Хэрэв Бренда хүнсний тулаан эхэлсний дараа амьд байсан юм бол Барби үнэхээр ямар ч буруугүй.

-Бид бүгд түүнийг танина. Тэр намайг скаутын багаас гарахаас өмнө охидын багт сургагч байсан юм гэж Норри хариуллаа. Гэхдээ тамхи татсаны төлөө тэндээс хөөгдсөнөө Норри энд ярих газар биш гэж үзсэн учир эю сэдвийг дэлгэрүүлсэнгүй.

-Эдгээр аллагын талаар юу ярьж байгааг би ээжээсээ мэдэж авсан. Тэр надад мэдэх бүхнээ хэлсэн. Цэргийн дугаартай энгэрийн тэмдэг. Та ойлгож байгаа гэж Жо үргэлжлүүлэв.

-Ээж нь мэдэж байгаа бүхнээ хэлэхийг хүсээгүй. Гэвч миний хүү их шаргуу шаарддаг хүн. Тэр нь ч хэрэг боллоо гэж Клер тайлбарлав.

-Тийм ээ гэж Расти толгой дохиод -Хатагтай Перкинс хаачсан юм бэ? Энэ асуултанд Бенни хариулав.

-Эхлээд хатагтай Гриннел дээр очсон. Тэр юу хэлсэн байлаа ч гэсэн их хүйтэн хүлээн авалттай учирсан. Яагаад гэвэл хатагтай Гриннел түүний хамрын урд хаалгаа тасхийлгэсэн.

Расти хөмсөг зангидав.

-Энэ үнэн. Хатагтай Перкинс түүнд шуудан юмуу ямар нэг тийм юм дамжуулсан гэж би бодож байна. Тэр түүнд дугтуй өгсөн. Өнөөх нь авангуутаа хаалгаа тасхийлгэсэн. Яг Беннигийн хэлдгээр гэж Норри батлав.

-Ойлголоо гээд Расти толгой дохилоо. Яг баасан гаригаас хойш Честерс-Миллд ямар ч шуудан тараагаагүй гэдгийг тэр санана. Гэхдээ тэр өөр зүйлд чухлыг харж байв. Бренда өглөөний 9 цагаас хойш амьд байгаад зогсохгүй хэн нэгний даалгаврыг биелүүлжээ. Харин Барби өглөөний 6 цагаас хойш минут бүрийг хаана өнгөрөөснөө баталж чадна. Өөрөөр хэлбэл түүний баталгаа төмөр учраас эргэлзээ үл төрүүлнэ.

-Дараа нь хаачсан бэ?

-Төв гудамжийг огтлоод Үйлдвэрийн гудамж руу эргэсэн.

-Энэ гудамж уу?

-Яг тийм. Расти Клер рүү эргэв.

-Тэр...

-Тэр энд ирээгүй. Гэхдээ би хэсэг хугацаанд хонгил руу орж лаазтай зүйлс ямар байгааг шалгасан. Хагас цаг хэртэй доошоо орсон. 40 минут ч байж мэднэ. Би... Би их дэлгүүрийн шуугианыг сонсохыг хүсээгүй юм.

Бенни өчигдөрийн хэлсэн үгээ давтлаа.

-Үйлдвэрийн гудамж дөрвөн хороолол дамнадаг, олон байшин бий.

-Миний хувьд энэ чухал биш гэж Жо үргэлжлүүлэв. -Би Энсон Уилер руу угасдсан. Тэр урьд нь скэтчин байсан ба одоо ч "Яма"-гаар гулгахаар Оксфорд руу явдаг. Би түүнээс

өчигдөр ноён Барбара ажлаа хийсэн эсэхийг асуухад тийм гэсэн. Ноён Барбара үймээн дэгдсэн хойно "Хүнсний ертөнц" рүү явсан гэсэн. Тэгээд тэнд хатагтай Роуз ба Энсон нартай хамт байсан. Тэгэхээр ноён Барбара хатагтай Перкинсийг яагаад ч алаагүй. Миний хэлснийг санаж байна уу? Хэрэв А байхгүй бол Б байхгүй. Тэд байхгүй бол цагаан толгой тэр чигээрээ байхгүй.

Энэ нь хүний ажил хэрэгт хамааруулахад хэт математик таамаглал болох талаар Расти бодсон ч Жо юу гэх гээд байгааг ойлгов. Бусад хохирогчдын тал дээр Барбид төмөр баталгаа байхгүй хэдий ч хүүрнүүдийн байдал нь алуурчин нэг хүн болохыг илттэнэ. Тэгээд Том Жим дөрвөн талийгаачийн доод тал нь нэгийг нь алсан юм бол -Лестер ламын толгой дээрх шарх үүнийг зааж байв -Тэр бусдыг нь ч бас унагаасан байж таарна.

Эсвэл одоо цагдаад алба хааж буутай явах болсон Жижгээ алсан.

-Бид цагдаад очиж үүнийгээ ярих ёстой тийм үү? гэж Норри асуулаа.

-Би үүнээс айж байна гэж Клер дуу алдав. -Би үүнээс маш их, бүр маш их айж байна. Хэрэв Ренни Брендаг алсан бол яах вэ? Тэр ч бас Үйлдвэрийн гудамжинд амьдардаг.

-Яг үүнийг өчигдөр хэлсэн гээд Норри толгой дохив.

-Хотын захиргааны нэг гишүүн дээр иртэл хамрынх нь өмнө хаалга хаагдсан тул тэр хөрш зэргэлдээ амьдрах нөгөө гипгүүн рүү нь очсон байх бүрэн магадлалтай.

-Энд ямар нэг холбоо байгаа гэдэгт би эргэлзэж байна ээжээ гэх Жо-гийн дуунд хөнгөн ивээнгүй аяс тодорно.

-Холбоо байхгүй байж болно. Гэвч тэр Жим Ренни дээр очиж мэднэ. Харин Питер Рэндолф гэснээ Клер толгой сэгсрэв. -Хэрэв Том Жим үсэр гэвэл Питер хэр өндөр үсрэхийг л асуух хүн.

-Хатагтай Макклэтчи, сайхан наргиан байлаа. Та жолоог гартаа барьж байна гэж Ренни дуу алдав.

-Баярлалаа Бенни. Гэхдээ энэ хотод Том Жим жолоог атгадаг юм.

-Тэгээд бид яах вэ? гээд Жо Расти руу түгшүүртэй харав.

Тэр дахиад л хар толбын тухай бодов. Шар тэнгэрийн тухай. Агаар дахь утааны үнэрийн тухай. Барбиг шоронгоос сугалж гаргах Жеккигийн шийдмэг боддын тухай бодлоо.

Мэдээж аюултай. Гэхдээ гурван хүүхдийн мэдүүлгээс илүүтэй аврагдах магадлал өндөр. Тэдний мэдүүлгийг сонсох цагдаагийн дарга нь удирдамж уншихгүйгээр бөгсөө арчих чадваргүй хүн гэдгийг тооцвол бүр тийм.

-Одоохондоо юу ч хийх хэрэггүй. Дейл Барбара одоохондоо аюулгүй байгаа гэж хэлэхдээ Расти үнэн байгаасай гэж найдна.

-Бид өөр юм хийх болно. Хэрэв та нар үнэхээр үүсгүүрийг олсон юм бол бид түүнийг салгах болно...

-Бусад асуудал аяндаа шийдэгдэнэ гэж түүний үгийг Норри дуусгав. Түүний дуунд хэмжих аргагүй хөнгөрөл сонсогдоно.

-Тэгэх байх гэж Расти зөвшөөрлөө.

7

Петра эмийн дэлгүүр рүүгээ буцсаны дараа (дотоод засал хийнэ гэж тэр хэлсэн) Тоби ямар нэг зүйлээр туслах эсэхийг Роммигоос асуув. Цаадах нь толгой сэгсрээд:

-Гэртээ харь. Ээж аавдаа туслах юм ол.

-Гэрт аав байгаа. Ээж бямба гаригт Касл-Рокийн их дэлгүүр рүү явсан. Тэр "Хүнсний ертөнц"-ийн үнэ хамаагүй өндөр гэдэг юм. Та юу хийх юм бэ?

-Онц юм хийхгүй. Тоби надад хэлээч... Петра та хоёр яагаад ийм цэнхэр даавуутай яваад байгаа юм бэ?

Тоби таг мартсан хүн шиг гарын цэнхэр боолтоо харлаа.

-Эв санааны нэгдлээ харуулж байгаа юм. Өчигдөр шөнө эмнэлэгт болсон явдлын дараа... ер нь болсон бүхний дараа...

Ромми толгой дохив.

-Чи цагдаад бичүүлсэн юмуу хаашаа юм?

-Чөтгөр гэж, үгүй. Энэ ердөө... 9 дүгээр сарын 11-ний явдлын дараа бүх хүн дүрэмт малгай юмуу цамц өмсөхийг хүсч байсныг та санаж байгаа. Нью-Йоркийн галтай тэмцэх газрын билүү эсвэл цагдаагийн захиргааны билүү? Манайд ч бас тийм юм болж байна. Хэрэв хотод тусламж хэрэгтэй болох юм бол би нэрээ бичүүлэх байсан. Гэвч цагдаа нар тэртэй тэргүй ажил үүргээ сайн биелүүлж байх шиг. Ингэхэд танд үнэхээр тусламж хэрэггүй гэж үү?

-Үгүй. Харин одоо эндээс тонилж үз. Хэрэв үдээс хойш дэлгүүрээ нээхээр шийдвэл би чам руу утасдана.

-За гэж Тоби хэлснээ нүд нь гялалзав. -Бид "Бүрхүүл дор" гэсэн үнэ хямдрал хийвэл ямар вэ? "Хэрэв амьдрал чамд нимбэг өгөөд байвал нимбэгний шүүс бэлд" гэсэн үг байдгийг та мэднэ.

-Магадгүй, магадгүй гэж хэлэхдээ Ромми ийм хямдрал болно гэдэгт эргэлзэж байв. Энэ өглөө хуучирсан барааг хүртэл борлуулах нь түүний сонирхолыг огт татахгүй байлаа. Сүүлийн гурван өдрийн дотор амьдралд хандах түүний хандлага болоод ирээдүйг харах үзэлд нь томоохон өөрчлөлт болсныг тэр мэдэрч байв. Галтай хийсэн тэмцэл ба энэ үед бий болсон нөхөрсөг уур амьсгал үүргээ гүйцэтгэжээ. Хот өөрийгөө харуулсан. Сайн талаа харуулсан. Гэхдээ энэ өөрчлөлт түүний эртнээс хайртай байсан Брендагийн үхлийг дагуулсан... Тэр эмэгтэй урьдын адил Роммигийн хувьд Бренда Морс чигээр үлдсэн. Тэр үнэхээр хөөрхөн байсан бөгөөд хэрэв тэр хэн түүнийг алсныг мэдэх юм бол тэр хүн асар их үнэ төлөх хэрэг гарна. Хэрэв Растигийн зөв байгаад Дейл Барбара ямар ч буруугүй байх юм бол алсан хүн дуусна. Энэ тал дээр Ромми Берпи биечлэн анхаарах болно.

Түүний зай ихтэй дэлгүүрийн гүнд "Засвар хийхэд шаардлагатай бүхэн" гэсэн тасаг бий. "Өөрөө хий" тасгийн дэргэд байх учраас цаг хэмнэнэ. Сүүлийн тасгаас Ромми төмөр хайчлахад зориулсан бат бөх хайч авлаа. Дараа нь эхний тасаг руу ороод худалдааны эзэнт улсынхаа хамгийн алсын, харанхуй, тоос шороотой булан руу чиглэв. Тэндээс ус сувгийн систем, пийшингийн яндан ба дээврийн тусгаарлалтанд голдуу ашигладаг хар тугалганы хэдэн арван ороомог тууз олов. Хоёр ороомог ба төмрийн хайчаа тэргэнцэрт хийгээд спортын барааны тасаг хүртэл түрэн алхлаа. Эндээс хэрэгтэй бүхнийг авав. Хэд хэдэн удаа инээд алдав. Тэр цацраг идэвхжилээс хамгаалах хувцас бэлдэж чадна гэдэгтээ эргэлзэхгүй байлаа. Гэхдээ энэ хувцасыг өмссөн Расти тун инээдтэй харагдах болно.

Ажлаа дуусгаад Ромми нуруугаа тэнийлгэн суниав. Энэ үед түүний харц овоо хараанд орсон бугыг дүрслэх зураг дээр туслаа. Зураг спортын барааны талын хананд өлгөөстэй байжээ. Дээгүүр нь "Ангийн улирал эхлэхэд бараг хугацаа үлдсэнгүй. Зэвсэглэх цаг болжээ" гэсэн байв.

Үүссэн нөхцөл байдал болоод болзошгүй өрнөлийг тооцсон Ромми зэвсэглэх нь тун сайн санаа гэж бодлоо. Тэр тусмаа Ренни юмуу Рэндолф цагдаа нарт байгаагаас бусад бүх зэвсэгийг хураах шийдвэр гаргавал.

Тэр дотор нь буу зэвсэг байх цоожтой ханын шүүгээнүүд рүү өөр нэг тэрэг түрж авчирав. Бүснээс дүүжилсэн цагирагнаас түлхүүрүүд авч шүүгээнүүдийг нээлээ. Ромми зөвхөн "Винчестер" компанийн бүтээгдэхүүн худалддаг. Бугын ангийн улирал эхлэхэд үнэхээр долоо хоног үлдсэн болохоор хэрэв ханын шүүгээнд яагаад хоосон зай үлдсэнийг асуувал асуудалгүй тайлбарлаж өгч чадна. Тэгээд 22 калибрын "Зэрлэг муур", бас "Хар сүүдэр", хоёр ширхэг "Хар хамгаалагч" буунуудыг авав. Дээрээс нь "Амь өрссөн цаг агаар-загвар 70" (дуран хараатай) ба "Үслэг ан 70" (дуран хараагүй) буунуудыг авав. Сонгосон буунууддаа зориулан хангалттай сум аваад тэргээ өрөөндөө түрж аваачаад буунуудыг том төмөр шүүгээнд хийж түгжлээ.

Төмөр шүүгээг нууц түлхүүр хийн түгжих үедээ, "Энэ ч сэрдэх дон байх пгүү нөхөр минь" гэж бодлоо.

Гэхдээ Ромми өөрийгөө донтон гэж бодохгүй байв. Расти ба хүүхдүүдийг нь хүлээхээр дэлгүүрээс гарах үедээ ханцуйндаа цэнхэр уяа зүүх хэрэгтэй гэж өөртөө санууллаа. Растид ч бас тэг гэж хэлнэ. Өнгөлөн далдлах нь үр ашгаа өгдөг.

Үүнийг бугын ямар ч анчин мэднэ.

8

Өглөөний 8 цагт Том Жим гэрийнхээ ажлын өрөөнд эргэж ирэв. Тэр Картерыг хэсэг хугацаанд өөрийн хувийн бие хамгаалагчаар сонгосон тул тэр ч бас ирээд одоо "Кар Энд Драйвер" сэтгүүлийг уншиж суув. Тэнд 2012 оны хосолсон хөдөлгүүртэй "БМВ" машин ба 2011 оны фордын "Веспер РТ" загваруудыг харьцуулсан нийтлэл гарчээ. Хоёр машин хоёулаа сэтгэл булаам харагдана. Гэхдээ солиотой хүн л "БМВ" жолоодож байгаагаа мэдэхгүй. Тэгээд дээр дурдсан бүхэн одоо Честерс-Милл хотын тухайд ноён Ренни бол хосолсон хөдөлгүүртэй "БМВ" гэдгийг ойлгохгүй хүмүүст хамаарна гэж Картер бодов.

Том Жимийн бие тун дажгүй байлаа. Барбаратай уулзсаны дараа бага зэрэг унтсан болоод тэр биз. Ойрын үед аль болох ойр амарч, дундуур нь цоглог байхыг зорьж байв. Бас өөр нэг шалтгаан байгааг тэр хүлээн зөвшөөрөхийг үл хүсэх бөгөөд тэр нь зүрхний хэмнэл алдагдах өвчин дахин дайрахаас зайлсхийх юм.

Нэгэнт Жижгээ галзуу юм шиг аашилж байгаа болохоор Картер дэргэд байнга байх нь түүнийг тайвшруулна. (Жижгээгийн биеэ авч яваа байдлыг өөр яаж нэрлэх билээ гэж Том Жим бодов). Картер дээрэмчин шиг харагдах боловч туслахын дүрд тохироод байх шиг. Хэдийгээр Том Жим бүрэн итгэлтэй биш байсан ч Картер Рэндолфоос хавьгүй ухаантай санагдана.

Тэр үүнийг шалгахаар шийдэв.

-Их дэлгүүрийг хэдэн хүн хамгаалж байгаа вэ? Хүү минь чи үүнийг мэдэх үү?

Картер сэтгүүлээ цааш тавиад арын хармаанаас жижиг, элэгдсэн дэвтэр гаргаж ирсэн нь Том Жимд таалагдав.

Картер хэдэн хуудас эргүүлээд хариуллаа.

-Өчигдөр шөнө 5 хүн байснаас 3 нь орон тооны, хоёр нь шинэ цагдаа. Ямар ч асуудал гараагүй. Өдөр ердөө гурван цагдаа байх болно. Гурвуулаа шинэ. Обри байна. Номын дэлгүүр түүний ахынх гэдгийг та мэднэ. Бас Тодд ба Конри

-Чи энэ хангалттай гэдэгтэй эв санааны нэгдэлтэй байна уу Картер?

-Юу гэнэ ээ?

-Чи зөвшөөрч байна уу? Картер. Эв санааны нэгдэлтэй гэдэг чинь зөвшөөрч байгаа гэсэн үг.

-Тийм. Бүрэн дүүрэн. Өдөр, ер нь бүх юм.

Ямар ч зогсолт авалгүйгээр, боссод ямар хариулт таалагдахыг бодолгүйгээр хариулж байв. Энэ Реннид таалагдлаа.

-За за. Одоо харин сонс. Чи өнөө өглөө Стейси Моггинтой холбоо барь. Танай жагсаалтанд байгаа цагдаа бүр рүү утасд гэж хэл. Оройн 7 цагт тэд бүгд "Хүнсний ертөнц" дээр ирсэн байх ёстой. Би тэдэнтэй ярилцах болно.

Үнэнийг хэлэхэд тэр дахин нэг яриа хийх гэж байсан бөгөөд үүгээр цэг тавих хүсэлтэй байлаа. Эдгээр залуусыг яг хуучны өвөөгийн цаг шигээ баадуудах ёстой.

-Бас хүн бүр нэг хүн дагуулж ир гэж хэл гээрэй.

-Ойлголоо гээд Картер туслахын дэвтэр дээрх жагсаалт дээгүүр үзүүрлэсэн харандаагаар зурж гүйлгэж гарав.

-Бид одоо... Түр хүлээгээрэй... 26-уулаа.

-Энэ хангалтгүй. Өчигдөр өглөө их дэлгүүрийн дэргэд юу болсон ба өчигдөр орой сонины редакци шатаасныг сана. Эсвэл бид, эсвэл анархи байдал. Энэ юу гэсэн үг болохыг чи мэдэх үү? Картер.

-Тийм ээ, ноён гэж хариулахдаа энэ "анархи" гэдэг үг буудлагатай холбоотой байх гэж тэр бодов. Тэгээд хэрэв цагдаа нар хяналтыг гартаа авахгүй юм бол Милл буудлагын газар болж хувирна гэж шинэ босс айж байгаа юм байна хэмээн тооцлоо. -Бид зэвсэг хураах юмуу нэг тиймэрхүү юм хийвэл ямар вэ?

-Том Жим инээд алдав. Тийм ээ энэ залуу түүнийг ердөө баярлуулж байна.

-Үүнийг бид хийнэ ээ. Дараа долоо хоногийн эхээр.

-Хэрэв Бүрхүүл үлдвэл. Та Бүрхүүл үлдэнэ гэж бодож байна уу?

-Тэгж бодож байна.

Бүрхүүл үлдэхгүй байх аргагүй. Хийх ажил маш их байна. Хийн нөөцийг хот даяар тараана. Радио студийн ард босгосон мет үйлдвэрлэх лабораторийн бүх ул мөрийг устгана. Хамгийн гол нь тэр байх гавьяатай агуу их байдалдаа хүрч амжаагүй байна. Хэдийгээр энэ замаар зөндөө мацсан боловч хүрээгүй.

-Харин одоохондоо орон тооны хоёр цагдааг "Берпигийн их дэлгүүр" рүү илгээж бүх зэвсэгийг хураа. Хэрэв Ромео Берпи дургүйцэх юм бол хэл гээрэй. Зэвсэг Дейл Барбарагийн хамсаатнуудын гарт орохыг бид хүсэхгүй. Чи үүнийг ойлгов уу?

-Тийм ээ гээд Картер дахин нэг тэмдэглэгээ хийв. -Дентон ба Жекки. Тэд тохирох уу?

Том Жим хөмсөг зангидлаа. Жекки чинь өнөөх том хөхтэй бүсгүй. Тэр түүнд итгэдэггүй. Ер нь тэр хөхтэй цагдаа нарт дургүй. Эмэгтэй хүн түүний бодлоор цагдаад алба хаах ёсгүй боловч энэ удаад өөр шалтгаан бий. Том Жимд түүний өөр рүү нь хэрхэн харсан нь таалагдаагүй.

-Дентон болно. Жекки хэрэггүй. Генри Моррисон бас хэрэггүй. Дентоныг Жоржтой явуул. Авчирсан бүхнээ зэвсэгийн өрөөнд тавь гэж хэлээрэй.

-Ойлголоо.

Том Жимийн утас хангинав. Тэр хөмсөг зангиддаа. Утсаа авав.

-Хотын захиргааныг гишүүн Ренни сонсч байна.

-Сайн уу? Хотын захиргааны гипгүүн ээ. Би хурандаа Жеймс Оу Кокс байна. Би "Бүрхүүл төсөл" ажиллагааг удирдаж байгаа. Тантай ярилцах цаг болсон гэж бодож байна.

Том Жим инээд алдаад сандалын араа налан хэвтэв.

-За яриач дээ хурандаа. Бурхан таныг ивээг.

-Надад ирсэн мэдээллээр бол та ерөнхийлөгчөөс Честерс-Милл хотын бүх асуудлыг шийдэх даалгавар авсан хүнийг баривчилсан байна.

-Тэр тийм пгүү ноёнтон. Барбараг хүн амины хэрэгт буруутган баривчилсан. Дөрвийн дөрвөн хэрэгт. Честерс-Милл хотын бүх асуудлыг цуврал аллага үйлдэгч шийдэхийг ерөнхийлөгч хүсэхгүй гэж би бодож байна.

-Тэгээд үр дүнд нь бүх асуудлыг та шийдэж байна.

-Үгүй, үгүй гээд Ренни бүр дарвайтал инээв. -Би бол хотын захиргааны даруухан хоёрдугаар гишүүн. Асуудлыг Энди Сандерс шийдэж байгаа. Харин Барбараг таныг мэдэж байгаагаар манай цагдаагийн шинэ дарга Рэндолф баривчилсан юм.

-Өөрөөр хэлбэл таны гар цэвэрхэн юм байна. Бүрхүүл үгүй болж мөрдлөг эхлэхэд таныг байр суурь ийм байх юм байна.

Том Жим энэ шалчгар балайн дуунд мэдрэгдэх цухалдалаас таашаал авч байв. Пентагоны цурхайн хүү бүгд өөрт нь захирагддагт дасчээ. Харин одоо өөрөө захирагдаж сурах цаг нь болсон.

-Миний гар яагаад бохир байх ёстой юм бэ? хурандаа. Нэг хохирогчийн гараас Барбарагийн цэргийн дугаартай тэмдэг олдсон. Үүнээс илүү жинтэй ул мөр төсөөлөх арга байна уу?

-Тун цагаа олж тэнд очжээ дээ.

-Тийм ч байж мэднэ.

-Хэрэв та мэдээллийн сувгууд үзэх юм бол Барбараг баривчилсан явдал нь түүний өөлөх аргагүй алба хаасан жагсаалтанд ноцтой асуудал дагуулж байгааг сонсоно. Бас өөлөх аргагүйн үнэр ч байхгүй таны алба хаасан жагсаалттай холбоотой асуултуудыг ч тавьж байна.

-Үүнд намайг гайхна гэж та бодоо юу? Мэдээллийг хүссэнээрээ удирдахдаа та нар мастер. Вьетнамын дайны үеэс үүнийг хийж байгаа.

-Си-эн-эн сувгаар та 90-өөд оны сүүлээр худалдан авагчдыг хямд үнээр дуудаад дараа нь өндөр үнээр өөр бараа шахсан тухай түүхийг ухааж олжээ. Энэ бол залилангийн хэрэг юм. Эн-Би-Си-гээр таны өгсөн зээлтэй холбоотой 2008 онд явагдсан мөрддөгийн тухай мэдээлж байна. Миний ойлгож байгаагаар та худалдан авагчдаас хэт өндөр хүү авч байсан нь хуулиар хориотой зүйл. 40-өөд хувь билүү дээ. Бас зарим нэг хөнгөн тэрэг ба пикапийг та бодит үнээс нь хоёр юмуу гурав нугалж зарсан тухай мэдээлж байна. Танай сонгогчид таны хийсэн хэргийг мэдээний сувгуудаас мэдэж авч байгаа байх.

Энэ бүх буруутгал аль хэдийн өнгөрсөн зүйл. Өнгөрөөхийн тулд Ренни асар их мөнгө төлсөн.

-Манай хотын оршин суугчид хэрэв энэ нь шамбарамын тосыг хэдэн арваар илүү зарах юмуу нойрны эмтэй хэдэн сав зарахад тус болно гэж үзвэл мэдээллийн сувгаар ямар ч үлгэр үзүүлж чаддаг гэдгийг мэддэг хүмүүс.

-Тэгээд зогсохгүй. Мэн муж улсын ерөнхий прокурорын мэдэгдсэнээр ням гаригт өөд болсон цагдаагийн өмнөх дарга таны татвараас зайлсхийсэн, хотын өмч ба сангийн мөнгийг луйвардсан болоод мансууруулах бодис хууль бусаар үйлдвэрлэхэд оролцсон талаарх хэргүүдийг мөрдөж байсан байна. Энэ сүүлчийн мэдээллийн тухайд бид хэвлэлд өгөөгүй байгаа ба өгөх бодолгүй байна. Гэхдээ хэрэв та харилцан буулт хийсэн тохиолдолд. Та хотын захиргааны гипгүүний суудлаас буух хэрэгтэй. Ноён Сандерс ч бас тэгэх ёстой. Хотын удирдлага захиргааны гуравдугаар гишүүн Андреа Гриннелд шилжиж байгаа бөгөөд тэр хүн амбан захирагч гэж зарлах ёстой. Тэгээд Жаклин Уэттингтон Честерс-Милл дэх ерөнхийлөгчийн төлөөлөгч гэж зарлаарай.

Яг энэ үед Том Жимийн эелдэг сайхан зангаас ул мөр үлдсэнгүй.

-Та нар солиоров уу? Андреа Гриннел бол оксиконтинд донтсон хар тамхичин. Харин Уэттингтоны чөтгөр толгойд тархи байхгүй.

-Ренни гуай. Энэ бүхэн тийм биш гэдгийг би танд хэлэх байна гэж хэлэхдээ Кокс ноён гэж хэлээгүй нь энхтайванч харилцааны эрин дууссаныг илтгэнэ. -Уэттингтон Германыг Вюрцбургийн арын албаны 67-р эмнэлгийн бааз дээр ажиллаж байхдаа хар тамхины наймаачдын сүлжээг илрүүлсний төлөө талархал хүлээсэн. Бүх цаг үеийн хамгийн мундаг цэргийн цагдаа болох Жек Ричер түүнийг миний даруухан бодлоор өөрийн биеэр цагдаад нэр дэвшүүлсэн.

-Танд даруухан юм гэж юу ч алга хурандаа. Тэгээд ч таны буруу номын хэл яриа надад эвгүй байна. Би христийн шашинтай хүн.

-Надад байгаа мэдээллээр бол хар тамхи худалдаалдаг христийн шашинтан.

-Чулуу мод бол яс хугалдаг юм. Харин хараалын үг хор хүргэдэггүй гэж хэлээд Том Жим инээнгээ ялангуяа энд Бүрхүүл дор гэж бодов. -Танд эд мөрийн баталгаа бий юу?

-Ренни больж үз. Нэг мундаг нөгөөгөөсөө асууж байгаа шиг асууя. Энэ бүхэн утга учиртай гэж үү? Бүрхүүл бол 9 дүгээр сарын 11-нээс хойшхи мэдээллийн хамгийн том үйл явдал болчихлоо. Одоохондоо хэвлэл мэдээлэл таныг өрөвдөж байна. Гэвч хэрэв бидэнтэй хамтран ажиллахгүй юм бол би таныг яаж ч угааж цэвэрлэх аргагүй болтол нь булаад өгье. Бүрхүүл алга болонгуут би таныг сенатын хорооны өмнө том шүүгчдийн өмнө аваачиж дараа нь шоронд илгээх талаар санаа тавина. Би танд үүнийг амлаж байна. Гэвч ухрах араа залгавал энэ бүхэн болохгүй. Үүнийг би бас амлаж байна.

-Бүрхүүл алга болонгуут гэсэн үү? Тэр чинь тэгээд хэзээ юм бэ? гэж Ренни гуншив.

-Таны бодож байгаагаас хурдан байж мэднэ. Би хамгийн түрүүнд дотогшоо орж бүхнээс түрүүнд таныг гавлаж Канзас муж улсын Форт-Ливенуорт руу онгоцоор илгээгээд тэнд шүүх хүртэл байлгахыг тушаах болно.

Ийм увайгүй харьцаанаас болоод Том Жеймс хэсэг хугацаанд хэлж ярих чадвараа алдав. Дараа нь инээлээ.

-Хэрэв та үнэхээр хотын тусын тулд ямар нэг юм хийхийг хүсч байвал огцор. Таны ганцаар удирдлагын үед юу болсныг хар. 6 хүн амины хэрэг. Эмнэлэгт өчигдөр шөнө хоёр хүн алагдсан. Амиа хорлосон хэрэг. Хүнсний үймээн. Танд энэ ажил тохирохгүй гэж Кокс үргэлжлүүлэв.

Том Жимийн хуруу бейсболын алтадсан бөмбөгийг бяц атгав. Картер одоо босс руугаа түгшүүртэй харна.

Хурандаа Кокс хэрэв чи энд байсан бол би Лестер лам шиг үзүүлээд өгөх байсан. Бурхан гэрчилнэ. Дуусгах байсан.

-Ренни?

-Би энд байна. -Түр чимээгүй болов. -Харин та тэнд байгаа. -Дахин түр чимээгүй болов. -

Бүрхүүл хаашаа ч алга болохгүй. Бид энэ тухай мэднэ гэж бодох юм. Та нар түүн дээр хамгийн том атомын бөмбөг хаялаа гэхэд ойр орчмын хотуудын амьдралыг 200 жил түлж хаяна. Бас Бүрхүүл завсар нэвтрэн орох цацраг идэвхит туяа Честерс-Миллийн бүх хүнийг ална. Гэвч Бүрхүүл хаашаа ч хөдлөхгүй. -Тэр одоо ойр ойрхон амьсгалах бөгөөд зүрх нь цээжин дороо хүчтэй жигд цохилно. -Яагаад гэвэл Бүрхүүл бурхны тааллаар тавигджээ.

Тэр үүнд одоо бүх зүрх сэтгэлээрээ итгэж байв. Бас бурхны тааллаар тэр Честерс-Миллийн эрх мэдлийг гартаа авах ёстой бөгөөд ирэх долоо хоног, сар, жилүүдэд түүн дээр унаж ирэх бүх сорилтын дундуур хөтлөх ёстой гэдэгт итгэж байв.

-Юу гэнэ ээ?

-Та намайг сонссон.

Тэр одоо бүх юмаа, түүний дотор өөрийн ирээдүйг Бүрхүүлийн хэр удаан оршихтой мөрий болгон тавьсанаа ойлгов. Зарим хүмүүс үүнийх нь төлөө түүнийг солиотойд тооцно гэдгийг ч мэдэж байлаа. Бас тэр хүмүүс бол итгэл шүтлэггүй зэрлэгүүд гэдгийг мэдэж байв. Яг энэ хурандаа Жеймс Оу булшлуулмар Кокс шиг.

-Ренни ухаалаг байгаач гуйя.

"Гуйя" энэ үг Том Жимд тун их таалагдаж сэтгэл санааны сайхан байдал тэр дороо эргэн ирэв.

-Хурандаа Кокс, алив дүнгээ гаргая. Энд би биш Энди Сандерс удирдаж байгаа. Хэдийгээр би тань шиг том самар над руу утасдаж гийгүүлсэнийг үнэлж байгаа ч тийм юм. Бас Энди ч тэндээс алсын удирддагаар биднийг удирдах таны саналыг эргэлзээгүй үнэлэх болно... Би яг одоо түүний хариултыг танд дамжуулж чадна гэж бодох юм. Тэр таныг саналаа эргүүлж аваад нар тусдаггүй тэр газар руугаа шургуул гэж хэлж таарна. Бид энд өөрөө өөрийнхөө хувь заяанд даатгагдсан бөгөөд бие даан учрыг нь олохыг зорьж байна.

-Тийм ээ, та үнэхээр солиотой хүн юм гэх Коксын дуунд гайхаад барахгүй өнгө тодорно.

-Бурхангүй хүмүүс сүсэг бишрэлтэй хүмүүсийг дандаа ингэж нэрлэдэг. Энэ бол шашин шүтлэгийн эсрэг тэдний хамгаалалтын сүүлчийн бүс юм. Бид ийм юманд дассан. Тийм учраас таныг буруутгахгүй гэх үедээ тэр худлаа ярьж байв. -Би танаас нэг юм асууж болох уу?

-Мэдээж.

-Та нар утас ба компьютеруудыг салгах гэж байгаа юу?

-Тэгвэл танд таалагдана тийм үү?

-Мэдээж үгүй гэх үед тэр дахиад худлаа хэлэв.

-Утас ба компьютерууд үлдэнэ. Баасан гаригийн хэвлэлийн бага хурал ч хэвээр үлдэнэ. Тэр үед та маш хүнд асуултуудад хариулах хэрэг болно доо.

-Ойрын ирээдүйд би ямар хэвлэлийн бага хуралд оролцох бодолгүй байгаа хурандаа. Энди ч бас. Хатагтай Андреагаас юу ч гарахгүй дээ хөөрхий. Тийм ч учраас та тэрнийгээ хойшлуулах...

-Үгүй, үгүй, огт үгүй гэх Коксын царайд инээмсэглэл тодорлоо гэж үү? -Хэвлэлийн бага хурал Баасан гаригийн үд дунд болно. Таны хэлсэнээр оройн мэдээгээр шамбарамын тос аль болох олныг зарахад туслахын тулд.

-Тэгээд түүнд чинь манай хотоос хэн оролцох юм бэ?

-Бүгд. Ренни. Бүгд. Яагаад гэвэл бид тэдний хамаатан саднуудад Бүрхүүлд ойртохыг зөвшөөрнө. Ноён Сандерсын эхнэр онгоцтойгоо унаж сүйдсэн газрыг та санаж байгаа. Тэнд, Моттоны хил талаас. Хэвлэл мэдээлэл бүхнийг бичих болно. Энэ бол шоронд болж байгаа нээлттэй хаалганы өдөр. Гэхдээ энэ шоронд байгаа хүмүүсийн хэн ч ямар ч буруугүй. Гэхдээ танаас бусад нь.

Ренни дахиад уур хилэнд авглаа.

-Та нар үүнийг хийж чадахгүй.

-Мэдээж чадна гэх үедээ Кокс инээж байв.

-Та Бүрхүүлийн өөрийнхөө талд суугаад надад хамраа харуулж болно. Харин би өөрийнхөө талд суугаад бас тэгж хариулна. Харин зочид хязгаарын дагуу эгнэж зогсоод зөвшөөрч байгаа хүн бүхэн "Дейл Барбара буруугүй" "Дейл Барбараг чөлөөл", "Жеймс Ренни огцор" гэсэн бичигтэй цамц өмсөх болно. Аз жаргалын нулимс урсч, хүмүүс бие биеийнхээ гаранг гарнаа наана. Хэдийгээр дунд нь Бүрхүүл байгаа ч хүмүүс үнсэлцэх гэж оролдох болно. Энэ бүхэн зурагтаар тун сайхан гарна даа. Үзэл суртлын хүчтэй үр нөлөөг хэлэх ч аргагүй. Хамгийн гол нь энэ бүхэн танай хотын ард иргэдийг бодоход хүргэнэ. Тан шиг чадваргүй хувь хүн жолоог барьж байгаа юм бол яахаа бодно.

Том Жимийн дуу хоолой уухилалт болон хувирав.

-Би үүнийг зөвшөөрөхгүй.

-Та тэгээд тэднийг яаж зогсоох юм бэ? Хэдэн мянган хүн шүү дээ. Та тэднийг бүтдийг нь буудаж чадахгүй гэснээ Кокс дуугаа хураав. Тэгээд дахин ярьж эхлэхэд түүний дуу тайван, ухаалаг болсон байлаа. -Хотын захиргааны гипгүүн та сонс. Бүх талаар тохиролцё. Та уснаас хуурай гарч болохоор байна. Үүний тулд хотын удирдлагыг өөр хүнд шилжүүлэх хэрэгтэй.

Жижгээ энэ үед унтлагын өмд ба углааштайгаа яг хий үзэгдэл шиг амьтан хонгилоор явж гадаа гарах хаалга руу чиглэхийг Том Жим харж байв. Гэхдээ огт тоосонгүй. Хэрэв Жижгээ үүдний өрөөнд унаад үхлээ гэхэд Том Жим нэг гартаа утас нөгөө гартаа алтадсан бейсболын бөмбөг барьсан чигээр ширээндээ суусаар байх байсан. Толгойд нь ганцхан бодол эргэлдэнэ. Андреад удирдлагыг шилжүүлж түүнд том хөхт цагдаа туслах юм гэнэ.

Харин ч нэг тоглоом наадам байна даа.

Муу тоглоом.

-Хурандаа Кокс та чөтгөр рүү тонилвол яасан юм бэ?

Тэр утсаа таслаад сандалтайгаа эргэнгүүтээ алдатсан бейсболын бөмбөгөө чулуудав. Бөмбөг Тайгер Вудсын гарын үсэгтэй гэрэл зургийг онолоо. Шил хагаран нижигнэж хүрээ нь шалан дээр унаж ирэв. Өөрөө барагтай бол айдаггүй бөгөөд хүмүүс түүнээс айдагт дассан Картер давхийн цочоод үсрэн босов.

-Ноён Ренни та зүтээр үү?

Тийм ч сайн биш харагдаж байна. Хацар дээр нь хүрэн улаан толбонууд асчээ. Жижиг нүд нь ухархайнаасаа бүлгийж цухуйсан тул хэмжээ нь томорсон байв. Духан дээр нь судас гүрэлзэнэ.

-Тэд хэзээ ч энэ хотыг надаас булааж чадахгүй гэж Том Жим шивнэлээ.

-Мэдээж булаахгүй. Та үгүй бол бид живнэ пгүү дээ гэж Картер үгийг нь дагуулав.

Энэ үг Том Жимийг жаахан тайвширахад тус болжээ. Тэр утас авсанаа Рэндолф унтахаар гэртээ харьсаныг саналаа. Хямрал эхэлснээс хойш шинэ дарга бараг л нүд аниагүй яваа. Тэгээд өнөөдөр багаар бодоход үд дунд хүртэл унтана гэж Том Жимд хэлсэн. Тэр нь сайн. Гэхдээ түүнээс тэртэй тэргүй гарах ашиг тун бага.

-Картер бич. Өнөө өглөө даргыг Моррисон орлож байгаа бол зурвасыг түүнд үзүүл. Тэгээд дараа нь Рэндолфын ширээн дээр тавиарай. Дараа нь наашаа эргэж ир гээд тэр хөмсөг зангидан дуугаа хураав.

-Бас Жижгээ цагдаагийн газарт ирсэн эсэхийг хар. Би өнөөх хурандаа Миний-хүссэнийг-хий гуайтай ярьж байх хооронд тэр гэрээс гарсан. Хэрэв тэр цагдаагийн газарт ирээгүй бол хайх хэрэггүй. Хэрэв ирсэн бол түүний бүх юм зүгээр эсэхийг шалгаарай.

-Мэдээж. Юу гэж бичих вэ?

-Хүндэт цагдаагийн дарга Рэндолфод. Цагдаа Уэттингтоныг Честерс-Милл хотын цагдаагаас цаг алдалгүй зайлуул.

-Халах гэж үү?

-Яг тийм гэхэд Картер тэмдэглэлийн дэвтэртээ бичиж эхэлсэн бөгөөд Том Жим түүнд цаг өгөв. Түүний бие дахиад дээрджээ. Сайн гэхээс ч илүү байв. Түүнийг 6 дахь мэдрэмж нь хөтөлнө. -Бас нэмж бич. "Цагдаа Моррисонд. Уэттингтоныг өнөөдөр цагдаагийн газарт ирэхэд нь халагдсан гэдгийг түүнд мэдэгд. Хувцас солих өрөөний шүүгээнээс эд юмсаа аваг. Хэрэв тэр шалтгааныг асуувал цагдааг өөрчлөн зохион байгуулж байгаа бөгөөд шинэ бүтцэд түүний хэрэг гарахгүй" гэж хэл.

-Өөрчлөн зохион байгуулах гэхэд чинь о үсэг орох уу ноён Ренни?

-Яаж бичих нь чухал биш. Гол нь утга нь. -Ойлголоо. Бичсэн.

-Хэрэв түүнд асуудал үүсэх юм бол над дээр ирэг. -Ойлголоо. Ингээд болоо юу?

-Үгүй. Түүнийг анх харсан хүн цагдаагийн тэмдэг ба гар бууг нь хурааж авах ёстой. Хэрэв тэр зөрүүдлэж энэ нь хувийн зэвсэг гэх юм бол хямрал дууссаны дараа түүнд гар бууг нь буцааж өгөх юмуу эсвэл үнийг нь төлж барагдуулна гэсэн баталгаа гаргаж өг.

Картер бичиж дуусаад толгойгоо өргөв.

-Ноён Ренни таныхаар Жижгээгийн юу нь нэг л биш байна

вэ?

-Мэдэхгүй. Зүгээр хатгадаг өвчин гэж бодох юм. Гэхдээ юу байлаа ч гэсэн надад одоо цаг алга. Илүү чухал ажил байна гээд тэр тэмдэглэлийн дэвтэр рүү зааж -Нааш нь өг.

Картер дэвтэрээ өгөв. Тэр гуравдугаар ангийн хүүхэд шиг арзайлган бичжээ. Гэхдээ юу ч орхисонгүй. Ренни гарын үсгээ татлав.

9

Картер нарийн бичгийн хөдөлмөрийнхөө үр дүнг цагдаагийн газарт хүргэлээ. Генри Моррисон зурвасыг уншаад бослого гаргах шахав. Картер Жижгээг харцаараа хайсан ч тэр цагдаагийн газарт орж ирээгүй бөгөөд хэн ч хараагүй байжээ. Хэрэв Жижгээ гэнэт орж ирвэл анзаарч байгаарай гэж Картер

Генригээс гуйлаа.

Дараа нь гэнэт сэтгэл хөдлөлдөө автан доошоо Барбара руу буув. Өнөөх нь гараа дэрлэчихсэн ханзан дээрээ хэвтэнэ.

-Танай босс утасдсан. Өнөөх Кокс. Ноён Ренни түүнийг хурандаа Миний-хүссэнийг-хий гэж нэрлэсэн.

-Тэгж нэрлэж байгаа гэдэгт мөрий тавихад бэлэн байна. Ноён Ренни түүнийг хөгжилтэй дөрвөн үсэгнээс бүтсэн үг рүү илгээсэн. Яасан гэдгийг мэдэх үү? Чиний армийн танил үүнийг дуугүй залгиад инээхэд хүрсэн. Энэ талаар чи юу гэж бодож байна даа?

-Би огт гайхахгүй байна гэж хэлэхдээ Барби тааз ширтсэн хэвээр байх бөгөөд дуу нь тайван байлаа. Энэ нь Картерын уурыг хүргэнэ.

-Картер чи энд юу болоод байгаа талаар бодож үзсэнгүй юу? Ирээдүй рүүгээ шагайх гэж оролдов уу?

-Ирээдүй гэж байхгүй. Адаглаад энд.

Барби урьдын адил тааз ширтэх бөгөөд хөнгөн инээмсэглэл амны буланг багахан мурийлгав. Яг л тэр Картерын мэдэхгүй зүйлийг мэдээд байгаа юм шиг. Картер хорих өрөөг нээж энэ баасын сүнсийг зайлуулахыг маш их хүсэв. Гэвч "Дипперс" зогсоол дээр болсон явдлыг санав. Тэгээд хэрэв Барбара чаддаг л юм бол цэргийн арга мэхүүдээ буудах багийн өмнө хэрэглэг гэж шийдлээ.

-Дахиад уулзана аа Барби.

-Би үүнд итгэлтэй байна гэж хэлэхдээ Барби Картер руу харсан ч үгүй. -Манай хот жижигхэн, хүү минь. Бид бүгд нэг л багийн хөгжөөн дэмжигчид.

10

Хаалганы хонх дуугарахад Пайпер Либби "Бостоны баавгайнууд" цамц ба унтлагын хувцасны үүрэг гүйцэтгэдэг богино өмдөө тайлж, арай аятайхан хувцас өмсч амжаагүй байлаа. Энэ өглөө арван цагт уулзаж Жоржиягийн оршуулгын тухай ярилцахаар тохирсон Элен Ру нэг цагийн өмнө ирсэн гэдэгт итгэлтэйгээр хаалгаа нээв. Гэтэл босгон дээр Жекки Уэттингтон зогсч байлаа. Цагдаагийн дүрэмт хувцастай боловч энгэрт нь тэмдэг, ташаанд нь буу алга. Тэр их цочирдсон харагдана.

-Жекки юу болсон бэ?

-Намайг халчихлаа. Энэ новш цагдаагийн газарт болсон зул сарын баярын үдэшлэгээс хойш надад өс санажээ. Намайг савардах гэхээр нь би гар руу нь цохичихсон юм. Гэхдээ шалтгаан зөвхөн үүнд байгаа гэдэгт би эргэлзээд байна...

-Орооч гэж Пайпер хэлээд хажуу тийш боллоо.

-Би зоорины өрөөний нэг пгүүгээнээс спиртэн халаагуур олсон. Миний өмнөх лам үлдээсэн байх. Гайхалтай нь тэр сайн ажиллаж байна. Халуун цай уух уу?

-Дуртайяа гэж хэлэх үед бүсгүйн нүдэнд нулимс дүүрээд хацрыг нь даган урслаа. Тэр бараг ууртай гэмээр нулимсаа арчив.

Пайпер түүнийг гал тогоонд дагуулан очоод ширээн байгаа "Бринкман" спиртэн халаагуурыг асаав. -Харин одоо надад бүхнийг яриад өг.

Жекки бүгдийг ярьлаа. Генри Моррисоны болхидуу боловч чин сэтгэлийн харууслын үгийг ч үлдээсэнгүй.

-Тэр надад шивэгнэж хэлсэн гээд Пайперийн гараас аягыг авав. -Одоо тэнд жинхэнэ утгаараа гестапо үүсчихлээ. Ингэж хэлсэнд уучлаарай.

Пайпер гараа савав.

-Хэрэв би хотын хурал дээр эсэргүүцэх юм бол бүр дор юм болно гэж Генри хэлсэн. Ренни намайг чадваргүй гэж буруутгана гэсэн. Тэр үнэн байх. Гэхдээ хэрэв чадваргүй талаар ярих юм бол энэ тал дээр цагдааг толгойлж яваа хүн тэргүүлнэ. Реннигийн тухайд бол... Тэр түүний төлөвлөгөөнд зохион байгуулалттай эсэргүүцэл үзүүлэх тохиолдолд өөрт нь үнэнч байх цагдаа нарыг цуглуулж байгаа.

-Ойлгомжтой хэрэг гээд Пайпер толгой дохилоо.

-Олонхи шинэ цагдаа нар шар айраг авахад ч нас хүрэхгүй мөртлөө зэвсэгтэй явж байна. Би тэндээс нисэх дараагийн нэр дэвшигч нь чи гэж Генрид хэлэхийг хүссэн юм. Тэр Рэндолфын удирдлагын талаар шүүмжлэлтэй ярьсан. Мэдээж бялдуучлагчид түүний үгийг дамжуулж таарна. Гэвч Генригийн царайгаар тэр өөрөө ч үүнийг мэдэж байгаа гэдгийг ойлгосон.

-Чи намайг Ренни дээр очоосой гэж хүсч байна уу?

-Ингэлээ гээд тус болохгүй. Хэрэв үнэнийг хэлэх юм бол би цагдаад алба хаахгүй болсондоо харамсахгүй байна. Зүгээр л халсанд нь дургүй хүрээд байна. Тэгсэн байлаа ч гэсэн намайг халлаа гээд энэ нь маргааш орой болох явдалд би тун муу хүн гэдгээ харуулахад минь нөлөөлөхгүй. Би Барбитай хамт нуугдах хэрэг болох байх. Мэдээж нуугдах газар олдвол.

-Чиний юу яриад байгааг би ойлгохгүй юм.

-Би мэдэж байгаа. Чамайг ч бас мэдүүлэх болно. Гэхдээ энэ бол аз туршилт гэдгийг тооцоорой. Хэрэв чи хэн нэгэнд ярих л юм бол би өөрөө Тахианы-саравчинд очно. Магадгүй Ренни буудах багаа гаргаж ирэхэд би Барбигийн дэргэд зогсч ч мэднэ.

Пайпер түүнийг нүд салгалгүй ширтэв.

-Жоржия Ругийн ээж 45 минутын дараа ирнэ. Энэ хооронд бүхнийг ярьж амжих уу?

-Хангалттай гээд Жекки оршуулгын товчоонд цогцосны үзлэг хийснээс эхэллээ. Лестер ламын нүүрэн дээрх шарх болоод Растигийн харсан бейсболын алтан бөмбөгийн талаар яриу. Хотын онцгой хурлын үеэр Барбиг чөлөөлөх төлөвлөгөөний талаар ярихын өмнө гүнзгий санаа алдав. -Гэхдээ бид түүнийг шоронгоос гаргалаа ч гэсэн хаана нуух талаар мэдэх юм алга. Чи юу гэж бодож байна? гээд цай уув.

-Би одоохондоо өөртөө цай аягалахаа л бодож байна. Чамд хийх үү?

-Минийх болсон. Баярлалаа.

Пайпер спиртэн халаагуурт дөхөж очлоо.

-Чиний төлөвлөгөө маш аюултай. Би энэ тухай чамд ярих эсэхдээ эргэлзэж байна. Гэвч гэм буруугүй хүний амийг аврах өөр арга үгүй юм шиг байна. Дейл Барбара хүн амины хэрэгт буруугүй гэдэгт би нэг хором ч эргэлзэж байгаагүй. Харин орон нутгийн цагдаа нартай ойрхон харьцаж үзсэний дараа хэрэв тэд түүнийг буудчихлаа гэхэд огт гайхахгүй. Түүнд эрх мэдэл өгөхгүйн тулд гэж ярьсанаа өөрөө ч мэдэлгүй Барбигийн бодлыг үргэлжлүүлэн яриу.

-Ренни ирээдүйг харж чадахгүй. Цагдаа нар ч бас. Тэд одоо ганцхан зүйлд санаа зовж байгаа нь хэн хотын хаан бэ? Сэтгэлгээний ийм хэлбэрээс зөвхөн гай түйтгэр хүлээж болно гэснээ тэр дахин сандал дээр суув. -Би хүүхэд байхаасаа эхлээд номлогч болохыг мөрөөддөг байсан ба номлогч болоод энэ хотод ирсэн цагаас эхлэн Жим Ренни бол мангасын үр хөврөл гэдгийг мэддэг байсан. Чи миний утга уянгын халилыг уучлаарай. Гэхдээ одоо тэр мангас болоод томорчихлоо.

-Бурхны аврал.

-Чи мангас төрсний төлөө бурханд талархаад байгаа юм уу? гэж Пайпер инээж хөмсөгөө сөхөв.

-Үгүй. Бурхны авралаар чи надтай санаа нэг байна.

-Гэвч чи бүгдийг нь хэлээгүй тийм үү?

-Бүгдийг нь биш. Гэхдээ хэрэв чи үүнд оролцохоос татгалзахгүй бол болно.

-Хонгор минь би аль хэдийн оролцоод эхэлчихсэн. Хэрэв чамайг завдсаны төлөө суулгалаа гэхэд намайг мэдсэн мөртлөө нуун дарагдуулсны төлөө суулгах болно. Одоо бид манай засгийн газрын хэлэх дуртайгаар бол "санаа нийлсэн алан хядагчид"

Жекки дуугүй л байлаа.

-Чи зөвхөн Барбарагийн чөлөөлөлтийн тухай бодоогүй тийм үү? Эсэргүүцлийн идэвхитэй хөдөлгөөн зохион байгуулахыг хүсч байна уу?

-Тийм гэж бодож байна гээд Жекки инээв. Гэхдээ түүний инээдэнд арчаагүй байдал тодорно. Би АНУ-ын армид 6 жил алба хаасан мөртлөө өөрийгөө ийм гэж бодсонгүй... Үргэлж тушаал биелүүлнэ. Ингэхэд Бүрхүүл алга болохгүй байж мэднэ гэсэн бодол чиний толгойд төрж байсан уу? Энэ намар бас өвөл ч. Магадгүй дараа жил үү? Эсвэл биднийг үхэх хүртэл байх уу?

-Тиймээ гэх Пайперийн дуу тайван байсан ч хацар нь хувхай цайжээ. -Тийм бодол төрж байсан. Ийм санаа Миллийн бүх хүнд төрсөн гэж би бодож байна. Гэхдээ хэн ч нухацтай бодоогүй байх л даа.

-Харин одоо өөр юм бод. Чи нэг жил юмуу таван жилийг энэ алуурчин-тэнэгийн дарангуйлал дор өнгөрөөхийг хүсэх үү? Бид таван жил амьд байна гэж үзэх тохиолдолд шүү дээ.

-Мэдээж үгүй.

-Тэгвэл түүнийг одоо л зогсоож чадна. Тэр одоо үр хөврөл биш болсон. Түүний барьж байгуулж байгаа бүтэц болох цагдаагийн машин үр хөврөлийн шатандаа байгаа юм. Одоо хамгийн тохиромжтой цаг гээд Жекки дуугаа хурааснаа: -Хэрэв тэр жирийн иргэдийн буу зэвсгийг хураах тухай тушаалыг цагдаад өгөх юм бол өөр тохиромжтой цаг гарах ч үгүй.

-Чи надаас юу хүсээд байгаа юм бэ?

-Танай гэрт хурал зохион байгуулъя. Өнөө орой. Найдвартай хүмүүсийг урья гээд арын хармаанаасаа Линда Эвереттэй хамт зохиосон жагсаалтаа гаргаж ирэв.

Пайпер хуудас цаасыг дэлгээд найман хүний нэр уншив.

-Биедээ талст авч явдаг номын санч Лисса Жеймисон уу? Эрни Кэлверт үү? Энэ хоёрт чи итгэж байна уу?

-Бидэнд өндийж буй дарангуйлал заналхийлэх үед номын санчаас илүү хамтран зүтгэгч олдох уу? Эрнигийн тухайд бол...Миний ойлгож байгаагаар их дэлгүүрийн дэргэд болсон явдлаас хойш хэрэв тэр галд шатаж байгаа Жим Ренниг харлаа гэхэд ус цацаж галыг унтраахаар зогсохгүй л хүн.

-Үүнээс илүү нүдэнд үзэгдтэл яаж хэлэх билээ дээ.

-Би Жулия Шамуэйг Эрни Лисса хоёр дээр оч гэж хэлэх гэж байсан юм. Одоо өөрөө хийхээс дээ. Би одоо чөлөөт цаг ихтэй болчихлоо.

Хонх дуугарав.

-Гашуудсан эх байх гээд Пайпер бослоо. -миний ойлгож байгаагаар нилээд халсан байх. Тэр кофены амттай бренди уух дуртай. Гэхдээ энэ архи түүний зовлонг намдаана гэдэгт би эргэлзэж байна.

-Чи энэ хуралд хэрхэн хандаж байгаагаа надад хэлсэнгүй гээд Жекки босч ирлээ.

Пайпер Либби инээмсэглэв.

-Манай "санаа нийлсэн алан хядагчид"-д оройн есөөс арав хагасын хооронд ир гээрэй. Хоёр хөлөөрөө, нэг нэгээрээ цуварч ир гээ. Францын Эсэргүүцлийн хөдөлгөөнийхний стандарт дүрэм. Бид юу хийж байгаагаа бусдад мэдэгдүүлэх шаардлагагүй.

-Чамд маш их баярлалаа.

-Юу ч биш. Энэ бол миний хот. Хэрэв би чамайг арын хаалгаар гар гэвэл дургүйцэхгүй биз дээ?

Фургон машинаасаа Берпи боодолтой цэвэрхэн алчуурууд олов. Расти хоёр хоёроор нь холбож амны хаалт болгоод нүүрнийхээ хагасыг дарж боолоо. Гэсэн хэдий ч хамар ба амаар нь үхсэн баавгайн өмхий үнэр ханхлана. Нүд, онгорхой ам ба задарсан тархин дээр нь өт язганана.

-Расти босоод найгаж хойш ухрахад Ромми тохойноос нь тулав.

-Хэрэв тэр ухаан алдах юм бол бариад аваарай. Том хүмүүст илүү хол зайнаас үйлчилдэг байж мэднэ гэж Жо цухалдлаа.

-Энэ зүгээр л үнэрээс болж байгаа юм. Одоо хэвийн болчихлоо гэж Расти тайвшруулав.

Гэхдээ л баавгайнаас хангалттай хол зайнд ч орчин тойрон нь өмхий үнэртсээр байлаа. Честерс-Милл хот тэр чигээрээ ганц том хаалттай өрөө болсон мэт агаар нь угаатай хүнд болжээ. Утаа ба амьтдын ялзарсан үнэрээс гадна муудсан ургамал болоод намгийн өмхий үнэрийг Расти мэдэрч байлаа. Энэ өмхий үнэр ширгэж байгаа Престил-Стрим голоос ханхалж байгаа нь эргэлзээгүй. Хэрэв бага зэрэг ч гэсэн салхи байсан бол гэж Расти бодов. Гэвч хааяа нэг бараг үл мэдэгдэм үлээх салхи бүр илүү муухай үнэр авчирна. Тэртээ баруун зүгт борооны үүл хуралдана. Нью-Хэмпширт хувингаар юүлэх мэт асгаж байгаа бололтой. Гэвч үүл Бүрхүүлд тулж ирэнгүүтээ аварга том хадан хамарт тулах гол мэт дундуураа хуваагдах ажээ. Хэрэв зав гарах юм бол аль нэг цаг уурын сайтыг үзэх хэрэгтэй юм байна гэж Расти дүгнэв. Ажил улам их болж, харин эмх журам багассаар байлаа.

-Эмч ээ, баавгай галзуурч үхсэн байж болох уу? гэж Ромми асуув.

-Эргэлзэж байна. Энэ бол хүүхдүүдийн хэлснээр амиа хорлолт гэж бодож байна.

Тэд эргээд фургонд суулаа. Ромми жолоо барьж, тэд Блек-Ридж-Роудаар аажуухан явав. Гейгерийн тоолуур Растигийн өвөр дээр байв. Чад чадхийн дуугарна. Зүү нэмэх хоёр зуу руу өгсөхийг Расти ажиглана.

-Ноён Берпи энд зогсоорой. Ойгоос гарахаас өмнө. Хэрэв та тасрах юм бол энэ нь машин явж байх үед болоосой гэж би хүсэхгүй байна. Машины хурд цагт арван миль байсан ч хүсэхгүй гэж Норри дуу алдав.

Ромми дуулгавартайгаар тоормос гишгэлээ.

-Гараарай хүүхдүүд ээ, би та нарыг хариуцна. Цаашаа эмч ганцаараа явна. Жолооны ард суу. Гэхдээ хурд нэмэх хэрэггүй шүү. Хэрэв цацраг идэвхижил аюултай түвшинг давах юм бол зогсоорой. Эсвэл бие чинь муудвал зогсоно шүү. Бид араас чинь явна гэж тэр Растид хэлэв.

-Ноён Эверетт болгоомжтой байгаарай гэж Жо санууллаа.

-Битгий санаа зов. Хэрэв тасрах юм бол замын хажуу руу ороорой. Ухаан орохоор чинь бид зам дээр татаж гаргана гэж Берпи нэмж хэллээ.

-Баярлалаа. Чиний зүрх их эелдэг шүү гээд Расти толгой дохилоо.

-Юу гэнэ ээ? -Чухал юм биш ээ.

Расти чулууны ард сууж хаалгаа хаав. Хажуугийн сандал дээр Гейгерийн тоолуур тачигнана. Фургон ойгоос тун аажуухан гарлаа. Өмнө нь Блек-Ридж-Роуд зам алимны цэцэрлэг рүү өгссөн харагдана. Эхлээд Расти онц юм юу ч олж хараагүй бөгөөд хоромхон хугацаанд урам хугарав. Дараа нь хурц улаан гялсхийлт нүдийг нь алгадах шиг болоход тэр тоормосоо огцом

гишгэлээ. Арчилгаагүй хаясан алимны модод ба бутсын дунд ямар нэг юм эргэлзээгүй байна. Толиор хойд талаа харвал бусад нь бас зогссон байлаа.

-Расти зүтээр үү? гэж Ромми хашгирав.

-Би түүнийг харж байна.

Тэр 15 хүртэл тоолоход улаан гэрэл дахиад гялсхийв. Расти Гейгерийн тоолуур руу гараа сунгатал жолоочийн хаалган дээр Жо хүрч ирлээ. Түүний арьсан дээгүүр шинэ тууралт өгч гялтгануур чулуу шиг болжээ.

-Та ямар нэг юм мэдэрч байна уу? Толгой эргэх юмуу бие сулрах.

-Үгүй.

Жо урагшаа заав.

-Яг тэнд бид тасарсан. Бараг дэргэд нь байна.

Замын зүүн талаар үлдсэн мөрнүүдийг Расти харлаа.

-Та нар дөрвүүлээ тийшээ оч. Дахиад тасрах эсэхийг харцгаая гэж тэр тушаав.

-Бурхан минь би одоо юу вэ? Туршлагын туулай юу? гэсээр Бенни Жо дээр ирэв.

-Тэрэндээ хүрэх юм бол туршлагын туулай нь Ромми шүү. Ромми чи бэлэн үү?

-Тийм ээ, хэрэв би тасраад та нар зүтээр байх юм бол намайг нааш нь чирж авчраарай. Энд бол хэнд ч, ямар ч аюул алга гэж тэр залууст хандан хэллээ.

Дөрвүүл шороон дээр гарсан мөр рүү хөдлөв. Расти фургоны жолоон дээр тонгойгоод тэднийг нүд үл салган ширтэнэ. Тэд үнгэлдсэн шороо руу бараг хүрч явтал Ромми эхлээд алхаа нь удаашраад дараа нь найган ганхав. Норри Бенни хоёр нэг талаас нь, Жо нөгөө талаас нь тулахаар ухасхийлээ. Гэвч Ромми унасангүй. Тэр дороо тэгшрэв.

-Энэ жинхэнэ юмуу эсвэл би мэдэхгүй байна... юу гэж нэрлэмээр юм... итгүүлэх хүч гэх үү? Гэвч би одоо хэвийн байна. Ганц хором толгой эргэсэн. Хүүхдүүд ээ та нар юм мэдэрсэн үү?

Тэд толгой сэгсрэв. Расти үүнд гайхсангүй. Салхин цэцэг өвчин шиг. Бараг бүх хүүхдүүд өвчилдөг гэхдээ нэг л удаа өвчилдөг.

-Эмч ээ яваарай. Чи мэдээж тулгамдсан шаардлага гарахгүй бол тугалган тууз үүрч явахыг хүсэхгүй байх. Гэхдээ болгоомжтой байгаарай гээд Ромми даллав.

Расти аажуухан явлаа. Гейгерийн тоолуур хурдан хурдан тачигнахыг сонсоно. Гэхдээ ер бусын ямар ч юм мэдэрсэнгүй. Алимны цэцэрлэгт 15 секунд тутамд ямар нэг юм гялсхийнэ. Тэр Ромми ба хүүхдүүдтэй зэрэгцэж ирээд өнгөрч явав.

-Би юу ч мэдрэхгүй... хэмээн ярьж эхэлтэл ер бусын юм боллоо. Толгой эргэх биш л дээ. Гайхалтай хурц тод мөртлөө бас бүх юмнаас хөндийрч одох мэт мэдрэмж төрөв. Яг энэ үед бол түүний толгой дуран авай болж хувираад ямар ч зайнаас хүссэн юмаа олж харж чадах мэт санагдав. Хэрэв хүсэх юм бол Сан-Диегод ажилдаа явж байгаа ахыгаа ч харж чадах мэт.

Хөрш орчлон ертөнцөөс Беннигийн дуу хүрч ирнэ.

-Пөөх Расти эмч биднээс холдож байна.

Гэвч тэр хаашаа ч холдсонгүй. Ойн замыг тод харж байв. Гайхалтай тод. Чулуу бүрийг, гялтагануурын гялалзах шигтгээ бүрийг харна. Тэгээд хэрэв тэр замаасаа гарсан бол үүний дараа буюу яг өмнө нь гэнэт гарч ирсэн эрэгтэй хүнийг дайрахаас зайлсхийхийн тулд билээ. Энэ нь улаан-цагаан-цэнхэр өнгийн тэнэг бортого малгайг инээдтэй хэлтгий тавьсан туранхай эр бөгөөд ийм малгайтайн улмаас их өндөр харагдана. Тэр жинсэн өмд ба дээр нь "Манай төрөлх Алабама"-Сүйрсэн хамтлагийн энэ дууг хамт тоглооч" гэсэн бичигтэй цамц өмсчээ.

Энэ хүн биш. Энэ хэллоуины хүүхэлдэй.

Мэдээж тийм. Өөр хэн байх юм бэ? Нүднийх нь оронд цагаан хэрээс оёсон шуудайн толгойтой, гартаа цэцэрлэгийн ногоон шүүр барьсан

-Эмч ээ, эмч ээ гэх Роммигийн дуу гарав.

Хэллоуины хүүхэлдэй галан хэлээ хурц гялалзуулав.

Хормын дараа бүх юм алга боллоо. Зам, орой дээр байх алимны цэцэрлэг ба 15 минут тутамд гялсхийх гэрэл л үлджээ. Тэр гэрэл нааш ир, нааш ир гэх шиг болов.

12

Ромми жолоочийн талын хаалгыг нээв. -Эмч ээ... Расти... Чи яаж байна?

-Маш сайн. Энэ юм ирээд явчихлаа. Чам шиг л гэж бодож байна. Ромми чи ямар нэг юм харсан уу?

-Үгүй. Гал үнэртэж байна гэж хоромхон зуур бодсон. Гэвч агаар утаатай болоод тэр биз.

-Би бол шатаж байгаа хулууны түүдэг үзсэн. Би энэ тухай ярьсан тийм үү? гэж Жо хэллээ.

-Тийм ээ.

Расти тэгэхэд Жогийн үгэнд анхаарал хандуулаагүй. Ийм үгсийг төрсөн охиныхоо амнаас ч сонссон удаатай. Харин одоо тун их анхаарав.

-Би хашгираан сонссон. Гэвч бусдыг нь мартчихжээ гэж Ренни сэтгэгдлээ хуваалцлаа.

-Би ч бас сонссон. Өдөр байсан мөртлөө тас харанхуй болсон. Хаа нэгтээ хашгирсан. Бас нүүрэн дээр хөө тортог унасан гэж Норри толгой дохив.

-Эмч ээ, бид буцсан нь дээргүй юу? гэж Ромми санал гаргалаа. Тийм юм болохгүй. Надад өөрийн хүүхдүүд болоод үлдсэн бүх хүүхдийг ийм байдлаас гаргах боломж байгаа цагт хэзээ ч тэгэхгүй.

-Зарим томчууд ч явахад бэлэн гэж бодож байна хэмээн Бенни нэмлээ. Жо түүнийг тохойгоор нудрав.

Расти Гейгерийн тоолуурыг харав. Зүү нэмэх 200 дээр наалджээ.

-Эндээ үлдэцгээ гэж тэр тушаалаа.

-Эмч ээ, хэрэв цацраг нэмэгдээд та ухаан алдвал яах вэ? Тэгвэл бид яах вэ? гэж Жо асуулаа. Расти хариуг бодов.

-Хэрэв би ойрхон байх юм бол намайг татаж аваарай. Гэхдээ Норри чи биш, зөвхөн эрчүүд.

-Яагаад би биш гэж?

-Яагаад гэвэл чи хүүхэдтэй болохыг хүсэх өдөр ирнэ. Гэхдээ хоёр нүдтэй, хөл гар нь байх ёстой газраа байгаа тийм хүүхэдтэй. Ойлголоо энд үлдье гэж Норри толгой дохив.

-Бусдын хувьд өндөр цацраг идэвхижлийн бүсэд богино хугацаанд ороход хор учрахгүй. Гэхдээ би маш богино хугацааны тухай ярьж байна. Хэрэв би толгой руу хүрэх замын талыг туулах юмуу цэцэрлэгт орох юм бол намайг тэнд нь үлдээ.

-Эмч ээ ингэж болохгүй гээд Ромми толгой сэгсэрлээ. -Үүрд биш л дээ. Танай дэлгүүрт хар тугалган тууз дахиад байгаа юу?

-Тийм ээ, бид бүгдийг нь наашаа авчрах байж дээ.

-Зөвшөөрч байна. Гэвч бүхнийг урьдчилж харах биш дээ. Хэрэв муу юм болох юм бол туузыг авчирч ирсэн машиныхаа цонхыг түүгээр хаагаад намайг аваарай. Чөтгөр гэж, тэр үед би ухаан ороод хот руу хоёр хөлөөрөө ирж ч мэднэ.

-Тийм ээ, эсвэл үхлийн тун аваад хэвтэж байж ч болох юм.

-Ромми бид дэмий санаа зовж байх шиг байна. Энэ түр зуурын үйлчлэл гэж би бодож байна. Хүүхдүүдийн ухаан алдаж байгаа ижил төстэй байдал нь Бүрхүүлтэй холбоотой бусад гэнэтийн зүйлсээс ялгагдахгүй байна. Чи түүнийг нэг удаа мэдрээд цаашдаа зүгээр болно.

-Чи амь насаараа дэнчин тавьж байх шиг.

-Ямар нэг хугацаанд бид мөрий тавих хэрэг гарна.

-Танд амжилт хүсье гээд цонхоор нударгаа оруулав.

Расти өөрийн нударгыг хөнгөн мөргүүлээд Норри Бенни нартай ч ингэв. Ромми тэднээс хоцорсонгүй.

-Хүүхдүүдэд сайн юм бүхэн надад сайн.

13

Растид бортого малгайтай хүүхэлдэй үзэгдсэн тэр газраас 20 ярд өнгөрөхөд Гейгерийн тоолуурын чадхийх нь улам нэмэгдэв. Зүү нэмэх 400 дээр очиж, улаан бүс рүү бараг орох шахаж байгааг тэр харлаа.

Расти машинаа зогсоож фургоноос өмсөхийг үл хүсэх өмсгөлөө гаргаж ирэв. Бусад руугаа харлаа.

-Эхний бөгөөд ганц удаагийн сануулга. Энэ нь юуны өмнө Беннид хамаарна. Хэрэв инээх л юм бол гэр рүүгээ буцаарай.

-Би инээхгүй гэж Бенни хариулсанаа тэр дороо бүгд инээлдсэн ба Расти өөрөө ч инээв.

Тэр жинсээ тайлж дотоож дээрээ хөл бөмбөгийн дасгалын өмд өмслөө. Гуя ба өгзөг дээрх зөөлөвчийг урьдаас хайчилж бэлдсэн хар тугалган тууз орложээ. Дараа нь скэйтчидийн шилбэний хаалт өмсөөд мөн хар тугалган туузаар ороов. Дараа нь бамбай булчирхайгаа хаах тугалган зах зүүв. Мөн биеийн урд хэсгийг хаасан тугалган хормогч. Расти хамгийн томыг нь авсан тул энэ хормогч шилбэний хурц ягаан хаалтанд тулж очжээ. Расти хоёр дахь хормогчоор нуруугаа хаах гэснээ

болилоо. (уушигны хорт хавдараар үхсэн дор тэнэг харагдсан дээр). Одоо түүний жин 300 фунт хүртэл нэмэгджээ. Цацраг туяа ар талаас орохгүй. Хэрэв эх сурвалж руу нүүрээр хандах юм бол аюулгүй.

Үгүй яахав аюулгүй байж мэднэ.

Энэ хүртэл Ромми ба хүүхдүүд инээдээ даран аяархан хи-хи гэснээр хязгаарлав. Расти дотор нь хоёр давхар хар тугалган тууз хийсэн резин малгай өмсөх үед тэд хяналтаа алдаж эхэлсэн бөгөөд нүд нь хамгаалалтын шилний цаагуур орж гартаа тохой хүрсэн урт бээлий өмсөх үед тэд инээдээ задгай тавив.

-Тэр амьд амьтан мөнүү? гэж Бенни хашгираад Франкенштейний мангас шиг урагш сунгасан гараа даллан: -Эзэн минь тэр амьд амьтан байна гэв.

Ромми найган инээсээр замаас гараад унасан модон дээр суулаа. Харин Жо Норри хоёр зам дээр аль хэдийн унаад шороонд хутгалдах ангаахай шиг өнхөрч байна.

-Та нар бүгд гэртээ явган хариарай гэж Расти бувтнав. Фургонд суух үедээ тэр өөрөө ч инээж байлаа.

Харин өмнө нь улаан гэрэл яг л гэрэлт цамхаг шиг анивчина.

Генри Моррисон цагдаагийн газрыг орхив. Сургуулийн хувцас солих өрөөг илүүтэй санагдуулам дуу шуугиантай шинээр цагдаа бологсод түүнийг бүрэн залхаажээ. Бүх юм өөрөөр эргэлээ, бүр бүх юм. Одоо хотын захиргааны гишүүн Ренниг хамгаалдаг болсон дээрэмчин Картер Жеккиг халах тухай гарын үсэгтэй тушаал барьж ирэхээс өмнө тэр үүнийг ойлгосон байсан. Сайн цагдаа ба сайхан эмэгтэйг халчихлаа.

Энэ тушаал бол Ренни дотроо Герцог Перкинсын нууц аялдан дагалдагчид хэмээн тооцож ирсэн өмнөх цагдаа нараас цагдаагийн газрыг бүрэн цэвэрлэх эхний алхам гэж Генри хүлээн авав. Дараагийнх нь хэн бэ гэдэгт тэр эргэлзсэнгүй. Фредди Дентон ба Руперт Либби нар үлдэнэ. Руперт бол тэвчээртэй баас. Дентон хорон санаатай. Линда Эверетт бол халагдах жагсаалтанд орно. Стейси Моггин ч бас энэ жагсаалт руу. Тэгвэл ухаан нь дорой Лорен Конриг эс тооцвол Честерс-Миллийн цагдаагийн газар эрчүүдийн клуб болон хувирна.

Тэр барууны ямар нэг кинонд гардаг хий үзэгдэл хотын гудамжаар явах мэт хов хоосон төв гудамжаар явж байв. Архичин хочит Сэм Вердро "Глобус"-ын саравчин дор сууна. Түүний өвдөгөндөө хавчуулсан лонхонд пепси-кола байгаа гэдэгт Моррисон эргэлзсэн ч зогсолгүй өнгөрөв. Архаг архичны таашаалыг таслаад ч яахав дээ.

Жонни ба Кэрри Карверууд "Бензин ба зууш" дэлгүүрийнхээ цонхыг хавтгай модоор таглаж байна. Тэд хоёулаа гартаа цэнхэр алчуур зангиджээ. Одоо ийм тэмдэг хот даяар бий болсон. Үүнийг хармагцаа Генригийн арьсан дээгүүр шоргоолж гүйх шиг болно.

Өнгөрсөн жил түүнд тавьсан саналаас татгалзаж Ороногийн цагдаагийн газарт шилжээгүйдээ тун харамсана. Мэдээж Генри тэгэхэд албан тушаал ахихааргүй байсан ба тэгээд ч согтуу мансуурсан оюутнуудтай харьцах нь жижигхэн таашаал боловч цалин өндөр амалсан юм. Эхнэр Фрида нь Онорогийн сургуулиас илүү сургууль олдохгүй гэж байсан.

Гэвч Герцог хотын ээлжит хурлын дараа түүний жилийн цалин дээр таван мянгыг нэмнэ гэж хэлээд үлдэхээр болгосон. Тэр маш нууц гэж байгаад хэрэв сайн дураараа огцрохгүй тохиолдолд Питер Рэндолфыг халах зорилготой байгаагаа хэлсэн. "Тэр цагт чи миний орлогч болно. Энэ чинь жилдээ 10 мянгыг нэмнэ гэсэн үг. Намайг тэтгэвэрт гарахаар хүсвэл миний суурийг эзлэх болно. Эсвэл чи Мэний их сургуулийн дотуур байраар өмдөн дээрх бөөлжис нь хатаж байгаа оюутнуудыг зөөх болно. Сайн бодоорой" гэж Герцог хэлсэн.

Түүнд Герцогийн үт таалагдсан. Фридад ч таалагдсан. (Бүр үлгэр мэт таалагдсан). Мэдээж хүүхдүүд нь сэтгэл амран урт амьсгаа авсан. (тэд шилжих тухай санааг жад барин угтсан). Гэвч одоо Герцог үхэж Честерс-Миллийг Бүрхүүл хучиж, харин цагдаагийн газар муухай үнэртэй газар болон хувирч байна.

Тэр Престил-Стрит рүү эргэвэл Маккейнуудын байшинг тойруулан татсан цагдаагийн шар туузны дэргэд унтлагын өмд ба углаашнаас өөр хувцасгүй зогсох Жижгээг олж харлаа. Тэр мэдэгдэхүйц ганхаж байв. Өнөөдөр Жижгээ ба архичин Сэм хоёрт адил юм тун их байна даа

гэж Моррисон эхлээд бодов.

Дараа нь Генри цагдаагийн газрын нэр төрийн тухай бодлоо. Тэр мэдээж ойрын ирээдүйд албанаасаа мулт үсэрч мэдэх хэдий ч одоохондоо цагдаа хэвээр байна. Гэтэл Герцог Перкинсийн хэлбэрэлтгүй мөрддөг зарчмуудын нэгэнд

"Честерс-Миллийн цагдаагийн нэр сүр шившигийн талбайн баганад байх ёсгүй" гэдэг. Энэ багана "Ардчилал"-ын дугаар бүрт гардаг юм. Харин Жижгээ Моррисонд таалагдах эсэхээс хамааралгүйгээр Миллийн цагдаад алба хаах болсон.

Генри цагдаагийн машинаа явган хүний зам руу шахаж тавиад хоёр тийш найгах Жижгээ рүү очлоо.

-Хүүе Жижгээ алив би чамайг цагдаагийн газарт хүргэж өгье. Кофе уулгая. Тэгээд... -"Тэгээд чи эрүүл болно" гэж тэр яриагаа дуусгах гэж байсан юм. Гэтэл залуугийн дотуур өмд нойтон байхыг олж харав. Жижгээ шээс алдсан бололтой.

Уур нь хүрч бас түтшсэн Генри гараа сунгаж Жижгээгийн мөрөөр тэврэв. Ийм юмыг хэн ч харах ёсгүй. Герцог харсан бол авсан дотроо эргэлдэх байх даа.

-Явья хүү минь. Чи өөрийгөө доог тохуу болгож байна.

-Тэд миний бүс-найз-уд байсан юм гэснээ Жижгээ түүн рүү эргэж харав. Улам хурдан найган ганхана. Одоо царай нь мөрөөдсөн бас хоосон мэт болсон байхыг Генри олж харлаа. -Би тэдэнд хартай, тийм ч учраас тэдэн дээр дур тавдаг. Ер бус хэлбэрээр. Франц маягаар гээд тэр тачигнатал инээж дараа нь нулимлаа. Эсвэл нулимах гэж оролдсон гэхэд болно. Өтгөн цагаан шүлс эрүүн дээрээс нь утас шиг унжаад савлуур шиг ганхав.

-Одоо болсон. Би чамайг гэрт чинь хүргэе.

Жижгээ энэ үед эргэн харахад согтуу биш болохыг нь Генри олж харлаа. Зүүн нүд нь шатах мэт улайжээ. Хүүхэн хараа нь маш том болсон байв. Амны зүүн булан доош унжаад хэд хэдэн шүд нь ил гарна. Түүний хөшсөн харц Генрид багадаа ихэд айдаг байсан "Мистер Сардоник" киног санагдуулав.

Жижгээг кофе уулгахаар цагдаагийн газар аваачих юмуу унтуулахаар гэрт нь хүргэх шаардлагагүй болжээ. Түүнийг эмнэлэг хүлээж байв.

-Залуу минь явья. Намайг дагаад алх гэж Генри хэллээ.

Эхэндээ Жижгээ эсэргүүцэлгүй машин хүрэх замын ихэнхийг туулснаа дараа нь гэнэт зогсов.

-Тэд яг адилхан үнэртэй байсан. Энэ бүхэн надад таалагддаг. Аймшиг, аймшиг, дахиад аймшиг, шоу одоо эхэлнэ гэж тэр мэдээлэв.

-Яг зөв гэж Генри хэлээд цагдаагийн машиныг урдуур нь тойрч Жижгээг урд талын сандал дээр суулгах гэж байснаа энэ сайн санаа биш болохыг ойлгов. Арын сандал илүү тохирно.

Цагдаагийн машины арын сандалаас онцгой үнэр гардаг ч гэсэн тохирно. Жижгээ Маккейнуудын байшин руу эргэн харлаа. Тэгээд түүний хөшсөн царайд дур тачаалтай төстэй зүйл илрэв.

-Бүс-найз-уд! Урт удаан! Ер бусаар франц маягаар! Муу ухна гэж Жижгээ хэлсэнээ хэлээ унжуулж уруулаа хурдан хурдан долоож эхлэв. Замын-гүйгч Залыт-чононоос (эдгээр нь хүүхэлдэйн киноны баатруудын нэр) зугтах үед дэлгэцээс ийм дуу сонсогддог. Тэр инээгээд буцаж эргэн Маккейнуудын гэр рүү алхав.

-Үгүй Жижгээ. Бид ингэх ёстой... гээд Генри унтлагын өмднийх нь бүсэлхийнээс барьж авлаа.

Жижгээ түүн рүү гайхалтай хурдан эргэв. Одоо тэр инээхээ больжээ. Царай нь үзэн ядалт ба уур хилэнгээс болж мурийсан байлаа. Тэр нударгаа савлан Генри рүү дайрлаа. Хэлээ урагш сунгаж шүдээрээ тас хазжээ. Тэгээд эгшиг үсэг байхгүй хачин хэллэгээр ярьж байв.

Генри үүнд ухрахаас өөр хариу өгч чадсангүй. Жижгээ түүний хажуугаар үсрэн гараад нударгаараа цагдаагийн машины дээрх анивчуурыг балбаж нэгийг нь хага цохилоо. Гараа зүсч цус гарав. Юу болоод байгааг харахаар хэд хэдэн хүн гарч ирлээ.

-Гтн бнт мнт! мнт! мнт! гтн! гтн! гэж Жижгээ уухилна. Нэг хөл нь замын хашлаганаас халтирч хажуугийн суваг руу оров. Жижгээ найган ганхсан ч унасангүй. Одоо эрүүг нь даган зөвхөн шүлс биш цус урсаж эхэллээ. Бас зүссэн хоёр гараас нь цус дусална.

-Тэр намайг араатан шиг уурлахад хүргэсэн. Би аамыг нь таглахын тулд би өвдөөрөө цохсон. Тэр уугаа хураасан. Эргэн тойрон баас. Би...би гэснээ тэр ухаан орох мэт дуугүй болов. Тэгсэнээ: -надад тусламж хэрэгтэй гэснээ хорин хоёр калибрын буугаар буудах мэт чанга уруулаа ташаад цагдаагийн машин ба явган хүний замын хоорондуур нүүрээрээ газар шаан унав.

Генри анивчуур ба дуут дохиогоо зэрэг залгаад түүнийг эмнэлэгт хүргэлээ. Тэр зөв ойлгоход ямар ч хүчлэл шаардахааргүй Жижгээгийн сүүлчийн үгсийн талаар огт юу ч бодсонгүй. Тэгэхтэйгээ манатай байв.

Асуудал хангалттай байлаа.

Расти одоо урт долгионы радиогийн шуугиан шиг тачигнах дуугарах Гейгерийн тоолуур руугаа ойр ойрхон харсаар Блэк-Ридж руу өгсөнө. Зүү нэмэх дөрвөн зуугаас нэмэх 1К болтолоо өргөгдөв. Уулын орой дээр гарахад нэмэх 4К болох юм байна гэж Расти бодлоо. Үүнд сайн юм огт байхгүй гэдгийг ойлгож байв. Гар хийцийн цацраг туяаны өмсгөл мэдээж найдвартай хамгаалахгүй. Цацраг туяа хуримтлагдаж байгааг өөртөө сануулан хэрэв саатахгүй бол үхлийн тунгаас зугтаж дийлнэ гэж урагшилсаар байлаа. Би түр зуур үсгүй болж мэднэ. Гэхдээ үхлийн тун авахгүй. Тэсрэх бөмбөг газарт хэрхэн булдаг тухай сайн бод. Ирээд, ажлаа хийгээд, шууд буцдаг шүү дээ.

Тэр радиогоо асаахад ХБЭ суваг дээр "Баяр хөөрийн агуу үйлс" дөрвөлийн дуу явж байхыг сонсоод шууд унтраав. Нүд рүү нь хөлс урсан орох тул ойр ойрхон анивчина. Хөргүүр бүрэн чадлаараа ажиллах боловч тамын халуун ноёрхоно. Тэр толинд араа харвал бусад судлаачид бөөгнөрөн зогссон байна. Тэд тун жижигхэн харагдана.

Гейгерийн тоолуур тачигнахаа болив. Расти түүн рүү харлаа. Зүү тэг дээр зогсжээ.

Расти машинаа зогсоох шахав. Тэгсэнээ дараа нь ингэх хэрэггүйг ойлгов. Ромми болоод бусад нь түүнийг зовлонд учирсан гэж ойлгох болно. Түүнээс гадна тоолуурын зай дууссан байж болно. Гэвч дахин шагайвал цахилгаан гүйдлийг заах гэрэл нь хурц асч байгааг олж харлаа.

Толгойн орой дээр зам урт улаан амбаарын өмнө тойрог үүсгэжээ. Энд хуучны ачааны машин ба ганц дугуйтай хазайсан бүр эртний трактор харагдана. Амбаарын хэдэн цонх хагарсан боловч дажгүй харагдах ажээ. Түүний цаана фермерийн байшин үзэгдэх бөгөөд өвлийн цасны хүндэд дарагдан дээврийн хагас нь нурсан бололтой.

Раст цонхны шилээ өргөлөө. Хөргүүр хамаг хүчээрээ ажиллаж байв. Гэвч амбаарын дэлгээстэй хаалгаар үжирсэн алимны үнэр Растид үнэртэнэ. Байшин руу хөтлөх шатны өмнө тэр фургоноо зогсоов. Урд нь гинж татаж "Зөрчигчид хариуцлага хүлээнэ" гэсэн бичээстэй самбар өлгөсөн байв. Самбарыг аль эрт өлгөсөн бололтой. Зэвэрч гүйцсэн байх бөгөөд хэн ч анхаарал хандуулаагүй нь илт. Хэзээ нэгэн цагт Маккойн гэр бүл зуны орой эгнэж суугаад хөнгөн салхинаас ханамж авч, эндээс үзэгдэх дүр зургийг харж байсан довжоон дээгүүр одоо шар айрагны хоосон лааз хөглөрнө. Эндээс Честерс-Милл хот тэр чигээрээ харагдах бөгөөд зүүн талд Нью-Хэмпшир руу сунасан ой харагдана. Нэгэн цагт улаан байгаад одоо цайвар ягаан болсон ханан дээр хэн нэгэн цацдаг будгаар ""Зэрлэг муурнууд" биднийг дагуулж байна" гэж бичжээ. Харин шалан дээр өөр өнгийн будгаар "Зэрлэг зугаа цэнгэлийн талбай" гэсэн байв. Бэлгийн дур хүсэлд автсан өсвөр насны залуусын толгойд ийм санаа төрөх байх гэж Расти бодлоо. Эсвэл хэн нэг нь өөрийн хайртай металл рок хамтлагийн нэрийг бичсэн байж ч болно.

Тэр Гейгерийн тоолуураа өргөөд хуруугаар тогшив. Зүү чичирхийлээд багаж хэд хэдэн удаа чадхийв. Хэвийн ажиллаж байгаа бололтой. Зүгээр л энэ хавьд цацраг туяаны эх сурвалж байхгүй байна.

Расти машинаас гарч дотроо өөртэйгөө жаахан маргасны эцэст цацраг туяаны өмсгөлийн ихэнхийг тайлсан бөгөөд зөвхөн хормогч, бээлий ба шилээ үлдээлээ. Дараа нь Гейгерийн тоолуурыг урдаа бариад саравчны дагуу явж үзэв. Хэрэв зүү тэгээс дээшлэх юм бол тэр дороо тайлсан өмсгөлөө өмсөхөөр буцна гэж өөртөө амаллаа.

Гэвч тэр саравчийг өнгөрч нууцлаг оч түүнээс ердөө дөчөөдхөн ярдын зайнд гялалзаж байсан боловч зүү хөдөлсөнгүй. Хэрэв цацраг туяа анивчих галтай холбоотой бол ийм юм байх ёсгүй. Расти ганцхан тайлбар дэвшүүлж чадах байв. Үүсгүүр нь түүнтэй адил сониуч судлаачдыг өөртөө ойртуулахгүйн тулд цацраг туяаны бүс үүсгэдэг бололтой. Өөрийгөө хамгаалахын тулд. Энэ шалтгаанаар Растигийн толгой эргэж харин хүүхдүүд ухаан алджээ. Зарааны өргөс юмуу үмхий хүрний унгас шиг хамгаалах хэрэгсэл.

Магадгүй тоолуур эвдэрсэнд хамаг учир байгаа юм биш биз. Тэгээд би хором тутамд гамма туяаны үхлийн тун авч байж мэднэ. Энэ чөтгөрийн тоолуур "хүйтэн дайны дурсамж".

Гэвч цэцэрлэгийн захад ирээд Расти зүлгэн дээгүүр гүйж явснаа мод руу авирах хэрэмийг олж харлаа. Хураагаагүй алим унжих мөчир дээр хөшөөд сүүлээ яндан шиг өргөж гялалзсан нүдээрээ хоёр хөлт зочныг харах ажээ. Хэрэм эрүүл саруул харагдах бөгөөд эгнэж ургасан бутасын дунд Расти амьтны сэг зэм харсангүй. Энд ямар ч амьтан амиа хорлоогүй бөгөөд тэр бүү хэл цацраг туяаны үйлчлэлд ороогүй бололтой.

Одоо Расти гэрлийн эх сурвалжид тун ойртсон бөгөөд өнөөх нь маш хурц гялсхийх тул Расти тэр тоолонгоор онийно. Хөлийнх нь баруун талаар бүхэл бүтэн ертөнц цэлийнэ. Дөрвөн миллийн зайтай байх хот яг л тоглоом шиг харагдана. Торлосон гудамж, Конго сүмийн шовгор орой, хэд хэдэн давхиж яваа машин наранд гялалзана. Тэр бас өөрийн эмнэлгийн намхан тоосгон байшинг харав. Тэртээ баруун талд далавчит пуужин цохилт өгсөн газарт хар толбо харагдана. Тэр өдрийн мэнгэ шиг агаарт өлгөгджээ. Дээрх тэнгэр бараг ердийн өнгөө хадгалсан цайвар цэнхэр байлаа. Харин тэнгэрийн хаяа руу ойртох тусам хурц шар туяатай болно. Өнгө өөрчлөгдөх нь бохирдолтой холбоотой гэдэгт тэр үл эргэлзэнэ. Мөн энэ шалтгаанаар одод ягаан болжээ. Гэвч энэ бохирдол нь Бүрхүүлийн үл үзэгдэх гадаргуу дээр суусан намрын тоосноос хавьгүй дор гэж сэжиглэнэ.

Расти цааш хөдлөв. Тэр энд бусдын нүднээс далд цэцэрлэгт удаан байхын хэрээр найз нөхөд нь илүү санаа зовж байгаа. Тэр улаан гэрлийн эх сурвалж руу шууд очих гэснээ болиод эхлээд цэцэрлэгээс гарч бэлийн ирмэг дээр очлоо. Тэр эндээс Ромми ба жаалуудыг харав. Тэд маш жижигхэн бараг цэг шиг харагдана. Расти Гейгерийн тоолуураа газарт тавиад бүх юм сайн гэж харуулан хоёр гараа толгой дээрээ өргөж удаан даллав. Тэд хариуд нь бас даллав.

-Сайн байна гэж тэр санаа алддаа. Хүнд бээлий өмссөн хоёр гар нь хөлс урсаж наалдамхай болжээ. -Харин одоо энд юу байгааг харцгаая.

16

Дорнод гудамжны бага сургуульд үдийн их завсарлага болж хүүхдүүд гэрээсээ авчирсан хүнсээ идэхээр суулаа. Жүди Жанни хоёр тоглоомын талбайн цаад талд найз охин 6 настай Диана Карвертай суух бөгөөд тэр нь насаар нь тооцох юм бол яг тэр хоёрын дунд төрсөн болж таарав. Диана цамцныхаа зүүн ханцуйнд жижигхэн цэнхэр уяа зүүжээ. Тэр сургуульд явахын өмнө эцэг эхтэйгээ адилхан байхын тулд ээжээсээ гуйсаар байж энэ уяаг зүүсэн юм.

-Энэ ямар хэрэгтэй юм бэ? гэж Жанни асуув.

-Би цагдаад хайртай гэсэн үг гэж Диана хариулаад жимсний ороомог зажилна.

-Би бас алчуур зүүмээр байна. Гэхдээ шарыг гэж Жүди дуу алдлаа. Тэр сүүлчийн үгийг тун нямбай хэлэв. Жаахан байхдаа "шар" гэхийг дандаа "сар" гэж хэлдэг байсан бөгөөд Жанни түүнийг шоолж инээдэг байжээ.

-Алчуур шар байж болохгүй. Зөвхөн цэнхэр байх ёстой. Амттай ороомог байна. Би үүнээс

тэрбумыг ч идэж чадна.

-Чи тарган болоод дэлбэрэх байсан гэж Жанни хэлэв.

Тэд инээлдээд дараа нь том хүүхдүүдийг ажиглан дуугүй суулаа. Тэр хооронд эгч дүүс гэртээ бэлдсэн газрын самрын тостой жигнэмэг идэцгээнэ. Хэдэн охид хичээл орж тоглоно. Хөвгүүд швед хана руу авирчээ. Хатагтай Голдстоун ихэр эгч дүүс Пруиттүүдийг савлуур дээр савлана. Хатагтай Вейндестин кикбол тоглоом зохион байгуулна. (энэ нь бейсболын нэг төрөл)

Бүх юм хэвийн байх шиг байна. Тэгсэн мөртлөө хэвийн юм юу ч байхгүй гэж Жанни дотроо бодов. Хэн ч хашгирахгүй, хэн ч шалбалсан өвдгөө барьж гомдоллохгүй. Ихэр эгч дүүс Минди ба Мэнди нар хатагтай Голдстоунаас тэдний адилхан үс засалтыг гайхаж шагширахыг гуйсангүй. Бүгд л одоо цайны цаг гэж харагдахыг хичээх бөгөөд томчууд ч мөн адил. Тэгээд бүгд, бас Жанни өөрөө ч тэнгэр рүү байн байн ширтэх бөгөөд өнөөх нь цэнхэр мэт байвч бас бүр ч тийм биш.

Мэдээж энэ бүхэн муу биш л дээ. Ухаан алдсанаас хойш хамгийн муу зүйл нь тун удахгүй ямар нэг муу юм болно гэх итгэл тасралтгүй өсч байв.

-Хэллоуинаар би бяцхан лусын дагина болохыг хүссэн юм. Харин одоо бол үгүй. Хэн ч болмооргүй байна. Гэрээсээ гармааргүй байна. Би хэллоуинаас айгаад байна гэж Диана нам гүмийг эвдэв.

-Чи муухай зүүд зүүдлээ юу? гэж Жанни асуулаа.

-Тийм ээ, гээд Диана үлдсэн жимсний ороомгоо эгч дүү нар руу сунгаж: -Идэх үү? Би бодсон шигээ тийм өлсгөлөн биш байжээ гэв.

-Үгүй гэж Жанни хариуллаа. Тэр самрын тостой жигнэмэгээ хүртэл гүйцэд идэх хүсэлгүй байсан нь урьд өмнө огт болж байгаагүй явдал. Нэгэн удаа Одри нохой нь гараашийн буланд хулгана шахсаныг Жанни санав. Хуцаж үсрэх бөгөөд харин хулгана тэндээс мултрах гэж оролдож байсан. Үүнийг хараад охинд маш гунигтай болсон бөгөөд тэр ээжийгээ дуудаж Одриг тэндээс гаргаж, хулганыг нохойн хоол болгохгүй байхыг гуйсан. Ээж нь инээсэн ч охиныхоо хүсэлтийг биелүүлж билээ.

Харин одоо тэд тийм хулгана болжээ. Жанни таталт өгөх үед зүүдэлсэн зүүдний ихэнхийг мартсан байна. Гэвч үүнийг бол яг мэдэж байв. Одоо тэднийг буланд шахжээ.

-Би зүтээр л гэрээсээ гарахгүй гэх Дианагийн зүүн нүдний булангаас бөв бөөрөнхий цэвэр тод нулимс бөмбөрөв.

-Хэллоуинаар гэрээс гарахгүй. Сургуульдаа ч явахгүй. Явахгүй. Хэн ч намайг хүчилж чадахгүй.

Хатагтай Вейндестин кикбол тоглоомоо дуусгаад нийтийн цугларалт зарлан хонх дуугаргасан

ч эхэндээ охидын нэг нь ч боссонгүй.

-Хэллоуин аль хэдийн болсон. Хараач гээд Жүди гудамжны нөгөө тал руу толгойгоор заахад Уилерийн байшингийн довжоон дээр хулуу байх нь харагдав.

-Тийшээ ч бас хар гээд Жүди шуудангийн хаалганы хоёр талд тавьсан зузаан цаасаар хийсэн хоёр хий үзэгдлийг заалаа. Тийшээ бас хар.

Одоо тэр номын сангийн өмнөх зүлэг рүү ширтэнэ. Лисса өвсөн дээр чихмэл хүүхэлдэй тавьжээ. Тэр мэдээж хүмүүстэй наргихыг хүссэн боловч томчуудад тоглоом наргиан болох зүйл нь хүүхдүүдийг голдуу айлгадаг. Энэ шөнө зүлгэн дээр байгаа чихмэл хүүхэлдэй түүнийг харанхуйд унтахаар хэвтэж байхад тэдний гэрт ирэх юм шиг мэдрэмж Жаннид төрөв.

Толгойг нь шуудайгаар хийсэн байх ба нүдийг нь цагаан хэрээс оёж тэмдэглэжээ. Малгай нь Сьюз эмчийн тухай түүхэнд гардаг муурнаас авсан аятай. Гарных нь оронд цэцэрлэгийн шүүр байв. Цамцан дээр нь ямар нэг юм бичжээ. Жанни үгсийг уншиж чадсан ч ямар утгатайг ойлгосонгүй. "Манай төрөлх Алабама-Сүйрсэн хамтлагийн энэ дууг тоглооч".

-Харж байна уу? гэхдээ Жүди уйлсангүй. Түүний ухаалаг нүд нь үгээр илэрхийлж чадахгүй тийм хэцүү ба дэндүү хар бараан мэдлэгээр дүүрсэн учир бүлтийжээ. -Хэллоуин болчихсон байна.

Жанни дүүгийнхээ гараас бариад босгохоор татав.

-Үгүй, арай болоогүй гэж хэлэхдээ Жанни хэллоуин үнэхээр ирсэн гэхээс айна. Тэднийг өмнө нь ямар нэг муу юм хүлээнэ. Галтай холбоотой муу юм. Ямар ч амттан байхгүй зөвхөн заваан муухай юмс. Хорон муухай юмс. Муу юмс. -

Сургууль руугаа явъя. Дуулцгаая. Сайхан болно гэж Жүди Диана хоёрт хэллээ.

Уг нь сайхан болдог л доо. Гэвч энэ өдөр тэнгэрт нирхийх дуу гарах хүртэлх хугацаанд ч ямар ч сайн сайхан юм байсангүй. Жанни нүдний оронд цагаан хэрээс оёсон чихмэл хүүхэлдэйн тухай бодно. Бас ямар нэг аймаар цамцны тухай. "Сүйрсэн хамтлагийн энэ дууг тоглооч".

Бүрхүүл үүсэхээс дөрвөн жилийн өмнө Линдагийн өвөө нас барсан бөгөөд ач зээ болгондоо дажгүй мөнгө үлдээсэн юм. Линда 17232 доллар 4 цент өвлөж авсан. Мөнгөний ихэнхи хэсгийг охидоо коллежид сургахад зориулан цааш хийжээ. Гэхдээ Растид зориулж хэдэн зуун доллар зарах нь зүйтэй гэж үзсэн. Төрсөн өдөр нь ойртож байсан учир түүнд "Эппл ти-ви" авч өгөхийг хүснэ. Хэдэн жилийн өмнө зах зээлд гарч ирсэнээс хойш л хүссэн билээ.

Хамт амьдрах хугацаандаа Линда түүнд илүү үнэтэй бэлэг авч байсан ч нэг нь ч Растид тийм их таашаал төрүүлээгүй. Сүлжээнээс кино татаж аваад компьютерийн жижиг дэлгэц дээр биш харин телевизийн дэлгэц дээр үзэж болох санаа нь өөрөө түүнийг хязгааргүй

баярлуулав. Энэ төхөөрөмж дөрөвний гурван дюйм зузаантай, ойролцоогоор 7 дюйм талуудтай цагаан хуванцар тэг дөрвөлжин хайрцаг байлаа. Растигийн Блэк-Ридж дээр олсон объект гадна төрхөөрөө тэр "Эппл ТВ"-г санагдуулна. Эхлээд тэр түүний өмнө өнөөх төхөөрөмж байна, гэхдээ арай сайжруулсан гэж бодлоо. Өндөр шийдлийн вай-файгийн тусламжтайгаар чиний зурагт руу "Бяцхан лусын дагина"-ыг зөвхөн нэвтрүүлээд зогсохгүй бүхэл бүтэн хотыг Бүрхүүл дор байлгана гэдэг чинь сайжруулсан л байж таарна.

Маккойгийн алимны цэцэрлэгийн хязгаар дээр байх объект нь өнгөөрөө ч бас ялгарч байв. Цагаан биш харин хар саарал өнгөтэй бөгөөд дээд таган дээр байдаг дассан тэмдэглэгээний оронд сэтгэл дотор түгшүүр төрүүлэх бэлэг тэмдэг байхыг Расти олж харлаа.

Дээд таг дээр энэхүү бэлгэ тэмдэгний дээр Растигийн чигчий хурууны хумсны чинээний бондгор төвгөр байх бөгөөд саравчаар хучигджээ. Саравчин дор шил юмуу эсвэл болор линз харагдана. Тэр нь давтамжтайгаар улаан гэрэл цацруулах ажээ.

Расти тонгойж үүсгүүрийн гадаргууд гараа хүргэв. Хэрэв үүсгүүр мөн бол шүү дээ. Хүчтэй цэнэг тэр дороо гараар дамжиж бүх биеийг нь цохилоо. Тэр гараа салгах гээд чадсангүй. Булчингууд нь хөшжээ. Гейгерийн тоолуур огцом таагүй дуу гаргаснаа чимээгүй болов. Зүү аюултай бүс рүү үсэрсэн эсэх талаар Расти ойлголтгүй байв. Яагаад гэвэл нүдээ ч хөдөлгөж чадсангүй. Гэрэл ертөнцийг орхилоо. Усны өрөөн дэх онгоцны бөглөөсийг авсны дараа ус нүх рүү эргэлдэн ордог шиг бүх юм эргэлдэв. Расти тайвнаар, гайхам тов тодорхойгоор "Би одоо үхлээ. Ямар тэнэг замаар хорвоог орхив..." гэж бодлоо.

Дараа нь харанхуйгаас нүүрнүүд гарч ирэв. Гэхдээ хүний нүүр биш. Хожим тэр нүүр байсан эсэхийг ч санахаа больсон. Илгэн арьсаар хучигдсан ямар нэг нүсэр юм. Хоёр талд нь байх ромбо хэлбэрийн далбагар зүйл л хүнтэй бага зэрэг төстэй санагдуулна. Магадгүй чих байх. Хэрэв тэр урдаа толгойнуудыг харж байгаа юм бол тэдгээр толгойнууд хоорондоо ярилцах гэсэн юмуу эсвэл ярилцахтай төстэй ямар нэг өөр юм хийхээр бие бие рүүгээ эргэж байв. Инээхийг нь сонслоо гэж Расти бодов. Ямар нэг сэтгэл хөөрлийг нь мэдэрсэн гэж бодов. Дорнод гудамжны бага сургуулийн тоглоомын талбай дээр байгаа хүүхдүүд нүдэнд нь үзэгддээ. Өөрийн охид ба тэдний найз боллоотой Дианаг төсөөлөв. Тэд гэрээсээ авчирсан хүнснийг солилцох бөгөөд их завсарлагаар нууцаа солилцоно.

Энэ бүхэн дөрөв тавхан секунд үргэлжилсэн. Түүнээс их биш. Дараа нь яваад өглөө. Цэнэг огт байгаагүй юм шиг гэнэт бүрэн алга болов. Бүрхүүлд анх гар хүрсэн хүмүүстэй болсон явдал шиг. Бас хэлтгий тавьсан бортого малгайтай хэллоуины хүүхэлдэйн хий үзэгдэл ба толгойн эргэлт гэнэт алга болсон шиг тийм хурданаар. Тэр ердөө л хот дээг сүндэрлэх толгойн хяр дээр сөхөрсөн байх бөгөөд хар тугалган хувцасан дотроо нортол хөлөрчээ.

Гэхдээ илгэн толгойнуудын дүр төрх үлдсэн байв. Тэд бие бие рүүгээ тонгойн инээлдэх бөгөөд ямар нэг хүүхдийн эвгүй яриагаар нэгджээ.

Миний найз нар тэртээ дороос над руу харж байгаа. Тэдэнд гараар даллах хэрэгтэй. Бүх юм хэвийн гэж мэдэгдэх хэрэгтэй.

Тэр хоёр гараа толгой дээрээ өргөв. Одоо гар нь хөнгөн уяхан хөдөлнө. Тэгээд цээж ба

нуруугаар нь хөлс горхи мэт урсаагүй юм шиг, зүрх нь алх давгах мэт цохилоогүй юм шиг гараа хоёр тийш аажуухан савлаа.

Доор зам дээр Ромми ба хүүхдүүд хариу даллав.

Расти хэд хэдэн удаа гүнзгий амьсгалж тайвшраад Гейгерийн тоолуурыг хар саарал дөрвөлжин хайрцаг руу чиглүүлэв. Зүү нэмэх тав ч хүрсэнгүй. Дэвсгэр, өөр юу ч биш.

Энэ дөрвөлжин хавтгай объект тэдний бүх гайны эх сурвалж гэдэгт Расти үл эргэлзэнэ. Амьтад, хүмүүн биш амьтад биднийг шоронд байлгахын тулд түүнийг ашигладаг аж. Үүгээр ч зогсохгүй. Тэд биднийг ажиглахын тулд бас ашигладаг.

Мөн зугаацахын тулд. Новшнууд инээлдэж байсан. Расти үүнийг сонссон.

Тэр хормогчоо тайлж дотор нь линз байрлах бондгортой хайрцгийг хучаад бослоо, ухарлаа. Эхний хэдэн хоромд юу ч болсонгүй. Дараа нь хормогч шатав. Агаарт тааламжгүй шинэ содон үнэр бий болов. Гялалзсан гадаргуу хөөсөрч ирсэнээ хагараад дараа нь шатахыг Расти харж зогсоно. Эцэст нь хормогч буюу жинхэнээрээ бол туузаар ороосон нимгэн тугалган хавтан зүгээр бутарч унав. Хамгийн том хэсэг нь хайрцаг дээр байх ба бусад хэсгүүд дахиад хэдэн хором шатлаа. Түүний дараахан хормогч, ян тан хэлэх юм бол түүнээс үлдсэн зүйл нь сарнин замхрав. Хэдэн чимх үнс ба үнэр үлдээд бусад нь байхгүй болжээ. Хормогч алга болов.

Би ийм юм олж үзлээ гэж үү хэмээн Расти өөрөөсөө асуулаа. Дараа нь асуултаа ойр тойронд байгаа бүхэнд зориулан чангаар давтав. Шатсан хуванцарын үнэр хамар цоргино. Өөр бас нэг илүү хүнд үнэр ханхлах нь шатаж байгаа тугалга аж. Солиотой юм. Ийм юм байж болшгүй. Гэвч хормогч алга болчихлоо.

-Би үнэхээр энэ бүхнийг харлаа гэж үү?

Түүний асуултанд хариулах мэт хайрцагны дээд талын гадаргууны саравчин доорх төвгөрөөс хурц гэрэл гялсхийв. Компьютерийн гаранд хуруу хүргэхэд дэлгэц дээр ажлын хуудсыг сэргээдэг шиг энэ дохио Бүрхүүлийг барьж байдаг юм болов уу? Энэ дохио илгэн толгойтнуудад хотыг ажиглаж байхад нь тусалдаг юм уу? Тэднийг аль алинаар нь хангадаг гэж үү? Эсвэл үүнд ямар ч хамаагүй юм уу?

Расти хавтгай хайрцаганд дахин ойртохгүй байхыг өөртөө тушаав. Тэр өөртөө хэлэхдээ одоо фургон хүртэл хар хурдаараа гүйгээд (хормогчгүй тул гүйж чадна) дараа нь хар хурдаараа хот руу буцах бөгөөд замдаа доор хүлээж байгаа дагуулуудаа авах гэж л фургоноо түр зогсооно гэж хэллээ.

Гэвч ингэхийн оронд тэр дахиад л хайрцаг руу явж очоод урд нь сөхөрсөн бөгөөд яг залбирч байгаа мэт санагдахад Растид огт таалагдсангүй.

Тэр нэг бээлийгээ тайлаад хайрцагны хажуугийн газарт шүргэснээ тэр дороо гараа татав. Халуун байна. Шатаж байгаа хормогчноос өвс ч бас шатжээ. Тэгээд Расти дотроо цэнэг цохих

юмуу түлэгдэхийг хүлээн агшсаар хайрцаг руу гараа сунгалаа... Тэр хэдийгээр шал өөр юмнаас айж байсан ч, тухайлбал илгэн нүүртийг дахиад харах, толгой гэмээргүй тэдгээр зүйлс бие бие рүүгээ тонгойгоод ямар нэг хөгжилтэй хуйвалдаан хийж байгаа нь харагдах вий гэж айв.

Юу ч болсонгүй. Нүүрнүүд харагдсангүй. Халууныг ч мэдэрсэнгүй. Хэдийгээр тэр дээр нь тавьсан тугалган хормогч эхлээд хөөсөрч дараа нь шатахыг нүдээрээ харсан боловч саарал хайрцаг тэмтрэхэд хүйтэн байлаа.

Улаан гэрэл дахиад л гялсхийв. Тэр линзний өмнө гараа тавихгүйг хичээнэ. Тэгээд Расти эхнэр ба хүүхэдтэйгээ санаандаа салах ёс хийж ийм тэнэгийнхээ төлөө уучлал гуйгаад хайрцагны хоёр талаас хоёр гараар зуурав. Одоо гэнэт дүрсхийгээд шатна гэж хүлээнэ. Дүрсхийгээгүй тул хайрцагийг өргөх гэж оролдов. Хэдийгээр хайрцагны талбай жижиг тавгаас ч томгүй бөгөөд өндөр нь ч бас тийм атал үүсгүүрийг Расти газраас суга татаж чадсангүй. Энэ хайрцаг шинэ Английн хөрс рүү 90-ээс доошгүй фут одсон багананд гагнагдсан мэт ажээ. Гэхдээ хайрцагийг хэн ч юунд ч гагнаагүй. Учир нь хайрцаг зүлэг дээр байх ба Расти доогуур нь хуруунуудаа шургуулж үзвэл хуруунууд уулзалдаж байв. Тэгэхээр нь хуруунуудаа салаавчлан бариад үүсгүүрийг дахиад өргөх гэж оролдлоо. Цэнэгийг мэдэрсэнгүй, юу ч харсангүй, халуунаар төөнөсөнгүй, гэхдээ хайрцаг ч байрнаасаа хөдөлсөнгүй. Тэр бүү хэл доргисонгүй.

Би гартаа харь гаригийн зүйл барьж байна. Харь гаригийн машин. Магадгүй би түүнийг удирдаж байгаа амьтадыг ч харсан.

Оюун санааны талаас энэ бодол гайхал төрүүлнэ. Тэр бүү хэл донсолгоно. Гэхдээ онцгой сэтгэл хөддөл дуудсангүй.

Магадгүй яагаад гэвэл Растигийн толгойг түүний чанаж боловсруулж чадахгүй мэдээллийн давалгаа хучжээ.

Одоо яах вэ? Чөтгөр аваг. Одоо юу хийх вэ?

Расти мэдэхгүй байлаа. Гэвч сэтгэл хөдлөл ямар ч гэсэн бий болох шиг болов. Түүнийг цөхрөл эзэмдлээ. Цөхрөлийг зогсоох, түүнд дийлдэхгүйн тулд Расти түүнийг хашгираан болгон хувиргаж л чадна. Тэгвэл доор зогсч байгаа дөрвөн хүн энэ хашгирааныг сонсоод түүнийг гайд учирсан гэж бодно. Гэхдээ тэгсэн л юм чинь. Гэвч тэр ганцаараа гайд учираагүй.

Расти нугарах гэж сандаргах хөшиж салгалсан хөл дээрээ босов. Хөдөлгөөнгүй халуун агаар яг тос мэт арьсан дээр наалдана. Тэр алимны моддын дундуур фургон руугаа аажуухан гэлдэрлээ. Зөвхөн ганцхан зүйлд эргэлзэхгүй байв. Ямар ч тохиолдолд Том Жим Ренни үүсгүүрийн тухай мэдэх ёсгүй. Том Жим түүнийг устгах гэж оролдох учраас тэр биш юм. Харин ч эсрэгээр. Тэр хэнд ч устгах боломж олгохгүйн тулд хамгаалалт гаргах болно. Үүсгүүр ажилласан хэвээр. Ренни хийсэн юмаа хийсээр байхын тулд. Яагаад гэвэл хотод болж байгаа бүхэн одоохондоо Том Жимд тун таалагдаж байв.

Расти фургоны жолоочийн талын хаалгыг нээх яг тэр агшинд Блэк-Риджээс хойшоо нэг миль гаруй зайд аварга том дэлбэрэлт болж, энэ өдрийг донсолгов. Яг л бурхан доошоо тонгойж байгаад тэнгэрээс буугаар панхийлгэх мэт.

Расти санаанд ороогүй байснаас чанга орилж толгойгоо өргөлөө. Тэгээд Честерс-Милл ба Ти-Эр-90 хоёрын зааг дээр тэнгэрт гялсхийсэн хурц гэрлээс болж нүдээ хаав. Бас нэг онгоц Бүрхүүлийг мөргөжээ. Энэ удаад жижигхэн "Хөх бух" биш Растигийн тооцоолсоноор 20 мянган футын өндөрт цохилт болсон газраас хар утаа дээшээ олгойдов. Хэрэв пуужингийн цохилтын дараах түймрийн үлдээсэн хар толбо түүнд хацар дээрх мэнгэтэй адил санагддаг байсан бол харин энэ шинэ зүйл улам өсөх арьсны хорт хавдартай адил байлаа.

Расти үүсгүүрийг мартжээ. Түүнийг хүлээж байгаа дөрвөн хүнийг ч мартав. Тэдний төлөө дөнгөж сая цөхөрсөн аз туршилт хийсэн дөрвөн хүүхдээ мартжээ. Бамбар дүрсхийгээд тэр алга болж мэдэх байлаа. Дараагийн хоёр минутанд энэхүү хар айдас түүний оюун ухааныг бүрэн эзэмдэв.

Хэсэг бусагууд Бүрхүүлийн нөгөө талд газарт унана. Агаарын хөлгийн цөм цохигдсон хамрын хэсгийн араас галд автсан хөдөлгүүр унав. Хөдөлгүүрийн араас онгоцны суудлуудаар бороо оров. Олонхи суудалд аюулгүйн бүсээр даруулсан зорчигчид сууж байжээ. Сандалуудын араас аварга том гялалзсан далавч унах ба салхинд хийсэх цаасан тууз мэт тахийжээ. Далавчны хойноос сүүл унах шиг болов. "Боинг 767". Дээр нь цайвар ногоон өнгөөр ямар нэг юм зурсан хар ногоон сүүл. Растид эхлээд хошингор зурсан мэт харагдав. Үгүй хошингор биш гурван салаа навч юм байна.

Онгоцны эх бие газар мөргөөд хугарсан сум шиг болж ойр орчмын ойг шатаав.

18

Дэлбэрэлт хотыг цочоож юу болсныг харахаар бүгд гадаа гарчээ. Честерс-Миллийн хаа сайгүй хүмүүс. Байшингийн өмнө, орцны зам дээр, явган хүний зам дээр, Төв гудамжны голд хүртэл зогсоцгооно. Хэдийгээр тэдний байгаа шоронгоос умар зүгт тэнгэр үүлтэй байсан боловч тэд хурц гэрлээс болж нүдээ анихад хүрч байв. Блэк-Риджийн орой дээр байсан Расти бол эхэндээ бүр хоёр дахь нар мандав уу гэж бодсон.

Мэдээж юу болсныг хүмүүс ойлгож байлаа. Зарим хурц хараатай нэг нь онгоцны их бие модцын цаагуур алга болохоос өмнө амжиж сүйрсэн онгоц аль компанийнх болохыг уншиж амжжээ. Энд хэт сонин юу ч алга. Хэдийгээр долоо хоног ч өнгөрөөгүй байтал энд ийм юмыг үзээд өнгөрсөн. (хэдийгээр түрүүчийн сүйрэл үүнтэй харьцуулах аргагүй боловч). Энэ аймшигт дэлбэрэлт Честерс-Миллийн оршин суугчдад айдас дуудлаа. Тэднийг үхэн үхтэл хотыг үл тавих бахь бий болжээ.

Үхлийн өвчтэй хүнийг асарч сувилсан хэн ч гэсэн эсэргүүцэл үхэж номхролд байраа тавьж өгдөг тийм цэг байдгийг танд хэлж чадна. Честерс-Миллийн олонхи оршин суугчдын хувьд энэ мөч нь аравдугаар сарын 25-ны өглөө болов. Бараг 300 хүн Ти-эр-90-ийн ой руу унах бүхнийг ганцаараа юмуу хөршүүдтэй харж зогсох тэр мөчид.

Энэ явдал болох хүртэл хүн амын дөнгөж 15 хувь "Эв нэгддийн" ханцуйн цэнхэр боолт зүүж байсан. Харин нар жаргах үед ийм хүмүүсийн тоо хоёр дахин нэмэгдэж харин пүрэв гаригийн өглөө хотын хүн амын бараг 50 хувьд нь ийм үзүүлэлт гарч ирлээ.

Эсэргүүцэл номхролд байраа алдаж байв. Харин номхрол нь хараат байдалд шилждэг. Үхлийн өвчтэй хүнийг асарсан хэн ч үүнийг танд хэлээд өгнө. Өвчтэй хүнд түүнд эм болоод уух амтат хүйтэн жүүстэй аяга барьж ирэх тийм хүн хэрэгтэй. Ургамлын хандтай тос түрхэж, үе мөчний өвчинг намдаах хүн хэрэгтэй. Шөнө дэндүү харанхуй болох бөгөөд цаг хэтэрхий сунаж уртсах үед дэргэд нь суух хүн хэрэгтэй. Түүнд "Одоо унт даа. Өглөө илүү дээрдэнэ. Би энд байх болно. Тэгэхээр унт. Одоо унт. Унтаад надад бүхний төлөө санаа тавихыг зөвшөөр" гэж хэлэх хүн хэрэгтэй. Унт.

19

Цагдаа Генри Жижгээг эмнэлэгт хүргэж ирэв. Тэр үед залуу ухаан орсон мэт байсан ч ямар нэг утга учиргүй юмыг тасралтгүй үглэсээр байлаа. Дуги түүнийг тэргэнд хэвтүүлээд авч явсанаар Моррисонд хязгааргүй хөнгөрөл үзүүлэв.

Генри лавлах дээрээс Том Жимийн гэрийн болоод хотын захиргаан дахь ажлын өрөөний утсыг оллоо. Хоёулаа суурин утас байв. Гэвч Реннитэй холбоо барьж чадсангүй. Реннигийн гар утасныг дугаар лавлахад ороогүй байна гэх автомат хариулагчийг сонсож байх яг тэр үед агаарын хөлөг дэлбэрчээ. Генри бусад бүх хүний хамт эмнэлгээс гүйн гарч өмнөх тойрог дээр зогсоод Бүрхүүлийн үл үзэгдэх гадаргуу дээр үүссэн хар тэмдгийг ширтэж байв. Эвдэрхий хэмхэрхийнүүд тэнгэрээс унаж байлаа.

Харин энэ үед Том Жим хотын захиргаан дахь ажлын өрөөндөө байсан бөгөөд хэлэх үгээ ямар нэг саадгүй тайван амгалан бэлдэхийн тулд утсаа салгажээ. Тэр хэлэх үг хоёрыг бэлдэж байсан бөгөөд нэг нь өнөөдөр цагдаа нарын өмнө хэлэх үг, нөгөө нь маргааш хотын хурал дээр хэлэх үг ажээ. Тэр дэлбэрэлтийг сонсоод гадагш яарав. Кокс атомын бөмбөг дэлбэлсэн байх гэж хамгийн түрүүнд бодлоо. Шалчгар атомын бөмбөг. Хэрэв тэр Бүрхүүлийг цоолох юм бол түүний бүх бодол төлөвлөгөө нуран унана.

Түүний дэргэд хотын захиргааны цэвэрлэгч Эл Тиммонс зогсож байв. Тэр хойд зүгт дээшээ тэнгэр рүү заасан ба тэнд утаа суунагласаар байлаа. Том Жимийн хувьд энэ бүхэн дэлхийн хоёрдугаар дайныг тухай хуучин кинонд гардаг зенитийн сум оносны дараа дэлбэрсэн онгоцтой тун төстэй харагдав.

-Онгоц байсан. Том онгоц. Бурхан минь хэн ч сануулаагүй гэж үү? хэмээн Эл хашгирна.

Том Жим тайвширч эхэлсэн бөгөөд байх ёстойгоос гурав дахин түргэн цохилдог түүний зүрх удааширч эхлэв. Хэрэв онгоц юм бол... Хэрэв зүгээр л нэг онгоц юм бол, атомын бөмбөг юмуу ямар нэг супер пуужин биш юм бол...

Гар утас нь дуугарав. Том Жим пиджакны хармаанаас утсаа аваад нээлээ.

-Питер чи юу?

-Үгүй ээ, ноён Ренни. Би хурандаа Кокс байна.

-Та нар юу хийгээд байгаа юм бэ? Бурхны нэр барьж асууя? Та нар юу хийчихэв ээ? гэж Ренни ориллоо.

-Юу ч хийгээгүй гэх үед Коксын дуунд урьдын эзэрхэг өнгө аяс ор сураггүй болжээ. Тэр өөрөө ч юу ч ойлгохгүй байв. -Бид энд ямар ч буруугүй. Энэ бол... Түр хүлээгээрэй.

Ренни хүлээв. Төв талбай амаа ангайн тэнгэр ширтэх хүмүүсээр дүүрчээ. Реннигийн хувьд энэ алмай амьтад хүний хувцастай хонийг санагдуулна. Маргааш орой тэд хурлын танхимд цуглаад бүх юм хэзээ дуусахыг асуун майлалдах болно. Майлангаа сайн цаг иртэл тэдний төлөө санаа тавихыг гуйх болно. Тэгээд тэр санаа тавих болно. Үүнийг хүссэндээ биш юм. Зүгээр л бурхны таалал тийм байжээ.

Утсанд дахиад Коксын дуу хадав. Барьц алдсан байдал дээр нь ядаргаа нэмэгджээ. Одоо Реннитэй тэтгэвэрт гарахыг ятгаж байсан тэр хүнээс шал өөр хүн ярьж байна. Би чиний дууг яг ийм өнгө аястай сонсохыг хүсч байна танил минь. Яг ийм.

-Урьдчилсан мэдээллээр бол Шенноноос Бостон руу нисч явсан 179-р чиглэлийн "Эр Айренд" нисэх компанийн онгоц Бүрхүүлийг мөргөж дэлбэрсэн байна. Хоёр өөр эх сурвалж сүүлэн дээрх гурван салаа навчны зургийг харжээ. Бас Харлоу дахь хаалттай бүсийн хил дээр ажиллаж байгаа Эй-Би-Си-гийн зураг авах баг магадгүй... Дахиад түр хүлээнэ үү...

Түр хүлээлт минутаас илүү үргэлжлэв. Том Жимийн зүрхний цохилтын хэмнэл аажмаар хэвэндээ орж байлаа. (минутанд 120 цохилохыг хэвийн гэх юм бол). Гэвч зүрх нь гэнэт хурдаа нэмээд нэг удаа бүтэн эргэх шиг болов. Том Жим ханиагаад цээж рүүгээ цохилоо. Зүрх нь дахин тайвширч эхлээд дараа нь хэмнэл нь бүр сайхан болоод ирэв. Том Жимийн духан дээр хөлс чийхарчээ. Одоо хүртэл бүүдгэр байсан өдрийн гэрэл гэнэт маш тод болж хувирав.

-Жим ээ гэж Эл түүнд хандлаа. Хэдийгээр тэр Том

Жимийн дэргэд байсан ч дуу нь алс холын огторгуйгаас сонсогдох мэт. -Чи зүгээр үү?

-Бүх юм сайн. Эндээ зогсч бай. Чи надад хэрэг болж мэднэ.

Кокс эргэн ирлээ.

-Энэ үнэхээр "Эйр Айленд"-ын онгоц байжээ. Би сүйрлийн тухай Эй-Би-Си-гийн сурвалжлага үзлээ. Сэтгүүлч үйл явдлын газар дээрээс материал бэлджээ. Сүйрэл түүний толгой дээр нь шахуу болсон юм байна. Тэд бүх зургийг авсан байна.

-Чансаа нь огцом дээшилнэ гэдэгт би итгэлтэй байна.

-Ноён Ренни магадгүй болсон явдлын талаарх бидний санал бодол өөр өөр. Гэвч та сонгогчиддоо хандаж түгших юм юу ч байхгүй гэж сануулна хэмээн би найдаж байна.

-Та надад зүгээр хэлээд өг. Ийм юм яаж... Зүрх нь дахиад бүтэн эргэх шиг болов. Тэр

уушигандаа агаар сорсон ч буцааж гаргаж чадахгүй байлаа. Ахиад цээжээ цохив. Энэ удаад хүчтэй цохисон бөгөөд хотын захиргаанаас явган хүний зам хүрэх нарийн замын дэргэд байх сандал дээр суулаа. Эл Тиммонс одоо Бүрхүүл дээр бий болсон хар сорвийг биш харин түүнийг ширтэх ажээ. Түүний царайд санаа зовсон төрх уншигдах ба Том Жимийн бодсоноор айдас илт байв. Хэдийгээр тэр одоо өвчтэй байсан ч Элийн царайн төрх түүнд баяр хөөр төрүүлэв. Өөрийгөө орлуулашгүй хүн гэж бодохоор баярлана. Хонин сүрэгт малчин хэрэгтэй.

-Ренни байна уу?

-Байна байна.

Ямар нэг сайнгүй юм болоод байгаа зүрх нь байгаа шиг тэр байж л байна.

-Яаж ийм юм болов оо? Яаж болж чадав аа? Та нар бүх хүнд сануулсан гэж би бодсон.

-Ян тан хариултыг бид хар хайрцаг олсны дараа л хэлж чадна. Гэвч таамаг бол бий. Бид зорчигч тээврийн бүх агаарын хөлгийг Бүрхүүлээс хол байх талаар шаардсан удирдамж илгээсэн. Бүрхүүл 179-р чиглэлийн зам дээр байдаг. Бидний бодлоор хэн нэг нь автомат нислэгийн программ өөрчлөхөө мартсан байна. Өөр юу ч биш. Юм тодорхой болонгуут би танд дэлгэрэнгүй мэдээлнэ. Гэвч одоо хамгийн гол нь үймээн сандраан хотыг цалгиахаас өмнө урьдчилан сэргийлэх хэрэгтэй.

Тодорхой нөхцөл байдалд үймээн сандрал ашиг авчирч ч мэднэ. Тодорхой нөхцөл байдалд үймээн сандрал нь хүнсний самуун юмуу редакцийг шатаасан шиг Том Жимийн усан тээрэм дээр ус асгаж мэднэ.

-Мэдээж энэ бол ноцтой үр дагавартай салан задгай явдал. Гэвч энэ бол яах аргагүй осол аваар юм. Хотын иргэд үүнийг мэдэх тал дээр анхаарал тавиарай гэж Кокс үргэлжлүүлнэ.

"Тэд миний юу гэж хэлэхийг л мэдэж авах болно. Надаас сонссон зүйлдээ л итгэх болно".

Реннигийн зүрх халуун хайруулын таваг дээр тавьсан өөх мэт донсолно. Нэг хэсэг хэвийн цохисоноо ахиад донсолж эхэлнэ. Тэр Коксод хариу өгөлгүйгээр утсаа салгаад гар утсаа хармаалав. Дараа нь Эл рүү харлаа.

-Чи намайг эмнэлэгт хүргээсэй гэж би хүсч байна. Нэг л сайн биш байна гэж тэр аль болох тайван хэллээ.

Гартаа эв санааны нэгдлийн тууз зүүсэн Эл улам илүү түгшив.

-Мэдээж Жим. Эндээ сууж бай. Би машин аваад ирье. Чамтай ямар нэг муу юм болохыг бид хүлээн зөвшөөрч чадахгүй. Чи хотод хэрэгтэй.

"Үүнийг би ямар мэдэхгүй ч биш дээ" гэж Том Жим бодлоо. Тэгээд сандалд сууж тэнгэр дээр том хар сорвийг харна.

-Картерийг олоод надтай ирж уулз гэж хэл. Тэр надад хэрэгтэй.

Том Жим Элд бусад захирамжууд өгөхийг хүссэн ч яг энэ үед зүрх нь бүрэн зогсов. Хоромхон зуур яг хөлнийх нь өмнө ёроолгүй хар ангал үүслээ. Ренни дуу алдаад дахин цээж рүү цохив. Зүрх нь байрнаасаа суга үсрээд нүх рүү одлоо.

"Чи намайг одоо битгий баллаач. Би маш их юм хийх хэрэгтэй. Шалчгар цохилуур тэгнэ гэж санасны ч хэрэгтгүй шүү. Бодох ч хэрэгтгүй".

20

-Энэ юу вэ? гэж Норри хүүхдийн чанга дуугаар хашгиран асуугаад дараа нь өөрөө хариуллаа.
-Онгоц. Дүүрэн хүнтэй онгоц гээд тэр цухиран уйлав.

Хөвгүүд нулимсаа барих гэж оролдсон ч чадсангүй. Ромми хичнээн уйлмаар байгаагаа мэдрэв.

-Тийм ээ, онгоц гэж бодож байна гээд тэр толгой дохилоо.

Жо тэдэн рүү чиглэн ирж яваа фургон руу эргэв. Толгой дээрээс уруудаад хурдаа нэмэх бөгөөд Расти хотод буцах гэж тэвчиж ядах мэт. Фургон зогсч эмч үсрэн гарч ирэхэд Растид яарах өөр шалтгаан байгааг Жо ойлгов. Тэр тугалган хормогчгүй болжээ.

Расти нэг ч үг хэлж амжаагүй байтал гар утас нь дуугарлаа. Тэр дугаарыг харсанаа утсаа авав. Жинни залгаж байна гэж бодтол шинэ хүн болох Маршалл байжээ.

-За. Юу вэ? Онгоцны тухайд бол би өөрөөсөө харсан... гэж эхэлсэнээ хөмсөг зангидан чагнаж толгой дохиж гарав. -За яахав тийм. Сайн байна. Одоо очлоо. Жинни Дуги хоёрт хэлээрэй. Хоёр мг валиун өг гээрэй. Үгүй ээ гурвыг өг. Тайвшир гэж хэл. Түүний хувьд энэ шинэ зүйл. Гэхдээ оролдоод үз гээрэй. Хүүд нь 5 мг-ийг өг гээд утсаа тасалж бүгд рүү хараад -Хоёр Ренни эмнэлэгт иржээ. Том нь зүрхний хэмнэл алдагдсан. Тийм юм болж байсан удаатай. Чөтгөр авсан тэнэгт бүр хоёр жилийн өмнө зүрх дэмжигч тавих ёстой байсан юм. Бага Реннигийн тухайд глион өвчний шинж илэрсэн гэж Маршалл хэлсэн. Би түүнийг алдаж байна гэж найдаж байна.

Норри Расти руу ширтэнэ. Хацраар нь нулимс урсана. Нэг гараар Бенниг тэврэхэд өнөөх нь нүдээ тасралтгүй нухах ажээ. Жо-г дөхөж ирээд зогсоход нөгөө гараараа бас тэврэв.

-Энэ чинь тархины хорт хавдар тийм үү? Хорт хавдар уу? гэж Норри асуулаа.

-Хэрэв бага Реннигийн насны залууд хавдар илрэх юм бол үргэлж хорт хавдар л байдаг.

-Чиний тэнд юу болсон бэ? гэж Ромми асуув.

-Хормогч чинь яачихаа вэ? гэж Бенни нэмлээ.

-Би тэнд Жо-гийн бодож байсныг оллоо.

-Үүсгүүр үү? Эмч ээ, чи итгэлтэй байна уу? гэж Ромми нягтлав.

-Тийм ээ, би урьд нь хэзээ ч иймэрхүү юм хараагүй. Энэ дэлхий дээр хэн ч хараагүй гэдэгт би бараг итгэлтэй байна.

-Өөр ертөнцийнх юм уу? гэж Жо шивнэхээс ч аяарханаар хэлээд -Би мэдсэн юмаа гэв.

Расти түүн рүү хатуу чанга харав.

-Чи үүнийг ярих ёсгүй. Хэнд ч. Хэн ч ярих ёсгүй. Хэрэв та нараас асуух юм бол бид очиж үзээд юу ч олоогүй гээрэй. -Манай ээжид ч болохгүй юу? гэж Жо өрөвдөлтэй асуув.

Расти бараг уярах шахсанаа өөрийгөө гартаа авав. Энэ нууцыг аль хэдийн таван хүн мэдэж байна. Аюулгүй байдлыг хангахад дэндүү олон байна. Гэвч хүүхдүүд мэдэх эрхтэй. Тэгээд ч Жо бол бараг тааварлаж байсан.

-Түүнд ч болохгүй. Ямар ч гэсэн одоохондоо.

-Би түүнд худлаа хэлж чадахгүй. Ер нь хэлээд ч бүтэхгүй. Түүнд эхийн совин бий гэж Жо хэллээ.

-Тэгвэл намайг хэнд ч юу ч хэлэхгүй гэсэн ам авсан гэж хэлээрэй. Ингэвэл дээр байх. Хэрэв тэр өөрийнхөөрөө зүтгээд байвал надтай ярь гээрэй. Одоо явцгаая. Би аль болох түргэн эмнэлэгт очих хэрэгтэй. Ромми жолоо барь. Би тэр чигээрээ цочирдсон байна.

-Чи юу ч хиймээргүй... гэж Ромми ярьж эхлэв.

-Би та нарт бүгдийг нь хэлнэ. Буцах замдаа магадгүй би үүнийг яах талаараа бодох хэрэгтэй байна.

21

"Эйр Айленд" нисэх компанийн "Боинг 767" онгоц Бүрхүүл мөргөснөөс нэг цагийн дараа гартаа амны цаасаар хучсан таваг барьсан Роуз Честерс-Миллийн цагдаагийн газрын хаалгаар шийдэмгий алхан орлоо. Стейси ширээний ард суух бөгөөд ядарч гунисан харагдана. Роузад ч бас ийм мэдрэмж төрнө.

-Энэ юу вэ? гэж Стейси асуув.

-Үдийн хоол. Миний тогоочид зориулагдсан. Улаан лооль ба салаттай. Хоёр ширхэг шарсан гахайн утсан мах бүхий хавчуургатай талх.

-Роуз би чамайг доошоо буухыг зөвшөөрөхгүй. Би хэнийг ч доош нь буулгаж чадахгүй.

Энэ үед Мел өнгөрсөн хавар Портлендын олон нийтийн төвд үзсэн ачааны тэрэгтгүүдийн шоуны тухай шинэ мэдээллийг хоёр шинэхэн цагдаатай ярьж зогсоно. Тэр Роуз руу эргэж:

-Хатагтай Роуз би түүнд хүргээд өгье.

-Чи хүргэж өгөхгүй гэж Роуз дургүйцэв.

Мелийн царайд гайхал тодорлоо. Бас гомдол. Тэр Роузд үргэлж хайртай байсан. Бүсгүй ч бас түүнд дургүй байгаагүй.

-Би чамд итгэхгүй байна. Яагаад гэвэл чи тавагаа алдаж мэднэ. Мел чиний хөл бөмбөг яаж тоглодогийг би харсан гэж Роуз тайлбарлав. Гэхдээ тэр бүх үнэнийг хэлсэнгүй. Тэр түүнд огт итгэдэггүй.

-За боль доо. Би тийм ч болхи хүн биш шүү.

-Бас би Барбигийн бүх юм зүгээр эсэхийг хармаар байна.

-Түүн дээр хэн ч орох ёсгүй. Рэндолф дарга тушаасан. Харин тэр хотын захиргааны гишүүн Реннигээс тушаал авсан.

-За яахав. Би доошоо буулаа. Чи намайг зогсоох гэвэл цахилгаан бороохой хэрэглэх ёстой болж дээ. Хэрэв чи тэгэх юм бол хэзээ ч надаас өөрийнхөө дуртай голдоо хайлуулсан тостой гүзээлгэний жигнэмэгээ авахгүй шүү. Түүнээс гадна чиний нэрлэсэн хүмүүсийг би энд олж харахгүй байна. Эсвэл тэд нуугдчихсан юмуу? гээд тэр эргэн тойрноо харав.

Мел мундаг цагдаагийн дүр эсгэж залуучуудад сэтгэгдэл төрүүлэхийг хүссэн бодлоо өөрчиллөө. Роуз түүнд үнэхээр таалагддаг. Түүний бэлдсэн жигнэмэг, ялангуяа хайлуулсан тостой нь бүр их таалагддаг. Тэр өмдөө татав.

-За яахав. Гэхдээ би тантай хамт бууна. Бас амны цаасыг сөхөж үзүүлэхээс нааш та түүнд юу ч өгч чадахгүй.

Роуз амны цаасыг сөхөв. Тэнд улаан лооль ба салаттай хоёр хавчуургайтай талх бас "Эглантери"-гийн үйлчлүүлэгчид авдаг тооцооны хуудасны ар дээр "Тэсээрэй. Бид чамд итгэж байна" гэж бичсэн зурвас байв.

Мел зурвасыг авч базаад хогийн сав руу чулуудав. Оносонгүй. Шинэ цэргүүдийн нэг нь яаран өргөөд хогийн сав руу хийлээ.

-Явцгаая гээд Мел шат руу очсоноо гэнэт зогсч тавагнаас нэг талхыг аваад том хазав. Тэгснээ -Тэр ийм ихийг тэртэй тэргүй идэж чадахгүй гэлээ.

Роуз ам нээгээгүй ч түүнийг урд нь орон шатаар буухад тавгаараа дэлсвэл аштай юу гэж бодлоо.

Тэд зоорийн хонгилын талаас өнгөрч явгал Мел гэнэт зогтусав.

-Хатагтай Роуз та цаашаа ойртож болохгүй. Тавгийг би аваачна гэхэд нь тэр тавгаа түүнд өгөөд гунигтай харж зогслоо. Мел доош сууж тавгийг торон завсар өгөөд: -Зоог барьлаа. Ноён Баас гэв.

Барби түүнийг тоосонгүй. Тэр Роуз руу харна.

-Баярлалаа. Гэхдээ энэ хоолыг Энсон шарсан бол би ганц хазаад л баярлахаа больж мэднэ.

-Хоолыг би бэлдсэн. Барби тэд яагаад чамайг зодсон юм бэ? Чи зугтах гэж оролдсон юм уу? Чи аймшигтай харагдаж байна? гэж Роуз асуув.

-Зугтах гэж оролдоогүй. Баривчлахад эсэргүүцэл үзүүлээгүй. Тийм биш гэж үү, Мел?

-Чи нэг их битгий чалчаад бай. Эс тэгвэл би ороод хавчуургатай талхыг чинь хураана шүү.

-Чи оролдож мэдээж чадна. Гэвч авч чадна гэдэгт би итгэхгүй байна гэв. Тэгээд Мел хавчуургатай талх руу дайрах оролдлого хийх хүсэл үзүүлээгүй тул дахиад Роуз руу хандлаа.

-Дахиад онгоц уу? Дуу нь онгоц л байсан даа. Том онгоц байсан уу?

-"Эйр Айленд"-ын агаарын хөлөг гэж зурагтаар хэлсэн. Дүүрэн хүнтэй.

-Би ойлгох шиг боллоо. Бостон юмуу Нью-Йорк руу нисч явсан онгоц. Хэн нэг тэнэг нь авто жолоодлогын программыг өөрчлөхөө мартсан байна.

-Мэдэхгүй. Энэ тухай хэн ч хэлээгүй.

-Явцгаая. Ярьж боллоо. Надад эвгүй юм тохиолдохоос өмнө бид явах ёстой гээд Мел бүсгүйн гараас барив.

-Чи зүгээр үү? гэж Роуз байрнаасаа хөдлөлгүй Барбигаас асуув.

-Тийм ээ. Харин чи ямар байна даа. Жеккитэй эвлэрсэн үү?

Ямар хариулт зөв бэ? Учир нь Роуз Жеккитэй муудалцаагүй гэдгээ мэднэ. Барби толгойгоо үл мэдэг сэгсрэв. Роуз тэгсэн гэж худлаа хэлээгүй байгаасай гэж найдах л үлдлээ.

-Үгүй.

-Чи түүнд гичий шиг аашлахаа боль гэж хэлэх ёстой доо.

-Тэр чинь зөв шүү гэж Мел бувтнаад Роузын гараас татаж: -Явцгаая. Цаг боллоо. Таныг чирч гаргахад бүү хүргээрэй.

-Түүнд дамжуулаарай. Чи сайн бүсгүй гэж намайг хэлсэн гээрэй. Та хоёр үнэхээр уулзаж ярилцах хэрэгтэй. Хавчуургатай талх өгсөнд баярлалаа гэж Роузыг Мелийн урд ороод шатаар өгсч явахад нь Барби хашгирав.

Түүнд дамжуулаарай. Чи сайн бүсгүй гэж намайг хэлсэн гээрэй.

Энэ илгээлт гэдэгт Роуз огт эргэлзсэнгүй. Мел ойлгосон гэж тэр бодохгүй байлаа. Тэр

бусдаас ямар нэг юмаар ялгардаг гэвэл тэнэгээрээ л байх. Бүрхүүл дор орлоо гээд түүний ухаан хумсын чинээ ч нэмэгдээгүй. Тийм ч учраас Барби азаа үзсэн.

Роуз Жеккиг аль болох түргэн олж илгээмжийг дамжуулахаар шийдэв. "Надад итгэж болно" гэж Барби хэлсэн.

Надтай нээлттэй байж болно гэж Барби хэлсэн.

-Мел чамд баярлалаа. Чи надад тус боллоо гэж Роуз дээшээ гараад хэллээ.

Мел эргэн тойрноо хараад энд түүнээс дээш тушаалтай хүн байхгүйг мэдэв.

-Ямар ч асуудалгүй. Гэхдээ та оройн хоол бариад доош бууж чадахгүй л болов уу? Яагаад гэвэл тийм юм болохгүй гэж хэлснээ бодлогоширч дараа нь гүн ухаанч маягаар: -Гэвч Барби ямар нэг амттан идэх гавьяатай гэж би бодож байна. Яагаад гэвэл дараагийн долоо хоногийн энэ өдөр түүнийг таны авчирсан хавчуургатай талх шиг шарах болно гэлээ.

"Тэгэхийг чинь харна аа" гэж Роуз дотроо бодов.

22

Энди Сандерс Шеф хоёр ХБЭ радио станцын ар талд зоорины дэргэд суугаад мет татна. Тэдний чанх урд талд дамжуулах цамхагийн эргэн тойрны талбай дээр шороон дов байх ба дээр нь банз зөрүүлж хадсан загалмай байх ажээ. Тэрхүү шороон довон дор одоо Литл Уолтерийн ээж, хүчингийн хэргийн хохирогч, хүүхэлдэй тамлагч Сэмми Буши нойрсч байна. Хожим Честерс цөөрмийн дэргэдэх оршуулгын газраас жинхэнэ загалмай хулгайлж авчирна гэж Шеф хэлсэн. Хэрэв цаг гарах юм бол. Цаг гарахгүй ч байж мэднэ.

Тэр сүүлчийн үгнийхээ хичнээн жинтэйг тодруулахын тулд гараашийн удирдлагаа өргөж харуулав.

Энди яг л Клодетт ба Доди нарын явж одсонд харууссан шигээ Сэммигийн талийсанд харуусч байлаа. Гэхдээ одоо энэ харуусал нь өөрийнх биш ч юм шиг. Сандерсын дотор үүссэн Бүрхүүл дотор хадгалагдаж байгаа ч юм шиг санагдана. Тэр харуусал байгааг анзаарч байсан ч түүнтэй нэгдэж чадахгүй байв. Энэ сайн хэрэг. Тэр үүнийг Шеф Бушид тайлбарлах гэж оролддоо. Гэвч өнөөх нь түүний санааг дундаас нь хойш ойлгохоо болив. Их хэцүү санаа бололтой. Гэхдээ Шеф толгой дохих бөгөөд хажуу бөөрөн дээр нь "Худалдахыг хуулиар хориглоно" гэсэн бичээс цохисон мет татах том гаансаа Эндид дамжуулав.

-Сайхан байна тийм үү?

-Тийм ээ гээд Энди толгой дохилоо. Нэг хэсэг тэр хоёр мансуурагчдын хувьд хамгийн чухал хоёр сэдвийг хөндөв. Энэ нь хичнээн сайн мет болоод ийм сайн мет гаргаж авахын тулд хичнээн их хөдөлмөр зарсан тухай юм. Тэдний яриаг умар зүгт болсон хүчтэй дэлбэрэлт тасаллаа. Энди метийн утаанд хорсох нүдээ анив. Тэр гаансаа унагах шахсан бөгөөд Шеф өрсөн шүүрлээ.

-Бурхан минь, энэ чинь онгоц байна гэж хэлээд Энди босох гэж оролдсон ч тэнийлгэн түлхэх эрч хүчийн үйлчлэлээр хоёр хөл нь чичирсэн боловч биеэ барьж дийлсэнгүй. Тэр эргээд суув.

-Үгүй дээ, Сандерс гээд Шеф гаансандаа тамхи чихлээ. Тэр завилан суух бөгөөд энэ нь Эндид энхтайвны гаанс татаж байгаа индианыг санагдуулна.

Ханын хажуугаар тэдний хооронд дөрвөн ширхэг АК-47 буу байх бөгөөд Оросод үйлдвэрлэгдэж, зооринд хадгалагдаж байгаа олон ашигтай зүйлийн адил Хятадаас импортоор орж иржээ. Тэдний хажуугаар тус бүр дотроо 30 сумтай тахир хэлбэртэй бууны дайзнууд бүхий таван хайрцгийг дээр дээрээс нь эгнүүлэн тавьжээ. Мөн РГД-5 гар бөмбөг бүхий хайрцаг байв. Шеф Эндид гар бөмбөгтэй хайрцаг дээр бичсэн "Энэ новшийг алдаж унагаж болохгүй" гэсэн бичээсийн уггыг тайлбарлав.

Шеф нэг буу авч өвдөг дээрээ тавьлаа.

-Энэ онгоц биш гэж тэр дурьдав.

-Үгүй юу? Тэгээд юу вэ?

-Бурхны тэмдэг гээд Шеф ханан дээр өөрийн гараар бичсэн хоёр ишлэлийг харав. Тэнд наминчлалын номноос авсан хоёр ишлэл "утга найруулгын засвартайгаар" бичигдсэн байх ба 31 гэсэн тоо тод харагдана. Дараа нь харцаа Энди рүү шилжүүллээ. Умар зүгт тэнгэр дэх угаан үүл тархаж байна. Гэтэл тэртээ доор шинэ угаа манарч эхлэв. Унасан онгоц ойг шатаажээ.

-Би огноо дээр алджээ гэх Шефийн дуу тун бодлогоширонгуй байлаа. -Энэ жил хэллоуин эрт болох юм байна. Магадгүй өнөөдөр. Эсвэл маргааш ч юмуу, нөгөөдөр ч байж мэднэ.

-Нэг өдрийн хойно ч байж мэднэ гэж Энди туслахыг хичээн нэмлээ.

-Магадгүй. Гэхдээ би эрт ирнэ гэж бодож байна. Сандерсаа?

-Юу гэв Шеф?

-Автомат бууг ав. Одоо чи бурхны армид орлоо. Чи христийн дайчин. Чиний бурханаас нүүр буруулсан гичийний хүүгийн бөгсийг долоож байсан өдрүүд ард үлдлээ.

Энди автомат бууг авч нүцгэн хөл дээрээ тавив. Бууны жин болоод халсан төмөр нь түүнд таалагдана. Буу гал хамгаалагч дээрээ тавигдсан эсэхийг шалгав. Тавигдсан байлаа.

-Шеф ээ чи ямар бурханаас нүүр буруулсан гичийний хүүгийн тухай яриад байна вэ?

Цаадах нь түүн рүү үзэн ядсан харцаар харсан ч Эндиг гаанс авахаар гараа сунгахад дуртайяа дамжуулав. Мет тэр хоёрт хангалттай. Төгсгөл иртэл хангалттай. Тэгээд ч төгсгөлийг хүлээхэд удаан хугацаа үлсдэнгүй.

-Реннигийн тухай ярьж байна. Бурхнаас нүүр буруулсан гичийний хүүгийн тухай.

-Тэр миний найз. Миний нөхөр. Гэхдээ тэр баас байж мэднэ. Яг тийм. Бурхан минь. Энэ мет ямар сайхан юм бэ? гэж Энди хэлэв.

-Сайхан шүү гэж Шеф зөвшөөрөөд гаансыг авлаа. (Одоо Энди түүнийг энхтайвны тамхины гаанс гэж бодох болов) -Хамгийн урт талст. Цэврүүдээс ч цэвэр энэ юу вэ Сандерс аа?

-Уйттар гунигаас аврах эм гэж Энди ухаалаг царайлан хариулав.

-Тэр одоо юу вэ? гээд Шеф Бүрхүүл дээр үүссэн шинэ хар толбыг заав.

-Тэмдэг. Бурхнаас илгээсэн.

-Тийм ээ, яг тийм. Бид бурхны заасан зам дээр байна Сандерс. Бурхан долоодугаар лацыг нээх үед юу болсныг мэдэх үү? Чи Гэгээрлийн номыг уншсан уу?

Энди өсвөр насандаа явж байсан залуу христчүүдийн зуслангийн тухай бодлоо. Долоодугаар лацыг нээхэд үсрэн гарч ирдэг сахиусан тэнгэрүүд. Яг л циркийн жижиг машинаас гарч ирдэг алиалагчид шиг. Гэвч энэ тухай ийм үгээр ярихыг хүссэнгүй. Шеф түүнийг бурхныг гутаалаа гэж тооцож мэднэ. Тиймээс толгой сэгсрэв.

-Би тэгж мэдсэн юмаа. Чи Ариун Гэм цайруулагчийн сүмд нүглээ наманчилж болно. Гэхдээ нүгэл наманчилах чинь боловсрол биш шүү. Нүгэл наманчилах бол нүдэнд харагдтал харуулдаг юм биш. Чи үүнийг мэдэх үү?

Энди ганцхан зүйлийг мэдэж байлаа. Тэр нь дахиад мет татах. Гэвч толгой дохив.

-Долоодугаар лац нээгдэхэд долоон бүрээтэй, долоон сахиусан тэнгэр гарч ирсэн. Тэгээд тэдний хэн нэг нь бүрээгээ үлээх тоолонгоор дэлхий дээр гай болдог. Алив татаач. Анхаарлаа төвлөрүүлэхэд тусална.

Тэд хичнээн удаан татсан бэ? Олон цаг мэт санагдана. Тэд үнэхээр онгоц сүйрэхийг харсан уу? Энди тийм гэж бодох боловч одоо баталж чадсангүй. Хий үзэгдэлтэй тун адил байв. Жаахан хэвтэж унтах ёстой юмуу. Гэвч нөгөө талаас Шефтэй зэрэгцэн суух, мет татах ба мэдлэг олж авах нь гайхалтай кайф.

-Би амиа хорлох шахсан. Гэвч бурхан намайг аварсан гэж тэр Шефэд үнэнээ хэлэв. Баярласандаа нулимс цийлэгнэлээ.

-Тийм ээ, тийм. Тэр мэдээж. Харин нөгөөх нь бол үгүй. Тэгэхээр сонс.

-Би сонсож байна.

-Эхний сахиусан тэнгэр бүрээгээ үлээхэд газар дээр цус асгарсан. Хоёрдугаар сахиусан тэнгэр үлээхэд далай дотор галан уул гулгисан энэ бол галт уул болоод бусад бааснууд.

-Тийм ээ гэж Энди хашгираад өөрийн мэдэлгүй өвөр дээрээ байсан Ак-47 бууны гохыг дарж орхив.

-Чи наадахтайгаа болгоомжтой байгаач. Хэрэв хамгаалагчийг түгжээгүй бол миний эрхтэн одоо тээр тэр нарс модон дээр өлгөөстэй байх байлаа. Май сор гээд Эндид гаансаа сунгав. Өнөөх нь Шефэд гаансыг өгсөнөө ерөөсөө санахгүй байлаа. Өгсөн л юм байж дээ. Ингэхэд одоо цаг хэд болж байна вэ? Үд дунд л байх. Яаж мэдэх вэ дээ. Урьд нь үдийн хоол дандаа идмээр санагддаг байсан ч энэ удаад хүссэнгүй. -Одоо сонс. Сандерс. Яагаад гэвэл энэ хамгийн чухал хэсэг.

Шеф Гэгээрлийн номыг эхнээс нь дуустал судалсан болохоор ишлэлийг шууд хэлдэг. Тэр радио станцад ирснээсээ хойш ингэтэл судалжээ. Галзуу хүн шиг л дахин дахин уншдаг байлаа. Заримдаа үүр цайтал уншина.

-Гурав дахь сахиусан тэнгэрээс том од унасан юм. Шатаж байгаа од. Яг чийдэн шиг.

-Бид дөнгөж сая түүнийг харлаа.

Шеф толгой дохив. Тэр "Эйр Айленд" нисэх компанийн 179-р чиглэлийн нислэг төгсч хар тэмдэг үлдсэн газар руу харав.

-Энэ одны нэрийг Агь гэдэг юм. Тэгэхэд олон хүн үхсэн. Яагаад гэвэл тэд гашуун болсон юм. Сандерс чи гашуун уу?

-Үгүй гэж Энди батлав.

-Үгүй. Бид амттай. Гэвч одоо нэгэнт тэнгэр Агь од ассан болохоор гашуун хүмүүс ирнэ. Энэ дэмий яриа биш. Бурхан надад сануулсан юм. Сандерс чи намайг шалга. Тэгээд чи миний дэмийрээгүй болохыг мэднэ. Гашуун хүмүүс энэ бүхнийг биднээс авах гэж оролдоно. Ренни ба түүний баастай найз нар.

-Хэзээ ч үгүй гэж Сандерс дуу алдлаа. Гэнэтийн айдас түүнийг эзэмдэв. Тэд энд байна. Баастай найзууд мод хоорондуур гэтэж байна. Баастай найзууд Литл-Битч-Роуд гудамжаар ачааны тэрэг ба пикапын цуваа болон явж байна. Тэгээд одоо Шефийг ярьсанаас хойш Ренни яагаад үүнийг хийхийг хүсээд байгааг тэр ойлгов. Тэр "Эд мөрийн баримтаас салах" зорилготой.

-Шеф гэж хашгираад Энди шинэхэн найзынхаа мөрнөөс зуурлаа.

-Сандерс аяар. Чи намайг өвтгөөд байна. Энди барьцаа сулруулав.

-Том Жим хийтэй чингэлэг ба савнуудыг ирж авна гэж ярьж байсан. Энэ түүний хийх эхний алхам. Шеф толгой дохилоо.

-Нэг удаа тэд ирцгээсэн. Хоёр чингэлэг аваад явсан. Би тэдэнд зөвшөөрсөн. Цаашид зөвшөөрөхгүй. Чи надтай адил уу? гээд тэр гар бөмбөгөө алгадав.

Энди тэдний нуруугаар налсан барилга дотор хадгалагдаж байгаа олон фунт хар тамхины тухай бодлоо. Тэгээд Шефийн хүлээж байсан хариултыг өгөв.

-Дүү минь гээд Шефийг тэвэрлээ.

Өмхий үнэртэй халуун энэ эрийг Энди чин сэтгэлээсээ тэврэв. Сүүлийн хорин жилийн дотор долоо хоногийн ажлын өдөрт анх удаа сахлаа хусаагүй хацрыг нь даган нулимс бөмбөрөв. Энэ их сайхан байлаа. Энэ бол... бол...

Энэ нь ойр дотно болгож байлаа.

-Дүү минь гэж цурхирах дуу түүнээс гарч Шефийн чих рүү оров.

Шеф түүнийг тэвэрч нүд рүү нь сүрлэг харав. -Бид бурхны туршуулууд.

Одоо хажууд нь сууж байгаа туранхай зөнчийг эс тооцвол Энди Сандерс энэ дэлхийд гав ганцаараа болжээ. Тэр: -Аминь гэв.

23

Эрни Кэлверт байшингийнхаа арын ногооны талбайг цэвэрлэж байхад нь Жекки олж очив. Пайпертай ярилцсан өөрийн санаа бодлыг Эрнид ярихдаа бага зэрэг тугшиж байсан ч энэ нь дэмий байжээ. Тэр цүдгэр гэдэстэй намхан нуруутай эрд баймгүй гайхалтай хүчирхэг гараараа мөрнөөс нь базав. Түүний нүд гялалзаж байлаа.

-Бурхны аврал. Хэн нэгэн энэ хөөмөл цацагт хяруул юу бодоод байгааг ойлгосон байна шүү. Уучлаарай. Цамцыг чинь муухай болгочихлоо гээд Эрни гараа буулгалаа.

-Айх юм байхгүй.

-Тэр аюултай шүү, цагдаа Жекки. Чи үүнийг мэдэж байгаа тийм үү? -Тийм.

-Бас ухаантай. Алан хядагч бөмбөг дэлбэлдэгийн яг адил тэр их дэлгүүрийн хажууд самуун зохион байгуулсан. -Би үүнд эргэлзэхгүй байна.

-Гэвч тэр бас их тэнэг. Ухаан ба тэнэглэл нь их хачин хослол. Ийм хүмүүс бусдыг араасаа дагуулж чаддаг. Там хүртэл дагуулна. Тэр Жим Жонсыг хар даа. Чи санаж байна уу? (энэ нь америкийн номлогч бөгөөд "Ард түмний сүм" шашны байгууллагын үүсгэн байгуулагч, түүнийг бишрэгчид 1978 онд нийтээрээ амиа хорложээ).

-Тэр шүтэн бишрэгчдээ хор уухад хүргэсэн. Чи тэгээд уулзалтанд ирэх үү?

-Итгэлтэй байж болно. Бас хэнд ч юу ч хэлэхгүй. Гэхдээ чи намайг Лиссатай ярихыг хүсэхгүй бол шүү дээ. Би дуртайяа хийнэ шүү.

Жекки хариу өгч амжаагүй байтал гар утас нь дуугарав. Хувийн гар утас. Цагдаагаас өгсөн гар утсыг тэр гар буу болоод тэмдэгтэйгээ хамт буцааж өгсөн.

-Байна уу? Жекки сонсож байна.

-Мийн роггагое ушпегатоз ахлагч Уэттингтон гэх үл таних эрэгтэй хоолой дуугарлаа.

Вюрцбург дахь цэргийн ангийнхаа уриаг сонсоод Жекки түгдрэлгүй хариулав. Энэ нь "шархтануудаа манайд авчир" гэсэн уриа юм.

-Чирээд ч хамаагүй, үүрээд ч хамаагүй авчирна. Бид өөрийнхнийгөө гай зовлонд орхидоггүй. Хэн бэ? Чөтгөр ав.

-Хурандаа Кокс байна. Ахлагч аа.

Жекки утас барьсан гараа буулгав.

-Эрни надад хугацаа өгөөч гэхэд өнөөх нь толгой дохиод ногооны талбай руугаа явав. Жекки хашаа руу очиж зогсоод:

-Хурандаа би таны төлөө юу хийж чадах вэ? Энэ шугамыг чагнаж байгаа юм биш биз?

-Ахлагч аа, хэрэв танай Ренни гаднаас орж ирж байгаа утасны дуудлагыг сонсож байгаа бол бид том гайд орлоо гэсэн үг.

-Тэр минийх биш.

-Ийм юм сонсоход таатай байна.

-Тэгээд ч би цэрэгт алба хааж байгаа биш. Өнөөдөр 67 дугаарыг арын шилэндээ ч харж чадахгүй.

-Ахлагч аа, арай ч тийм биш шүү. Нэгдсэн улсын ерөнхийлөгчийн тушаалаар таныг дахиад цэргийн албанд татсан. Бидний эгнээнд тавгай нэгдэгтүн.

-Ноёнтон би танд талархах юмуу эсвэл тонил гэж хэлэхийнхээ алийг мэдэхгүй байна.

Кокс онцын хөгжил баясалгүй ч инээлээ.

-Жек Ричер танд мэнд дамжуулж байна.

-Та миний дугаарыг түүнээс аваа юу?

-Дугаар болоод сайшаалын үгийг. Ричарын сайшаал гэдэг их үнэтэй. Та бидний төлөө юу хийж чадахаа асуусан. Хариулт нь хоёр хэсгээс бүтэх бөгөөд энгийн. Нэгдүгээрт Дейл Барбараг шоронгоос гаргах хэрэгтэй. Гэхдээ хэрэв та түүнийг бүх талаар буруутай гэж бодохгүй байгаа бол.

-Эсрэгээр пгүү ноён. Би түүнийг буруугүй гэдэгт итгэлтэй байна. Яг хэлэх юм бол бид итгэлтэй байна. Бид хэдүүлээ болсон.

-Сайн байна. Маш сайн байна гэх тэр эрийн хоолойд сэтгэл хөнгөрөл тодрох нь эргэлзээ

төрүүлсэнгүй. -Хоёрдугаарт та нар Ренниг тухалсан суудлаас нь ховх цохих ёстой.

-Энэ бол Барбарагийн ажил. Хэрэв... энэ утсыг чагнахгүй байгаа гэдэгт та итгэлтэй байна уу? -Бүрэн итгэлтэй.

-Хэрэв бид түүнийг суллаж гаргаж чадвал. -Та нар энэ талаар ажиллаж байгаа юу? -Тийм. Ноёнтоон.

-Маш сайн. Ингэхэд Реннид хэдэн хар цамцтан байгаа вэ? -Яг одоогоор 30 гаруй. Гэвч тэр шинэ хүмүүсийг хөлсөлж

байгаа. Миллд бол тэд цэнхэр цамцтангууд. Гэхдээ би таныг ойлгосон. Хурандаа түүнийг дугуу үнэлж болохгүй шүү. Хотын ихэнхи хэсэг түүний хармаанд байдаг. Бид Барбараг сугалж гаргах гэж оролдох болно. Та бидний амжилтанд найдсан нь дээр. Яагаад гэвэл би өөрөө бол Том Жимийг дийлэхгүй. Дарангуйлагчийг гаднаас тусламжгүйгээр авч хаях нь миний тэнхээ хүрэх ажил биш. Жирийн цагдаагийн цалингаар бүтэхгүй. Тэгээд ч Честерс-Миллийн цагдаагийн алба маань дуусчихсан. Ренни намайг гаргаад хаячихсан.

-Надад итгэж байгаарай. Барбараг чөлөөлж түүнд эсэргүүцлийн хөдөлгөөний удирдлагыг өг. Өөр хэнийг гаргаж хаяхыг нь бид харна.

-Ноёнтон миний ойлгож байгаагаар та энд байхыг хүсч байна уу?

-Бүх сэтгэл зүрхээрээ гэж Кокс өчүүхэн ч эргэлзэлгүй хариулав. -Би 12 цагийн дотор түүний бүх өдийг зулгааж хаях байсан.

Жекки үүнд тун эргэлзэж байв. Бүрхүүл дор бүх юм ондоо байлаа. Хөндлөнгийн хүмүүс ойлгохгүй. Цаг хугацаа хүртэл өөрөөр урсч байв. Тавхан хоногийн өмнө энд бүрэн эмх журам ноёрхож байсан. Харин одоо...

-Аа бас зурагт үзэх цаг олоорой. Реннигийн амьдралыг хүндрүүлэхийн тулд бид өөрийн зүгээс бүх хүчээ тавих болно гэж хурандаа Кокс үргэлжлүүлэв.

Жекки салах ёс гүйцэтгээд холбоог тасаллаа. Тэгээд ногооны талбайд тонголзох Эрни дээр эргэж ирэв.

-Чамд цахилгаан үүсгүүр бий юу?

-Өчигдөр шөнө амьсгаа хураасан гээд Эрни гашуун инээлээ.

-За яахав зурагт гарч байгаа газар олж очъё. Миний найз мэдээ үзсэн нь дээр гээд байна.

Тэд "Эглантери"-г чиглэлээ. Замаараа Жулиятай таараад хамт авч одов.

Зодуулж баривчлагдав

1

Роуз үдийн хоолноос үлдсэн зүйлсээр хөнгөхөн оройн хоол бэлдэх санаатай "Эглантери"-г 5 цаг хүртэл хаажээ. Тэр төмсний салат бэлдэнгээ зурагт харж зогстол хаалга тогшив. Жекки, Эрни, Жулия нар ирэв. Роуз гараа хормогчиндоо арчингаа хоосон танхимаар өнгөрч хаалгаа нээлээ. Горас нохой чихээ унжуулж нөхөрсөг инээн Жулиягийн дэргэд зогсоно. Роуз тэднийг урьж оруулаад "хаалттай" гэсэн бичиг байрандаа эсэхийг шалгаад хаалгаа хаав.

-Баярлалаа гэж Жекки талархлаа.

-Зүгээр дээ. Тэгээд ч би чамтай уулзах гэж байсан юм.

-Бид үүний төлөө ирлээ гээд Жекки телевиз рүү заав.

-Би Эрнигийн дэргэд байсан юм. Замаараа Жулиятай таарсан. Тэр түймрийн газрын эсрэг талд суучихсан гарз хохиролдоо гашуудаж байсан.

-Би гашуудаагүй гээд Жулия толгой сэгсрэв. -Би горастайгаа хотын хурлын дараа яаж сониноо гаргах талаар бодож байсан юм. Хоёрхон хуудастай жижигхэн хэдий ч сонин гарах болно. Би заавал гаргана гэж шийдсэн.

Роуз зурагт руу хяламхийлээ. Дэлгэцэн дээр залуухан хөөрхөн бүсгүй шууд дуран руу харан зогсоно. Түүний доогуур гүйдэг туузан дээр "Өнөөдрийн зураг авалтыг Эй-Би-Си-гийн зөвшөөрлөөр хийлээ" гэсэн бичиг давтагдана. Тэр дороо ямар нэг юм нирхийгээд тэнгэрт галан бөмбөлөг асав. Энэ үед дуран эмэгтэй рүү харахаа больжээ. Зураглаач нь "Эйр Айленд"-ын нисэх хөлгийн үлдэгдэл хэрхэн газарт унаж байгаа зургийг авна.

-Энэ зүгээр л ослын зураг авалтыг давтаж байна гэх Роузын царайд ямар ч сонирхол төрсөнгүй. -Хэрэв та нар үзээгүй байгаа бол үз үз. Жекки өнөө өглөө би Барбаратай уулзсан. Би хавчуургатай талх авч очсон юм. Тэгээд хорих өрөөнүүд байдаг хонгил руу буухыг зөвшөөрсөн. Намайг Мел Сирлс дагалдсан.

-Чамд аз тохиожээ гэж Жекки хэлэв.

-Тэр ямар байна даа? Зүгээр үү? гэж Жулия асуув.

-Тэр яг л бурхны айдас шиг харагдаж байсан. Гэхдээ зүгээр гэж бодож байна. Тэр надад хэлсэн... Гэхдээ би түүний хэлсэн үгийг зөвхөн чамд хэлэх ёстой байх тийм үү Жекки?

-Юу хэлсэн байлаа ч гэсэн чи Эрни Жулия хоёрын дэргэд бол хэлж болно.

Роуз түүний үг дээр ганцхан хором бодов. Хэрэв тэр Эрни Жулия хоёрт итгэхгүй юм бол итгэл төрүүлэх хэн байгаа юм бэ?

-Тэр намайг чамтай ярилц гэж хэлсэн. Бид муудалцчихсан юм шиг эвлэргэсэн. Бас тэр намайг сайн бүсгүй гэж чамд дамжуул гэсэн.

Жекки эргэж Эрни Жулия хоёр руу харав. Тэр асуулт асуугаад хариулт авах шиг Роузад санагдлаа.

-Хэрэв Барби тэгж хэлсэн бол тийм л байх ёстой гэж түүнийг хэлэхэд Эрни түргэн түргэн толгой дохив.

-Хонгор минь, өнөө орой бид жижиг уулзалт зохионо. Пайперын гэрт. Гэхдээ энэ бол зарим нэг талаар нууц шүү...

-Бүх талаар нууц гэж Жулия яриаг нь засаад: -Хотын үйл явдал хэрхэн өрнөж байгааг тооцох юм бол нууц чигээр үлдэх нь дээр.

-Хэрэв би юуны тухай яриа болоод байгааг зөв ойлгож байгаа бол би та нартай хамт. Гэхдээ Энсон биш шүү. Тэр чөттөр авмар ханцуйн цэнхэр зүүлт зүүж яваа гэж Роуз дуугаа намсган хэллээ.

Яг энэ үед дэлгэц дээр "Си-Эн-Эн"-ний шуурхай мэдээлэл гэсэн бичиг гарч ирэв. Бүрхүүлийн тухай мэдээ гарах бүрт энэ сувгаар нижигнэдэг дургүй хүрэм хөгжим бас цуурайтлаа. Андерсон Купер юмуу хайртай Вольфийгоо олж харна гэж Роуз хүлээнэ. Тэд одоо хоёулаа Касл-Рокод сууринээ. Гэвч дэлгэцэн дээр пентагоны сурвалжлагч Барбара Старр гарч ирэв. Тэр эмэгтэй Харлоу дахь цэргийн тэргүүн баазын майхан хотхоны дэргэд зогсоно.

-Бүрхүүл хэмээн нэрлэгдээд байгаа аварга том үл тайлагдам хаалт бямба гаригт гэнэт бий болсон тэр цагаас хойш пентагоны тусгай бүрэн эрхэт төлөөлөгчөөр ажиллаж байгаа хурандаа Жеймс Оу Кокс хямрал эхэлснээс хойш хоёр дахь удаагаа хэвлэлд мэдээлэл өгөх гэж байна. Сэдвийг нь дөнгөж сая сэтгүүлчид зарласан бөгөөд энэ сэдэв ойр дотны хүмүүс нь тусгаарлагдсан Честерс-Милл хотод байгаа хэдэн мянган америкчуудыг анхаарлыг татах нь дамжиггүй. Бидэнд мэдээлэхдээ... гэснээ тэр чихэвчээ чагнав. -Одоо хурандаа Кокс...

Ресторанд лангууны хажуугийн өндөр сандалд суугаад зурагт үзэж байгаа дөрөв дүрс солигдохыг ажиглана. Том майхан доторхи дуран залгагдлаа. 40 орчим сурвалжлагчид эвхдэг сандалд суух бөгөөд бүр олон сэтгүүлчид араар нь зогссон байна. Олонхи нь хоорондоо шивэр авир ярилцана. Майхны алсын буланд яаруу сандруу босгосон өндөрлөг байх ажээ. Тэрхүү өндөрлөг дээр индэр байрлуулаад хажуугаар нь Америкийн дарцагтай микрофонуудыг тавьсан байв. Индэрийн ар талын дэлгэц цайрна.

-Хээрийн нөхцөлд гэхэд тун мэргэжлийн байна шүү гэж Эрни бувтнав.

-Энэ бол гэрийн бэлтгэл гэж би бодох юм хэмээн Жекки хэллээ. Тэр Кокстой ярилцсанаа санав. "Бид өөрийн талаас Эрнигийн амьдралыг хүндрүүлэхэд бүх хүчээ тавих болно".

Майхны зүүн ханын унжуулсан хаалга сөхөгдөж тийм ч өндөр биш нуруутай цэх биетэй буурал унасан үстэй эр орж ирэв. Пүрштэй юм шиг хөнгөн алхан өндөрлөгийг чиглэлээ.

Индэртэй тавцангийн дэргэд дээр нь гарахад зориулан хоёр гишгүүр хийх юмуу ядахдаа хайрцаг тавих санаа хэнд ч төрөөгүй бололтой. Гэвч хүмүүсийг хүлээлгэсэн илтгэгч маань түүнтэй түүнгүй хөнгөхөн үсрэн гарлаа. Тэр бүү хэл алхаагаа ч нэмэлгүйгээр хөнгөхөн үсэрч гарав. Тэр хээрийн ногоон өнгөтэй хувцастайгаар хэвлэлийн бага хуралд иржээ. Хэрэв тэр төрөөс шагнал авч байсан бол ямартаа ч энэ удаад одонгийн туузнууд байхгүй байв. Гагцхүү "Хурандаа Ж.Кокс" гэсэн бичиг л энгэртээ оёсон байлаа. Тэр гартаа ямар ч цаас барьсангүй. Сурвалжлагчид тэр дороо нам гүм болоход Кокс тэдэнд хөнгөн инээмсэглэл бэлэглэв.

-Энэ залуу дандаа хэвлэлийн бага хурал явуулмаар юм байна. Сайхан харагдаж байна гэж Жулия тайлбарлалаа.

-Жулия чимээгүй гэж Роуз өөрийн эрхгүй хэллээ.

-Ноёд хагагтай нар аа, ирсэнд баярлалаа. Би богинохон мэдээлэл хийгээд дараа нь хэдэн асуултанд хариулна. Честерс-Милл хот болоод бидний Бүрхүүл хэмээн нэрлэж байгаа зүйлийн тухайд нөхцөл байдал ийм байна. Хот урьдын адил таслагдсан хэвээр байгаа ба бид Бүрхүүл ямар шалтгаанаар бий болсон, яаж бий болсон талаар урьдын адил ойлголтгүй байна. Одоохондоо бид энэ саадыг цөмөлж чадаагүй байна. Хэрэв чадсан бол та бүхэн заавал мэдэх байсан. Америкийн шилдэг эрдэмтэд бол дэлхийн шилдгүүд билээ. Тэд энэхүү асуудал дээр ажиллаж, бид түүнийг шийдэх хэд хэдэн болзошгүй арга замыг судалж байгаа. Гэхдээ тэр талаар надад асуулт тавих хэрэггүй. Яагаад гэвэл хариулт авахгүй гэж хэлэхэд сурвалжлагчид дургүйцэн шуугилаа. Кокс тэдэнд саад хийсэнгүй. Түүний доогуур "Энэ удаад ямар ч хариулт өгөхгүй" гэсэн бичгийг Си-Эн-Эн гэрэлтүүлэв. Хүмүүсийн дургүйцэл чимээгүй болоход Кокс үргэлжлүүлээ. -Та бүхний мэдэж байгаагаар бид Бүрхүүлийн эргэн тойронд хориотой бүс бий болгосон. Эхэндээ нэг миль өргөнтэй байсныг ням гаригт хоёр миль, мягмар гаригт дөрвөн миль болгосон. Ингэх ноцтой шалтгаан байлаа. Тэдгээр шалтгаануудаас хамгийн гол нь Бүрхүүл бол биедээ электрон багаж төхөөрөмжтэй хүмүүст тун аюултай. Жишээ нь зүрх дэмжигч гэх мэт. Хоёрдугаар шалтгаан нь Бүрхүүлийг үүсгэж байгаа эрч хүчний талбай хүний эрүүл мэндэд хортой үйлчилгээ үзүүлж болзошгүй гэж бид үзсэн. Гэхдээ одоохондоо энэ талаар мэдэхгүй байна.

-Та цацраг туяаны тухай яриад байна уу хурандаа? гэж хэн нэг нь асуув. Кокс түүнийг харцаараа намжаагаад сурвалжлагч авах ёстой сургамжаа авсан гэж тооцсон үедээ яриагаа үргэлжлүүлэв. (асуулт тавьсан хүн нь Вольфи биш харин "Фокс Ньюс"-ийн халзан хайнга залуу байсанд Роуз сэтгэл ханав).

-Харин одоо бид энэхүү хүчний талбай хортой үйлчлэл үзүүлдэггүй гэдэгт итгэлтэй болсон. Ямар ч гэсэн богино хугацаанд. Тиймээс баасан гариг буюу аравдугаар сарын 27-нд өөрөөр хэлбэл нөгөөдөр Бүрхүүлийн дэргэд уулзалтын өдрийг зохион байгуулах гэж байна.

Коксийг ийнхүү мэдэгдсэний дараа асуултаар булсан нь ойлгомжтой. Хурандаа сурвалжлагчдыг багтрах хүртэл нь хүлээж чадав. Тэгээд үгийн давалгаа нь сулраад ирмэгц индэрийн тавцан дээрээс алсын удирдлага авч товчийг дарлаа. Өндөр нягтралтай гэрэл зураг (Жулиягийн бодлоор "Гугл-Дэлхий" сайтаас татаж авдагаас ч илүү чанартай) цагаан дэлгэцэн дээр гарч ирэв. Энд Милл хот ба түүнээс өмнө зүгт байрлах хоёр хот буюу Моттон болоод Касл-Рокийг харуулж байв. Кокс удирдлагыг хойш нь тавиад лазер заагчийг гартаа авлаа.

Одоо түүний доогуур "Баасан гариг Бүрхүүлаан дэргэдэх уулзалтын өдрөөр зарлагдлаа" гэсэн бичиг гарав.

Жулия инээд алдлаа. Кокс "Си-эн-эн"-ийг баригдуулчихлаа. Тэд яарсандаа туузанд "зөв бичих дүрмийг шалгах" гэсэн үйлдлээ залгахаа мартжээ.

-Бид 1200 зочныг хүлээн авч Бүрхүүлд хүргэж чадна гэдэгтээ итгэлтэй байгаа. Эдгээр нь зөвхөн хамгийн ойрын хамаатнууд байх болно... Бид бүгд хоёр дахь удаагийн ийм уулзалтын шаардлага гарахгүй гэдэгт найдаж залбирч байна. Цуглах газар нь энэ. Касл-Рокийн яармагийн нутаг дэвсгэр дээрх "Оксфорд Плейнс"-ийн авто талбай дээр. Бид хоёр хэсэг автобус бэлдэнэ. Хэсэг бүрт 12 автобус байх юм. Автобусуудыг тойргийн ойр орчмын 6 сургуулиас зээлдэх бөгөөд уулзалтын өдөр зохион байгуулахтай холбоотойгоор бидэнд туслахын тулд энэ өдөр сургуулиуд хичээллэхгүй бөгөөд үүнийх нь төлөө бид чин сэтгэлээс талархаж байна. 25 дахь автобус хэвлэлийнхэнд зориулагдсан ба Моттоны "Шайнерийн загасны хэрэгсэл ба өгөөш" дэлгүүрийн дэргэд хүлээх болно. Тэнд согтууруулах ундаа зардаг болохоор та нарын ихэнхи нь хаана байдгийг нь мэдэж байгаа. Хэвлэлийнхнийг нэг, давтан хэлье, ганцхан явуулын телевизийн станц дагалдах болно. Тиймээс бүх телевизээр гарах дүрслэл ижилхэн байх юм. Харин хэний станц явах вэ гэдгийг сугалаагаар шийднэ гэж Кокс чанга хатуу дуугаар ярив.

Сурвалжлагчид дуу алдсан ч нэг их чанга биш.

-Хэвлэлийнхэнд зориулсан автобус 48 суудалтай. Харин энэ дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэдэн зуун төлөөлөгч цуглажээ...

-Хэдэн мянга гэж буурал эрийг хашгирахад сурвалжлагчид инээлээ.

-Хэн нэгэн хөгжил баясалтай байгаад би баяртай байна гэж Эрни гашуунаар тайлбар хэлэв.

Кокс өөртөө инээмсэглэхийг зөвшөөрлөө.

-Ноён Грегори таны залруулгыг хүлээн авлаа. Суудлыг мэдээллийн товчоодоор хуваана. Телевизийн компаниуд, Ройтер, ТАСС, Ассашейтед Пресс гэх мэтчилэн. Харин товчоод өөрсдийн төлөөлөгчдийг сонгох ёстой.

-Си-Эн-Эн-ээс Вольфи яваасай. Миний хүсэх юм тэр л байна гэж Роуз дуу алдлаа.

Сурвалжлагчид хөдөлгөөн орон ярилцаж эхлэв.

-Үргэлжлүүлж болох уу? Мессеж илгээж байгаа хүмүүс байвал болихыг гуйя гэж Кокс үргэлжлүүллээ.

-Пөөх надад ятгаж итгүүлж чаддаг эрчүүд таалагддаг гэж Жекки хэлэв.

-Та бүхнийг энд юу хөтөлж авчирсаныг мэдээж санаж байгаа. Хэрэв та нар уурхайд гарсан түймэр дээр ирэх юмуу эсвэл газар хөдлөлтийн дараа нурсан байшингууд дор хүмүүс дарагдсан байвал ингэхгүй биз дээ.

Майханд яг л багш нь уурласны дараа дөрөвдүгээр ангийн хичээл дээр байдаг шиг нам гүм ноёрхов. Тэр үнэхээр итгүүлж үнэмшүүлж чаддаг юм байна гэж Жулия бодсон бөгөөд Кокс энд ирээд Бүрхүүл дор орж хотын удирдлагыг гартаа аваасай гэж бүх сэтгэл зүрхээрээ хүсэв. Гэвч хэрэв гахай далавчтай байсан бол гахайн утсан мах нисэх л байсан.

-Ноёд хагагтай нар аа та нарын ажил хоёр хэсгээс бүрдэнэ. Нэгдүгээрт та бүхэн уулзалтын өдрийн тухай мэдээллийг хүн бүрт хүргэхэд туслах ёстой. Хоёрдугаарт Бүрхүүлийн дэргэдэх уулзалтын өдөр ямар нэг асуудалгүй өнгөрөхийн тулд бүхнийг хийх ёстой.

Энэ үед Си-Эн-Эн туузаа сольж "Хэвлэлийнхэн баасан гаригт зочдод туслах ёстой" гэсэн бичиг гаргалаа.

-Манай орны өнцөг булан бүрээс хамаатан саднуудын давалгаа Мэн рүү халихыг бид хүсэхгүй байна. Бүрхүүлийн хавь ойрт тусгаарлагдсан арван мянгаад хамаатан саднууд байна. Энэ хавийн зочид буудал, буурчийн газар ба амралтууд чигжээстэй байгаа. Тиймээс улсын бусад хэсэгт байгаа хамаатан саднуудад та бүхэн "хэрэв та энд байгаа биш бол ирэх хэрэггүй" гэдгийг тодорхой ойлгуулж өгөх хэрэгтэй. Гаднаас ирсэн хүмүүст Уулзалтын өдөрлөг рүү нэвтрэх зөвшөөрөл өгөхгүйгээр зогсохгүй энд, энд, бас энд байрлах харуулын цэгүүдээс буцаах болно гэж хэлээд тэр Льюистон, Обурн, Норт-Уиндэм ба Нью-Хэмпшир муж улсын Конуэй зэрэг хэд хэдэн газар заалтуураа чиглүүлэв.

-Энэ хавьд байрлаж байгаа хамаатан саднууд яармаг болоод авто талбай дээр байгаа бүрэн эрхэт офицерууд дээр очиж бүртгүүлэх ёстой. Гэхдээ хэрэв яг одоо машиндаа суугаад тийш давхих гэж байгаа бол ингэх хэрэггүй. Бид энд "Файленс" их дэлгүүрийн цагаан үнэ хямдрал зохиож байгаа биш. (Энэ нь дотуур хувцас ба ихэнхдээ цагаан паалантай байдаг гэр ахуйн хэрэгсэлийн худалдааг хэлжээ). Та дугаарт хамгийн түрүүнд зогслоо гээд юу ч хожихгүй. Оролцогчдыг сугалаагаар тодруулах учир та бүхэн бүртгүүлээрэй. Уулзалтын өдөрт оролцохыг хүссэн хүн бүхэн бүртгэлийнхэн дээр хувийн бичиг баримтанд байдаг шиг хоёр хувь гэрэл зурагтай ирнэ. Бид Честерс-Миллд хоёр болоод түүнээс олон хамаатан садан нь байгаа хүмүүст давуу байдал олгох санаатай байгаа ч үүнийг амлаж чадахгүй. Бас шууд сануулах хэрэгтэй. Хэрэв та баасан гаригт нэвтрэх бичиггүйгээр юмуу эсвэл хуурамч бичигтэйгээр автобусанд суух гэж ирээд энэхүү ажиллагаанд саад болох юм бол таныг баривчилна. Үүнийг амьдрал дээр батлан үзүүлэхэд биттий хүргээрэй. Баасан гаригийн өглөөний 8.00-д автобусанд суулгаж эхэлнэ. Хэрэв ямар нэг алдаа гарахгүй бол та бүхэн ойр дотны хүмүүстэйгээ доод тал нь 4 цаг ба түүнээс илүү хугацааг өнгөрөөнө. Хэрэв саад үүсгэвэл Бүрхүүлийн наад талаас явуулах үйл ажиллагаа удааширна. Хамгийн сүүлийн автобус Бүрхүүлээс 17.00-д явна.

-Уулзалт хаана болох юм бэ? гэж нэг эмэгтэй хашгирав.

-Би яг үүнийг хэлэх гэж байна гээд Кокс удирдлагыг авч 119-р зам ба тэр хавийн нутаг дэвсгэрийн зургийг томсгов.

Жекки энэ газрыг сайн мэднэ. Яг энд Бүрхүүлийг мөргөж хамраа хугалах шахсан. Динсморын байшингуудыш дээвэр аж ахуйн барилгууд ба үнээний саравчнууд зураг дээр харагдана. Кокс заалтуурын гэрлийг газрын зураг руу чиглүүлээд:

-Энэ Моттоны талын хар зах байна. Автобусууд энд зогсох болно. Хамаатан саднууд автобусаас бууж Бүрхүүл рүү явган очно. Замын хоёр талаар талбай байдаг учраас газар бүх хүнд хангалттай. Тэр хавийн бүх эвдэрхий сэгийг баасан гариг гэхэд зайлуулна.

-Бүрхүүлд хэр ойртож болох юм бэ? гэж нэг эр асуув.

Кокс уулзалтын өдрийн болзошгүй оролцогчдод зориулан дуран руу нүүрээ харуулж зогсов. Энэ хүмүүсийн одоо эдэлж байгаа айдас болоод найдварыг Роуз төсөөлж чадна. Тэд баар ба буурчийн газарт нэвтрүүлэг үзэх юмуу машины радио хүлээн авагчаар сонсч байгаа.

-Зочид Бүрхүүлээс хоёр ярд зайтай байрлахыг зөвшөөрнө. Хэдийгээр бид ямар ч амлалт өгч чадахгүй ч ингэвэл аюулгүй гэж үзэж байгаа. Энэ бол амралт зугаалгын газрын тоглоом биш болохоор бид аюулгүй байдлыг нь шалгах боломжгүй. Биедээ цахилгаан төхөөрөмж суулгасан хүмүүс холхон байх хэрэгтэй. Хүмүүс өөрөө өөртөө анхаарах ёстой. Бид хүн бүрт зүрх дэмжигч суулгаснаас үлддэг шарх сорви байгаа эсэхийг шалгаж чадахгүй. Бас зочид гар утас, айпод гээд бүх цахилгаан хэрэгслээ автобусанд үлдээнэ. Сурвалжлагчид микрофон ба дүрс бичлэгийн дуран барьж Бүрхүүлд ойргож болохгүй. Тэнд зөвхөн зочид байх юм. Тиймээс зочид болоод Бүрхүүлийн нөгөө талд байгаа ойр дотны хүмүүстэйгээ юу болох нь хэнд ч хамаагүй. Хэрэв та нар энэ тал дээр туслах юм бол бүх юм бүтнэ гэдэгт би итгэлтэй байна. "Оддын зам"-ын нэр томъёогоор хэлэх юм бол үүнийг хийхэд бидэнд туслаач гээд тэр заалтуураа буулгаснаа -Харин одоо би хэдхэн асуултанд хариулна. Зөвхөн хэдхэн асуултанд. Ноён Блитцер гэв.

Роузын царай гэрэлтээд явчихлаа. Аягатай кофегоо өргөөд зурагтын дэлгэц рүү тулгах хөдөлгөөн хийв.

-Вольфи чи сайхан харагдаж байна. Чи хүссэн үедээ миний орон дотор жигнэмэг идэж болно шүү.

-Хурандаа Кокс хотын түшмэдтэй хэвлэлийн бага хурал явуулах төлөвлөгөө бий юу? Бидний ойлгож байгаагаар одоо тэнд хотын захиргааны хоёрдугаар гипгүүн Жеймс Ренни бүгдийг удирдаж байгаа. Энэ чиглэлд юу хийж байгаа вэ?

-Бид ноён Ренни болоод оролцохыг хүсч болзошгүй хотын бусад түшмэдтэй хэвлэлийн бага хурал хамтран хийх тал дээр маш их хүч тавьж байгаа. Хэрэв бүх юм төлөвлөсний дагуу явах юм бол үд дунд хэвлэлийн бага хурал болно.

Эдгээр үгсийг алга ташилтаар шагнав. Сэтгүүлчид хэвлэлийн бага хуралд маш дуртай. Хэвлэлийн бага хурлаас дээгүүр тавьдаг ганц зүйл байдаг нь өндөр албан тушаалтай улс төрчийг өндөр төлбөртэй биеэ үнэлэгчтэй нэг оронд байхад нь гардах явдал.

-Уг нь хэвлэлийн бага хурлыг шууд зам дээр явуулбал дээр гэж бодож байгаа. Хэн ч байлаа гэсэн хамаагүй, хотын түшмэд Бүрхүүлийн өөрийн талаас зогсч, харин ноёд хатагтай та нар нөгөө талаас нь зогсож байгаад.

Баярлан хашгиралдав. Сэтгүүлчдэд нүдэнд үзэгдэх үр нөлөө хамгийн их таалагддаг.

-Ноён Холт гээд Кокс хуруугаар заалаа.

Лестер Холт суудлаасаа үсрэн босов. (энэ хүн бол Эн-би-си-гийн долоо хоног тутмын мэдээнийн хөтөлбөрийг хөтөлдөг нэрт сэтгүүлч).

-Ноён Ренни хэвлэлийн бага хуралд ирнэ гэсэн итгэл та нарт байгаа юу? Би яагаад ингэж асууж байгаа гэвэл түүний хийсэн санхүүгийн луйврын тухай мэдээлэл байгаа. Бас Мэн муж улсын ерөнхий прокурор түүний гэмт хэргийн үйл ажиллагааны талаар мөрдлөг явуулж байгаа гэсэн?

-Би энэ тухай сонссон. Гэвч энэ мэдээллийг тайлбарлахад бэлэн бус байна. Магадгүй ноён Реннид тийм хүсэл төрнө гээд Кокс дуугүй болоход уруул нь инээмсэглэх маягтай болов. - Хэрэв би түүний оронд байсан бол ийм хүсэл төрөх л байсан.

-Си-Би-Эс-ийн Рита Брейвер байна. Таны Честерс-Милл хотын захирагчид нэр дэвпгүүлсэн Дейл Барбара хүн амины хэргээр баривчлагдсан гэж үнэн үү? Честерс-Миллийн цагдаагийн газар түүнийг цуврал алуурчин гэж үзэж байгаа юм уу?

Хэвлэлийнхэн таг чимээгүй боллоо. Сэтгүүлчид хөдөлгөөн бүрийг шүүрэх нэг том чих болон хувирав. "Эглантери"-гийн лангууны дэргэд зогсч байгаа дөрөв ч мөн адил.

-Энэ үнэн гэхэд сэтгүүлчид шивнэлдлээ.

-Гэхдээ Дейл Барбарагийн бурууг батлах нотлох баримтыг шалгах юмуу түүнд тулгасан ял пгударга эсэхийг үнэлэх боломж бидэнд байхгүй. Бид интернетийн мэдээлэл ба утасны чалчаа ярианаас өөр мэдээлэлгүй байна. Өөрөөр хэлбэл ноёд хатагтай та нартай адилхан мэдээллийн эх сурвалжийг ашиглаж байгаа. Гэвч Дейл Барбара бол одон тэмдэгт офицер хүн. Түүнийг хэзээ ч ямар ч хэргээр баривчилж байгаагүй. Би түүнийг олон жил таньж мэдэхийн хувьд ерөнхийлөгчийн өмнө батлан хариуцсан. Яг одоо миний мэдэж байгаа байдлаас авч үзэх юм бол би алдаа гаргасан гэж өөрийгөө тооцох шалтгаан надад байхгүй.

-Пи-Би-Эс-ийн Рей Суарес. Ахмад Барбара, бишээ одоо хурандаа Барбарагийн эсрэг тулгаж байгаа ял нь улс төрийн учир шалтгаантай гэдэгт та итгэж байна уу? Ренни ерөнхийлөгчийн тушаалаар түүнийг хотыгн удирдлагыг авахад саад болохын тулд шоронд хийсэн байж болох уу?

Энэ бүхнийг шоуны хоёрдугаар хэсэгт зориулж бүгдийг нь бэлдсэн байна шүү дээ гэж Жулия ухаарав. Кокс хэвлэл мэдээллийг "Америкийн дуу хоолой" болгож хувиргасан бөгөөд харин бид Берлиний ханаар тусгаарлагдсан хүмүүс аж. Тэгээд тугал шиг бахдан баярлав.

-Хэрэв баасан гаригт та бүхэнд хотын захиргааны гипгүүн Реннид асуулт тавих боломж бүрдэх юм бол мэдээж түүнээс асуугаарай. Ноёд хатагтай нараа та бүхэнд хэлэх мэдээлэл дууслаа гэж Кокс мөс шиг хүйтэн тайвнаар зарлав.

Тэр майхнаас өнөөх л үсэрхийлсэн алхаагаараа гарч цугласан сэтгүүлчид асуулт хашгирч амжихаас өмнө хаалганы цаагуур далд оров.

-Супер гэж Эрни бувгналаа.

-Тэр үнэн гэж Жулия санаа нийлэв.

Роуз зурагтаа унтраалаа. Тэр бүр гэрэлтэж байв.

-Уулзалт хэдэн цагт гэсэн бэ? Хурандаа Кокс энэ бүхнийг хэлсэнд би үнэхээр баярлаж байна. Гэхдээ Барбид сайн юм болохгүй болов уу?

2

Барби Коксын хэвлэлийн бага хурлын тухай хонгил руу бууж ирсэн улаан хоншоорт Мануэль Ортегагаас сонсов. Урьд нь Динсморьш хөлсний ажилчин байсан Ортега одоо урт ханцуйтай цэнхэр цамц өмсч, өөрөө хийсэн юмуу гэмээр цагдаагийн тэмдэг зүүсэн байх бөгөөд гуяны орчим тээглэсэн хоёр дахь бүсэндээ дөчин таван калибрийн гар буу зүүсэн нь дээрэмчинтэй тун төстэй харагдана. Барбигийн мэдэхээр энэ залуу их дуугүй, арьс нь наранд түлэгдсэн, үс нь шингэрсэн нэгэн байсан бөгөөд үхрийн тухай ярих дуртай, өглөөний цайны үеэр өдрийн хоолондоо олады, гахайн утсан мах болоод нүдэлж шарсан өндөг захиалах дуртай нэгэн байсан. Өндөг шаруулахдаа яг болохын өмнө шартай талаар нь эргүүлж бага зэрэг хайрч өгөхийг гуйдаг байсан. Тэр ноён Динсмор галловей үйлдрийн "бүсэлхийтэй" үхэр худалдан авахгүй байгаад тун их харуусдаг байсан. (бүсэлхийтэй галловей үүлдэр нь их биеийн дундуур цагаан судалтай махны чиглэлийн үхэр). Хэдийгээр тэр Мануэль Ортега гэсэн овог нэртэй ч яс махандаа хүртэл цэвэр янки бөгөөд хуурай наргиан нь бусдаас нь ялгагдаг байв. Тэр Барбид үргэлж таалагддаг байсан.

Гэтэл хонгил руу дасч сурсан наргианаа ор тас мартсан, шал өөр Мануэль бууж ирэв. Тэр тээж ирсэн сүүлийн үеийн мэдээгээ торон завсар хашгирсан бөгөөд цахрах шүлсээрээ нэмж байв. Түүний царайд уур хилэн багтаж ядна.

-Чиний армийн энгэрийн тэмдгийг хөөрхий охины гараас олсон тухай нэг ч үг хэлсэнгүй. Дараа нь тэр нэг цэргийн гоожуур бүх нүгэлд Жим Ренниг буруутгасан. Энэ бүхэн болсноос хойш Милл хотыг живүүлчихэлгүй хөвүүлж яваа хүнийг. Өөрийн биеэр, нүцгэн гараараа амьд утаснаас чирч яваа хүн.

-Мануэль тайвшир.

-Би цагдаа Ортега шүү, бэлгивч минь.

-Ойлголоо цагдаа Ортега гэж хэлэхдээ Барби ханзан дээрээ суух бөгөөд Ортегагийн хувьд хуйнаас хуучин "скофилд" буугаа сугалан буудаж эхлэх нь хичнээн амархан байгааг бодов. -Би энд, Ренни тэнд байгаа. Түүний бүх юм сайн байгаа гэдэгт би итгэж байна.

-Дуугаа тат гэж Мануэль орилов.

-Бид бүгдээрээ энд байна. Бүгд хараал идсэн Бүрхүүл дор байгаа. Олден юу ч хийхгүй зөвхөн архи ууж байна. Амьд үлдсэн хүү нь юу ч идэхгүй байна. Хатагтай Динсмор Роригийн араас

уйлаад л байна. Жек Эванс тархиа зад буудсан. Чи үүнийг мэдэх үү? Харин тэр цэргийн ухнууд шавар шавхай чулуудахаас дээр юм олсонгүй. Чи энд хүнсний самуун зохиож, тэр бүү хэл манай сонины редакцийг шатааж байхад тэд цул санаанаас зохиосон худлаа юм ярьж байна. Хатагтай Шамуэй чиний тухай үнэнийг бүү бичээсэй гэсэндээ шатаасан тийм үү?

Барби дуугүй сууна. Өөрийгөө хамгаалах ганцхан үг хэлэхэд л амь нас нь дуусч болох талаар тэр бодож байлаа.

-Тэд өөрсдөд нь таалагдаагүй бүх улс төрчийг ингэдэг. Тэд манай хотыг хүчиндэгч алуурчин удирдаасай гэж хүсээд байгаа юм уу? Журамт Христийн шашинтан биш. Хүүр хүчиндэгч үү? Энэ арай дэндэж байна.

Мануэль гар бугаа суга татаж торон завсараар шагайв. Барбид бууны амны нүх яг галт тэрэгний хонгил зам мэт том харагдлаа.

-Чамайг ойрын хананд аваачиж буудах багийн өмнө зогсоохоос өмнө Бүрхүүл алга болдог юм бол би үүнийг өөрөө хийх ганц минутыг гаргаж чадна. Би дугаарын нэгдүтээрт байх болно. Энэ дугаар их урт. Яагаад гэвэл одоо Миллд чамтай тооцоо хийх боломжийг хүлээсэн маш олон хүн байгаа гэж Мануэль үргэлжлүүлэв.

Барби одоо үхэх эсвэл амьсгаа нь үргэлжлэх эсэхийг мэдэхгүй дуугүй суулаа. Роузын авчирч өгсөн улаан лооль ба салаттай гахайн утсан махны хавчуургатай талх хоолой руу өгсч, бөглөх гэж оролдов.

-Бид амьд үлдэх гэж оролдож байна. Гэтэл тэд ганцхан юм хийж чадна. Тэр нь эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлж байгаа хүн рүү шавар шавхай цацах явдал гэж хэлээд огцом хөдлөн бугаа хуйнд нь дүрэв. -Чи одоо болно. Чамаар би гараа бузарлахгүй.

Ортега ингэж хэлээд толгойгоо унжуулж мөрөө буулгасан амьтан шат руу том том алхлаа.

Барби хананд наалдаж зогсоод урт амьсгаа авав. Дух нь хөлсөөр хучигдаж түүнийг арчих гэж өргөсөн гар нь салгалан чичирч байлаа.

3

Берпигийн фургон орцны зам руу орж ирэхэд Клер гэрээсээ гүйн гарч ирэв. Тэр уйлж байлаа.

-Ээж ээ гэж Жо хашгираад фургон бүрэн зогсохоос өмнө үсрэн буулаа. Бусад нь түүнийг дагав. -Ээж ээ юу болсон бэ?

-Зүгээр ээ гэж Клер цурхиран уйлаад хүүгээ тэвэрч биедээ наав. -Уулзалтын өдөр болох юм байна. Баасан гаригт. Жо хоёулаа аавыгаа үзэх нь.

Жо баярлан хашгираад Клерийг тойрон бүжиглэв. Бенни Норрийг тэвэрч энэ боломжийг ашиглан үнслээ. "Бяцхан зальтан" гэж үүнийг анзаарсан Расти бодов.

-Ромми намайг эмнэлэгт хүргээд өгөөч гэж тэр гуйлаа. Тэгээд гудамж руу ухран гарах үед

Клер ба хүүхдүүд рүү гараар даллав. Хатагтай Клертэй ярихгүй болсондоо Расти баярлаж байлаа. Эхийн зөн совин бага эмчийг барьж мэднэ. -Англиар ярьж надад тус болооч. Зурагт номны баатар шиг тэр раг1е дээр бүү яриад бай.

-Хэн бүхэнд түшиг тулгуур болох соёлын өв байдаггүй нь харамсалтай. Тэр цагт байгаадаа атаархдаг юм.

-Тийм байх. Танай ээж хаймар таавчиг өмсдөг байлгүй?

-Яг тийм. Гэхдээ зөвхөн бороо орохоор.

Растигийн гар утас дугарч мэдээ иржээ. Нээж уншвал "21.30-д Пайперийн гэрт уулзалттай заавал ир. ЖУ" гэжээ.

-Ромми хэрэв би эцэг хүү Реннитэй тэсч харьцаж чадах аваас энэ орой нэг уулзалтанд хамт явах тал дээр ямар бодолтой байна вэ? гэж гар утсаа хаангаа асуув.

4

Эмнэлэгт Жинни түүнийг үүдний танхимд угтан авлаа.

-Өнөөдөр "Кэтрин Рассел"-д Реннигийн өдөр гэж тэр дурамжхан зарлав. -Маршалл хоёулан дээр нь орсон. Расти минь энэ хүнийг бурхан бэлэглэсэн байна. Түүнд Жижгээ огт таалагдаагүй. Тэр Френкитэй хамт цөөрмийн дэргэд мань хүнтэй бүдүүлэг харьцсан бололтой. Гэхдээ Маршалл жинхэнэ мэргэжилтэн гэдгээ харуулсан. Энэ хүн аль нэг коллежийн англи хэл утга зохиолын танхимд авьяасаа булшилж яваа юм байна. Тэр уг нь эмнэлэгт ажиллах ёстой байсан юм. Тэр үнэхээр надаас илүү. Дугигаас ч дээр гэж дуугаа намсган хэллээ.

-Тэр одоо хаана байна вэ?

-Залуу найз бүсгүй ба асарч байгаа хоёр хүүхэдтэйгээ амьдарч байгаа гэр рүүгээ явчихсан. Тэр тэдэнд үнэхээр дассан бололтой.

-Бурхан минь Жинни. Чи дурлачихжээ гэж Расти инээмсэглэв.

-Юун солиорол вэ? гэж Жинни уурлалаа. -Ренни аль тасагт байгаа вэ?

-Жижгээ долдугаарт, том нь 19-рт. Том нь Картертай хамт ирсэн. Дараа нь түүнийг ямар нэг ажлаар явуулчихаад хүү дээрээ ганцаараа орсон. Тэнд нэг их удаагүй. Гар утсаар л яриад байсан. Жижгээ ухаан орсон ч зүгээр суугаад байгаад. Генриг авчрахад тийм байгаагүй шүү гэж Жинни илт ёрлосон инээдээр инээв.

-Том Жим зүрхний хэмнэл алдагдсан юм уу? Бидний амжилт ямархуу байна вэ?

-Маршалл хэвэнд нь оруулсан.

"Түр хугацаанд" гэж Расти дотроо таашаалтай биш гэх аргагүй бодов. "Валиумын үйлчлэл зогсохоор зүрх нь дахиад үсчих болно".

-Эхлээд Жижгээг үзээрэй гэж танхимд хоёулханаа байсан ч Жинни шивнэсээр байв. -Тэр надад таалагддаггүй. Хэзээ ч таалагдаж байгаагүй. Гэвч одоо би өрөвдөж байна. Тэр удна гэж бодохгүй байна.

-Маршалл Реннид Жижгээгийн байддын тухай хэлсэн үү?

-Тийм ээ асуудал их ноцтой гэж хэлсэн. Гэтэл энэ нь Реннигийн гар утсаар ярьсан ярианаас илүү ноцтой байгаагүй бололтой. Баасан гаригт уулзалтын өдөр болох тухай хэн нэгэн түүнд мэдээлжээ. Үүнээс болоод Ренни аймаар ууртай байгаа.

Расти Блэк-Ридж дээр байгаа түүний өргөж дийлээгүй, тавиадхан квадрат дюйм талбай бүхий нимгэн хайрцагныг тухай бодов. Хөдөлгөж чадаагүй. Бас хоромхон зуур харагдаад өнгөрсөн инээж байгаа илгэн толгойнуудын тухай бодов.

-Зарим хүн зочинд дургүй байдаг юм гэж хэлээд Расти санаа алдлаа.

5

-Жижгээ бие ямар байна даа?

-Зүтээр. Дээрдсэн гэж тэр амьгүй мэт хоолойгоор хариулав. Түүнд эмнэлгийн халат өмсгөсөн байх ба цонхны дэргэд сууна. Түүний цонхийсон царайн дээр нарны гэрэл тусчээ. Жижгээ амьдралдаа олон юм үзсэн дөчөөд насны эр шиг л харагдана.

-Ухаан алдахаас өмнө юу болсныг надад хэлж өгөөч.

-Би сургууль орох гэж явсан юм. Тэгээд үүний оронд Энжигийн гэрт очсон. Френктэй эвлэрэх ёстойг нь хэлэх гэсэн юм. Тэр их шаналж яваа.

Френки ба Энжи нарын үхсэн тухай Жижгээ мэдэх эсэхийг Расти бараг асуух шахсанаа эцсийн мөчид бодлоо өөрчлөв. Ямар угта байх вэ? Түүний оронд өөр асуулт тавьлаа.

-Чи сургуульдаа явах гэсэн юм уу? Бүрхүүлийг яах болж байна?

-Нээрээ тийм гэж тэр урьдын адил ямар ч сэтгэл хөдлөлгүй амьгүй дуугаар хариулав. -Би түүнийг мартсан байна.

-Хүү минь чи хэдэн настай билээ? -Хорь... нэг.

-Ээжийг чинь хэн гэдэг байсан бэ? Жижгээ бодов.

-Жейсон Жамби гэж тэр арай гэж хариуллаа. (энэ нь алдарт бейсболчны нэр). Тэгснээ түсхийтэл инээв. Гэвч нүүр нь цонхигор үхмэл хэвээр үлдэв.

-Бүрхүүл хэзээ үүссэн бэ?

-Бямба гаригт.

-Тэгээд хэр удаж байгаа вэ?

Жижгээ хөмсөг зангидав.

-Долоо хоног бил үү? Хоёр долоо хоног ч билүү хэсэг хугацаанд байгаа нь лавтай гэснээ тэр Растигийн царай руу харлаа. Маршаллын тарьсан валиум тарианаас болоод нүд нь гялалзана.

-Чи энэ асуултуудыг Барбигийн хэлснээр тавиад байна уу? Тэр тэднийг алсан. Мэдэх үү? гэснээ Жижгээ толгой дохиод: -Бид түүний тэмдэгжүүлсэн адилтгалыг олсон гэснээ түр дуугүй болоод -Биш ээ, адилтгасан тэмдэгийг гэв.

-Энэ асуултуудад Барби ямар ч хамаагүй. Тэр шоронд байгаа.

-Тун удахгүй тамд очно гэж хэлэх үед түүний дуу ямар ч сэтгэл хөдлөлгүй жигд байлаа. -Бид түүнийг пгүүж дараа нь цаазлана. Миний аав тэгж хэлсэн. Мэн муж улсад үхлийн ял оноодоггүй. Гэвч одоо бид дайныг цагийн хуулиар амьдарч байгаа гэж тэр хэлсэн. Өндөгтэй салат илчлэг ихтэй байдаг юм.

-Тэр үнэн шүү гээд Расти авчирсан чагнуур, даралт хэмжих багаж ба нүдний багаж гурваа дэлгэв. Дараа нь даралтын аппаратыг Жижгээгийн булчинд зүүнгээ: -Чи Америкийн сүүлийн гурван ерөнхийлөгчийг нэрлэж чадах уу Жижгээ?

-Мэдээж шүү дээ. Буш, Пуш ба Туш гэснээ тэр тачигнатал инээхэд царай нь бас л өөрчлөгдсөнгүй.

Жижгээгийн даралт өндөр байлаа. Зуун дөчин долоо ба зуун хорь. Гэвч Расти илүү муу юмыг хүлээж байв.

-Надаас өмнө чам дээр хэн ирснийг санаж байна уу?

-Тийм ээ, Френки бид хоёр цөөрмийн дэргэд хүүхдүүдийг олохоос өмнө таарсан тэр өвгөн. Хүүхдүүд зүгээр гэж найдаж байна. Тэд их хөөрхөн хүүхдүүд байсан.

-Тэдний нэрийг санаж байна уу?

-Эйден ба Элис Эпплтон. Бид клуб руу хамт явсан. Тэр улаан үст бүсгүй ширээн доогуур надад арьс өгөөд байсан. Ингээд сална гэж бодсон байх.

-Ойлгомжтой гэж Расти хэлээд нүдний багажаа авав. Баруун нүд нь зүв зүгээр. Харин зүүн нүдний харах мэдрэлийн таваг нь товойжээ. Харах мэдрэлийн таваг хавагнах нь тархины хорт хавдар хүндэрсний түгээмэл шинж.

-Ямар нэг сонирхолтой юм олж үзэв үү?

-Үгүй гээд Расти нүдний аппаратаа доош тавьж долоовор хуруугаа гозойлгон гараа өргөв. Хуруу яг Жижгээгийн хамрын түвшинд байлаа. -Хуруугаараа миний хуруунд хүрээд дараа нь хамрандаа хүр гэхэд Жижгээ тэгж хийв. Расти хуруугаа хоёр тийш аажуухан хөдөлгөнө. - Хүрээд байгаарай.

Эхний удаад Жижгээ хөдөлж байгаа хуруу ба хамартаа хүрч чадав. Хоёр дахь удаад хуруунд хүрсэн ч хацартаа хүрэв. Гурав дахь удаад хурууг ч оносонгүй, бас баруун хөмсөгтөө хүрлээ.

-Пөөх дахиад хийлгэмээр байна уу? Би үүнийг өдөржин хийсэн ч чадна шүү.

Расти сандалаа түлхээд бослоо. -Би Жинниг эм бичиж өгөөд явуулна. -Түүний дараа би зангуугаа авч болох уу? Харьж болох уу гэсэн үг.

-Чи энэ шөнөдөө энд хононо Жижгээ. Ажиглах хэрэгтэй.

-Гэхдээ би эрүүл биз дээ? Өглөөгүүр толгой өвдсөн. Аймаар өвдсөн. Гэвч одоо өвчин намдчихлаа. Би зүгээр биз дээ тийм үү?

-Яг одоо би чамд юу ч хэлж чадахгүй. Би Маршаллтай ярилцаж бас хоёр гурван ном унших хэрэгтэй байна.

-Хүн гуай тэр чинь эмч биш шүү. Тэр англи хэлний багш.

-Тийм ч байж мэднэ. Гэвч тэр чамд бүх юмыг зөв хийсэн. Миний ойлгож байгаагаар Френки та хоёрын өөрт нь харьцсанаас хамаагүй дээр харьцсан байна.

Жижгээ гараа савлаа.

-Бид зүгээр л наргисан юм. Түүнээс гадна хүүхдүүдтэй бол яг байх ёстойгоор нь харьцсан тийм үү?

-Тэр тал дээр маргахгүй. Жижгээ одоохондоо амар. Хэрэв хүсвэл зурагт үз.

Жижгээ хэсэг бодсоноо асуув.

-Оройн хоолонд юу өгөх юм бэ?

6

Үүссэн нөхцөл байдалд Расти ганцхан зүйлийн талаар бодож болохоор байсан нь бага Жим Реннид судсаар нь маннитол хийх замаар гавал доторх даралтыг буулгах явдал байв. Тэр өвчтөний хаалган дээрх хайрцагнаас картыг нь татаж авах үедээ дугуй үсэгтэй үл таних бичиг бүхий зурвас бэхэлснийг олж харлаа.

"Хүндэт Эверетт эмч ээ.

Энэ өвчтөнд маннитол хийвэл ямар вэ? Би заавар өгч чадахгүй. Яагаад гэвэл зөв тунгийн

талаар мэддэггүй. Маршалл".

Расти тунг бичлээ. Жинни алдаагүй байжээ. Терстон Маршалл их юм мэддэг, бас чаддаг аж.

7

Том Жимийн тасгийн хаалга онгорхой бөгөөд тасаг хоосон байхыг Расти олж харав. Гэтэл Хаскель эмчийн зүүрмэглэх дуртай байсан өрөөнөөс түүний дуу гарахыг сонслоо. Расти тийш явахдаа Том Жимийн картыг аваагүй аж. Энэ алдааныхаа төлөө тэр харамсах болно.

Хэдийгээр ханан дээр хурц улаан өнгийн гар утсыг дээрээс нь хэрээс дарж зурсан зурагт хуудас байсан ч Ренни бүрэн хувцаслаад цонхны дэргэд сууж чихэндээ гар утсаа наажээ. Том Жимд утас ашиглахыг нь хориглосоноор хязгааргүй таашаал авах болно гэж Расти бодов. Магадгүй энэ нь байцаалт ч биш маргаан ч биш ямар нэг зүйл болж хувирах тийм ярианы улс төрийн алдаатай эхлэл байж болно. Гэвч тэр ингэхээр шийддээ. Том Жим рүү алхсанаа зогтусав. Яг шаасан гадас шиг.

Толгойд нь хурц дурсамж гялсхийв. Нойр нь хүрэхгүй тул тэр доошоо бууж Линдагийн жигнэсэн хэрчим цангис ба амтат жүржийн хольцтой талх идэхээр орноосоо боссон. Охидын өрөөнөөс гарах Одри нохойн улих дуу. Охид ямар байгааг шалгахаар явж байсан. Ханна Монтана ба түүнийг хамгаалдаг сахиусан тэнгэрийн зурагны дор байх Женнигийн орон дээр сууна. (энэ нь америкийн цуврал кино)

Яагаад энэ дурсамж зөвхөн одоо сэргэсэн юм бол? Яагаад Том Жимтэй түүний гэрийн өрөөнд нь ярьж байхад санагдсангүй вэ?

Яагаад гэвэл тэр үед би хүн амины хэргүүдийн тухай юу ч мэдэхгүй байсан. Миний сонирхолыг зөвхөн хий татаж байсан. Яагаад гэвэл Жанни таталт өгөөгүй байсан ба тэр зүтээр л хагас унтлагын байдалд орсон байсан. Зүүдэндээ ярьж байсан.

Аав аа, түүнд алтадсан бейсболын бөмбөг байна. Энэ их муу бейсболын бөмбөг.

Тэр бүү хэл өчигдөр орой оршуулгын товчоонд байхад ч энэ дурсамж тодроогүй билээ. Харин одоо магадгүй дэндүү оройтжээ.

Гэвч энэ юу гэсэн үг болохыг бодъё. Блэк-Ридж дээрх төхөөрөмж зөвхөн тодорхой хэмжээний цацраг туяа гаргаад зогсохгүй өөр ямар нэг юм дуудаад байх шиг. Түүнийг зөн совин өгөх гэх юмуу эсвэл өөр ямар нэг нэргүй зүйлээр нэрлэж болох хэдий ч ямар нэг нэр өглөө ч гэсэн энэ юу ч юм зүйл оршин байна. Хэрэв Жанни алтадсан бейсболын бөмбөгийн тухай үнэн хэлж байгаа юм бол хэллоуинаар гай нөмрөх тухай зөгнөн хэлж байгаа бүх хүүхдүүд зөв ярьж байж болно. Гэхдээ яг тэр өдөр гай тохиох гэж үү? Магадгүй арай эрт байж мэднэ.

Хоёр дахь таамаг арай бодитой гэж Расти шийдлээ. Яагаад гэвэл амттан-юмуу-муу юмны талаар хөөрч догдолсон хотын олонхи өсвөр насны хүүхдүүдийн хувьд хэллоуин аль хэдийн ирчихсэн байгаа.

-Стюарт чиний юу хийж байгаа надад падгүй гэж Том Жим ярина. Гурван миллиграмм валиум түүнийг огт тайвшруулаагүй бололтой. Тэр үргэлж байдаг шигээ буцалж байв. - Фернтэй тийшээ яв. Рожерийг бас аваарай... Юу гэнэ ээ... Би чамд үүнийг хэлэхгүй ч байсан чадна. Чи энэ шалчгар зурагтыг үзсэн үү? Хэрэв тэр дургүйцэх юм бол чи... гэснээ Ренни толгойгоо өргөж, хаалган дээр зогсч байгаа Растиг олж харав. Том Жимийн царайд тэр сүүлийн хэдэн минутанд юу хэлсэнээ сандран санаж байгаа нь илт мэдрэгдэв. Хөндлөнгийн хүн хэр ихийг сонсож амжсаныг мэдэхийг оролдов. -Стюарт нааш нь илгээ. Би чам руу дахиад ярина. Намайг ярих үед чи миний сонсохыг хүссэн зүйлийг хэлсэн нь дээр шүү гээд тэр холбоогоо тасалж гар утсаа Расти руу сунгаад инээж дээд шүднүүдээ ярзайлгав.

-Би мэдэж байна, мэдэж байна. Үгэнд орсонгүй. Гэвч хотын ажил хүлээж чадахгүй шүү гээд Ренни санаа алддаа. -Өөрөөс нь бүх юм хамаардаг хүн байх амаргүй. Тэр тусмаа бие муу бол.

-Хэцүү байх даа.

-Надад бурхан тусалдаг найз минь. Миний амьдрах зарчмыг мэдэх үү? Үгүй -Мэдээж.

-Бурхан хаалга хаахдаа цонх нээдэг юм. -Та тэгж бодоод байна уу?

-Би үүнийг мэднэ. Бас хэрэв чи өөрийнхөө хүссэн зүйлийг гуйж залбирах юм бол бурхан дүлий чихээрээ ханддаг гэдгийг би үргэлж санахыг хичээдэг. Харин чамд зайлшгүй хэрэгцээт зүйлийн тухай залбирах юм бол тэр нэг ч үгийг сонсохгүй өнгөрөөхгүй.

-За за гээд Расти амралтын өрөө рүү орлоо. Хананд өлгөсөн телевиз ажиллах бөгөөд дууг нь дарсан Си-Эн-Эн суваг гарч байна. Ярьдаг толгойн ард Том Жеймс Реннигийн хар цагаан зургийг өлгөсөн байх ба их эвгүй байдалд дарсан зураг байна. Том Жим нэг хуруугаа гозойлгож дээд уруул нь сөхөгдсөн байв. Гэхдээ инээд биш яг араатны зэвүүн ярзайлт.

Дэлгэцийн хамгийн доод талаар "Бүрхүүл доорх хот хар тамхины диваажин байсан уу?" гэсэн асуулт гүйнэ. Ярьдаг толгой ба гэрэл зураг алга болж оронд нь Растигийн үргэлж уурыг нь хүргэдэг хуучин машины салоны реклам гарна. Энэ рекламд худалдагч нарын нэгний дүрс томоор гарч дуран руу: "Тэрэг авбал танд аз дайрна. Том Жим үүнд туслана" гэж хашгирсанаар дуусдаг.

Том Жим бичиг рүү зааж гунигтай инээгээд:

-Тэр талд байгаа Барбарагийн найз нар намайг яаж байгааг харав уу? Чөтгөр гэж үүнд гайхах юм байна уу? Христ хүн төрөлхтөнийг аврахаар ирэхэд түүнийг өөрт нь зориулсан загалмайг үүрч Голгоф руу мацахад хүргэсэн бөгөөд тэр тэндээ цус шороонд дарагдаж үхсэн.

Энэ валиум ямар хачин эм болохыг Расти гайхсан нь анх удаа биш юм. Тэр уепхаз ш уто үнэн эсэхийг мэдэхгүй боловч валиум эмэнд үнэн хангалттай байдаг. Хүмүүс энэ эмийг судсаар тариулсаны дараа өөрийнхөө тухай шударга үнэнээр ярих нь олон.

Расти сандалаа ойртуулж чагнуураа бэлдлээ.

-Цамцаа өргө гэж хэлээд Том Жимийг гар утсаа хажуу тийш тавингуут авч энгэрийн хармаандаа хийв. -Би утсыг авлаа. Тэгээд үүдний өрөөний ширээн дээр тавина. Тэнд бол гар утсаар ярьж болно. Тэндхийн сандал эндхийнх шиг тухтай биш боловч сууж болно.

Том Жим эсэргүүцэж тэр бүү хэл тэсэрнэ гэж хүлээсэн ч өнөөх нь нэг ч үг унагалгүй бүдүүн гэдэс ба том үлбэгэр цээжээ нүцгэлэв. Расти урагш тонгойж чагнаж гарлаа. Түүний бодсон шиг тийм муу биш байлаа. Хэмнэл нь хаа нэгтээ алдагдах минутанд 110 удаагийн цохилт байлаа гэхэд түүнийг баярлуулахаар байв. Гэтэл Том Жимийн зүрх минутанд 90 удаа жигд тогтвортой цохилж байна.

-Миний бие хавьгүй дээр байна. Бүх юм стрессээс боллоо. Аймаар цухалдаж байна. Би энд ганц хоёр цаг амрах бодолтой. Энэ цонхоор ажил хэргийн дүүрэг тэр чигээрээ харагддагийг чи мэдэх үү? Дараа нь би Жижгээ дээр бас орно. Түүний дараа миний даралтыг дахиад хэмжээрэй. Бас...

-Энэ зөвхөн стресс биш. Таны жин илүү бөгөөд та хэвийн бус байна.

Том Жим худал инээн дээд шүдээ ил гаргав.

-Найз минь, чамд гэж хэлэхэд би бизнесийнхээ хажуугаар хотыг үүрч явдаг юм. Тийм ч учраас надад гүйлтийн зам, унадаг дугуй болоод тиймэрхүү юманд зарцуулах цаг бага үлддэг.

-Та зүрх дэмжигч тавих болсон цагаас хойш хоёр жил өнгөрлөө. Та пароксизмаль тахиаритмия өвчтэй байна.

-Би ямар өвчтэйгөө мэднэ. Би эмнэлэгт очиход эрүүл хүмүүс ч ийм байдалд ордог гэж хэлсэн...

-Хаскел эмч таныг хоолны дэглэм барьж жингээ хянахыг шууд хэлж байсан. Эм ба тунг сонгосноор хэмнэл алдагдлыг хяналтандаа авч болно. Хэрэв эмийн эмчилгээ тус болохгүй бол бөглөрөлийг арилгах үүднээс мэс засалчид хандах ёстой.

Том Жим одоо өндөр сандал дээрээс бууж чадахгүй байгаа өрөвдөлтэй хүүхэд шиг харагдана.

-Бурхан надад үүнийг бүү хий гэж хэлсэн. Бурхан ямар ч зүрх дэмжигч хэрэггүй гэсэн. Бурхны зөв байж. Герцог Перкинс зүрх дэмжигч тавиад яаж дууссаныг хар.

-Бэлэвсэн эхнэрийн тухайд ч хэлэх үг алга. Тэр тун азгүй байжээ. Буруу цагт буруу газарт очсон байх даа гэж Расти зөөлөн нэмж хэллээ.

Том Жим гахайных мэт жижиг нүдээрээ түүн рүү ширтэв. Дараа нь харцаа тааз руу шилжүүллээ.

-Гэрэл ахиад асч байна тийм үү? Би чиний гуйснаар хийг буцааж өгсөн. Зарим хүнээс талархал хүлээгээд ч ирдэггүй. Гэхдээ би үүнд дасчихжээ.

-Хий маргааш өглөө дуусчихна.

Том Жим толгой сэгсрэв.

-Маргааш орой хэрэв чамд тийм хэрэгцээ байгаа бол зул сарын баяр хүртэл хүрэлцэх хий ирэх болно. Нэгэнт чи өвчтөнүүддээ ийм сайн санаа тавьдаг хойно би чамд амлаж байна. Чи ер нь сайн залуу.

-Угаас надад байсан зүйлийн төлөө хэн нэгэнд талархахад хэцүү байна. Би ийм л хүн.

-Аан-хаан, чи одоо өөрийгөө эмнэлэгтэй адилтгах болоо юу? гэж Том Жим тургив.

-Яагаад болохгүй гэж. Та өөрийгөө христтэй адилтгадаг. Алив эмнэлгийн асуудалдаа эргэж оръё тэгэх үү?

Том Жим бүдүүн хуруутай том гараа хайхрамжгүй савлаа.

-Валиум зүрхний хэмнэл алдах өвчинг эмчлэхгүй. Хэрэв та эндээс явах юм бол оройн таван цагт дахиад ноцтой асуудал үүснэ. Энэ нь бөглөрөлд хүргэж ч мэднэ. Гэвч гэгээлэг тал бас бий. Та харанхуй болохоос өмнө аврагч бурхантай уулзаж мэднэ.

-Тэгээд чи юу зөвлөх вэ? гэж Ренни тайван асуулаа. Тэр одоо дахин биеэ барих болжээ.

-Би танд ямар нэг юм өгөөд асуудлыг шийдэж магадгүй. Энэ бол эм.

-Ямар эм?

-Гэхдээ та төлбөр хийх хэрэг гарна.

-Би мэдсэн юм. Чи миний өрөөнд ирээд нэг юм, бас өөр юм шаардаж эхлэх үед чиний Барбарагийн талд байгааг би мэдсэн гэх Реннигийн дуу гэтэх мэт сонсогдоно.

Расти тэгэхэд зөвхөн хий шаардаж явсан билээ. Гэвч түүнийг тодруулах гэж оролдсонгүй.

-Та бүр тэр үед Барбарад өөрийн талынхан байсан гэдгийг яаж мэдсэн юм бэ? Хүн амины хэрэг илрээгүй байсан. Та хаанаас мэдсэн юм бэ?

Реннигийн нүдэнд хөгжил баясал болоод хардалт сэрдэлтийн дон гялалзав. Аль аль нь гялалзсан.

-Надад тийм арга бий. За тэгээд ямар үнэтэй юм бэ? Миний зүрхний өвчинг эмчлэх эмийн хариуд чи юу авмаар байна даа гэснээ Растиг хариулахаас өмнө үргэлжлүүлэн: -Таахыг зөвшөөрнө үү? Барбара эрх чөлөөтэй болохыг чи хүсч байгаа тийм үү?

-Үгүй. Яагаад гэвэл түүнийг цагдаагийн газраас гарах л юм бол хотынхон дураараа алах болно.

Том Жим инээд алдаад:

-Чи заримдаа саруул ухааны хугархай үзүүлэх юм гээч.

-Би таныг огнроосой гэж хүсч байна. Сандерстай хамт. Эрх мэдлийг Андреад өг. Тэгээд Жулия Шамуэй түүнд туслаг. Андреаг эмийн хамаарлаас бүрэн салгах хүртэл.

Энэ удаад Том Жим бүр чанга инээж хоёр өвдгөө алгадав.

-Би Коксыг юу ч сэтгэдэггүй юм байна гэж бодсон. Тэр хэлэхдээ Андреад өнөөх том хөхтэй хүүхэн туслах ёстой гэсэн. Гэтэл чи бүр дор юм байна. Шамуэй. Энэ хар хэл амтай шулмас өөрийгөө ч удирдаж чадахгүй.

-Та Лестер ламыг алсныг би мэднэ.

Уг нь Расти үүнийг хэлэх бодолгүй байсан ч энэ үг аяндаа гарчихав. Барьж амжихаас нь өмнө гараад явчихлаа. За тэгээд яагаад болохгүй гэж? Дэлгэцнээс тэднийг харж байгаа Си-Эн-Эн-ийн Жон Робертсыг эс тооцвол тэд одоо хоёулхнаа байна.

Үр дүн амжилттай болов. Честерс-Милл хотыг Бүрхүүл хучсан тэр цагаас хойш анх удаа Том Жим цохилт алджээ. Тэр нүүр царайгаа хэвийн байлгах гэж чамгүй хүч гаргасан ч чадсангүй. -Чи солиорчээ.

-Миний солиороогүйг та мэдэж байгаа. Өчигдөр шөнө би "Боуигийн орпгуулгын товчоо"-нд очиж дөрвөн хохирогчийн цогцосыг үзсэн.

-Чамд тийм эрх байхгүй. Чи шинжээч эмч биш. Тэр бүү хэл чи шалчгар эмч ч биш.

-Ренни гуай тайвшир. Арав хүртэл тоол. Зүрхээ бод гээд Расти хэсэг дуугүй байснаа

-Нөгөө талаас бол таны зүрх надад яршиг л байна. Таны юу хийсэн болоод одоо юу хийгээд байгаатай харьцуулах юм бол таны зүрх чөтгөр рүү тонилбол таарна. Лестер ламын толгой ба нүүрэн дээр шархнууд байсан. Тун хэвийн бус шархнууд. Гэхдээ амархан танигдахаар. Эдгээр шарх таны бичгийн ширээн дээр байхыг нь би харсан бейсболын дурсгалын бөмбөгний шарх гэдэгт өчүүхэн төдий ч эргэлзээ алга.

-Энэ юуг ч өгүүлэхгүй байна гэж хэлэхдээ Ренни усны өрөө рүү орох нээлттэй хаалга руу харна.

-Энэ олон юм өгүүлнэ. Тэр тусмаа бүх цогцосыг нэг дороос олсоныг тооцох юм бол. Энэ нь Лестер ламын алуурчин бусдыг ч бас алсан гэдгийг надад хэлээд байна. Тэр хүн нь та гэж би бодож байна. Магадгүй Жижгээ та хоёр. Хүн амины хэрэг дээр гар нийлсэн эцэг хүү хоёрын талаар юу хэлэх вэ? Энэ тал дээр юу хэлэх вэ?

-Би ийм юм сонсохоос татгалзаж байна гээд Том Жим өндийв. Расти түүнийг ёворч суулгалаа. Гайхалтай нь үүнийг тун амархан хийв. -Байрандаа зогс. Зараа чамайг аваг. Байрандаа зогс гэж Ренни хашгирав.

-Та яагаад тэднийг алсан юм бэ? Тэр хар тамхи үйлдвэрлэлийн талаар бүхнийг ярина гэж

сүрдүүлсэн үү? Тэр хэрэгт оролцсон юм уу?

Хэдийгээр Расти аль хэдийн сандал дээрээ суусан байсан боловч Том Жим: -Байрандаа зогс гэж хашгирсаар байв. Ренни өөр хэн нэгэнд зориулан үүнийг хэлж байгаа гэх санаа Растид даанч төрсөнгүй.

-Би энэ талаар хэнд ч хэлэхгүй байж чадна. Бас би танд зүрхний хэмнэл алдагдах өвчинд валиумаас илүү тустай эм өгч чадна. Үнэ нь таны огцрох явдал. Та эрүүл мэндийн шалтгаанаар албан тушаалаасаа явж эрх мэдлээ Андреад шилжүүлж байгаа гэж маргааш орой хотын хурал дээр зарлах ёстой. Тэгвэл та баатар хэвээр үлдэнэ.

Том Жим татгалзаж чадахгүй. Тэр одоо буланд шахуулсан гэж Расти бодов.

Ренни усны өрөөний нээлттэй хаалга руу эргээд:

-Одоо орж болно гэлээ.

Амралтын өрөөнд Картер Тибодо орж ирэв. Араас нь Фредди Дентон орж ирлээ. Тэд усны өрөөнд нуугдаад чагнаж байжээ.

8

-Чөттөр аваг гэж Стюарт Боуи хараалаа. Тэр ахынхаа хамт оршуулгын товчооны хонгилд ажиллаж байв. Стюарт Арлетт хэмээх Миллийн хамгийн сүүлийн амиа хорлогчийг оршуулахад бэлдэж байлаа. Энэ цогцос ах дүү хоёр дээр дөнгөж сая иржээ.

-Энэ нэг новшийн, дур гутам, булуулмар баас.

Тэр гар утсаа ширээн дээр чулуудаад хормогчны энгэрийн өргөн хармаанаас самрын тостой жигнэмэгийн боодол гаргаж ирэв. Стюарт сэтгэл санаа тавгүйтсэн үед дандаа юм иддэг ба дандаа хайш яйш иддэг. (түүнийг хоол идсэний дараа аав нь ширээн дээр үлдсэн хогийг хараад энд гахай хоолложээ гэж хэлдэг байсан). Харин энэ удаад жигнэмэгийн үйрмэг талийгаачийн амарлингуй бус нүүрэн дээр асгарна. Хэрэв энэ эмэгтэй "Ликвид-Пламп" хэмээх бөглөө арилгах гель ууснаар Бүрхүүл дороос түргэн бөгөөд зовлонгүй зугтана гэж бодсон бол тун том алджээ. Идэмхий бодис түүний ходоодыг идээд нуруугаар нь цоолон гарчээ.

-Ямар нэг юм болохгүй байна уу? гэж Ферн асуув.

-Би энэ хараал идсэн Реннитэй яах гэж холбогдов оо?

-Мөнгөний төлөө биз дээ?

-Одоо мөнгө ямар хэрэгтэй юм бэ? Би мөнгөөр яах юм. Берпигийн их дэлгүүрийг худалдаж авах юмуу гэж Стюарт гаслав. Настай бэлэвсэн талийгаач эмэгтэйн амыг ангайлгаж үлдсэн жигнэмэгээ чихэж гарав.

-Муу шулмас. Ид. Одоо чиний хооллох цаг болсон.

-Стюарт гар утсаа шүүрч аваад лавлах ном эргүүлж хэрэгтэй дугаар руугаа залгалаа.

-Хэрэв тэр хариулахгүй бол гэж Стюарт Фернд юмуу эсвэл өөртөө хандан хэлсэнээ -Би өөрөө тийшээ явж түүнийг олоод хараал идсэн бөгс рүү нь тахиа чихнэ...

Гэвч Рожер Кильян утсаа авав. Цаана нь гарах дуунаас үзвэл тахианы саравчиндаа байх бололтой. Шувуу дугарахыг Стюарт сонсов. Мөн тахианы саравчинд тарааж өлгөсөн чанга яригчаар Мантованигийн хийлийн найрлын дуу сонсогдоно. Кильяны хүүхдүүд нь саравчинд ажиллах юм бол тахианууд "Металлик" юмуу "Тантер" хамтлаг сонсоход хүрдэг.

-Байна уу?

-Рожер оо би Стюарт байна. Чи эрүүл байна уу?

-Өөрийнхөөрөө гэж Рожер хариулав. Энэ нь тэр архи уугаагүй бөгөөд зөвхөн мет татсан гэсэн үг юм. Гэхдээ энэ нь ямар ч утгагүй хэрэг.

-Над руу хүрээд ир. Хотын гараашг уулзацгаая. Бид хоёр том ачааны тэрэг аваад, өнөөх татагчтайг аваад, радио станц руу явцгаая. Бүх хийг хот руу буцааж авчрах шаардлагатай болсон. Бид үүнийг ганц өдөрт амжуулж чадахгүй. Гэвч Жим өнөөдөр эхлэх хэрэгтэй гэсэн. Маргааш би итгэлтэй зургаа юмуу долоон залууг дайчилна. Хэрэв Жим өгөх юм бол түүний чөттөрийн армиас авна. Тэгээд бүгдийг дуусгана.

-Үгүй дээ Стюарт... Би тахиагаа тэжээх ёстой. Миний үлдсэн хүүхдүүд одоо цагдаа болсон.

Энэ чинь тэгвэл чи өөрийнхөө жижигхэн шорон шиг өрөөнд суугаад мет татаж, өнөөх баасны хөгжмөө сонсож, компьютер дээр лесби хүүхнүүдтэй видео үзнэ гэсэн үг үү гэж Стюарт бодлоо. Тахианы сангасны үнэр бараг хутгаар зүсч болмоор тийм өгтөн байхад яаж хүсэл тачаал төрж болохыг тэр ойлгохгүй байсан ч харин Рожер тачаалдаж чаддаг байв.

-Энэ бол сайн дурын арга хэмжээ биш. Би тушаал авсан. Одоо чамд тушааж байна. Хагас цагийн дараа уулзацгаая. Хэрэв хүүхдүүдээсээ хэн нэгнийг харвал дагуулаад ир.

Рожер ямар нэг юм хэлэхээс түрүүнд утсаа салгаж амжаад уурандаа шатан хэдэн хором зогслоо. Орой болтол хийтэй сав чингэлэгүүдийг ачааны тэргэнд татаж гаргах нь түүнд огт таалагдахгүй байв. Гэвч яг энэ ажлыг л хийх хэрэг болжээ. Тийм ээ, тийм.

Тэр угаалтуураас уян хоолойг суга татаж үзүүрийг нь талийгаачийн хиймэл пгүднүүдийн завсар чихээд усыг нээв. Ус өндөр даралттай байсан тул хүүр ширээн дээр үсрэв.

-Жигнэмэгийг угаах хэрэгтэй авгай минь. Хоолойг чинь бөглөөд бүтэж үхэхэд хүргэж болохгүй шүү дээ гэж тэр даажигнав.

-Зогс гэж Ферн хашгирлаа. -Ус нүхээр гараад... Тэр хожимджээ.

Том Жим Расти руу харан инээлээ. Түүний инээд "юунд хүрсэнээ хар" гэж хэлэх ажээ. Дараа нь Картер ба Дентон нар руу эргэж:

-Ноён Эверетт надад юу тулгасныг та нар сонссон уу?

-Мэдээж сонссон гэж Фредди хариулав.

-Тэр амь насны үзүүлэлтээр надад зайлшгүй шаардлагатай байгаа эмийг хэрэв би огцрохгүй бол өгөхгүй гэж заналхийлэхийг та нар сонссон уу?

-Тийм гэж Картер толгой дохиод Расти руу ширүүн харц хаялаа. Харин Расти өөрөөсөө "Би яаж ингэж тэнэглэж чадав аа?" гэж асуув.

Их урт өдөр байлаа. Түүн рүү л буруугаа чих.

-Энэ бол верапамил гэдэг эмний тухай яриа юм. Өнөөх урт үстэй эр миний судсаар тарьсан гээд Том Жим дахин нэг тааламжгүй инээд бэлэглэхэд жижигхэн шүднүүд нь ил гарав.

Верапамил. Расти Том Жимийн хаалган дээрх дугтуйнаас эмнэлгийн картыг авч уншаагүйдээ өөрийгөө хараав.

-Та нарынхаар бол бид энд ямар гэмт хэргийн тухай ярих вэ? Өөрийнхөө хүслийг заналхийлэн тулгах гэсэн оролдлого уу? гэж Том Жим үргэлжлүүлэв.

-Мэдээж бас хүчээр тулгах гэж Фредди давслав.

-Больж үз. Энэ бол алах гэж оролдсон хэрэг гэж Картер эсэргүүцлээ.

-Тэгвэл хэн түүнийг ийм юм хийлгэх гэж ятгасан бэ? -Барби гэж Картер хариулаад Растигийн нүүрэн дундуур нударгаллаа.

Өнөөх нь ийм юм огт хүлээгээгүй байсан болохоор цохилтоос бултах оролдлого ч хийсэнгүй эсвэл гараар хааж ч амжсангүй. Тэр хойшоо шидэгдэж сандал мөргөөд хажуугаараа түүн дээр унаж задарсан уруулаас нь цус урсав.

-Баривчлах үед эсэргүүцэл үзүүлсэн тул уруулыг чинь зад цохисон гэж Том Жим зарлаад: - Гэвч энэ хангалттай биш.

Хүүхдүүд ээ түүнийг шалан дээр дарж бай. Тийм байдалд надад хэрэгтэй.

Расти зугтахыг оролдож сандалаас дөнгөж өндийтөл Картер гарнаас нь шүүрч нуруунд нь мушгив. Фредди Растигийн хоёр хөлийн завсар хөлөө хийхэд Картер түлхлээ. Расти шалан дээр унах үедээ яг л сургуулийн хашаанд байгаа хүүхдүүд шиг гэж бодов.

Картер түүний дээрээс уналаа. Расти цохиж амжив. Картерын зүүн хацар дээр онов. Тэр

залхаасан ялааг хөөх мэт түүний гарыг яаралгүй түлхлээ. Ганц хормын дараа аль хэдийн цээжин дээр нь суугаад нүүр рүү нь инээнэ. Тийм ээ яг сургуулийн хашаанд байгаа юм шиг. Гэвч болж байгаа явдлыг хэн ч дэлгэцээр харж энэ замбараагүйтлийг таслахгүй.

Расти одоо босч ирсэн Ренни рүү толгойгоо эргүүлж:

-Та үүнийг хийхийг хүсэхгүй шүү дээ гэж арай гэж хэлэв. Зүрх нь хүчтэй цохилно. Агаар дутагдана. Картер их хүнд жинтэй ажээ. Фредди тэдний хажууд өвдөглөн суужээ. Тэр яг л бөхийн барилдааны шүүгч шиг Растид санагдав.

-Эверетт минь би хүсч байна. Бурхан чамайг ивээг. Би тэгэх ёстой. Фредди түүний энгэрийн хармаанаас миний гар утсыг ав. Хагарахыг хүсэхгүй. Шалчгар амьтан түүнийг хулгайлсан юм. Түүнийг цагдаагийн газарт аваачихдаа гэмт хэргийн жагсаалтанд нь үүнийг бас нэмчихээрэй гэж Том Жим хэлэв.

-Бусад хүмүүс мэдэж байгаа гэж хэлэхдээ Расти урьд хожид хэзээ ч өөрийгөө ийм арчаагүй байдалд мэдэрч байгаагүйгээ ойлгов. Бас ийм тэнэг. Жеймс Ренниг дутуу үнэлсэн анхны хүн нь би биш гэх бодол түүнд онц тус болсонгүй. -Таны юу хийснийг мэдэх бусад хүмүүс байгаа.

-Магадгүй гээд Том Жим мөрөө хавчив. Гэхдээ тэд хэн юм бэ? Дейл Барбарагийн бусад найзууд шүү дээ. Хүнсний самууныг эхлүүлж, сонины редакцийг шатаасан тэр хүмүүс. Тэдний зүтгэлээр энд Бүрхүүл үүссэн гэдэгт би эргэлзэхгүй байна. Миний бодлоор засгийн газрын ямар нэг туршилт явж байна. Гэвч бид торонд байгаа харх биш тийм үү? Картер тийм үү?

-Тийм.

-Фредди чи юу хүлээгээ вэ?

Фредди Том Жимийг сонсонгуут түүний царайд Одоо л бүхнийг ойлголоо гэсэн бичиг гарч ирэв. Тэр Том Жимийн гар утсыг Растигийн энгэрийн хармаанаас авч буйдан дээр шидэв. Дараа нь Расти руу тонгойгоод:

-Та нар үүнийг хэр эртнээс төлөвлөсөн бэ? Бидний юу хийхийг харахын тулд хот дотор нь хорихыг хэзээнээс төлөвлөсөн бэ?

-Фредди чи өөрийгөө сонс. Энэ бол солиорол. Ямар ч утгагүй. Чи харахгүй байна гэж үү?... Расти арай ядан шивнэж байлаа. Энэ Картер ямар хүнд юм бэ? Бурхан минь.

-Гарыг нь шаланд шахаад барьж бай. Зүүн гарыг нь гэж Том Жим тушаав.

Фредди тушаалыг биелүүллээ. Расти эсэргүүцэх гэж оролдсон ч Картер шуунаас нь атгаж дарсан тул амжилт олсонгүй.

-Залуу минь чамайг ингэж байгаадаа би харамсч байна. Гэвч алан хядагчид хяналтанд байгаа гэдгийг манай хотынхон харах ёстой.

"Харамсч байна" гэсэн үгийг Ренни хэдэн ч удаа хэлж чадна. Гэвч гутлынхаа өсгийгөөр дамжуулан 230 фунт жингээ Растигийн зангидаж барьсан зүүн сарвуу дээр буулгахын өмнөхөн хотын захиргааны хоёрдугаар гишүүний кабардинтай өмд зад үсэрлээ. Ренни тун их таашаал авав. Гэхдээ оюуны гэсэн утгаар биш л дээ.

Дараа нь өсгий нь бууж ирээд гарыг нь нухаж гарлаа. Хүчтэй, илүү хүчтэй, бүр хүчтэй. Том Жимийн царай чулуун хөшөө шиг хөшив. Нүдэн доогуур нь хөлс бөмбөрнө. Хоёр шүднийх нь завсар хэлний үзүүр бултайжээ.

Битгий хашгир. Хашгирвал Жинни гүйж ирээд бас орооцолдоно. Ренни үүнийг хүсч байгаа. Түүнд таашаал өгөх хэрэггүй.

Гэвч Том Жимийн өсгийн дор яс нь шажигнахад Расти ориллоо. Өөрийгөө яаж ч чадсангүй.

Дахиад начигналаа. Гурав дахь удаагаа.

Ренни ханасан бололтой нэг алхам ухрав.

-Хөл дээр нь босгоод шоронд аваач. Найз дээрээ очиг.

Растигийн хавдаж эхэлсэн сарвууг Фредди нягталж үзэв. Гурван хуруу нь тал тал тийш эвгүй унжжээ.

-Хугарсан байна гэж тэр тун сэтгэл ханамжтай дүгнэлт хийв.

Амралтын өрөөний хаалган дээр нүд нь бүлтийсэн Жинни гарч ирэв.

-Та нар яаж байна аа?

-Новшийг гэмт үйлдэл болоод хүн алах гэсэн оролдлогын төлөө баривчилж байна гэж Фредди хариулах үед Картер Растиг ганц дугтран хөл дээр нь босгов.

-Энэ бол зөвхөн эхлэл. Тэр баривчилгааг эсэргүүцсэн тул бид тайвшруулахаас аргагүй болсон. Хатагтай холдож үз.

-Та нар солиорчээ. Расти чиний гар гэж Жинни дуу алдлаа.

-Би зүгээр ээ. Линда руу утасдаарай. Эдгээр дээрэмчдийн тухай хэлээрэй...

Тэр өөр юу ч хэлж амжсангүй. Картер түүний хүзүүнээс атгаад хаалга руу чиглүүлэв. Бас чихэнд нь шивнэв.

-Хэрэв би тэр өвгөн анагаах ухаанд чамаас дутуугүй мэдлэгтэй гэж яг мэдсэн бол би өөрийн гараар чамайг алах байсан.

Тэгээд энэ бүхэнд ердөө дөрөвхөн хоног хангалттай байжээ гэж Расти гайхан боддоо. Картер хүзүүнээс нь базан дарж тонгойлгоод хонгилоор авч явах үед түүнд төрсөн бодол. Зүүн гар нь

гар биш харин шуунаас эхлэх өвдөлтийн багана болон хувирах шиг. Ердөө дөрөвхөн өдөр.

Ингэхэд илгэн толгойтнууд энэ шоуг хараад таашаал авсан болов уу? Тэд хэн юм, эсвэл юу юм гэдэг нь хамаагүй таашаал авсан болов уу? гэх асуултыг бас өөртөө тавьлаа.

10

Бүр үдээс хойш Линда сая Миллийн номын санчийг олов. Лисса 117-р гудамжаар унадаг дугуйгаа унан хот руу буцаж явав. Тэр уулзалтын өдрийн тухай дэлгэрэнгүй ярилцахаар Бүрхүүлийн хил дээр зогсох харуулууд дээр очсон гэнэ.

-Тэд уг нь хотынхонтой харилцах ёсгүй боловч зарим нэг нь харилцаж байна. Ялангуяа цамцныхаа дээд талын гурван товчийг тайлчихвал. Энэ арга яриа үүсгэхэд их тус болох юм. Ялангуяа цэргүүдтэй. Харин тэнгэсийн явган цэргүүд... Хэрэв би чармай нүцгэлээд макарена бүжиглэсэн ч тэд нэг ч үт дуугарахгүй бололтой. Тэр залууст бол бэлгийн дур хүслээс сэргийлэх вакцин хийчихсэн юм билээ. Гэхдээ би ч бас Кейт Уинслеттэй андуурагдахаар хүүхэн биш л дээ гээд тэр инээв.

-Ямар нэг сонирхолтой юм мэдэж чадав уу?

-Үгүй гэж хариулахдаа Лисса унадаг дугуйнаасаа бугаагүй бөгөөд зорчигчийн талын цонхоор Линда руу шагайна. -Тэд юу ч мэдэхгүй. Гэхдээ бидний төлөө маш их санаа зовж байна. Энэ нь миний сэтгэлийг хөдөлгөсөн. Тэд яг л бидэнтэй адил маш их цуу яриа сонсчээ. Нэг нь бүр хотод зуугаад хүн амиа хорлосон гэдэг үнэн үү гэж асуусан.

-Чи миний машинд ганц хором сууж чадах уу?

Лисса бүр малийтал инээв.

-Би баривчлагдаж байгаа юм уу?

-Чамтай ярих юм байна.

Лисса тулуурыг буулган унадаг дугуйгаа налуулж тавиад урд сандал дээр байсан торгуулийн хуудастай дэвгэр ба богино долгионы холбоог цааш түлхэн суулаа. Линда оршуулгын товчоо руу хийсэн нууц айлчлал болоод Пайперийнд болох гэж байгаа уулзалтын тухай ярив. Лисса шууд л халуунаар дэмжлээ.

-Би ирнэ. Намайг оролнуулахгүй байгаад үзээрэй.

Энэ үед богино долгионы радиогоор Стейссигийн дуу хадав.

-Дөрөвдүгээр, дөрөвдүгээр яаралтай хариу. Яаралтай хариу.

Линда яригчийг шүүрэн авлаа. Энэ үед тэр Расти биш охидынхоо тухай бодож байв.

-Дөрөвдүгээр сонсож байна. Стейси яриарай.

Стейсигийн ярианаас Линдагийн түгшүүр бүр айдас болон хувирлаа.

-Надад чамд хэлэх хоёр муу мэдээ байна. Би чамайг биеэ барь гэж хэлэх байна. Гэвч одоо чи тэгж чадна гэж бодохгүй байна. Растиг баривчилжээ.

-Юу? Юу гэнэ ээ? гэж Линда бараг чарлав. Гэвч чанга яригчийн бөөрөн дээрх "дамжуулах" гэсэн товч дээр дарахаа мартсан тул түүнийг ганцхан Лисса л сонслоо.

-Түүнийг Тахианы-саравчинд Барбитай хамт суулгасан. Тэр гайгүй байх шиг байна. Гэхдээ миний харсанаар гар нь хугарчээ. Расти гараа цээжиндээ наасан, хавдсан байсан гээд Стейси дуугаа намсгаж: -Баривчлах үед тэр эсэргүүцэл үзүүлсэн тул ийм болсон гэж тэд хэлсэн. Хариу.

Энэ удаад Линда товчийг саналаа.

-Би одоо очлоо. Растид намайг очлоо гэж хэл. Хариу.

-Чадахгүй. Тусгай жагсаалтанд байгаа цагдаа нараас өөр хэнд ч доошоо буухыг зөвшөөрөхгүй байгаа. Тэнд миний нэр алга. Хүн алахыг оролдсон болоод хүн амины хэрэгт тусалсан гээд ялын бүхэл бүтэн жагсаалт тулгаж байна. Хот руу давхих хэрэггүй. Тэртэй тэргүй чамайг оруулахгүй. Тиймээс замын хажуу руу нисэх юмуу ямар нэг юм мөргөлөө гээд ашиг гарахгүй шүү.

-Би түүнтэй заавал уулзана гэж Линда зөрүүдлэв.

Гэвч уулзаж чадаагүй. Бүхэл өдөржин шахуу унтаад амарсан царайтай харагдах Рэндолф дарга цагдаагийн газрын шатны хамгийн дээд талын гишгүүр дээр түүнийг тосоод цагдаагийн энгэрийн тэмдэг ба гар буугаа өгөхийг тушаав. Тэр Растигийн эхнэрийн хувиар хотын хууль ёсны засаг захиргааны эсрэг хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулсан болоод үймээн самуун дэгдээсэн хэрэгт сэжиглэгдэж байгаа ажээ.

Сайн байна. Намайг ч бас баривчлаад доошоо нөхөр дээр минь аваачаад өг гэж тэр хэлэхийг хүсэв. Гэвч дараа нь энэ өдөр сургууль дээр юу болсон тухайгаа ээжийгээ ирэхээр ярьж өгөх хүсэлтэй Марта дээр түүнийг хүлээж байгаа охидынхоо тухай бодлоо. Бас өнөө орой Пайперынд болох уулзалтын тухай ч бодов. Хэрэв түүнийг хонгилд суулгачихвал тэр тийшээ очиж чадахгүй. Харин одоо энэ уулзалт улам илүү чухал утга учиртай болж байна.

Хэрэв тэд маргааш орой нэг хоригдольгг суллах гэж байсан юм бол хоёрыг суллаж яагаад болохгүй гэж?

-Түүнд намайг хайртай гэж хэлээрэй гэж хэлээд Линда үсээ задалж бүснээс бууны хуйгаа салгав. Тэр гар бууг угаасаа нэг их ашиглаад байдаггүй. Түүний гол ажил нь хүүхдүүдийг зам хөндлөн гаргаж өгөх юмуу дунд сургуулийн сурагчдаас тамхиа унтраахыг шаардах, эсвэл хараал зүхэл хэлэхээ болихыг шаардах хойно доо.

-Хатагтай Эверетт би түүнд таны үгийг дамжуулъя.

-Түүний гарыг хэн нэгэн үзсэн үү? Гар нь хугарсан байж болзошгүй гэж би сонссон.

Рэндолф хөмсөг зангидлаа.

-Танд хэн тэгж хэлсэн юм бэ?

-Надтай хэн холбоогоор харьцсаныг би санахгүй байна. Нэрээ хэлсэнгүй. Манай залуусын нэг л байсан гэж би бодож байна. 117 дугаар зам дээр холбоо их муу сонсогдож байна билээ.

Рэндолф түүний үгийг бодсоноо энэ сэдвийг гүнзгийрүүлэх шаардлагагүй гэж шийдэв.

-Растигийн гар бүрэн хэвийн байгаа. Тэгээд манай залуус одоо таны залуус биш болсон. Гэртээ харь. Танд тавих асуулт бидэнд гарна гэдэгт би итгэлтэй байна.

Нүдэнд нь нулимс цийлэгнэхийг тэр мэдэрсэн ч барьж чадлаа.

-Тэгээд би охиддоо юу гэж хэлэх вэ? Аав нь шоронд байгаа гэх үү? Расти сайн хүн гэдгийг та мэдэж байгаа. Та үүнийг мэднэ. Бурхан минь, өнгөрсөн жил таны цөсний чулууг тэр л оношлосон.

-Хатагтай Эверетт, би энд бол юугаар ч тус болж чадахгүй.

Түүнийг Линда гэж нэрлэдэг байсан тэр цаг өнгөрчээ.

-Гэвч аав нь Лестер Коггинс ба Бренда Перкинс нарыг алсан хэрэгт Дейл Барбаратай хамт оролцсон гэдгийг тэдэнд хэлэх хэрэггүй гэж би бодож байна. Нөгөө хоёр хүүхний үхэлд бол бид итгэлтэй биш байгаа. Тэд бол бэлгийн шалтгаантай хэрэг бөгөөд Расти тэр тухай мэдээгүй байж болно.

-Энэ чинь солиорол.

Рэндолф түүний үгийг сонсоогүй мэт байв.

-Тэр бас хотын захиргааны гишүүн Реннид амин чухал хэрэгтэй эмийг өгөхөөс татгалзаж алахыг оролдсон. Гэвч Том Жимд ойр хавьдаа хоёр цагдаа нуух ухаан хүрсэн юм билээ гээд цагдаагийн дарга толгой сэгсрэв. -Хотын сайн сайхны төлөө өөрийгөө үл хайрлах хүнд амин чухал эм өгөхөөс татгалзана гэдэг чинь. Тэгээд энэ хүн таны тэр сайн залуу чинь үү? Энэ хүн булуулвал таарах сайн залуу.

Линда мэдэж байгаа бүхнээ гадагш цуггалгүй арай гэж тэслээ. Тэгээд тэвчээр барагдахаас өмнө явав. Пайперын гэрт уулзах хүртэл дөрвөн цаг үлджээ. Дуусахгүй урт хугацаа. Линда хаашаа явж юу хийхээ мэдэхгүй байв.

Дараа нь гарц оллоо.

Растигийн гар зүгээр биш байсан нь ойлгомжтой. Тэр бүү хэл Барбара үүнийг харж байв. Уг нь тэдний хооронд гурван ч хоосон хорих өрөө байсан.

-Расти би чамд ямар нэг юмаар тус болж чадах уу?

Расти хүчээр инээмсэглэв.

-Үгүй дээ. Гэхдээ надад хоёр ширхэг аспирын шидэж болох юм. Эсвэл дарвосет байвал илүү дээр. -Дуусчихсан. Тэд чамд юу ч өгөөгүй юм уу? -Үгүй. Гэхдээ өвчин намдаж байна. Би тэсч гарнаа.

Хэлсэн нь бодит байдалтай огт нийцэхгүй байлаа. Гар нь аймаар өвдөж байв. Түүний бодсон зүйл өвдөлтийг улам нэмэх болно. -Би хуруутайгаа ямар нэг юм хийх ёстой.

-Амжилт хүсье.

Ренни түүний нэг ч хурууг хугалж чадаагүй нь мэдээж гайхамшиг. Гэхдээ сарвууны ясыг гэмтээжээ. Тэр цамцаа цуулаад чиг барин боохоос өөр юу ч хийж чадсангүй. Гэхдээ эхлээд...

Расти үеэрээ мултарсан долоовор хуруугаа барив. Кинонд ийм юм их хурдан болж өнгөрдөг. Харамсалтай нь бодит амьдралд бол хурд байдлыг дордуулахаас биш тус болохгүй. Тэр даралтаа аажмаар нэмж, яаралгүй салгалалгүй оролдов. Аймаар өвдлөө. Шүд нь тачигнав. Хуруу нь онгойхоо болиод удаж байгаа хаалганы нугас шиг нужигнахыг Расти мэдэрлээ. Их ойрхон мөртлөө алсын улсад Барби хорих өрөөнийхөө торны дэргэд зогсоод ажиглаж байгааг тэр анзаарав.

Дараа нь хуруу гэнэт шидтэй юм шиг тэгшрээд өвчин намдлаа. Ямартаа ч энэ хурууны өвчин. Расти дөнгөж сая барианы шугам өнгөрсөн гүйгч шиг ойр ойр амьсгалан ханзан дээрээ унав.

-Болсон уу?

-Бүрэн биш. Босгож харуулдаг тэр хуруугаа тэгшлэх хэрэгтэй байна. Хэрэг болж мэднэ.

Расти дунд хуруугаа бариад долоовор хуруутайгаа хийсэн бүхнээ хийв. Дахиад л өвдөлт тэсэх аргагүй болж ирэх тэр үе мултарсан үед байх ёстой байрандаа оров. Одоо Расти сэржим өргөж үг хэлэх гэж байгаа мэт хажуу тийш ёрдойсон чигчий хуруу л үлдлээ.

Хэрэв чадахаар байсан бол сэржим өргөөд үг хэлэх л байсан. Амьдралын хамгийн новшийн өдрийн төлөө. Ямартаа ч Расти Эвереттийн амьдралын ийм өдрийн төлөө.

Тэр чигчий хуруутайгаа ноцолдов. Энэ хуруу өвдөж байлаа. Түүнийг тийм ч хурдан янзлах боломжгүй.

-Чи юу хийчихэв ээ? гэж Барби асуугаад дараа нь хуруугаар хоёр удаа инчдэж дээшээ тааз руу зааснаа алгаа чихэн дээрээ тавив.

Тахианы-саравчийг чагнадаг гэдгийг тэр үнэхээр мэдэж байсан юмуу эсвэл тэгж бодсон

юмуу? Ямар байсан ч хамаагүй гэж Расти шийдэв. Гэхдээ чагнаж байгаа гэж л бодох хэрэгтэй. Гэхдээ энэ тэнэгүүдийн хэн нэг нь ийм юм сэтгэнэ гэж бодоход хэцүү л байсан.

-Том Жимийг огцруулах гэж оролдоод алдаа хийчихлээ. Мэдээж над дээр дахиад хэдэн арван хэрэг тохно гэдэгт би эргэлзэхгүй байна. Гэхдээ зарчмын хувьд бол би түүнийг морио битгий шавдуулаад бай эс тэгвэл зүрхний шигдээж болно шүү гэж зөвлөсний төлөө намайг суулгачихлаа.

Мэдээж Расти Коггинсын талаар дурссангүй. Энэ сэдвийг хөндөхгүй байсан нь дээр гэж бодов. Эрүүл мэндэд хортой байж мэднэ.

-Энд хоол ямархуу байна даа?

-Муугүй шүү. Роза үдийн хоол авчирсан. Усны тухайд болгоомжтой байх хэрэгтэй. Давс хийж ч мэднэ.

Барби баруун гарын хоёр хуруугаа дэлгээд нүд рүүгээ зааж дараа нь нийлүүлээд ам руугаа заав. "Ажигла".

Расти толгой дохилоо.

-Маргааш орой гэж Барби зөвхөн уруулаараа хөдлөв.

-Мэднэ гэж Расти яг тэгж хариуллаа. Уруул нь хагарчээ. Дахиад цус урсав.

Барби нэмж хэлэв: -Бидэнд...аюулгүй...газар...хэрэгтэй.

Расти бодсоноо тийм газар байгаа гэж үзлээ. Жо Макклетчи ба түүний найзуудад баярлалаа.

12

Энди Сандерст уналт өгчээ.

Гарцаагүй ингэх л байсан. Тэр дөнгөж метэнд татагдан орсон мөртлөө маш их татсан. Энди ХБЭ студид "Бидний амин талх" хамтлагийн тоглосон "Чи ямар агуу юм бэ?" хөгжмийг сонсч, нүдэнд үл үзэгдэх найрал хөгжмийг удирдаж байна. Дараа нь мөнхийн орны хийлний утсаар дамжин нисч яваагаа олж харав.

Шеф гаансаа аваад хаа нэг тийшээ явахдаа "шармал" гэж нэрлэдэг өөрөө ороосон бүдүүн тамхийг Эндид үлдээсэн юм. "Чи болгоомжтой хандаарай. Энэ бол бөмбөг пгүү. "Дарс ууж дасаагүй хүн түүнд хүчтэй татагдаж болохгүй" гэсэн байдаг. Энэ бол Тимофейн нэгдүгээр сургамжинд байгаа. Шармалд ч бас хамаарна" гэж Шеф сануулсан юм.

Энди их л ухаалаг царайтай толгой дохисон ч яг чөтгөр шиг утаа суунаглуулж байсан бөгөөд Шефийг хаалганы цаагуур оронгуут хоёр шармал авч угсруулан татав. Шармал татах бүртээ хуруу түлэх бяцхан ёзоор болтол нь татжээ.

Муурны шээсний үнэр ханхлуулах шатсан метний үнэр түүний үнэрийн хит парадад нэгдүгээр эгнээнд гарсан байлаа. Тэр гурав дахь шармалыг татан яг л Бернстайн шиг удирдаач хийж байхдаа нэг гүнзгий сороод тэр дороо тасрав. Шалан дээр унаж, сүмийн хөгжмөн голд живж яваа хүн шиг татвалзав. Хазсан шүдний завсараар хөөс цахарлаа. Хагас аниатай нүд нь ухархайндаа эргэлдэж, болоогүй юмнуудыг олж харав. Одоохондоо болоогүй юмсыг.

Арван минутын дараа ухаан орж студи ба түүний ар талд барьсан урт улаан зоорины барилгын голын замаар салхи шиг хурдлах тэнхээтэй болжээ.

-Шеф ээ чи хаана байна? Тэд ирж явна гэж ориллоо.

Шеф Буши агуулахын байшингийн хажуугийн хаалгаар гарч ирэв. Үс нь тостой зүү болж тал тал тийш арзайна. Унтлагын бохир өмдний салтаанд шээсний толбо, харин бөгсөн тал нь өвсний толбо болжээ. Өмдөн дээр зурсан хүүхэлдэйн киноны баатар мэлхийнүүд "Вааг-вааг" гэж дуугарах мэт. Өмд нь өгзөгөөс бараг сугарах шахах бөгөөд урд талын давсагны үс нь ил гарч, бас ар талаасаа бол туранхай өгзөгийн хоорондох зураас харагдаж байна. Шеф нэг гартаа бөгсөн дээр нь "Бурхны дайчин" гэсэн үгийг нямбай сийлсэн Ак-47 буу, нөгөө гартаа гараашийн алсын удирдлагыг барьжээ. Тэр "бурхны дайчин"-аа газарт тавьсан ч харин бурхны удирддагаа гараас салгасангүй. Эндигийн мөрнөөс нь зуурч хүчтэй сэгсрээд:

-Сандерс боль. Чи сандарч тэвдсэн байна.

-Тэд ирж явна. Гашуун хүмүүс. Чиний хэлсэн хүмүүс.

Шеф бодлогоширов.

-Чам руу хэн нэгэн утасдаж сануулсан юм уу?

-Үгүй. Би харсан юм. Би тасарч унаад харсан.

Шефийн нүд томроод ирэв. Сэжиглэл нь хүндэтгэлд байраа тавьлаа. Харцаа Эндигээс Литл-Битч-Роуд гудамж руу нйилсэн орцны зам руу шилжүүлснээ дахиад Энди рүү харав.

-Чи юу харсан юм бэ? Олон байсан уу? Тэд бүгдээрээ юмуу эсвэл өнгөрсөн удаагийнх шиг хэдхэн байна уу?

-Би... Би... Би...

Шеф түүнийг дахин сэгсрээд арай зөөлнөөр: -Сандерс тайвшир. Чи одоо христийн цэрэгт байгаа. Тэгээд...

-Христийн цэрэг.

-Тийм, тийм, тийм. Би чиний удирдагч. Тийм учир илтгэ. -Тэд хоёр ачааны тэргээр ирж явна.

-Зөвхөн хоёр уу? -Тийм.

-Ягаан өнгөтэй юу? -Тийм.

Шеф унтлагын өмдөө татаад (тэр дороо өмнөх байдалдаа оров) толгой дохилоо.

-Хотын ачааны тэрэг. Өнөөх тэнэгүүд бололтой. Ах дүү Боуи ба ноён тахиачин.

-Ноён юу гэнэ ээ?

-Кильян өөр хэн байх юм бэ? Тэр мет татдаг мөртлөө метийн зориулалтыг мэддэггүй. Тэр бол тэнэг. Тэд хий авахаар ирж яваа.

-Бид нуугдах юм уу? Нуугдаад тэдэнд хий авахыг нь зөвшөөрөх үү?

-Би түрүүнд тэгсэн. Одоо бол үгүй. Цаашид нуугдаж хүмүүс хүссэн юмаа авахыг зөвшөөрч чадахгүй. Агь од аль хэдийн гэрэлтэж эхэлсэн. Бурхны хүмүүс далбаагаа өргөх цаг боллоо. Чи надтай юу?

Бүрхүүл үүссэнээс хойш юуны төлөө амьдрах ёстой байсан бүхнээ алдсан Энди огт түгдрэлгүй хариуллаа.

-Тийм.

-Эцсээ хүртэл үү Сандерс аа? -Эцсээ хүртэл.

-Чи тэгээд буугаа хаашаа хийчихсэн юм бэ?

Энди түүнийг энэ хорвоогоос хальсан Лестер ламын Пэт Робертсонтой (Америкийн алдарт теле номлогч) тэврэлдсэн хөргийн дор студийн хана налуулан орхисоноо бүүр түүр санав.

-Түүнийг явж авъя гээд Шеф "Бурхны дайчин"-аа шүүрэн авч сумтай дайзыг шалгав. - Одооноос эхлээд чи буугаа хаа сайгүй барьж явах ёстой ойлгов уу?

-За.

-Сумтай хайрцаг тэнд байгаа юу? -Тийм.

Энди цагийн өмнө дайзтай сум бүхий хайрцгийг студид аваачсан. Ямартаа ч тэр цагийн өмнө гэж бодож байв. Энэ шармалууд хугацааг их өөрчилжээ.

-Ганц минут хүлээ гээд Шеф зоорины барилгын булан

тойрч хятад гар бөмбөгнүүд бүхий хайрцаг руу очоод гурвыг авчирч, хоёрыг Эндид өгөөд хармаалахыг тушаав. Гурав дахийг нь "Бурхны дайчин"-ы овоо хараанаас чагтны гогцоогоор нь өлгөв.

-Сандерс аа, чагтыг мулталснаас хойш 7 секундын дараа дэлбэрч доторхио цацдаг гэж надад хэлсэн. Гэвч би холгүй байдаг хайрганы уурхайд нэгийг шалгаж үзсэн чинь дөрвөн секундын

дараа дэлбэрдэг юм билээ. Ази хүмүүст итгэж болохгүй. Үүнийг санаж ав.

Энди санах болно гэж хариулав.

-Сайн байна. Явцгаая. Чиний бууг авья.

Энди хулчиганан асуулаа.

-Бид тэднийг алах юм уу?

Шефийн царайд үл ойлгох байдал тодорлоо.

-Үгүй. Бүр онцгой шаардлага гарахгүй бол үгүй.

-Мэддээ.

Энди ямар ч тохиолдолд хэнд ч хор хүргэхийг үл хүснэ. -Гэвч хэрэв тэд өөрсдийнхөөрөө зүтгэж дайрах юм бол бидэнд өөр зам үлдэхгүй. Чи үүнийг ойлгож байна уу? -Тийм ээ.

Шеф Эндигийн мөрийг найрсагаар алгадав.

13

Бенни Норри хоёр энд хонож болох эсэхийг Жо ээжээсээ асуув. Эцэг эх нь дургүйцэхгүй бол үлдэж болно гэж Клер хариуллаа. Энд байх нь түүний сэтгэлд нийцэж байв. Блэк-Ридж дээр болсон адал явдлаас хойш нүдэнд харагдаж байвал дээр гэж бодох болжээ. Зууханд мод түлээд поп-корн бэлдэх бөгөөд "Монополь" тоглоомыг шуугиантай наадаж байлаа Үнэнийг хэлбэл дэндүү шуугиантай тоглоно. Тэдний часхийн хашгирах ба инээх нь их тайвангүй байдалтай.

Бенни ба Норри нарын ээж нар зөвшөөрсөнд Клер гайхав.

-Сайн байна гэж Жоани Кэрверт хэлээд: -Энэ явдал болсноос хойш би юм бичих гээд завгүй байлаа. Өнөө орой боломж гарах нь. Клер чи Норрид хэлээрэй. Маргааш орой өвөөгөө олж уулзаад миний өмнөөс үнс гээрэй.

-Өвөө нь хэн юм бэ?

-Эрни. Чи Эрнийг мэднэ тийм үү? Эрниг бүгд мэддэг. Тэр ач охиндоо түгшээд байгаа юм. Би ч бас заримдаа тэгдэг. Тэр скэйт бол... гэх Жоанигийн дуу чичигнэв.

-Би түүнд хэлнэ ээ.

Клер дөнгөж утсаа тавьгал хаалга тогшлоо. Дунд хэрийн насны, түгшсэн цонхигор царайтай эмэгтэйг тэр эхлээд таньсангүй. Гэвч дараа нь хүүхдүүдийг зам гаргаж өгөх юмуу, хоёр цагаас илүүгүй машин тавих ёстой агал гудамжны зогсоол дээр машинаа дэндүү удаан орхисон жолооч нарыг торгож явдаг Линда Эверетт болохыг танив. Тэр уг нь дунд насны

эмэгтэй биш. Одоо харин тэгж харагдаж байна.

-Линда юу даа. Юу болоо вэ? Раститай ямар нэг юм болсон уу? Яасан бэ? гэж Клер дуу алддаа. Тэр цацраг туяаны тухай боджээ. Ямартаа ч хамгийн анх төрсөн санаа нь тэр байв. Дараа нь хавьгүй дор бусад санаанууд төрөв.

-Түүнийг баривчилсан.

"Монополь" тоглоом зогслоо. Оролцогчид гал тогоо ба зочдын өрөөний хоорондох хаалган дээр гарч ирсэн бөгөөд Линдагаас нүд үл салгана.

-Түүнийг маш олон хэрэгт буруутгаж ял тулгасан. Түүний дотор Бренда ба Лестер нарыг алсан хэрэгт.

-Үгүй гэж Бенни дуу алдав.

Хүүхдүүдийг эндээс гарга гэж хэлэх эсэхээ Клер бодсоноо хэлээд ч нэмэргүй гэж шийдлээ. Тэр Линдагийн ирсэн шалтгааныг ойлгож байсан ч түүнд уур хүрнэ. Растид ч бас уур хүрнэ. Яагаад гэвэл тэр хүүхдүүдийг ийм юманд татан оруулсан. Гэхдээ тэд бүтд л үүнд оролцсон л доо. Бүрхүүл дор орсон хүмүүсийн тухайд энэ бүхэнд оролцох нь сонголтоор болохгүй.

-Тэр Реннид саад болжээ. Хэргийн учир энд л байна. Том Жимийн тухай ярих үед хэн түүнтэй зам нийлэх, хэн үгүй гэдэгт л хамаг хэрэг байгаа юм. Том Жим бидний ороод байгаа аймшигт нөхцөл байдлын тухай бүр мартсан. Үгүй ээ, түүнээс ч дор. Тэр энэ байдлыг ашиглаж байна гэж Линда үргэлжлүүлэв.

Жо Линда руу нүд салгалгүй ширтэнэ.

-Хатагтай Эверетт, бид өнөө өглөө хаашаа явсныг ноён Ренни мэдэж байгаа юу? Тэр өнөөх хайрцагны тухай мэдэх үү? Тэр хайрцагны тухай мэдэх ёстой гэж би л лав бодохгүй байна.

-Ямар хайрцаг?

-Бид түүнийг Блэк-Ридж дээр олсон юм. Тэндээс гараад байгаа гэрлийг л бид харсан. Харин Расти дээшээ гарч бүтдийг нь үзсэн гэж Норри тайлбарлав.

-Энэ бол үүсгүүр. Гэхдээ Расти салгаж чадаагүй. Үүсгүүр өчүүхэн жижиг гэсэн мөртлөө өргөж чадаагүй байна лээ гэж Бенни нэмлээ.

-Би энэ тухай юу ч мэдээгүй гээд Линда мөрөө хавчив.

-Тэгвэл Ренни ч мэдэхгүй юм байна гэх үед Жо мөрөн дээрээсээ хүнд ачаа авч хаясан мэт боллоо.

-Чи яагаад тэгэж бодов?

-Яагаад гэвэл тэр биднийг байцаалгахаар цагдаа явуулах байсан. Хэрэв бид хариулахгүй бол

шоронд хийнэ.

Алсаас хоёр ч удаа тасхийх дуу гарлаа. Клер толгойгоо гижийлгээд хөмсөг зангидав.

-Энэ буун дуу юу эсвэл цаасан буу юу?

Линда мэдэхгүй байв. Тэр энэ дуунд огт санаа зовсонгүй. Яагаад гэвэл хотод дуугараагүй. Дэндүү сул сонсогдож байна.

-Хүүхдүүд ээ, Блэк-Ридж дээр юу болсон тухай яриач. Бүгдийг ярь. Та нар юу харсан ба Расти юу харсаныг. Харин орой энэ тухай бас хэдэн хүнд ярих болно. Одоо бид мэдэх бүхнээ нэгтгэх цаг болжээ. Уг нь аль хэдийн ингэх ёстой байсан юм гэж Линда хэллээ.

Клер үүнд оролцохгүй гэж хэлэхээр ам ангайснаа гаргаж хэлсэнгүй. Яагаад гэвэл түүнд сонголт байхгүй. Дээр нь бас тэр хайрцгийг хараагүй болохоор.

14

ХБЭ студи Литл-Битч-Роудаас хангалттай хол байрлах бөгөөд орцны замын урт нь (хатуу хучилттай ба гол замаас хавьгүй дээр) милийг дөрөв хуваасны нэгтэй бараг тэнцэнэ. Энэ зам хоёр ширхэг зуун наст царс модны дундуур гараад Литл-Битч-Роудтай нийлдэг. Тэдгээр царс модны намрын гоёл энэ цаг үед бол тун хурц гоёмсог байдаг бөгөөд жуулчны номны хавтсанд баймаар. Гэвч одоо бол өрөвдөлтэй харагдах бөгөөд навч нь хүрэн болж унжин хатжээ.

Энди Сандерс нэг царс модны барзгар голын ард, харин Шеф нөгөөгийн ард зогсоно. Хүнд даацын ачааны тэрэгнүүдийн дизель хөдөлгүүрийн уухилах дуу ойртохыг тэд сонсоно. Эндигийн духнаас хөлс гарч нүд рүү нь урсахад шудран арчив.

-Сандерс аа.

-Юу вэ?

-Чи бууныхаа хамгаалагчийг авсан уу? Энди шалгаж үзээд -Тийм.

-Сайн байна. Бүгдийг ганц сонсоод санаж ав. Хэрэв би бууд гэх юм бол энэ новшнуудыг тугалгаар булаарай. Дээрээс доош нь. Баруунаас зүүн тийш. Хэрэв би бууд гэхгүй бол зүгээр л зогсож бай. Ойлгов уу?

-За.

-Бид хүн ална гэж бодохгүй байна. Бурхны аврал гэж Энди бодов.

-Хэрэв зөвхөн Боуи ба ноён Тахиа ирэх юм бол бид хүн алахгүй. Гэвч би үүнд итгэлтэй биш байна. Хэрэв би эхлэх юм бол чи намайг дэмжих үү?

-Тийм гэж огтхон ч эргэлзэлгүй хариулав.

-Харин одоо гохноос хуруугаа ав. Тэгэхгүй бол өөрийнхөө толгойг авч хаях нь.

Энди доош харж хуруу нь үнэхээр гохон дээр байгааг анзаараад яаран суга татав.

Тэд хүлээж байлаа. Зүрх нь толгой дотор нь хүчтэй цохилохыг Энди чагнав. Айх нь тэнэг хэрэг гэж өөртөө хэллээ. Хэрэв тэр нэг удаа азтайгаар утас дугараагүй бол үхчихсэн байх байсан. Гэвч энэ бодол одоо түүнд тусалсангүй. Яагаад гэвэл түүний өмнө шинэ ертөнц нээгджээ. Энэ хуурамч ертөнц гэдгийг Энди ойлгож байв. (Андреа хар тамхинаас болоод яасныг тэр харж байсан). Гэвч одоо тэдний амьдарч байгаа баасны ертөнцөөс хавьгүй дээр.

Бурхан минь тэд яваад өгөөсэй гэж тэр залбирна.

Ачааны тэрэгнүүд гарч ирлээ. Өдрийн үлдсэн бүрэнхий рүү хар утаа багшируулан цацаж удаан явна. Энди модны цаанаас шагайвал эхний машины кабинд хоёр эр харагдав. Ах дүү Боуи бололтой.

Шеф удтал хөдөлгөөнгүй зогслоо. Энди түүнийг бодлоо өөрчилсөн юм байх гэж шийдэв. Тэгсэн бол ирсэн хүмүүс хийгээ авч болно гэсэн үг. Гэтэл Шеф модны араас гарч ирээд хоёр удаа бууддаа.

Шеф хар тамхи татсан эсэхийг мэдэхгүй ч тун мэргэн буудав. Эхний ачааны тэрэгний урд хоёр дугуй нь хагарав. Радиаторын хаалт тор гурваас дөрвөн удаа дээшээ доошоо савснаа тэрэг зогсов. Араас нь явсан тэрэг түүнийг бараг мөргөх шахлаа. Эндигийн чихийг хөгжим дэлсэв. Хоёр дахь тэрэгний жолоон дээр сууж яваа хүн хөгжим чанга тавьснаас буун дууг сонсоогүй юм байна гэж Энди таалаа. Эхний тэрэгний кабин хоосон мэт болов. Хоёр эр хялбар бай болохгүйн тулд тонгойжээ.

Вааглах мэлхийн зурагтай унтлагын өмд өмсөж хөл нүцгэн явах Шеф Буши өнгөрсөн удаагийнх шиг царс модны ард нуугдаад байсангүй. (гараашийн удирдлага бүснээс нь санжиганана).

-Стюарт Боуи. Ферн Боуи. Кабинаас гарч надтай ярь гэж хашгираад тэр "бурхны дайчин"-аа царс мод түшүүлэн тавив.

Эхний тэрэгнээс хэн ч гарсангүй. Хоёр дахь тэрэгний хаалга онгойж Рожер Кильян газарт үсрэн буулаа.

-Яагаад зогсчихвоо? Би түргэн харьж тахиагаа хооллох ёстой гэж тэр хашгирав. Тэгээд Шефийг олж харлаа.

-Фил сайн уу? Юу болоо вэ?

-Хэвт. Энэ галзуурсан жингэрийн хүү буудаад байна гэж Боуи бахирав.

Рожер эхлээд Шефийг, дараа нь царс мод түшүүлэн тавьсан АК-47 бууг харав.

-Буудсан байж болно. Гэвч одоо бол буу газарт байна. Тэгээд ч энд тэр ганцаараа байна. Фил

юу болоо вэ?

-Би одоо Шеф. Намайг Шеф гэж дууд.

-Тэгье Шеф ээ. Ямар асуудал байна?

-Стюарт гараад ир. Ферн чи ч бас хэнд ч аюулгүй гэж Шеф хашгирлаа. Эхний тэрэгний хаалганууд нээгдэхэд Шеф эргэж харалгүйгээр заавар өгөв.

-Сандерс энэ хоёр тэнэгийн нэг нь буутай гарч ирэх юм бол шууд бууд, нэг сумаар биш шүү. Тэднийг швейцарь бяслаг шиг болтол нь сийч.

Гэвч ах дүү Боуи зэвсэггүй бууж ирлээ. Тэр бүү хэл Ферн гараа өргөсөн байв.

-Найз минь чи хэнтэй яриад байгаа юм бэ? гэж Стюарт асуув.

-Сандерс гараад ир гэж Шеф тушаалаа.

Энди гарч ирэв. Одоо шууд тулааны аюул үгүй болсон тул энэ бүхэн түүнд таалагдаж эхэлжээ. Хэрэв тэр Шефийн шармалуудаас нэгийг аваад ирэх ухаан төрсөн бол бүр ч их таалагдах байв.

-Энди юу даа? Чи энд юу хийж байгаа юм бэ? гэж Стюарт гайхав.

-Би Христийн дайчинд бүртгүүлсэн. Та нар бол гашуун хүмүүс. Бид та нарын тухай бүхнийг мэднэ. Энэ та нарын байх газар биш.

-Юу гэнэ ээ? гээд Ферн гараа буулгав. Том тэрэгний урд хэсэг дугуйн хий гарч дуусахын хэрээр газар руу аажим татагдана.

-Сайхан хэллээ Сандерс гэж Шеф түүнийг магтав. Дараа нь Стюартад хандаад: -Та нар бүгд хоёр дахь машины кабинд сууж болно. Машинаа эргүүлээд эндээс тонил. Хот хүрэнгүүтээ тэр чөтгөрийн хүүд ХБЭ одоо биднийх гэж хэл. Лаборатори ба нөөц ч биднийх.

-Фил чи юу донгосоод байгаа юм бэ?

-Шеф гээрэй.

Стюарт ууртай гараа савлаа.

-Өөрийгөө хүссэнээрээ нэрлэ. Гэхдээ энэ бүхэн юу болоод байгааг надад хэлээд өг.

-Би чиний дүүг тэнэг гэдгийг мэднэ. Бас ноён Тахиа зааваргүйгээр гутлаа үдэж ч чадахгүй байх...

-Хүүе хэлээ татаарай гэж Рожер уурсав.

Энди буугаа өргөлөө. Хэрэв боломж гарах юм бол бууны бөгсөн дээр "Клодетт" гэж сийлнэ гэж бодов.

-Үгүй пгүү. Чи харин амаа тат.

Рожер хувхай цайгаад алхам ухарлаа. Энди хотын хурал дээр үт хэлэхэд ийм юм болж байгаагүй учраас хотын захиргааны нэгдүтээр гишүүнд энэ бүхэн тун таалагдав.

Шеф яриаг нь хэн ч таслаагүй юм шиг үргэлжлүүлнэ.

-Гэвч Стюарт чамд тал толгой тархи бий байх. Тиймээс түүнийг зориулалтаар нь ашигла. Эхний тэргийг одоо байгаа газарт нь орхиод хоёр дахь тэргэнд сууж хот руу буц. Реннид хэлээрэй. Одоо энд түүний гэх юм байхгүй. Энд байгаа бүх юм бурхных. Бас Агь од гэрэлтсэн гэж хэл. Хэрэв тэр ертөнцийн сүйрэл хэт эрт ирэхийг хүсэхгүй бол тайван бай гээрэй гээд Шеф хэсэг дуугүй болсноо нэмж: -Бид урьдын адил хөгжмөө дамжуулсаар байх болно гэж хэл. Энэ түүний санааг зовоохгүй гэдэгт би эргэлзэхгүй байна. Гэвч хотын зарим иргэдэд ийм хөгжим таалагддаг нь гарцаагүй.

-Түүнд одоо хичнээн цагдаа байгааг чи мэдэх үү? гэж Стюарт асуулаа.

-Би наадахийг чинь нулимаж хаяна.

-Гуч гаруй гэж би бодож байна. Маргааш гэхэд тавь болно. Бас хотын тэн хагас нь түүнийг дэмжиж, тэр нэг чөтгөрийн цэнхэр уяа зүүдэг болсон. Хэрэв тэр чиний учрыг ол гэж тэдэнд тушаах юм бол хүндрэл үүсэхгүй байх.

-Энэ түүнд тус болохгүй. Бид бурханд итгэдэг. Энэ итгэл бидний хүчийг арав дахин нэмдэг.

-Тэглээ гээд хорь л болох юм байна шүү дээ гэж Рожер математикийн чадвараа үзүүлэв. - Тэгсэн ч цагдаа нар олон юм байна.

-Рожер амаа тат гэж Ферн тасаллаа. Стюарт дахин нэг оролдлого хийв.

-Фил... Үгүй би Шеф гэх гэсэн юм. Чи ухаан орох хэрэгтэй байна. Яагаад гэвэл энэ тоглоом биш шүү. Бидэнд хар тамхи хэрэггүй. Зөвхөн хий хэрэгтэй. Хотын цахилгаан үүсгүүрийн тал нь ажиллахгүй байна. Долоо хоногийн сүүлээр дөрөвний гурав нь амьсгаа хураана. Бидэнд хий авахыг зөвшөөрөөч.

-Надад юмаа бэлдэхэд хий хэрэгтэй. Уучлаарай.

Стюарт Шеф рүү яг галзуу хүн харж байгаа юм шиг харна. "Тэр үнэхээр солиорсон байх. Бид хоёулаа солиорчээ. Гэхдээ Жим Ренни ч бас солиотой. Тэгэхээр бид бүгд нэг л модны жимснүүд гэж Энди бодов.

-Одоо явцгаа. Тэгээд Реннид дамжуулаарай. Хэрэв тэр цагдаа илгээх гэж оролдвол гашуунаар харамсах болно гэж Шеф яриаг дуусгав.

Стюарт бодсоноо дараа нь мөрөө хавчаад:

-Үнэнийг хэлэхэд надад хамаагүй л дээ. Ферн, Рожер явцгаая. Би жолоо барина.

-Би дэмжиж байна. Араа солихыг үзэн яддаг гэж Рожер мөн мөрөө хавчин хэлсэнээ Шеф Энди хоёр руу итгэлгүй харц чулуудаад хоёр дахь тэргийг чиглэв.

-Залуус аа та нарыг бурхан ивээг гэж Энди араас нь хашгирав.

Стюарт мөрөн дээгүүрээ баргар харц түүн рүү чулуудаад:

-Бурхан чамайг ч бас ивээг. Яагаад гэвэл чамд түүний ивээл шаардагдах болно гэдгийг бурхан өөрөө гэрчилнэ.

Умард Америкийн мет үйлдвэрлэлийн хамгийн том лабораторийн шинэхэн эзэд бөөр нийлүүлэн зогсоод ягаан ачааны тэрэг хэрхэн зам руу ухран гарч дараа нь болхидуу эргэлт хийгээд явж одохыг харна.

-Сандерс.

-Юу гэв Шеф ээ?

-Би арай цоглог хөгжим хүсч байна. Энэ хотод Мейвис

Стэплс (америкийн нэрт дуучин, иргэний эрхийн төлөө тэмцэгч) юмуу "Эгч дүү Кларк" (орчин цагийн америкийн хөгжмийн хамтлаг) хэрэгтэй. Би хөтөлбөр бэлдсэний дараа хоёулаа тамхиа татъя. Эндигийн нүдэнд нулимс цийлэгнэв. Тэр одоо Шеф болсон Фил Бушигийн ясан мөрөөр тэврээд цээжиндээ наалаа.

-Шеф би чамд хайртай.

-Баярлалаа Сандерс.

-Би ч чамд хайртай. Гэхдээ автоматаа цэнэгтэй байлгахаа бүү март. Энэ мөчөөс эхлээд бид харуулд гарах болно.

Нар жаргахын алдад өдөр ягаан өнгөөр будагдах тэр мөчид Том Жим хүүтийнхээ орны дэргэд сууж байлаа. Жижгээд тариа хийхээр Дуги тасагт орж ирэв. Одоо Жижгээ бөх унтаж байна. Хэрэв Жижгээ үхэх юм бол түүний амьдрал олон талаар хөнгөрнө гэдгийг Том Жим ойлгож байлаа. Амьд, тэр тусмаа тархин дээр нь хорт хавдар дарах хүү... Тэр ер нь юу хэлж, юу хийхийг хэн ч үл мэднэ. Мэдээж жаалхүү түүний мах цусны тасархай. Гэвч энэ мөчид бол эцгийн хайр гэхээс илүү хотын эрх ашиг түрэн гарч ирнэ. Ханын нгүүгээнд байгаа нөөц дэрнүүдийн нэг энэ асуудлыг шийдэж мэдэх л байх...

Яг энэ үед гар утас дуугарлаа. Том Жим дэлгэц дээр гарсан дугаарыг хараад хөмсөг зангидав.

Ямар нэг юм биш болж дээ. Тэгээгүй бол Стюарт ийм хурдан залгахгүй байсан.

-Юу гэнэ ээ? гээд тэр улам гайхан сонсов. Энди тэнд байна гэнэ үү? Энди автоматтай юу?

Стюарт хариу хүлээнэ. Юу хийхийг хэлж өгөхийг хүлээнэ. "Харин надад хэн хэлж өгөх билээ дээ" гэж Том Жим бодоод санаа алдав. -Жаахан хүлээ. Энэ тохиолдолд бодох хэрэгтэй. Би чам руу утасдана.

Тэр утсаа таслаад шинэ асуудал дээр анхаарал төвлөрүүлээ. Ренни өнөө орой тийшээ цагдаа нарыг илгээж чадна. Тийм ч муу санаа биш. "Хүнсний ертөнц"-д жаахан эргэлдүүлж байгаад дараа нь тулалдаанд хаяна. Эндиг аллаа гэхэд тэр гашуудахгүй. Энэ тохиолдолд Жеймс Ренни хотын захиргааг толгойлох болно.

Гэтэл маргааш орой хотын бүх нийтийн шуурхай хуралдаан зарласан байгаа. Бүгд ирж асуулт тавих болно. Тэр мет үйлдвэрлэлийн лабораторийг Барбара ба түүний нөхөд рүү тохож чадна гэдэгтээ эргэлзэхгүй байв. (Том Жимийн толгойд Энни Сандерс аль хэдийн хотын удирдлага дахь Барбарагийн найз болчихсон). Гэвч арай болохгүй юм байна. Үгүй. Үгүй.

Хонин сүрэг айх ёстой болохоос биш сандарч гүйлдэх ёсгүй. Сандралдаан хотод бүрэн хяналтаа тогтоох түүний зорилгод нийцэхгүй. Хэрэв Энди Буши хоёр одоо байгаа газартаа хэсэг байлаа гэхэд муу нь юу байна вэ? Харин ч эсрэгээр сайн талууд бий. Тэд өөртөө итгэлтэй болно. Тэд өөрсдийг нь мартсан гэж бодно. Яагаад гэвэл хар тамхинд тэнэглэлийн аминдэм дүүрэн байдаг.

Нөгөө талаас баасан гаригт энэ муу шалчгар уулзалтын өдрөөр зарласан. Бүгд Динсморын талбай руу зүтгэнэ. Берпи хот-догийн худалдаа зохион байгуулна. Тэгээд энэ булингар үргэлжилж байх хооронд, Кокс ганцаараа хэвлэлийн бага хурлаа явуулж байх хооронд, Том Жим 16-18 цагдаа дагуулан радио станц дээр очоод мет татсан хоёр үймээнчийг устгах болно.

Тийм ээ. Энэ бол хайж байсан хариулт. Тэр Стюарт руу утасдаж өөрийнхөө ажлыг хий гэв. - Гэхдээ би чамайг хийх хэрэгтэй гэж бодсон гэж Стюарт үтлэлээ.

-Бид түүнийг олно. Харин чи хүсэх юм бол тэр хоёртой тооцоо хийхэд тусалж болно.

-Би хүсэх болно. Итгэлтэй байгаарай. Том Жим уучлаарай. Гэхдээ энэ муу жингэрийн хүү Бушийг байранд нь тавих хэрэгтэй.

-Бид тавих болно. Баасан гаригийн өдөр. Энэ үеэр юу ч битгий хийгээрэй.

Том Жим дахиад л бие нь гайхалтай сайжрав. Зүрх нь ямар нэг зогсолт ба бульгалтгүйгээр жигд амгалан цохилно. Баяр төрүүлнэ. Яагаад гэвэл "Хүнсний ертөнц"-д цагдаа нарын өмнө үг хэлэхээс эхлээд хийх ажил асар их байлаа. "Хүнсний ертөнц" бол шинэхэн цагдаа нарт эмх журмыг хүндэтгэх ухаан суулгахад яг тохирох газар. Тийм ээ, үнэхээр үймээн болсон газар нь хүмүүсийг удирдагчийнхаа араас дагахад дээд зэргээр өдөөдөг.

Тэр хаалга руу хөдөлсөнөө буцаж эргэж ирээдунтаж байгаа хүүгийнхээ хацар дээр үнсэв. Ямар ч гэсэн Жижгээгээс салах шаардлагатай. Гэвч одоохондоо хүлээж болно.

16

Честерс-Миллийг дахин нэг шөнө нөмөрлөө. Бүрхүүл дор дахин нэг шөнө ирэв. Гэвч бидэнд амрах цаг байхгүй ба гарах ч үгүй. Бид хоёр хурал дээр очих ёстойгоос гадна Горасыг унтахаас нь өмнө салхилуулах ёстой. Горас энэ үдшийг Андреатай хамт өнгөрөөж байгаа бөгөөд оновчтой цагийг сонгон хүлээж байв. Тэр буйдан ба хананы хооронд унасан попкорныг мартаагүй.

Тийм учраас та бид хоёр сэрүүн байх хэрэгтэй. Оройн бүрэнхий тэнгэрээр тэлж, нойрсуулах эм үнэртсэн өвчтөн ширээн дээр хэвтэх ишг л тэндээ налайх болно. Толгой дээр өөр өнгөтэй болсон одод гарч ирэх хүртэл сэрүүн байцгаая. Энэ орой зөвхөн Честерс-Миллд одод түгсэн юм биш. Умард Шинэ Английн дөрвөн муж улсад бороо орж, үзэгчид тун удахгүй хиймэл дагуулаас авсан гайхалтай зургийг харах болно. Үүлэнд Честерс-Миллийн оймс шиг хэлбэрийг яг давтсан нүх үүссэнийг харах болно. Энд одод гялалзаж байна. Гэхдээ энэ бол бохир одод. Яагаад гэвэл Бүрхүүл өөрөө бохир.

Таркерс-Миллс ба Касл-Рок дээр хүчтэй аадар буулаа. Си-Эн-Эн-ийн цаг уур тайлбарлагч Рейнольдс Вольф (Роуз Твитчелийн пгүгдэг Вольфитай хамаагүй) баруунаас зүүн тийш хөдөлсөн агаарын урсгал нь үүлийг Бүрхүүлийн баруун талд шахсанаар үүлс умард юмуу өмнө зүгт тарж одохоос өмнө хөөсөнцөрөөс ус шахдаг шиг шахагдаж байгаа тухай тэр ярьсан ба гэхдээ бүрэн итгэлтэй биш гэж нэмж тайлбарлав. Тэр үүнийг "Гайхалтай онцгой үзэгдэл" гэж нэрлэв. Хөтлөгч Сюзанн түүнээс хямрал удааширах аваас Бүрхүүл дорх цаг агаарын урт хугацааны төлөв байдлын тухай асуулаа. Вольф түүнд хариулж байна.

-Энэ их сайхан асуулт байна. Гэхдээ бид ганцхан зүйлийг л тодорхой мэднэ. Хэдийгээр бороо хүчтэй орох юм бол тэр хэсгээрээ чийг нэвтэрч болохоор Бүрхүүл хангалттай нэвтрүүлэх чадвартай боловч өнөө орой Честерс-Миллд бороо орохгүй гэдгийг л хэлж чадна. Агаар мандал ба далай тэнгисийн цаг уурын үндэсний газраас бидэнд мэдээлэхдээ Бүрхүүл дор тунадас унах тал дээр урт хугацааны таамаглал сэтгэл амраахааргүй байгаа гэсэн. Бас тус хотын усны гол судас болох Престил-Стрим гол бараг хатсан. Газар доорх усны суваг байдагт бурханд талархая гээд тэр гайхалтай пгүдээ харуулан инээв.

-Тийм шүү гээд Сюзанн толгой дохив. Дараа нь Америкийн дэлгэц дээр геккон Гейко гарч ирлээ. (автомашинь даатгалын зах зээл дэр амжилттай ажилладаг компанийн сурталчилгаа).

Гэвч кабелийн сувгийн мэдээний талаар ярьж боллоо. Бид Конго сүм ба уулзалт эхлээгүй байгаа Пайперийн гэрийн дэргэдүүр бараг хоосон гудамжнууд дээгүүр нисье. (Пайпер аль хэдийн ус тавьж кофе цацсан бөгөөд харин Жулия шажигнах коулманы чийдэнгийн гэрэлд сэндвич огтолж байв). Цагдаагийн шар туузаар хүрээлэгдсэн Маккейны гэрийн хажуугаар гарч толгойг уруудан хотын талбайн хажуугаар цэвэрлэгч Эл ба түүний хоёр найз маргааш зарлагдсан хотын бүх нийтийн хуралд бэлтгэн шал шүүрдэж тавилгын тоос арчиж байгаа хотын захиргааны байшингийн дэргэдүүр өнгөрч, Люсьен Кэлвертийн хөшөө сүндэрлэх цэргийн дурсгалын талбайн хажуугаар өнгөрцгөөе. (Норригийн өвөг дээдэс. Гэвч би энэ

тухай хэлэхгүй байж болох л байсан).

Гэхдээ Барби Расти хоёр ямархуу байгааг харахаар зогсоцгооё тэгэх үү? Доошоо буухад асуудал байхгүй. Жижүүрийн хэсэгт ердөө гурван цагдаа байсны ахлагч нь болох Стейси гараа дэрлээд ширээн дээрээ унтаж байна. Цагдаагийн тасгийн бие бүрэлдэхүүний үлдсэн хэсэг нь "Хүнсний ертөнц"-д Том Жимийн бадрангуй яриаг сонсож байна. Гэхдээ хэрэв тэд бүгдээрээ энд байлаа ч гэсэн хамаагүй. Яагаад гэвэл бид нүдэнд үл үзэгдэнэ. Бид дэргэдүүр нь өнгөрөхөд цагдаа нар салхи зөөлөн сэржигнэхээс өөр юу ч мэдрэхгүй.

Тахианы-саравчинд олон юм харж чадахгүй. Яагаад гэвэл найдвар бол яг бидэн шиг үл үзэгдэгч. Хоёр эрд маргааш оройг хүлээж бүх юм төлөвлөгөөний дагуу болно гэж найдахаас өөр юу ч үлдсэнгүй. Растигийн гар өвдөнө. Гэхдээ түүний санасан шиг хүчтэй биш. Бас хавдар ч түүний айсан шиг том биш. Тэгээд ч Стейси таван цагийн үед доошоо бууж чадаад түүнд өвчин намдаах эм шургуулж амжсан. Түүний сайхан сэтгэлийг бурхан ивээг.

Бидний баатар болох энэ хоёр эр хэсэг хугацаанд ханзан дээрээ суугаад "Хорин асуулт"-аар наадав. Одоо Растигийн таах ээлж.

-Амьтан, ургамал юмуу эрдэс гэж тэр асуув. -Тийм юу ч байхгүй.

-Юу юу ч байхгүй гэж. Тэдний нэг нь байх ёстой. -Байхгүй гэж Барби хариулав. Тэр Пап Смурфын тухай бодлоо. (энэ нь хүүхэлдэйн цуврал киноны баатар одой) -Чи намайг хуураад байна уу? -Үгүй.

-Өөрөөр байж болохгүй.

-Маргалдахаа болиод асуултаа тавь.

-Ядаж дөхүүлэхгүй юм уу?

-Үгүй. Энэ чиний анхны "үгүй". 19 үлдлээ.

-Жаахан хүлээгээч дээ. Шударга биш байна.

Бид тэднийг дараагийн хорин дөрвөн цагаа хүлээхээр үлдээе. Өөр яах ч арга алга тийм биз дээ. Урьд нь "Ардчилал" сонины редакци байрлаж байгаад одоо овоолгоостой үнс болсон газрын хажуугаар өнгөрье. (харамсалтай нь энэ сонин одоо гутлыг санагдуулах бяцхан хотод үйлчлэхээ больжээ) Бас "Сандерсын хотын эмийн сан дэлгүүр"-ийн хажуугаар өнгөрье. (хэдийгээр Сандерс дахин орохгүй боловч бага зэрэг утагдахаас өөрөөр хохироогүй) Бас Ма180п (1e8 Иеигз номын дэлгүүр ба бүх цэцэг нь гандаж гундсан Леклерийн дэлгүүрийн хажуугаар өнгөрцгөөе. Төв гудамж 117 ба 119-р зам болон салаалдаг уулзварын дэргэдэх, ажиллахаа больсон гэрлэн дохионы доогуур нисэцгээе. (бид түүнийг жаахан шүргэхэд тэр ганхаж байна. Гэвч удахгүй болино) "Хүнсний ертөнц"-ийн машины зогсоолыг дайран гаръя. Бид яг л унтаж байгаа хүүхдийн амьсгал шиг чимээгүй.

Хэдийгээр шалан дээрх ихэнхи толбыг Жек ба Эрни нар зүлгэж арчсан ч Хүнсний ертөнц

тарааж цацсан хүнс ба зад татсан хайрцагнууд хөглөрсөн үзэмжгүй газар болон хувирсан бөгөөд дэлгүүрийн ихэнхи шилэн хоргыг Тэббигийн мод зүсэх газраас авчирсан далбагар хавтангуудаар таглажээ. Зарим нэг хүнс (янз бүрийн зоорь руу зөөгөөгүй юмуу цагдаагийн газрын арын гараашт аваачиж хураагагүй) тавиур дээр үлдсэн байна. Зайдас бэлддэг хөлдөөгч, шар айраг ба хийжүүлсэн ундааны сав зэрэг хагарчээ. Асгарсан дарсны үнэр ханхлана. Үймээн самуунаас үлдсэн энэ эмх замбараагүй байдлыг шинэ цагдаа нар хараасай гэж Том Жим хүссэн юм. Тэдгээр нь ихэнхидээ цэл залуу цагдаа нар байлаа. Бүх хот ийм харагдаж мэднэ гэж ойлгуулахыг тэр хичээнэ. Гэхдээ чихэнд нь энэ тухай ярих хэрэггүй гэдгийг мэдэхээр ухаалаг хүн Ренни. Тэд тэртэй тэргүй гол санааг ойлгоно. Хэрэв малчин хяналтаа сулруулж сүрэг мал сандралд автах юм бол ийм юм болдог гэдгийг ойлгуулна.

Бид түүний яриаг сонсох хэрэгтэй юу? Үгүй. Бид Том Жимийг маргааш орой сонсоно. Бидэнд бүрэн хангалттай. Тэгээд ч бид түүний юу ярихыг мэднэ. Америк улс рокн-ролл ба хуурамч сүржигнэлээр алдартай. Бид тэдний аль алийг нь сонсож ханасан хүмүүс.

Гэвч явахын өмнө сонсогчдыш царайг нэг харах хэрэгтэй. Тэд хичнээн бахархсан харцаар харж байгааг тэмдэглэх ёстой. Дараа нь одоогийн цагдаа нарын олонхи нь (Картер Тибодо, Микки Уэрдлоу, Тодд Уэндлстет гээд зөвхөн гурвыг нэрлэе) хичээл дээр сахилгүйтсэн юмуу ариун цэврийн өрөөнд зодолдсон хэргээр хичээлийн дараа ангид үлдэх шийтгэл амсалгүйгээр долоо ч хонох чадваргүй залуус. Гэвч тэд Реннигээр ховсдуулжээ. Ренни хүнтэй нүүр тулан уулзах үедээ онцгой сэтгэгдэл төрүүлж чаддаггүй боловч цугларсан олны өмнө үг хэлэхдээ тэднийг хөөргөж дөнгөдөг. Тархиных нь багахан хэсэг ажиллагаатай байх үедээ Клайтон Бресси ингэж хэлсэн юм. Том Жим тэдэнд нарийн цэнхэр шугамын тухай, та бүхний өмнө үг хэлж байгаадаа бахархаж байгаа тухай, болон хот та нарт л найдаж байгаа тухай ярина. Өөр юм ч ярина. Хэзээ ч өөрийн дур булаам чадварыг алддаггүй зөв үгсийг хэлнэ.

-Том Жим Барби руу хазайв. Барбигийн найз нөхөд урьдын адил энд байгаа бөгөөд бохир зорилгодоо хүрэхийн тулд үймээн самуун, сандрал дэгдээж байна гэж яриу. Дуугаа намсгаад нэмж хэлсэн нь:

-Тэд намайг шившиглэх гэж оролдож байна. Ичих зовох юмгүйгээр худал ярихад бэлэн байна гэлээ.

Сонсогчдын дунд дургүйцсэн шивнээн өнгөрөв.

-Та нар тэдний хуурамч яриаг сонсов уу? Намайг шившиглэхийг нь зөвшөөрөх үү? Хамгийн том гай нөмөрсөн мэт хотыг хүчтэй удирдагчгүй үлдэхэд хүргэх үү?

Хариулт нь мэдээж чих дөжрөм

-Үгүй.

Хэдийгээр Том Жим ярьсаар байгаа боловч (тэр олонхи улс төрчдийн адил будаан дээр тос хичнээн хийсэн ч муудахгүй гэдэгт итгэлтэй) бид түүнийг орхиё.

Хоосон гудамжаар нисч Конго сумын номлогчийн гэрт очъё. Хүүе хараач. Бидний өмнө хуучирсан жинсэн өмд ба скэйтчдийн хуучин сургалтын бэлэг тэмдэг болсон

"Далавчтай Риппер" гэсэн бичиг бүхий цамц өмссөн 13 настай охин зогсож байна. Ээжийгээ цөхрөлд оруулдаг Норригийн өнөөх мятаршгүй царай төрх одоо огт үгүй болжээ. Түүний оронд гайхал тодрох бөгөөд үүний ачаар тэр саяхан дайраад өнгөрсөн найман настай үеийн охин шигээ болж хувирсан байв. Түүний харцыг дагуулан харвал хотын дорно зүгт үүлсээс хөөрч байгаа бүтэн сарыг харна. Өнгө ба дүрсээрээ тэр дөнгөж сая хиртсэн ягаан жүржнээс ялгагдах юмгүй.

-Бурхан минь гэж Норри шивнэв. Тэр зангидсан гараа дөнгөж урагш түрж буй цээжин дээрх хоёр бөмбөгөрийн дунд тавиад энэ ягаан зэрэмдэгийг харж байлаа. Дараа нь цаашаа явав. Гэхдээ хойноо сүүл үлдээж болохгүй гэдгээ санан үе үе явсан замаа эргэж харахтайгаа байв. Линдагийн тушаал ийм байсан. Ганцаараа ирээд, хэний ч анхаарлыг үл татах бөгөөд хойноос хэн ч дагаагүйг шалгах ёстой.

-Энэ бол тоглоом биш шүү гэж Линда сануулсан. Норрид түүний үг нь биш харин түгшүүртэй цонхигор царай нь их сэтгэгдэл төрүүлсэн.

-Хэрэв тэд биднийг барих юм бол бидний нүдний шилийг авахуулах юмуу тоглоомын нүүдэл алгасахад хүргэхээр зогсохгүй шүү. Та нар үүнийг ойлгож байна уу?

-Би Жо-той хамт явж болох уу? гэж Линда шиг цонхийсон Клер асуув.

Тэр толгой сэгсэрлээ.

-Муу санаа.

Яг энэ үе Норригийн сэтгэгдлийг бүхнээс илүү хөдөлгөсөн юм. Үгүй. Энэ тоглоом биш. Энд амьдрал үхэл шийдэгдэнэ.

Гэвч бид сүмийн дэргэд аль хэдийн иржээ. Ар талд жаахан баруун тийшээ номлогчийн гэр байна. Гал тогооны цонхоор асч байгаа бололтой Коулманы чийдэнгийн хурц цагаан гэрлийг Норри харав. Удалгүй Норри дээвэр дор шургаж энэ аймшигтай ягаан сарны харцнаас нуугдана. Тэр удахгүй аюулгүй болно.

Илүү өтгөн сүүдрээс нэгэн сүүдэр гулсан гарч ирээд гарнаас нь барих хүртэл охин ингэж бодсон.

Энэ халдалт Норриг аймаар цочоосон тул тэр хашгирч ч чадсангүй. Тэр нь сайн болжээ. Дөхөж ирсэн хүний царайг ягаан сар гэрэлтүүлэхэд Ромео Берпи болохыг охин олж харав.

-Та намайг үхтэл айлгалаа гэж охин шивнэлээ. -Уучлаарай би хэн явж байгааг л харах гэсэн юм. Найз залуус чинь хааччихаа вэ? гэж Ромми эргэн тойрноо харав. Норри инээмсэглээд:

-Мэдэхгүй. Бид нэг нэгээрээ, өөр өөр замаар ирэх ёстой. Линда тэгж хэлсэн гээд толгойн бэл рүү харсанаа: -Жо-гийн ээж ирж явах шиг байна. Бид дотогш орсон нь дээр.

Тэд чийдэнгийн гэрлийг чиглэн явлаа. Пайперийн гэрийн хаалга түгжээгүй байлаа. Гэсэн хэдий ч Ромми аяархан тогшив.

-Ромми Берпи найз охины хамт. Хэрэв нууц үг хэрэгтэй бол бид мэднэ.

Пайпер хаалгаа нээж тэднийг гэрт оруулав. Норри руу сониучхан харна. -Чи хэн бэ?

-Хэрэв энэ миний ач охин биш бол намайг чөтгөр аваг гэсээр Эрни өрөөнд орж ирэв. Тэр гартаа нимбэгтэй устай шилэн аяга бариад инээмсэглэж байв. Охин минь нааш ир.

Норри ээжийнхээ захиснаар өвөөгөө чанга тэврэн үнсэв. Тэр ээжийнхээ захиасыг ийм хурдан биелүүлчихнэ гэж санаагүй ч ихэд баярлалаа. Тэгээд ч тэр өвөөдөө үнэнийг хэлж чадахаар болов. Хэрэв өөр хүмүүсийн дэргэд бол түүнийг тамласан ч энэ үг уруул дээрээс нь нисэхгүй байсан.

-Өвөө, би маш их айж байна.

-Бид бүгд айж байгаа гээд өвөө нь охиноо биедээ улам чанга нааж царай руу нь хараад: -Чиний энд юу хийж байгааг би мэдэхгүй. Нэгэнт ирсэн хойно нимбэгтэй ус уувал ямар вэ?

Норри кофе чанагч руу харав.

-Би кофег илүүд үзнэ.

-Би ч бас гээд Пайпер санаа алдав. -Цахилгаан байхгүйг санахаасаа өмнө ус хийгээд кофе цацчихсан гээд тэр толгойгоо юмнаас салгах мэт сэгсрэв. -Бүрхүүл тал бүрээс хашиж байна.

Дахин хаалга цохиж хацар нь улайсан Лисса орж ирэв.

-Гэлэнмаа, би танай гараашт унадаг дугуйгаа тавьчихлаа. Та дургүйцэхгүй биз дээ?

-Огт үгүй. Бид бүгд гэмт хэргийн хуйвалдааны оролцогчид хойно доо. Ренни ба Рэндолф нар бидний үйлсийг ямар ч эргэлзээгүй ингэж нэрлэх байсан. Намайг зүгээр л Пайпер гэж дуудаарай. Бид бүгд бие биетэйгээ чи гэж харьцах болно.

Бүгд эрт цугласан учраас 10 цаг дөнгөж болоход Пайпер өөрсдийн нэрлэснээр Честерс-Миллийн хувьсгалт хорооны хурал нээснийг мэдэгдэв. Хамгийн эхлээд юу гайхал төрүүлсэн гэвэл хорооны бүрэлдэхүүн байлаа. Найман эмэгтэй ба дөрвөн эрэгтэй. Тэдгээрийн нэг нь тэтгэврийн хөгшин бөгөөд хоёр нь эцэг эхийн хамт биш бол кино театрт нэмэх 18 ангиллын кинонд нэвтрүүлэхээргүй хүүхдүүд. Тиймээс Пайпер дэлхий даяар хэдэн зуун партизаны армид одоо түүний гэрт байгаагаас хамаагүй бага насны хүүхдүүд болоод эмэгтэйчүүдэд буу тарааж өгдөг тухай сануулахад хүрэв. Мэдээж энэ буруу. Гэвч заримдаа дүрэм журам ба

зайлшгүй шаардлага хоёр сөргөлдөх нь бий.

-Бид бүгд нэг минутын турш толгой бөхийлгөхийг би хүсч байна. Би залбирах бодолгүй байна. Яагаад гэвэл үүнийг хийх үедээ хэнтэй ярьж байгаадаа итгэлтэй биш болсон. Гэвч та нар өөрсдийн итгэдэг бурханд үг хэлэхийг хүсч мэднэ. Яагаад гэвэл өнөөдөр бидэнд авч болох бүх тусламж хэрэг болно гэж Пайпер яриагаа эхэллээ.

Тэд тэгж хийцгээв. Зарим нь нүдээ аньж толгойгоо унжуулсан хэвээр сууна. Пайпер толгойгоо өргөж дөнгөж сая ажлаас халагдсан хоёр эмэгтэй цагдаа, тэтгэвэрт гарсан хүнсний дэлгүүрийн эрхлэгч, сонингүй үлдсэн эзэн, номын санч, рестораны эзэгтэй, гартаа хуримын бөгжөө тасралтгүй эргэлдүүлэх Бүрхүүлийн бэлэвсэн эмэгтэй, нутгийн их дэлгүүрийн эзэн ба бие биендээ наалдан төв царайлан буйдан дээр суух гурван жаалыг тойруулан харав.

-За боллоо. Аминь. Би одоо хурал удирдах ажлыг юу хийж байгаагаа сайн мэдэх Жеккид шилжүүлье.

-Энэ бүхэн хэтэрхий өөдрөг байж мэднэ. Бүр яарсан ч байж болно. Яагаад гэвэл би Жо Макклетчид үг хэлэх эрх өгч байна гэж Жекки тэмдэглэв.

Жо түүн рүү гайхан бүлтийлээ.

-Надад уу?

-Гэвч тэр ярьж эхлэхээс өмнө би түүний найз нарыг эргүүлд гараасай гэж хүсэх байна. Норри байшингийн урд, Бенни хашаанд гэж Жекки үргэлжлүүлэв. Царай төрхөөр нь тэд одоо эсэргүүцэх гэж байгааг ойлгоод таслахын тулд гараа өргөн: -Энэ бол та нарыг өрөөнөөс гаргах шалтаг биш. Та бүхэнд чухал ажил даалгаж байна. Хэрэв биднийг энд барих юм бол бүх юм эмгэнэлтэйгээр эргэнэ гэдгийг та нарт ярих хэрэггүй гэж би бодож байна. Та хоёр хамгийн бага нь шүү дээ. Харанхуй газар олоод нуугд. Хэрэв хэн нэгэн сэжигтэй хүнийг харах юмуу эсвэл хотын эргүүлийн машиныг үзэх юм бол алгаа ингэж ташаарай гээд Жекки нэг ташиж түр зогсоод хоёр удаа бас дахин нэг удаа ташив. -Дараа нь та нарт энд болсон бүхнийг ярихаа би амлаж байна. Өдрийн шинэ дүрэм бол бүх мэдээллээ хуваалцах бөгөөд нууцлахгүй байх. Тэднийг явсны дараа Жекки Жо руу эргэж -Линдад ярьсан хайрцагныхаа тухай бүгдэд нь ярь. Эхнээс нь дуустал.

Жо самбарын дэргэд хичээл хариулж байгаа хүүхэд шиг зогсон ярив.

-Дараа нь бид хотод эргэж ирсэн. Тэгээд тэр Ренни новш Растиг баривчилсан байна гэж тэр яриагаа дуусгаад духны хөлсөө арчиж буйдан дээр суулаа.

Мөн хуралд ирсэн Клер түүний мөрөөр тэврэв.

-Ренни хайрцагны тухай мэдэх ёсгүй гэж Жо хэлсэн. Хайрцаг хийж байгаа ажлаа цаашаа хийгээсэй гэх сонирхол Реннид байгаа гэдэгт тэр итгэлтэй байна. Ренни хайрцагийг салгах юмуу устгах гэж оролдохгүй.

-Жо-гийн зөв гэж бодож байна. Тиймээс бидний хамгийн анхны нууц бол хайрцаг байгаа болоод түүний байрлал юм гээд Жекки толгой дохилоо.

-Би итгэлтэй биш байна гэж Жо гэнэт дугарав.

-Өөрөөр хэлбэл? Реннид энэ тухай мэдүүлэх ёстой гэж чи бодоод байгаа юмуу? гэж Жулия гайхлаа.

-Магадгүй. Зарим нэг талаар. Гэхдээ би бодох хэрэгтэй.

Жекки Жо-д дахин асуулт тавилгүй үргэлжлүүлэв.

-Манай өдрийн хөтөлбөрийн дараагийн зүйл. Би Барби Расти хоёрыг шоронгоос гаргах оролдлого хийхийг хүсч байна. Маргааш орой хотын хурлын үеэр. Ерөнхийлөгч Барбиг хотын захиргааны тэргүүнээр томилсон. Тиймээс...

-Ренни л биш бол хэн ч яахав. Энэ бурхангүй гичийн хүү хот түүний өмч гэж боддог хэмээн Эрни дүрсхийлээ.

-Тэр нэг л юманд сайн. Хэрэгтэй үед ус булингартуулах. Хүнсний самуун ба редакцийг шатаах... Бүгд түүний тушаал гэж би бодоод байна хэмээн Линда дэмжив.

-Мэдээж түүний тушаал. Номлогчоо алж чадсан хүн... гээд Жекки толгой дохив.

Роуз түүн рүү бүлтийн харлаа.

-Ренни Лестер ламыг алсан гэх гээд байна уу?

Жекки "Боуигийн оршуулгын товчоо"-ны хонгилд хийсэн айлчлалын тухай болоод Лестер ламын нүүрэнд үлдсэн няцралтууд Реннигийн ажлын өрөөнд Растигийн харсан алтадсан бейсболын бөмбөгнийх байж мэдэх талаар ярьлаа. Энд байгаа хүмүүс айдастай сонсох боловч нэгнийх нь ч нүүрэн дээр эргэлзээ төрсөнгүй.

-Охидыг тэр бас уу? гэж Лисса асуухад түүний намуун дуу айдсаар дүүрчээ.

-Түүний хүү гэж би бодож байна. Энэ аллага бол Том Жимийн улс төрийн луйвартай ямар ч холбоогүй. Жижгээ өнөө өглөө ухаан алдсан. Гэхдээ хүүр олдсон Маккейний байшингийн хажууд. Хүүрнүүдийг тэр олсон гэж байгаа хэмээн Жекки хэллээ.

-Ямар сүрхий давхцал вэ? гээд Эрни тургив.

-Тэр одоо эмнэлэгт байгаа. Жинни хэлэхдээ тэр бараг л тархины хорт хавдартай бөгөөд энэ нь хяналтгүй хүчирхийлэл гаргах шалтгаан болж болзошгүй гэсэн.

-Алуурчдын гэр бүлийн баг юмуу? гээд Клер Жо-г өөртөө чанга наав.

-Баг биш. Үүнийг цухалдах үед үүсдэг удам дамжсан биеэ авч явах байдлын гажуудал гэж

нэрлэх нь зөв гээд Жекки толгой сэгсэрлээ.

-Гэвч хүүрнүүдийг нэг газарт олсон нь алуурчид хоёулаа байсан юм бол мэдээлэлтэй хөдөлсөнийг харуулж байна. Тэгээд миний нөхөр Барбара хоёр алуурчины гарт байгаа бөгөөд өнөөх нь том хуйвалдааны онолыг үүсгэхийн тулд тэднийг ашиглаж байна. Ренни тэдний жишээн дээр сургамж өгөх санаатай байгаа учраас л тэд одоо хүртэл амьд байна. Тэднийг олны нүдэн дээр цаазлахыг тэр хүсч байгаа гэж Линда хэлэв. Хоромхон зуур царай нь үрчийсэн ч тэр нулимсаа давж гарлаа.

-Би түүнийг тэгтлээ цаашаа явчихсан гэж итгэж чадахгүй юм. Бурхан минь, тэр чинь ердөө л хуучин машины худалдаачин шүү дээ гээд Лисса амьдралын Түлхүүрээ гартаа эргэлдүүлэв.

Бүгд дуугүй суун түүнд хариуллаа.

-Харин одоо сонсоцгоо гэж Жекки сунжирсан завсарлагыг дуусгав.

-Линда бид хоёр юу хийх гэж байгаагаа та нарт хэлсэнээр би та нарыг жинхэнэ хуйвалдагсад болголоо. Тиймээс би та нарын саналыг хураана. Хэрэв та бүхэн үүнд оролцохыг хүсвэл гараа өргөөрэй. Гараа өргөхгүй нь явж болно. Энэ хуйвалдааны тухай хэнд ч ярихгүй гэж амлаарай. Гэхдээ хэн ч үүнийг хийх хүсэлгүй байгаа гэж би бодож байна. Хэрэв та нар энд хэн байсан болоод юу ярилцсан тухай хэнд ч ярихгүй бол та өөрөө яагаад энд ирсэн тухайгаа тайлбарлах хэрэг гарахгүй. Эю маш аюултай. Бид бүгд шоронд орж мэднэ. Гэхдээ шоронд орох ч бас хамгийн муу юм биш. Харин одоо та нарын шийдвэрийг харъя. Хэн үлдэх вэ?

Жо гараа нэгдүгээрт өргөв. Пайпер Жулия, Роуз ба Эрни нар түүнээс бараг хоцорсонгүй. Линда Ромми хоёр хамт өргөлөө. Лисса Пайпер руу харна. Цаадах нь урт амьсгаа аваад толгой дохив. Тэгээд хоёр эмэгтэй гараа өргөлөө.

-Ээж ээ яг зөв гэж Жо түүнийг дэмжлээ.

-Хэрэв чи аавдаа би чамайг юунд хутгалдахыг зөвшөөрсөн талаар хэлэх юм бол чамайг цаазлахад Жеймс Ренни шаардагдахгүй. Би өөрөө хийнэ шүү гэж Клер хүүдээ сануулав.

19

Ромми Жеккид хандан:

-Линда баривчлагдсан хүмүүсийг суллахаар цагдаагийн газарт очиж чадахгүй шүү дээ. - Тэгээд хэн гэж?

-Чи бид хоёр хонгор минь. Линда хотын бүх нийтийн хуралд очих хэрэгтэй. Хожим зургаан зуугаас найман зуун хүн түүнийг тэнд харсанаа гэрчлэх болно.

-Би яагаад та нартай явж болдоггүй юм бэ? Миний нөхөр шоронд байгаа гэж Линда асуув.

-Тийм учраас л гэж Жулия хялбархан тайлбарлалаа.

-Чи үүнийг яаж хийх бодолтой байна даа? гэж Ромми Жеккигээс асуув.

-Бид нүүрэндээ баг хийж явах хэрэгтэй...

-Ойлгомжтой гээд Роуз царайгаа мурийлгахад бүтд инээлдлээ.

-Бидэнд аз таарлаа. Манай дэлгүүрт хэллоуины баг зөндөө бий гэж Ромми зарлав.

-Би бяцхан лусын гүнж болох ёстой юм болов уу? гэх Жеккигийн дуунд мөрөөдөнгүй өнгө аяс дуулдана. Бүгд түүн рүү харж байгааг анзаараад улайв. -Ямар ч тохиолдолд бидэнд буу хэрэг болно. Миний гэрт "беретта" гар буу байгаа. Ромми чамд юу байгаа вэ?

-Би хэд хэдэн карабин буу дэлгүүрийнхээ төмөр пүүгээнд нуусан. Нэг нь дурантай. Цагдаагийн газар руу довтлох хэрэгцээ гарахыг урьдчилан харсан гэж хэлж чадахгүй ч зэвсэг хэрэг болно гэдгийг мэдэрсэн юм.

-Та нарт бас сууж явах машин хэрэгтэй. Мэдээж таны фургон биш Ромми. Яагаад гэвэл түүнийг бүгд мэднэ гэж Жо ярианд оролцлоо.

-Энэ тал дээр надад санаа байна. "Реннигийн хуучин автомашины салон"-ы зогсоол дээрээс машин авъя. Өнгөрсөн жил тэр харилцаа холбооны компанийн гүйдэл ихтэй олон хуучин микроавтобус авсан. Тэдгээр нь зогсоолын гүнд байж л байна билээ. Хэрэв бид тэднээс нэгийг нь ашиглалаа гэхэд энэ нь өнөөх төгс шударга явдал гэж хэлдэг чинь л болох байх гэж Эрни хэлэв.

-Бид түлхүүрийг нь яаж олох вэ? Салон дахь Реннигийн өрөөг эвдэх юмуу? гэж Ромми асуулаа.

-Хэрэв бидний авах микроавтобусны асаалт нь электрон биш бол би түлхүүртэй түлхүүргүй асааж чадна гэснээ Эрни Жо руу хатуу харангаа: -Залуу минь чи энэ тухай миний ач охинд бүү дамжуулаасай гэж хүсэх байна.

Жо амаа цахилгаанаар хааж байгаа дүрс үзүүлэхэд бас л бүгд инээлдэв.

-Маргааш хотын бүх нийтийн хурал долоон цагт эхэлнэ. Хэрэв бид найман цагт цагдаагийн газарт очих юм бол... гэж Жекки санууллаа.

-Бид бүхнийг нарийн тооцоолж чадна. Хэрэв би заавал тэр чөтгөрийн хуралд очих хэрэгтэй юм бол би ашигтай ажиллах болно. Том хармаатай даашинз өмсөөд цагдаагийн богино долгионы нэг яригчийг хармаална. Миний хувийн машинд нэг яригч үлдсэн. Та хоёр микроавтобусанд бэлэн сууж байгаарай гэж Линда яриаг таслан хэллээ.

Өрөөнд гэнэт түгшүүртэй болж ирсэн нь ажил хэрэгт нухацтай орж эхэлсэнийг бүтд ухаарсан хэрэг.

-Бид манай их дэлгүүрийн арын ачих буулгах тавцан дээр байх болно. Тэнд хэн ч биднийг харахгүй гэж Ромми тодруулав.

-Ренни яриад эхэлмэгц би богино холбоогоор гурван удаа дохио өгнө. Энэ эхлэх дохио.

-Цагдаагийн газарт хэдэн цагдаа байх бол? гэж Лисса асуулаа.

-Би үүнийг Стейси Моггиноос мэдээд авчихна. Гэхдээ олон байхгүй болов уу. Тэд тэнд хөглөрөх ямар хэрэгтэй юм бэ? Барбид хотод жинхэнэ найзууд гэж байхгүй бөгөөд өөрийнх нь тавьсан сүрлэн мануухайнууд л байгаа гэдгийг Том Жим мэдэж байгаа гэж Жекки хариуллаа.

-Түүний зөөлөн бөгсийг сайн хамгаалах тал дээр л санаа тавихыг хүсэх болно гэж Жулия нэмж хэлэв.

Хэн нэг нь инээсэн ч Жогийн ээжийн царайд түгшүүр тодрон:

-Гэхдээ л цагдаагийн газарт хэн нэг нь байж таарна. Хэрэв эсэргүүцэл үзүүлбэл юу хийх гэж байна вэ?

-Эсэргүүцэл үзүүлэхгүй. Би тэднийг юу болоод байгааг ойлгохоос нь өмнө хонгилын хорих өрөөнд түгжчихнэ гэж Жекки итгэлтэй мэдэгдэв.

-Хэрэв ямар ч гэсэн эсэргүүцэл үзүүлбэл?

-Гарцаагүй шаардлага гарахгүй бол тэднийг алахгүй гэх үед Линдагийн дуу тайван байсан ч тэр нулимсаа барихын тулд цөхөртөл оролдож байгааг нүд нь хэлээд өгөв. -Гэвч Бүрхүүл дахиад хэсэг хугацаанд байгаад байх юм бол аллага тэртэй тэргүй болно. Барби болоод манай нөхрийг Цэргийн дурсгалын талбай дээр буудах нь зөвхөн эхлэл болох байх.

-Та нар тэднийг тэндээс гаргалаа гэж бодъё. Тэгээд хааш нь аваачих юм бэ? Наашаа юу? гэж Жулия толгой дохин асуулаа.

-Үгүй үгүй гэж Пайпер хэлээд хавдсан хэвээр үлдсэн уруулдаа гар хүргэв. -Би Реннигийн хар жагсаалтанд аль хэдийн орчихсон. Одоо түүний хувийн хамгаалагч болсон тэр залуугийн талаар ярих ч хэрэггүй. Тибодо. Миний нохой түүнийг хазсан.

-Тэгээд ч танай гэр төвд дэндүү ойрхон. Төвийн нэг ч байшин тохирохгүй. Ренни самнан хайж мэднэ. Одоо түүнд цагдаа хангалттай болсоныг бурхан гэрчилнэ гэж Роуз тэмдэглэв.

-Дээр нь гартаа бүч уясан тэр олон хүн байна гэж Ромми ч нэмэв.

-Честер цөөрмийн дэргэдэх зуны байшингуудын нэг байвал ямар вэ? гэж Жулия асуулаа.

-Магадгүй. Гэхдээ Ренни ч бас энэ тухай бодож мэдэх юм гэж Эрни хэлэв.

-Гэхдээ л энэ хамгийн сайн зам юм гэж Лисса Жулиатай санаа нийлэв.

-Ноён Берпи танайд өнөөх өргөн тугалган тууз үлдсэн үү? гэж Жо асуулаа.

-Мэдээж хэдэн тонноороо байгаа. Гэхдээ намайг Ромми гэж дуудаарай.

-Хэрэв ноён Кэлверт маргааш орой машин хулгайлж чадвал та дэлгүүр дээрээ очоод урьдаас огтолож бэлдсэн тугалган хавтангууд машинд ачаад өгч чадах уу? Цонх хаахуйц том огтлох хэрэгтэй.

-Чадна гэж бодож байна...

Жо Жекки рүү харан:

-Хэрэв шаарддага гарвал та хурандаа Кокстой холбоо барьж чадах уу?

-Тиймээ гэж Жекки Жулия хоёр зэрэг хариулсанаа бие бие рүүгээ гайхан харав.

Роммигийн нүд гялалзаад явчихлаа.

-Чи Маккойн байшингийн тухай бодсон тийм үү? Блэк-Ридж дээр. Хайрцаг байгаа газар.

-Тиймээ уг нь муу санаа. Гэвч бидэнд бүгдэд нь зугтах хэрэгцээ гарвал...хэрэв бид тэнд цуглавал...бид хайрцагийг хамгаалж чадна. Түүнээс бүх юм эхэлсэн болохоор энэ нь солиорол мэт сонсогдож мэдэх хэдий ч бид Реннид түүнийг авахыг зөвшөөрөхгүй.

Ромми толгой дохив.

-Би чамайг ойлгож байна. Тэгээд бидэнд Аламагийн төлөөх бас нэг тулаан хийх хэрэг гарахгүй гэж найдах юм. (Аламагийн тулаан дууссанаас Техас мужийг Мексикээс салгажээ.) Гэхдээ энэ удаад алимны цэцэрлэгт болох тулаанаас.

-Бид өөр зарим нэг зүйл хийх хэрэгтэй. Энэ бага зэрэг аз үзсэн хэрэг. Бүтэхгүй ч байж мэднэ...гэж Жо үргэлжлүүлэв.

-Ярь гээд Жулия Жо руу бараг л шүтэх аятай ширтэв.

-Тэгвэл...Гейгерийн тоолуур чиний машинд байсаар л байгаа юу Ромми?

-Тийм гэж бодож байна.

-Хэн нэг нь түүнийг атомын хоргодох байранд буцааж тавих хэрэгтэй гэснээ тэр Жекки Линда хоёр руу харж: -Та хоёрын хэн нэг нь тийшээ орж чадах уу? Та нарыг албаа өгчихсөн болохоор ингэж асууж байгаа юм.

-Эл Тиммонс биднийг тийшээ оруулна гэж бодож байна гэж Линда хариуллаа. -Стейси Моггиныг бол баталгаатай оруулна. Тэр бидний талд. Стейси энд байхгүй байгаа шалтгаан нь тэр өнөөдөр ээлжтэй. Гэхдээ энэ ямар хэрэгтэй юм бэ Жо?

-Хэргийн учир нь... гэж тэр хэлэх үг бүрээ цэгнэх шиг сурсан зангаараа тун удаан ярина. -Блэк-Ридж дээр цацраг туяа байгаа, ойлгож байна уу? Маш хүчтэй. Гэхдээ энэ бол ердөө

нарийхан бүс... Би энэ бүсийг ямар нэг хамгаалалтгүйгээр нэвгэрч болно гэж маргахад ч бэлэн байна. Хэрэв тэр бүсийг ойр ойрхон нэвтрэхгүй байх юмуу маш хурдан давхиж өнгөрөх юм бол биед ямар ч хор болохгүй... Үүнийг Том Жимийн хүмүүс мэдэхгүй. Тэд тэнд байгаа цацраг туяаны талаар мэдэхгүй байгаа нь бас гай. Тэдэнд Гейгерийн тоолуур байхгүй цагт мэдэж ч чадахгүй.

Жекки хөмсөг зангидав.

-Хүү минь гайхалтай санаа. Гэхдээ надад нэг л юм таалагдахгүй байна. Биднийг хаанаас хайхыг бид Реннид өөрсдөө зааж өгөх юм байна. Ингэлээ гээд манай аюулгүй байдал өснө гэж би огт бодохгүй байна.

-Бид юу ч заах хэрэггүй гэж Жо сурсан зангаараа өөрийн төлөвлөгөөний сул талыг хайнгаа аажуу ярив. -Ямар ч гэсэн шууд бол биш. Бидний хэн нэг нь Кокстой холбоо барина. Тэгээд түүнийг Реннитэй холбоо барьж Бүрхүүл дор маш хүчтэй цацраг туяаны эх үүсвэр байгаа тухай мэдээл гэж хүснэ. Кокс жишээ нь "Бид байршилыг нь ян тан тогтоож чадахгүй байна. Яагаад гэвэл цацраг туяа нэг гарч ирээд нэг алга болоод байна. Гэхдээ туяаны түвшин хангалттай өндөр бөгөөд тэр бүү хэл үхлийнх юм. Тиймээс болгоомжтой байгаарай. Ингэхэд танайд Гейгерийн тоолуур байхгүй биз дээ?" гэж хэлж болох юм.

Удтал дуугүй боллоо. Бүгд Жогийн саналыг бодож үзэв. Эхлээд Ромми ярилаа.

-Бид Барбара Расти хоёрыг Маккойн ферм дээр аваачна. Хэрэв тэгэх хэрэг гарвал өөрсдөө ч тийшээ явна...ер нь тэгж л таарах байх. Тэгээд цагдаа нар тийшээ нэвтрэх гэж оролдвол...

-Тэд Гейгерийн тоолуур дээр цацраг туяаны идэвхжилийг хараад хэнд ч хэрэггүй төмсөгөө даран гэр рүүгээ харайлгах болно. Клер Макклэтчи, танай хүү суутан гэж Эрни хяхтнав.

Клер хоёр гараараа хүүгээ чанга тэвэрлээ.

-Үүний оронд тэр өрөөгөө сайхан цэвэрлэдэг байсан ч болоосой.

20

Горас Андреа Гриннелийн зочдын өрөөнд хоншоороо савар дээрээ тохон хэвтэх ба эзнийх нь түүнтэй хамт орхисон эмэгтэй рүү нэг нүдээрээ харна. Уг нь Жулия хаашаа ч явсан түүнийг аваад л явдаг. Хэзээ ч ямар нэг төвөг удаггүй тайван нохой. Хэрэв тэдний гэрт муур байлаа ч тэдний муухай үнэрээс болоод мань нохой ойртох ч үгүй байсан. Харин энэ орой дөнгөж сая нохой нь үхсэн Пайпер Либби амьд Горасыг хараад гуниглаж мэднэ гэж Жулия бодсон юм. Андреад нохой таалагдаж байгааг ч бас анзаарсан тул шарталтын тухай бодлоос нь холдуулахын тулд үлдээсэн. Шарталтын шинж тэмдэг урьдынх шиг хүчтэй биш болсон ч огт үгүй болчихоогүй л байв.

Хэсэг хугацаанд бүх юм түүний санаснаар боллоо. Андреа ганц ачдаа зориулан хадгалж байсан хаймар бөмбөгийг тоглоомтой хайрцагнаас олов. (ач нь тоглоомтой хайрцаг сонирхох наснаас аль хэдийн өнгөрчээ). Горас бөмбөгний араас дуулгавартай гүйж, шаардлагатай бол

зуун авчирч байв. Гэхдээ онцгой таашаал аваагүй. Тэр нисэлт дунд зуудаг бөмбөгийг илүүд үздэг юм. Гэвч ажил бол ажил пгүү дээ. Тиймээс Андреа даарсан хүн шиг гэнэт чичирч эхлэх хүртэл энэ үйлдэлд оролцсоор л байв.

-Түй, чөтгөр. Дахиад л эхэллээ.

Тэр бүх биеэрээ дагжин чичрээд буйдан дээр хэвтэв. Буйдангийн дэрнүүдийн нэгийг авч цээжиндээ наагаад тааз руу ширтэнэ. Тун удалгүй шүд нь тачигнаж эхэллээ. Горасыг энэ дуу ихэд уурлуулж байв.

Тэр түүний анхаарлыг өөр зүгт хандуулах санаатай бөмбөг зууж очиход өнөөх нь түүнийг түлхэв.

-Үгүй хонгор минь, одоо биш. Намайг үүнийг давж гарахыг зөвшөөр.

Горас бөмбөгийг ажиллахгүй байгаа зурагт руу аваачаад өөрөө хэвлээ. Дагжин чичрэх хүч нь сулрахын хажуугаар өнөөх эмэгтэйгээс гарч байсан өвчний үнэр намдаад ирлээ. Түүнийг унтмагц буйдангийн дэр базаж байсан гарын хүч нь

суларлаа. Дараа нь тэр хурхирч гарав. Энэ бол идэх цаг боллоо гэсэн үг.

Горас "Вейдер" хавтасны файлаас хэвлэсэн цааснуудтай дугтуйг дахиад тойрон ширээн доогуур мөлхөнө. Дугтуйн цаад талд поп-корны диваажин буй. Тэр өөрийгөө азтай нохойд тооцож болохоор байлаа.

Горас найрлаж эхэлсэн тул түүний сүүлгүй бөгсөн бие авч байгаа таашаалыг илтгэн хоёр тийш шарвалзана. (шалаар тарсан бөмбөлөгнүүд гайхалтай тослог, гайхалтай давстай, хамгийн гол нь бүрэн задарсан байлаа). Гэвч энэ үед үхсэн хүний дуу дахиад ярьж эхэллээ.

Үүнийг түүнд аваач.

Гэвч тэр чадахгүй шүү дээ. Эзэгтэй байхгүй. Нөгөө эмэгтэйд.

Үхсэн хүний дуу татгалзахыг тэвчихгүй мэт, тэгээд ч поп-корноос бараг юу ч үлдсэнгүй. Үлдсэн бөмбөлгүүдийг дараагийн удаад больё гэж Горас шийдээд дугтуй урьд нь гарч иртэл ухарч мөлхлөө. Түүнээс юу хүсээд байгааг хоромхон зуур мартсанаа дараа нь санаад дугтуйг зуун авлаа.

Сайн нохой.

Андреагийн хацрыг ямар нэг хүйтэн юм илээд авав. Тэр түлхээд цаашаа харж хэвлээ. Нойрондоо дахиад хэдхэн хором дарагдаад байтал нохой хуцах дуу гарав.

-Горас боль гээд тэр буйдангийн дэрийг толгой доороо ивлээ.

Гэвч нохой дахин хуцаад түүний хорин дөрвөн фунт жин хөл дээр нь буув.

-Хөөе гэж Андреа дуу алдаад өндийж суув. Гялалзах хүрэн улаан өнгийн хос нүд ба үнэг шиг инээх хоншоорыг нь харав. Гэвч инээмсэглэлийг нь ямар нэг юм халхалжээ. Зузаан хүрэн цаасан дугтуй байлаа.

Горас түүнийг Андреагийн гэдсэн дээр хаяад өөрөө шал руу үсрэн буув. Уг нь тэр хэзээ ч хүний буйдан дээр гардаггүй боловч үхсэн хүний дуу энэ ажлыг хойшлуулж болохгүй гээд байсан юм.

Горасын шүдний хонхорхой гарсан дугтуйг Андреа авлаа. Нохойн идсэн поп-корны үйрмэг бас наалдсан байсныг бүсгүй сэгсэрлээ. Дотор нь ямаг нэг овоо том юм байв. Нүүрэн талд нь том үсгээр бичсэн хоёр бичээс байхыг Андреа уншлаа."ВЕЙДЕР ХАВТАС" гээд арай доор "ЖУЛИЯ ШАМУЙЭД" гэжээ.

Горас чи үүнийг хаанаас авсан юм бэ?

Нохой мэдээж хариулж чадахгүй, гэхдээ хариуны хэрэг ч байсангүй. Поп-корны үйрмэг түүнд бүгдийг хэлээд өгөв. Тэгээд зүүд гэмээр бодит бус замхарсан тийм дурсамж хөвөн гарч ирэв. Тэр ингэж зүүдэлсэн юмуу эсвэл анхны шарталтын аймаар шөнийн дараа Бренда Перкинс үнэхээр түүн дээр ирлүү? Хотын нөгөө талд хүнсний үймээн болж байхад уу?

Энэ чам дээр байж байг. Түр зуур. Надад нэг ажил байна. Би дугтуйг биедээ авч явахыг хүсэхгүй байна.

-Тэр энд ирсэн юм гэж Андреа Гораст мэдээлэв. -Энэ дугтуйтай. Би түүнийг аваад...авсан гэж бодогдоод байна... дараа нь бөөлжис цугтасан. Бөөлжсөн. Дахиад бөөлжсөн. Нойл руу гүйхдээ ширээн дээр чулуудсан байх. Тэгээд унасан гэж үү? Чи түүнийг шалан дээрээс олсон уу?

Горас чанга хуцав. Эсвэл тэр тийм гэж хариулсан байх, эсвэл хүсч байвал дахиад бөмбөгөөр тоглоё гэсэн байх.

-Ямар ч гэсэн баярлалаа. Сайн нохой. Би Жулияг ирэнгүүт дугтуйг нь өгнөө.

Одоо нойр хүрэхээ больжээ. Бас хэсэг хугацаанд чичрэхээ ч болив. Гэхдээ сониуч занд идэгдэж байлаа. Яагаад гэвэл Бренда үхсэн. Түүнийг алсан. Энд дугтуйг үлдээсний дараа байх. Өөрөөр хэлбэл дугтуй дотор ямар нэг чухал юм байж болох аж.

-Би зүгээр л шагайгаад орхиё, за юу.

Горас дахиад хуцав. Андреагийн хувьд энэ нь "яагаад болохгүй гэж" хэмээн сонсдов.

Андреа дугтуйг нээхэд Том Жимийн ихэнх нууц түүний өвөр дээр асгарлаа.

Клер гэртээ түрүүлж ирэв. Дараа нь Бенни, Норри нар ирлээ. Жо зүлгийг хөндлөн гарч сүүдэр дагасаар ирэх үед тэд гурвуул Макклетчигийн байшингийн довжоон дээр сууж байлаа.

Бенни Норри хоёр бүлээн содтой ус ууна. Клер нөхрийнхөө шар айрагнаас нэг лонхыг гартаа бариад савладаг сандал дээр удаан ганхана. Жо түүний дэргэд суухад Клер

ясархаг мөрөөр нь тэвэрлээ. Тэр маш хэврэгхэн гэж ээж нь бодно. Тэр өөрөө мэдэхгүй байгаа ч яг тийм юм. Яс нь яг л шувууных шиг.

-Хүн гуай бид санаа зовж эхлээд байлаа шүү гээд Бенни түүнд хадгалж үлдээсэн хийжүүлсэн усаа сунгав.

-Хатагтай Шамуэй хайрцагны тухай хэдэн асуулт тавьсан юм. Бас миний хариулж чадахгүй асуултууд ч тавьсан. Бурхан минь энэ ус ямар бүлээн юм бэ? Яг зуны шөнийнх шиг. Бас энэ сарыг хар даа гээд тэр тэнгэр рүү толгой сэжив.

-Хүсэхгүй байна. Айлгаад байна гэж Норри хариуллаа.

-Бүх юм зүгээр үү хонгор минь? гэж Клер асуув.

-Тийм ээ ээжээ. Харин та?

Тэр гунигтай инээмсэглэв.

-Мэдэхгүй байна. Бүтэх болов уу? Та нар юу гэж бодож байна даа? Үнэнээр нь хэл.

Хэсэг хугацаанд хэн ч хариу хэлээгүй тул Клер бүр их айв. Дараа нь Жо түүний хацар дээр үнсээд:

-Бүтнэ.

-Чи иттэлтэй байна уу? -Тийм ээ.

Хэрэв хүү нь худлаа ярих юм бол тэр дандаа мэдэрдэг. Магадгүй түүний энэ чадвар нас ахихаар алга болж мэдэх л юм. Гэтэл энэ удаа худлаа гэх ямар ч юм мэдэрсэнгүй.

Клер Жог үнслээ. Түүний бүлээн амьсгал шар айрагнаас болоод яг аавынх шиг болжээ гэж Жо бодов.

-Хамгийн гол нь цус асгарахгүй байх явдал.

-Асгарахгүй ээ гэж тэр ээждээ баталлаа.

Клер дахиад инээмсэглэв.

-За за. Тэгвэл энэ бүхэн надад нийцтэй байна.

Тэд хоорондоо юу ч ярилгүй хэсэг хугацаанд харанхуйд суув. Дараа нь хотыг ягаан сар дор унтуулахаар орхиод гэртээ орцгоолоо.

Яг нэг цаг болж байхад.

Хаа сайгүй цус

1

Жулия арван сарын хорин зургаан болсоны дараа Андреагийн орж ирлээ. Арван хоёр хагаст. Чимээгүйхэн орж ирэв. Гэвч ингэж хичээх хэрэггүй байжээ. Яагаад гэвэл Андреагийн жижиг хүлээн авагч ажиллаж байв. "Стэпл сингерс" хамтлаг "Зөв сүмээ сонго" дуугаар ёстой бүх хүний чихийг зурж байна. Горас эзэнтэйгээ мэндчилэхээр үүдний танхимд гарч ирлээ. Бөгсөө шарвалзуулж, энэ үүлдрийн нохой л чадах тийм ухаангүй инээдээр инээж байлаа. Савраа алцайлгаж толгойгоо бөхийхөд Жулия нохойныхоо хамгийн мэдрэмтгий цэг байдаг чихний арын хэсэгт маажлаа.

Андреа буйдан дээр суугаад цай ууж байв.

-Хөгжим тавьсанд уучлаарай. Унтаж чадахгүй байна гээд тэр дуугаа намсгав.

-Хонгор минь энэ танай гэр шүү. Харин ХБЭ-ний хувьд энэ зүгээр л рок-н-ролл.

Андрей инээмсэглэв.

-Оройжингоо түргэн аястай хөгжим явлаа. Банк тоносон юм шиг мэдрэмж төрж байна. Уулзалт ямар байв даа? -Сайн гээд Жулия суулаа. -Энэ тухай ярилцах уу?

-Чи түгших хэрэггүй дээ. Өөрийнхөө биед л анхаар. Чи дээрдсэн харагдаж байна шүү, үүнийгээ мэдэх үү?

Тэр үнэнийг хэлсэн юм. Андреагийн царай цонхигор хэвээр бөгөөд мэдэгдэхүйц үлбэгэр байв. Гэхдээ л нүдэн доорх хар хүүдий цайрч, харцанд нь оч асчээ.

-Сайхан үг хэлсэнд баярлалаа.

-Горас сайн байсан биз дээ?

-Бүр дэндүү. Бид бөмбөг тоглоод дараа нь жаахан унтсан юм. Хэрэв би дээрдсэн харагдаж байгаа бол шалтгаан нь тэр юм. Өдрийн цагаар унтах нь эмэгтэй хүний царайд маш сайн.

-Нуруу ямар байна даа?

Андреа инээмсэглэв. Бага зэргийн хөгжилтэй, олон утгатай инээмсэглэл.

-Тийм ч муу биш л дээ. Тонгойх үед хүртэл бага зэрэг л мэдэгдэж байна. Миний юу бодож байгааг мэдэх үү?

Жулия толгой сэгсрэв.

-Хар тамхины тал дээр бие тархи хоёр хамтардаг юм шигээ. Хэрэв тархинд хар тамхи

хэрэгтэй бол бие түүнд тусалдаг. "Бүү санаа зов. Өөрийгөө буруутай гэж битгий бод. Бүх юм зүгээр. Би үнэхээр өвдөөд байна" гэж хэлдэг шиг байгаа юм. Энэ цэвэр санаагаараа өвдөж байгаа хэрэг биш. Би энэ тухай яриагүй байна. Бүх юм тийм ч хялбар биш. Гэхдээ... гээд Андрей дуугаа хураахад нүд нь сүүмийж Андреа бодол санаандаа бол шал өөр газарт одох шиг боллоо.

Ямар газарт вэ? гэж Жулия дотроо бодов.

-Хүний бие махбодь өөрөө өөрийгөө сөнөөхөөр хөдөлж мэднэ. Чи хотыг хэзээ нэг цагт бие гэж авч үзэж байсан уу?

-Тийм ээ гэж Жулия бодолгүй шууд хариуллаа.

-Бие нь тэгтлээ хүсээд байгаа хар тамхийг тархи аваасай гэсэндээ бие "өвдөөд байна" гэж хэлдэг байж болох уу?

Жулия бодсоноо толгой дохив.

-Энэ тохиолдолд Том Жим хотын тархи тийм үү?

-Тиймээ хонгор минь. Би тийм л гэж хэлнэ.

Андреа буйдан дээр толгойгоо унжуулан сууна. Дараа нь жижигхэн хүлээн авагчаа унтраагаад босов.

-Би явж унтлаа. Би үнэхээр унтаж чадна гэж бодогдоод байна.

-Энэ сайн хэрэг гэж Жулия толгой дохив. Тэгсэнээ ямар нэг шалтгаангүй атал гэнэт асуув. -Намайг эзгүй хооронд ямар нэг болоо юу?

Андреагийн царайд гайхал тодров.

-Тиймээ, мэдээж. Горас бид хоёр бөмбөг тоглосон гээд өвдсөндөө ярвайлгүйгээр тонгойгоод: -Долоо хоногийн өмнө бол амьдралдаа хэзээ ч ингэж чадахгүй гэж хэлэх байсан байхаа гэснээ Горас руу гараа сунгав. Өнөөх нь илүүлэх санаатай толгойгоо унжууллаа. -Тэр бөмбөгийг үнэхээр сайн барьдаг юм билээ.

2

Андреа унтлагын өрөөндөө ороод орон дээр сууж "Вейдер" хавгаснаас хэвлэсэн баримт бичгүүдийг дахин уншиж гарлаа. Энэ удаад илүү анхааралтай уншив. Бараг шөнийн хоёр цаг болж байхад хуудаснуудыг зузаан цаасан дугтуй руу буцаан хийв. Дугтуйгаа дотор нь 38 калибрийн гар буу хэвгэх орны дэргэдэх шүүгээний шургуулганд хаяв. Хоёр жилийн өмнө энэ бууг түүний дүү Дуглас төрсөн өдрөөр нь бэлэглэж билээ. Тэгэхэд тэр их айсан. Харин

Дуги өөрийнхөөрөө зүтгэж ганцаараа амьдардаг эмэгтэй хамгаалалттай байх ёстой гэсэн.

Одоо Андреа гар бууг гаргаж ирээд бортогыг хажуу тийш унагаж сумнуудыг шалгав. Дугигийн зааж өгснөөр хамгийн анх гох дарахад цохилтон дор орших тэр нүх сумгүй хоосон байлаа. Харин бусад таван үүр сумтай. Нөөц сумнууд хананы шүүгээний дээд тавиур дээр байгаа боловч түүнд буугаа дахин сумлах боломж олдохгүй нь мэдээж. Цагдаа нарын бяцхан арми түүнийг дарж авна.

Гэвч хэрэв тэр Ренниг таван буудалтаар алж чадахгүй юм бол амьдрах хэрэг байхгүй.

-Эцсийн эцэст хэмээн Андреа гар бууг шургуулганд хийнгээ үглэнэ. -Би яах гэж хар тамхины хамаарлаас салсан юм бэ?

Хариу нь тов тодорхой байлаа. Яагаад гэвэл хар тамхи одоо түүний ухааныг сааралтуулахаа больжээ. Гар чичрэхээ больж буугаа яг байнд чиглүүлэхийн тулд тэр үүнийг хийсэн. -Яг үүний тулд гэж чанга хэлээд толгой дохисоноо гэрлээ унтраав.

Таван минутын дараа Андреа нам унтаж байлаа.

3

Жижгээ унтсангүй. Хачин ягаан сар түүний урьд нь хараагүй Бүрхүүл дээрх хар толбыг гэрэлтүүлэхийг эмнэлгийн тасгийн цонхны дэргэд байх ганц сандал дээр суун харна. Пуужингийн бүтэлгүй цохилтын дараа үлдсэн бусад толбонуудаас том бөгөөд арай дээр байрлалтай толбо. Түүнийг ухаангүй хэвтэж байхад Бүрхүүлийг цөмлөх бас нэг оролдлого хийсэн хэрэг үү? Жижгээ мэдэхгүй байв. Тэгээд ч үүнд санаа зовохгүй байлаа. Хамгийн гол нь Бүрхүүл урьд байсан газраа байгаад оршино. Хэрэв Бүрхүүл үгүй болсон бол хот Вегас шиг гял цал хийж, гудамжаар цэргүүд дүүрэх байсан. Хэдийгээр энд тэнд гэрэл үзэгдэж шөнө оройтож хэвтдэг хүмүүс хаана амьдрахыг харуулах боловч Честерс-Миллийн ихэнхи хүмүүс унтаж байна. Энэ сайн хэрэг. Яагаад гэвэл Жижгээд бодох юм бий. Түүний бодолд саад болохыг үл хүснэ.

Барби болоод түүний найзуудын тухай бодох болно. Цонхны дэргэд суухаар Жижгээгийн толгой өвдөхгүй байв. Ой санамж эргэн иржээ. Гэвч залуу Ренни хүнд өвдсөн гэдгээ ойлгож байлаа. Биеийн зүүн тал бүхлээрээ сэжигтэй сулбайх нь мэдрэгдэнэ. Бас амны зүүн булангаар шүлс заримдаа аяндаа гоожно. Шүлсээ зүүн гараар арчихаар заримдаа арьс арьсанд хүрэх нь мэдрэгдэх боловч заримдаа бол үгүй. Түүнээс гадна хэлбэр нь цоожны нүхийг санагдуулах хар толбо нүдний харааны зүүн хэсэгт хөвнө. Яг зүүн нүдэнд нь ямар нэгэн юм тасарчихсан юм шиг. Магадгүй тийм байх.

Бүрхүүлийн өдөр түүнийг эзэмдсэн галзуурлыг Жижгээ санав. Энжиг гал тогоо хүрэх хонгилоор хэрхэн хөөсөн, түүнийг хэрхэн хөргөгч рүү чулуудсан, хэрхэн нүүр рүү өвдөглөснөө санана. Түүний өвдгөн дор бүсгүйн нүдний цаад талд ямар нэг шаазан таваг бут үсрэх дуу гарсныг санана. Тэр галзуурал одоо байхгүй болжээ. Түүний толгойд байх ямар нэг ёроолгүй эх сурвалжаас жигдхэн уур хилэн бүх биеэр нь урсах бөгөөд өнөөх галзуурлын орон зайг эзэлнэ. Энэ бол түүнийг цэвэрлэж бас мөстүүлж байгаа түлхүүр нь юм.

Френки тэр хоёрын Честерс цөөрмийн дэргэд байх ёстой байранд нь тавьсан хөгшин ухна

орой түүнийг үзэхээр ирсэн. Мэргэжилтэн царайлж түүний даралт ба халууныг хэмжиж, толгой өвдөж байгаа эсэхийг асууж, тэр бүү хэл хаймар толгойтой жижиг алхаар өвдөгний рефлексийг хүртэл тогшиж шалгасан. Дараа нь түүнийг явмагц хүмүүс хоорондоо ярьж инээлдэхийг Жижгээ сонссон. Барби гэсэн нэр дурьдагдаж байв. Жижгээ хаалга руу гэтлээ.

Хөгшин ухна ба залуу сувилагчдын нэг болох Буффало овогтой хөөрхөн итали хүүхэн хоёр байв. Хөгшин ухна түүний цамцыг тайлж хөхийг нь самардана. Харин бүсгүй түүний өмдийг тайлаад өнөөхийг нь оролдоно. Тэднийг хорт ногоон гэрэл бүрхжээ.

"Жижгээ түүний найз хоёр намайг зодсон. Одоо түүний найз үхсэн. Тэр бас удахгүй үхнэ. Барбигийн тушаал" гэж хөгшин ухна ярина.

"Надад Барбигийн эрхтэнийг хөхөх таалагддаг. Яг л гаатай чихэр шиг" гэж бүсгүй хариулахад хөгшин ухна түүнд ч бас энэ таалагддаг гэсэн.

Дараа нь Жижгээ нүдээ нэг цавчаад хартал тэр хоёр хонгилоор явж байв. Шалиг гар ба ногоон Бүрхүүлийн аль нь ч алга. Энэ хий үзэгдэл юм болов уу? Үгүй ч байж мэднэ. Нэг л зүйл эргэлзээ үл төрүүлнэ. Тэд бүгд нэг тал. Барбигийн багийнхан. Тэр шоронд байгаа. Гэхдээ энэ түр зуурынх. Өрөвдүүлэх гэж л тэр биз. Барбигийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг. Тэгээд ч шоронд байгаа түүнд Жижгээ хүрч чадахгүй гэж бодсон хэрэг.

-Энэ тал дээр тэр алдаж байна даа гэж Жижгээ одоо үе үе манантах нүдээр шөнийн харанхуй руу ширтэн цонхны дэргэд суунгаа шивнэв. -Алдаж байна.

Жижгээ одоо түүнтэй юу болоод байгааг яг мэдэж байлаа. Ухаарал огцом гялсхийн орж ирсэн ба дүтнэлтийн зөв эсэх эргэлзээ үл төрүүлнэ. Англид өнөөх оросыг хордуулсан шиг түүнийг таллийгаар хордуулсан байна. Барбигийн армийн энгэрийн тэмдэг таллийгийн тоосоор хучигдсан байжээ. Жижгээ түүнд хүрээд одоо үхэж байна. Нэгэнт эцэг нь түүнийг Барбигийн гэр рүү явуулсан гэдэг чинь хүүгээ хордуулахад оролцсон гэсэн үг. Эцэг бол Барбичуудын нэг... Ийм хүмүүсийг ингэж нэрлэдэг...

-Миньонууд гэж Жижгээ шивнэв. Барбигийн хийдэг махан миньоны дөнгөж нэг нь.

Тэр энэ тухай дөнгөж бодмогц, оюун ухаан нь цэвэршмэгц, бүх юм байрандаа орлоо. Эцэг нь түүнийг Лестер лам болоод Брендагийн тухай хэнд ч бүү хэлээсэй гэсэндээ амыг нь таглах гэсэн. Тэгээд таллийгаар хордуулсан. Бүгд дүйж байна.

Гадаа зүлэгний цаана нэг чоно машины зогсоолоор хөндлөн гарч явна. Зүлгэн дээр хоёр шалдан эмэгтэй 69 байрлалд хэвтэж байна. "Хоёр бүсгүйд зориулсан 69" гэж Френки тэр хоёр багадаа хашгирдаг байсан. Энэ юу гэсэн үг болохыг мэдэхгүй бөгөөд ямар ч гэсэн бүдүүлэг үг гэдгийг л мэдэх тул хамт явж байгаа хоёр хүүхэн харагдвал ингэдэг байсан. Өнөөх зүлгэн дээр байгаа хоёр торгон нүүртийн нэг нь Сэмми Буши шиг харагдана. Жинни нэртэй сувилагч Сэммиг үхсэн гэж Жижгээд хэлсэн. Өөрөөр хэлбэл худлаа ярьжээ. Тэгвэл Жинни ч бас Барбитай нэг тал.

Ингэхэд энэ хотод Барбигийн тал биш ганц ширхэг хүн байна уу? Түүний талд багтай ороогүй

хүн бий юу?

Байгаа гэдгийг Жижгээ мэдэж байв. Нэг ч биш бүр хоёр байгаа. Френки тэр хоёрын цөөрмийн дэргэд олсон хүүхдүүд. Элис ба Эйден нар. Тэдний шаналсан нүдийг тэр санаж байна. Жижгээ гартаа тэврэх үед охин хэрхэн тэвэрсэнийг санаж байна. Одоо тэд аюулгүй гэж хэлэхэд Элис "Чи амлаж байна уу?" гэхэд нь Жижгээ "тийм" гэж хариулсан. Энэ амлалт түүний сэтгэл санааг шууд өргөв. Түүнд наалдсан охины итгэлээс болоод сэтгэл санаа хөнгөрсөн.

Яг энэ үед Жижгээ гэнэт шийдвэр гаргасан нь тэр Дейл Барбараг алах ёстой. Хэрэв түүний замд хэн нэгэн саад болох юм бол тэр бүтдийг нь алах болно. Дараа нь эцгийгээ олж бас ална... Жижгээ үүнийг олон жилийн турш мөрөөдөж ирсэн. Гэвч үүнийг хүсч байгаа гэдгээ зөвхөн одоо л хүлээн зөвшөөрөв.

Дараа нь Элис Эйден хоёрыг хайж олно. Үүнд саад болох юм бол тэр саад болсон хүнийг бас ална. Хүүхдүүдийг Честерс цөөрөмд аваачаад асрах болно. Элист өгсөн амлалтаа биелүүлэх болно. Амлалтаа биелүүлж байхдаа үхэхгүй. Тэр хүүхдүүдийг асарч байгаа цагт таллийд хордож үхэхийг бурхан зөвшөөрөхгүй.

Одоо Энжи Доди хоёр бүжиглэнгээ авто зогсоолыг хөндлөн гарлаа. Дэмжигч бүлгийн оролцогчдын богино банзал ба энгэр дээрээ "Зэрлэг муурнууд" гэсэн үгийн товчлол болох ЗМ гэсэн бичигтэй спорт цамц өмсчээ. Жижгээ тэднийг харж байгааг мэдчихээд бөгсөө хөдөлгөн хормойгоо сөхөж байна. Тэдний үжирч муудан задарч унжиж байгаа нүүр царай хоёр тийш бас дээш доош савлана. Тэд "Зоорины хаалгыг нээ. Тэгээд эрхтэнээ оруул. Урагшаа. Багийн төлөө" гэж хашгирцгаана.

Жижгээ нүдээ анив. Нээлээ. Найз охид алга болжээ. Дахиад л хийсвэр үзэгдэл. Яг өнөөх чоно шиг. Харин 69 хэлбэртэй охид үнэхээр байсан даа.

Хүүхдүүдийг цөөрөм рүү авч очих хэрэггүй юм болов уу? Тэднийг Маккейний байшингийн зоорь руу аваачсан нь дээр үү? Энэ арай ойрхон. Хоол хүнс хангалттай.

Мэдээж тэнд харанхуй.

-Хүүхдүүд минь би та нарын төлөө санаа тавих болно. Та нар надтай аюулгүй байх болно. Барби үхмэгц бүх хуйвалдаан нурна гэж Жижгээ шивнэв.

Удалгүй тэр шилэнд духаа наагаад унтаад өглөө.

Генриетта Клавар зөвхөн өгзөгөө няцалсан бөгөөд хэдийгээр ахар сүүл хугараагүй боловч аймшигтай өвдөнө. Гэвч 84 настай хүний ямар нэг юм өвдөх юм бол мэдээж аймаар өвдөнө гэдгийг тэр мэдэж байсан. Эхэндээ Генриетта зөвхөн өвдөлт л түүнийг пүрэв гаригийн энэ хар үүрээр сэрээлээ гэж бодов. Тэгэхээр гурван цагт уусан өвчин намдаах эм үйлчилж эхлээгүй бололтой. Түүнээс гадна Генриетта талийгаач нөхрийнхөө тусгай цагирагийг олсон

нь их тус болсон. (Жон нь шамбарам өвчтэй байжээ). Үгүй ээ, сэрээсэн шалтгаан өөр байж. Тэр үүнийг удалгүй ойлгов.

Фрименүүдийн ирланд нохой Бадди ульж байжээ. Бадди бол Кэтрин-Рассел-драйваас салсан Бэтл-стриг богино гудамжны хамгийн хүмүүжилтэй нохой бөгөөд урьд нь хэзээ ч ульж байгаагүй. Тэгээд ч Фримений цахилгаан үүсгүүр нам болсон байна. Гэхдээ Генриетта нохой улих дуунаас биш үүсгүүр гэнэт чимээгүй болсоноос сэрсэн гэж бодов. Орой үүсгүүрийн хүнгэнэх дуу түүнийг бүүвэйлсэн. Тэдний үүсгүүр тачигнаж уухилах юмуу агаарт өмхий утаан үүл хаядаггүй. Нэгэн хэвийн чанга биш хүнгэнэх дуу нь тайвшруулж байв. Ийм цахилгаан үүсгүүр их үнэтэй байх даа гэж Генриетта бодсон. Гэхдээ Фрименд энэ юу ч биш. Нэгэн цагт Том Жим Реннигийн авах гэж оролдсон "Тоёота" салон Уилл Фрименийх. Хэдийгээр машин худалдагчдын хувьд хүнд хэцүү цаг тохиосон ч Уилл бусдаас ялгардаг байлаа. Зөвхөн өнгөрсөн жил гэхэд тэр эхнэрийн хамт байшингийнхаа дэргэд бас нэг залгаа барилга босгосон.

Гэвч энэ улилт. Нохой их өвдөж шаналж байгаа бололтой. Тэднийх шиг сайхан аашгай хүмүүс хайртай нохойнхоо гомдолыг шууд л анхаармаар юм даа... Яагаад анхаарахгүй байна вэ?

Генриетта орноосоо сугарч цонхон дээр очлоо. Фримений хоёр давхар байшин аравдугаар сарын сүүлийн хагасын өглөө эрт хэдий ч хурц цэвэр биш харин бүүдгэр саарал болсон гэрэлд алган дээр мэт харагдав. Цонхон дээр ирэхэд нохойн дуу илүү тод сонсогдсон ч тэднийд хэн нэгэн хөдлөх нь үл харагдана. Байшин тас харанхуй байх ба нэг ч цонхонд гэрэл асахгүй байв. Эзэд нь хаа нэг тийшээ явчихжээ гэж бодож болохоор байсан ч орцны өмнөх зам дээр хоёр машин нь хоёулаа байлаа. Тэд ер нь хаашаа явж чадах вэ дээ.

Нохой ульсаар байв.

Генриетта халат ба углааш өмсөөд гэрээс гарав. Явган хүний зам руу хүрч явтал дэргэд нь машин зогслоо. Дуги эмнэлэг рүүгээ явж байгаа нь эргэлзээгүй. Дутуу унтсанаас нүд нь хавдсан байх бөгөөд гартаа "Эглантери"-гийн шошготой цаасан аяга барьсан нь цаг алдахгүйн тулд кофегоо замдаа ухаар шийдсэнийх.

-Хатагтай Генриетта та зүгээр үү?

-Фрименийх нэг л биш байна. Чи сонсов уу?

-Тийм ээ.

-Тэд ч бас сонсмоор юм. Машин нь байна. Яагаад тэд нар нохойгоо болиулахгүй байна вэ?

-Би үзээд ирье. Та эндээ байж бай гээд Дуги кофегоо балгаж аягаа машины хамар дээр тавив.

-Дэмийр гээд Генриетта тоосонгүй.

Тэд явган хүний замаар хорин ярд алхаад Фримений орцны зам руу эргэлээ. Нохой ульсаар л байв. Хэдийгээр өглөө дулаан байсан ч улих дуунаас болоод Генриеттагийн арьс арзайв.

-Агаар их муу байна. Би дөнгөж нөхөрт гарах тэр үед, цаасны үйлдвэрүүд ид ажиллаж байхад Рамфордод ийм үнэртэй байсан. Хүнд их хортой гэж тэр гомдоллоно.

Дуги амандаа нэг юм бувтнаад хаалганы хонхыг дарав. Хэн ч хариулаагүй тул хаалгыг тогшиж дараа нь дэлдэв.

-Цоожгүй юм биш биз. Үз гэж Генриетта хэллээ.

-Болох эсэхийг мэдэхгүй байна...

-Больж үз гээд Генриетта түүний хажуугаар дайрч бариулыг дарвал хаалга нээгдлээ. Дотор нь нам гүм байв. Өрөөнүүд өглөөний өтгөн сүүдэрт нуугджээ. -Уилл, Лу та нар энд байна уу?

Хэн ч хариулсангүй. Нохой ульсаар байв.

-Нохой арын хашаанд байх шиг байна гэж Дуги хэллээ.

Тийшээ очих хамгийн богино зам нь гэр дотуур өнгөрөх явдал. Гэвч тэдэнд энэ замыг ашиглах хүсэл төрсөнгүй. Тиймээс тэд орцны зам дээр буцаж очоод Уиллийн машинаа биш харин тоглоомууд нь болох хоёр цаснаа явагч, дөрвөн дугуйт мотоцикл, газар сайгүй явагч "ямаха" мотоцикл ба хондагийн "голд уинг" мотоцикл зэргээ байлгадаг гарааш ба байшингийн дундуур тавьсан, гөлгөр хавтангаар хучсан замаар алхав.

Фримений хашаа өндөр битүү ханаар хүрээлэгджээ. Нарийн зам намхан хаалганд тулав. Дуги дөнгөж хаалгыг нээтэл далан фунт жинтэй, айж сандарсан ирланд нохой түүнийг шууд мөргөлөө. Дуги гэнэтийн энэ зүйлээс болж хашгираад гараа өргөсөн ч нохой түүнийг хазах оролдлого хийсэнгүй. Бадди аврагдсандаа баярлажээ. Тэр Дугигийн сүүлчийн цэвэр цамцан дээр урд хөлөө тавьж шавхай болгонгоо сувилагчийн нүүрийг долоож гарав.

-Боль гэж Дуги хашгирлаа. Баддиг түлхэхэд өнөөх нь дөрвөн хөл дээрээ газардсанаа тэр дороо хойд хөл дээрээ босч, урд хөлөөрөө цамцан дээр шинэ мөр гаргангаа ягаан хэлээрээ Дугигийн хацрыг долоов.

-Бадди суу гэж Генриетта тушаалаа. Нохой тэр дороо суугаад харцаа тэр хоёрын хооронд шилжүүлэнгээ ульж гарав. Удалгүй түүний дор шээсний шалбааг үүслээ.

-Хатагтай Генриетта энэ ч сайн биш шүү.

-Сайны тэмдэг биш.

-Та нохойтой үлдвэл яасан...

Генриетта тургиж орхиод Фримений хашаа руу шийдэмгий оров. Дуги түүнийг гүйцэхээс өөр аргагүй боллоо. Бадди толгойгоо унжуулж сүүлээ хавчин ульсаар тэднийг дагав.

Тэд чулуун хавтанцар шигтгэсэн дотор хашаанд ороход "гал тогоо хаалттай" гэсэн бичээстэй ногоон өнгийн ус үл нэвтрэх даавуугаар нямбай хучсан хоовон байна. Хоовонгийн цаана

зүлэгний ирмэг дээр улаан модон тавцан байх ажээ. Энд жакузи суулгасан байв. Дуги бодохдоо энэ өндөр битүү хашаа ганцхан зорилготой байсан нь эднийхэн нүцгэнээр усанд сэлэх, тэр бүү хэл хэрэв хүсвэл жакузид булхах үед хэн ч харахгүй байх явдал ажээ.

Уилл ба Лу нар одоо устай онгоцондоо сууж байгаа боловч тэдний шумбадаг байсан цаг ард хоцорчээ. Тэдний толгойд гялгар уут углаастай байх бөгөөд хүзүүгээр нь резин юмуу оосроор ороосон харагдана. Уут дотроо хөлөрсөн боловч Фрименүүдийн царай харагдахгүй болтолоо хөлрөөгүй ажээ. Тэр хоёрын цогцосны хажууд улаан модон ширээн дээр вискитэй лонх ба шахмалын сав харагдана.

-Зогс гэж Дуги өөрийн эрхгүй хэлэв. Тэр энэ үгийг өөртөө юмуу эсвэл Генриеттад хэлж байгаагаа мэдсэнгүй. Магадгүй ахиад л гунигтай улих Баддид хэлсэн байж болно. Гэхдээ нохойнд ингэж хандахгүй нь тодорхой болохоор тэр талийгаач нарт хандаж хэлжээ.

Генриетта зогссонгүй. Тавцанд дөхөж очоод яг цэрэг шиг цэх нуруулан хоёр шаг өгсч, одоо өөрчлөгдсөн эелдэг хөршүүдийнхээ царайг харлаа. (тэд хэвийн хүмүүс байсан).

Дараа нь вискитэй лонхыг харав. (энэ нь "гленливет" байсан учир тэд үхэн үхтэлээ нэг архиндаа үнэнч байжээ). Эцэст нь "Сандерсын хотын эмийн сан" дэлгүүр гэсэн шошготой савыг авч харав.

-Амбиен юмуу эсвэл лунеста юу гэж Дуги сөөнгөтөн асуув.

-Амбиен байна. Тэр миний ойлгосноор сүүлчийн шөнө нойрны эмээ хуваалцаж дээ гэх Генриеттагийн хоолой ам нь хатсан боловч дуу нь бараг хэвийн байлаа.

-Зурвас байна уу?

-Энд алга. Магадгүй гэрт нь байж мэднэ.

Гэвч зурвас олдсонгүй. Ямартаа ч ил харагдахгүй байв. Тэгээд ч тэд гэрээслэл зурвасаа нуух санаа хүний толгойд төрөх шалтгааныг бодож олсонгүй. Бадди өрөөнөөс өрөө дамжин тэднийг дагахдаа улихаа больсон бөгөөд харин дотроо аяархан гийнах ажээ.

-Түүнийг гэртээ авах хэрэгтэй юм байна гэж Генриетта шийдлээ.

-Тэгэхээс өөр арга алга. Би эмнэлэг рүү аваачиж чадахгүй. Би Стюарт руу утасдаж тэднийг ирж ав гэж хэлнэ гээд Дуги эрхий хуруугаараа мөрөө давуулан заав. Ходоод нь донслон хөдлөх боловч хамгийн муу нь түүнийг сэтгэл гутрал хучин авлаа. Ихэнхидээ нарлаг байдаг сэтгэлийг нь өгтөн сүүдэр хучив.

-Тэд яагаад ийм юм хийх болсныг би ойлгохгүй юм. Хэрэв бид Бүрхүүл дор жил... эсвэл сар... амьдарсан бол ойлгож болно. Гэтэл долоо ч хоноогүй. Үгүй ээ. Сэтгэц эрүүл хүн гай зовлонд ийм хариу барьдаггүй гэж хэлээд Генриетта толгой сэгсэрлээ.

Дуги тэдний сэдлийг ойлгож байна гэж бодсон ч Генриеттад хэлсэнгүй. Тэд Бүрхүүл дор сар амьдарч чадах байсан. Жил ч чадна. Түүнээс урт хугацаанд байж болно. Улам бохирдох агаар,

дуусах нөөц, бороогүйгээр. Хэрэв дэлхийн шинжлэх ухаан техникийн дэвшлийн тэргүүлэгч болох түүний эх орон өнгөрсөн хугацаанд тулгарсан асуудлыг шийдэх нь байтутай Честерс-Миллтэй юу болсныг ойлгож ч чадахгүй байгаа бол удахгүй чөлөөлөгдөх нь худлаа. Уилл үүнийг ойлгосон бололтой. Эсвэл энэ санаа Лугийнх байж болно. Цахилгаан үүсгүүр амьсгаа хураахад бүсгүй "Хонгор минь жакузигийн ус хөрч амжихаас өмнө үүнийг хийе. Ходоод дүүрэн байгаа дээрээ Бүрхүүл дороос гарцгаая. Чи юу гэмээр байна. Ганц удаа шумбаад замд гарахын өмнө хэдэн аяга ууцгаая" гэж хэлсэн байх.

-Онгоц тэвчээрийн сүүлчийн дусал болж өгсөн байх. Өчигдөр Бүрхүүлийг мөргөсөн "Эйр Айлэнд" гэж Дуги хэлэв.

Генриетта үгээр хариу хэлсэнгүй. Бүгшин ханиагаад цэрээ гал тогооны угаалтуур руу нулимлаа. Тэр өөрийн дургүйцлийг ийм эвгүй аргаар илэрхийлэв. Дараа нь тэд байшингаас гарлаа.

-Олон хүн ингэх байх тийм үү? Яагаад гэвэл амиа хорлох вирус заримдаа ханиад шиг агаарт түтдэг гэж тэр орцны замын төгсгөлд очингоо хэллээ.

-Зарим нь аль хэдийн ингэчихсэн.

Нэгэн дуунд гардаг шиг амиа хорлох нь өвдөлт өгдөггүй эсэхийг Дуги мэдэхгүй. Гэхдээ тодорхой нөхцөл байдалд халдвартай. Ялангуяа нөхцөл байдал тодорхой бус байх агаад яг өнөө өглөөнийх шиг салхигүй, хэвийн бус, дулаан өглөө агаар дотор муухайрам үнэртэй байх юм бол бүр их халдвартай.

-Амиа хорлогчид бол хулчгарууд. Энэ бол ямар ч өөр тайлбаргүй үнэн гэж Генриетта итгэлтэй мэдэгдэв.

Төрсөн эцэг нь ходоодны хорт хавдараар удтал аймшигтай шаналж үхэхийг үзсэн Дуги түүний баталгааны үнэн зөвд эргэлзэж байсан ч юу ч хэлсэнгүй.

Генриетта ясан өвдөг дээр гараар тулаад нохой руу тонгойлоо. Нохой түүнийг үнэрлэхээр толгойгоо өргөв.

-За үсэрхэг найз минь хөрш айлдаа орж дээ. Надад гурван өндөг бий. Муудахаас нь өмнө чи идэж болно гээд тэр гэр рүүгээ алхсанаа дахин эргэж Дуги руу хараад -Тэд хулчгарууд гэж хашгирав.

Жим Ренни эмнэлгээс гарч өөрийнхөө ичээнд сайн унтаад сэргэг хүчтэй болж сэрэв. Хэдийгээр тэр үүнийг хэзээ ч, хэнд ч хэлэхгүй боловч түүний ийнхүү бөх бат унтсан нь гэрт Жижгээ байхгүйтэй холбоотой.

Тэгээд одоо өглөөний найман цаг гэхэд түүний хар хаммер Роузын ресторанаас холгүй зогсоно. Тэр Рэндолф, Мел, Дентон ба Картер нартай хамт хооллож байв. Картер Том

Жимийн баруун гарын дүрд улам гүн орсоор байв. Одоо тэр хоёр гар буутай явах болсон. Өөрийнх нь буу гуян дээр нь санжиганах ба саяхан Линдагаас хураасан бууг мөрнөөс зүүсэн хуйнд хийжээ.

Энэ дөрөв үргэлж энд байдаг хүмүүсийг ичих зовох юмгүй хөөгөөд цуу ярианы ширээг эзлэв. Роуз тэдэнд ойртоогүй бөгөөд Энсоныг үйлчлэхээр явууллаа.

Том Жим ээжийнхээ хийдэг байсан гахайн тосонд шарсан талх, хоёр ширхэг зайдас ба нүдэлж шарсан гурван өндөг захив. Тэр холестерины хэрэглээг багасгах ёстойг мэдэж байсан ч өнөөдөр бол нөөцөлж болох бүх эрч хүч шаардагдахыг мэдэрч байлаа. Түүндээ хүрэх юм бол өнөөдөр лав биш. Бас дараагийн хэдэн өдөр ч биш. Үүний дараа бүх юм хяналтанд орох тул холестеринтойгоо учраа олох боломж гарна. (Энэ үлгэрийг тэр өөртөө арван жил ярьж байна).

-Боуи хаана байна. Энэ тэнэг Боуи нар надад хэрэгтэй. Тэд хаана байна гэж Картераас асуув.

-Тэд Бэтл-Стрит руу явахаас аргагүй болсон. Ноён ба хатагтай Фрименүүд амиа хорложээ.

-Тэр булшлуулмар шалчгар өөртөө гар хүрсэн хэрэг үү? гэж Том Жим дуу алдлаа. Лангууны урдуур сууж Си-Эн-Эн үзэж байсан хэдэн үйлчлүүлэгч түүн рүү эргэж харсанаа эргээд зурагтаа ширтэв.

-Үүнд гайхах юмгүй гэж хэлэхдээ Ренни одоо "тоёота" салон түүний гарт өөрөө орж ирнэ гэж бодлоо. Гэвч тэр салон одоо хэнд хэрэгтэй юм бэ? Ренни том олз шүүрч чадна. Бүхэл бүтэн хот. Гүйцэтгэх засаглалыг авангуутаа зарлахыг хүсч байгаа тушаалуудын жагсаалтаа хүртэл тэр бичиж амжжээ. Өнөө орой хотын бүх нийтийн хурал дээр. Дашрамд хэлэхэд тэр биеэ тоосон тэр гичийн хүү ба түүний том хөхтэй шулмас эхнэрийг аль хэдийнээс үзэн яддаг болсон.

-Залуус аа тэр эхнэр Лу-гийн хамт тэнгэрт хооллож байгаа гэж Ренни хэлээд дуугүй болсноо гэнэт тачигнатал инээв. Улс төрийн алдаатай алхам мөн боловч тэр өөрийгөө яаж ч чадсангүй. -Зарц нарт зориулсан хоолны өрөөнд байгаа. Үүнд бол би эргэлзэхгүй.

-Боуи нар тэнд байх хооронд бас нэг дуудлага ирсэн. Динсморын фермээс. Бас амиа хорложээ гэж Картер үргэлжлүүлэв.

-Хэн бэ? Олден уу? гэж Рэндолф асуув.

-Үгүй. Эхнэр нь.

-Харин энэ удаад харамсах ёстой. Нэг минут толгой бөхийе гэж Том Жим хэлээд гараа сунгахад нэг гараас нь Картер нөгөө гараас нь Мел барьж Рэндолф Дентон нар цагирагийг битүүлэв.

-Бурхан минь гуйя. Тэдний хөөрхий сүнсийг амраа. Христийн нэрийн өмнөөс аминь гээд Том Жим толгой өргөснөө: -Одоо ажилдаа орцгооё Пит.

Рэндолф тэмдэглэлийн дэвгэрээ гаргалаа. Картер түүнээс өмнө тавагны хажууд дэвгэрээ тавьжээ. Том Жимд энэ залуу улам их таалагдах болов.

-Би алдагдсан хийг олсон. ХБЭ дээр байгаа гэж Ренни зарлав.

-Бурхан минь, бид тийш нь ачааны тэрэг явуулж авчрах хэрэгтэй гэж Рэндолф дуу алдав.

-Тийм. Гэхдээ өнөөдөр биш. Маргааш, бүх хүн хамаатан садантайгаа харьцах үеэр. Би үүн дээр ажиллаад эхэлчихсэн. Ах дүү Боуи, Рожер нар явна. Бас хэдэн цагдаа хэрэгтэй. Фредди Мел нар. Миний бодлоор дээр нь дахиад 4-5 хэрэгтэй. Картер чи биш шүү. Чи надтай байгаасай гэж би хүсч байна.

-Хэдэн хийтэй чингэлэг авчрахад цагдаа ямар хэрэгтэй юм бэ? гэж Рэндолф асуув.

-Харж байна уу? гэснээ Жим өндөгний шарыг хэрчим талхаар арчиж авангаа: -Бүх юм ахиад л манай найз Барбара ба хотын нөхцөл байдлыг тогтворгүйжүүлэх түүний төлөвлөгөөн дээр буцаад оччихлоо. Радио станц дээр зэвсэгтэй хоёр хүн байна. Тэд хар тамхи үйлдвэрлэх лабораторийг хамгаалж байгаа бололтой. Барбара өөрөө манай хотод ирэхээсээ хавьгүй өмнө энд бүхнийг бэлтгэсэн гэж би бодож байна. Бүхнийг маш нарийн нягт төлөвлөжээ. Одоогийн хамгаалагчдын нэг нь Фил Буши.

-Тэр ажилгүй амьтан гэж Рэндолф бувтнав.

-Хоёр дахь нь хэлэхэд гунигтай байгаа ч Энди Сандерс.

Рэндолф шарсан төмснөөс нэг уртыг хатгаж байснаа санаанд оромгүй юм сонссондоо сэрээгээ алдахад өнөөх нь ширээн дээгүүр ойв.

-Энди юу даа?

-Гунигтай боловч бодитой. Барбара түүнийг элсүүлж чаджээ. Би үүнийг багтай мэдэж байгаа ч хэн хэлснийг нь надаас битгий асуу. Хэлсэн хүн нь нэрээ нууцгахыг гуйж байна гэснээ Том Жим санаа алдаад өндөгний шар нялсан хэрчим талхыг амандаа чихэв. Бурхан минь, энэ өглөө тэр ямар сайхан байна вэ?

-Миний ойлгож байгаагаар Энди мөнгөний гачаалд оржээ. Банк түүний дэлгүүрийг хаах гэж байж. Бизнес тэр ухаан муутай.

-Хотыг удирдахдаа ч мөн адил гэж Дентон нэмлээ.

Том Жим тушаал багатай хүн яриаг нь таслахад ерөнхийдөө дургүй байдаг ч өнөөдөр энэ түүнд таалагдав.

-Харамсалтай нь энэ үнэн гээд бүдүүн гэдэс нь олгох боломжийн хэрээр ширээн дээр тонгойгоод:

-Би өчигдөр хий авчрахаар хүмүүс явуулсан. Ачааны тэрэгний нэг рүү нь Буши тэр хоёр

буудсан байна. Урд дугуйнуудыг нь цоо буудсан. Энэ шалчгар бааснууд аюултай юм.

-Зэвсэглэсэн хар тамхичид. Хууль сахиулах байгууллагын хар дарсан зүүд. Тийшээ явах хүмүүс сум үл нэвтрэх хантааз өмсөх ёстой гэж Рэндолф толгой дохив.

-Ажил хэрэгч санаа.

-Би Эндигийн аюулгүй байдлыг баталж чадахгүй.

-Бурхан чамд хайртайг би мэднэ. Хийх ёстой юмаа л хий. Бидэнд хий хэрэгтэй. Хот хийгүй байж чадахгүй. Өнөө орой хотын бүх нийтийн хурал дээр хийн нөөц олсон тухай би зарлах гэж байгаа.

-Намайг тийшээ явуулахгүй гэдэгтээ та итгэлтэй байна уу, ноён Ренни? гэж Картер асуув.

-Үүнд чиний урам хугарч байгааг би мэднэ. Гэвч чи маргааш намайг дагах хэрэгтэй. Тэдний өнөөх уулзалтын үдэшлэг зохиох газар руу. Рэндолф ч бас. Хэн нэгэн энэ ажлыг зохицуулах ёстой. Эс тэгвэл бүрэн булингар болно. Хүмүүс бие биенээ дарж алахгүйн тулд бид бүх хүчээ тавих ёстой. Гэвч зарим нэг нь гишгэлүүлж таарна. Яагаад гэвэл ард түмэн биеэ жолоодож чаддаггүй. Дугид тийшээ түргэний тэрэг аваач гэж хэл.

Картер үүнийг бичиж авлаа. Түүнийг бичих хооронд Том Жим Рэндолф руу эргэв. Түүний царайд гуниг тодорно.

-Энэ бүхнийг ярих хүсэл огт төрөхгүй байгаа боловч Пит минь миний мэдээлэгч Жижгээ ч бас тэр хар тамхиныг лабораторитай холбоотой гэсэн.

-Жижгээ юу даа? Жижгээ л лав биш гэж Мел давтан асуув.

Том Жим толгой дохиод хуурай нүдээ алгаар арчив.

-Надад ч бас итгэхэд хэцүү байна. Би үүнд итгэхийг

хүсэхгүй. Гэвч тэр эмнэлэгт байгааг та нар мэднэ. Бүгд толгой дохилоо.

-Хар тамхины тун хэтрүүлсэн гэж Ренни ширээн дээр улам тонгойн шивнэв. -Сүүлийн үед түүнтэй тохиолдоод байгаа бүхний хамгийн боломжит тайлбар энэ бололтой гээд тэр нуруу тэнийж Дентон руу анхаарал хандуулаад: -Тийшээ гол замаар очих гэж битгий оролдоорой. Хамгаалагчид үүнийг л хүлээж байгаа. Радиостанцаас дорно зүгт ойролцоогоор нэг миль зайд туслах зам бий...

-Би түүнийг мэднэ. Нэгэн цагт Сэм Вердрогийн өмч байсан ойн зурвас тэнд байдаг. Дараа нь банкны мэдэлд очсон. Харин одоо бол Ариун Гэм цайруулагч сүмийн газар гэж Дентон дундуур нь ярьлаа.

Том Жим инээгээд толгой дохив. Гэвч үнэн хэрэгтээ энэ газар Невадагийн корпорацийн өмч бөгөөд ерөнхийлөгч нь тэр өөрөө юм.

-Энэ замаар яваад радиостанц руу араас нь орох хэрэгтэй. Тэндхийн ой хөгшин болохоор та нар ядралгүй нэвтэрнэ.

Том Жимийн гар утас дуугарав. Тэр дэлгэц рүү хараад дуут шуудан тавих гэснээ дараа нь бодлоо өөрчиллөө. "Яагаад үгүй гэж". Ийм өглөө Кокс амандаа хөөс цахруулан ямар нэг юм баглахыг сонсох тааламжтай.

-Ренни байна. Хурандаа Кокс та юу хүсээ вэ? гээд тэр сонсож эхэлсэнээ инээмсэглэл нь буув.
-Таны үнэн ярьж байгаа эсэхийг би хаанаас мэдэх вэ? гээд тэр дахин сонссоноо салах үт хэлэлгүй яриагаа дуусгав. Авсан мэдээллийг толгойдоо чанан хөмсөгөө зангидаж суулаа. Толгойгоо өргөж Рэндолф руу хандаад: -Манайд Гейгерийн тоолуур байгаа юу? Атомын хоргодох байранд байгаа юу?

-Юу ч мэдэхгүй. Эл Тиммонс мэдэж магадгүй.

-Түүнийг олж шалга.

-Энэ тийм чухал юмуу? гэж Рэндолф Картер хоёр зэрэг асуув.

-Босс оо, энэ чинь цацраг туяа гэсэн үг үү?

-Санаа зовох юмгүй. Хэрэв Жижгээ энд байсан бол тэр, "зүгээр л намайг замаас минь хазайлгахыг оролдож байна" гэж хэлэх байсан. Би үүнд итгэлтэй байна. Гэхдээ Гейгерийн тоолуурын талаар мэдэж ав. Хэрэв байгаа болоод ажиллаж байвал надад авчир гэж Том Жим тушаав.

-За гэх Рэндолфын царайнд айдас тодорлоо.

Том Жим яриаг дуут шуудан руу холбоогүй болоод тоолуурын тухай ярьсандаа харамслаа. Мел мэдээж чалчина. Тэгээд цуу тарна. Рэндолф өөрөө ч донгосно. Гэтэл айх юм юу ч байхгүй байж мэднэ. Тэр зэс духтай шалчгар амьтан энэ сайхан өдрийг эвдэх гэж оролдож байж мэднэ. Магадгүй түүний амьдралын хамгийн чухал өдөр.

Дентон гол сэдвээс хазайх гэсэнгүй.

-Ноён Ренни тэгээд бид хэзээ радиостанц руу дайрах вэ?

Том Жим уулзалтын өдрийн тухай мэдэх бүхнээ толгойдоо эргэлдүүлээд дараа нь инээмсэглэв. Жижиг шүднүүдээ ил гарган чин сэтгэлээс баяртай инээлээ.

-Арван хоёр цагт. Тэр үед бүгд 119-р зам дээр овоороод хот бараг хоосорно. Та нар радиостанц руу дайрч, бидний хийг сандайлсан хоёр булшинд ормор амьтдын учрыг ол. Яг 12 цагт. Хуучны барууны нэгэн кинонд гардаг шиг. (энэ нь "Яг үд дунд" гэдэг киног хэлжээ).

байлаа. Маргааш энэ зам машинаар дүүрч яндангийн угааны хар үүл хөших болно. Харин өнөөдөр бол хоосон байв. Роуз жолоо барьж Эрни зорчигчийн сандалд суух бөгөөд тэдний дунд хөдөлгүүрийн бүрхүүл дээр Норри тухалжээ. Тэр гартаа эрд эдүүгээгийн "Сталаг№17"-гоос эхлээд "Дэд милкмен" хүртэл панк хамтлагуудын наалт наасан скэйтээ барьсан байлаа.

-Агаар ямар муухай үнэртэй юм бэ? гэж Норри гомдоллов.

-Энэ Престил-Стрим гол. Тэр одоо Моттон руу урсахын оронд том өмхий намаг болсон гэж Роуз хариулав. Шалтгаан зөвхөн хатсан голд байгаа биш гэдгийг тэр мэдэж байвч ярихыг хүссэнгүй. Тэд тэртэй тэргүй амьсгалах ёстой болохоор, юу үнэрлэхэд хүрч байгаадаа санаа зовоод яахав дээ.

-Чи ээжтэйгээ ярьсан уу?

-Тийм гэж Норри барайн хариуллаа. -Тэр явах болно. Гэхдээ энэ санаанд нэг их баярлаагүй.

-Жоани цаг нь болохоор хүнс авна биз дээ?

-Тийм ээ, багаажаа дүүргэнэ гэж хэлэхдээ Норри Жоанигийн хувьд хамгийн түрүүнд спиртээ нөөцөлж ачаад харин хүнс бол хоёрдугаар хийл хөгжим гэдгийг хэлсэнгүй. -Гэвч цацраг туяа яасан бэ Роуз? Бид бүх машиныг тугалган туузаар боож чадахгүй.

-Хэрэв хүмүүс цацраг туяаны бүсээр нэгээс хоёр удаа гарахад юу ч болохгүй.

Роуз энэ тухай мэдээллийг интернетээс олж аваад өөрөө итгэсэн. Түүнээс гадна цацраг туяаны аюул нь цацрагийн хүчээс бас хамаардаг гэдгийг мэднэ. Хөндлөнгөөс хянах боломжгүй зүйлээс болж түгших нь утгагүй хэрэг.

-Хамгийн гол нь нөлөөлөх цагийг хязгаарлах ёстой. Тэгээд ч Жо цацраг туяаны бүс нэг их өргөн биш гэсэн.

-Жо-гийн ээж явахыг хүсэхгүй байна лээ гэж Норри хэллээ.

Роуз санаа алдав. Тэр үүнийг мэдэж байгаа. Уулзалтын өдөр сайн муу талтай. Нэг талаар тэдний зугталтыг халхалж өгөх боловч Бүрхүүлийн гадна хамаатан садан нь үлдсэн хүмүүс тэдэнтэйгээ уулзалдахыг хүсч байв. Түүний нөхөр азтай тасалбар сугалахгүй ч байж мэдэх юм гэж Роуз бодов.

Урьд нь "Жим Реннигийн хуучин автомашины салон" харагдах бөгөөд том самбар дээр "Тэрэг сонгохдоо та азтай байх болно. Том Жим үүнд тусална" гэсэн бичигтэй том самбар гарч ирэв. Бас "Манайхаас зээл аваарай" гэжээ.

-Санаж ав... гэж Эрни эхэллээ.

-Би мэднэ. Хэрэв тэнд хэн нэгэн байвал зүгээр л эргээд хот руу буцна гэж Роуз яриаг нь таслав.

Зогсоол дээр "Зөвхөн өөрийн ажилтнуудад" гэсэн бүх талбай хоосон байлаа. Харин хаалган дээр "Дараагийн удирдамж иртэл хаалттай" гэсэн зарлал өлгөжээ. Роуз барилгыг яаран тойров. Ар талын том зогсоол дээр хөнгөн тэрэг ба пикапууд эгнэсэн байх бөгөөд салхины шилэн дээрээ үнэ болоод янз бүрийн уриа бичиж наажээ. "Азтай худалдан авалт". "Сэтгэл шингээж бүтээсэн". "Миний хичнээн сайхныг хараач" гэх мэтээр. (бүх О үсгийг тачаангуй эмэгтэйн нүд шиг урт сормуустай дүрсэлжээ). Үнэн хэрэгтээ энд үзэх бүх юмаа үзсэн ажлын моринууд байх бөгөөд үзүүлэх танхимд тавигддаг детройт ба немец цэвэр үүлдрийн морьдын чигчид ч хүрэхгүй. Харин хамгийн цаад төгсгөлд торон хашааны дэргэд салоны нутаг дэвсгэр ба ойн бохир зурвасыг заагласан тэр газарт бөөрөн дээр нь "АГ ба Т" гэсэн шошготой харилцааны компанийн хуучин микроавтобуснууд тавьжээ.

-Энэ дээ гээд Эрни эргэж сандал дороосоо урт нарийхан төмөр савх гаргаж ирлээ.

-Энэ чинь дэгээ түлхүүр байна. Чамд яахаараа ийм юм байдаг юм бэ? гэж Роуз түгшүүртэй байсан мөртлөө инээд алдав.

-"Хүнсний ертөнц"-д ажиллаж байх тэр үеэс. Хичнээн хүн түлхүүрээ машиндаа орхиж түгждэгийг чи төсөөлж ч чадахгүй.

-Өвөө та хөдөлгүүрийг яаж асаах юм бэ? гэж Норри асуув. Эрни үл мэдэг инээмсэглэлээ.

-Ямар нэг юм бодож олно оо. Роуз зогс гээд тэр бууж нас нь дал дөхөж яваа хүн гэхэд гайхалтай цоглог алхсаар ойрын микроавтобусыг чиглэв. Цонхоор нь шагайж толгой сэгсэрсэнээ дараагийнх руу явлаа. Гурав дахь дээр нь очиход дугуйн хий гарсан байв. Дөрөв дэх машин руу шагайсанаа Роуз руу эргэж эрхий хуруугаа гозойлгов. -Яв. Цаг алдах хэрэггүй.

Ач охин нь дэгээ түлхүүрийг хэрхэн ашиглаж байгааг харахыг Эрни хүсэхгүй байгааг Роуз ойлголоо. Сэтгэл нь хөдөлж үзэсгэлэнгийн танхимыг тойроод зогсов.

-Чамайг энд буулгавал зүтээр биз дээ?

-Зүгээр ээ, хэрэв тэр хөдөлгүүрийг асааж чадахгүй бол бид явган буцна гэж Норри машинаас буухдаа хэллээ.

-Бараг гурван миль шүү. Тэр явж чадах болов уу?

Норригийн царай цайсан ч инээмсэглэж байв.

-Өвөө намайг хол хаяна. Тэр өөрийнх нь үгээр бол үе мөчөө зэврээхгүйн тулд өдөр бүр дөрвөн миль алхдаг. Яваарай. Тэгэхгүй бол хэн нэг нь таныг харчихна.

-Чи зоригтой охин.

-Би өөрийнхөө зоригтойг мэдэрдэггүй.

-Зоригтой хүн үүнийгээ мэдэрдэггүй юм хонгор минь.

Роуз хот руу яваад өглөө. Норри фургоныг харцаараа далд ортол нь үдээд дараа нь скейтээ хөлөглөн хоосон зогсоол дээр хээн мөр зурж гарав. Зогсоол налуу хажууд байрлах тул Норри зөвхөн нэг тал руу явахдаа гараар тулж түлхэж байв... Гэхдээ тэр маш сэтгэл зовж байсан учраас өөрөө ч анзааралгүй хотын талбайн дэргэдэх толгой руу ч гарч мэдэхээр байлаа. Ер нь тэр ямар ч үзүүлбэр хийхдээ юу ч мэдрэхгүй байж мэдэхээр байв. Хэрэв хэн нэгэн ирвэл яах вэ? Микроавтобус үзэхээр өвөөтэйгөө ирсэн гэж хэлнэ. Өвөөгөө хүлээж байна гэж хэлээд дараа нь тэд хот руу хамт буцах болно. Өвөө нь алхах дуртайг бүгд мэднэ. Үе мөчөө зэврээхгүйн тулд. Ганцхан Норри л өөр шалтгаантай гэж боддог. Эмээгийн тархи толгой муудсанаас хойш өвөө нь ингэж алхах болсон. (хэдийгээр энэ нь альцгеймерийн өвчин гэдгийг бүгд мэдэж байсан ч хэн ч ам нээгээгүй). Тэр уй гашуунаас зугтахыг хүсдэг гэж Норри бодно. Ийм юм байж болох уу? Тийм гэж тэр бодно. Өөр дээрээ ч мэднэ. Ямар нэг үзүүлбэр хийхэд бэлдэн скэйтээр гулгаж явахад толгойд нь баяр хөөр ба айдасаас өөр юуны ч зай гардаггүй. Гэхдээ баяр хөөр нь дийлдэг. Айдас бол арын хашаанд нуугдана.

Хэдийгээр Норри тун удсан мэт санагдах боловч богинохон хугацааны дараа барилгын цаанаас харилцааны компанийн микроавтобус гарч ирсэн ба жолооны ард өвөө нь суужээ. Норри скэйтээ сугандаа хавчуулаад үсэрч суув. Тэр амьдралдаа анх удаа хулгайлсан машинаар явах болно.

-Өвөө та жинхэнэ гайхамшиг гээд үнсэв.

7

Жо хөргөгчинд үлдсэн алимны жүүстэй сүүлчийн савнуудын нэгийг авахаар гал тогоо руу явж байхдаа "боргоцой" гэхийг сонсоод зогтуслаа.

Эх эцэг нь анх танилцаад Мэний их сургуульд суралцаж байсан тэр алс өдрүүдэд найз нар нь Сэм Макклэтчиг "боргоцой" гэж дууддаг байсныг тэр мэднэ. Гэвч ээж нь ингэж дуудах нь тун ховор. Хэрэв хэллээ гэхэд энэ хоч нэр ямар нэг эвгүй утгатай мэт улайж инээдэг байв. Жо тэр утгыг мэдэхгүй. Гэхдээ өөр юмыг мэдэж байлаа. Хэрэв ээжийнх нь амнаас энэ эртний хоч нэр гарсан бол тэр тун ууртай байгаа гэсэн үт.

Тэр гал тогооны хагас нээлттэй хаалганд дөхөж очив. Дүрэмт хувцасны оронд хуучирсан жинс ба цамц өмссөн Жекки ээж хоёрыгоо олж харлаа. Хэрэв тэд хаалга руу харж зогссон бол тэд ч бас түүнийг харах байсан. Жод нуугдах санаа үгүй бөгөөд үүнийг муу үйлдэлд тооцно. Тэр тусмаа ээж нь ууртай бол. Гэвч хоёр эмэгтэй бие бие рүүгээ харжээ. Гал тогооны ширээнд суусан байна. Жекки Клерийн гарыг барьжээ. Эхийнх нь нүд нойтон байхыг хараад тэр ч бас уйлмаар болов.

-Болохгүй. Чиний хүсч байгааг би мэднэ. Гэвч болохгүй. Тэр тусмаа өнөөдөр бүх юм бодсоноор болох юм бол гэж Жекки хэллээ.

-Би үнэхээр түүн рүү ядахдаа утасдаад маргааш очихгүй гэдгээ тайлбарлаж болохгүй гэж үү? Эсвэл би цахим шуудан илгээе. Үүнийг би хийж чадна.

Жекки толгой сэгсрэв. Царай нь эелдэг байвч тэр шийдвэрээ өөрчлөхгүй бололтой.

Тэр үт алдаж мэднэ. Тэгээд энэ яриа Реннид хүрэх магадлалтай. Хэрэв Ренни биднийг Барби Расти хоёрыг чөлөөлөхөөс өмнө үнэрлэх юм бол гай гарцаагүй.

-Би түүнд хэнд ч биттий хэлээрэй гэж бичвэл...

-Клер чи ойлгохгүй байна гэж үү? Бид дэндүү их юмаар дэнчин тавьжээ. Хоёр хүний амь нас. Бидний амь нас. Чиний хүүгийн, бас гээд тэр дуугаа хураав.

Клерийн мөр буулаа. Дараа нь тэгшрэв.

-Тэгвэл та нар Жо-г аваад яв. Би уулзалтын өдрийн дараа ирнэ. Ренни намайг юунд ч сэжиглэхгүй. Би Дейл Барбараг танихгүй. Растиг ч танихгүй. Хааяа гудамжинд мэндлэхээс цаашгүй. Би Каслл-Рокт эмчлүүлдэг байсан.

-Гэхдээ Жо Барбиг танина. Пуужингийн цохилтын дүрст нэвтрүүлгийг Жо хийсэн. Үүнийг Том Жим мэдэж байгаа. Тэр чамайг шоронд хийгээд бидний хаашаа явсныг хэлэх хүртэл дарамтлах болно.

-Би хэлэхгүй. Хэзээ ч хэлэхгүй.

Жо гал тогоонд орлоо. Клер хацраа арчаад инээмсэглэх гэж оролдов.

-Сайн уу хонгор минь, бид уулзалтын өдрийн тухай ярьж байлаа...

-Ээж ээ тэр зүгээр дарамтлахгүй. Тэр тамлаж мэднэ. Ээжийнх нь царайд айдас тодров.

-Үгүй тэр ийм юм хийхгүй. Ренни муу хүн гэдгийг би мэднэ. Гэхдээ тэр эцсийн эцэст хотын захиргааны гишүүн...

-Тэр хотын захиргааны гишүүн байсан. Харин одоо эзэн хаан болохыг хүсч байгаа. Эрт орой хэзээ нэг цагт бүх юм эхэлдэг гэдэг. Чиний хумсыг нэг нэгээр нь суга татаж байгаагаар Жо төсөөлөхийг чи хүсээд байна.

-Боллоо. Энэ аймшигтай гэж Клер дуу алдав.

Клер гараа суга татах гэж оролдовч Жекки тавьсангүй.

-Асуулт энгийнээр тавигдаж байгаа. Эсвэл бүх юмаа, эсвэл юу ч биш. Харин одоо юу ч биш гэхэд оройтсон. Ажиллаад эхэлчихсэн. Тиймээс бид түүнтэй хамт хөдлөх болно. Хэрэв Барби бидний тусламжгүйгээр өөрөө шоронгоос гарч чадах юм бол Том Жим түүнд явах боломж өгөх байсан. Яагаад гэвэл ямар ч дарангуйлагчид хүмүүсийг айлгах мануухай хэрэгтэй.

Гэвч тэр ганцаараа байхгүй шүү дээ. Тиймээс Том Жим устгахын тулд биднийг олох гэж оролдоно.

-Би үүнд оролцоогүй нь дээр байсан юм. Тэр уулзалтанд Жо-г явахыг зөвшөөрөхгүй, өөрөө ч явахгүй бол дээр байж.

-Гэвч бид түүнийг зогсоох ёстой. Ноён Ренни Миллийг хувиргах гэж оролдож байна... Та ойлгож байна уу? Цагдаагийн улс болгох гэж байна хэмээн Жо эсэргүүцлээ.

-Би хэнийг ч зогсоож чадахгүй. Би зүгээр л гэрийн авгай гээд Клер цурхирах шахав.

-Хэрэв энэ чамайг тайтгаруулах юм бол би хэлье. Хүүхдүүд хайрцаг олох тэр үед чиний сугалаа сугалагдсан гэж Жекки хэллээ.

-Тайтгаруулахгүй. Үгүй.

-Зарим нэг талаар бидэнд, тэр бүү хэл аз дайрсан. Бид энэ түүх рүү хэт олон гэм буруугүй хүнийг татаж оруулаагүй. Одоохондоо оруулаагүй гэж Жекки ярина.

-Ренни ба түүний цагдаа тэртэй тэргүй биднийг олно. Эсвэл чи үүнийг мэдэхгүй байгаа юм уу? Манай хот тийм том биш гэж Клер дуу алдлаа.

Жекки баясгалангүй инээмсэглэв.

Тэгвэл бид олуулаа болно. Зэвсэгтэй ч болно. Ренни үүнийг мэдэх болно.

-Бид радиостанцыг аль болох хурдан эзлэх хэрэгтэй. Хүмүүс нөхцөл байдлын талаарх бидний ойлголтыг сонсох ёстой. Бид тэдэнд үнэнийг хэлэх ёстой гэж Жо хэллээ.

Жеккигийн нүд очтон асав.

-Жо энэ чинь чөтгөр шиг сайхан санаа байна.

-Бурхан минь гээд Клер санаа алдаж нүүрээ дарлаа.

8

Эрни харилцааны компанийн фургоныг Берпигийн их дэлгүүрийн ачих буулгах тавцанд тулгалаа. Одоо би гэмт хэрэгтэн. Харин миний арван хоёр настай охин хамсаатан. Эсвэл арван гуравтай ч билүү? гэж тэр бодов. Гэхдээ түүний нас ямар ч хамаагүй л дээ. Хэрэв Питер Рэндолф тэднийг баривчиллаа гэхэд ач охинд нь насанд хүрээгүй гэх үүднээс хандана гэдэгт тэр эргэлзэж байв.

Ромми арын хаалгыг нээж тэднийг хараад гартаа буу тэвэрсээр ачих буулгах тавцан руу гарч ирлээ.

-Ямар нэг асуудалтай тулгараагүй биз?

-Бүх юм тун сайхан болсон. Зам дээр хүн алга. Өөр зэвсэг байгаа юу? гэж Эрни гишгүүрээр тавцан руу өгсөнгөө асуув.

-Байгаа. Хаалганы ард. Норри чи бас тусла.

Охин хоёр карабин буу аваад зэвсгийг микроавтобусанд ачаалж буй өвөөдөө дамжуулав.

Ромми ачих буулгах тавцан дээр тэрэг түрсээр гарч ирлээ. Дээр нь хуйлаастай тугалган тууз ачжээ.

-Бүтдийг нь одоо заавал ачих албагүй. Би цонхонд тааруулаад тайрна. Нүүрний салхины шилийг тэнд очоод хаая. Яг "шерман" танк шиг, юм харах нарийн зурвас үлдээгээд цаашаа явна. Эрни бид хоёр үүнийг хийж байх хооронд охин минь чи хоёр дахь тэргэнцэрийг түрээд ир. Хэрэв чадахгүй бол орхиорой, бид дараа янзалъя.

Хоёрдугаар тэргэнцэрт хайрцагтай хүнс байлаа. Голдуу жуулчдын хэрэглэдэг нөөшилсөн зүйл бүхий уутнууд ба лаазтай хүнс байна. Нэг хайрцагийг ундаа бэлтгэх зориулалттай уусдаг нунтагаар дүүргэжээ. Тэрэг хүнд байсан ч Норри байрнаас нь арай гэж хөдөлгөмөгц хөнгөхөн гулсав. Гэхдээ охин тэргийг зогсоож чадахгүй байсан. Хэрэв Ромми түүнд туслахаар ирээгүй бол тэргэнцэр тавцан дээрээс нисэх байлаа.

Эрни микроавтобусын арын шилийг тугалган туузны хэрчмээр хаагаад тусгаарлах туузаар бэхэлж наангуугаа духны хөлсөө арчив.

-Берпи минь, Маккойн цэцэрлэг рүү бүхэл бүтэн цуваа явна гэдэг чинь дэндүү аз үзсэн хэрэг шүү.

Ромми мөрөө хавчлаа. Дараа нь хүнстэй хайрцагнуудыг ачиж гарав. Тэдгээрийг хана дагуулан хурааж дундуур нь зорчигчдод зориулан зай үлдээх бөгөөд тэд удахгүй микроавтобусанд сууна гэж найдаж байлаа. Түүний цамцан дээр хөлс нэвчинэ.

-Бид бүгдийг түргэн болоод чимээгүй хийнэ гэж найдах л үлдлээ. Харин хотын бүх нийтийн хурал биднийг халхавчилна. Бидэнд сонголт байхгүй шүү дээ.

-Жулия хатагтай Макклетчи нар өөрсдийнхөө машины цонхыг таглах тугалган тууз авах уу? гэж Норри асуув.

-Тиймээ. Өнөөдөр. Би тэдэнд тусална. Дараа нь тэд машинаа энд дэлгүүрийн ард үлдээх хэрэг гарна. Тугалгаар тагласан шилтэй машинаар хот дундуур яваад байж болохгүй. Хүмүүс асууна шүү дээ.

-Харин чиний "эскалада"-гийн тухайд яах вэ? Чиний машин үлдсэн хүнсийг хахалгүй залгиж чадна даа. Эхнэр чинь жолоон дээр сууж... хэмээн Эрни ярьтал Ромми:

-Миша явахгүй ээ. Энэ бүхэнтэй ямар нэг талаар холбогдохыг хүсэхгүй байгаа юм. Би түүнээс гуйсан. Өвдөг дээрээ сөгдөх шахан бүхнийг хийсэн. Гэвч шал дэмий агаар шатааж дээ. Ингэнэ гэж би мэдэж байсан л даа. Тийм ч учраас түүнд мэдэж байгаагаас нь илүү юм хэлээгүй. Тэр бараг л юу ч мэдэхгүй. Гэвч Ренни түүн дээр ирвэл энэ түүнийг аврахгүй. Гэвч тэр юу ч ойлгохыг хүсэхгүй байгаа.

-Яагаад хүсдэггүй юм бэ? гэж Норри асууснаа өвөө нь дургүйцэн хөмсөг зангидахыг хараад

оновчгүй асуулт болохыг ойлгов.

-Яагаад гэвэл тэр дэндүү зөрүүд. Энэ бүхэн түүнд муугаар эргэнэ гэж би хэлсэн. "Оролдоод үзэг" гэж байна билээ. Миний Миша ийм л хүн. За яахав яахав. Хэрэв дараа нь боломж гарвал хот руу шурдхийгээд бодлоо өөрчилсөн эсэхийг нь мэдчихнэ. Эмэгтэй хүний хувьд энэ ердийн зүйл гэдэг. Алив дахиад хэдэн хайрцаг ачъя. Зэвсэгээ хол тавих хэрэггүй Эрни. Хэрэг болно.

-Охин минь чамайг ийм юманд татаж оруулсандаа итгэж чадахгүй юм гээд Эрни толгой сэгсэрлээ.

-Бүх юм зүтээрээ өвөө. Хажуугаас харж зогссоноос оролцох нь надад дээр гэж Норри цэвэр үнэнээ хэлэв.

9

Пан. Чив чимээгүй Пан. Чив чимээгүй Пан. Чив чимээгүй

Олли Динсмор хөлөө завилаад Бүрхүүлээс дөрөвхөн фут зайд суух бөгөөд хажууд нь гэрийнхээ дэргэдээс цуглуулсан чулуугаар дүүргэсэн хуучин бойскаут үүргэвч хэвгэнэ. Олли бараг гурав нугаран арай гэж чирэхээр тэгтэл дүүргэсэн бөгөөд даавуу нь задарч сумнууд газарт асгарах вий гэж айсан билээ. Гэвч асгараагүй болохоор тэр одоо Бүрхүүлийн дэргэд сууна. Дахин нэг гөлгөр өнгөлсөн чулуу гаргаж ирээд Бүрхүүл руу шидэхэд тунгалаг агаар руу цохиод буцаж ойв. Олли чулууг аваад дахин шидлээ.

Пан. Чив чимээгүй.

Бүрхүүл рүү нэг л шалтгаанаар ирсэн юм. Түүний дүү болоод ээж нь Бүрхүүлээс болж үхсэн. Хөгшин үслэг Есүс үүний гэрч. Оллигийн нэг үүргэвч чулуу бүтэн өдөр хүрэлцээтэй.

Чулуун бумеранг гэж тэр бодоод инээлээ. Чин сэтгэлээсээ инээв. Гэхдээ энэ инээд түүнийг муухай болгоно. Яагаад гэвэл нүүр царай нь дэндүү туржээ. Сүүлийн үед тэр угаас бага идэж байсан бол одоо удахгүй ширээнд сууна гэдэгтээ бүр эргэлзэх болов. Буун дуу сонсоод гал тогоо руу гүйж ирэхэд хормой нь сөхөгдөж дороос нь дотоож нь харагдах ээж нь шалан дээр хэвгэж байхыг олсон бөгөөд толгойн тэн хагас нь зад үсэрсэн байсан...Тиймээ ийм үзэгдэл хоолны дуршилд тусална гэж үү?

Пан. Нам гүм.

Бүрхүүлийн нөгөө талд амьдрал буцалж байлаа. Майхан хот босч байв. Жип ба ачааны тэрэгнүүд ирж буцна. Хэдэн зуун цэргүүд амьсгаа дарах завгүй тушаал хашгирч эсвэл тушаалаа хүчингүй болгох офицеруудын эргэн тойронд овоорно.

Аль хэдийн байсан майхнууд дээр гурван ч урт нэмэгдэв. Тэдгээрийн өмнө "Зочин хүлээж авах цэг №1", "Зочин хүлээж авах цэг №2", "Анхны тусламж үзүүлэх цэг" гэсэн бичигтэй самбарууд харагдана. "Хөнгөн зууш" гэсэн бичигтэй самбар хэмжээгээр нөгөө гурваас ч том

нэг майхны өмнө үзэгдэнэ. Олли энд суугаад чулуу шидэж эхэлсэнээс хойш тун удалгүй зөөврийн нойлтой хоёр тавцант-ачааны тэрэг ирэв. Тэгээд хамаатан саднууд бие биенээ харж ярих боломжтой ч хүрэлцэх боломжгүй тэр газраас нилээд хол зайд тэнгэрийн өнгөтэй бие засах газрууд ярайв.

Ээжийнх нь толгойноос асгарсан зүйл гүзээлзгэний хөгцөрсөн чанамалыг санагдуулж байсан. Тэгээд Олли яагаад ээж нь яг энд, яг заавал ингэснийг ойлгож чадахгүй байв. Яагаад заавал хамтдаа өглөөний цайгаа ууж, үдийн ба оройн хоолоо иддэг байсан тэр өрөөнд? Түүний толгой тэр чигээрээ эргүүтээд, тэр бас юм идэхийг хүсдэг хоёрдахь хүү нь байгаа гэдгийг ухаарахаа больчихсон хэрэг үү? (түрүүлээд өлсөж үхчихгүй л бол). Шалан дээр харсан аймшгийг Олли хэзээ нэг цагт мартана гэж үү?

Тиймээ, тэр бүрмөсөн солирсон. Яагаад гэвэл Рори үргэлж түүний баяр баясгалан ба хайртай хүү нь байсан. Үхэр бэлчих үед би баас цэвэрлэх юмуу эсвэл үнээгээ саахаа мартсан үед л ээж минийх байдгийг санадаг байсан. Эсвэл би гэртээ муу дүнтэй хүснэгтээ авчрах үед. Рори бол зөвхөн онц дүн л авдаг байсан.

Олли чулуу шидлээ.

Пан. Чив чимээгүй.

Хэдэн цэргийнхэн Бүрхүүлийн хязгаараар шинэ заалт тавьж байна.

АНХААР

ТАНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨӨ БҮРХҮҮЛЭЭС 2 ЯРД (6 ФУТ) ЗАЙ БАРИНА УУ

Самбарын нөгөө талд мөн ийм юм бичээстэй байгаа гэж Олли таав. Бүрхүүлийн гадна бол энэ заалт үр дүнгээ өгч мэднэ. Тэнд эмх журамд анхаарах олон хүн байх юм чинь. Харин энэ талд бол хотын найман зуун иргэдэд арваадхан цагдаа оногдохоос ихэнх нь шинэчүүд. Мэдээж тэд хүмүүсийг Бүрхүүл рүү ойртуулахгүйг хичээж мэдэх ч энэ нь элсэн цайзыг далайн давалгаанаас хамгаалахтай адил үр дүн л өгөх байх.

Түүний дотоож норж, алцайж жийсэн хөлний завсар шалбааг үүссэн байсан. Тэр гох дарахынхаа өмнө шээсэн юм болов уу, эсвэл дарангуутаа юу? Олли дараа нь гэж бодож байв.

Тэр чулуу шидлээ.

Пан. Чив чимээгүй.

Нэг цэрэг хажууд иржээ. Залуухан эр. Ханцуйн дээрээ таних тэмдэггүй. Тэгээд Олли түүнийг байлдагч гэж бодлоо. Арван зургаан настай харагдах боловч хамаагүй ах гэдгийг Олли ойлгоно. Цэрэгт очихын тулд насаа нэмдэг залуусын тухай тэр сонссон. Гэхдээ тийм юм энэ бүхнийг хянах чадвартай компьютер бий болохоос өмнө л байж болох талтай гэдэгт үл эргэлзэнэ.

Цэрэг эргэн тойрноо харсанаа түүнийг хэн ч харахгүй байгаад итгэмэгц аяархан ярилаа.

Аялгатай яриа нь өмнө зүгийн хүн болохыг илтгэнэ.

-Үхэрчин-жаал минь. Чи үүнийгээ болихгүй юмуу? Би бүр галзуурлаа.

-Тэгвэл өөр тийшээ яваач дээ.

Пан. Чив чимээгүй.

-Чадахгүй. Тушаалтай.

Олли юу ч хариулалгүй дахин нэг чулуу шидлээ. Пан. Чив чимээгүй.

-Чи яагаад ийм юм хийгээд байгаа юм бэ? гэж цэрэг асуув. Тэр Оллитой ярих боломж олохын тулд дараагийн самбартай ноцолдсоор л байлаа.

-Яагаад гэвэл эрт орой хэзээ нэгэн цагт чулуунуудын нэг нь эргэж ойхгүй. Тэр цагт би босоод явах бөгөөд дахин энэ фермийг хэзээ ч үзэхгүй. Би дахин үнээ саахгүй. Танай тэнд агаар ямар байна даа?

-Сайхан. Гэхдээ сэрүүхэн байна. Би Өмнөд Каролинаас ирсэн. Эндхийн аравдугаар сар Өмнөд Каролиныхоос шал ондоо. Үүнийг би чамд баттай хэлэх байна.

Гэтэл өмнөдийн цэргээс ердөө гурван ярд зайд, Оллигийн сууж байгаа газарт халуун байлаа. Бас өмхий ханхална.

Цэрэг Оллигийн цаад руу заагаад:

-Чи чулуу шидэхээ болиод үнээтэйгээ ноцолдвол яасан юм бэ? Саравчинд нь оруулаад, саагаад, дэлэнг нь тосоор арчаад, ажил хангалттай шүү дээ.

-Тэднийг маллах хэрэггүй ээ. Тэд хаашаа явахаа өөрсдөө мэднэ. Одоо тэднийг саах ч хэрэггүй. Тослох ч хэрэггүй. Сүү өгөхөө больчихсон.

-Тийм үү?

-Тийм. Өвс нэг л биш болчихлоо гэж аав хэлсэн. Агаар нэг л биш байгаа болохоор өвс бас нэг л биш байгаа юм. Энд их муухай үнэртэй байна, мэдэж байна уу? Энд баас л үнэртэж байна.

-Тийм үү? гэх цэргийн царайд гайхшрал тодорлоо. Тэр самбар тогтоох гадсаа дахин хоёр удаа дэлссэн ба уг нь гадас огт ганхахгүй байсан.

-Тийм ээ. Манай ээж өнөө өглөө амиа хорлочихсон.

Цэрэг дахиад цохих гэж байсан алхаа буулгав.

-Чи миний хульхин дээр сарнай ургуулаад байна уу?

-Үгүй ээ. Тэр гал тогооны ширээний хажууд өөрийгөө буудсан. Би түүнийг тэндээс олсон.

-Чөттөр гэж. Ямар аймаар юм бэ? гээд цэрэг Бүрхүүл рүү алхав.

-Өнгөрсөн ням гаригт манай дүү үхсэний дараа бид түүнийг хотод аваачсан. Яагаад гэвэл тэр арай амь тавиагүй байсан юм. Харин ээж бол шууд үхсэн. Бид түүнийг толгой дээр оршуулсан. Аав бид хоёр. Тэр тэнд байх дуртай байсан. Бүх юм ийм аймаар болж эргэхээс өмнө тэр толгой их гоё байсан.

-Бурхан минь. Үхэрчин-жаал чи там туулж гарчээ.

-Одоо ч тэндээ байна гэснээ энэ үг түүний дотор ямар нэг хавх нээсэн юм шиг Олли уйллаа. Тэгээд босч Бүрхүүл рүү алхав.

Одоо цэрэг тэр хоёр бие биенээсээ нэг футээс бага зайд зогсоно. Цэрэг гараа өргөөд хоромхон зуур гүйдэл цохиход ярвайв. Дараа нь алгаа дэлгээд Бүрхүүлд наалаа. Олли ч алгаа дэлгээд өөрийн талаас Бүрхүүлд наав. Тэдний гар хуруу хуруугаа, алга алгаа шүргэлцэх шиг боллоо. Гэхдээ ингэх шиг л боллоо. Яагаад гэвэл нүдэнд үл үзэгдэх саад тэднийг салгаж байв. Маргааш бие биедээ хүрэх гэсэн энэ бүтэлгүй оролдлого хэдэн зуун удаа хэдэн мянган удаа давтагдах болно.

- Үхэрчин-жаал минь...

-Байлдагч Эймс. Новшийн бөгсөө тэндээс зайлуул гэж хэн нэгэн хашгирав.

Байлдагч Эймс яг л жимсний чанамал хулгайлж байгаад баригдсан жаал шиг үсрэн босов.

-Над дээр. Гүйгээд.

- Үхэрчин-жаал минь тэсээрэй гээд байлдагч Эймс загнуулахаар гүйлээ.

Олли түүнийг гүйлгээд л бүх шийтгэл нь дуусна гэж бодов. Яагаад гэвэл байлдагчийн албан тушаалыг бууруулах гэж байхгүй хойно. Түүнийг амьтны хүрээлэнгийн аль нэг амьтантай ярилцсаны төлөө сахилгад суулгахгүй нь мэдээж. "Надад ядахдаа самар өгсөнгүй" гэж Олли бодлоо.

Тэгээд сүү өгөхөө больсон үнээнүүдээ хэсэг харав. Тэр бүү хэл өвс зулгаахаа ч больжээ. Дараа нь үүргэвчнийхээ хажууд өмнөх газраа суулаа. Ухаж байгаад дахин нэг бөөрөнхий чулуу олов. Үхсэн ээжийнх нь сунгасан гарын халцарсан хумсны будагны тухай бодов. Дэргэд нь утаа савсах буу байсан. Чулуугаа шидлээ. Бүрхүүлийг оноод буцаж ойв.

Пан. Чив чимээгүй.

Пүрэв гаригийн үд дундаас хойш бүх Шинэ Английг үүл бүрхэж ганцхан Честерс-Милл дээр оймстой төстэй нүх рүү чиглүүлсэн тольдуур мэт нар тусах тэр цагт Жинни

Жижгээгийн тасагт орлоо. Толгойн өвчин намдаах эм хэрэгтэй эсэхийг асуув. Тэр эхлээд "үгүй" гэснээ бодлоо өөрчилж тайленол юмуу адвил байвал өгөөч гэв. Бүсгүйг эргэж ирэхэд Жижгээ эмийг нь авахаар тасгийг хөнддөн алхлаа. Бүсгүй карт дээр "доголж байгаа боловч урьдынх шиг илт анзаарагдахгүй" гэж бичив.

Харин Терстон Маршалл дөчин таван минутын дараа тасаг руу шагайхад хоосон байлаа. Тэр Жижгээг зурагт үзэхээр амралтын өрөөнд орсон байх гэж бодсон ч тэнд зүрхний шигдээсээр ирсэн Эмили Уайтхаус л байв. Эмили тун түргэн эдгэж байгаа. Хүрэн үстэй доголон алхах залууг харсан эсэхийг түүнээс асуулаа. Үгүй гэж тэр хариулав. Терс Жижгээгийн тасагт эргэж ирээд ханын шүүгээг нээж үзэв. Хоосон байна. Тархины хорт хавдартай залуу хэнд ч юу ч хэлэлгүй хувцаслаад явчихсан бололтой.

11

Жижгээ гэр рүүгээ явж байв. Булчингаа ажиллуулмагц хазганахаа бүр больжээ. Түүнээс гадна түүний зүүн нүдний харааны хагаст нь хөвөөд байсан цоожны хар нүх жижиг бөмбөлөг болтлоо багасчээ. Магадгүй түүнд талийгийн үхлийн тун арай ороогүй бололтой. Хэлэхэд хэцүү. Ямар ч тохиодолд тэр Бурханд өгсөн амлалтаа биелүүлэх гэж байна. Хэрэв Жижгээ эгч дүү Эпплтон нарт санаа тавих юм бол Бурхан түүнд санаа тавих болно.

Тэр эмнэлгийг арын хаалгаар орхин гарахдаа (ажилчдын хаалгаар) тэр юуны өмнө эцгээ алах зорилготой байлаа. Гэвч ээж нь үхсэн, Лестер Коггинс үхсэн, Бренда Перкинс үхсэн тэр гэрт ирэнгүүтээ бодлоо өөрчлөв. Хэрэв аавыг одоо алах юм бол хотын бүх нийтийн онцгой хуралдааныг хүчингүй болгоно. Жижгээ үүнийг огт хүсэхгүй байв. Яагаад гэвэл энэ хурал түүний гол ажлын сайхан халхавч болно. Ихэнх цагдаа нар тийшээ явах тул түүнд Тахианы-саравч руу нэвтрэхэд хялбар болно. Армийн хортой энгэрийн тэмдэг байхгүй байгаад тэр харамсана. Түүнийг нь үхэж байгаа Барбигийн ам руу баяртай чихэх байсан юм.

Гэвч Том Жим гэртээ угаас байсангүй. Жижгээг ганцхан амьд амьтан угтсан нь үүрээр эмнэлгийн өмнөх машины зогсоолыг хөндлөн гүйсэн өнөөх чоно. Чоно довжооны гишгүүр дээр суужээ. Тэгээд түүн рүү харж бөглүү архирах аж. Үс нь боссон байна. Нүд нь хорсолтой шаргалтана. Хүзүүнд нь Барбигийн цэргийн адилтгах тэмдэг зүүлттэй.

Жижгээ нүдээ аниад арав хүртэл тоолов. Нээхэд чоно алга болжээ.

-Одоо би өөрөө чоно. Би ороолон. Би хатан хаантай бүжиглэж байгаа Лон Чейнийг харсан (олон тооны аймшгийн кинонд тоглосон америкийн нэрт жүжигчин) гэж Жижгээ халуун хоосон гэртээ шивнэлээ.

Тэр хазганасан хэвээр боловч үүнийгээ үл анзаарах бөгөөд хоёр давхарт гарлаа. Дүрэмт хувцас шүүгээнд байх бөгөөд "беретта-торус" гар буу ч тэнд байв. Цагдаагийн газарт ийм буу арван хоёр ширхэг байх бөгөөд ихэнхийг нь Үндэсний аюулгүй байдлын яамны санхүүжилтээр авчээ. Тэр "беретта"-гийн дайзыг арван таван сумтай эсэхийг шалгаж, гар буу бүрэн цэнэгтэйд итгэлээ. Бууг хуйнд шургуулаад ихэд турсан бүсэлхийндээ бүс зүүгээд өрөөнөөс гарав.

Төлөвлөснөө хэрэгжүүлэх хүртэл буюу хурал эхлэх хүртэл хаашаа явах, хаана байхаа бодон шатны дэргэд зогсосхийв. Жижгээ хэнтэй ч ярихыг хүсэхгүй байсан ба бас хэн ч түүнийг харахыг хүссэнгүй. Тэгээд цагдаагийн газрын хажуухан талд байх нууцлаг газрыг саналаа. Чөтгөрийн хазганалт эргэн ирж, дээр нь нүүрний зүүн хагас хөлдсөн юм шиг мэдээ алдсан тул шатаар болгоомжтой буулаа. Тэгээд хонгилоор хазганан алхав. Эцгийнхээ өрөөний хаалган дээр зогтусав. Төмөр шүүгээг нь нээгээд бүх мөнгийг нь шатаадаг юм уу? Гэхдээ энэ барилдахаасаа таахалзахтай адил гэж үзэв. Хоосон арал дээр аваачсан банкируудын тухай онигоог тэр бүүр түүр санав. Тэд тэнд хувцасаа ашигтай зараад баяжсан гэдэг. Хэдийгээр онигооны утга болоод гол үгс нь ой тойнд алга байсан ч Жижгээ нохой хуцах шиг инээлээ.

Нар Бүрхүүлийн баруун талын үүлсийн цаагуур орж бүрэнхийлж байна. Жижгээ гэрээсээ гарч харанхуйд уусав.

12

Таван цаг дөчин таван минут болж байхад Элис Эйден хоёр түр зуур амьдарч байгаа байрныхаа арын хашаанаас эргэж ирэв.

-Каро? Чи Эйденийг, бас намайг... Эйден бид хоёрыг том хуралд авч явах уу?

Думегены гал тогоонд Думегений талхаар (хатсан ч идэж болохоор) оройн хоолонд зориулан хавчуургатай талх бэлдэж байсан Каролин Стержес хүүхдүүд рүү гайхан харлаа. Хүүхдүүд томчуудын хуралд очихыг хүсч байсныг тэр хэзээ ч сонсоогүй юм байна. Ийм уйтгартай арга хэмжээн дээр байхгүйн тулд тэд бүхнийг хийх болно гэж л боддог байсан. Гэвч энэ санаа түүнд таалагдсангүй. Яагаад гэвэл хэрэв хүүхдүүд тийшээ явах юм бол тэр ч бас явах хэрэг болно.

-Та нар итгэлтэй байна уу? Та хоёр хоёулаа хүсээд байгаа юм уу? гэж тэр тонгойн асуулаа. Сүүлийн хэдэн хоног хүртэл тэр хүүхдэд өөрийгөө ямар ч сонирхолгүй гэж бодож ирсэн. Түүний зорилго бол багш утга зохиолчийн хувьд амжилтын шатаар ахих, эсвэл бүр дэврүүн зохиолчийн шатаар ахих гэж боддог байв. Гэхдээ роман бичих нь аз үзсэн хэрэг л дээ. Мянган хуудастай номонд хамаг цагаа зарсан чинь түүнийг авч хэлэлцэхгүй бол яах вэ? Гэтэл яруу найраг...улс орноороо аялах (мотоциклоор ч хамаагүй)...олны өмнө үг хэлэх юмуу сургалт хөтлөх, шувуу шиг эрх чөлөөтэй байх чинь үнэхээр сайхан. Сонирхолтой эрчүүдтэй уулзаж, дарс шимэж, орондоо Сильвия Платтын тухай ярилцаад л. Эйден Элис хоёр түүний тохиргоог өөрчилжээ. Тэр тэдэнд хайртай болсон. Бүрхүүл нураасай гэж мэдээж хүсч байв. Гэхдээ хүүхдүүдийг ээжид нь буцааж өгөх үед зүрх нь шимширнэ гэдгийг мэдэж байлаа. Хүүхдүүдийн зүрх ч бас өчүүхэн ч гэсэн шимширнэ гэж Каролин найдна. Мэдээж нэг их сайхан бодол биш боловч яг л ийм бодол толгойд нь төрж байв. -Эйден чи үнэхээр тийшээ явмаар байна уу? Томчуудын хурал урт бөгөөд уйтгартай байдаг.

-Би явмаар байна. Би бүх хүнийг хармаар байна гэж Эйден хэллээ.

Каролин сая л ойлгов. Тэдний сонирхолыг хотод байгаа нөөц болоод түүнийг хэрхэн хэрэглэх тухай маргаан огт татахгүй байна. Юу гэж тэгэх билээ дээ? Элис, ес харин Эйден таван настай. Харин нэг гэр бүл шиг цугласан хотынхоныг харах нь өөр хэрэг. Тун байж болох зүйл.

-Та нар биеэ зөв авч явж чадах уу? Шивнэлдэх юмуу өндөлзөөд байхгүйгээр.

-Мэдээж гэж Эйден сүрхий хариуллаа.

-Та хоёр явахаасаа өмнө шээх үү?

Энэ удаад Элис нүдээ тэнгэр рүү ширтсэн нь Карогоос ийм тэнэг асуулт сонсоно гэж бодоогүй гэж хэлж байгаа хэрэг..Карод ч энэ таалагдав.

-Тэгвэл би энэ хавчуургатай талхнуудыг бас авна. Тэгээд биеэ зөв авч явдаг ба гуурс ашиглаж уудаг хоёр хүүхдэд зориулан хоёр лааз хийжүүлсэн ундаа авцгаая. Хийжүүлсэн ундаа урсаж орохоос өмнө биедээ байгаа бүхнийг юүлнэ гэх юм бол.

-Би үргэлж гуурс хэрэглэдэг. "Вуп" ямар вэ? гэж Эйден хэллээ.

-Тэр "Вупи-пай"-г ярьж байгаа юм гэж Элис тайлбарлав.

-Би мэдэж байна. Гэхдээ байхгүй юм шигээ. Харин амтаг жигнэмэг бол харсан юм шиг санагдаад байна. Дотроо хүрэн чихэртэй.

-Хүрэн жигнэмэг амттай. Каро би чамд хайртай гэж Эйден толгой дохилоо.

Каролин инээмсэглэв. Түүний уншсан нэг ч пгүлэг ийм сайхан байгаагүй мэт санагддаа. Тэр бүү хэл Уильямсын бичсэн хүйтэн чавганы тухай шүлэг ч.

13

Андреа шатаар аажим боловч итгэлтэй доошлохыг Жулия гайхан харна. Нээрээ Андреа гайхалтай өөрчлөгдчихлөө. Үс засалт ба нүүр будалт үүргээ гүйцэтгэв. Энэ хэдэн өдөр байсан навсгар Андреагаас юу ч үлдсэнгүй. Гэхдээ бүх юм үүгээр хязгаарлагдаагүй. Түүнийг хараад Жулия хотын захиргааны гуравдугаар гипгүүн өөртөө итгэлтэй байж өөрөөр харагддаг байсан тэр цагаас хойш хичнээн хугацаа өггөрсөнийг ухаарав. Энэ үдэш Андреа нүд бүлтийм улаан даашинз өмсөж, бүсэлхийдээ бүс зүүв. "Энн Тейлор" байхаа. Тэгээд том цүггх авлаа.

Горас хүртэл түүн рүү гайхан харна.

-Би ямархуу харагдаж байна даа? Шүүр сандайлбал хотын бүх нийтийн хуралд нисч очиж дөнгөх болов уу? гэж Андреа сүүлийн гишгүүрээр өнгөрөнгөө асуув.

-Чи сэтгэл догдлуулам харагдаж байна. Хорин насаар залуужжээ.

-Хонгор минь чамд баярлалаа. Гэхдээ дээр толь байгаа л

даа.

-Тэр толь чинь чиний хичнээн сайхан харагдаж байгааг харуулж чадаагүй юм байна. Доор байгаа толинд харж бай. Гэрэл сайтай байдаг.

Андреа цүнх нь хүнд байх мэт нөгөө гартаа шилжүүлэн барив.

-Тиймээ би арай дээр харагдаж байгаа байх. Гэхдээ жаахан.

-Хүч хүрэх үү?

-Тийм гэж бодож байна. Гэхдээ салгалах юм бол хажуугийн хаалгаар гарна.

Гэхдээ Андреа салгаллаа ч гэсэн тэндээс гарах бодолгүй байв.

-Цүнхэнд юу байгаа юм бэ?

Жим Реннид зориулсан оройн хоол. Би бүх хотынхоны нүдний өмнө түүнийг хооллох болно.

-Би нэхмэлээ үргэлж авч явдаг юм. Хотын хурал ихэнхдээ их урт бас уйтгартай байдаг.

-Уйтгартай байна гэж бодохгүй юм.

-Чи бас явна биз дээ?

-Тэгэх байхаа гэж Жулия тодорхойгүй хариуллаа. Хурал дуусах үед тэр хотын төвөөс хангалттай холдсон байх зорилготой. -Гэхдээ би эхлээд жаахан ажил амжуулмаар байна. Чи тийшээ ганцаараа хүрч чадна биз дээ?

Андреа нүүрээ үрчийлгэж "ээжээ больж үз" гэх шиг болов.

-Уулзвар хүрээд, толгойгоор уруудаад, тэгээд л очих ёстой газраа оччихно. Би энэ замыг нэг бус жил туулж байна даа.

Жулия цагаа харлаа. Таван цаг гучин таван минут.

-Арай эрт явж байгаа юм биш үү?

-Хэрэв би буруу бодоогүй бол Эл Тиммонс танхимыг яг зургаан цагт нээнэ. Би сайн суудал эзэлмээр байна.

-Хотын захиргааны гишүүний хувьд чи тайзан дээр суух ёстой. Гэхдээ хэрэв хүсвэл гэж Жулия цохов.

-Үгүй, тэгж бодохгүй байна. Андреа цүнхээ нөгөө гартаа шидлээ. Цүнхэн дотор нэхмэл, "ВЕЙДЕР" хавгаснаас хэвлэсэн материалтай дупуй, гэрээ хамгаал гэж дүү Дугласын бэлэглэсэн гучин найман калибрын гар буу бий. Энэ буу хотыг хамгаалахад ч зүтгэж болно гэж Андреа бодсон. Хот бол их бие. Гэхдээ хүний биетэй харьцуулах юм бол эргэлзээгүй давуу талтай. Хэрэв хотод муу тархи таарах юм бол түнийг зүгээр л сольж орхидог. Заавал аллага хийх замаар биш. Жулия түүн рүү асуух мэт харав. Андреа өөрийнхөө бодолд дэндүү гүн автсанаа ойлголоо. -Би хотын иргэдийн дунд суух болно. Гэхдээ цаг нь болохоор үтээ заавал хэлнэ. Итгэлтэй байгаарай.

Эл танхимын хаалгыг зургаан цагт нээнэ гэж хэлэхдээ Андреа алдаагүй байжээ. Бүхэл өдөржин шахуу хоосон байсан Төв замд энэ үеэр хотын иргэд үзэгдэж эхэллээ. Тэд жижиг бүлгүүд болж бөөгнөрөөд хотын талбайн дэргэдүүр толгойн бэл рүү уруудан хотын захиргааг чиглэнэ. Истчестер ба Нортчестерээс дүүрэн хүн суусан машинууд ирж эхэллээ. Энэ орой хэн ч ганцаар үлдэхийг хүсэхгүй бололтой.

Андреа өөрийн бодлоор байраа сонгож чадахаар хангалттай эрт иржээ. Тэгээд гуравдугаар эгнээнд голын гудамлаг талын захын суудалд суув. Түүний яг урд хоёрдугаар эгнээнд Каролин Стержес ба эгч дүү Эпплтон нар суулаа. Хүүхдүүд бүх хүнийг бас бүхнийг нүдээ бүлтийгэн харцгаана. Жаалхүү хараад байхад гартаа амтат жигнэмэг барьжээ.

Линда Эверетт мөн эрт иржээ. Жулия Андреад Растиг баривчилсан тухай ярьсан. Ямар ч үндэслэлгүйгээр. Эхнэр нь түгшүүрт автсаныг тэр мэдэж байлаа. Гэвч Линда том хармаатай гоё даашинз ба нүүрний будгаараа үүнийгээ нууж чаджээ. Өөрийн байдлыг тооцож үзээд (ам нь хатаж, толгой өвдөж, ходоод хатгаж байв) Андреа энэ эмэгтэйн эрэлхэгийг бахархав.

-Линда миний хажууд суу. Расти яаж байна? гээд тэр дэргэдэх сандалаа алгадав.

-Мэдэхгүй гэж хэлээд Линда түүний дэргэдүүр өнгөрч сандалд суухад түүний хармаанд байгаа ямар нэг юм сандалыг тогшив. -Надад түүнтэй уулзахыг зөвшөөрөөгүй.

-Энэ байдал сайн тал руугаа эргэнээ.

-Тиймээ өөрчлөгдөнө гэж Линда барайн зөвшөөрөөд дараа нь урагшаа бөхийж: -Сайн уу хүүхдүүдээ та нарыг хэн гэдэг вэ?

-Энэ Эйден гэж Каро хариулав. -харин энэ бол...

-Би Элис гээд охин гараа ихэмсэгээр сунгав. Яг л хатан хаан үнэнч албаттайгаа мэндлэх мэт. - Би бас Эйден...Эйден бид хоёр... өнчтөн. Энэ нь Бүрхүүлийн өнчин хүүхдүүд гэсэн үг. Терстон биднийг тэгж нэрлэсэн. Тэр янз бүрийн илбэ мэддэг. Чиний чихнээс хорин доллар гаргаж ирэх юмуу, тиймэрхүү юмнууд.

-За яахав. Энэ тал дээр түүнд аз дайрчээ гээд Линда инээмсэглэв. Тэр арай гэж инээмсэглэнэ. Тэр амьдралдаа хэзээ ч ингэтлээ сэтгэл зовж байсангүй. Зүгээр сэтгэл зовсон ч юм биш. Хэзээ ч ийм зэрлэг айдсыг эдэлж явсангүй.

Зургаа хагас гэхэд хотын захиргааны арын зогсоол дээр сул зай үлдсэнгүй. Тиймээс дараагийн машинууд Төв зам болоод Баруун болон Дорнод замууд дээр зогсож эхэллээ. Зургаа дөчин тав гэхэд шуудан болоод цагдаагийн газрын зогсоолууд дүүрч, харин хурлын танхимд бүх суудал эзэнтэй болжээ.

Том Жим ийм юм болохыг урьчилан харжээ. Тэгээд Эл Тиммонс хэдэн шинэ цагдаагийн

тусламжтайгаар "Америк легион"-ы танхимаас сандалуудыг зүлгэн дээр зөөж гаргана. Нэгэн дээр нь "Манай дайчдыг дэмжээрэй" нөгөө дээр нь "Бинго дахиад тоглоцгооё" гэж бичжээ. Гол хаалганы хоёр талаар "ямаха"-гийн чанга яригчууд суурилуулжээ.

Ихэнх цагдаа нар эмх журам сахиулахад оролцоно. Түүний дотор ахмад цагдаа нар бүгд байх ба тэднээс ганцхан хүн л алга. Хоцорч ирсэн хүмүүс гадаа суух болсондоо гомдоллож эхлэхэд (зүлгэн дээрх сандал ч хүрэлцэхээ байсан тул зогсоход хүрэв) Рэндолф дарга тэдэнд эрт ирэх хэрэгтэй байсан гэж л хариулна. Хэн амжаагүй нь хоцорсон гэнэ. Тэгээд энэ үдэш дулаахан, салхигүй, тааламжтай байгаа бөгөөд удахгүй тэнгэрт том ягаан сар гарна гэж тэр ярина.

-Үнэрийг анхаарахгүй бол тааламжтай л даа гэж Жо Боксер бувтнана. Тэрбээр эмнэлэгт болсон өрмөнцөрийн мөргөлдөөнөөс хойш сэтгэл санаа нь муу байв. -Энэ новшоор дамжуулаад бүгдийг сонсоно гэж найдахаас гээд тэр чанга яригч руу заалаа.

-Сонсоноо гээд Рэндолф дарга толгой дохив. -Бид "Дипперс"-ээс авсан юм. Томми Андерсон чанга яригчаа дээд зэргийн чанартай гэсэн ба өөрөө тохиргоо хийсэн. Чи өөрийгөө авто кинотеатрт байна гэж л бод. Гэхдээ дэлгэцгүй.

-Ийм театрт кино үзвэл бөгс өвдөхөөс өөр үр дүнгүй гэж би боддог гээд Жо Боксер хөлөө ачин суугаад өмднийхөө индүүдлэгийг засав.

Жижгээ Энхтайваны гүүрэн дээрээс энэ бүхнийг ажиглана. Тэр хананд гаргасан нүхээр шагайх ажээ. Ийм олон хүн нэг цагт нэг газарт цугласанд тэр гайхаж байв. Чанга яригч түүний амьдралыг хөнгөвчилж өглөө. Тэр одоо байгаа газраасаа бүхнийг сонсож чадах бөгөөд

эцэг нь титэм үгээ хэлж эхлэх үед өөрийн төлөвлөгөөг хэрэглжүүлэх болно.

Бурхан минь. Миний зам дээр хөндөлсөх хүмүүст туслаарай гэж тэр бодов.

Гэдэс нь цэндийсэн эцгийгээ Жижгээ энэ бүрэнхийд ч ядах юмгүй танилаа. Тэгээд ч хотын бүх нийтийн хурлыг тохиолдуулан захиргааны цахилгаан үүсгүүр бүрэн хүчин чадлаараа ажиллах ба нэг цонхны гэрэл Том Жимийн зогсож байгаа зогсоолын булан дээр тусна. Мэдээж тэр Картер Тибодотой хамт байв.

Том Жим түүний араас ажиглаж байгааг мэдрээгүй. Хэрэв ян тан хэлэх юм бол бүх хүн түүн рүү харж байгааг мэдэрч байв. Гэхдээ энэ хоёр адилхан даа. Рэнни цагаа харлаа. Найм дөнгөж өнгөрч байна. Улс төрийн олон жилийн туршлагаараа тэр чухал хурлыг товлосон цагаас эрт ч үгүй, орой ч үгүй яг арван минутын дараа эхлэх ёстойг мэднэ. Тэгвэл одоо хөдлөх цаг болжээ гэсэн үг. Ренни гартаа яриагаа буулгасан хавтас барьсан ч энэ текст түүнд хэрэг болохгүй гэдгийг эртнээс мэдэж байлаа. Тэр юу хэлэхээ тэртэй тэргүй мэднэ. Том Жим өнгөрсөн шөнө энэ яриаг зүүдэндээ давтсан бөгөөд нэг бус удаа. Тэгээд давтах тусам улам сайн болж байлаа.

Тэр Картерын сүвээ рүү нударав.

-Шоу эхлэх цаг боллоо.

-Ойлголоо гээд Картер захиргааны хаалга руу хөтлөх шатны гишгүүр дээр зогсож байгаа Рэндолф руу гүйв. (өөрийгөө Юлий Цезарь гэж төсөөлж байх бололтой гэж Том Жим бодов). Тэгээд даргыг дагуулсаар ирлээ.

-Бид хажуугийн хаалгаар орно гээд Ренни дахиад цагаа харлаа. -Тав...бишээ дөрвөн минутын дараа. Питер чи эхлээд. Би чиний араас. Харин Картер миний араас. Найгаж ганхалгүй итгэлтэй алхана шүү. Алга ташна. Хөдөлгөөнгүй зогсоод намжих хүртэл нь хүлээ. Дараа нь сууцгаана. Питер чи миний зүүн талд. Картер миний баруун гар талд. Би индэрт гарна. Эхлээд залбирал, дараа нь төрийн дуулал явахад бүгд босно. Дараа нь би ярьж эхлээд бид өдрийн хуваарийг түргэхэн шудрах болно. Хүмүүс бүх юмны төлөө саналаа өгнө. Ойлгов уу?

-Би аймаар сэтгэл хөдлөөд байна гэж Рэндолф үнэнээ хэллээ.

-Дэмий дээ. Бүх юм сайхан болно. Том Жим энэ тал дээр алджээ.

16

Том Жим ба түүний бараа бологсод захиргааны хажуу хаалга руу зүглэх тэр мөчид Роузын жолоодсон фургон Макклетчигийн гэрийн орцны зам руу эргэв. Фургоны араас ердийн жижиг тэр дагалдах ба Жоани Кэлверт жолоодох ажээ.

Клер нэг гартаа чемодан нөгөө гартаа хүнс хоолтой том даавуун цүнх барьсаар гарч ирэв. Жо Бенни Дрейк хоёр бас л чемоданууд барьсан байх ба гэхдээ Беннигийн чемоданд байгаа хувцасны ихэнх нь саяхан Жогийн авдарт байсан юм. Бенни мөн дунд зэргийн хэмжээтэй цүнх барьсан байх ба Макклетчигийн зоориноос олсон олзоор дүүргэжээ.

Захиргаанаас чанга яригчаар хүч оруулсан алга таших дуу нижигнэнэ.

-Түргэлээрэй. Тэд эхэлж байна. эндээс зугтах цаг болсон гэж Роуз шавдуулна.

Ачааг машинд оруулахад туслахаар Лисса Жеймисон машинаас буув.

-Цонх хаах тугалган тууз бидэнд байгаа юу? гэж Роуз Жогоос асуулаа.

-Тиймээ. Бас Жоанигийн машинд зориулсан нөөц хавгаснууд ч бий. Бид холхон очоод цонхоо битүүлнэ. Чемоданаа ачаанд тавь.

-Энэ ёстой солиорол гээд Жоани Кэлверт өөрийн "шевроле"-гоос фургон хүртэлх зайг найгаж ганхалгүй тууллаа. Тэгэхээр мань эмэгтэй зөвхөн зориг орох үүднээс ердөө ганц хоёр аяга л уусан юм байна гэж Роуз бодлоо. Сайны тэмдэг гэж бас шийдэв.

-Чиний зөв байхаа. Бүгд бэлэн үү? гэж Роуз асуулаа.

Жоани санаа алдаад охиныхоо хэврэгхэн мөрийг тэврэв.

-Юунд? Там руу явахад уу? Яагаад үтгүй гэж? Тэгээд тэнд хэр удаан байх юм дээ?

-Мэдэхгүй гэж Роуз хариулав.

Жоани дахин санаа алдав.

-Ядахдаа дулаан байгаа нь сайн хэрэг.

-Өвөө чинь хаана байгаа юм бэ? гэж Норригоос Жо асуув.

-Жекки ба ноён Берпи нартай өнөөх Реннигээс хулгайлсан

микроавтобусанд байгаа. Тэд Расти ба Барбара нарыг суллахаар дотогшоо орох үед өвөө цагдаагийн газрын дэргэд машиндаа хүлээх юм. Тэр жолооч нь болж өгнө гээд Норри айсан байдалтай инээмсэглэнэ.

-Хөгшин тэнэгээс илүү тэнэг байдаггүй юм гэж Жоани тайлбар хийв.

Роуз түүнийг дэлсээд авмаар тун их санагдлаа. Тэр Лисса руу харахад тэр ч бас арай гэж биеэ барьж байгааг ойлгов. Гэвч одоо маргах ба нударга зөрүүлэх цаг байхгүйг ойлгож байв.

Эсвэл хамтдаа тэсч гарна, эсвэл нэг нэгээрээ дүүжлэгдэнэ гэж Роуз бодов.

-Жулия хаана байгаа вэ? гэж Клер асуув.

-Тэр Пайпертай хамт явна. Бас нохойтойгоо.

Хотын төвөөс чанга яригчаар хүч орсон (бас зүлэг дээр тавьсан сандалууд дээр сууж байгаа хүмүүсийн дуугаар дэмжигдсэн) "Од ба судалтай далбааны" дууны үг дуурсана. Честерс-Милл хотын Нэгдсэн найрал дуулж байна.

-Явцгаая гээд Роуз машиндаа сууснаа: -Би түрүүлэе гэв.

-Ямартаа ч дулаахан байна гэж Жоанни өөрийгөө зоригжуулах мэт дахин хэлэв. -Явцгаая Норри. Ээжийнхээ зам заагч болно шүү.

Хулгайлсан микроавтобус Леклеркийн "Ma1\$оп дез Иеигз"-ийн орцны зам дээр хамраа Төв гудамж руу харуулан зогсоно. Эрни, Жекки, Ромми нар суугаад захиргаанаас хадах төрийн дууллыг сонсоно. Жекки нүд нь хорсож эхлэхийг мэдэрсэн бөгөөд тэр ганцаараа сэтгэл догдолж байгаа биш болохоо харав. Жолооны ард суусан Эрни амны алчуураа гаргаад нүдээ арчлаа.

-Линдагийн дохио бидэнд тийм ч хэрэгтэй биш шиг байна. Чанга яригч ажиллана гэж бодоогүй. Тэднийг надаас лав аваагүй гэж Берпи тэмдэглэв.

-Гэхдээ хүмүүс түүнийг харна гэдэг чинь сайн хэрэг. Ромми баг чамд байгаа юу? гэж Жекки хэлэв.

Тэр Дик Чейнигийн хаймар багийг харууллаа. Хэдийгээр асар их нөөцтэй боловч тэр Жеккиг бяцхан лусын гүнжийн багаар хангаж чадсангүй. Тиймээс бүсгүй Харри Поттерын найз бүсгүй Хармонигийн баг зүүхээс аргагүй болжээ. Харин

Эрнигийн өөртөө сонгосон Дарта Вейдерийн баг сандалын арын хармаанд байна. Гэхдээ хэрэв тэр энэ багийг үнэхээр өмсөх юм бол тэдэнд хүнд асуудал үүссэн гэсэн үг гэж Жекки бодов. Гэвч тэр бодлоо чангаар мэдээж хэлээгүй.

Тэгээд энэ багнууд зарчмын хувьд ямар нэг утга учиртай гэж үү дээ.? Бид бүгд хотоос гэнэт алга болохоор хүмүүс тэртэй тэргүй л мэднэ пгүү дээ.

Гэхдээ нөгөө талаас бол сэжиглэх гэдэг чинь гарцаагүй мэдэх гэсэн үг бас биш. Хэрэв Ренни Рэндолф нарт сэжиглэхээс өөр юу ч үлдэхгүй бол тэд хотод үлдсэн бидний найз нөхөд ба хамаатан саднуудыг зөвхөн хагуу байцааж л чадах байх.

Гэхдээ одоогийн нөхцөлд бол энэ үгний цаана юу ч байж болохыг Жекки ухаарч байв.

Төрийн дуулал дууслаа. Дахин алга ташив. Тэгээд хотын захиргааны хоёрдугаар гишүүн ярьж эхэллээ. Жекки авч гарсан хувийн гар буугаа шалгав. Тэгээд одоо ирэх хэдхэн минут түүний амьдралд хамгийн урт хугацаа байх болно гэж бодлоо.

18

Барби Расти хоёр Том Жимийн яриаг сонсон хорих өрөөнийхөө торны дэргэд зогсоно. Захиргааны хаалганы дэргэд суурилуулсан чанга яригчийн ачаар тэдэнд чихээ хурцлах шаардлага ч гарсангүй.

-Та бүхэнд баярлалаа. Та бүхэнд бүгдэд нь бас хүн нэг бүрт баярлалаа. Ирсэнд тань баярлалаа. Бас та бүхэн АНУ-ын хамгийн нугаршгүй, хамгийн найдвартай, хамгийн эрэлхэг хүмүүс гэдгийн тань төлөө баярлалаа.

Алга нижигнүүлэн ташив.

-Ноёд хатагтай нараа...бас хүүхдүүдээ, би та бүхний дунд хэд хэдэн хүүхдийг харж байна... Хүмүүс эелдэг инээлдлээ.

-Бид аймшигтай байдалд ороод байна. Та бүхэн үүнийг мэдэж байгаа. Өнөөдөр би та бүхэнд бид яаж ийм байдалд орсон тухай ярьж өгөх зорилготой ирлээ. Би бүгдийг нь мэдэхгүй. Гэхдээ мэдэж байгаагаа та бүхэнтэй хуваалцана. Яагаад гэвэл та бүхэн хуваалцах гавьяатай. Би байгаа нөхцөл байдлыг танилцуулж дууссаны дараа бид хэд хэдэн чухал шийдвэр гаргана. Гэхдээ эхлээд, бүхний түрүүнд, та бүхнээр хичнээн бахархаж байгаагаа би та бүхэнд хэлэхийг хүсч байна. Энэ онцгой үед та бүхний болоод Бурханы удирдагчаар сонгосон тэр хүн байх хичнээн аймаарыг хэлмээр байна. Бас бид хамтдаа Бурханы тусламжтайгаар энэ

сорилтыг туулан гарах бөгөөд түүнээс илүү хүчтэй, илүү цэвэр, өөртөө илүү итгэлтэй болсоор гарч ирнэ гэдгийг та бүхэнд амлах байна. Одоо бол бид яг цөлд байгаа Израилийн хүүхдүүд шиг л байна...

Барби тэнгэр рүү өлийн харсан бол Расти Ренниг гутаах гэсэн мэт гараар эвгүй хөдөлгөөн үзүүлэв.

-...Гэвч бид удахгүй өөрсдийн Ханааныг олж сүү ба балаар найрлах болно. Бурхан болоод бидний адил америкийн иргэд биднийг хүнддэх болно.

Чих дөжрөм алга ташилт. Зогсоод алга ташиж байгаа бололтой. Хэрэв хонгилд "цох" байлаа ч гэсэн энд үлдсэн хоёр гурван цагдаа хаалганы дэргэд зогсоод Том Жимийг сонсож байгаа нь гарцаагүй тул Барби шивнэв.

-Бэлдээрэй, найз минь.

-Би бэлэн. Надад итгэ, би бэлэн гэж Расти хариуллаа.

"Цагдаагийн газар руу дайран орохоор төлөвлөж байгаа хүмүүсийн дунд Линда л битгий байгаасай" гэж тэр бодно. Эхнэр нь хэн нэгнийг алахыг үл хүсэх бөгөөд бас тэр амь насаараа аз үзэхийг бүр үл хүснэ. Түүнийг аврахын төлөө байсан ч. Байгаа газраа үлдээсэй. Би мэдээж толгой эргэж гүйцсэн байх. Гэвч Линда одоо бүх хот байгаа тэр газарт байх юм бол аюулгүй байх болно.

Буудалцаан эхлэхээс өмнө тэр ингэж бодсон юм.

19

Том Жим баярлан хөөрч байлаа. Тэр Миллийн оршин суугчидтай хүссэнээ хийлээ. Тэд түүний гараас хооллож байв. Зуун зуун хүн. Түүний төлөө саналаа өгсөн болоод өгөөгүй хүмүүс. Ренни энэ танхимд ийм олон хүнийг хэзээ ч харж байсангүй. Тэр бүү хэл сургуулийн төсөв юмуу сургуулийн залбиралын тухай хэлэлцэхэд ч. Хүмүүс зөвхөн танхимд биш зүлгэн дээр ч гуя гуяараа, мөр мөрөөрөө наалдан суугаад түүнийг зүгээр ч нэг сонсоогүй юм. Сандерс тэнээд алга болсон. Андреа танхимд байна. (гуравдахь эгнээнээс улаан даашинз нүдэнд шууд тусна). Тиймээс цугласан хүмүүс зөвхөн түүнд харьяалагдаж байлаа. Хүмүүсийн нүд түүнээс халамж тавихыг гуйж байна. Аврахыг. Түүний хөөрлийг дэргэд нь суугаа бие хамгаалагч болоод хананы дагуу эгнэсэн цагдаа нар, түүний цагдаа нар улам нэмж өгнө. Бүгд дүрэмт хувцас өмсөөгүй хэдий ч зэвсэг бүгдэд нь бий. Танхимд доод тал нь зуун хүн гартаа бүч зүүжээ. Тэр хувийн армитай болсон мэт.

-Хотын иргэд найз нараа. Бид Дейл Барбара нэртэй хүнийг баривчилсан гэдгийг та нарын олонхи нь мэдэж байгаа...

Хүмүүсийн шүтэлдэж хашгирах дуу түүнийг тасалдуулав. Том Жим тэдний намжихыг хатуу чанга царйлан хүлээх боловч харин сэтгэлдээ дарвайтал инээж байв.

-Бренда Перкинс, Лестер Коггинс ба бидний бүгд мэдэх ба хайрлах хоёр залуу бүсгүйг алсаны төлөө. Энжи Маккейн ба Доди Сандерс.

Дахиад л хашгирч шүгэлдэнэ. "Түүнийг тасчих хэрэгтэй", "Алан хядагч". "Брауны дэлгүүр"-ийн эрхлэгч Велма Уинтер баривчлагдсан хүнийг тэгж нэрлэх шиг болов.

-Та бүхэн өөр нэг юм мэдэхгүй байна. Бүрхүүл бол солиотой эрдэмтдийн элит бүлэглэлийн зохион байгуулсан хуйвалдааны үр дүн бөгөөд худалдагдсан төрийн түшмэд нууцаар санхүүжүүлсэн юм. Хотын иргэд та бүхэн энэхүү туршилтын туулайнууд бөгөөд Дейл Барбара энэ туршилтыг дотроос нь удирдах даалгавартай хүн.

Гайхсан чимээгүй байдал хариулт болж өгөв. Дараа нь уурсан хашгирах дуугаар солигдлоо.

Хүмүүс жаахан тайвширмагц Том Жим индэрийн ирмэгээс гараар базан зогсоод үргэлжлүүлсэн бөгөөд түүний царай үнэнч байдлаар гэрэлтэнэ. (ихэд хүчилсэндээ цус юүлэгджээ). Хэлэх үг түүний өмнө хэвтэх бөгөөд гэхдээ хавтас дотроо байв. Түүнд тийшээ шагайх хэрэг ч гарсангүй. Бурхан түүний хоолойг ашиглаж, түүний хэлийг хөдөлгөх ажээ.

-Би нууц санхүүжилтын тухай ярьсан. Та бүхэн энэ юу гэсэн үг вэ гэж асууж байгаа байх. Хариу аймаар боловч амархан. Дейл Барбара бидний одоогоор мэдэхгүй байгаа хотын зарим иргэдийн хамт их хэмжээний метамфетамин үйлдвэрлэх лабораторийг зохион байгуулсан бөгөөд ТТГ-ын тусламжтайгаар Дорнод эргийн бүх хар тамхины баронуудад хүргэдэг байна. Тэр хэдийгээр хамсаатнуудаа нэрлээгүй байгаа боловч тэдний нэг нь, үүнийг хэлэхэд зүрх урагдаж байгаа боловч, Энди Сандерс юм байна.

Гайхаж балмагдан хашгирч шуугилаа. Андреа Гриннел суудлаасаа боссоноо буцаад суухыг Том Жим харав. Тэр чинь зөв. Дуугүй суу. Хэрэв надад асуулт тавьж зүрхэлбэл би чамайг амьдаар нь залгина. Эсвэр чам руу хуруугаар заагаад хам хэрэгтэн гэж зарлана. Тэгвэл энэ хүмүүс чамайг амьдаар чинь залгина.

Тэгээд үнэнийг хэлэхэд энэ бол түүний эрх мэдлийн хүрээнд гэдгийг тэр мэдэрч байв.

-Барбарагийн босс буюу түүнд тушаал заавар өгдөг хүнийг та бүхэн мэдээний сувгуудаар харсан. Тэр өөрийгөө америкийн армийн хурандаа гэж танилцуулдаг ч үнэн хэрэгтээ энэхүү тамын туршилтыг явуулж байгаа эрдэмтэд ба төрийн түшмэдийн зөвлөлийн гишүүн юм. Барбарагийн хэргээ хүлээсэн баримт энд надад байна гээд тэр дотор хармаанд нь түүний түрийвч ба есүсийн хэлсэн үгсийг улаанаар тодруулсан Шинэ Гэрээ байгаа пиджакаа цохилоо.

Дахиад л хашгиралдав. "Түүнийг тасчиж хая". Том Жим гараа өргөж хөшөөд толгойгоо тонгойлгож нухацтай царайлан хашгираан намжихыг хүлээлээ.

-Бид бүх хотоороо, нэг цул болж, эрх чөлөөгөө олж авах тэмүүллээрээ нэгдэн Барбарагийн цээрлэлийн тал дээр саналаа өгнө. Ноёд хатагтай нараа, бүх юм та нарын гарт байна. Хэрэв та бүхэн түүнийг цаазлахын төлөө саналаа өгвөл бид цаазална. Би та нарын удирдагч байсан цагт дүүжлэнэ гэж байхгүй. Түүнийг буудлагын багийн өмнө зогсоох болно...

Түүнийг нижигнэтэл дуу алдан алга таших дуу таслав. Олон хүн суудлаасаа үсрэн босчээ. Том Жим микрофон руу тонгойгоод:

-гэхдээ энэхүү өрөвдөлтэй урвагч зүрхний нууж байгаа бүх мэдээллийг авсаны дараа.

Энэ удаад танхим тэр чигээрээ бослоо. Гэхдээ Андреа биш. Тэр урьдын адил гуравдугаар эгнээний гол гудамлаг талын захын сандалд суусан чигээр Ренниг доороос нь дээш харна. Түүний нүд зөөлөн биш харин Том Жимийн харж дассан алдагдсан манантсан нүд байв.

Хүссэнээрээ л хар. Гэхдээ сайн жаахан охин шиг чимээгүй

Харин одоохондоо Том Жим алга ташилтанд угаагдаж байв.

20

-Цаг нь болсон уу? Жекки чи юу гэж бодож байна? гэж Ромми асуулаа.

-Дахиад жаахан хүлээе.

Зөн совин нь хүлээх хэрэгтэй гэж байв. Харин Жекки зөн совиндоо найддаг.

Харин дараа нь "За хөдөлье" гээд хэлчихсэн бол хичнээн амь насыг аврах байсан тухай өөрөөсөө асуудаг юм.

21

Энхтайваны гүүрний хажуугийн нүхэнд наалдсан Жижгээ зүлгэн дээр эгнүүлсэн сандал дээр сууж байсан хүмүүс үсрэн босохыг харах үед Жеккид хүлээхийг санал болгосон зөн совин харин түүнд бол цаг нь боллоо гэж хэлэв. Тэр хазганасаар хотын талбай руу гарч Төв гудамжийг чиглэв. Түүнийг анх дусаасан адгуус яриагаа сэргээж байхад тэр цагдаагийн газар руу алхаж явлаа. Харааны зүүн хэсэгт байх хар толбо дахиад томорч ирсэн ч ухаан санаа нь тод хэвээр байв.

Барби, би чам дээр ирж явна. Чам руу шууд очно.

22

-Энэ хүмүүс хуурамч мэдээллийн мастерууд гэж Том Жим үргэлжлүүлнэ. -Тэгээд маргааш та бүхэн ойр дотны хүмүүстэйгээ уулзахаар Бүрхүүл рүү очих үед миний эсрэг ажил эрч хүчээ авах болно. Кокс ба түүний хамтрагчид намайг гутаахын тулд юуны ч өмнө зогсохгүй. Тэд намайг магадгүй худалч хулгайчаар дуудна. Тэр бүү хэл тэдний хийсэн хар тамхи үйлдвэрлэлийг намайг удирдсан мэтээр ярьж ч мэднэ.

-Чи толгойлсон шүү дээ гэх чанга тод дуу Андреа Гриннелийнх байлаа.

Хурц улаан даашинз өмссөн хүн-анхааруулах тэмдэг босч ирэхэд бүх хүний харц түүн дээр уналаа. Тэр Том Жимийг хүйтэн жигшилээр хараад дараа нь дөрвөн жилийн өмнө Жек

Кейлигийн аав Билл зүрхний шигдээсээр өөд болсоны дараа түүнийг хотын захиргааны гуравдугаар гишүүнээр сонгосон хүмүүс рүү эргэв.

-Та бүхэн айдсаа ядаж хоромхон зуур мартаж хэрэгтэй. Хэрэв тэгж чадах юм бол түүний яриад байгаа түүх ямар тэнэг болохыг лугууд олж харна. Жим Ренни та бүхнийг хонин сүргийг аянга цахилгааны үед тууцаг шиг тууж болно гэж бодож байна. Би энэ хотод бүх насаараа амьдарсан бөгөөд түүний буруу гэж бодож байна хэмээн үргэлжлүүлээ.

Том Жим эсэргүүцэн хашгирахыг хүлээв. Тэгсэнгүй. Хотынхон түүнд шууд итгэсэн болоод тэр биш. Зүгээр л үйл явдал гэнэт ингэж гайхалтай эргэсэнд барьц алдсан хэрэг. Элис Эйден хоёр сандал дээрээ өвдөглөн хойшоо харж суугаад улаан хувцастай эмэгтэйг нүд бүлтийлгэн ширтэнэ. Каро ч тэднээс багагүй гайхан хөшиж орхижээ.

-Нууц туршилтаа? Ямар дэмий юм бэ? Манай төр сүүлийн тавин жилд хэрэгцээгүй юм олон хийсэн. Би үүнтэй хамгийн түрүүнд санал нийлнэ. Харин бүхэл бүтэн хотыг ямар нэг хүчний талбайн хавхаг дор барина гэдэг чинь? Энэ юу болохыг төсөөлж байна уу? Бүрэн тэнэглэл. Зөвхөн айсан хүмүүс л үүнд итгэнэ. Ренни үүнийг мэдэх тул энэ бүх айдсаар удирдаад байна.

Гэнэтийн довтолгоон хэсэг зуур Том Жимийн амьсгааг хаав. Гэвч тэр дахиад ярьж эхэллээ. Мэдээж микрофон урьдын адил түүний мэдэлд байв.

-Ноёд хатагтай нараа. Андреа Гриннел маш сайхан эмэгтэй. Гэвч өнөөдөр тэр өөрийгөө хянаж чадахгүй байна. Тэр та нарын олонхийн адил сандарч тэвджээ. Мэдээж хэрэг. Гэвч харамсалтай нь би та бүхэнд бас нэг юм мэдээлэх ёстой. Энэ хүн эм байнга уусаар хар тамхины хамааралтай болсон хүн. Эмийн нэр нь...

-Би олон өдөр аспиринаас өөр юу ч уугаагүй байгаа гэж Андреа түүнийг өнөөх л тод чанга дуугаар таслаад: -Харин одоо миний мэдэлд баримтууд орж ирсэн. Энэ баримтууд юу харуулж байна гэвэл...

-Мелвин Сирлс гэж Том Жим нүргэлэв. -Та нар хотын захиргааны гуравдугаар гишүүнийг танхимаас гаргаж гэрт нь хүргэж өгч чадах уу? Эсвэл эмнэлэгт аваачиж ажиглах хэрэгтэй. Тэр өөрөө өөрийгөө хянахгүй байна.

Хаа нэгтээ сайшаан шивнэх дуу гарсан ч Том Жим найдсан дэмжлэгээ авсангүй. Мел Сирлс түүн рүү ганцхан алхаж амжтал Генри Моррисон цээж рүү нь түлхсэнээр өнөөх нь хана мөргөн их дуутай унав.

-Яриагаа дуусгаг. Тэр ч бас хотын захиргаанд бидний сонгосон хүн. Тиймээс ярих боломж өг гэж Генри үйлдлээ тайлбарлав.

Мел Том Жим рүү харсан ч өнөөх нь яг л ховсдуулсан хүн шиг Андреагаас харц үл салгах ба цаадахь нь том цүнхнээсээ зузаан хүрэн цаасан дугтуй гаргаж ирлээ. Дугтуйг харангуутаа энэ юу болохыг тэр ойлгов. Бренда Перкинс. Ямар гээч гичий вэ? Үхсэн хойноо ч намайг хорлож байдаг.

Андреа дөнгөж дугтуйгаа өргөтөл тэр чичирч эхлэв. Салгалалт буцаад ирлээ. Хараал идсэн салгалалт. Үүнээс илүү муу цагийг тэр сонгож чадахгүй нь мэдээж. Гэхдээ Андреа гайхсангүй. Тэр үүнийг бүр хүлээж байсан юм. Стресс ил гарахгүй байна гэж байдаггүй.

-Энэ баримт бичгүүд надад Бренда Перкинсээс ирсэн юм. Бэлдсэн хүмүүс нь түүний нөхөр ба муж улсын ерөнхий прокурор. Герцог Перкинс Жеймс Ренниг олон тооны хүнд гэмт хэргийнх нь төлөө мөрдөж байсан.

Бурханы авралаар хоолой нь чичрэхгүй байв.

Мел найз Картер руугаа ядаж ямар нэг тушаал авах санаатай харав. Картер ч түүн рүү харна. Түүний нүд гялалзаж, энэ болж байгаа бүхэн Тибодод наргиантай байх шиг. Тэр Андрей руу заагаад гарын ирмэгээр хүзүүгээ зурсан нь "амыг нь хамхи" гэсэн үг бололтой. Энэ удаад Мел дахин Андреа руу хөдлөхөд Генри түүнийг зогсоосонгүй. Тэр бусдын адил Андреа руу ангайн харж байв.

Кино үзэж байгаа хүмүүст саад болохыг хүсээгүй мэт тонгойгоод тааз даган гэтэх Мелтэй Марти Арсено ба Фредди Дентон нар нийлэв. Нөгөө талаас Тодд Уэндлсет ба Лорен Конри нар ч голын гудамлаг руу дөхлөө.

Андреа тэднийг харсан боловч дуугаа хураасангүй.

-Баталгаа нь энэ дугтуйнд байгаа. Миний итгэлтэй байгаа зүйл бол эдгээр баталгаа нь... тэр яриагаа "Брендагийн үхлийн шалтгаан болсон" хэмээн дуусгахыг хүссэн. Гэвч хөлстэй салгалсан зүүн гар нь том цүнхний жинг даасангүй. Цүнх унахад гэр орноо хамгаал гэж түүнд бэлэглэсэн гучин найман калибрийн бууны ам яг дуран авай шиг цухуйв.

Яг энэ үед бүх танхим сонсохуйц тод чанга дуугаар Эйден Эпплтон:

-Пөөх энэ эгчид гар буу байна гэлээ.

Дахиад хэсэгхэн хугацаанд чив чимээгүй болцгоов. Дараа нь Картер Тибодо үсрэн босч боссынхоо урдуур орж халхлаад: -Буу, буу, буу гэж хашгирлаа.

Эйден олзоо илүү сайн харахын тулд голын гудамлаг зай руу бууж ирэв.

-Эйден, болохгүй ээ гэж Каро хашгираад хүүг шүүрэхээр тонгойх үед Мел гал нээлээ.

Бууны сум Каролин Стержесийн хамрын урд, цэвэрлэсэн модон шалан дээр нүх гаргав. Зомгол ийш тийш үсрэв. Нэг нь баруун нүдний доор зоогдоход нүүрээр нь цус урслаа. Эрэн тойрон бүх хүн хашгирахыг тэр бүүр түүр сонсов. Каролина сөхөрсөн чигээр Эйденийг мөрнөөс нь тэврээд яг хөл бөмбөгийн бөмбөг шиг хоёр хөлөн дундаа чихэв. Өнөөх нь завсар нь гараад сууж байсан эгнээ рүүгээ орсон бөгөөд гайхсан царайтай ч ямар нэг гэмтэлгүй байв.

-Зэвсэг. Түүнд зэвсэг байна гэж Фредди Дентон Мелийг түлхэн хашгирлаа. Дараа нь тэр залуу бүсгүй буу руу зүтгэсэн бөгөөд тэр түүнийг шархдуулах гэснээс өөр юу ч хүсээгүй

хэмээн тангараглах болно.

23

Чанга яригчийн ачаар хулгайлсан микроавтобуст сууж байсан гурван хүн танхимд болж байгаа үйл явдал төлөвлөөгүй найруулгаар явсаныг сонслоо. Том Жимийн яриа ба алга ташилтыг ямар нэг эмэгтэйн дуу тасалдуулсан бөгөөд хэдийгээр чанга ярьж байсан ч микрофоноос хол байсан болохоор тэд ойлгож чадсангүй. Дараа нь өнөөх дуу орилоон чарлаанд живэв. Буун дуу тасхийв.

-Юу гээч чөтгөр вэ? гэж Ромми гайхлаа.

Дахиад буун дуу. Хоёр юмуу гурван удаа. Дахиад л орилоон бархираан

-Хамаагүй ээ. Эрни яв. Хурдал. Хэрэв бид үүнийг хийх гэж байгаа л юм бол одоо яг цаг нь гэж Жекки түүнд хэлэв.

24

-Үгүй ээ. Биттий бууд. Энд хүүхдүүд байна. Энд хүүхдүүд байна гэж Линда үсэрч босонгоо хашгирлаа.

Хурлын танхим там болон хувирав. Энд ирсэн хүмүүс хоёрхон минут сүрэг мал биш болсон байх. Харин одоо дахиад тийм болон хувирлаа. Цугласан хүмүүс гол хаалга руу хөдөллөө. Эхний хэд нь үсэрч гарч амжаад дараа нь бөглөрөл үүсэв. Зарим нэг нь саруул ухааны үлдэгдлээ харуулж хажуугийн хаалга руу гүйв. Гэхдээ тун цөөн нь.

Линда Каролин руу тонгойж түүнийг эгнээ хоорондын арай аюул багатай завсар руу татах гэж хичээж байтал голын зайгаар гүйж явсан Тобби Мэннинг өвдгөөрөө дагз руу нь онов. Тэр ухаан балартаж нүүрээрээ харуулдан уналаа.

-Каро гэж хаа нэгтээ алсаас Элис хашгирна. -Каро бос. Каро бос. Каро бос.

Каролин өндийх гэж оролдох тэр үед Фредди Дентон хоёр нүднийх нь дунд сумаа зоож газар дээр нь аллаа. Хүүхдүүд орилж эхлэв. Тэдний нүүр цусаар будагджээ.

Түүнийг өшиглөж дэвслэхийг Линда бүүр түүр санав. Эгцрэн босох талаар яриа ч байхгүй учир тэр арай гэж дөрвөн хөллөөд гол гудамлагийн нөгөө талын эгнээний завсар руу мөлхөв. Каролины цус түүнд наалджээ.

Элис Эйден хоёр Каро дээр очихыг оролдов. Гудамлагт тэднийг гишгэж мэдэхийг Андреа ойлголоо. (тэгээд ч хүүхдүүдийн ээжийгээ гэж хүлээж авсан эмэгтэй ямар байдалтай болсоныг тэд хараасай гэж хүссэнгүй). Андреа сандалын ар дээгүүр тонгойгоод хүүхдүүдийг барих гэж оролдлоо. Хэвлэсэн хуудастай дугтуйгаа тэр унагав.

Картер Тибодо яг үүнийг хүлээж байжээ. Тэр урьдын адил Реннигийн өмнө түүнийг халхлан зогсож байсан бөгөөд одоо хуйнаас сугалсан бугаа тохойгоор нугалсан нөгөө гар дээрээ

тавилаа. Гохоо дарахад энэ олон асуудлыг үүсгэсэн улаан хувцастай эмэгтэй хойшоо шидэгдэв. Түүнээс л болж энэ бүх эмх замбараагүй байдал эхэлсэн.

Хурлын танхимд ноёлсон эмх замбараагүйтлийг үл тоон Картер тайзнаас буугаад улаан хувцастай эмэгтэйн хэвтэж байгаа газрыг чиглэв. Хүмүүс гол гудамжаар гүйхэд тэр тэднийг баруун солгойгүй түлхэж шидэлнэ. Жаахан охин уйлангаа түүний хөлнөөс зүүгдэх гэж оролдоход тэр тоох ч үгүй өшиглөлөө.

Эхлээд тэр дугтуйг харсангүй. Дараа нь олж харав. Дугтуй Гриннелийн гар дор хэвтэж байна. "ВЕИДЕР" гэсэн бичгэн дээр хэн нэгний гутлын цустай мөр үлджээ. Картер бараг л олимпийн тамирчин шиг тайван байдлаа хадгалан эргэж харахад Ренни таран гүйлдэх сонгогчдоо харж байна.

Том Жимийн айж цочирдсон царайгаар бол тэр нүдэндээ итгэхгүй байх аж. Сайн хэрэг.

Картер цамцныхаа хормойг өмднөөсөө суга татлаа. Орилж бахирсан Карла Вензиано гэх эмэгтэй түүнийг ирж мөргөхөд хажуу тийш чулуудав. Дараа нь дугтуйг бүсэн завсараа хавчуулаад цамцаараа хаав.

Болгоомж хэнд ч гай тарьж байгаагүй.

Тэр хэн нэгэн дахин ирж мөргөөд унагахаас сэргийлж тайз руу ухрав. Гишгүүр хүртэл яваад эргэж харангуутаа өгсөн гүйлээ.

Хотын цагдаагийн аймшиггүй дарга Рэндолф махлаг гуян дээр гараа тавиад суусан газартаа лаглайж байна. Духан дунд нь лугших судас байгаагүй бол хөшөө гэж андуурмаар.

Картер Реннигийн гараас барилаа.

-Босс явцгаая.

Том Жим хаана байгаа болоод тэр хэн болохыг ч ойлгохгүй байгаа мэт харав. Дараа нь харц нь арай цэвэршив. -Гриннел яасан бэ?

Картер голын гудамд тэрийх цогцосыг заав. Толгойнх нь дэргэд даашинзных нь өнгөтэй адил өнгө бүхий шалбааг үүсчээ.

-Энэ сайн. Эндээс явцгаая. Доошоо. Алив Питер чи ч бас яв. Бос гэж Том Жим толгой дохин хэлээд Рэндолф суусаар байсан тул түүнийг шилбэ рүү нь өшиглөв. -Хөдлөөч.

Энэ үймээнд хажуугийн байшинд нүргэлэх буудалцааныг хэн ч сонссонгүй.

Барби Расти хоёр бие бие рүүгээ харлаа. -Чөттөр гэж тэнд юу болоод байна вэ? -Мэдэхгүй. Ямартаа ч сайн юм биш байх гэж Расти хариулав.

Захиргаанд дахиад л буун дуу хадсанаа дараа нь хавьгүй ойрхон дээд давхарт гарлаа. Барби энэ бол аврагчид гэж найдсан ч дараа нь хэн нэгэн хашгирахыг сонсов.

-Үгүй ээ Жижгээ. Чи солиороо юу? Уэрдлоу надад туслаач.

Дахиад буун дуу хадав. Дөрөв юмуу таван удаа. -Бурхан минь. Энэ гай пгүү гэж Расти багтрав. -Мэдэж байна аа.

26

Жижгээ цагдаагийн газар руу орох шатан дээр зогсоод чанга чанга дуу гарах захиргааны байшин руу эргэж харав. Зүлгэн дээр суугаа хүмүүс үсрэн босоод ямар нэг юм олж харах санаатай хүзүүгээ сунгасан ч Жижгээ тэд нарын хэнд ч харагдах юм байсангүй. Магадгүй хэн нэг нь түүний эцгийг алсан юмуу. Тэр үүнд найдна, нэг ажил багасана биз дээ. Гэхдээ одоо Жижгээд цагдаагийн газарт хийх өөр ажил байна. Нарийн зааж хэлэх юм бол Тахианы-саравчинд.

"Та бүхний хотын цагдаагийн газар ба та. Хамтдаа ажиллацгаая" гэсэн бичигтэй хаалгаар явж оров. Стейси Моггин түүн рүү яарлаа. Түүний араас Руп Либби. Кофе ба боов сурталчилсан зураг дор Микки Уэрдлоу зогсоно. Хздийгээр сүртэй том биетэй ч тэр өөртөө итгэлгүй айж түтшсэн царайтай зогсох ажээ.

- Жижгээ чи ийшээ орж болохгүй гэж Стейси түүнийг зогсоохыг оролдов.

-Мэдээж болно гэж хэлэх гэсэн боловч амных нь тал нь мэдээ алдсан тул "мдээш олон" гэж дуулдав. Таллийгаар хордуулсан болоод тэр. Барби хордуулсан. -Би цагдаад алба хаадаг -"Би шагдаа аба аадаг"

-Чи сопуу байна. Тийм учир эндээс яв. Тэнд юу болоод байна вэ? гэснээ түүнээс ойлгомжтой хариу сонсохгүй нь гэж бодсон бололтой энэ муу жингэр цээж рүү нь түлхлээ. Өвчтэй хөл нь нугараад тэр яг унах шахав. - Жижгээ яв гээд Стейси эргэн тойрноо харж, энэ хорвоо дээрх сүүлчийн үгээ хэлэв. -Уэрдлоу чи энд зогс. Доошоо хэнийг ч бүү нэвтрүүл.

Тэгээд түүнийг цагдаагийн газраас гаргах санаатай Жижгээ рүү эргэтэл өмнөөс нь бууны ам шагайж байв. "Өө үгүй ээ. Тэр ингэхгүй" гэж бодож амжлаа. Тэгээд ямар нэг өвчин үл мэдрүүлэгч боксын бээлий хөхнийх нь хооронд цохиж хойш нь чулууцав. Стейсигийн толгой эргэж, тэр Рупын царайд гайхал тодрохыг олж харав. Дараа нь түүнийг харанхуй залгилаа.

-Үгүй ээ Жижгээ. Чи солиоров уу? Уэрддоу надад туслаач гэж Руп хашгираад гар буугаа шүүрлээ.

Гэвч Микки гадас шиг зогсоод Жижгээ Пайперын хамаатанд таван сум зоохыг харах ажээ. Жижгээгийн зүүн гар мэдээ алдсан ч харин баруун гар нь зохих ёсоор ажиллаж байв. Тэгээд ч бай долоохон фут зайтай байхад нэг их мэргэн байх ч хэрэг алга. Эхний хоёр сум Рупын гэдсэнд онож түүнийг Стейсигийн ширээ рүү чулуудав. Ширээ хөмөрлөө. Руп гэдсээ тэврээд тонгойлоо. Гуравдахь сум хажуугаар нь сүнгэнэж харин сүүлчийн хоёр сум Рупын дагзыг

хийсгэв. Тэр балетын ямар нэг маягтай хөдөлгөөн хийх мэт газарт унахад хөл нь алцайгаад толгой нь үнэндээ бол толгойноос үлдсэн нь сүүлчийн удаа гүнээ мэхийх мэт газар түгхийтэл мөргөв.

Жижгээ утаа баагих буугаа урдаа барьсаар жижүүрийн хэсэг рүү гүйн орлоо. Хэдэн удаа буудсанаа ч үл санана. Долоо юмуу найм гэж бодно. Эсвэл бүр зуун ер. Хэн ян тан мэдэх билээ? Толгойн өвчин эргэн иржээ.

Микки гараа өргөлөө. Түүний малигар нүүрэнд айж түгшсэн боловч тайвшруулахыг оролдох инээмсэглэл тодорно.

-Ах минь хүссэнээ хий. Би танд асуудал үүсгэхгүй гээд Микки дунд ба долоовор хуруугаа өргөн V үсэг харуулсан нь "энх тайвны бэлэг тэмдэг" ажээ.

-Тэгвэл би хийе дээ гэж Жижгээ хариулав.

Тэр Миккиг буудлаа. Саяхан нүд байсан газарт нүх үүсэв. Хоёрдахь нүд нь ноосоо хяргуулах гэж байгаа хонины номхон харцаар Жижгээг харна. Жижгээ баталгаатай байх нь дээр гэж үзээд нөгөө нүд рүү нь бас нэг сум зоов. Эргэн тойрноо харлаа. Одоо цагдаагийн газар түүний мэдэлд ирсэн бололтой.

-За яахав. За яахав гэж тэр сэтгэл ханамжтай дуугарна.

Жижгээ шат руу хөдөлсөнөө Стейсигийн цогцос дээр эргэн ирэв. Түүний хуйнд яг өөрийнх шиг нь "беретта-торус" буу байгааг үзээд бууныхаа дайзыг сугаллаа. Тэгээд дүүрэн сумтай дайзаар солив.

Эргэтэл найгаад нэг хөл дээрээ сөхөрсөн ч босч ирэв. Харааны зүүн хэсэг дэх хар толбо одоо яг усны хоолойн таг шиг том болж ирсэн тул зүүн нүд хаагдсаныг тэр ойлгов. За яахав, тийм ч чухал юм биш. Хэрэв торонд байгаа хүнийг буудахад нэг нүд хангалтгүй байх юм бол би сохор зоосны ч үнэгүй гэсэн үг.

Жижгээ жижүүрийн хэсгийг дахин өнгөрөхдөө Миккигийн цусан дээр хальтраад дахин унах шахав. Гэсэн ч хөл дээрээ тогтож чадав. Толгой нь хагарах шахавч тэр дургүйцсэнгүй. Тамираа барихад тусалж байна.

-Сайн уу Барби гэж тэр шатаар буунгаа хашгирлаа. -Чамайг надад ямар муу юм хийснийг би мэднэ. Тэгээд очиж явна. Хэрэв хүсвэл зальбирч бай. Чи энэ тал дээр яаравчилсан нь дээр шүү.

Хазганасан хөл гишгүүрээр доошлохыг Расти харна. Дарийн утаа болоод цусны үнэр хамар дэлсэнэ. Түүний үхэл ирж явааг тэр ойлгоно. Хазганасан эр Барбиг алахаар хонгил руу бууж ирсэн. Гэхдээ тэр торонд түгжигдсэн нэг муу бага эмчийг амьд үлдээхгүй. Тэгэхээр Расти одоо эхнэр ба хүүхдээ хэзээ ч дахин үзэхгүй.

Хараанд нь Жижгээгийн цээж, хүзүү ба толгой орж ирлээ. Түүний амны зүүн тал унжиж мушийх мэт болсон байх бөгөөд зүүн нүднээс нь цус шүүрэхийг хараад бодов. "Одоо хүртэл хөл дээрээ тогтож байгаа нь үнэхээр гайхалтай. Жаахан хүлээж чадаагүй нь харамсалтай. Хэрэв дахиад жаахан байсан бол тэр гудмаар гарч чадахгүй байсан".

Тэртээ холоос, өөр ертөнцөөс, хотын захиргаанаас чанга яригчийн дуу хадна.

-Битгий гүйгээрэй. Битгий сандар. Одоо аюулгүй болсон. Цагдаа Генри Моррисон ярьж байна. Аюулгүй болсон гэдгийг давтан хэлж байна.

Жижгээ хальтарсан ч энэ үед сүүлчийн гишгүүр дээр иржээ. Унаж хүзүүгээ хугалахын оронд тэр ердөө л сөхрөв. Шүүгч найм хүртэл тоолохыг хүлээж дараа нь босоод тэмцээнээ үргэлжлүүлэх гэж байгаа мэргэжлийн боксчин шиг зогсоно. Растигийн бүх мэдрэмж хурцадлаа. Хүрээлэн буй орчлон тун эмзэг нимгэн болон хувирч, энэ болоод дараагийн мөчийн дунд утаа болон хувирлаа. Хэрэв дараагийн мөч ирэх юм бол шүү дээ.

Жижгээ рүү харангаа "унаач" гэж бодно. "Толгойгоороо уна. Ухаан алд, муу зулбасга".

Гэвч Жижгээ арай чамай босоод гар буу руугаа урьд нь хэзээ ч хараагүй юм шиг гөлрөв. Дараа нь харцаа хонгилын төгсгөлд байгаа хорих өрөө рүү шилжүүлээ. Барби торны төмрийг гартаа базаад Жижгээ рүү харан зогсох ажээ.

-Барби гээд Жижгээ хөлөө чирэн хонгилоор явав.

Тэр өөрийг нь анзаарахгүй байж мэднэ гэж найдаад Расти хойшоо ухарлаа. Барбиг алсаныхаа дараа амиа хорлож мэднэ. Энэ хулчгар санаа гэдгийг мэдэж байсан ч бас амьдралтай санаа гэдгийг ч мэдэж байв. Тэр Барбид юугаар ч тус болж чадахгүй боловч өөрөө амьд гарч мэдэх юм.

Гэвч хэрэв Растиг зүүн талын хорих өрөөнүүдийн нэгэнд хийсэн бол түүний үйлдэл хэрэгжиж мэдэх байсан. Яагаад гэвэл Жижгээгийн зүүн нүд ажиллагаагүй болжээ. Гэвч Расти баруун талын хананд байсан тул түүний нүд хөдөлгөөнийг анзаарав. Зогсоод Растиг харахад хагас хөшсөн царайд нь хорсол ба үл ойлгох байдал зэрэг илэрлээ.

-Фасти? Чиний овог билүү? Эсвэл Беррик билүү? Санахгүй юм.

Түүнээс амь гуйхыг хүссэн ч хэл нь тагнайндаа наалджээ. Гуйгаад ямар утга байх билээ. Залуу буугаа өргөлөө. Жижгээ түүнийг алах гэж байв. Алуурчинг энэ хорвоод хэн ч, юу ч зогсоож чадахгүй.

Растигийн оюун санаа энэ сүүлчийн мөчид гарц хайж байв. Амьдралын сүүлийн бусад олон мөчид хайсан шигээ. Унтраалгыг эргүүлэхийн өмнө, хаалт нээгдэхийн өмнө, чамархайд тулгасан буу галаар тургихын өмнө. "Энэ бүхэн зүүд. Бүгд бүгдээрээ. Бүрхүүл, Динсморын талбайд болсон ухаангүйтэл, хүнсний самуун, энэ залуу. Тэр гохоо дарахад зүүд дуусаад би намрын сэтгэл сэргээм сэрүүн өглөө хөнжилдөө сэрэх болно. Линда руу эргээд хэлнэ: "Би ямар аймаар хар дарсан зүүд зүүдэлсэн гээч. Чи итгэхгүй дээ гэнэ".

-Фасти нүдээ ань. Тэгвэл хөнгөн байх болно гэж Жижгээ зөвлөв.

28

Жекки Уэттингтон цагдаагийн хэсэгт орж ирэнгүүтээ хамгийн түрүүнд "бурхан минь газар сайгүй цус" гэж бодлоо.

Стейси Моггин иргэдэд зориулсан мэдээллийн самбартай хананд хөшжээ. Сэгсгэр цайвар үс урьдын адил нүүрийг эмжих боловч харин нүд нь тааз руу цэхийнэ. Өөр нэг цагдаа жижүүрийн хөмөрсөн ширээний урд нүүрээр доош харан хэвтэх тул хэн болохыг нь таньсангүй. Хоёр хөл нь бараг шпагат сууж байгаа юмуу гэмээр алцайжээ. Цаана нь жижүүрийн хэсэгт өөр нэг цагдаа хажуудан унажээ. Шинэ цагдаа нарын нэг Уэрдлоу байх. Өөр ийм том биетэй хүн байхгүй. Кофе чанагчийн дээрх зургийг залуугийн нус ба тархи буджээ.

Жеккигийн ард хэн нэгэн шогшрох дуу гарав. Тэр өөрөө ч мэдэлгүй бугаа өргөн огцом эргээд Роммиг олж харав. Харин өнөөх нь буу шагайсныг ойлгох ч үгүй хүүрнүүдийг бүлтийн ширтэнэ. Дик Чейнигийн баг шогширч байв. Ромми түүнийгээ тайлаад газарт шидэв.

-Бурхан минь, энд юу болоо вэ? Энэ...

Түүнийг үтээ дуусгаж амжаагүй байтал Тахианы-саравчнаас хашгирах дуу хадлаа.

-Хөөе муу зулбасага. Би чамайг болгож тавьсан тийм үү? Би чамайг бүрэн болгож тавьсан.

Энэ хашгирааны дараа инээд хадсан нь итгэх аргагүй, чих зүсэм ба гажигтай инээд. Хэсэг хугацаанд Жекки Ромми хоёр бие бие рүүгээ харахаас өөр юу ч хийж чадахгүй хөдөлж ч чадахгүй зогсоцгоов.

-Энэ Барбара гэж би бодож байна гэж Ромми хэллээ.

29

Эрни Кэлверт харилцааны компанийн микроавтобусны жолоо барин сууна. Хөдөлгүүр сул ажиллана. Микроавтобус "Хэрэв та цагдаа руу орох бол зөвхөн 10 минут зогсож болно" гэсэн цардмал зам дээрх бичээс дээр зогсоно. Захиргааны байшингаас Төв гудамжаар гүйж яваа үймж сандарсан хүмүүсийн хэн нэг нь машинд суух гэж оролдох вий гэсэндээ бүх хаалгыг дотроос нь түгжээд байв. Роммигоос авсан карабин бугаа суудлын ард тавьсан ч хэн нэгэн микроавтобусанд дайрч суулаа гэхэд буудаж чадна гэдэгтээ эргэлзэж байлаа. Эрни энэ хүмүүсийг таних бөгөөд олон жилийн турш тэдэнд хүнс зарсан. Айдас тэдний царайг өөрчилсөн ч арай танигдахааргүй болтол бишээ.

Ангийн нохой хэрэгтэй үнэрээ хайх мэт захиргааны байшингийн өмнөх зүлгэн дээр наашаа цаашаа холхих Генри Моррисоныг тэр харж байна. Цагдаа чанга яригчаар хашгирч, замбараагүйтэлд ядахдаа эмх журмын үнэр оруулах гэж хичээнэ. Хэн нэгэн түүнийг мөргөж унагасан ч бурхны авралаар тэр дороо хөл дээрээ босов.

Одоо бусад нь гарч ирлээ. Жорж Фредерик, Марти Арсено ба өнөөх Сирлс гэдэг хүү (толгойн боодлоор нь таньж болохоор байв), ах дүү Боуи, Рожер Кильян, бас хоёр ч шинэ цагдаа. Фредди Дентон гартаа буу барьсаар захиргааны байшингийн өргөн гишгүүрээр бууж ирлээ. Рэндолфыг Эрни олж харсангүй. Цагдаагийн шинэ даргыг мэдэхгүй хэн бугай ч тэр хүн эмх замбараагүйтэл өсөхөөс сэргийлж эмх журамтай төстэй ямар нэг юм тогтоохын тулд хүчдэл тавих ажлыг толгойлно гэж бодох болно.

Гэвч Эрни бол хэнтэй харьцаж байгаагаа мэднэ.

Тайван цагт ч Питер Рэндолфоос хүлээх юм юу ч байхгүй. Тиймээс энэ ШНАФУ циркийн тавцан дээр түүний эзгүй байгаад гайхсангүй. (Энэ нь английн 8КАРИ буюу Зидгайоп Ёюгпа1 А11 Ро1ес1 Цр гэсэн үг). Санаа ч зовсонгүй. Өөр юманд санаа зовж байлаа. Цагдаагийн газраас хэн ч гарч ирсэнгүй. Дотор дахиад л буун дуу гарав. Цагдан хоригдсон хүмүүсийг хорих өрөөнүүд байдаг хонгилоос гарах мэт бөглүү дуулдана.

Ердийн цагт шашин шүтдэггүй Эрни харин одоо зальбирч байв. Захиргааны хүмүүсээс хэн ч микроавтобусны жолооны ард суух өвгөнийг бүү анзаараасай гэж. Жекки Ромми хоёр Барбара Расти хоёртой хамт, эсвэл тэдэнгүйгээр ч хамаагүй амьд, эсэн мэнд ирээсэй гэж. Толгойд нь зүгээр л яваад өгч болох юм гэх санаа төрөхөд тэгэх хүсэл ямар их байгааг гайхахад хүрэв.

Гар утас нь дуугарлаа.

Тэр хэсэг хугацаанд юу сонссоноо ойлгохгүй зүгээр л суугаад байв. Дараа нь бүснээсээ салгалаа. Нээж харвал дэлгэц дээр "Жоани" гэжээ. Гэхдээ бэр нь биш Норри залгасан байв.

-Өвөө, та зүтээр үү?

-Тийм ээ гэж тэр нүдний өмнө ноёрхож буй эмх замбараагүйтлийг ширтэн хэллээ. -Та нар тэднийг гаргаж авсан уу?

-Гаргаж авна аа хонгор минь гэж хэлэхдээ тэр худал ярьж нүгэл үйлдэж байгаа гэж огт бодохгүй байлаа. -Одоо ярьж чадахгүй нь ээ. Та нар аюулгүй биз дээ? Та нар... тэндээ очсон уу?

-Тийм ээ өвөө. Өнөөх чинь шөнө гэрэлтдэг юм байна. Цацраг туяаны бүс. Машиныуд бас гэрэлтсэнээ тэр дороо больсон. Жулия аюулгүй гэж бодож байна. Зориулалт нь хүмүүсийг айлгах гэж тэр бодож байна.

"Чи үүнд нэг их найдахгүй байсан нь дээр дээ" гэж Эрни бодов.

Дахиад хоёр удаа бөглүү буун дуу цагдаагийн газраас дуулдлаа. Тахианы-саравчинд хэн нэгэн үхлээ. Өөрөөр байх боломжгүй.

-Норри одоо ярьж чадахгүй ээ.

-Өвөө бүх юм сайхан болно оо.

-Тийм тийм. Би чамд хайртай. Норри.

Эрни гар утсаа хаав. Дотроо "тэр гэрэлтдэг гэнэ" гэж бодлоо. Тэгээд гэрэлтэж байгааг нь харж чадах болов уу гэж таав. Блэк-Ридж ойрхон байдаг (жижиг хотод бүх юм ойрхон) боловч одоо маш хол санагдана.

Тэр цагдаагийн газрын хаалгыг ширтэж сэтгэлийн хүчээрээ найз нараа гаргаж ирэх гэж оролдоно. Гэвч тэд гарч ирээгүй тул Эрни микроавтобусаасаа буулаа. Тэнд суугаад байж чадсангүй. Дотогшоо орж тэнд юу болоод байгааг харахаар шийдэв. Тэр багаа таг мартжээ.

30

Жижгээ буугаа өргөхийг Барби харсан. Растид нүдээ анихыг зөвлөж байгааг ч сонссон. Тэгээд юу ч бодолгүйгээр, юу ярьж байгаагаа ч ойлголгүйгээр хашгирсан бөгөөд тэдгээр үтс түүний уруулаас өөрсдөө л нисэв.

-Хөөе муу зулбасага. Би чамайг болгож тавьсан тийм үү? Би чамайг бүрэн бүрэн болгож тавьсан.

Үүний дараах инээд яг л солиотой хүний инээд байлаа. Бичиж өгсөн эмээ уугаагүй солиотын инээд шиг.

"Тэгэхээр би үхлийн ирмэг дээр зогсоод инээж байгаа юм байна. Санаж авах хэрэгтэй" гэж бодсоноо энэ бодлоосоо болоод бүр чанга инээв.

Жижгээ түүн рүү эргэлээ. Нүүрний баруун хэсэгт гайхал тодорсон ч харин хөшсөн зүүн хэсэг нь үрчийв. Жижгээгийн царай төрх Барбид багадаа уншиж байсан супер хорон санаатныг санагдуулах боловч нэрийг нь одоо санаж чадахгүй байв. Бэтмений дайснуудын нэг байсан байхаа. Тэднийг үргэлж хамгийн аймшигтайгаар дүрсэлдэг. Дараа нь түүний төрсөн дүү Уэндл "дайсан" гэсэн үгийг удтал "дайшин" гэж хэлдэг байсныг санав. Барбигийн инээд улам хүчтэй боллоо.

"Үхэх долоон дор өөр замууд ч бий" гэж Барби бодов. Тэгээд торны завсар хоёр гараа оруулаад хоёр дунд хуруугаа Жижгээд харууллаа. ""Моби Дик"-д гардаг Стаббсыг санаж байна уу? "Намайг юу хүлээж байгааг би мэдэхгүй. Гэхдээ би хувь тавилан руугаа инээсээр очно" гэдэг дээ".

Барби түүнд дунд хуруугаа бүр стерео байдлаар харуулж байгааг Жижгээ харав. Тэгээд Растиг мартлаа. Гар буугаа урдаа бариад богинохон хонгилоор алхлаа. Барбигийн мэдрэхүйн таван эрхтэн хурцадсан ч тэр тэдэнд итгэхгүй байлаа. Дээр хүмүүс явж ярьж байгааг тэр сонсов. Гэхдээ хий дүрслэл түүнтэй хатуу тоглоом хийж мэднэ. Гэсэн хэдий ч Барби эцсээ хүртэл тэмцэхээр шийджээ. Ямартаа ч үүгээрээ тэр Растид амьдралын хэдхэн хором болоод амьсгаа гаргаж өглөө.

-Хүрээд ирсэн үү зулбасага? Би "Дипперс" зогсоолд амыг чинь цэвэрлэж өгсөнийг санаж байна уу? Чи яг гахайн тоорой шиг чарлаж байдаг шүү.

-Би чарлаагүй.

Хятад рестораны ямар нэг хачин сонин хоолны нэр хэлэх мэт дуурсав. Жижгээ аймаар харагдаж байлаа. Зүүн нүднээс сахал ургасан хацар дээр нь цус дусна. Тиймээс Барби түүнд бас боломж байна гэж бодов. Тийм том биш. Гэхдээ ямар ч боломж огт байхгүйгээс дээр. Тэр ханз болоод суултуурын өмнүүр нэг хананаас нөгөө ханын хооронд эхлээд удаан дараа нь улам хурдаа нэмэн холхиж эхэллээ.

Одоо би буудлагын газрын явдаг галуу юу мэдэрдэгийг мэдэж авлаа. Үүнийг ч би бас санаж авах болно.

Жижгээ түүний хөдөлгөөнийг ганц эрүүл нүдээрээ харна.

-Чи түүнийг эдэлсэн үү? Чи Энжиг эдэлсэн үү? -"Чи үүний эдсэн үү? Чи Нжи эдсэн үү?"

Барби дахиад л инээлээ. Өөрөө ч үл таних солиотой инээд. Гэхдээ жүжиглэсэн юм юу ч байгаагүй.

-Түүнийг эдэлсэн үү гэж үү? Түүнийг эдэлсэн үү гэж үү? Жижгээ би түүнийг хүссэнээрээ эдэлсэн. Дээрээс нь доороос нь урдаас нь араас нь. Тэр "Толгойлогч мандтугай" бас "Муу сар мандлаа" гэж дуултал нь эдэлсэн. Тэр нударгаараа газар балбаж, дахиад гуйтал нь эдэлсэн...
Би

Жижгээ буу руу толгой гилжийв. Барби үүнийг анзаараад цаг алдалгүй зүүн тийш үсэрлээ. Жижгээ буудав. Сум улаан тоосгон ханыг онолоо. Хүрэн улаан хэлтэрхий нисэв. Зарим нь торыг онов. Хэдийгээр буун дуунаас түүний чих хангинаж байсан ч лаазанд хийсэн буурцаг сэгсрэх мэт төмөр цохих дууг Барби сонсов. Гэхдээ Жижгээг нэг нь ч оносонгүй. Баас. Хонгилд Расти ямар нэг юм хашгирав. Жижгээгийн анхаарлыг татах гэсэн бололтой. Гэвч тэр одоо юунд ч анхаарал хандуулсангүй. Яагаад гэвэл алахыг хамгаас их хүссэн хүнээ овоо хараандаа харж байлаа.

Гэхдээ алаагүй байна гэж Барби бодлоо. Тэр урьдын адил инээж байв. Солиорол, дэмийрэл, гэхдээ инээж байв. Алж чадаагүй л байна. зэрэмдэг, ганц нүдэт бэлгивч.

- Жижгээ чинийх босдоггүй гэж тэр хэлсэн. Тэр чамайг

Супер Сулрал ноён гэсэн. Бид үхтэлээ инээсэн... Жижгээ яг гох дарах үед тэр баруун тийшээ үсэрлээ. Энэ удаад сум толгойнх нь дэргэдүүр сүнгэнэв. "З-з-з-з-з" гэх дууг Барби сонслоо. Тоосгоны хэлтэрхийнүүд дахиад нисэв. Нэг нь Барбигийн хүзүүнд зоогдлоо. -За яасан бэ Жижгээ? Чи нэг л биш байна тийм үү? Тарвага тооны хичээл бодож чаддаггүй шиг чи муу буудах юм. Чи бүр усан тэнэг юм уу? Энжи Френки хоёр чамайг дандаа тэгж хэлдэг байсан.

Барби баруун тийш гүйх гэж байгаа мэт болсоноо зүүн тийш гүйнэ. Жижгээ гурвантаа буудав. Буудлага бүр чих дөжрүүлж, агаар даринь үнэрээр дүүрлээ. Хоёр сум тоосгонд зоогдож, гуравдахь нь шалан дээр байх төмөр суултуурыг онолоо. Ус асгарав. Барби алсын хананд маш хүчтэй наалдсан тул шүд нь харшина.

-Одоо би чамд хүрлээ гээд Жижгээ хүндээр амьсгаллаа. Гэвч үрэвссэн тархинд нь эсвэл үрэвсээгүй үлдсэн тархины тэр хэсэгт эргэлзээ төрөв. Түүний зүүн нүд сохорсон ба харин баруун нүдэнд нь бүх юм хөвнө. Тэр нэг Барби биш гурвыг харж байлаа. Жижигээг буудах үед үзэн яддаг жингэрийн хүү ханзан дээр унасан ба энэ сум ч хажуугаар нь өнгөрчээ. Ханзны толгойд хэвтэх цагаан дээрний голд хар нүд нээгдлээ. Одоо ядаж тэр хэвтэж байв. Одоо наашаа цаашаа гүйхээ больжээ. Би бүтэн дайз сум буундаа хийсэн нь бурханы аврал.

-Барби чи намайг хордуулсан.

Жижгээ юу яриад байгааг Барби огт мэдэхгүй байсан ч шууд л зөвшөөрлөө.

-Энэ зөв шүү. Жижигхэн өмхий баас идэгч минь. Мэдээж хордуулсан.

Жижгээ буугаа торны завсар дүрээд өвчтэй зүүн нүдээ гараар таглав. Одоо гурван Барбины оронд хоёрыг харж байв. Торон завсар хэл нь бултайж нүүрээр нь хөлс ба цус урсана.

-Алив Барби чиний яаж гүйхийг харцгаая.

Барби одоо гүйж чадахаа больжээ. Гэхдээ мөлхөж чадах байв. Тэгээд мөлхөж өнхрөн Жижгээгийн баруун талд гарав. Дараагийн сум толгой дээгүүр нь шунгинаж, бас жинс ба дотуур өмдийг өгзөг хавьд нь ураад тэр бүү хэл арьсыг нь шүргэх шиг түүнд мэдрэгдэв.

Тийрэлт Жижгээг хойш нь шидэж хөл нь мушгираад тэр унах шахсан ч баруун гараар торноос зуурсаны ачаар хөл дээрээ зогсож үлдэв. Тэгээд орилно.

-Муу зулбасага хөдлөөч.

Барби ханз руугаа ухасхийгээд хугтаа хайлаа. Тэр хараал идсэн хугаа таг мартжээ.

-Нуруундаа сум зоолгомоор байна уу? Тэг л дээ. Надад ялгаа байхгүй.

-Түүнийг ал. Түүнийг ал. Түүнийг ал гэж Расти гэнэт ориллоо.

Дараагийн буун дуу тасхийхээс өмнө Барби: "Бурхан минь, Эверетт чи хэний талд байна вэ?" гэж бодож амжив.

Жекки түрүүлж, Ромми түүний араас бууж ирлээ. Тэр таазны чийдэнгийн тэнд суунаглах дарины утааг анзаарав. Шатсан дарь хүхрийн үнэрийг мэдэрлээ. Дараа нь Расти хашгирав.

-Түүнийг ал, түүнийг ал.

Жекки бага Ренниг хонгилын төгсөлд байхыг олж харлаа. Цагдаа нарын нэг нь "Ритц" гэж нэр өгсөн тэр хорих өрөөний торны дэргэд. Тэр ямар нэг юм хашгирах боловч Жекки нэг ч үгийг нь ойлгосонгүй.

Жекки юу ч бодсонгүй. Тэр Жижгээг гараа өргөж эргэж харахыг тушаасангүй. Шууд л нуруунд нь хоёр сум зоов. Нэг нь баруун уушгийг цөмлөв. Нөгөө нь зүрхийг нь нүхлэв. Жижгээ хоёр торны завсар чихсэн нүүр нь шал руу гулгахаас өмнө амь тавьжээ. Нүд нь хялайсан тул яг японы үхлийн баг шиг харагдана.

Жижгээ халхлахаа болиход ханзан дээрээ түүнээс хайж хурааж чадаагүй хутга барин хэвтэх Барбараг сая харлаа. Барби хутгаа дэлгэж амжаагүй байлаа.

32

Фредди Дентон цагдаа Генри Моррисоныг мөрнөөс нь шүүрэв. Дентон энэ орой түүний дотно хүн биш. Цаашид ч тийм болохгүй. Урьд нь ч хэзээ ч байгаагүй гэж Генри барайн бодов.

-Тэр хөгшин тэнэг Кэлверт яахаараа цагдаагийн газар руу явж байдаг билээ? гэж Дентон асуулаа.

-Би яаж мэддэг юм? гээд Генри алан хядагчдын тухай ямар нэг юм солиорон дэргэдүүр гүйж өнгөрсөн Донни Барибогийн гараас пгүүрэв. -Зогс гэж Генри түүний нүүр рүү ориллоо. -

Бүх юм дууссан. Одоо бүгд сайхан болсон.

Донни Генригийн үсийг засдаг бөгөөд нэг л улиг болсон онигоогоо арван жилийн турш долоо хоногт хоёр удаа ярьдаг хүн. Харин одоо цагдаа руу огт танихгүй хүн харж байгаа юм шиг гөлрөв. Дараа нь гараа суга татан авсанаа үсчний газар нь байдаг Дорнод гудамж руу гүйж одлоо. Тэнд алан хядагчдаас нуугдах гэсэн байх.

-Өнөөдөр иргэдэд цагдаагийн газарт очих ямар ч хэрэг байхгүй гэж Дентон өөрийнхийгөө зүтгүүлэв. Түүн дээр Мел бас нэмэгджээ.

-Чи яагаад өөрөө тийшээ очоод тэнд юу болоод байгааг шалгаж болдоггүй юм бэ, аан алуурчин? гэж Генри Дентонд үг хаялаа. -Энэ новшийг бас дагуулаад яв. Яагаад гэвэл энд та хоёроос гарах ашиг нэг ч байхгүй.

-Тэр буу руу зүтгэсэн гэж Фредди анх удаа үйлдлээ тайлбарласан бөгөөд энэ нь сүүлчийн удаа бас биш юм. -Би түүнийг алах гээгүй. Зүгээр л зогсоох гэсэн юм.

Генри түүнтэй маргах бодолгүй байв.

-Тийшээ очоод өвгөнд тонил гэж хэл. Бас биднийг энд толгойгоо тасдуулсан тахиа шиг эргүүтэж байхад хэн ч баривчлагдсан хүмүүсийг суллах гээгүй эсэхийг шалгаарай.

Фредди Дентоны манантсан нүдэнд цахилгаан гялсхийв.

-Баривчлагдагсад. Мел явцгаая.

Тэд цагдаагийн газар руу дөхөж явсанаа ард нь гуравхан ярдын зайд Генригийн чанга

яригчаар хэлсэн дуу тасхийхэд газарт шаасан мэт зогтусав.

-Буугаа далдхий, тэнэгүүдээ.

Фредди чанга яригчаар хүч оруулсан дуунд захирагдав. Мел ч бас. Тэд Цэргийн дурсгалын талбайг хөндлөн гараад шатаар өгсөж эхэллээ. Гар буу нь хуйндаа байсан ба энэ нь Норригийн өвөөд тун их тус болсон юм.

33

Хаа сайгүй цус гэж Эрни мөн л Жеккигийн адил бодов. Тэр энэ ярга болсон газрыг хирдхийн харсанаа өөрийгөө хүчлэн байрнаас хөдөллөө. Руп ширээг хөмрөх үед Стейсигийн бүх юм газарт унажээ. Түүний дотор одоо хонгилд байгаа хүмүүст хэрэг болж мэдэх улаан хуванцар гурвалжин.

Тэр гурвалжинг авахаар тонгойх үед (бөөлжис ч үгүй болж дээ. Энэ бүхэн түүний Вьетнамын дайнд А-Шау хөндийд үзэж харсанаас илүү юм) ард нь хэн нэгэн хашгирлаа.

-Ёстой баас байна даа. Эрни аяархан бос. Гараа толгойнхоо ард ав...

Гэвч Фредди ба Мел нар дөнгөж хуй руу гараа явуултал хонгилоос Ромми гарч ирэв. Тэр Эрнигийн олсон зүйлийг хайхаар иржээ. Ромми гартаа 40 угсран бууддаг "Хар сүүдэр" буу барьсан байв. Тэр цагдаа нар руу огт эргэлзэлгүй чиглүүллээ.

-Хурдан орж ир. Мөрөө нийлүүлээд зогс. Хэрэв та хоёрын дундуур зай гарах юм бол буудна. Би тоглоогүй пгүү. Үүнд итгэж болно.

-Буугаа буулга. Бид цагдаа гэж Фредди хариуллаа.

-Нэгдүгээр зэргийн бааснууд. Та нар ийм л хүмүүс. Алив энэ мэдээллийн хана руу зогс. Мөрөө нийлүүл. Эрни чи юу хийж байгаа юм бэ?

-Буун дуу сонсоод санаа зовоод гээд Тахианы-саравчны хорих өрөөнүүдийг нээдэг соронзон түлхүүрийг өргөв. -Энэ хэрэг болно гэж бодож байна. Хэрэв зөвхөн... Хэрэв зөвхөн тэд үхээгүй бол.

-Тэд үхээгүй. Гэхдээ бид арай гэж амжлаа. Жеккид аваачиж өг. Би энэ хоёрыг манаж байя.

-Та нар тэднийг суллаж болохгүй. Тэд баривчлагдсан. Барби бол алуурчин. Нөгөөх нь ямар нэг цаасны тусламжтай ноён Ренниг хэрэгт чихэх гэж оролдсон... Эсвэл нэг тиймэрхүү юмаар гэж Мел эсэргүүцэв.

Ромми хариулах гэж оролдсонгүй.

-Эрни яв. Хурдал.

-Бид яах болж байна? Та нар бидний алахгүй биз дээ? гэж Фредди асуув.

-Фредци би чамайг алж яах юм бэ? Чи өнгөрсөн хавар авсан зүлэг хяргагчийн тооцоогоо хийгээгүй. Хэрэв би алдаагүй бол төлбөрөө хийхгүй байгаа. Үгүй. Бид та нарыг Тахианы-саравчинд хийнэ. Тэнд хэр таалагдахыг харъя. Мэдээж шээс ханхалж байгаа. Гэвч энэ үнэр та нарын сэтгэлд нийцнэ.

-Та нар яах гэж Миккийг алсан юм бэ? Сайн залуу шүү дээ. Жаахан тэнэг гэж Мел асуув.

-Бид хэнийг ч алаагүй. Үүнийг чиний дотны найз Жижгээ хийсэн гэснээ дотроо "гэвч үүнд хэн ч итгэхгүй л дээ" гэж бодов.

-Жижгээ юу? Тэр хаана байна гэж Фредди дуу алдлаа. -Тамын пийшинд нүүрс хүрдэж байгаа гэж бодож байна. Тэнд шинээр ирсэн хүмүүст ийм л ажил өгдөг.

34

Барби Расти Жекки ба Эрни нар дээшээ гарч ирэв. Хоригдол хоёр амьд үлдсэндээ одоо хүртэл итгэхгүй байх мэт. Ромми Жекки хоёр Фредди ба Мел нарыг Тахианы-саравчинд аваачив.

-Та нар үүндээ харамсах болно доо гэж газарт тэрийсэн Жижгээгийн цогцосыг хараад Мел дуу алдлаа.

-Амаа тат. Шинэ гэртээ ор. Хоёулаа нэг өрөөнд. Та хоёр чинь найзууд биз дээ? гэж Ромми тушаав.

Ромми Жекки хоёр дөнгөж дээшээ гарангуут шинээр баривчлагдагсад хоолойн хамаг хүчээр хашгирч гарлаа.

-Амжихаар байгаа дээр нь эндээс явцгаая гэж Эрни сандрав.

35

Шатны өмнөх тавцан дээр Расти ягаан оддыг хараад өмхий боловч гайхалтай амттай агаарыг цээж дүүрэн сорлоо. Барби руу эргээд:

-Тэнгэрийг дахин харна гэж бодохоо больсон байсан.

-Би ч бас. Хотоос явцгаая. Боломж байгаа дээр. Майами-Бич танд таалагдах уу?

Микро автобусанд суух үед Расти инээсээр байлаа. Захиргааны өмнөх зүлэг дээр хэдэн цагдаа зогсоно. Тэдний нэг Тодд эргэж харав. Эрни түүнд гараар даллав. Цагдаа мөн тэгж хариулаад өндөр өсгийгөөр ямар нэг юманд тээглэж өвсөн дээр унасан эмэгтэйд туслахаар тонгойлоо.

Эрни жолооны ард суугаад хянах самбарын доор сул унжих цахилгааны утсыг холбов. Хөдөлгүүр асч хажуугийн хаалга хаагдаад машин явган хүний замаас гарлаа. Тэд толгой өгсөн хотын талбай руу явах ба одоо хүртэл бүрэн тайтгаралгүй үүгээр тэнүүчлэх хотын бүх

нийтийн хуралд оролцогсодыг тойрон гарна. Хотын төв дөнгөж ард үлдэнгүүт Эрни хурдаа нэмж тэд Блэк-Ридж рүү давхилаа.

Шоргоолж

1

Одоо доогуур нь лаг шаврын дундуур нарийхан горхи урсах хуучин зэвэрсэн гүүрээр гарангуут тэд гэрлийг олж харав. Хойно сууж явсан Барби урд сандалуудын дундуур тонгойлоо.

-Энэ юу вэ? Хамгийн том "Индигло" цаг шиг харагдаж байв. (нүүрээ гэрэлтүүлэхийн тулд электролюминисцент ашигласан цаг)

-Энэ бол цацраг туяа гэж Эрни хариулав.

-Бүү санаа зов. Бидэнд тугалган хуудас хангалттай гэж Ромми хэллээ.

-Та нарыг хүлээж байх хооронд Норри миний гар утас руу ярьсан. Гэрэлтүүлгийн тухай хэлсэн юм. Жулиягийн бодлоор энэ ердөө л... Мануухай юмуу нэг тийм юм гэж хэлсэн. Ингэж хэлж болохоор бол. Ямар ч аюулгүй.

-Жулия чинь инженер биш сэтгүүлчийн дишюмтай гэж би бодсон юмсан. Тэр их ухаалаг сайхан эмэгтэй. Гэвч бид энэ хуягийг өлгөх хэрэгтэй. Тийм үү? Яагаад гэвэл 40 дэх төрсөн өдрөө хийх үед өндгөвчний юмуу хөхний хавдар гэх мэтийн бэлэг авах хэрэг надад үгүй гээд Жекки толгой сэгсэрлээ.

-Бид энэ хэсгийг түргэн туулна. Цээж ба өмдний урд хэсгээ хэрэв санаа зовоод байвал тугалган туузаар хааж болно гэж Ромми амлав.

-Би инээдийг мартсан нь үнэхээр инээдтэй гэж бүсгүй хариулав. Дараа нь хамгийн сүүлийн үеийн загвараар оёсон тугалган дотоож ба хөхний даруулгатай байгаагаар өөрийгөө төсөөлөөд инээд алдав.

Тэд утасны шонгийн дэргэд хэвтэх баавгайн сэгэнд дөхөж ирлээ. Гэрлээ унтраасан ч харагдахаар байв. Яагаад гэвэл ягаан сар ба цацраг туяаны гэрэлд сонин уншиж ч болохоор байлаа.

Ромми Жекки хоёр микро автобусны цонхыг тугалган туузаар хааж байх үед бусад нь үмхийрч муудсан баавгайг хагас тойрон зогсов.

-Цацраг туяа биш байна гэж Барби хэллээ.

-Биш. Амиа хорлолт гээд Расти толгой дохив.

-Ганцаараа ч биш байх.

-Тийм ээ, гэхдээ жижигхэн амьтад нь аюулгүй байх шиг. Би хүүхдүүдтэй хамтдаа шувуудыг харсан. Алимны цэцэрлэгт хэрэм ч харсан. Цовоо байна билээ.

-Тэгвэл Жулиягийн зөв. Гэрэлтүүлэг бол айлгах зориулалттай. Харин үхсэн амьтад өөр зүйл. Ердийн аюулгүйн бүс.

-Найз минь ойлгосонгүй гэж Эрни үнэнээ хэлэв.

Харин бага эмчийн сургуульд сурсан Расти "аюулгүйн бүс" гэсэн ойлголттой танил учир пгууд ойлгов.

-Сониуч хүмүүсийг ойлгох давхар анхааруулга. Өдрийн цагаар амьтадын сэг зэм. Харин шөнөөр гэрэлтэх цацраг туяаны бүс.

-Миний мэдэхээр зөвхөн шинжлэх ухааны уран зөгнөлт кинонд цацраг туяагаар хордсон газар гэрэлтдэг гэж Ромми хэлэв.

Тэд одоо яг шинжлэх ухааны уран зөгнөлт кинонд орсон бөгөөд орой дээр байгаа тэр хачин хайрцагт гар хүрэхээрээ Ромми бүхнийг ойлгоно гэж Расти хэлэхийг хүслээ. Гэхдээ мэдээж Ромми зөв ярьж байв.

-Бидэнд үүнийг шургуулсан хэрэг. Амьтны сэг зэм ч бас адил. "Пөөх энэ бол том биетэй хөхтөн амьтанд нөлөөлдөг үхлийн туяа юм байна. Холхон байсан нь дээр. Эцсийн эцэст бид том хөхтөн шүү дээ" гэж хэлэхээр тооцоолжээ.

-Гэвч хүүхдүүд эргэж буцаагүй гэж Барби санууллаа.

-Яагаад гэвэл тэд хүүхдүүд гэж Эрни хариулаад жаахан бодсоноо -Дээр нь бас скэйтчид. Энэ шал өөр гэв.

-Надад таалагдахгүй байна. Гэвч өөр хаашаа ч явах газаргүй тул мэдрэл муудахаас өмнө энэ Ван Аллений бүсээр дайраад гарч чадах байх. Цагдаагийн газарт болсон явдлаас хойш би чичрээд л байна гэж Жекки өөрийнхөөрөө зүтгэлээ.

-Жаахан хүлээ. Энд нэг л биш. Надад эргэлзээ байхгүй. Гэхдээ үүнийг яаж нэрлэх талаар бодохын тулд хоромын хугацаа өгөөч гэж Барби баавгайг харангаа хэлэв.

Тэд хүлээлээ. Сарны гэрэл ба цацраг туяаны гэрэлтүүлэг баавгайн сэг зэмийг хучина. Барби урьдын адил түүнээс нүд салгалгүй ширтэнэ. Эцэст нь толгойгоо өргөөд:

-Намайг ганцхан юм түгшээж байна. Тэд. Бид Тэдний тухай мэднэ. Яагаад гэвэл Растигийн олсон хайрцгийг байгаль бүтээгээгүй.

-Чөттөр шиг үнэн. Түүнийг хэн нэгэн бэлдсэн. Гэхдээ дэлхий дээр биш. Би амь насаараа дэнчин тавихад ч бэлэн байна гэж Расти дуу алдлаа. Гэвч ердөө цагийн өмнө түүнийг

алдах шахсанаа бодоод давхийн цочив. Жекки түүний мөрнөөс базлаа.

-Би үүний тухай яриагүй. Бид тэдэнтэй харьцаж байна. Хэрэв тэд үнэхээр биднийг нэвтрүүлэхийг хүсээгүй бол нэвтрүүлэхгүй байсан. Тэд чинь Честерс-Миллийг бүх

ертөнцөөс салгаж чадсан. Хэрэв тэд биднийг энэ хайрцагнаас хол байлгахыг хүссэн бол яагаад түүн дээр бяцхан Бүрхүүл тавиагүй юм бэ?

-Эсвэл түүнийг ямар нэг дуу цацруулагчаар цэнэглээд тахианы хөлийг бичил долгионы зууханд шардаг шиг бидний тархийг шарж болох л байсан биз дээ. Жинхэнэ цацраг туяа гэдэг чинь энэ шүү дээ гэж хэлэхдээ Расти Барби хаашаа чиглээд байгааг ойлгож эхэлжээ.

-Энэ жинхэнэ цацраг туяа байж ч мэднэ. Та нарын барьж ирсэн Гейгерийн тоолуур үүнийг баталж өгсөн гэж Эрни тодруулав.

-Тийм ээ, гэхдээ Гейгерийн тоолуурын бүртгэсэн туяа аюултай гэсэн үг мөн үү? Расти болоод хүүхдүүдэд ямар ч хохирол учраагүй. Тэдний үс унаагүй ба өөрийнхөө ходоодоор бөөлжихгүй байгаа гэж Барби дурьдлаа.

-Одоохондоо үгүй гэж Жекки тодотгов.

-Үүнд баярлах хэрэгтэй гэж Ромми давслаа.

Барби тэдний өргөс үгийг тоосонгүй.

-Хэрэв тэд америкийн шилдэг пуужинг сөнөөх саад үүсгэж чадсан юм бол түргэн алах, тэр бүү хэл хоромхон зуур алах цацраг туяаны бүс байгуулахад ядах юмгүй. Тэгээд ч энэ нь тэдний сонирхолд нийцнэ. Хоёр хүний хүүр хүсээгүй суддаачдыг зогсооход хэдэн арван амьтны сэгээс илүү. Би тэгж бодохгүй байна. Жулиягийн зөв. Цацраг туяаны бүс гээд байгаа хоргүй гэрэлтүүлгийг бидний багажинд бүртгэгдэхээр тохируулсан юм байна. Хэрэв тэд үнэхээр харь гаригийнхан мөн бол энэ багаж дэндүү болхи бүдүүлэг үзэгдэж байгаа.

-Гэхдээ яагаад? Ер нь яах гэж энэ саад хэрэгтэй юм бэ? Би тэр чөтгөрийн хайрцгийг өргөж дийлээгүй. Хөдөлгөж ч чадаагүй. Тугалган хормогчоор хучихад шатчихсан. Тэгсэн мөртлөө хайрцаг хүйтэн байсан гэж Расти дүрсхийв.

-Хэрэв тэд энэ багажийг хамгаалж байгаа юм бол түүнийг устгах юмуу салгах арга байж л таарна. Хэрэв зөвхөн... хэмээн Жекки саналаа хэллээ.

Барби түүн рүү инээмсэглэв. Өөрийгөө нэг л хачин мэдрэв.

Өөрийнхөө толгой дээгүүр хөвөх мэт. -Алив Жекки хэлээч.

-Хэрэв зөвхөн тэд түүнийгээ огт хамгаалдаггүй юм бол тийм үү? Түүнд нь хүрэх зорилготой хүмүүсээс хамгаалдаггүй.

-Энэ бас бүгд биш. Тэд бидэнд багажаа өөрсдөө зааж өгөөгүй гэж үү? Жо ба түүний нөхөд талхны үйрмэгийн замаар явсан юм шиг л болсон.

-Жинхэнэ бяцхан дэлхийн дайчид. Тэгээд та нар тэр хайрцгийг яах юм бэ? Түүнд хүрч очих зориг хүрсэн та нар? гэж Расти мушийв.

-Нөхцөл байдал яг ийм байна. Явцгаая. Оргилд харцгаая гэж Барби толгой дохилоо.

2

Расти Эрнид хандан: -Надад жолоо барихыг зөвшөөр. Хүүхдүүд ухаан алдсан газар энүүхэнд байгаа. Ромми ч бас бараг тасрах шахсан. Би бас ямар нэг юм мэдэрсэн. Дөлөөр хучигдсан, хүн шиг өндөр нуруутай, хэллоуины хүүхэлдэй нүдэнд үзэгдсэн.

-Бас нэг сануулга юм болов уу? гэж Эрни таамаглав.

-Мэдэхгүй.

Расти ой төгсч чулуурхаг бэл Маккойн алимны цэцэрлэг рүү өгсөх тэр газарт ирэв. Урд талд агаар хүчтэй гэрэлтэх тул нүд онийход хүрнэ. Гэхдээ тэд гэрлийн эх үүсвэрийг олж хараагүй бөгөөд гэрэлтэлт агаарт хөвөх аятай. Олон гэрэлт цох харж байгаа юм шиг Барбид санагдав. Гэхдээ тэд байх ёстойгоосоо сая дахин хүчтэй гэрэлтэх мэт. Харин гэрлэн бүсийн цаагуур ахиад тас харанхуй болох бөгөөд сарны ягаан гэрлийг эс тооцвол юм.

-Хэн нэгэн ухаан алдахгүй гэдэгт чи итгэлтэй байна уу? гэж Барби асуув.

-Яг Бүрхүүлд шүргэх шиг тийм түүх давтагдана. Бүх насаараа сэргийлэх тариа тариулах мэт. Хиймэл шүднүүдээ сайн бариарай ноёд хатагтай нараа гээд Расти жолоон дээр сууж хурдаа залгав.

Микроавтобус гэрэл рүү давхилаа. Цонх хаасан тугалган хавгаснууд юу болж байгааг харах боломж үл олгоно. Гэвч хяр дээр аль хэдийн гарсан хэдэн хүн тэднийг ажиглаж байв. Алимны цэцэрлэгийн хил дээр зогсонгоо санаа зовох нь улам өсөн нэмэгдэх ба харна. Яг бүс дотор орохдоо микроавтобус хүчтэй тольдуурын гэрэлд орсон юм шиг тод харагдлаа. Бас бүсээс гарсан хойноо хэдэн минут гэрэлтсэн нь хулгайлагдсан микроавтобусыг радиийгаар будсан мэт. Бас машины араас яг яндангийн утаа шиг гэрэлтэх мөр зурайв.

-Жинхэнэ баас байна даа. Үүнээс илүү тусгай нөлөөллийг би үзэж байсангүй гэж Бенни дуу алдав.

Микроавтобусыг хүрээлсэн гэрэлтүүлэг бүүдийж, сүүл алга боллоо.

3

Гэрэлтэх бүсийг дайран гарах үед Барби түр зуур толгой эргэхийг мэдэрсэн бөгөөд өөр яасан ч үгүй. Эрнигийн тухайд микро автобус болоод түүн дотор байсан хүмүүс, бас бодит ертөнц алга болж, дотор нь хуш үнэртэж Ниагарын хүрхрээ хүржигнэх нь сонсогдох зочид буудлын өрөө болчихов. Тэгээд ердөө 12 цагийн өмнө түүний эхнэр болсон эмэгтэй унтлагын цамцтайгаа ирсэн бөгөөд цамц нь арцны утааг санагдуулах ба түүний гарыг авч хөхөн дээрээ тавиад "энэ удаад бид зогсох хэрэггүй хонгор минь" гэж хэлэв.

Дараа нь тэр Барбигийн хашгирахыг сонсоод бодит байдалд эргэн ирлээ.

-Расти тэр уналт өгч байх шиг байна. Зогсоорой.

Эрни эргэн тойрноо харвал Жекки салганан чичрэх бөгөөд нүд нь цагаанаар эргэлдэж, хуруунууд нь тал тал тийш татаж хөшсөн байв.

-Тэр загалмай өргөж байна. Бүх юм шатаж байна, дэлхий шатаж байна, хүмүүс шатаж байна гэж тэр хашгирах ба амнаас нь шүлс цацарна. Дараа нь машин дүүрэн чарлалаа.

Расти замаас гарах шахсан ч замын гол руу мушгиж дөнгөөд Барбигийн аль хэдийн нээсэн хажуугийн хаалга руу гүйв. Жекки пгүлсээ гараар арчина. Ромми түүний мөрөөр тэвэрлээ.

-Чи зүтээр үү? гэж Расти асуув.

-Одоо бол тийм. Би зүгээр л... Бүгд... Бүгд шатсан. Өдрөөр шөнө болсон. Хүмүүс шатаж байсан... гээд тэр уйлж эхлэв.

-Чи загалмай барьсан эрэгтэйн тухай ямар нэг юм хэлсэн гэж Барби санууллаа.

-Том цагаан загалмай. Тэр нь савхин тууз билүү эсвэл уяанд өлгөөстэй байсан. Түүний нүцгэн цээжин дээр. Дараа нь тэр хүн загалмайгаа нүүрнийхээ өмнө өргөсөн гээд Жекки гүнзгий амьсгаа авч гаргахыг хэд хэд давтсанаа: -Одоо бүгд мартагдаж байна. Гэвч...

Расти хоёр хуруугаа гозойлгон гараа өргөөд хэдэн хуруу харж байгааг асуув. Жекки зөв хариуллаа. Дараа нь эрхий хуруугаа гозойлгон хоёр тийш дээш доош хөдөлгөхөд нүдээрээ дагуулж харав. Расти түүний мөрөн дээр алгадаад дараа нь ард хоцорсон гэрэлт бүсийг үл итгэсэн нүдээр харав. Голдум чинь Бильбо Бэггинсийн тухай юу гэж хэлдэг билээ дээ? "Харж байгаа бүхэн хуурамч хонгор минь". (энэ нь английн зохиолч Ж.Толкины зохиолын баатрууд).

-Барби чи зүгээр үү?

-Тийм ээ, хоёр секунд толгой эргэснээс өөр яагаа ч үгүй. Эрни чи?

-Би эхнэрээ үзсэн. Бал сараар буудалласан зочид буудлын өрөөнд. Тод бөгөөд тодорхой.

Эхнэр нь түүнд хэрхэн ойртсоныг тэр бодов. Энэ тухай бодолгүй олон жил болжээ. Ийм гайхалтай дурсамжийг тоохгүй байна гэдэг чинь ямар ичмээр юм бэ? Шөнийн хувцасны богино хормойн дороос цухуйх түүний цасан цагаан гуя, умдагны нямбай зассан хар гурвалжин, алга зүсэх шахах нимгэн торго, тэр хэлээ түүний аманд хийгээд доод уруулны дотор талаар долоосон.

Энэ удаад бид зогсох хэрэггүй хонгор минь.

Эрни хойшоо хэвтээд нүдээ анив.

Расти өгсүүр замыг туулсан тул одоо хурдаа хасч микроавтобусаа хагас нурсан барилга ба амбаарын хоорондуур тавьлаа. Энд "Эглантери"-гийн фургон, Берпигийн их дэлгүүрийн фургон ба "Шевроле Малибу" зогсоно. Жулия прусээ амбаарт оруулжээ. Горас нохой машиныг хамгаалах мэт ар талд нь хэвтэнэ. Тэр нохой жаргалтай харагдахгүй байх ба хүмүүстэй мэндлэх гэж амбаараас гарсангүй. Гэрт Коулманы хоёр чийдэн асна.

Жекки "Берпид өдөр бүр үнэ хямдарсан худалдаа" гэсэн бичигтэй фургоныг заав.

-Энэ яаж ийшээ ирсэн юм бэ? Танай эхнэр боддоо өөрчилсөн юм уу?

Ромми инээд алдлаа.

-Хэрэв чи ингэж бодож байгаа бол Мишаг мэдэхгүй юм байна. Үүний төлөө Жулияд талархах хэрэгтэй. Тэр шилдэг сэтгүүлчдээ дагуулсан. Эдгээр залуус...

Дуугаа хураав. Яагаад гэвэл сарны туяанд гэрэлтсэн алимны цэцэрлэгээс Жулия Пайпер ба Лисса нар гарч ирлээ. Тэд гар гараасаа хөтлөн уйлж байв.

Барби Жулия дээр гүйж очоод мөрөөр нь тэвэрлээ. Тэр хамгийн захад явах бөгөөд чөлөөтэй гартаа газар руу чиглүүлсэн чийдэн барьжээ. Толгойгоо өргөөд инээх гэж оролдов.

-Тэд ямар ч гэсэн чамайг гаргаж чаджээ, хурандаа Барбара. Манай баг нэг оноо авлаа.

-Юу болоо вэ? гэж Барби асуув.

Цэцэрлэгээс Жо Бенни ба Норри нар гарч ирлээ. Ээж нар нь араас нь дагажээ. Гурван эмэгтэй ямар байдалд байгааг хараад хүүхдүүдийн хашгирах дуу тасалдав. Горас эзэгтэй рүүгээ хуцан гүйлээ. Жулия өвдөглөж суугаад түүний үсэнд нүүрээ наав. Горас түүнийг үнэрлэснээ гэнэт ухарлаа. Оцойн суугаад улив. Жулия үүнийг харсанаа дараа нь ичсэн мэт нүүрээ гараар дарав. Норригийн хоёр гараас Жо Бенни нар атгажээ. Тэдний царайд айдас түгшүүр тодорно. Пит, Тони ба Роуз нар байшингаас гарч ирсэн ч тэдэнд ойртсонгүй. Гал тогооны хаалган дээр овоорон зогсоно.

-Бид өнөөх хайрцаг руу очсон юм гэж Лисса хөндий ярьж эхлэв. Түүний үргэлж хөөрч баярлаж явдаг сэтгэлээс ул мөр үлдсэнгүй. -Бид тойрч суугаад сөхөрсөн. Түүн дээр миний урьд нь хэзээ ч хараагүй тэмдэг зурсан байна... Каббал лав биш...

-Энэ үнэхээр аймаар гээд Пайпер нүдээ арчив. Дараа нь Жулия түүнд гар хүрсэн. Тэр ганцаараа хүрсэн. Гэхдээ бид... Бид бүгдээрээ...

-Та нар тэднийг хараа юу? гэж Расти асуув.

Жулия гараа унжуулаад түүн рүү чичирхийлэн харсанаа:

-Тийм ээ, би харсан. Бид бүгд харсан. Тэднийг. Аймаар.

-Илгэн толгойтуудыг уу?

-Юу гэнэ ээ? гэж Пайпер асууснаа толгой дохиод -Тийм ээ, тэгж нэрлэж болох юм байна. Царай төрхгүй нүүр. Өндөр зуйван нүүр.

Өндөр нүүр гэж Расти дотроо давтав. Энэ юу гэсэн үг болохыг мэдэхгүй боловч зөв үг гэдгийг ойлгож байлаа. Дараа нь өөрийн охид болоод тэдний найз охин Диана нар гэрээсээ авч гарсан хүнс ба жигнэмэг солилцож байсан тухай дахин бодлоо. Дараа нь хүүхэд насны найз, биш ээ хэсэгхэн зуурын найз, яагаад гэвэл хоёрдугаар ангидаа Жорж тэр хоёр муудалцсан, түүний тухай бодонгуут аймшиг нөмөрлөө. Барби түүнийг тэврэв.

-Юу вэ? Одоо бас юу вэ? гэж тэр бараг хашгирав.

-Зүтээр. Зөвхөн... Хүүхэд насанд надад нэг найз байсан юм. Жорж Лэтроп. Нэг удаа төрсөн өдрөөр нь томруулдаг шил бэлэглэсэн. Тэгээд заримдаа... Их завсарлагаар... Бид...

Расти Жулияд босоход нь туслав. Горас түүн дээр ямар нэг юмнаас айх мэт дөхөж очсоноо өнөөх айлгасан зүйл нь микроавтобусыг хүрээлсэн гэрэлтүүлэг хайлсан мэт дөхөв.

-Та нар юу хийсэн юм бэ? гэх үед Жулиягийн хоолой тайван болоод -Ярь гэлээ.

-Энэ явдал Төв гудамж дахь хуучин бага сургуульд болсон юм. Ердөө хоёр өрөөтэй. Эхний өрөөнд 1-4-р анги, нөгөө өрөөнд 5-8-р анги байдаг. Тоглоомын талбай нь цардмал биш. Тэр байшинд усны хоолой ч байгаагүй. Ганц жорлон байсныг хүүхдүүд нэрлэхдээ... гэснээ тэр цухалдан инээлээ.

-Зөгийн балан байшин. Би бас тэнд хичээлд явдаг байсан гэж Жулия хэлэв.

-Жорж бид хоёр швед хананы хажуугаар хашаа руу явж байлаа. Тэнд шоргоолжны үүрнүүд байдаг. Бид шоргоолж шатаадаг байсан.

-Өөрийгөө үүнд зэмлэх хэрэггүй дээ гээд Эрни толгой сэгсрэв. -Олон хүүхдүүд ийм юм хийдэг байсан. Түүнээс ч дор юм.

Эрни өөрөө хэдэн найз нартайгаа муурны сүүлийг керосинд дүрээд дараа нь шатааж байсан. Хуримын шөнийн дурсамж шигээ энэ дурсамжийг тэр хэнд ч ярихгүй.

Яагаад гэвэл юуны өмнө бид яг солиотой хүмүүс шиг инээж байсан. Бурхан минь. Бид яаж инээлдэж байв даа гэж тэр бодно.

-Үргэлжлүүл гэж Жулия хэлэв.

-Би яриад дуусчихлаа гэж Расти хариуллаа.

-Үгүй байлгүй дээ.

-Сонсооч гэж Жоани дундуур нь оров. -Энэ бүх сэтгэл суддал энэ тэр тун сонирхолтой гэдэгт би итгэдэг. Гэвч яг одоо бол...

-Жоани дуугүй бол гэж Клер түүнийг таслав.

Жулия Растигийн нүүрнээс нүд салгасангүй.

-Энэ чамд яагаад тийм чухал байгаа юм бэ? гэж Расти асуулаа. Энэ мөчид эргэн тойронд хэн ч байхгүй бөгөөд өөрөө өөртэйгөө ярих шиг түүнд санагдана.

-Зүгээр л хэл.

-Нэг удаа үүнийг хийж байтал... Шоргоолж ч бас өөрийн амьдралтай гэх санаа надад төрсөн юм. Энэ сэтгэлийн хөдлөл шиг сонсогдож байгааг би ойлгож байна...

-Дэлхийн сая сая хүүхэд үүнд итгэдэг. Энэ итгэлтэйгээ амьдардаг гэж Барби эсэргүүцэв.

-Нэг үгээр хэлэхэд би ингэж бодлоо. "Бид тэдэнд хор хүргэж байна. Бид тэднийг газар дээр шатааж байна. Магадгүй газар доорх гэрт нь шатааж байна". Газар дээр бол Жоржийн томруулдаг шил тэднийг үнэхээр шатааж байсан. Зарим нь хөдлөхөө больдог ч ихэнхи нь шатдаг юм.

-Энэ аймшигтай гэж Лисса өөрийн эрхгүй хэлэв. Тэр амьдралын Түлхүүрээ гартаа эргэлдүүлнэ.

-Тийм ээ хатагтай. Нэг удаа би Жоржоос үүнийг болихыг гуйв. Тэр намайг сонссонгүй. "Энэ бол амтаг дайн" гэж хэлсэн. Би яг санаж байна. Атомын биш амтаг дайн гэсэн. Би түүнээс томруулдаг шилийг нь авах гэж оролдсон. Дараагийн мөчид бид аль хэдийн зодолдож эхэлсэн. Харин томруулдаг шил хага үсэрсэн. Гэхдээ энэ худлаа. Би тэр үед аавд яг ингэж хэлсэн. Намайг зодсон ч би үгээсээ буцаагүй. Харин Жорж эцэг эхдээ үнэнийг хэлсэн. Би томруулдаг шилийг албаар хагалсан юм. Хэрэв би чаддаг бол тэр хайрцгийг хагалмаар байна. Яагаад гэвэл одоо бид шоргоолж болжээ. Харин энэ хайрцаг томруулдаг шил гээд харанхуй руу заалаа.

Эрни сүүл нь шатсан муурын тухай бодов. Клер найз охины хамт гуравдугаар ангид байхдаа тэднийг үзэн яддаг охин уйлахад нь дээр нь сууснаа бодов. Тэр охин сургуульд дөнгөж шилжиж ирсэн бөгөөд амандаа нухсан төмс чихсэн юм шиг инээдтэй өмнөдийн аялгаар ярьдаг байсан. Охин чанга уйлах тусам тэд чанга инээж байв. Хилари Клинтон Нью-Хэмпширт уйлж байхад Берпи соптол архи ууснаа саналаа. Зурагтын дэлгэцтэй хундага тулгаад "Муу гичий, чиний төлөө ууя. Замаас зайл. Эр хүнд эр хүний ажлаа хийх боломж олго" гэж хэлсэн. (энэ нь Нью-Хэмпшир мужид 2008 онд Хиллари Клинтон санал асуулгаас хамааралгүйгээр Барак Обамаг ялсан тухай хэлжээ).

Барби өнөөх спорт танхимыг бодов. Цөлийн халуун, баасны үнэр, инээд.

-Би хайрцгийг өөрөө хармаар байна. Надтай хэн явах вэ? Расти санаа алдаад: -Би, би гэв.

явах үед хотын захиргааны гишүүн Ренни дөнгөж саяхан Барбигийн хоригдож байсан хорих өрөөнд зогсч байлаа.

Жижгээгийн цогцосыг ханзан дээр тавихад нь Картер туслав.

-Намайг түүнтэй үлдээ гэж Том Жим тушаалаа.

-Босс оо, одоо таньд тун муу байгааг би ойлгож байна. Гэвч таны анхаарлыг даруй шаардаж буй хэдэн зуун ажил байна.

-Би мэднэ. Ажиллах болно. Гэвч эхлээд хүүтэйгээ хэсэг хугацаанд хамт байх хэрэгтэй. Дараа нь чи хоёр залуу аваад түүнийг оршуулгын товчоонд хүргээрэй.

-Мэдлээ. Би таны гарзанд харуусч байна. Жижгээ сайн залуу байсан.

-Үгүй. Тэр тийм байгаагүй гэж Том Жим өдөр тутмын хоолойгоор хэлснээ: -Гэвч тэр миний хүү байсан юм. Би түүнд хайртай байсан. Энэ тийм ч муу зүйл биш шүү. Чи үүнийг мэдэх үү?

Картер бодсоноо -Би мэднэ гэв.

Том Жим инээмсэглээд:

-Чиний мэдэж байгааг би мэднэ. Одоо чи бол надад үргэлж үгүйлэгдэж байсан тэр хүү гэж би бодох болсон.

Картер сэтгэл ханаснаас болж улайгаад жижүүрийн хэсэгт хөтлөх шат руу алхлаа.

Түүнийг явсны дараа Том Жим ханзан дээр суугаад Жижгээгийн толгойг өвөр дээрээ тавив. Залуугийн нүүрэнд шарх байсангүй. Картер түүний нүдийг аниулав. Хэрэв цамцан дээр нь цус байгаагүй бол тэр унтаж байгаа мэт сэтгэгдэл төрнө.

Тэр бол миний хүү байсан юм. Би түүнд хайртай байсан.

Том Жим үнэнийг хэлсэн. Тэр Жижгээг гарзанд гаргах гэж байсан. Түүх ийм олон жишээг мэднэ. Голгофт юу болсоныг уншихад хангалттай. Яг Христ шиг. Жаалхүү зөв үйлсийн төлөө үхжээ. Андреа хичнээн хор хүргэсэн байлаа ч Барби хэд хэдэн цагдааг алж түүний дотор толгойлогчийнх нь ганц хүүг алсныг мэдээд хүмүүс бүхнийг мартана. Улс төрийн өнцгөөс харах юм бол эрх чөлөөтэй болсон бөгөөд шинэ хорлолууд зохион байгуулж мэдэх Барби багагүй ашиг авчирч мэднэ.

Том Жим хэсэг хугацаанд сууж Жижгээгийн үсийг илээд царайд нь зэмлэл тодорсон нүүрийг нь харлаа. Дараа нь үл сонсогдом дуугаар, хөх хөхдөг өлгийтэй нярай амьтан гайхаж томорсон нүдээр хорвоог харж хэвтэхэд ээж нь Жижгээд дуулж өгдөг байсан тэр дууг дуулав.

-Бяцхан хүүгийн завь нь мөнгөн сар юм. Тэр завь тэнгэрт хөөрч, зүүдний тэнгист хөвнө. Дэргэдүүр нь үүлс хөвнө... Хөв жаалхүү минь хөв, хөв... Далай тэнгисийг туулан хөв...

Дараа нь дуугүй боллоо. Бусад үгийг санасангүй. Жижгээгийн толгойг өргөөд босов. Зүрх нь салгалсан ч Том Жим амьсгалаа барьмагц зүгээр болчихлоо. Удахгүй верап билүү юу билээ тэр тарианаас бас нэг хийлгэх юм байна гэж бодов. Эндигийн эмийн нөөцнөөс гаргаж авна. Гэвч одоохондоо ажил дүүрэн байна.

6

Тэр Жижгээг ханзан дээр үлдээгээд бариулаас зууран шатаар аажим өгсөв. Картер жижүүрийн хэсэгт хүлээж байлаа. Цогцосыг авч одов. Газраар дэвссэн сонинд Миккигийн цус нэвчжээ.

-Цагдаа нар наашаа ирээгүй байгаа дээр захиргаа руу явцгаая гэж тэр Картерт хэлээд: - Уулзалтын өдөр албан ёсоор эхэлж байна... гэснээ Ренни цагаа харж: -Ойролцоогоор 12 цагийн дараа. Тэр хүртэл бид их юм амжуулах хэрэгтэй.

-Би мэднэ.

-Миний хүүг битгий мартаарай. Боуи нар хичээгээсэй гэж би хүсч байна. Цогцосыг чанартай бэлдэх ба сайхан хайрцаг байх ёстой. Хэрэв Жижгээг тэдний саравчинд байдаг хямдхан авснуудын нэгэнд харах юм бол ална гэж Стюартад хэл.

Картер дэвтэр дээрээ тэмдэглэв.

-Би үүнд санаа тавина.

-Стюартад удахгүй би түүнтэй ярина гэж хэлээрэй. Хэдэн цагдаа орж ирлээ. Цэл залуу шал ногооноороо байгаа тэдгээр цагдаа нар дарамтанд орсон, тэр бүү хэл айж түгшсэн харагдана. Том Жим суудлаасаа босч амьсгаагаа жигдлэв.

-Явах цаг боллоо.

-Би бэлэн гэсэн мөртлөө Картер байрнаасаа хөдөлсөнгүй.

Том Жим эргэж хараад -Хүү минь ямар нэг юм хэлэхийг хүсээ юу?

Хүү минь. Энэ үг Картерт таалагдав. Түүний эцэг таван жилийн өмнө Лидсийн ихэр гүүрний нэгийг пикапаараа мөргөж үхсэн бөгөөд Картер үүнд огт харамсдаггүй. Эцэг нь эхнэр ба хоёр хүүхдээ зоддог байсан. (Картерийн ах одоо усан цэрэгт алба хашдаг) Гэхдээ зодлоо гээд Картер гомдож байсангүй. Ээж нь сөрөг сэтгэл хөдлөлөө мохоохын тулд кофений архи уудаг байсан бөгөөд Картер ч үргэлж ганц хоёр балгачихдаг байв. Тэр эцгийгээ байнга яншдаг ба тэнэгийнх нь төлөө үзэн яддаг байсан. Чөтгөр гэж, хүмүүс Картерийг тэнэг гэж л боддог. Жижгээ ч тэгж боддог байсан. Гэвч тэд алдсан. Харин ноён Ренни ойлгосон. Ноён Ренни гомдоллож яншдаг хүн биш.

Ирээдүйн төлөвлөгөөгөө тодорхойлсон болох нь Картерт гэнэт ойлгогдов.

-Надад нэг юм байгаа. Танд хэрэг болох байх.

-Юу юм бэ?

Том Жим Картерийг хувцас солих өрөө рүү очиж шүүгээгээ нээгээд "Вейдер" гэсэн бичигтэй дугтуйг аван эргэж ирээд түүнд сунгахыг хүлээв. Цаасан дээр хэн нэгний гутлын өсгийний цуст тамга улайна.

Ренни дугтуйг нээв.

-Жим гэх Рэндолфын дуу гарлаа. Тэр анзаарагдалгүй орж ирээд одоо ядарч барьц алдсан амьтан хамгийн сүүлд Стейсигийн сууж байсан хөмөрсөн ширээний дэргэд зогсоно.

-Бид хотыг их бага хэмжээгээр тайвшруулсан гэж бодож байна. Гэхдээ би хэдэн шинэ цагдаа нарыг олж чадахгүй байна. Тэд албаа орхисон бололтой.

-Ийм юм болох л байсан. Гэхдээ түр зуур орхисон. Хэв журам бүрэн сэргэхээр тэд эргэж ирнэ. Тэд Барбара хэзээ ч гэсэн тэднийг амьдаар нь залгихын тулд цусанд дурласан махчдын бүлгээ хотод авчирч мэднэ гэдгийг ухаарах болно.

-Гэхдээ энэ чөтгөр авсан уулзалтын өдрийг...

-Маргааш энэ хотын хүн бүр торго шиг л биеэ авч явах болно. Тэгэхгүй хүмүүсийн учрыг олох хүч хангалттай гэдэгт би итгэлтэй байна.

-Харин хэвлэл мэдээллийг яах вэ?

-Би ажилтай байгааг харж байна уу? Пит чи үүнийг харж байна уу? Бурхан минь. Хагас цагийн дараа захиргааны хурлын танхимд хүрээд ир. Чиний хүссэн бүхнийг хэлэлцэнэ. Харин одоо намайг тайван орхиж үз.

-Уучлаарай. Мэдээж гээд Пит ухрахад хоолой ба хөдөлгөөнд нь гомдол мэдрэгдэв.

-Зогс гэж Ренни гэнэт хэллээ.

Рэндолф зогсов.

-Чи надад хүүгээ алдсаны хувьд эмгэнэл илэрхийлсэнгүй.

-Би... Би их харамсаж байна.

Том Жим Рэндолфыг харцаараа хэмжив.

-Үнэхээр харамсч байна.

Цагдаагийн даргыг явсны дараа Ренни дугтуйнаас цааснуудыг гаргаад түргэн гүйлгэж харангуутаа буцааж хийв. Дараа нь Картер руу тун сониучирхан харж: -Чи яагаад надад шууд өгөөгүй юм бэ? Өөртөө байлгахыг хүссэн юм уу?

Нэгэнт дугтуйг өгсөн хойно зөвхөн үнэнийг хэлэх эрхтэйг Картер ойлгов.

-Тийм. Хэсэг хугацаанд. Юмыг яаж мэдэхэв гээд.

-Юуг мэдэхэв гэж?

Картер мөрөө хавчлаа.

Том Жим энэ сэдвийг өргөжүүлсэнгүй. Тэр өөрөө таагүй байдал учруулж мэдэх хүмүүсийг гутаах материал цуглуулж сурсан. Тиймээс Картерийн үйлдлийн дарааллыг ойлгож байв. Гэхдээ өөр асуултын хариулт түүний сонирхолыг хавьгүй илүү татна.

-Чи яагаад бодлоо өөрчилсөн юм бэ? Картер дахиад л үнэнийг хэлэхээр шийддээ. -Яагаад гэвэл би таны хүн болмоор байна. Босс оо. Том Жим өтгөн хөмсөгөө өргөлөө.

-Түүнээс том уу? гээд Ренни Рэндолфын дөнгөж гарсан хаалга руу толгой сэжив.

-Тэр үү? Тэр хоосон суудал.

-Тийм дээ гээд Том Жим Картерын мөрөн дээр гараа тавьлаа. Энэ үнэн. Явцгаая. Захиргаанд хүрэнгүүтээ цаасыг зууханд шатаана. Хамгийн эхлээд энэ ажлаас эхлэе.

7

Тэд үнэхээр өндөр байлаа. Бас аймаар. Барби гараар гүйсэн цэнэгийн үйлчлэл үгүй болмогц тэднийг олж харав. Мэдээж хайрцагнаас салах хүсэл төрсөн. Гэвч тэр энэ хүслээ дарж хайрцгийг тавиагүй бөгөөд одоо хүмүүсийг хорионд байлгаж байгаа тэдгээр амьтадыг харав. Хэрэв Растигийн санаанаас авч үзвэл хүмүүсийг таашаал авахын тулд хорьж тамлаж байгаа амьтад.

Тэдний царай төрх, хэрэв тэр үнэхээр нүүрийг нь харсан бол, янз бүрийн өнцгөөс бүрдэж байв. Гэхдээ мохоо өнцөг бөгөөд байнга өөрчлөгдөх тул эдгээр амьтад тогтсон хэв дүрсгүй мэт ажээ. Тэд хэдүүлээ болоод хаана байгааг нь тэр хэлж чадахгүй. Эхлээд дөрвүүлээ гэж бодов. Дараа нь найм, эцэст нь хоёр гэж боддоо. Тэд ой гутааж байлаа. Яагаад гэвэл магадгүй хүлээж авч болохооргүй тийм гадны төрхтэй ажээ. Мэдрэхүйн эрхтэнээс ирэх мэдээллийн урсгалыг боловсруулдаг түүний тархины хэсэг нь нүднээс ирсэн дохиог тайлж чадахгүй байв.

Миний нүд тэднийг олж харж чадахгүй байна. Амьдаар нь харж чадахгүй. Дуран авайн тусламжтай ч чадахгүй. Эдгээр амьтад одоо бүр алс холын ямар нэг орчлонд байна.

Гэхдээ тэр үүнийг ян тан мэдэж чадахгүй. Хайрцагны эзэд өмнөд туйлын мөсөн дор өөрийн баазыг байгуулсан юмуу эсвэл өөрийн "Энтерпрайз" оддын хөлгөөрөө сарыг тойрон эргэж байгаа ч юмуу тэр мэдэхгүй. Тэд гэртээ байв... Тэдний гэр ямар байлаа ч гэсэн. Тэд ажиглаж байна. Тэд таашаал авч байна.

Таашаал авахгүй байхын аргагүй. Яагаад гэвэл энэ гичийн хүүхдүүд инээлдэж байв.

Фаллуж дахь спорт танхим ой тойнд сэргэн гарч ирлээ. Халуун байсан. Ямар ч хөргүүр байхгүй. Таазан дор өлгөсөн сэнсний далбангууд л хөлс нэвчсэн зуунга агаарыг залхуутай зүснэ. Тэд хоёр Абдулаас бусад байцаалтанд авчирсан хүмүүсийг бүгдийг нь тавьж явуулсан. Тэр хоёр Абдул хоёр ширхэг гар хийцийн тэсрэх төхөөрөмж зургаан америкийн амийг авч бас нэг мэргэн буудагч бүх нийтийн хайрыг татсан Кентуккигээс ирсэн Кастейрсыг алсны маргааш өдөр цэргийнхний хараанд өртсөн юм. Тиймээс тэд Абдулуудыг спорт танхимаар элдэж хувцасыг нь урж байсан. Барби хаалганы цаана гармаар байна гэж хэлэхийг хүссэн ч гараагүй. Үүнд оролцохгүй гэж хэлэхийг хүссэн ч оролцсон. Тэд бүгд ямар нэг чичиргээнд автсан. Тэр нэг абдулын баас нялагдсан ясархаг өгзөг дээр чанга гишгэхэд цэрэг гутлын улаан мөр үлдсэнийг санаж байв. Тэгэхэд абдулуудыг аль хэдийн чармай нүцгэлсэн байсан. Эмерсон нөгөө абдулын савлах төмсөг рүү хүчтэй өшиглөнгөө "энэ Кастейрийн төлөөс, муу хар элсний негр" хэмээн хашгирч байсныг санав. Тун удалгүй аль нэгэн абдулын ээж шарилынх нь дэргэд эвхдэг сандал дээр сууж байхад дарцаг өгөх болно. Дэлхий шиг буурал түүх. Тэгээд Барби энд ахлагч нь тэр өөрөө болохыг санах тэр мөчид ахлагч Хэкермейер нэг залууг нь хананд чирч аваачсан. Хоригдлын хувцаснаас зөвхөн тайлагдаж хөвөрсөн толгойн боолт л үлджээ. Боолтыг куфи гэдэг. Ахлагч түүний толгойд бугаа наав. Түр зуур нам гүм болоход хэн ч энэ нам гүмийг "үгүй" гэх юмуу "битгий ийм юм хий" гэсэн үгээр дүүргээгүй. Тиймээс ахлагч гохоо дарж цус ханыг будсан. 3 мянган жил юмуу түүнээс ч их хугацаанд цус хана будаж ирсэн шиг. Ингэснээр абдулын бүх юм дууссан. Ля-ля-ля. Онгон бүсгүйчүүдийн хальсыг цоолохгүй чөлөөт цагаараа надад захидал бичихээ битгий мартаарай.

Барби хайрцагнаас гараа авч босох гэж оролдсон ч хөл нь түүнээс урвав. Расти хажуугаас нь шүүрч бусдын тусламжгүй зогсч чадахаар болох хүртэл нь түшлээ.

-Бурхан минь гэж Барби хэлэв.

-Чи тэднийг харсан тийм үү?

-Тийм.

-Тэд хүүхдүүд үү? Чи юу гэж бодож байна? -Магадгүй. Тийм байх гэхээс өөр Барбид бэлэн хариулт байсангүй.

Тэд урд нь үлдэгсэд зогсох фермерийн байшинд буцаж ирлээ.

-Бүх юм зүгээр үү? гэж Норри асуув.

-Тийм ээ гээд Барби толгой дохилоо. Тэр хүүхдүүдтэй ярих ёстойгоо санана. Жеккитэй, бас Раститай. Гэвч одоо биш. Эхлээд өөрийгөө гартаа авах хэрэгтэй.

-Чи итгэлтэй байна уу?

-Тийм ээ.

-Ромми танай дэлгүүрт тугалган тууз дахиад бий юу? гэж Расти асуув.

-Байгаа. Би ачих буулгах тавцан дээр хуйлаастай тууз үлдээсэн.

-Сайн байна гээд Расти Жулиягийн гар утсыг гуйлаа. Линда цагдаагийн газарт байцаагдахаар сууж байгаа биш гэртээ байгаа гэж тэр найдна. Тэр зөвхөн найдаж л чадна.

8

Раститай ярьсан яриа тун богино байсан бөгөөд ердөө 30 секунд болов. Гэвч энэ аймшигт ггүрэв гариг 180 хэм эргэж, харанхуй шөнөөс гэгээн өдөр болж хувирахад Линдагийн хувьд хангалттай болжээ. Тэр гал тогооны ширээний ард сууж нүүрээ гараар таглаад уйллаа. Учир нь дээр хоёр биш дөрвөн хүүхэд унтаж байгаа тул чимээгүй уйлав. Тэр эгч дүү хоёрыг гэртээ авчирсан. Одоо тэднийд хоёр Ж-гээс гадна хоёр Э байна.

Элис ба Эйден нар аймаар сэтгэл донсолжээ. Тэгэхээс өөр яах билээ бурхан минь. Гэвч Жанни Жүди хоёр тайтгарахад нь тусалсан. Бас унтлагын хүүдий ч тусалсан. Тэр охидын шаардлагаар өрөөнийх нь шалан дээр унтлагын хүүдийнүүд дэвссэн бөгөөд одоо дөрвүүлээ тэнд унтаж байгаа. Жүди Эйден хоёр тэврэлджээ.

Тэр бараг тайтгарах шахаж байтал гал тогооны хаалга тогшив. Хамгийн түрүүнд цагдаа нар гэх бодол Линдад төрлөө. Уг нь хотын төвд болсон цус асгаралт ба үймээний дараа тэднийг тийм түргэн ирнэ гэж хүлээх хэрэггүй мэт. Гэвч эзэрхэг биш аяархан цохилт.

Тэр замдаа нүүрээ арчихын тулд гал тогооны алчуур аваад хаалга руу очив. Эхэндээ үс засалтаа өөрчилсөн болохоор нь шөнийн зочныг таньсангүй. Маршалл үсээ морины сүүл шиг ардаа боогоогүй учир мөрөн дээр нь унжиж нүүрийг нь эмжсэн тул тэр яг одоо урт бөгөөд хүнд ажлын өдрийн дараа аймшигтай мэдээ сонссон хөгшин угаагч мэт харагдаж байв.

Линда үүдээ нээлээ. Маршалл үүдэнд хоромхон зуур зогтусав.

-Каро үхчихсэн юмуу? Үнэхээр үхсэн үү? гэж аяархан сөөнгөтөн асуув. Яг л Вудстокийн наадам дээр хоолойгоо тасалчихаад дахин сэргээгүй юм шиг гэж Линда бодлоо.

-Тийм гэж айж байна. Би их харамсч байна ноён Маршалл гэж Линда хүүхдүүдээс болоод мөн л шивнэн хариуллаа.

Тэр дахиад хэдэн хором хөдөлгөөнгүй зогсов. Дараа нь нүүрний хоёр талаар унжсан буурал үснээсээ зуураад хоёр тийш найган ганхав. Линда урьд нь Мая ба Декабр нарын романтик харьцаанд итгэдэггүй байжээ. Тэр их хуучинсаг хүн байсан. Тэр Маршалл ба Каро нарын харьцаанд 6 сар юмуу дээд тал нь хоёр жил өгөх байсан. Тэдний бэлиг эрхтэн утаа уугиулахаа болиход ийм хугацаа шаардагдана. Гэвч энэ орой энэ эрийн хайр түүнд ямар ч эргэлзээ төрүүлсэнгүй. Түүний алдсандаа харуусах нь мөн адил.

Тэдний мэдрэмж ямар байлаа ч гэсэн хүүхдүүд байсан нь энэ мэдрэмжийг улам хурц болгожээ гэж Линда бодов. Бүрхүүл ч бас адил. Бүрхүүл доорх амьдрал бүхнийг хурцатгаж байв. Бүрхүүл дор хэдэн өдөр биш хэдэн жил амьдарсан юм шиг Линдад санагдах болсон. Гадаад ертөнц сэрэхэд арилдаг зүүд шиг хайлж байв. Тэр шөнийн зочноо урьлаа.

-Ороорой. Гэхдээ аяар. Ноён Маршалл. Хүүхдүүд унтаж байгаа. Миний ба таны хүүхдүүд.

Линда түүнийг нарны цайгаар дайлав. (энэ нь наранд тавьсан цай юмуу өвсний ханд бөгөөд голдуу мөстэй өгдөг). Хүйтэн биш тэр бүү хэл бүлээн цай байв. Гэвч тэр өөр юу ч санал болгож чадсангүй. Тэр хагас аягыг уугаад ширээн дээр тавьлаа. Дараа нь аль хэдийн унтах цаг нь болсон хүүхэд шиг нударгаар нүдээ нухав. Линда түүнийг ойлгоно. Тэр биеэ барихыг хичээж байгаа. Тиймээс түүнд саад бололгүй чимээгүй суув.

Маршалл гүнзгий агаар сороод эргэн гаргаж гараа хуучин цэнхэр цамцныхаа энгэрийн хармаанд дүрлээ. Тэндээс сурны тасархай гаргаж ирээд үсээ ардаа боов. Энэ сайн тэмдэг гэж Линда тооцлоо.

-Юу болсныг бас яаж болсныг надад яриад өгөөч? гэж тэр гуйв.

-Би бүгдийг нь хараагүй. Хэн нэгэн миний толгой руу өшиглөсөн юм. Таны Карог голын гудамлагаас татаж авах гэж байтал.

-Гэвч цагдаа нарын нэг нь түүнийг буудсан тийм үү? Энэ чөтгөрийн буудах дуртай цагдаа нараар дүүрсэн хотын нэг цагдаа.

-Тийм ээ гээд Линда ширээн дээгүүр гараа сунгаж түүний гарыг барьлаа. -Хэн нэг нь зэвсэг гэж хашгирсан. Гэхдээ тэнд зэвсэг байсан. Андреагийн гар буу. Тэр хурал дээр авчирсан байсан. Магадгүй Ренниг алахаар сэдсэн байх.

-Тэгээд энэ Каротай учирсан явдлыг зөвтгөнө гэж та бодоод байна уу?

-Бурхан минь үгүй. Харин Андреаг ил цагаан алсан.

-Каро хүүхдүүдийг хамгаалах гэж оролдоод алагдсан тийм

үү?

-Тийм.

-Гэтэл тэд өөрийнх нь хүүхэд ч биш. Линда дуугүй сууна.

-Гэхдээ тэд түүний болоод миний хүүхдүүд болсон. Үүнийг нөхцөл байдлаас болоод гэх юмуу Бүрхүүлийн шалтгаанаар гээд дуртайгаараа нэрлэ. Гэвч тэд бидний хүүхэд болсон. Тэгээгүй бол хэзээ ч болохгүй байсан. Бүрхүүл алга болтол. Хэрэв ер нь хэзээ нэгэн цагт алга болох юм бол тэр хүртэл миний хүүхдүүд байх болно.

Линда түргэн бодно. Энэ эрд итгэж болох уу? Тийм гэж бодлоо. Расти түүнд багтай итгэж байсан. Түүнийг анагаах ухаантай харьцалгүй удсан хүн гэхэд онц мэргэжилтэн гэж ярьж байсан. Тэгээд ч Маршалл Бүрхүүл дор захирч байгаа хүмүүсийг үзэн яддаг. Түүнд ингэх шалтгаан бий.

-Хатагтай Эверетт.

-Линда гээрэй.

-Линда би танай буйдан дээр унтаж болох уу? Хүүхдүүд шөнө гэнэт сэрэх юм бол би дэргэд нь баймаар байна. Би тэднийг сэрэхгүй гэж найдаж байна. Хэрэв тэд сэрэхгүй бол өглөө доошоо бууж ирээд намайг олж үзэхийг би хүсч байна.

-Тэг л дээ. Өглөө бид хамтдаа цай ууя. Овьёосоор дайлна. Сүү гашлаагүй байгаа. Гэвч удахгүй гашлах болно.

-Муугүй сонсогдож байна. Хүүхдүүд цайгаа уухаар бид явцгаана. Хэрэв та хотын эх оронч бол намайг өршөөгөөрэй. Гэвч би Честерс-Милл гэхээр бөөлжис цутгаж байна. Би энэ хотыг одоохондоо бүрмөсөн орхиж чадахгүй. Гэвч аль болох хол явмаар байна. Эмнэлэгт бие нь муу байсан ганц хүн Реннигийн хүү байлаа. Гэвч өдөр юу ч хэлэлгүй яваад өгсөн. Тэр эргэж ирнэ. Түүний толгойд ургаж байгаа новш түүнийг эргүүлж авчирна. Гэвч одоо...

-Тэр үхсэн.

Маршалл онц гайхсангүй. -Уналт өгсөн гэж би бодож байна.

-Үгүй. Түүнийг шоронд буудчихсан.

-Харамсаж байна гэж хэлмээр байгаа ч чадахгүй нь.

-Би ч бас гээд Линда толгой дохив. Жижгээ яаж шорон руу ороод тэнд юу хийснийг Линда мэдэхгүй. Гэвч гашуудсан эцэг нь ямар байдлаар гялалзуулахыг тэр төсөөлж байв.

-Би хүүхдүүдийг аваад энэ бүхэн болох үед Каро бид хоёрын байсан цөөрөм рүү явлаа. Тэнд чимээ аниргүй. Тэгээд ч хүнсний нөөц хэсэг хугацаанд хангалттай гэдэгт би итгэж байна. Магадгүй арай урт хугацаагаар. Цахилгаан үүсгүүртэй байшин олох ч юм билүү хэн мэддээ. Нийгмийн амьдралын тухайд гэснээ түүний нүүр ярвайж: -Одоо болсон. Хүүхдүүд ч хангалттай.

-Магадгүй би танд арай илүү дээр газар санал болгож чадна.

-Үнэн үү? гээд Линда хариу хэлээгүй тул гараа ширээн дээгүүр дамнаж түүний гарыг атгав. Та хэн нэгэнд итгэх хэрэгтэй. Надад итгэсэн нь дээр.

Линда түүнд бүхнийг ярьлаа. Түүний дотор Берпигийн их дэлгүүр рүү очиж ачих тавцангаас тугалган тууз авсны дараа Блэк-Ридж рүү явах тухайгаа. Тэд бараг шөнө дунд болтол ярилцав.

Маккойн байшингийн хойд хэсэг нь хүн амьдрах боломжгүй байв. Өнгөрсөн өвөл дэндүү их цас орсны улмаас зочдын өрөөний дээвэр нь цөмөрчээ. Гэвч байшингийн баруун талын төмөр замын вагон шиг урт гал тогоо нь хохирол амссангүй. Честерс-Миллийн дүрвэгсэд

тэнд цуглав. Эхлээд Барби Жо, Норри, Бенни нараас тэд юу харсан болоод гэрэлтдэг бүсийн хил дээр ухаан алдахдаа юу үзсэнийг сайтар асуув.

Жо шатаж байгаа хулуунуудыг саналаа. Норри бүх юм харанхуй болж нар алга болсныг ярив. Бенни эхлээд юу ч санахгүй байна гэснээ дараа нь гэнэт дуу алдаж:

-Хашгираан, би орилж хашгирахыг сонссон. Аймшигтай орилоон.

Бүгд хэсэг хугацаанд дуугаа хураав. Эхлээд Эрни ярьлаа.

-Хурандаа Барбара. Хэрэв бид ямар нэг юм хайх гэж байгаа бол шатаж байгаа хулуу тус болохгүй. Энэ хотын амбаар бүрийн наран талд хулуу овоолгоостой. Ургац сайтай жил байсан.

-Расти танай охид юу ярьсан бэ?

-Бас нэг иймэрхүү юм гээд Расти санасан бүхнээ ярив.

-Хэллоуиныг зогсоо. Том хулууг зогсоо гэж Ромми бодлогширон давтана.

-Хүмүүс ээ, энд ямар нэг ерөнхий зүйл байна гэж Бенни дуу алдав.

-Зараанд ч ойлгомжтой, Шерлок минь гэж Роуз хэлэхэд бүгд инээлдлээ.

Барби бага эмч рүү эргээд: -Расти одоо чиний ээлж. Өгсч яваад тасрахад юу болсон бэ?

-Би бүрэн тасраагүй. Энэ бүхнийг стрессээр тайлбарлаж ч болно. Бүлгээрээ догдлоно гэж байдаг. Түүний дотор бүлгээрээ хий юм үзэх нь бий. Стрессийн байдалд байгаа хүмүүсийн хувьд ердийн үзэгдэл.

-Баярлалаа доктор Фрейд. Харин одоо юм үзсэнээ яриач гээд Барби толгой дохив.

Расти эх оронч туузаар чимсэн бортого малгай хүртэл ярьж амжаад байтал Лисса Жеймисон дуу алдлаа.

-Энэ чинь номын сангийн дэргэдэх зүлгэн дээр байсан хүүхэлдэй байна. Дээр нь миний хуучин цамц байсан. Уоррен Зевоны ишлэлтэй манай... (энэ нь америкийн нэрт рок дуучин, хөгжимчин, дуу зохиогч)

-""Манай төрөлх Алабама"-Сүйрсэн хамтлагийн энэ дууг тогло" гэж Расти ишлэл хэлэв. Гарны оронд цэцэрлэгийн шүүр байсан. Дараа нь тэр шатсан. Тэгээд гэнэт алга болчихсон. Толгой эргэхийн хамтаар гэснээ тэр эргэн тойрноо харахад бүгд түүн рүү бүлтийн ширтэж байв.

-Тайвширцгаа. Магадгүй би хүүхэлдэйг энэ бүхэн болохоос өмнө харсан байх. Тэгээд Расти Барби руу хуруугаа чиглүүлж: -Дахиад намайг доктор Фрейд гэж нэрлэвэл би чамайг болгоод өгнө гэв.

-Чи түүнийг урьд нь харсан уу? Охидоо сургуулиас авах юмуу эсвэл хаа нэг тийшээ явж байхдаа? Яагаад гэвэл номын сан, хүүхдийн талбайн гудамжны нөгөө талд байдаг гэж Пайпер асуулаа.

-Би санахгүй байна гэж Расти хэлэхдээ сарын эхнээс хойш охидоо нэг ч удаа сургуулиас аваагүй гэдгээ хэлсэнгүй. Тэгээд ч хэн нэгэн хэллоуинд ийм эртнээс бэлтгэж эхэлсэн гэхэд тэр эргэлзэж байв.

-Харин одоо Жекки чи ярь гэж Барби түүн рүү эргэлээ.

Бүсгүй уруулаа долоов.

-Энэ үнэхээр тийм чухал юм уу?

-Тийм гэж би бодож байна.

-Шатаж байгаа хүмүүс. Тэгээд утаа. Бас утаа хажуу тийш хазайлвал дундаас нь цойлон гарах гал. Бүх дэлхий шатаж байгаа мэт санагдсан.

-Тийм ээ, хүмүүс хашгирч байсан. Яагаад гэвэл шатаж байсан. Би одоо саналаа гээд Бенни Элвагийн мөрөнд нүүрээ наав. Бүсгүй түүний мөрөөр тэвэрлээ.

-Хэллоуин хүртэл дахиад тав хоног байна гэж Клер сануулав.

-Барби толгой сэгсрээд -Би тэгж бодохгүй байна гэлээ.

11

Хотын захиргааны зөвлөгөөний тэнхимийн буланд байх пийшинг тоос даржээ. Түүнийг ашиглаагүй удсан ч ажиллах нь ажиллана. Том Жим яндангийн хаалтыг сугалаад (зэвэрсэн тул чахрав) дараа нь Герцог Перкинсийн үлдээсэн хэвлэмэл баримтыг дугтуйнаас гаргалаа. Хуудас хуудсаар нь эргүүлж харангаа хөмсөг зангидах бөгөөд дараа нь хуудаснуудыг зуух руу чулуудав. Дупуйг үлдээлээ.

Картер Стюарттай утсаар ярих бөгөөд Том Жим хүүгээ яаж оршуулахыг хүсч байгаа талаар тайлбарлаж энэ ажилд цаг алдалгүй орохыг сануулав. "Сайн хүү. Хол явна. Гэхдээ хэрэв талхан дээрх цөцгийн тос аль талдаа байдгийг санаж явах аваас" гэж Том Жим бодлоо. Үүнийг мартсан хүмүүс тооцоогоо төлөхөд хүрдэг. Андреа үүнийг энэ орой мэдэж авсан.

Зуухны хажуугийн тавиур дээр хайрцагтай шүдэнз байв. Том Жим нэгийг зураад галыг Брендагийн эд мөрийн баримтад аваачлаа. Хэрхэн шатаж байгааг нь харахаар хаалгыг онгорхой орхив. Энэ үзэгдэл таашаал төрүүлнэ.

Картер хүрч ирлээ.

-Стюарт хүлээж байна. Таныг эргээд залгана гэж хэлэх үү? -Утсаа өг гээд Том Жим гараа сунгав. Картер дугтуй руу заагаад: -Үүнийг бас шатаах уу?

-Үгүй. Чи дотор нь бичгийн цэвэр цааснууд хийгээрэй. Картер хоромхон зуур учрыг ойлголоо.

-Тэр эмэгтэй удаан хугацаагаар хар тамхи хэрэглэсэн бол хий юм харах өвчин туссан тийм үү?

-Хөөрхий эмэгтэй гээд Том Жим толгой дохив. Хүү минь атомын хоргодох байр руу яв. Тийшээ гээд зуухны хажууд байгаа шар дэвсгэр дээр хар гурвалжингууд зурсан хуучин төмөр хүснэгт өлгөөстэй нүдэнд үл анзаарагдам хаалгыг заалаа. -Тэнд хоёр өрөө байгаа. Хоёр дахь өрөөний төгсгөлд жижигхэн цахилгаан үүсгүүр бий.

-Ойлголоо.

-Цахилгаан үүсгүүрийн урд нүх байгаа. Нүдэнд анзаарагдахгүй. Гэвч чи олно. Тагийг нээгээд дотогшоо шагай. Тэнд шингэрүүлсэн хийтэй савнууд байгаа. Найм юмуу арав. Ямар ч гэсэн өнгөрсөн удаад би тийш шагайхад тийм байсан. Тоолоод хэд үлдсэнийг надад хэлээрэй гэснээ тэр Картер "ях гэж?" гэж асуухыг хүлээсэн ч тэр асуусангүй. Тушаалыг гүйцэтгэхээр шууд эргэв. Том Жимийн тушаал. -Хүү минь чамд зөвлөгөө өгөх гэсэн юм. Эцсийн цэгийг хагтах нь амжилтыгн нууц. Мэдээж бурхан чиний талд байна.

Картерьг явмагц Том Жим утсаа чихэндээ наав. Хэрэв Стюарт холбоог тасалсан бол тэр харамсах болно.

Гэвч Стюарт таслаагүй байна.

-Жим чамд гарз тохиосонд эмгэнэж байна гээд тэр яриагаа зөв эхлэж оноо авлаа.

-Бид бүх юмагд санаа тавих болно. Би "Үүрдийн амгалан" авсны тухай бодож байна. Царс мод, мянган жилийг даана.

Өөр хүмүүсийн тархийг эргүүл гэж Том Жим бодсон ч дуугарсангүй.

-Цогцосныг тухайд бид чадах бүхнээ хийнэ. Тэр яг одоо сэрээд нүдээ нээж инээх гэж байгаа юм шиг харагдах болно.

-Баярлалаа найз минь гэж Том Жим хариулахдаа дотроо чамаас яг үүнийг шаардсан юм гэж бодов.

-Харин одоо маргаашийн аялалын тухайд хэмээн Стюарт сэдвийг өөрчиллөө.

-Би яг энэ талаар чам руу залгах гэж байлаа. Чи мэдээж болох эсэхийг тааж байгаа. Тийм ээ болно.

-Гэвч ийм юм болсны дараа...

-Юу ч болоогүй. Үүнийх нь төлөө бид бурханы сайхан сэтгэлд талархая. Стюарт би чамаас аминь гэж сонсохгүй байх чинь.

-Аминь гэж дуулгавартай давтав.

-Гар буутай, сэтгэцийн тогтворгүй байдлаар өдөөгдсөн эмэгтэйн солиорлоос цаашгүй. Тэр одоо есүс ба гэгээнүүдтэй хооллож байгаа. Үүнд би эргэлзэхгүй байна. Яагаад гэвэл болсон явдалд түүний буруу байхгүй.

-Гэвч Жим...

-Намайг ярьж байхад битгий таслаад бай. Энэ бол хар тамхи. Чөтгөрийн хар тамхи түүний тархийг идчихжээ. Хүмүүс жаахан тайвшраад үүнийг ойлгоно. Честерс-Милл хотод ухаалаг, зоригтой хүмүүс амьдардаг нь аз. Би тэднийг ямар ч сорилтыг давна гэдэгт итгэж байна. Үргэлж итгэдэг байсан. Итгэх ч болно. Түүнээс гадна одоо тэд хамаатан садантайгаа уулзахыг л бодож байгаа. Манай ажиллагаа төлөвлөсөн ёсоор үд дунд болно. Чи, Ферн, Рожер, Мел нар. Дентон удирдана. Хэрэв шаардлагатай гэж үзвэл тэр 4-5 хүн авна.

-Түүнээс дээр хүн чамд алга уу? -Дентон дийлнэ.

-Картер ямар вэ? Чиний дэргэд санжиганадаг залуу.

-Стюарт чамайг амаа нээх бүрт гэдэсний чинь хагас нь асгараад байна. Тиймээс дуугүй сонс. Бид цаашдаа галуунд "кис" гэж хэлж ч чадахгүй эм зүйч болоод ясархаг хар тамхичин хоёрын тухай ярьж байна. Би аминь гэх үгийг сонсох юм.

-Тийм ээ, аминь.

-Хотын ачааны тэргүүдийг ав. Энэ яриаг дуусаад Дентоныг ол. Тэр ойрхон байгаа. Түүнд юу ямар учиртайг тайлбарла. Зэвсэглэх ёстойг хэлээрэй. Цагдаагийн газрын зооринд хэрэгтэй бүх тоног хэрэгсэл бий. Аюулгүй байдлын яаманд баярлалаа. Тэнд хуягт хантааз, дуулга өөр юу байгааг бүү мэд. Тэднийг бүтдийг нь ашиглаж болно. Дараа нь тийшээ очоод тэр залуусыг ал. Бидэнд хий хэрэгтэй.

-Лабораторийг яах вэ? Түүнийг шатаах хэрэгтэй гэж би бодоод байна...

-Чи солиоров уу? гэх үед зөвлөгөөний зааланд буцаж ирсэн Картер Том Жим рүү гайхан харав. -Тэнд нөөцөлсөн бүх химийн бодистой юу? Найз минь юу ярихаа бод. Эс тэгвэл чамайг би Рожер шиг усан тэнэг гэж сэжиглэхэд хүрэх нь.

-За гэх Стюартын дуунд уурласан нь мэдрэгдэнэ. Гэвч Том Жим тэр бүхнийг хийнэ гэдэгт эргэлзсэнгүй. Тэгээд ч Стюартын толгойг илэх цаг үлдсэнгүй. Рэндолф одоохон ирнэ.

Хэзээ ч дуусахгүй тэнэгүүдийн жагсаал гэж Том Жим бодлоо.

-Харин одоо би чиний хэрхэн бурхныг магтаж байгааг сонсож байна гэж тэр хэлэв. Дотроо Стюартын нуруун дээр суугаад түүний махбодийг шавартай хугтаж байгаагаар харж марсайтал инээв.

-Бурхныг мапья гэж Стюарт бувтналаа.

-Аминь гээд Том Жим утсаа таслав.

Удалгүй хурлын танхимд Рэндолф орж ирлээ. Тэр ядарсан мөртлөө сэтгэл ханамжтай харагдана.

-Бид Додсон, Роуклифф, Ричардсон гээд хэд хэдэн шинэ цагдаагаа алдсан. Тэд биднийг орхиж явсан боловч олонхи нь үлджээ. Бас шинэ хүмүүс ч ирлээ. Жо Боксер... Тагжгар Норман...

Том Жим түүнийг хангалттай тэвчээртэйгээр, гэхдээ хагасыг нь чихний хажуугаар өнгөрөөн сонсов. Тэгээд Рэндолфыг арай гэж ярьж дуусахад гялалзуулсан ширээн дээгүүр "Вейдер" гэсэн дугтуйтай дупуйг түүн рүү түлхэв.

-Энэ хөөрхий Андреагийн савчаад байсан зүйл. Хар даа.

Рэндолф жаахан эргэлзсэнээ дараа нь дугтуйг нээж доторхийг нь гаргалаа.

-Үгүй энэ чинь цэвэрхэн цааснууд байна.

-Чиний түмэн зөв. Маргааш өглөө чи цагдаа нараа цагдаагийн газарт яг долоон цаг цуглуулаарай. Чи Жим ахдаа итгэж болно. Яагаад гэвэл шоргоолжнууд өглөө эрт үүрнээсээ гардаг юм. Тиймээс хөөрхий хүүхэн юу ч сэтгэдэггүй байсан гэдэг цагдаа нар итгэх тал дээр анхаар. Яг өнөөх ерөнхийлөгч Маккинлиг буудсан анархист шиг.

-Энэ чинь уул биш гэж үү? хэмээн Рэндолф гайхав.

Том Жим түүний асуултыг бодох гэж хэдэн хором зарлаа. Хатапай Рэндолфын бяцхан хүү ямар модноос унасан юм болоо? Дараа нь үргэлжлүүлээ. Энэ шөнө найман цаг унтана гэж тэр тооцож чадахгүй байсан ч таван цаг бол чангаана гэж бодов. Учир нь түүнд нойр хэрэпэй байлаа. Түүний хөөрхий хуучирсан зүрхэнд нойр хэрэпэй.

-Эргүүлийн бүх машиныг хөдөлгөөрэй. Машин бүрт хоёр цагдаа суулга. "Мейс"-тэй баллонууд болоод цахилгаан бороохой авцгааг. Гэхдээ хэн нэг нь сурвалжлагч нар, дуран болоод шалчгар гадаад ертөнцийн өмнө буу сугалах юм бол... би өөрөө түүний гэдсийг сугалж гаргана. -Ойлголоо ноёнтон.

-Замын хоёр хажуугаар, цугласан хүмүүсийн захаар яваг. Дуут дохио огт хэрэггүй. Гэхдээ анивчуураа асаана.

-Яг ёслолын жагсаал дээрх шиг гэж Рэндолф толгой дохив.

-Тиймээ ёслолын жагсаал дээр байгаа шиг. Машинаар ирсэн хүмүүсийг машинаа тавиад цаашаа явган яв гээрэй. Чанга яригч ашигла. Бүрхүүлийн дэргэд надад сайн мөртлөө ядарсан хүмүүс хэрэгтэй. Ядарсан хүмүүс томоотой байдаг.

-Зугтсан гэмт хэрэгтнүүдийг эрж хайхад хэсэг цагдаа хэрэгтэй гэж бодохгүй байна уу? гэснээ

Том Жимийн нүд гялалзахыг хараад: -Зүгээр л асууж байна. Зүгээр л асууж байна гэлээ.

-За яахав. Чи хариулт авах гавьяатай. Чи чинь эцсийн эцэст цагдаагийн дарга шүү дээ. Тийм үү Картер?

-Тийм гэж товч, баталсан хариу өглөө.

-Хариулт нь "үгүй". Рэндолф даргаа яагаад гэвэл...одоо анхааралтай сонс.тэд зугтаж чадахгүй. Честерс-Миллийн эргэн тойронд Бүрхүүл байгаа. Тэгэхээр тэд яасан ч...ямар ч тохиолдолд.. зугтаж чадахгүй. Одоо чи миний санааг ойлгов уу? гээд Рэндолфын хацар хэрхэн улайхыг хараад: -Хариугаа бодохыг зөвлөө. Би бол бодох байсан.

-Би ойлгож байна.

-Тэгвэл өөр зүйлийг ч ойлго. Дейл Барбара өөрийн хамтрагч Эвереттэй эрх чөлөөтэй байгаа цагт хүмүүс хууль сахиулагчдаас хамгаалалт гуйн өөрсдөө хандах болно. Хэдийгээр бидэнд өөр ажил хоолой татаж байгаа ч бид тэдний найдварыг хөсөрдүүлэхгүй тийм үү?

Рэндолф арай гэж ойлгов. Тэр Маккинли гэдэг нь зөвхөн уулын нэр биш бөгөөд АНУ-д ийм нэртэй ерөнхийлөгч байсныг мэдэхгүй байж болох ч, харин бутанд суусан Барби нь хориотой Барбигаас хавьгүй дээр болохыг ойлгов.

-Тийм ээ гээд тэр толгой дохив. -Би хөсөрдүүлэхгүй. Яг зөв. Хэвлэлийн бага хуралыг яах билээ? Хэрэв чи тэнд ирмээргүй байгаа бол ядахдаа томилох...

-Үгүй, хүсэхгүй. Би үйл явдлын өрнөлийг энд, эрхийнхээ дагуу эзэлж байгаа байр сууринаасаа ажиглах болно. Хэвлэлийн бага хурлын тухайд тэд түүнийгээ ажилгүй алмайнууд барилгын талбайн хашааны дэргэд цугладаг шиг хотын өмнөд хил дээр овоорох мянга мянган хүнтэй хийж болно. Тэгээд сэтгүүлчид сонссон дэмий үгсээ тайлж ойлгож чадах юм бол их азтай хэрэг.

-Зарим нэг оршин суугч таны тухай эвгүй үг хэл ярьж мэдэх юм.

-Үүний тулд л Бурхан бидэнд хүчтэй мөр хайрласан юм шүү дээ найз минь. Түүнээс гадна нүх бүр рүү шагайдаг энэ муу шалчгар Кокс өөр юу хийж чадах юм бэ? Энд ирээд биднийг хаалганы цаана гаргаж тавих юм уу?

Рэндолф сэтгэл ханамжтай инээснээ үүд рүү чиглээд гэнэт зогслоо.

-Тэнд олон хүн удаан хугацаагаар байх болно. Армийнхан нүүддийн жорлон авчирсан байна. Бид өөрийнхөө талаас тавих хэрэгтэй болов уу? Хотын захиргааны залгаа барилгад хэд хэд бий гэж бодож байна. Гол нь замын багийнханд зориулсан. Эл Тиммонс магадгүй...

Том Жим галзуу хүн харж байгаа юм шиг түүн рүү харлаа.

-Хэрэв шийдвэрийг би гаргах байсан бол манай хотынхон маргааш еврей нар Египетийг орхисон шиг хотоо орхих биш харин гэртээ суух байсан юм гээд тэр жүжиглэн түр

зогсосхийв. Тэгээд: -Хэрэв тэдний хэн нэг нь тэсэхээ болих юм бол ойд хэрэгцээгээ хангаг.

13

Рэндолфыг явсаны дараа Картер асуув. -Хэрэв би таны бөгсийг долоож байгаа биш гэдгээ амлах юм бол хэдэн үг хэлэхийг зөвшөөрөх үү? -Мэдээж

-Ноён Ренни таны хэрхэн ажиллаж байгаа надад таалагддаг.

Том Жим бүх царайгаа гэрэлтүүлсэн, нар мэт малтийсан, дарвайсан инээдээр инээмсэглэв.

-За яахав, хүү минь чамд боломж байна. Хэрэв чи урьд нь хүн бүхнээс суралцаж байсан бол одоо шилдэгээс суралцах болно.

-Би үүнд найдаж байгаа.

-Харин одоо чи намайг гэрт хүргэхийг би хүсэж байна. Маргааш чамайг яг найман цагт хүлээх болно. Бид энд ирээд Си-эн-эн-ээр шоу үзэх болно. Гэвч эхлээд хотын талбайн дэргэд толгойн орой дээр суугаад байддыг ажиглана. Үнэнийг хэлэхэд гунигтай байна. Моисейгүй еврей нар.

-Үүргүй шоргоолжнууд. Үүргүй зөгийнүүд гэж Картер нэмлээ.

-Чи намайг авахаар ирэхээсээ өмнө хотын зарим нэг хүн рүү шагайх хэрэгтэй. Эсвэл оролдоод үз. Чи тэднийг олохгүй гэж би өөртөө мөрий тавьсан. Яагаад гэвэл тэд оргосон.

-Хэн?

-Роуз Твитчел ба бага эмчийн эхнэр Линда Эверетт. -Би түүний хэн болохыг мэднэ.

-Шамуэйг бас шалга. Тэр эмэгтэй гэлэнмаа Либбигийнд хүмүүжилгүй нохойн хамт хоргодож байгаа гэж би сонссон. Хэрэв хэн нэгнийг нь олох юм бол зугтсан хүмүүс хаана байгааг асуугаарай.

-Хатуугаар уу, зөөлнөөр үү?

-Дундуур нь. Би Эверетт ба Барби нарыг түргэн баривчлахыг хүсэхгүй байна. Гэхдээ тэдний хаана байгаа тухай мэдээлэл илүүдэхгүй.

Захиргаанаас гарч ирээд Жим өмхий агаар цээж дүүрэн сорсоноо дараа нь ханамжтай гаргав. Тааламжтай байдлыг Картер ч мэдэрлээ. Долоо хоногийн өмнө тэр зэвний үртэс нүдэнд орохоос сэргийлэн хамгаалалтын шил зүүж байгаад бууныхаа дуу намсгагчийг сольсон юм. Өнөөдөр чухал байр суурь эзэлж багагүй нөлөөтэй болоод байна. Бага зэрэг муудсан агаар сайн тал руу хөвөрсөн энэ бүх өөрчлөлтөнд тийм ч өндөр төлбөр биш.

-Чамд асуулт тавимаар байна. Хүсэхгүй бол хариулахгүй байж болно? гэж Том Жим түүн рүү хандав.

Картер түүн рүү дуугүй харлаа.

-Тэр Буши...ямар байсан бэ? Сайхан уу?

Картер жаахан эргэлзэж байснаа хариулав.

-Эхэндээ жаахан хуурай байсан. Дараа нь норж ирээд бүх юм эвтэйхэн болсон.

Том Жим инээлээ. Түүний инээд автомат тоглоомын тосгуур дээр унаж ирэх зоосны хангинаан шиг ямар нэг төмөр дуугаар хадав.

14

Шөнө дунд ягаан сар Таркерс-Миллийн тэнгэрийн хаяа руу бууж, үүр цайтал тэндээ байх ба бүр алга болохынхоо өмнө хий үзэгдэл болон хувирна.

Жулия Маккойн эдлэн газар Блэк-Риджийн налуугаар аажим доошилж эхлэх тэр хэсэгт, алимны цэцэрлэгээр явж байлаа. Тэгээд нэг модонд наалдсан хар сүүдрийг хараад гайхсангүй. Түүний баруун талд хачин тэмдэглэгээтэй хайрцаг арван таван секунд тутам хурц гэрэл гялсхийлгэнэ. Энэ дэлхийн хамгийн жижигхэн мөртлөө хамгийн хачин гэрэлт цамхаг.

-Барби? Кен ямархуу байна? гэж тэр аяархан дуудлаа.

-Сан-Франциско явчихсан. Гей нарын ёслолын жагсаалд оролцохоор. Түүний бэлгийн хандлага дандаа сэжиг төрүүлдэг байсан юм.

Жулия инээд алдаад түүний гарыг авч үнслээ. -Найз минь. Чиний аюулгүй байгаад би маш их баярлаж байна.

Тэр бүсгүйг тэврээд тавихаасаа өмнө хоёр хацар дээр нь үнсэв. Удаанаар үнсэв. Жинхэнээр үнсэв. -Найз минь, би ч бас.

Тэр дахин инээсэн ч хүзүүнээс өвдөг хүртэл бүх биеэр нь загатналаа. Хэдийгээр ингээгүй удсан ч тэр энэ загатналыг мэднэ. "Охин минь зөөлөн байж үз. Наадах чинь чиний хүүхэд баймаар залуухан юм".

Тийм дээ...хэрэв тэр арван гуравтайдаа жирэмсэлсэн бол.

-Бүгд унтаж байна. тэр бүү хэл Горас. Тэр хүүхдүүдтэй хамт байгаа. Тэд түүнийг савааны араас гүйлгэсээр байгаад хэл нь газар хүртэл унжжээ. Тэр үхээд тэнгэрт очлоо гэж зүүдэлж байгаа гэж маргахад бэлэн байна.

-Би унтах гэж оролдсон ч чадсангүй.

Тэр хоёр ч удаа бараг л унтахын даваан дээр байгаагаа мэдэрсэн ч тухай бүрт Тахианы-саравчинд Жижгээтэй нүүр тулжээ. Эхний удаад Барби баруун тийш үсрэхийн оронд ханзанд

тээглэн унаад тэрийж сайхан бай болж өгөв. Хоёрдахь удаад Жижгээ торон завсар санаанд багтамгүй урт сунадаг гараа оруулаад амь нас хөнөөхөд хангалттай хэдэн хором багалзуурдахын тулд барьж авав. Үүний дараа Барби эрчүүд байрласан амбаараас гараад цэцэрлэг рүү ирсэн. Агаар нь зургаан сарын өмнө архаг тамхичин үхсэн өрөөг санагдуулах хэдий ч хотод байснаас хавьгүй дээр.

-Доор гал маш бага байна. Уг нь энэ цагт ч бараг ес дахин их байдагсан. Гудамжны гэрлүүд ч хоёр эгнээ сувд шиг харагддаг гээд Жулия санаа алдлаа.

-Гэхдээ бидэнд энэ байна гээд Барби нэг гараар түүний бүсэлхийгээр урьдын адил тэврэхийн зэрэгцээ нөгөө гараар гэрэлтэх бүсийг заав. Өнөөх нь Бүрхүүлд дөхөж очоод огцом тасарч, битүү Бүрхүүлээс ялгаатай нь морины тахыг санагдуулна.

-Яг тийм. Кокс түүнийг яагаад дурссангүй вэ? Энэ гэрэлтүүлэг сансараас авсан зураг дээр харагдах ёстой доо. Ямар ч гэсэн надад энэ талаар хэлээгүй. Чамд хэлсэн биш биз?

-Үгүй. Кокс заавал хэлэх байсан. Энэ нь тэгвэл Бүрхүүлийн гадна хэн ч, юу ч харахгүй байна гэсэн үг. Тэр зөвхөн бидэнд зориулагджээ.

-Чи Растигийн зөв гэж бодож байна уу? Бид харгис хүүхдүүдийн томруулдаг шилээр зовоодог шоргоолжнууд гэж? Хэрэв хүүхдүүддээ өөр ухаалаг ертөнцтэй ийм юм хийх боломж олгож байгаа юм бол энэ ямар гээч ухаалаг ертөнц вэ?

-Бид өөрсдийгөө ухаалаг гэж тооцож байна. Харин тэд? Шоргоолжнууд бол хамтач шавьж бөгөөд байшин барьдаг, колони үүсгэдэг гэдгийг мэднэ. Гайхалтай уран барилгачид. Тэд яг бидэн шиг хөдөлмөрч. Тэд үхэгсэдээ яг бид нар шиг оршуулдаг. Тэр бүү хэл арьсны үзлээр дайн явуулдаг. Хар шоргоолжнууд улааны эсрэг. Бид бүгд үүнийг мэдэх боловч тэднийг ухаалаг гэж тооцдоггүй.

Бүсгүй түүний гарыг биедээ чанга наалаа.

-Ухаалаг эсэх тухай яриа зөв бишээ.

-Зөвшөөрч байна. Олонхи хүмүүс тэгж боддог. Расти бүр хүүхэд байхдаа ойлгосон. Гэтэл хүүхдүүдэд ихэнхдээ ёс суртахууны зарчим бүрдээгүй байдаг. Түүний хөгжилд олон жил зарцуулагддаг. Тэгээд том болоод бид хүүхэд насны олон зүйлээ өнгөрсөнд үлдээдэг. Түүний дотор ялааны далавчийг таслах юмуу шоргоолжны үүрийг томруулдаг шилээр шатаахыг. Тэдний насанд хүрэгчидтэй бас ийм юм тохиолддог байх. Хэрэв тэд бидэн шиг хүмүүсийг ер нь анзаардаг бол. Чи хамгийн сүүлчийн удаа хэзээ шоргоолжны үүр рүү тонгойж сайтар харсан бэ?

-Гэвч үүний хажуугаар...хэрэв бид Ангараг дээр шоргоолж тэр бүү хэл нян олсон байлаа ч бид устгахгүй шүү дээ. Яагаад гэвэл орчлонт ертөнцөд амьдрал нь ховор юм. Манай нарны аймгийн бусад бүх гариг амьдралгүй.

Хэрэв НАСА-гийн эрдэмтэд Ангараг дээр амьдрал оллоо гэхэд түүний төлөөлөгчдийг

микроскоп дор тавьж анхааралтай судлахын тулд санаа зоволгүй устгах байх гэж Барби бодсон ч өөр юм хэлэв.

-Хязгааргүй сансар огторгуйгаар аялахад яг хэрэгтэй зүйлс нь болох манай иргэншил техникийн илүү хөгжилтэй, эсвэл оюуны хувьд илүү урагшилсан байх аваас бид газар сайгүй амьдралыг тэр дор нь олж харах байсан. Бидэнд энэ хотод байгаа шоргоолжны үүрнээс хавьгүй олон хүн амтай дэлхийнүүд ба ухаалаг иргэншилүүд нээгдэх байсан.

Түүний гар бүсгүйн хагас бөмбөлөгт аль хэдийн наалдсан уу? Жулия тийм гэж бодов. Эрэгтэй хүний гар тэнд байснаас хойш их хугацаа өнгөрчээ. Тэгээд энэ мэдрэмж түүнд таалагдав.

-Би нэг л юманд итгэлтэй байна. Энд дэлхий дээр суурилуулсан жижигхэн дурангаараа бидний хардагаас өөр ертөнцүүд байгаа гэдэгт би итгэлтэй байдаг. Эсвэл бүр "Хаббл"-ын тусламжтай харсан байлаа ч. Тэгээд...тэд энд байхгүй гэдгийг мэдэж байна уу? Энэ бол цөмрөлт биш. Тэд зүгээр л харж байна. Тэгээд магадгүй...тоглож байна.

-Чамтай тоглох гэж юу болохыг би мэднэ гээд Жулия толгой дохино.

Барби түүн рүү харж байв. Үнсэлтийн зайнаас. Хэрэв түүнийг үнслээ гэхэд тэр дургүйцэхгүй байсан. Огт дургүйцэхгүй.

-Чи хэний тухай яриад байна вэ? Ренни юу?

-Чи хүний амьдралд эргэлтийн мөч байдаг гэдэгт итгэдэг үү? Биднийг өөрчилдөг чухал үйл явдалд?

-Тийм гээд тэр түүний гуталнаас абдулын өгзөг дээр үлдсэн улаан мөрний тухай бодов. Ердийн амьдралаар амьдарч байсан ердийн хүний өгзөг. -Бат итгэдэг.

-Намайг дөрөвдүгээр ангид байхад ийм явдал болсон юм. Төв гудамжны бага сургуульд.

-Яриач дээ.

-Энэ их хугацаа эзлэхгүй. Тэр өдөр хамгийн урт өдөр байсан. Гэвч түүх нь их богино. Барби хүлээв.

-Би айлын ганц хүүхэд. Миний эцэг орон нутгийн сониньгг эзэмшдэг. Түүнд хоёр сэтгүүлч ба нэг рекламны агент байсан ч тэр голдуу өөрөө бүтдийг хийдэг байсан. Энэ нь түүнд таалагддаг учир. Эцэг тэтгэвэрт гарсаны дараа би жолоог атгана гэдэгт хэн ч эргэлзэж байгаагүй. Тэр үүнд итгэдэг, ээж итгэдэг, багш нар итгэдэг, би өөрөө ч итгэдэг байсан. Миний дээд боловсролыг, бүгдийг нь урьдаас төлөвлөсөн. Эл Шамуэйн хүүхдэд Мэний их сургууль шиг ямар ч хоёрдугаар зэргийн сургууль байх ёсгүй. Эл Шамуэйн охин Принстоны их сургуульд суралцах ёстой. Намайг дөрөвдүгээр ангид орох жилээс Принстоны таних тэмдэг миний орны дээр өлгөгдсөн. Би бараг чемоданаа бэлдээд байв. Бүгд, түүний дотор би өөрөө ч дээгүүр нь алхаж яваа газартаа мөргөх шахна. Дөрөвдүгээр ангийн сурагчдаас бусад

нь. Тэр үед би шалтгааныг мэдээгүй ч харин одоо бол яагаад анзааралгүй өнгөрсөнөө ойлгодоггүй юм. Би дандаа тэргүүн эгнээнд суудаг, хатагтай Коннот асуухад дандаа гараа өргөдөг, дандаа зөв хариулдаг байсан. Би чадвал даалгаварыг хугацаанаас нь өмнө гүйцэтгээд нэмж гуйдаг байлаа. Би дандаа цээжлэгч, хааяа бялдууч байв. Нэг удаа хатагтай Коннот биднийг ангид орхиж түр гараад эргэж ирэхэд жижигхэн Жесси Вачоны хамраас цус гарсан юм. Хэн ингэснийг хэлэх хүртэл хүүхдүүд ангиасаа гарахгүй гэж хатагтай Коннот хэлэв. Би гараа өргөөд Энди Мэннинг гэдгийг хэлсэн юм. Жесси түүнд юмаа өгөхөөс татгалзахад Энди түүний хамар руу нь цохисон юм. Би үнэнийг хэлсэн болохоор өөрийн үйлдэлд ямар ч муу юм олж харахгүй байлаа. Чи ерөнхий зургийг төсөөлж байна уу? -Чи эвгүй явдал руу оржээ.

-Үүний дараа би хотын талбайг огтолж явгал бүлэг охид над руу дайрлаа. Тэд Энхтайваны гүүрэн дээр нуугдаж байжээ. Зургуулаа. Лайла Страут удирджээ. Одоо тэр Лайла Кильян болсон. Рожер Кильянтай суусан. Болж. Хүмүүс том болоод хүүхэд насны гомдлоо санадаггүй гэж чамд хэлбэл битгий сонс. Тэд намайг тавцан руу чирж аваачлаа. Эхэндээ би мултрах гэж оролдсон. Тэдний хоёр нь Лайла ба хожим Тоби Мэннингийн ээж болсон Синди Коллинз нар намайг цохив. Хүүхдүүд тэгдэг шиг мөр рүү биш. Синди хацар руу, харин Лайла цээж рүү нударгалсан юм. Ямар их өвдсэн гээч. Миний хөх дөнгөж ургаж эхлээд байнга өвддөг байсан. Би уйллаа. Ихэнхдээ энэ дохио болж өгдөг. Ялангуяа хүүхдүүдийн хувьд одоо болсон гэсэн дохио. Гэхдээ тэр өдөр биш байжээ. Намайг хашгирахад Лайла "амаа тат, тэгэхгүй бол бүр дор юм болно шүү" гэж сүрдүүлэв. Тэднийг хэн ч тарааж чадахааргүй байв. Хүйтэн, бороотой өдөр байсан болохоор биднийг эс тооцвол хотын талбай хоосон байлаа. Лайла намайг хүчтэй алгадахад хамраас цус гарсан. Тэр "Бууны нохой, давстай өргөст хэмх. Шалан дээр хөглөрч хэн ч иддэггүй" гэж хэлсэн. Бусад охид инээлдэнэ. Тэдний надад дургүйцсэн шалтгаан нь миний Эндиг барьж өгсөн явдал гэж байв. Тэр үед би тийм л гэж бодсон. Харин одоо ойлгож байна. Яриа өөр олон юманд байжээ. Тэр бүү хэл миний хормогч банзал цамц ба туузны өнгө бие биедээ тохирдог байсанд хүртэл. Тэд хувцас өмсдөг би гоёл өмсдөг байж. Энди бол зүтээр л эцсийн дусал нь болж өгсөн.

-Чамд хүнд тусчээ.

-Тэд намайг алгадаж байв. Үснээс зулгааж чирсэн. Бас... над руу нулимаж байлаа. Бүгд. Миний хөл нугарч тавцан дээр унасны дараа тэгсэн юм. Би бүр чанга уйлж нүүрээ гараар тагласан ч тэдний нулимаж байгааг мэдэрсээр байв. Бүлээн шүлс, ойлгож байна уу?

-Мэднэ.

-Тэд намайг багтнийн бялдууч, "үнэргүй баас" нэртэй жижигхэн мисс гэж доромжиллоо. Дараа нь ингээд дууслаа гэж бодтол Корри Мейсингтон "түүний өмдийг нь тайлья" гэв. Тэр өдөр би ээжийн каталогоор захиалж авч өгсөн слакс өмссөн байсан юм. Би түүндээ их хайртай байсан. Принстонд охид яг ийм слакстай явдаг байв. Тэгэхэд би тэгж боддог байсан юм л даа. Би байдгаараа эсэргүүцсэн ч мэдээж тэд ялсан. Дөрөв нь барьж байгаад Лайла Корри хоёр миний слаксыг тайлав. Дараа нь Синди Коллинз инээгээд "түүний дотоож дээр новшийн Винни Пухын зураг байна" гэлээ. Үнэн хэлсэн л дээ. Зөвхөн Винни Пух биш бас Иа Ру хоёр зураг ч байсан. Тэгээд тэд бүгд инээлдсэн. Тэгээд...Барби...би агшиж эхэлсэн...агшаад л...агшаад л...агшаад л. Тавцан аварга цөл болтол агшсан юм. Харин би цөл дэх шавьж болсон. Цөлийн дунд үхэж байгаа.

-Өөрөөр хэлбэл яг томруулдаг шилэн дор үхэж байгаа шоргоолж.

-Өө үгүй. Үгүй Барби. Тэгэхэд халуун биш хүйтэн байсан. Би бээрсэн. Хөлөөр шоргоолж гүйх шиг болсон. Корри "түүний дотоожийг тайлъя" гэж хэлсэн. Гэхдээ тэд ийм юм хийж арай зүрхлээгүй. Лайла миний слаксийг тавцангийн дээвэр дээр шидсэнээр бүх юм дууссан. Дараа нь тэд яваад өглөө. Лайла хамгийн сүүлд явсан. "Хэрэв энэ удаад матах юм бол би ахынхаа хутгыг аваад чиний жингэр хамрыг огтолно шүү" гэж сануулав.

-Дараа нь юу болсон бэ? гэж Барби асуув. Тиймээ түүний гар хагас бөмбөлөг дээр тавигджээ.

-Дараа нь тавцан дээр жижигхэн айсан охин үлдээд хүүхдийн дотоожоо хотын тэн хагаст харуулалгүй яаж гэртээ харихаа тааж ядаж байв. Би өөрийгөө энэ хорвоогийн хамгийн жижигхэн, бас хамгийн аз жаргалгүй охиноор мэдэрч байв. Эцэст нь харанхуй болтол хүлээхээр шийдлээ. Эцэг эх санаа зовж, цагдаа руу утасдахаар байсан ч үүнд би сэтгэл төвдсөнгүй. Би харанхуй болтол хүлээгээд дараа нь хүн ойртвол модны араар нуугдсаар харанхуй нарийн гудамжаар харина гэж тооцов. Би зүүрмэглэсэн бололтой. Яагаад гэвэл миний дэргэд зогсож байгаа Кайла Бевинсийг гэнэт олж харсан. Тэр бусад охидтой хамт намайг алгадаж, үснээс зулгааж, нулимаж байсан юм. Лайла Корри нар миний слаксийг шувтлахад миний гарыг барьж өгсөн. Бас нэг пгуумаг нь унжиж байхыг хараад Кайла бариул дээр гарч зогсоод миний гар хүрэхээргүй болгож дээш нь чулуудсан юм. Би түүнээс намайг зодохгүй байхыг мөргөн гуйв. Бардам зан сайн талуудаа би аль хэдийн бүрэн алджээ. Миний дотоожийг тайлахгүй байхыг түүнээс гуйлаа. Тэгээд надад туслахыг мөн гуйв. Тэр намайг хоосон газар шиг сонсоод л зогсож байсан. Би үнэндээ хоосон газар болсон байсан даа. Тэр үед бол мэдээгүй. Магадгүй он жил өнгөрөхөд мартсан. Гэвч одоо Бүрхүүлийн тусламжтайгаар саналаа. Дараа нь би дуугүй болоод ихэр татан хэвтэж байв. Тэр намайг хэсэг харж байснаа дараа нь ноосон цамцаа тайлсан. Хуучин, хэлхгэр, хүрэн өнгийн, бараг өвдөг татмаар. Тэр том биетэй охин болохоор их том цамц өмсдөг. Тэр цамцаа тайлж шидээд "гэртээ өмсөөрэй, яг дашинз шиг харагдах болно". Энэ тэгэхэд түүний хэлсэн бүх үг. Хэдийгээр би түүнтэй Миллийн ахлах сургууль төгстөл найман жил хамт сурсан ч бид хэзээ ч дахин ярилцаж байгаагүй. Заримдаа би зүүдэндээ түүний "гэртээ өмсөөрэй, дашинз шиг харагдах болно" гэж хэлэхийг сонсдог юм. Түүний үгэнд үзэн ядалт байхгүй ч өрөвдөж хайрласан аяс бас байхгүй. Тэр намайг өрөвдсөндөө юмуу эсвэл амыг минь таглах гэсэндээ үүнийг хийгээгүй. Тэр яагаад үүнийг хийснийг би мэдэхгүй. Тэр ер нь яагаад эргэж ирсэнийг ч би мэдэхгүй. Харин чи?

-Үгүй гээд тэр бүсгүйн уруул дээр үнслээ. Түргэн боловч дулаан, нойтон боловч сэтгэл догдлом.

-Чи үүнийг яах гэж хийв?

-Яагаад гэвэл чиний байдлыг хараад байхад чамд энэ хэрэгтэй шиг байна. Харин би өөртөө юу хэрэгтэйг мэднэ. Дараа нь юу болсон бэ Жулия?

-Би цамцыг өмсөөд гэртээ харьсан...өөр юу билээ дээ? Эх эцэг намайг хүлээж байжээ гээд тэр эрүүгээ бардам өргөлөө. -Би тэдэнд юу болсоныг хэлээгүй, тэд ч юу ч олж мэдэж чадаагүй. Долоо хоног орчмын дараа би сургуулиас харьж яваад тавцангийн шовгор орой

дээр байгаа өмдөө харав. Түүгээр явах бүртээ зүрхийг минь хурц хутгаар зүсэх мэт ичингүйрэл ба өвдөлтийг мэдэрдэг байсан. Дараа нь үгүй болсон. Өвдөлт арилаагүй ч, үүний дараа хөнгөрсөн. Хурц өвдөлтөөс мохоо өвдөлт болж хувирсан. Аав их уурлаж намайг хатуу шийтгэсэн ч би охидыг зааж өгөөгүй. Зургаан сар хүртэл би зөвхөн сургууль гэр хоёрын хооронд явж чадахаар болтлоо шийтгүүлсэн юмдаг. Би бүтэн жилийн турш мөрөөдсөн Портлендын Урлагийн музей рүү хийсэн аялалд хүртэл яваагүй. Надтай "муухай харьцсан" хүүхдүүдийн нэрийг хэлсэний дараа л бүх хязгаарлалтаа цуцлах ба аялалд явах болно гэж аав хэлсэн. Тэр энэ явдалд ийм нэр өгсөн юм. Би тэднийг хэлж өгөөгүй. Гэхдээ хэлээ хазах чадвартай болоод тэр биш. Итгэл үнэмшилийн бэлэг тэмдэгийн хүүхэд хувилбар гэхүү дээ.

-Чи дотроо, чамтай тэдний хийсэн бүхнийг амсах гавьяатай гэж дотроо мэдэрсэн учраас л үүнийг хийгээгүй.

-Гавьяатай гэдэг буруу үг байна. Чи урьдын биеэ авч явсан байдлынхаа төлөө төлбөр хийсэн. Энэ хоёр ондоо. Энэ явдлаас хойш миний амьдрал өөрчлөгдсөн. Би сайн дүн авсан хэвээр байсан ч гараа байнга өргөхөө больсон. Өөрөөр хэлбэл суралцахаа болиогүй ч ангийнхаа бүх хөнжлийг өөр рүүгээ татахаа болив. Би ахлах сургуулийн төгсөлтийн үг хэлж чадах байсан ч хичээлийн жилийн хоёрдугаар хагаст бага зэрэг тоормослосон. Карлин Пламмерыг урдаа гаргах яг тийм хэмжээнд. Би үт хэлэхийг, өндөржүүлсэн анхаарал татахыг хүсээгүй. Надад найз нөхөд бий болсон. Хамгийн сайн найзуудтайгаа би ахлах сургуулийн арын тамхи татах газарт танилцсан. Хамгийн том өөрчлөлт нь Портленд биш Мэний их сургуульд элсэх тухай миний шийдвэр байв. Намайг тэнд үнэхээр хүлээн авсан. Эцэг маань үсчиж уухилж байлаа. Миний охин тосгоны коллежид явах ёсгүй гээд л. Гэвч би өөрийнх дээрээ хатуу зогссон. Хангалттай хатуу. Гэхдээ харилцан буулт хийх нь хайрын нууц бүрэлдэхүүн. Харин би аавдаа хайртай. Тиймээс зун төгсөлтийн үдэшлэгийн дараа эцсийн мөчид би Бейтс рүү бичиг баримтаа өгсөн юм. Үүнийг "онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн өргөдөл" гэж нэрлэдэг. Намайг хүлээн авлаа. Аав миний банкин дахь хувийн данснаас сүүлчийн хувь нэмрээ хийхэд хүргэсэн. Би баяртай хийсэн юм. Яагаад гэвэл манай гэрт арван зургаан сарын турш үргэлжилсэн хилийн дайн дууссан болохоор. Хяналт тавих эцэг эх ба хэмжээ жижиг боловч сайтар хамгаалагдсан бардам Өөрийгөө тодорхойлсон охин гэдэг улсуудын хооронд болсон дайн. Би сэтгүүлчийн танхим сонгосноор тавцан дээр өнгөрөөсөн тэр өдрөөс хойш эцэг эх ба бидний хооронд үүсээд байсан ан цавыг гүйцэд хаалаа. Энэ ан цав юунаас болж үүссэнийг тэд мэдэхгүй чигээрээ үлдсэн. Харин Миллд бол би тэр өдрөөс болоод байж байгаа юм биш. "Ардчилал" дахь миний ирээдүй намайг төрөхтэй хамт л тодорхой болсон. Гэхдээ миний одоо ямар хүн байгаа нь тэр өдөртэй ихээхэн холбоотой гэснээ тэр Барби руу дахин харахад түүний нүдэнд дайчин нулимс цийлэлзэв. -Тэгсэн хэдий ч би шоргоолж бишээ. Би шоргоолж биш.

Барби түүнийг дахин үнслээ. Тэр ч өмнөөс нь чанга тэврээд чадах чинээгээрээ хариулав. Барбигийн гар цамцны хормойг өмднөөс сугалаад хөхийг базахаар гэдсээр тэмтчихэд хэлээ аманд нь хийв. Тэд үнсэлтээ зогсооход Жулия ойр ойрхон амьсгалж байв.

-Хүсч байна уу? гэж Барби асуулаа.

-Тийм ээ. Харин чи?

Тэр түүний гарыг аваад хүслийнх нь хэмжээг мэдрээсэй гэсэндээ жинсэн өмдөн дээрээ тавилаа.

Минутын дараа Барби тохой дээрээ тулан түүний дээр хэвтэж байв. Жулия өнөөхийг нь аваад чиглүүллээ.

-Хурандаа Барбара болгоомжтой. Би үүнийг яаж хийдгийг ч мартчихсан байна.

-Энд ч бас унадаг дугуйгаар явах шиг тийм нөхцөл байдал үүсээд байна.

Барби алдаж хэлээгүй нь тодорхой болов.

15

Бүх юм дуусахад бүсгүйн толгой түүний гаран дээр хэвтэх бөгөөд тэр ягаан оддыг харна.

-Чи юу бодож байна? гэж Жулия асуув. Тэр санаа алдлаа.

-Зүүдний тухай. Зөн совингийн тухай. Юу гэж ч нэрлэсэн яахав дээ. Чамд гар утас бий юу?

-Үргэлж. Цэнэгээ их сайн барьдаг юм. Гэхдээ одоо хэр удахыг мэдэхгүй байна. Хэнтэй ярих нь вэ? Кокс гэж бодож байна?

-Зөв таалаа. Түүний дугаар чиний утасны жагсаалтанд байгаа юу?

-Байгаа гээд Жулия өвсөн дээр хэвтэх өмд рүүгээ зүтгэж бүснээс утсаа авав. Жагсаалтнаа "Кокс" нэрийг олж ярих товчийг дараад утсаа Барбид өгөхөд тэр шууд ярьж эхлэв. Кокс анхны дууддагаар л утсыг авсан бололтой.

-Сайн уу хурандаа, би Барби байна. Би эрх чөлөөтэй болсон. Азаа үзэж хаана байгаагаа танд мэдээлэхэд бэлэн байна. Энэ бол Блэк-Ридж. Маккойн алимны хуучин цэцэрлэг. Танайд мэдээж тэмдэглээстэй байгаа. Тэгээд та нар хиймэл дагуулаас авсан хстын зурагтай биз дээ?

Тэр Коксийг сонсоод дараа нь асуув. Зураг дээр Блэк-Риджийг хүрээлж Ти-Эр-90-ийн хил дээр дуусах гэрлэн тах харагдаж байгаа эсэхийг? Кокс үгүй гэж хариулаад Барбигаас мэдээллээ хуваалцахыг гуйлаа.

-Одоо бишээ. Яагаад гэвэл надад таны тусламж хэрэгтэй байна. Хурдан тусмаа сайн. Үүний тулд хос "чинук" хэрэг болно. (цэргийн тээврийн хүнд нисдэг тэрэг)

Тэр юу хэрэгтэй байгаагаа тайлбарлав. Кокс сонсоод дараа нь асуулт тавилаа.

-Одоо ямар нэг ойлгомжтой юм хэлж чадахгүй. Энд ямар нэг аймаар юм болоод байгаа бөгөөд өмнө маань бүр долоон дор юм хүлээж байгаа гэдэгт итгээрэй. Хэрэв бидэнд аз дайрах юм бол Хэллоуин хүртэл юу ч болохгүй байж мэднэ. Гэхдээ үнэнийг хэлэх юм бол би үүнд итгэхгүй байна.

Барби хурандаа Жеймс Кокстой ярьж байх үед Энди Сандерс ХБЭ-ий барилгын арын зоорийн байшингийн хажуу ханыг налан суугаад ер бусын ягаан оддыг харна. Тэр яг л цаасан шувуу шиг элин халих бөгөөд сэргэг аз жаргалтайгаа мэдэрнэ. Гэвч дээд талын энэ оргилсон давхаргын дор газар доорх хүчтэй голыг санагдуулам гуниг байх ба түүнийг тайвшруулж, номхруулна. Түүний газрын ажлаар дүүрэн амьдралд урьд нь хэзээ ч урьдчилан мэдэх мэдрэмжийн орон зай байсангүй. Харин одоо бий болжээ. Энэ бол түүний дэлхий дээр өнгөрөөж байгаа сүүлчийн шөнө гэдгийг мэдэж байв. Тэгээд гашуун хүмүүс ирэхээр тэр болоод Шеф Буши явахаас өөр аргагүй болно. Тэмдэглэж хэлэхэд тэр энэ тал дээр ямар ч мууг олж харахгүй байлаа.

-Би ямар ч гэсэн шагнал амьдралаар амьдарч байна гэж Энди чанга хэлээд: -Шахмалыг анх хэрэглэсэн яг тэр мөчөөс эхлээд л.

-Сандерс чи юу яриад байна? гэж радиостудиэс нүцгэн хөлөн доодхоо гар чийдэнгээр гэрэлтүүлсээр ирж яваа Шеф асуулаа. Мэлхийн зурагтай унтлагын өмд урьдын адил туранхай өгзөг дээр арай гэж тогтоно. Гэхдээ түүний царай төрхөд шинэ зүйл бий болжээ. Том цагаан загалмай. Загалмай хүзүүндээ уясан савхин уяанд өлгөөстэй байв. Шеф мөрөндөө "Бурханы дайчин"-ы гол төмрийг тохжээ. Бууны бөгсөн доор уясан өөр савхин уяанд хоёр гар бөмбөг санжигнана. Нөгөө гартаа тэр гаражийн удирддагаа барьсан байв.

-Зүгээр ээ Шеф. Өөрөө өөртэйгөө ярьж байна. Эдгээр өдрүүдэд намайг сонсож байгаа ганц хүн нь би өөрөө бололтой.

-Шал дэмий юм Сандерс. Бүрэн төгс дэмийрэл. Бурхан сонсож байгаа. ТТГ утсанд "цох" тавьдаг шиг Бурхан хүн бүрийн сэтгэлд тавьдаг юм. Би ч бас чамайг сонсож байна.

Хэлсэн үгний уран гоё ба тайтгаруулал Эндигийн сэтгэлийг баяраар дүүргэв. Тэр Шефэд гаансаа санал болголоо.

-Тат. Энэ чамайг сэргээнэ.

Шеф сөөнгөтөн инээгээд гүнзгий сорж утааг уушигтаа удтал барьсанаа цацаж гаргав.

-Гайхалтай. Бурханы хүч. Сэргэсэн хүч гэж дуу алдлаа.

-Чи бүхнийг зөв ойлгож байна гэж Энди зөвшөөрлөө. Доди дандаа ингэж хэлдэг. Түүний тухай бодонгуут Сандерсын зүрх дахиад урагдав. Тэр нүдээ хайш яйш шударлаа. -Чи загалмайг хаанаас аваа вэ?

Шеф дэнлүүгээрээ радиостудийг заав.

-Коггинсийн өрөөнөөс. Түүний ширээнд байжээ. Дээд

шургуулга түгжээтэй байхаар нь эвдсэн. Тэндээс юу олсоныг мэдэх үү? Ийм хачин зураг хэзээ ч харж байсангүй.

-Хүүхдүүд үү? гэж Энди асуулаа. Тэр үүнд гайхахгүй. Чөтгөр номлогчийг эзэмдэх юм бол их доошоо унах ёстой. Толгойдоо бортого углаад хоржигнуурт могойн доогуур мөлхөхөөр, тийм доошоо.

-Сандерсаа, түүнээс ч дор. Ази хүүхнүүд гэж Шеф дуугаа намсган хэллээ.

Шеф Эндигийн гуя дамнан хэвтэж байсан АК-47 бууг нь өргөв. Дэнлүүний гэрлийг бууны бөгс рүү тусгалаа. Энди цаасны хутга ашиглан "Клодетт" гэж нямбай сийлжээ.

-Миний эхнэр. Бүрхүүлийн хамгийн анхны хохирогч гэж Энди тайлбарлав.

Шеф түүний мөрөөр тэвэрлээ.

-Чи түүнийг дурсаж байгаа бол сайн хүн. Бурхан биднийг уулзуулсанд би баяртай байна.

-Би ч бас. Би ч бас Шефээ гээд Энди гаансыг буцаан авлаа.

-Маргааш юу болох ёстойг мэдэж байгаа юу?

Энди автоматын бөгсийг чанга шахаж барилаа. Өөр хариултын хэрэг байсангүй.

-Тэд бараг л гарцаагүй хуягт хантаазтай ирж таарна. Тиймээс тулалдах хэрэг гарвал толгой руу нь онилоорой. Хэзээ ч тусад нь бүү бууд, шууд л шүршээрэй. Хэрэв тэд дийлээд ирэх шиг болох юм бол...үүний дараа юу болохыг чи мэдэж байгаа тийм үү?

-Тийм.

-Бид хоёр үхэн үхгэлээ хамтдаа шүү Сандерс гээд Шеф гаражийн удирддагаа өргөж дэнлүүгээ тийш чиглүүлэв.

-Эцсээ хүртэл гэж Энди санал нийллээ. Тэгээд гаражийн удирддагыг автоматны амаар шүргэв.

Олли Динсмор муухай зүүд зүүдлээд сэрэв. Нэг л биш гэдгийг мэдэрнэ. Орондоо хэвтээд цонхоор нэвтрэх ямар нэг бохир ба сулхан өглөөний анхны туяаг харна. Тэгээд энэ бол бараг бүрэн мартагдсан хар дарсан аймшигт зүүд бөгөөд ердөө л зүүд гэж өөртөө итгүүлэхийг хичээнэ. Тэр зөвхөн гал ба орилооныг санаж байв.

Орилоон биш. Зэрлэг бахираан.

Орны дэргэдэх ширээн дээр хямдхан цаг цохилно. Олли түүнийг шүүрч авлаа. Таван цаг дөчин таван минут болж байх бөгөөд эцэг нь гал тогоонд байгааг илэрхийлэх ямар ч чимээ үл гарна. Бас кофены үнэр ч алга. Эцэг нь дандаа их оройтлоо гэхэд таван цаг арван таван минутанд босоод хувцасаа өмсдөг билээ. (үхэр биднийг хүлээхгүй гэсэн номлолоор Олден Динсмор амьдардаг). Тав хагас гэхэд тэр аль хэдийн дөнгөж сая чанасан кофегоо өөртөө

аягалдаг. Гэхдээ энэ өглөө биш.

Олли босоод өчигдөр өмссөн өмдөө дахин шургуулав. -Аав аа?

Ямар ч хариу алга. Цаг цохих ба алсад аль нэг үхэр ханамжгүй мөөрөхөөс өөр чимээгүй. Жаалхүүг айдас эзэмдэв. Гэхдээ түгших шалтгаан үгүй гэж жаалхүү өөрийгөө ятгана. Дөнгөж долоо хоногийн өмнө бүрэн бүтэн бөгөөд тийм аз жаргалтай байсан түүний гэр бүл одоо Бурханы илгээсэн бүх эмгэнэлийг туулж гарсан гэж итгүүлнэ. Ядахдаа хэсэг хугацаанд. Тэр өөрөө өөртөө ингэж ятгавч үл итгэнэ.

-Аав аа?

Байшингийн арын цахилгаан үүсгүүр урьдын адил ажиллах бөгөөд тэр гал тогоонд орж ирээд бичил зуух болон цахилгаан зуухны ногоон дэлгэцийг харсан ч "Ноён кофе" аппарат харанхуй бөгөөд хоосон байлаа. Зочдын өрөөнд ч тэр хэн нэгнийг олсонгүй. Оллиг унтахаар явахад эцэг нь зурагт үзэж байсан бөгөөд зурагт одоо ч дуу нь хаалттай ажилласаар байв. Бүрсгэр бие хаатай ямар нэг эр машин угаах ба арчихад зориулсан шинэхэн сайжруулсан даавуун цаасыг танилцуулна.

-Та бүхэн сар бүр цаасан алчуурт дөчин доллар зарж мөнгөө салхинд хийсгэдэг гэж тэр баргар эр ийм жижиг сажиг юм ихээхэн утга учиртай байж мэдэх өөр ертөнцөөс ярьж байв.

Тэр үнээгээ тэжээж байгаа. Өөр юу ч биш.

Гэхдээ эцэг нь цахилгаан хэмнэхийн тулд яагаад зурагтаа унтраагаагүй юм бол? Тэднийх их том чингэлэгтэй боловч түүний хий ч эрт орой хэзээ нэг цагт дуусч таарна.

-Аав аа?

Бас л хэн ч хариулсангүй. Олли цонхон дээр очоод амбаар руу харлаа. Хэн ч алга. Айдас улам ихэссээр ээж аавын унтлагын өрөө рүү очив. Тогших гэснээ ингэх хэрэггүйг ухаарав. Хаалга нь онгорхой байлаа. Хураагаагүй (эцэг нь үнээний саравчаа л цэгцэлдэг) хоосон хоёр хүний өргөн ор харагдана. Эргэх гэснээ түүнийг түгшээсэн өөрчлөлтийг анзаарлаа. Оллигийн санаж байгаагаар Олден ба Шелли нарын хуримын хөрөг хананд өлгөөстэй байдаг билээ. Харин одоо алга болоод хананы цаасан дээр цайвар мөр үлдээжээ. Айх юмгүй дээ.

Гэвч тэр өөрөө үүнд итгэхгүй байв.

Олли хонгилоор цаашаа алхаж сүүлийн нэг жилд хэн ч хаагаагүй өөр нэг хаалга руу очиход харин одоо хаалттай байхыг харав. Хаалганд ямар нэг шар юм хавчуулжээ. Зурвас. Олли үгийг харахаар бүр ойртохоосоо өмнө эцгийн үсгийн маягийг танив. Энэ том налуу үсгийг Рори тэр хоёр сургуулиас харьж явахдаа зөндөө л хардаг байсан. Зурвас нь дандаа л адилхан дуусдагсан.

"Амбаар цэвэрлээд явж тогло. Улаан лооль ба шошоо услаад дараа нь явж тогло. Хатсан угаасан хувцас гэрт оруул гэхдээ юу ч газарт унагаж болохгүй шүү. Дараа нь явж тогло".

Тоглоом дуусчээ гэж Олли айн бодлоо.

Энэ үед толгойд нь найдвар төрүүлсэн санаа төрөв. Энэ бүхэн зүүд юм биш биз? Яагаад болохгүй гэж? Дүү нь буцаж ойсон суманд оногдон үхэж ээж нь амиа хорлосны дараа тэр гэртээ ганцаараа үлдсэн гэж зүүдэлж болохгүй гэж үү?

Дахиад л үнээ мөөрөв. Гэхдээ энэ мөөрөлт зүүдний дуу мэт санагдана.

Одоо зурвас цухуйж байгаа хаалттай хаалганы цаана Том өвөө амьдардаг байсан. Зүрхний архаг дутагдалтайн улмаас өөрөө өөрийгөө асарч чадахгүй болсон тул эднийд ирсэн юм. Нэг хэсэг өвөө гэр бүлтэй хамт хооллохоор доошоо бууж ирдэг байв. Гэвч сүүлдээ хэвтгэрээс босохоо больсон. Эхэндээ хамарт нь бэхэлсэн хуванцар зүйлтэй байдаг байлаа. Канделябр билүү нэг тиймэрхүү л нэртэй эд. Дараа нь бүх нүүрээрээ амьсгалын маск зүүдэг болсон. Рори нэг удаа өвөөгөө энэ дэлхийн хамгийн хөгшин сансарын нисгэгч шиг харагдаж байна гэж хэлээд ээжээр алгадуулсан юмдаг.

Амьдралын хамгийн сүүлчийн өдрүүдэд бүгд ээлжлэн түүнд хүчилтөрөгчийн баллон сольж өгдөг болсон. Харин нэгэн шөнө ээж нь түүнийг шалан дээр үхсэн хэвтэж байхыг олсон билээ. Өвөө нь орноосоо босох гэж оролдоод их хүчлэл гаргаснаас болж үхсэн мэт байлаа. Ээж нь Олденыг дуудахад тэр гүйж ирэн харсанаа дараа нь цээжин дээр нь чихээ наагаад эцэст нь хүчилтөрөгчийг салгасан. Шелли Динсмор уйлж гарав. Тэр цагаас хойш энэ өрөө рүү хэн ч ороогүй.

"Уучлаарай. Хот руу яваарай Олли. Морган Дентон юмуу эсвэл Либби гэлэнмаа чамайг харж асарна" гэж тэр зурвасыгт уншлаа.

Олли зурвасыгт удтал харж зогсоод дараа нь хаалганыг бариулыгт өөрийнхөө гараар эргүүлэхдээ онцгой эмх замбараагүй байдал үүсээгүй гэж бодов.

Энэ тал дээр түүний найдвар зөвтжээ. Эцэг нь өвөөгийн орон дээр гараа энгэр дээрээ тавиад хэвтэж байлаа. Яг хот орох гэж байгаа мэт үсээ нямбай самнажээ. Тэр хуримын зургаа барьсан байв. Өвөөгийн хуучин хүчилтөрөгчийн ногоон баллонуудын нэг буланд байна. Олден таган дээр нь "Аваргууд" гэсэн бичигтэй "Ред сокс"-ын бейсбольн малгайг өлгөжээ.

Олли аавыгаа мөрнөөс нь сэгсэрлээ. Угаарын үнэр түүнд мэдрэгдэхэд хэдхэн хором найдвар зүрхэнд нь амилав. (дэндүү зөрүүд бөгөөд заримдаа үзэн ядалт дагуулдаг). Тэр зүтээр л согтголоо уучихсан юм биш биз?

-Ааваа, аав. Сэрээрэй.

Гэвч Олли хацар дээрээ амьсгал мэдрээгүй ба харин одоо аавыгнх нь нүд бүрэн хаалттай биш байгааг харав. Аньсаганыг завсар нарийн цагаан харагдана. Ээжийнх нь "жорлонгийн" гэж нэрлэдэг байсан үнэр бас хамарт сэнхийв.

Эцэг нь үсээ самнасан хэдий ч үхэхээр хэвтэж байхдаа амиа хорлосон эхнэрийнхээ адил шээсэн байжээ. Хэрэв шээхээ мэдсэн бол эцэг нь болих байсан эсэхийг Олли өөрөөсөө асуув.

Олли орноос ухарлаа. Энэ бүхэн муухай зүүд байхыг тэр ямар их хүснэ вэ. Үнэхээр муухай зүүдтэй дэндүү адил боловч гагцхүү түүнээс сэрнэ гэж хүлээх хэрэггүй аж. Ходоод нь мушгираад цөс хоолой руу өгсөв. Тэр усны өрөө рүү гүйж ороход тэнд түүнийг нүд нь бүлтийсэн үл таних хүн угтав. Угаалтуурын дээрх толинд өөрийн дүрсийг харж байгаага ойлгохыгн өмнө Олли золтой хашгирсаггүй.

Суултуурын дэргэд унаад Рори тэр хоёрын өвөөгийн шээсний бариул гэж нэрлэдэг байсан бариулаас зуураад бөөлжив. Гэдэс нь хоосормогц тэр усаа татлаа. (цахилгаан үүсгүүр ба гүн сайн худагт баярлалаа. Тэдний ачаар усаа татаж чадсан). Суултуурыг таглаад дээр нь сууж бүх биеэрээ чичирлээ. Дэргэд нь угаалтуурт Том өвөөд нь зориулсан эмний хоёр сав ба "Жек Дэниельс"-ийн лонх харагдана. Бүгд хоосон. Олли нэг савыг авлаа. Дээр нь "перкосет" гэсэн бичиг байв.

Хоёрдахийг нь авсангүй.

-Одоо би гав ганцаараа гэж хэллээ.

"Морган, Дентон юмуу Либби гэлэнмаа чамайг харж асарна".

Гэхдээ тэр харж асруулахыг хүссэнгүй. Энэ үг өөрөө ч түүнд огт таалагдсангүй. Заримдаа Олли фермийг үзэн яддаг байсан ч түүнийг хайрлах хайр нь давдаг. Тэр фермгүй амьдарч чадахгүй. Ферм ба үнээгүйгээр. Тэд түүний нэг хэсэг, тэр өөрөө тэдний нэг хэсэг нь байлаа. Рори эндээс явна гэдгийг мэддэг шиг Олли үүнийг мэддэг байсан. Рориг эхлээд коллежид дараа нь алсын том хотод гялалзсан амжилттай ахилт хүлээж байгаа гэдгийг мэддэг байсан. Тэр тэндээ театр, уран сайхны үзэсгэлэн гээд тиймэрхүү газруудаар явах болно. Их ертөнцөд ямар нэг юманд хүрэх ухаан дүүд нь хангалттай байсан. Харин Олли өөрийнхөө тухай бол өөрөөр бодно. Банкны зээлдүүлэгчидтэй цагаа олж тооцоо хийх ба зээлийн карт дээр өр хуримтлуулахгүй байх ухаан бол хүрнэ. Үүнээс илүүгүй.

Тэр гэрээс гарч үнээгээ тэжээхээр шийдэв. Хэрэв тэд идэх юм бол тэжээлийн хольцоос давхар орцоор өгөхөөр шийдэв. Тэр бүү хэл нэг хоёрыг нь саах хэрэг болно. Хэрэв тэгэх юм бол яг хүүхэд цаг шигээ дэлэнгээс гарсан сүүг шууд ууна.

Үүний дараа том талбайгаар аль болох хол яваад Бүрхүүл рүү чулуу шидэх санаатай байв. Хүмүүс хамаатан садантайгаа уулзахаар цуглаж ирээгүй байгаа дээр нь. "Нухацтай хэрэг" гэж түүний эцэг хэлэх байсан. Гэхдээ Олли Өмнөд Каролинаас ирсэн байлдагч Эймсээс өөр хэнийг ч харахыг үл хүснэ. Нагац Лу ба авга Скутер нар ирж мэднэ. Тэд Нью-Глостерт амьдардаг. Гэхдээ тэд ирлээ гэхэд юу хэлж чадах юм бэ? "Сайн уу авгаа, нагацаа. Надаас бусад нь бүгд үхсэн. Ирсэнд баярлалаа" гэх үү?

Үгүй ээ. Бүрхүүлийн нөгөө талаар хүмүүс цуглаад эхлэнгүүт тэр ээжийгээ оршуулсан толгой руу гарч шинэ нүх ухна. Үүнд цаг ба хүч хэрэгтэй тул дараа нь орондоо орохоор унтаж чадах байх.

Усны өрөөнд Том өвөөгийн хүчилтөрөгчийн баг өлгөөстэй байв. Ээж нь сайтар угаагаад энд өлгөжээ. Юуны тулд гэдгийг хэн мэдэх билээ? Багийг харж зогсохдоо Олли болсон явдлыг

арай гэж ойлгов. Төгөлдөр хуур гантиг шалан дээр унадаг шиг бодит амьдрал түүн дээр бууж ирэв. Жаалхүү суултуурын таган дээр сууж нүүрээ гараар дараад уйлан хойш урагш ганхлаа.

18

Линда Эверетт хоёр том даавуун цүнхийг лаазалсан хүнсээр дүүргэв. Хаалга руу аваачих гэснээ Маршаллтай хамт хүүхдүүдийг аялалд бэлдэх хооронд зооринд байлгасан нь дээр гэж шийддээ. Орцны замаар ирж яваа Тибодог хараад цүнх ил байгаагүйд баярлав. Залуу түүнийг үхтэл айлгасан. Гэтэл лаазалсан хүнс, хуурай шөл, шош ба туна загасаар дүүргэсэн цүнхийг тэр харах юм бол айх шалтгаан улам нэмэгдэх байлаа.

Хатагтай Эверетт хаа нэг тийшээ явж байгаа юм уу? Алив энэ тухай ярилцъя.

Рэндолфын цуглуулсан бүх шинэ цагдаа нараас ганцхан Тибодо л ухаалаг байв.

Ренни яагаад Мел Сирлсийг нааш нь явуулсангүй вэ?

Яагаад гэвэл Мельвин Сирлс мод шиг дүнхүү. Бүх юм тун энгийн, хүндэт Ватсон.

Тэр гал тогооны цонхоор гадагш харвал Терстон савлуур дээр Жанни Элис хоёрыг савлаж байв. Одри хоншоороо нэг савар дээрээ тавиад дэргэд нь хэвтэнэ. Жүди Эйден хоёр элсний хайрцаг дотор тоглоно. Жүди нэг гараар Эйденийг тэврээд тайвшруулж байх бололтой. Линда үүнийх нь төлөө түүнийг магтаж л чадахаар байв. Одоо хашаанд байгаа таван хүн ирсэнийг нь мэдэхээс өмнө ноён Картерын сониуч занг хангаад үдэж амжина гэж найдав. Линда коллежид байхдаа "Хүслийн трамвай" дуурьд тоглодог байсан юм. Энэ өглөө ч бас тайзан дээр гарах гэж байлаа. Үнэнийг хэлэхэд ганцхан сайн шүүлт өгөхийг хүсэх бөгөөд харин тэр нь түүнд болоод энд байгаа бүх хүнд эрч чөлөө бэлэглэх байв.

Линда хаалга нээхийн өмнө тухайн энэ мөчид түүнд тохирно гэж бодсон ихэд санаа зовсон төрхийг царайдаа тодруулаад зочны өрөө дундуур хаалга руу яарлаа. Картер гутал арчигч дээр зогсож байв. Тогшихоор гараа өргөөд байлаа. Эмэгтэй түүний дороос дээш харна. Таван фут есөн дюйм өндөр болохоор Картер түүнээс бараг хагас фут өндөр ажээ.

-Ийм юм бас байдаг аа? Долоо хагас ч болоогүй байхад тэр бүрэн гоёсон байдаг байна шүү? гээд тэр инээв.

Гэхдээ түүнд инээх хүсэл тийм ч их байсангүй. Бүтэлгүй өглөө байлаа. Гэлэнмаа явчихсан, сонингийн жингэр хоёр сэтгүүлчтэйгээ зугтжээ. Роуз Твитчел ч бас хаашаа ч юм алга болж. Ресторан нээгдэж Уилер гал зууханд зогсох боловч эзэгтэй нь хаачсан талаар ямар ч ойлголтгүй байв. Картер түүнд итгэв. Энсон дуртай ясаа хаана булсанаа мартсан нохойг санагдуулна. Гал тогооноос гарах дур гутам үнэрээр бол тэр хоол хийхдээ сайнгүй аж. Картер фургон нь байгаа эсэхийг үзэхээр рестораныг араар нь тойрсон. Тэгээд олж харсангүй. Гайхсангүй.

Рестораны дараа тэр их дэлгүүр рүү очив. Гол хаалгыг, дараа нь арын хаалгыг тогшив. Арын хаалганы хажууд мартамхай худалдагч хуйлаастай дээврийн материал орхисон нь хэн нэг

хулгайч аваасай гэсэн мэт. Гэхдээ бодох юм бол одоо бороо орохоо больсон хотод дээврийн материал хэнд хэрэгтэй юм бэ?

Эвереттийн гэрт цоожтой хаалга мөргөнө гэдэгтээ Картер эргэлзээгүй. Түүний бүх даалгаварыг яс биелүүлсэн гэж боссдоо илтгэхийн тулд л ийшээ ирэв. Гэвч орцны зам руу эргэх үед хашаанаас хадах хүүхдүүдийн дууг сонсов. Тэгээд ч орцны зам дээр минивэн машин зогсоно. Линдагийнх гэдэг нь эргэлзээгүй. Хянах самбар дээр зөөдөг анивчуур харагдав. Хэдийгээр босс байцаалтын үед хэт хичээхгүй байхыг анхааруулсан ч түүнд олдсон ганц хүн нь Линда болохоор бүрэн хөтөлбөрийн дагуу шахаад өгөх хэрэгтэй гэж бодлоо. Түүнд таалагдах эсэх нь хамаагүй. Мэдээж таалагдахгүй л дээ. Эверетт түүний олоогүй бүх хүний төлөө хариуцах болно. Гэвч тэр ам нээж амжаагүй байтал Линда ярьж гарав. Зүгээр ярих ч биш, бүр гарнаас нь барьж аваад гэртээ шууд татаж оруулав.

-Та нар түүнийг олсон уу? Картер гуйя, Расти зүтээр үү? Хэрэв үгүй бол гээд Линда гараа унжуулж: -Хэрэв үгүй бол аяархан яриарай. Хүүхдүүд хашаанд байгаа. Тэд улам их хямраасай гэж би хүсэхгүй байна.

Картер түүний хажуугаар явж гал тогоонд ороод угаалтуур дээгүүр цонхоор харлаа.

-Энэ хиппи доктор энд юу хийж байгаа юм бэ?

-Тэр харж асардаг хүүхдүүдээ авчирсан юм. Өчигдөр орой Каро тэднийг хуралд дагуулж очоод тэгээд...түүнтэй юу болсоныг чи мэднэ.

Картер ийм чалчилтыг огт хүлээж байсангүй. Магадгүй тэр үнэхээр юу ч мэдэхгүй юм болов уу? Эсвэл түүнийг мэхлэх гээд байна уу? Нөгөө юм хийх гээд байна уу...за байз юу гэдэг билээ дээ...хамгаалах цохилт. Бүрэн боломжтой. Ухаантай. Нүдэнд шууд тусч байна. Түүний насны хүүхэн гэхэд хөөрхөн юм аа.

-Та нар түүнийг олсон уу? Барбара... гэх үед түүний хоолой жинхэнэ мэт чичирлээ. -Барбара түүнд хор хүргээгүй биз? Хаа нэгтээ зэрэмдэглээд хаячихаагүй биз дээ? Чи надад үнэнийг хэлж болно шүү.

Тэр цонхоор тусах нарны сүүмгэр гэрэлд бага зэрэг инээмсэглэн эргэж харав.

-Чи анхных нь.

-Юу гэнэ ээ?

-Чи анхных гэж би хэллээ. Чи надад үнэнийг хэл.

-Би нэг л юм мэднэ. Тэр шоронд байхгүй гэснээ мөр нь унжаад ирэв. -Чи ч бас түүний хаана байгааг мэдэхгүй юм байна. Чиний мэдэхгүй болохыг би харж байна. Хэрэв Барбара түүнийг алчихвал? Эсвэл түүнээс дор...

Картер Линдаг барьж аваад тосгоны бүжиг хийх гэж байгаа мэт цааш нь харуулаад мөрний үе начигнах хүртэл гарыг нь мушгилаа. Тэр үүнийг гайхалтай түргэн хийв. Ёолж ч амжсангүй.

Тэр мэдэж байна. Тэр мэдэж байгаа бөгөөд намайг өвтгөх гэж байна. Намайг тамлах болно. Би тэгэх хүртэл...

Картерын амьсгаа түүний чихийг төөнөв. Сахал нь Линдагийг хацрыг хатгалаа. Дургүй хүрч хамаг бие нь салгалав.

-Ээж гуай, миний тархийг битгий эргүүлээд бай. Уэттингтон та хоёр үргэлж хамтдаа, хөхөө нийлүүлээд зогсдог байсан. Тэгээд чи түүний танай нөхрийг шоронгоос гаргах зорилгыг мэдэхгүй байсан гэх гээд байгаа юм уу? Үүнийг чи надад хэлээд байна уу? гэж шивнэхээс арай чангаар асуулаа.

Тэр гарыг нь улам дээш татсан тул Линда хашгирахгүйн тулд уруулаа хазахад хүрлээ. Хүүхдүүд дэргэд байна. Жанни Терсээс улам сайн савлуулахыг гуйна. Хэрэв тэд гэрээс хадах хашгирааныг сонсвол...

-Хэрэв тэр надад хэлсэн бол би Рэндолфод хэлэх байсан. Миний нөхөр ямар ч буруугүй байтал би Растигийн амь насаар азаа үзнэ гэж чи бодож байна уу? Гэж хэлэнгээ Линда агаар

Стивен Кинг залгилна.

-Тэр буруутай. Тэр боссыг огцрохгүй бол эм өгөхгүй гэж сүрдүүлсэн. Энэ бол хараал идсэн айлган сүрдүүлэлт. Би өөрөө бүгдийг сонссон гээд гарыг нь улам чанга мушгихад Линдагийн уруулаас гаслах дуу гарлаа. -Ээж гуай, энэ сэдвээр хэлэх юм байна уу?

-Би Растиг хараагүй, түүнтэй яриагүй болохоор хаанаас мэдэх юм бэ? Гэхдээ энэ хотод анагаахад түүнээс илүү ойлгодог хүн байхгүй. Ренни Растиг хэзээ ч буудахгүй. Барбараг магадгүй. Растиг бол үтүй. Би үүнийг мэднэ. Чи ч гарцаагүй мэдэж байгаа. Харин одоо гар тавь.

Картер бараг тавих шахав. Тэр нээрээ бүхнийг зөв ярьж байлаа. Дараа нь түүний толгойд арай илүү санаа төрсөн тул Линдаг угаалтуур руу аваачлаа.

-Ээж гуай, тонгой.

-Үгүй.

Тэр дахиад гарнаас нь өргөлөө. Мөрний үеийн толгой хонхорхойноос мултарч байгааг тэр мэдрэв.

-Тонгой. Сайхан цайвар үсээ угаах гэж байгаа юм шиг.

-Линда. Чи тэнд ямархуу байна? гэж Терстон дуудав.

Есүс бүрхан минь, лаазалсан хүнсний талаар л бүү асуугаарай.

Тэр дороо толгойд өөр бодол орлоо. Хүүхдүүдийн эд юмс хаана байгаа вэ? Охин бүр нэг нэг жижиг цүнх бэлдсэн. Түүнийгээ гэнэт зочдын өрөөнд орхисон бол яах вэ?

-Бүх юм сайн гэж түүнд хэл хэмээн Картер шивнэв. -Бид хиппиг үүнд хутгахыг хүсэхгүй шүү дээ. Эсвэл хүүхдүүдийг. Хүсэхгүй тийм үү?

Бурхан минь үгүй. Гэхдээ тэдний цүнх хаана байна вэ?

-Бүх юм сайн гэж Линда хашгирлаа.

-Бараг дууссан уу? гэж Терс дараагийн асуултаа тавив.

Өө, Терс минь амаа хамхиач.

-Дахиад таван минут хэрэгтэй.

Терстон дахиад нэг юм асуух гэснээ болиод савлуур руу охид дээр эргэж очлоо.

-Сайн байна гээд тэр бүсгүй рүү налахад түүний өнөөх нь бослоо. Жинстэй өгзөг нь хатуурсан эрхтэнийг мэдэрлээ. Яг л дэлгэгддэг түлхүүр шиг том. Дараа нь Тибодо гэнэт холдов. -Юу бараг дууссан уу гэсэн бэ?

Линда өглөөний цай гэж хэлэх шахсанаа угаалтуур бохир

саваар дүүрнийг харав. Хэсэг зуур толгой нь хов хоосон боллоо. Тэр бүү хэл эрхтэнээ дахиад наагаасай гэж хүсэв. Яагаад гэвэл эр хүнийг өнөөхийнх нь жижигхэн толгой эзлэх юм бол том толгой тайван байдалд ордог.

Гэвч Картер дахиад гарнаас нь өргөлөө.

-Ээж гуай хэл. Аавдаа ханамж өг.

-Талх. Би талх хийхээр амласан юм. Хүүхдүүд гуйсан гэж тэр арай гэж хэллээ.

-Цахилгаангүй талх уу? Долоо хоногийн шилдэг наргиан уу? гээд тэр мушийн инээв.

-Жигнэх хэрэггүй талх. Зоорь руу шагай. Жингэрийн хүү минь.

Хэрэв тэр шагайсан бол тавиур дээрээс жигнэх хэрэггүйгээр шууд талх болдог овъёосны гурилын бэлдэцтэй хүүдий олох байсан. Гэхдээ мэдээж Картер доошоо харсан бол боож бэлдсэн хоёр цүнхийг ч харах байлаа. Тэгээд улам сайн харах юм бол зоорины тавиурууд хагас хоосон байхыг илрүүлэх байв.

-Чи түүний хаана байгааг мэдэхгүй юм уу? гэх үед түүний эрхтэн Линдад шахагдаж наалдав. Гэвч бүсгүйн гар аймшигтай өвдөж байсан болохоор тэр үүнийг мэдрэхгүй байлаа. -Чи итгэлтэй байна уу?

-Тиймээ. Чамайг мэдэж байгаа гэж бодсон. Түүнийг шархадсан юмуу эсвэл... энэ талаар хэлэх гэж ирж байна л гэж бодсон.

-Харин би чамайг хуурамч бас дур татсан бөгс гэж бодож байна гээд тэр гарыг улам чанга мушгихад өвдөлт тэсэж тэвчихийн аргагүй боллоо. Линда хашгирахгүй арай гэж л тэслээ. Гэхдээ л тэсч чадлаа. -Ээж гуай чи олон юм мэднэ гэж би бодоод байна. Хэрэв чи хэлэхгүй бол би чиний гарыг мөчнөөс нь суга татна. Сүүлчийн боломж өгье. Тэр хаана байна?

Гар юмуу мөрний хугаралт гарцаагүй гэдэгтэй Линда эвлэрлээ. Магадгүй аль аль нь хугарах байх. Ганц асуудал нь хашгирахгүй байж чадах эсэх л байв. Яагаад гэвэл хэрэв хашгирлаа гэхэд Терстон ч, бас хүүхдүүд ч гүйн ирнэ. Үс нь угаалтуур руу унжиж толгой бөхийсөн чигээр хариулав.

-Миний бөгсөнд байгаа. Чи түүнийг яагаад үнсэж болохгүй гэж муу зулбасага. Тэр тэндээс цухуйгаад чамтай мэндэлж мэдэх юм.

Түүний гарыг хугалахын оронд Картер инээлээ. Үнэхээр сайн хариуллаа. Тэгээд тэр түүнд итгэв. Хэрэв тэр худлаа ярьж байсан бол түүнтэй ингэж ярьж зүрхлэхгүй. Түүний жинстэй байгаад харамсах л үлдлээ. Түүнийг эдэлж болохгүй бололтой. Хэрэв тэр банзалтай байсан бол ч дуулгаваргүй хэсэгтэй нь арай дотно харьцаа тогтоох байсан юм. Гэхдээ л эмэгтэйн бөгсөнд хүрнэ гэдэг чинь Уулзалтын өдрийн тийм ч муу эхлэл биш шүү. Энэ бөгсийг зөөлөн дотоож биш хатуу жинс хаасан байлаа ч.

-Номхон зогсоод амаа хамхиж байгаарай гэж Картер санууллаа. -Тэгж чадвал чи бүрэн бүтэн үлдэж болох юм.

Тэр хэрхэн цахилгаанаа буулгахыг Линда мэдрэв. Дараа нь түүнд үрж гарлаа. Одоо тэднийг даавууны нингэн давхарга л тусгаарлаж байна. Линда бараг шинэхэн жинс өмссөндөө баярлаж түүнийг эрхтэнээ цус гартал нь үрнэ гэж найдлаа.

Охид маань орж ирээд намайг ийм байдалд битгий харчихаасай даа.

Гэнэт тэр улам хүчтэй наалддаа. Гарыг нь хугалах шахсан гар түүний хөхийг базаж байлаа.

-Оо-оо-оо гэж тэр уухилна.

Түүн дээр үрийн шингэн асгарахыг Линда мэдэрсэн ч шөнийн дараа өдөр ирдэг шиг үрийн шингэн гадашлахын араас гарцаагүй дагалддаг чийгийг мэдэрсэнгүй. Бурханы авралаар даавуу тун зузаан ажээ. Мөчийн дараа Картер түүний гарыг тавилаа. Линда сэтгэл хөнгөрсөндөө уйлж болохоор байсан ч уйлсангүй. Уйлах ч бодолгүй байв. Эргэж харлаа. Тэр өмдөө татаж байв.

-Талх хийхээсээ өмнө жинсээ солихгүй юу? Би чиний оронд байсан бол солино гээд Картер мөрөө хавчсанаа: -Гэвч хэн мэдэх билээ...чамд ийм нь таалагддаг ч юм бил үү? Хүн бүрт өөрийн гажиг бий.

-Чи тэгээд хуулийг ингэж хамгаалах гэж байгаа хэрэг үү? Ийм хууль танай боссод таалагдах уу?

-Тэр томоор сэтгэдэг хүн гээд Картер зоорь руу эргэхэд Линдагийн ойр ойрхон цохилох зүрх зогслоо. Тэр гэнэт цагаа харсанаа цахилгаанаа татав. -Хэрэв танай нөхөр чамтай холбоо барих юм бол ноён Ренни юмуу над руу утасдаарай. Энэ чиний хувьд хамгийн сайн зам шүү, надад итгэ. Хэрэв чи үүнийг хийгээгүйг би мэдэх юм бол дараагийн удаад юмаа хийх ёстой газар руу нь тултал хийх болно. Хүүхдүүдийн

хажууд байх эсэх хамаагүй. Надад үзэгчид саад болдоггүй. -Тэднийг ирээгүй дээр эндээс явж үз. -"Гуйя" гэж хэл дээ ээж гуай.

Линдагийн хоолой боогдсон ч удахгүй Терстон явахад бэлэн эсэхийг мэдэхээр гал тогоо руу шагайж таарна. -Гуйя.

Тэр хаалга руу хөдөлсөнөө дараа нь зочдын өрөө рүү шагайгаад зогтуслаа. Яагаад гэвэл цүнхнүүдийг олж харжээ. Ингэсэн гэдэгт Линда эргэлзсэнгүй.

Гэвч түүнийг өөр юм зогсоосон байж.

-Тэгээд бас чиний минивэнд байхыг харсан анивчуурыг өг. Хэрэв чи мартсан байгаа бол чамайг халчихсан шүү дээ.

19

Маршалл ба хүүхдүүд гурван минутын дараа орж ирэхэд Линда дээд давхарт байв. Хамгийн эхлээд хүүхдийн өрөө рүү шагайлаа. Хүүхдүүдийн цүнх орон дээр байна. Нэгнээс нь Жүдигийн чихмэл бамбарууш цухуйжээ.

-Хүүхдүүд ээ зурагтай ном үзэж бай. Би хэдэн минутын дараа бууж ирнэ гэж ттуошз §a1 (үргэлж хөгжилтэй байдаг) Линда хашгирав.

Маршалл шат руу очлоо.

-Бид үнэхээр явах цаг болчихлоо...

Тэр бүсгүйн нүүрийг харсанаа таг дуугүй болов. Линда гараар даллан дээшээ дуудлаа.

-Ээж ээ, хэрэв би бүгдтэй нь хуваана гэвэл сүүлчийн лааз пепсийг ууж болох уу гэж Жани хашгирав.

Линда ихэнхидээ хүүхдүүдэд эрт кола уухыг зөвшөөрдөггүй боловч энэ удаад дургүйцсэнгүй.

-Тэг, тэг. Гэхдээ битгий асгачихаарай.

Маршалл шатны дунд хүртэл өгслөө.

-Юу болсон бэ?

-Аяархан ярь. Ийшээ цагдаа ирсэн. Картер. -Өнөөх ханхар цээжтэй залуу юу?

-Тэр мөн. Намайг байцаахаар ирсэн... гэх үед Маршалл хувхай цайв. Мань хүн Линдад хашгирсан асуултаа саналаа гэдгийг ойлголоо. Тэр түүнийг ганцаараа гэж бодсон... -Би бүх юм сайн гэж бодож байна. Гэвч түүний яг явсан эсэхийг шалгаарай. Гудамжийг шалгаад хашааны завсар хөрш эдлэн рүү шагай. Харин би өмдөө солих хэрэгтэй.

-Тэр чамайг яасан бэ?

-Яагаа ч үгүй. Түүний явсан эсэхийг шалга. Хэрэв явсан бол бидэнд ч бас энд хийх юм алга гэж шивнэв.

20

Пайпер хайрцгийг тавиад хойшоо гэдийж хот руу нулимс цийлэгнэн гялалзах нүдээр харна. Тэр өчигдөр шөнө Байхгүйд зориулан уншсан бүх залбиралаа бодлоо. Одоо энэ бол хүүхдийн тэнэг тоглоом гэдгийг мэдэх болов. Гэтэл тоглоомын хэрэгсэл нь тэр өөрөө болчихсон нь тодорхой. Яагаад гэвэл тэнд Хэн-нэгэн байсан. Үнэндээ Бурхан бол биш.

-Та тэднийг харсан уу?

Пайпер давхийв. Дэргэд нь Норри зогсч байлаа. Тэр туржээ. Том болж байгаа учраас. Бас тэр хөөрхөн хүүхэн болон хувирч байгаад Пайпер эргэлзсэнгүй. Хэрэв хөвгүүд эргэн тойронд нь аль хэдийн эргэлдэж эхлээгүй байгаа бол тун удахгүй ингэх болно.

-Тийм ээ хонгор минь, харсан.

-Расти Барби хоёрын зөв үү? Биднийг хараад байгаа хүмүүс ердөө хүүхдүүд гэж үү?

Үүнийг мэдэхийн тулд өөрөө хүүхэд байх хэрэгтэй гэж Пайпер бодлоо.

-Хонгор минь би зуун хувь итгэлтэй биш байна. Чи өөрөө оролдоод үз.

Норри түүн рүү гөлрөн харав.

-Тийм үү?

Пайпер өөрийгөө зөв юм хийж байгаа эсэхийг мэдэхгүй боловч толгой дохиод: -Тийм.

-Хэрэв надтай... Би мэдэхгүй байна... Хэрэв би хачин үйлдэл хийвэл та намайг татаж авах уу?

-Тэгье. Гэхдээ өөрөө хүсэхгүй бол хийх ёсгүй. Би чамайг аз турш гэж гуйж байгаа юм биш.

Гэвч Норри сониуч занд автлаа. Тэр өндөр өвсөнд сөхрөн суугаад хайрцагны хоёр талаас зуурав. Цэнэг тэр дороо түүнийг цохилоо. Толгой нь хойшоо огцом гэдийхэд Пайпер сээр нь нужигнахыг сонсов. Охин руу гараа сунгаснаа доошоо буулгалаа. Яагаад гэвэл Норри аль хэдийн суларчээ. Эрүү нь цээж рүүгээ унжиж чанга аньсан байсан нүд нь нээгдэв. Алсыг чиглэсэн манантсан нүд.

-Тэд яагаад ийм юм хийж байгаа юм бэ? Яагаад? гэж тэр асуулаа.

Пайперийн гараар шоргоолж гүйх шиг боллоо.

-Хэлээд өгөөч гэх үед Норригийн нэг нүднээс нулимс урсаж хайрцаг дээр унаад шажигнаснаа алга болов.

-Хэлээд өгөөч гэснээ чив чимээгүй боллоо. Удаан чимээгүй байв. Дараа нь охин хайрцагийг тавиад түүнээс холдож бөгсөөрөө газарт унав. -Хүүхдүүд байна.

-Ягуу?

-Яг. Хэр олон болохыг хэлж мэдэхгүй. Тоо нь өөрчлөгдөөд байна. Тэд толгойдоо илгэн малгай өмсчээ. Тэд хэрэлдээд байна. Тэд хамгаалалтын шил зүүсэн бөгөөд хайрцаг руугаа харж байна. Хайрцаг нь зурагттай төстэй юм. Тэд бүтдийг, бүх хотыг харж байна.

-Чи яаж мэдсэн юм бэ?

Норри арчаагүй толгойгоо сэгсрээд:

-Бүү мэд. Гэвч мэдэж байна. Яг тийм. Тэд байнга хэрэлддэг муу хүүхдүүд. Би дахиад энэ хайрцагт гар хүрэхийг хүсэхгүй. Шавхайнд хөрвөөсөн мэт боллоо гээд тэр уйлав.

Пайпер түүнийг тэвэрлээ.

-Чамайг яагаад гэж асуухад тэд юу гэж хариулсан бэ?

-Юу ч хариулаагүй.

-Тэд чамайг сонссон болов уу?

-Тэд сонссон. Тэд биднийг нулимаж байна.

Араас сэнсний тачигнах дуу гарч хором тутамд чангарав. Хоёр тээвэрлэгч нисдэг тэрэг Ти-Эр-Р-ээс Бүрхүүл рүү түрсэн моддыг шүргэх шахан умар зүгээс айсуу.

-Тэд Бүрхүүлийг санамаар юм даа. Өнөөх онгоц шиг мөргөх вий гэж Норри санаа зовов.

Нисдэг тэрэгнүүд мөргөсөнгүй. Тэднээс хоёр милийн зайд аюулгүйн бүсэд агаарт тогтсоноо доошилж эхэллээ.

Кокс Барбид Маккойн алимны цэцэрлэгээс Ти-Эр-90-ийн хил рүү сунасан хөдөөгийн замыг зааж өгсөн бөгөөд түүгээр явж болох мэт. Баасан гаригийн өглөөний 7 цаг 30 минутын орчимд Барби, Расти, Ромми, Жулия ба Пит нар ийм оролдлого хийв. Барби 200 мл-ийн өндөрөөс авсан ойн замын зурагт биш харин Коксод итгэж байлаа. Тиймээс тэд Том Жимийн

зогсоолоос Эрнигийн хулгайлсан микроавтобусаар явав.

Хэрэв энэ машин эвдрэх юмуу суулаа гэхэд Барби огтхон ч харамсахгүй байсан.

Пит харин бүр түрүүнд гэрэл зургийн аппаратгүй болсон юм. Хайрцагт дөхөж очих үеэр түүний тоон "Никон" ажиллахаа больчихсон.

"Харь гаригийнхан папарацид дургүй юм байна дүү минь" гэж Барби тайлбарлав. Уг нь Питийг инээлгэнэ гэж тооцсон ч өнөөх нь гэрэл зургийн аппаратын тал дээр бол хошин мэдрэмж огт үгүй.

Харилцааны компанийн микроавтобус тэднийг бүрхүүлд эсэн мэнд хүргэж ирлээ. Одоо тэд тавуулаа аварга том нисдэг тэрэгнүүд Ти-Эр-90-ийн талаас ойртохыг харна. Зам цааш одсон тул "чинук"-ын сэнснүүд шороон үүл босгов. Барби ба бусад нь нүдээ хаасан боловч энэ нь зөвхөн дадлын үйлдэл бөгөөд ямар ч шаардлагагүй ажил. Тэднийг чиглэсэн шороо тоос Бүрхүүлд хүрэнгүүтээ тал тал тийш бутарна.

Нисдэг тэрэг яг л бөгсөнд нь арай багадсан театрын сандал дээр суух тарган хатагтай нар шиг ихэмсэгээр бууж ирэв. Төвгөр хад пгүргэсэн металлын чөтгөрийн мэт хяхрааныг Барби сонслоо. Зүүн талын нисдэг тэрэг дахин буух оролдлого хийхийн өмнө гучин ярд хажуу тийш байраа сэлгэв.

Онгойсон нээлхийнээс нэгэн эрэгтэй үсэрч буугаад тоосыг гараар хөөнгөө шороон үүлэн дундуур том том алхлаа. Барби түүнийг шууд танив. Тоос шороо саад болсонгүй. Кокс Бүрхүүлд ойртож ирээд хурдаа хасч, харанхуйд саад хайн тэмтчих сохор хүн шиг гараа урдаа сунгав. Дараа нь дахиад л шороо үргээлээ.

-Хурандаа Барбара, таныг эрх чөлөөний агаар амьсгалж байгааг харахад таатай байна.

-Тийм ээ ноёнтон.

Кокс харцаа сэлгээд

-Сайн уу? Хатагтай Шамуэй. Барбарагийн бусад найз нарт мэнд. Би бүхнийг сонсмоор байна. Гэвч яарах хэрэгтэй. Хотын нөгөө талд удахгүй бяцхан шоу эхэлнэ. Би түүнд амжиж очих ёстой.

Кокс гараар арагшаа заахад тэнд цахилгаан үүсгүүртэй холбогдсон хэдэн арван "Эр Макс" сэнснүүдийг буулгаж байлаа. Том сэнснүүд байна гэж Барби сэтгэл хөнгөрөн бодов. Хүчтэй борооны дараа морин тойруулгын талбай юмуу газрын теннисний тавцанг ийм сэнсээр хатаадаг. Сэнс бүр хоёр

дугуйтай тэргэнцэр дээр байрлажээ. Цахилгаан үүсгүүрийн чадлыг хараад байхад дээд тал нь хорин морины хүчтэй. Энэ хангалттай гэж Барби найдав.

-Юуны өмнө сэнс хэрэг болохгүй гэж надад хэлэхийг би хүсч байна.

-Би ян тан мэдэхгүй. Гэхдээ хэрэг болж мэднэ гэж айх юм. Та нар хотынхон хамаатан садантайгаа уулзах 119-р зам дээр сэнс аваачих хэрэг гарах байх.

-Орой болно. Түүнээс эрт амжихгүй.

-Заримыг нь эндээс ав. Хэрэв тэд бүтд бидэнд хэрэг болох юм бол бид тэгсэн тэгээгүй бүрэн дуусна.

-Үгүй дээ. Бид эндээс авахгүй хүү минь. Хэрэв бид Честерс-Миллийн агаарын орон зайд шууд нислэг хийж болох байсан бол тэгэх байсан. Гэвч тийм боломжтой байсан бол ерөөсөө ямар ч асуудалгүй байх байсан үнэн үү? Тэгээд ч хэрэв бид эдгээр үйлдвэрийн сэнсийг зочид ирэх газарт тавих юм бол арга хэмжээ ямар ч утгагүй болно. Хэн ч юу ч сонсохгүй. Эд нар дэндүү их чимээтэй гээд Кокс цагаа харсанаа: -Ингэхэд та нар 15 минутанд хэр их юм ярьж амжих вэ? гэлээ.

Хэллоуин эрт ирлээ

1

Долоон цаг 44 минутанд Линдагийн бараг шинээрээ ногоон өнгийн "хонда-одиссей" машин "Берпигийн их дэлгүүр"-ийн арын ачих буулгах тавцан дээр ирэв. Жолоочийн хажуугийн сандалд Маршалл сууна. Хүүхдүүд (хотоос гарч аялах гэж байгаа гэхэд дэндүү нам гүм) ард сууцгаажээ. Эйден Одригийн толгойг тэвэрнэ. Нохой тэр хүүхдийн түтшүүрийг мэдэрсэн бололтой тэвчээртэй хэвтэнэ.

Линда гурван давхар аспирын уусан боловч мөр нь урьдын адил лугшин өвдсөөр байлаа. Түүний санаанд Картерийн царай үе үе орж ирнэ. Эсвэл хөлс ба үнэртэй ус холилдсон түүний үнэр хамарт мэдрэгдэнэ. Ард нь гэнэт Картерын жолоодсон цагдаагийн машин гарч ирээд ухрах зам хаана гэж тэр цаг үргэлж хүлээсээр байв. Дараагийн удаад би чамд хийх ёстой газар руу нь тултал нь зооно, хүүхэд байх эсэх хамаагүй.

Тэр үүнийг хийх байсан. Ямар ч асуудалгүй. Тэр хотоос бүр явж чадахгүй гэлээ ч Том Жимийн энэ шинэхэн Баасангаас аль болох хол зайтай байхыг хүснэ.

Линда Маршалл руу эргэлээ.

-Бүх хуйлаастай зүйлийг төмрийн хайчтай нь ав. Алхны хайрцаг дотор байгаа. Расти тэгж хэлсэн юм.

Маршалл хаалгаа нээснээ гэнэт хөшив.

-Би үүнийг хийж чадахгүй. Дараа нь өөр хэн нэгэнд хэрэг болбол яах вэ?

Линда маргасангүй. Тэр хүүхдүүдийг айлган түүн рүү хашгирахад бэлэн байлаа.

-Хүссэн юмаа хий. Зөвхөн хурдал. Бид энд занганд байгаа юм шиг л байна.

-Бүхнийг чадах чинээгээр хурдан хий.

Гэвч тэр тугалган хавтас хайчлахад бүхэл бүтэн зуун болох шиг санагдаж Линда цонхоор цухуйн "Чи төрөлхийн сааталтай юмуу эсвэл том болоод ийм болчихсон юмуу" гэж асуумаар санагдахад арай ядан биеэ барьж байв.

Дуугүй бай. Тэр дөнгөж өчигдөр хайртай хүнээ алдсан.

Тийм ээ, хэрэв хурдлахгүй бол Линда ч бас бүхнийг алдаж мэдэхээр байв. Төв гудамжинд 119-р зам ба Динсморын сүүний ферм рүү чиглэж, эртхэн сайн байрлал авахыг хүссэн хүмүүс аль хэдийн гарчээ. Цагдаагийн чанга яригч сонсох бүртээ Линда давхийн цочиж байв.

-Замаар машин явахыг хориглосон. Хэрэв та өвчтөн биш бол явган явах ёстой.

Картерт ямар нэг юм шиншлэх ухаан бий. Тэр гэнэт эргэж ирээд машин байхгүйг илрүүлбэл яах вэ? Линдаг хайхаар хаашаа явах бол?

Тэр хооронд Маршалл хуйлаастай тугалган туузанаас хавтан хайлчилсаар байв. Эргэхээр нь Линда дууслаа гэж бодсон ч үгүй байжээ. Цонхны шилийг нүдээрээ хэмжиж байгаа нь тэр аж. Дахиад тууз хайчлав. Магадгүй түүнийг галзууруулах гээд байна уу? Тэнэг санаа. Гэвч нэг толгойнд орчихоод гарахыг огт хүсэхгүй байна.

Картер түүний бөгсөнд хэрхэн үрсэнийг Линда өөрийн эрхгүй санав. Хацар дээр нь түүний сахал хатгасныг. Түүний хөхийг базах хуруунуудыг. Уг нь тэр жинсээ тайлахдаа дээр нь наалдаж үлдсэн зүйлийг бүү хар гэж өөртөө тушаасан. Гэвч яаж ч чадсангүй. Толгойд нь "эр хүний шүлс" гэсэн санаа харвахад өглөөний цайгаа ходоодондоо үлдээхийн тулд богино боловч хурц тэмцэл хийхэд хүрч билээ. Хэрэв үлдээж чадаагүй бол Картер баярлах байсан даа.

Линдагийн духан дээр хөлс бурзайлаа.

-Ээж ээ гэх Жүдигийн дуу чихэн дээр нь тасхийхэд Линда өөрийн эрхгүй хашгирав. - Уучлаарай ээж ээ би таныг айлгахыг хүсээгүй. Би ямар нэг юм идэж болох уу?

-Одоохондоо үгүй.

-Энэ хүн яагаад ийм чанга яриад байгаа юм бэ? -Хонгор минь би чамтай ярьж чадахгүй. -Та гунигтай байна уу? -Тийм, бага зэрэг. Харин одоо байрандаа суу. -Бид аав дээрээ очих уу?

-Тийм. Одоо суу гэснээ дотроо хэрэв биднийг барихгүй бөгөөд намайг бүгдийн нүдэн дээр хүчиндэхгүй бол гэж бодов.

Маршалл арай гэж машин руу ирлээ. Бяцхан ч гэсэн энэ баяр хөөрийн төлөө бурханд талархая. Тэр бараг танк бүрж хүрэхээр олон дөрвөлжин болоод тэг дөрвөлжин хавтангууд чирнэ.

-Харж байна уу? Аль хэдийн бэлэн... пөөх баас. Хүүхдүүд инээлдэхэд энэ дуу Линдагийн толгойд ууртай жингэнэх мэт сонсогдов.

-Ноён Маршалл та хараалын хадгаламжинд хорин тавыг нэмлээ гэж Жанни хашгирлаа.

Маршалл ичингүйрэн толгойгоо унжуулав. Тэгснээ бүсэндээ хавчуулсан хайчийг олж хараад:

-Би түүнийг байсан газарт нь хайрцаг дор буцааж...

Түүнийг ярьж дуусаагүй байхад Линда хайчийг шүүрлээ. Хотгор цээж рүү нь хайчаар хатгах хүслээ арай ядан барив. Миний биеэ барих чадвар гайхамшигтай юм гэж бодоод байсан газарт нь тавихаар машинаас буулаа.

Яг энэ үед өөр нэг машин дөхөн ирж энэ мухраас гарах ганц зам болох Баруун гудамжийг хааж зогсов.

Төв гудамжны дэргэдэх хотын талбайн хажууд, толгойн орой дээр Жим Реннигийн "хаммер" зогсоно. Хөдөлгүүр сул ажиллана. Тэр дор чанга яригчаар зөвхөн тахир дутуу хүмүүс машинаар явж болно хэмээн сануулж байна. Хүмүүс явган хүний замаар явах ба олонхи нь нуруундаа үүргэвчтэй ажээ. Том Жим тэднийг жигшин зэвүүцсэн төрхтэйгээр харна. Ахмадыг асрах газарт хүнийг энэрэх хайраар бус харин үүргийнхээ дагуу сууж байгаа асрагчид л ийм царайтай байдаг.

Урсгалын эсрэг ганцхан Картер алхана. Тэр замын голоор том том алхах бөгөөд замд таарсан хүмүүсийг түлхэнэ. Тэр "хаммер" машин дээр ирж зорчигчийн сандал дээр суугаад хөлсөө арчив.

-Ёо ёо. Хөргүүр гэдэг чинь ганц хэрэгтэй юм байна. Өглөөний найман цаг ч болоогүй байхад агаарын дулаан 30 хэмээс багагүй байна. Агаар яг үнсний сав шиг үнэртэж байна. Ингэж хэлсэнд уучлаарай босс.

-Чамд аз завшаан инээд хайрлав уу?

-Тэгсэн болоосой.

-Сайрхаж ярих юм алга уу?

-Тийм гэхээс илүүтэй үгүй. Би цагдаа Эвереттэй ярьсан. Цагдаа байсан. Бусад нь алга болчихож. -Тэр ямар нэг юм мэдэж байна уу?

-Үгүй. Эмч түүнтэй холбоо бариагүй. Жекки ч түүнтэй мөөг шиг харьцаж байжээ. Харанхуйд байлгаад баасаар борддог.

-Чи итгэлтэй байна уу?

-Тийм.

-Хүүхдүүд нь хамт байна уу?

-Тийм. Хиппи бас тэнд байна. Таны зүрхийг эмчилсэн хүн. Бас Жижгээ Френки хоёрын цөөрмийн дэргэдээс олсон хоёр хүүхэд. Түүний хүүхнийг алчихсан. Нөгөөгийн нөхөр нь зугтчихсан. Энэ долоо хоногийн сүүл гэхэд Линда тэр хоёр туулай шиг л ноололдох байх. Хэрэв та намайг дахиад тэднийд оч гэвэл би дуртайяа очно.

Том Жим жолооноос гараа авалгүй ганц хуруугаа гозойлгон ганхуулсан нь үгүй шаардлагагүй гэсэн үг. Одоо тэр шал өөр юм анхаарч байв.

-Картер тэднийг хараач.

Тэр харахгүй байж чадсангүй. Хүмүүсийн урсгал минут тутамд өтгөрч байлаа.

-Тэдний олонхи нь 9 цаг гэхэд Бүрхүүлд хүрнэ. Харин шалчгар хамаатнууц нь 10-д ирнэ. Хамгийн эртдээ. Тэгэхэд тэд ядраад ам нь цангах болно. Үд дунд гэхэд ус авчрах ухаан ороогүй хүмүүс нь Динсморын цөөрмөөс үнээний шээс уух болно. Бурхан тэдэнд хайртай. Бурхан хайртай байх ёстой. Яагаад гэвэл хүмүүсийн олонхи нь ажил хийж чадахааргүй тэнэг. Хулгай хийж чадахааргүй хулчгар байдаг.

Картер тачигнатал инээв.

-Бид ийм л хүмүүстэй харьцах болно. Бөөгнөрөл. Булвал таарах шаарнууд. Тэдэнд юу хэрэгтэй юм бэ Картер? гэж Ренни үргэлжлүүлэв.

-Босс би мэдэхгүй.

-Мэдээж чи мэдэхгүй. Тэдэнд хоол хүнс, Опрагийн шоу, кантри хөгжим, нар жаргахаар өнөө ажлаа хийх дулаан ор л хэрэгтэй. Тэгээд яг өөрсөд шигээ юмсыг үйлдвэрлэнэ. Чи хар даа. Энэ омгийн бас нэг төлөөлөгч явж байна.

Рэндолф дарга толгой руу өгсөх ба час улаан нүүрээ амны алчуураар арчина.

Том Жим дөнгөж ам халж байв. Тэр лекц унших тун дуртай.

-Картер минь, бидний ажил бол тэднийг халамжлах. Бидэнд энэ таалагдахгүй байж болно. Тэд халамжлуулах ёстой хүмүүс гэж бид дандаа бодоод байдаггүй. Гэвч бурхан бидэнд хайрласан ажлыг хийх л болно. Гэхдээ энэ ажлыг хийхийн тулд юуны өмнө бид өөрсдийгөө халамжлах ёстой. Тийм ч учраас "Хүнсний ертөнц"-өөс шинэ жимс ногооны багагүй хэсгийг хоёр хоногийн өмнө хотын захиргаанд аваачсан. Чи үүнийг мэдээгүй тийм үү? Тийм байх ёстой. Чи бүхнээс нэг алхамын өмнө. Харин би чамаас нэг алхамын өмнө. Цаашид ч ийм байх болно. Сургаал нь энгийн. Өөртөө тусалдаг хүнд л бурхан тусалдаг юм. -Тийм ээ, ноёнтон.

Рэндолф ирлээ. Тэр хүндээр амьсгалах бөгөөд нүдэн дор нь хүүдий үүсчээ. Бүр турчихсан ч юм шиг. Том Жим товчийг дарж шилээ буулгав.

-Дарга суу. Хөргөөсөн агаар амьсгал гээд Рэндолф урд талын зорчигчийн сандал руу хөдлөхөд нь Том Жим: -Тэнд биш ээ, тэнд Картер сууж байгаа. Арын сандалд суу гээд инээлээ.

"Одиссей" минивэн рүү цагдаагийн машин биш харин эмнэлгийн түргэн тусламжийн тэрэг иржээ. Жолооны ард Дуги Твитчел сууна. Жинни гартаа унтаж байгаа хүүхэд тэврээд хажууд нь суусан байв. Арын хаалганууд нээгдэхэд Жина сувилагчийн цагаан халаттайгаа газарт үсрэн буув. Түүний араас "Америкийн Олимпийн үнсэлтийн баг" гэсэн бичигтэй цамц ба жинсэн өмдтэй Гарриет бууж ирлээ.

-Юу вэ?... юу вэ? гэхээс өөр үг Линда хэлж чадсангүй. Толгойд нь цус хөөрснөөс чихний

хэнгэрэг хагарах шахав.

-Расти бидэн рүү утасдаад Блэк-Риджийн алимны цэцэрлэгт ирэхийг тушаасан. Би тэнд алимны цэцэрлэг байдгийг ч мэдэхгүй. Харин Жинни мэддэг юм байна. Линда яасан бэ? Хонгор минь чи цаас шиг цагаан болчихлоо? гэж Дуги ярина.

-Би зүгээр ээ гэж хэлэх үедээ Линда ухаан алдахын ирмэг дээр байгаагаа ухаарав. Дараа нь чихнээсээ чимхлээ. Расти түүнд энэ аргыг аль эрт зааж өгсөн. Түүний ардын уламжлалт олон аргын адил үр дүнгээ өгөв. Линда дахин ярьж эхлэхэд дуу нь жигд, хэвийн болсон байлаа.

-Та нарт эхлээд наашаа ирэх хэрэгтэй гэж тэр хэлээ юу?

-Тийм. Үүнийг ав гэсэн гээд ачих буулгах тавцан дээр байгаа хуйлаастай тугалган туузыг заав.

-Аюулгүй байдлын үүднээс. Тэр ингэж хэлсэн. Би цонхонд зориулж хавган хайчлах хэрэгтэй.

-Дуги ахаа гэж Жанни хашгираад тэврүүлэхээр ухасхийв.

-Барын зулзлага минь ямархуу байна? гээд охиныг тэвэрч агаарт эргүүлээд газарт буулгав. Жанни цонхоор жаахан хүүхдийг харна.

-Түүнийг хэн гэдэг юм бэ?

-Литл Уолтер гэдэг хэмээн Жинни хариулав.

-Мундаг.

-Жинни хурдан машинд суу. Бид хөдлөх ёстой гэж Линда тушаалаа.

-Тэгээд мухлагт хэн үлдсэн юм бэ? гэж Терс асуув. Жинни ичингүйрлээ.

-Хэн ч байхгүй. Гэхдээ Расти байнга арчилгаа шаардах хэн ч байхгүй бол санаа зовох зүйлгүй гэсэн. Уолтераас өөр тийм хүн байсангүй. Түүнийг аваад гарч ирлээ. Бид эргэж ирэх болно гэж Твитч хэлсэн.

-Хэн нэгэн ирэх хэрэгтэй байх гэж Терс гутранги хэлэв. Одоо Терсийг гутрал орхихоо больсоныг Линда анзаарлаа. -Хотын гуравны нэг нь 119-р замаар Бүрхүүл рүү явж байна. Агаар муу, бас эхний автобусууд ирэх 10 цаг гэхэд агаарын хэм дахиад арваар нэмэгдэнэ. Ренни ба түүний дагалдагсад нарнаас нуугдах ямар нэг юм босгож байгаа талаар би сонсоогүй. Нар жаргахад Честерс-Миллд өвчтэй хүн олон болно. Хэрэв наршсан юмуу багтраа өвчин хөдөлсөн хүмүүс ирвэл аз. Гэтэл зүрхний шигдээс хэд хэд ирж мэднэ.

-Эсвэл бид буцах хэрэгтэй юм уу? Би живж байгаа онгоцноос зугтдаг харх шиг санагдаад байна гэж Жина хэлэв.

-Үгүй гэж Линда огцом хариулахад бүгд тэр бүү хэл Одри хүртэл түүн рүү харлаа. -Ямар нэг муу юм болж мэднэ гэж Расти хэлсэн. Өнөөдөр биш байж болно... Гэхдээ тохиолдоно.

Тиймээс түргэний тэрэгний цонхонд зориулан тугалган хавтан хайчлаад явцгаая. Би та нарыг хүлээж чадахгүй. Реннигийн дээрэмчдийн нэг нь өглөө ирсэн. Хэрэв тэр дахин ирээд миний машин байхгүйг харвал...

-Мэдээж явж бай. Би ухраад чамайг гаргая. Төв зам руу битгий ороорой. Тэнд аль хэдийн бөглөрөл үүссэн гэж Твитч яаран хэллээ.

-Төв гудамжаар, цагдаагийн газрын хажуугаар уу? Тэр ёстой үгүй шүү. Баярлалаа. Ээжийн такси баруун гудамжаар явна гэж Линда давхийн хариулав.

Твитч түргэний жолооны ард суухад хоёр залуу сувилагч ачаа руу орлоо. Жина Линдаг эргэлзэнгүй харсаар үлдэв.

Линда унтаж байгаа хөлстэй хүүхдийг өнгийн хараад дараа нь Жиннитэй харц тулгарав.

-Орой Твитч та хоёр эмнэлэг рүү буцсан нь дээр байх. Юу болж байгааг үзэхээр. Нортчестерт байсан гэх юмуу нэг тиймэрхүү тайлбар хэлээрэй. Ямар ч тохиолдолд Блэк-Риджийн тухай юу ч битгий яриарай.

-Ойлголоо.

Хэлэхэд амархан. Хэрэв Картер чамайг толгойгоор чинь угаалтуур руу хийвэл хүндрэл үүсч мэднэ гэж Линда бодлоо.

Тэр Одриг машин руу түлхээд хажуугийн хаалгаа хааж жолооны ард суув.

-Эндээс явцгаая. Армид алба хаахаас зайлсхийхийг оролдсон тэр цагаас хойш ийм айдаст авгаж байсангүй гэж Терс хэлээд түүний дэргэд суулаа.

-Сайн байна. Тэгвэл шалтгаан байгаа л юм байна. Айдас бол хамгийн сайн манаач гээд Линда толгой дохив.

Машин ухарч түргэний тэргийг тойроод Баруун гудамж руу давхилаа.

4

-Жим ээ би энэ довтолгооны тухай бодоод байна гэж Рэндолф "хаммер"-ын арын суудлаас дуугарав.

-Сайн байна. Тэгээд бидэнтэй санаагаа хуваалцаж яагаад болохгүй гэж Питер ээ?

-Би цагдаагийн дарга хүн. Хэрэв Динсморын фермийн дэргэд цугласан хүмүүсийг эмх журамтай байлгах юмуу эсвэл зэвсэглэсэн хар тамхичид хуулиар хориотой газрыг хамгаалах гэж оролдож мэдэх хар тамхи үтшдвэрлэлийн лаборатори руу хийх довтолгооныг удирдахын аль нэгийг сонгох хэрэг гарвал... Юу гэхэв дээ. Миний хүлээсэн үүрэг надаас юу шаардаж байгааг би мэднэ. Ингэж хэлье.

Эсэргүүцэх хүсэлгүй байгаагаа Том Жим гэнэт ойлгов. Тэнэгүүдтэй ямар нэг юм хэлэлцэх нь дэмий хөдөлмөр. Радиостанц дээр ямар зэвсэг хадгалагдаж мэдэх талаар Рэндолф ойлголт байсангүй. Үнэнийг хэлэхэд Том Жим өөрөө ч мэдэхгүй. (Буши нууц данс ашиглан юу ч захиалсан юм билээ) Гэхдээ тэр ядаж л мууг төсөөлж чадах байв. Харин энэ дүрэмт хувцастай цацагт хяруулаас оюуны баатарлагийг хүлээх хэрэг байхгүй. Хэрэв Рэндолфтой ямар нэг юм учирвал... гэвч тэр дотроо шийдсэн биш гэж үү? Картер илүү ирээдүйтэй нөхөөс гэж.

-Тэг дээ Пит. Би чиний болоод үүргийн чинь дундуур орж зогсохыг хүсэхгүй. Чи шинэ удирдагч, Дентон чиний орлогч. Энэ болох уу?

-Бүх юм ёсоор болно гэж хэлэхдээ Рэндолф бардамнан хөөв. Яг л донгодох гэж байгаа тарган азарган тахиа шиг харагдана. Наргианы мэдрэмжээрээ гайхуулж чадахгүй Том Жим хүртэл инээдээ арай гэж барьлаа.

-Тэгвэл цагдаагийн газарт очоод багаа бүрдүүл. Хотын ачааны тэрэгнүүдийг санаж байна уу?

-Мэдээж. Бид үд дунд цохилт өгнө гээд тэр агаарт нударгаар дэлсэв.

-Радиостанц руу ойгоор очоорой.

-Жим ээ, би яг энэ талаар чамтай ярихыг хүссэн юм. Энэ дэндүү хэцүү зам юм биш үү? Радиостанцын эргэн тойрны ой их өгтөн. Тэнд хортой ороонги өвс олон... хортой царс нь бүр долоон дор...

-Тэнд мод тээвэрлэх зам бий. Чи тэр замыг ашигла. Араас нь цохь гэж Том Жим тэвчээр алдаж эхлэв. -Гэхдээ...

-Толгойдоо сум зоолгох нь хортой ороонги өвснөөс хамаагүй дор. Пит чамтай ярихад таатай байлаа. Чиний иймийг харахад баяртай байна... -Ийм гэдэг чинь юуг хэлээд байна вэ? Ингэхэд тэр ер нь ямар хүн бэ? Маадгар уу? Тэнэг үү? Эсвэл усан тэнэг үү? гэж дотроо бодох хооронд Картер үг хавчууллаа.

-Жинхэнэ багийн тоглогч.

-Картер баярлалаа. Чи яг хэлэн дээрээс үг шүүрлээ. Генри Моррисонд хэлээрэй. Одоо 119-р зам дээрх эмх журмыг тэр хариуцна. Мод тээвэрлэх замыг ашигла.

-Би үнэхээр бодохдоо...

-Картер түүнд хаалга нээж өг.

-Бурхан минь гэж Линда хашгираад жолоогоо зүүн тийш мушгив. Машин уулзвараас зуун ярд хүрэхгүй зайд хажуугийн хашлага чулуу руу үсэрч гарлаа. Машин хашлага дээр ойход гурван охин инээлдсэн ба ганцхан Эйдений царайд түтшүүр тодров. Тэгээд Одригийн ноолуулж

дууссан толгойг дахин шүүрлээ.

-Юу вэ? Одоо яах юм бэ? гэж Терс уурсав.

Линда том царс модны ард хэн нэгний эддэнгийн зүлгэн дээр зогсчээ. Гэхдээ түүний машин ч чамгүй том хэмжээтэй. Мод бараг навчгүй аж. Машин далдлагдсан гэж итгэхийг хүссэн ч бүтсэнгүй.

-Чөтгөр, уулзварын дэргэд Жим Реннигийн "хаммер" зогсож байна.

-Чи хүчтэй хараал хэллээ. Хараалын хадгаламжинд хоёр ширхэг хорин тавт гэж Жүди дуугарав.

Терс хүзүүгээ сунгаад: -Чи итгэлтэй байна уу?

-Манай хотод ийм том машинтай өөр хүн байгаа гэж бодов

уу?

-Бурхан минь гэж Терстон дуугарлаа. -Хараалын хадгаламж гэж Жүди Жанни хоёрын дуу нийлэв.

Ам нь хатахыг Линда мэдэрлээ. Хэл нь тагнайндаа наалдав. "Хаммер"-аас Картер гарч ирлээ. Тэр урд талын сандалд сууж байжээ. Хэрэв тэр тэдний зүт харсан бол...

Хэрэв тэр биднийг олж харвал би түүнийг няц дайрна. Энэ санаа яагаад ч юм түүнийг шууд тайвшруулав.

Картер арын хаалга нээхэд Рэндолф гарч ирлээ.

-Энэ хүн өмднийхөө цаанаас өөрийгөө дугтарч байна гэж Элис бусаддаа хэлэв. -Энэ нь хүндээр бие засахыг хүсч байна гэсэн үг гэж ээж хэлсэн.

Терстон Маршалл инээхэд одоо мөд инээж чадахгүй гэж бодож байсан Линда ч нэгдэв. Бүгд инээлддээ. Тэр бүү хэл яг юунд инээгээд байгааг мэдэхгүй Эйден ч инээв. Линда өөрөө ч сайн ойлгохгүй байлаа.

Рэндолф урьдын адил дүрэмт өмдөө татсаар толгой руу хоёр хөлөөрөө уруудав. Уг нь инээх юмгүй мэт. Тийм учраас л инээдтэй харагдсан юм байх.

Одри ч хоцрохгүйг хичээн хуцлаа.

Хаа нэгтээ нохой хуцав. Том Жим сонссон боловч толгойгоо эргүүлсэнгүй. Рэндолф доошоо уруудан алхахыг дүүрэн сэтгэл ханамжтай ажиглана.

-Тэр бөгснийхөө завсараас өмдөө татаж гаргахыг хар. Манай эцэг энэ үед жорлон орох болжээ гэдэгсэн гэж Картер хэллээ.

-Рэндолфын очих ганцхан газар нь ХБЭ. Нэгэнт тэр нүүрнээс нь довтлохыг хүсч байгаа учир тэр өөр хаашаа ч явахгүй. Хотын захиргаа руу явцгаая. Энэ циркийг зурагтаар жаахан харъя. Тэгээд залхах үед чи өнөөх хиппи эмчийг олоорой. Түүнд хаашаа ч зугтах гэж санаархах хэрэггүй гэж хэл. Бид түүнийг олоод шоронд суулгана.

-Ойлголоо ноёнтон гэж Картер ийм даалгаврыг дуртайяа зөвшөөрөв. Цагдаа асан Эверетт түүний гарт дахин орж мэднэ. Энэ удаад өмдийг нь заавал шувтлана.

Том Жим араагаа залгаж "хаммер" зам чөлөөлөхийг яарахгүй хүмүүсийг чагнаалаар тарааж хөөсөөр аажуухан уруудав.

"Хаммер" хотын захиргаа руу эргэнгүүт Линдагийн машин уулзвар дээр үсрэн гарч ирээд хотын төвөөс улам холдон урагш давхилаа. Энд явган хүн бараг байхгүй тул Линда хаазны гишгүүрийг шал руу улам хүчтэй жийнэ. Терс "Автобусын дугуй" дуулж эхлэхэд удалгүй бүх хүүхдүүд хамтдаа дуулав.

Хэсэг хугацааны дараа Линда ч дуулж эхэллээ. Урагш ахихын хэрээр айдас багасч байв.

7

Честерс-Милл хотод уулзалтын өдөр ирлээ. Дөнгөж тавхан хоногийн өмнө Жо-гийн зохион байгуулсан жагсаал эвгүйгээр дууссан Динсморын ферм рүү 119-р гудамжаар алхах хүмүүс баяр хөөрт автжээ. Тэд найдвараар дүүрэн байв. Хэдийгээр агаар өмхий, гадаа халуун бөгөөд тэрхүү жагсаалын тухай хүнд дурсамж хэвээр байсан ч хүмүүс найдвараар амьсгална. Бүрхүүл бохирдлоор хучигдсан тул моддын дээрх тэнгэр бүрхэг, тэнгэрийн хаяа бүүдгэр харагдана. Урдах замаа харсан нь дээр. Гэвч ингэлээ гээд ч бүх юм хэвийн биш. Цэнхэр өнгө шар туяатай болсон нь яг л хөгшин хүний нүдэнд цэгээ унасан мэт.

-Далаад онд цаасны үйлдвэрүүд бүрэн хүчин чадлаараа ажиллаж байх үед тэнгэр ийм байсан гэж Генриетта Клавар ярина. Тийм ээ, өнөөх өгзөгөө гэмтээсэн ч ахар сүүлээ хугалаагүй эмгэн. Тэр нэг лонх гааны ундааг дэргэдээ алхаж яваа Петра Сирлсд санал болгов.

-Үгүй баярлалаа. Би ус авчихсан.

-Дээр нь архи нэмсэн юмуу? Минийх бол нэмсэн. Тавь тавийн харьцаатай. Би энэ коктейльдоо "Канадын дарин пуужин" гэсэн нэр өгсөн.

Петра лонхыг авч сэтгэлээсээ залгилав. -Сайхан орлоо.

Генриетта ажил хэрэгчээр толгой дохиж: -Тийм шүү хагагтай. Онцгой юмгүй мөртлөө хүний амьдралыг өнгө оруулдаг.

Хотын олон иргэд зурагт хуудас авсан нь гадаад ертөнцийн зочид болоод дэлгэцээр пгууд гарах өглөөний шоуны үзэгчдэд харуулах зорилготой. Гэхдээ өглөөний шоуны зурагт хуудсууд

зөвхөн баяр хөөртэй байдаг бол эндхийн зурагт хуудсын ихэнхи нь тийм биш. Зарим нь өмнөх жагсаалаас үлдсэн хуудсыг барьжээ. "Засагтай тэмц" юмуу эсвэл "Биднийг чөлөөлөөч. Чөтгөр ав". Эдгээр зурагт хуудас дээр шинэ хуудсууд нэмэгджээ. "Засгийн газрын туршилт. Яагаад? Үнэнийг хэл" гэх юмуу "Бид хүн болохоос туршлагын туулай биш" гэх ажээ. Жонни Карвер "Бурхны нэрээр оройтоогүй дээр нь үүнийгээ зогсоо" гэсэн бол Фрида Моррисон "Биднийг үхүүлж байгаа нь хэний гэмт хэрэг вэ?" хэмээн сэтгэл хөдлөлөө асуулт болгожээ. Харин эерэг сэтгэл хөдлөл буулгасан ганцхан хуудас барьж яваа хүн нь Брюс Ярдли байв. Зурагт хуудсаа долоон фут урт бариулд хатгасан бөгөөд цэнхэр хивээр чимжээ. (Бүрхүүлийн дэргэд энэ зурагт хуудас бүхний дээр сүндэрлэх нь илт). "Кливлендэд байгаа ээж аав хоёр минь сайн уу? Би та нартаа хайртай" гэжээ.

Есөөс арван зурагт хуудас дээр Библиетэй холбоотой бичээс байна. Хотын мод боловсруулах газрын эзний эхнэр Бонни Моррел "Тэднийг бүү өршөө. Учир нь тэд юу хийж байгаагаа мэдэж байгаа" гэсэн бол Трайна Коул "Бурхан-Миний малчин" гээд доор нь хонь маягийн юм зурсан нь яг хонь эсэхийг бүү мэд. Донни Барибби "Бидний төлөө залбир" хэмээн гуйжээ.

Энд ирсэн хүмүүсийн дотор Эвереттийн хүүхдийг харж өгдөг Марта Эдмундс үгүй байна. Түүний салсан нөхөр Саут-Портлендад байдаг бөгөөд гэхдээ тэр түүнийг ирнэ гэдэгт эргэлзжээ. Тэр ирлээ гэхэд Марта юу хэлэх юм бэ? "Эрхтэнээ унжуулсан амьтан чи нөхөн төлбөрөө яагаад удаагаад байна?" гэх юмуу тиймээс тэр 119-р замын оронд Литл-Битч-Роудыг чиглэв. Нэгэнт түүнд явган явах шаардлагагүй тул сайн хэрэг. Тэр "Акур" машинаа унасан бөгөөд хөргүүр нь бүрэн чадлаараа ажиллана. Очих газар нь Клайтон Брэссигийн сүүлийн жилүүдээ өнгөрөөсөн жижиг тухтай байшин. Тэр хүн түүний холын хамаатан бололтой. Хэдэн үеийн цаадах хамаатан болохоо Марта санахгүй байсан ч түүнд цахилгаан үүсгүүр байсныг мэдэж байв. Хэрэв үүсгүүр ажиллах юм бол зурагт үзэж чадна. Бас авга ах Брэссигийн бүх юм зүгээр эсэхийг үзэхээр шийджээ. Гэхдээ 105 настай, тархи нь эрдэнэшишийн нэвс шиг болж хувирсан хүн зүгээр гээд ямар байх билээ.

Тэр зүгээр биш байна. Брэсси хотын хамгийн өндөр настай хүний суудлаа тавьж өгчээ. Тэр зочдын өрөөнд хайртай буйдан дээрээ суух бөгөөд өвөр дээр нь хаа нэгтээ паалан нь ховхорсон шөнийн хөтөвч байлаа. "Бостон пост" таяг нь буйдангийн дэргэд хана налан үлджээ. Брэсси өөрөө давстай жигнэмэг шиг хүйтэн байв. Гол асрагч болох гучинцар охин Нелл Тумигийн ул мөр ч алга. Тэр ах ба бэр эгчээ дагаад Бүрхүүл рүү явжээ.

-Өө авга минь, тун харамсалтай байна. Гэвч цаг нь болжээ гээд Марта санаа алдав.

Унтлагын өрөөнд орж ханын шүүгээнээс цэвэрхэн даавуу аваад хөгшнийг хучлаа. Эзэд нь удаан хугацаагаар явж байгаа айл тавилгаа ингэж хучдаг. Тэгээд ч буйданд суух өвгөн хөлтэй өндөр пургуулгатай шүүгээг яагаад ч юм санагдуулна. Марта хашаанд хүнгэнэх цахилгаан үүсгүүрийг сонсоод яагаад болохгүй гэж хэмээн бодов. Тэгээд зурагтыг асааж си-эн-эн сувгийг олоод урт буйдан дээр суулаа. Дэлгэц дээр гарч байгаа үйл явдал тун сонирхолтой учир Марта дэргэд нь хүүр байгааг бараг мартжээ.

Агаараас зураг авч байна. Нисдэг тэргэнд суусан зураглаач Бүрхүүл рүү хотын иргэдийн хамаатан садныг авчрах автобуснууд зогсох ёстой Моттоны хар зах дээр хөшжээ. Честерс-Миллийн оршин суугчдын түрүүч нь ирсэн байв. Араас нь гол хүч айсуй. Хоёр урсгалтай зам

"Хүнсний ертөнц" хүртэл хоёр хажуугаа хальтал хүнээр дүүрчээ. Бүрхүүл рүү алхах хүмүүс ба шоргоолжны жагсаал цувааг харьцуулах хүсэл эрхгүй төрнө.

Ямар нэг сурвалжлагч "гайхалтай" "сэтгэл догдлом" гэх мэт үг ашиглан ярьж байна. "Би амьдралдаа хэзээ ч ийм юм үзээгүй" гэж дахин дахин хэлнэ. Бүсгүй "Ийм юмыг угаасаа хэн ч үзээгүй тэнэг толгойт" гэж бодоод дууг хаав. Марта идэх юм юу байгааг харахаар босч гал тогоо руу явах гэж байлаа. (хэдийгээр хүүр байгаа өрөөнд хооллох нь сайнгүй ч чөтгөр шиг өлсөж байв) Энэ үед дүрслэл дэлгэцийн хагас хүртэл жижгэрээд нөгөө хагаст өөр дүрслэл гарч ирлээ. Зүүн талын хагаст өөр нисдэг тэрэгнээс авсан зургийг үзүүлэх бөгөөд автобусны цуваа Касл-Рокоос гарчээ. Дэлгэцийн доод талаар "Зочид 11 цаг гэхэд ирнэ" гэсэн зурвас гүйнэ.

Тэгвэл өглөөний цай уух хугацаа байгаа юм байна. Марта жигнэмэг, самрын тос ба гурван лонх "Бад" шар айраг олсон нь үүнээс дээр өглөөний цай гэж байхгүй. Тавиур дээр зулж, бүгдийг нь зочдын өрөөнд авчраад буйдан дээр тухлав.

-Баярлалаа авга ах аа гэж тэр хэлнэ.

Дууг нь хаасан хэдий ч зэрэгцэн гаргах дүрслэлүүд эрхгүй татаж нүд булаана. Энэ бол тогтоон барих аргагүй хүч ба хөдөлшгүй объектын уулзалтын хүлээлт гэдгийг Марта ойлгож байв. Хоёр талаас нийлэх үед дэлбэрэлт болохгүй юу гэсэн асуулт мэдээж гарч ирнэ.

Хүмүүс цуглаж байгаа тэр газраас холгүй толгой дээр Олли Динсмор аавдаа нүх ухаж байв. Хүрзээ тулаад хүмүүсийн бөөгнөрөл хэрхэн үүсэхийг харна. 200, 400, дараа нь 800 доод тал нь 800 хүн. Нуруундаа имж цүнхэнд нялх хүүхдээ үүрсэн эмэгтэйг хараад ийм жаахан хүүхдийг ийм халуунд малгай ч үгүй авчирдаг ухаантай хүн үү, үгүй юу гэх асуулт төрөв. Хотын иргэд хөшсөн утааны цаанаас ёлтойх нарны дор зогсоод ийш тийш харж автобус ирэхийг хүлээнэ. Энд бүх юм дуусахаар тэд буцаад хичнээн удаан, бас удтал алхах бол гэж Олли бодов. Үдээс хойш зэрэглээтэй халуун хот хүртэл алхана. Тэгээд тэр тасалдсан ажилдаа эргэн орлоо.

119-р замын хажуу талаар хүмүүсийн ард цагдаа нар явна. Генригээр ахлуулсан баахан шинэ цагдаа нар. Анивчуураа асаасан цагдаагийн машинуудыг зогсоожээ. Сүүлийн хоёр машин хоцорч ирэв. Яагаад гэвэл Генри гал унтраах хэсгийн гоожуураас ус авч дүүргэсэн савнуудыг багажандаа нөөцлөхийг тушаасан юм. Тэндхийн цахилгаан үүсгүүр ажиллаж байх ба хийн нөөц нь дахиад хоёр долоо хоног хүрэхээр байгааг тэр олж мэджээ. Мэдээж Бүрхүүлийн дэргэд цугласан хүмүүсийг тооцвол ус хангалтгүй, тэр бүү хэл багадна. Гэлээ гээд үүнээс ихийг тэд хийж чадахгүй. Энэ усыг наранд цохиулж ухаан алдах хүмүүст бэлджээ. Ийм хүмүүс бага байгаасай гэж Генри найдах боловч заавал гарч ирнэ гэдгийг мэдэж байв. Тэгээд Том Жимд уур нь хүрэх бөгөөд учир нь тэр уулзалтын өдрийг нулимаж орхисон.

Генри шинэ цагдаа нараас бүрэн итгэсэн ганц хүн болох Памела Чентэй хамт ирлээ. Бөөгнөрсөн хүмүүсийн хэмжээг барагцаалаад эмнэлэг рүү утасдахыг гуйв. Түргэн тусламж энд ирж бэлэн байхыг Генри хүснэ. Памела 5 минутын дараа шинэ мэдээтэй ирэхэд Генри гайхсан ч үгүй, ер бусын гэж бодсон ч үгүй. Памелаг утасдахад өнөө өглөө бугуйгаа хугалаад эмнэлэгт ирсэн залуу бүсгүй хариулжээ. Түүний үгээр бол эмнэлэг дээр нэг ч хүн байхгүй

бөгөөд түргэний тэрэг ч үгүй гэнэ.

-Ийм юм болдог байжээ гэж Генри зүрхэндээ дуу алдаад -Эмнэлгийн анхны тусламж үзүүлэхийг чи мартаагүй биз дээ? Яагаад гэвэл одоо энэ чадвараа ашиглаж мэдэх байх.

-Би хиймэл амьсгаа хийж чадна.

-Сайн байна гээд тэр "Эгго" өрмөнцөрт нугасгүй дуртай шүдний эмч Жо Боксер руу заав. Тэр гартаа цэнхэр тууз уясан ба ихэд чухал царайлан хүмүүсийг зорчих хэсгээс хажуу руу гарахыг гараар даллан заана. (Түүнийг анхаарч байгаа хүн ч алга) -Хэрэв хэн нэгний шүд өвдөх юм бол биеэ тоосон энэ мангуу энд шууд суга татах байх даа.

-Гэхдээ төлбөр нь байвал гэж Памела тодотгов. Агт араа ургах үед тэр Жо Боксероор үйлчлүүлээд авсан. Эмч тэгэхэд "төлбөрөө үйлчилгээгээр хийж болно" гэж хэлээд хөхийг нь нүдээрээ идэх шахаж билээ. Памелад энэ огт таалагдаагүй.

-Миний машины багажинд "Ред Сокс" бейсболын малгай байгаа. Хэрэв байвал тийш нь аваачиж өг гээд Генри түрүүн Оллигийн анзаарсан хүүхэн рүү заав. Имж цүнхэнд толгой нүцгэн хүүхэд нь байна.

Малгайг хүүхдэд өмсгөж өгөөд эмэгтэйг нь тэнэг гэж хэлчихээд ир.

-Малгайг аваачиж өгье, харин хэлж чадахгүй гэж Памела тайван хариулаад -Мэри-Лу Костас байна. 17 настай. Өөрөөсөө хоёр дахин ах алсын тээврийн жолоочтой суугаад жил болж байгаа. Өнөөх нь түүнтэй уулзахаар ирнэ гэж мэдээж найдаж байгаа.

Генри санаа алдаад: -Тэгсэн ч гэсэн тэнэг. Гэвч 17 настайдаа бид бүгд ийм байдаг даа.

Хүмүүс нэмэгдсээр байлаа. Нэг эр ус аваагүй нь илт боловч харин том радио нэвтрүүлэгч авчирчээ. Түүнийгээ ХБЭ суваг дээр тавиад орчин тойрноо сүмийн дуугаар дөжрүүлэв.

Түүний хоёр найз нь "Бидэнд туслаач гуйя" гэсэн зурагт хуудас дэлгэлээ.

-Бүх юм тун муу болно гэж Генри зөгнөн хэлэв. Мэдээж түүний зөв. Гэвч хэр зэрэг муу болохыг өөрөө мэдэхгүй байв.

Өсөн нэмэгдэх бөөгнөрөл нарны доор зогсон хүлээв. Давсаг султай хүмүүс өнөөхөө асгахаар замын баруун талын бут руу орно. Олонхи нь хөнгөрөхийн тулд гүрийх хэрэгтэй болно. Нэг тарган эмэгтэй (чихрийн шижингээр өвчилсөн Мейбл Олстон) шагайгаа мултлаад орилон хэвтэнэ. Хоёр эрэгтэй туслахаар очоод үлдсэн ганц эрүүл хөл дээр нь босголоо. Шуудангийн салбарын дарга Ленни Мичам (ямар ч гэсэн сүүлчийн шуудан илгээмж ирсэн өнгөрсөн долоо хоног хүртэл дарга байсан) түүнд таяг олж өгөв. Генрид энэ эмэгтэйг хотод аваачих хэрэгтэй гэлээ. Өнөөх нь машин гаргаж чадахгүй. Сүүдэрт сууж байг гэж хариулав.

Ленни Мичам гараа дэлгээд замын хоёр талыг зааж: -Хэрэв чи анзаараагүй байгаа бол замын нэг талд үнээний бэлчээр, нөгөө талд нь бут байна. Ямар ч сүүдэр алга гэхэд нь Генри Динсморын фермийн амбаар руу заав.

-Тэнд сүүдэр хангалттай.

-Тийшээ очиход өчнөөн зай байна гэж Ленни Мичам ууртай дуугарлаа.

Генри түүнтэй маргасангүй.

-Миний машины урд сандалд суулга.

-Наранд суухад халуун байна. Түүнд хүйтэн агаар хэрэгтэй.

Тийм ээ, Генри түүнд хөргүүр хэрэгтэйг мэдэж байв. Гэвч энэ нь хөдөлгүүрийг асааж бензин шатаах хэрэгтэй гэсэн үг. Одоохондоо бензин тасраагүй байгаа. Гэвч зөвхөн ганцхан тохиолдолд, тухайлбал шатахуун түгээх станцын газар доорх чингэлэгээс соруулбал хангалттай болно. Эцэстээ тэр аливаа асуудлыг үүссэн дор нь шийдэх хэрэгтэй гэсэн дүгнэлт хийв.

-Түлхүүр зоолттой байгаа. Хөргүүрийг хамгийн бага хүйтэн дээр тавиарай гэж Генри гуйв.

Ленни "тэгнэ" гэж хэлээд Мейбл рүү эргэлээ. Гэтэл нүүр нь хүрэн улаан болж хацраар нь хөлс урсч байсан ч өнөөх нь хаашаа ч явахгүй гэв.

-Би явж чадахгүй. Надад хийх юм байна гэж тэр дургүйцлээ.

Шинэхэн цагдаа нарын нэг Лео Ламуан Генри дээр ирэв.

Ийм хүмүүсгүйгээр тэр бүхнийг чадах л байсан. Леогийн тархи нь тэмээн хяруулынхаас бага.

-Тэр энд яаж ирдэг байна вэ?

-Мэдэхгүй. Ирсэн л байна гэж Генри ядрангуй хариулав. Түүний толгой өвдөж эхэллээ.

-Хэдэн эмэгтэйг дагуулаад ир. Миний машины ард түүнийг тойрч зогсож байгаад шээлгэх хэрэгтэй.

-Ямар эмэгтэй?

-Том гээд Генри холдож алхав. Леогийн хамар дундуур буулгаад авах хүслээ барьж дийлэхгүй гэж айж байна.

Нэг эмэгтэй өөр дөрвөн эмэгтэйн хамт Мейблийг цагдаагийн машин руу өргөж аваачив. Мейбл арын зөөлөвчөөс барьж байгаад шээхэд тэд тавуул халхалж өгөхдөө: -Ийм цагдаа гэж юу байсан юм бэ? хэмээн уурсав.

Ямар ч бэлтгэлгүй. Та нар өөрсдийн аймшиггүй толгойлогчид болох Ренни Рэндолф нарт л баярлалаа гэж хэл. Тэд юунд ч бэлдсэнгүй гэж хэлмээр Генрид санагдана. Гэвч тэр өчигдөр Андреаг хамгаалахдаа илүү үг дуугарсанаа мэдэж байв. Тиймээс -Өөр ямар ч цагдаа та нарт байхгүй гэлээ. Шударгаар тэмдэглэж хэлэх ёстой зүйл нь Мейблийн хүндэт харуулд зогссон эмэгтэйчүүдийн адил олонхи хүмүүс бие биедээ туслахад бэлэн байв. Ус авчрахаа мартаагүй

нь мартсантайгаа хуваалцана. Олонхи нь бага багаар ууна. Гэвч овоорсон хүний дунд усыг бодлогогүй хэмжээгүй уух тэнэгүүд байж л байдаг. Зарим нэг нь давсалсан жигнэмэг хивэх тул тун удалгүй бүр их ам нь цангана. Мэри-Лугийн охин томдсон бейсбольш малгайн дороо ууртай уйлав. Мэри-Лу охиныхоо халсан хацар ба хүзүүг усаар норгосон ч удалгүй лонх нь хоосорлоо.

Генри Памелагийн гараас барьж дахиад Мэри-Лу руу заагаад: -Түүний лонхыг аваад манай усаар дүүргэ. Хүмүүст харуулахгүй байхыг хичээ. Тэгэхгүй бол ус үдээс өмнө дуусна шүү.

Түүнийг тушаал биелүүлэхээр явахад Генри бодов. "Хэрэв жижигхэн хотын цагдаагийн газарт алба хаахыг хүсэх юм бол энэ эмэгтэй юманд хүрнэ дээ".

Памелагийн юу хийхийг хэн ч харсангүй. Энэ сайн хэрэг. Автобуснууд ирэх юм бол хотынхон халуу ба ам цангахаа ядаж хэсэг хугацаанд мартана. Мэдээж зочид яваад өгөхөөр...бас тэд эргээд хот хүртэл удтал явган аялах хэрэгтэйгээ ойлгох үед...

Энэ үед Генригийн царай хөхрөөд явчихлаа. Тэр "цагдаа" нараа тойруулан хараад тэдний дотор итгэж найдаж болох хүн хичнээн цөөн, харин тэнэгүүд хичнээн олон байгааг харлаа. Ядаж өчүүхэн ч гэсэн хэрэг болж мэдэх хүмүүсийг нь Рэндолф ямар нэг нууц ажиллагаатай гээд аваад үлдсэн. Энэ ажиллагаа нь Андреагийн Ренниг зохион байгуулсан гэж буруутгаад байсан хар тамхины үйлдвэрлэлтэй холбоотой гэж Генри бодно. Гэвч одоо түүнд энэ падлий ч байхгүй. Хамгийн гол нь энд гайгүй цагдаа байхгүй бөгөөд Генри өөрөө 119 дүгээр замаас хаашаа ч явж чадахгүй.

Гэхдээ тэр эндээс явж чадах хүнийг мэдэх учир түүнийг өөр дээрээ дууддаа.

-Генри чи юу хүсээ вэ? гэж Билл Олнат асуув.

-Дунд сургуулийн түлхүүр чамд байгаа юу?

Миллийн дунд сургуульд гучин жил цэвэрлэгчээр ажилласан Олнат толгой дохилоо.

-Надад байгаа гээд утаат нарны дор гялалзах хэлхээтэй түлхүүрээ алгадав. -Үргэлж авч явдаг. Юу гэж?

-Дөрөв дугаартай машиныг ав. Хот руу аль болох хурдан буц. Хоцорч ирэгсэдийг дайрчихваа. Аль нэг автобусанд суугаад нааш нь аваад ир. Дөчин дөрвөн суудалтай автобуснуудын нэгийг.

Олнат ийм зааварт баярлаад байсангүй. Түүний царай хөшлөө. Янкичууд ингэдэг. Генри өөрөө ч янки юм. Тэр ийм юм олныг үзсэн бөгөөд тэвчиж чаддаггүй. Түүний царай төрх "найз минь надад өөрийн ажил хангалттай байна" гэх шиг.

-Хэрэв чи энэ бүх хүнийг сургуулийн ганц автобусанд суулгах гэж байгаа бол чи сэтгэцийн өвчтөн.

-Бүгдийг бишээ. Бие даагаад хот руу буцах чадваргүй хүмүүсийг гэх үедээ Генри Мейбл ба нүүр нь түлэгдсэн нүүртэй охиноо тэвэрсэн Мэри-Лу нарын тухай бодно. Мэдээж өдрийн

гурван цаг гэхэд хот орж чадахгүй хүмүүс дахиад нэмэгдэнэ. Хот орох нь бүү хэл алхаж гишгэж ч чадахгүй хүмүүс.

Гэвч Оллнатын царай мятрашгүй байв. Сөхсөн хамар нь хөлөг онгоцны хамрыг санагдуулна.

-Үгүй ээ ноёнтон. Миний хоёр хүү эхнэрүүдийнхээ хамт ирнэ. Тэд өөрсдөө надад хэлсэн. Хүүхдүүдээ ч авчирна гэсэн. Би тэдэнтэй уулзах боломжоо алдаж чадахгүй. Би бас эхнэрээ орхиж чадахгүй. Тэр маань маш их сэтгэл зовсон байгаа.

Генри тэнэгийнх нь төлөө энэ хүнийг дуртайяа цохих байв. (хувиа хичээснийх нь төлөө боож алах байсан). Гэвч тэр Оллнатаас түлхүүрээ өгөхийг гуйж аль түлхүүрээр сургуулийн гараж нээхийг асуулаа. Дараа нь Оллнатыг эхнэр дээрээ очиж болно гэв.

-Генри уучлаарай. Гэхдээ би хүүхдүүд ба ач нараа харахыг үнэхээр хүсээд байна. Би тэгэх гавьяатай. Би хазгар, өвчтэй юмуу сохор хүмүүсийг ийшээ ир гэж гуйгаагүй болохоор тэдний тэнэглэлийн төлөө төлбөр хийхийг хүсэхгүй байна гэж Оллнат хариуллаа.

-Тиймээ чи жинхэнэ америк хүн. Энд өөр бодол байж болшгүй. Миний нүднээс далд ор.

Оллнат эсэргүүцэх гэж амаа нээснээ (цагдаа Моррисоны царайнаас ямар нэг юм олж харсан бололтой) бодлоо өөрчлөөд хөлөө чирсээр явж одов. Генри Памелаг дуудахад тэр хот руу буцахыг эсэргүүцээгүй бөгөөд зөвхөн хаашаа очиж юу хийх болоод яагаад гэдгийг асуув. Генри түүнд тайлбарлаж өглөө.

-За яахав. Гэхдээ тэр машин чинь механик хурдны хайрцагтай биш биз дээ? Яагаад гэвэл би механик машинаар яаж явахыг мэдэхгүй.

Генри Бүрхүүлийн дэргэд эхнэр Саратайгаа зогсох Оллнатаас энэ асуултыг хашгирч асуулаа. Тэд Бүрхүүлийн цаад талын Моттоны замыг тэсч ядан харах ажээ.

-Арванзургаа дугаартай нь механик. Бусад нь автомат гэж Оллнат мөн л хашгиран хариулав. - Хамгаалалтын бүсээ битгий март гэж түүнд хэл. Хэрэв жолооч хамгаалалтын бүсээ зүүхгүй бол асдаггүй юм шүү дээ.

Генри Памелаг хот руу илгээв. Ямар нэг аз туршилт хийхгүйгээр, гэхдээ чадахын хэрээр хурдлахыг гуйлаа.

Эхэндээ хүмүүс Бүрхүүлийн дэргэд зогсоод хоосон замаас нүд салгахгүй байв. Дараа нь ихэнх нь суулаа. Бүтээлэг авчирсан нь дэлгэнэ. Зарим нэг нь майхны сүүдэрт толгойгоо утаат нарнаас нууна. Яриа намжиж олонхи нь царцаа хаачсан тухай (хаашаа алга болсон, өндөр өвсөн дунд яагаад дуугарахгүй байгаа тухай) Уэнди Голдстоун найз охин Элленээсээ асуухыг чагнана.

-Эсвэл би дүлийрчихсэн юмуу? гэж тэр нэмж хэлэв.

Уэнди дөжрөөгүй. Царцаа эсвэл дуугарахгүй байна, эсвэл энд огт алга.

ХБЭ студийн цэлгэр төв танхим (бас харьцангуй сэрүүхэн) Торх хочих Эрни Келлог ба "Түүний азтай гурвал"-ын дуунаас болон чичирнэ. Тэд "Над руу Тэнгэрээс утасдлаа. Утсан дээр Есүс байлаа" хэмээн дуулна. Хоёр эр харин сонсохгүй байв. Тэд дэлгэцээр зэрэгцэн гарах дүрслэлийг хараад удвисдуулсан мэт байв. Яг Марта Эдмундсын адил. (тэр бүсгүй хоёр дахь лонх "Бад"-аа аль хэдийн ууж дуусаад цагаан даавуугаар хучиж орхисон Клайтон Брэссигийн цогцосыг таг мартжээ). Америкийн бүх хүн шиг удвисдуулсан байв. Тийм ээ, дэлхийн бүх хүн шиг.

-Сандерс тэднийг хар гэж Шеф хэллээ.

-Би харж байнаа гэх түүний өвөр дээр "Клодетт" хэвтэнэ. Шеф түүнийг хоёр гар бөмбөг авахыг зөвлөсөн ч тэр энэ удаад татгалзав. Тэр чагтыг мултлаад шидэж чадахгүй хөшихөөс айна. Тэр кинонд нэг удаа тийм юм үзсэн. -Сэтгэл догдлом юмаа. Гэхдээ зочдоо хүлээж авахад бэлдэх цаг болсон гэж бодохгүй байна уу?

Эндигийн зөв гэдгийг Шеф мэдэж байвч автобусны цувааг толгойлсон телевизийн явуулын станцийн дамжуулах дүрслэлийг харуулах дэлгэцийн тэр хэсгээс нүдээ салгах үнэхээр хэцүү байлаа. Тэд хаана явааг Шеф мэдэж байв. Чиглүүлэгч нь өндрөөс танигдаж байлаа. Зочид Бүрхүүлд улам ойртсоор байв.

Бид ч бас төгсгөлд улам ойртож байна гэж тэр бодлоо.

-Сандерс

-Юу гэв Шеф?

Өнөөх нь түүнд "Сукретс"-ийн төмөр лааз сунгав.

-Тэднийг хад хаацайлахгүй, үхсэн модод хоргодох байр болохгүй, царцаа цар цар хийх нь хөнгөрүүлэхгүй. Энэ ямар номонд гардагийг харин санахгүй юм.

Энди лаазыг нээж гараар ороосон зургаан бүдүүн тамхи арай гэж багтсаныг харав. Тэгээд бодсон нь: "Пөөх оргилсон таашаалын цэргүүд". Энэ бол түүний амьдралын хамгийн яруу санаа байв. Бүр уйлмаар санагдав.

Шеф зурагт унтраахын тулд алсын удирддага хэрэглэдэг. Автобуснууд ирэхийг харах хүсэл төрнө. Хэдийгээр тэр зожиг хүн мөн эсвэл биш байлаа ч, хэдий сэтгэцийн өвчтөн юмуу эсвэл биш байлаа ч аз жаргалтай нийлэлтийн дүр зураг үзэхийг үнэхээр хүсдэг. Гэвч гашуун хүмүүс хэзээ ч ирж мэднэ.

-Сандерс

-Тийм ээ Шеф

-Би гаражнаас бөөрөн дээрээ "Дугуйн дээрх христийн зоог" гэсэн бичигтэй фургоноо гаргахыг хүсч байна. Түүнийг зоорины барилгын алсын буланд тавина. Түүний ард нуугдах юмуу эсвэл өмнөө бүх ойг харж болно гээд тэр "Бурханы дайчин"-аа шүүрч авлаа. Бөгсөнд нь

бэхэлсэн гар бөмбөг савлаж мөргөлдөнө. -Энэ тухай бодох тусам итгэл үнэмшил улам бэхжиж байна. Тэд тэндээс ирнэ гэж бодогдоод байна. Тэнд мод тээвэрлэх зам бий. Тэд намайг мэдэхгүй гэж бодож байгаа гэх үед Шефийн улаан нүд гялалзана.

-Шеф олон хүний боддогоос илүүг мэддэг.

-Би мэднэ. Би чамд хайртай Шеф.

-Баярлалаа Сандерс. Би ч бас чамд хайртай. Хэрэв тэд ойгоос ирэх юм бол би чамд талбайд гарах боломж өгье. Дараа нь ургац хураалтын үеэр хадуур эрдэнэ шиш хяргадаг шиг хяргана. Гэхдээ бид бүх өндгөө нэг сагсанд хийж болохгүй. Тийм учраас чи тэднийг урьд нь тоссон тэр замыг хараандаа авахыг хүсч байна. Хэрэв тэдний хэн нэг нь тэр замаар явах юм бол...

Энди буугаа өргөлөө.

-Сандерс чиний зөв. Гэхдээ яарах хэрэггүй. Тэднийг хариу буудаж эхлэхээс өмнө аль болох олныг унагаа.

-Унагаана гэж Энди хэлэх ба заримдаа зүүдэндээ амьдраад байгаа юм шиг мэдрэмж төрдөг бөгөөд энэ удаад яг тийм байв. -Ургац хураах үед эрдэнэ шиш хяргадаг шиг.

-Яг тийм. Гэхдээ сайн сонс. Яагаад гэвэл энэ их чухал. Намайг буудаж эхлэхийг сонсоод эзэлсэн байрлалаа орхиж болохгүй. Чамайг буудаж эхлэхэд би ч бас байрлалаа орхихгүй. Тэд биднийг хамт биш байгааг тааварлах байх. Гэвч би бүгдийг тооцсон. Чи шүгэлдэж чадах уу?

Энди хоёр хуруугаа амандаа хийгээд чанга шүгэлдэв.

-Сайн байна Сандерс. Үнэнийг хэлэх юм бол бүр гайхалтай.

-Бага сургуульд байхдаа сурсан юм гэж Энди хариулахдаа "Тэгэхэд амьдрал хавьгүй хялбар байсан" гэж нэмсэнгүй.

-Тэд дийлж байна гэдэгт итгэх хүртлээ битгий шүгэлдээрэй. Чамайг шүгэлдвэл би гүйж очно. Харин намайг шүгэлдэх юм бол миний байрлалыг хүч нэмэхийн тулд хар хурдаараа гүйгээрэй.

-Ойлголоо.

-Дахиад татъя Сандерс. Чи юу гэмээр байна. Энди энэ санааг дэмжив.

Блэк-Ридж дээр Маккойн алимны цэцэрлэгийн хажууд хотын 17 дүрвэгсэд Жон Фордтой кинонд гардаг индианууд шиг бохир тэнгэрийн дэвсгэр дээр зогсоно. Тэдний олонхи нь 119-р замаар хөврөх хүн урсгалыг дуугүй бүлтийн ширтэнэ. Тийшээ очиход 6 миль зайтай боловч ийм олон хүн цугласан нь их алсад мэт сэтгэгдэл төрүүлнэ.

Ганцхан Расти хавьгүй ойр байгаа зүйлийг харж сэтгэл нь хязгааргүй хөнгөрөхийг мэдэрнэ. Бүүр дуулмаар байлаа. "Одиссей" машин Блэк-Ридж-роудаар айсуу. Машин ойн цоорхой ба

өдрөөр үл харагдах гэрэлт бүсэд дөхөж ирэхэд Растигийн амьсгаа давхцав. Хэрэв жолоон дээр байгаа Линда ухаан алдаж машин осолд орох юм бол бүх юм аймаар төгсөнө гэж бодох хугацаа түүнд гарсан ч аюултай газар ард үлдэв. Машин бага зэрэг хазайх шиг түүнд санагдсан ч хийсвэр сэтгэлгээ түүнтэй наргиж мэднэ гэдгийг тэр мэднэ. Машин удалгүй дөхөж ирлээ.

Дүрвэгсэд хайрцагнаас зүүн тийш хэдэн зуун ярд зайнд зогсоно. Харин Жо түүнийг мэдэрсээр байна гэж бодов. Улаан гэрэл анивчих болгонд тархинд нь ямар нэг юм болно. Магадгүй энэ бүхэнд түүний хийсвэр сэтгэлгээ хөгжсөн нь буруутай байх. Гэвч тэр үүнд эргэлзэхгүй байлаа.

Барби түүний дэргэд зогсоод хатагтай Шамуэйг тэврэв. Жо түүний мөр рүү алгадаад:

-Ноён Барбара ямар аймшигтай юм бэ? Ийм олон хүн нэг дор. Энэ аймаар.

-Тийм гээд Барби толгой дохино.

-Тэд харж байгаа. Илгэн толгойтууд. Би үүнийг мэдэрч байна.

-Би ч бас.

-Би ч бас гэж Жулия бараг сонсогдохгүй дуугаар хэллээ.

Хотын захиргааны зөвлөгөөний өрөөнд Том Жим ба Картер хоёр суугаад зэрэгцэн гарч байсан хоёр дүрслэл газраас авсан дүрслэлд байраа тавихыг үзнэ. Эхэндээ энэ дүрслэл тэсрэх бөмбөг чихсэн машин дэлбэрэх юмуу хар шуурга ойртон ирж байх үеийн зураг авалт шиг чичирч байв. Тэнгэр, чулуу ба гүйж байгаа хөлний зургийг тэд харав. Хэн нэгэн бувтнав. -Алив түргэл.

Тэр дороо Вольф Блитцерийн дуу сонсогдлоо.

-Явуулын станц газар дээрээ ирлээ. Тэд яарч байгаа гэдэгт би итгэлтэй байна. Хэдхэн хормын дараа... Өө бурхан минь үүнийг хараач.

Бүрхүүл дор байгаа бүх хүмүүс босч ирэх үед дүрс бичлэгийн дуран Честерс-Миллийн хэдэн зуун оршин суугчид руу чиглэв. Задгай газарт хэдэн зуун мөргөл үйлдэгчид залбирал хийсний дараа босч байгаа мэт сэтгэгдэл төрөв. Арын хүмүүс нь өмнөх хүмүүсээ Бүрхүүлд шахна. Хотын хүмүүсийн хамар, хацар, уруул мурийж, яг шилэн хананд наалдах шиг болохыг Том Жим харлаа. Хоромхон хугацаанд Реннигийн толгой эргэсэн бөгөөд шалтгааныг нь тэр ойлгов. Тэр анх удаа болж байгаа бүхнийг гаднаас нь харлаа. Анх удаа үйл явдлын бодит болоод хэмжээ дамжааг ухаарав. Тэр анх удаа үнэхээр айлаа.

Бүрхүүл дотор тул дуу нь намжсан ч гар бууны тас тасхийх дуу сонсогдов.

-Би буун дуу сонсож байна. Андерсон Купер чи буун дуу сонсов уу? Юу болоод байна вэ? гэж Вольф хэллээ.

Куперийн дуу бараг сонсогдохгүй байх нь тэр Австралийн нутгийн гүнээс хиймэл дагуулын утсаар ярих мэт ажээ.

-Вольф, бид газар дээрээ очоогүй байна. Гэвч надад жижиг дэлгэц байгаа. Ийм мэдрэмж...

-Би харж байна гэж Вольф түүний яриаг тасалсанаа -Миний бодлоор...

-Энэ Генри Моррисон байна. Түүний мэдрэл бат бэх гэж би хэлж чадна гэх Картерийн дуу гарав.

-Тэр маргаашнаас халагдсан гэж Том Жим хэллээ.

Картер түүн рүү харахад хөмсөг нь дээшлэв.

-Өчигдөр хурал дээр хэлсэн үгнээсээ болоод уу?

Том Жим түүн рүү хуруугаар онилоод: -Чамайг ухаантай залуу гэдгийг би мэдсэн юм гэлээ.

Бүрхүүлийн дэргэд Генри өчигдрийн хурлын тухай, эр зоригийн тухай, тэр бүү хэл үүргээ гүйцэтгэх тухай ч бодсонгүй. Хэрэв тэр ямар нэг арга хэмжээ маш түргэн авахгүй бол хүмүүсийг Бүрхүүлд няцална гэдгийг л бодож байв. Тиймээс гар буугаа суга татаад дээш буудлаа. Тодд Уэндлстет, Рэнс Конрой ба Жо Боксер гэсэн хэдэн цагдаа түүнийг дуурайв.

Орилж хашгирч байсан дуу (даруулж байсан хүмүүсийн орилоон) түгшүүртэй нам гүм байдлаар солигдоход Генри амандаа чанга яригч аваачаад:

-Бүрхүүлийн дагуу тарцгаа. Тарцгаа чөтгөр ав. Бүгдэд нь хангалттай зай бий. Ганцхан цэг дээр битгий овоороод бай.

Хатуу чанга хэлсэн үг буу буудахаас илүү толгой цэлмүүлэх үйлчилгээтэй. Хамгийн зөрүүд нь зам дээр үлдсэн ч (тэдний дотор Билл ба Сара Олнат, мөн Жонни ба Кэрри Карвер нар байв) бусад нь Бүрхүүл даган тарлаа. Зарим нь баруун тийш, ихэнхи нь зүүн тийш Динсморын бэлчээр рүү тарсан бөгөөд тэдний хөдөлгөөнд бут саад болсонгүй. Генриетта ба Петра нар тэдний дунд байх бөгөөд "Канад дарин пуужин"-гаас болоод хоёулаа найгана.

Генри буугаа далд хийгээд бусад цагдааг дуурайхыг тушаав. Тодд ба Рэнс нар тушаалыг дагасан ч харин Жо Боксер урьдын адил богино амтай гучин найман калибрын гар буугаа барьсаар байлаа. Хэрэв Генри буруу таниагүй бол "сэтели-найт спейшл" буу.

-Намайг хүчлэх гээд оролдоод үз гэж Жо тургив. Харин Генри энэ хар дарсан зүүд. Би тун удахгүй орондоо сэрээд цонх руу очиж зогсон намрын цэнгэг сайхан өдрийг харах болно гэж бодов.

Бүрхүүл рүү очих шийдвэр гаргаагүй хүмүүсийн олонхи нь (тэдний дотор амьсгалын замын асуудал үүссэн хүний тоо тун олон) болж байгаа явдлыг зурагтаар үзнэ. "Дипперс"-д гуч дөчөөд хүн цуглажээ. Эзэд нь Бүрхүүл рүү явсан ч рестораны хаалгыг нээлттэй, зурагтаа асаалттай үлдээжээ. Бүжиглэх талбайн модон шалан дээр цугласан хүмүүс их аядуу байх

бөгөөд хаа нэгтээ чимээгүй уйлах дуу сонсогдоно. Телевизийнхэнд талархахад дүрслэл өндөр нягтралтай, тод, хурц байсан. Тэгээд үзэж харснаас зүрх урагдаж байв.

Нүдэнд үл үзэгдэх саадын дагуу эгнэж, зарим нь агаар тулан зогсох мэт харагдах 800 хүний дүрсэнд зөвхөн тэд донсолсон юм биш. Вольф ярьж байна.

-Хүний царайд ийм их уй гунигийг хэзээ ч харж байсангүй. Би... Эдгээр дүрс тайлбар шаардахгүй гэж бодож байна гэснээ амьсгаа нь давхцав.

Тэр дуугаа хураасан нь сайн хэрэг. Болж байгаа үйл явдлыг үгээр илэрхийлэх шаардлагагүй.

Хэвлэлийн бага хурал дээр Кокс тайлбарлахдаа "хамаатан саднууд автобуснаас буугаад Бүрхүүл рүү явган явна... Зочид Бүрхүүлээс хоёр ярдын зайд байрлахыг зөвшөөрнө. Ингэвэл аюулгүй гэж бид бодож байгаа. Гэхдээ ямар ч баталгаа гаргаж чадахгүй" гэсэн. Мэдээж амьдрал өөрийн тодоттолыг хийв. Автобуснууд дөнгөж хаалгаа нээхэд хүмүүс ойр дотны хүнийхээ нэрийг хашгиран Бүрхүүл рүү хурдаллаа. Зарим нь унаж гишгүүлэв. (нэг хүн үхэж, 14 хүн гэмтсэнээс 6 нь хүндээр гэмтэх болно) Бүрхүүлийн дэргэд аюулгүйн бүс хангахыг оролдсон цэргүүдийг урсгав.

"Ойртож болохгүй" гэсэн бичигтэй шар туузууд урагдаж, хэдэн зуун хөл гишгэлж орхив. Дөнгөж ирсэн хүмүүс Бүрхүүлийн дэргэд очингуутаа сүйт бүсгүй ба хархүү, охид хөвгүүд, ээж аав, эхнэр нөхрийнхөө нэрийг хашгиран Бүрхүүлийн дагуу уйлан гүйлдлээ. Дөрвөн хүн биед нь суулгасан анагаахын электрон төхөөрөмж байгаа эсэхийг асуухад худал хариулсан юмуу эсвэл таг мартсан юмуу бүү мэд. Гурав нь газар дээрээ үхэв. Жагсаалтанд хориглосон зүйлсийн дотор зайгаар ажилладаг сонсох аппаратыг олж үзээгүй дөрөв дэх хүн тархины олон тооны цус алдалт булшинд хүргэхээс өмнө долоон хоног ухаангүй хэвтэх болно.

Бага багаар бүтд шигшигдсэн ба ерөнхий зургийг бүх сувгаар үзүүлэх дүрс бичлэгийн дурангууд нэг ч юм үл алдана. Хотын оршин суугчид ба зочид үл үзэгдэх саадаар тусгаарлагдан алгаа нийлүүлэхийг харуулна. Хүмүүс үнсэлцэх гэж оролдохыг бүгд харав. Бие биенийхээ нүд рүү харан уйлах эр эм хүмүүсийг томоор харуулна. Бүрхүүлийн дотор юмуу гадна ухаан алдан унах хүмүүсийг харуулж байлаа. Урд урдаасаа харж сөхрөн суугаад гараа нийлүүлэн залбирах хүмүүсийг ч харуулна. Жирэмсэн эхнэр рүү нь нэвтрүүлэхгүй байгаа саадыг арьс нь урагдаж агаарт цусан дусал тогтох хүртэл нударгаараа нүдэх Бүрхүүлийн гадна байгаа эрэгтэй хүнийг татаж үзүүлэв. Цурхиран уйлах ач охиндоо хурууны өндгөө хүргэх гэж оролдон үл үзэгдэх хананд наах эмгэн дээр дурангаа удтал барив.

Дүрс бичлэгийн дуран нисдэг тэрэг дахин агаарт хөөрч, урт сунасан хоёр эгнээ хүн-могойны дүрсийг дамжууллаа. Моттоны талд навчис 10-р сард байдаг янзаараа улайж бүжиглэнэ. Харин Честерс-Миллийн талд унжиж үл хөдөлнө. Хотын оршин суугчдын цаагуур зам дээр, талбай дээр, буган дотор тэдний чирч ирсэн хэдэн арван зурагт хуудас хөглөрнө. Уулзан нийлэх мөчид (бараг л нийлэх) улс төр ба эсэргүүцэл мартагджээ.

Кэнди Краули ярьж байна.

-Вольф оо, энэ бол миний сурвалжлагчийн амьдралдаа нэвтрүүлж байсан бүхнээс ямар ч

эргэлзээгүй хамгийн гунигтай хамгийн хачин үйл явдал.

Гэвч хүн гэдэг амьтан нөхцөл байдалд дасч дадах чадвартай. Бага багаар сэтгэл хөдлөл ба ер бусын нөхцөл байдал арын эгнээнд шилжиж эхэллээ. Одоо хамаатан саднууд хоорондоо зүгээр л харилцаж гарав. Бүрхүүлийн хоёр талд хүчлэлийг тэс гараагүй хүмүүсийг авч одно. Миллийн талд улаан загалмайн майхан байхгүй тул цагдаа нар тийм хүмүүсийг машины сүүдэрт аваачиж суулгаад Памела сургуулийн автобус авчрахыг хүлээнэ.

Цагдаагийн газарт ХБЭ-г дайран эзлэх багийн гипгүүд Бүрхүүлийн дэргэд болж байгаа үйл явдлыг илбэдүүлсэн мэт таг дуугүй ажиглана. Рэндолф тэдэнд саад болсонгүй. Цаг бас бий. Тэр жагсаалтын дагуу нэрсийг шалгана. Дараа нь гараар дохин Дентоныг дуудаад шатны тавцан дээр гарлаа. Энэхүү ажиллагааг удирдах үүрэг ноогдоогүйд Дентон дургүйцэх байх гэж тэр бодсон ч тийм юмны үнэр ч алга. (Рэндолф бүх насаараа бусдыг өөрөөрөө хэмжиж ирсэн) Энэ бол хөгшин архичныг хүнсний дэлгүүрээс чирч гаргахаас хавьгүй ноцтой даалгавар учраас бүх хариуцлага өөр хүнд оногдсонд Дентон харин ч баярлаж байв. Хэрэв бүх юм сайн болох юм бол эсвэл муу боллоо ч гэсэн алдар гавьяа түүнд оногдох аваас юунд эсэргүүцэх билээ. Рэндолф энэ талаар бодсонгүй. Тэнд нэг муу ажилгүй үймээнч бас нэг идэх хоолон дотроо баас харсан ч хэлж чадахгүй хулчгар эмийн санч хоёр байгаа. Хүчний байдал ийм байхад юм өөрөөр эргэж болно гэж үү?

Саяхан дээрээс нь Пайперыг түлхэж байсан тэр шатан дээр зогсож байхдаа Дентоныг удирдлагаас бүрмөсөн халах боломжгүй нь тодорхой боллоо. Рэндолф түүнд хуудас сарвайв. Энд долоон хүний нэр байлаа. Тэдний нэг нь Дентон. Бусад нь Мел Сирлс, Жорж Фредерик, Марти Арсено, Обри Таул, Тагжгар Норман ба Лорен Конри нар.

-Чи энэ багийг мод тээвэрлэх замаар авч явна. Замыг мэдэх үү? гэж Рэндолф асуув.

-Тийм ээ, Литл-Битчээс салсан, хот талдаа зам. Архичин Сэмийн аав тавьсан...

-Түүнийг хэн тавьсан нь надад хамаагүй гэж Рэндолф яриаг нь таслаад: -Чиний үүрэг бол энэ замаар дуустал нь явах. Үд дунд хүмүүсээ ойгоор авч явна. Та нар радиостанц руу ар талаас нь орно. Үд дунд шүү Дентон. Энэ нь нэг минутын эрт юмуу орой биш гэсэн үг.

-Бид бүгд тэр замаар явна гэж би бодсон.

-Төлөвлөгөө өөрчлөгдсөн.

-Өөрчлөгдсөнийг Том Жим мэдэх үү?

-Том Жим бол хотын захиргааны гипгүүн. Харин би цагдаагийн дарга. Дашрамд хэлэхэд чиний ч бас дарга. Тэгэхээр амаа татаад сонс.

-Уучлаарай гээд Дентон гараа чихэндээ барьсан нь зөөлнөөр хэлэхэд үл хүндэтгэл юм.

-Би Литл-Битчээр радио станц руу эргэх замаас жаахан цаашаа өнгөрч явна. Стюарт Ферн хоёрыг авч явна. Бас Рожерийг. Хэрэв Буши Сандерс хоёр та нар руу гал нээж тэнэгтэх юм

бол, өөрөөр хэлбэл хэрэв бид буун дуу сонсвол бид радио станц руу хөдөлж тэдний ар талаас дайрна. Чи ойлгов уу?

-Тийм.

-Сайн байна. Алив цагаа нийлүүлье. -Энэ... Юу? Рэндолф санаа алдаад.

-Бидний цаг ижил явж байгаа бөгөөд үд дунд бидний хувьд яг зэрэг болно гэдэгт итгэхийн тулд

Дентоны царайд урьдын адил юу ч ойлгоогүй байдал тодорсон ч тэр тушаалыг дагав.

Цагдаагийн газраас хэн нэгний магадгүй Тагжгарын хашгирах дуу гарлаа.

-Хүүе хараач. Дахиад нэг нь шороонд хоншоороо наалаа. Тэд ухаан алдсан хүмүүсийг цагдаагийн машины цаагуур мод шиг хурааж байна.

Түүнд инээж алга ташин хариулав. Бүгд сэтгэл санаа тун өндөр байх бөгөөд Мелийн хэлснээр "Буудах дадлага хийх боломжтой" болсонд тэсч ядна.

-11 цаг 15 минутанд эндээс гарна. Тиймээс дахиад 45 минут зурагт үзэж болно гэж Рэндолф хэлэв.

-Поп-корн идэх үү? Бичил зуухны дээд талын тавцанд таваг дүүрэн байна гэж Дентон асуулаа.

-Яагаад үтүй гэж?

Бүрхүүлийн дэргэд Генри өөрийн цагдаагийн машинд очиж ус уув. Дүрэмт хувцас нь хөлсөнд нэвг норсон байх ба тэр хэзээ ингэж ядарч байснаа үл санана. (шалтгаан нь муу агаарт байгаа гэж Генри боддоо. Тэр цээж дүүрэн амьсгалж чадахгүй байв) Гэхдээ өөртөө болоод өөрийн хүмүүстээ ерөнхийдөө сэтгэл ханамжтай байлаа. Бүрхүүлийн дэргэд бие биенээ дарж гишгэхээс зайлсхийж чадсан бөгөөд энэ талд хэн ч үхээгүй. Одоохондоо үхээгүй байгаа ба хүмүүс тайвширчээ. Моттоны талд дүрс бичлэгийн дуран барьсан хэдэн арван сэтгүүлчид урагш хойш гүйлдэнэ. Тэд азтай нийлэлтийн жишээ аль болох олныг буулгах гэж хичээнэ. Энэ бол хувийн амьдралд халдсан хэрэг гэдгийг Генри мэдэж байсан ч америк болоод бүх дэлхий ийм юм харах эрхтэй гэж үзэв. Тэгээд ч хүмүүс өөрсдөө ч дургүйцэхгүй байх бололтой. Заримд нь тэр бүү хэл таалагдаж байна. Тэд алдарын арван таван минут авсан хэрэг. Генрид ээж аавыгаа хайх боломж байсан ч тэднийг харахгүй байгаадаа гайхсангүй. Тэд аль хэдийн Дерри рүү нүүсэн бөгөөд тэгээд ч өндөр настай. Зочдыг сонгох сугалааны нэрсийн жагсаалтанд тэднийг оруулсан гэдэгт эргэлзэж байлаа.

Баруун зүгээс шинэ нисдэг тэрэг айсуй бөгөөд хэдийгээр Генри мэдэхгүй боловч дотор нь хурандаа Кокс явж байв. Түүний бодлоор уулзалтын өдөр муугүй болж байлаа. Честерс-Миллийн талаас хэвлэлийн бага хуралд хэн ч оролцох бодолгүй байгааг түүнд хэлсэн ч тэр үүнд гайхах юмуу урам хугарсангүй. Түүнд хуримтлагдсан мэдээллийг тооцож үзэх юм бол

хэрэв Ренни хэвлэлийн бага хуралд ирлээ гэхэд тэр гайхах байсан. Он удаан жилийн уртад Кокс олон хүнтэй харьцаж ирсэн болохоор хулчгар худалчийг милийн цаанаас ч мэдэрдэг.

Дараа нь Кокс зочдын урт цуваа ба тэдний урдаас харан зогсох хотын иргэдийг олж харав. Жеймс Реннигийн тухай бодол толгойноос нь нисэн одоход энэ хангалттай байжээ.

-Ямар аймаар юм бэ? Хэн ч хэзээ ч үүнээс аймаар юм үзээгүй гэж тэр шивнэлээ.

...Бүрхүүл дор шуурхай томилогдсон туслах Тоби Мэннинг хашгирна.

-Автобус ирж явна гэхэд энгийн хүмүүс анхаарал хандуулахгүй бөгөөд тэд хамаатан садантайгаа ярилцах юмуу эсвэл тэднийгээ хайсаар байв. Харин цагдаа нар баярлан дуу алдаж энэ мэдээг угтлаа.

Генри цагдаагийн машиныхаа арын бүслүүрт ойртох үед сургуулийн том шар автобус яг Жим Реннигийн хуучин машины салоны дэргэдүүр өнгөрч явав. Памела 150 фунтээс илүүгүй жинтэй бөгөөд нойтон хувцастай боловч тэр одоо хүмүүсийн анхаарлын төвд оржээ. Том автобусны жолоон дээр сууж байна.

Генри цагаа харав. 11 цаг 20 минут. Бид дийлэх юм байна. Маш сайн давах юм байна.

Төв гудамжинд, гурван ширхэг ягаан өнгийн том ачааны тэрэг хотын талбайн дэргэдэх толгойн налуугаар өгсөнө. Гурав дахь машины кабинд Стюарт, Ферн, Рожер нар суужээ. (түүнээс тахиа үнэртэнэ) Ачааны тэрэгнүүд Литл-Битч-роуд ба радио станцыг чиглэжээ.

Гэнэт Рэндолфын толгойд бодол харвахад тэр духаа алгадалгүй арай гэж тэсэв. Тэдэнд зэвсэг хангалттай боловч харин хуягт хантааз ба дуулгаа мартжээ. Буцах уу? Хэрэв буцах юм бол эхлэх байрлалдаа 12 цаг 15 минут юмуу эсвэл түүнээс хожуу очно. Тэгээд ч хантааз илүүдэл сэргийлэлт байлгүй дээ. Хоёрын эсрэг тэд арван нэгүүлээ. Түүнээс гадна тэр хоёр чөтгөр болголоо хар тамхи татсан.

Үнэхээр бүх юм яг бичсэний дагуу шиг л болох ёстой.

8

Энди Сандерс өнгөрсөн удаад гашуун хүмүүс радио станцад нэвтрэхийг оролдоход байсан тэр царс модныхоо ард байрлал эзлэв. Гар бөмбөг аваагүй ч харин бүсэндээ гэдсэн талдаа 6, ташаандаа дөрвөн ширхэг дүүрэн сумтай дайз хавчуулжээ.

Дахиад 20 ширхэг түүний хөлд байгаа модон хайрцаг дээр хэвгэнэ. Бүхэл бүтэн армийг ч хэвгүүлэхэд хүрэлцээтэй сум. Гэхдээ Том Жим тэдний эсрэг үнэхээр бүхэл бүтэн арми илгээх юм бол өөрийг нь амархан дуусгана гэж тэр бодно. Эцсийн эцэст түүний ердийн ажил бол эм зарах.

Эндигийн ямар юг хэсэг нь, тэр үнэхээр үүнийг хийж байгаа гэдэгт итгэж чадахгүй байсан ч хотын захиргааны нэгдүгээр гишүүн мет хэрэглэх тэр мөч хүртэл өөртөө байгаа тухай сэжиглэдэг ч үгүй байсан биеийнх нь өөр нэг хэсэг бол барайн баярлана. Түүний хажуугаар

бас уурсана. Эю хорвоогийн Том Жимүүдэд эндээс оногдох юм үгүй бөгөөд тэд эндээс юу ч авч явахгүй. Энэ удаад ямар ч хэлэлцээр, ямар ч улс төр, ямар ч харилцан буулт байхгүй. Тэр сэтгэл санааны ахтайгаа мөр зэрэгцэн зогсох болно. Түүний сэтгэл санаа үгүйсгэх үзэлд автсан байдалд байгааг Энди ойлгож байсан ч зэмлээд байх юм олж харсангүй. Тэр бүхний үнэ өртөг тоолон насаа барсан. Харин одоо метийн дагуулж ирсэн бүхнийг-нулимж-хаях сэтгэл санааны байдал нь сайн өөрчлөлт мэтээр ойлгогдоно.

Энди ойртон ирж яваа ачааны тэрэгүүдийн хөдөлгүүрийн чимээг сонсоод цагаа харлаа. Тэрэгнүүд зогсов. Цаг нь зогсчээ. Тэгэхээр нь тэнгэр рүү харж бүүдгэр цайвар шар толбо болж хувирсан нарны байрлалаас үд дунд болж байгааг ойлгов.

Энди дизель хөдөлгүүрийн чимээг урьдын адил чагнах бөгөөд чимээ хуваагдахад түүний найз нөхөр нь ням гаригийн тоглолтонд туршлагатай хамгаалагч өрсөдцөгчийнхөө хийх үйлдүүдийг тоондог шиг бүхнийг зөв тооцоолсныг ухаарлаа. Ачааны тэрэгний хагас нь мод тээвэрлэх замаар орж радио станцын ар тал руу ирэх аж.

Энди ээлжит шармалаа гүнзгий сороод чадах чинээгээрээ амьсгалаа удаан барьсны дараа гаргав. Ёзоорыг харамсангуй хаяад гишгэлээ. Утаа (хичнээн амттай ч гэсэн) түүний байрлалыг зааж өгөхийг хүссэнгүй.

Шеф би чамд хайртай.

Энди Сандерс "калаш" бууныхаа гал хамгаалагчийг буулгалаа.

9

Мод тээвэрлэх замыг нарийн гинж хаажээ. Эхний тэрэгний жолоог барьж явсан Дентон тоормос гишгэлгүй зүгээр л тас дайран гарав. Дараа нь тэр түүний араас хоёр дахь машин (Мел жолоодно) ой руу гүнзгий орлоо.

Гурав дахь машины жолоон дээр Стюарт сууна. Тэр Литл-Битч-роудын голд зогсоод толгой сэжин ХБЭ цамхаг руу зааснаа Ферн ба хаалганы хооронд шахуулсан Рэндолфыг харав. Даргын өвдөг завсар ХК буюу "хеклер-ба кох" хагас автомат карбин буу байв.

-Дахиад хагас миль яв. Дараа нь замын хажуу руу гараад хөдөлгүүрээ унтраа гэж Рэндолф тушаах үед цаг 11.35-ыг зааж байв. Маш сайн. Цаг хангалттай.

-Ямар төлөвлөгөө байна вэ? гэж Ферн асуув.

-Төлөвлөгөө үд дундыг хүлээх. Буун дуу сонсогдмоц шууд дайрч ар талаас нь эзэлю.

-Энэ ачааны тэрэгнүүд дэндүү чимээтэй юм. Тэр залуус сонсвол яах ю? Тэгвэл бид өнөөхөө алдана. Юу билээ дээ? Гэнэтийн байдлыг давуу тал? гэж Рожер хэлэв.

-Тэд биднийг сонсохгүй гэж Рэндолф итгүүлээд: -Тэд студиц сууж хөргөсөн агаараас таашаал аван зурагт үзэж байгаа. Тэдэнтэй юу учирахыг ойлгох ч үгүй.

-Бид хуягт хантааз юмуу тиймэрхүү юм авах байсан юм биш үү? гэж Стюарт асуув.

-Халуун өдөр бие дээрээ хүнд юм чирэх хэрэг юу ю? Энэ Чич ба Чон нар үхсэн гэдгээ ойлгож ч амжаагүй байхдаа тамд очсон байх болно. (Энэ нь америкийн хошин шогийн хослол).

10

Үд дунд болохоос хэдхэн минутын өмнө Жулия эргэн тойрноо харахад Барби үгүй байв. Фермерийн байшинд ирэхэд тэр ' 'Эглантери' '-гийн фургонд лаазалсан хүнс ачиж байхтай таарлаа. Харилцааны компаниын хулгайлагдсан микроавтобусанд хэдэн цүнх хийв.

-Чи юу хийж байгаа юм бэ? Бид дөнгөж өчигдөр орой ачаагаа буулгасан гэж тэр асуулаа.

Барби түүн рүү эргэж харав. Царайд нь инээмсэглэлийн сүүдэр ч үгүй бөгөөд ихэд түгшсэн харагдана.

-Бид буруу юм хийснийг би бодож, бас мэдэж байна. Хайрцагт ойрхон байгаа нь нөлөөлж байгаа гэж баталж чадахгүй. Гэвч Растигийн ярьсан томруулдаг шил яг миний толгой руу чиглэсэн бөгөөд тун удахгүй нар мандаж тэр шилээр тусах юм шиг мэдрэмж төрөөд байна. Энэ тал дээр би алдаж байгаа байх гэж найдах юм.

Эмэгтэй түүн рүү нүд салгалгүй ширтэнэ.

-Өөр юу ачих ю? Би чамд туслая. Буулгаж бол хэзээ ч амжина.

-Тийм дээ. Бид буулгаж хэзээ ч амжина гээд Барби хүчээр инээмсэглэв.

11

Мод тээжрлэх зам аль хэдийн хаягдсан байпгин байх хожуул цоорхойд тулаад дуусав. Ягаан өнгийн хоёр ачааны тэрэг тэнд очоод зогсоход цагдаа нар кабинаас гарлаа. Эхний тэрэгний ачаан дээрээс "Аюулгүй байдлын яам" гэсэн бичигтэй урт хүнд цүнхнүүд буулгалаа. Нэг цүнхэн дээр нь хэн нэгэн наргианч эр "Аламог санаарай" гэж хар үзгээр нэмж бичсэн байв. Цүнхнүүдэд хагас автомат ХК карбин буунууд ба найм үсэрдэг урт буу болоод сумнууд, сумнууд, сумнууд.

-Фредди бид хуягт хантааз юмуу тиймэрхүү юм авах ёстой байсан юм биш үү? гэж Тагжгар Норман асуув.

-Бид тэдний араас нь довтолно, санаа зовох зүйлгүй гэж Фредди хариулахдаа хоолойд нь өөрөө ч мэдрэхгүй байгаа итгэл дуурсана гэж найдлаа. Ходоод нь булгилна.

-Бид тэдэнд бууж өгөх боломж өгнө биз дээ? Ноён Сандерс хотын захиргааны гишүүн байсан болохоор би тэгж хэлээд байна гэж Мел асуув.

Фредди энэ тухай бодлоо. Бас дэлхийн хоёрдугаар дайны дараа албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан гурван цагдаагийн зураг байдаг Честерс-Миллийн алдар гавьяаны

самбарын тухай бодов. Түүний гэрэл зураг энэ самбар дээр гарч ирээсэй гэж огт хүсэхгүй байлаа. Нэгэнт Рэндолф дарга эю тал дээр ямар ч тушаал буужаагүй тул өөрийн үзэмжээр хөдлөхөөр шийдэв.

-Хэрэв тэд гараа өргөх юм бол амьдрах болно. Хэрэв тэд зэвсэггүй бол амьдрах болно. Өөр ямар юг тохиолдолд тэд үхю. Эсэргүүцэх зүйл байна уу?

Дургүшгэх дууг олж сонссонгүй. Үд дунд болоход дөрвөн минут үлджээ. Бараг цаг үлдсэнгүй.

Фредди бүх эрчүүдийг тойруулж хараад (түүний дотор хавтгай хөх, хатуу царайтайн улмаас эрэгтэй гэж тооцож болохоор Лоренийг) гүүгий санаа алдан тушаал буулгав.

-Миний араас. Нэгийн цуваагаар. Ойн захад зогсож цааш яахаа харцгаая.

Рэндолфын хортой царс мод ба ороонго өвсний тухай болгоомжлол үндэсгүй байжээ. Модод бие биенээсээ хангалттай зайтай учир хэдийгээр зэвсэг ба сум багагүй жинтэй байсан ч цагдаа нар түргэн урагшлав. Хэрэв зам дээр арцны бут таарсан бол ийм түргэн ба дуу чимээгүй явж чадахгүй байсан гэж Фредди бодлоо. Бүх юм сайхан болно гэх мэдрэмж төрж эхлэв. Үнэнийг хэлэхэд одоо радио станцад бушуухан хүрэх гэж тэсч ядаж байв. Ажиллагаа нэгэнт эхэлсэн болохоор айдсын эрүүхэй гэдсэн дотор нь дэвэхээ больжээ.

Бүх юм хөнгөн өнгөрнө. Хөнгөн бөгөөд тайван. Дараа нь пан. Тэд юу болсныг ч мэдэж амжихгүй.

12

Зоорины барилгын арын өндөр өвсөн дотор цэнхэр бүхээгтэй фургоны ард нуугдсан Шеф, тэднийг хөгшин Вердрогийн нурсан балгас аажмаар газартай тэгширч байгаа ойн хожуул цоорхойг дөнгөж орхиход нь олж сонсов. Аюулын улаан түвшиний бүсэд байрлах хар тамхиар хурцалсан сонсгол болон тархинд тэд ус уухаар ирж яваа үхрийн сүргийг санагдуулахуйц шуугиантай.

Тэр фургоны урд хэсэгт очоод автоматын голыг эмжээр түшүүлэн тавьж өөрөө сөхрөн суув. Урьд нь "Бурхны дайчин"-д өлгөсөн гар бөмбөгнүүд одоо газарт хэвтэнэ. Шефийн батта шавсан туранхай нуруун дээр хөлс гялалзана. Гараашийн алсын удирдлагыг мэлхийний зурагтай унтлагын өмднийхөө бүсэнд хавчуулжээ.

Яарах хэрэггүй. Тэд хэдүүлээ байгааг чи мэдэхгүй. Шууд битгий буудаарай. Бүгд ойгоос гарсных нь дараа бүтдийг нь түргэн хяргаад өгнө гэж өөртөө захив.

"Бурхны дайчин"-ы хэдэн дайзтай сумыг тэр өмнөө зулж тавиад Эндид шүгэлдэх хэрэг гарахгүй байх гэж найдна. Тэр өөрт нь ч ийм хэрэг гарахгүй гэж найдна. Тэд өнөөдөр ямар ч гэсэн мултарч чадаад маргааш шинэ тулалдааныг хүлээн авч мэднэ.

13

Дентон ойн захад ирээд гацуурын мөчрийг бууны гол төмрөөр хажуу тийш болгоод гадагш

шагайлаа. Өндөр ургасан өвсөөр хучигдсан талбай харагдав. Голд нь дамжуулах цамхаг байх бөгөөд нам долгионыг цацруулах тул шүдний ломбо түүнээс болж чичрэв. Цамхагийг дээр нь "Өндөр хүчдэл" гэсэн бичиг бүхий самбар өлгөсөн хашаагаар хүрээлжээ. Фреддигийн зүүн гар талд радиостудийн нэг давхар тоосгон байшин байна. Тэр хоёрын дунд улаан ханатай том амбаар харагдана. Амбаар зоорины үүрэг гүйцэтгэдэг байх гэж Фредди тооцов. Эсвэл хар тамхи үйлдвэрлэх газар. Эсвэл аль алиных нь зорилгоор.

Түүний дэргэд Марти Арсено гарч ирлээ. Дүрэмт хувцасны суган дор хөлсний хар толбо тодорно. Нүдэнд нь айдас хуржээ.

-Энэ фургон яахаараа энд байдаг юм бэ? гээд бууныхаа амаар заав.

-Энэ чинь "Дугуйн дээрх хоол" фургон байна. Өнчин ядуу хүмүүст зориулсан. Эсвэл чи хотод түүнийг хараагүй юм уу?

-Харсан. Ачаа буулгахад нь тусалж байсан. Би өнгөрсөн жилээс Ариун Гэм цайруулагчийн сүмийг илүүд үзэж католик сүмд явахаа больсон. Тэр яагаад гараашгаа биш энд байна вэ?

-Би яаж мэдэх юм? Надад хамаа байхгүй. Тэр залуус студид байгаа.

-Чи яагаад тэгж бодов?

-Яагаад гэвэл тэнд зурагт үзэж байгаа. Бүрхүүлийн дэргэд гэдэг том шоуг бүх сувгаар нэвтрүүлж байгаа. Марти ХК буугаа өргөөд:

-Би энэ фургонд хэдэн сум зоож болох уу? Минажүүлсэн байж мэдэх юм. Эсвэл тэд дотор нь суусан байж болно. Дентон түүний бууг доош нь дараад:

-Ариун Есүс минь, чи солиоров уу? Бидний энд ирснийг тэд мэдэхгүй. Гэтэл чи барьж өгөх нь үү? Танай ээжийн төрүүлсэн өөр ямар нэг хүүхэд амьд торниж чадсан уу?

-Тонил чи гэж Марти тургиснаа жаахан бодоод: -Ээжтэйгээ хамт гэж нэмлээ.

Дентон эргэн тойрныг харна.

-Урагшаа. Талбайгаар студи руу. Арын цонхнуудыг хараарай. Хэрэв тэд цонхоор харагдвал бууд. Сайхан хөвөөрэй гэж хэлээд тэр инээлээ.

Үргэлж тун бага ярьдаг Обри Таул ганцхан үт хэлэв.

-Харцгаая.

Литл-Бидж-роуд дээр үлдсэн ачааны тэргэнд ноёрхох удаан чимээгүй байдлыг Ферн эвдэв. - Би юу ч сонсохгүй байна.

-Сонсох болно. Жаахан хүлээ гэж Рэндолф зүтгүүлнэ. Цагийн зүү 12 цаг 02 минутыг зааж байлаа.

15

Гашуун хүмүүс модон доороос гараад талбайг ташуулдан студи чиглэхийг Шеф ажиглана. Гурав нь дүрэмт хувцастай, дөрөв нь цэнхэр хувцас өмссөн нь дүрэмт хувцаст тооцогдож байгаа юм байна гэж Шеф тааварлав. Тэр Лоренийг таньлаа. (өвс зардаг байсан тэр хол цагийн худалдан авагч) Бас нутгийн хуучин эдлэлийн худалдаачин Тагжгар Норман. Жижгээгийн

найз ба түүний мөн л эртний түнпгүүдийн нэг Мелийг бас танив. Саяхан өөд болсон Фрэнкигийн найз болохоор энэ Мел түүний Сэмийг хүчиндсэн хүмүүсийн нэг гэсэн үг. Одоо яая гэхэв. Энэ өдрөөс хойш тэр хэнийг ч хүчиндэж чадахгүй.

Долоо. Ямар ч гэсэн энэ талд ийм хүн байна. Сандерсын талд хэд байгааг бүү мэд.

Дахиад хүн гарч ирэхийг Шеф хүлээв. Хэн ч гарч ирсэнгүй. Тиймээс тэр өндийж фургоны хамар дээр тохойлдоод хашгирлаа.

-Эх дэлхийг цөл болгон хувиргахаар уур хилэндээ шатсан догшин бурхны өдөр ингээд ирлээ.

Тэдний толгой түүн рүү эргээд хоромхон хугацаанд тарж зугтах юмуу зэвсэгээ өргөхийг оролдолгүй хөшив. Тэд ямар ч цагдаа биш бөгөөд нисэхээ мэдэхгүй газарт хөглөрсөн тэнэг шувууд болохыг Шеф харж байв.

-Эх дэлхийгээс нүгэлтнүүдийг хяргах өдөр. Исаигийн номны 13-р хэсэг. Зулбасаганууд аваарай.

Шеф ингэж хашгираад гал нээж бууны амыг баруун зүүн тийш эргүүлэв. Дүрэмт хувцастай хоёр цагдаа ба Тагжгар Норман нар эвдэрсэн хүүхэлдэй шиг хойшоо шидэгдээд цус нь өвс будлаа. Амьд үлдсэн хүмүүс саатлын байдлаас гарав. Хоёр нь ой руу гүйлээ. Лорен ба дүрэмт хувцастай сүүлчийн цагдаа студи рүү. Шеф тэднийг хараагаад дахин гал нээв. "Калашников" хэд тургиснаа чимээгүй боллоо. Дайз хоосорчээ.

Лорен хүзүүн дээр нь шумуул хазсан юм шиг өөрийнхөө хүзүүн дээр алгасанаа өвс рүү нүүрээрээ шургав. Хөл нь хоёр удаа таталдаад чимээгүй боллоо. Нөгөө халзан цагдаа студид хүрчээ. Ойд нуугдсан хоёр нь Шефийн сонирхолыг татсангүй. Тэр халзанг алдахыг үл хүснэ. Хэрэв халзан булан тойрох юм бол Сандерсийг олж хараад араас нь буудах болно.

Шеф дүүрэн сумтай дайз аваад хоосорсон дайзны оронд нүхэнд шургуулав.

16

Халзан гэж нэрлэгдээд байгаа Фредерик Говард Дентон ХБЭ студийн арын хананд хүрэх үедээ юу ч бодож чадахгүй болжээ. Лорен хүзүүндээ буудуулан газарт унахыг харсан ба ингээд түүний үр дүнтэй байж мэдэх санаа бодол дуусав. Фредди ганцхан юмыг мэдэж

байлаа. Түүний гэрэл зураг алдарын самбарт өлгөгдөхийг үл хүснэ. Нуугдах газар олох ёстой, өөрөөр хэлбэл студид орох ёстойг ойлгов. Хаалгыг оллоо. Хаалганы цаана ямар нэг хөгжмийн хамтлаг "Түүний титмийг тойруулан гараа нийлүүлцгээе" шашны дууг тоглоно.

Фредди бариулаас зуурав. Дарагдсангүй.

Цоожтой.

Тэр буугаа унагаагаад гараа өргөж хашгирлаа.

-Би бууж өгье. Битгий буудаарай. Би бууж...

Түүний бүсэлхий рүү гурван хүнд цохилт ирэв. Хаалган дээр улаан юм цацагдахыг хараад хуягт хантаазаа санах хэрэгтэй байжээ гэж бодож амжлаа. Хөл нь нугарсан ч тэр нэг гараар хаалганы бариулаас зуурсаар байсан бөгөөд яагаад гэвэл хорвоо дэлхий түүнээс хурдтай холдож байна. Тэр хэн байсан болоод түүний мэддэг байсан бүхэн ганцхан гэрлийн хурц цэг болж нэгдлээ. Дараа нь энэ цэг бөхөв. Гар бариулаас гулгалаа. Фредди хаалга налаад сөхөрсөн чигээр үхжээ.

17

Мел бас юу ч бодохгүй байв. Марти, Жорж ба Тагжгар Норман нар автоматын ээлжинд хяргуулж өвсөнд өнхрөхийг харсан. Бас нэг сум яг нүднийх нь өмнүүр исгэрэн өнгөрөхийг мэдэрсэн бөгөөд ийм юм санах бодох үйл ажиллагаанд нэмэр болно гэж үү дээ.

Мел зүгээр л зугтлаа.

Нүүрийг нь шавхуурдах мөчрийг үл анзааран моддын дундуур хугалан зүтгэв. Нэг унасан ч үсэрч босоод ачааны тэрэг зогсч байгаа хожуулын цоорхой хүртэл зогсолтгүй гүйлээ. Эрүүл ухаан түүнд кабинд үсрэн ороод хөдөлгүүрээ асаан зугтахыг хэлж өгсөн ч Мел ба эрүүл ухаан хоёр одоо нөхөрлөхөө больжээ. Хэрэв радиостанцыг ар талаас нь довтлохоор зэхэж байсан дайрах багаас амьд үлдсэн хоёр дахь хүн түүний мөрнөөс зуурч том нарс модны голыг мөргүүлээгүй бол тэр энэ чигээрээ түлээний замаар Литл-Битч хүртэл гүйх байв.

Энэ бол номын дэлгүүрийн эзний дүү Обри Таул байлаа. Заримдаа ахдаа тавиур дээр ном өрөхөд нь тусалдаг цайвар өмдтэй том биетэй болхи эр. Обри ярих нь ховор тул хүмүүс түүнийг тэнэг гэж боддог. Харин одоо бол тэр тийм харагдахгүй байна. Айж сандарсан шинж ч алга.

-Би эргэж очоод тэр муу жингэрийн хүүг сумаар хадмаар байна гэж Обри Мелд хэллээ.

-Найз минь амжилт хүсье гээд Мел модны голоос салж мод тээвэрлэх зам руу эргэв.

Обри түүнийг дахин модны голд наасан бөгөөд энэ удаад хүчтэй түлхлээ. Нүд дарсан үсээ сэжээд буугаа Мел рүү чиглүүлэв.

-Чи хаашаа ч явахгүй.

Радиостанцаас дахиад буун дуу хадав. Дараа нь орилж хашгирна.

-Чи үүнийг сонсож байна уу? Чи дахиад тийшээ очмоор байгаа юм уу? гэж Мел асуув.

Обри түүн рүү тэвчээртэй харна.

-Чамд тийшээ заавал оч гэж хэлэхгүй. Гэвч чи намайг галаар хаацайлж өгөх ёстой. Ойлгож байна уу? Чи үүнийг хийхгүй юм бол би чамайг буудна.

18

Рэндолф даргын уруул хуурай инээмсэглэл болж мурийв.

-Эсрэг тал тулалдаанд татагдан орлоо. Бүх юм төлөвлөгөө ёсоор болж байна. Стюарт яваарай. Радио станцын орцны зам руу эргэ. Бид гарч студиэр дамжина.

-Хэрэв тэд зооринд байвал яах вэ?

-Тэгвэл бид мөн л араас нь цохино. Одоо явж үз. Хоцорч болохгүй.

Стюарт Боуи явлаа.

19

Зоорины байшингийн араас хадах буудалцааныг Энди сонсож байв. Гэвч Шеф шүтэлдээгүй тул тэр модны ард байсан газраа зогссоор байлаа. Эндид өөрт нь асуудал үүссэн учир Шефийн бүх юм зүгээр гэж найдна. Учир нь ягаан ачааны тэрэг орцны зам руу эргэлээ.

Энди модыг тойрон хөдөлж бууны ам үргэлж тэр болоод ачааны тэрэгний дунд байхаар хөдөлнө. Тэрэг зогслоо. Кабины хаалга нээгдэж дөрвөн хүн газарт үсрэн буув. Тэдний гурав нь түрүүнд ирсэн хүмүүс шиг Эндид санагдав. Ноён тахиа яг ирсэн. Түүний ногоон хаймран гутлыг Энди хаана ч танина. Гашуун хүмүүс. Энди тэднийг Шефийн ар талаас хэзээ ч оруулахгүй.

Тэр модны араас гараад орцны замаар алхлаа. Буугаа энгэртээ барьж, амыг нь тэнгэр рүү чиглүүлжээ. Хөл дор нь хайрга шажигнавч түүнийг сонсоно гэж айх зүйлгүй. Стюарт машинаа асаагаастай орхисноос гадна студид сүмийн дуу нижигнэнэ.

Энди буугаа гашуун хүмүүс рүү чиглүүлээд бага зэрэг хүлээв. "Бие биендээ ойртог. Хэрэв ойртвол" тэд үнэхээр студийн хаалга руу дөхөөд бөөгнөрлөө.

-Пөөх энэ чинь ноён Тахиа ба түүний найз нар байх чинь. Жаалууд минь ямархуу байна даа? гэж Энди Жон Уэйний аялгаар хэлэв.

Тэд эргэлээ.

-Шеф чиний төлөө гээд Энди гал нээв.

Эхний ээлжээр тэр ах дүү Боуи ба ноён Тахиаг хяргажээ. Рэндолфыг зөвхөн шүргэв. Тэр Шефийн сургасан ёсоор хоосон дайзыг буунаас салгаад бүснээсээ дүүрэн сумтай дайз авч нүхэнд түлхлээ. Рэндолф даргын баруун хөл гараас цус асгарах бөгөөд тэр студийн хаалга руу мөлхөв. Тэр эргэж харахад хөлстэй нүүрэн дээр нь асар том болсон нүд нь гялалзана.

-Энди гуйя. Бидэнд чамд хор хүргэлгүйгээр хотод авчрахыг тушаасан. Чи цаашдаа Жимтэй ажиллах ёстой.

-Яг зөв. Чи хэний чихэн дээр цэцэг ургуулж байгаа юм бэ? Та нар энэ бүхнийг авахыг хүссэн гээд Энди толгой дохин тачигнатал инээв.

Студийн цаанаас дахиад буун дуу хадлаа. Магадгүй Шеф аюулд оржээ. Тусламж хэрэгтэй байх. Энди буугаа өргөв.

-Намайг битгий алаач. Гуйя гэж Рэндолф хашгирлаа. Нүүрээ гараар таглав.

-Есүсийн дэргэд хүлээж байгаа жигнэсэн махтай хоолныхоо тухай бодсон нь дээр. Гурван хоромын дараа чи амны цаасаа дэлгэх болно.

Богино ээлж тачигнахад Рэндолф бараг хаалга хүртэл шидэгдэв. Энди барилгыг тойрон гүйнгээ хагас суларсан дайзыг шинээр солино.

Студийн цаанаас шүтэлдэх дуу тасхийв.

-Шеф би ирж явна. Тэсээрэй би ирж явна гэж Энди хашгирлаа.

Ямар нэг юм дэлбэрэв.

20

Обри ойн захад зогсоод цамцаа тайлж хоёр хувааснаа нэгээр нь яг Рэмбо шиг толгойгоо ороонгоо заналтай хэлнэ.

-Намайг халхал. Хэрэв чи намайг араас буудаж алах гэж байгаа бол ганц буудалтаар алаарай. Яагаад гэвэл хэрэв алж чадахгүй бол би чамд заавал хүрч очоод хоолойг чинь хэрчинэ.

-Би халхлана гэж Мел амлав. Халхлана гэж ч бодож байлаа. Энд ойн захад аюулгүйг мэдрэв. Ямар ч гэсэн талбайд байснаас дээр.

Обри ойр ойрхон амьсгалж өөрийгөө тулалдаанд бэлдэн зоригжуулна.

-Энэ муу метэд дурласан солиотой амьтан зүтээр өнгөрөхгүй. Хар тамхинд мансуурсан зулбасага гэснээ тэр дуугаа өндөрсгөж: -Солиотой мансуурсан зулбасага. Би чамайг алахаар явж байна гэж хашгирав.

Шеф "Дугуйн дээрх хоол" фургоны араас гарч хохирогчдыг үзэхээр шийдэв. Обри уушигныхаа бүх хүчээр хашгиран модон дороос үсрэн гарах үед тэр яг ой руу эргэсэн юм.

Энэ үед Мел буудаж эхэлсэн бөгөөд хэдийгээр сум хажуу талаар хол нисч байсан ч Шеф зөнгөөрөө доошоо суулаа. Ингэж суух үед гараашийн удирдлага унтлагын өмдний бүснээс гулгаад өвсөн дээр унав. Шеф түүний араас гар сунгах үед Обри автомат винтовоор гал нээлээ. Сум фургоны бүхээгийг цоолов. Нэг нь кабины зорчигчийн талын хажуугийн шилийг будаа болгоход нөгөө нь салхины шилний төмөр хүрээнээс ойж исгэрэв.

Шеф гараашийн удирдлагыг газарт орхисон чигээр хариу гал нээлээ. Гэвч одоо гэнэдүүлэх давуу байдлаа алдсан тул Обри байрандаа зогсолгүй тахир зам татуулан дамжуулах цамхаг руу хурдлав. Цамхаг түүнийг хаацайлахгүй байж мэдэх ч харин одоо Мелийн галын шугамыг нээж өглөө.

Обригийн дайз хоосорсон ба сүүлчийн сум Шефийн толгойг зурав. Цус урсч хуйхны хэсэг үс туранхай мөрөн дээр нь унаад хөлстэй арьсанд наалдав. Шеф бөгсөөрөө суун тусаад буугаа алдсан ч тэр дороо шүүрлээ. Тэр ноцтой шархадсан гэж бодоогүй ч хэрэв Сандерс амьд бол ирэх цаг яг мөн гэж бодов. Шеф амандаа хоёр хуруугаа хийгээд пгүгэлдлээ.

Мел дахиад ойн захаас буудаж эхлэх үед Обри дамжуулах цамхагийг тойруулсан хашаанд хүрэв. Энэ удаад тэр фургоны арын хэсгийг бай болгожээ. Сум төмөрнүүдийг цоолно. Бензиний сав дэлбэрч гал дүрэлзээд бүхээгийг хучлаа.

Шеф ар нурууг нь халуун төөнөхийг мэдэрч бас дотроо гар бөмбөгний тухай бодож амжив. Дэлбэрэх болов уу? Хашаанд хүрсэн хүн түүн рүү онилж байхыг хараад гэнэт сонголтын өмнө тулгарсанаа ойлголоо. Эсвэл хариу гал нээх эсвэл гараашийн удирдлагыг шүүрэх. Тэр удирдлагыг сонгов. Хуруу нь дөнгөж атгаж автал эргэн тойрны агаар нүдэнд үл үзэгдэх зөгийн дүнгэнээнээр дүүрлээ. Нэг зөгий мөрөн дээр нь хатгаж хоёр дахь нь сүвээ рүү нь зоогдоод гэдэс дотор эмх замбараагүй болов. Шеф Буши газарт унаж өвсөн дээгүүр өнхрөхөд удирддага дахиад гараас нь мултарлаа. Түүн рүү гараа сунгах үед хоёр дахь удаагаа зөгийн сүрэг дүнгэнэв. Шеф гараашийн удирдлагыг тэндээ орхиод өндөр өвс рүү мөлхөх ба одоо зөвхөн Сандерст найдна. Өнөөх эр дамжуулагчийн хашаанаас түүн рүү айсуй. Долоон гашуун хүнээс ганцхан нь зоригтон. Тиймээ ганцхан гэж Шеф бодлоо. "Бурханы дайчин" одоо маш хүнд болжээ. Өөрийнх нь бие ч хүнд болсон хэдий ч Шеф өвдөглөж суугаад гохоо дарж чадав.

Юу ч болсонгүй.

Эсвэл дайзаа дуустал буудчихсан юмуу, эсвэл сум гацчихсан юмуу.

-Тэнэг зулбасага. Солиорсон торхонцор. Мэдэх болноо чи... гэж Обри Таул хэллээ.

-"Клодетт" гэж Сандерс хашгирав.

Обри эргэсэн ч хожимджээ. Богино ээлж тасхийхэд хятадад үйлдвэрлэсэн 7,62 калибрийн дөрвөн сум Обригийн толгойн ихэнх хэсгийг мөрнөөс нь тасдав.

-Шеф гэж хашгираад Сандерс найз нь сөхрөн суух тэр газар руу гүйв. Түүний мөрнөөс, сүвээнээс, зовхиноос цус урсана. Нүүрний зүүн хагас тэр чигээрээ улаан нойтон болж гялалзана. - Шеф Шеф гээд Сандерс сөхрөн сууж түүнийг тэврэв. Дайрах багийн бүх

гишүүдээс амьд үлдсэн ганцхан хүн болох Мел Сирлс ойгоос гарч тэдэн рүү болгоомжтой гэтэхийг хэн нь ч харсангүй.

-Удирдлагыг ав гэж Шеф шивнэв.

-Юу гэнэ ээ? гээд Энди "клодетт"-ийн гох руу харлаа. Гэхдээ Шеф өөр юм хэлж байгаа бололтой.

-Гаражийн удирдлагыг ав гэж Шеф тодруулав. Түүний зүүн нүдийг пус бүрхсэн ч харин нөгөө нүд нь Сандерсыг

тасралтгүй харна.

Өвсөнд хэвтэх гаражийн удирдлагыг Энди олж хараад өргөж Шефэд сунгав. Тэр шууд л базаад авлаа.

-Чи...бас...Сандерс.

Энди Шефийг тэвэрлээ.

- Шеф би чамд хайртай гээд тэр түүний хуурай цусан дусалтай уруулыг үнслээ.

-Хайртай...чамд...бас...Сандерс.

-Хүүе гомонуудаа гэх Мелийн дуу чөтгөрийн баясалтайгаар хадав. Тэр тэднээс ердөө аравхан ярд зайтай зогсоно. -Өрөө захиалаарай. Надад өөр сайн санаа алга. Тамд өөрсдөдөө өрөө захиал.

-Одоохон...Сандерс...одоохон.

Мел гал нээв. Сумнууд Энди Шеф хоёрыг хоёр тийш чулуудлаа. Гэвч үүнээс өмнө тэдний барьцалдсан гар "нээх" гэсэн бичигтэй цагаан товчийг дарж амжжээ.

Цагаан дэлбэрэлт эргэн тойрныг хаман авлаа.

119 дүтээр зам ба зүүн өмнө зүгээс буун дуу хадах үед Честерс-Миллийн дүрвэгсэд алимны цэцэрлэгийн захад салхинд гарч явав.

-Энэ Литл-Битч-роуд дээр дуугарч байна. Бидэнд дуран байхгүй нь харамсалтай гэж Пайпер хэлэв.

Бөөрөн дээрээ "Дугуйн дээрх хоол" гэсэн бичигтэй фургоны бензиний сав дэлбэрсний дараах шар утаан баганыг харахад дуран хэрэггүй байжээ.

Твитч тахианы рагуг хуванцар халбагаар идэж байв.

-Тэнд юу болоод байгааг бүү мэд. Гэхдээ энэ радиостанц дээр болж байгаа нь багтай.

Расти Барбигийн мөрөөр тэврээд:

-Хий тэнд байгаа юм байж. Тэд түүнийг хар тамхи үйлдвэрлэхэд зориулан нөөцөлжээ. Тэнд хотын хийний нөөц хадгалагдаж байгаа юм байна.

Юу ямар учиртайг ойлгоход Барбид ганц хором хүрэлцэв. Хамгийн муу зүйл дайрахаас өмнө ганцхан хором. Тэднээс дөрвөн милийн зайнд утаатай тэнгэр рүү цагаан оч гялсхийв. Доошоо биш дээшээ цохисон цахилгаан. Тэр дороо аймшигтай дэлбэрэлт өдрийн гэрлийг нүхэллээ. Галын улаан бөмбөлөг эхлээд ХБЭ-гийн дамжуулах цамхагийг, дараа нь ойр хавийн ойг, эцэст нь өмнө ба умар зүгт тархахын хэрээр бүх тэнгэрийн мандалыг залгив.

Блэк-Ридж дээр байсан хүмүүс хашгирсан ч өөрийгөө ч сонсохгүй байлаа. Тэдний дуу наян фунт тэсрэх бодис ба арван мянган галлон химийн дэлбэрэлтээс бий болсон аянга буухтай төстэй улам өсөх дүнгэнээнд живж одов. Тэд нүдээ хааж найгаад идэж амжаагүй хавчуургатай талхан дээгүүр гишгэж ундаануудаа асгалаа. Терстон Элис Эйден хоёрыг гар дээрээ өргөх үед Барби түүний царайг харлах тэнгэрийн дэвсгэр дээр ганц хором харж амжлаа. Энэ бол айдаст бүрэн автсан хүний сунаж ангайсан царай бөгөөд өмнө нь нээгдэх тамын хаалга болоод түүний цаана хүлээж байгаа галан далайг харсан мэт.

-Бид байшиндаа буцах ёстой гэж Барби хашгирав.

Жулия уйлаад түүнд наалдлаа. Тэдний ард Жо цурхиран уйлах ээждээ туслах гэж оролдоно. Энэ хүмүүс явж чадсангүй. Ямар ч гэсэн хэсэг хугацаанд.

Ойрын гурван минутанд Литл-Битч-роудын ихэнхи хэсэг оршин байхаа болих баруун өмнөд хэсгийн шаравтар цэнхэр тэнгэр хар болж хувирав. Энэ үед Барбид "Одоо бид томруулдаг шилэн дор орлоо" гэж төгс тайвнаар бодох хугацаа гарчээ.

Дэлбэрэлт хотын төвийн бараг хүнгүй байсан хэсгийн бүх цонхыг хагалж, цонхны хаалтуудыг эвдэж, утасны шонгуудыг булгалж, хаалгыг нугасаар нь тас татаж, шуудангийн хайрцагуудыг бутлав. Том Жим Ренни ба Картер нарт зөвлөгөөний танхим газар хөдлөлтийн үеийнх шиг доргих мэт санагдав.

Зурагт ажилласаар байлаа. Вольф Блитцер асуулт тавих бөгөөд түүний дуунд жинхэнэ түгшүүр илэрчээ.

-Энэ юу вэ? Андерсон Куперээ? Кэнди Кроули? Чеп Майерсаа? Соледад Брайан аа? Юу болоод байгааг мэдэх хүн байна уу? Юу болоод байна вэ?

Бүрхүүлийн дэргэд Америкийн мэдээний албаны бүх одод Честерс-Милл рүү харан зогсоно. Дүрс бичлэгийн дурангууд тэдний нурууг харуулах ажээ. Харин тэд нүүрээ гараар таглаад Бүрхүүлийн дэргэд байгаа хүмүүсийн цаад руу харна. Нэг дүрс бичлэгийн дуран дээш өргөгдөхөд өргөөшөө сунаж байгаа аймшигтай хар утаан үүл дэлгэцийг дүүргэв.

Картер үсрэн бослоо. Том Жим түүний бугуйнаас шүүрэв.

-Байдал хэр муу байгааг харахад нэг нүдээр шагайх л хангалттай. Тэр дороо эргэж ир. Бид атомын бөмбөгийн хорогдох байранд нуугдаж чадна.

-За.

Түүнийг үүдний танхимыг туулах үед гол хаалганы хагарсан шилний үйрмэгүүд хөл дор шажигнана. Шатны тавцан дээр үсрэн гараад амьдралдаа төсөөлж чадахгүй тийм юмыг олж харлаа. Энэ үзэгдэл түүнийг хүүхэд насанд нь эргүүлж тэр хоромхон зуур хөшөөд "Энэ бол хэн нэгний үзсэн хамгийн хүчтэй, хамгийн аймшигтай аянга байна. Гэхдээ түүнээс ч дор" гэж бодов.

Баруун талын тэнгэр хар бэхэн утаан үүлээр хүрээлэгдсэн улбар улаан там болжээ. Агаарт шатсан хийний үнэр ханхлана. Арван ган бутлагч бүрэн хүч чадлаараа ажиллах мэт чимээ хадна.

Толгой дээрх тэнгэр нисэх шувуудаар харлажээ.

Хаашаа ч нисэх газаргүй эдгээр шувуудын дүр Картерыг бодит амьдралд эргүүлэн авчирлаа. Дараа нь салхи нэмэгдэхийг мэдрэв. Честерс-Миллд салхи болоогүй зургаа хоносон. Харин энэ халуун, новшийн, шатсан мод ба өмхий хийгээр үнэртэх салхи.

Аварга том хугарсан царс мод гол гудамжинд газардахад түүний мөчир аль хэдийн тог гүйхээ больсон цахилгааны шугамуудыг тас татав.

Картер буцаад гүйлээ. Том Жим зөвлөгөөний танхимын хаалган дээр зогсох бөгөөд махлаг нүүр нь хувхайрч айсан байх ба анх удаа өөртөө итгэлгүй болжээ.

-Доошоо атомын хорогдох байр руу. Тэр ирж явна. Галан шугам айсуй. Энд ирэхдээ хотыг бүх юмтай нь залгина гэж Картер хашгирлаа.

Том Жим гаслан дуу алдав.

-Энэ тэнэгүүд юу хийчихэв ээ?

Картерт ямар ч хамаагүй. Хэн нэгэн юу хийсэн байлаа ч одоо өөрчлөх аргагүй. Хэрэв тэд яарахгүй бол өөрсдөө ч дуусах болно.

-Доор агаар цэвэрлэх төхөөрөмж байгаа юу босс оо?

-Тийм.

-Цахилгаан үүсгүүрт холбогдсон уу? -Мэдээж.

-Үүний төлөө есүст талархья. Бидэнд боломж гарч мэднэ.

Том Жимийг хурдан хөдөлж хоргодох байр руу буухад нь туслангаа Картер тэр доор амьдаараа шарагдахгүй хэмээн найдах ажээ.

"Дипперс" шөнийн клубийн нээлттэй хаалга асар хүчтэй хаагдлаа. Шилэн хаалт хаалганаасаа үйрмэг болон бут үсэрч нисэхэд өрөөний гүнд бүжгийн талбай дээр зогсч байсан хүмүүс оногдов. Генри Моррисоны дүү Уитэд хамгийн хүнд туссан бөгөөд шилний хагархай түүний венийн судсыг тас татав.

Хүмүүс том дэлгэцтэй зурагтыг мартаад үүд рүү харайлаа. Цус нь асгаран шалбааг болж, түүн дээрээ үхэж байгаа хөөрхий Уит Моррисоныг тэд гишгэлэв. Хаалган дээр бөглөрөл үүсч сэрийсэн хагархай шилнүүд олон хүнийг огтлов.

-Шувууд, бурхан минь, шувуудыг хараач гэж хэн нэгэн хашгирлаа.

Олонхи нь дээшээ биш харин баруун тийш харах бөгөөд тэндээс тэнгэрийн доогуур галан давалгаа айсуй. Харин тэнгэр одоо шөнө дунд шиг тас хар болсон байх ба хортой агаараар ханажээ.

Гүйж чадах нэг нь шувуудаас жишээ авч 117-р замаар байдгаараа хурдлав. Хэдэн хүн тун саяхан нутгийн дөрвөн залуу Барбараг зодох гэж оролдсон хайрган зогсоол руу харайж машинаа зүглэв. Бие биенээ шүргэх машинуудын төмөр харших дуу сонсогдоно.

Велма Уинтер хуучин пикап машиндаа үсрэн орж амжсан бөгөөд хэнийг ч мөргөж шүргэлгүй зогсоолын гарц руу ухасхийлээ. Гэвч зүүн талын зам гүйлдэж байгаа хүнээр дүүрчээ. Баруун тийш харвал Литл-Бич-Роудыг залгиад яг аварга том салхин дарвуул мэт айсуй яваа галан давалгааг олж харав. Тиймээс явган хүмүүсийг нулимж орхиод жолоогоо зүүн тийш мушгилаа. Урдаа юу ч харахгүй хурдаа нэмнэ. Нялх хүүхдээ тэвэрсэн Карл Вензианог дайрав. Машин нь оволзож тэдний биен дээгүүр өнгөрөхийг Велма мэдэрсэн ч Карлагийн орилох дууг сонсохоос татгалзана. Түүний нуруу хугарч харин жаалхүү нь дарагдан үхэв. Велма ганцхан юм мэдэж байсан нь эндээс зайлах байлаа. Ямар нэг байдлаар тэр ингэж чадав.

Уулзалтын өдөр гэнэт ирсэн ертөнцийн сүйрлээр тасарлаа. Дотор байгаа хүмүүс хамаатан садантайгаа харьцахаас илүү чухал ажилтай болсоноо мэдэв. Баруун хойд зүгт аварга том мөөг хэлбэрийн утаан үүл томорч галан багана дээр сандайлах бөгөөд энэ багана одоо бараг нэг миль өндөртэй болжээ. Картер ба Том Жимийг атомын хоргодох байранд ороход хүргэсэн салхины эхний үлээлт тэднийг цохиж Бүрхүүл рүү шиддээ. (Бүрхүүлийн цаана байгаа хүмүүс энэ үлээлтийг мэдрээгүй) Гэсэн хэдий ч Бүрхүүлийн цаадах хүмүүс хойш ухрав. Ухарч чадах азтай хүмүүс.

Түүний гарыг хүйтэн хуруунууд базахыг Генриетта мэдэрлээ. Эргэж харвал Петра Сирлс байв. Петрагийн үс хавчаараасаа мултгаад хацар даган унжжээ.

-Танд баяр хөөрийн шүүс үлдсэн үү? гэж асуух үедээ тэр хүчээр хий үзэгдэл шиг инээж чадлаа. -Хоёулаа хөгжилдье тэгэх үү?

-Уучлаарай. Бид бүгдийг нь уучихсан.

-За за...гэхдээ энэ ямар ч нөлөөгүй байх.

-Надтай хамт бай хонгор минь. Надтай хамт бай. Тэгвэл чиний бүх юм сайхан болно.

Гэвч Петра хөгшний нүд рүү харах үед итгэл найдварын алийг ч олж үзсэнгүй. Үдэшлэг дуусахад ойрхон болжээ.

Харин одоо хар. Харвал танд ойлгогдоно. Найман зуун хүн Бүрхүүлд шахагдаж, тэд бүтд дээш харсан байх ба нүд нь том нээгдэж, гарцаагүй үхэл хурдлан ирж явааг харцгаана.

Энд Жонни ба Кэрри Карвер болоод "Хүнсний ертөнц"-д ажиллаж байсан Брюс Ярдли байна. Энд Тэбби Моррел байна. Түүнд өөрийн хөрөө рамын газар байдаг ч удахгүй үнс болж хувирна. Эхнэр Бонни нь бас байна. "Берпигийн их дэлгүүр"-ийн худалдагч Тоби Мэннинг Трина Коул ба Донни Барибо, Уэнди Голдстоун найз ба хамт ажилладаг багш Эллен Вейндестинтэй, сургуулийн автобуса авчрахаар явж өгөөгүй Билл Олнат есүсийг дуудан айсуй яваа галан хананаас аврахыг гуйх эхнэр Сарагийн хамт, энд Тодд Уэндслет ба Мануэль Ортега нар байна. Тэдний нүүр бүгд ертөнц угаанд живэх баруун тийш ханджээ. Шөнийн клубтээ дахиад хэзээ ч нэг ч Бостоны хамтлаг урихгүй Томми ба Уиллоу Андерсонууд энд байна. Тэднийг бүгдийг нь хар, бүхэл бүтэн хотын хүн амыг, үл үзэгдэх хананд шахагдсан эдгээр хүмүүсийг.

Тэдний ард хүмүүс эхлээд хойш огао харайж, дараа нь ухарч, эцэст нь зугтан гүйлдлээ. Тэд автобусанд анхаарал үл хандуулах ба Моттоны зам руу тэмүүлэв. Хэдэн цэрэг байран дээрээ үлдсэн ч ихэнх нь зэвсэгээ хаяад хүмүүсийн араас эргэж ч харалгүй зугтлаа. Яг л Лот Содомыг эргэж хардаггүй шиг.

Кокс зугтсангүй. Кокс Бүрхүүл рүү очоод: -Хүүе даргаа гэж хашгирлаа.

Генри Моррисон эргэж хараад хурандааг чиглэв. Нүдээрээ харж чадахгүй бөх бат таавар мэт хаалтыг гараар туллаа. Амьсгалахад ч хэцүү байв. Галан давалгаагаар үүссэн салхи Бүрхүүлийг алгадаж эргэлдээд дараа нь буцаж эргэн Бүрхүүлийг чиглэж яваа өлсгөлөн мангас руу хийсэв. Улаан нүдтэй хар чоно. Энд Моттоны хил дээр тэдний залгихыг хүсч байгаа хонинууд байна.

-Бидэнд туслаач гэж Генри хэллээ.

Кокс галан давалгааг харах бөгөөд энэ давалгаа цаад тал нь 15 минут магадгүй 3 минутын дараа хүмүүст хүрэхийг тооцов. Энэ бол зүгээр нэг түймэр юмуу дэлбэрэлт биш. Битүү болоод хангалттай оронд зайд энэ бол сүйрэл билээ.

-Ноёнтон би чадахгүй гэж тэр хариуллаа.

Генриг хариу хэлж амжаагүй байхад Жо Боксер түүний гараас зуурав. Тэр эр ямар нэг утгагүй юм үглэнэ.

-Жо боль. Зугтах газар байхгүй. Залбирах л үлддээ гэж Генри түүнд хэлэв.

Гэвч Жо залбирах бодолгүй байлаа. Тэр урьдын адил гартаа жижигхэн буугаа барьсаар байсан бөгөөд ирж байгаа тамыг дахин нэг хараад гар бууг чамархайндаа аваачих нь яг орос эргүүлгээр наадах мэт. Генри гарыг шүүрэх гэж оролдсон ч хожимдлоо. Жо гохоо дарав. Шууд үхсэнгүй. Толгойноос нь цусан оргилуур задрав. Тэр жижиг буугаа яг хамрын алчуур шиг даллан хашгирч ганхан ухарлаа. Сөхөрч суугаад гэнэт гэгээрсэн хүн шиг тэнгэр рүү хоёр гараа өргөснөө зарим газарт ховхорсон замын цагаан тусгаарлах зурвас дээр нүүрээ шаан унав.

Генри барьц алдан Кокс руу эргэж харлаа. Хурандаа түүнээс гуравхан футын зайд мөртлөө сая миллийн зайд байв. -Найз минь, би маш их харамсч байна гэж Кокс хэллээ. Памела гүйж ирэв.

-Автобус гэж тэр ойртон ирж байгаа галан давалгааны дүнгэнээнийг давж хашгирахыг оролдоно. -Бид автобусанд суугаад галыг нэвт гарахыг оролдох хэрэгтэй. Энэ бол бидний ганцхан боломж.

Генри энэ бол боломж огт биш гэдгийг мэдэж байсан ч толгой дохиод Кокс руу сүүлчийн удаа харав. (цагдаагийн цөхрөл дүүрэн аймшигт харцыг Кокс хэзээ ч мартажгүй) Памелагийн гараас хөтлөөд 19-р автобус руу гүйлээ. Харин тэдний урдаас утаан харанхуй ирж явав.

Гал хотын төвд хүрч Төв гудамжаар хурдлав. Энхтайваны гүүр ууршин алга боллоо. Толгой дээр нь захиргааны байшин дэлбэрэхэд Том Жим ба Картер хоёр атомын хоргодох байранд атгын чинээ болон атирч суув. Цагдаагийн газрын тоосгон хана эхлээд дотогшоо цөмөрсөнөө дараа нь тэнгэр рүү зад үсэрлээ. Люсьен Кэлвертийн хөшөөг сууринаас нь хуу татав. Люсьен буугаа өмнөө зоримог барьсаар шатам харанхуй руу нисэн одлоо. Номын сангийн өмнөх зүлгэн дээр байгаа хөгжилтэй бортого малгай ба гарны оронд цэцэрлэгийн шүүр бүхий хэллоуины хүүхэлдэй яг бамбар шиг дүрэлзэн шатав.

Бурхан өөрөө тоос сорогч асаачихсан юм шиг хүчтэй дүнгэнэж, хүчилтөрөгчөөр цангасан гал хорт ганц уушгаа дүүргэхийн тулд сайн агаарыг сорон авахын хэрээр аймшигт нүргээн улам хүч орно. Төв гудамжны барилгууд ээлж дараалан дэлбэрч, бараа таваар, самбар, дээврийн хучлага, цонх шил бүгд шинэ жилийн шөнийн чихэр шиг тэнгэрт нисэв. Хаягдсан кино театр, "Сандерсын хотын эмийн сан дэлгүүр", "Берпигийн их дэлгүүр", "Бензин ба зууш", номын дэлгүүр, Цэцгийн дэлгүүр, Үсчин. Оршуулгын товчоонд хамгийн сүүлийн хүүрнүүд төмөр пгургуулга дотроо яг зууханд байгаа тахиа шиг шарагдав. Гал "Хүнсний ертөнц"-ийг залгиснаар Төв гудамжаар хийх ёслолын гүйлтээ дуусгаад зогсоол дээр нь бөглөрсөн машины эзэд хашгиралдан гараар даллах "Дипперс" рүү өнхөрлөө. Тэр хүмүүсийн энэ хорвоод харсан хамгийн сүүлчийн дүр зураг нь тэдэн рүү довлон ирсэн хэдэн зуун ярд өндөр галан хана байв. Одоо дөл гол гудамжуудаар хийсч цардмал замыг нялцгай болгон хайлуулна. Тэгэнгээ Истчестер хүрч, яппи нарын байшинг үнс нурам болгосон ба дотор нь үлдсэн яппи нарыг ч тийм болгов.

Миша Берпи хонгил руу яаран гүйсэн ч хожимдлоо. Гал тогооны өрөө эргэн тойронд дэлбэрч, энэ дэлхийд харсан сүүлчийн юм нь хайлж байгаа "Амана" хөргөгч байв.

Сүйрэлд хамгийн ойрхон байсан Таркерс ба Честерсийн хил дээрх цэргүүд гал хүчгүй

нударгаараа Бүрхүүлийг харлуулан дэлдэхэд ухарлаа. Бүрхүүлийг нэвтрэх халууныг цэргүүд мэдрэв. Дулааны хэм хэдхэн хоромд хориор нэмэгдэж, ойр хавийн модны навч тэр дороо хатав. "Дотор нь атомын бөмбөг дэлбэрсэн шилэн бөмбөлгийн хажууд зогсож байгаа мэт байсан" гэж хожим тэдний нэг ярих болно.

Одоо Бүрхүүлийн дэргэд зогсож байсан хүмүүс дээр үхсэн ба үхэж байгаа шувууд унаж эхэллээ. Хэрээ, тогойлон бялзуухай, хар тодол, бор шувуу, цахлай, тэр бүү хэл галуунууд урьд нь мөргөлдөхөөс зайлсхийж тун хурдан сураад байсан өнөөх Бүрхүүлээ мөргөн зад үсэрч байв. Динсморын талбайгаар нохой муур гээд хотын амьтдын давалгаа өнгөрсөн ба тарвага, зурам, зараа ч байв. Тэдний дунд буга, болхидуу цогих хандгай, мэдээж Олден Динсморын үнээнүүд нүдээ бүлтийлгэж гай зовлонгоо мөөрч зарлан харайлгаж явна. Тэд Бүрхүүлд хүрээд түүнийг мөргөнө. Азтай амьтад нь тэр дороо үхэж, харин азгүйчүүд яс нь хугарсан хэвтэх ба хуцаж, уухилж, мяулж, бахирч байлаа.

Нэгэн цагт үзэсгэлэнгийн ялагчийн цэнхэр туузыг эзэндээ авчирч байсан гайхалтай сайхан, удам сайт үнээ Доллигоо Олли Динсмор олж харлаа. (Олли ба Долли адилхан юм байна гээд ээж нь тийм нэр өгсөн). Долли Бүрхүүл рүү хүндээр гүйх ба хэн нэгний нохой түүний цус гоожсон хөлийг хазлаа. Үнээ Бүрхүүлийг бүх хүчээрээ мөргөхөд галын дүнгэнээн дунд Олли цохилтыг сонссонгүй... тэр зөвхөн дотоод мэдрэмжээрээ сонссон ба үхэх тавилантай нохой түүн рүү дайрч хамгаалалтгүй болсон дэлэнг нь зулгаахыг харав. Энэ бол орон дээр хэвтэж байгаа үхсэн аавыгаа харахаас илүү аймаар үзэгдэл байлаа.

Нэгэн цагт түүний хамгийн хайртай амьтан байсан үнээний дүр түүнийг мансуурлын байдлаас гаргав. Энэ аймшигт өдрийг давж гарах эсэхээ тэр мэдэхгүй байсан ч оюун санаанд нь хоёр зүйл гайхалтай тод гарч ирлээ. Нэг нь дээр нь түүний талийгаач эцгийн "Ред сокс" бейсболын малгай өлгөөтэй байсан хүчилтөрөгчтэй төмөр сав. Нөгөө нь усны өрөөнд дэгээнд өлгөж орхисон Том өвөөгийн хүчилтөрөгчийн баг. Одоо удахгүй үгүй болох фермерийн байшин руугаа, бүх насаа өнгөрөөсөн байшин руугаа Олли харайлгах үед толгойд нь ганцхан бодол байсан нь төмсний зоорь. Амбаарын доор ухаж толгойн доогуур сунах төмсний хонгил зоорь хамгийн аюулгүй газар байж мэднэ.

Дүрвэгсэд алимны цэцэрлэгийн зах дээр зогссоор байлаа. Барби тэднийг байрнаас нь хөдөлгөх нь бүү хэл дуугаа сонсож ч чадсангүй. Гэвч тэр тэднийг фермерийн байшин ба машин дээр аваачих ёстой. Яаралтай.

Блэк-Ридж дээрээс бүх хотын дүр зураг нээгддэг. Тиймээс генерал довтолж байгаа армийн хөдөлгөөний болзошгүй чиглэлийг агаарын зургийн өгөгдөлөөр хардаг шиг Барби галын замыг мэдэж болохоор байв. Гал зүүн өмнө зүгт хөдөлж яваа бөгөөд Престил-Стримийн баруун эрэг дээр зогсч мэднэ. Гол хэдийгээр бараг хатсан ч галд байгалийн саад болж өгнө. Галын нүүрнээс үүссэн салхи галыг хотын хойд хэсэгт хүрэхгүй байхад тусална. Хэрэв гал Касл-Рок ба Моттоны хил хүртэл замдаа таарсан бүхнийг гутлын ул ба өсгий ч үлдээхгүй шатаах юм бол Честерс-Миллийн Ти-Эр-90-тэй хиллэдэг умард хэсэг бүтэн үлдэж мэднэ. Ядахдаа галаас. Гэхдээ Барбиг гал түгшээсэнгүй.

Салхи түүний сэтгэлийг зовооно.

Мөрөн дээгүүр ба салтаагаар өнгөрч байгаа салхи Жулиягийн үсийг нүүрэн дээр нь чулуудах ба хувцасыг нь сэгсрэх хангалттай хүчтэй байгааг Барби мэдэрлээ. Салхи тэдний талаас үлээж, галыг тэжээж байна. Одоо нэгэнт Милл бараг хаалттай орон зай бөгөөд Бүрхүүлийн нэвтрэн орж ирэх сайн агаар алдаж байгаатайгаа харьцуулах аргагүй дэндүү бага. Барби нэг удаа хүчилтөрөгч үлдээгүй шилэн хоргоны усны гадаргуу дээр үхсэн алтан загас гэдсээ дээш харуулан хөвж яваа тухай хар дарж зүүдэлсэн.

Барби гарнаас нь пгүүрч Блэк-Ридж-роудаар урдаа ямар нэг юм өнхрүүлэн явж байгаа хүнийг заахаас өмнө Жулия түүн рүү эргэлээ. Энэ холоос эрэгтэй юмуу эмэгтэй хүний аль нь болохыг Барби хэлж чадсангүй. Тэгээд хэн байх нь ямар хамаатай билээ. Хэн байлаа ч гэсэн энэ хүн хяр руу өгсөхөөс өмнө бүтэж үхэх болно.

Барби Жулиягийн гарыг атгаж чих рүү нь тонгойгоод:

-Бид явах ёстой. Пайперийн гараас барь. Тэр бас дэргэдэх хүнийхээ гараас бариг. Бүгдээрээ...

-Энэ тал дээр яах вэ? гэж Жулия ганц хүн рүү урьдын адил зааж хашгирав. Тэр хүн урдаа хүүхдийн тэрэгтэй төстэй юм түрэх ажээ. Хүний дүрс байдгаараа бөхийж тун удаан хөдлөхийг харвал их хүнд юм ачсан бололтой.

Цаг маш бага үлдсэн тул Барби түүнд ойлгуулах хэрэгтэй болов.

-Тэр хүнийг март. Бид фермерийн байшин руу буцна. Яг одоо бүгд гар гараасаа бариад нэгийгээ энд үлдээхгүй гэхэд бүсгүй түүн рүү эргэж харахыг хичээх боловч Барби ийм боломж олгосонгүй. Түүнд Жулиягийн чих хэрэгтэй байв. Шууд утгаараа. Хүчээр ойлгуулахын тулд: -Хэрэв бид одоо явахгүй бол оройтно. Агаар дуусна.

117-р зам дээр галзуу мэт хурдлах машинуудыг пикап унасан Велма Уинтер тэргүүлэв. Тэр толинд ард харагдах гал ба утаанаас өөр юу ч үл бодно. Хурдны заалт 70 орчимд хүрсэн ба айж сандарсаныг улмаас таг мартсан Бүрхүүлийг очиж мөргөв. (өөрөөр хэлбэл бас нэг пгувуу, гэхдээ газар дээр) Бүрхүүл дөнгөж үүссэний дараа нөгөө талд Билли, Нора, Эльза нарын үхсэн яг тэр газар энэ явдал болов. Пикапын хөдөлгүүр дотогш цөмрөн орж ирээд бүсгүйг хоёр хуваажээ. Биеийн дээд хэсэг урд салхины шилээр нисэн гарахдаа урт зайдаснууд шиг гэдсээ чирээд бүдүүн шавьж шиг Бүрхүүл дээр зад үсрэв. Энд нийт 12 машин мөргөлдлөө. Хэн нэг нь газар дээрээ үхэж зарим нь гэмтэл авсан бөгөөд гэхдээ тэд удаан зовж тарчлахгүй.

Генриетта ба Петра нар тэднийг халуун хучихыг мэдэрлээ.

Хотын энэ олон хүнээс урьд нь автобусанд нилээдийг ачсан байв. Тэдний дунд Мейбл, Мэри-Лу хүүхдийнхээ хамт байлаа. Хүүхэд нь урьдын адил Генригийн малгайг өмссөн байв. Бас орилж бархирах нь зогсоогүй Лео энд байлаа. Гэхдээ одоо бие өвдсөндөө биш айсандаа бахирч байв.

-Хаазаа гишгээд умар зүгт давхи гэж Памела хашгирав. Галын тэргүүн эгнээ бараг хажууд ердөө 50 ярд зайтай ирсэн ба түүний уухилах нь хорвоог донсолгоно. -Чөттөр шиг хурдал. Битгий зогсоорой.

Энэ бүхэн ямар ч хэрэггүй гэдгийг Генри мэдэж байв. Гэвч тэр өөр нэг юм мэдэж байсан нь Бүрхүүлд арчаагүй наалдаж зогсохын оронд хорвоогоос ингэж явсан нь дээр. Генри холын гэрлээ асаагаад хаазаа гишгэлээ. Памела Чээ багшийн өвөр дээр унав. Чэзийн зүрхний хэмнэл алдагдсан тул автобусанд суулгах хэрэг гарсан. Тэр Памелаг газарт унагахгүйн тулд барьж авав. Хойноос айж түгшин орилох дуу хадавч Генри бараг сонссонгүй. Хэдий холын гэрэл асаасан ч зам удахгүй харагдахаа болино гэдгийг мэдэж байсан ч тэглээ гээд сүйдтэй юм биш. Ажлын үүргийн дагуу Генри энэ замаар хэдэн зуун хэдэн мянган удаа явсан.

"Люк хүчээ ашигла" гэж тэр бодоод ("Оддын дайн" киноноос ишлэл) дөл улангасах харанхуй руу орохдоо чанга инээв. Хаазыг шаланд хүртэл гишгэсэн байлаа.

Арын хаалганаас барьж зогссон Ричи Кильян амьсгалж чадахгүй болсоноо гэнэт ойлгов. Түүний гарыг гал хучихыг харж амжлаа. Ганцхан хормын дараа автобусны гаднах дулааны хэм 400 хүрэхэд Кильян эхлээд лаа шиг дүрэлзэн ассанаа яг л шарах тогоон дээр унасан хэрчим мах шиг шатав.

Автобусан дотор шөнийн зуушны газар шиг сул гэрэл түгээх таазны гэрлүүд асч байсан. Энэ гэрэл айсан бөгөөд хөлсөнд норсон зорчигчдын царайг гэрэлтүүлнэ. Харин гадна талд хорвоо дэлхий хар болжээ. Хөө тортог машины гэрэл тусах зайг эрс богиносгов. Генри автобусыг ой санамжаараа жолоодож, хэзээ дугуй хагарах бол хэмээн тааж ядна. Тэр хэдийгээр 19 дугаартай автобусны хөдөлгүүрийн хоржигнох ба уухилах дуунд дарагдсан өөрийнхөө дууг сонсохгүй байсан ч инээсээр байв. Тэр замаар явж байна. Энэ л чухал. Галын шуурганаас хэзээ мултран гарах бол? Тэд гарч чадах уу? Чадна гэж Генри бодож эхэллээ. Ариун бурхан минь энэ галан хананы зузаан хэр юм бол оо?

-Чи чадна, чи чадна гэж Памела хашгирна.

Магадгүй, болж магадгүй гэж Генри бодов. Гэвч бурхан минь ямар халуун юм бэ? Тэр хөргүүрийн бариул руу гараа сунгаж "дээд зэргийн хүйтэн" дээр тавихыг оролдов. Яг энэ мөчид цонх дэлбэрч, автобус галаар дүүрлээ. Үгүй, үгүй бид бараг гарч чадсан пгүү дээ.

Шатсан автобус утаанаас суга үсрэн гарч ирэхэд галан давалгааны цаана тас хар цөл үлдсэнийг Генри харав. Модод бяцхан хожуул болтолоо шатаж, харин зам өөрөө хөөсөрсөн суваг болжээ. Дараа нь галан хөнжил түүнийг араас нь эргэн хучсанаар Генригийн бүх юм дууслаа. 19 дугаартай автобус замын үлдэгдэл дээр халтираад эргэлдэв. Галын дөл хагарсан бүх цонхоор орж ирлээ. Арын бүхээг дээр бичсэн "Найз минь тоормосоо гишгэ. Бид хүүхдүүддээ хайртай" гэсэн бичиг түргэн харлав.

Олли Динсмор амбаар руу гүйнэ. Хүзүүндээ Том өвөөгийн хүчилтөрөгчийн маскийг өлгөж, бас хүчилтөрөгчтэй хоёр төмөр сав чиржээ. (хоёр дахь төмөр савыг гарааш руу гүйж явахдаа анзаарсан) Ганцхан секундын өмнө бол тэр ийм юманд хүч хүрнэ гэж төсөөлж ч чадахгүй байсан. Тэр төмсний хонгил руу аваачдаг шат руу яарна. Тачигнах дуу гарч, амбаарын дээвэр нурж байв. Барилгын баруун талд овоолгоостой байсан хулуу шатаж эхэллээ. Амьсгал боох хүчтэй үнэр түгэв. Яг л тамд байгаа талархалын өдөр аж.

Гал Бүрхүүлийн өмнө тал руу үсчив. Хэдхэн зуун ярд үлджээ. Дэлбэрэх дуу хадаж,

Динсморын байшин үхрийн саравч ба амбаар дууслаа. Генриетта ойртон ирж байгаа галан давалгааг хараад "Би хөгшин хүн яахав дээ амьдрахаа амьдарчихсан. Харин энэ хөөрхий охин ийм юм хэлж чадахгүй" гэж бодов.

-Хонгор минь над руу хар. Тэгээд миний цээжинд наалд гэж тэр Петрад хэллээ.

Петра айж түгшсэн дэндүү залуу царайгаа түүн рүү харуулав.

-Өвдөх болов уу?

-Ердөө ганцхан секунд. Нүдээ ань. Харин эргээд нээх үед чи хүйтэн голд хөлөө угааж байх болно. Петра сүүлчийн үгээ хэлэв. -Сонсоход таатай байна.

Тэр нүдээ аньлаа. Генриетта түүний жишээг дагав. Гал тэднийг хучлаа. Энэ хоромд тэд энд байна. Дараагийн хоромд... тэд байхгүй болжээ.

Кокс Бүрхүүлийн хажууд зогссоор байсан бөгөөд дүрс бичлэгийн дурангууд зураг авсаар байв. Тэд хар захын талбай дээр байгаа болохоор аюулгүй байлаа. Америк даяар нүд салгалгүй үзнэ. Сурвалжлагчид цочирдож айсны улмаас чив чимээгүй байх бөгөөд зөвхөн дууны дэвсгэр сонсогдох нь гал хүнгэнэх чимээ бөгөөд гэхдээ энэ дүүрэн хангалттай байв.

Ямар нэг хугацаанд Кокс урт хүн-могойг харж чадаж байв. Хэдийгээр хүмүүс галын дэвсгэр дээр зүгээр л дүрс мэт харагдаж байсан ч харж байсан. Эцсийн эцэст арай гэж фермерийн байшин ба машин руу гүйлдсэн Блэк-Риджийн дүрвэгсэдийн адил энд байгаа хүмүүсийн ихэнхи нь гар гараасаа барьсан байв. Дараа нь галан давалгаа Бүрхүүлийг цохиход тэд алга боллоо. Тэдний алга болсныг батлах гэсэн юм шиг Бүрхүүл эргээд харагдахуйц болоход аварга том хар хана тэнгэр рүү одов. Бүрхүүл халууны ихэнхи хэсгийг барьж чадсан ч түүгээр шүүрэн гарч ирсэн хэсэг нь хүртэл Коксыг эргээд зугтахад хүргэв. Тэр гүйдэл дундаа утаа баагих хүрмээ тайлж чулуудлаа.

Гал яг Барбигийн тооцоолсоноор хотыг баруун хойноос зүүн өмнө зүгт ташуулдан гарчээ. Үхэх цаг болоход гал энэ ажлыг гайхалтай түргэн хийж байна. Тэр хүчилтөрөгчийг хаман авч ардаа метан, формальдегид, давсны хүчил, нүүрсхүчлийн хий, угаар ба дугуугүй хортой хийн ул мөрөө үлдээв. Бас шатсан байшин модод ба мэдээж хүмүүсээс хатуулаг бичил хэсгүүдийн бүгчим үүл үүсгэж байлаа.

Гал ардаа юу үлдээв гэвэл зөвхөн хор.

28 дүрвэгсэд ба хоёр нохой Честерс-Милл болоод Ти-Эр-90-ийн хил рүү хөдөллөө. Энэ хэсэг нутгийг хотын хуучин иргэд Кантон гэж нэрлэдэг. Тэд минивэн, фургон, микро автобус, хоёр хөнгөн тэрэг ба түргэний тэрэгт чихжээ. Тэднийг зорьсон газраа ирэх үед өдөр мөртлөө харанхуйлж амьсгаа авахад туйлын хүнд болжээ.

Барби Жулиягийн "приус"-ийг тоормослоод Бүрхүүл рүү гүйж очив. Тэнд сэтгэл түгшсэн

армийн дэд хурандаа ба цэргүүд угтлаа. Хэдийгээр хол гүйх хэрэггүй байсан ч Бүрхүүлийг тэмдэглэсэн улаан шугам хүрэх үед Барби арай ядан амьсгалж байв. Сайн агаар угаалтуурын ус шиг алга боллоо.

-Сэнснүүд. Сэнснүүдээ залгаарай гэж дэд хурандаад амьсгаадан хэлэв.

Клер Жо хоёр "Берпигийн их дэлгүүр"-ийн фургоноос

унаж тусан гарч ирээд агаарыг шуналтай залгилан найгана. Дараа нь цахилгааны компанийн микроавтобус ирэв. Тэндээс Эрни гараад хоёр алхангуугаа сөхрөн уналаа. Норри ээжийн хамт түүнд туслах гэж оролдоно. Хоёулаа уйлна.

-Хурандаа Барбара юу болсон бэ? Илтгэ гэж армийн дэд хурандаа хэлэв. Энгэрийн хаттамалыг харвал нэр нь "Стрингфеллоу" гэх аж.

-Чи тэр илтгэлтэйгээ далд ор гэж Ромми бахирлаа. Ухаан алдсан хүүхэд гартаа тэвэрчээ. Энэ бол Эйден байв. Маршалл Элисийг тэврэн араас нь алхах ба цамцан дээр нь шүлс болоод бөөлжис цайрна. —Үхсэний чинь илтгэл. Сэнсээ залга.

Дэд хурандаа тушаал өгөхөд дүрвэгсэд сөхрөн унаж Бүрхүүлийг гараар тулаад хүчирхэг сэнснүүд саадыг нэвтрэн түлхэх цэвэр агаарыг шуналтай залгилав.

Тэдний ард гал дүнгэнэсээр байлаа.

Үлдэгсэд

1

Милл хотын хоёр мянган оршин суугчдаас зөвхөн 397 хүн амьд үлджээ. Тэдний олонхи нь хотын зүүн хойд хэсэгт байсан хүмүүс. Харин шөнө болж Бүрхүүл дор харанхуй болоход амьд үлдсэн хүний тоо 106 болж буурав.

Бямба гаригт нар мандаж Бүрхүүлийн бүрэн харлаагүй тэрхэн хэсгээр арай ядан тусах үед Честерс-Миллийн хүн амын тоо 32 болж буурлаа.

2

Олли гишгүүрээр гүйхийн өмнө хонгилын хаалгыг хаав. Бас чийдэн асах эсэхийг мэдэхгүй боловч гэрэл асаахын тулд унтраагуурыг дарав. Чийдэнгүүд асав. Хонгил руу буунгаа (Одоохондоо хүйтэн байлаа. Гэвч түүний араас халуун орж ирэхийг тэр мэдрэв) Олли дөрвөн жилийн өмнөх тэр өдрийг саналаа. Касл-Рокоос ирсэн "Ивс Электрик"-ийн ажилчид шинэхэн "хонда" цахилгаан үүсгүүр буулгахын тулд амбаар руу ачааны тэрэг ухруулан оруулсан.

"Энэ үнэтэй новш тултал ажиллавал дээр дээ. Яагаад гэвэл үүнийг авахын тулд би их өрөнд орчихлоо" гэж Олден тайлбарлаж байсан.

Цахилгаан үүсгүүр сайн ажиллаж байсан. Тэр одоо ч ажиллаж байх бөгөөд гэвч удахгүй болино гэдгийг Олли мэднэ. Гал бусад бүх юмыг авсан шигээ түүнийг авна. Хэрэв нэг минутын дотор гэрэл унтрахгүй бол Олли гайхах байлаа.

Энэ минутын дотор үхэж ч чадна.

Хонгилын голд бохир бетон шалан дээр төмс ялгах машин байв. Олон тооны гинж араа ба туузан дамжуулагчтай энэ машин эрт цагийн тамлах хэрэгслийг санагдуулна. Машины цаана төмсний аварга овоо харагдана. Энэ жил төмс сайн ургасан бөгөөд Динсмор Бүрхүүл үүсэхээс ердөө гурав хоногийн өмнө хурааж дууссан. Ердийн он жилүүдэд Олден ба түүний хүүхдүүд 11 сарын турш төмсөө ангилан ялгаад дараа нь Моттон, Харлоу, Таркерс-Миллийн зам дагуух мухлагууд болоод Касл-Рокийн хоршооллын зах дээр худалддаг. Энэ жил төмснөөс мөнгө олно гэж бодох хэрэггүй болжээ. Гэвч энэ төмс түүний амийг аварч болох юм гэж Олли бодно.

Тэр овоолгоостой төмсний зах руу гүйн очоод төмөр саваа харахын тулд зогтусав. Гэрээс авсан савны заалт хагас хоосон болохыг харуулна. Харин гараашаас авсан төмөр сав дүүрэн цэнэгтэй ажээ. Тэр хагас хийтэй төмөр савыг бетон шалан дээр орхиод багаа гараашаас авсан хоёр дахь саванд холбов. Том өвөөг амьд байхад тэр энэ ажлыг олон удаа хийж байсан тул хэдхэн хоромд амжууллаа.

Тэгээд багаа дөнгөж хүзүүндээ өлгөтөл гэрэл унтрав.

Агаар халж эхэллээ. Олли өвдөг сөхрөн суугаад овоолгоостой хүйтэн төмс рүү шумбаж гарав. Урт гонжгор төмөр савыг биеэрээ хааж, нэг гараар дороо оруулан чирээд хөлөөрөө төмснүүдийг түлхэнэ. Харин нөгөө гараар усанд сэлэх мэт болхи хөдөлгөөн хийнэ.

Төмснүүд цасан хунгар мэт түүн дээр асгарахыг сонсоод буцаж ухрах тэвдсэн хүслээ арай гэж барив. Тэр өөрийгөө амьдаар нь оршуулж байх мэт санагдана. Тэгээд өөртөө хэрэв өөрийгөө амьдаар оршуулахгүй юм бол үхэж мэднэ гэж ятгасан ч нэг их тус болсонгүй. Олли амаараа агаар үмхэх бөгөөд ханиана. Агаар биш төмсний шороогоор амьсгалж байв. Нүүрэндээ хүчилтөрөгчийн баг зүүлээ... Юу ч өөрчлөгдсөнгүй.

Төмөр савны эргэдэг түгжээг тэмтэрч олох хүртэл бүхэл бүтэн зуун өнгөрөх шиг болов. Цээжин доторх зүрх нь торонд байгаа араатан шиг үсчинэ. Харанхуйд нүдний өмнө улаан цэцэгс дэлгэрнэ. Төмс хүйтэн бөгөөд хүнд жингээр түүнийг дарна. Ийм юм хийхдээ тэр лав солиорсон байх. Бүрхүүл рүү буудахаар шийдсэн Рорри шиг солиорсон байх. Одоо тэр энэ солиорлын төлөө төлбөр хийнэ. Одоо Олли төмсөн доор үхнэ.

Хуруунууд нь арай гэж түгжээг олов. Эхэндээ эргэж өгөхгүй байлаа. Гэвч буруу тийш эргүүлж байгаагаа Олли ухаарав. Нөгөө тийш эргүүлмэгц хүйтэн сайхан агаар багийг дүүргэлээ.

Олли шуналтай амьсгалан төмсөн доор хэвтэнэ. Гал хонгилын хаалгыг цөм цохиход тэр бага зэрэг хөдлөв. Тэгээд ганцхан хоромд өөрийгөө доор нь орж хэвтсэн бохир хог дотор харав. Улам халуун болох тул өнөөх хагас хийтэй төмөр сав дэлбэрэх болов уу гэж өөрөөсөө асууна. Бас толгойд нь бусад бодол эргэлдэнэ. Бүтэн хийтэй төмөр сав хэр удаан хүрэлцэх вэ? Ер нь ингэтлээ зүтгэх хэрэг байсан уу?

Гэвч эдгээр асуултыг тархи тавьж байсан бөгөөд харин бие бол ганцхан зүйлд тэмүүлсэн нь амьд үлдэх байв. Олли баг

нь хазайх болгонд засч төмөр савыг хамт чирэн овоолгоостой төмс дор улам гүнзгий шумбалаа.

3

Хэрэв Вегас дахь тааварчид уулзалтын өдөр болсон сүйрлээс хэн амьд үлдэх талаар мөрий тавьсан бол Сэм Вердрогийн амьд үлдэх боломжийг мянгад ганц гэж дүгнэх байсан. Гэвч хавьгүй бага боломж ч заримдаа хожил авчирдаг. Хүмүүсийн дахин дахин казинод ирдэг гол шалтгаан энэ юм. Блэк-Ридж-Роудаар мацаж явсан Сэмийг дүрвэгсэд фермерийн байшингийн хажууд байсан машин руу зугтахын өмнөхөн Жулия олж харжээ.

Архичин Сэм яг Олли шиг шалтгаанаар амьд гарсан юм. Түүнд хүчилтөрөгч байсан.

Дөрвөн жилийн өмнө тэр Хаскель эмч дээр очсон. Сүүлийн үед агаар дутагдаж байгаа тухай Сэм хэлэхэд Хаскель эмч хөгшин архичны исгэрэн амьсгалахыг чагнаад хэр зэрэг тамхи татдагийг асуув.

"Ойд ажиллаж байхдаа өдөрт дөрвөн хайрцгийг татдаг байсан. Гэвч одоо тахир дутуугийн

тэтгэмж ба нийгмийн халамжаар амьдарч байгаа болохоор мэдээж хавьгүй бага татдаг" гэж Сэм хариуллаа.

Одоо яг хэдийг татаж байна? гэж Хаскел эмч асуув. Сэм өдөрт хоёр хайрцаг "Американ иглс" татдаг гэв.

"Урьд нь би "Честер-угаа" тамхи татдаг байсан. Одоо тэр тамхи зөвхөн шүүлтүүртэй хийгдэх болсон. Тэгээд ч үнэтэй. Харин "Американ иглс" тамхи хямд бөгөөд татахаас өмнө шүүлтүүрийг тасдаж болдог их энгийн" гэж хариулаад Сэм ханиав.

Хаскел эмч гайхалтай нь түүний уушигнаас хорт хавдар олсонгүй. Гэтэл рентген зураг болохоор уушигны эмфизем өвчин чөтгөр шиг хүндэрснийг харуулна. Тиймээс эмч түүнд амьдралын сүүлчийн өдөр хүртлээ хүчилтөрөгчөөр амьсгалахыг зөвлөжээ. Эмч буруу онош тавьсан юм. Гэвч түүнд хэтэрхий хатуу хандахаа больё. Эмч нарын хэлдгээр хэрэв туурайн чимээ сонсвол эрээн тахины тухай бодохгүй гэдэг дээ. Тэгээд ч хүмүүс хүссэн зүйлээ харах талдаа байдаг. Тийм биз дээ? Хэдийгээр Хаскел шууд хэлэхэд баатарлаг үхлээр үхсэн боловч хэн ч түүний дотор Расти ч түүнийг Грегори Хаус гэж хүлээн авахгүй. Үнэн хэрэгтээ Сэм бронхиттой байжээ. Шидтэн эмч уушигны эмфезим өвчин илрүүлснээс хойш удалгүй зүгээр болчихсон.

Гэвч тэр үед Сэм аль хэдийн долоон хоног тутам "Каслс Эр"-ээс (мэдээж Касл-Рок-д байдаг компани) хүчилтөрөгчтэй сав авахаар бүртгүүлчихсэн байсан ба энэ үйлчилгээнээсээ татгалзалгүй үлджээ. Юуны төлөө татгалзах билээ. Судасны даралтын эмнүүдийнхээ адил хүчилтөрөгчийг ч тэр бас "Медикэл" хөтөлбөрөөр авдаг. ("Тье МесисаГ" гэж бичигдсэн байх ба энэ нь ядуу бөгөөд өндөр настай америкчуудад зориулсан "Мешсаге" хэмээх анагаахын үнэ төлбөргүй үйлчилгээний тухай бололтой). Энэ юун хөтөлбөр болохыг Сэм мэдэхгүй ч нэг л юм ян тан мэдэж байсан нь хүчилтөрөгч түүнд сохор зоосны ч төлбөргүй ирдэг. Бас тэр хүчилтөрөгчөөс ганц нэг залгихад бие сэтгэл ихэд сэргэдэгийг өөрийн туршлага дээр мэдэж авчээ.

Заримдаа өөрөө "Хүчилтөрөгчийн баар" гэж нэрлэдэг болсон жижиг нэмэлт барилга руу явах хэрэгтэй гэж Сэм бодох хүртэл нэг бус долоо хоног өнгөрсөн байдаг байв. Тэгээд "Касл эр"-ийн залуус хоосон сав авахаар ирэх үед (тэд энэ ажилд гараа хөдөлгөхөөс аль болох цааргална) Сэм өөрөө хүчилтөрөгчийн бааранд очиж, эргэлддэг тагийг нээж, хүчилтөрөгчийг савнаас бүрэн гаргах ба дараа нь түүнийгээ хүүгийнхээ улаан түрдэг тэргэнд ачаад бөөрөн дээрээ агаарын бөмбөлөгнүүд зурсан хөгжилтэй цэнхэр фургон машинд хүргэж өгдөг байлаа.

Хэрэв Сэм хөгшин Вэрдрогийн байр байсан Литл-Битч-Роудад урьдын адил амьдарч байсан бол дэлбэрэлтийн дараах анхны минутанд л шатах байв. (Марта Эдмундсын адил). Гэвч тэр байшин болоод хүрээлсэн ой нь аль хэдийн татвар төлөөгүйн төлөөсөнд явчихсан. (2008 онд Жим Ренни хуурамч компаниар дамжуулан сохор зоосны үнээр авсан юм). Сэмийн охин дүү Год-Крик-Роудын ойд жижиг эдлэн газартай бөгөөд хорвоо дэлбэрэх тэр өдөр Сэм яг тэнд байж таарчээ. Энэ оромж онц юм юу ч үгүй бөгөөд бие засах газар нь гадаа хашаанд байдаг. (байшинд ус өгөх албыг гал тогоонд байх хуучны гар насос гүйцэтгэнэ) Харин бүх татвараа бол ян тан төлдөг байв. Охин дүү нь энэ тал дээр маш нарийн хянаана... Тэгээд "Медикэл"

хөтөлбөрийн дагуу Сэм авах ёстой бүхнээ авдаг байжээ.

"Хүнсний ертөнц"-ийн дэргэд болсон үймээнийг өдөөн хатгасан гэдгээрээ тэд ердөө ч бахархахгүй. Сэм олон жилийн турш Жоржия Ругийн эцэгтэй архидаж ирсэн бөгөөд олон лонх виски түүнээс ч их шар айраг хувааж уусан. Тиймээс ийм хүнийхээ охины нүүр рүү чулуу шидэхээс аргагүй болсонд ихэд гутарч байв. Чулууны цохилт ямар дуу гаргасан болоод Жоржиягийн хугарсан эрүү хэрхэн унжсан, бас амаа ангайсан уруулаа хөдөлгөлгүй яригч-хүүхэлдэй шиг болсон зэргийг байнга бодох болжээ. Бурхан минь, тэр түүнийг алж мэдэх байв. Алаагүй нь үнэхээр гайхамшиг. Гэхдээ үүний дараа Жоржия удаан амьдраагүй. Удалгүй түүний толгойд бүр ч гунигтай бодол орж ирлээ. Хэрэв тэр түүнийг тайван орхисон бол бүсгүй эмнэлэгт хэвтэхгүй байсан. Эмнэлэгт хэвтээгүй бол одоо амьд байх байсан.

Ингэж хөөж үзвэл тэр түүнийг алсан хэрэг болж байна.

Радиостанц дээр болсон дэлбэрэлт түүнийг согтуу нойрноос нь суга татав. Цээжээ дарж орон дээрээ өндийж суугаад эргэн тойрноо харлаа. Орны харалдаа дээрх цонх хага үсэрчээ. Үнэндээ бол бүх цонх хагарсан байх ба баруун хананы хаалга нугаснаасаа мулт үсэрсэн байв.

Сэм оромжноос хог өвсөөр дүүрсэн хашаа руу гарч ирээд баруун зүгт гайхан харлаа. Тэнд бүх дэлхий галаар буцалж байв.

4

Урьд нь хстын захиргаа сүндэрлэж байсан тэр газрын доор байх атомын хорогдох байранд хуучирсан загварын жижиг цахилгаан үүсгүүр ажиллана. Гэвч түүний ачаар л хоргодох байрны хүмүүс нөгөө ертөнцөд очилгүй энэ ертөнцдөө үлдэв. Цэнэг хураагуураас тэжээгдэх чийдэнгүүд том өрөөний булангаас шар гэрэл түтээнэ. Ганц сандал дээр Картер суужээ. Том Жим хоёр хүний буйданг ганцаараа эзэлж суугаад лаазтай сардин загас идэх бөгөөд нэг нэгээр нь бүдүүн хуруугаараа гогдон гаргаж ирээд хатаамал ээдмэг дээр тавина.

Энэ хоёр эр бие биетэйгээ бараг ярихгүй байв. Картерыг хайж олох хүртэл унтлагын өрөөнд тоос цуглуулан хэвтэж байсан зөөврийн зурагт тэдний бүх анхаарлыг татжээ. Энэ зурагт Поланд-Спрингсийн дабль-эм-ти-дабль-ю гэсэн ганцхан суваг барьж байсан ч энэ нь хангалттай. Бүр илүү хүрэлцээтэй ч гэж болно. Ийм сүйрлийг тархиндаа чанаж ойлгоход хэцүү. Хотын төв хэсгийг бүрэн сүйтгэжээ. Хиймэл дагуулаас гарсан гэрэл зураг дээр Честерс цөөрмийн эргэн тойрны ой бүрэн шатсан харагдана. 119-р замаар уулзалтын өдөрт ирсэн хүмүүс салхинд тоос болон хувирч байв. 20 мянган фут хүртэл өндөрт Бүрхүүл үзэгдэхээ больжээ. Газар нутгийн 70 хувь нь шатсан хотыг тойрсон эцэс төгсгөлгүй утсан шоронгийн хана.

Дэлбэрэлтийн дараа тун удалгүй хонгил дахь дулаан нэмэгдэж эхлэв. Том Жим Картерт хөргүүр залгахыг тушаалаа.

-Цахилгаан үүсгүүрийн чадал хүрэх үү? гэж нөгөөдөх нь асуув.

-Хэрэв хүрэлцэхгүй бол бид шарагдана. Ямар ялгаа байгаа юм бэ? гэж Том Жим ууртай

ХЭЛЛЭЭ.

Над руу битгий архираад бай, над руу битгий архир. Яагаад гэвэл энэ бүхэн чамаас болсон. Болсон бүхний төлөө зөвхөн чи хариуцлага үүрэх ёстой гэж Картер дотроо бодов.

Тэр хөргүүр олохоор босох үед өөр нэг бодол толгойд нь орж ирэв. Сардин загас үнэхээр өмхий үнэртэж байлаа. Хэрэв тэр одоо ам руугаа хийж байгаа загас чинь үхсэн хөгшний салтааны үнэртэй адил байна гэж хэлбэл босс юу гэж хариулах бол гэж бодов.

Гэвч Том Жим түүнийг үнэн сэтгэлээсээ "хүү минь" гэж дуудсан болохоор Картер амаа хамхлаа. Хөргүүрийг залгахад шууд ажиллав. Цахилгаан үүсгүүр өөр дээрээ нэмэлт ачаа үүрэх мэт хүнгэнэх дуу нь бага зэрэг нэмэгдэв. Тэгээд мэдээж үлдсэн хийг түргэн идэж гарлаа.

Ер нь Реннигийн зөв байжээ. Бидэнд хөргүүр хэрэгтэй байж гэж өндөрт нисч байгаа онгоцнууд ба хиймэл дагуулын авсан зурагнаас эвдрэл сүйрлийг харахдаа Картер өөртөө хэлэв. Доогуур Бүрхүүлийн ихэнхи хэсэг тунгалаг биш болжээ.

Том Жим тэр хоёрын анзаарсанаар зүүн хойд хэсэгт лав биш. Өдрийн гурван цагт дүрс бичлэгийн дурангууд тийшээ очиж амжив. Зураг авалтыг ойд байрлах цэргийн хуарангаас хийж байлаа.

-Би Жейк Тэппер байна. Бид Честерс-Миллийн умар талаас хил залгадаг хотын албан ёсны эрхгүй Ти-Эр-90-ийн нутаг дэвсгэрээс нэвтрүүлэг хийж байна. Бидэнд ойртохыг зөвшөөрөөгүй боловч бид эндээс ч амьд хүмүүсийг харж байна. Давтан хэлье. Үлдэгсэд байна.

-Амьд үлдсэн хүмүүс энд ч байна, тэнэг гэж Картер тургив.

-Дуугаа таг гэж Том Жим хэллээ. Зузаан хацарт нь цус хурж магнай руу урсав. Нүд нь ухархайнаасаа мултрах шахаж гараа зангидлаа. -Энэ Барбара байна. Энэ жингэрийн хүү Дейл Барбара байна.

Картер түүнийг бусад хүмүүсийн дундаас олж харав. Алсын таталттай дуран бүхий дүрс бичлэгийн хэрэгсэлээр зураг авч байлаа. Тийм болохоор дүрслэл яг л дулааны униарын цаанаас мэт бага зэрэг бүдэг байв. Гэхдээ л хангалттай тод байсан. Барбара. Хэл амтай номлогч эмэгтэй. Хиппи эмч. Хүүхдүүд. Линда Эверетт.

Энэ гичий эхнээсээ худлаа ярьжээ. Тэр худлаа ярьсан. Харин тэнэг Картер түүнд итгэсэн гэж Ренни бодов.

-Та нарын сонсож байгаа хүнгэнэх дуу бол нисдэг тэрэг биш. Хэрэв бид жаахан ухарч зураг авах юм бол гэж Жек хэллээ.

Дүрс бичлэгийн дуран ухраад цахилгаан үүсгүүрт холбож тэргэн дээр байрлуулсан эгнээ сэнсийг харуулав. Түүнээс хэдхэн милийн зайд байгаа энэ хүч чадлын дүрслэл Картерын хар

агааг төрүүлнэ.

-Та бүхэн харж байна. Энэ бол нисдэг тэрэг биш. Харин үйлдвэрийн сэнс ажээ. Одоо... Хэрэв бид үлдэгсэдийг дахиад харуулж чадах юм бол...

Дуран тэднийг харуулав. Тэд сөхөрч суух юмуу эсвэл Бүрхүүлийг налж яг сэнсний урд сууцгаана. Салхи тэдний үсийг хөдөлгөхийг Картер харав. Үсийг нь хийсгэхгүй бөгөөд яг усан доорх урсгалд орших усны ургамал шиг найган ганхуулна.

-Жулия Шамуйэ бас тэнд байна гэж Том Жимийн дуунд гайхал тодорлоо. -Би боломж байгаа дээр энэ шулмыг алах ёстой байсан юм.

Картер түүний үгийг чихнийхээ хажуугаар өнгөрөөв. Тэр дэлгэцнээс нүд үл салгана.

-Дөчөөд сэнс асар хүчтэй үлээж байгаа тул уг нь энэ хүмүүсийг хөл дээрээ тогтохгүй болгох ёстой. Гэвч бидний харж байгаагаас үзвэл Бүрхүүлийг нэвтрэн тэдэнд очих агаар зөвхөн амь насаа хадгалахад хүрэлцэж байна. Бүрхүүл доторх агаар мандал нүүрсхүчлийн хий, метан ба юуг нь зөвхөн бурхан л мэдэх тийм юмсын хорт цуглуулга болжээ.

Шинжээчдийн үзэж байгаагаар Честерс-Миллд байсан хүчилтөрөгчийн хязгаарлагдмал нөөц галыг хөгжөөхөд бүрэн зарцуулагдсан. Эдгээр шинжээчдийн нэг болох Принстоны химийн профессор Дональд Ирвин надад утсаар хэлэхдээ одоо Бүрхүүл доторхи агаар Ангарагийн агаар мандалаас нэг их ялгарахгүй гэсэн.

Дэлгэц дээр Нью-Йоркийн студид аюулгүй орчинд суугаа Чарлигийн сэтгэл зовсон дүр гарч ирэв. "Азтай новш" гэж Картер бодлоо.

-Түймрийн шалтгаан юу байсан тухай мэдээлэл байна уу?

Дуран Жейк Тэппер болоод тэдний ард дэвсгэр болон үзэгдэх амьд үлдсэн хүмүүсийг харуулав. Амьсгалж болох агаар бүхий жижигхэн бортогонд цугласан хүмүүс.

-Үгүй Чарли бүх юм нэг дэлбэрэлтээс эхэлсэн. Энэ тал дээр эргэлзээ байхгүй. Честерс-Милл ба цэргийнхнээс ямар ч мэдээлэл байхгүй байна. Та бүхний дэлгэцэн дээр харж байгаа хүмүүсийн хэн нэгэнд гар утас байж таарна. Гэвч гар утас нь ажиллалаа гэхэд тэдэнтэй зөвхөн хурандаа Кокс харьцаж чадна. Тэр хүн 45 минутын өмнө газардаад одоо амьд үлдэгсэдтэй ярьж байна. Тэгээд дүрс бичлэгийн дуран ийм холоос энэ гунигтай дүрсийг үзүүлж байх хооронд би Америк болоод бүх дэлхийн санаа зовж байгаа хүмүүст одоо Бүрхүүл дор амьд үлдээд их бага хэмжээгээр танигдаж байгаа тэр хүмүүсийн нэрийг нэрлэе. Нэрийг цагаан толгойн дарааллаар хэлэх тул үүний төлөө надад бүү уурлаарай.

-Тэгэхгүй дээ Жейк. Бидэнд ч бас зарим нэг гэрэл зураг бий. Гэхдээ бүү яар.

-Урьд нь ахмад байсан одоо хурандаа Дейл Барбара АНУ-ын арми гэх үед цөлийн дүрэмт хувцастай Барбигийн гэрэл зураг дэлгэцэн дээр гарч ирэв. Тэр инээмсэглэх ирак хүүг тэвэрчээ. -Одонт ахмад дайчин. Сүүлийн үед ресторанд тогоочоор ажиллаж байсан.

Анжелина Буффалино... Бидэнд түүний зураг бий юу?... Байхгүй юу?... За яахав. Хотын их дэлгүүрийн эзэн Ромео Берпи гэх үед дэлгэцэн дээр Роммигийн зураг гарч ирэв. Тэр эхнэрийн хамт шарсан махны дэргэд зогсоно. Түүний цамцан дээр "Би франц хүн. Намайг үнсээч" гэсэн бичиг байна. Эрнест Кэлверт ба түүний охин Жоан бас Жоаны охин Элеанор гэх үед гэр бүлийн ямар нэг арга хэмжээг харуулсан зураг гарч ирсэн бөгөөд Кэлвертүүдээр дүүрчээ. Норри хөөрхөн боловч баргар царайтай, сугандаа скэйт хавчуулсан байв. Элва Дрейк... түүний хүү Бенжамин Дрейк...

-Наадахаа унтраа гэж Том Жим бувгнав.

-Адагааад тэд гадаа байна. Нүхэнд чихэгдээгүй. Би оргон зайлсан Садцам Хуссейн шиг болсоноо мэдрээд байна гэх Картерийн дуунд агаа жөтөө илэрнэ.

-Эрик Эверетт, түүний эхнэр Линда ба хоёр охин...

Бас нэг гэр бүл гэх Чарлигийн дуунд сайшаасан өнгө аяс илэрнэ. Том Жим тэссэнгүй. Босч очоод өөрөө бариулыг эргүүлэн зурагтыг унтраалаа. Нөгөө гартаа сардин загастай лаазаа барьсан хэвээр бөгөөд тос цалгиж өмдөн дээр нь асгарав.

Чи энэ толбыг арилгаж чадахгүй гэж Картер бодсон ч хэлээгүй. Бас уг нь би зурагт үзэж байсан юмсан гэж бодсон ч дуугарсангүй.

-Энэ муу сонины шулам гэж Том Жим суунгаа үгээнэ. Түүний хүнд жин дор буйдангийн дэрнүүд дургүйцэн чихрав.

-Тэр үргэлж миний эсрэг байсан. Бүх хэрэгслийг хөдөлгөдөг байсан. Хараал идсэн бүх хэрэгслээ. Ахиад нэг лааз загас өгөөч.

Өөрөө ав гэж Картер бодсон ч хэлсэнгүй. Босч очоод тавиур дээрээс лаазтай загас авав.

Загас ба талийгаач эмэгтэйн бэлиг эрхтэний хоорондох үнэрийн адилтгалын тухай ярихын оронд тэр зөв асуулт тавив.

-Босс оо, одоо яах вэ?

Том Жим лаазны ёроолоос түлхүүр авч тагны хэлэнд суулгаад эргүүлж гарав. Ийнхүү муудсан загасны шинэ багийг нээлээ. Ослын чийдэнгийн гэрэлд загаснууд тослог гялалзана.

-Агаар цэвэрхэн болтол хүлээнэ. Дараа нь дээшээ гараад бүхнийг шинээр барьж эхэлнэ дээ хүү минь гээд тэр санаа алдаж загасаа хатаамал ээдмэг дээр тавиад идэв. Үйрмэг тосон дусалд наалдаж уруул дээр нь үлдлээ.

-Бидэн шиг хүмүүс ингэж л хөдөлдөг хариуцлагатай хүмүүс. Анжис чирдэг хүмүүс.

-Хэрэв агаар цэвэршихгүй бол яах вэ? Зурагтаар хэлэхдээ...

-Аюул, тэнгэр унаж байна, аймшиг, тэнгэр унаж байна гэж хэлэхдээ Том Жим тун хачин

аялгаар хэллээ.

-Наад хүмүүс чинь ийм юмыг олон жил ярьж ирсэн тийм үү? Эрдэмтэд болоод ард түмний төлөө шаналдаг либералиуд. Дэлхийн гуравдугаар дайн. Дэлхийг цөм рүү нь хүртэл түлэх цөмийн тогоонууд. 2000 оны компьютерийн сүйрэл. Азоны давхарга цоорох, туйлын мөс хайлах. Алуурчин хар салхи. Даяаршсан дулаарал. Санаа тавьж хайрлагч Бурхны авралт итгэдэггүй новшийн бурхангүйчүүд. Тэд бүхнийг хайрлаж санаа тавьдаг Бурхан байгаад итгэхээс татгалздаг.

Том Жим тос гялалзах боловч үл салгалж чичрэх хуруугаар залуу руу заагаад: -Энэ мөнхийн хүмүүнлэгчүүдийн баталгааны эсрэг тэнгэр хэзээ ч унасангүй. Хүү минь тэд нуруун дээр нь зурагдсан хулчгарын шар зурааснаас хаашаа ч зугтаж чадахгүй. "Нүгэлтэй хүн хэн ч араас нь хөөгөөгүй байхад ч зугтаж байдаг" гэж Левит номонд бичсэнийг чи мэдэх үү? Гэхдээ энэ бүхэн бурхны үнэнийг сольж дийлэхгүй. Түүнд итгэдэг хүмүүс хэзээ ч ядрахгүй бөгөөд бүргэдийн жигүүртэй болдог. Энд ердөө л утаа тортог байна. Агаар түүнээс цэвэршихийн тулд цаг хугацаа хэрэгтэй.

Гэвч хоёр цагийн дараа буюу дөрвөн цагийн үед атомын хоргодох байрны амьдралыг хангах механик систем байрлах нүхнээс пип пип гэх дуу чанга дуу хадав.

-Энэ одоо юу вэ? гэж Картер асууна.

Буйдан дээр нүдээ хагас анин хэвтэж байсан Том Жим өндийж суугаад чагналаа.

-Агаар цэвэршүүлэгч. Ионжуулагч. Үзэсгэлэнгийн танхимд нэг тийм юм байсан. Сайн эд байна лээ. Агаарыг зүгээр нэг цэвэрлээд зогсохгүй статик цахилгааныг багасгадаг. Энэ цахилгаан ялангуяа хүйтэнд хуримтлагддаг...

-Хэрэв хотын агаар цэвэршиж байгаа юм бол ионжуулагч яахаараа ажилладаг юм бэ?

-Ингэхэд Картер чи яагаад дээшээ гарч болохгүй гэж? Хаалга нээгээд тэнд юу болж байгааг хар. Шууд тайвшрах ч юм бил үү?

Картер тайвшрах эсэхээ мэдэхгүй байв. Гэвч сандал дээр суугаад байх нь мэдрэл барна. Тэгээд шатаар өгслөө.

Картерийг дөнгөж явангуут Том Жим буйдангаас босч жижиг хөргөгч ба зуухны дунд байрласан хайрцаг руу чиглэв. Ийм том биетэй хүн гэхэд гайхалтай түргэн бөгөөд чимээгүй хөдөлнө. Тэр хайж байсан зүйлээ гурав дахь хайрцагнаас оллоо. Эргэн харж ганцаараа байгаадаа итгэмэгц хэрэгтэй юмаа авав.

Шатны хөтөлж аваачсан хаалган дээр Картер нилээд заналтай бичиг байхыг харлаа. -"Та цацраг туяаны түвшинг шалгах хэрэгтэй. Сайн бод".

Картер бодов. Тэгээд хотын агаар цэвэрших тал дээр Том Жим худлаа буудаж байгааг ойлголоо. Сэнсний өмнө зогссон тэдгээр хүмүүс Честерс-Милл ба гадаад ертөнцийн хооронд

агаар солилцоо бараг тэг гэдгийг баталж байв.

Гэвч шалгаад үзэх нь үнэхээр зөв. Эхлээд хаалга нээгдсэнгүй. Амьдаараа оршуулагдсан байж болох тухай бодол түүнийг сандралд оруулж хаалгыг хүчтэй түлхлээ. Энэ удаа хаалга жаахан хөдлөв. Тоосгонууд унаж самбар шажигнахыг Картер сонслоо. Тэр хаалгыг өшөө том нээж чадах байх. Гэхдээ яах гэж? Нэг дюйм орчим өргөнтэй завсараар орж ирэх агаар нь агаар биш харин хөдөлгүүр ажиллах үед утааны яндангаас гарах зүйлтэй адил үнэртэв. Хоргодох байрны гадна хоёр гуравхан минут байх юм бол үхнэ гэдгээ ойлгоход түүнд ямар нэг хэцүү багаж огт шаардагдсангүй.

Ганц асуулт үлдэв. Реннид юу гэж хэлэх вэ?

"Юу ч хэлэхгүй. Тэр энэ тухай мэдэх юм бол байдал бүр дордоно. Тэгээд түүнтэй хамт байхад хэцүү болно гэж амьд үлдэхийг хүссэн хүний хүйтэн хоолой түүнд хэллээ.

Цахилгаан үүсгүүр хийгээ дуусгамагц хоргодох байранд үхэхээс өөр замгүй болохоор энэ бүхэн ямар утга учиртай юм бэ? Бүх юм тийшээ хандаж байхад ер нь юу утга учиртай юм бэ?

Тэр шатаар бууж ирэв. Том Жим буйдан дээр сууна. -За яав?

-Мэдээж муу байна.

-Гэхдээ амьсгалж болно тийм үү?

-Тийм. Гэхдээ шууд булингартаж байна. Бид энд хүлээх хэрэгтэй юм байна босс оо?

-Мэдээж хүлээсэн нь дээр гэж Том Жим Картер өөр ямар нэг зүйл санал болгосон юм шиг хэлэв. Картер энэ хорвоогийн хамгийн том тэнэг аятай хандав.

-Гэвч бидний бүх юм сайхан болно. Энэ гол нь. Бурхан бидэнд санаа тавьж байгаа. Тэр дандаа тэгдэг. Одоохондоо энд агаар сайн, халуун биш, хоол хангалттай. Хүү минь ингэхэд чи яагаад бидэнд ямар нэг амттан байгаа эсэхийг үзэж болохгүй гэж. Шоколад юмуу тиймэрхүү юм. Өөрийгөө эрхлүүлмээр байна.

Би чиний хүү биш. Чиний хүү үхсэн гэж Картер бодсон ч мэдээж хэлсэнгүй. Тэгээд тавиур дээгүүр шоколад байгаа эсэхийг шалгахгаар унтлагын өрөөнд орлоо.

Оройн арван цагийн үед Барби түгшүүртэй нойронд автжээ. Жулия дэргэд нь хэвтэх бөгөөд тэдний бие шүргэлцэнэ. Зүүдэнд нь бага Ренни орж ирнэ. Жижгээ Тахианы-саравч дахь түүний хорих өрөөний дэргэд зогсоно. Жижгээ гартаа буу барьсан байлаа. Энэ удаад Барбиг хэн ч аварч чадахгүй. Яагаад гэвэл гадаа агаар хор болж хувираад бүх хүн үхжээ.

Хар дарсан зүүд арай гэж холдон тэр илүү гүн нойронд автав. Барби Жулиягийн адил толгойгоо Бүрхүүл рүү харуулан хэвтэнэ. Цэвэр агаар Бүрхүүлийг нэвтрэн нгүүрнэ. Энэ агаар амьд байхад хангалттай ч тайвшруулж чадахгүй.

Шөнийн 2 цагт Барбиг ямар нэг юм сэрээв. Барби хөө тортогт хучигдсан Бүрхүүл, тэр талд дэлгэсэн цэргийн хуарангийн унтарсан галуудыг харав. Дараа нь дуу дахин давтагддаа. Аймшигтай, нам дорой, хүчлэн ханиах дуу. Түүний баруун гар талд гар чийдэн гялсхийв. Барби Жулияг сэрээхгүйн тулд чадах хэрээр болгоомжтой босоод өвсөн дээр унтаж байгаа бусдынхаа дээгүүр давж гишгэлэн гэрлийг чиглэв. Олонхи нь дотуур хувцаснаасаа бусдыг тайлжээ. Арваадхан футын цаана харуулууд зузаан хүрэм ба бээлий өмссөн байв. Харин Бүрхүүл дор урьд байснаасаа илүү халуун байлаа.

Расти ба Жинни хоёр Эрнигийн хажууд өвдөглөн суужээ. Растигийн хүзүүнд чагнуур байх бөгөөд тэр гартаа хүчилтөрөгчийн баг барьсан харагдана. Энэ багийн дээр нь "Эмнэлгийн түргэн тусламж. Авч гарч болохгүй, байнга солих" гэж бичсэн жижигхэн улаан төмөр сав харагдана. Норри ба түүний ээж тэврэлдээд тэдэн рүү сэтгэл зовон харна.

-Чамайг сэрээсэнд уучлаарай. Түүний бие муу байна гэж Жоани Барбиг хараад хэллээ.

-Маш муу юу?

Расти толгой сэгсрэв.

-Мэдэхгүй. Дуугаар нь бол хүчтэй ханиад юмуу бронхит байх. Гэвч шалтгаан үүнд биш гэдэг нь ойлгомжтой. Муу агаар. Би түүнд хүчилтөрөгч өгсөн. Хэсэг хугацаанд тус болсон юм. Гэвч одоо... Тэр мөрөө хавчсанаа: -Түүний зүрх таалагдахгүй байна. Асар их ачаалал авсан шүү дээ. Харин тэр залуу хүн биш.

-Өөр хүчилтөрөгч байхгүй юу? гэж Барби асуулаа. Тэр хүмүүсийн пиндээ байлгаж үргэлж цэнэглэхээ мартдаг гэрийн гал унтраагуурыг санагдуулах улаан сав руу заав. -Тийм үү?

Тэдэн дээр Маршалл ирэв. Дэнлүүний гэрэлд тэр ядарч барайсан харагдана.

-Дахиад нэг байгаа. Гэхдээ би бодохдоо, Расти Жинни бид гурав бодохдоо түүнийг жаахан хүүхдүүдэд нөөцлөх гэсэн юм. Эйден бас ханиаж эхэлсэн. Би түүнийг Бүрхүүл рүү сэнсэнд хамгийн ойр хэвгүүлсэн. Гэвч тэр ханиагаад л байна. Бид Эйден, Элис Жүди ба Жанни нарыг сэрэхээр нь хүчилтөрөгчийг тунгаар өгч эхэлнэ. Хэрэв цэргийнхэн илүү олон сэнс авчирвал...

-Тэд хичнээн их цэвэр агаар өглөө ч Бүрхүүлийг илүү их агаар нэвгэлж гарахгүй. Бид Бүрхүүлд хичнээн ойртсон ч тэртэй тэргүй баасаар амьсгалж байна. Тэгээд энэ хэнд хамгийн муу вэ гэдэг нь ойлгомжтой гэж Жинни хэллээ.

-Хөгшин хүмүүс ба хүүхдүүдэд гээд Барби толгой дохив.

-Явж хэвт. Хүчээ хэмнэ. Чи энд байлаа гээд юугаар ч тус болохгүй гэж Расти санал болгов.

-Харин чи яах вэ?

-Магадгүй. Түргэний тэргэнд хамрын дусаагуур бий. Хэрэв түүндээ хүрэх юм бол эпинефрин ч бий.

Барби нүүрээ сэнс рүү харуулаад Бүрхүүлийн дагуу явав. Одоо тэд автоматаар ингэдэг болсон. Жулия дээр очих үед үхтэл ядарсанаа мэдэв. Зүрх нь галзуу мэт цохилж амьсгаа дутагдана.

Жулия унтаагүй байв.

-Эрни бүр дордсон уу?

-Мэдэхгүй. Сайн гэх юм бага байна. Түүнд түргэний төмөр савнаас хүчилтөрөгч өгч байна. Гэсэн ч тэр сэрэхгүй байна.

-Хүчилтөрөгч үү? Хэр их байгаа юм бэ?

Барби үнэнийг хэлсэнээ дараа нь харамсав. Яагаад гэвэл бүсгүйн нүдний гал бага зэрэг унтарлаа.

Тэр түүний гарыг барихад хөлстэй нойтон боловч хүйтэн хуруутай байв.

-Бид уурхайд дарагдчихсан юм шиг мэдрэмж төрж байна.

Тэд мөрөөрөө Бүрхүүлийг налаад урд урдаасаа харан суув. Тэдний дундуур үл анзаарагдам салхи үлээнэ. "Эр Макс" сэнснүүдийн жигд хүнгэнэх нь дуун дэвсгэр болж хувирна. Хүмүүс түүнийг давж гарахын тулд чанга ярина. Бусад талаар анзаарахгүй.

Хэрэв тэд дуугүй болчихвол бид анзаарах болов уу? Хэдэн минут анзаарах бол? Харин дараа нь үүрд анзаарахаа болино гэж Барби бодов.

Жулия хуурай инээгээд

-Чи надад санаа зовж байгаа бол боль. Дунд хэрийн насны Бүгд Найрамдахч эмэгтэй гэхэд миний бүх юм зүгээр. Наад зах нь би дахиад нэг удаа энгэр зөрүүлж амжсан. Тун муугүй.

Барби хариуд нь инээмсэглэв.

-Таашаал авсан хүн нь бий пгүү. Надад итгээрэй.

-Ням гаригт туршиж үзэх гэж байгаа атомын жижиг бөмбөгийн талаар юу бодож байна вэ?

-Би юу ч бодохгүй. Би зөвхөн найдаж байгаа.

-Тэгээд чиний найдвар хэр их вэ?

Тэр бүсгүйд үнэнийг хэлэхийг үл хүснэ. Гэвч тэр зөвхөн үнэнийг сонсох гавьяатай.

-Болсон явдал дээр үндэслээд хайрцагийг удирдаж байгаа амьтдын талаар тун бага мэддэгээ тооцох юм бол тийм ч их найдвар биш.

-Чи бууж өгөөгүй гэдгээ надад хэл.

-Энэ бол харин үнэн. Тэр бүү хэл би айгаагүй байна. Би бодохдоо яагаад гэвэл... Энэ бүхэн анзаарагдамгүй болсон, гэвч би уналтанд дасчээ.

-Нээрээ гэж үү?

Барби инээлээ.

-Үгүй. Чиний хувьд ямар байна. Айж байна уу?

-Тийм. Гэхдээ юуны өмнө гунигтай байна. Ертөнцийн төгсгөл ингэж ирдэг байжээ. Аянга цахилгаан нижигнэсэнгүй. Харин багтарч үхэх юм байна гээд нударгаар амаа таглан ханиав.

Бусад хүмүүстэй ч ийм юм болж байгааг Барби сонсоно. Тэдний дотор одоо Маршаллын хүү болсон жижигхэн банди ханиана. "Өглөө тэр арай илүү юм авах болно" гэж Барби бодов. Тэгснээ дараа нь Маршалл "тунгаар" гэж хэлснийг саналаа. Ийм юмаар ханатал амьсгалахгүй л дээ.

Зөвхөн жаалхүү ч биш хэн ч ханатал амьсгалахгүй.

Жулия өвс рүү нулимаад дахин Барби руу эргэв.

-Бид өөрсдөө ийм юм хийсэн гэхэд би итгэж чадахгүй. Хайрцгийг удирдаж байгаа амьтад илгэн толгойтнууд энэ нөхцөл байдлыг зохиосон. Гэвч тэд ердөө л зугаацахыг хүссэн хүүхдүүд гэж бодож байна. Тэдний хувьд видео тоглоомтой адил байх. Тэд гадна талд байгаа. Бид дотор байна. Энэ болж байгаа бүхнийг бидний гар л хийсэн.

-Өөрийгөө ийм шалтгаанаар зэмлэхэд хүрнэ гэдэг чинь чамд бусад асуудал хангалтгүй байна уу? Хэрэв хэн нэгэн буруутай бол тэр хүн нь Ренни л байх. Тэр л хар тамхи үйлдвэрлэх лаборатори зохион байгуулаад хотын бүх хийг тийшээ зөөж эхэлсэн. Тэр л тийшээ хүмүүсийг илгээж ямар нэг сөргөлдөөн өдөөсөн. Би үүнд итгэлтэй байна.

-Гэхдээ хэн түүнийг сонгосон юм бэ? Хэн түүнд энэ бүхнийг хийх боломж олгосон бэ?

-Чи л лав биш. Чиний сонин үргэлж түүний эсрэг байсан. Эсвэл би буруу ярьж байна уу?

-Чиний зөв. Гэхдээ зөвхөн сүүлийн найм гаруй жил. Эхэндээ "Ардчилал" өөрөөр хэлбэл би тэр хүнээс илүү юм зүсмэл талх л байна гэж хүмүүсийг итгүүлдэг байлаа. Түүний хэн болохыг ойлгох үед Ренни аль хэдийн гүнзгий үндэстэй болсон байсан. Түүний хажуугаар үргэлж инээж явдаг тэнэг Сандерсийг олж авсан. Тэгээд үргэлж түүний араар нуугддаг болсон.

-Тэгсэн ч гэсэн чи өөрийгөө буруутгаж болохгүй...

-Болно. Бас буруутгана. Хэрэв би биеэ тоосон бүдүүлэг жингэрийн хүү жинхэнэ хямралын үед биеэ хэрхэн авч явахыг мэдсэн бол. Би... би... би... Муурын зулзагыг хувинд живүүлдэг

шиг түүнийг живүүлэх байсан.

Барби инээсэн ч тэр дороо ханиав.

-Чи Бүтд Найрамдахчтай улам бага төстэй болоод байх юм... гэж Барби ярьж эхэлсэнээ дуусгаж чадсангүй.

-Юу вэ? гэж бүсгүй асууснаа дараа нь чагналаа. Харанхуйд ямар нэг юм доргих бөгөөд чихарч дуугарна. Энэ дуу чимээ ойртох бөгөөд удалгүй тэд дээр нь тонгойсон хүний түрж яваа хүүхдийн тэргийг олж харлаа.

-Чи хэн бэ? гэж Дуги асуув.

Тэр хүн хариу хэлэх үед дуу нь бөглүү сонсогдсон бөгөөд учир нь тэр хүчилтөрөгчийн баг зүүжээ.

-Бурхан чамд талархая. Би замын хажуу дээр зүүрмэглээд дараа нь энд хүрэхээс наана миний агаар дуусах нь гэж бодсон шүү. Гэвч би энд байна. Цагаа олжээ. Яагаад гэвэл хүчилтөрөгчийн сав бараг хоосорсон гэж архичин Сэм хэллээ.

6

Бямба гаригийн өглөө эрт 119 дугээр зам дээрх цэрпшн хуаран гунигтай харагдана. Тэнд гучаадхан цэрэг ба ганцхан "чинук" үлджээ. Арваад хүн нисдэгт тэргэнд эвхэж хураасан майхан ба "Эйр макс" сэнснүүдийг ачна. Дэлбэрэлтийн тухай мэдээ авмагцаа хурандаа Кокс хотын урд хэсэгт аваачихыг тушаасан тэдгээр сэнснүүд. Сэнснүүдийг ажиллуулах хэрэг гарсангүй. Тэднийг ирэх үед эдгээр сэнсний тусламжтай цэвэр агаарыг Бүрхүүл рүү нэвт түлхлээ гэхэд түүнийг үнэлэх хүн нэг ч үлдсэнгүй. Гал өчигдөр орой зургаан цагийн үед бүх шатахуун ба хүчилтөрөгчөө зарцуулж дуусаад унтрав. Гэвч Честерс-Миллийн тадц байсан бүх хүн үхжээ.

Өөр арваад хүн том асар майханг эвхэнэ. Бусад нь цэргийн хамгийн эртний ажлуудыг хийж байсан нь байсан газар нутгаа цэюрлэх байлаа. Тархи толгой үл шаардах мохоо ажил нь мздээж боловч хэн ч дургүйцсэнгүй. Өчигдөр нүдээр харсан аймшигт зүйлийг юу ч мартуулж чадахгүй хэдий ч цаас, лааз, лонх, тамхины иш цуглуулахад ядахдаа анхаарал өөр зүгт хандах аж. Жаахан удахад л том "чинук"-ийн далбангууд эргэлдэнэ. Цэргүүд хөлгийн бүхээгт суугаад хаашаа ч юм нисэн одно. Энэхүү оршуулгын багийн гишүүд өөр газарт явахаар тэсч ядна.

Тэдний дунд Өмнөд Каролина муж улсын Хикори-Гроуваас ирсэн байлдагч Клинт Эймс бас цэвэрлэгээ хийж байна. Тэр ногоон өнгийн гяжар уут гартаа барьж гишгэлэгдсэн зүлгээр аажуухан алхах ба баастай ахлагч Грод ажиллаж байгаагаа харуулахын тулд хаа нэгтээ коланы базсан лааз юмуу хаясан зурагт хуудас хамна. Эймс бараг л унтаж явсан бөгөөд одоо сонсож байгаа тогших чимээг зүүдэлсэн гэж эхэндээ боджээ. (зузаан тавгийг ясан хуруугаар тогших шиг). Энэ тогшилт Бүрхүүлийн нөгөө талаас гарах шиг болсон тул өөр юу ч бодох билээ дээ?

Клинт эвшээгээд ташаагаа тулан эгцрэв. Энэ үед дахиад тогшлоо. Нээрээ Бүрхүүлийн харласан хананы цаанаас дуулдаж байв.

Тогших дуутай хоолойн дуу нэгдлээ. Сул дорой, хий үзэгддийн дуу. Эймсийн хамаг бие арзайв.

-Хүн байна уу? Хэн югэн намайг сонсож байна уу? Гуйя, би үхлээ.

Бурхан минь тэр энэ дууг урьд нь сонсож байсан шүү дээ. Энэ чинь өнөөх дуу...

Эймс гялгар уугаа хаяад Бүрхүүл рүү гүйлээ. Харласан бөгөөд бүлээнээрээ байгаа гадаргуу дээр гараа тавив. -Үхэрчин жаал юу? Чи юу?

Би солиорч байх шиг байна. ийм юм байж болохгүй. Галан шуурганд хэн ч амьд үлдэх боломжгүй.

-Эймс? Чи тэнд ямар чөтгөрөө хийгээд байна? гэж Гро гуагалав.

Тэр хариулах гэтэл хар гадаргууны цаанаас дахиад л дуу гарлаа.

-Би байна. Битгий... битгий орхиоч. Байлдагч Эймс чи энд байгаа бол битгий яваач гэснээ нохой хуцах мэт ханиалаа.

Дараа нь гар үзэгдэв. Яг дуу шигээ хөө тортог болсон хий үзэгдэлийн хуруунуудтай гар. Тэр гар Бүрхүүлийн дотор талаас арчиж цонх гаргалаа. Ганц хормын дараа нүүр нь үзэгдэв. Эймс эхэндээ үхэрчин жаалыг таньсангүй. Дараа нь жаал хүү хүчилтөрөгчийн багтай байгааг ойлгов.

-Миний агаар дуусаж байна. Зүү улаан шугам дээр байгаа. Сүүлчийн хагас цагийн турш гэж үхэрчин жаал сөөнгөтөв.

Эймс айдас дүүрэн нүдээр үхэрчин жаал руу харах ба өнөөх нь Эймсийг ширтэнэ. Байлдагчийн толгойд ганцхан бодол үлдсэн нь үхэрчин жаалыг үхүүлэхгүй байх байлаа. Түүний энэ туулж гарсан бүхний дараа...гэхдээ Эймс тэр энэ бүхнийг яаж туулаад гарчихсаныг ойлгож чадсангүй.

-Намайг сонс. Сөхөрч суугаад...

-Хүүе Эймс, булуулмар ажилгүй амьтан гэсээр ахлагч Гро түүн рүү том том алхлан айсуй. - Зугаацахаа болиод ажлаа хий. Миний тэвчээр барагдлаа, өмхий ухна.

Байлдагч Эймс түүний хашгирахыг тоосонгүй. Тэр өмнөөс нь бохир шил мэт зүйлийн цаанаас харж байгаа нүүрнээс хараа салгаж чадахгүй байв.

-Газарт хэвтээд доогуур сайн арч. Гэхдээ залуу минь аажуухан хийгээрэй.

Царай алга боллоо. Эймс түүнийг ухаан алдаагүй түүний хүсэлтийг биелүүлж байгаа гэж

найдах л үлдэв.

Ахлагч Грогийн гар түүний мөрөн дээр тавигдав.

-Чи дүлийрэв үү? Би чамд хэлсэн шүү...

-Ахлагчаа сэнсээ авчраарай. Бидэнд сэнс хэрэгтэй.

-Чи юугаа чалч...

-Энд хэн нэгэн амьд үлджээ гэж Эймс ахлагчийн гайхаж балмагдсан нүүр рүү хашгирлаа.

7

Архичин Сэм Бүрхүүлийн дэргэдэх дүрвэгсдийн хуаранд ирэхэд ердөө ганцхан ширхэг хүчилтөрөгчийн сав улаан тэргэнд нь үлдсэн байлаа. Даралт хэмжигчийн зүү тэг дээр очиход өчүүхэн зайтай байв. Расти түүний багийг авч, Эрни Кэлверт дээр тавихад тэр дургүйцсэнгүй. Харин Барби Жулия хоёрын сууж байсан газрын дэргэд Бүрхүүл рүү мөлхөж очив. Дөнгөж сая ирсэн хүн дөрвөн хөллөөд гүнзгий амьсгаа авлаа. Жулиягийн дэргэд суух Горас нохой түүн рүү сонирхон харна.

Сэм өнхөрч дээшээ харлаа.

-Тийм ч сайхан биш байна. Гэхдээ түрүүчийнхээс дээр боллоо. Төмөр савны ёроолын үлдэгдэл дээд хэсгээрээ их муу байдаг юм байна.

Дараа нь тэр тамхи татсан нь гайхалтай.

-Тамхиа унтраа. Та яаж байна аа галзуурав уу? гэж Жулия хашгирав.

-Тамхи татахыг үхгэлээ хүслээ. Хүчилтөрөгчөөр амьсгалж байхад татаж чадахгүй гэдгийг та нар ойлгоно. Миний дотор бүх юм дэлбэрч мэднэ. Гэхдээ үүнийг хийдэг хүмүүс байдаг гээд Сэм гүнзгий соров.

-Татаж л байг. Тамхины утаа одоо бидний амьсгалж байгаа бааснаас дор биш байх. Миний мэдэж байгаагаар түүний уушигт байгаа давирхай ба никотин уушгийг нь бүр илүү хортой зүйлээс хамгаалж өгнө гэж Ромми хэлэв.

Расти ирээд суулаа.

-Төмөр сав дууссан. Гэвч Эрни хэд хэд амьсгалж чадлаа. Арай хөнгөрөх шиг болсон. Баярлалаа Сэм. Тэр гараа савав.

-Миний агаар бол чиний агаар эмч ээ, ямар ч гэсэн тийм байсан. Харин чи түргэний тэрэгт байгаа ямар нэг зүйлийн тусламжтай илүү ихийг хийж чадахгүй юу? Бүх хот зэс хувингаар хучигдах хүртэл надад төмөр савнууд авчирдаг байсан залуус үүнийг шууд ачааны тэргэн дээрээ хийчихдэг байсан. Тэд тэр багажаа насос гэлүү дээ тиймэрхүү нэр хэлж байсан.

-Хүчилтөрөгчийн экстрактор. Чиний зөв, тэр бидэнд байгаа. Харамсалтай нь эвдэрчихсэн. Эвдрээд гурван сар болж байна гэж Расти толгой дохин ярихад мушийн инээх мэт шүд нь гялалзав.

-Дөрвөн сар гэж энэ үед ойртож ирсэн Дуги засч хэлээд

Сэмийн тамхийг харангаа -Чамд дахиад байна уу?

-Бодох ч хэрэггүй шүү гэж Жинни дуу алдав.

-Халуун бүсийн энэ диваажинг утаагаар бохирдуулахаас айгаад байгаа юм уу? гээд Твитч мушийн инээв. Гэхдээ л Сэм түүнд хайрцагтай "Американ иглс" тамхи сарвайхад толгой сэгсэрлээ.

-Би хүчилтөрөгчийн экстрактор солих тухай хүсэлтийг эмнэлгийн зөвлөлд өгсөн. Төсөв дууссан тул хотоос тусламж гуйх хэрэгтэй гэж байсан. Тиймээс би хүсэлтээ хотын захиргааны зөвлөлд явуулсан юм гэж Расти хэлэв.

-Реннид гэж Пайпер дундуур нь үт хавчуулав. Расти толгой дохиод:

-Реннид. Тэгээд албан ёсны хариулт авсан. 11 дүгээр сарын төсвийн хурал дээр хүсэлтийг авч хэлэлцэнэ гэж заасан байсан. Тэр үед мөнгө гаргах эсэхийг харцгаая гэж тэр гараа тэнгэр рүү сунгаж инээлээ.

Бусад хүмүүс одоо тойрон цуглаж Сэмийг сонирхон харцгаана. Тамхи руу нь бүр айдастай харна.

-Та яаж энд хүрч чадав? гэж Барби асуулаа.

Сэм өөрийн түүхээ ярих боломжтой болсонд ихэд баярлав. "Энфизем" өвчний оношноос эхлээд хүчилтөрөгчтэй сав байнга авдаг болсноо ярьж, "Медикэл" хөтөлбөрт талархаад заримдаа хүчилтөрөгч овоордог байсныг хэллээ. Дэлбэрэлт сонссоноо оромжноосоо гараад юу харсанаа ярив. Одоо түүний яриаг Бүрхүүлийн цаад талд байгаа цэргийнхэн сонсох болсны дотор ногоон эрээн өнгийн богино өмд ба майктай зогсох Кокс бас байв.

-Дэлбэрэлт ямар хүчтэйг харангуут цаашид юу болохыг би шууд ойлгосон. Ойд ажиллаж байхдаа том түймрүүд үзэж явлаа. Хоёр ч удаа бүх юмаа хаяад зугтах хэрэг гарч байсан. Хэрэв бидний ашигладаг байсан ачааны тэрэг эвдэрсэн бол түймэр биднийг гүйцэх байсан. Хамгийн аймшигтай нь дээгүүр гардаг оройн түймэр байдаг. Яагаад гэвэл ийм түймэр өөрөө салхи үүсгэдэг. Энэ түймэр ямар хэмжээнд хүрэхийг би шууд ойлгосон. Их том юм дэлбэрсэн байна. Яг юу юм бол?

-Пропан хий гэж Роуз хариулав.

Сэм сахал ургасан эрүүгээ маажгаад:

-Үгүй дээ. Зөвхөн пропан хий биш өөр ямар нэг химийн бодис дэлбэрчээ. Яагаад гэвэл галын

дөл ногоон өнгөтэй байсан. Хэрэв гал шууд намайг зүтлэсэн бол тэгээд дуусах

байлаа. Та нар ч бас. Гэвч гал эхлээд өмнө зүгт явсан. Газрын нугалаа давалгаа үүнд тус болсон байх. Яг хэлж чадахгүй. Бас голын гольдирол тусалсан. Нэг үгээр хэлэхэд би юу болохыг ойлгоод хүчилтөрөгчтэй төмөр савнуудаа баарнаас гаргалаа. -Хаанаас гэнэ ээ? гэж Барби асуув.

Сэм сүүлчийн удаа тамхиа сороод ёзоорыг нь газарт шидлээ.

-Би хүчилтөрөгчтэй савнууд хадгалдаг барилгаа тэгж нэрлэдэг юм. Тэнд таван ширхэг дүүрэн хүчилтөрөгчтэй сав байсан.

-Тав аа? гэж Маршалл гаслав.

-Тийм ээ, гэвч би хэзээ ч тавыг чирч дийлэхгүй. Хөгшин болжээ. Мэдэж байна уу? гэж Сэм баяртай дуу алдлаа.

-Та хөнгөн тэрэг юмуу пикап олж авч чадаагүй юмуу? гэж Лисса асуулаа.

-Миний жолооны эрхийг долоон жилийн өмнө хасчихсан. Найм ч билүү. Замын хөдөлгөөний дүрэм дэндүү олон зөрчсөн дөө. Хэрэв би түрдэг тэрэгнээс том ямар нэг юм жолоодлоо гэхэд намайг зогсоогоод шоронд хийж түлхүүрийг нь чулууудах байсан.

Сэмийн бодолд байгаа үндсэн алдааг зааж өгдөг юм билүү гэж Барби бодсоноо тэгж хүчээ бараад яахав гэж шийдэв. Тэртэй тэргүй амьсгаа авах тоолонгоор хүнд хэцүү байна.

-Нэг үгээр хэлэхэд энэ жижигхэн улаан тэргэн дээр дөрвөн савнаас илүүг авч явж чадахгүй гэж бодсон. Тэгээд дөрөвний нэг миль ч яваагүй байхдаа эхний саванд гар хүрч эхэлсэн. Яагаад гэдгийг та бүхэн мэднэ.

-Бидний энд байгааг чи мэдэж байсан юмуу? гэж Жекки асуув.

-Үгүй. Блэк-Ридж бол хотын хамгийн өндөр цэг. Тэгээд л тэр. Савтай агаар бүх амьдралд хүрэлцэхгүйг би мэднэ. Би та нарын энд байгаа тухай ойлголтгүй байсан. Сэнснүүдийн тухай ч юу ч мэдэхгүй байсан. Зүгээр л өөр хаашаа ч явах газаргүй болоод тэр.

-Бидэн дээр хүрч иртлээ яагаад ийм их удсан юм бэ? гэж Пит асуув.

-Нэг хачин юм болсон. Би Блэк-Ридж-Роудаар зам даган өгсч явлаа. Гүүрээр гарсан... Хэдийгээр улам халуун болж байсан ч эхний савтай хүчилтөрөгчөө ашигласаар байв.

Гэтэл... Та нар төсөөлж байгаа. Та нар баавгайн сэгийг харсан биз дээ? Утасны шон мөргөөд тархиа задалсан юм шиг тэр баавгайг.

-Бид харсан. Цаашаа яриач. Баавгайн хажуугаар өнгөрөхөд чиний толгой эргэж ухаан алдсан байх? гэж Расти толгой дохин ярина.

-Чи яаж мэдээ вэ?

-Бид ч бас тэр замаар ирсэн. Тэнд ямар нэг хүч үйлчилж байсан. Хүүхэд ба хөгшдөд илүү хүчтэй үйлчилж байна билээ.

-Би хөгшин биш гэж Сэм гомдолтой дуугараад: -Зүтээр л ээжийгээ дагаад эрт бууралтсан юм.

-Та ухаангүй хэр удаан хэвтсэн бэ? гэж Барби асуув.

-Надад цаг байхгүй л дээ. Гэхдээ цаашаа явах үед харанхуй болсон байсан. Тэгэхээр удсан гэсэн үг. Хоромхон зуур би сэргэсэн. Яагаад гэвэл амьсгалж чадахгүй байв. Шинэ саванд залгаад дахиад ухаан алдчихсан. Солиотой тийм үү? Би юу зүүдэлсэн гэж санана. Яг болж байгаа юм шиг тов тод зүүд. Харанхуй болсон хойно би бүрэн сэргээд шинэ саванд залгагдсан. Нэг их хэцүү биш байв. Яагаад гэвэл миний эргэн тойронд гэгээтэй байсан. Санаагаар бол Бүрхүүл дээр ийм их хөө тортог суусан юм чинь би юу ч харж чадахгүй байх ёстой. Гэвч миний явж байгаа тэр зүт, өмнө маань хурц бүс гэрэлтэж байсан. Өдөр харагдахааргүй. Харин шөнө тэрбум гэрэлт цох сүрэглэсэн юм шиг.

-Гэрэлтэх бүс. Бид тийм нэр өгсөн гэж Жо дундуур нь хэллээ. Норри Бенни тэр гурав хамт зогсоно. Бенни гараа амандаа бариад ханиана.

-Сайхан нэр байна. Тэр үед би дээр хэн нэгэн байгааг ойлгосон. Яагаад гэвэл сэнсний дууг сонсч, гал харж байсан гээд Сэм Бүрхүүлийн цаана байгаа цэргийн хуаран руу толгой сэжив.

-Агаар дуусахаас өмнө тэнд хүрч чадах эсэхээ мэдэхгүй байлаа. Өгсөхөд их хүч зарцуулж ойр ойрхон амьсгалж байв. Гэхдээ хүрсэн гээд тэр Кокс руу сониучирхан харсанаа -Хүүе хурандаа Клинк би таны амьсгалахыг харж байна. Та пальто нөмрөөд дулаан газар руу явсан нь дээр дээ гэснээ инээж үлдсэн хэдэн шүдээ харуулав.

-Би Клинк биш Кокс байна. Тэгээд ч даараагүй.

-Сэм та юу зүүдэлсэн бэ? гэж Жулия асуулаа.

-Энэ тухай та нар асуусан нь хачирхалтай. Миний зүүдэлсэн бүх юмнаас ганцхан зүйлийг санаж байна. Тэр бол таны тухай зүүд байсан. Та хотын талбайн тавцан дээр хэвтээд уйлж байсан.

Жулия Барбигийн гарнаас чанга базсан ч харцаа Сэмээс салгаж чадахгүй байв.

-Яагаад та намайг гэж бодоо вэ?

-Яагаад гэвэл таны дээр "Ардчилал" сонины дугаар хэвтэж байсан. Та хувцасгүй нүцгэн юм шиг тэр сониныг биедээ наагаад байсан. Та уучлаарай. Гэвч та өөрөө л асуусан шүү. Энэ таны сонссон зүүднүүдээс хамгийн хачирхалтай нь тийм үү?

Богино долгионы холбоо гурвантаа тасхийв. Кокс бүснээсээ холбоог авлаа.

-Юу вэ? Хурдан яриач. Би ажилтай байна.

Тэд бүгд Кокстой ярьж байгаа хүний дууг сонслоо.

-Хурандаа бид хотын өмнө талд амьд үлдсэн хүн оллоо. Давтан хэлье. Бид амьд үлдсэн хүн оллоо.

8

Аравдугаар сарын 28-ны өглөө нар мандахад Динсморын гэр бүлийн гишүүдээс үлдсэн сүүлчийн хүний тухайд амьд гарлаа гэж хэлж чадахаар болов. Олли бүх биеэрээ Бүрхүүлд наалдан хэвтээд сэнс нэвт түлхэх агаараар амьсгална. Одоо нүдэнд үзэгдэх болсон хаалтыг нэвтрэх агаар түүнийг зөвхөн амьд байлгахад л арай гэж хүрэлцэнэ.

Тэр саван дахь хүчилтөрөгч дуусахаас өмнө Бүрхүүлийн өөрийн талын гадаргууны хангалттай хэсгийг цэвэрлэж амжжээ. Түүнийг овоолгоостой төмсөн дор шургахад шалан дээр үлдсэн тэр сав. Энэ сав дэлбэрэх юм биш биз гэж бодож байснаа тэр санав. Дэлбэрсэнгүй. Үүгээрээ тэр Олли Динсморт тун их тус болжээ. Хэрэв дэлбэрсэн бол тэр одоо "рассет" ба "урт цагаан" сортын төмсөн оршуулгын бунхан дор хэвтэж байх байсан.

Олли Бүрхүүлийн дэргэд сөхрөн суугаад хар давхаргыг маажиж эхэлсэн. Энэ давхаргын зарим хэсэг нь хүнээс үлдсэн гэдгийг тэр мэдэж байв. Гарыг нь үе үе ясны хэлтэрхий хатгахыг Олли анзаарахгүй байж чадсангүй. Хэрэв эхэлсэнээ үргэлжлүүлэхийг байнга ятгах байлдагч Эймс дэргэд нь байгаагүй бол тэр бууж өгөх байлаа. Гэвч Эймс түүнд үхэрчин жаал минь биттий бууж өг. Зүлгэ, зүлгэ хэмээн үглэж байв. Чөтгөр ав. Зүлгэ, энэ бүх баасыг зүлгэ. Сэнснүүд чам руу агаар түлхэхийн тулд чи үүнийг хийх ёстой.

Олли ердөө ганцхан шалтгаанаар бууж өгөөгүй гэж бодно. Юу гэвэл Эймс түүний нэрийг мэдэхгүй. Дунд сургуульд түүнийг бүх хүүхдүүд баас идэгч юмуу баас саагч гэж дуудсаар тэр бүр бууж өгчээ. Харин Өмнөд Каролинаас ирсэн энэ бүтэлүй амьтан түүнийг үхэрчин жаал гэх тэнэг нэрээр дуудаж байгаа цагт үхэхгүй гэж өөртөө тангараглав.

Сэнснүүд уухилан эргэлдэхэд Олли халсан арьсыг нь сулхан салхи илбэхийг мэдэрлээ. Тэр багийг нүүрнээсээ авч чулуудаад ам хамраа Бүрхүүлийн гадаргууд наав. Дараа нь амаараа агаар залгилж хөө тортогийг нулиман Бүрхүүл дээр өөрийн талаас наалдсан бүхнийг цэвэрлэсээр байлаа. Одоо тэр яг хулганы үүр рүү шагайж байгаа мэт дөрвөн хөллөн суугаад толгойгоо бөхийлгөсөн Эймсийг олж харав.

-За тэр. Одоо дахиад хоёр сэнс авчирна. Үхэрчин жаал минь битгий бууж өг гэж тэр хашгирна.

-Олли гэж тэр арай гэж хэллээ.

-Юу гэнэ ээ?

-Миний нэр Олли. Намайг үхэрчин жаал... гэж дуудахаа боль.

-Одоо би чамайг үхэн үхтэлээ Олли гэж дуудах болно. Гэхдээ чи сэнсний агаар үлээх хэсгийг

цэвэрлэх хэрэгтэй.

Оллигийн уушиг ямар нэг байдлаар Бүрхүүлд нэвтрэн шүүрэх агаараас амьд үлдэх ба ухаантай байхад хүрэлцэх хэмжээний агаарыг амьсгалж чадав. Хөө тортог дахь нүхний цаана хорвоо ертөнц өнгө гэгээтэй байхыг тэр харна. Гэрэл мэдээж тусалж байв. Гэхдээ Бүрхүүл дээр үлдсэн бохир давхаргын цаанаас харах юм бол үүрийн гэгээ ягаан биш болохыг хараад зүрх нь шимширлээ. Гэвч гэрэл баяр хөөр төрүүлнэ. Яагаад гэвэл энэ талд бүх юм тас хар, шатаж түлэгдсэн хахир хатуу, дуу чимээгүй байсан.

Өглөөний таван цагт Эймсийг солихоор шийдэв. Түүнийг амраахаар явуулах гэтэл Олли үлдэхийг гуйн хашгирсан тул Эймс явахаас таггалзлаа. Дарга бууж өгөв. Амаараа Бүрхүүлд наалдаж уушигандаа агаар сорохын тулд түр завсарлаж байгаад Олли хэрхэн амьд үлдсэн тухайгаа бага багаар ярьж дөнгөв.

-Гал унтрах хүртэл хүлээх ёстойг би мэдэж байсан. Тийм учраас хүчилтөрөгчөө хэмнэсэн юм. Том өвөө хэрэв тэр унтах юм бол нэг сав бүхэл шөнөд хүрэлцдэг гэж ярьж байсныг санаад хөдөлгөөнгүй хэвтсэн юм. Төмсөн дор агаар үлдсэн бөгөөд би амьсгалж болж байсан тул ямар нэг хугацаанд хүчилтөрөгчөө ашиглахгүй байж чадсан. Тэр уруулаа гадаргууд наахад хөө тортог амтагдана. Энэ нь ердөө 20 цагийн өмнө амьд байсан хүний үлдэгдэл байх магадлалтай ч тэр үүнд санаа зовсонгүй. Тэр агаарыг шуналтай сорж, хар шүлсээр нулиман үргэлжлүүлэн ярина. -Эхлээд төмсөн дор хүйтэн байсан. Дараа нь дулаарч эцэстээ халуун болсон. Би амьдаараа шарагдах юм байна гэж бодлоо. Толгой дээр амбаар шатсан. Бүх юм шатсан. Гэхдээ түргэн шатаагүй нь намайг аварсан байх. Мэдэхгүй. Эхний сав хоосрох хүртэл би төмсөн дор байсан. Тэгээд гарч ирэхэд хүрэв. Би хоёр дахь савыг дэлбэрэх вий гэж айсан ч дэлбэрээгүй. Гэхдээ дэлбэрэхийн даваан дээр байсан гэж маргасан ч болно. Эймс толгой дохилоо.

Олли дахиад л Бүрхүүлээр агаар соров. Зузаан бохир даавууны цаанаас амьсгалахтай адил.

-Гол нь гишгүүр. Хэрэв тэр бетон биш модон гишгүүр байсан бол би тэндээс гарч чадахгүй байсан. Эхэндээ оролдоогүй. Эргээд төмсөн дороо орсон. Бүх юм аймаар халуун байсан. Дээд талын төмснүүд жигнэгдэж болсон байв. Би үнэрийг нь мэдэрч байлаа. Дараа нь амьсгалахад хэцүү болсон. Хоёр дахь сав дуусч байгааг би ойлгосон гээд тэр дуугүй болж ханиав. Ханиадаа даваад үргэлжлүүллээ. -Үхэхийн өмнө хүний дуу сонсох юмсан гэж маш их хүссэн. Чиний дууг сонссондоо баяртай байна. Байлдагч Эймс.

-Намайг Клинт гэдэг. Одоо чи үхэхгүй.

Гэвч Бүрхүүлийн ёроол орчмын бохир нүхээр Эймсийг харж байгаа нүд авсны шилэн нүхээр харж байгаа юм шиг бүлтэгнэх бөгөөд энэ нүд үнэнд арай ойрхон өөр үнэнийг мэдэж байлаа.

Дохио хоёр дахь удаагаа жингэнэн дуугарахад Картер хэдийгээр түүнийг энэ дуу зүүдгүй гүн нойрноос сэрээсэн боловч ямар учиртайг шууд ойлгов. Яагаад гэвэл бүх юм дуусах юмуу Картер өөрөө үхэх хүртэл тархины зарим хэсэг унтаж чадахгүй байв. Тэр амьд үлдэх зөн

совин үйлчилж байгааг тааварлав. Энэ бол тархины гүнд нуугдсан хэзээ ч үл зүүрмэглэх харуул билээ.

Бямба гаригийн өглөөний 7 цаг 30 минут болж байв. Товчон дээр дарахад цагны дэлгэц гэрэлтсэн учраас тэр хугацааг мэдэж байлаа. Шөнө ослын гэрэлтүүлгийн чийдэн унтарч, атомын хоргодох байранд тас харанхуй ноёрхсон.

Тэр суугаад хүзүү рүү нь ямар нэг юм чичлэхийг мэдэрсэн. Энэ нь шөнө ашигласан гар чийдэнгийн бариул байх гэж тааварлав. Тэмтрээд асаалаа. Тэр шалан дээр сууж байв. Том Жим буйдан дээр тухалжээ. Тэр л гар чийдэнгээр түүнийг чичилсэн аж.

Мэдээж түүнд буйдан оногдлоо. Тэр чинь босс шүү дээ гэж Картер дурамжхан бодов.

-Алив хүү минь, аль болох хурдан гэж Том Жим түүнийг яаруулна.

Яагаад би гэж? хэмээн Картер бодсон ч хэлсэнгүй. Мэдээж тэр л байж таарна. Яагаад гэвэл босс хөгшин, босс тарган ба боссын зүрх өвчтэй. Бас яагаад гэвэл мэдээж тэр босс болохоор. Жеймс Ренни бол Честерс-Миллийн эзэн хаан.

Хуучин машинуудын эзэн хаан. Чи бол тэр. Бас чи загасны тос ханхлуулж байна.

-Алив. Чи юу хүлээгээ вэ? гэж цухалдаж бас түтшсэн дуу гарав.

Картер босоход дэнлүүний гэрэл атомын хоргодох байрны элдэв юмаар өрж дүүргэсэн тавцан дээгүүр гүйлээ. (ямар олон сардин загас вэ) Тэгээд ханз байрлах нөгөө өрөө рүү оров. Энд ослын гэрэлтүүлгийн нэг чийдэн асч байх ба гэхдээ маш сул, бас анивчина. Жингэнэх дуу чанга, нэг хэмнэлтэйгээр "А-а-а-а" гэж дуугарна. Энэ бол айсуй төгсгөлийн дуу.

Бид эндээс гарч чадахгүй гэж Картер бодно.

Тэр дэнлүүний гэрлээ нэгэн хэмнэлээр тасралтгүй дуугарч түүнийг хязгааргүй цухалдуулах цахилгаан үүсгүүрийн урд талын нээлхий рүү чиглүүлэв. Яагаад ч юм Картер боссынхоо тухай гэнэт бодов. Магадгүй яагаад гэвэл энэ жингэнэх дуу ба боссын дуу хоолой хоёр ихэнхидээ нэг утгатай байв. Намайг тэжээ. Намайг тэжээ. Намайг тэжээ. Надад хий өг, надад сардин өг, надад миний "хаммер"-т тохирох өндөр октавтай бензин өг. Намайг тэжээ. Би үхлээ. Дараа нь чи үхнэ, тэгээд үүнд санаа зовох хэн ч байхгүй. Хэн анзаарах юм бэ? Намайг тэжээ. Намайг тэжээ. Намайг тэжээ.

Хонгилд одоо хийтэй долоохон сав үлджээ. Картер хоосорсон савыг солих үед 6 үлдэнэ. Тэдний амьд байгаа болоод бүтэж үхэх хоёрын хооронд зургаан өрөвдөлтэй савны хэмжээ. Агаар цэвэршүүлэгч салахаар үхэл гарцаагүй.

Картер нэг сав гаргаж ирээд цахилгаан үүсгүүрийн хажууд тавьлаа. Тэр хий хов хоосон болоогүй цагт хуучин савыг солих бодолгүй байв. "А-а-а-а-а" гэх цухалдуулсан дууг ч тоохгүй. Ингэхэд "Максвелл Хаус" кофений рекламанд юу гэдэг билээ дээ. Сүүлчийн дусал хүртлээ амттай.

Гэвч жингэнэх дохио мэдрэлд үйлчилнэ. Картер түүнийг олоод тасалж чадна гэж бодож байв. Гэвч хэрэв тэгэх юм бол хий дууссаныг яаж мэдэх юм бэ?

Бид яг л хөмөрсөн хувин дотроос гарч чадахгүй хос харх.

Тэр хэцүү биш тооцоо хийж үзлээ. Зургаан сав үлдсэн. Сав бүр 11 цаг ажиллана. Хэрэв тэд хөргүүрийг унтраах юм бол нэг савнаас цахилгаан үүсгүүр ажиллах хугацаа 12-13 цаг болж нэмэгдэнэ. Багаар бодсон нь дээр. Тиймээс 12 цаг. 6 удаа 12 цаг гэдэг чинь... энэ хэд вэ?...

"А-а-а-а-а" гэх дуунаас болж тоо бодоход хэцүү байлаа. Гэвч эцсийн эцэст дүнг гаргав. Харанхуйд бүтэж үхэх аймшигт үхэл хүртэл 72 цаг үлджээ. Яагаад харанхуйд гэж. Яагаад гэвэл аваарын гэрэлтүүлгийн системийн цэнэг хураагуурыг хэн ч цагт нь сольсонгүй. Яагаад гэвэл энэ цэнэг хураагуурыг 20 жил солиогүй байх. Түүнээс ч их байж мэднэ. Босс мөнгөө хэмнэжээ. Тэгээд яагаад ХБЭ дээр дэлбэлэхийг хүлээсэн тэрбум галлон хий байхад энэ хонгилд өрөвдөлтэй долоохон сав хий байдаг билээ. Яагаад гэвэл боссод түүний хүссэн газарт бүх юмыг хадгалах нь таалагддаг.

Цахилгаан үүсгүүрийн дэргэд суугаад "а-а-а-а-а" сонсож байхдаа Картер эцгийн хэлдэг байсан үгийг санах. "Цент" хэмнэх юм бол доллар алдана. Энэ яг Реннид зориулсан үг. Хуучин машины эзэн хаан Ренни. Нэрт улс төрч Ренни. Хар тамхины хаан Ренни. Тэр хар тамхи үйлдвэрлээд хэдийг олсон бол? Сая доллар уу? Хоёр сая уу? Одоо энэ бүхэн ямар утга учиртай юм бэ?

Тэр лав мөнгөө хэзээ ч үрэхгүй байсан. Одоо бол үрэхгүй нь бүр тодорхой боллоо. Энэ хоргодох байранд юу ч үрэгдэхгүй. Түүний мэдэлд зөвхөн тэр л идэж чадах сардин загас бий. Тэр нь үнэ төлбөргүй.

-Картер гэх дуу харанхуйгаас хөвж ирэв. -Чи савыг солих гэж байна уу? Эсвэл жингэнэх дохиог сонссоор байх уу?

Минут болгон хэрэгтэй учраас хүлээх ёстой гэж Картер хашгирахаар яг амаа нээтэл "а-а-а" гэх дуу таг болов. Агаар цэвэршүүлэгч бас зогслоо. -Картер.

-Хийж байна аа босс. Тэр дэнлүүг сугандаа хавчуулаад хоосон савыг авч төмөр тавцан дээр шинийг тавив. Уг нь энэ тавцан дээр арав дахин том сав тавихаар зай хангалттай байлаа. Тэгээд цахилгаан үүсгүүрт холбов.

Минут болгон хэрэгтэй... Эсвэл үгүй юу? Хэрэв бүх юм бүтэж үхэхээр дуусах юм бол яагаад хэрэгтэй гэж?

Гэвч амьд үлдэхийг хариуцсан харуул далан хоёр цаг бол далан хоёр цаг л учраас тэр цагны минут бүхэн хамаатай гэж бодно. Энэ хугацаанд юу болохыг хэн мэдлээ? Цэргийнхэн Бүрхүүлийг нээх аргыг олж мэднэ. Эсвэл тэр анх гарч ирсэн шигээ санаанд оромгүй гэнэтхэн өөрөө алга болж мэднэ.

-Картер чи тэнд юу хийгээд байна вэ? Миний эмээ хүртэл чамаас түргэн дуусгах байсан.

Гэтэл тэр үхсэн хүн.

-Бараг дууслаа.

Холболт нягт болсон эсэхийг шалгаад өдөөгчийн товчон дээр хуруугаа тавив. (бяцхан цахилгаан үүсгүүрийн цэнэг хураагуур аваарын гэрэлтүүлгийн системийн цэнэг хураагуур шиг хуучирсан бол асуудал үүсч мэднэ гэж бодов) Дараа нь шал өөр шалтгаанаар товчийг дарахаа болилоо.

Хоёр хүнд 72 цаг. Хэрэв тэр ганцаараа байсан бол хийний нөөцийг 90 цаг юмуу 100 цаг хүртэл сунгаж мэднэ. Амьсгалахад бүр боломжгүй болох хүртэл агаар цэвэршүүлэгчийг салгаж болно. Тэр энэ тухай Том Жимд хэлсэн ч өнөөх нь энэ санааг няцаасан.

"Миний зүрх өвчтэй. Агаар муу байхын хэрээр хурдан дордоно" гэж тэр Картерт сануулсан.

-Картер гэх чанга шаардангуй дуу хадав. Урьд нь боссын сардин загасны үнэр хамар цоргисон шиг энэ дуу чих рүү хатгав. -Чи юу болоод байна вэ?

-Бэлэн босс оо гээд тэр товчийг дарлаа. Өдөөгч тасхийгээд цахилгаан үүсгүүр шууд ажиллав.

Энэ талаар бодох хэрэгтэй гэж Картер өөртөө хэлэв. Гэвч амьд үлдэхийг хариуцсан харуул өөр бодолтой байлаа. Өөртөө бус зориулсан минут бүр алдагдсан минут гэж тэр бодов.

Тэр надад их сайн ханддаг байсан. Чухал даалгаврууд өгдөг байсан гэж Картер өөртөө хэлэв.

Өөрөө хийхийг хүсэхгүй бохир ажлуудыг даалгаж байсан.

Тэр ийм л даалгавар өгсөн. Бас хамт үхэхийн тулд газар доорх нүх рүү чирч оруулсан. Үүнийг битгий мартаарай.

Картер шийдвэрээ гаргалаа. Том өрөө рүү буцахаас өмнө хуйнаас гар буугаа сугалав. Эхэндээ боссод анзаарагдахгүйн тулд гар буугаа ардаа нуухыг хүссэн ч энэ санаанаас буцав. Ренни түүнийг хүү гэж нэрлэдэг. Түүний хувьд энэ зүгээр нэг үг биш байх. Тэгэхээр сүүлчийн залбиралаа хийлгүй дагзандаа гэнэт буудуулж үхэхээс арай дээр үхлээр үхэх гавьяатай.

10

Хотын хамгийн алсын зүүн хойд хэсэгт үүр цайлаа. Энд Бүрхүүл мөн л хөө тортогт хучигдсан ч тунгалаг байддаа бүрэн алдсангүй. Нар түүний цаанаас гэрэлтэж, эргэн тойрны бүх юмыг хайлсан ягаан өнгөөр будна.

Норри Барби Жулия хоёр дээр гүйж ирэв. Охин ханиаж байсан ч гүйжээ.

-Манай өвөө харвалт өгчихлөө гэж тэр хашгираад дараа нь сөхрөн сууж хахаж цацан ханиав.

Жулия охиныг тэврээд нүүрийг нь дүнгэнэх сэнснүүд рүү харууллаа. Эрниг Расти, Жинни ба Дуги нар тойрон зогсох тэр газар руу Барби мөлхөв.

-Тарцгаа. Түүнд хүчилтөрөгчөө өг гэж Барби тушаав.

-Асуудал энд л байна. Тэд үлдсэн бүхнээ түүнд өгсөн... Хүүхдүүдэд өгөх гэж байсныгаа. Гэвч... гэж Тони хариулав.

-Эпи гэж Расти дүгнээд Дугид тариур сунгав. -Жинни зүрхний иллэг хий. Чамайг ядрахаар Дуги солигдоно. Дараа нь би. (эпи дайрлага-дахин давтагдах салгалалт, ухаан алдалт)

-Би бас хүсч байна. Би хичээлд явсан гэж Жоани хэллээ. Түүний хацраар нулимс урсана.

-Би ч бас. Би туслая гэж Клер хэлэв.

-Би бас. Би өнгөрсөн зун тусгай дамжаа төгссөн гэж Линда нэгдлээ.

Манай хот жижигхэн. Түүний хувь заяаг бид хамт хуваалцдаг гэж Барби бодов. Авсан гэмтлээсээ болж нүүр нь хавдсан Жинни Эрнигийн цээжин дээр иллэг хийж эхэллээ. Барби дээр Жулия Норри нар ирэх үед Дуги иллэг хийхээр зэхээд байв.

-Тэд түүнийг аварч чадах уу? гэж Норри асуулаа. -Мэдэхгүй гэж Барби хариулав. Гэвч тэр мэдэж байсан. Үүнд л бүх аймшиг байлаа.

Дуги Жиннигийн байрыг эзлэв. Дугигийн духнаас дуслах хөлс Эрнигийн цамцан дээр хар толбо болон томрохыг Барби харж байна. Таван минутын дараа тэр болиод сөөнгөтөн ханиалаа.

Расти түүнийг орлох гэсэн боловч Дуги толгой сэгсэрлээ.

-Тэр явчихлаа. Хатагтай Кэлверт би маш их харамсч байна гэж тэр Жоанид хандав.

Жоанигийн нүүр чичирсэнээ дараа нь мурийв. Тэр гашуунаар хашгирсанаа дараа нь ханиалаа. Норри түүнийг тэврээд хамт ханиана.

-Барби хоёрхон үг сольё гэх дуу гарлаа.

Түүнийг Кокс дууджээ. Бүрхүүлийн гаднах хүйтнээс хамгаалан зузаан хүрэм өмссөн байв. Түүний царай баргар байгаа нь Барбид таалагдсангүй. Жулия хамт очлоо. Тэд жигд удаан амьсгалахыг хичээн Бүрхүүлд наалдав.

-Нью-Мексико муж улсын Киртленд дэх агаарын цэргийн бааз дээр золгүй явдал боллоо. Тэнд бага оврын атомын бөмбөгийн сүүлчийн туршилт явагдаж байсан юм. Бид түүнийг хэрэглэх гэж байсан. Гэтэл... чөтгөр гэж Кокс дуугаа намсган ярив.

-Дэлбэрчихсэн үү? гэж Жулия айдаст автан асуулаа.

-Үгүй. Хайлчихлаа. Хоёр хүн үхсэн. Бас нилээд хэдэн хүн цацраг түлэгдэлт ба туяанаас удахгүй үхнэ. Гэвч гол нь бид бөмбөггүй болчихлоо. Бид атомын бөмбөггүй болчихлоо.

-Ямар нэг эвдрэл гараа юу? гэж тун их найдан асуув. Яагаад гэвэл тэгэх юм бол цэргийнхэн бага оврын бөмбөг ашиглах санаанаас татгалзах байв.

-Үгүй дээ хурандаа тийм учраас л би золгүй тохиолдол гэж хэлсэн. Хүмүүс яарах үед ийм юм болчихдог. Харин бид бүгд аймшигтай яаруу нөхцөлд ажиллаж байна.

-Тэр хүмүүст би маш их харамсч байна. Хамаатан саднууд нь мэдсэн үү? гэж Жулия хэллээ.

-Та нарын байгаа нөхцөл байдлыг тооцох юм бол ингэж харууссанд маш их баярлалаа. Удахгүй мэдээлнэ. Шөнийн нэг цагт ийм юм болжээ. Гэхдээ хоёр дугаартай бага оврын бөмбөгийн ажил аль хэдийн эхэлсэн. Гурав хоногийн дотор бэлэн болгох ёстой. Дээд тал нь дөрөв хоног.

-Баярлалаа ноёнтон. Гэвч бид тийм удаан тэснэ гэдэгт би итгэхгүй байна.

Тэдний ард зүрх зүсэм гашуудалтай уртаар чарлах дуу гарав. Хүүхдийн чарлах дуу. Барби Жулия хоёрыг эргэж харахад чарлах дуу ханиах ба цацах болж хувирав. Линда том охин дээрээ сөхрөн суугаад тэвэрсэн байхыг тэд харлаа.

-Тэр үхэж болохгүй. Одри үхэж болохгүй гэж Жанни хашгирна.

Гэвч нохой үхсэн. Эвереттийн алтан шар өнгөтэй нохой нь хоёр охин нохойнхоо хоёр талаар унтаж байхад ямар нэгэн шуугиан тарилгүй нөгөө ертөнцөд одов.

11

Картерийг том өрөөнд эргэж ирэхэд Честерс-Миллийн захиргааны хоёрдугаар гишүүн дээр нь хүүхэлдэйн тоть зурсан хайрцагтай өглөөний хуурай хоол идэж байв. Картер хүүхэд байхдаа өглөө ширээн дээр олон удаа харсан энэ гоё шувууг таньлаа. "Фрут лупс" хуурай хоолны ариун ивээгч Тукан Сэм тоть.

Энэ цагирагнууд чөтгөр шиг хатуу байгаа байх даа гэж Картер бодоод хоромхон зуур боссыг өрөвдөв. Дараа нь далан хоёр ба ная эсвэл бүр зуун цагийн хоорондох ялгааг санаад зүрх нь дахиад чулуужив.

Том Жим дахиад нэг атга цагариг ам руу илгээх үедээ Картерийн гарт буу байхыг харлаа.

-Энэ юу вэ?

-Босс уучлаарай.

Том Жим хуруугаа тэнийлгэхэд гарт нь үлдсэн хурц өнгөтэй цагаригнууд эргээд хайрцаг руу асгарав. Гэвч хэдэн ширхэг цагариг хөлсөнд норсон хуруу ба алганд нь наалдлаа. Духан дээр нь хөлс гялалзаж, үсэн дороос нь урсав.

-Хүү минь ийм юм биттэй хий.

-Ноён Ренни би хийх ёстой. Хувийн юм юу ч байхгүй.

Картер үүнд итгэж байв. Энд хувийн юм огт байхгүй. Тэд энд занганд оржээ. Бүх асуудал энд байна. Нэгэнт тэд Том Жимийн гаргасан шийдвэрийн ачаар ийшээ орсон бол тэр л төлбөр хийх ёстой.

Ренни "Фрут лупс"-ийн хайрцагаа шалан дээр тавьлаа. Хэрэв шал руу шидвэл хайрцаг задарна гэж айх шиг маш болгоомжтой тавив.

-Тэгвэл юу гэж?

-Бүх юм... Агаарт учир байна.

-Агаар. Ойлголоо.

-Би буюгаа ардаа нууж орж ирээд толгой руу чинь сум зоож болох л байсан. Гэвч ингэхийг хүсээгүй. Би танд бэлдэх хугацаа өгөх гэсэн юм. Яагаад гэвэл танаас би зөвхөн сайныг олж хардаг байсан.

-Хүү минь тэгвэл намайг зовж шаналахад битгий хүргээч. Хувийн юм юу ч байхгүй хойно чи намайг зовж тарчлаахгүй биз дээ?

-Хэрэв чи номхон байх юм бол зовж тарчлаах хэрэг гарахгүй. Бүх юм түргэн дуусна. Би ойд шархадсан буга буудах шиг таныг буудна.

-Бид энэ тал дээр ярилцаж болох уу?

-Үгүй ноёнтон. Би шийдвэрээ гаргасан.

Том Жим толгой дохив.

-За яахав. Би эхлээд залбирч болох уу? Чи надад үүнийг зөвшөөрөх үү?

-Тийм ноёнтон. Хэрэв та хүсвэл залбирч болно. Гэхдээ түргэл. Надад ч бас хэцүү байна. Ойлгож байна уу?

-Би чамд итгэж байна. Хүү минь чи сайн залуу.

Арван дөрвөн настайгаасаа хойш уйлж үзээгүй Картер нүднийх нь булан хорсож эхлэхийг мэдрэв.

-Намайг хүү гэж дуудах хэрэггүй. Энэ чамд тус болохгүй.

-Гэвч надад тус болдог юм. Чиний сэтгэл хөдөлсөнийг би харж байна. Энэ ч надад тус болж байна гээд Том Жим буйдангаас гулсаж сөхрөн суув. Энэ үед "Фрут лупс"-ын хайрцгийг шүргэхэд өнөөх нь хазайн унав. Том Жим гунигтай инээгээд: -Сүүлчийн хоол онц биш байсан гэдгийг чамд илтгэе.

-Тийм. Онц биш. Харамсаж байна.

Том Жим одоо Картер руу нуруугаа харуулан суугаад санаа алдлаа.

-Гэвч би нэг хоёр минутын дараа есүстэй нэг ширээнд суугаад жигнэсэн мах идэх учраас бүх юм хэвийн гэснээ памбагар хуруугаа өргөж үсэн доогуур хүзүү рүүгээ хүргээд -Ийшээ. Нугасны багана руу. Ойлгов уу?

Картер том хуурай хөвөн бөмбөлөг залгих мэт шүлсээ залгив.

-Тийм ээ, ноёнтон.

-Хүү минь надтай хамт сөхрөхийг хүсч байна уу? Удтал уйлж үзээгүйгээс илүү залбирч огт үзээгүй Картер тийм гэж хариулах шахав. Дараа нь босс хичнээн зальтай байж

болохыг саналаа. Магадгүй тэр одоо зальдаагүй байж болно. Гэвч түүнийг ингэж байхыг олон удаа харж байсан Картер аз үзэхийг хүссэнгүй. Тэр толгой сэгсрэв.

-Залбир. Хэрэв хүсвэл аминь хүртэл яваарай. Таны залбирал богинохон байх ёстой.

Том Жим Картер руу нуруугаа харуулан сөхөрч суугаад буйдангийн дэрэн дээр гараа тавив. Дэр түүний хүнд жинтэй бөгсөн дор шалчийсан байлаа.

-Ариун бурхан минь би чиний зарц Жеймс Ренни байна. Миний ойлгож байгаагаар би хүссэн хүсээгүй чам руу очиж явна. Миний уруулд аяга барьсан тул би чадахгүй... гэснээ сөөнгөтөн цурхираад: -Картер гэрлээ унтраа. Би чиний нүдэн дээр уйлахыг хүсэхгүй байна. Эр хүн ингэж үхэх ёсгүй гэв.

Картер буутай гараа урагш сунгахад бууны ам Том Жимийн хүзүүг бараг шүргэв.

-За яахав энэ чиний сүүлчийн хүсэлт шүү гээд дэнлүүгээ унтраалаа.

Тэр яг үүнийг хийж байх үедээ алдаа гаргаснаа ойлгосон ч аль хэдийн хожимджээ. Босс зүрхний өвчтэй том биетэй хүн гэхэд гайхалтай түргэн хөдлөв. Картер буудахад бууны амнаас манасхийсэн гэрэлд бөгсний мөр гарсан буйдангийн дэрэн дээр нүх үлдэх нь харагдав. Том Жим буйдангийн өмнө сөхрөхөө больсон хэдий ч тэр хичнээн хурдаллаа гээд хол явж чадсангүй. Гэвч Картер дэнлүүний товчтой ноцолдож байх хооронд Том Жим махны хутгаар дүрлээ. Хутгыг тэр урьд нь зуухны хажуугийн шургуулганаас авсан билээ. Тэгээд 6 дюйм урт ган төмөр Картерийн гэдэс рүү зоогдов.

Тэр өвдсөндөө хашгираад дахин буудлаа. Сум чихнийх нь хажуугаар шунгинахыг Том Жим мэдэрсэн ч зугтсангүй. Түүний толгойд ч бас амьд үлдэхийг хариуцсан харуул байдаг. Энэ харуул түүнд олон жил үнэнч зүтгэсэн бөгөөд хэрэв Том Жим ухрах юм бол үхнэ гэдгийг сануулав. Тиймээс Ренни төвөггүй босч зогсохдоо хутгаа хамт дээш өргөж Том Жим Ренниг ялах санаатай байсан тэнэг жаалын гэдсийг хүү татлаа.

Гэдэс нь хоёр хуваагдахад дахиад хашгирав. Цусны дуслууд Том Жимийн нүүрийг будав. Энэ

цусан дусал жаалхүүгийн сүүлчийн амьсгалтай хамт нисэн гарсан гэж Том Жим найдлаа. Тэгээд Картерийг түлхэв. Түүний гарнаас унасан дэнлүүний гэрэлд Картер газраар хөглөрсөн хуурай хоол дээгүүр гишгэлж гэдсээ даран ухрав. Тэр тавиураас барих гэж оролдоод сөхрөн уналаа. Дээрээс нь лаазалсан шөл сардин загаснууд асгарав. Хоромхон зуур өвдөг дээрээ хөшиж бодлоо өөрчлөөд залбирахаар шийдсэн мэт суув. Үснүүд нь духан дээр нь унажээ. Дараа нь тавиураас барьсан хуруунууд тавигдаж тэр доош харан тэрийв.

Том Жим хутгаа хараад түүний өвчтэй зүрхэнд (тэр энэ хямрал дуусангуут эрүүл мэнддээ анхаарна гэж өөртөө амлав) дэндүү хүнд ачаалал болно гэж үзэв. Тиймээс Картерийн бууг шалан дээрээс аваад тэнэг жаалд дөхөж очлоо.

-Картер чи энэ хорвоодоо байна уу?

Картер гаслан ёолов. Дээшээ харах гэж оролдоод чадсангүй.

-Би чиний хүссэн шиг яг нугас руу чинь сум зоох гэж байна. Гэвч чамд нэг зөвлөгөө өгөх гэсэн юм. Чи сонсч байна уу? Картер дахиад ёолов. Энэ эерэг хариулт гэж Ренни үзлээ.

-Ийм зөвлөгөө байна. Сайн улс төрчид залбирах цаг хэзээ ч биттий өгч бай.

Тэгээд Том Жим гохыг дарлаа.

12

-Тэр үхэж байна гэж би бодож байна. Залуу үхэж байх шиг байна гэж байлдагч Эймс хашгирав.

Ахлагч Гро Эймсийн хажууд өвдөглөн суугаад Бүрхүүлийн ёроолын бохир цонх руу шагайлаа. Олли Динсмор хажуугаараа хэвтэж тэдний харж болохоор байсан гадаргууд уруулаа наасан байв. Яагаад гэвэл жаалхүү Бүрхүүлийг бүрэн цэвэрлэж чадаагүй. Гро яг л цэргийн сургуулилтын талбай дээр байгаа юм шиг гуаглана.

-Хүүе Олли Динсмор зэрэгц дундаа.

Олли маш удаан нүдээ нээгээд түүнээс ганц футээс ч бага зайнд мөртлөө илүү хүйтэн цэвэр ертөнцөд өвдөглөн суух хоёр эрийг харлаа.

-Юу вэ? гэж тэр шивнэв.

-Зүтээр хүү минь дахиад унт гээд ахлагч Эймс рүү эргэж -Байлдагч тайвшир. Тэр хэвийн байна гэв. -Үгүй. Та түүнийг хараач дээ.

Гро Эймсийн гарнаас барьж түүнийг босоход нь эелдгээр туслав.

Тэгснээ шивнэн хэллээ.

-Үгүй. Тэр хэвийн биш байна. Гэвч тэр амьд ба унтаж байна. Одоо бид үүнээс өөр юунд ч

найдах аргагүй. Хүн унтах үедээ хүчилтөрөгч бага хэрэглэдэг. Чи юм идэх хэрэгтэй. Чи цайгаа уусан уу?

Эймс толгой сэгсрэв. Өглөөний цайны тухай бодол түүний толгойд орсонгүй.

-Би энд байхыг хүсч байна. Хэрэв тэр сэрвэл гэснээ дуугүй болоод дахин нэмж хэлэв. -Хэрэв тэр үхвэл би дэргэд нь баймаар байна.

-Одоохондоо тэр үхэхгүй гэж Гро хэлэхдээ үнэн эсэхийг мэдсэнгүй. -Ямар нэг хуурай юм ид. Ядаж хиамтай талх. Чи аймаар харагдаж байна шүү цэрэг минь.

Эймс шатсан газар дээр ам хамраа Бүрхүүлд наагаад унтаж байгаа хүүгийн зүг толгой сэжив. Нүүрийг нь тортог хучжээ. Тэд цээж нь хэрхэн өргөгдөж бас бууж байгааг арай гэж харна.

-Ахлагч аа, тэр хэр удаан тэсэх бол? Та юу гэж бодож байна?

Гро толгой сэгсрэв.

-Нэг их удахгүй байх. Хотын нөгөө талд байгаа бүлгийн хэн нэг нь өнөө өглөө үхсэн. Бас хэдэн хүний бие муу байгаа. Дашрамд хэлэхэд тэнд илүү дээр агаартай. Арай цэвэр. Чи муу юм болоход бэлдэх ёстой.

Эймс бараг уйлах шахав.

-Энэ залуу гэр бүлээ бүгдийг нь алдсан.

-Чи яваад өөртөө идэх юм ол. Чамайг эргэж иртэл би энд байж байя.

-Дараа нь би энд үлдэж болох уу?

-Байлдагч аа, чи түүнд хэрэгтэй. Тэр чамайг авах болно. Эцсийг нь хүртэл энд байж болно.

Эймс нисдэг тэрэгний орчим тавьсан ширээн дээр байх ганц нэг идэх юм руу хар хурдаараа гүйхийг Гро ажиглана. Энэ бүхэн өглөөний 10 цагт болсон явдал. Намар оройн цагаар байдаг тийм л сайхан өглөө байлаа. Нар халж өвсийг хучсан цан хярууг хайлуулна. Гэвч эндээс хэдхэн футын зайд Бүрхүүлээр хучигдсан өөр ертөнц байв. Тэнд мөнхийн харанхуй ноёлж, агаар амьсгалахад хэрэгцээгүй болж, цаг хугацаа утга учраа алджээ. Гро төрөлх хотынхоо паркад байдаг цөөрмийг санав. Цөөрөмд том хөгшин алтан карп загаснууд байдаг. Хүүхдүүд тэднийг байнга хооллоно. Нэгэн цэцэрлэгчийн буруугаар цөөрөмд ямар нэгэн бордоо орох хүртэл ийм байсан. Тэгээд загаснууд "баяртай" болсон. Бүх арав билүү арван хоёр загас гэдсээ дээш харуулан хөвж байсан.

Бүрхүүлийн цаана унтаж байгаа бохир жаалхүүг харахдаа ахлагч тэр загаснуудыг бодохгүй байж чадсангүй... Гэхдээ жаалхүү загас биш.

Эймс ямар нэг юм идэнгээ эргэж ирсэн ч дур хүсэл байхгүй нь мэдрэгдэнэ. Грогийн бодлоор тэр сайн цэрэг биш боловч эелдэг зүрхтэй залуу.

-Байлдагч Эймс суу. Ахлагч Гро хажууд нь суулаа. Үд дундын алдад Бүрхүүлийн хойд хэсэгт амьд үлдсэн бас нэг хүн үхсэн тухай мэдээлэв. Эйдэн нэртэй жаахан хүү гэнэ. Бас нэг хүүхэд. Гро түүний эхийг нэг хоногийн өмнө харсан санагдана. Тийм биш байх гэж найдавч яг түүнийг харсан байх гэж айна.

-Үүнийг хэн хийсэн юм бэ? Ахлагч аа, энэ бүхнийг хэн зохиосон юм бэ? Бас яагаад? гэж Эймс асуув. Гро толгой сэгсрээд: -Мэдэхгүй.

-Энэ ямар ч утгагүй пгүү дээ гэж Эймс дуу алдана.

Бүрхүүлийн цаана Олли хөдөллөө. Хоёр ертөнцийг хуваасан хаалтнаас ам нь салж агаарын эх сурвалжаа алдангуут нойрон дундаа дахиад л сэнснүүд агаар шахах Бүрхүүл рүү эргэв.

-Түүнийг битгий сэрээгээрэй гэж Гро санууллаа.

Хэрэв тэр нойрондоо явах юм бол бүхний хувьд дээр байх болно.

13

Өдрийн хоёр цаг гэхэд гайхалтай нь архичин Сэмээс бусад бүх хүн ханиаж эхэллээ. Харин тэр энэ аймаар агаараас бүр цэцэглэх шиг болов. Бяцхан Литл-Уолтер үргэлж унтах бөгөөд хааяа нэг сүү юмуу жүүс ууна.

Барби Бүрхүүлийн дэргэд Жулияг тэврэн сууна. Холгүй Маршалл аймшигтайгаар гэнэт үхсэн Эйденийг хучаад дэргэд нь суужээ. Одоо тасралтгүй ханиах Маршалл Элисийг гартаа тэвэрчээ. Охин унтах хүртлээ уйлав. Хорин футын цаана Расти эхнэр болоод ханиаж ханиаж дөнгөж сая унтсан охидоо тэврэн сууна. Охидын нүднээс зайлуулж Одриг түргэний тэрэгт хийжээ. Тийшээ явж ирэх хооронд амьсгаагүй гүйхэд хүрсэн. Бүрхүүлээс 15 ярд холдоход л агаар бүтээж алж байв.

Амьсгалаа сэргээнгүүт бяцхан хүүгийн цогцосыг мөн ингэхээр Расти бодож байлаа. Одри түүнд сайн нөхөр болно. Тэр үргэлж хүүхдэд хайртай байсан.

Жо Барбигийн хажууд газарт хэвтэнэ. Тэр одоо үнэхээр мануухай шиг харагдаж байв. Цонхигор царайг нь батга дүүрч, нүдэн доор нь том улаан хүүдий үүсчээ.

-Ээж унтаж байна гэж тэр мэдээлэв.

-Жулия ч бас. Тиймээс чимээгүй бай.

Жулия нэг нүдээ нээгээд: -би унтаагүй гэснээ тэр дороо хаав. Ханиагаад, чимээгүй болоод, дахиад ханиаж эхлэв.

-Бенни өвчилсөн. Жаалхүү үхэхийнхээ өмнө тэгсэн шиг халуурсан. Миний ээж ч бас хачин халуун байна. Энд халуун болоод тэр байж мэднэ. Гэвч... би тэгж бодохгүй байна. Хэрэв тэр үхвэл яах вэ? Хэрэв бид үхвэл яах вэ?

-Бид үхэхгүй. Тэд ямар нэг юм бодож олно гээд Барби Бүрхүүл рүү толгой сэжив.

Жо толгой сэгсрээд:

-Тэд чадахгүй. Та үүнийг мэдэж байгаа. Яагаад гэвэл тэд гадна талд байгаа. Гадна талаас бидэнд хэн ч туслаж чадахгүй гэснээ нэг хоногийн өмнө хот байсан хар үнс рүү хараад инээсэн ба удалгүй хэржигнэв. Энэ инээд айдас төрүүлэв. Яагаад гэвэл энэ инээдэнд ямар ч хөгжил баяр байсангүй. -Честерс-Милл 1803 онд хот болсон. Бид үүнийг сургуульд уншсан. 200 гаруй жилийн өмнө. Гэтэл газрын хөрснөөс арчихад долоо хоног хүрэлцлээ. Үүнд ердөө долоо хоног зарцуулжээ. Яаж ийм юм байж болох вэ? Хурандаа Барбара.

Барби юу гэж хариулахаа мэдсэнгүй.

Жо амаа таглаад ханиав. Бүрхүүлийн нөгөө талд сэнснүүд хүнгэнэсээр байлаа.

-Би ухаантай хүүхэд. Та үүнийг мэдэх үү? Би өөрийгөө магтаж байгаа биш гэж хэлэх гэсэн юм. Би ухаантай.

Барби пуужингийн цохилтын газраас энэ хүүгийн зохион байгуулсан дүрс бичлэгийн нэвгрүүлгийг бодлоо.

-Асуудал байхгүй Жо.

-Спилбергийн кинонд ухаантай хүүхэд л хамгийн сүүлийн мөчид бүхнийг аврах шийдэл олдог. Эсвэл үгүй юу?

Жулия дахиад хөдлөхийг Барби мэдрэв. Тэр одоо хоёр нүдээ нээгээд Жо руу тасралтгүй харна.

Жаалхүүгийн хацраар нулимс урслаа.

-Би Спилбергийн киноны хүүгийн дүрд тохирохгүй юм байна. Хэрэв бид Юрийн галавын цэцэрлэгт байсан бол үлэг гүрвэлүүд биднийг идэх байсан.

-Хэрэв тэд зөвхөн ядарсан бол гэж Жулия мөрөөдөнгүй хэллээ.

-Хэн? гэж Жо түүнд хандав.

-Илгэн толгойтнууд. Илгэн толгойтой хүүхдүүд. Хүүхэд чинь тоглоомондоо ядраад өөр юм хийдэг биз дээ? Эсвэл... эсвэл ээж аав нь хоолоо ид гэж дуудвал? гэснээ тэр хүчтэй ханиав.

-Магадгүй тэд хоол идцэггүй байж болно. Магадгүй тэдэнд эцэг эх байдаггүй байж болно гэж Жо барайн хэлэв.

-Магадгүй. Тэдний тэнд цаг хугацаа өөр байж ч мэднэ. Тэдний ертөнцөд бол тэд хайрцагныхаа өмнө дөнгөж суусан ч байж мэднэ. Тоглоом дөнгөж эхэлж байж болно. Тэд хүүхдүүд эсэхийг ч бид мэдэхгүй гэж Барби нэмлээ.

Тэдний ярианд Пайпер нэгдэв. Нүүр нь шатаж үс нь хацартаа наалджээ.

-Тэд хүүхдүүд.

-Чи яаж мэдсэн юм бэ? гэж Барби асуув.

-Зүгээр л мэдэж байна. Тэд бол гурван жилийн өмнө миний итгэхээ больсон Бурхан. Сансарын орон зайд икс-бокс тоглож байгаа хэсэг бяцхан муу хүүхдүүд болж хувирсан Бурхан. Энэ инээдтэй биш гэж үү? гээд Пайпер инээснээ тэр дороо цурхиран уйлав.

Жулия улаан гэрлээр анивчих хайрцагны зүг харлаа. Царай нь бодлогоширонгуй, бас бага зэрэг мөрөөдөнгүй болов.

14

Честерс-Миллд бямба гаригийн үдэш боллоо. Уг нь энэ өдрийн орой "Дорнодын од" бүлгэмд багтдаг эмэгтэйчүүд хурлаа хийдэг байсан. (хурлын дараа тэд голдуу Генриеттагийн очиж дарс уугаад сүүлийн үеийн онигоо ярьдаг) Энэ үдэш Рэндолф ба түүний нөхөд голдуу хөзөр наадна. (тэд мөн л сүүлийн үеийн онигоо ярьдаг). Энэ үдшийн орой Стюарт Ферн хоёр голдуу Льюистон орж доод Лисбон-Стрит гудамжны буурчийн газарт хоёр биеэ үнэлэгч авдаг. Энэ өдрийн үдэш гэгээн лам Лестер Ариун Гэм цайруулагчийн сүмд хүүхдүүдтэй залбирдаг. Харин Пайпер Конго сүмийн хонгилд залуучуудад зориулан бүжиг зохиодог. Энэ өдрийн үдэш "Дипперс" шөнийн нэг цаг хүртэл нижигнэнэ.

(12 хагасын үед цугларсан согтуучууд Бостоны бүх рок хамтлагийн сайн мэддэг өөрсдийн сүлд дуу болох "Бохир ус"-ыг дуулна) Энэ өдрийн үдэш Гови ба Бренда Перкинс нар гар гараасаа хөтлөн таньдаг бусад хүмүүстэйгээ мэндлэн хотын талбайгаар салхилж алхдаг. Энэ өдрийн үдэш Олден Динсмор эхнэр Шелли ба хоёр хүүхдийн хамт бүтэн сарны гэрэлд бөмбөг шидэн тоглодог. Честерс-Миллд (өөрийн багийг дэмждэг олонхи жижиг хот шиг) бямба гаригийн үдэш голдуу бүжиг, секс ба хүсэл мөрөөдөлдөө автсан хамгийн шилдэг үдэш байдаг.

Гэвч энэ бямба гаригийн үдэш биш. Энэ үдэш баргар бөгөөд төгсгөлгүй сунжирна. Салхи аль хэдийн амь тавьжээ. Хортой агаар халуун бөгөөд хөшүүн. Саяхан 119-р зам байгаад одоо галд хайлсан тэр газарт Олли Динсмор Бүрхүүлийн цэвэрлэсэн гадаргууд наалдан хэвтэнэ. Тэр амьдралаас байдгаараа зуурах бөгөөд хагас футын зайнд байлдагч Эймс тасралтгүй жижүүрлэнэ. Хэн нэг тэнэг нь Олли руу дэнгийн гэрэл чиглүүлэхийг хүсэв. Харин Эймс (ахлагч Грогоор дэмжүүлсэн. Өнөөх нь тийм ч харгис аймаар хүн биш байжээ) үүнийг хийлгээгүй. Яагаад гэвэл үүр цайхаас өмнө үхэх гэж байгаа жаалхүү рүү биш зөвхөн алан хядагч руу л бол унтаж байхад нь нүүр рүү нь гэрэл тусгадаг. Эймст өөрт нь гар чийдэн байсан бөгөөд тэр хааяа асааж жаалхүү амьсгалсаар байгаа эсэхийг шалгана. Тэр амьсгалж байв. Гэвч Эймс чийдэн асаах бүртээ Оллигийн цээж өргөгдөхөө больсныг харахыг хүлээнэ. Эймсийн биеийн аль нэг хэсэг нь гарцаагүйтэй эвлэрчээ. Олли амьд гарахыг хичнээн хичээгээд ч, амьдралынхаа төлөө хичнээн баатарлаг тэмцээд ч түүнд ирээдүй алга. Гэхдээ энэ тэмцлийг ажиглах нь маш хэцүү. Удалгүй шөнө дундаас хойш байлдагч Эймс түүний суларсан хуруунаас мултрах шахсан дэнлүүгээ бариад суусан чигээр унтав.

"Чи унтаж байна уу? Чи ганц цаг сэрүүн байж чадах уу?" гэж Есүс Петраас асуудаг.

Үүн дээр Шеф Буши "Матфей, Сандерсын ном" гэж нэмж мэднэ.

...Нэг цаг дөнгөж өнгөрч байхад Роуз Барбигийн мөрнөөс сэгсрэв.

-Маршалл үхсэн. Расти дүү хоёр түүний цогцосыг түргэний тэрэг рүү аваачиж байгаа. Бяцхан охин сэрээд хэт их хямрахаас сэргийлж байна. Гэхдээ хэрэв сэрвэл. Элис бас өвчтэй гэж хэллээ.

-Бид бүгд өвчтэй. Тэр хар тамхичны хүү ба Сэмээс бусад нь гэж Жулия хариулав.

Расти Дуги хоёр Бүрхүүл рүү яаран ирээд нэг сэнсний өмнө унаж агаарыг уушиг руугаа дуутай соров. Дуги ханиаж эхэлсэн тул Расти түүнийг Бүрхүүлд ойртуулж чирлээ. Дуги Бүрхүүлийг толгойгоор мөргөв. Энэ дууг бүгд сонслоо.

Роуз ярьж дуусаагүй байжээ.

-Бенни бас маш муу байна. Тэр өглөө болтол тэсэхгүй гэж Жинни бодож байна. Хэрэв бид ядаж ямар нэг юм хийхгүй бол хэмээн шивнэн хэлэв.

Барби хариу хэлсэнгүй. Жулия ч бас. Гэхдээ тэр байрнаас нь хөдөлгөх аргагүй тавин квадрат дюйм талбайтай ганц дюйм зузаантай хайрцагны зүт харсаар байлаа. Жулиягийн харц бодлогоширсон, манантсан харагдана.

Улаавтар сар арай гэж Бүрхүүлийн зүүн хэсгийн бохирдлыг нэвтрэн бүх юмыг цусан өнгөөр будав. Аравдугаар сар дуусч байна. Харин аравдугаар сар Честерс-Миллд хамгийн хайр найргүй сар боллоо. Энэ үхмэл газарт цэцэг алга. Цэцэг мод өвс алга. Сар бүрэн сүйрсэн газрыг ширтэнэ. Учир нь өөр харах юм юу ч алга.

15

Том Жим зүрхээ базан харанхуйд сэрэв. Зүрх нь дахиад л жигд бус цохилно. Тэр цээжээ дэлслээ. Дараа нь ээлжит савны хий ёроолдоо хүрснийг сануулан цахилгаан үүсгүүрийн дохио залгагдав. А-а-а-а-а... Намайг тэжээ. Намайг тэжээ.

Том Жим давхийн цочоод муухай хашгирлаа. Түүний хөөрхий зовсон зүрх давхийж цохилтонд өртөөд нэг үсэрсэнээ өөрийгөө гүйцэхээр хурдлав. Тэр өөрийгөө доголдсон карбюратортай хуучин машинтай адилтгав. Сарампай машин. Шинэ машины төлбөрт багтааж авсан хуучин машин. Дараа нь хэзээ ч зарж чадахгүй. Яагаад гэвэл хог дээр л очиход таарна. Том Жим амаараа агаар залгилж цээжээ нүднэ. Түрүүнд эмнэлэгт очсон шиг давчидлаа. Магадгүй бүр хүчтэй.

А-а-а-а-а гэх дуу царцаа шиг, аварга том шавьж шиг жингэнэнэ. Магадгүй харанхуйд түүний хөрш болсон мэт. Тэгээд юу гэж? Түүнийг унтаж байхад ийшээ хэн ч нэвтэрсэн юм билээ.

Том Жим дэнлүүгээ хайна. Нөгөө гараар цээжээ илж нүднэ. Зүрхээ тайвшрахыг, үгэнд

ордоггүй жаахан хүүхэд шиг байж болохгүйг шаардана. Тэр харанхуйд үхэхийн тулд ийм урт зам туулаагүй.

Ренни дэнлүү олоод арай гэж хөл дээрээ босч сүүлчийн туслагчийнхаа хүүрэнд тээглэв. Дуу алдаад өвдөг дээрээ уналаа. Чийдэн хагараагүй ч гараас нь мулт үсэрч өнхрөв. Хөдөлгөөнтэй гэрэл улаан лоолийн нухаштай лааз ба гоймонтой хайрцаг эгнүүлж өрсөн зүүн талын хамгийн доод тавиурыг гэрэлтүүлэв.

Том Жим чийдэнгийн араас мөлхлөө. Гэтэл Картерийн нээлттэй нүд хөдлөв.

-Картер?

Том Жимийн нүүрээр хөлс урсана. Хацрыг нь ямар нэг өмхий үнэртэй нарийн хальс хучсан мэт санагдана. Цамц нь биед наалдахыг мэдэрлээ. Түүний зүрх дахиад хэд хэдэн удаа эвгүй хөдөлсөнөө дараа нь гайхамшиг юм болж хэвийн хэмнэлээр цохилон. Гэхдээ үгүй. Бүр ч тийм биш. Гэвч ядахдаа хэвийнд ойрхон. -Картер чи амьд уу?

Мэдээж тэнэг. Том Жим барьж эрэг дээр гаргасан загас шиг гэдсийг нь хүүлсэн. Дараа нь дагз руу нь буудсан. Тэр яг Гитлер шиг үхдэл. Тэгсэн мөртлөө Том Жим баталж чадна... Бараг чадна... Хүүгийн нүд...

Картер гараа сунган хоолойг нь базах гэж байна гэсэн санааг хүчээр хөөхөд хүрэв. Бага зэрэг цухалдах нь (айж түгших) хэвийн зүйл гэж өөртөө хэлэхэд хүрлээ. Яагаад гэвэл энэ хүү түүнийг алах шахсан. Гэсэн ч тэр Картер одоо өндийж суухыг хүлээнэ. Түүнийг өөр рүүгээ татаад өлсгөлөн шүдээ хоолойд зооно гэж хүлээнэ.

Том Жим Картерийн эрүүн доор хүзүүг нь дарж үзэв. Ямар ч цохилт алга. Цус зууралдсан хүйтэн арьс. Мэдээж ямар ч цохилт байхгүй. Залуу үхсэн. Үхээд 12 цаг юмуу түүнээс илүү болж байгаа.

-Хүү минь чи аврагчтайгаа хооллож байгаа. Жигнэсэн мах ба төмсний нухаш. Амттан нь алимны бялуу гэж Том Жим шивнэв.

Энэ үгсийн дараа тэр тайвпгирлаа. Тэгээд дэнлүүний араас мөлхөв. Харин ардаа ямар нэг дуу гарахад, магадгүй бетон шалаар гулсах дуу гарахад тэр эргэж харсангүй. Цахилгаан үүсгүүрийг тэжээх хэрэгтэй. Энэ а-а-а-а-а дууг зогсоох хэрэгтэй.

Том Жим зоориноос үлдсэн таван савны нэгийг гаргаж ирэх үед түүний зүрх дахиад хэмнэл алдлаа. Тэр онгорхой нээлхийний хажууд суугаад амаараа агаар залгилж зүрхээ ханиалгангаа жигд цохилуулах гэж оролдоно. Бас залбирна. Гэхдээ түүний залбирал нь өөрийгөө зөвтгөсөн ба шаардсан үтсийн цуврал болохыг өөрөө ч мэдсэнгүй. Түүнийг тайвшруулаад өг, энэ миний буруу биш, намайг эндээс гарга, би чадах бүхнээ хийсэн, бүхнийг хэвэнд нь оруулахыг хичээсэн, чадваргүй юмнууд намайг балласан, миний зүрхийг эдгээ.

-Есүсийн аврал аминь гэж дуусгав. Гэвч эдгээр үгс тайвшруулахын оронд зөвхөн айдас нэмэв. Үгс булшинд байгаа араг яс шиг доргив.

Түүний зүрх бага зэрэг тайвшрах тэр үед царцаа цар цар хийх мэт түтшүүрийн дохио ч чимээгүй боллоо. Цахилгаан үүсгүүрт холбосон саван дахь хий дуусчээ. Хэрэв дэнлүүний гэрэл байгаагүй бол атомын хорогдох байрны унтлагын өрөөнд том өрөөнийх шиг харанхуй ноёлох байв. Ослын гэрэлтүүлгийн сүүлчийн чийдэн аль хэдийн унтарчээ. Хоосон савыг авч төмөр тавцан дээр дүүрэн хийтэй сав тавьж байхдаа Том Жим жил билүү эсвэл хоёр жилийн өмнө атомын хоргодох байрны үйл ажиллагааны чадамжийг дээшлүүлэх талаарх хүсэлт дээр "Мөнгө олгохгүй" гэсэн цохолт хийж байснаа бүүр түүр санав. Магадгүй тэр хүсэлтэд ослын гэрэлтүүлгийн чийдэнд зориулсан цэнэг хураагуурын зайг солих тухай дурьдсан л байх. Гэвч тэр одоо өөрийгөө үүнд буруутгаж чадахгүй. Хотын төсөв хязгаарлагдмал бөгөөд хүмүүс үргэлж алга тосон намайг тэжээ, намайг тэжээ гэдэг байсан.

Эл Тиммонс үүнийг өөрийн санаачлагаар хийх ёстой байсан. Санаачлага гаргах гэдэг тийм том ажил гэж үү бурхан минь? Тэр ажиллаж байгаа байшингийнхаа техникийн бэлэн байдлыг хариуцсан хүмүүс үүнийхээ төлөө мөнгө авдаггүй гэж үү? Эл тэр мэлхий тэжээлтэн Берпи дээр очоод хотод зориулан цэнэг хураагуурын зай хандивлахыг ариун бүхний нэрээр гуйж болох л байсан. Би байсан бол тэгэх байсан гэж Том Жим өөртөө хэлэв.

Тэр дүүрэн хийтэй савыг цахилгаан үүсгүүрт холбох үед зүрх нь дахиад доголддоо. Гар нь чичрээд дэнлүү доошоо зоорь руу нисч, үлдсэн савнуудын нэгийг цохилоо. Шил нь хагарч Том Жим дахиад тас харанхуйд хонров.

-Үгүй. Үгүй чөтгөр ав. Үгүй гэж тэр үглэнэ. Харанхуй болоод нам гүм Том Жимийг дарамталж, зүрх нь агшиж салгална. Зүрх нь түүнээс урвана. -Айх зүйлгүй. Өөр өрөөнд дэнлүү байгаа. Шүдэнз ч бий. Олох л хэрэгтэй. Хэрэв Картер бүгдийг нэг дор өрсөн бол би шууд л олно.

Харин тэр, Том Жим, жаалхүүг хэт үнэлжээ. Картер найдвар төрүүлж байна гэж бодсон ч эцэстээ үзэж өнгөрсөн материал болох нь тодорсон. Ренни инээснээ тэр дороо хүчээр болив. Харанхуйд инээд айлгахаас цаашгүй.

За яахав одоо цахилгаан үүсгүүрээ ажиллуул.

Тийм. Зөв. Цахилгаан үүсгүүр санаа тавих ёстой нэг дугаарын зүйл. Цахилгаан үүсгүүр ажиллаж эхлээд агаар цэвэрлэж гармагц тэр хийтэй савны холбоосны найдвартай эсэхийг шалгана. Дараа нь дахиад нэг гар чийдэн олно. Магадгүй коулманы чийдэн ч олж мэднэ. Тэгвэл хийтэй савыг солих ээлжит хугацаа хүртэл гэрэл хангалттай.

-Энэ чухал. Энэ ертөнцөд ямар нэг юмыг зөв хийхийг хүсвэл өөрөө хийх хэрэгтэй. Лестер ламаас асуу. Үймээн дэгдээгч Брендагаас асуу. Тэд мэднэ гэснээ Ренни инээлээ. Яаж ч чадсангүй. Эдгээр дурсамж түүний сэтгэлийг ихэд халаах ажээ.

-Тэд ойлгосон. Хэрэв чи жижигхэн саваатай бол том нохойг ярдаглуулах хэрэггүй гэдгийг. Үгүй шүү ноёнтон. Хэзээ ч болохгүй.

Тэр өдөөгчийн товчийг хайн цахилгаан үүсгүүрийг тэмтэрч тэмтэрч арай гэж олоод дарлаа. Юу ч өөрчлөгдсөнгүй. Гэнэт өрөөний агаар өтгөрч эхлэв.

Би буруу товч дарчихжээ. Өөр юу ч биш.

Тийм биш гэдгийг тэр мэдэж байлаа. Гэвч эсрэг санаанд итгэнэ. Яагаад гэвэл итгэхийг маш их хүснэ. Зарим нэг тоглогчид хүйтэн даалууг халаах гэж оролддог шиг хуруу руугаа үлээнэ. Дараа нь дахин үүсгүүрийг тэмтэрч байгаад өдөөгчийн товчийг оллоо.

-Бурхан минь би чиний зарц Жеймс Ренни байна. Энэ ямбий сэгийг асахад туслахыг гуйя. Би чиний хүү Есүс Христийн нэрээр гуйж байна.

Тэр товчийг дарав.

Юу ч болсонгүй.

Одоо түүн рүү дайраад амьдаар залгихад бэлэн болсон айдас сандралыг дарахыг хичээн хийтэй сав хадгалах нүх рүү хөлөө унжуулаад Ренни харанхуйд сууна. Сайн бодох хэрэгтэй. Амьд гарах өөр арга алга. Гэвч эргэн тойрон харанхуй бөгөөд зүрх хэзээ ч зогсоход бэлэн байхад боддоо цэгцлэх маш хэцүү.

Хамгийн муу нь юу вэ? Түүний хийсэн бүхэн, 30 жилийн турш зүтгэсэн бүхэн одоо юу ч юм бодит бус болоод хувирчихлаа. Яг л Бүрхүүлийн нөгөө талд байгаа хүмүүс шиг. Тэд явж, ярьж, машинаар давхиж тэр бүү хэл нисдэг тэрэг ба онгоцоор нисч байна. Гэвч энэ бүхэн бодит амьдралд, Бүрхүүл доорх амьдралд ямар ч хамаагүй.

Өөрийгөө гартаа ав. Хэрэв бурхан чамд туслахгүй байгаа бол өөрөө өөртөө тусал.

За яахав. Хамгийн эхний асуудал бол гэрэл. Шүдэнз ч байсан болно. Хажуу өрөөний тавиур дээрээс ямар нэг юм заавал олдоно. Тэр бүгдийг тэмтрэх болно. Олох хүртлээ аажуухан дэс дараатайгаар. Дараа нь тэр цахилгаан үүсгүүрийн цэнэг хураагуурын зайг олно. Зай байгаа гэдэгт тэр итгэлтэй байв. Яагаад гэвэл түүнд цахилгаан үүсгүүр хэрэгтэй. Цахилгаан үүсгүүргүй бол тэр үхнэ.

Чи цахилгаан үүсгүүрийг асаасан гэж бодъё. Тэгээд хий дуусахаар юу болох вэ?

За яахав дээ ямар нэг юм өөрчлөгдөнө. Тэр энд үхэх бодолгүй. Есүстэй хамт жигнэсэн мах идэх гэж үү? Тэр энэ хоолыг идэхгүй ч байж чадна. Хэрэв түүнийг ширээний хойморт суулгадаггүй л юм бол тэнд юугаа ч хийх юм билээ.

Энэ санаа түүнийг инээхэд хүргэлээ. Том өрөө рүү орох хаалга руу аажуухан болгоомжтой хөдлөв. Сохор хүн шиг гараа урдаа сунгажээ. Хэд алхаад хананд хүрэв. Ханыг хурууны өндгөөр тэмтрэн баруун тийш явлаа. Аа хаан. Хоосон байна. Хаалганы нүх, сайн байна.

Тэр харанхуй байсан ч итгэлтэй хөдлөн түүгээр гарав. Энэ өрөөг Ренни сайн санаж байлаа. Урд нь буйдан, хоёр талаар тавиур байгаа...

Тэр өнөөх шалчгар жаалд тээглэн уналаа. Духаараа шал мөргөөд муухай орилов. Өвдсөнөөс биш гайхсан ба уурласандаа. Хивс цохилтыг зөөлрүүлсэн болохоор өвдсөнгүй. Гэвч бурхан минь, хүүрийн гар хоёр хөлний дунд тээглэв. Яг төмсөгнөөс нь аттах мэт.

Том Жим өвдөг дээрээ бослоо. Урагшаа мөлхөөд дахиад толгойгоор юм мөргөв. Энэ удаад буйданг. Дахин муухай орилоод буйдан дээр гарч хөлөө суга татлаа. Яг л эргэн тойрон аварга махчин загастай усан дотор сал хөлөглөн хөвж яваа хүн шиг.

Тайвшрах хэрэгтэй гэж өөртөө хэлэнгээ бүх биеэрээ салгалан хэвтэв. Тайвшрах хэрэгтэй. Тэгэхгүй бол харвалт өгнө.

"Хэрэв та зүрхний хэмнэл алдагдаж байгааг мэдрэх юм бол бүх анхаарлаа өөртөө төвлөрүүлээд урт гүнзгий амьсгал" гэж түүнд хиппи эмч хэлсэн. Тэр үед Том Жим үүнийг булингар гэж бодож байв. Харин одоо оролдоод үзэхээс өөр юу ч үлдсэнгүй.

Болчих шиг боллоо. Хорин удаа гүнзгий амьсгаа авч аажуухан удаан гаргасны дараа зүрх нь тайвшрахыг мэдэрлээ. Амнаас нь зэсийн амт ариллаа. Гэвч харамсалтай нь цээжин дээр нь ямар нэг хүнд юм дарж эхэллээ. Өвчин зүүн гар руу нь мөлхөв. Энэ харвалтын шинж тэмдэг гэдгийг Ренни мэднэ. Гэхдээ үүний шалтгаан нь сардин загас хэт их идсэний дараа үүссэн цээж хорсолт байж мэднэ гэж бодов. Бараг л тийм байх. Яагаад гэвэл аажуухан удаан амьсгаа авч гаргасны дараа зүрх нь хэвийн болсон. (гэвч тэр энэ яршигтай байдал дууссаны дараа мэргэжилтэнд хандах хэрэгтэй. Магадгүй тэдний үтэнд орж зүрхэндээ юм тавиулах болно) Халуун болсон тул нэмэлт асуудал үүсэв. Халуун ба өтгөрсөн агаар. Чийдэн олж цахилгаан үүсгүүрийг ажиллуулах хэрэгтэй. Ганц минут хэвтээд, магадгүй хоёр...

Энд хэн нэгэн амьсгалав.

Мэдээж шүү дээ би амьсгалж байна.

Гэвч өөр хэн нэгний амьсгалахыг сонсох мэт мэдрэгдэв. Гэхдээ ганц хүн биш. Хэд хэдэн хүн. Тэд хэн болохыг Ренни мэдэх мэт.

Энэ шал тэнэг.

Тийм. Амьсгалж байгаа хүмүүсийн нэг нь буйдангийн ард зогсоно. Хоёр дахь нь буланд. Гурав дахь нь буйдангийн өмнө гурван фут зайнд.

Үгүй. Боль. Одоохон зогс.

Бренда буйдангийн ард зогсч байна. Хугарч унжсан эрүүтэй Лестер лам буланд байна. Харин буйдангийн урд...

-Үгүй. Энэ шал дэмий юм. Энэ солиорол гэж Том Жим өөрийн эрхгүй хашгирав.

Тэр нүдээ аниад удаан амьсгалж гаргах тал дээр анхаарахыг оролддоо.

"Аав аа, танай энд сайхан үнэртэй байна. Яг зооринд байгаа юм шиг. Миний найз хүүхнүүд үнэртээд байна" гэж буйдангийн урд зогсох Жижгээ хэллээ.

Том Жим орилов.

"Дүү минь надад тусал. Тэр намайг хүчтэй хэрчлээ. Бас буудсан" гэж шалан дээр хэвтэх Картер ярив.

-Боллоо. Би юу ч сонсохгүй байна. Тиймээс болсон. Би амьсгалаа тоолж байна. Би зүрхээ тайвшруулж байна гэж Том Жим шивнэв.

"Цааснууд надад байж л байгаа. Маш олон хуулбар. Удахгүй Жулия сонины сүүлчийн дугаараа өлгөсөн шиг энэ цааснууд бүгд хотын холбооны шонгууд дээр өлгөгдөнө. Чи нуглийнхээ төлөө шийтгэл хүлээнэ. Шийтгэл чамайг дайрна. Итгэлтэй байгаарай. "Тоонууд" ном 32-р бүлэг гэж Бренда ярив.

-Чи энд байхгүй.

Гэвч ямар нэг юм, мэдрэгдэж байгаагаар бол хуруу түүний хацрыг иллээ.

Том Жим дахиад муухай орилов. Атомын хоргодох байрыг үхдэлүүд дүүрч, өмхий агаараар ядах юмгүй амьсгалах бөгөөд хөнгөн шаламгай хөдөлнө. Тас харанхуйд ч тэр тэдний цонхийсон царайг харж чадаж байв. Үхсэн дүүгийнхээ нүдийг харав.

Том Жим буйдангаас үсрэн босоод хар агаарыг нударгалж гарав.

-Тонил цаашаа. Бүгд надаас зайлцгаа.

Тэр шат руу гүйгээд хамгийн доод гишгүүрт бүдэрлээ. Энэ удаад хивс цохилтыг зөөлрүүлсэнгүй. Нүд рүү нь цус орж ирэв. Үхдэлийн гар түүний дагзыг илнэ.

-"Чи намайг алсан" гэж Лестер лам хэлнэ. Гэвч эрүү нь хугархай тул И-и-аг-аг-сан-сан" гэж дуулдах ажээ.

Том Жим шатаар гүйж хаалгыг хүнд жингээрээ түрэв. Шатсан самбар нурсан тоосгуудыг түлхэн хаалга нээгдлээ. Том Жим багтахуйц хангалттай өргөн онгойв.

-Үгүй. Намайг бүү оролд. Үгүй. Надад битгий гар хүр гэж Том Жим хашгирна.

Захиргааны байшингийн балгас доторх харанхуй нь атомын хоргодох байрныхаас нэг их ялгарсангүй. Гэвч нэг ноцтой ялгаа байсан нь эндхийн агаар амьсгалахад тохирохгүй.

Том Жим гуравхан удаа сороод л үүнийг ухаарав. Биеийн сүүлийн огцом хөдөлгөөнүүдээс ачаалал авсан зүрх нь хоолой руу нь үсэрлээ. Энэ удаад бууж ирэлгүй тэндээ үлдэв.

Том Жим түүний цээж рүү чулуу дүүргэсэн шуудайтай төстэй ямар нэг хүнд юмаар цохихыг гэнэт мэдрэв. Тэр гүнзгий нялцгай шавар дундуур явж байгаа хүн шиг хоёр тийш ганхан хаалга руу буцах гэж оролдлоо. Тэр завсраар нь чихэн орох гэж оролдсон ч энэ удаад гацав. Түүний ангайсан амнаас аймаар дуу хадлаа.

-А-а-а, намайг тэжээ. Намайг тэжээ.

Тэр найгав. Хоёр дахь удаа, гурав дахь удаагаа найгав. Амь орох сүүлчийн боломж руу гараа сунгалаа. Харанхуйд хэн нэгний гар гарыг нь илэв. -Аав аа гэх дуу сонсдов.

16

Ням гаригийн өглөөний туяа татахаас өмнө Барбигийн мөрнөөс хэн нэг нь сэгсрэв. Тэр дурамжхан сэрлээ. Ханиангаа зөн совингоороо Бүрхүүл рүү түүний цаана байгаа сэнс рүү эргэв. Ханиах нь намдсаны дараа хэн сэрээснийг харлаа. Жулия. Түүний үс сэгсийж хацар нь халуу шатаж байвч нүд нь ухаалаг хурц байх ажээ.

-Цагийн өмнө Бенни үхсэн.

-Өө Жулия, бурхан минь, маш харамсалтай байна гэж тэр ярих биш хэржигнэх бөгөөд өөрийнхөө дууг арай ядан танина.

-Би Бүрхүүл үүсгэж байгаа хайрцаг дээр очих хэрэгтэй. Би яаж очих вэ?

Барби толгой сэгсрэв.

-Чи ямар нэг юм хийж чадах байлаа ч гэсэн хайрцаг эндээс бараг хагас миль зайд хяр дээр байгаа. Бид фургон юмуу микроавтобуст хүрэх ч агаар үгүй байна. Гэтэл тэд ердөө тавин фут зайтай.

-Нэг арга байна гэх хэн нэгний дуу гарав. Тэд эргэж харвал Сэм Вердо зогсож байлаа. Тэр сүүлчийн тамхиа татаад тэднийг эрүүл нүдээр харна. Тэр эрүүл, цоо эрүүл, найман жилийн хугацаанд анх удаа эрүүл байлаа.

-Нэг арга бий. Би та нарт үзүүлье гэж тэр давтав.

Гэртээ өмсөөрэй. Яг даашинз шиг харагдах болно

1

Өглөөний 7 цаг 30 минут гэхэд тэд нэг дор бөөгнөрөв. Тэр бүү хэл гашуудан үхэх гэж байгаа, уйлснаас болж улаан нүдэлсэн Беннигийн ээж хүртэл. Элва Элисийн мөрөөр тэвэрчээ. Охины хөгжилтэй амьд зан авираас ул мөр ч үлдсэнгүй. Харин амьсгалах үед хавчиг цээж нь хэржигнэнэ.

Сэмийг дуугүй болмогц чив чимээгүй болов... Гэхдээ мэдээж сэнсний хүнгэнэхийг эс тооцвол.

-Энэ солирол, та нар үхнэ гэж Расти эхлээд хэллээ.

-Тэгээд энд үлдвэл амьд гарах юмуу? гэж Барби асуув.

-Ер нь тэгж оролдох ямар хэрэг байна вэ? Сэмийн санаа бүтлээ ч гэсэн та нар амжихгүй... гээд Линда мөрөө хавчив.

-Би бол амжина гэж бодож байна гэж Ромми хэллээ.

-Мэдээж бүтнэ гээд Сэм толгой дохив.

-Питер Бергерон гэдэг тэр залуу 47 онд Бар-Харборт болсон их түймрийн дараа надад ярьсан юм. Онцлог нь Пит худалч хүн байгаагүй.

-Бүтлээ ч гэсэн ямар хэрэгтэй юм бэ? гэж Линда зүтгэлээ.

-Яагаад гэвэл энэ нь бидний оролдож хийж үзээгүй ганцхан зүйл гэж Жулия хариулав. Тэр нэгэнт шийд гаргаж Барби хамт явахаа хэлснээс хойш бүрэн тайвширчээ.

-Бид гуйх гэж л оролдоогүй.

-Жулия чи солирсон байх. Тэд сонсоно гэж бодно уу? Сонслоо ч гэсэн үгэнд орох уу? гэж Тони Гуэй хэлээд толгой сэгсрэв.

Жулия Расти руу хандлаа.

-Чиний найз Жорж Лэтроп томруулдаг шилээр шоргоолжийг шатааж байх үед шоргоолжнууд ийм юм хийхгүй байхыг хэрхэн гуйхыг чи сонссон уу?

-Шоргоолж гуйж чадахгүй шүү дээ Жулия.

-Чи өөрөө хэлсэн. "Шоргоолжинд ч бас өөрийн амьдрал бий гэсэн санаа толгойд төрсөн" гэж. Энэ санаа яагаад чиний толгойд төрсөн юм бэ?

-Яагаад гэвэл... Тэр үгээ гүйцээлгүй мөрөө хавчив.

-Чи тэднийг сонссон юм биш үү? гэж Лисса асуув.

-Би хэдийгээр та бүхнийг хүндэлж байгаа ч энэ бол бүрэн дэмийрэл. Шоргоолж бол шоргоолж. Тэд гуйж чадахгүй гэж

Стивен Кинг Пит дэмжив.

-Тэгвэл хүмүүс чадна. Бидэнд өөрийн амьдрал байхгүй гэж үү? хэмээн Жулия хэллээ.

Энэ удаад хэн ч хариулсангүй.

-Тэгээд бид ер нь өөр юу хийж чадах юм бэ?

Тэдний ард хурандаа Коксын дуу гарлаа. Тэд түүнийг мартжээ. Одоо гадаад ертөнц ба тэндхийн оршин суугчид ямар ч хамаагүй болжээ.

-Би та нарын байранд байсан бол оролдоод үзэх байсан. Намайг зэмлэх хэрэггүй. Гэвч... Тийм ээ, би бол оролдох байсан. Барби чи?

-Би аль хэдийн зөвшөөрсөн. Түүний зөв. Өөр ямар ч арга зам үлдсэнгүй.

2

-Алив тэр хүүдийнүүдийг үзье гэж Сэм хэллээ.

Линда түүнд гурван ширхэг том ногоон "Хефти" хүүдийг сунгав. Хоёрт нь урьд нь түүний болоод Растигийн хувцас, бас охидын хэдэн ном байжээ. (үлдэгсэдийн жижигхэн багийн ард газарт цамц, өмд, оймс ба дотуур хувцас хөглөрнө). Ромми бугын анд зориулсан хоёр буу хийж ирсэн гурав дахь хүүдийг өгчээ. Сэм гурвууланг нь үзээд бууны хүүдийнээс нүх олонгуут хажуу тийш чулуудав. Нөгөө хоёр нь бин битүү байддаа хадгална.

-Сайн байна. Анхааралтай сонс. Хайрцаг хүртэл хатагтай Эвереттийн минивэн машинаар очно. Гэхдээ эхлээд машинаа нааш нь авчрах хэрэгтэй. Та шилээ буулгаагүй гэдэгтээ итгэлтэй байна уу? Үүнээс хүмүүсийн амь нас хамаарах тул итгэлтэй байх хэрэгтэй.

-Буулгалгүй ирсэн. Бид хөргүүрээ ажиллуулсан гэж Линда толгой дохив.

Сэм Расти руу хараад:

-Чи машиныг нааш нь авчрах ёстой эмч ээ. Гэхдээ түүнээс өмнө хөргүүрийг унтраана. Яагаад гэдгийг нь ойлгож байгаа тийм үү?

-Машинд агаар хадгалахын тулд.

-Мэдээж хаалга нээхэд муу агаар дотогш нэвгэрнэ. Гэвч чи хурдлах юм бол бага зэрэг л орно.

Дотор нь сайн агаар үлдэнэ. Хотын агаар. Тэгэхээр машинд суух хүмүүс хайрцаг хүртэл тэр агаараар амьсгалж чадна. Хуучин микроавтобуснаас ямар

ч ашиг гарахгүй. Зөвхөн цонхыг нь буулгасан болоод тэр биш.. гэх үед Норри харилцааны компанийн хулгайлагдсан микроавтобус руу харж:

-Бид тэгэхээс аргагүй байсан. Хөргүүр эвдэрчихсэн. Өвөө тэгж хэлсэн гэх үед зүүн нүднээс нь нулимс гарч бохир хацрыг даган бөмбөрөв. Эргэн тойрон бохир бөгөөд бүрсгэр тэнгэрээс нүдэнд бараг үл үзэгдэх жижиг ширхэгтэй хар хөө унаж ирнэ.

-Бүх юм зүтээр хонгор минь. Энэ дугуй сохор зоосны ч үнэгүй. Энэ ямбийг хэний хуучин машины зогсоолоос авсан нь нэг харахад л ойлгогдоно гэж Сэм түүнийг тайвшруулав.

-Хэрэв бидэнд хоёр дахь машин хэрэгтэй бол миний машин тохирох юм байна. Би аваад ирье гэж Ромми хэллээ.

Сэм толгой сэгсрэв.

-Хатагтай Шамуэйн машиныг авсан нь дээр. Дугуй нь жижиг болохоор жолоодоход амар. Тэгээд ч шинэ. Агаар нь бас цэнгэг.

Жо гэнэт инээлээ.

-Дугуйнаас агаар авах гэж үү? Дугуйнаас агаар авч хогийн уут руу шахах юмуу? Гар хийцийн агаарын хүүдий. Ноён Вердро энэ суут санаа.

Архичин Сэм мөн л инээж үлдсэн зургаан шүдээ ил гаргав.

-Хүү минь, үүнийг би өөртөө наалдуулж чадахгүй. Пит Бергероны санаа. Бар-Харборт түймэр гарч хоёр хүн орчноос таслагдсан тухай тэр ярьсан юм. Түймэр модны оройгоор дамжиж байсан гэдэг. Тэд шатах аюулгүй байсан ч амьсгалах боломжгүй болсон. Тэгэхээр нь тэр хоёр мод тээвэрлэх машины дугуйн бөглөөсийг сугалаад салхи агаарыг цэвэрлэх хүртэл нүхэнд нь ээлжлэн наалдаж амьсгалж байжээ. Пит хэлэхдээ дугуйн агаар аль хэдийн үхсэн загасны үнэртэй адил байсан ч түүний ачаар амьд үлдсэн гэсэн.

-Нэг дугуй болох уу? гэж Жулия асуув.

-Магадгүй. Гэхдээ бид ердийн дугуй биш нөөц дугуйнд итгэж болохгүй. Тэр чинь цардмал замаар хорин миль явахад л зориулагдсан байдаг.

-Үгүй. Ердийн дугуй. Би хуурамч юмыг тэвчиж чаддаггүй. Би Жоннигоос шинэ дугуй тавихыг хүсэхэд тэр тавьж өгсөн. Жонни ба Кэрри нар үхсэн байх даа? гээд хот руу харав.

-Бид машинаас дахиад нэг дугуй салгах хэрэгтэй. Юмыг яаж мэдэх билээ. Чамд өргүүр байгаа юу гээд Жулия руу харав.

Тэр толгой дохилоо.

Ромми Расти руу ямар ч хөгжил баясалгүй инээмсэглээд:

-Эмч ээ, чамайг ирүүл тулаанд дуудаж байна. Чиний машин уу? Эсвэл Жулиягийн машин уу? Аль нь хурдан бэ?

-"Приус"-ийг би аваад ирье. Чи эндээ байж бай Ромми. Их муу харагдаж байна гэж Пайпер дургүйцэв.

-Гэлэнмаагаас ийм юм сонсоход таатай байна гэж Ромми бувтналаа.

-Чи намайг юм ярихаар цовоо сэргэлэн байгаад бурханд талархах ёстой.

Үнэнийг хэлэхэд гэлэнмаа тийм ч цовоо сэргэлэн харагдсангүй. Гэсэн ч Жулия түлхүүрээ түүнд өгөв. Одоо тэднээс хэн нь ч дуулж бүжиглэж чадахгүй нь ойлгомжтой ч Пайпер хавьгүй дээр байв. Бусдаас, түүний дотор цаас шиг цагаан цонхийсон Клерээс.

-За яахав. Гэхдээ бидэнд нэг жижиг асуудал байна. Гэвч эхлээд... Сэм ярьж эхлэхэд Линда таслан -Юу вэ? ямар асуудал?

-Одоохондоо үүнд санаа зовохоо больё. Эхлээд тээврийн хэрэгслээ авчрах хэрэгтэй. Хэзээ оролдох вэ?

Расти Ариун Гэм цайруулагч сүмийн лам руу харлаа. Пайпер толгой дохив.

-Яг одоо шууд гэж тэр Сэмд хариулав.

3

Хотын үлдсэн хүмүүс харан зогсоно. Ганцхан тэд ч бишээ. Кокс болоод бараг зуу гаруй цэргүүд Бүрхүүлийн хажууд цуглаж яг теннисний тэмцээн үзэж байгаа юм шиг болж байгаа бүхнийг анхааралтай ширтэнэ.

Расти Пайпер хоёр уушигандаа аль болох их хүчилтөрөгч авахын тулд Бүрхүүлд наалдан зогсоод хэдэн удаа гүнзгий амьсгаа авлаа. Дараа нь гараасаа хөтлөлцөөд машин руу гүйцгээв. Тэд гараа тавихад Пайпер нэг хөл дээрээ сөхөрч унаад "прус"-ын түлхүүрийг алдахад үзэгчид дуу алдав.

Гэвч тэр тэр дороо өвснөөс түлхүүрийг шүүрээд бослоо. Гэлэнмаа "прус"-ын хаалгыг нээж дотогш орох үед Расти аль хэдийн хөдөлгүүр нь ассан машиндаа сууж байв.

-Тэд хөргүүрээ унтраахыг мартахгүй гэж найдья хэмээн Сэм бувтнав.

Машиныуд байрнаасаа гулсан хөдлөхөд "прус" илүү том "Одиссей"-н араас яг хонь хариулж байгаа нохой шиг дагав.

Овон товон газар дээгүүр ганхан хурдан давхисаар Бүрхүүл дээр ирлээ. Дүрвэгсэд хоёр тийш хагарав. Элва Элисийг, харин Линда ханиах охидоо сугандаа тэвэрчээ.

"Прус" бохир Бүрхүүлээс фут хүрэхгүй зайд зогсов. Расти машинаа эргүүлээд ухарч зогслоо.

-Танай нөхөр сэтгэлийн тэнхээтэй, бас уушиг нь чулуу юм гэж Сэм Линда руу харан тайлбар хийв.

-Яагаад гэвэл тэр тамхиа хаясан гэж Линда хариуллаа. Тэр Твитчийн арай ядан инээхийг сонсоогүй юмуу сонссон ч тоосонгүй.

Растигийн уушиг ямар байлаа ч тэр цаг алдсангүй. Машинаас шууд үсрэн гараад Бүрхүүл рүү хурдлав.

-Гар хурууны үзүүрийн ажил... гэснээ ханиалаа.

-Сэм зөв бодсон уу? Машин дотор амьсгалж болох нь уу? гэж Линда асуув.

-Ямар ч гэсэн эндхийн агаараас дээр. Гэвч Сэм нөгөө талаар ч бас зөв байж. Хаалгыг нээх тоолонгоор сайн агаар гадагшилж муу агаар орж байна. Та бүхэн дугуйны агааргүйгээр хайрцагт хүрч болох юм. Гэвч тийм агааргүй буцаж ирнэ гэдэгт би эргэлзэж байна.

-Тэдний хэн ч жолоон дээр суухгүй. Машиныг би барих болно гэж Сэм хэллээ.

Сүүлийн хэдэн өдрийн дотор уруул нь жинхэнээр инээмсэглэхийг Барби мэдрэв.

-Чиний жолооны үнэмлэхийг хураачихсан шиг санагдах юм?

-Энд цагдаа харагдахгүй л байна даа. Хурандаа та юу хэлэх вэ? Танай тэнд нутгийн тэнэгүүд юмуу замын цагдаа таарав уу? гэж тэр Кокс руу хандав.

-Нэг ч алга гэж Кокс баталлаа.

Жулия Барбиг хажуу тийш дуудаад:

-Чи үнэхээр явах юмуу?

-Тийм.

-Бидний боломж хамгийн бага юмуу эсвэл байхгүйтэй адил гэдгийг мэдэх үү? -Тэгэлгүй дээ.

-Хурандаа Барбара та гуйж чаддаг уу?

Тэр Фаллуж дахь спорт танхимыг саналаа. Эмерсон нэг олзлогдсон хүнийг дээшээ үсэртэл нь төмсөг рүү өшиглөнө. Хэкермейер хоёр дахь хүнийг толгойн ороолтоос нь татаж хананд аваачаад духанд нь буу тулгав. Хүмүүс бороохой барин тулалдаж эхэлсэн тэр цагаас хойш дандаа тэгдэг болсон шигээр цус хана руу үсэрлээ.

-Мэдэхгүй. Гэвч би ганц зүйлийг мэдэж байна. Одоо миний гуйх ээлж иржээ.

Ромми Пит ба Тони нар "прус"-ыг өргөөд нэг дугуйг нь салгав. Машин том овортой биш болохоор жирийн цагт байсан бол тэд арын хэсгийг гар дээрээ өргөж дийлэхээр байлаа. Гэвч одоо биш. Хэдийгээр машиныг сэнсний хажууд тавьсан ч эрчүүд үе үе агаар залгихын тулд Бүрхүүлд наалдана. Эцэст нь ханиаж бүтэж эхэлсэн Тониг Роуз орлов.

Ингээд Бүрхүүлийн дэргэд хоёр салсан дугуй бий боллоо.

-Одоохондоо бүх юм сайн байна. Харин өнөөх жижиг асуудлыг ярих хэрэгтэй. Би яахаа мэдэхгүй байгаа болохоор хэн нэг нь санаа төрүүлнэ гэж би найдаж байна хэмээн Сэм хэлэв.

Бүгд түүн рүү харлаа.

-Манай найз Пит ярихдаа өнөөх хоёр дугуйны бөглөөг сугалаад шууд дугуйнаас амьсгалж байсан гэсэн. Бид тэгж чадахгүй. Бид энэ хүүдийг дүүргэх ёстой. Өөрөөр хэлбэл нүх нь том байх ёстой. Бид дугуйг цоолж болно. Гэтэл нүх рүү гуурс юмуу ямар нэг юм зоохгүй бол бид агаарыг авахаасаа илүү алдах болно. Юу байвал дээр вэ? Хэн нэгэн майхан авчраагүй биз? Хөнгөн цагаан баганатай гээд тэр бүтдийг тойруулан харлаа.

-Манай охидод тоглоомын майхан байгаа. Гэвч гэрт гараашт байгаа гэж Линда хэлснээ одоо гарааш ба гэрийн аль нь ч байхгүйг санаад зэрлэгээр инээв.

-Үзэгний их бие ямар вэ? Надад "Бик" үзэг байгаа гэж Жо хэлэв.

-Дэндүү нарийхан. Түргэн тусламжийн тэргэнд ямар нэг юм байхгүй юу Расти? гэж Барби асуув.

-Трахеотомигийн хоолой гэж Расти хэлэх үед эргэлзээтэй дуу гарсан ба дараа нь өөрөө өөртөө хариулах мэт.

-Үгүй. Бас хэт нарийн гэв.

Барби Бүрхүүл рүү хандаж

-Хурандаа Кокс санаа байна уу?

-Бидэнд бол таарах юм зөндөө л байна. Гэвч та нарт ямар тусалж чадах биш дээ гэж Кокс дуртай дургүй хариуллаа.

-Биднийг юу ч зогсоох ёсгүй. Хогийн уутыг чөтгөрт өг. Бид дугуйнуудаа аваад тэндээсээ шууд амьсгалж болно гэж Жулия дуу алдав. Түүний дуу уур цухал ба сандралаар дүүрсэнийг Барби олж сонслоо.

Сэм толгой сэгсэрлээ.

-Бүтэхгүй хатагтай. Харамсалтай байна. Болохгүй.

Линда Бүрхүүлд наалдаж хэд хэдэн удаа амьсгаа аваад сүүлчийн амьсгаагаа түгжив. Дараа нь машин руу очиж арын шилний хөөг арчаад дотогш шагайв.

-Бурхан минь хүүдий байрандаа байна.

-Ямар хүүдий? гэж Расти асуув.

-Төрсөн өдрөөр "Шилдэг худалдан авалт"-аас чамд зориулж авсан бэлэгтэй хүүдий. 11 дүгээр сарын 18-ныг чи мартчихсан уу?

-Тийм дээ. Албаар мартсан юм. Тавин нас хүрсэнээ хэн санах дуртай байх вэ? Тэгээд тэнд юу байгаа гэж?

-Хэрэв би гэртээ оруулчихвал чи хүүдийг олно гэдгийг би мэдэж байсан. Чи их сониуч хүн. Тэгээд би машиндаа үлдээсэн юм гээд тэр бүтдийг нь тойруулан харахад тэнүүлчийнх шиг бохир царай нь туйлын буурь суурьтай харагдав.

-Чи түүнд юу авсан юм бэ Линда? гэж Жекки асуулаа. -Бид бүгдэд зориулсан бэлэг.

5

Бэлтгэлээ дуусгаад Барби Жулия архичин Сэм гурав бүгдийг тэвэрч, хүүхдүүдийг ч үлдээлгүй үнсэв. Үлдсэн хүмүүсийн царайд найдвар байхгүй ажээ. Тэд ядарч туйлджээ. Агаар хүрэлцэхгүй болоод ийм байна гэж Барби өөртөө итгүүлэхийг хүсэвч үнэн хэрэгтээ яагаад ингэж байгааг сайн ойлгож байлаа. Энэ бол хагацлын үнсэлт байв.

-Хурандаа Барбара амжилт хүсье гэж Кокс хашгирав.

Барби толгой дохиод Расти руу эргэлээ. Хэрэв хэн нэгэн ямар нэг юм хийж чадна гэвэл тэр нь Расти юм. Яагаад гэвэл Бүрхүүл дор байгаа.

-Бүү цөхөр. Тэдэнд найдвараа гээхийг бүү зөвшөөр. Хэрэв энэ бүтэлгүй болох юм бол чадах хэрээр, чадлынхаа хэрээр тэдэнд санаа тавь.

-Би ойлголоо. Чи ч бас чадах бүхнээ хийхийг хичээгээрэй.

Барби Жулия руу толгой сэжээд:

-Энэ түүний оролдлого гэж бодож байна. Бүх юм бүтэхгүй байсан ч бид эргээд ирэх ч юм билүү хэн мэдэх вэ?

-Мэдээж эргэж ирнэ гэх Растигийн дуу үнэн сонсогдсон ч харин нүд нь итгэхгүй байгааг илтгэнэ.

Барби түүний мөрөөр алгадаад дараа нь Бүрхүүлд наалдан зогсож түүгээр нэвтрэх цэюр агаарыг гүнзгий сорох Жулия Сэм хоёртой нийлэв.

-Чи явна гэдэгтээ игтэлтэй байна уу? хэмээн Сэмээс асуулаа.

-Тийм ээ, би гэмээ цайруулмаар байна.

-Ямар гэм?

-Би энэ талаар яримааргүй байна. Тэгээд ч хотыш сонины эрхлэгч дэргэд байхад гээд тэр инээхчээн аядав.

-Бэлэн үү? гэж Барби Жулиягаас асуулаа.

-Тийм. Чадах чинээгээрээ бэлдсэн гээд тэр түүний гараас чанга атгав.

6

Ромми Жекки хоёр "Одиссей" машины гүйдэг хаалганы хажууд зогсоно. Барбиг "Явцгаая" гэж хашгирангуут Жекки хаалгыг нээж Ромми дотогш нь "прус"-ын хоёр дугуй шиддээ. Барби Жулия хоёр араас нь оронгуут хаалга хаагдав. Архинд хордсон хөгшин Сэм урьдын адил цовоо байх бөгөөд аль хэдийн жолооны ард сууж хөдөлгүүрийг асаав.

Машин доторх агаар Бүрхүүлээр хүрээлэгдсэн тэр орчны үнэрээр буюу шатсан давирхайн үнэр ханхлуулна. Хэдэн арван сэнс ажиллах Бүрхүүлийн дор одоо амьсгалж байгаа тэр агаартай харьцуулах юмгүй.

Ийм агаартай удаан байхгүй. Бид гурвуул болохоор хүчилтөрөгэгийг дор нь сорно гэж Барби бодов.

Жулия "Шилдэг худалдан авалт" дэлгүүрийн хар шаргал хүүдийг авч задалж сэгсрэв. Хүүдийнээс дээр нь "Гайхалтай цуурай" гэж бичсэн хуванцар бортого уналаа. Түүний дор Жулия "50 компакт диск" гэж уншив. Хуванцар боодлыг тайлах гэж ороддсон ч нэг л болж өгөхгүй байлаа. Барби цэрпгйн хуггаа гаргах гэж хармаагаа ухаад зүрх нь ёгхийв. Хутга байсангүй. Мэдээж пгүү дээ. Цагдаагийн газарт үлдсэн. Яг хэлэх юм бол түүний нуранги дор байгаа.

-Сэм чамд тонгорог байхгүй биз?

Сэм шууд л хутга шидэв.

-Энэ миний аавынх. Тэр бүх насаараа биедээ авч явсан. Тиймээс буцааж өгөөрэй.

Хутганы хоёр хажуугийн модон бариул цаг хугацааны эрхээр элгэдэж багасчээ. Гэхдээ Барби хутгыг нээхэд хурц ир нь гялсхийв. Энэ хугга хуванцар боолтыг задлах юмуу дугуйг цоолоход хангалттай.

-Түргэлээрэй. Бидэнд хэрэгтэй зүйл байгаа гэж хэлэх хүртэл бид явж болохгүй. Тэгээд ч машины хөдөлгүүр ийм агаарт удаан ажиллана гэдэгт би итгэхгүй байна гэж ханггираад хаазан дээр гишгэв.

Барби боолтыг хэрчихэд Жулия урж тасдана. Бортогыг цагийн зүүний эсрэг эргүүлэхэд тэр сууринаасаа саллаа. Растигийн төрсөн өдөрт зориулж авсан цэвэр компакт дискүүд хар хуванцар гол дээр углагджээ. Жулия дискүүдийг машины шалаар тарааж шидээд голыг нь хуруугаар базав. Маш их хүчлэл гаргаснаас уруул нь нарийн зураас болжээ.

-Алив би... гэж Барби эхэлтэл Жулия голыг суга татсан байлаа.

-Бүсгүйчүүд ч хүчтэй байдаг юм байна. Ялангуяа үхгэлээ айсан үед.

-Тэр хөндий болов уу? Хэрэв үгүй бол бид дууслаа.

Бүсгүй голыг нүүрэндээ аваачихад Барби нөгөө талаас нь харвал цэнхэр нүд харагдав.

-Явцгаая Сэм. Замд гаръя гэж тэр тушаав.

-Бүтнэ гэдэгт чи итгэж байна уу? гээд Сэм араагаа залгалаа.

-Мэдээж гэж Барби хариулав. Яагаад гэвэл "Би яаж мэдэх вэ?" гэсэн хариулт хэнийг ч сэргээхгүй. Түүний дотор өөрийг нь ч сэргээхгүй билээ.

7

Машин хөдөөгийн замаар явж одохыг амьд үлдэгсэд дуугүй харж зогсоно. Норригийн нэрлэснээр "Гялсхийгч хайрцаг" байгаа тэр газар руу хөшсөн утаанд машин уусч хий үзэгдэл болон хувираад удалгүй алга болов.

Расти Линда хоёр хүүхдүүдээ тэврэн зэрэгцэн зогсоно.

-Чи юу бодож байна вэ Расти? гэж бүсгүй асуув.

-Сайнд найдах хэрэгтэй гэж л бодож байна.

-Тэгээд мууд бэлэн байх мөн үү?

-Түүнийг орхигдуулж болохгүй.

8

Тэд фермерийн байшинг өнгөрөхөд Сэм хашгирлаа.

-Одоо алимны цэцэрлэгт орно. Сайн бариарай. Яагаад гэвэл машины ёроол цөмөрсөн ч би зогсохгүй шүү.

-Алив гэж Барби хариулав. Тэр дороо хоёр гараар тэвэрч байсан дугуйтайгаа хамт тааз хүртэл үсэрлээ. Хоёр дахь дугуйг Жулия барьж байсан бөгөөд хөлөг онгоц сүйрэх үед аврах цагирагаас зуурдаг шиг дугуйнаасаа зуурав.

Цонхны цаана үжирч унжсан бохир навчнуудтай алимны мод харагдана. Алимны ихэнхи нь газраар хөглөрнө. Дэлбэрэлтийн дараа үүссэн салхи цэцэрлэгийг дайрахдаа авч чулууджээ.

Дахин нэг донслоход Жулия Барби хоёр хамтдаа дээш шидэгдэв. Бүсгүй дугуйг зуурсан хэвээр түүний өвөр дээр буулаа.

-Хөгшин тэнэг минь, чи жолооны үнэмлэхээ хаана авсан юм бэ? "Сирс ба Роубак"-т уу? гэж Барби хашгирав.

-"Уол-Март"-д тэнд бүх юм хямд байдаг гээд хөгшин инээснээ тэр дороо царай нь төв болж - Би өнөөхийг харж байна. Анивчдаг баасыг. Яг хажууд нь зогсох болно. Намайг зогсонгуут дугуйгаа хэрчээрэй. Тэгэхгүй бол хэт том хагалчихна шүү.

Ганц хормын дараа тэр тоормос гишгэлээ. Машин тун огцом зогссон тул Барби Жулия хоёр арын сандалын ар талд очиж наалдав. Пинболын бөмбөгт ямархуу байдгийг би одоо мэддэг боллоо гэж Барби бодов.

-Чи яг Бостоны таксичин шиг явах юм гэж Жулия дургүйцэн хашгирав.

-Тийм бол цайны мөнгө өгөхөө бүү мартаарай. 20 хувь гэж Сэм ханиангаа ихэд доройтсон дуугаар хэлэв.

-Сэм чи зүтээр үү? гэж Жулия асуулаа.

-Тийм биш ч байж магадгүй. Цус алдаж байна. Хоолойноос юмуу эсвэл бүр гүнд. Уушгаа цоолчих шиг боллоо гэж Сэм хариулаад ханиав.

-Бид яах вэ? гэж Жулия санаа зовлоо.

Сэм ханиадаа дараад:

-Тэднийг энэ чөтгөрийн хаалтаа авахад хүргээрэй. Бид эндээс мултрах хэрэгтэй. Тэгэхгүй бол миний тамхи дуусчихсан.

-Би бүгдийг нь хийнэ. Чи ойлгов уу? гээд Жулия Барби руу харав.

Өнөөх нь толгой дохилоо. -Мэдлээ хатагтай.

-Чи зөвхөн агаарыг хянах болно. Хэрэв минийх болохгүй бол бид байраа сольё.

-Чи яг юу бодож олсоныг мэдмээр байна.

-Тодорхой юм юу ч байхгүй. Надад зөвхөн зөн совин ба өчүүхэн найдвар байна.

-Ийм гутранги байж болохгүй. Чамд хоёр дугуй, хоёр хогны уут ба нэг хөндий гол байгаа.

Тэр инээмсэглэв. Түүний бохирдсон бас түгшсэн царай гэрэлтлээ.

-Яг хэллээ шүү.

Сэм дахин ханиаж жолоо руу тонгойв. Ямар нэг юм нулимаж гаргалаа.

-Хүндэт бурхан ба түүний хүү есүс минь ямар балиар амттай юм бэ? Түргэлээрэй гэж тэр хэржигнэв.

Барби өөрийнхөө дугуйг цоолоод хутгаа сугалахад "пш-пш" гэж агаар гадагшлах дуу гарав. Жулия түүнд мэс заслын өрөөнд сувилагч хэрэгтэй багажийг дамжуулах мэт голыг итгэлтэй өглөө. Барби хөндий голыг зүсэлт рүү зооход хаймар тал талаас нь шахаж хөхөхийг харангаа шатам халуун нүүр рүү нь агаарын урсгал ирэхийг мэдрэв. Өөрийгөө дийлэлгүй гүнзгий амьсгаа авлаа. Энэ агаар хүчилтөрөгчийн агууламж ба цэнгэг байдлаараа сэнснүүд Бүрхүүлийг нэвт үлээх агаараас хавьгүй дээр ажээ. Тархи нь сэрэх шиг болж тэр алгуурлалгүй шийдвэр гаргав. Уутыг агаараар дүүргэхийн оронд тэр нэг уутнаас нь том жигд бус хэрчмийг урж тасаллаа.

-Чи юу хийгээд байна вэ? гэж Жулия асуув.

Барби хөндий голыг уутны тасархайгаар таглав.

-Надад итгэ. Зүгээр л хайрцаг руу очоод хүссэнээ хий.

Бүсгүй түүн рүү нүдээ том нээн харсанаа машины гүйдэг хаалгыг нээлээ. Унах шахаад хөл дээрээ тогтов. Юманд тээглэж бүдрээд гялсхийх хайрцагны дэргэд сөхөрлөө. Барби хоёр дугуйгаа бариад түүнийг дагав. Сэмийн хугга хармаанд нь байлаа. Барби Жулиягийн хажууд сөхөрч унаад голоос нь хар хөндий гуурс пухуйх дугуйг түүнд өглөө.

Бүсгүй бөглөөсийг суга татаад гүнзгий амьсгалав. Хацар

нь пөмбийгөөд ирлээ. Амныхаа нэг булангаар амьсгалаа гаргаад дахин амьсгаа авав. Хацар дээгүүр нь нулимс урсч, шинэхэн мөр татуулав. Барби бас уйллаа. Энэ бүхэн сэтгэл хөдлөлтэй ямар ч хамаагүй. Тэд зүгээр л идэмхий хүчлийн бороон дор орчихсон мэт болжээ. Энд яг Бүрхүүлийн хажууд байснаас хавьгүй дор байв. Жулия дахин амьсгаллаа.

-Сайхан байна. Маш сайхан. Загас үнэртэхгүй байна. Зөвхөн тоос гэж амьсгаа гаргангаа хэлээд дахин нэг соронгуут дугуйг Барбид өгөв.

Хэдийгээр түүний уушиг урагдаж эхэлсэн ч Барби толгой сэгсрээд дугуйг түлхлээ. Өөрийнхөө цээжийг дэлдээд түүний цээж рүү заав.

Жулия дахин амьсгалав. Хоёр дахь удаагаа амьсгалав. Барби түүнд туслан дугуйг барьж өгнө. Алс хол өөр ертөнцөд Сэм ханиаж, бөгшүүлэн ханиана.

Тэр бүх юмаа урж хаях нь дээ гэж Барби бодлоо. Гэвч хэрэв яг одоо агаар сорохгүй бол түүний дотор ч гэсэн урагдах гэж байгааг мэдрэв. Тэгээд Жулия хоёр дахь удаагаа дугуйг

түлхэхэд гар хийцийн гуурсандаа наалдаад уушигаа бүтэн дүүргэхийн тулд энэ тоостой гайхамшигт агаарыг гүнзгий соров. Агаар хүрэлцэхгүй байлаа. Сандарч тэвдсэн ийм цагт хүрэлцэх ч аргагүй биз дээ.

(бурхан минь би живж байна)

гэж тэр бараг хэлэх шахав. Машин руу гүйх хүсэл Жулияг март гэх аж. Жулия өөрөө өөртөө санаа тавиг гэх бодол түүнийг дийлдэшгүй эзэмдэх мэт санагдана... Гэвч Барби тэсч чадлаа. Нүдээ аниад амьсгалж, байж болшгүй тийм хүйтэн тайван тулах цэгийг олох гэж оролдов.

Зөөлөн. Аяархан. Зөөлхөн.

Тэр гурав дахь удаагаа амьсгаа авах үед галзуу мэт дэлдэж байсан зүрх нь удаашраад ирлээ. Жулия урагш тонгойж, хайрцагны хоёр талаас зуурахыг Барби харна. Юу ч болж өнгөрсөнгүй. Тэр үүнд гайхсангүй. Анх энд ирэх үед Жулия хайрцаганд хүрсэн учир дархлаа суужээ.

Дараа нь түүний нуруу гэнэт гүдийв. Жулия гасаллаа. Барби түүнд гуурс санал болгосон ч бүсгүй тоосонгүй. Түүний хамар ба баруун нүднээс цус урслаа. Улаан дуслууд хацрыг даган урсав.

Би мэдэхгүй байна. Би юу болоод байгааг мэдэхгүй байна гэж Барби цөхрөн бодлоо.

Гэвч тэр нэг зүйлийг ян тан мэдэж байсан нь Жулия одоохон агаар сорохгүй бол үхнэ. Тэр эхний дугуйнаас голыг суга татаж аваад амандаа зууж Сэмийн хутгийг хоёр дахь дугуй руу зоов. Нүх рүү голоо зоогоод гялгар уугаар таглалаа.

Тэгээд хүлээв.

10

Энэ бол цаг хугацаанаас гадуур цаг хугацаа.

Жулия дээвэргүй аварга том цагаан өрөөнд байх бөгөөд толгой дээр харь гаригийн ногоон тэнгэр цэлийнэ. Энэ... юу вэ? Тоглоомын өрөө юу? Тийм. Тоглоомын өрөө. Тэдний тоглоомын өрөө.

(Үгүй тэр тавцангийн шалан дээр хэвтэж байна)

Тэр ямар нэг насны эмэгтэй.

(Үгүй. Тэр бяцхан охин)

Энд цаг хугацаа байхгүй.

(Энэ бол 1974 он. Тэгээд энэ ертөнцөд цаг хугацаа хүссэнээр байгаа)

Тэр дугуйнаас агаар сорох хэрэгтэй. (Тэр сорохгүй байна)

Ямар-нэг юм түүнийг харна. Ямар нэг аймшигтай юм. Гэвч тэр ямар нэг юмны хувьд Жулия ч бас аймшигтай. Яагаад гэвэл тэр байх ёстойгоосоо том бөгөөд бас тэр энд байна. Уг нь тэр энд байх ёсгүй. Тэр хайрцагт байх ёстой. Гэхдээ ингэлээ гээд хоргүй. Ямар нэг юм үүнийг мэдэж байна. Хэдийгээр ямар нэг юм боловч.

(Тэр ердөө л хүүхэд)

Нас маш бага. Нярай наснаас дөнгөж гарч байгаа. Тэр ямар нэг юм хэлж байна.

-Чи санаанаас төрсөн хуурамч уу?

-Үгүй. Би жинхэнэ. Гуйя. Би жинхэнэ. Бид бүгд жинхэнэ.

Илгэн толгойтой амьтан түүн рүү нүдгүй нүүрээр харна. Нүүрээ үрчийлгэв. Хэдийгээр ямар ч амгүй боловч амны завьж нь унжлаа. Түүнд маш их аз дайрсаныг Жулия ойлгов. Хайрцагны дэргэд тэр ганцхан амьтантай таарчээ. Ихэнхидээ тэд олуулаа байдаг. Гэвч тэд хоолоо идэхээр гэр рүүгээ явсан, цайгаа уухаар гэр рүүгээ явсан, унтахаар явсан, сургуульдаа явсан, амрахаар явсан, хаашаа явсан нь чухал биш, тэд явчихжээ.

Хаашаа ч юм явжээ. Хэрэв тэд хамт байсан бол түүнийг буцаагаад хөөх байсан. Энэ амьтан ч түүнийг буцааж хөөж чадна. Гэвч энэ эмэгтэй амьтан их сониуч юм.

Эмэгтэй гэж үү?

Тийм.

Энэ амьтан Жулия шиг эмэгтэй.

-Гуйя, биднийг тавиач. Бидэнд бяцхан амьдралаа амьдарч өнгөрөөхийг зөвшөөрөхийг гуйя.

Хариу байхгүй. Хариу алга, хариу ирсэнгүй. Дараа нь: -Та нар жинхэнэ биш. Та нар...

Юу гэнэ ээ? Тэр юу ярина вэ? Та нар тоглоомын дэлгүүрийн тоглоом гэнэ үү? Үгүй. Гэвч нэг тийм юм ярьж байна. Жулиягийн толгойд ахынх нь шоргоолжны фирмийн дурсамж гүйнэ. Алс холын хүүхэд насны дурсамж. Энэ дурсамж секундыг арав хуваасан хугацаанд ирээд явж одлоо. Шоргоолжны ферм бол тоглоомын дэлгүүрийн тоглоом яг ч биш л дээ. Гэхдээ ойрхон. Нэг торхноос гэж хэлдэг шиг.

-Та нар жинхэнэ биш байж яаж өөрийн амьдралтай байх юм бэ?

-Бид жинхэнэ гэж тэр хашгирав. Түүний чарлах дууг Барби сонслоо.

-Яг та нар шиг жинхэнэ.

Дуугүй болов. Дээвэргүй аварга том байранд байгаа бас Честерс-Миллийн хотын талбай дахь тавцан дээр нэг зэрэг байгаа байнга өөрчлөгдөх илгэн нүүртэй амьтан хариу хэлсэнгүй. Дараа нь

-Тэгвэл батлаад өг.

-Гараа өг.

-Надад гар байхгүй. Надад бие байхгүй. Бие жинхэнэ биш. Би бол зүүд.

-Тэгвэл оюун ухаанаа өг.

Илгэн толгойтой хүүхэд өгсөнгүй. Өгөх ч үгүй. Тиймээс Жулия түүнийг булаан авлаа.

11

Энэ бол орон зайд үл хамаарах орон зай.

Тавцан дээр хүйтэн бөгөөд Жулия ихэд айжээ. Түүнээс гадна тэр... Доромжлуулсан уу? Үгүй. Энэ бол доромжлолоос хавьгүй дор. Тэр гишгэлэгдсэн. Тийм тийм дэвслүүлсэн. Тэд түүний өмдийг авсан.

(Харин хаа нэгтээ цэргүүд спорт танхимд шалдан хүмүүсийг өшиглөж байна. Хэн нэгний ичингүйрэл түүний ичингүйрэлтэй холилдоод байна)

Жулия уйллаа.

(Тэр бас уйлмаар байгаа боловч уйлахгүй байна. Одоо тэд яаж ийгээд зөвтгөх ёстой)

Охид түүнийг орхиод явчихлаа. Гэвч түүний хамраас цус гарсаар. -Лайла түүний нүүрийг цохисон. Хэрэв өөр хэн нэгэнд хэлэх юм бол хамрыг нь огтолно гэж амалсан. Тэд түүнийг нулимсан. Одоо тэр энд хэвтэж байна. Тэр их уйлсан байх. Түүний зөвхөн хамраас биш нүднээс цус гарч байгаа гэж тэр бодно. Тэр амьсгалж чадахгүй байна. Тэр хүүхдийн тэнэг дотоожтой гэр рүүгээ явсан дор тавцан дээр цус алдаж үхсэн нь дээр. Хэрэв энэ нь цэргийг харахгүйд хүргэнэ гэх юм бол тэр дуртайяа цус алдаж үхэх юмсан.

(Дараа нь Барби энэ цэргийн тухай бодохгүйг хичээж байна. Гэвч бодох үед нь Хэкермейер нь Хэкермангас болон хувирч байна)

Нүцгэн хүнийг алчуураас нь өргөж байгаа мангас.

(Куфийнээс нь)

Толгойдоо зүүж явдаг алчуураас нь. Яагаад гэвэл энэ бүхэн яаж дуусахыг Жулия мэднэ. Хэрэв чи Бүрхүүл дор байгаа бол бүх юм үргэлж ингэж л дуусна.

Охидын нэг нь эргэж ирснийг тэр харлаа. Кайла Бевинс эргэж ирэв. Тэр зогсоод ухаантай гэж бодож байсан тэнэг Жулияг харна. Хүүхдийн дотоож өмссөн тэнэг жаахан Жулия Шамуэйг харна. Кайла үлдсэн хувцасыг тайлж тавцангийн дээвэр рүү хаях гэж ирсэн юм уу? Тэгээд тэр бэлиг эрхтнээ гараар хаагаад гэртээ шалдан харих уу? Хүмүүс яагаад ийм зэрлэг байдаг юм бэ?

Жулия нулимс дүүрсэн нүдээ аниад дараа нь нээхэд Кайла шал өөр болчихжээ. Тэр нүүр царайгүй болсон байв. Зөвхөн зогсоо чөлөөгүй өөрчлөгдөх арьсан баг. Энэ баг шаналал зовлон, хайр дурлал, тэр бүү хэл үзэн ядалтыг ч мэдэхгүй.

Зөвхөн... Сониучирхал. Яг тийм. Хэрэв би ингэчихвэл яах бол? Эсвэл ингэвэл яах бол?

Жулия Шамуэй одоо байхгүй. Жулия Шамуэй юу ч биш. Өчүүхэн жижгүүдээс хамгийн өчүүхнийг олоод доогуур нь шагай. Тэр энэ байна. Мөлхдөг ялаа Шамуэй. Бас тэр олзлогдсон нүцгэн ялаа, олзлогдсон ялаа. Хувцаснаас нь ганцхан толгойн задарсан алчуур үлджээ. Харин алчуур дор дөнгөж сая эхнэрийн гараар жигнэгдсэн сайхан үнэртэй гамбирын тухай дурсамж. Тэр сүүл нь шатах муур, томруулдаг шилэн дор орсон шоргоолж, бороотой өдөр гуравдугаар ангийн сурагчийн сониуч гарт өртөж одоохон далавчнаасаа салах ялаа, биегүй мөртлөө бүх Орчлон ертөнц хөлөнд нь хөглөрөх хийх ажилгүй уйтгарласан хүүхдүүдийн тоглоом. Жулия бол - Барби, Жулия бол - Линдагийн машинд үхэж байгаа Сэм. Жулия бол нүүрс болсон талбайд үхэж байгаа Олли. Жулия бол - талийгаач хүүгийнхээ араас гашуудаж байгаа Элва.

Гэвч юуны өмнө Жулия бол хотын талбайн тавцангийн өргөстэй хэсэгт хэвтэх бяцхан охин. Ямар ч буруугүй шазруун зангийнхаа төлөө шийтгүүлсэн бяцхан охин. Хэн ч биш атлаа өөрийгөө хэн нэгэн гэж бодон алдаа гаргасан бяцхан охин. Юу ч төлөөлөөгүй мөртлөө өөрийгөө ямар нэг юм төлөөлж байгаа гэж бодсон бяцхан охин. Хорвоо бол хөдөлгүүртэй, тольдуур гэрэлгүй, хүмүүнлэг бус, аварга том бух тэрэг байтал түүнийг хүмүүст эелдэг гэж бодон алдаа хийсэн бяцхан охин. Тэгээд өөрийн бүх зүрх, оюун ухаан ба сэтгэл зүрхээр тэр хашгирч байв.

-Гуйя. Бидэнд амьдрахыг зөвшөөр. Би чамаас мөргөн гуйж байна. Гуйя.

Тэгээд зөвхөн ганцхан хормын дотор Жулия цагаан өрөөнд байгаа илгэн толгойт болж хувирав. Жулия тавцан дээр эргэн ирсэн охин (өөртөө ойлгомжгүй шалтгаанаар) болж хувирав. Ганцхан аймшигт хормын дотор үүнд өртсөн охин биш харин үүнийг хийсэн охидын нэг болж хувирлаа. Тэр бүү хэл Барбигийн хориглоогүй бөгөөд хар дарсан зүүдэнд нь дандаа ирдэг гартаа буу барьсан цэрэг, Хейкермангас болж хувирав.

Харин дараа нь Жулия -Энэ бол Жулия.

Кайла Бевинсийг доороос нь дээшээ харах охин.

Кайла ядуу айлын хүүхэд. Эцэг нь Ти-Эр-т түлээ унагах ба "Фрешис" бааранд архидна. (цаг хугацаа өнгөрөхөд "Дипперс" нэртэй болсон) Ээжийнх нь хацар дээр төрөлхийн том улаан мэнгэ байх учраас хүүхдүүд түүнийг Гүзээлзгэнэ-толгойт юмуу Тоорон-хацарт хэмээн нэрлэдэг. Кайлад гоё хувцас байхгүй. Өнөөдөр тэр хуучин хүрэн ноосон цамц, хуучин банзал ба яйжгар гутал бас резин нь сунасан цагаан оймс өмссөнөөс тэр нь шувтарна. Нэг өвдөг нь шалбарчээ.

Тэр унасан юмуу эсвэл түүнийг тоглоомын талбай дээр түлхэж унагасан. Энэ бол Кайла. Яг тийм. Гагцхүү түүний нүүр илгэн болжээ. Тэгээд хэдийгээр энэ царай хэлбэрээ байнга солих

боловч хэлбэрийн аль нь ч хүний нүүр царайд огт ойртохгүй.

Жулия бодов. Хэрэв шоргоолж шатаж үхэхийнхээ өмнө дээш харж томруулдаг шилний өөрийн талаас толгойгоо өргөх юм бол шоргоолжинд хүүхдүүд яг ингэж харагддаг байх.

-Кайла гуйя. Чамаас гуйя. Бид амьд.

Кайла юу ч хийхгүй түүнийг дээрээс доош харна. Дараа нь гараа энгэртээ зөрүүлэв. Энэ үед түүнд хүний гар харагддаа. Тэгээд цамцаа толгойгоор сугалав. Түүнийг ярих үед хоолойд нь хайр энхрийлэл, гэмшсэн байдал юмуу гэмээ наманчилсан өнгө аяс аль нь ч алга.

Магадгүй өрөвдсөн байдал.

Тэр ярьж байна.

12

Түүнийг хэн нэгний гар чулуудах мэт Жулия хайрцагнаас ховх үсрэв. Цээжиндээ тэгтэл удаан барьсан агаар шуугиантай гадагшиллаа. Жулия амьсгаа авч амжаагүй байхад нь Барби мөрөөр нь тэврээд гуурсны хуванцар бөглөөсийг мулт татаж гуурсан голыг эмэгтэйн ам руу шууд зоосон бөгөөд хэлийг нь зүсч тагнайг нь гэмтээгээгүй гэж найдна. Тэр энэ эмэгтэйг хорт агаар амьсгалуулж чадахгүй. Тэгэх юм бол хүчилтөрөгчийн өлсгөлөнгийн улмаас таталт өгч, бүр түүнийг үхүүлж ч мэднэ.

Жулия өөрөө ч үүнийг ойлгож байх мэт. Тэр "прус"-ын дугуйнаас амь тэмцэн зуурч гуурсаар агаар шуналтай соров. Бүх бие нь хэрхэн салгалахыг Барби мэдэрлээ.

Сэм арай гэж ханиахаа больсон ч ханиахын оронд өөр дуу гарав. Жулия ч бас сонсчээ. Цээж дүүрэн нэг сороод нүдээ бүлтийлгэн дээш харлаа.

Нохой хуцав. Горас байх. Яагаад гэвэл өөр нохой үлдээгүй. Тэр...

Барби түүний гарыг маш чанга базсан тул хугарах вий гэж тэр айлаа. Түүний царайд гайхал тодров.

Хачин бэлэгдэл бүхий хайрцаг газраас дөрвөн фут өндөрт өргөгджээ.

13

Цэнгэг агаарыг хамгийн түрүүнд Горас мэдэрсэн юм. Яагаад гэвэл тэр газарт хамгийн ойрхон байсан. Хуцаж эхлэв. Дараа нь Жо мэдэрлээ. Түүний хөлстэй нуруу руу гайхалтай хүйтэн салхи үлээв. Жаалхүү Бүрхүүл налан сууж байсан юм. Бүрхүүл хөдөллөө. Өргөгдөв. Халуурч улайсан нүүртэй Норри Жо-гийн цээжийг налан унтаж байсан. Түүний зууралдсан бохир үс сэвэлзэхийг Жо олж харав. Тэр нүдээ нээлээ.

-Юу вэ?... Жо юу болоод байна вэ?

Жо мэдэж байсан ч гайхсандаа ярих чадвараа алдаж, хариу хэлсэнгүй. Түүний нуруугаар ямар нэг юм гулгахыг тэр мэдэрсэн. Төгсөшгүй шилэн хана өргөгдөж байв.

Горас галзуу мэт хуцаж нуруугаа хотойлгоод газарт хамраа наав. Энэ байрлал уг нь би тогломоор байна гэсэн үг. Гэвч Горас тоглоогүй юм. Тэр өргөгдөж байгаа Бүрхүүл доогуур хамраа шургуулаад хүйтэн амтлаг цэнгэг агаарыг амьсгалав.

Бурханлиг сайхан.

14

Бүрхүүлийн өмнөд хэсэгт байлдагч Эймс зүүрмэглэнэ. Тэр 119-р замын шороон хажуу дээр индиан хүн шиг бүтээлэг нөмрөөд завилан суужээ. Эймсийн толгойд эргэлдэх муу бодлууд шиг агаар гэнэт хар болоод биеийн хэлбэрт хувирлаа. Дараа нь тэр ханиагаад үүнээсээ болж сэрэв.

Түүний өндөр түрийтэй гутлын эргэн тойронд хөө хуйларч газрын ногоон өнгөтэй өмдөн дээр нь бууна. Бурхан минь хаанаас гарч ирдэг байна вэ? Бүрхүүл доорх бүх юм шатсан пгүү дээ. Дараа нь тэр харав. Бүрхүүл яг аварга цонхны хаалт мэт өргөгдлөө. Ийм юм байж болшгүй. Саад газар руу олон миль зоогдож орсныг бүгд мэднэ. Харин тэр одоо өргөгдөж байна.

Эймс нэг хором ч эргэлзсэнгүй. Урагшаа мөлхөөд Олли Динсморыг гарнаас нь барьж авав. Хоромхон зуур Бүрхүүлийн ирмэгийг бэлхүүсээр шүргэв. Одоо тэр бууж намайг хуваана даа бодож амжлаа. Гэвч жаалхүүг гадагш чирсээр байв.

Эхэндээ хүүр чирч байх мэт санагдлаа.

-Үгүй гэж тэр хашгирав. Оллиг гар дээрээ өргөөд сэнснүүдийн нэгэнд аваачлаа. -Үхэрчин жаал минь үхэж болохгүй шүү.

Олли ханиалгаад бага зэрэг бөөлжив. Эймс хүүг гартаа тэвэрсээр байв. Бусад нь баяртай хашгиралдан тэдэн рүү гүйх

бөгөөд бүхнээс түрүүнд ахлагч Гро харайлгана. Олли дахиад бөөлжлөө.

-Намайг үхэрчин жаал гэж битгий нэрлэ хэмээн тэр шивнэв.

-Түргэн тусламж. Бидэнд түргэн тусламж хэрэгтэй гэж Эймс ориллоо.

-Үгүй. Бид түүнийг Мэний төв эмнэлэг рүү нисдэг тэргээр илгээнэ. Пацаан минь, хэзээ нэг цагт нисдэг тэргээр нисч үзсэн үү? гэж Оллигоос асуув.

Манарсан нүдтэй Олли толгой сэгсэрлээ. Дараа нь ахлагчийн гутал дээр бөөлжив.

Грогийн царай гэрэлтэж, Оллигийн бохир гарнаас атталаа.

-АНУ-д эргэж ирсний баяр хүргэе хүү минь. Их ертөнцөд эргэн ирсний баяр.

Олли Эймсийн хүзүүгээр тэвэрлээ. Тэр ухаан алдаж байгаагаа мэдсэн ч яаж ч чадсангүй. Баярлалаа гэж хэлэхийн тулд тэсэх гэж оролдсон ч бүтсэнгүй. Харанхуйд унахынхаа өмнө өмнө зүгийн цэрэг хацар дээр нь үнсэхийг мэдэрч амжив.

15

Умар зүгт Бүрхүүл дороос хамгийн түрүүнд сугарсан нь Горас байлаа. Шууд хурандаа Кокс дээр давхиж хүрээд хөлөнд нь бүжиглэв. Сүүлгүй нь түүнд огт саад болсонгүй. Бөгс нь тэр чигээрээ хоёр тийшээ савчина.

-Намайг хараал идэг гэж Кокс дуу алдаад нохойг гартаа тэвэрлээ. Нохой тэр дороо түүний нүүрийг долоож гарав.

Амьд үлдэгсэд өөрийнхөө талд бөөгнөрөн зогсоно. (тусгаарлах шугам өвсөн дээр тод ялгагдана. Нэг талаасаа тод ногоон, нөгөө талаасаа амьгүй саарал өнгөөр) Тэд юу болсныг дөнгөж ухаарч эхэлсэн ч итгэж чадахгүй байв. Расти Линда ба тэдний бяцхан охид, Жо, Норри ба тэдний ээж нар. Жина, Жинни, Гарриетт нар тэврэлдлээ. Дуги Литл-Уолтерийг бүүвэйлж цурхиран уйлах Роуз эгчийгээ тулав. Пайпер Лисса ба Жекки нар гар гараасаа атталаа. "Ардчилал"-ын редакцийн үлдсэн ажилтнууд болох Пит ба Тони хоёр тэдний ард зогсоно. Элва Роммид наалдаж, харин өнөөх нь Элисийг тэвэрчээ.

Бүрхүүлийн бохир гадаргуу тэнгэрт одохыг тэд харна. Гадна талын намрын навчис гоо сайхнаараа гайхуулна.

Амттай цэнгэг агаар тэдний үсийг сэвэлзүүлж хөлс хатаана.

-Бид яг бүүдгэр шилний цаанаас харж байжээ. Харин одоо нүүр нүүрээрээ харж байна гэж Пайпер лам хэлээд уйлав.

Горас Коксын гарнаас үсрэн бууж газарт наймын тоо зурж, хуцаж, үнэрлэж, шээхийг оролдон бүгдийг зэрэг хийв.

Амьд үлдэгсэд аравдугаар сарын энэ өдөр шинэ Английн дээр цэлийсэн өглөөний цэнхэр тэнгэрийг итгэж ядан харна. Харин тэднийг хорионд байлгасан бохир хаалт улам хурдан хурдан дээшилж, хэмжээ нь жижгэрсээр цэнхэр цаасан дээрх харандааны хар цэг болон хувирлаа.

Бүрхүүл байсан газар дээгүүр шувуу нисч өнгөрөв. Элис Роммид тэврүүлсэн чигээр пгувууг хараад инээд аддлаа.

16

Барби Жулия хоёр дугуйны хоёр талд сөхрөн суугаад дотроос нь цухуйх гуурсан гол руу ээлжлэн наалдана. Хайрцаг дахиад өргөгдөж эхлэхийг тэд ажиглана. Эхлээд удаан, 60 орчим футын өндөрт очоод эргэлзэх мэт хоёр дахь удаагаа хөшив. Тэгснээ дараа нь дээшээ суга

үсэрсэн бөгөөд хүний нүд дагуулж харах боломжгүй. Хүн нисч яваа сумыг харж чаддаггүй шүү дээ. Бүрхүүл эсвэл дээшээ ниссэн эсвэл буцаж одсон.

Хайрцаг. Тэр Бүрхүүлийг араасаа чирч байна. Соронз төмрийн үртэсийг татдаг шиг гэж Барби бодов.

Салхи нисэн ирлээ. Өвсний хөдөлгөөнөөр Барби анзаараад Жулиягийн мөрнөөс сэгсэрч умар зүгт заав. Бохир саарал тэнгэр ахиад цэнхэр болсон нь нүдэнд дэндүү хурцдах ажээ. Тэгээд модод намрын өнгөө эргүүлэн авав.

-Би хэзээ нэгэн цагт ийм юм харсанаа мэдэхгүй... гэж Барби эхэлтэл салхи тэдэн дээр хүрч ирлээ. Жулиягийн үсийг өргөж бохир нүүрэн дээрх хөлсийг нь эелдгээр, яг л хайртай хүнийх нь алга шиг хатааж гарав.

Жулия ханиалаа. Барби анх удаа эндхийн агаарыг залгиад түүний нуруун дээр цохив. Агаар урьдын адил өмхий үнэртэж хоолой зүсч байсан ч одоо амьсгалж болохоор болжээ. Муу агаар урагш түрж цэнгэг агаар Бүрхүүлийн Ти-Эр-90-ийн зүгээс, үгүй ээ Бүрхүүлийн Ти-Эр-ийн талд байсан тэр газраас ирэв. Хоёр дахь амьсгаа илүү дээр болж, гурав дахь нь бүр сайжирч, дөрөв дэх нь бурхны хишиг боллоо.

Эсвэл илгэн толгойтой охиныг хиптиг.

Барби Жулия хоёр хайрцаг байсан хар дөрвөлжин газрын дэргэд тэврэлдэв. Энэ газар дээр дахиад хэзээ ч юу ч ургахгүй.

17

-Сэм. Бид Сэмийг гаргах ёстой гэж Жулия дуу алдав.

Тэд машин руу гүйж явахдаа ханиасаар байлаа. Харин Сэм ханиахгүй байв. Тэр жолоон дээр тэгнэж хэвтээд нүд нь нээлттэй хэржигнэн амьсгалж байв. Нүүрний доод хэсгийг цус буджээ. Барби түүнийг суудлын ар налуулах санаатай хойш нь татахад цамцны энгэр нь хөх биш бохир улаан болсон байхыг олж харав.

-Чи түүнийг авч явж чадах уу? Түүнийг цэргүүд дээр аваачиж чадах уу? гэж Жулия асуув.

Мэдээж тэр чадахгүй. Гэвч оролдоод үзье гэж хариуллаа.

-Хэрэггүй гэж Сэм шивнэв. Түүний нүд тэдэн дээр туслаа.

-Их өвдөж байна гэж хэлэх үед үгийн тоолонгоор амнаас нь цус гадагшилна. -Та нар үүнийг хийж чадсан уу?

-Жулия хийсэн. Яаж гэдгийг мэдэхгүй. Гэвч хийсэн.

-Спорт танхимд байсан хүний ачаар. Хэкермангаст буудуулсан тэр хүн гэж Жулия тайлбарлав. Барбигийн эрүү унжлаа. Гэвч Жулия үүнийг анзаарсангүй. Сэмийн мөрөн дээр

гараа тавиад хоёр хацар дээр нь үнсэн: -Сэм чи бас үүнийг хийсэн. Биднийг нааш авчирч бас тавцан дээр байгаа жаахан охиныг олж харсан.

-Би чамайг зүүдэндээ жижигхэн охин байхыг харсан. Чи том болжээ.

-Жаахан охин урьдын адил энд байгаа гээд Жулия цээжээ дарж: -Урьдын адил энд. Амьд байгаа.

-Намайг машинаас гарахад туслаач. Цэвэр агаар залгихыг хүсч байна. Үхэхээсээ өмнө гэж Сэм шивнэв.

-Чи тэгэхгүй...

-Эмэгтэй минь дуугүй бай. Бид бүхнийг мэднэ.

Барби Жулия хоёр түүнийг машинаас гарахад нь туслаад газарт болгоомжтой суулгав.

-Үнэрлээч. Агаар ямар байна вэ? гэх Сэмийн дуу бахдалаар дүүрчээ.

-Ариун бурхан минь гээд гүнзгий амьсгаа авч, дараа нь ханиахад амнаас нь цус цацагдав. -Би анхилуун үнэр мэдэрч байна.

-Би ч бас гэж Жулия толгой дохиод духан дээрх үсийг нь хойшлуулав.

Тэр түүний гаран дээр өөрийнхөө гарыг тавьлаа. -Тэд... Тэд бидний зовлонг мэдэрсэн үү?

-Тэнд нэг нь л байсан. Хэрэв олуулаа байсан бол юу ч болохгүй байсан. Би тэдний нийлсэн харгислалыг тэмцэж дийлэхгүй байсан гэж бодож байна. Тэгээд үгүй. Тэр юу ч мэдрээгүй. Тэр биднийг өршөөсөн. Өөр юу ч биш.

-Тэд бидэн шиг биш юмуу? гэж өвгөн шивнэв.

-Үгүй. Огт бидэн шиг биш.

-Өршөөх нь хүчтэй хүмүүст оногддог хувь заяа гээд тэр санаа алдав. -Би зөвхөн харамсаж л чадна. Би үүнийг архи уухын тулд хийсэн. Гэсэн ч харамсч байна. Хэрэв би чаддагсан бол бүхнийг буцаах байсан.

-Чи юу хийсэн байлаа ч одоо бол гэмээ цайруулсан гэж Барби батлан хэллээ. Зүүн гараас нь аттав. Ядам хуруунд нь хуримын бөгж арай ядан тогтох бөгөөд энэ турсан бие махбодид дэндүү томдох ажээ.

Сэмийн хөхөрсөн нүд Барби руу шилжээд, хөгшин инээмсэглэх гэж оролдов.

-Магадгүй цайруулсан байх... Тэгээд ч би энэ бүхнийг баяртайгаар хийсэн. Гэвч бодохдоо ийм юм болох... гэснээ ханиаж цусаар тургилаа.

-Одоо болсон. Ярихаа боль гэж Жулия дуу алдав. Тэр хоёр өвгөний хоёр талд сөхрөн суужээ. Бүсгүй Барби руу харав. -Түүнийг авч явж болохгүй юм байна. Дотор нь гэмтжээ. Бид тусламж авчрахаар хурдлах хэрэгтэй.

-Тэнгэр ямар сайхан юм бэ? гээд Сэм амьсгаа гаргав.

Үүтээр тэр хүний бүх амьдрал дууслаа. Дахин амьсгаа аваагүй учраас цээж нь доошлоод буцаж өргөгдсөнгүй. Барби нүдийг нь хаахаар гараа сунгахад Жулия гарыг нь барьж аваад зөвшөөрсөнгүй.

-Харж л байг. Тэр үхсэн гэсэн ч хүссэнээрээ хараг.

Тэд түүний хажууд сууцгаана. Шувууд жиргэнэ. Хаа нэгтээ горас хуцлаа.

-Би нохой дээрээ очих ёстой байх.

-Тийм. Явах уу? гээд Барби толгой дохив.

Бүсгүй толгой сэгсэрлээ.

-Алив алхацгаая. Хэрэв бид яарахгүй бол хагас миль алхаж болно гэж бодогдоод байна.

Барби түүнийг босоход нь туслав. -Одоо тодруулъя.

18

Гар гараасаа хөтлөн хөдөөгийн замын энхэл донголоор алхах үедээ Жулия түүний нэрлэсэнээр "Хайрцаг дотор" юу болсоныг түүнд ярив.

Жулияг ярьж дуусахад Барби толгой дохиод -Ойлгомжтой. Чи түүнд бид ямар муу үйл хийх чадвартай тухай ярих юмуу эсвэл тэднийгээ түүнд үзүүлжээ. Гэвч тэр биднийг сулласан байна.

-Муу үйлсийн тухайд тэд бүгдийг мэдэж байсан.

-Фаллужид өнгөрөөсөн тэр өдөр миний амьдралын хамгийн муу дурсамж. Хамгийн аймшигтай нь... Би үүнийг хийсэн атал надтай ийм юм хэн ч хийгээгүй.

-Чи үүнийг хийгээгүй. Үүнийг өөр хүн хийсэн гэж бүсгүй сануулав.

-Чухал биш. Хэн хийсэн байлаа ч тэр залуу үхсэн нгүү дээ.

-Хэрэв спорт танхимд зөвхөн гурав юмуу эсвэл хоёр хүн байсан бол ийм юм болох байсан уу? Эсвэл чи ганцаараа байсан бол?

-Үгүй. Мэдээж үгүй.

-Тэгвэл хувь заяаг буруутга. Эсвэл Бурханыг. Эсвэл Орчлон ертөнцийг. Харин өөрийгөө буруутгахаа боль.

Хэрэв Сэм үхэхийнхээ өмнө юу хэлэхийг хүссэнийг ойлгосон бол Барби ингэж чадахгүй байсан байх. Буруу хийсэн зүйлийнхээ төлөө харамсана гэдэг юу ч хийхгүй байснаас дээр. Гэвч аллага үйлдэх үед эдэлсэн баяр хөөрийг ямар ч харамсалаар цайруулах боломжгүй. Олзлогдсон хүнийг буудах юмуу эсвэл шоргоолж шатаах нь ялгаагүй аллага.

Тэр Фаллужид ямар нэг баяр хөөрийг мэдрээгүй. Энэ тал дээр өөрийгөө буруутай гэж мэдэрсэнгүй. Энэ л түүний сэтгэлийг хөнгөрүүлнэ.

Цэргүүд тэдэн рүү гүйлдлээ. Одоо тэр хоёрт бие биедээ зориулах ганцхан минут үлджээ. Магадгүй хоёр.

-Жулия би чиний хийсэн зүйлийн чинь төлөө чиний өмнө сөгдөж байна.

-Би мэднэ гэж бүсгүй тайван хариуллаа.

-Чи гайхалтай эр зориг харуулсан.

-Чиний дурсамжийг хулгайлсаны төлөө намайг өршөөх үү? Би ийм юм болохыг хүсээгүй. -Чи бүрэн өршөөгдсөн.

Цэргүүд ойртон ирлээ. Кокс хамт гүйнэ. Горас гээг дарна.

Удахгүй Кокс энд ирээд Кен ямар байна даа гэж асууна. Энэ асуулттай хамт тэд их ертөнцөд эргэн ирнэ.

Барби цэнхэр тэнгэрийг харж цэвэрлэгдэж байгаа агаарыг гүнзгий сорлоо.

-Бүрхүүл байхгүй гэхээр итгэж чадахгүй юм.

-Тэр эргэж ирэх болов уу, чи юу гэж бодож байна?

-Энэ гариг руу биш, бас тэдгээр хүүхдүүд биш. Тэд том болж тоглоомын өрөөг орхино. Гэвч хайрцаг үлдэнэ. Бусад хүүхдүүд түүнийг нь олно. Эрт орой хэзээ нэгэн цагт цус хананд үргэлж цацагддаг.

-Аймаар юм.

-Магадгүй. Гэхдээ би энэ сэдвээр миний ээж юу гэж хэлдэг байсныг сонсохыг хүсэх үү? - Мэдээж.

-Манай гудамжинд ч баяр болох цаг ирнэ гэхэд Жулия инээлээ. Түүний энэ инээд Барбид хичнээн таалагдав. -Илгэн толгойтой охин хамгийн сүүлд юу гэж хэлсэн бэ? Хурдан хэл. Хүмүүс ирж явна. Харин энэ бол зөвхөн бид хоёрт үлдэнэ.

Түүний царайд гайхал тодорлоо. Тэр яаж мэдэхгүй байж чадна вэ?

-Тэр яг Кайлигийн хэлсэн үгийг надад хэлсэн. "Гэртээ өмсөөрэй. Яг даахинз шиг харагдах болно".

-Тэр тэгэхээр хүрэн ноосон цамцны тухай ярьсан хэрэг үү? Жулия дахин түүний гараас атгалаа.

-Үгүй дээ. Бидний амьдралын тухай. Бидний бяцхан амьдралын тухай.

Барби бодлогоширов.

-Хэрэв тэр энэ амьдралыг чамд буцааж өгсөн юм бол түүнийг өмсөцгөө. Жулия гараа өргөөд: -Хэн ирж явааг хараач гэв.

Горас түүнийг аль хэдийн олж харжээ. Хурдаа нэмж гүйлдэж яваа хүмүүсийн дунд ороод тэднээс сугарч чөлөөтэй зайд гармагцаа дөрөвдүгээр араандаа залгав. Хоншоорт нь инээмсэглэл тодорно. Хоёр чих нь толгойдоо наалджээ. Хөө тортог хучсан өвсөн дээгүүр сүүдэр нь ниснэ.

Жулия өвдөг сөхрөн суугаад гараа сунгалаа.

-Ээж дээ ир, хонгор минь.

Нохой үсрэв. Бүсгүй барьж аваад инээн нуруугаараа уналаа. Барби түүнийг татаж босгов.

Тэд авсан бэлгээ тээсээр их ертөнцөд хамтдаа эргэн ирлээ.

Энэ бэлэг бол амьдрал.

Өрөвдөх бол мэдээж хайр биш. Гэвч хэрэв чи жаахан хүүхэд мөртлөө нүцгэн хүнд хувцас өгч байвал энэ зөв зам руу явж байгаа алхам юм гэж Барби бодов.



“ДАШВААНЖИЛ” ХХК
Улаанбаатар, Увс, Төв, Дорнод, Дархан-Уул

ТАЛАРХАЛ

Дэлхийн шилдэг бүтээлүүдийг монгол түмэнд түгээхэд санхүүгийн туслалцаа үзүүлсэн Монголын хийн түлшний салбарын анхдагч үндэсний компани болох “ДАШВААНЖИЛ” ХХК-ийн ерөнхий захирал Н.БААТАРЖАВ таны оюуныг дээдэлсэн их үйлсэд гүнээ талархаж, орчин цагийн дэвшилтэт технологи бүхий, санхүүд хэмнэлттэй, хүн байгальд ээлтэй ажил хөдөлмөрт тань өндөр амжилт хүсч, амьдрал тань аз жаргалаар үргэлж бялхаж явах болтугай хэмээн уншигч түмнийхээ хамт ерөөж байна.

СТУДЕНТ
КНИГ

ЦУВРАЛ

2

ISSN 9952-3-705-3



9 789996 217050

ЭНЭ МЭДЭЭНИЙ
САНХҮҮГИЙГ ХУВЬСАН
МОНГОЛЫН
УЛААНБААТАР



Table of Contents

Шоронд
Давс
Чандар
"Сүйрсэн хамтлагийн энэ дууг тоглооч"
Зодуулж баривчлагдав
Хаа сайгүй цус
Шоргоолж
Хэллоуин эрт ирлээ
Үлдэгсэд
Гэртээ өмсөөрэй. Яг даахинз шиг харагдах болно